

ЗАХИРГААНЫ ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ

АНХНЫ ХЭВЛЭЛ



ЗАХИРГААНЫ ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ

АНХНЫ ХЭВЛЭЛ

Улаанбаатар хот
2022 он

ДАА** 342
ННА* 67.401
3-327



ЗАХИРГААНЫ ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ

**Төслийн зөвлөх,
редактор**

Профессор **Ш.Батсүх**
Удирдлагын академийн дэд захирал

Профессор **Н.Бурмаа**
*МУИС-ийн Олон Улсын Харилцаа,
Нийтийн Удирдлагын Сургуулийн
Нийтийн удирдлагын тэнхим*

Профессор **Я.Долгоржав**
*Удирдлагын академийн Төрийн захиргааны
тэнхимийн эрхлэгч*

**Төслийн зохицуулагч,
редактор**

С.Ганзаяа
*Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сангийн
хөтөлбөрийн менежер*

Редактор

Г.Золжаргал

Төслийн нарийн бичиг

Э.Сундуй
Ардчилал судлалын төвийн судлаач

Хэвлэлийн эх бэлтгэсэн

С.Даш-Очир

Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сангаас эрхлэн гаргав.

Зохиогчийн эрх @ Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сангийн Суурин
төлөөлөгчийн газар

© Уг бүтээлийг зохиогчийн эрхийн зөвшөөрөлгүйгээр бүхлээр нь болон хэсэгчлэн хэвлэх, хайлтын системд байршуулах, бүх төрлийн хуулбар зэрэг ямар ч хэлбэрээр хувилж, олшруулахыг Зохиогчийн эрхийн тухай хуулиар хориглосон болно.

ISBN 978-9919-26-684-4

Зохиогчид

Дэд профессор З.Алтанчимэг	<i>МУИС-ийн Бизнесийн Сургуулийн Менежментийн тэнхимийн багш (З.А)</i>
Дэд профессор П.Амаржаргал	<i>Хуульч (П.А)</i>
Доктор М.Амартүвшин	<i>Удирдлагын академийн Төрийн захиргааны менежментийн тэнхимийн багш (М.А)</i>
Дэд профессор Г.Баасанжав	<i>МУИС-ийн Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургуулийн Нийтийн удирдлагын тэнхимийн эрхлэгч (Г.Б)</i>
Дэд профессор Б.Баясгалан	<i>Удирдлагын академийн дэд захирал (Б.Б)</i>
Доктор Ц.Дэлгэржаргал	<i>Удирдлагын академийн Төрийн захиргааны тэнхимийн багш (Ц.Д)</i>
Доктор Ж.Жаргал	<i>Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимийн багш (Ж.Ж)</i>
Профессор Д.Зүмбэрэлхам	<i>Хуульч (Д.З)</i>
Дэд профессор Ч.Лодойравсал	<i>МУИС-ийн Хэрэглээний Шинжлэх Ухаан, Инженерчлэлийн Сургуулийн Электроник, холбооны инженерчлэлийн тэнхимийн багш (Ч.Л)</i>
Дэд профессор Ч.Нарантуяа	<i>МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч (Ч.Н)</i>
Профессор Б.Пүрэвсүрэн	<i>ШУА-ийн Философийн хүрээлэнгийн захирал (Б.П)</i>
Дэд профессор Я.Төгөлдөр	<i>ШУТИС-ийн Бизнесийн Удирдлага, Хүмүүнлэгийн Сургуулийн Нийгмийн ухааны салбарын эрхлэгч (Я.Т)</i>
Доктор Т.Түмэнцогтоо	<i>Удирдлагын академийн Төрийн захиргааны тэнхимийн багш (Т.Т)</i>
Шинжлэх ухааны доктор А.Цанжид	<i>ШУА-ийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан (А.Ц)</i>
Профессор С.Цэдэндамба	<i>Философич (С.Ц)</i>
Профессор Д.Чимгээ	<i>МУИС-ийн Бизнесийн Сургуулийн Менежментийн тэнхимийн багш (Д.Ч)</i>
Профессор Ч.Энхбаатар	<i>Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн багш (Ч.Э)</i>
Дэд профессор А.Энхбат	<i>МУИС-ийн Бизнесийн Сургуулийн Санхүүгийн тэнхимийн багш (А.Э)</i>
Дэд профессор А.Энхцэцэг	<i>Социологич (А.Э.ц)</i>

АГУУЛГА

МЭНДИЙН ҮГ 22

ӨМНӨХ ҮГ 23

А

- АВЛИГА (А.Энхцэцэг) 27
- АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
(П.Амаржаргал) 27
- АВТОРИТАРИЗМ (Я.Төгөлдөр) 28
- АГВААНЧОЙЖИРДОНДОВ ГАВЖ
(А.Цанжид) 28
- АГЕНТЫН ОНОЛ (Т.Түмэнцогтоо) 29
- АГУУЛГЫН ОНОЛ (Ц.Дэлгэржаргал) 29
- АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗАР (Г.Баасанжав) 30
- АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ (А.Энхцэцэг) 30
- АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ТАНГАРАГ
(Ц.Дэлгэржаргал) 31
- АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БОДЛОГО
(Ч.Нарантуяа) 31
- АЖЛЫН БАЙРНЫ ЗУРАГЛАЛ
(А.Энхцэцэг) 32
- АЖЛЫН БАЙРНЫ ШИНЖИЛГЭЭ
(М.Амартүвшин) 32
- АЖ ҮЙЛДВЭР 4.0 (Б.Пүрэвсүрэн) 33
- АЗ ЖАРГАЛЫН ИНДЕКС (Г.Баасанжав) 34
- АЙМАГ (А.Цанжид) 34
- АЙМГИЙН ЗАХИРГААНЫ ДҮРЭМ
(А.Цанжид) 34
- АЛБАДЛАГА (Я.Төгөлдөр) 35
- АЛБАН БУС МАНЛАЙЛАГЧ (Д.Чимгээ) 35
- АЛБАН ЁСНЫ ХЭЛ (А.Цанжид) 36
- АЛБАН ТАСАЛГАА (А.Энхцэцэг) 36
- АЛБАН ТОМИЛОЛТ (Г.Баасанжав) 37
- АЛБАН ТУШААЛЫН БҮРЭН ЭРХ
(М.Амартүвшин) 37
- АЛБАН ТУШААЛЫН СУЛ ОРОН ТОО
(М.Амартүвшин) 37
- АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ
(М.Амартүвшин) 37
- АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИН
(Г.Баасанжав) 38
- АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ (М.Амартүвшин) 38
- АЛБАН ХАРИЛЦАА (А.Энхцэцэг) 38
- АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ (Г.Баасанжав) 39
- АМАР А. (А.Цанжид) 39
- АМЕРИКИЙН /АНУ/ ЗАХИРГААНЫ
УЛАМЖЛАЛ (А.Цанжид) 40
- АМЬДРАЛЫН ЧАНАР (Т.Түмэнцогтоо) 41
- АНАРХИСТ ҮЗЭЛ (Я.Төгөлдөр) 41
- АПАРТЕЙД (Я.Төгөлдөр) 42
- АРАВТЫН ТОГТОЛЦОО (А.Цанжид) 42
- АРВАН БУЯНТ НОМЫН ЦАГААН ТҮҮХ
(А.Цанжид) 42
- АРВАН ТАВНЫ ЦАГДАА (А.Цанжид) 43
- АРГА БИЛГИЙН ЁС (А.Цанжид) 43
- АРД ТҮМНИЙ ЗАСАГЛАЛ
(Т.Түмэнцогтоо) 44
- АРД/ОЛОН ТҮМНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ
(Т.Түмэнцогтоо) 44
- АРД ТҮМНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ БҮТЭЭХ
(Т.Түмэнцогтоо) 45
- АРД ТҮМЭН / ТӨР (Т.Түмэнцогтоо) 46
- АРДЧИЛАЛ (Ж.Жаргал) 46
- АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛ (Ж.Жаргал) 47
- АРДЧИЛСАН ТӨВЛӨН УДИРДАХ ЁС
(А.Цанжид) 48
- АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРАЛ
(А.Цанжид) 48
- АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА (А.Цанжид) 48
- АРДЫН ТҮР ЗАСГИЙН ГАЗАР
(А.Цанжид) 49
- АРДЫН ХЯНАН ШАЛГАХ БАЙГУУЛЛАГА
(А.Цанжид) 49
- АРДЫН ЭРХТЭЙ ХЭМЖЭЭТ ЦААЗАТ
МОНГОЛ УЛСЫН ХУРАЛ (А.Цанжид) 49
- АРХИВ (Г.Баасанжав) 50
- АУДИТ (А.Энхбат) 50

АУТСОРСИНГ *(М.Амартүвшин)* 50
 АХЛАХ ТҮШМЭЛ *(М.Амартүвшин)* 51
 АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГА
(Б.Баясгалан) 51
 АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ *(Ж.Жаргал)* 51
 АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС АНГИД
 БАЙХ *(Г.Баасанжав)* 51
 АЮУЛГҮЙ БАЙДАЛД УЧРАХ ХАЛДЛАГА
(Д.Зүмбэрэлхам, Ч.Лодойравсал нар) 52

Б

БАГААР АЖИЛЛАХ ЧАДВАР
(Г.Баасанжав) 53
 БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ *(Д.Чимгээ)* 53
 БАЙГУУЛЛАГА БА ХЭРЭГЛЭГЧ
 ХООРОНДЫН ЦАХИМ ХАРИЛЦАА
(Д.Зүмбэрэлхам, Ч.Лодойравсал нар) 54
 БАЙГУУЛЛАГЫН АЛСЫН ХАРАА
(С.Цэдэндамба) 54
 БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН
 ТӨЛӨВЛӨГӨӨ *(М.Амартүвшин)* 54
 БАЙГУУЛЛАГЫН ДОТООД СҮЛЖЭЭ
(Д.Зүмбэрэлхам, Ч.Лодойравсал нар) 55
 БАЙГУУЛЛАГЫН ЗАН ҮЙЛ
(Ц.Дэлгэржаргал) 55
 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГУУД
(С.Цэдэндамба) 56
 БАЙГУУЛЛАГЫН НӨӨЦ ТӨЛӨВЛӨЛТ
(Д.Зүмбэрэлхам, Ч.Лодойравсал нар) 56
 БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОГЧ ТАЛУУД
(Д.Чимгээ) 57
 БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ *(Ц.Дэлгэржаргал)* 57
 БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ
(Ч.Энхбаатар) 57
 БАЙГУУЛЛАГЫН СУРАЛЦАХУЙ
(Д.Чимгээ) 58
 БАЙГУУЛЛАГЫН СЭТГЭЛ ЗҮЙ
(Ц.Дэлгэржаргал) 58
 БАЙГУУЛЛАГЫН ТӨВЛӨРСӨН СИСТЕМ
(Д.Зүмбэрэлхам, Ч.Лодойравсал нар) 59
 БАЙГУУЛЛАГЫН УУР АМЬСГАЛ
(Ц.Дэлгэржаргал) 59
 БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
 ТӨЛӨВЛӨГӨӨ *(С.Цэдэндамба)* 60
 БАЙГУУЛЛАГЫН ҮНЭЛГЭЭ
(А.Энхцэцэг) 60

БАЙГУУЛЛАГЫН ҮНЭТ ЗҮЙЛС
(С.Цэдэндамба) 60
 БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ
(С.Цэдэндамба) 60
 БАЙГУУЛЛАГЫН ЭРХЭМ ЗОРИЛГО
(Д.Чимгээ) 61
 БАРНАРД, ЧЕСТЕР ИРВИНГ *(А.Цанжид)* 61
 БАТ-ОЧИР Ч. *(А.Цанжид)* 62
 БАЯЛГИЙН САН *(А.Энхбат)* 62
 БЕХАВИОРИЗМ *(Ц.Дэлгэржаргал)* 63
 БИЕ ХҮНИЙ ХЭВ МАЯГИЙН ОНОЛ
(Ц.Дэлгэржаргал) 64
 БИОМЕТРИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ
(Д.Зүмбэрэлхам, Ч.Лодойравсал нар) 64
 БИЧЭЭЧ *(А.Цанжид)* 65
 БЛОКЧЭЙН
(Д.Зүмбэрэлхам, Ч.Лодойравсал нар) 65
 БНМАУ-ЫН ЗАХИРГАА *(А.Цанжид)* 65
 БНМАУ-ЫН ТӨРИЙН ДЭЭД ЭРХ БАРИХ
 БАЙГУУЛЛАГА *(А.Цанжид)* 66
 БНМАУ-ЫН ҮНДСЭН ХУУЛИУД
(А.Цанжид) 66
 БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН ЗАХИРГАА
(А.Цанжид) 67
 БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
(М.Амартүвшин) 68
 БОДЛОГО *(Ж.Жаргал)* 68
 БОДЛОГО СУДЛАЛ *(Я.Төгөлдөр)* 68
 БОДЛОГЫН ОРОЛЦОГЧ ТАЛУУД
(Я.Төгөлдөр) 69
 БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ *(Я.Төгөлдөр)* 70
 БОЙКОТ *(Я.Төгөлдөр)* 70
 БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР *(А.Энхбат)* 71
 БОЛОВСОН ХҮЧНИЙГ ШИЛЖ СОНГОХ
(А.Цанжид) 71
 БОЛОМЖИЙН ӨРТӨГ *(Б.Баясгалан)* 72
 БОНД *(А.Энхбат)* 72
 БРИТАНИЙН ЭЗЭНТ ГҮРНИЙ
 ЗАХИРГААНЫ УЛАМЖЛАЛ *(А.Цанжид)* 73
 БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ *(А.Энхбат)* 74
 БҮЛГИЙН СЭТГЭЛГЭЭ *(Ц.Дэлгэржаргал)* 74
 БҮЛГЭРХЭХ ҮЗЭЛ *(Ц.Дэлгэржаргал)* 74

БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦОО
(Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар) 75

БҮРТГЭЛИЙН СИСТЕМ (Ч.Нарантуяа) 75

БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ (Т.Түмэнцогтоо) 76

БҮТЭЭМЖ (Б.Баясгалан) 76

БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ҮҮРГИЙН САН
(Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар) 77

БЮРОКРАТ ТОГТОЛЦОО (Т.Түмэнцогтоо) 77

БЮРОКРАТ ТҮШМЭЛ (Т.Түмэнцогтоо) 77

В

ВАЛЮТЫН ХАНШНЫ ДЭГЛЭМ
(А.Энхбат) 79

ВЕБ 2.0
(Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар) 80

ВЕБ АГУУЛГА
(Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар) 80

ВЕБ АППЛИКЕЙШН
(Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар) 80

ВЕБЕР, МАКС (А.Цанжид) 81

ВЕБ САЙТ
(Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар) 81

ВЕБ САЙТЫН АРХИТЕКТУР
(Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар) 81

ВЕБ СТАНДАРТ
(Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар) 81

ВЕБ ҮЙЛЧИЛГЭЭ
(Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар) 82

ВЕБ ХУУДАС
(Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар) 82

ВЕБ ХУУДАСНЫ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ
(Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар) 82

ВИЛЬСОН, ТОМАС ВУДРО (А.Цанжид) 82

ВИРТУАЛ БАЙГУУЛЛАГА (З.Алтанчимэг) 83

Г

ГАЗАР ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ
(Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар) 84

ГАЗАР ЗҮЙН ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ
(Т.Түмэнцогтоо) 84

ГНЕЙСТ, ХАЙНРИХ РУДОЛФ ФРИДРИХ
ФОН (А.Цанжид) 84

ГОБЕС, ТОМАС (А.Цанжид) 85

ГОМДЛЫН МЕНЕЖМЕНТ
(М.Амартүвшин) 85

ГҮДНОВ, ФРЕНК ЖОНСОН (А.Цанжид) 86

ГҮЙЦЭТГЭЛ (М.Амартүвшин) 86

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ (А.Энхбат) 86

ГҮЙЦЭТГЭЛИЙН ГЭРЭЭ
(М.Амартүвшин) 87

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ
(М.Амартүвшин) 87

ГҮЙЦЭТГЭЛИЙН МЕНЕЖМЕНТ ЗАГВАР
(А.Энхцэцэг) 88

ГҮЙЦЭТГЭЛИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН
ОНОЛ (Ц.Дэлгэржаргал) 88

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
(М.Амартүвшин) 89

ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГА
(Т.Түмэнцогтоо; М.Амартүвшин нар) 89

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ
(М.Амартүвшин; Т.Түмэнцогт;
А.Энхбат нар) 89

ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЭМЖИЛТ
(М.Амартүвшин) 90

ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
(М.Амартүвшин) 90

ГҮЙЦЭТГЭХ (Г.Баасанжав) 91

ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ (Ж.Жаргал) 91

ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛЫН
БАЙГУУЛЛАГУУД (Ж.Жаргал) 91

ГҮЛИК, ЛЮТЕР ХАЛСЕЙ (А.Цанжид) 91

ГЭРЭЭЛЭХ (Т.Түмэнцогтоо) 92

ГЭРЭЭТ АЖИЛТАН (А.Энхцэцэг) 93

Д

ДААТГАЛ (Б.Баясгалан) 94

ДААТГАЛЫН ГЭРЭЭ (Б.Баясгалан) 94

ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
(Б.Баясгалан) 94

ДАВХАР ДААТГАЛ (Б.Баясгалан) 95

ДАН (ТАНИЛТ НЭВТРЭЛТИЙН НЭГДСЭН
СИСТЕМ)
(Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар) 95

ДАХИН ИНЖЕНЕРЧЛЭХҮЙ
(Т.Түмэнцогтоо) 95

ДАХИН ХУВААРИЛАЛТ (Б.Баясгалан) 95

ДАЯАРШИЛ (*Т.Түмэнцогтоо*) 96
 ДАЯАРШЛЫН ЕРТӨНЦ ДЭХ ЗАСАГЛАЛ
 (*Т.Түмэнцогтоо*) 96
 ДИМОК, МАРШАЛЛ ЭДВОРД (*А.Цанжид*) 96
 ДИНАМИК ШИНЖИЛГЭЭ (*Д.Чимгээ*) 97
 ДОТООД АУДИТ (*А.Энхбат*) 97
 ДОТООД ХЯНАЛТ (*М.Амартувшин*) 98
 ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН - ДНБ
 (*А.Энхбат*) 98
 ДУНД ХУГАЦАА (*А.Энхбат*) 98
 ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
 (*М.Амартувшин*) 99
 ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
 МЭДЭГДЭЛ (*А.Энхбат*) 99
 ДҮРМИЙН САН (*А.Энхбат*) 100
 ДҮРЭМ, ЖУРМЫГ ХЯЛБАРШУУЛАХ
 (*Т.Түмэнцогтоо*) 100
 ДҮҮРЭГ (*Ч.Энхбаатар*) 100
 ДЭД БҮТЭЦ (*Ч.Нарантуяа*) 100
 ДЭМЖИГЧ МАНЛАЙЛАЛ
 (*Ц.Дэлгэржаргал*) 101
 ДЭМЧИГДОРЖ Ч. (*А.Цанжид*) 101
 ДЭНДЭВ Л. (*А.Цанжид*) 102
 ДЭС ТҮШМЭЛ (*М.Амартувшин*) 103

Е

ЕВРОПЫН ЗАХИРГААНЫ УЛАМЖЛАЛ
 (*А.Цанжид*) 104
 ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАСАГЛАЛ
 (*Я.Төгөлдөр*) 104

Ё

ЁС ЗҮЙ (*Ц.Дэлгэржаргал*) 105
 ЁС СУРТАХУУН (*Ц.Дэлгэржаргал*) 105

Ж

ЖАНЖИН /аймгийн/ (*А.Цанжид*) 107
 ЖЕНДЭР БА ХҮЙС (*Б.Баясгалан*) 107
 ЖЕНДЭРИЙН АСУУДЛЫГ БОДЛОГОД
 ТУСГАХ НЬ (*Ж.Жаргал*) 107
 ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ
 (*Б.Баясгалан*) 108

ЖЕНДЭРИЙН ХАРИЛЦАА (*Б.Баясгалан*) 108
 ЖЕРРИМАНДЕРИЗМ (*Я.Төгөлдөр*) 108
 ЖИЛИЙН ТӨСВИЙН ДЭЭД ХЯЗГААР
 (*А.Энхбат*) 109

З

ЗАЙН СУРГАЛТ
 (*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 110
 ЗАНГИ (*А.Цанжид*) 110
 ЗАН ҮЙЛ (*Ц.Дэлгэржаргал*) 110
 ЗАН ҮЙЛИЙН ОНОЛ (*Ц.Дэлгэржаргал*) 111
 ЗАРДАЛ - ҮР АШГИЙН ШИНЖИЛГЭЭ
 (*А.Энхбат*) 111
 ЗАРДЛЫГ НӨХӨХ (*Ч.Нарантуяа*) 112
 ЗАРДЛЫН ТӨВ (*Ч.Нарантуяа*) 112
 ЗАРЛАГА (*А.Энхбат*) 112
 ЗАРЛИГААР ТОГТООСОН МОНГОЛ УЛСЫН
 ХУУЛЬ ЗҮЙЛИЙН БИЧИГ (*А.Цанжид*) 112
 ЗАРЦУУЛАЛТЫН ЭРХ (*А.Энхбат*) 113
 ЗАСАГ БА ЗАСАГ БУС ВАН, ГҮНГҮҮДИЙН
 ЭРХ ХЭМЖЭЭНИЙ ДҮРЭМ (*А.Цанжид*) 113
 ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН
 НЭГЖ (*А.Энхцэцэг*) 113
 ЗАСАГЛАЛ (*Г.Баасанжав; Т.Түмэнцогтоо;
 Я.Төгөлдөр нар*) 114
 ЗАСАГЛАЛЫН АРГА ХЭРЭГСЭЛ
 (*Ж.Жаргал*) 114
 ЗАСАГЛАЛЫН ЧАНАР (*Т.Түмэнцогтоо*) 115
 ЗАСГИЙГ ШИНЭЧЛЭН БҮТЭЭХҮЙ
 (*Т.Түмэнцогтоо*) 115
 ЗАСГИЙН ГАЗАР (*Ж.Жаргал*) 116
 ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГА
 ХООРОНДЫН ХАРИЛЦАА (*Ж.Жаргал*) 116
 ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭН ЭРХ
 (*Г.Баасанжав*) 117
 ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (*А.Энхбат*) 118
 ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА
 (*А.Энхбат*) 118
 ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮГИЙН
 НЭГДСЭН ТАЙЛАН (*А.Энхбат*) 118
 ЗАСГИЙН ГАЗРЫН ТАНХИМ (*Ж.Жаргал*) 118
 ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН
 (*А.Энхбат*) 119

- ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС
(А.Энхбат) 120
- ЗАСГИЙН ГАЗРЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ
(Г.Баасанжав) 120
- ЗАСГИЙН ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ
 АЖИЛЛАГАА *(Б.Баясгалан)* 120
- ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭЛБЭРҮҮД
(Ж.Жаргал) 120
- ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
(Ж.Жаргал) 121
- ЗАХ ЗЭЭЛ *(Б.Баясгалан)* 121
- ЗАХ ЗЭЭЛИЙН ЖОЛООДЛОГО
(Т.Түмэнцогтоо) 121
- ЗАХ ЗЭЭЛИЙН ХҮЧ *(Ч.Нарантуяа)* 122
- ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ
(Б.Баясгалан) 122
- ЗАХИРАХ, ЗАХИРАГДАХ ЁСНЫ ТУХАЙ
(А.Цанжид) 123
- ЗАХИРГАА *(Ч.Энхбаатар)* 123
- ЗАХИРГААНЫ АКТЫН БИЧМЭЛ БУС
 ХЭЛБЭР *(Ч.Энхбаатар)* 123
- ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧ
(Ж.Жаргал) 124
- ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА
(Т.Түмэнцогтоо) 124
- ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГААС ИРГЭН,
 ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД УЧРУУЛСАН
 ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ
(Ч.Энхбаатар) 125
- ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫГ
 ТӨЛӨӨЛӨХ *(Ч.Энхбаатар)* 125
- ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ
(Г.Баасанжав) 126
- ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ
 АЖИЛЛАГААНЫ УЯЛДАА
(Г.Баасанжав) 126
- ЗАХИРГААНЫ ДҮРЭМ *(Т.Түмэнцогтоо)* 126
- ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬ
(Ч.Энхбаатар) 127
- ЗАХИРГААНЫ ЁС ЗҮЙ
(Ц.Дэлгэржаргал) 127
- ЗАХИРГААНЫ ЗАН ҮЙЛ
(Ц.Дэлгэржаргал) 127
- ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ *(Б.Баясгалан)* 128
- ЗАХИРГААНЫ ЗӨВЛӨЛ *(А.Энхцэцэг)* 128
- ЗАХИРГААНЫ ОНОЛ *(А.Энхцэцэг)* 128
- ЗАХИРГААНЫ ПРОЦЕСС *(Ч.Энхбаатар)* 129
- ЗАХИРГААНЫ СИСТЕМ *(Г.Баасанжав)* 129
- ЗАХИРГААНЫ СОЁЛ *(Ц.Дэлгэржаргал)* 129
- ЗАХИРГААНЫ СУУРЬ БҮТЭЦ
(А.Энхцэцэг) 130
- ЗАХИРГААНЫ ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ
(Т.Түмэнцогтоо) 130
- ЗАХИРГААНЫ ҮЗЭЛ САНАА
(Ц.Дэлгэржаргал) 131
- ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА
(Ч.Энхбаатар) 131
- ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
 ХЭЛБЭР *(Ч.Энхбаатар)* 131
- ЗАХИРГААНЫ ҮНЭТ ЗҮЙЛ
(Ц.Дэлгэржаргал) 132
- ЗАХИРГААНЫ ҮҮСЭЛ *(А.Цанжид)* 132
- ЗАХИРГААНЫ ФИЛОСОФИ
(Ц.Дэлгэржаргал) 133
- ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ
(Ч.Энхбаатар) 133
- ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР
(М.Амартүвшин) 133
- ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГАРГАЛТ
(М.Амартүвшин) 134
- ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГАРГАХ
 АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОГЧ
(Ч.Энхбаатар) 134
- ЗАХИРГААНЫ ШИНЖЛЭХ УХААН
(А.Энхцэцэг) 135
- ЗАХИРГААНЫ ШИНЖЛЭХ УХААНЫ
 ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ *(А.Цанжид)* 136
- ЗАХИРГААНЫ ШИНЭЧЛЭЛ
(Т.Түмэнцогтоо) 136
- ЗАХИРГААТ ТӨР *(А.Цанжид)* 137
- ЗОРИЛТОГ БҮЛЭГ *(М.Амартүвшин)* 137
- ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ
(Д.Чимгээ) 138
- ЗОХИОН БАЙГУУЛАХ
(Г.Баасанжав; Т.Түмэнцогтоо нар) 138
- ЗОХИЦУУЛАЛТ *(Т.Түмэнцогтоо)* 139
- ЗӨВЛӨЛДӨХ ОРОЛЦОО *(З.Алтанчимэг)* 139
- ЗӨВЛӨЛТИЙН ЗАХИРГАА *(А.Цанжид)* 140
- ЗӨВШИЛЦӨЛ *(Я.Төгөлдөр)* 140

ЗҮТГЭЛГҮЙ ҮЙЛДЭХ ЁСОН (А.Цанжид) 142
 ЗЭМЛЭЛ (Ц.Дэлгэржаргал) 142
 ЗЭРЭГ ДЭВ (А.Энхцэцэг) 142
 ЗЭЭЛ (Б.Баясгалан) 143
 ЗЭЭЛЛЭГ (Б.Баясгалан) 143

И

ИВЭЭХ БОДЛОГО (Ц.Дэлгэржаргал) 144
 ИДЭВХГҮЙ ОРОЛЦОО (З.Алтанчимэг) 144
 И-МАЯГТ (Д.Чимгээ) 144
 ИННОВАЦ (А.Энхцэцэг) 145
 ИНСТИТУЦ/ХҮРЭЭЛЭН (Б.Баясгалан) 145
 ИНСТИТУЦИЙН ЭДИЙН ЗАСАГ
 (Б.Баясгалан) 146

ИРГЭДИЙН ИТГЭЛ (М.Амартүвшин) 146
 ИРГЭДИЙН НИЙГМИЙН ӨМНӨ ХҮЛЭЭХ
 ҮҮРЭГ (Т.Түмэнцогтоо) 147

ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ
 (Ч.Энхбаатар) 147

ИРГЭДИЙН ОРОЛЦОО (Т.Түмэнцогтоо) 147

ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ШИЙДВЭР
 ГАРГАЛТ (М.Амартүвшин) 148

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
 (Ч.Энхбаатар) 148

ИРГЭДИЙН ТӨСӨВ (А.Энхбат) 149

ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭНИЙ КАРТ
 (Д.Чимгээ) 149

ИРГЭД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА
 ХООРОНДЫН ЦАХИМ ХАРИЛЦАА
 (Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 150

ИРГЭНД ЧИГЛЭСЭН ТӨРИЙН
 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗЭЛ САНАА
 (М.Амартүвшин) 150

ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХ
 (П.Амаржаргал) 150

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН УЛСЫН
 НЭГДСЭН СҮЛЖЭЭ
 (Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 151

ИРГЭНИЙ ЖОЛООДЛОГО
 (Т.Түмэнцогтоо) 151

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА
 (Б.Баясгалан) 151

ИРГЭНИЙ НИЙГЭМ (Я.Төгөлдөр) 152

ИРГЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ
 (Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 153

ИРГЭНИЙ ҮҮРЭГ (Ч.Энхбаатар) 153

ИРГЭНИЙ ЭРХЭД ШААРДЛАГАТАЙГААС
 ИЛҮҮ ХАЛДАХГҮЙ БАЙХ (хэр хэмжээнд
 нийцсэн байх) ЗАРЧИМ (Ч.Энхбаатар) 153

ИРЭЭДҮЙН ӨВ САН (А.Энхбат) 153

ИТГЭЛТЭЙ БАЙДАЛ (Т.Түмэнцогтоо) 154

ИТГЭЛЦЛИЙН ОНОЛ (Ц.Дэлгэржаргал) 154

ИТГЭЛЦЭЛ БИЙ БОЛГОХ
 (Т.Түмэнцогтоо) 155

ИХ ЗАСАГ ХУУЛЬ (А.Цанжид) 156

ИХ ӨГӨГДӨЛ
 (Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 156

ИХ ШАВИЙН ЗАХИРГАА (А.Цанжид) 157

К

КАМЕРАЛИЗМ (А.Цанжид) 158

КАРЬЕР/ТЭРГҮҮР (Г.Баасанжав) 158

КАРЬЕР/ТЭРГҮҮР ХӨГЖЛИЙН ЗАРЧИМ
 (Г.Баасанжав) 159

КАУТИЛЬЯ (А.Цанжид) 159

КЛЕВЕЛАНД, ФРЕДЕРИК АЛЬБЕРТ
 (А.Цанжид) 160

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ
 (Т.Түмэнцогтоо) 160

КОНСЕРВАТИЗМ (Я.Төгөлдөр) 161

КОНЦЕСС (А.Энхбат) 161

КРИПТОГРАФ
 (Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 161

КСЕНОФОБИ (Я.Төгөлдөр) 162

КҮНЗ (А.Цанжид) 162

Л

ЛАБАНД, ПАУЛ (А.Цанжид) 163

ЛЕВИТАН, ДЕВИД М. (А.Цанжид) 163

ЛИБЕРАЛИЗМ (Я.Төгөлдөр) 163

ЛИЦЕНЗ (Ч.Энхбаатар) 164

ЛОББИДОХ (ятган ухуулах) (Ж.Жаргал) 165

ЛОКК, ЖОН (А.Цанжид) 165

М

- МАЖОРИТАР ТОГТОЛЦОО (Я.Төгөлдөр) 167
- МАНДАТ/ХУУЛЬ ЁСНЫ ТӨЛӨӨЛӨХ
ЭРХИЙН БАТАЛГАА
(Т.Түмэнцогтоо; Я.Төгөлдөр нар) 167
- МАНЛАЙЛАЛ
(Ц.Дэлгэржаргал; Г.Баасанжав нар) 168
- МАРКС, КАРЛ ХАЙНРИХ (А.Цанжид) 168
- МАСЛОУ, АБРАХАМ (А.Цанжид) 169
- МАТЕРИАЛЛАГ УРАМШУУЛАЛ
(Ц.Дэлгэржаргал) 169
- МЕНЕЖЕР (А.Энхцэцэг) 170
- МЕНЕЖЕРИАЛИЗМ (Т.Түмэнцогтоо) 170
- МЕНЕЖМЕНТИЙН ТҮВШИН
(Г.Баасанжав) 171
- МЕРИТ ЗАРЧИМ (Г.Баасанжав) 171
- МЕРИТ САЙН ҮЙЛС, ҮЙЛЧИЛГЭЭ
(Д.Чимгээ) 171
- МКГРЕГОР, ДУГЛАС (А.Цанжид) 172
- МОДЕРНИЗАЦИ (Я.Төгөлдөр) 172
- МОНГОЛ ЖУРГААН (А.Цанжид) 173
- МОНГОЛ ОЙРАДЫН ИХ ЦААЗ
(А.Цанжид) 173
- МОНГОЛ УЛСЫН ИРГЭН (Ч.Энхбаатар) 173
- МОНГОЛ УЛСЫН ШАСТИР (А.Цанжид) 174
- МОНОПОЛ (А.Энхбат) 174
- МОНТЕСКЬЕ, ШАРЛЬ ЛУЙ (А.Цанжид) 174
- МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Б.Баясгалан) 175
- МӨНГӨНИЙ БОДЛОГО (Б.Баясгалан) 175
- МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ (Б.Баясгалан) 175
- МӨНГӨНИЙ ҮНЭ ЦЭНЭ (Б.Баясгалан) 175
- МӨНГӨН УРСГАЛЫН ТАЙЛАН
(Б.Баясгалан) 176
- МӨРГӨЛДӨӨН СУДЛАЛ (Я.Төгөлдөр) 176
- МЭДЛЭГ, УР ЧАДВАР
(Б.Пүрэвсүрэн; Г.Баасанжав нар) 177
- МЭДЭЭЛЛИЙГ ЗАДРУУЛАХ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 178
- МЭДЭЭЛЛИЙГ ӨМЧЛӨГЧ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 178
- МЭДЭЭЛЛИЙН АЛБАН ЁСНЫ ЭХ
СУРВАЛЖ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 178
- МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 178
- МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
БОДЛОГО
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 179
- МЭДЭЭЛЛИЙН БОЛОВСРОЛ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 179
- МЭДЭЭЛЛИЙН БОЛОН КИБЕР ОРЧНЫ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 179
- МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 179
- МЭДЭЭЛЛИЙН САН
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 180
- МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 180
- МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ДЭД БҮТЭЦ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 180
- МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ЭМЗЭГ
БАЙДАЛ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 180
- МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 181
- МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АСУУДАЛ
ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГА
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 181
- МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ДЭД
БҮТЭЦ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 182
- МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН НЭГ
ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 182
- МЭДЭЭЛЛИЙН ТУНГАЛАГ БАЙДАЛ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 182
- МЭДЭЭЛЛИЙН ХУВИЙН НУУЦЛАЛЫН
АСУУДАЛ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 182
- МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ АЖИЛЛАГАА
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 182
- МЭДЭЭЛЭЛ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 183
- МЭДЭЭЛЭЛ АВАХ ЖУРАМ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 183
- МЭДЭЭЛЭЛ АВАХ ХҮСЭЛТ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 183

МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ
(*Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар*) 184

МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ
(*Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар*) 184

МЭДЭЭЛЭЛ ЗҮЙ
(*Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар*) 184

МЭДЭЭЛЭЛ ХАЙХ ЭРХ
(*Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар*) 185

МЭДЭЭЛЭЛ ХҮСЭГЧИЙН ЭРХ
(*Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар*) 185

МЭРГЭЖЛИЙН БАЙДАЛ
(*Т.Түмэнцогтоо*) 185

МЭРГЭЖЛИЙН ЛОББИ БҮЛЭГ
(*Я.Төгөлдөр*) 186

МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА
(*Г.Баасанжав*) 186

МЭРГЭШСЭН БАЙДАЛ (*Т.Түмэнцогтоо*) 186

МЭРГЭШҮҮЛЭХ СҮРГАЛТ
(*Г.Баасанжав*) 187

Н

НАМ (*Я.Төгөлдөр*) 188

НАМЫН УДИРДЛАГА (*А.Цанжид*) 189

НИЙГМИЙН БАЯЛАГ
(*Б.Баясгалан; Г.Баасанжав нар*) 189

НИЙГМИЙН БАЯЛАГ БА ҮЙЛЧИЛГЭЭ
(*Ч.Нарантуяа*) 190

НИЙГМИЙН БОДЛОГО (*Б.Баясгалан*) 191

НИЙГМИЙН ДААТГАЛ (*Б.Баясгалан*) 191

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН
(*Б.Баясгалан*) 191

НИЙГМИЙН ЗАСАГЛАЛ (*Б.Баясгалан*) 192

НИЙГМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛ
(*Б.Пүрэвсүрэн*) 192

НИЙГМИЙН ИННОВАЦ (*Б.Пүрэвсүрэн*) 193

НИЙГМИЙН КАПИТАЛ (*Б.Пүрэвсүрэн*) 193

НИЙГМИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ
(*Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар*) 195

НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ
(*Б.Пүрэвсүрэн*) 195

НИЙГМИЙН САЙН САЙХНЫ
ЗОРИУЛАЛТТАЙ ЗҮЙЛС
(*Ц.Дэлгэржаргал*) 196

НИЙГМИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ХАНДЛАГА
(*Ц.Дэлгэржаргал*) 196

НИЙГМИЙН СЭТГЭЛ СУДЛАЛ
(*Ц.Дэлгэржаргал*) 197

НИЙГМИЙН ТЭГШ БУС БАЙДАЛ
(*Б.Пүрэвсүрэн*) 197

НИЙГМИЙН УДИРДЛАГА (*Б.Пүрэвсүрэн*) 198

НИЙГМИЙН ХАЛАМЖ (*Б.Баясгалан*) 198

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН
(*Б.Баясгалан*) 199

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
(*Б.Баясгалан*) 199

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА
(*З.Алтанчимээ*) 200

НИЙГМИЙН ШУДАРГА ЁС
(*Б.Пүрэвсүрэн*) 200

НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГА
(*М.Амартүвшин*) 201

НИЙГМИЙН ЭНТРЕПРЕНЕРШИП
(*Б.Пүрэвсүрэн*) 202

НИЙГЭМЛЭГ/ХҮЙ ЭЛГЭН (*Б.Баясгалан*) 202

НИЙТИЙН ДОМАЙН (*Б.Баясгалан*) 203

НИЙТИЙН СОЁЛ (*Б.Пүрэвсүрэн*) 203

НИЙТИЙН СОНИРХОЛ (*Ц.Дэлгэржаргал*) 204

НИЙТИЙН СОНСГОЛ (*Г.Баасанжав*) 204

НИЙТИЙН ҮҮЛЭН ТООЦООЛОЛ
(*Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар*) 204

НИЙЦЛИЙН АУДИТ (*А.Энхбат*) 205

НИЙЦТЭЙ БАЙДАЛ (*Ц.Дэлгэржаргал*) 205

НОГДОЛ АШИГ (*Б.Баясгалан*) 205

НӨӨЦ (*Б.Баясгалан*) 205

НӨХӨН ТӨЛБӨР (*Г.Баасанжав*) 205

НӨХЦӨЛ БАЙДЛЫН ОНОЛ
(*Ц.Дэлгэржаргал*) 206

НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ
(*М.Амартүвшин*) 207

НУТГИЙН ЗАХИРГАА (*Г.Баасанжав*) 207

НУТГИЙН ЗАХИРГААНЫ ДҮРЭМ
(*А.Цанжид*) 208

НУТГИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГЫН
БАЙГУУЛЛАГА (*Г.Баасанжав*) 208

НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁС
(*Ч.Энхбаатар*) 208

НУТГИЙН УДИРДЛАГА (*Г.Баасанжав*) 208

НЭГДСЭН СТРАТЕГИ (*Д.Чимгээ*) 209

- НЭГДСЭН ТӨСӨВ *(А.Энхбат)* 210
- НЭГДСЭН УДИРДЛАГААР ХАНГАХ *(Г.Баасанжав)* 210
- НЭГ ИРГЭН - НЭГ БҮРТГЭЛ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР *(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар)* 210
- НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ *(М.Амартүвшин)* 210
- НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ *(Т.Түмэнцогтоо)* 211
- НЭЭЛТТЭЙ ЗАСАГ *(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал; Т.Түмэнцогтоо нар)* 211
- НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ *(Б.Баясгалан)* 212
- НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ПОРТАЛ *(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар)* 212
- НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ЭКОСИСТЕМ *(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар)* 212
- НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ *(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар)* 213
- НЭЭЛТТЭЙ СИСТЕМ *(Д.Чимгээ)* 213
- НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ *(М.Амартүвшин)* 213
- НЭЭЛТТЭЙ СТАНДАРТ *(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар)* 213
- НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР *(А.Энхбат)* 214
- НЭЭЛТТЭЙ ФОРМАТ *(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар)* 214
- НЭЭЛТТЭЙ ХЭРЭГЛЭГЧИЙН НЭР *(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар)* 214
- НЭЭЛТТЭЙ ЭХ БҮХИЙ ПРОГРАММ *(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар)* 214
- НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ *(Б.Баясгалан)* 215
- НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО *(Б.Баясгалан)* 215
- НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СТАНДАРТ *(Б.Баясгалан)* 216
- НЯГТРАЛЫГ СИЙРЭГЖҮҮЛЭХ *(Т.Түмэнцогтоо)* 216
- О**
- ОВСГООТ ЧАНАР *(Ц.Дэлгэржаргал)* 217
- ОЛИГАРХИ *(Я.Төгөлдөр)* 217
- ОЛОН НИЙТИЙН БАЙГУУЛЛАГА *(А.Цанжид)* 218
- ОЛОН НИЙТИЙН САНАА БОДОЛ *(Ц.Дэлгэржаргал)* 218
- ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ *(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар)* 220
- ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТ *(Г.Баасанжав)* 220
- ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА *(Г.Баасанжав)* 220
- ОЛОН ТҮМНИЙ ТӨЛӨӨХ СОНГОЛТЫН ОНОЛ *(Т.Түмэнцогтоо)* 221
- ОЛОН УЛСЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА *(Б.Пүрэвсүрэн)* 221
- ОЛОН УРГАЛЧ ҮЗЭЛ *(Я.Төгөлдөр)* 222
- ОМБУДСМЭН *(Ж.Жаргал)* 222
- ОНЦ БАЙДАЛ *(Ч.Энхбаатар)* 223
- ОРЛОГО *(Б.Баясгалан)* 224
- ОРЛОГО, ҮР ДУНГИЙН ТАЙЛАН *(Б.Баясгалан)* 224
- ОРЛОГЫН ТАТВАР *(Б.Баясгалан)* 224
- ОРЛОГЫН ҮР НӨЛӨӨ *(Б.Баясгалан)* 225
- ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ *(Б.Баясгалан)* 225
- ОРОЛЦОГЧ ТАЛУУД *(Т.Түмэнцогтоо)* 225
- ОРОЛЦОО *(Б.Баясгалан)* 225
- ОРОЛЦООГ ОГООРОХ ҮЗЭЛ *(Я.Төгөлдөр)* 226
- ОРОЛЦООТ ЗАСАГЛАЛ *(Б.Баясгалан)* 226
- ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР *(Г.Баасанжав)* 226
- ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН *(А.Энхбат)* 226
- ОРЦ *(Б.Баясгалан)* 227
- ОТОГ *(А.Цанжид)* 227
- ОЮУН ТҮЛХҮҮР *(А.Цанжид)* 227
- ОЮУН УХААН *(Ц.Дэлгэржаргал)* 227
- ОЮУНЫ УРСГАЛ *(Б.Пүрэвсүрэн)* 228
- Ө**
- ӨГЛӨГ, ӨР ТӨЛБӨР *(Б.Баясгалан)* 229
- ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЭЦ *(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар)* 229
- ӨГӨГДЛИЙН САН *(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар)* 229
- ӨГӨГДЛИЙН УДИРДЛАГА *(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар)* 229

- ӨГӨГДЛИЙН ЧАНАР**
(*Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар*) 230
- ӨГӨГДЛИЙН ШИНЖИЛГЭЭ**
(*Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар*) 230
- ӨГӨГДӨЛ**
(*Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар*) 230
- ӨГӨГДӨЛД ТУЛГУУРЛАСАН УДИРДЛАГА**
(*Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар*) 230
- ӨГӨГДӨЛД ТУЛГУУРЛАСАН ШИЙДВЭР**
(*Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар*) 230
- ӨМНӨХ ҮЕ** (*А.Энхцэгэ*) 231
- ӨМЧ** (*Б.Баясгалан*) 231
- ӨНЧИДИЙН АВЛИГА БУЮУ САН**
(*А.Цанжид*) 231
- ӨӨРТӨӨ ЗАСАХ ЭРХ** (*Ж.Жаргал*) 232
- ӨӨРЧЛӨЛГИЙН УДИРДЛАГА** (*Д.Чимгээ*) 233
- ӨР** (*А.Энхбат*) 233
- ӨРИЙН БАТАЛГАА** (*А.Энхбат*) 234
- ӨРСӨЛДӨӨН** (*Б.Баясгалан*) 234
- ӨРСӨЛДӨӨНИЙ ЗОХИЦУУЛАЛТ**
(*Б.Баясгалан*) 234
- ӨРТГИЙН ТООЦООЛОЛ** (*Б.Баясгалан*) 234
- ӨРТӨГ** (*Б.Баясгалан*) 235
- ӨРТӨӨ** (*А.Цанжид*) 235
- П**
- ПАРАДИГМ**
(*Т.Түмэнцогтоо; Б.Пүрэвсүрэн нар*) 236
- ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛ**
(*Я.Төгөлдөр*) 236
- ПАТРОНАЖ/ИВЭЭЛД АВАХ ҮЗЭЛ**
(*Я.Төгөлдөр*) 237
- ПОПУЛИЗМ** (*Я.Төгөлдөр*) 237
- ПРОКУРОРЫН ХЯНАЛТ** (*Ч.Энхбаатар*) 239
- ПРУССЫН ЗАХИРГАА** (*А.Цанжид*) 239
- С**
- САЙМОН, ХЕРБЕРТ АЛЕКСАНДР**
(*А.Цанжид*) 240
- САЙН ЗАСАГЛАЛ** (*Т.Түмэнцогтоо*) 240
- САЛА ЗАГВАР** (*Ц.Дэлгэржаргал*) 241
- САЛБАР ДУНДЫН ШИНЖИЛГЭЭ**
(*Б.Пүрэвсүрэн*) 242
- САНХҮҮГИЙН БОДЛОГО** (*Ч.Нарантуяа*) 242
- САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ** (*А.Энхбат*) 243
- САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ**
(*Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар*) 243
- САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ЗАРЧИМ**
(*Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар*) 243
- САНХҮҮГИЙН САХИЛГА БАТ**
(*А.Энхцэгэ*) 244
- САНХҮҮГИЙН ТАЙЛАН** (*Б.Баясгалан*) 244
- САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**
(*А.Энхбат*) 244
- САНХҮҮГИЙН ТҮРЭЭС** (*Б.Баясгалан*) 245
- САНХҮҮГИЙН УДИРДЛАГА**
(*Б.Баясгалан*) 245
- САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЛҮҮД**
(*Б.Баясгалан*) 245
- САНХҮҮГИЙН ХЭЛЦЭЛ** (*Б.Баясгалан*) 246
- САНХҮҮГИЙН ХЯНАЛТ**
(*Б.Баясгалан; А.Энхбат нар*) 246
- САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ**
(*Б.Баясгалан*) 246
- САХИЛГА, ХАРИУЦЛАГА** (*А.Энхцэгэ*) 247
- СИСТЕМИЙН АНАЛИЗ** (*Б.Пүрэвсүрэн*) 247
- СИСТЕМИЙН ӨӨРЧЛӨЛТ**
(*З.Алтанчимэгэ*) 248
- СИСТЕМИЙН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА**
(*Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар*) 248
- СИСТЕМИЙН ҮЗҮҮЛЭЛТ** (*Д.Зүмбэрэллхам; Ч.Лодойравсал нар*) 249
- СОЁЛЫН ХЭМ ХЭМЖЭЭ**
(*Т.Түмэнцогтоо*) 249
- СОЛОНГОСЫН ЗАХИРГААНЫ УЛАМЖЛАЛ**
(*А.Цанжид*) 249
- СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО**
(*Я.Төгөлдөр*) 250
- СОНГУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ** (*Ж.Жаргал*) 250
- СОНГУУЛЬ** (*Ж.Жаргал*) 251
- СОНИРХЛЫН БҮЛЭГ** (*Я.Төгөлдөр*) 252
- СОНИРХОЛ** (*Ц.Дэлгэржаргал*) 253
- СОЦИАЛ ДЕМОКРАТ ҮЗЭЛ** (*Я.Төгөлдөр*) 253
- СОЦИАЛИЗМ** (*Ж.Жаргал*) 254
- СОЦИОЛОГИЧ** (*А.Энхцэгэ*) 255

СОШИАЛ ТӨЛБӨР

(Д.Зумбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 256СӨРГӨЛДӨӨН *(Ц.Дэлгэржаргал)* 256СӨРГӨЛДӨӨНИЙ УДИРДЛАГА
(Ц.Дэлгэржаргал) 256СПОЙЛ ТОГТОЛЦОО *(Г.Баасанжав)* 257СТАНДАРТ *(М.Амартувиши)* 258СТРАТЕГИ *(А.Энхцэгэ)* 258СТРАТЕГИЙН АЛСЫН ХАРАА
(Д.Чимгээ) 258СТРАТЕГИЙН ИДЭВХЖҮҮЛЭЛТ
(З.Алтанчимэг) 259СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
(М.Амартувиши) 259СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨЛТ
(Т.Түмэнцогтоо) 260СТРАТЕГИЙН ТҮНШЛЭГЧ
(Г.Баасанжав) 260СТРАТЕГИЙН УДИРДЛАГА
(Т.Түмэнцогтоо) 261СТРАТЕГИЙН ҮНЭЛГЭЭ *(З.Алтанчимэг)* 261СТРАТЕГИЙН ХОЛБОО *(З.Алтанчимэг)* 262СТРЕСС *(Ц.Дэлгэржаргал)* 262СУМ *(А.Цанжид)* 263СУРАЛЦАГЧ БАЙГУУЛЛАГА
(Г.Баасанжав) 264СУРГУУЛЬ (ТҮШМЭДИЙН) *(А.Цанжид)* 264СУРТАЛ УХУУЛГА *(Ц.Дэлгэржаргал)* 265СУУРЬ ЗОХИЦУУЛАЛТ БА ХЭМ ХЭМЖЭЭ
(А.Энхцэгэ) 265СУУРЬ ТҮВШИНД ҮНДЭСЛЭСЭН ТӨСӨВ
(А.Энхбат) 266СҮҮДРИЙН ЭДИЙН ЗАСАГ *(А.Энхбат)* 266СЭДЭЛ - ЭРҮҮЛ АХУЙН ХУЧИН ЗҮЙЛИЙН
ОНОЛ *(Ц.Дэлгэржаргал)* 267СЭДЭЛЖҮҮЛЭЛТ *(Ц.Дэлгэржаргал)* 268СЭТГЭЛ САНААНЫ ДЭМЖЛЭГ
(Ц.Дэлгэржаргал) 268СЭТГЭЛ СУДЛАЛ *(Ц.Дэлгэржаргал)* 268СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЗАГВАР
(Ц.Дэлгэржаргал) 269СЭТГЭЛ ХӨДЛӨЛ *(Ц.Дэлгэржаргал)* 269СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН ИНДЕКС
(Ц.Дэлгэржаргал) 270

Т

ТАЙЛАГНАХ *(Т.Түмэнцогтоо)* 271ТАМГА *(А.Цанжид)* 271ТАМГЫН ГАЗАР *(А.Цанжид)* 272ТАРИФЫН БОДЛОГО *(Б.Баясгалан)* 272ТАРХИНЫ ДАЙРАЛТ *(Д.Чимгээ)* 273ТАСРАЛТГҮЙ САЙЖРУУЛАЛТ
(Г.Баасанжав) 273ТАТААС *(Б.Баясгалан)* 274ТАТВАР *(А.Энхбат)* 274ТАТВАРЫН АЧААЛАЛ *(А.Энхбат)* 275ТАТВАРЫН БОДЛОГО *(А.Энхбат)* 275ТАТВАРЫН ОРЛОГО/ЗАРЛАГА
(А.Энхбат) 275ТАТВАРЫН ЦАХИМ ТАЙЛАНГИЙН
СИСТЕМ
(Д.Зумбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 275ТЕМПЕРАМЕНТ *(Ц.Дэлгэржаргал)* 275ТЕНДЕР *(А.Энхбат)* 277ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ
(А.Энхбат) 277ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА
(З.Алтанчимэг) 277ТИНК ТАНК *(Ж.Жаргал)* 277ТОГЛООМЫН ОНОЛ *(Б.Баясгалан)* 278ТОГТВОРТОЙ БАЙДАЛ *(Б.Баясгалан)* 278ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ *(Б.Пүрэвсүрэн)* 279ТОГТОЛЦООНЫ ЗАГВАРЧЛАЛ
(Д.Зумбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 280ТОДОРХОЙ БУС БАЙДАЛ *(Г.Баасанжав)* 280ТОКВИЛЬ, АЛЕКСИС ДЕ *(А.Цанжид)* 280ТОЛИЛУУЛГА-ТОДРУУЛГА *(санхуугийн
тайлангийн)* *(Б.Баясгалан)* 281ТООН ГАРЫН ҮСЭГ
(Д.Зумбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 281ТООН ТЕХНОЛОГИЙН БОЛОВСРОЛ
(Д.Зумбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 282ТОТАЛИТАРИЗМ *(Я.Төгөлдөр)* 282ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ *(Ж.Жаргал)* 282ТОХИРУУЛГА *(Т.Түмэнцогтоо)* 283ТӨВ ЗАСГИЙН ГАЗАР *(Ж.Жаргал)* 283

- ТӨВИЙГ САХИХ *(Ж.Жаргал)* 284
- ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ
(Г.Баасанжав; Т.Түмэнцогтоо нар) 284
- ТӨВЛӨРӨЛ *(Т.Түмэнцогтоо)* 285
- ТӨЛБӨР *(Б.Баясгалан)* 285
- ТӨЛБӨРИЙН ЧАДВАР *(Б.Баясгалан)* 286
- ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ЭРСДЭЛ
(Б.Баясгалан) 286
- ТӨЛӨВЛӨГӨӨ *(М.Амартүвшин)* 286
- ТӨЛӨВЛӨЛТ
(М.Амартүвшин; Т.Түмэнцогтоо нар) 286
- ТӨРД БУЮУ УЛСАД УЧРУУЛСАН
ХОХИРОЛ *(Г.Баасанжав)* 287
- ТӨРИЙН АЛБА
(Ч.Энхбаатар; Г.Баасанжав нар) 287
- ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ
(Ч.Энхбаатар; Г.Баасанжав нар) 288
- ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛ
(М.Амартүвшин) 289
- ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН
МЭРГЭЖЛИЙН ШААРДЛАГА
(М.Амартүвшин) 289
- ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН ТӨРӨЛ
(Ч.Энхбаатар) 289
- ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН
ШААРДЛАГА *(Г.Баасанжав)* 290
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧ
(М.Амартүвшин) 290
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЗАН ҮЙЛ
(Ц.Дэлгэржаргал) 290
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЛБАН
ҮҮРЭГ *(М.Амартүвшин)* 290
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙ
(Ц.Дэлгэржаргал; М.Амартүвшин нар) 291
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН
ДҮРЭМ *(Ц.Дэлгэржаргал)* 292
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН
ХЭМ ХЭМЖЭЭ *(Ч.Энхбаатар)* 293
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН МЭРГЭШИЛ
(М.Амартүвшин) 294
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ
БАТАЛГАА *(Ч.Энхбаатар)* 294
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН УЛСЫН
НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 295
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН УЛСЫН
НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛ ХӨТЛӨХ,
МЭДЭЭЛЭЛ АВАХ ЖУРАМ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 295
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН УЛСЫН
НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛИЙН
МЭДЭЭЛЛИЙН САН
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 295
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН
ХАРИУЦЛАГА *(Г.Баасанжав)* 295
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ХУВИЙН
ХЭРЭГ *(М.Амартүвшин)* 296
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЦАЛИН
ХӨЛС *(Г.Баасанжав)* 296
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ
(М.Амартүвшин) 297
- ТӨРИЙН АЛБАНЫ АНГИЛАЛ
(Г.Баасанжав) 297
- ТӨРИЙН АЛБАНЫ ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ
(Г.Баасанжав) 297
- ТӨРИЙН АЛБАНЫ ЗАРЧИМ
(Ч.Энхбаатар) 297
- ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ
(Ч.Энхбаатар) 298
- ТӨРИЙН АЛБАНЫ ИЛ ТОД БАЙДАЛ
(Г.Баасанжав) 299
- ТӨРИЙН АЛБАНЫ МАНЛАЙЛАЛ
(Г.Баасанжав) 299
- ТӨРИЙН АЛБАНЫ СТАНДАРТ
(Ч.Энхбаатар) 300
- ТӨРИЙН АЛБАНЫ СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГА *(Г.Баасанжав)* 300
- ТӨРИЙН АЛБАНЫ СЭДЭЛЖҮҮЛЭЛТ
(Ц.Дэлгэржаргал) 300
- ТӨРИЙН АЛБАНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГА
(Г.Баасанжав) 301
- ТӨРИЙН АЛБАНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН
САНАЛ *(Г.Баасанжав)* 301
- ТӨРИЙН АЛБАНЫ ТУСГАЙ ШАЛГАЛТ
(Г.Баасанжав) 302
- ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦ
(Г.Баасанжав) 302
- ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН
АУДИТ *(Г.Баасанжав)* 302
- ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН
БОДЛОГО *(Г.Баасанжав)* 303
- ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН
БҮРДҮҮЛЭЛТ *(Г.Баасанжав)* 303

ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН
МЭДЭЭЛЛИЙН САН
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 303

ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ
(*Г.Баасанжав*) 303

ТӨРИЙН АЛБАНЫ ШАЛГАЛТ
(*Г.Баасанжав*) 304

ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭЧЛЭЛ
(*Т.Түмэнцогтоо*) 304

ТӨРИЙН АЛБА ХААХ НАСНЫ ДЭЭД
ХЯЗГААР (*Г.Баасанжав*) 305

ТӨРИЙН АППАРАТ (*Ч.Энхбаатар*) 306

ТӨРИЙН АУДИТ (*Б.Баясгалан*) 306

ТӨРИЙН АУДИТОР (*Г.Баасанжав*) 307

ТӨРИЙН БАЙГУУЛАМЖ
(*Ч.Энхбаатар; Я.Төгөлдөр нар*) 307

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА
(*Ч.Энхбаатар; Г.Баасанжав нар*) 308

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД ХООРОНДЫН
ЦАХИМ ХАРИЛЦАА
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 308

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БЭЛЭГ ТЭМДЭГ
(*Г.Баасанжав*) 308

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ
СОЛИЛЦОО
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 309

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ
МЭДЭЭЛЭЛ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 309

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ
ҮЙЛЧИЛГЭЭНД ХОЛБОГДСОН БАЙДАЛ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 309

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ
(*Г.Баасанжав*) 309

ТӨРИЙН БОДЛОГО (*Я.Төгөлдөр*) 310

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧ
(*Г.Баасанжав*) 312

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА
(*Ч.Энхбаатар*) 312

ТӨРИЙН БУЮУ ОЛОН ТҮМНИЙ ӨМЧИТ
КОРПОРАЦ (*З.Алтанчимэг*) 313

ТӨРИЙН БУЮУ УЛСЫН ӨМЧ
(*Ч.Энхбаатар, Б.Баясгалан нар*) 313

ТӨРИЙН БУЮУ УЛСЫН ӨМЧИЙН ЭД
ХӨРӨНГӨ (*Г.Баасанжав*) 314

ТӨРИЙН БУЮУ УЛСЫН ӨМЧИТ ХУУЛИЙН
ЭГТЭЭД (*Г.Баасанжав*) 314

ТӨРИЙН БҮТЭЭМЖ (*Б.Баясгалан*) 314

ТӨРИЙН ГАДААД БОДЛОГО
(*Я.Төгөлдөр*) 315

ТӨРИЙН ЁСЛОЛ (*А.Цанжид*) 315

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБА
(*Г.Баасанжав*) 316

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛД
ТАВИХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА
(*Ч.Энхбаатар*) 316

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ
АЛБАН ТУШААЛААС НЬ ТҮР ЧӨЛӨӨЛӨХ,
ЧӨЛӨӨЛӨХ (*Ч.Энхбаатар*) 317

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ
АЛБАН ТУШААЛААС НЬ ХАЛАХ
(*Ч.Энхбаатар*) 317

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ
ЗАХИРГААНЫ САНААЧИЛГААР АЛБАН
ТУШААЛ БУУРУУЛАХ (*Ч.Энхбаатар*) 318

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ
ӨӨР АЛБАН ТУШААЛД ШИЛЖҮҮЛЭХ
(*Ч.Энхбаатар*) 318

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ
СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ (*Ч.Энхбаатар*) 318

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭГТЭХ
ҮНДЭСЛЭЛ (*Ч.Энхбаатар*) 318

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН
ГҮЙЦЭГТЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
(*М.Амартүвшин*) 319

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН
НИЙТЛЭГ ҮҮРЭГ (*Ч.Энхбаатар*) 319

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН
НИЙТЛЭГ ЭРХ (*Ч.Энхбаатар*) 320

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН
НЭМЭГДЭЛ БАТАЛГАА (*Ч.Энхбаатар*) 321

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН
СУРГАЛТ (*М.Амартүвшин*) 322

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН
ТАНГАРАГ (*М.Амартүвшин*) 322

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН
ШАЛГАЛТ (*Г.Баасанжав*) 322

ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ БУСАД
БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭГТҮҮЛЭХ
(*Ч.Энхбаатар*) 323

ТӨРИЙН ЗАХИРГАА (*Т.Түмэнцогтоо*) 323

- ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБА
(Г.Баасанжав) 324
- ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛ
(М.Амартүвшин) 324
- ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН
ТУШААЛД ТАВИХ ТУСГАЙ ШААРДЛАГА
(Ч.Энхбаатар) 324
- ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН
ТУШААЛЫН АНГИЛАЛ, ТЭДГЭЭРИЙН
ЗЭРЭГ ДЭВ
(М.Амартүвшин; Ч.Энхбаатар нар) 325
- ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ГҮЙЦЭТГЭХ
АЛБАН ТУШААЛ (М.Амартүвшин) 326
- ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТУСЛАХ АЛБАН
ТУШААЛ (М.Амартүвшин) 326
- ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДАХ АЛБАН
ТУШААЛ (М.Амартүвшин) 326
- ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ШИНЭТГЭЛ
(З.Алтанчимэг) 326
- ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР
(А.Энхцэцэг) 327
- ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН САН
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 327
- ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ “ХУР”
СИСТЕМ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 327
- ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
(Ч.Энхбаатар) 328
- ТӨРИЙН НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ӨМЧ
(Г.Баасанжав) 328
- ТӨРИЙН НЭЭЛТГЭЙ ӨГӨГДӨЛ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 328
- ТӨРИЙН ОРОЛЦОО (Г.Баасанжав) 329
- ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТ (Г.Баасанжав) 329
- ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА
(Г.Баасанжав) 329
- ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖ
(Б.Баясгалан) 329
- ТӨРИЙН САН (А.Энхбат) 330
- ТӨРИЙН САНГИЙН НЭГДСЭН ДАНС
(А.Энхбат) 330
- ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
(А.Энхбат) 330
- ТӨРИЙН САНХҮҮ (А.Энхбат) 330
- ТӨРИЙН САНХҮҮГИЙН УДИРДЛАГА
(Ч.Нарантуяа) 330
- ТӨРИЙН ТУСГАЙ АЛБА (Г.Баасанжав) 331
- ТӨРИЙН УДИРДЛАГА (Т.Түмэнцогтоо) 331
- ТӨРИЙН УЛАМЖЛАЛТ АЛБАН БИЧИГ
(А.Цанжид) 332
- ТӨРИЙН УЛС ТӨРИЙН АЛБА
(Г.Баасанжав) 332
- ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ТЕХНОЛОГИЙН ШИЙДЛЭЭР
ОНОВЧЛОХУЙ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 333
- ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН
ЗАРЧИМ (Ч.Энхбаатар) 333
- ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (Ч.Энхбаатар) 333
- ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ГЭРЭЭГЭЭР
ГҮЙЦЭТГҮҮЛЭХ (М.Амартүвшин) 333
- ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭХ АРГА
(М.Амартүвшин) 334
- ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА
(Г.Баасанжав) 334
- ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА
(Г.Баасанжав) 334
- ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОПЕРАТОРЫН
БОЛОН НЭГДСЭН ПОРТАЛ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 335
- ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ
(М.Амартүвшин) 335
- ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМЖИЛТ
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 335
- ТӨРИЙН ХАР ХҮН (А.Цанжид) 336
- ТӨРИЙН ХЭЛБЭР (Ч.Энхбаатар) 336
- ТӨРИЙН ХЯНАЛТ (С.Цэдэндамба) 336
- ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНД
БЭЛЭН ИРГЭН
(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 336
- ТӨРИЙН ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ АЖИЛ
ҮЙЛЧИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭГЧ (А.Энхбат) 337
- ТӨРИЙН ЭРХ МЭДЭЛ ХУВААРИЛАХ
ЗАРЧИМ (Ч.Энхбаатар) 337
- ТӨРТ ЁС (А.Цанжид) 337
- ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ
(Б.Баясгалан; Т.Түмэнцогтоо нар) 337
- ТӨСВИЙН АШИГ/АЛДАГДАЛ
(А.Энхбат) 338
- ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА (А.Энхбат) 339
- ТӨСВИЙН БОДЛОГО (А.Энхбат) 339
- ТӨСВИЙН ЕРӨНХИЙ ДАНС (А.Энхбат) 340

- ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
(*А.Энхбат*) 340
- ТӨСВИЙН ЖИЛ (*А.Энхбат*) 340
- ТӨСВИЙН ЗАРЧИМ (*А.Энхбат*) 340
- ТӨСВИЙН ЗАХИРАГЧ (*С.Цэдэндамба*) 341
- ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ (*А.Энхбат*) 341
- ТӨСВИЙН ОРЛОГО/ЗАРЛАГА
(*А.Энхбат*) 341
- ТӨСВИЙН СУДАЛГАА (*А.Энхцэгэ*) 341
- ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО/ЗАРЛАГА
(*А.Энхбат*) 342
- ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН
(*А.Энхбат*) 342
- ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ
(*А.Энхбат*) 342
- ТӨСВИЙН ТОДОТГОЛ (*А.Энхбат*) 342
- ТӨСВИЙН ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ
(*Т.Түмэнцогтоо*) 342
- ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
(*А.Энхбат*) 343
- ТӨСВИЙН ТӨСӨЛ (*А.Энхбат*) 343
- ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГА
(*А.Энхбат*) 343
- ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО/
ТЭНЦЭЛ (*А.Энхбат*) 343
- ТӨСВИЙН УДИРДЛАГЫН ШИНЭЧЛЭЛ
(*А.Энхцэгэ*) 343
- ТӨСВИЙН УРСГАЛ ТЭНЦЭЛ (*А.Энхбат*) 344
- ТӨСВИЙН ХӨРӨНГӨ (*А.Энхцэгэ*) 344
- ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
(*А.Энхбат*) 345
- ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛ (*Т.Түмэнцогтоо*) 345
- ТӨСЛИЙН УДИРДЛАГА (*З.Алтанчимэг*) 346
- ТӨСӨВ (*А.Энхбат*) 346
- ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ
(*А.Энхцэгэ*) 346
- ТӨСӨВЛӨЛТ (*Т.Түмэнцогтоо*) 347
- ТӨСӨЛ (*З.Алтанчимэг*) 347
- ТӨХӨӨРӨМЖИЙН ЗОХИЦОЛДОО
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 347
- ТУНГАЛАГ БАЙДАЛ (*Т.Түмэнцогтоо*) 348
- ТУРШИЛТЫН СУДАЛГАА
(*З.Алтанчимэг*) 348
- ТУСГАЙ ГАЗАР [ТӨРИЙН] (*А.Цанжид*) 349
- ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ
(*А.Энхбат*) 349
- ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ (*Ч.Энхбаатар*) 349
- ТУСЛАХ ТЕХНОЛОГИ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 349
- ТУСЛАХ ТҮШМЭЛ (*М.Амартүвшин*) 350
- ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ (*Б.Баясгалан*) 350
- ТҮШМЭЛ (*А.Цанжид*) 350
- ТҮШМЭЛИЙГ ШАЛГАН БАЙЦААХ НЬ
(*А.Цанжид*) 351
- ТЭГ СУУРЬТ ТӨСӨВ (*З.Алтанчимэг*) 351
- ТЭГШ БАЙДАЛ
(*Б.Баясгалан; Г.Баасанжав нар*) 352
- ТЭЙЛОР, ФРИДРИХ УИНСЛОУ
(*А.Цанжид*) 352
- ТЭРГҮҮЛЭН УДИРДАХ
(*Ц.Дэлгэржаргал*) 352
- ТЭРГҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТ (*А.Энхцэгэ*) 353
- ТЭРГҮҮН ТҮШМЭЛ (*М.Амартүвшин*) 354

У

- УАЙТ, ЛЕОНАРД ДЮПИ (*А.Цанжид*) 355
- УАЛДО, КЛИФФОРД ДУАЙТ (*А.Цанжид*) 355
- УДИРДАН ЗОХИОН БАЙГ УУЛАХ
(*Г.Баасанжав*) 356
- УДИРДАН ЧИГЛҮҮЛЭХ (*Т.Түмэнцогтоо*) 356
- УДИРДЛАГА (*А.Энхцэгэ*) 356
- УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 357
- УИЛЛОБИ, УИЛЬЯМ ФРАНКЛИН
(*А.Цанжид*) 357
- УЛАМЖЛАЛТ ЭРХ МЭДЭЛ (*А.Энхцэгэ*) 358
- УЛС (*Я.Төгөлдөр*) 358
- УЛС ТӨР (*Ж.Жаргал*) 360
- УЛС ТӨР ДЭХ ЖЕНДЭР (*Я.Төгөлдөр*) 360
- УЛС ТӨРИЙН АМЛАЛТ (*Ж.Жаргал*) 361
- УЛС ТӨРИЙН БОДЛОГО (*Я.Төгөлдөр*) 361
- УЛС ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ
(*Я.Төгөлдөр*) 362
- УЛС ТӨРИЙН ДЭГЛЭМ (*Я.Төгөлдөр*) 363
- УЛС ТӨРИЙН ЁС ЗҮЙ (*Я.Төгөлдөр*) 364

- УЛС ТӨРИЙН ЛЕГИТИМ БАЙДАЛ
(*Я.Төгөлдөр*) 364
- УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО (*Я.Төгөлдөр*) 365
- УЛС ТӨРИЙН СОЁЛ (*Я.Төгөлдөр*) 365
- УЛС ТӨРИЙН СЭТГЭЛ ЗҮЙ (*Я.Төгөлдөр*) 367
- УЛС ТӨРИЙН ТОГТОЛЦОО (*Я.Төгөлдөр*) 367
- УЛС ТӨРИЙН ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ
(*Т.Түмэнцогтоо*) 368
- УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ СУРТАЛ
(*Я.Төгөлдөр*) 369
- УЛС ТӨРИЙН ХЯМРАЛ (*Я.Төгөлдөр*) 370
- УЛС ТӨРИЙН ЭЛИТ (*Я.Төгөлдөр*) 370
- УЛС ТӨРИЙН ЭРХ ЗҮЙ (*Я.Төгөлдөр*) 371
- УЛС ТӨРЧ (*А.Энхцэцэг*) 371
- УЛСЫН БАГА ХУРАЛ (*А.Цанжид*) 372
- УЛСЫН БАЙЦААГЧ (*Г.Баасанжав*) 372
- УЛСЫН ИХ ХУРАЛ (*Ч.Энхбаатар*) 372
- УЛСЫН САЛБАРЫН ШИНЭ УДИРДЛАГА
(*Т.Түмэнцогтоо*) 373
- УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
(*Г.Баасанжав*) 373
- УРВИК, ЛИНДОЛ ФОУНС (*А.Цанжид*) 374
- УРСГАЛ ОРЛОГО/ЗАРЛАГА
(*Б.Баясгалан*) 374
- УРТ ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
(*М.Амартүвшин*) 374
- УХААЛАГ ЗАСАГ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 375
- УХААЛАГ ЗАСАГ ТӨСӨЛ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 375
- УХААЛАГ УЛААНБААТАР ХӨТӨЛБӨР
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 376
- УЯН ХАТАН ТӨСӨВ (*Ч.Нарантуяа*) 376
- Ү**
- ҮЗЭЛ САНАА (*Ц.Дэлгэржаргал*) 378
- ҮЗЭЛ СУРТАЛ (*Ц.Дэлгэржаргал*) 378
- ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ
(*Д.Чимгээ*) 378
- ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОНОВЧТОЙ ХЭМЖЭЭ
(*Б.Баясгалан*) 379
- ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛ
(*М.Амартүвшин*) 379
- ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР
(*М.Амартүвшин*) 379
- ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ (*М.Амартүвшин*) 380
- ҮЙЛ ЯВЦЫН ОНОЛ (*Ц.Дэлгэржаргал*) 380
- ҮЙЛ ЯВЦЫН УДИРДЛАГА
(*Г.Баасанжав*) 381
- ҮНДСЭН ХӨРӨНГӨ (*Ч.Нарантуяа*) 381
- ҮНДСЭН ХУУЛИЙН ХЯНАЛТ (*Монгол Улсын Үндсэн хуулийн цэц*) (*Ч.Энхбаатар*) 382
- ҮНДЭСНИЙ АДЛИСАЛ
(*Ц.Дэлгэржаргал*) 383
- ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 383
- ҮНДЭСНИЙ УХАМСАР
(*Ц.Дэлгэржаргал*) 384
- ҮНИЙН ХЯНАЛТ (*Б.Баясгалан*) 384
- ҮНЭЛГЭЭ (*М.Амартүвшин*) 385
- ҮНЭНЧ БАЙДАЛ (*Ц.Дэлгэржаргал*) 385
- ҮНЭНЧ ШУДАРГА ЗАН
(*Ц.Дэлгэржаргал*) 385
- ҮНЭТ ЗҮЙЛ (*Ц.Дэлгэржаргал*) 386
- ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ЭРХЭМЛЭХ ҮЗЭЛ
(*Ц.Дэлгэржаргал*) 386
- ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ (*Б.Баясгалан*) 387
- ҮР АШИГ (*Б.Баясгалан*) 387
- ҮР ДҮН (*Б.Баясгалан*) 387
- ҮР ДҮНГИЙН ТЭГШ БУС БАЙДАЛ
(*Б.Пүрэвсүрэн*) 388
- ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
(*М.Амартүвшин*) 388
- ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН (*Т.Түмэнцогтоо*) 388
- ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН ТӨСӨВЛӨЛТ
(*Б.Баясгалан*) 389
- ҮР НӨЛӨӨ (*Б.Баясгалан*) 389
- ҮР ӨГӨӨЖ ХҮРТЭГЧ (*Б.Баясгалан*) 390
- ҮҮЛЭН ТООЦООЛОЛ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 390
- ҮҮЛЭН ТООЦООЛОЛД СУУРИЛСАН БАЙГУУЛЛАГЫН НӨӨЦ УДИРДАХ СИСТЕМ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 390
- ҮҮЛЭН ТООЦООЛОЛД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 391

ҮҮРГИЙН ЗӨРЧИЛДӨӨН

(З.Алтанчимэг) 391

ҮҮРЭГ-ЗОРИЛГЫГ ДАХИН ХЯНАХ

(М.Амартүвшин) 391

ҮҮРЭГ ХҮЛЭЭЛТ (Т.Түмэнцогтоо) 392

ҮҮРЭН ХОЛБООНЫ ДУГААРААР

БАТАЛГААЖУУЛАХ

(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 392

Ф

ФАЁЛ, ХЭНРИ (А.Цанжид) 393

ФЕМИНИЗМ (Я.Төгөлдөр) 393

ФОЛЛЕТ, МЭРИ ПАРКЕР (А.Цанжид) 394

ФРАНЦЫН ЗАХИРГААНЫ УЛАМЖЛАЛ

(А.Цанжид) 394

ФРОЙД, ЗИГМУНД (А.Цанжид) 395

ФУНКЦИОНАЛ ЭРХ МЭДЭЛ (Ж.Жаргал) 395

Х

ХААЛТТАЙ ТОГТОЛЦОО (Ж.Жаргал) 397

ХААЛТТАЙ ФОРМАТ

(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 397

ХАКЕР

(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 397

ХАЛАМЖИЙН УЛС (Ж.Жаргал) 398

ХАЛХ ЖУРАМ (А.Цанжид) 398

ХАМААРАЛ БҮХИЙ ТАЛУУД

(Б.Баясгалан) 399

ХАМЖИХ ЗАСАГЛАЛ (Т.Түмэнцогтоо) 399

ХАМТЫН АЖИЛЛАГАА

(Т.Түмэнцогтоо) 400

ХАМТЫН ХОЛБОО (Я.Төгөлдөр) 400

ХАМТЫН ХҮЧ/СИНИЕРГИ

(З.Алтанчимэг) 401

ХАНДЛАГА (Ц.Дэлгэржаргал) 401

ХАРААТ БАЙДАЛ (Г.Баасанжав) 401

ХАРААТ БУС БАЙДАЛ (Г.Баасанжав) 401

ХАРИЗМ (Ц.Дэлгэржаргал) 402

ХАРИЗМАТИК МАНЛАЙЛАЛ

(Ц.Дэлгэржаргал) 402

ХАРИЗМТ ЭРХ МЭДЭЛ (Ц.Дэлгэржаргал) 403

ХАРИЗМЫН ИНДЕКС (Ц.Дэлгэржаргал) 403

ХАРИЛЦАА (Ц.Дэлгэржаргал) 404

ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ ЧАДВАР

(Т.Түмэнцогтоо) 405

ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

(Г.Баасанжав) 405

ХАРЬЦУУЛСАН ДАВУУ ТАЛ (Д.Чимгээ) 405

ХАРЬЯА ДЭЭД ШАТНЫ АЛБАН

ТУШААЛТАН (Г.Баасанжав) 406

ХИЙМЭЛ ОЮУН УХААН (Б.Пүрэвсүрэн) 406

ХИЛИЙН ЦАХИМ ГАРЦ

(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 407

ХОЁР ХЭМЖЭЭСТ КОДООР ХИЙХ ТӨЛБӨР

(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 407

ХОЁР ХЭМЖЭЭСТ КОДТОЙ ТӨЛБӨРИЙН

БАРИМТ

(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 407

ХОЛИМОГ ЭДИЙН ЗАСАГ

(Ч.Нарантуяа) 408

ХОМС БАЙДАЛ (Б.Баясгалан) 408

ХОРОО (Ч.Энхбаатар) 408

ХОСОЛМОЛ ҮҮЛЭН ТООЦООЛОЛ

(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 409

ХОТ (Ч.Энхбаатар) 409

ХОТ, ХӨДӨӨ (ТОСГОН)-ГИЙН САЙН

ЗАСАГЛАЛ (Ц.Дэлгэржаргал) 409

ХОТЫН ЗАХИРГАА (Ж.Жаргал) 410

ХӨГЖИЛ (Т.Түмэнцогтоо) 410

ХӨДӨЛГӨӨНТ ХОЛБОО

(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 411

ХӨДӨЛГӨӨНТ ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИД

СУУРИЛСАН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

(Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар) 412

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН

(Б.Баясгалан) 412

ХӨРӨНГИЙН ТӨСӨВ (А.Энхбат) 412

ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА (А.Энхбат) 413

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ (А.Энхбат) 413

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (А.Энхбат) 413

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ЦЭВЭР ЗЭЭЛИЙН

ДҮН (А.Энхбат) 413

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ

(Ч.Нарантуяа) 413

ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ХЭРЭГСЭЛ

(А.Энхбат) 414

- ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА
(*А.Энхбат*) 414
- ХӨТӨЛБӨРТ ТӨСӨВ (*А.Энхбат*) 414
- ХУВИЙН АШИГ СОНИРХОЛ (*Ж.Жаргал*) 415
- ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 415
- ХУВИЙН ӨГӨГДӨЛ ХАМГААЛАЛ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 415
- ХУВИЙН ТҮЛХҮҮР
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 415
- ХУВИЙН ҮҮЛЭН ТООЦООЛОЛ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 416
- ХУВИЙН ХЭВШИЛ (*Ч.Нарантуяа*) 416
- ХУВИЙН ХЭВШИЛЙН ТОГТОЛЦОО
(*З.Алтанчимэг*) 416
- ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ
(*Б.Баясгалан*) 417
- ХУВЬ ТЭНЦҮҮЛСЭН БҮЮУ
ПРОПОРЦИОНАЛ ТОГТОЛЦОО
(*Я.Төгөлдөр*) 417
- ХУВЬ ХҮНИЙ ӨГӨГДӨЛ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 418
- ХУВЬЧЛАЛ (*Б.Баясгалан*) 418
- ХУВЬЧЛАЛЫН БОДЛОГО (*Б.Баясгалан*) 419
- ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ЦАХИМ СИСТЕМ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 419
- ХУУЛЬ (*Ч.Энхбаатар*) 419
- ХУУЛЬ БУС ЗАХИРГААНЫ АКТ
(*Ч.Энхбаатар*) 420
- ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЗАРЧИМ
(*Ч.Энхбаатар*) 420
- ХУУЛЬ ЁСНЫ РАЦИОНАЛ ЭРХ МЭДЭЛ
(*Т.Түмэнцогтоо*) 420
- ХУУЛЬ ТОГТООМЖ (*Ч.Энхбаатар*) 421
- ХУУЛЬ ТОГТООМЖИЙН АКТЫН
ЭРЭМБЭЛЭЛ (*Ч.Энхбаатар*) 421
- ХУУЛЬ ТОГТООХ ЭРХ МЭДЭЛ
(*Ч.Энхбаатар*) 422
- ХУУЛЬД ҮНДЭСЛЭХ ЗАРЧИМ
(*Ч.Энхбаатар*) 422
- ХҮЙТЭН ДАЙН (*Я.Төгөлдөр*) 422
- ХҮЛЭЭЛТИЙН ОНОЛ (*Ц.Дэлгэржаргал*) 423
- ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ
(*Т.Түмэнцогтоо*) 423
- ХҮНИЙ НӨӨЦ (*С.Цэдэндамба*) 424
- ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЭХ
(*Т.Түмэнцогтоо*) 424
- ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА
(*Д.Чимгээ*) 425
- ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ
(*Ч.Нарантуяа*) 425
- ХҮНИЙСЭЛ (*Ц.Дэлгэржаргал*) 426
- ХҮНИЙ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ
(*З.Алтанчимэг*) 427
- ХҮНИЙ ХӨГЖИЛ (*М.Амартүвшин*) 427
- ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС
(*М.Амартүвшин*) 428
- ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ (*Ч.Энхбаатар*) 428
- ХҮННҮГИЙН ЭЭЭНГ ГҮРНИЙ ЗАХИРГАА
(*А.Цанжид*) 428
- ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ХАМГААЛАЛ
(*З.Алтанчимэг*) 429
- ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ЭДИЙН ЗАСГИЙН
АСУУДЛУУД (*Ч.Нарантуяа*) 429
- ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТАН
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 429
- ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ
(*Д.Чимгээ*) 430
- ХЭЛЦИЙН ЗАРДАЛ (*Б.Баясгалан*) 430
- ХЭЛЦЭЛ (*Б.Баясгалан*) 430
- ХЭМ ЗОХИЦОЛГҮЙ МЭДЭЭЛЭЛ
(*Б.Баясгалан*) 430
- ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
(*Ж.Жаргал*) 431
- ХЭРЭГЛЭГЧИЙН ЗАН ҮЙЛ (*Б.Баясгалан*) 431
- ХЭРЭГЛЭГЧИЙН СОНГОЛТ
(*Б.Баясгалан*) 432
- ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
(*Д.Чимгээ*) 432
- ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ (*Б.Баясгалан*) 432
- ХЭРЭГЦЭЭ (*Ц.Дэлгэржаргал*) 433
- ХЭРЭГЦЭЭНИЙ ШАТЛАЛЫН ОНОЛ
(*Ц.Дэлгэржаргал*) 433
- ХЯМРАЛЫН УДИРДЛАГА (*Г.Баасанжав*) 434
- ХЯНАЛТ (*М.Амартүвшин*) 434
- ХЯНАЛТ БА ТЭНЦВЭР (*Ж.Жаргал*) 434
- ХЯНАЛТ ШАЛГАЛТ (*М.Амартүвшин*) 435
- ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
(*М.Амартүвшин*) 435

Ц

ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ (*Г.Баасанжав*) 436

ЦАХИМ-АРДЧИЛАЛ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 436

ЦАХИМ АРИЛЖАА
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 436

ЦАХИМ БАРИМТ БИЧИГ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 437

ЦАХИМ БОЛОВСРОЛЦАХИМ СУРГАЛТ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 437

ЦАХИМ БҮРТГЭЛ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 437

ЦАХИМ ДЭЛГҮҮР
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 437

ЦАХИМ ЗАСАГЛАЛ (*Д.Зүмбэрэлхам;
Ч.Лодойравсал; Т.Түмэнцогтоо нар*) 438

ЦАХИМ МОНГОЛ ХӨТӨЛБӨР
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 439

ЦАХИМ СУРГАЛТЫН ПЛАТФОРМ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 439

ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ (*Д.Зүмбэрэлхам;
Ч.Лодойравсал нар*) 439

ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 440

ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 440

ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖТЭЙ
БАЙДЛЫГ ДЭМЖСЭН ТЕХНОЛОГИ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 440

ЦАХИМ ХАЛДЛАГА
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 440

ЦАХИМ ХУВААГДАЛ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 441

ЦАХИМ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 441

ЦАХИМ ХУРАЛ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 442

ЦАХИМ ШИЛЖИЛТ
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 442

ЦАХИМ ШУУДАН
(*Д.Зүмбэрэлхам; Ч.Лодойравсал нар*) 442

ЦЭВЭР ӨРСӨЛДӨӨН (*З.Алтанчимэг*) 442

ЦЭВЭЭН Ж. (*А.Цанжид*) 443

ЦЭРЭНДОРЖ Б. /ХИЧЭЭНГҮЙ САЙД/
(*А.Цанжид*) 444

Ч

ЧАДАВХЫН МЕНЕЖМЕНТ
(*Г.Баасанжав*) 445

ЧАДВАРЖУУЛАХ ЗАМААР
ХҮЧИРХЭГЖҮҮЛЭХ НЬ
(*Т.Түмэнцогтоо*) 445

ЧАНАРЫН ДУГУЙЛАН (*М.Амартүвшин*) 446

ЧАНАРЫН НЭГДСЭН УДИРДЛАГА
(*М.Амартүвшин*) 446

ЧАНАРЫН УДИРДЛАГА (*Д.Чимгээ*) 447

ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ХАНДЛАГА
(*Г.Баасанжав*) 447

ЧАНАРЫН ХЯНАЛТ (*З.Алтанчимэг*) 447

ЧИГ ҮҮРГИЙН ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ
(*Т.Түмэнцогтоо*) 448

ЧИГ ҮҮРЭГ (*Г.Баасанжав*) 448

ЧИМИД, БЯРААГИЙН (*А.Цанжид*) 448

ЧИНГИСИЙН БИЛЭГ (*А.Цанжид*) 449

ЧӨЛӨӨЛӨЛТ (*Б.Баясгалан*) 450

ЧУУЛГАН (*А.Цанжид*) 450

Ш

ШАВЬ (*А.Цанжид*) 451

ШАТАЛСАН БҮТЭЦ (*Т.Түмэнцогтоо*) 451

ШАТЛАЛ (*Ж.Жаргал*) 452

ШИЙДВЭР ГАРГАЛТ (*Я.Төгөлдөр*) 452

ШИЙДВЭРИЙН МОД (*Д.Чимгээ*) 453

ШИЙДВЭРИЙН ОНОЛ (*Д.Чимгээ*) 453

ШИЙТГЭВЭР (*Ч.Энхбаатар*) 454

ШИЛЖИЛТИЙН ЭДИЙН ЗАСАГ
(*Ч.Нарантуяа*) 454

ШИЛЖҮҮЛГИЙН ЗАРДАЛ (*Б.Баясгалан*) 455

ШИЛЖҮҮЛЭГ (*Б.Баясгалан*) 455

ШИЛЭН ДАНС (*А.Энхбат*) 455

ШИНЖЛЭХ УХААН (*Б.Пүрэвсүрэн*) 456

ШИНЖЛЭХ УХААНЫ МЕНЕЖМЕНТ
(*Б.Пүрэвсүрэн*) 457

ШТАЙН, ГЕНРИХ ФРИДРИХ
(*А.Цанжид*) 458

ШУДАРГА БАЙДАЛ (*Ц.Дэлгэржаргал*) 458

ШУДАРГА БАЙДЛЫН ТОГТОЛЦОО
(Ц.Дэлгэржаргал) 459

ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ
(Ч.Энхбаатар) 459

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ
(Ч.Энхбаатар) 460

ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ (Ч.Энхбаатар) 460

Э

ЭДИЙН ЗАСАГЧ (А.Энхцэцэг) 462

ЭДИЙН ЗАСГИЙН ЗАСАГЛАЛ
(Ч.Нарантуяа) 462

ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛ (А.Энхбат) 463

ЭДИЙН ЗАСГИЙН ОРОЛЦООТОЙ ӨСӨЛТ
(А.Энхбат) 464

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ (А.Энхбат) 465

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ (А.Энхбат) 465

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ (Б.Баясгалан) 465

ЭЭРЭГ МАНЛАЙЛАЛ (З.Алтанчимэг) 466

ЭЭРЭГ НӨЛӨӨЛӨЛ БҮХИЙ ЗАХИРГААНЫ
АКТ (Ч.Энхбаатар) 466

ЭЗЭН АГЕНТЫН АСУУДАЛ
(Б.Баясгалан) 466

ЭЛЭГДЭЛ, ЭЛЭГДЛИЙН ЗАРДАЛ
(Б.Баясгалан) 467

ЭНГИЙН ХУВЬЦАА (Б.Баясгалан) 467

ЭППЛЕБИ, ПОЛ (А.Цанжид) 467

ЭРГЭЛТИЙН САН (Б.Баясгалан) 468

ЭРГЭН ТӨЛӨГДӨХ ЗЭЭЛ (Б.Баясгалан) 468

ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛГҮЙ
ОЛГОСОН САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ
(Б.Баясгалан) 468

ЭРДЭС БАЯЛГИЙН БУС ДОТООДЫН НИЙТ
БҮТЭЭГДЭХҮҮН (Б.Баясгалан) 468

ЭРСДЭЛ (Б.Баясгалан) 469

ЭРСДЭЛИЙН ЗАСАГЛАЛ (З.Алтанчимэг) 469

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Г.Баасанжав) 469

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ
(Г.Баасанжав; Б.Баясгалан нар) 470

ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ
(З.Алтанчимэг) 470

ЭРТНИЙ МОНГОЛ УГСААНЫ УЛСУУДЫН
ТӨР, ЗАХИРГАА (А.Цанжид) 471

ЭРТНИЙ ХЯТАДЫН ЗАХИРГАА
(А.Цанжид) 471

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН
(Б.Баясгалан) 472

ЭРХ ЗҮЙТ УЛС (Ч.Энхбаатар) 472

ЭРХ МЭДЛИЙГ БҮРЭН ШИЛЖҮҮЛЭХ
(Т.Түмэнцогтоо) 473

ЭРХ МЭДЛИЙГ ТӨЛӨӨЛҮҮЛЭХ
(Т.Түмэнцогтоо) 473

ЭРХ МЭДЭЛ (Ж.Жаргал) 473

ЭРХ МЭДЭЛ ХУВААРИЛАХ (Ж.Жаргал) 475

ЭРХЭЛСЭН ТҮШМЭЛ (М.Амартүвшин) 475

ЭРЭЛТ (Б.Баясгалан) 476

ЭРЭЛТИЙН УДИРДЛАГА (Б.Баясгалан) 476

ЭС ҮЙЛДЭХҮЙ (Ч.Энхбаатар) 476

ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ (Ц.Дэлгэржаргал) 477

ЭЭЛЖИЙН АМРАЛТ (Г.Баасанжав) 477

Я

ЯАМ (А.Цанжид) 478

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ
(Ц.Дэлгэржаргал) 478

ЯПОНЫ ЗАХИРГААНЫ УЛАМЖЛАЛ
(А.Цанжид) 479

ЯРГ ОНОЛ (Ц.Дэлгэржаргал) 480

НОМ ЗҮЙ 481

МЭНДИЙН ҮГ

Захиргааны шинжлэх ухаан, түүний хөгжлийн талаар өгүүлсэн эл бүтээлд мэндийн үг өргөж буйдаа, түүнчлэн захиргааны шинжлэх ухааны анхны хамтарсан толь бичгийг танилцуулж байгаадаа нэн баяртай байна.

ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сан нь дотоодын болон олон улс дахь төлөөлөгчийн газруудаараа дамжуулан олон арван жил Герман Улсад төдийгүй олон улсад ардчиллыг бэхжүүлэх, хүний эрхийг хангах зэрэг өргөн хүрээний ажлыг түншлэгч байгууллагуудын хамтын ажиллагаанд суурилан иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, иргэний улс төр, нийгэм, соёл, шинжлэх ухааны оролцоог дэмжих чиглэлд төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирлээ.

Түүхийг олон нийтэд таниулах нь КАС-ийн үндсэн зорилтуудын нэг билээ. Захиргааны шинжлэх ухаан нь нийгэм, улс төрийн хөгжлийн тодорхой шатанд улс төр судлал, эрх зүйгээс салбарлан гарч олон шинжлэх ухааны уулзвар дээр интеграл шинжлэх ухаан болж хөгжсөнийг харгалзан зохиогчдын багийн бүрэлдэхүүнд төрийн удирдлага, философи, сэтгэл судлал, түүх, эдийн засаг, улс төр, хууль эрх зүй, менежмент, санхүү зэрэг шинжлэх ухаанаар мэргэшсэн судлаач эрдэмтдийн баг бүрдүүлэн ажиллалаа. Тус бүтээлийн зөвлөхөөр Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академи, Монгол Улсын Их сургуулийн эрдэмтэн, профессорууд ажиллалаа.

Энэхүү үнэ цэнэ бүхий эрдмийн бүтээлд оюун ухаан, эрдэм мэдлэг, үнэт цагаа зориулан хамтран ажилласан хүндэт зөвлөхүүд, хүндэт судлаачиддаа чин сэтгэлээсээ талархал илэрхийлье!

Виктор Франк

*Монгол Улс дахь Конрад-Аденауэр
Сангийн Суурин төлөөлөгч*

ӨМНӨХ ҮГ

Эрхэм уншигч Танаа Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сангийн суурин төлөөлөгчийн газрын санаачилга, санхүүгийн дэмжлэгтэйгээр манайд анхлан гарч буй “Захиргааны шинжлэх ухааны нэр томьёоны тайлбар толь” хэмээх энэхүү хамтын бүтээлийг толилуульж байгаадаа нэн баяртай байна. Энэ “Толь”-д орсон нэр томьёоны сонголт, тэдгээрийг англи хэл дээр буулгасан үгийн оноолт, агуулга, тайлбарыг манай үндэсний судлаачид хүчин чармайлт гарган хийсэн болно. Аливаа анхны юм бүхэн элдэв төрлийн бэрхшээл, сорилттой тулгарч, тэр хэмжээгээрээ алдаа, мадаг гаргах эрсдэлтэй байдаг жамыг энэ “Толь”-ийг бүтээхэд оролцсон хүн бүхэн мэдэрсэн гэдэгт эргэлзэх юун. Гэвч дэлхий дахинд орчин цагийн захиргааны шинжлэх ухаан үүсэж хөгжөөд даруй зуу гаруй жил өнгөрсөн хойно манай улсад дөнгөж суурь нь тавигдаж эхэлсэн энэ салбарынхан гучаад жилийн туршид хуримтлуулсан мэдлэг туршилагаа нэгтгэн Захиргааны шинжлэх ухааны энэхүү анхны толь бичиг гаргах оролдлого хийсэн нь бас ч олзуурхууштай юм.

Захиргааны шинжлэх ухаан нь нийгэм, улс төрийн хөгжлийн тодорхой шатанд Улс төр судлал, Эрх зүйн ухаанаас салбарлан гарч олон шинжлэх ухааны уулзвар дээр интеграл шинжлэх ухаан болж хөгжсөнийг харгалзан зохиогчдын багийн бүрэлдэхүүнд төрийн удирдлага, философи, сэтгэл судлал, түүх, эдийн засаг, улс төр, хууль эрх зүй, менежмент, санхүү зэрэг шинжлэх ухаанаар мэргэшсэн судлаач эрдэмтдийн баг ажиллуулсан юм. Тус бүтээлийн зөвлөхөөр Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академи, Монгол Улсын Их сургуулийн эрдэмтэн судлаачид ажиллалаа. Зөвлөх багийн зүгээс судлаачдын бие даасан, эрх чөлөөт байдлыг эрхэмлэн үзэж тэдний хийсэн нэр томьёоны тайлбар, бичвэрээрээ илэрхийлсэн хэлбэр, байр суурь, сэтгэлгээний онцлог, асуудалд хандсан өнцөг, ялангуяа зарим нэр томьёоны монгол, англи хэлний оноолтод захиргааны шинжлэх ухааны олон талт хандлага, олон ургалч үзлийг хүндэтгэх үүднээс нэг талыг барьж туйлшралгүй хандсаныг зориуд тэмдэглэж байна. Тухайлбал, энэ тольд англи хэлээр “Public” гэх нэг л үгээр илэрхийлж болох тодотголыг монгол хэлний “Төрийн”, “улсын”, “нийтийн” гэхчлэн олон янз байдлаар бичсэн нь бий. Энэ нь “захиргаа” хэмээх ойлголтыг хэрэглэж буй нөхцөл байдал, хам шинж утгаасаа хамаарч харилцан адилгүй ойлгон хэрэглэж ирсэн түүхэн учир шалтгаантай, дэлхийн улс орнуудын тэр дундаа баруун европын түүх, соёл, улс төрийн уламжлал, төрийн байгуулал, дэглэм, өөрчлөлт хөгжил, шинэчлэлийн хүрээнд төрийн оролцоо их эсвэл бага байсан жам ёсны хөгжлийн үр дүнтэй холбогдож буй нь эргэлзээгүй юм. Иймд тухайн ойлголт, түүний үндсэн агуулгыг тодотгосон шинжтэй бусад ойлголтуудыг хам утгаар нь өргөн хүрээнд ойлговол зохилтой юм.

Энэ мэт нь олон талт, интеграл шинжлэх ухаан болох захиргааны шинжлэх ухааны тайлбар толийн нэгдмэл байдалд муугаар нөлөөлөхгүй бөгөөд харин ч нэр томьёог цаашид улам чамбайруулж нэгдсэн нэг үзэлд хөтлөх сэжүүр болно гэдэгт итгэж байна. Захиргааны шинжлэх ухаан манай улсад цаашид эрчимтэй хөгжихөд

бас нэгэн шинэ түлхэц өгөх энэхүү түүхэн ач холбогдолтой анхны толь бичиг олны хүртээл болсноор олон нийт, хувь хүмүүс бүгдээрээ энэ толийн агуулгыг баяжуулан бүтээгч болж бүтээлчээр хамтран ажиллана гэдэгт ч бид итгэж бас найдаж байна. Орчин үеийн мэдээллийн технологийн хөгжил, е-засаглалын үзэл баримтлал үүнд бодит боломж олгоно гэдэг нь эргэлзээгүй ээ. “Захиргааны шинжлэх ухааны нэр томьёоны тайлбар толь”-ийг бүтээхэд үнэт цаг, мэдлэг оюунаа дайчлан хамтран ажилласан зохиогчдын багийн нийт хамт олон, уг бүтээлийг санаачлан олны хүртээл болж хэвлэгдэн гарахад бүх талын туслалцаа үзүүлсэн Конрад-Аденауэр-Сангийн удирдлагын баг, бидэнтэй өдөр тутам нягт хамтран ажилласан менежер С.Ганзаяа нартаа чин сэтгэлийн талархал дэвшүүлж байна. Дэлхий нийтээр ковид цар тахалд өртсөн онцгой хүнд нөхцөлд захиргааны шинжлэх ухаанаар мэргэшсэн эрдэмтэн судлаачид цар тахалд “захирагдалгүй” бүтээсэн энэхүү бүтээлийг уншигч Та хүлээн авна уу. Хүндэт уншигч Та энэхүү бүтээлтэй танилцаж санах, сэрэх санаа өгөх үнэт зөвлөгөө, шүүмжийг бүтээлийг хамтран бичсэн зохиогчдын багийн хамт олон гүнээ талархалтай хүлээн авч цаашдын сайжруулалтдаа анхаарах болно. Уншигч Таны мэлмий хурц, оюун тунгалаг байхын өлзийтэй ерөөлийг дахин дэвшүүлье.

Төслийн зөвлөх, редакторууд:

Профессор Ш.Батсүх

Удирдлагын академийн дэд захирал

Профессор Н.Бурмаа

МУИС-ийн Олон Улсын Харилцаа,

Нийтийн Удирдлагын Сургуулийн

Нийтийн удирдлагын тэнхим

Профессор Я.Долгоржав

Удирдлагын академийн

Төрийн захиргааны тэнхимийн эрхлэгч

**ЗАХИРГААНЫ ШИНЖЛЭХ УХААНЫ
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ**

A

АВЛИГА (*Corruption*) Нийгэм, төр, захиргааны хүрээнд ажил үйлсээ бүтээхийн тулд хувийн шунал хүслээс сэдэлтэй хууль бус арга хэрэглэх, мөн нийтийн ашиг сонирхлыг үл хайхран хувийн ашиг сонирхлыг тэргүүн эгнээнд тавьж гүйцэлдүүлэх, гэсэн утга илэрхийлдэг. Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц (2003)-д авлигын тодорхойлолт оруулаагүй байдаг ч конвенцын оролцогч улс орнуудад хээл хахууль, эд хөрөнгө завших, урвуулан ашиглах, нөлөөлөх санал тавих, албан тушаалаа урвуулан ашиглах, хууль бусаар баяжих зэрэг үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх, хуулийн арга хэмжээ авах тухай заагаад улс орнууд үндэсний хууль тогтоомждоо авлигыг нарийвчлан тодорхойлохыг нээлттэй үлдээсэн юм. Авлигын анхны хэлбэр 1300-аад онд гэмдэглэгдсэн бөгөөд авлигын тодорхойлолтуудыг авч үзвэл, НҮБХХ (1998): улс төрч, төрийн албан хаагч хэн боловч тэдэнд олгосон эрх мэдлийг урвуулан ашиглах замаар өөрснөө болон, тэдний ойр дотны хүмүүст хууль бусаар баяжих боломж олгох, хээл хахууль, нөлөөллөөр наймаалцах, тал засах, хууран мэхлэх, эд хөрөнгө завших, урвуулан ашиглах замаар албан тушаал, эрх мэдлийг хувийн эрх ашигтаа урвуулан ашиглах үйлдэл

гэж өргөн хүрээнд тодорхойлсон байдаг. Монгол хэлний тайлбар толь бичигт: Авлигыг “ёсон бусаар шунаж авсан эд юм” гэж тайлбарлажээ. Монгол Улсын Авлигын эсрэг хуульд “төрийн албан тушаалтан эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх эрх зүйн зөрчлийг хэлнэ” гэсэн байна. Авлигын гэмт хэрэг нь бүх улс оронд тогтмол давтамжтай гардаг социологийн түгээмэл үзэгдэл учир авлига, гэмт хэргийг хянах, устгахад улс орон бүр өөр өөрийн аргаар тэмцдэг байна. Авлигатай тэмцэх байгууллага нь бодлогын шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах, мэдээлэл түгээх, хяналт - шинжилгээ хийх, мөрдөн байцаалт явуулах, хариуцлага тооцох зэрэг авлигатай тэмцэх гол ажлыг удирдан чиглүүлэх чиг үүрэгтэй тусгай, байнгын үйл ажиллагаатай байгууллага юм. (А.Э.ц)

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР (*The Independent Authority Against Corruption (IAAC)*) Монгол Улсад авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг

илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, авлигын эсрэг хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан төрийн тусгай байгууллага юм.¹ Монгол Улсад 2006 онд анх удаагаа Улсын Их Хурлаас Авлигын эсрэг хуулийг баталж, авлигатай тэмцэх байгууллага, түүний бүрэн эрх, зарчим, бүтэц, чиг үүргийг хуулиар тодорхойлжээ. Тухайлбал, Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлээр Авлигатай тэмцэх газрын чиг үүргийг 3 ангилсан. Нэгдүгээрт: Олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, хоёрдугаарт: Хөрөнгө орлогын мэдүүлгийг хянан шалгах, гуравдугаарт: Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллах тухай тус тус заасан. Уг хуулиар авлигын эсрэг төрийн бодлого, шийдвэр түүнчлэн авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах гэх мэт 17 бүрэн эрхийг зааж, нэгдмэл удирдлагатай байх, бие даасан, хууль дээдлэх, хараат бус, ил тод байх, нууцыг чанд сахих тухай 5 зарчмыг тусгасан. Байгууллагын бүтэц, орон тоог Улсын Их Хурлаас батлах бөгөөд урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, судалгаа дүн шинжилгээний, хяналт шалгалтын, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажлын, захиргааны гэсэн үндсэн бүтэцтэй байна. (П.А)

АВТОРИТАРИЗМ (*Authoritarianism*) нь эрх мэдэл нэг хүний гарт эсвэл засаглалын нэг институтэд төвлөрснөөс үүдэлтэй улс төрийн

дэглэмийн хэлбэр юм. Энэ дэглэм нь бусдын, ялангуяа төлөөллийн институтийн үүргийг бууруулж, улс төрийн сөрөг хүчин болон олон нийт, үйлдвэрчний зэрэг бие даасан байгууллага, холбоо, хөдөлгөөний үйл ажиллагаа, оролцоог хамгийн доод түвшинд байлгахыг шаарддаг. Авторитар дэглэм нь төр, нийгмийг холбогч улс төрийн механизм, тогтолцоо ба институцийн зохицуулалтыг алдагдуулж, эцэст нь хүний эрх, эрх чөлөөг хаан боогдуулдаг аюултай. Энэ дэглэм нь хувийн өмч, зах зээлийн харилцааг харьцангуй нээлттэй хүлээн зөвшөөрөх боловч захирах, тушаах, албадах зэрэг арга хэрэгслээр нийгмийн харилцааг хянах, удирдах бүрэн боломжтой дарангуйллын тогтолцоо юм. Иргэдийн улс төрийн эрх нь төрийн бүрэн хяналтад байж, залхаан цэрлүүлэхэд хэзээд бэлэн бодлогыг баримталдаг тул төр болон төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хатуу хяналтын систем үйлчилсэн, ардчилсан бус хаалттай тогтолцоо гэж үздэг. Зарим тохиолдолд иргэдийн өмчлөх болон хараат эвлэлдэн нэгдэх эрхийг хүлээн зөвшөөрдөг үндэслэлээр “хагас ардчилсан буюу саармаг” тогтолцооны дэглэм ч гэж нэрлэдэг. (Я.Т)

АГВААНЧОЙЖИРДОНДОВ ГАВЖ (*Agvaan-choijirdondov*) Дарба бандид Агваан-чойжордондов XV жарны цагаан морин жил аргын тооллын 1870 онд Сайн ноён хан аймгийн Хөндлөн мэргэн засгийн хошуунд, одоогийн Архангай аймгийн Цэцэрлэг суманд Ё.Насангийн гэр бүлд мэндэлжээ. Жинхэнэ нэр нь Дамдинсүрэн. Дөрвөн настайдаа Дарба бандидын хувилгааны 6-р дүрээр тодорч Одоогийн Хөвсгөл аймгийн Рашаант

¹ С.Нарангэрэл: Эрх зүйн эх толь бичиг Dictionary of Law Улаанбаатар 2008, х. 6.

сумын төвд байсан Дашдаржайлин хийдэд заларсан байна. Шашны номд нэвтэрхий суралцсан эрдэмтэн, олон арван шавьд номын авшиг өгсөн багштан байсан ажээ. Дарба бандитан Монголд шинээр тогтсон Ардын намын ёс, ардын засгийн бодлогыг бурхны номтой нийлэлцэх зөв зүйтэй хэмээн үзэж “Ард түмний ариун ёс” хэмээх зохиолоо туурвижээ. Уг зохиолыг эрдэмтэн Л.Хүрэлбаатар номт, хэмжээт эрхт, ардын ардчилсан зэрэг аль ч төрийн бодлого ёсонд түгээмэл тохирох хөтөлбөрийн шинжтэй бүтээл гэжээ. Тухайн үед шинээр үүсэн байгуулагдсан ардын засаг гаднын нөлөөнд орж коммунист маягийн сурталд автаагүй байсан тул Дарба бандид уг зохиолоо ардын засагт зориулан бичсэн нь тодорхой юм. Тийм ч учраас МАН-ын Төв хорооноос дэмжин төвд хэлээр орчуулж лам нарт түгээхийн зэрэгцээ 1923 онд тусгай дэвтэр болгон хэвлэжээ. “Ард түмний ариун ёс” зохиолд: хуучин засгийн бурангуй, муу муухайг шүүмжлэн “цаашид улсын засгийн хөрөнгийг арвитган, эдийн засгийг зузаатган, баян идэрхэг улс болох, хууль ёсыг хэтэрхий сул, хатуу бус сахиулж буй эрх баригчдын зан авир, ёс зүйг ариун байлгах, олны хэргийг гагц биеийн амин завшаалыг бодолгүй, ямагт бусдын тусын төлөө бодох, олныг тэгш асран тэтгэж, чухамхүү хүмүүн болсны тус хэргийг бүтээхийн учир утгыг сэнхрүүлэх, ард олны харанхуйг арилгаж гэгээнийг нээж, чингэхийн учир бичиг үсгийн эрдэмд нэвтрэн сурах явдал эрхэм болох тухай” зэрэг олон сэдвийг хөндсөн байна. (А.Ц)

АГЕНТЫН ОНОЛ (*Agency theory*)

Оновчтой сонголт, ажил үйлчилгээний өртгийн онолын хүрээнд хөгжжээ. 1990-ээд оны эхээр Дитмар Браун

бодлого боловсруулах судалгаанд уг онолыг ашиглаж болохыг санал болгожээ. Онолын үндэс нь төрөл бүрийн гэрээгээр зохицуулагддаг хоёр талын буюу зөвшилцөлд хүрдэг эзэн хэмээх тал, харин нөхөн олговор авах замаар эзний нэрийн өмнөөс асуудлыг шийдвэрлэхийг зөвшөөрдөг агент хоорондын солилцооны үзэл баримтлал болно. Энэ онол нь өөр хоорондоо тодорхой нөөцийг солилцож буй хоёр субъектийн харилцаа. Нэг талаас эзэн буюу итгэмжлэгч нөгөө талаас түүний үүргийг төлөөлөн гүйцэтгэгч агент юм. Энэ онолын үзэл баримтлалын хүрээнд төрийн байгууллагын зарим чиг үүргийг хувийн хэвшлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх үйл ажиллагааг ойлгож болно. (Т.Т)

АГУУЛГЫН ОНОЛ (*Content theory*)

Хувь хүний зан үйлийг чиглүүлэх, сэдэлжүүлэх хэрэгцээнд үндэслэсэн хүний дотоод хүчин зүйл (сэтгэл зүй)-ийг голлон судалдаг онол. Зан үйлийн сэдлийн онолыг агуулгын онол (content theories), үйл явцын онол (process theories), бэхжүүлэх онол (reinforcement theories) гэж ерөнхийд нь ангилдаг². Агуулгын гол онолуудад Маслоугийн “Хэрэгцээний онол”, Герцбергийн “Хоёр хүчин зүйлийн онол буюу Сэдэл-эрүүл ахуйн хүчин зүйлийн онол”, Альдерферийн “ERG” зэрэг онолуудыг нэрлэж болно. Тэдний үзсэнээр тодорхой хэрэгцээгээ хангах хүсэл эрмэлзэл нь хүмүүсийг илүү сайн ажиллахад хүргэдэг. Хөдөлмөрийн үйл ажиллагаанд хүнийг чухам юу өдөөн идэвхжүүлж байгааг ойлгоход агуулгын онолууд ач холбогдолтой. Зөвхөн мөнгө хүнийг хөдөлмөрт идэвхжүүлдэг

2 안희남 (1997), 행정학, 법문사, 서울, p. 477
(An Hui Nam (1997), *Tөрийн захиргаа. Пөбмүн хэвлэлийн газар, Сөүл, х. 477.*)

(шинжлэх ухааны менежмент) хэмээн үзэж байсан ба хожим ажлын нөхцөл, аюулгүй байдал, ардчилсан удирдлага гэх мэт олон хүчин зүйлс (хүмүүсийн харилцааны онол) идэвх зүтгэлд нөлөөлдгийг нээжээ. Үүний дараа хүндлүүлэх, өөрийгөө илэрхийлэх сэдэл хэрэгцээ (А.Маслоу), хариуцлага, хүлээн зөвшөөрөлт, амжилт, албан тушаал ахих (Х.Герцберг), өсөлт хөгжил (Альдерфер) зэрэг нь идэвх зүтгэлтэй ажиллах гол хөшүүрэг хэмээн үзэх болсон³. (Ц,Д)

АЖ АХУЙН ТООЦООТой ҮЙЛДВЭР-ИЙН ГАЗАР (*State owned industrial enterprise*) Аж ахуйн тооцоот үйлдвэр газар нь тухайн байгууллагын талаас илүү хувь нь төрийн шууд болон шууд бус эзэмшилд байдаг боловч өөрөө өөрийгөө санхүүжүүлэх байгууллага байна. Аж ахуйн тооцоот үйлдвэр газар нь бизнесийн үйл ажиллагааны зарчимд тулгуурлах ба өөрт олгогдсон эд хөрөнгөнд үндэслэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар өөрөө өөрийгөө санхүүжүүлэх хуулийн этгээд юм. Төрийн өмчид суурилан үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь бизнесийн зарчимд тулгуурладаг тул тухайн байгууллагын үйл ажиллагаанд төрийн дэмжлэг, татаас, тусгай санхүүжилт олгох зэрэгт дэмжлэг дутмаг байдаг. Гэсэн хэдий ч тухайн байгууллагын эд хөрөнгийг зөвхөн тодорхой үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглахаар хязгаарлагдана. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулсан орлогоос өөрт ногдох хэсгийг захиран зарцуулах байдлаар бие даан үйл ажиллагаа эрхэлнэ. Улсын үйлдвэрийн газар нь мөн төрийн өмчид тулгуурлан үйл ажиллагаа

явуулах ба төрийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээд байна. Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага өмчийн хадгалалт, хамгаалалтыг ханган ажиллаж түүний үр дүнг хариуцна. Мөн аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын удирдлага буюу захирал хууль эрх зүйн хүрээнд менежментийн бодлого, үйл ажиллагааны дагуу тухайн байгууллагын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэн ажиллана. (Г,Б)

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ (*Contract of performing work*) иргэн, хуулийн этгээдийн хооронд харилцан ажил гүйцэтгэх болон бизнесийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх үйл явцад үүссэн эрх зүйн зохицуулалтын нэг чухал хэлбэр бол ажил гүйцэтгэх гэрээ бөгөөд нэг талаас үүргээ биелүүлэх албан ёсны гэрээ нөгөө талаас гэрээлэгч талуудын хариуцан гүйцэтгэх үйл ажиллагаа, авах арга хэмжээг тусгасан зохицуулалт юм. Монгол Улсад Иргэний ба Хөдөлмөрийн хуулиар зохицуулсан нөхцөлийг үндэслэн ажил олгогч ажиллах нөхцөл байдлаа холбогдох харилцааны дагуу харилцан тохиролцон иргэн, байгууллага, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлдэг. Монгол Улсын Иргэний хуулийн 31 дүгээр үлэгт ажил гүйцэтгэх гэрээний талаар дэлгэрэнгүй заасан бөгөөд 343 дугаар зүйлд “Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ”. Захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүрэгтэй. Ажил гүйцэтгэх

³ П.Увш, Б.Хэрлэн 2017, Байгууллагын зан үйл. Улаанбаатар, х. 50.

зарим төрлийн гэрээний онцлог зохицуулалтыг тусгай хуулиар зохицуулж болно. “Захиалагч, гүйцэтгэгч хоёр талын хооронд байгуулсан хугацаатай, төлбөртэй хийх ажлыг харилцан зөвшөөрч гарын үсэг зурсан хуулийн дагуух баримт бичгийг ажил гүйцэтгэх гэрээ гэнэ” гэж заасан. Энэ гэрээ нь олон төрөлтэй боловч ажил гүйцэтгэх гэрээний зорилго, үндсэн ойлголт нь “үр дүн” мөн биет, эсвэл биет бус зүйл байж болохыг тодотгон тайлбарлаад гэрээний онцлог шинж болох ажлын үр дүн буюу гэрээний зүйл нь ирээдүйд гүйцэтгэх үүрэг байж болох тухай онцолсон байдаг. (А.Э.ц)

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ТАНГАРАГ *(Oath of professional office)*

Тухайн албан хаагч албан тушаалынхаа үйл ажиллагаагаа эхлэхийн өмнө өргөдөг тангараг. Тангараг нь төрийн хууль тогтоомж болон байгууллагын дүрмээр тодорхойлогдсон байдаг бөгөөд тэдгээр ажил олгогчоос уг тангаргийг өргөхийг заавал шаардана. Ийм тангаргийг ихэвчлэн ёслол хүндэтгэлийн байдалтай, зарим үед олон нийтийн өмнө хүндэтгэлтэйгээр өргөдөг. Ихэвчлэн “би тангараглаж байна” гэж хэлдэг боловч зарим тохиолдолд “амлаж байна” гэсэн үг хэллэгээр илэрхийлэгддэг. Төрийн болон шашны байгууллагуудад хэрэглэх нь түгээмэл. Монгол Улсын иргэн төрийн захиргааны албанд анх ажилд орохдоо Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар ТЖАХ нь “Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, Монгол Улсын хууль, ёс зүйн язм хэмжээг чанд сахиж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан албан үүргээ үнэнч иударгаар биелүүлэхээ тангараглая. Тангаргаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ”

хэмээн тангараг өргөдөг. (Ц.Д)

АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БОДЛОГО *(Employment policy)*

Тухайн улсын ажил эрхлэлтэд тавигдах зорилго, түүнд хүрэх арга замыг тусгасан үндэсний түвшинд боловсруулдаг төлөвлөгөө. Улс орон бүрийн хувьд ажил эрхлэлтийн бодлого нь тухайн улсын хөгжлийн өнөөгийн болон зорьж буй түвшин, бодит нөхцөл байдалд тулгуурласан, хэрэгжих боломжтой, ажил хэрэгч төлөвлөгөө байх ёстой. Энэ төлөвлөгөө нь тухайн улсын хөгжлийн хэтийн төлөв, учирч болох сорилт болон боломжийн бүрэн тооцоонд суурилна. Мөн холбогдох талууд болох ажил олгогч болон үйлдвэрчний эвлэл зэрэг ажилтнуудын эрх ашгийг хамгаалдаг байгууллагуудын оролцоог хангасан байна. Ажил эрхлэлтийн бодлого нь ажлын байр бий болгох энгийн хөтөлбөр төдий биш бөгөөд эдийн засаг, нийгмийн өргөн хүрээтэй асуудлуудыг хамруулдаг. Хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт ба нийлүүлэлт болон энэ зах зээлийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлдэг бүхий л хүчин зүйлс, эдгээртэй холбоотой институц, байгууллага, хөтөлбөр, арга хэмжээг бүхэлд нь хамарна. Ажил эрхлэлтийн бодлого нь зохистой хөдөлмөрийг (decent work) дэмжихэд чиглэнэ. Энэ нь нэг талаас, хөдөлмөрийн олон улсын стандартыг хангах, нийгмийн хамгаалал болон ажилчдын суурь эрхийг баталгаажуулах, нөгөө талаас ажлын байр бий болгохыг хөхиүлэн дэмжихийг оновчтой хослуулдаг, зохистой бодлого юм. Бодлогыг боловсруулахад дэлхийн болон улс орны хүн ам зүйн чиг хандлага, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, технологи ба инновац, түүнийг дагаад бүтээмжид гарах өөрчлөлтүүд,

шилжих хөдөлгөөн, албан бус сектор, орлогын ялгаварлал, ядуурал, жөндөрийн ялгаа, цаашилбал хүмүүсийн таашаал болон хандлагад гарч буй өөрчлөлтүүд зэрэг олон талт асуудлыг зайлшгүй тусгана. Иймээс ажил эрхлэлтийн бодлого нь үндэсний хөгжлийн бодлого, ядуурлын эсрэг болон нийгмийн хамгаалал, халамжийн бодлого, цаашилбал боловсрол ба эрүүл мэндийн зэрэг өргөн хүрээний бодлоготой нягт уялдана. (Ч.Н)

АЖЛЫН БАЙРНЫ ЗУРАГЛАЛ (*Workplace map*)

Аливаа ажлын үр дүн, бүтээмжийг сайжруулах үүднээс үйл явцыг бүхэлд нь болон ажлын байртай холбоотой бүх мэдээллийг цуглуулан задлан шинжлэх процессыг ажлын байрны зураглал гэдэг. Энэ ойлголт нь анх газрын зураг хийх үйл явцаас үүссэн байдаг. Ажлын байрны зураглал хийснээр захиргааны байгууллагуудад ажлын үр дүнг хянах, ажилтны шалгуур бий болгож, бусад ажилтнуудтай ажил үүргийн давхардал бий болохоос сэргийлэн байгууллагын цалин хөлсний системийг боловсронгуй болгох, ажлын байрны маргаан зохицуулалт, ажилтнуудын сургалтын хэрэгцээг тодорхойлоход гарч болох алдаа дутагдлыг урьдчилан илрүүлэх, ажилтнуудын ачааллыг тэнцвэржүүлэх зэрэг ач холбогдолтой. Энэхүү стратегийн хэрэгсэл тухайн ажлын давуу ба сул талыг илрүүлэх хамгийн үр дүнтэй аргуудын нэг төдийгүй ажиллах хүчний талаарх үнэн зөв, мэдээллийг олж авах үйл явц. Мөн төлөвлөгөөний биелэлт, үр дүнг хэмжих хэрэгсэл тул ажлын байрны зураглалыг ажиглалт, асуулга, ярилцлагын аргаар хийхээс гадна өөр олон янзын арга байдаг боловч эхлэлийн цэг олох, зорилгоо зөв

тодорхойлох нь чухал. Байгууллагын бүтцэд дүн шинжилгээ хийж ажлын үр дүн сайжруулах албан тушаалын тодорхойлолт, зорилго, зорилт, үйл ажиллагааны чиг үүрэг, хариуцлага, эрх мэдэлд тавигдах шаардлагыг нарийвчлан шинжилж тодорхойлсон нарийвчилсан тодорхойлолт гаргадаг. Төрийн албаны тухай хуулийн 14.1.1-д зааснаар “Төрийн тухайн албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг тогтоосон албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтыг албан ёсоор гаргуулан авах, түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг шаардах” нийтлэг эрхийг төрийн жинхэнэ албан хаагч эдлэх бөгөөд мөн хуулийн 10.5-д “Төрийн үйлчилгээний албан тушаалд тавих тусгай шаардлага болон ёс зүйн хэм хэмжээг албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээ, контрактаар тодорхойлно” гэж заасан нь ажлын байрны шинжилгээ, тодорхойлолт, үнэлгээ хийх эрх зүйн орчныг тодорхойлж байна. (А.Э.ц)

АЖЛЫН БАЙРНЫ ШИНЖИЛГЭЭ (*Workplace analysis*)

Гүйцэтгэх ажлын мөн чанар, ажлын байрны зорилго, зорилт, чиг үүрэг, ажил гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай мэргэжил, мэргэшил, бие бялдар, оюуны чадавхын түвшин, ажиллах орчин нөхцөл, шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж зэргийн талаарх мэдээллийг цуглуулж, шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх системтэй үйл ажиллагаа. Энэхүү шинжилгээ нь албан тушаалын тодорхойлолт боловсруулах, ажилтныг сонгон шалгаруулж авах, ажлын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах болон идэвхжүүлэх, сургалтын хэрэгцээг тодорхойлох зэрэг олон зорилгоор ашиглагдана.

Иймээс ажлын байрны шинжилгээг хүний нөөцийн удирдлагын үндэс суурь гэж үздэг. (М.А)

АЖ ҮЙЛДВЭР 4.0 (Industry 4.0) Аж үйлдвэржилт нь хөгжлийн өмнөх төлөв байдлаас эрчимтэй өөрчлөгдөж буй технологийн дэвшилд суурилсан үйлдвэржилт, нийгэм-эдийн засгийн шилжилтийн үе, үйл явцыг хэлнэ. Аж үйлдвэржилт нүүрс, газрын тосны өргөн хэрэглээнд суурилж ирсэн боловч хөгжлийнхөө явцад улам бүр байгаль орчинд ээлтэй технологид шилжих болсон нь хүн төрөлхтний төгөлдөржилтийн түүх хэмээн үздэг. Хүнд хүчир технологийн хэрэглээ, гар ажиллагаа давамгайлсан ХАА, байгалийн нөөцийг хувирган ашиглаж байсан үеийг аж үйлдвэржилтийн өмнөх үе 1800 он хүртэл үргэлжилсэн. Аж үйлдвэрийн хувьсгал нь гар ажиллагаанаас машинт үйлдвэрлэлд шилжин XIX зууны дунд үед Англид биеллээ олсон. 1960-аад он хүртэл үргэлжилсэн энэхүү эрчимтэй хөгжлийн үед дотоод шаталтад хөдөлгүүр, эрчим хүчний бүтээн байгуулалтууд хэрэгжсэн энэ үе онцгой байв. Товчилбол: үйлдвэрлэл дамжлагын тогтолцоонд орж, эдүгээ хиймэл оюунд суурилсан ухаалаг үйлдвэрийн эрин эхэлснийг аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал хэмээн нэрлэсэн. XX зууны хоёрдугаар хагас гэхэд “Азийн бар” улс хэмээх ойлголт гарсан нь шинэ аж үйлдвэржилтийн үеийг нотлон БНСУ, Сингапур, Гонконг, Тайвань улсуудыг нэрлэж байв. Дэлхий дахинаа Давосын эдийн засгийн чуулга уулзалтыг санаачилагч Швейцарын эдийн засагч К.Швабын санаачилгаас хойш аж үйлдвэржилтийн дараах нийгмээс аж үйлдвэржилтийн дөрөвдүгээр хувьсгалын эрин үе буюу Аж үйлдвэр 4.0 рүү шилжиж буй тухай хэлэлцэх

болсон. К.Швабаас өмнө АНУ-ын социологич, аж үйлдвэржилтийн нийгмийн тухай онолыг үндэслэгч Даниел Белл тэртээ 1973 онд “Айлчлан ирж буй аж үйлдвэржилтийн дараах нийгэм” хэмээх ирээдүй судлалын бүтээлүүд туурвисан. Д.Белл: аж үйлдвэржилтийн дараах нийгмийг хэмжихэд нийгмийн бүтэц, улс төрийн тогтолцоо, соёлын хүрээнд шинжилгээ хийх хэрэгтэй. Тэдгээр нь дотроо мөн томоохон бүтэцтэй, тухайлбал, нийгмийн бүтэц нь эдийн засаг, технологи, ажил эрхлэлтийг багтаах бол улс төрийн байгуулал нь засаглалын харилцааг бүхэлд нь, харин соёл нь яруу сайхны болон илэрхийллийн бэлгэдэлт тогтолцоо хэмээн эдгээр суурь өөрчлөлт нь аж үйлдвэржилтийн дараах нийгмийн урьдач нөхцөл гэжээ. 2015 онд ХБНГУ-ын Ханновер хотод болсон үзэсгэлэн худалдаанд анх удаа “Аж үйлдвэр 4.0” хэмээх нэр томьёог хэрэглэж эхэлсэн түүхтэй. К.Швабын “Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал” болон бусад бүтээлд дөрөв дэх хувьсгалыг илэрхийлэх виртуал хоёр технологийн салбар, виртуал болон физик, хүн болон хүрээлэн буй ертөнцийг өөрчилж буй технологи, үйлдвэрлэлийн системүүд дэлхийн түвшинд бие биетэйгээ хэрхэн уялдаж, харилцан үйлчлэлцэх замаар өнөөгийн аж үйлдвэржилтийг бүтээж буй тухай өгүүлсэн. Тоон технологийн түгэн дэлгэрэлт: блокчейн, интернет, квантум компьютер: физик ертөнцийн хүрээнд хиймэл оюун ухаан болон робот, дэвшилтэт буюу шинэ материал, олон хэмжээст хэвлэл; хүнийг өөрчлөх хүрээнд биотехнологи, нейротехнологи, виртуал бодит байдал; хүрээлэн буй орчны хувьд энерги, геонженеринг, сансрын технологи тус тус багтана. Дүгнэвэл: “Аж үйлдвэр 4.0” нь

үйлдвэрлэлийн үйл явцад гарч буй технологийн гүнзгий өөрчлөлт, хувьсал төдийгүй нийгмийн парадигм, соёлын кодыг өөрчлөхөд чиглэгдсэн төлөв байдал. (Б.П)

АЗ ЖАРГАЛЫН ИНДЕКС (*Happiness index*) Хувь хүний болон дэлхийн улс орны хүн амын сэтгэл хангалуун байдал, аз жаргалтай, баяр баясалтай сайн сайхан байх зан үйл, сэтгэл хөдлөлийн түвшинг илэрхийлсэн хэмжигдэхүүн. Аз жаргалын индекс нь үндэсний аз жаргалын зэрэглэлийг өөрсдийнхөө амьдралыг үнэлсэн дэлхийн аз жаргалын тайлангийн нэг хэсэг бөгөөд судалгаанд оролцогчид амьдралын янз бүрийн хүчин зүйлстэй уялдаатай шалгуур үзүүлэлтүүдээр амьдралын чанарыг оноогоор үнэлж, аз жаргалын түвшинг жагсаасан үзүүлэлт юм. (Г.Б)

АЙМАГ (*Aimag*) Монгол Улсын засаг захиргааны хоёр дахь түвшний нэгж. Үгийн үндсэн утга нь аливааг тусгайлан төрөл анги болгосон хуваарь юм. Амьтны аймаг, нарны аймаг г.м. Монгол хэлэнд анх төрөл, угсаа гарал, зан заншлаараа нэгдмэл хүмүүсийн бүлэг гэсэн утгыг илэрхийлж байснаа улмаар засаг захиргааны нэгжийн нэр болсон. Монголд аймгууд ХҮИ сүүл үед буй болжээ. 1691 онд Халх Манж чин улсад дагаар орох асуудлыг хэлэлцсэн Долоон нуурын чуулганаар Халхын засаг захиргааны хуваарьт өөрчлөлт оруулж Засагт хан, Түшээт хан, Сэцэн хан аймгуудыг байгуулсан ба хожим 1725 онд тэр үеийг хүртэл Түшээт ханд харьяалагдаж байсан Сайн ноёны 7 хошууг таслан Сайн ноён хан аймгийг байгуулжээ. Богд хаант Монгол Улс эдгээр 4 аймгийг хэвээр үлдээсэн байна. 1921 онд Ардын засаг байгуулагдсанаар аймгуудын нэрийг

өөрчилж, хангуудын нэрийг халж, газар нутгийн нэртэй болгосон. 1923 онд Ардын засгийн газрын тогтоолын дагуу Сэцэн хан аймгийг Ханхэнтий уулын аймаг, Түшээт хан аймгийг Богд хан уулын аймаг, Засагт хан аймгийг Хантайшир уулын аймаг, Сайн ноён хан аймгийг Цэцэрлэг мандал уулын аймаг хэмээн тус тус нэрлэсэн байна. 1931 онд засаг захиргааны хуваарьт томоохон өөрчлөлт оруулж 13 аймгийг байгуулжээ. БНМАУ 18 аймагтай байв. 1992 онд батлагдсан Үндсэн хуулиар Дархан, Эрдэнэт хотуудыг аймаг болгон, хожим Говьсүмбэр аймгийг Дорноговь аймгаас гарган бие даалгаснаар Монгол Улс 21 аймагтай болжээ. (А.Ц)

АЙМГИЙН ЗАХИРГААНЫ ДҮРЭМ (*Rules of aimag administration*) 1921 оны хувьсгал ялж, Ардын засаг байгуулагдсаны дараа шинэ төрийн тогтолцоог буй болгох, ардчилах, засаг захиргааны хуваарь буй болгох зорилгоор гаргасан олон хууль тогтоомжуудын нэг. Анх 1923 оны 6-р сарын 23-нд найман бүлэг 38 зүйлтэй баталсан. Дүрмийн нэгдүгээр зүйл: эл дүрэм нь нутгийн захиргааны дүрмийн нэг бүлэг хэмээжээ. Дүрмийн хоёр дугаар зүйлд: аймгийн өөрөө эрхлэн шийтгэх асуудлуудыг 23 зүйлээр тус тус тодорхойлон заасан. Дүрмийн хоёр дугаар бүлэгт аймгийн хурлын үйл ажиллагааг зохицуулах хэм хэмжээг тодорхойлон эхний 9 зүйлд аймгийн хурлыг байгуулах асуудал, 10-р зүйлд хурлын эрхлэх асуудлуудыг тодорхойлсон. Гуравдугаар бүлэгт аймгийн яамны дүрэм, дөрөвдүгээр бүлэгт албан хаагчдын цалин хэрэглэл, тавдугаар бүлэгт аймгийн орлого, сан хөмрөг, зургаа дугаар бүлэгт аймгаас жилд нэг удаа төвд тайлагнаж байх асуудлууд, долдугаар бүлэгт гурван

жилд нэг удаа тайлагнах асуудлууд, наймдугаар бүлэгт аймгийн яамны хэргийг хянан байцаах комиссын дүрэм зэргийг багтаажээ. (А.Ц)

АЛБАДЛАГА (Coercion) Латин хэлний “coerctiōn” буюу барих, хязгаарлах гэсэн үгнээс гаралтай. Хүчлэн тулгаж, захиран тушаах үйлийн нэр. Төрөөс бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн бусад байгууллага, хуулийн этгээдэд албадан шахах арга хэрэглэхийг, мөн улс төрийн харилцааны субъектэд албадан нөлөөлөхийг хэлнэ. Нийгмийн шинжлэх ухааны олон салбарууд албадлагын тухай авч үздэг боловч ихэнхдээ төрийн удирдлага, улс төр, эрх зүйн салбарт түлхүү хэрэглэгддэг ойлголт. Хууль эрх зүйн үүднээс ил (хуулийн дагуу) ба далд (хууль бус) албадлагыг ялгаж үзэх нь чухал. Олон улсын харилцаа болон улсын дотоодод цэргийн хүчийг зөвхөн олон улсын эрх зүйн үүднээс НҮБ-ын тусгай мандаттайгаар ашиглахыг хууль ёсны албадлага гэж ойлгоно. Харин хууль бус гадаад албадлагын төрөл нь бусад улс орныг эзлэх, түрэмгийлэн халдах зэрэг болно. Улс орны дотоодод төрийн байгууллагаас хүч хэрэглэх үндэс, зөрчлийн шинж байдлыг хууль тогтоомжийн дагуу тодорхойлдог. Иймд төрийн удирдлагын тогтолцоонд албадах, хүч хэрэглэх журам, горимыг зөвхөн хуулиар тогтоож, хэрэглэнэ. Тухайлбал, хуулийн дагуу гарсан шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд хүч хэрэглэх албадлагыг зөвхөн зөрчлийг арилгах зорилгоор хэрэглэж болно. Ардчилсан нийгэмд албадлагын хэрэгцээ улам бүр багасаж, төрийн удирдлага, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд илрэх хэлбэрийг зөвхөн эрхэд суурилсан нийгмийн хэрэгжилтийг хангах зорилгоор ашиглах нь зохимжтой гэж үздэг. (Я.Т)

АЛБАН БУС МАНЛАЙЛАГЧ (Informal leader) Албан бус манлайлагч нь тухайн хүний нэр хүнд, итгэл үнэмшил, ажлын байран дахь нөлөөгөөр манлайлагч хэмээн байгууллага, эсвэл багийн гишүүд хүлээн зөвшөөрдөг хүн. Албан бус манлайлагч нь байгууллага дотроо бүлгийг удирдах албан ёсны эрх мэдэлгүй, хэн өөрийг нь дагаж байгааг хянадаггүй ч эргэн тойрныхоо хүмүүст нөлөөлж чаддаг чадвар. Манлайлагч нь манлай бологч, тэргүүлэгч, хошуучлагч юм⁴. Судлаач Е.Льюис (E.Lewis)-ийн тодорхойлсноор амжилттай удирдагчдын манлайллын нийтлэг шинжүүд нь байгууллагаа өөрийн зорилгодоо хүрэх хэрэгсэл гэж үздэг, зорилго нь зөвхөн оргилд хүрэх биш хамт олныг ямар нэгэн чухал зүйл хийхийн төлөө чиглүүлэх явдал юм. Судлаач Норма Риккуччи (Norma Riccucci): бодлогын орчинд үр дүнтэй өөрчлөлт хийх, төлөвлөх, зохион байгуулах, ойлгомжтой харилцах, ажилтнуудаа идэвхжүүлэх, бодитой зорилго тавих, шударга байх, улс төрийн мэдлэгтэй, салбартаа мэргэшсэн байх зэрэг удирдахуйн ур чадвар болон төрөл бүрийн чиглэлээр өргөн мэдлэгтэй хүн манлайлагч байна. Манлайлагчийн хувийн зан чанар нь “үнэнч шударга байдал”, “найдвартай”, “ёс зүйтэй”, “хошин шогийн мэдрэмжтэй” байх. Манлайлагч хүнэссуртахуунызарчим, зорилгодоо тууштай байж, бусдад үлгэр жишээ үзүүлж байснаараа бусдаас ялгарч, нэр хүндтэй болдог. Манлайлагч хүн “ухаалаг, ухамсартай, сонор сэрэмжтэй, хариуцлагатай, санаачилгатай, тууштай, өөртөө итгэлтэй, нийтэч байдаг”⁵. Байгууллагын манлайлагч

⁴ Монгол Улсын ШУА, Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь М-С, Улаанбаатар, х. 1207.

⁵ Encyclopedic Dictionary of Public Administration, 2012, www.dictionnaire.enap.ca/

нь ихэвчлэн дээд эсвэл түүнтэй ойролцоо түвшинд байдаг гэсэн ойлголт, хандлага ихэнх хүмүүст бий. Орчин үеийн манлайллын онолоор байгууллагын аль ч түвшинд манлайлах боломжтой. Ялангуяа багаар ажиллахад манлайлал ихээхэн ач холбогдолтой. Багийн ахлагч нь хамгийн өндөр албан тушаалтан байх албагүй бөгөөд нөхцөл байдлаас шалтгаалан багт албан бус манлайлагч гарч ирж болно. (Д.Ч)

АЛБАН ЁСНЫ ХЭЛ (*Official language*)

1953 онд ЮНЕСКО-гийн шинжээчид төрийн хэл болон албан ёсны хэл хэмээх ойлголтуудыг ялган тодорхойлжээ. Тэрхүү тодорхойлолтоор “төрийн хэл нь тухайн улсыг улс төр, нийгэм, соёлын хүрээнд нэгтгэн нягтруулах үүрэг гүйцэтгэдэг, тухайн улсын бэлгэ тэмдэг болдог” хэл ажээ. Харин албан ёсны хэл бол “төрийн удирдах, хууль тогтоох, шүүн таслах үйл ажиллагаанд хэрэглэдэг” хэл юм. Албан ёсны болон төрийн хэлний үүргийг нэг, эсхүл өөр өөр хэлээр гүйцэтгэдэг улс байдаг. Монгол хэл бол Монгол Улсын төрийн хэл, мөн албан ёсны хэл мөн. (А.Ц)

АЛБАН ТАСАЛГАА (*Office*) Аливаа байгууллагын объект, захиргааны ажилтнуудын ажил үүргээ гүйцэтгэдэг өрөө буюу талбайг хэлнэ. Албан ажил үүрэг гүйцэтгэх зориулалт бүхий төвлөрсөн барилга байгууламж, байшин дотор ажил үйлчилгээ явуулах, үйлчилгээ үзүүлэх өрөө, албан тасалгааг “Оффис” хэмээн монгол хэлнээ хэрэглэж заншжээ. Оффисын гол зорилго нь ажилтнууд ажлаа гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэх. Оффисын ажлын орон зайг ихэвчлэн унших, бичих, уулзалт хийх, компьютер дээр ажиллах гэх мэт ердийн үйл ажиллагаанд ашигладаг.

Жеймс Стивенсоны тодорхойлсноор: “Оффис бол төрөл бүрийн үйл ажиллагааны чиглэл, зохицуулалтад зориулагдсан бизнес, аж ахуйн нэгжийн нэг хэсэг” юм. Дундад зууны дунд үеийн эртний сонгодог оффис нь ихэвчлэн ордны цогцолбор эсвэл томоохон сүм хийдийн нэг хэсэг байв. XVIII зууны үеэс анхны зориулалтын байрууд баригдаж, XVIII-XIX зуунд аж үйлдвэрийн хувьсгал эрчимжсэнээр банк, төмөр зам, даатгал, жижиглэнгийн худалдааны салбарууд, нефть, цахилгаан холбоо огцом өсөж, олон бичиг хэргийн ажилтнууд шаардагдсаны улмаар оффисын байрны хэрэгцээ нэмэгджээ. 1915 онд үйлдвэрлэлд анхлан нэвтрүүлсэн Ф.В.Тейлорын “Орчин үеийн бүтээмжийн ширээ” загварын оффис тухайн үеийн ажлын цаг-хөдөлгөөний судалгааны дүнгээр менежер нь ажилчдаа хянах боломжтой байсан бол XX зууны дунд үе гэхэд үр ашигтай ажиллахад албаны төдийгүй хувийн орон зайг хамгаалах шаардлагатай болжээ. Орчин үеийн оффис хувь хүний өрөөнөөс гадна хурал, амралтын өрөө, материал хувилах, бүрдүүлэх зэрэг туслах үйл ажиллагааны хэсгээс гадна цайны завсарлагын өрөөтэй болсон. Албан тасалгааны гол зорилго нь ажлын байр, ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх явдал юм. Байгууллагын амжилт ажилчдаас шалтгаалдаг бол ажлын бүтээмж нь ажлын байр орчны тохижилтоос шалтгаалдаг байна. Ажилтан амьдралынхаа ихэнх цагийг оффист өнгөрөөхдөө авьяас чадвараа хөгжүүлж, багаар ажиллахад тав тух, төвлөрөх боломжтой орчноор хангагдсан байх нь ажлаа сайн гүйцэтгэх хөшүүргээс гадна тухайн байгууллагын нэрийн хуудас, нэр хүнд, таних тэмдэг болдог. (А.Э.ц)

АЛБАН ТОМИЛОЛТ (*Business trip*)

Тусгай ажил хийх хүнийг албан ёсоор сонгон үүрэг даалгавар өгснөөр тухайн үүрэг даалгаврыг биелүүлэхээр явах үйл явцыг хэлнэ. Гадаад болон дотоодод өгөгдсөн ажлын чиг үүргийг биелүүлэх зорилгоор тодорхой хугацаанд ажлын байрнаас гадуур ажиллахыг албан томилолт хэмээн ойлгох бөгөөд байгууллагын удирдлагаас, эсвэл харьяалах дээд шатны байгууллагын удирдлагын тушаалаар энэхүү үйл явц, үйл ажиллагаа явагдана. Албан томилолтын дараа тухайн албан тушаалтан томилолтын үйл ажиллагааны тайлан, холбогдох санхүүгийн баримтыг холбогдох субъектэд гарган өгнө. Тухайн үйл ажиллагааны зорилгод хүрсэн эсэхийг албан томилолтын үр дүнгээр тодорхойлно. (Г.Б)

АЛБАН ТУШААЛЫН БҮРЭН ЭРХ (*Position power*)

Бүрэн эрх нь албан тушаалын хүрээнд гүйцэтгэх үүрэг болон үүргээ биелүүлэхийн тулд шаардлагатай эрх мэдэл, хариуцлагын зохист харьцаа⁶. Бүрэн эрх бол тодорхой албан тушаалд олгогдсон хязгаарлагдмал эрх бөгөөд чиг үүргийн хүрээгээр энэхүү хязгаар нь тодорхойлогдоно⁷. Бүрэн эрх нь тухайн хувь хүнд бус албан тушаалд олгогддог тул тухайн хүний албан тушаал солигдоход бүрэн эрх “хүнтэйгээ” хамт солигдохгүй, тухайн албан тушаалд үлдэнэ. Жишээлбэл Монгол Улсын ерөнхийлөгчийн бүрэн эрх. (М.А)

АЛБАН ТУШААЛЫН СУЛ ОРОН ТОО (*Vacant position*)

“Сул орон тоо” гэж төрийн жинхэнэ албан хаагчийг албан

тушаалаас нь бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсан, өөр албан тушаалд сонгогдсон, томилогдсон, эсхүл төрийн жинхэнэ албан хаагч нас барсны улмаас тухайн албан тушаалын орон тоо суларсан байхыг, түүнчлэн шинээр бий болсон⁸ албан тушаалын орон тоог хэлнэ⁹. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас нөхнө. Хэрэв нөхөх боломжгүй бол төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс нөхөх ба боломжгүй бол нээлттэй сонгон шалгаруулалт зарлана¹⁰. (М.А)

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ (*Job description*)

Албан тушаалын тодорхойлолт нь тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг баталгаажуулсан албан ёсны баримт бичиг¹¹. Өөрөөр хэлбэл уг албан тушаалд ямар шаардлага хангасан хүн ажиллах, хийх ажлын цар хүрээ, түүнийг дагасан үүрэг хариуцлага, эрх мэдэл нь ямар байхыг тодорхойлж өгсөн баримт бичиг бөгөөд төрийн албан хаагч тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг хариуцах үндэслэл болохын зэрэгцээ

6 Цэнд. Н., Батхүрэл Г., Шуурав Я., ... нар, “Менежмент”, 2013, 159 дэх тал.

7 Цэнд. Н., Батхүрэл Г., Шуурав Я., ... нар, “Менежмент”, 2013, 163 дахь тал.

8 Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам, ТАЗ-ийн 2019 оны 14 дүгээр тогтоол.

9 Төрийн албаны тухай хуулийн 3.1.4 дэх заалт.

10 Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйл.

11 Төрийн албаны тухай хуулийн 3.1.5 дахь заалт.

тухайн албан тушаалд тохирох хүнийг шилж сонгох, томилох зэрэгт ашиглагдана. Шинээр томилогдсон албан хаагчийн хамгийн түрүүнд танилцах баримт бичиг нь албан тушаалын тодорхойлолт байна. Албан тушаалын тодорхойлолтыг ажлын байрны шинжилгээнд үндэслэн боловсруулах бөгөөд уг тодорхойлолт нь 1) албан тушаалын тодорхойлолтын ерөнхий мэдээлэл, 2) албан тушаалын зорилго, зорилт, чиг үүрэг, 3) албан тушаалын тусгай шаардлага, 4) албан тушаалын харилцах субъект, 5) албан тушаалын тодорхойлолтын баталгаажуулалт гэсэн хэсгүүдээс бүрдэнэ¹². (М.А)

АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИН (*Salary of Position*) Албан тушаалын ангилал, зэрэглэлээс шалтгаалж олгогдох цалин. Тухайн албан тушаалын гүйцэтгэх эрх, үүрэгт үндэслэн цалингийн хэмжээг тодорхойлно¹³. Энэ нь хэдийгээр төрийн албан хаагчдын хийж гүйцэтгэвэл зохих ажил үүргийн хэм хэмжээнд тулгуурлах давуу талтай ч тэдний ажлын ачааллыг харгалзан үздэггүй, албан тушаалын мөн чанар, эрх үүрэгт анхаарах бус тушаал шийдвэрийг биелүүлэхэд чиглэдэг сул талтай. (Г.Б)

АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ (*Temporary replacement of job duties*) Төрийн албан хаагч эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар түр хугацаагаар чөлөөтэй байгаа тохиолдолд тодорхой хугацаанд тухайн албан хаагчийн албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг хариуцан хэрэгжүүлэх албан хаагчийг хэлнэ¹⁴. Албан үүргийг түр

орлон гүйцэтгэх албан хаагч нь үндсэн албан тушаалаасаа чөлөөлөгдөхгүй. Түр орлон гүйцэтгэх хугацаа болон эрх хэмжээг түр орлон гүйцэтгэгчийг томилсон шийдвэрт тусгана. (М.А)

АЛБАН ХАРИЛЦАА (*Official relationship*) Харилцаа нь латин хэлний communication гэсэн үг бөгөөд ерөнхий утгаараа хүн болон амьтан ургамал хүрээлэн буй орчин, эд юмстай болон өөр хоорондоо холбоо тогтоох тэмүүлэх үйлийг хэлнэ. Үгийн гарал зүйн талаасаа ямар нэг зүйлийг хамтран хийх, хуваалцах гэсэн утга агуулдаг. Энэ бол зөвхөн мэдээлэл дамжуулах төдий харилцаа биш, харин бүлэг хамт олны амьдралын гүнд хүмүүс бие биетэйгээ харилцан үйлчлэх, үзэл бодол, итгэл үнэмшил, хандлагаа солилцохыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, тогтсон хандлагыг төлөвшүүлэх, нийгэм түүхийн туршлага эзэмших үйл явцыг албан харилцаа гэнэ. Хүн хоорондын ба хүний нийгмийн харилцааны үүргийг холбох, төлөвшүүлэх, баталгаажуулах, гадагш илэрхийлэх, дотогшоо хандах үүрэг гэж задалж үзэж болно. Түвшин талаас нь авч үзвэл, харилцаа нь өөрийн дотоод, бие хүн хоорондын, бүлэг ба байгууллагын, нийгмийн, олон нийтийн, даяаршлын харилцаа гэж ангилдаг. Албан харилцаа бол харилцааны үндсэн таван төрлийн нэг бөгөөд “албан тушаалтан”-тай харилцахдаа хэлэлцэж буй асуудлаар санал зөрж, өөрийн байр суурь зэргийг тууштай хамгаалж болох ч хэт найзархах, хамтрагчийнхаа найз нөхөд, гэр бүлийн талаар ярилцах, санхүүгийн бүх шийдвэрийг нь сонирхох зэрэг сэдэв хөндөх нь зохисгүй. Ажлын байрны орчин баг, хамт олны хамтын ажиллагаа, албан харилцааг дэмжиж өгснөөр

12 Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам, ТАЗ-ийн 2019 оны 03 дугаар тогтоол.

13 Civil Service Bureau of Kingdom of Bahrain, “Position Classification”, 2008, p. 3.

14 Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйл.

хамтран ажиллагчид биесээ хүндлэх үнэлэмжийг нэмэгдүүлдэг. Хувь хүмүүсийн хоорондын харилцаа болон зан төрх үйлдэл байгууллагын ажил хэрэг, амжилтад их нөлөөлдөг. Жишээ нь: хүн бүр бусдыг сонсох чадвар сул тул мэдээлэл солилцох, харилцах явцад олон бэрхшээл учирдаг. Удирдагч хүн сонсох чадварынхаа зөвхөн 25%-ийг ашигладаг гэсэн судалгаа бий. Профессор Кет Девисийн санал болгосон хүний яриаг анхааралтай сонсох дүрмийг дурдвал: 1. Анхааралтай сонсох, 2. Ярьж байгаа хүндээ чөлөөтэй байх боломж олгох, 3. Сайн сонсогч байх, 4. Сонсож байхдаа өөр үйлдэл эс хийх, 5. Ярилцаж буй хүнийхээ оронд өөрийгөө тавьж үзэх, 6. Хүний яриаг таслахгүй байх, 7. Эсэргүүцлээ шууд илэрхийлэхгүй тэвчээртэй байх, 8. Эс маргалдах, шүүмжлэх, 9. Асуулт тавих, 10. Хэт удаан ярихгүй байх гэжээ. Албан харилцаанд хүн бүрийн үнэт цаг хугацаа, эрч хүчийг үр ашиггүй өнгөрөөхгүйн тулд асуудлыг товч тодорхой эерэгээр илэрхийлэх чадвар эзэмшиж, сөрөг хандлагаас зайлсхийж сурах нь чухал. Харилцааны онол нь хувь хүний туршлагад нөлөөлдөг, нийгмийн болон сэтгэл зүйн хүчин зүйлс болох нийгмийн үйл ажиллагааны гол чиглэл гэж Холлис 1964 онд тодорхойлжээ. Харилцаанд суурилсан хандлага нь шинэ үзэгдэл биш бөгөөд харилцааг мөн сэтгэл зүйн загвараар тодорхойлсон байдаг. Хувь хүний ухамсар, харилцааны онолоос үл хамааран ихэнх хүмүүс харилцааг өөрсдийн үзэл бодлын бодит байдал гэж үзэх хандлагатай байдаг бол “.. хавсарга онол, психоанализ ба системийн онолоор хувь хүний хандлага, өнөөгийн харилцаа нь хувь хүмүүсийн хөгжил, хүмүүс хоорондын харилцааны байдал яагаад харилцан адилгүй

байдлыг ойлгох аргыг тайлбарлана” гэж зарим нь үздэг (Макклуски ба Хупер, 2000). Түүнчлэн 1992 онд Харилцааны онолын төлөөлөгч Уильям Гудыкунст, Янг Ким нар нийгмийн соёлын түвшин, зан байдлын нийтлэг шинжээс үл хамаарч хувь хүн бүрд өвөрмөц ялгаатай зан үйл бий, тухайлбал, “АНУ-д ихэнх хүмүүс индивидуалист хандлагатай ч бас зарим нь хамтач байдаг бол Япон хүмүүс ерөнхийдөө хамтач байдаг ч бас индивидуалист хандлагатай хүмүүс ч байдаг” гэжээ. (А.Эц)

АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ (*Official documentation*) Байгууллагын үйл ажиллагааны явцад баримт бичиг боловсруулах, стандартын дагуу зохиож бүрдүүлэх, бичиг хэрэгт хүлээн авах, бүртгэл, хянан шийдвэрлэх, ангилан төрөлжүүлэх, албан хэрэгт хадгалах, мэдээлэл лавлагаанд ашиглах, байгууллагын архивд хадгалах, байнгын архив шилжүүлэх болон устгалд оруулах цогц үйл ажиллагаа. Албан хэрэг хөтлөлт нь объект, системийн процедурын зарим шинж чанарыг тайлбарлахад ашигладаг боловсруулах, бүрдүүлэх үйл явц билээ. Албан хэрэг хөтлөлтийн үр дүнд үүссэн баримт бичгүүд эмх цэгцтэй, тогтоосон стандартын дагуу байх ёстой. Эдгээр нь оролцогч талуудын сонирхсон мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэн, шийдвэр гаргах үндсийг хангана. (Г.Б)

АМАР А. (*Amar A.*) Монгол төрийн нэрт зүтгэлтэн. 1886 онд Түшээт хан аймгийн Эрдэнэ дайчин засгийн хошуу, одоогийн Булган аймгийн Хангал сумын нутагт Анандын гэр бүлд мэндэлжээ. Арван хоёр наснаас бичиг үсэгт суралцаж, Манж, Төвд хэл гадарладаг болж,

улмаар хошууны тамгын газар, алтны уурхай, аймгийн жасаанд бичээч, эх зохиогч түшмэлээр ажилласан байна. 1913 оноос Богд хаант Монгол Улсын Гадаад явдлын яам, аймгийн чуулган зэрэг газруудад бичээч, эх зохиогч түшмэлийн алба хашин, 1921 оны хувьсгалын дараагаар Гадаад явдлын яамны эрхэлсэн түшмэл, сайд, Аж ахуйн яамны сайд, Дотоод явдлын яамны сайд, эдийн засгийн зөвлөлийн тэргүүлэгчээр ажилласан байна. 1928-1930, 1936-1939 онуудад Монгол Улсын Ерөнхий сайд, 1930-1932 онд Шинжлэх ухааны хүрээлэн, 1932-1936 онд БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн даргын албыг тус тус хашиж байв. А.Амар Монгол Улсын тусгаар тогтнолыг хамгаалах, эдийн засгийг хөгжүүлэх, эрдэм соёлыг өрнүүлэх талаар ихэд анхаарал тавьж, засгийн бодлого, үйл ажиллагаанд Монгол орны онцлог, нөхцөл байдлыг харгалзахыг эрмэлзэн, төр, захиргааны ажлыг сайжруулахад үлгэр дуурайл үзүүлдэг, зарчимч шударга байхыг дэмждэг нэгэн байжээ. А.Амар улс төрийн хилс хэрэгт гүтгэгдэн 1941 оны 7-р сарын 10-нд Москвад цаазлан хороожээ. Түүнийг 1960 онд цагаатгасан байна. А. Амар төрийн гарамгай зүтгэлтний зэрэгцээ эрдэмтэн, түүхч хүн бөгөөд Хүннү гүрнээс эхлэн Их Монгол Улсын түүхийг багтаасан “Монголын товч түүх” хэмээх зохиолыг туурвисан байна. (А.Ц)

АМЕРИКИЙН /АНУ/ ЗАХИРГААНЫ УЛАМЖЛАЛ (*Tradition of American administration*) Захиргааны онол, үйлдлэгийн асуудлыг тус улсыг үндэслэн байгуулсан үеэс л ярьж эхэлсэн гэж болно. Александр Хамилтон: төр бол хүчтэй, төвлөрсөн, гэхдээ захиргаа нь илүү хүчтэй байх ёстой гэсэн

санааг илэрхийлж байсан бол Томас Жефферсон: захиргаа нь юуны өмнө ардчиллыг гүнзгийрүүлэхэд чиглэж байх ёстой хэмээн үзэж байв. Америкийн захиргаа эхэн үедээ цөөн тооны ажилтантай жижиг албатай байсан. Ж.Вашингтоны үед төрийн, цэргийн, баялгийн гэсэн гурван гол департаментыг буй болгожээ. Шуудангийн алба улам бүр томорч байсан нь Америкийн захиргааны томролтын эхлэл байсан гэдэг. 1820 –иод оноос намуудын нөлөө хүчтэй болж, ялангуяа Ерөнхийлөгч Эндрю Жексоны үед спойл систем өргөн дэлгэрч, орон даяар лоялистууд захиргааны албанд томилогдох болсон нь захиргааны хоёр дахь томролтыг өдөөжээ. XIX зууны сүүл рүү аж үйлдвэржилт хөгжсөнөөр хүн ам ихэд өссөн. Зарим бүс нутагт хотууд цэцэглэн хөгжиж, төмөр зам, холбооны шугам бараг бүх нутгийг хамрах болсон нь холбооны улсын төв захиргааг хүчтэй болгосон байна. Төр, төрийн албан хаагчид концесс, газар олгох гэх мэт асуудлыг эрхлэх болсон нь төрийн зохицуулалтыг хүчтэй болгов. Оюуны болон эдийн засгийн салбарын элитүүд 1870-аад оны дунд үеэс спойл системийг хүчтэй шүүмжлэх болжээ. Үүний улмаас ерөнхийлөгч Т.Жеферсоны үеэс эхлэн мерит системийн эхлэл тавигдан 1883 онд төрийн албаны реформын тухай хууль гарсан байна. Энэ хуулиар холбооны засгийн газрын албанд хүмүүсийг шилж сонгох, халах, дэвшүүлэх зэрэг үйл ажиллагааг мерит системд суурилан нээлттэй, өрсөлдөөнт шалгалт авч шийдвэрлэх үүрэг бүхий Төрийн албаны зөвлөлийг байгуулсан байна. Америкийн захиргааг хөгжүүлэхэд ерөнхийлөгч В.Вильсон томоохон үүрэг гүйцэтгэн захиргаа нь менежментийн ухаанд суурилан үйл ажиллагаагаа явуулах

ёстой хэмээн захиргааны шинжлэх ухааныг хөгжүүлэх эхийг тавьсан. 1930-аад оны их хямралын үеэс эхлэн Америкийн засаг захиргаа тухайн үеийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийн тулд янз бүрийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн нь төрийн аппаратын хэмжээ, албан хаагчдын тоог улам бүр өсгөжээ. 1960 он гэхэд албан хаагчдын тоо 2.2 саяд хүрсэн байна. Ерөнхийлөгч Р. Рейганы үеэс төрийн албан хаагчдын тоог багасгах талаар оролдлого хийсэн боловч батлан хамгаалахын зардлыг урьд байгаагүй хэмжээгээр нэмсэн зэргээс болж төдийлөн үр дүнд хүрээгүй байна. (А.Ц)

АМЬДРАЛЫН ЧАНАР (*Quality of life*)

гэдгийг монгол хэлнээ амьдралын чанар хэмээн орчуулан хэрэглэдэг. “Амьдрал” буюу “life” гэдэг нь эртний Английн “life”, харин “чанар” буюу “quality” гэдэг нь Латин хэлний “qualitatem (чанар, шинж чанар, байдал)” үгнээс үндэстэй. Амьдрал: хүн, амьтны төрж бий болохоос үхэж мөхөх хүртэлх үеийн оршин байх үе, харин чанар нь аливаа юмны бодит шинж тэмдэг нөгөөгөөс ялгарах онцлог юм. Амьдралын чанарын талаарх ойлголт академик хүрээнд дэлхийн хоёрдугаар дайны дараа нийгмийн тэгш бус байдлыг танин мэдэж, хүлээн зөвшөөрөх болсон үед хэрэглэгдэх болжээ. Амьдралын чанар нь хувь хүний болон нийгмийн сайн сайхан байдал, амьдралын эерэг, сөрөг шинж байдлыг дүрслэн харуулдаг түвшин юм. АНУ-ын эрдэмтэн D.Morris 1978 онд амьдралын чанарын индексийг бичиг үсэг тайлагдалт (literacy), нялхсын эндэгдэл (infant mortality), насжилт (life expectancy at age one) гэсэн гурван үзүүлэлтээр тодорхойлсон. (Т.Т)

АНАРХИСТ ҮЗЭЛ (*Anarchism*)

Грекийн “anarkhos” үгнээс гаралтай “дүрэмгүй, удирдлагагүй” гэсэн утгатай. Түүхэн хөгжлийн хувьд Францын зохиолч Пьер-Жозеф Прудоны (Pierre-Joseph Proudhon) 1840 онд бичсэн “What is Property? номондоо “анархи болон анархизм” гэдэг үгийг ашиглаж, өөрийгөө анархист үзэлтэн гэж анх зарласан. 1793 онд У.Годвини “Godwin’s Enquiry Concerning Political Justice” бүтээлд улс төрийн онолын анархизмын талаар анх бичигдсэн. Анархизмын үзэл санааны гол дэлгэрэлт нь XIX зууны дунд үеэс эхлэлтэй бөгөөд Германы улс төрийн зүтгэлтэн М.Штирнер, Б.Такер, Ж.Прудон, Оросын анархист үзэлтэн М.А.Бакунин нарын нэртэй холбоотой юм. Анархизм нь хүн эрх чөлөөгөө эдлэхэд төр үргэлж саад болдог тул аливаа нэгэн албадлага, хууль, дүрэмгүйгээр нийгэм өөрөө оршин тогтнох ёстой, хүмүүсийн хамтын амьдрал жам ёсны болоод иргэдийн эрх чөлөөт, сайн дурын холбооны үндсэн дээр зохион байгуулагдана гэсэн үзэл санааг илэрхийлнэ. Засаг төргүй, ямар нэг дүрэм журамгүй байх нь анархизмын онолын нийгмийн зохион байгуулалтын үзэл санааны суурь. Төрийн захиран тушаах аливаа эрх мэдлийг үгүйсгэж, иргэдийн сайн дурын нийгэмлэгүүдээр түүнийг орлохыг уриалсан улс төрийн үзэл санааг зарчим болгодог. Эрх чөлөөг туйлын утгаар илэрхийлэгдэж, хэрэгжих ёстой гэсэн үзэл санаанд тулгуурласан боловч төр засаггүй тэдний хүсэж буй нийгэм, төрийн удирдлагын тогтолцооны цогц онол, сургаал болоогүй. Тиймээс улс орнуудын нийгэм, улс төрийн практикт анархизмын үзэл санаа хэрэгжиж байгаагүй, хэрэгжих боломжгүй гэж судлаачид үздэг.

Ердийн ухамсрын түвшинд анархизмыг “ёс суртахуунгүй, улс төрийн замбараагүй байдал” хэмээн үзэх ойлголт, хандлага түгээмэл. (Я.Т)

АПАРТЕЙД (*Apartheid*) Апартейд – “салан тусгаарлалт” гэсэн утгатай африк үгнээс гаралтай. ӨАБНУ-д 1948-1994 онуудад хэрэгжүүлж байсан арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бодлоготой холбоотой гарч ирсэн ойлголт. Цагаан арьстнууд хар арьст хүмүүсийг өөрийн эрхшээлд байлгаж, өөрсдийгөө дээгүүр зиндаанд тавих бодлогыг хамгаалах зорилготой үзэл юм. Апартейдийн бодлогыг хоёр ангилдаг: а/ Арьсны ялгаатай бүлгүүдийг бүх түвшинд тусгаарлах (тусад нь сургууль, байгууллагууд, байр байшин барин тусгаарлах) б/ Нутаг дэвсгэрээр тусгаарлах буюу нутаг дэвсгэрүүдийг хуваарилж өгөх зэрэг агуулгаар ойлгож болно. Хар арьстнууд зөвхөн өөрийн нутаг дэвсгэртээ л иргэний болон улс төрийн эрхээ эдлэх боломжтой. Харин тухайн нутаг дэвсгэрт эрлийз болон шар арьстнууд тодорхой хугацааны дараа иргэний эрхээ эдлэх боломжтой болсон түүхтэй. 1991 онд цагаан арьстны цөөнхийн үндэсний нам болон хар арьстны эсэргүүцлийн хөдөлгөөнүүд хамтын хэлэлцээр хийж эхэлснээр 1994 онд Өмнөд Африкт иргэдийн тэгш эрхийг тунхагласан үндсэн хуулийг батлахад хүргэж, энэ дэглэм эцэс болсон түүхтэй. (Я.Т)

АРАВТЫН ТОГТОЛЦОО (*Decimal system*) Эртний Хүннү гүрний үеэс уламжилж ирсэн, Төв азийн нүүдэлч улсуудын засаг захиргааны тогтолцоо. Хүн амыг аравт, зуут, мянгатаар хувааж зохион байгуулна. Энэ нь суурин улс түмний нэгэн адил газар нутгаар баримжаалж засаг захиргааны хуваарь хийх боломжгүй,

хүн ам нь байнга хөдөлгөөнтэй байдаг нүүдэлчин ард түмний онцлогийг харгалзан буй болгосон хуваарь юм. Их Монгол улс ийм тогтолцоотой байсан ба Чингис хаан анх 95 мянгатыг буй болгожээ. Доод нэгж нь аравт байсан ба цэргийн насны арван эрээр зохион байгуулдаг байжээ. Аравтын тогтолцооны улбаа Манж Чин улсын эрхшээлд байсан үед, Богд хаант Монгол Улс, түүнчлэн Ардын хувьсгалын дараах үеийн засаг захиргааны хуваарьт ч хадгалагдаж байсны жишээ нь “арван гэр”, “хорин гэр”, “хороо хорин” гэх мэт анхан шатны нэгжүүд юм. (А.Ц)

АРВАН БУЯНТ НОМЫН ЦАГААН ТҮҮХ (*The white story of the Ten Virtuous Books*) Монголын төрт ёс, хууль цааз, эрх зүйн сэтгэлгээний үнэтэй сурвалжуудын нэг бөгөөд Юань улсын үед Хубилай хааны зарлигаар зохиожээ. Зохиогч нь тодорхойгүй боловч зарим судлаачид Пагва ламыг зохиосон хэмээн таамагладаг. К.Сагастер: Хубилай хаан өөрөө зохиосон, С.Жалан-Аажав: Хубилай хаан эрдэм номтой хүмүүсийг татан оролцуулж өөрөө санаачлан зохиосон гэж үзэн олон хувилбараар уламжлагдан өнөөг хүрсэн. К.Сагастер: Цагаан түүх нь тухайн үеийн албан хаагчдын баримталж байсан гол хууль гэж, харин С.Жалан-Аажав Хубилай хааны төр засах хөтөлбөр гэжээ. Цагаан түүх нь төр, шашныг хослох хоёр ёсны үзэлд суурилсан Юань Улсын гол хууль. Хаан улсдаа “хоёр ёсыг тэгшид явуулах” –аа тунхаглаж “Арван буянт номын цагаан түүх”-д, тунхагласан байна. Тэрбээр “эдүгээ би бээр түүнчлэнхүү хоёр ёсыг тэгшээр явуулсугай хэмээгээд түүгээр эн урьдад хүрэхүйеэ хоёр ёсыг аль буй хэмээвээс, номын төр тарни, судар хоёр

хийгээд ертөнцийн төр энх хялбар хоёр” хэмээжээ. “Цагаан түүх”-д Юань гүрний төрийн тогтолцоог номын болон төрийн талаас нь алган тодорхойлж, ажиллах хүмүүсийн орон тоо, чиг үүрэг, мэдлэг чадварыг заасан. Судар, тарниас бүрдэх номын ёсыг эрхлэн явуулагчдыг тодорхойлон арван зургаан тушаалтныг жагсааж, тэд ямар эрдэм чадалтай байх ёстойг заажээ. Эдгээр нь чухамдаа арван зургаан байгууллага ч гэж үзэж болох юм. Учир нь дээд, дунд, дэд ламын албанд байх ёстой яам буюу орон тоог нэрлэсэн. Үүний дараа мөн хаан төрийн талд ажиллагчдыг буюу ертөнцийн төр энх хялбар хоёрыг эрхлэгчдийг буюу хамгийн дээд тушаалтан нь хаан учраас эхлээд хоёр ёсыг тэгшид явуулагч төрийн хаан ямар байх ёстойг тодорхойлсон байна. Хаан ямар байх, юу хийх ёстойг чанарын дөрвөн хаан буюу хааны үйл ажиллагааны дөрвөн онцлог талыг дурдсан. Дараа нь хааны удаад орох улсын томоохон тушаалтнуудыг хонжингоос эхлэн нэрлэж тэд ямар эрдэм чадалтай байх ёстойг тодорхойлжээ. Энэ мэтээр хонжин, тайш, заяач, хашха нарыг дэс дараалан дурдсаны зэрэгцээ төрийн хар талд байх түшмэдүүдийг нэрлэн, тэдний чиг үүргийг тодорхойлжээ. Эхлээд өмнөхийн адил хааны үүрэг, тэр үүргээ хэрэгжүүлэхэд хэрэгтэй чадвар, төрийн бэлгэдэл юу болохыг: хан хүн гурван их үйлс, дөрвөн их төр, зургаан их үлгэр, долоон их бин, есөн их бэлгэтэй байна гэжээ. Ийнхүү тодорхойлогдсон төрийн чиг үүргийг төрийн байгууллагууд тус тусдаа хэрэгжүүлэхээр заасан. “Гурван их үйлсийг гурван хонжин мэд, Дөрвөн их төрийг дөрвөн тайш мэд, Зургаан их үлгэрийг зургаан тайш мэд, Долоон их бинг долоон зайсан мэд, Есөн их бэлгийг есөн өрлөг мэд” хэмээн

хуваарилжээ. Түүнчлэн аравт, зуут, мянгат, түмтийн ноёд нь энэ загвараар аймаг улсаа мэд хэмээн заажээ. Хаант төрийн албыг дэлгэрэнгүй есөн яам, дунд гурван яам, хураангуй гурван яам хэмээн зэрэглээд тэдгээрт ямар ямар албан тушаалтнууд хамаарагдахыг заасан нь өнөө үеийн төрийн албаны ангилал лугаа адил болой. Ийнхүү Арван буянт номын цагаан түүх бол төрийн тогтолцоо, эрх үүргийн хуваарь, төрийн албан хаагчдын шинж чанар, төрийн үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээ, үзэл суртлыг яруу тодорхой тусгасан Үндсэн хууль маягийн хууль байжээ. (А.Ц)

АРВАН ТАВНЫ ЦАГДАА (*Peace-keeping police*) 1911 оноос Богд Жавзандамбын лүндэнгийн дагуу Нийслэл хүрээнд хэв журам сахиулах үүрэг бүхий цагдаа нарыг ажиллуулах болжээ. Захын эргүүлийн цагдаа морьтой, харин дотор эргүүлийн цагдаа явган явдаг байжээ. Нийслэл хүрээний нутаг дэвсгэрийг 15 хувааж цагдаа нарт тодорхой нутаг дэвсгэрийг хариуцуулсан учраас арван тавны цагдаа хэмээн нэрлэсэн ба хожим “амгаланг сахиулах цагдаа” хэмээн нэрлэх болжээ. 1916 онд морьт болон явган цагдааг нэгтгэн “Нийслэл хүрээний цагдан сэргийлэх албаны газар”-ыг байгуулан тус газрын 27 зүйл бүхий дүрмийг батлан мөрдүүлсэн байна. (А.Ц)

АРГА БИЛГИЙН ЁС (*The principle of method and wisdom*) Хорвоо ертөнцийн тогтолцоо, хүний үйлдэхүйн ёсны зарчмыг тодорхойлсон дорно дахины сургаал. Даосын номлолоос эхтэй хэмээн үздэг энэхүү ёс нь дорно дахины ард түмний дунд ихэд дэлгэрч, бусад сургаал номлолын агуулгад ч багтсан. Монголчууд энэ номлолыг

өөриймшүүлэн оюун санааныхаа нэг үндэс болгож иржээ. Монголчуудын дунд дэлгэрч, нэг ёсондоо төр барих ухааны сурах бичиг болсон Оюун түлхүүр, Чингисийн билиг гэх мэт сургаал зохиолуудад арга билгийн ёсыг баримтлахын чухлыг ямагт тэмдэглэж иржээ. Инжиннаши “энэ хорвоогийн түг түмэн хэрэг үйлсийн сайн муу хэмээгч ертөнцийн арга билгийн хоёр амьсгал мэт толгой сүүл залгагдсан буюу” хэмээгээд мэргэний туйл мунхаг, мунхагийн туйл мэргэн хэмээжээ. Ийнхүү хорвоогийн аливаа юм эсрэг тэсрэг боловч өөр хоорондоо нягт холбоотой бөгөөд байраа солин хувьсан өөрчлөгдөж байдаг ажээ. Ч.Дэмчигдорж арга билгийг дагаж нам болно, билиг аргыг дагаж хөдлөнг болно хэмээн бичсэн нь билиггүйгээр арга, аргагүйгээр билиг оршихгүй, чухамхүү арга билгийн холбоонд юмс оршин тогтнож, хөдлөн хувьсдгыг илэрхийлжээ. Үүнээс үзвэл төр захиргааны бодлого, үйл ажиллагаанд даяарших дангааршихийг хослон, уламжлалт бодлого арга барил, гадаадын номлол, арга хэрэгслийг хэрэглэхдээ арга билгийн ёсоор хандах нь зүйтэй. (А.Ц)

АРД ТҮМНИЙ ЗАСАГЛАЛ (Public governance) “Public” гэдэг нь Латины “publicus” гэсэн үгнээс үндэстэй. Үгийн утга нь “ард иргэд, төр улс, (of the people, of the state)” гэсэн агуулгыг илэрхийлдэг¹⁵. Засаглал (governance) гэдэг нь XIII зууны сүүлээс “kubernáo” буюу ‘залуурдах, жолоодох’ гэсэн утгатай грек үгнээс анх үүсэж латин болон бусад хэлэнд шилжсэн байна¹⁶. Энэ хоёр үгийн нийлэмж нь төр улсыг ард түмэн засаглах гэсэн санааг илтгэдэг. Ард түмний засаглал нь аливаа улсын иргэд нэгэн хүй элгэн

болж хамтаараа амьдарч байгаагийн хувьд тэдний үнэт зүйлийг эрхэмлэн төрийн үйл хэргийг эрхлэх, засан төвхнүүлэх үйл ажиллагаатай холбогдож байна. Өөрөөр хэлбэл, энэ нь өөрчлөгдөж буй орчин нөхцөлд тухайн улсын Үндсэн хуулийн үнэт зүйлийг хадгалах, хамгаалах үүднээс ардиргэдийн шийдвэр хэрхэн гарч, ард түмний үйл хэрэг хэрхэн явагдахыг тодорхойлдог зохицуулалтын хэлбэр юм. Ард түмний засаглалын үзэл санаа нь иргэд болон оролцогч талуудын хүсэн хүлээж байгаа сайн үр дүнд хүрэхийн тулд байгууллагууд (оролцогч талууд) өөр хоорондоо хэрхэн харилцаж хамтран ажиллаж байгааг чухалчлан үздэг. (Т.Т)

АРД/ОЛОН ТҮМНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ (Public value) “Value” гэдэг нь Латины “valere” гэх үгнээс үндэстэй. Үгийн утга нь “хүчтэй байх, сайхан байх, үнэ цэнэтэй байх (be strong, be well, be worth)” гэсэн санааг илэрхийлдэг. XIV зууны сүүлээр энэ үг нь “ямар нэг ачтай/буянт үйл” гэсэн утгыг илэрхийлж байв. Үгийн ерөнхий утгыг үзвэл “value” гэдэг нь “ямар нэг юмны утга учир, чухал хэрэгцээт чанар”-ыг илэрхийлж байна. Монгол хэлнээ “value” гэдгийг эрхэмлэх “үнэт зүйл” гэсэн утгаар орчуулан хэрэглэдэг. Харин “Public” гэдэг нь “нэгдмэл цул, ард түмэн” гэсэн утгаар тайлбарлагддаг. Үгийн нийлэмжийг үзвэл ард түмний эрхэмлэх үнэт зүйлийн тухай агуулга илэрхийлэгдэж байна. Төрийн захиргаанд 2000-аад оноос үнэт зүйлийн хүчин зүйлийг харгалзан үзэх талаар зарим эрэл хайгуул хийгдэж тодорхой үзэл баримтлал ч боловсрогджээ. Үүний эхлэлийг 1995 онд Харвардын Их сургуулийн профессор Марк Моор тавьсан байдаг. Тэрээр “ард түмний үнэт зүйлийн

¹⁵ Public (adj.). (n.d.). Retrieved from <https://www.etymonline.com/word/public>


¹⁶ <https://www.etymonline.com/word/govern>

онол” (The Theory of Public value)-ыг үндэслэгч бөгөөд ард түмний үнэт зүйл гэдгийг “хувь эзэмшигчид / үр шимийг хүртэгсэд/-ийн үнэт зүйлийн нэгдмэл /ижил төсөөтэй/ байдалтай” (it as the equivalent of shareholder value in public management) холбон тайлбарлажээ. Энэхүү “үзэл баримтлал нь тухайн байгууллага, үйлдвэр, аж ахуйн газарт ажиллагчид үнэт зүйлийг хамтран бүтээж, улмаар түүнийхээ хувь эзэмшигчид, үр нөлөө ашигийг хүртэгсэд байснаар улсын салбарын менежментийн ажил хэрэгч, овсгоотой байдлыг дээшлүүлж, улмаар нийт нийгмийн хөгжилд, олон түмний төлөөх буянт үйлсэд эерэг нөлөө үзүүлнэ гэж үздэг” (Я.Долгоржав). Гэхдээ үнэт зүйл нь тодорхой түвшинд хуваагддаг, түвшин тус бүрийн хувьд эрхэмлэх үнэт зүйлс нь өөр өөр байдаг. Учир нь хүмүүс нэгдэн хүй элгэн болж нийгэмшин амьдарч байгаагийн хувьд нэгдмэл, зорилго, үнэт зүйлстэй байх шаардлага гарч ирдэг. Ард түмний үнэт зүйлсийг тодорхойлох, бүтээх үйл явц нь ардчилсан нийгмийн хувьд ард түмэн өөрсдөө үнэт зүйлээ тодорхойлж, түүнийг нь төр, захиргааны байгууллагууд хууль тогтоомж, дүрэм журам, үйлчилгээ болон бусад үйл ажиллагаагаар дамжуулын бүтээн бий болгодог онцлогтой. Энэ нь төрийн албыг төрийн гүйцэтгэх ёстой функц руу илүү ойртуулан шинэтгэх, ингэхдээ төрийн алба, нийгмийг харилцаа, хамтын ажиллагаа, харилцан ойлголцол, итгэлцлийг бий болгох замаар манлайлах явдал юм (Т.Т).

АРД ТҮМНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ БҮТЭЭХ (*Creating public value*) “Creating” гэдэг үгийн үндэс нь “create” буюу латины “creatus” (XV зуун) гэх үгнээс үндэстэй. Үгийн утга нь “бүтээх, бий

болгох” гэсэн санааг илэрхийлдэг. Монгол хэлнээ бүтээх гэдэг нь “аливаа зүйлийг бэлэн болгох, байгуулах, биелүүлэх” гэсэн санааг илэрхийлдэг тул ард түмний үнэт зүйлийг бүтээх гэсэн утга илүү тохиромжтой. Харвардын их сургуулийн профессор Марк Н.Мооре (1995) ард түмний үнэт зүйлийг бүтээх үйл явцыг “стратегийн гурвалжин” гэсэн зураглалаар тайлбарласан. Стратегийн гурвалжин нь ард түмний үнэт зүйл (public value), хууль ёсны байдал (legitimacy), үйл ажиллагааны чадавх (operational capacity) гэсэн гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг. Төрийн байгууллага, менежер, ард түмний үнэт зүйлийг бий болгохдоо эдгээр гурван зүйлийн хоорондын зохицол, уялдаа холбоог анхаарч ажиллах шаардлага бий болдог. Төрийн байгууллага нь энэхүү гурван талт харилцаа (*нэгд*, улс оронд хэрэгтэй гэдгийг нотлох, ард иргэдэд хүрэх - гадагш чиглэсэн, *хоёрт*, улс төрийн хувьд тогтвортой, хууль ёсны байдлаа хадгалах – гадагш чиглэсэн, *гуравт*, байгууллагын чадавхыг илэрхийлэхдотогш чиглэсэн) чухалчилсан. Харин ард түмний үнэт зүйл бий болсон эсэхийг иргэдийн нийтлэг хэрэгцээ хангагдсан эсвэл төлөвлөсөн үр дүнд хүрсэн байдлаар иргэдийн сэтгэл ханамжийн түвшингээр тодорхойлох боломжтой. Ард түмний үнэт зүйл нь иргэд (нийгмийн хэрэгцээ шаардлага)-ээр тодорхойлогдож, төрийн байгууллагын нийгэмд гүйцэтгэж байгаа үүрэг, оруулсан хувь нэмрээр бий болдог байна.

Гэхдээ тухайн нийгмийн үр дүн нь олон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байх учиртай. Ард түмний үнэт зүйлийг бүтээх үйл явц нь 1) төрийн байгууллагын аливаа үйл ажиллагаа нь иргэдийн хэрэгцээ,

The Strategic Triangle

шаардлагад нийцэж буй эсэх, 2) тэрхүү үйл ажиллагааны үр дүн нийгэмд эерэг өөрчлөлт авчирсан эсэх, 3) нийгэмд бий болсон өөрчлөлт нь иргэдийн хүлээлтэд нийцсэн, 4) иргэдийн төрд итгэх итгэл нэмэгдсэн эсэхээр тодорхойлогддог. Товчоор: ард түмний үнэт зүйл хэрхэн бий болсныг төр засгийн үйл ажиллагаанд иргэд хэр зэрэг сэтгэл ханамжтай, төрд итгэх иргэдийн итгэлийн түвшин нь ямар байгаагаар тодорхойлдог ажээ. Учир нь төр, захиргааны ажилтнуудын эрхэмлэдэг үнэт зүйлс нь тэдний боловсруулж, хэрэгжүүлдэг бодлого, хөтөлбөрүүдэд нь тусгалаа олдог. Үнэт зүйл нь тухайн бие хүний онцлог, эсвэл хэсэг бүлгийн тодорхойлогч шинж чанарыг илтгэж шууд ба шууд бусаар илэрлээ олдог ойлголт бөгөөд үйл ажиллагааныхаа арга маяг, хэрэгсэл, зорилгыг сонгон авахад нөлөөлдөг. (Т.Т)

АРД ТҮМЭН/ТӨР (Public) “Public” гэдэг нь Латины “publicus” буюу “хоёроос дээш хүн, бүлэг хүмүүс, төр засагтай холбоотой үйл ажиллагаа” гэсэн үгнээс үндэстэй. Үгийн утга нь “ард иргэд, төр улс, (of the people, of the state)” гэсэн агуулгыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, энэ үг нь бүгд,

нэгдмэл цул, ард түмэн, тодорхой улс оронд оршин суугаа ард түмэн гэсэн агуулгыг илэрхийлдэг. Ард түмэн улс төрийн болоод засаглалын эрх мэдлээ хэрэгжүүлэх зохион байгуулалтыг төр гэдэг. Энэ утгаараа ард түмэн өөрөө төр мөн юм. (Т.Т)

АРДЧИЛАЛ (Democracy) Ардчилал нь “demos” буюу ард түмэн, “kratos” буюу засаг гэсэн эртний Грек үгнээс гаралтай. Ардчилал нь ард түмний буюу олонхын засаглалд суурилсан улс төрийн дэглэм бөгөөд цөөнхийн дарангуй дэглэмээс ялгаатай. АНУ-ын 16 дахь Ерөнхийлөгч Абрахам Линкольн “Ардчилал бол ард түмний, ард түмнээс сонгогдсон, ард түмний төлөө ажилладаг төрийн хэлбэр” гэж тодорхойлсон. Ардчилал анх эртний Грекийн хот улсуудад МЭӨ 600-500 оны үед үүссэн бөгөөд төрийн олон хэлбэрээс Афины ардчилал хамгийн алдартай нь байв. Тухайн үед цэргийн бэлтгэл хийсэн эрчүүд санал өгөх эрхтэй байв. Ардчиллын түүх бол иргэд төр засагтаа өөрсдийн үзэл бодол, ашиг сонирхол, үнэлэмжийг илэрхийлж, түүнд шахалт үзүүлэх хууль ёсны эсвэл хуулиас гадуурх арга замуудыг боловсруулж, хэрэглэж ирсэн тухай юм. 1215 онд Английн язгууртнууд эзэн хааныг “Магна Карта” хэмээх алдарт баримт бичигт хүчээр гарын үсэг зуруулж чаджээ. Ингэснээр эзэн хаан бусадтай адил хуульд захирагдах болсноор үндсэн хуульт ардчиллын эх үндэс тавигдсан байна. Орчин үед эртний Грект байсан шууд ардчиллын зарим нэг шинж хадгалагдаж үлджээ. Тухайлбал, Швейцарын Кантонуудад (муж) 1848 оноос хойш бүх нийтийн санал асуулгын (референдум) хэлбэртэй шууд ардчилал тогтсон бөгөөд одоо ч цөөн кантон энэ уламжлалаа хадгалсаар байна. Ардчиллын үндсэн

шинжүүд нь 1) ард түмэн төрийн засаглалын үйл ажиллагаанд шууд (жишээлбэл: нийгмийн амьдралын чухал асуудлаар референдум явуулахад оролцож саналаа өгөх) болон төлөөллийн ардчиллын замаар (ард түмэн засгийн эрхийг өөрсдийн төлөөллөөр дамжуулж хэрэгжүүлдэг) оролцдог байх, 2) асуудлыг олонхын саналыг үндэслэж цөөнхийн үзэл бодлыг хүндэтгэн шийдвэрлэх, 3) төрийн удирдлагын төвийн болон орон нутгийн байгууллагууд нь сонгуулийн замаар байгуулагдаж, халагдан солигддог, сонгогчдын өмнө хариуцлага хүлээдэг байх, 4) ард түмэн төр, засгийн газрыг хүлээн зөвшөөрдөг буюу төрийн засаглалын легитим байдал хангагдсан байх, 5) зөвшилцөх, эвлэрүүлэх, итгүүлэн үнэмшүүлэх аргуудыг түлхүү хэрэглэж хүчирхийлэл, албадлагын аргаас зайлсхийдэг, 6) иргэний болон хүний эрх, эрх чөлөөг бодитойгоор хэрэгжүүлж хамгаалдаг байх, 7) улс төрийн олон ургалч үзэл төлөвшсөн, олон намын систем, чөлөөт өрсөлдөөн хангагдсан, 8) олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь хөндлөнгийн хяналт, шахалтаас ангид оршдог, 9) засаглал хуваарилах зарчим бодитой үйлчилдэг байх. Эдгээр шинжүүд ардчиллыг дарангуйллаас ялгадаг байна. Ардчилал нь хүн төрөлхтний түүхийн явцад хувьсан өөрчлөгдсөөр ирсэн боловч үндсэн суурь шинжээ алдаагүй байна. 2021 оны Freedom house-ийн ардчиллын үнэлгээгээр дэлхий дээр эрх чөлөөтэй, ардчилсан 82, хагас эрх чөлөөтэй 59, эрх чөлөөгүй 54 орон байна. Сүүлийн жилүүдэд эрх чөлөө ухарч, дарангуйлал байр сууриа ахиулж, хагас ардчилсан дэглэмүүд байраа хадгалах төлөв байдалтай байна¹⁷.

Тус судалгаагаар 1 оноо авсан бол хамгийн ардчилсан, 7 оноо авсан бол дарангуй дэглэмтэй гэсэн үнэлгээг өгдөг. Монгол Улс ардчиллын үнэлгээгээр 1990 он хүртэл 7 оноо авч эрх чөлөөгүй гэсэн ангилалд багтаж иржээ. 1990-1991 онд 4 оноо авч хагас эрх чөлөөтэй, түүнээс хойш тогтмол 2-2.5 оноо, 2003 оноос 2 оноо авах болсон байна. (Ж.Ж)

АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛ (*Democratic governance*)

Ардчилсан засаглал нь ил тод, хариуцлагатай байдгаараа бусад засаглалын хэлбэрээс онцлогтой. Иргэдийн оролцоог хангасан нээлттэй засаглалын үйл явц нь илүү шударга, сайн төрийн бодлого гарах нэг үндэс бөгөөд бодлогын үйл явц нь иргэдийн санаа бодол, ардчилсан үнэт зүйлсийг тусгадаг. Ардчилал нь сонгогдсон улс төрчид бодлого боловсруулж, тухайн бодлогыг төрийн албан хаагчид хэрэгжүүлэх үйл явцтай нягт холбоотой. Төрийн албан хаагчид нь сонгогдсон улс төрчдийн өмнө, улс төрчид нь сонгогчдын өмнө хариуцлага хүлээнэ. Энэхүү хариуцлагын тогтолцоо орчин үеийн нийгэмд алдагдах болсноор ардчилсан засаглал, сайн засаглалын тухай асуудал гарч ирсэн түүхтэй. Ардчилсан засаглал нь дотроо олон хэлбэр, загвартай. Тухайлбал: ардчилалд шууд, төлөөллийн, либерал, сонгуулийн, зөвлөлдөх, олон ургалч, үндсэн хууль, эдийн засгийн, бүгд найрамдах, зөвшилцлийн, шашны зэрэг ардчиллын төрлүүд багтана. Ардчилсан засаглал тухайн улс оронд төлөвшин хөгжихөд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглал болон улс төрийн нам, сонирхлын бүлгүүд, хэвлэл мэдээлэл чухал нөлөөтэй. Хууль тогтоох байгууллага нь иргэдийг төлөөлөх, хууль батлах, гүйцэтгэх засаглалд

17 Freedom in the World 2021: Democracy under siege. Freedom house. 2021, p. 4.

хяналт тавих үүргээ ил тод нээлттэй хэрэгжүүлэх ёстой. Гүйцэтгэх засаглалын үндсэн чиг үүрэг нь төрийн бодлогыг тодорхойлж, түүний хэрэгжилтийг хангах бөгөөд төрийн захиргааны үйл ажиллагаанд хяналт тавьж, хариуцлага хүлээж ажиллана. Шүүх засаглал нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж, хараат бус, гагцхүү хуульд захирагдана. Чөлөөт ардчилсан хэвлэл мэдээлэл нь орчин үеийн эрчимтэй даяаршиж буй нийгэмд чухал үүрэг гүйцэтгэн иргэдийг мэдээллээр хангахаас гадна, боловсрол, танин мэдэхүй, төрийн байгууллагуудыг хянах, “хоточ нохойн” үүрэг гүйцэтгэдэг. Улс төрийн намууд нь улс төрийн нийгэмшилт, иргэдийн оролцоог хангаж, тэдний ашиг сонирхлыг нэгтгэн илэрхийлэх, сонгуульд оролцох, ялсан тохиолдолд улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлох, ялагдвал сөрөг хүчний үүрэг гүйцэтгэн эрх баригч намд хяналт тавих зэрэг өргөн хүрээтэй үүрэг гүйцэтгэдэг. Ардчилсан засаглалын хамгийн чухал бүрэлдэхүүн хэсгийн нэг нь улс төрийн оролцоо юм. Улс төрийн оролцоо нь ардчилсан түвшинг тодорхойлох гол шалгуур болно. Оролцоо нь янз бүрийн хэлбэртэйгээр илрэх бөгөөд хууль ёсны оролцоонд сонгуульд санал өгөх, төрийн албан хаагчтай уулзаж холбогдох, жагсаал цуглаанд оролцох зэрэг үйл ажиллагаа багтах бол хууль бус оролцоонд террорист халдлага зэрэг болно. (Ж.Ж)

АРДЧИЛСАН ТӨВЛӨН УДИРДАХ ЁС (*Democratic centralism*) Төр, олон нийтийн байгууллагуудын зохион байгуулалт, удирдлагын зарчим. Бүх байгууллагууд доороос дээш сонгогдон байгуулагдах, доод байгууллага нь дээд байгууллагадаа

захирагдах, тухайн шатны сонгож байгуулсан байгууллагадаа болон дээд байгууллагадаа тайлагнах нь ардчилсан төвлөн удирдах зарчмын агуулга юм. Энэхүү зарчим нь доод шатны байгууллагын бие даасан байдлыг алдагдуулж эрх мэдлийг дээд байгууллагад төвлөрүүлнэ. (А.Ц)

АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРАЛ (*Khural of people's deputies*)

Ассамблейн хэв маягийн улс төрийн тогтолцооны монгол хувилбар буюу АДХ нь Үндсэн хуулийн дагуу аймаг, сум, хороодын эрх барих дээд байгууллага байв. Нам ба нам бусчуудын эвслээс нэр дэвшигдсэн хэмээн үздэг нэг хүний нэрийг тойрог бүрд дэвшүүлэн хоёр жилийн хугацаатай сонгогддог депутатуудаас бүрдэнэ. Нэр дэвших хүнийг намын байгууллагаас судлан тухайн шатны удирдах ажилтнуудаас гадна ажлаараа шалгарсан ажилчин малчин, сэхээтнүүдийн нэрийг дэвшүүлдэг байв. Улс ардын аж ахуйн салбаруудын төлөөлөл, эмэгтэйчүүд болон залуучуудыг заавал оролцуулдаг байв. АДХ нь тухайн шатны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагыг байгуулах, тайланг нь сонсох, жил жилийн төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийг хэлэлцэхээс гадна нийгмийн амьдралын олон талт асуудлуудыг хэлэлцэнэ. Депутатуудыг эгүүлэн татах заалт Үндсэн хуульд тусгагдсан байв. (А.Ц)

АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА (*Executive administration of Khural of people's deputies*)

Ардн депутатуудын хурлын гүйцэтгэх байгууллага. Ардын хувьсгалын эхний жилүүдэд Аймгийн яам хэмээн нэрлэдэг байжээ. АДХ-аас дарга, орлогч дарга, хариуцлагатай нарийн бичгийн даргыг оролцуулан

аймагт 7-11, сум, хороонд 5-9 хүний гишүүний бүрэлдэхүүнтэй сонгоно. Бодит амьдралд захиргааны даргыг аймгийн намын хороо (сум, хорооны), НТХ (аймаг, хотын) томилж, АДХ-аар ёсчлон баталдаг байв. БНМАУ-ын үед АДХГЗ-ны дарга нь тухайн сумд байгаа ХАА-ийн нэгдлийн даргаар хавсран ажилладаг байв. Тиймээс сум, нэгдлийн дарга хэмээн нэрлэж байжээ. (А.Ц)

АРДЫН ТҮР ЗАСГИЙН ГАЗАР (*People Provisional Government*) 1921 оны 3-р сарын 13-нд Д.Сүхбаатар, Х.Чойбалсан нар болон цэргийн анги ба хошуу, шавийн төлөөлөгч бусад хүмүүс оролцон хуралдаж Монгол ардын засгийн хэргийг бүгд түр ерөнхийлөн захирах газар буюу Ардын түр засгийн газрыг байгуулсан. Мөн оны 4-р сарын 23-нд түр засгийн газрын дүрмийг баталжээ. Улмаар 1921 оны 7-р сарын зургаанд таван яамны сайд, эрхэлсэн түшмэл, засгийн газрын зөвлөх нар хуралдаж “түр” гэдэг үгийг хасаж Ардын засгийн газар гэж нэрлэхээр тогтжээ. Хэдийгээр улсын хурал байгуулах хүртэл анхны нэрээрээ байх нь зүйтэй гэж үзэж байсан боловч зарим хүмүүс “түр” гэдэг үгийг батгүй, түр зуур оршин тогтноод мөхөх гэсэн агуулгатай мэтээр ойлгох болсон тул ийнхүү Улсын хурлаас өмнө нэрийг өөрчилсөн ажээ. (А.Ц)

АРДЫН ХЯНАН ШАЛГАХ БАЙГУУЛЛАГА (*People's inspection authority*) МАХН-ын Төв хорооны 1972 оны 3-р бүгд хурлаас тогтоол гаргаж, нам, улс, олон нийтийн хянан шалгах байгууллагын үндсэн дээр хяналт шалгалтын нэгдсэн систем буй болгох шийдвэр гаргажээ. Уг тогтоолд “... төрийн үйл хэргийг удирдах, аж ахуй соёлын байгуулалтын явцыг

хянан шалгахад хөдөлмөрчин олон түмнийг өргөн оролцуулах, тус орны нийгмийн амьдралд хяналт шалгалтын үүргийг дээшлүүлэх, социалист өмчийг бэхжүүлэхийн төлөө тэмцлийг хүчтэй болгох, улс олон нийтийн хяналт шалгалтыг зөв хослуулах” хэмээн уг байгууллагын зорилгыг тодорхойлжээ. Уг шийдвэрийн дагуу Ардын их хурлаар Үндсэн хуульд өөрчлөлт оруулж “Ардын хянан шалгах байгууллагын тогтолцоог буй болгожээ. БНМАУ-ын, аймаг, сумын ардын хянан шалгах хороо, үйлдвэр аж ахуйн газруудад ардын хянан шалгах групп, постууд байгуулагдсан. Эдгээр байгууллагууд өмч хөрөнгийн зарцуулалт, төлөвлөгөөний биелэлт, бүтээгдэхүүний чанар гэх мэт олон асуудлаар хяналт шалгалт явуулж байв. Ардын хянан шалгах байгууллагын гишүүнээр ажилчин, малчин, сэхээтэн, гэрийн ажилтай хүмүүс, оюутан сурагчид ч ажиллаж байжээ. (А.Ц)

АРДЫН ЭРХТЭЙ ХЭМЖЭЭТ ЦААЗАТ МОНГОЛ УЛСЫН ХУРАЛ (*State Khural of Mongolia with people's sovereignty and limited Royal power*) 1921 онд Ардын засаг байгуулагдсаны дараа хуучны хамжлагат ёсыг халж, Монгол Улсын төрийн тогтолцоог ардчилах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нэг нь энэхүү дүрэм юм. Уг дүрмийг гаргахаас өмнө 1921 оны 9-р сарын 20-нд Улсын түр цагийн хурлыг зөвлөх эрхтэйгээр байгуулж дүрмийг нь баталсан. Уг хуралд яамны тэргүүн ба дэд сайдууд, эрхэлсэн түшмэд, аймаг, шавь, цэрэг ба залуучуудын төлөөлөгчид хуралдаж Засгийн газарт зөвлөх үүрэгтэй байв. Улмаар 1923 оны 10-р сарын 5-нд Ардын эрхтэй хэмжээт цаазат Монгол Улсын хурлын дүрмийг баталж

Сонгуулийн журмаар байгуулагдах анхны хурлыг буй болгов. Дүрмийн 2-р зүйлд тус хурал нь Ардын эрхтэй хэмжээт цаазат Монгол Улсын дээд эрхийг хадгалах газар болно хэмээн заажээ. Хурал байнгын болон цаг зуурын байхаар тогтоосон байна. Хурал намрын сүүл сарын шинийн нэгнээс эхлэн нэг сар хуралдаж, шаардлагатай бол дахин нэг сараар сунган хуралдаж байхаар дүрэмд заажээ. (А.Ц)

АРХИВ (Archive) Аливаа мэдээллийн хэрэгслээр хадгалагдсан түүхэн тэмдэглэлүүдийн цуглуулга эсвэл хувь хүн, байгууллагын амьдралын туршид хуримтлагдсан чиг үүргийг илтгэх харуулах үүднээс хадгалагдаж ирсэн анхан шатны эх баримтыг агуулагч юм. Иймээс өмнө дурдсан баримтыг хүлээн авах, бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах, хяналт тавих, ашиглуулах үүрэг бүхий байгууллага эсвэл байгууллагын зохион байгуулалтын нэгж байж болно. (Г.Б)

АУДИТ (Audit) Аудит нь (англ. “номын шалгалт, тооцооны шалгалт”; лат. *auditus*= сонсох) нь тухайн тодорхой үйл явцад тавигдсан шаардлага болон шаардсан стандартыг биелүүлж байгаа эсэхийг шинжлэх буюу шалгах үйл ажиллагаа. Аудит нь гаргасан шийдвэрүүд тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах үйл ажиллагаа бөгөөд эрэлт хэрэгцээнд тулгуурлан хийгддэг. Энэ утгаараа аудит нь эдийн засгийн үйл ажиллагаа, эрэлт хэрэгцээний асуудал бөгөөд эрх мэдлийн хуваарилалтаар дамжуулан итгэмжлэгдсэн төлөөлөгч байдлаар олон нийтийг өмгөөлөн хамгаалах эрх мэдлийг хэрэгжүүлэх, сонирхогч талууд тодорхой нөхцөл бүхий өөрсдийн капиталыг хянах,

зээлийн байгууллагууд хөрөнгийн үр өгөөжийг хянах, компанийн удирдлага өмнөх гүйцэтгэлтэй уялдуулан ирээдүйг үр ашиг, үр нөлөөтэй төлөвлөх боломжуудыг олгодог. Аудит нь төрийн байгууллага болон хувийн байгууллагын аль алиных нь хувьд хяналт хийх арга юм.¹⁸ (А.Э)

АУТСОРСИНГ (Outsourcing) Энэ нь “Outsource”¹⁹ буюу Монголоор “гадагш чиглэсэн эх сурвалж” хэмээх үгийн нийлэмж. Байгууллагын үйл ажиллагаанд хэрэгцээ шаардлагатай ямар нэгэн ажлыг тухайн ажлыг хийж мэргэшсэн өөр байгууллагаар гүйцэтгүүлэхийг аутсорсинг гэнэ. Өөрөөр хэлбэл төрийн байгууллагын өмнөөс ажил гүйцэтгэх өөр нэгэн этгээдийг (хувийн байгууллага, төрийн бус байгууллага, эсвэл өөр төрийн байгууллага) тухайн байгууллага гэрээ хийн хөлсөөр ажиллуулах утгыг илэрхийлнэ²⁰. Аутсорсингийн өөрөөр гадагш гэрээлэх (contracting out)²¹ гэж мөн нэрлэнэ. Аутсорсингийн харилцаанд оролцож буй талуудын хооронд гэрээ хийгдэх бөгөөд талууд аль аль нь ашиг тус хүртэхийг эрмэлзэнэ. Олон улсын туршлагаас төрийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх чиглэлээр тухайлбал цэвэрлэгээ, хог хаягдлыг зайлуулах үйлчилгээ гэх зэрэг, цаашилаад үндсэн бус туслах чанартай мэдээллийн технологийн болон хуулийн үйлчилгээ гэх мэт үйлчилгээг гадагш гэрээлэх болсон байна²². (М.А)

18 Төрийн аудитын онолын хүрээ Дэд проф. Доктор Мехмет Алпертунг Авчи

19 Online etymology dictionary, <https://www.etymonline.com/search?q=outsource>, retrieved by 2021.04.08.

20 John Alford, Janine O'Flynn, “Rethinking Public Service Delivery”, pp. 84-85.

21 John Alford, Janine O'Flynn, “Rethinking Public Service Delivery”, p. 20.

22 John Alford, Janine O'Flynn, “Rethinking Public Service Delivery”, p. 86.

тушаалтнаас үүргээ гүйцэтгэхэд албан болон хувийн сонирхол зөрчилдөх буюу төрийн албан хаагчийн хувийн сонирхол нь албан үүргээ гүйцэтгэхэд нь харшаар нөлөөлөх нөхцөлийг хэлнэ²⁶. Ашиг сонирхлын зөрчлийг судлаачид авлига, авлига бий болох эрсдэл гэж үздэг²⁷ ба төрийн байгууллага үйл ажиллагаагаа иргэдийн нийтийн эрх ашигт чиглүүлснээр ашиг сонирхлын зөрчлөөс ангид оршино. Ашиг сонирхлын зөрчил нь бодит, ойлгогдохуйц, болзошгүй хэлбэртэй байна.

Бодит: Аливаа албан тушаалтан албан үүргээ хэрэгжүүлэхэд хувийн ашиг сонирхол нь хангалттай хэмжээнд зүй бусаар нөлөөлж буй нөхцөл байдал оршин байна.

Ойлгогдохуйц: Мэдээлэл бүхий иргэд ашиг сонирхлын зөрчил үүссэн гэж үнэмшүүлэх нөхцөл байдал бий болгосон үед энэ хэлбэрийн ашиг сонирхлын зөрчил бий болно.

Болзошгүй: Ашиг сонирхлын зөрчил бодитоор үүсээгүй боловч ирээдүйд бодит зөрчилд хүргэж болзошгүй нөхцөл байдлын үед болзошгүй ашиг сонирхлын зөрчил үүснэ.

Урьдчилан сэргийлэх, зохицуулах, хянах байдлаар ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлнэ. (Г.Б)

АЮУЛГҮЙ БАЙДАЛД УЧРАХ ХАЛДЛАГА (*Security attack*)

Мэдээллийг өөрчлөх, зөвшөөрөлгүй цуглуулах, системд зөвшөөрөлгүй хандах, компьютерын дэд бүтцийг зөвшөөрөлгүй ашиглах, удирдах зэрэг бүхий л хөнөөлт үйлдэл. Халдлага нь идэвхтэй эсвэл эсвэл идэвхгүй

хэлбэртэй. Идэвхтэй халдлага нь системийн нөөцийг өөрчлөх эсвэл түүний үйл ажиллагаанд нөлөөлөхийг оролддог. Идэвхгүй халдлага нь системд өөрчлөлт оруулахгүйгээр системийн мэдээллийн тухай мэдэх, ашиглах оролдлого. Сүүлийн жилүүдэд хөнөөлт халдлагын тоо эрс өсөж цахим гэмт хэрэг гэж үзэх болсон. (Д.З; Ч.Л нар)

²⁶ Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, Төрийн албан дахь сонирхлын зөрчлийн менежмент: Гарын авлага, 2007.

²⁷ Д.Цэцэгмаа: “Төрийн албан дахь сонирхлын зөрчил, түүнийг зохицуулах арга зам”, Улаанбаатар 2017, х. 94.

Б

БАГААР АЖИЛЛАХ ЧАДВАР *(Team working skills)*

Харьяалах байгууллага, албан тушаалын чиг үүргийг үр дүнтэй биелүүлэх, өөртөө болон бусад ажлын таатай орчныг бүрдүүлэх, нэг зорилгод хүрэхийн тулд бусадтай хамтран ажиллах үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх нөөцийг хэлнэ. Зөөлөн ур чадваруудын нэг болох “багаар ажиллах чадвар” ойлголт нь төрийн байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагчийн түвшинд хэрэглэгдэх бөгөөд удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны багийн ажиллагаа, эсвэл нэг чиг үүрэг бүхий нэгжийн гишүүдийн хоорондын багийн ажиллагаа, мөн нэг чиг үүргийн төрийн албан хаагч, өөр чиг үүргийн хэд хэдэн төрийн албан хаагчтай хамтран ажиллах хэлбэрээр нийтийн салбарт хэрэглэгдэнэ. Багаар ажиллах чадвар нь багийн хамтын ажиллагаанаас илүүтэй, нэг бүхэл болж, нэгдсэн зорилгод хүрэхэд бусдыгаа хэрхэн нэгтгэж, эсвэл хэрхэн нэгдэж чадаж байгаа нөөц бололцоо буюу багийн гишүүн болж ажиллах чадвараар илэрдэг. (Г.Б)

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ *(Environmental assessment)*

Байгаль орчны үнэлгээ (ЕА) нь төлөвлөсөн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх шийдвэр гаргахаас өмнө боловсруулсан

төлөвлөгөө, бодлого, хөтөлбөр, бодит төслүүдийн байгаль орчинд үзүүлэх үр дагаварт хийх үнэлгээ. "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ" (БОНБҮ) гэсэн нэр томъёог ихэвчлэн хувь хүмүүс, компаниуд бодит төслүүдэд ашигладаг. "Байгаль орчны стратегийн үнэлгээ" (SEA) нэр томъёог ихэвчлэн төрийн байгууллагуудын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдэд хэрэглэдэг. Байгаль орчны үнэлгээ нь төслийг батлах, шийдвэр гаргах баримтын нэг хэсгийг бүрдүүлдэг менежментийн хэрэгсэл бөгөөд байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар нөөц ашиглалт, бүс нутаг, салбарын хэмжээнд бодлого баримтлах, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулахад чухал үүрэгтэй. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд байгаль орчны стратегийн, төлөв байдлын, нөлөөллийн, хуримтлагдах зэрэг нөлөөллийн үнэлгээ багтана. Энэхүү үнэлгээг цацраг идэвхт болон бусад ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын төсөл, бусад шаардлагатай төсөлд зайлшгүй хийдэг. (Д.Ч)

БАЙГУУЛЛАГА БА ХЭРЭГЛЭГЧ ХООРОНДЫН ЦАХИМ ХАРИЛЦАА (*Business to Consumer (B2C) relations*)

Байгууллага үйлчлүүлэгч болон хэрэглэгчтэйгээ цахимаар харилцаж үйл ажиллагаа явуулах арга хэлбэр. Байгууллага хэрэглэгч хоорондын цахим харилцаа нь худалдааны загвар гэдгээр нийгэд танил болсон. Анхны санааг 1979 онд Майкл Алдрич (Michael Aldrich) телевизийг хэрэглэгчдэд хүрэх үндсэн сувгаа болгон хэрэгжүүлсэн. Улмаар 1990-ээд онд дотком (dotcom - үндсэн үйл ажиллагаагаа веб сайтаараа зохион байгуулдаг компани) компанийн тэсрэлтийн үед интернетийг ашиглан үйлчилгээгээ хүргэх, бүтээгдэхүүнээ зарах нь түгээмэл болжээ. В2С загварын шууд худалдаа, худалдааны онлайн зуучлал, сурталчилгаанд суурилсан үйлчилгээ, хураамжид суурилсан үйлчилгээ гэсэн таван нийтлэг ангилалтай. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага үйлчилгээгээ эсвэл бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд хүргэх, энэ талаар ажил хэргийн мэдээлэл солилцох үйл ажиллагааг цахим хэлбэрээр байгууллага ба хэрэглэгч хоорондын цахим харилцаа хэрэгжинэ. Харилцаа, үйлчилгээний энэ хэлбэр нь хоёр талын аль алинд нь цаг хугацаа, зардал, чирэгдлийг дээд зэргээр хэмнэж үр ашгаа өгдөг. (Д.З, Ч.Л нар)

БАЙГУУЛЛАГЫН АЛСЫН ХАРАА (*Organisation vision*)

Байгууллага алсдаа юуг хамгийн сайн хийх, ямар байгууллага байх тухай хэтийн төсөөлөл. Байгууллага бүрийн онцлогоос хамаарч 5-10 жил, ихэвчлэн 10 болон түүнээс дээш жилийн хугацаанд төсөөлдөг бөгөөд эрхэм зорилго, зорилго, зорилтыг тодорхойлох үндсэн баримт болдог. (С.Ц)

БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (*Organisational performance plan*)

Нэг жилийн хугацаанд байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэхээр тооцоолсон, хүлээгдэж буй үр дүн (гүйцэтгэлийн стандарт¹), түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг² тооцож тусгасан баримт бичиг. Энэхүү баримт бичиг нь байгууллагын стратегийн төлөвлөгөөнд үндэслэх бөгөөд стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болно. Монгол Улсын төрийн албанд 2002 оноос гарцад суурилсан гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэж, 2003 оноос төсвийн байгууллагын удирдлага дээд шатны төсөв захирагчтайгаа үр дүнгийн гэрээ байгуулж эхэлсэн. Уг гэрээний хавсралт нь тухайн байгууллагын нэг жилийн ажлын төлөвлөгөө (гүйцэтгэлийн төлөвлөгөө) байв. 2017 онд Монгол Улсын төрийн албаны тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаар 2019 оноос төрийн байгууллагууд “гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г (яг энэ нэрээр хуульд тусгагдан) нэг жилийн хугацаагаар боловсруулан батлан хэрэгжүүлэх болов³. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд гүйцэтгэлийн зорилт, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилт, арга хэмжээний биелэлтийг хэмжих шалгуур үзүүлэлт, түүний хүрэх түвшинг, хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн хамт тусгана. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө нь байгууллагын доторх зохион байгуулалтын нэгжийн болон албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үндэслэл болно. (М.А)

1 Зорилго, зорилгоор тодорхойлогдсон үр дүн.

2 Хүний, санхүүгийн гэх мэт нөөцүүд.

3 Төрийн албан тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2017, 55-р зүйл.

БАЙГУУЛЛАГЫН ДОТООД СҮЛЖЭЭ

(Local area network) Байгууллагын үйл ажиллагаа явуулах орон зайд хэрэглэгдэж байгаа компьютерүүдийг дотоодын мэдээлэл дамжуулах, солилцох зорилгоор нэгдсэн системд холбосон сүлжээ. Байгууллагын дотоод сүлжээ нь зөвхөн тухайн байгууллагын мэдээлэл солилцох болон дамжуулах хэрэгцээнд зориулагдсан тул өөрийн аюулгүй байдлын хамгаалалттай байдаг. Төрийн байгууллага нь дотоод сүлжээндээ мэдээллийн аюулгүй байдлын тусгай бодлого хэрэгжүүлэх шаардлагатай. (Д.З; Ч.Л нар)

БАЙГУУЛЛАГЫН ЗАН ҮЙЛ (Organizational behavior)

Байгууллага, менежмент дэх хүний зан үйл, үзэл бодол, ажил үүргээ гүйцэтгэх байдлыг ялангуяа, байгууллага дахь хүчин зүйлс хүний зан үйлд хэрхэн нөлөөлдөг, хүний зан үйл нь байгууллагад эргээд хэрхэн нөлөөлж буйг судалдаг ойлголт. Учир нь байгууллагын зан үйлийг судалснаар удирдагч өөрчлөлт, байгууллагын мөн

чанарыг онолын түвшинд зөв ойлгох, байгууллага дахь хүмүүс хоорондын харилцааны шинэ хандлагыг эзэмших, онолоор эзэмшсэн мэдлэг чадвараа амьдрал дээр оновчтой хэрэглэх мэдлэг, дадал, зохион байгуулалтын орчин бүрдэнэ. Л.Фред (Fred Luthans): байгууллагын зан үйл байгууллагын онол, байгууллагын хөгжил, хүний нөөцийн удирдлага хоорондын холбоо хамааралд үндэслэн байгууллага дахь хүмүүсийн зан үйлийн мөн чанар, агуулгыг гаргаж болно гэжээ. Байгууллагын зан үйл (organizational behavior)-ийг судлах нь хүмүүсийн зан үйлийг таних, урьдчилан таамаглаж сурах, удирдахад чиглэсэн мэдлэг. Байгууллагын зан үйлийн онолын үндсийг когнитив (танин мэдэхүйн), бихевиорист, нийгмийн хандлага гэсэн гурван хандлагаар тайлбарладаг. Когнитив хандлага нь хүний зан үйлийн эерэг, сайн дурын хүрээг авч үзэхдээ хүлээлт, хэрэгцээ, урамшуулал зэрэг ойлголтуудыг авч үзнэ. Энэ хандлагын гол зүйл болох танин мэдэхүй нь зан үйлийн өмнөх үе бөгөөд хүний сэтгэх

Зураг 1. Нийгмийн хандлагын бүтэц

Эх сурвалж: П.Уви, Б.Хэрлэн. Байгууллагын зан үйл. 2017, Улаанбаатар. х. 12.

дүрийг бий болгох, хүртэхүйн асуудлыг шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах үйл явцыг судална. Бихеворист хандлага нь И.Павлов, Джон Б.Уотсон нар: анх зан үйлийн ажиглагдаж байгаа хэлбэрийг судлах хэрэгтэй гэж үзэн хүний зан үйлийг С-Р гэсэн томьёогоор тайлбарлажээ. С буюу өдөөлт нь Р буюу хариу үйлдлийг шаарддаг байна. Нийгмийн суралцахуйн хандлага нь танин мэдэхүйн болон бихеворист хандлагыг нэгтгэн, хүн өөрийн ухамсартай, тэдний зан үйл нь зорилгод чиглэсэн хэмээн үздэг нь хүмүүс хүрээлэн байгаа орчноо таньж мэдэн, өөрчилж бүтээдэгтэй холбоотой. Л.Фред: байгууллагын гишүүн, байгууллагын зан үйл, байгууллагын орчин гэсэн харилцан хамаарал бүхий 3 ухагдахууныг авч үзсэн. Байгууллагын зан үйлийг судалсан эрдэмтэд хүмүүнлэгийн болон танин мэдэхүйн хандлагыг хэрэглэж ирсэн. Тухайлбал, 1960 онд хэвлүүлсэн “Байгууллагын хүний тал (The human Side of Enterptise)” номондоо Дуглас МакГрегор (D.McGeorgy) хүмүүнлэг талыг, Виктор Врум, Даймон Портер, Эдвин Локк нар байгууллагын зан үйлийн талаарх бүтээлээ гол төлөв танин мэдэхүйн хандлагад тулгуурласан. Сүүлийн үеийн судалгааны бүтээлүүдэд бихеворист хандлагыг түлхүү хэрэглэх болсон. Байгууллага дахь хүний зан үйлийг ойлгох нь байгууллага судлалын гол судлагдахуун. (Ц.Д)

БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛТУУД (*Organizational objectives*) Байгууллагын зорилгын биелэлтийг хангах үр дүнг тооцоолж тодорхой хугацаанд хэмжээн зорилтууд юм. Байгууллагын стратегийн зорилгын биелэлтийг хангахад хэд хэдэн зорилт биелүүлж ажиллах шаардлага үүсэж болох

бөгөөд үр дүн, цаг хугацааг нарийн тооцсон байх ёстой. (С.Ц)

БАЙГУУЛЛАГЫН НӨӨЦ ТӨЛӨВЛӨЛТ (*Enterprise Resource Planning (ERP)*)

Байгууллага төвлөрсөн өгөгдлийн сан үүсгэн үндсэн бүх үйл ажиллагаагаа нэгтгэн үр ашигтай удирдан зохион байгуулах программ хангамжийн цогц систем бүхий технологийн шийдэл. Байгууллагын нөөцийн төлөвлөлтийн товчилсон хэлбэр (ER-P)-ээр анх 1990-ээд онд Гартнер групп хэрэглэсэн. Эхлээд материал таталтын төлөвлөлт дараа нь үйлдвэрлэлийн нөөц төлөвлөлт хэлбэртэйгээр өргөжүүлсэн. Улмаар 1990-ээд оны дунд үеэс байгууллагын нөөц төлөвлөлтийн систем үйлдвэрлэгчид санхүү бүртгэл, засвар үйлчилгээ, хүний нөөцийн бүрэлдэхүүнийг багтаасан байгууллагын үндсэн үйл ажиллагаанд чиглэсэн цогц хэлбэрт шилжин төрийн болон төрийн бус байгууллагууд байгууллагын нөөц төлөвлөлтийн системийг хэрэглэж эхэлсэн. Төрийн алба, аж үйлдвэр, боловсрол, банк санхүү, үйлчилгээ зэрэг төрийн болон хувийн хэвшлийн олон салбарт хүний, мөнгө санхүүгийн, хөрөнгө материалын зэрэг гол хүчин зүйлүүдийн нөөцийг хамгийн үр ашигтай удирдан зохион байгуулахад туслах хэд хэдэн модулиас бүрдсэн хэрэглээний программ хангамжийн багц системтэй болох нь нийтлэг болж байна. Байгууллагын нөөцийг төлөвлөх тогтолцоо нь өгөгдлийн санд суурилсан нэгдмэл системийн хэлбэртэй байх бөгөөд үйл ажиллагааны цогц шинжилгээнд үндэслэсэн оновчтой шийдвэр гаргах нөхцөлийг хангах үндсэн зориулалттай байдаг. Энэхүү систем нь өөрийн дэд бүтцэд суурилсан болон үүлэн тооцооллын үйлчилгээнд суурилсан хэлбэртэй байдаг. (Д.З; Ч.Л нар)

БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОГЧ ТАЛУУД (*Organizational stakeholder*)

Байгууллагын үйл явц, түүний үр дүнг сонирхогч болон түүнд нөлөөлж болзошгүй хүмүүс, субъект. Байгууллагын оролцогч талууд: “бодлогын шийдвэр гаргахад оролцож байгаа болон түүний үр дүн, нөлөөнд өртөх хүмүүс, эсвэл сонирхлын бүлгүүд”⁴-ийг хамааруулж ойлгоно. Байгууллагын хүрээнд оролцогч талууд (stakeholder) нэр томъёог 1960-аад онд Стэнфордын судалгааны хүрээлэн (SRI) хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигч гэсэн нэр томъёоны ерөнхий ойлголт болгож боловсруулсан. Энэхүү оролцогч талуудын талаарх үзэл баримтлал нь пүүсийн хамгийн нягт холбоотой хүмүүст чиглэгдсэн ба 1980-аад оны дунд үеэс эхлэн энэхүү үзэл баримтлалын санаа нь засаглалын гол ойлголт болсон⁵. (Д.Ч)

БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ (*Organization culture*)

Байгууллагын соёлын олон тодорхойлолт байдаг ч нийгмийн гишүүдийн зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн утга санааны тогтолцоо гэдэг ойлголтод нэгддэг. Соёл бол нийгмийн амьдрал, байгууллагын үйл ажиллагаанд бүхэлд нь хүчтэй нөлөө үзүүлдэг өвөрмөц үзэгдлийн тухай хийсвэр ойлголт юм. Байгууллагын соёл судлаач Шайн (E.H.Schein) сонирхол нэгт судлаачид, байгууллагын ажилтнуудтай ярилцахад соёлын нөлөө, ач холбогдлыг бүгд хүлээн зөвшөөрсөн боловч чухам энэ нь юу болох талаар өөр өөр бодолтой байжээ. Шайн: байгууллагын дотоод

харилцаа бол бүлгийн харилцаа гэсэн санаанд үндэслэн бүлгийн соёлыг “бүлэг гадаад орчиндоо дасан зохицох, дотооддоо нягтрах явцад суралцсан, үйлчлэлийнхээ үр дүнгээр зөв гэж үнэлэгдсэн, аливаа асуудлыг хүлээн авах, тэдгээрийн талаар бодох, мэдрэх зөв арга хэмээн шинэ гишүүддээ заадаг, бүгдээр хүлээн зөвшөөрсөн суурь баримтлалуудын цогц” гэж тодорхойлжээ⁶. Тиймээс байгууллагын соёл нь байгууллага бүрд байдаг өвөрмөц бөгөөд нийтлэг амьдралын хэв маяг. Өөрөөр хэлбэл байгууллагын ихэнх гишүүдэд байдаг нийтлэг итгэл үнэмшил, үнэт зүйл, хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт, хэм хэмжээ, зан үйлийн суурь баримтлал. Байгууллагын соёл нь корпорацийн соёлоос өргөн хүрээтэй ойлголт бөгөөд корпорацийн соёл нь байгууллагын удирдлагын зүгээс хүмүүстээ эзэмшүүлэхийг эрмэлзэж буй үнэлэмж, баримтлалаас бүрддэг, байгууллагын албан ёсны соёл. Гэтэл ямар ч байгууллагад үүнээс гадна хүмүүсийн хувийн итгэл үнэмшил, үнэлэмж, янз бүрийн бүлгүүдийн бичил соёл бий. Байгууллага гадаад орчинд дасан зохицох, байгууллагыг дотооддоо нэгтгэх үйл явцаас үүдэлтэй бэрхшээлүүдийг даван туулах зорилгоор байгууллагын соёлыг эрэлхийлж, хөгжүүлж, төлөвшүүлдэг тул байгууллага хэмээх системийг нэгтгэж, гишүүд эв нэгдэлтэй, байгууллагадаа үнэнч байх мэдрэмжийг төрүүлдэг⁷ байна. (Ц.Д)

БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ (*Organizational strategy*)

Тухайн байгууллагын алсын хараа зорилго, зорилтуудыг биелүүлэхэд чиглэсэн төлөвлөлт, төлөвлөлтийн хэрэгжилт,

4 Ц.Даваадулам, Засаглал үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг, Glossary Of Concepts And Terms In Governance, 2010, х. 21

5 Britannica, David Manuel-Navarrete, Stakeholder organizational element, www.britannica.com/https://www.britannica.com/topic/stakeholder/Stakeholder-management-and-corporate-governance

6 E.H.Schein, Organization Culture and leadership, San Francisco, 2004, p. 12.

7 조석중, 허종경 (1995). 공공조직관리, 한국라디오 및 텔레비전대학, p. 203.

хэрэгжилтийн үнэлгээ, үнэлгээнд үндэслэсэн өөрчлөлтийн тасралтгүй үйл явц. (Ч.Э)

БАЙГУУЛЛАГЫН СУРАЛЦАХУЙ (*Organizational learning*)

Байгууллагын менежерүүд, ажилтнууд шинэ нөхцөл байдал, бэрхшээлийг даван туулахын тулд сурч, илүү чадварлаг, туршлагатай болох үйл явц⁸. Байгууллагын гүйцэтгэлийг сайжруулахад мэдлэг бүтээх, хадгалах, түүнийгээ хуваалцах зорилготой үйл ажиллагаа. Байгууллагын суралцахуйн талаарх үзэл баримтлалын төлөөлөгч Фиол (Fiol), Лайлс (Lyles) нар: байгууллага суралцах нь "илүү сайн мэдлэг, ойлголтоор үйл ажиллагаагаа сайжруулах үйл явц" болно. Байгууллагын суралцахуй нь өмнөхөөсөө ялгаатай шинэ зан төлөвийг бий болгох замаар өөрчлөлтийн үйл явцыг өдөөдөг цогц механизм. Альфред Чандлер, Питер Сенге (Peter M. Senge) нар байгууллага дахь мэдлэг, суралцах үнэ цэнийг онцлон байгууллагын удирдлага суралцахуйн үр дүнд сөргөөр нөлөөлдөг нийтлэг асуудлуудыг харгалзан үзэх нь зүйтэй гэжээ. Тухайлбал, байгууллагын суралцахуйн үр дүнг сайжруулахын тулд мэдлэгээ хэрхэн ашиглах талаар тодорхой, хэмжигдэхүйц зорилго тавиагүй, хувь хүн эсвэл багийн суралцах үйл ажиллагаанд оролцох урамшуулал хангалтгүй, түүнчлэн сурч боловсрох, хуваалцах хамгийн үр дүнтэй үйл явцын талаар эргэлзээ байдагтай холбоотой асуудлууд тулгардаг байна. Байгууллагын суралцахуйн үр дүнд манлайлагчид чухал нөлөөтэй тул тэд тэргүүлэн оролцож, үлгэр дуурайл болж, мэдлэгийг дэмжих нь чухал.

Байгууллага суралцахуйн бүтцийг тодорхойлох нь шаардлагатай хүмүүст хэрэгцээтэй үед нь мэдээлэл дамжуулах сүлжээ, зохицуулах арга замууд болох суралцахуйн хөтөлбөр болон хэрхэн мэдлэгээ олж авах, хэрэглэх, хуваалцахыг тодорхойлно. Байгууллагын суралцахуй нь хувь хүний, бүлгийн, байгууллагын, байгууллага хоорондын гэсэн төрлүүдтэй. Байгууллагын суралцахуйн хэлбэрт хувь хүн суралцах, тасралтгүй суралцах, давтан суралцах, суурилуулсан систем, манлайлагчид, ярилцлага, лавлагаа, багаар суралцах зэрэг тус тус орно. Байгууллагын суралцахуйг өдөөдөг гол үйл явц нь мэдлэгийг бий болгох, хадгалах, хуваалцахтай холбоотой. (ДЧ)

БАЙГУУЛЛАГЫН СЭТГЭЛ ЗҮЙ (*Organizational psychology*)

Байгууллагын ажилтнуудын сэтгэл зүйн уур амьсгал, хувь хүний хөгжил, хөдөлмөрийн аятай нөхцөлийг бий болгох зорилгоор хүмүүсийн зан үйл, сэтгэцийн үйл ажиллагааг бүхий л талаар судлах сэтгэл судлалын шинжлэх ухааны салбар юм. Харвардын их сургуулийн профессор Хуго Мюнстерберг (Hugo Münsterberg) 1913 онд “Үйлдвэрлэлийн үр ашиг ба сэтгэл зүй” бүтээлдээ ажилтныг сонгон шалгаруулах, тусгай чадварыг сорих, техникийн аюулгүй байдлыг хангахад сэтгэл зүйн сорил зайлшгүй шаардлагатай гэсэн санаа дэвшүүлсэн байна. Байгууллага нь сэтгэл зүйн үйл явц болохын хувьд байгууллагыг нэгэн тогтолцооны харилцан уялдааг хангах зорилгоор бий болсон хүмүүс хоорондын сэтгэл зүйн онцгой орчин юм. Нийгмийн шинжлэх ухаанд тухайн байгууллагын гишүүдэд төлөвших ур чадварт илүү анхаарлаа төвлөрүүлдэг бол байгууллагын

⁸ Кембриж тайлбар толь, <https://dictionary.cambridge.org/dictionary/english/organizational-learning>

сэтгэл зүй нь хувь хүний сонголт, сургалт хөгжил, үнэлгээ, ажлын байран дахь байршил, байгууллага ба хувь хүний, албан ба албан бус бүлгийн харилцаа, байгууллага хоорондын харилцааг илүү анхааран судалдаг⁹ нь ажлын байран дахь үр бүтээмж, бие махбодын болон сэтгэл зүйг дэмжихэд түлхүү анхаардагтай холбоотой. Шайн: (Edgar H. Schein) байгууллагын зохион байгуулалтын судалгаанд хувь хүнээс бүлэгт чиглэсэн, бүлгээс байгууллагад чиглэсэн сэтгэл зүйг судлах шаардлагатай. Байгууллагын үзэгдлийг судлахдаа зөвхөн албан ёсны байгууллагуудаар хязгаарлах бус, байгууллагын орчинд хамаарагдах албан бус бүлгүүдийг ч орхигдуулж болохгүй гэжээ¹⁰. (Ц.Д)

БАЙГУУЛЛАГЫН ТӨВЛӨРСӨН СИСТЕМ (*Enterprise system*)

Байгууллагын мэдээлэл солилцоо, нөөцийн удирдлага, өгөгдөлд тулгуурласан мэдээллийн шинжилгээ зэрэг төрийн болон бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг болох зориулалт бүхий программ хангамжуудын бүрдэл хэсгүүдээс бүрдсэн нэгдмэл тогтолцоо. Байгууллагын нөөц төлөвлөлт (Enterprise Resource Planning - ERP), нийлүүлэлтийн сүлжээний менежмент (Supply Chain Management - SCM) болон хэрэглэгчидтэй харилцах менежмент (Customer Relationship Management - CRM)-ийн систем нь байгууллагын төвлөрсөн системийн жишээ юм. Байгууллагын төвлөрсөн системийг нэвтрүүлснээр дараах үр дүн гарна. Үүнд: -үйл ажиллагааны үзүүлэлтийг илэрхийлэх чухал мэдээллийг бүх түвшний удирдах ажилтнуудад шуурхай хүргэснээр оновчтой шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэх; -үйл ажиллагааны

болон хүний нөөцийн зардлыг бууруулах; -дотоод бизнес үйл ажиллагааг нэгтгэснээр үйлдвэрлэх, түгээх, хэрэглэгчдэд үйлчлэх чанарыг сайжруулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх; -үйл ажиллагаа болон ижил мэдээллийг бүгд хэрэглэх байгууллагын соёлыг төлөвшүүлэхийг дэмжих зэрэг болно. Байгууллагын төвлөрсөн систем нь тухайн байгууллагын чиг үүргийг биелүүлэх хамгийн үр ашигтай удирдлага, зохион байгуулалтын нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ. (Д.З; Ч.Л нар)

БАЙГУУЛЛАГЫН УУР АМЬСГАЛ (*Organization climate*)¹¹

Ажиллах орчныг бүрдүүлэгч цогц элемент буюу байгууллагын дотоод орчны шинж чанарын ажилтнуудын үнэлгээ юм¹². Энэ шинж чанар нь тухайн байгууллагад ажиллаж буй ажилтнуудад мэдрэгдэж, тэдний ажил, бүтээмжид багагүй нөлөө үзүүлдэг. Хүмүүс хоорондын харилцан үйлчлэлийн үр дүнд харилцаа үүсэж, байгууллага доторх харилцаа нь ажил үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон албан болон албан бус харилцаанаас бүрдэнэ. Учир нь ажилтан байгууллага дээрээ зөвхөн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой бодол санаагаа агуулан зөвхөн ганц дүрээр тодорхойлогдож байдаггүй. Түүнтэй амьдралын бусад олон “дүр” нь хамт байж, тэдгэртэй холбоотой үйл ажиллагаанаас үүдсэн санаа бодол, стресс нь ажил үүргээ гүйцэтгэхэд нөлөөлж байдаг. Байгууллагын ажилтнууд хоорондын харилцаа нь байгууллагын зорилгыг хэрэгжүүлэх болон ажилтнуудын хэрэгцээг хангахад чухал үүрэгтэй.

9 E.H.Schein, Organizational Psychology, Englewood Cliffs, N.J.: Prentice-Hall, 1966.

10 Мөн тэнд

11 한호섭 (1999). 행정학 용어 사전. 서울, 행정학용어표준화연구회. 새 정보 미디어

12 А.Цанжид: Төрийн захиргаа, Улаанбаатар 2009, УБ, х. 96.

Байгууллагад ажилласнаар хувь хүний хэрэгцээг хангах боломж нь ажилтнуудын зан үйл, ажлаа хийх сэдэл, сонирхол, бусадтай харьцах байдал, байгууллагаас зохиож буй аливаа ажилд оролцох идэвх зэрэг олон зүйлд нөлөөлж бүхэлдээ байгууллагын уур амьсгалыг бүрдүүлдэг. Иймд байгууллагын уур амьсгал нь ажилтнуудын өөрсдийнх нь байгууллагаа үнэлэх үнэлгээ. Хүмүүс эв нэгдэлтэй, хамт олонч, бүтээлч, эсвэл хоорондоо таарамжгүй гэж байгууллагынхаа дотоод байдлыг ярих нь элбэг байдаг. Энэ нь тэр хүмүүсийн хийсвэр үнэлгээ байж болох боловч нэгэнт хүн ийм үнэлгээгээ баримтлан ажилдаа ханддаг учраас ажилтнуудын олонхын өгсөн үнэлгээ нь байгууллагын уур амьсгалын бодит дүр төрх гэж үзнэ. (Ц.Д)

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (*Organizational action plan*) Байгууллагын дэвшүүлсэн зорилт-уудын биелэлтийг хангах үр дүн, цаг хугацааг тооцсон гүйцэтгэх ажлын жагсаалт. Гүйцэтгэлийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, өөрчлөлт сайжруулалт гэсэн үйл явцын хүрээнд хийгдэнэ. (С.Ц)

БАЙГУУЛЛАГЫН ҮНЭЛГЭЭ (*Evaluation of organization*) Байгууллагын үйл ажиллагаа, гүйцэтгэлд нөлөөлдөг хүчин зүйлсийн тухай үнэн зөв мэдээлэл олж авах системчилсэн үйл явц юм. Тодорхой байгууллагад анхаарлаа төвлөрүүлдэг тул бусад төрлийн үнэлгээнээс ялгаатай юм. Байгууллагын үнэлгээ хийхэд зураглал, төлөвлөгөө, таамаглал гаргах, ямар үр дүнд хүрэх зорилгоо тодорхойлох хэрэгцээ гарна. Аливаа байгууллага нь амьд организм болохын хувьд үргэлж өөрчлөгдөн шинэчлэгдэн нийгмийн хөгжлийн

шаардлагад нийцүүлэн үр ашгаа нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа сайжруулах гэх зэргээр өөрчлөн шинэчлэх шаардлагын дагуу үнэлгээ хийдэг. Байгууллагад үнэлгээ хийхийн тулд эхлээд судалгаа хийснээр судалгааны үр дүнг дараах хэлбэрээр үнэлж болно. Үүнд: 1. Зохион байгуулалт, 2. Хүний нөөц, 3. Зөрчилдөөний хэмжээ, 4. Соёлын онцлог. Түүнчлэн байгууллагууд дасан зохицох, тэсэж үлдэх, гүйцэтгэх чадвараа сайжруулахын тулд үнэлгээ хийж болно. Байгууллагууд гүйцэтгэлийнхээ талаар ашигтай мэдээлэл олж авах, үр дүнд хүрэх эсвэл саад болж буй чухал хүчин зүйлийг тодорхойлох байр сууриа олоход нь тусална. Энэ нь бүтээгдэхүүн, үйлчилгээний үр дүнг сайжруулахад дэмжлэг тусалцаа үзүүлэхэд тухайн байгууллагын чадавхыг сайн ойлгох хэрэгцээ. (А.Э.ц)

БАЙГУУЛЛАГЫН ҮНЭТ ЗҮЙЛС (*Organizational values*) Байгууллагын үнэт зүйлс нь үйл ажиллагааны чиглэлийн дагуу нийгэмд ямар итгэл үнэмшил, ёс зүйтэй байх, байгууллагын хандлагыг илтгэнэ. Байгууллагын зорилго, чиг үүрэг, зорилтоос хамаарч үнэт зүйлс өөр өөр байх боловч байгууллагын удирдлага, хамт олны баримтлах, нэгдэх, нийтлэг үнэлэмж байна. (С.Ц)

БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ (*Organizational function*) Байгууллагын чиг үүрэг нь нийгмийн харилцааны хэрэгцээ шаардлагатай уялдана. Төрийн байгууллагын хувьд хяналтын, захиргааны, үйлчилгээний, бодлого зохицуулалтын, гэх мэт тодорхой зайлшгүй гүйцэтгэх үйл ажиллагаатай холбоотой чиг үүрэг гүйцэтгэдэг. Төрийн байгууллагыг шинээр бий болгох, өөрчлөн байгуулах, эсвэл татан буулгах нь тухайн хэрэгцээ шаардлагаар шинэ

чиг үүрэг үүссэн, эсвэл тэр чиг үүрэг нь өөрчлөгдсөн буюу шаардлагагүй болсон, эсвэл тэр чиг үүрэг нь байгаа атлаа байгууллага нь түүнийг хэрэгжүүлэх чадамжгүй болсонтой шууд холбоотой. Байгууллагын чиг үүрэг нь тухайн байгууллагын эрхэм зорилго, зорилт, үнэт зүйл, үйл ажиллагааны чиглэлээр тодорхойлогдоно. Ийнхүү тухайн байгууллага нь төрийн тогтолцоонд эсвэл салбартаа тодорхой чиг үүрэг хүлээхээс гадна байгууллагын дотоод бүтцийн нэгжүүд бас тус тусын гүйцэтгэх чиг үүрэгтэй. (С.Ц)

БАЙГУУЛЛАГЫН ЭРХЭМ ЗОРИЛГО **(Organizational mission)**

Байгууллагын хөгжлийн чиг хандлагыг чиглүүлсэн, хэрхэн хөгжих, юунд хүрэх, зорилгыг нэгтгэсэн үзэл баримтлал¹³. Байгууллагын эрхэм зорилго нь өнөөгийн байдал илүү чиглэгдсэн, зорилтод хүрэх төлөвлөгөөний гол санааг илэрхийлнэ. Эрхэм зорилго нь байгууллага оршин тогтнож, юунд хүрэхийг зорьсон, зорилгоо биелүүлэхийн тулд байгууллагаас хэрэгжүүлдэг үндсэн үйл ажиллагаа, үнэт зүйлс, байгууллагын зорилгыг хэрэгжүүлэхэд ажилтнуудыг чиглүүлдэг зарчим, итгэл үнэмшлийг тодорхойлж өгнө. Байгууллага эрхэм зорилгоо тодорхойлохдоо өөрийн хүчин чармайлтаар өөрчилж чадах үйл ажиллагааны үр дүнг товч тодорхойлон оруулна¹⁴. Эрхэм зорилгыг ажиллагсад болон байгууллагын бусад оролцогч талуудад ойлгомжтой байхаар тодорхойлно. Эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд тодорхой зорилго,

түүний тухайлсан зорилтуудыг боловсруулдаг. Эрхэм зорилго тодорхой бус бол ажилтнуудаа идэвхжүүлэн удирдан чиглүүлэх боломжгүй¹⁵. (Д.Ч)

БАРНАРД, ЧЕСТЕР ИРВИНГ (Barnard, Chester Irving, 1886–1961) Америкийн бизнесмен бөгөөд төрийн албан хаагч, менежмент, байгууллагын социологийн салбарын нэрт эрдэмтэн. Харвардын их сургуулийн эдийн засгийн ангид сурч байсан боловч төгсөөгүй. Гэвч хожим хэд хэдэн их сургууль түүнд хүндэт доктор цол олгожээ. 1909 онд Америкийн телефон ба телеграфийн газарт ажиллан улмаар 1927 онд Нью Жерсейн Телефон компанийн ерөнхийлөгч болсон. 1939 онд Америкийн артс ба шинжлэх ухааны академийн гишүүн болж, Рокфеллерийн сан, Үндэсний шинжлэх ухааны сангийн ерөнхийлөгчөөр ажиллаж байжээ. 1950-иад оны сүүлчээр байгуулагдсан Системийн ерөнхий шинжилгээний нийгэмлэгийн анхны гишүүний нэг байжээ. Менежмент, байгууллага судлалын чиглэлээр олон бүтээл, өгүүлэл бичжээ¹⁶. Тэрбээр байгууллага бол хүмүүсийн хамтын ажиллагааны систем хэмээн үзэж байв. Байгууллага ихэвчлэн үр нөлөө болон үр ашиг гэсэн хоёр үндсэн шалгуурыг давж чадаагүй учраас нас богинотой байдаг хэмээн гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг, эрх мэдэл ба сэдэлжүүлэлт зэрэг сэдвээр шинэлэг онолууд боловсруулжээ. (А.Ц)

¹⁵ Т.Дорж, Менежмент, сурах бичиг, 2018, х. 223.

¹⁶ The Functions of the Executive, 1939. Dilemmas of Leadership in the Democratic Process, 1946. A Report on the International Control of Atomic Energy, 1948. Organization and Management, 1956. Organization and Management: Selected Papers, 1956. On the Teaching of Law in the Liberal Arts Curriculum. With Harold Joseph Berman. Harvard Law, 1958. Elementary Conditions of Business Morals, 1986. Philosophy for Managers: Selected Papers of Chester I. Barnard. Edited by William B. Wolf and Haruki Iino гэх мэт.)

¹³ Менежментийн шинжлэх ухааны нэр томьёоны тайлбар толь, Glossary of Management Science Terminology, Улаанбаатар, 2020, х. 51.

¹⁴ Alan Walter Steiss, Strategic Management for Public and Nonprofit Organizations, Marcel Dekker, Inc., 2010 х. 63, 62.

БАТ-ОЧИР Ч. (*Bat-Ochir Ch.*) Шадар билэгт хэмээн нэрлэгдсэн бичгийн их хүн Бат-очир 1874 онд Сэцэн хан аймгийн Сэцэн ханы хошуу, одоогийн Хэнтий аймгийн Баянхутаг сумын нутагт Чулууны гэр бүлд төржээ. Бага насандаа бичиг үсэг сурсан түүнийг Сэцэн хан Навааннэрэн тамгын газартаа бичээч, түшмэлээр томилон ажиллуулсан аж. Тэр ч байтугай Навааннэрэнд бичиг зааж байсан гэдэг. Эрдэмд шунаг тэрээр Манж, Хятад хэл сурсан байна. Хүрээнд шилжин суурьшсаны дараа Шашин төрд туслах яам, Хууль цаазын бичиг зохиох газарт бичээч, туслах түшмэлийн албыг хааж байжээ. Эл албанд зүтгэл гаргасны учир 1918 онд “гүн” зэргээр шагнуулсан байна. Түүхчдийн бичсэнээр Богд хааны тамга дээрх шүлгийг зохиожээ. Богд хааны мөнгөн тамганы дээд талд болон дөрвөн талд нь “Тэнгэр энх түвшин, дэлхий, төр маш бат, шашин маш тунгалаг” хэмээн монгол үсгээр бичсэн байдаг ажээ. 1921 оны хувьсгалын дараагаар судар бичгийн хүрээлэнг хамтран байгуулж, уг хүрээлэнгийн нарийн бичгийн даргаар хавсран ажиллаж байжээ. Тэрбээр түүх судар цуглуулах, судалгаа, орчуулга хийх зэргээр Монгол Улсад орчин цагийн шинжлэх ухааныг үүсгэн байгуулахад хүчин зүтгэсэн гавьяат хүмүүсийн нэг юм. “Монгол үсгийн мөрдөн дуурайх эх”, “Мандах нарны туяа”, “Монгол Улсын эртнээс уламжлан ирснийг товчлон тэмдэглэсэн бичиг” зэрэг бүтээлүүдийг туурвиж хятад хэлнээс “Нэвтэрхий толь”, “Ган му бичиг” зэргийг орчуулсан байна. 1922 онд Ардын засгийн газраас байгуулсан үндсэн хууль боловсруулах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллаж байв. (А.Ц)

БАЯЛГИЙН САН (*Wealth fund*) Нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор төсвөөс гадна хуримтлуулсан хөрөнгийг хэлнэ. "Баялгийн сан" нэр томьёог анх 2005 онд Эндрю Розанов "Улс үндэстний баялгийг хэн эзэмшдэг вэ?" Төв банкны сэтгүүлд¹⁷ хэвлүүлсэн нийтлэлдээ ашиглаж байжээ. Энэ сэтгүүлийн өмнөх дугаарт уламжлалт нөөцийн менежментээс баялгийн сангийн менежмент рүү шилжсэнийг тайлбарласнаар энэ нэр томьёо өргөн тархсан. Нийгмийн баялгийн сан нь хувьцаа, бонд, үл хөдлөх хөрөнгө, үнэт металл зэрэг бодит болон санхүү, эсвэл хувьд хөрөнгө оруулдаг төрийн өмчит хөрөнгө оруулалтын санг нэрлэдэг. Ихэнх Баялгийн сан нь түүхий эдийн экспортын орлого эсвэл төв банкны хадгалдаг валютын нөөцөөс санхүүждэг бөгөөд дэлхийн хэмжээнд хөрөнгө оруулалт хийдэг. Зарим үндэсний баялгийн санг улс орны банкны системд хөрөнгө төвлөрүүлдэг төв банк эзэмшиж болдог; энэ төрлийн сан нь ихэвчлэн эдийн засаг, төсвийн томоохон ач холбогдолтой. Бие даасан бусад баялгийн сангууд нь хөрөнгө оруулалтын өгөөжийн зорилгоор янз бүрийн байгууллагуудын хөрөнгө оруулсан улсын төсвийн хуримтлал бөгөөд төсвийн менежментэд чухал үүрэг гүйцэтгэхгүй байж болзошгүй юм. Хуримтлагдсан сангууд нь гадаад валютын хадгаламж, алт, эх үүсвэрийн тусгай эрх (SDR) болон Олон улсын валютын сангийн (ОУВС), төв банкууд, мөнгөний эрх бүхий байгууллагуудын эзэмшиж буй нөөцийн албан тушаал, тэтгэвэр

¹⁷ "Who holds the wealth of nations?" (PDF). *Central Banking Journal*. 15 (4). May 2005. Archived from the original (PDF) on 29 May 2008. Retrieved 2 September 2008.

зэрэг үндэсний бусад хөрөнгөтэй холбоотой байж болох юм. Эдгээр нь ихэвчлэн дотоодын болон өөр нөөцийн валютаар (доллар, евро, фунт, иен гэх мэт) хадгалагддаг бүрэн эрхт улсуудын хөрөнгө юм. Ийм хөрөнгө оруулалтын менежментийн байгууллагуудыг албан ёсны хөрөнгө оруулалтын компаниуд, улсын тэтгэврийн сан, бие даасан сангууд гэж мэтээр байгуулж болно. Баялгийн сангууд урт хугацааны өгөөжийг хамгийн их байлгах, валютын нөөцийг богино хугацааны "валютын тогтворжилтыг" хангах, хөрвөх чадварын менежментээр тодорхойлж болно. Ихэнх нь богино хугацааны, хөрвөх чадвартай мөнгөн хөрөнгөөс бусад хөрөнгийг асар их хэмжээгээр төрөлжүүлсэн гэж үздэг боловч энэ мэдэгдлийг баталгаажуулах бараг бүх мэдээлэл олон нийтэд нээлттэй байдаггүй. Түүхий эд экспортлогч олон улс орон баялгаас орох орлогоос Засгийн газрын санхүүгийн удирдлагад учруулах сорилтуудыг даван туулахын тулд нөөцийн сан байгуулдаг. Нөөцийн сангуудыг үндсэн зорилгоных нь үйл ажиллагааны горимын хатуу чанга эсвэл уян хатан эсэхээс нь хамааран а) тогтворжуулах зорилго бүхий хатуу дүрэм бүхий сангууд б) хуримтлуулах зорилго бүхий хатуу дүрэм бүхий сангууд в) уян хатан дүрэмтэй төсвийн тэнцэлтэй уялдуулан тогтворжуулах ба эсвэл хуримтлуулах зорилго бүхий сангууд гэж ангилдаг. Зарим сангууд хуримтлуулах болон тогтворжуулах давхар зорилготой байж болдог. Мөн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, төсвийн зарцуулалтын тодорхой хэсгийн санхүүжилтийг шийдвэрлэх, төсвийн гадуур зарцуулах зэрэг бусад зорилгууд байж болно. Товчдоо: Баялгийн сан нь дунд болон урт хугацааны макро эдийн засгийн ба

санхүүгийн зорилгоор баялгийг хадгалж, удирдаж, зохицуулдаг Засгийн газрын эсвэл Засгийн газрын эзэмшлийн эсвэл хяналтын байгууллагын хөрөнгө оруулалтын сан юм.¹⁸ Баялгийн сангийн институтийн тодорхойлолтоор "Баялгийн сан" нь төрийн эзэмшлийн хөрөнгө оруулалтын нөөц эсвэл нэгж бөгөөд дараах хэсгүүдээс бүрдэнэ.

1. Байгалийн баялгийн болон эдийн засгийн илүүдэл орлого
2. Албан ёсны гадаад валютын үйл ажиллагаа
3. Хувьчлалын орлого
4. Засгийн газрын шилжүүлэг
5. Сангийн илүүдэл
6. Ашигт малтмал экспортлохтой холбогдох орлого

Баялгийн сангуудын уламжлалт ангилал:

1. Тогтворжуулалтын сан
2. Хадгаламжийн ба ирээдүй хойч үеийнхний сан
3. Тэтгэврийн хуримтлалын сан
4. Хуримтлалын хөрөнгө оруулалтын сан
5. Стратегийн хөгжлийн баялгийн сангууд (SDSWF) зэрэг болно. (А.Э)

БЕХАВИОРИЗМ (Behaviorism) ХХ зууны эхээр сэтгэл судлалын ухаанд буй болсон урсгал. Хүмүүс болон амьтдын зан үйлийн шалтгаан үрийн холбоог тогтоох, системчлэхэд гол анхаарлаа хандуулна. Менежментийн ухаанд зан үйлийг хүссэн болон хүсээгүй зорилгуудтай холбон үздэг. Менежерүүд ихэвчлэн зорилгоо тодорхойлдог боловч бодит хэвшмэл зан үйл өөр байж болно. Зан үйл үйлдэгдэхээс өмнө хүмүүс үйлдэх гэж буй зан үйлд нөлөөлдөг сэдлүүдэд анхаарлаа хандуулдаг.

¹⁸ Олон улсын валютын сан 2008.

Нэгэнт зан үйл үйлдэгдсэний дараа үр дүн нь гарна. Үр дүн нь урамшуулал, эсхүл шийтгэл байдаг. Тиймээс бехавиоризмд суурилсан судалгаа нь хүмүүс болон судалж буй объектын зан үйлийг ажиглах, хэмжих, зураглах, тайлбарлах, улмаар урьдчилан харахад гол анхаарлаа хандуулна. Пост бехавиоризм нь улс төрийн судалгаанд бехавиорист арга давамгайлахын хариу үйлдэл маягаар гарч иржээ. Түүний гол төлөөлөгч нь Дэвид Истон юм. Пост бехавиористууд бехавиорист арга нь хэдийгээр дундыг барьсан үнэлэмж бүхий байр суурьтай хэмээн тунхагладаг боловч хэрэг дээрээ нийгмийн өөрчлөлтөд хөтлөх бус, хуучныг хамгаалж хэвээр хадгалахад үйлчилдэг хэмээн шүүмжилжээ. Тэдний үзлээр судалгаа нь дундыг барьсан бус, үнэлэмжүүдийг харгалзсан байх учиртай ажээ. Зөвхөн ажиглаж, хэмжиж болох зүйлд анхаарлаа хандуулах нь өнгөн талын, жижиг сажиг зүйлийг судлаад чухал асуудлуудыг орхиход хүргэж байна гэж үздэг. Судалгаа нь нийгэмд хэрэгтэй, судлаачид ч нийгэмд чухал үүрэгтэй хүмүүс байх ёстой аж. (Ц.Д)

БИЕ ХҮНИЙ ХЭВ МАЯГИЙН ОНОЛ (*Personality types theory*) Нийгмийн харилцаанд орж тухайн нийгмийн субьектив шинжүүдийг өөртөө бүрдүүлэн бий болгосноор бие хүн болж төлөвшдөг. Хүн бие хүн болж төлөвших явц нь сэтгэхүй, сэтгэл хөдлөл, зоригийн хөгжлөөр тодорхойлогддог ба бие хүний хэв маягийг судалдаг олон онолууд бий. Престус (R.Presthus) өнөөгийн захиргааны байгууллагад гишүүд нь байгууллагуынхаа амьдралд дасан зохицохын хэрээр дээш тэмүүлэгч (upward-mobiles), хайхрамжгүй байдал (indifferents.), хоёрдмол

шинжтэй (ambivalents) гэсэн гурван төрлийн хэв маяг илэрч байдаг гэж үздэг¹⁹. МакКлелланд (David C.Mc-Clelland): амжилтын хэрэгцээ нь хүнд хэцүү ажлыг хийх, хүн-асуудал-санаа бодлыг давамгайлах, зохицуулах хийгээд удирдах, саад бэрхшээлийг даван туулан өндөрт гарах, тэрхүү байр сууриа хадгалах хүсэл эрмэлзэл гэж тодорхойлон амжилтад хүрэх хүсэл эрмэлзэл ихтэй, амжилтад хүрэх хүсэл эрмэлзэл багатай хүмүүс хэмээн ангилжээ. Даунс (Anthony Downs): захиргааны байгууллага албан хаагчдын хэв маягийг тэдний биелүүлэх зорилгын төрлөөс хамаарч онцлог шинж чанарыг нь амжилтад тэмүүлэгч (climbers), байр сууриа хадгалахыг эрхэмлэгч (conservers), уриалагч (advocates), төрийн зүтгэлтэн (statesman) гэсэн таван төрөлд хуваан үзсэн байна. (Ц.Д)

БИОМЕТРИЙН БАТАЛГААЖУУЛАЛ (*Biometric authentication*) Хурууны хээ, алганы хээ, нүдний солонгон бүрхүүл, нүүрний төрх, дуу хоолой гэх мэт хүний биологийн дахин давтагдахгүй онцлог шинжид үндэслэн тухайн хүн мөн эсэхийг таних, баталгаажуулах арга ажиллагаа. Биометрийн баталгаажуулалтыг ашиглахын тулд ийм зориулалт бүхий системд хэрэглэгчдийн биометрийн өгөгдлүүдийг урьдчилан бүртгэж сан үүсгэсэн байх шаардлагатай. Хүнийг танихдаа бүртгэлд авсан биометрийн өгөгдлийг тухайн сангаас шүүж харьцуулан дүгнэдэг. Биометрийн баталгаажуулалтыг үйлчилгээнд хэрэглэгчээ таних, цаг бүртгэх, хамгаалалттай бүсэд нэвтрэх, хилийн цахим гарцаар нэвтрэх гэх мэт хэрэглээнд өргөн ашигладаг. (Д.З; Ч.Л нар)

¹⁹ Robert V. Presthus (1962). The Organizational society: an analysis and a theory. New York: Vintage Books.

БИЧЭЭЧ (*Clerk, penpusher*) Монгол төрийн албаны эртний бөгөөд маш чухал албан тушаалын нэг. Эртний монгол угсааны Сяньби, Жужан улсуудын үед ч “битигчи” хэмээх албан тушаалтан байсан тухай түүх шастирт дурдсан нь монгол төрийн түүхэнд уламжлагдан ирсэн байна. Харц гаралтай хүн бичиг үсэг сурвал бичээч болж улмаар төрийн албанд зүтгэх зам нь нээгддэг байжээ. Тийм учраас бичиг сурч, бичээч болох нь эгэл жирийн хүн нийгмийн дотор шат ахих нэгэн хэрэгсэл болж бай. Ж.Самбуу, А.Амар нарын зэрэг төрийн ахмад зүтгэлтэн хүмүүсийн намтарт бичиг үсэг сураад тал бичээчээс эхлэн бичээч, эх зохиогч түшмэл болж дэвшсэн тухай дурдсан байдаг. Өнөө үеийнх шиг албан бичгийг хувиан олшруулах техникгүй үед олон газар руу явуулах бичгийг олшруулах үүргийг чухамхүү бичээч нар гүйцэтгэдэг байжээ. (А.Ц)

БЛОКЧЭЙН (*Blockchain*) Мэдээллийн аливаа өгөгдлийг тархмал байдлаар хадгалдаг бүртгэлийн технологийн нэгэн төрөл. Блокчейн нь криптограф / cryptography / буюу кодлол / encryption / -ийн аргаар ажилладаг механизм бөгөөд математикийн тусгайлсан алгоритмыг ашиглан тасралтгүй нэмэгдэх өгөгдлийн бүтцийг бий болгон, баталгаажуулдаг. Энэхүү технологи нь төвлөрсөн бус тархмал шинжтэй, нээлттэй, хамгаалалт сайтай учраас илүү найдвартайд тооцогддог. Жишээ нь санхүүгийн гүйлгээний мэдээлэлд энэ арга хэлбэр өргөн хэрэглэдэг. Төрийн мэдээллийн ач холбогдол, нууцлал өндөрсөх тусам энэ технологийг ашигладаг. Ердийн өгөгдлийн сан болон блокчэйн сангийн ялгаа нь өгөгдөл хадгалах бүтэц юм. Блокчэйн нь мэдээллийг багцлан блок болгон хадгалдаг. Блок бүр тодорхой

хэмжээтэй бөгөөд мэдээлэл ихсэх тусам блокчэйн тоо нэмэгдэж блокууд нь хоорондоо гинжлэн холбогддог. Иймд гинжин хэлхээнд шинээр блок бичигдэх бүрд үүссэн хугацааны нарийвчилсан цаг бүртгэгддэг бөгөөд блокчэйндээ хадгалагддаг. Блокчэйн нь блокуудаа зөвхөн нэг өмчлөгчийн серверт хадгалдаггүй бөгөөд зөвшилцлийн үндсэн дээр хэдэн арваас хэдэн мянган компьютерт хувиан байршуулдаг. Шинээр блок үүсгэхдээ тухайн блок дээр үнэн зөв мэдээлэл бичигдэж байгаа эсэхийг баталгаажуулсны эцэст блокчэйн рүү бичдэг. Баталгаажуулагч нь олон байх бөгөөд зөвшилцлийн дагуу сонгогддог. Тиймээс хэн нэгэн ганцаараа блок үүсгэх нэмэх боломжгүй юм. Блокчэйн дээр байгаа бүхий л мэдээлэл, гүйлгээ ил тод хэн ч харах боломжтой. (Д.З, Ч.Л нар)

БНМАУ-ЫН ЗАХИРГАА (*Administration in MPR*) БНМАУ-д төрийн захиргааны дээд болон төвийн байгууллагууд, орон нутгийн захиргааны байгууллагууд захиргааны тогтолцоог бүрдүүлж байв. Улсын бүх өмч төрийн мэдэлд байсан учраас эдийн засаг, нийгмийн хөгжлийг төлөвлөх хэрэгжүүлэх ажил бүхэлдээ Сайд нарын зөвлөл, салбарын яамд, тусгай газрууд, орон нутгийн захиргааны чиг үүрэгт хамаарч байсан тул бодит байдалд эдгээр байгууллагыг захиргааны тогтолцоонд хамруулан үзэж болох юм. Сайд нарын зөвлөл нь Ардын Их хурлаас Сайд нарын зөвлөлийн дарга, түүний орлогчид, сайд нар гэсэн бүрэлдэхүүнтэй байгуулагддаг байжээ. Яамд гол төлөв салбарын шинжээр, тусгай газрууд салбар хоорондын шинжтэй чиг үүрэгтэй байгуулагдаж байв. (А.Ц)

БНМАУ-ЫН ТӨРИЙН ДЭЭД ЭРХ БАРИХ БАЙГУУЛЛАГА (*The highest state authority of the MPR*)

1924 оны Үндсэн хуульд “Бүгд найрамдах Монгол Ард Улсын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалах бөгөөд мөн хурлын чөлөө цагт Улсын бага Хуралд, мөн хурлын чөлөө цагт Бага Хурлын тэргүүлэгчид ба Засгийн газрын дунд хадгалуулбал зохино” хэмээн заажээ. Улсын Их Хурлын төлөөлөгчдийг аймгийн хурлаас нэг жилээр сонгох, аймгийн хурал хуралдах бололцоогүй бол хошуудаас томилон явуулахаар зохицуулжээ. Улсын Их Хурлыг УБХ-аас эрхлэн жилд нэг удаа зарлан хуралдуулна. 1940 оны Үндсэн хуульд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын засгийн дээд эрхийг барих газар нь Улсын Их Хурал болно” хэмээн хуульчилсан. Улсын Их Хурлын аймаг, хотын хурлуудаас 1500 хүн тутмаас нэг төлөөлөгчөөр бодож сонгоно. Мөн УБХ-аас эрхлэн гурван жилд нэг удаа хуралдах заалттай байв. 1924 оны Үндсэн хуульд Улсын Их Хурлын эрхэлбэл зохих асуудлыг нэлээд өргөн хүрээтэй тусгасан бол 1940 оны Үндсэн хуульд Үндсэн хуулийг батлах ба өөрчлөх, гадаад, дотоод улс төрийн бодлогын үндсэн зарчим ба арга хэмжээнүүдийг тогтоох, Бага хурлын гишүүнийг сонгох гэсэн гурван зүйлээр хязгаарласан байна. Их Хурлын чөлөө цагт Улсын бага хурал засгийн дээд эрхийг барьж нэлээд өргөн хүрээтэй чиг үүргийг хэрэгжүүлж байв. 1960 оны Үндсэн хуульд “БНМАУ-ын төрийн эрх барих дээд байгууллага нь Ардын Их хурал мөн” хэмээн тунхаглаж тус улсад гагцхүү Ардын Их Хурал хууль тогтоох эрхтэй байна гэсэн заалтыг анх удаа оруулжээ. Ардын Их хурлыг 4000 хүн тутмаас нэг депутат байхаар бодож гурван жилийн хугацаагаар сонгоно. 1969 онд АИХ-ын чуулганаар

орон нутгийн хурлыг гурав, АИХ-ыг дөрвөн жилийн хугацаагаар сонгож байхаар хуульчилсан. Ардын Их хурлын ээлжит чуулган жил бүр нэг удаа чуулна. Ардын Их хурлын чөлөө цагт түүний тэргүүлэгчид төрийн эрхийг барих дээд байгууллагын эрхийг эдэлдэг байжээ. 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдсанаар Монгол Улсад олон намын оролцоотой сонгуулиар байгуулагдсан Байнгын ажиллагаатай парламент-Улсын их хурал буй болсноор Ардын Их Хурал байхаа больжээ. Үндсэн хуулийн дагуу төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх гэсэн өөр хоорондоо уялдаа, харилцан тэнцэл бүхий эрх мэдлийн гурван салбартай байхаар зохицуулсан юм. (А.Ц)

БНМАУ-ЫН ҮНДСЭН ХУУЛИУД (*Constitutions of MPR*)

Монгол Улс өөрийн орны амьдралд гарсан өөрчлөлтийг үндэслэн түүхэндээ дөрвөн удаа Үндсэн хуулиа шинээр батлан мөрдсөн. 1924 оны Үндсэн хуулийн оршилд “Бидний ардын эрхтэй хэмжээт цаазат улсыг тэргүүлж байсан Богд Жавзандамба хутагт хаан ... таалал төгссөн учир ... олноор хувьсгал үүсгэн гадаадын харгисуудыг харьяат орон нутгаас хөөн гаргаж, дотоодын эзэрхэг байдлыг устгаж...” хэмээн үүссэн нөхцөл байдлыг тодорхойлоод “нэгэнт зоригоо илтгэсэн олон ардын ашиг тусад нийцүүлэхийн тулд” Үндсэн хуультай болж байгаагийн учрыг тодорхойлсон байна. Уг хууль Монгол Улсыг Бүгд Найрамдах Улс хэмээн тунхаглажээ. “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын зорилт бол хуучны эзэрхэг харгисын ёс суртлын үлдэгдлийг үндсээр устгаж, улс төрийн захиргааны явдлыг жинхэнэ ардын ёсонд нийлүүлж, шинэ

ёсны Бүгд Найрамдах Улсын үндэс тулгуурыг бататган бэхжүүлнэ” хэмээн тодорхойлсон байна. 1940 оны Үндсэн хуульд нөхцөл байдлын өөрчлөлтийн талаар тусгайлан бичсэн зүйл байхгүй боловч уг хуулийн нэгдүгээр зүйлд улсаа тодорхойлохдоо “... эзэрхэг түрэмгийг ба феодалын дарлалыг устгасан цаашид нийгэм журамд дэвшин орохын учир улс орноо хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангаж буй хөдөлмөрчин (малчин, ажилчин, оюутан) ардын тусгаар тогтносон улс мөн болно” гэжээ. 1960 оны Үндсэн хуулийн оршилд “Бүгд Найрамдах Монгол Ард Улс нь... империалистуудын түрэмгийлэл, дотоодын харгис хүчний эсрэг шаргуу тэмцэн улс төр, эдийн засгийнхаа тусгаар тогтнолыг бэхжүүлж, урьд ноёрхож байсан үндэсний ба нийгмийн дарлалын хүнд хоруршгийг гэтлэн давж, феодал ангийг устган социалист аж ахуй, соёлоо бүтээсний үрээр өсөж” бэхэжсэн, “... нийгэм эдийн засгийн үндсэн их өөрчлөлт хийж социалист шинэ эдийн засгийг байгуулж, социалист үйлдвэрлэлийн харилцааг бүх улс ардын аж ахуйд ялуулж, хөдөлмөрчин ард түмний аж амьдрал, соёлын хэмжээг дээшлүүлэх талаар түүхэн их амжилт” олсон хэмээн дурдсан байна. Түүхэнд 1921-1940 оныг феодализмын үндсийг устгаж, ардын ардчилсан ёсыг тогтоох үе, 1940-1960 оны үеийг социализмын үндсийг тавих, 1960-аас хойших үеийг социалист байгуулалтын жилүүд хэмээн тодорхойлж ирсэн нь үндсэн хуулиудын эдгээр заалтад тусгалаа олсон. 1990 оны эхээр дэлхийн социалист систем нуран унаж, хуучин социалист гэгдэж байсан улс орнуудад гүн гүнзгий өөрчлөлт гарч Монгол Улсад ардчилсан өөрчлөлт болсон билээ. Улс төрийн ардчилсан

тогтолцоо, оюун санааны олон ургалч, чөлөөт байдал, хүний эрх, эрх чөлөөт эрхэмлэсэн, өмчийн олон хэвшилд тулгуурласан эдийн засгийн зах зээлийн харилцаа буй болсон зэргийг баталгаажуулан Монгол Улс дөрөв дөх, ардчилсан шинэ Үндсэн хуулиа 1992 онд батлан мөрдсөн билээ. (А.Ц)

БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН ЗАХИРГАА (*Administration in Royal Mongolia*)

Богд хаант Монгол Улс нь засаг захиргааны хувьд аймаг, хошуунд хуваагддаг байсан. Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичигт тодорхойлсноор Их шавь болон хутагтуудын шавийн 43 отог, Халхын дөрвөн аймгийн 92 засаг хошуу, Дөрвөдийн 2 аймгийн 27 засаг хошуунаас бүрдэж байжээ. Дотоод, Гадаад, Цэрэг, Сан, Шүүх, Гааль, Шашин төрд туслах яам, түүний дор шавь нарын хэрэг эрхлэх Эрдэнэ Шанзудбын яам/ зэрэг яамдын албад, Улсын хурлын алба, Улиастай, Ховд, Хиагтын сайд нарын алба зэрэг болон аймаг, хошуу, отгийн албад тус улсын засаг захиргааны гол хэсгийг бүрдүүлж байв. Жишээ нь: Дотоод яамны орон тоог жагсаавал ёслолыг удирдагч түшмэл 2, эх бичиг зохиох түшмэл 6, жинхэнэ бичээч 12, нярав 1, хаалганы дарга 1, зарлага 5, хаалга сахигч 4, галч 4, нийт 35 орон тоотой байжээ. Аймаг бүрд чуулган дарга, цэрэг захирах жанжин байжээ. Хошуудад туслагч, захирагч занги, мэйрэн залан тус бүр нэг, сумдад сумын занги 1, орлон хөөгч 1, хөөгч 6, хуяг 50 байхаар тогтоосон байна. Зургаан сумд залангийн занги нэг байжээ. Арван гэр тутамд дарга тавих ёстой байв. Их шавь, отогт тодорхой тооны орон тоог тоогтоон байгуулжээ. Энд дурдсанаас гадна хилийн харуул, өртөөний алба зэрэг захиргаанд багтах албад байжээ. Тайж нар

төрлийн даргатай байсан нь арван гэртэй дүйцүүлэх зохион байгуулалт байжээ. (А.Ц)

БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ **(Short term plan)**

Төлөвлөгөөг хугацаагаар нь урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө хэмээн ангилна. Богино хугацааны төлөвлөгөө нь нэг жил болон түүнээс дотогш хугацааны төлөвлөгөө байна²⁰. Богино хугацааны төлөвлөгөө нь урт болон дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны шинжтэйгээс гадна хяналтын²¹ зориулалттай төлөвлөгөө юм. Жишээ нь: Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын нэг жилийн төсвийн төлөвлөгөө, аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, орон нутгийн нэг жилийн төсвийн төлөвлөгөө, төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудлын хүрээний гүйцэтгэлийн төлөвлөгөө гэх мэт. Хэдийгээр ихэнх судлаачдын бүтээлүүдэд богино хугацааны төлөвлөгөө нь нэг жил болон түүнээс дотогш хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөө байхыг тэмдэглэсэн ч зарим судлаачдын бүтээл, улс орны туршлагаас хөгжлийн төлөвлөлтөд 2 эсвэл 3 жил хүртэлх хугацааг богино хугацаа хэмээн төлөвлөсөн практик байна²². (М.А)

БОДЛОГО (Policy) Бодлого нь өргөн хүрээтэй, утга агуулга том ойлголт учир олон янзын тодорхойлолтууд бий. Бодлого нь одоо болон ирээдүйд гарах шийдвэрүүдэд чиг баримжаа болох тодорхой үе шатуудыг дамжин боловсруулан гаргасан зорилго, үйл ажиллагааны

төлөвлөгөө, үзэл санааны нийлбэр цогц юм. Бодлогыг богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж болно. Бодлогыг улс төрийн нам, сонирхлын бүлэг, хувийн хэвшил, төрийн байгууллага, хувь хүмүүс харилцан тохиролцож бодлогын хувилбаруудаас сонгож баталсан тодорхой зорилгод хүрэхэд чиглэсэн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө. Бодлого нь Ж.Андерсоны үзлээр асуудлыг тодорхойлох, боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн таван үе шат бүхий эргэх холбоонд оршдог²³. Бодлого нь эцсийн дүндээ нийгэм, улс төрийн амьдралд эерэг өөрчлөлт гарахад чиглэсэн бөгөөд аливаа сөрөг нөлөөнөөс аль болох зайлсхийсэн байна. Бодлого нь тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, бэрхшээлийг даван туулж, зорилгодоо хүрэхийн тулд олон төрлийн арга хэрэгслийг ашигладаг. Бодлогын арга хэрэгслүүд нь хэдэн арваар тоологдоно. Тэдгээр нь тухайлбал, стратеги төлөвлөгөө, хөтөлбөр, суртал ухуулга (propaganda), олон нийтийг мэдээллээр хангах, хориг, татвар, тэлбэр, санхүүгийн дэмжлэг, стандарт тогтоох зэрэг болно. Бодлого нь хуваарилах, зохицуулах, дахин хуваарилах гэсэн төрлүүдтэй байхаас гадна албан ёсны төрийн бодлого, байгууллагын, компанийн бодлого, улс төрийн тунхаг бичиг (manifesto), хочлол бичиг - памфлет (pamphlet), улс төрийн намын мөрийн хөтөлбөр - платформ (platform) хэлбэртэй байна. (Ж.Ж)

БОДЛОГО СУДЛАЛ (Policy studies)

1960-1970-аад оны үеэс бодлого судлал нь бодлогын шинжлэх ухааны бие даасан салбар чиглэл болон хөгжжээ. Судалгааны талбар нь

20 W.Arthur Lewis, Development Planning, 1966, p. 140.

21 W.Arthur Lewis, Development Planning, 1966, p. 140.

22 Andrew S. Downes, Long-Term planning: Institutional action and restructuring in the Caribbean, 2000, p. 17. https://repositorio.cepal.org/bitstream/handle/11362/7335/1/S00100937_en.pdf, retrieved by 2020.11.27.

23 James E. Anderson. Public Policymaking: An Introduction. fifth edition. Houghton Mifflin Company. 2003. p. 27.

төрийн салбарт төвлөрч (эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал зэрэг) хөгөлбөрийн үнэлгээ, нөлөөллийн судалгаа, бодлого боловсруулах үйл явц, мөн чанарыг судалдаг. Бодлого судлалын баримт бичиг нь мэргэжлийн нэр томьёо, үг хэллэг ихтэй, бодлогын мэргэжилтнүүдэд зориулагдсан, ерөнхий зөвлөмж, мэдээлэл зэргээр ялгардаг. Бодлого судлал нь хүний хөгжил дэвшлийн тулгамдсан асуудлуудыг авч үзэхдээ тухайн салбарын тэргүүлэх чиглэл, онол арга зүй, дэлхий дахины шинэчлэл, хөгжилд нөлөөлж буй нийгэм эдийн засаг, засаг, захиргааны олон хүчин зүйлийг харгалзана. Өнөөгийн бодлого судлалын хандлага нь дараах үндсэн чиглэлтэй бөгөөд чиглэл бүр нь дотроо олон салбарт хуваагдана. Үүнд: улс төрийн эдийн засаг ба геополитикийн асуудлуудыг багтаасан олон улсын харилцааны асуудлууд; хүрээлэн буй орчин, нийгмийн тогтвортой хөгжилд хамаарах асуудлууд; бодлогын судалгааны онол, загвар, тэдгээрийн шинжилгээний арга хэрэгслүүд; бодлогын шинжилгээний харьцуулсан судалгааны асуудлууд зэрэг багтана. Бодлого судлал нь бодлого судлалын хүрээлэн, төвүүдийн бэлтгэн гаргадаг сэтгүүл, судалгааны тайлан, ном, бүтээлүүдээр дамжин дэлхий дахинд тархан хөгжин, зарим их сургуулиуд боловсролын бодлого судлалаар мэргэжилтнүүд бэлтгэж байна. (Я.Т)

БОДЛОГЫН ОРОЛЦОГЧ ТАЛУУД (*Policy stakeholders*) Төрийн бодлогод газар зүй, бүс нутгийн онцлог, нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин болон бусад олон хүчин зүйлс хамаарах бөгөөд ашиг сонирхлоо илэрхийлэх, нөлөөлөх оролцогч талуудын байр суурь чухалд тооцогддог. Төрийн бодлогын үйл

явцад оролцож, шийдвэрт нөлөөлөх зорилготой сонирхлын бүлгүүдийг шахалтын бүлэг ба зарим улс оронд хуулийн дагуу байгуулагдсан лобби бүлгүүдийг оролцогч тал гэж хүлээн зөвшөөрдөг байна.

Бодлого боловсруулах нь нийгэмд шууд нөлөө үзүүлэх боловч хэрэгжилтийн түвшинд оролцогчид нь янз бүрийн хүмүүс байдаг. Ихэнхдээ хэрэгжилтийн явцад оролцогчид нь хувь хүн, бүлэг хүмүүс байх ба бодлогын шийдвэрийн үр дүнг шууд, шууд бусаар сонирхогчид болон үр дүнг шууд хүртэгчид байна. Үүнээс гадна бодлогын сонирхогч талууд нь төрийн алба, бодлогын зөвлөхүүд, төрийн бус байгууллагууд, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагууд, бодлогын судалгааны хүрээлэн, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил эсвэл иргэд, хэсэг бүлэг хүмүүс багтдаг. Эдгээрийн гол цөмд асуудлыг зохицуулан шийдвэрлэх зорилготой төрийн холбогдох байгууллага эсвэл шууд ба шууд бусаар хамаарах төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллагууд мөн багтана. Иймд бодлогын оролцогч талууд нь тухайн асуудлыг боловсруулах бүхий л үе шатуудад хамаарах субъектүүдээс бүрддэг байна. Тодруулбал: бодлого санаачлагчид; боловсруулагчид; хэрэгжүүлэгчид; хэрэгжилтийг үнэлэгчид; үр дүнг хүртэгчид гэсэн үйл ажиллагааны үе шат бүртэй холбогдох оролцогчид хамрагдана. Зарим нөхцөлд бодлогын шинжээчид, бодлого судлалын оюуны төвүүд нь төрийн байгууллагатай хамт шууд бодлогын зөвлөмж өгөх хэлбэрээр захиалагч болох тохиолдол бий. Бодлого судлалын төвүүдээс урд нь явуулсан судалгаа нь бодлогын гүнзгийрүүлсэн шинжилгээний үндэс

болно. Бодлого боловсруулах үйл явцад оролцогч талуудын хоорондын зөрүүтэй саналаас үүдсэн зөрчил эсвэл ашиг сонирхлын зөрчил, түүнийг шийдвэрлэх арга замын тухай асуудал заавал хөндөгддөг байна. Ашиг сонирхлын зөрчил нь тухайн оролцогчийн (хувь хүн, бүлэг) ашиг сонирхол буюу байр суурь нь нөгөө оролцогчийн (хувь хүн, бүлэг) ашиг сонирхлыг хөндөх үед тухайн нэг үйл явдал эсвэл тодорхой нэг нөхцөл байдалд үүсдэг харилцаа юм. Иймд энэхүү харилцаанд үүссэн оролцогч талуудын хоорондын зөрчлийг шийдвэрлэх арга зам нь зөрчлийн хэлбэр, төрөл, түвшингээс хамаарч харилцан адилгүй арга хэмжээ авагддаг. Гэхдээ төрийн бодлогын арга хэрэгслээр зөрчлийг шийдвэрлэх арга замууд нээлттэй, мөн олон төрөлтэй. Тухайлбал, төрийн даатгал, урамшуулал, татаас мэдээллээр хангах, торгууль ногдуулах гэх мэт. (Я.Т)

БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ (Policy analysis) Бодлогын шинжилгээ нь бодлогын үйл ажиллагаа руу илүү чиглэсэн бодлого боловсруулах өргөн хүрээний асуудлыг хамардаг. Бодлогын шинжилгээг улс төрийн шинжлэх ухаан болон уламжлалт удирдлагын шинжлэх ухаанаас ялгах нь түүний нэн тэргүүний зорилго байдаг ч тэдгээрийн хамаарлыг бүрэн үгүйсгэх боломжгүй гэж үздэг. Бодлогын шинжилгээ нь шийдвэрийн үр дагаврыг урьдчилан харж, хамаарах хувилбаруудын давуу болон сул талуудыг гаргах, шүүмжлэлтэй тунгаан бодоход чиглэгддэг. Бодлогын шинжилгээний үр дүн нь эцсийн шийдвэр гаргахад нөлөөлөх бөгөөд нийгмийн бодит асуудлын шийдэлд хамгийн оновчтой хариу өгөх аргачлал буюу асуудлыг судалгаа

шинжилгээгүй гаргахын үгүйсгэлийн хувилбар юм. Мөн төрийн захиргааны чиглэлийн бодлого боловсруулах аргачлалыг бодлогын шинжилгээ гэж нэрлэх хандлага ч бий. Бодлогын шинжилгээ нь төрийн бодлого, үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлын нуугдмал үндсэн шалтгааныг олж илрүүлэхээс судалгаагаа эхэлдэг тул хамгийн оновчтой хувилбарыг сонгох боломжийг боловсруулдаг шинжилгээний арга гэж үздэг. Түүнчлэн бодлогын шинжилгээг хамрах хүрээ, хэрэгжих хугацаа, далайцаар нь дөрвөн төрөлд хуваан үзэж, судалгааны цар хүрээ, зорилгот бүлгүүдийг тодорхойлох боломжтой болдог байна. Үүнд: бодлогыг макро түвшний; салбарын; хөтөлбөрийн шинжтэй; тодорхой асуудалд чиглэсэн гэж ангилна. Сүүлийн жилүүдэд бодлого боловсруулалтын шинжилгээний хандлага өөрчлөгдөж, бодлогын хэлэлцүүлэгт оновчтой санаа, бодлоо хуваалцах шинжээчдийн багийн (think tank) үүрэг ихээхэн нэмэгдэж байна. Бодлогын шинжилгээ нь шийдвэр гаргагчдад зориулсан, бодитой хэрэгжихүйц тодорхой бодлогыг төлөвлөх, энгийн, ойлгомжтой хэллэгтэй, товчхон бичигддэг бичвэрийн бүтэц, онцлогууд нь түүнийг бодлого судлалаас ялгаатай болгодог. (Я.Т)

БОЙКОТ (Boycott) Ирландын Засгийн газрын агентлагийн түрээсийн төлбөрийг бууруулахаар 1880 онд английн ахмад Чарльз К.Бойкотт эсэргүүцэл үзүүлсэн боловч Ирландчууд түүний эсрэг харилцаагаа зогсоох арга хэмжээ авсан тохиолдлоос хойш түүний нэрээр нэрлэсэн түүхтэй. Бойкот хэмээх ойлголт нь дараах гурван янзаар хэрэглэгдэж ойлгогддог. Үүнд:

1) ямар нэгэн байгууллага, хувь хүний улс төр, эдийн засгийн шаардлагыг дэмжихээс бүрэн эсвэл хэсэгчилж татгалзах, 2) ямар нэгэн зорилготой тодорхой эрх болон болзлоос эсвэл үүрэг биелүүлэхээс татгалзах, 3) тодорхой этгээдэд эсэргүүцлээ илэрхийлж харилцаагаа зогсоох үйлдлийг ойлгодог. Энэ нь ямар нэгэн хурал, цуглаанд оролцохгүй байх, тухайн нэг улс орны буюу компанийн бараа бүтээгдэхүүнийг худалдаж авахгүй байх зэргээр шийтгэл хүлээлгэх буюу шахалт үзүүлж бодлогын эсвэл үйлдлийн хэв маягийг өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагааг нэрлэдэг. Бойкотын олон үр дүнтэй стратеги байдаг бөгөөд олон хэлбэрээр хэрэгждэг. Ихэнхдээ бойкот нь богино хугацаанд шударга бус байдлыг засахад чиглэсэн хэлбэрүүд байдаг бол зарим хэлбэр нь урт хугацааны болон илүү том зохион байгуулалтын эсвэл бүтцийн хэлбэрийн байдлаар ашиглагдаж байна. Жишээлбэл, системчилсэн хөрөнгө оруулалтын хориг тавих, бизнес эрхлэгчдээ татан авах, олон улсын уриалга гаргах гэх мэт. (Я.Т)

БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР (*Contingent liabilities*) Засгийн газрын гаргасан баталгааг хангах, эсхүл үндэсний аюулгүй байдал, улс төр, нийгэм, эдийн засаг, санхүү, төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төрөөс хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээтэй холбогдон төсөвт үүсэж болзошгүй эрсдэлийг мөнгөн дүнгээр тооцож илэрхийлсний²⁴ хэлдэг. Болзошгүй өр төлбөр нь тайлангийн хугацаанд өр төлбөрөөр бүртгэгдээгүй боловч ирээдүйд төлөхөөр үүрэг хүлээж өр төлбөр болох эсвэл болохгүй ч байж болох өр юм. Болзошгүй өр төлбөрийг жинхэнэ

өр төлбөрөөс тусгаарлан авч үзэх хэрэгтэй бөгөөд ихэвчлэн санхүүгийн тайлангийн тодруулгад авч үздэг. Өр төлбөрийг үүссэн хугацаагаар нь богино хугацаатай өр төлбөр – энэ нь бизнесийн үйл ажиллагааны хэвийн цикл эсвэл нэг жил хоёрын аль уртад одоо байгаа эргэлтийн хөрөнгөөр эсвэл богино хугацаат өөр өр төлбөр үүсгэх замаар барагдах үүрэг хариуцлагыг хэлнэ. Урт хугацаатай өр төлбөр нь бизнесийн үйл ажиллагааны хэвийн орчил эсвэл нэг жилийн хугацаанд төлөгдөхгүй буюу эргэлтийн хөрөнгөөр хэмжигдэхгүй үүрэг хариуцлагыг хэлдэг. (А.Э)

БОЛОВСОН ХҮЧНИЙГ ШИЛЖ СОНГОХ (БНМАУ) (*Recruitment of officials in MPR*) Социализмын үед МАХН улс орныг удирдан чиглүүлэгч хүчний хувьд боловсон хүчнийг бэлтгэх, давтан бэлтгэх, шилж сонгох, томилох асуудлыг хариуцаж байв. Намын байгууллагууд шат шатандаа уг ажлыг хариуцаж байжээ. Боловсон хүчнийг албан тушаалын нь том багыг харгалзан намын анхан шатны байгууллагын, аймаг, хотын намын хорооны, намын төв хорооны, улс төрийн товчооны мэдлийн хэмээн хуваарилж хариуцна. Тухайн шатны намын байгууллага нь өөрийн мэдлийн боловсон хүчний жагсаалт гаргаж, албан тушаал бүр дээр 2-3 хүнийг бэлтгэх ёстой байв. Албан тушаалд орон тоо гарсан тохиолдолд уг бэлтгэгдсэн хүмүүсээс дэвшүүлэн тавих ёстой боловч заримдаа зөрчигдөж, өөр хүн томилогдох тохиолдол гардаг байсан. Боловсон хүчнийг шилж сонгохдоо улс төр, ажил хэрэг, ёс суртахууны шинж чанараар нь сонгох журамтай байжээ. Улс төрийн шинж чанар гэдэгт марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын үзэл санаанд

²⁴ Төсвийн тухай хууль

үнэнч байхыг, ажил хэргийн шинж чанарт тухайн салбарыг мэддэг, удирдах, хүнтэй ажиллах чадварыг эзэмшсэн байх, ёс суртахууны шинж чанарт шударга байх, залилан мэхлэх, улсын өмч хөрөнгө шамшигдуулахгүй байх, эхнэр нөхрөөс салаагүй байх гэх мэт олон зүйл хамаардаг байжээ. (А.Ц)

БОЛОМЖИЙН ӨРТӨГ (*Opportunity cost*)

Эдийн засгийн нөөц хязгаарлагдмал байдгаас шалтгаалж хувь хүн, байгууллага өөрийн эзэмшилд байх хөрөнгө, цаг хугацаагаа хамгийн үр ашигтай зарцуулах оновчтой шийдэлд хүрэх боломжит хувилбаруудаас сонголт хийх шаардлага үүсдэг. Ийнхүү хийж буй сонголт бүхэн өртөг, үнэ цэнэтэй. Нэг сонголтыг хийснээр нөгөө сонголтудаас олж болох байсан ашиг, өгөөжөө алддаг. Үүнийг алдагдсан боломжийн өртөг буюу сонголтын өртөг гэнэ. Сонголт буюу алдагдсан боломжийн өртгийг тооцоолохдоо аль нэг сонголтын шууд өртгөөс гадна уг сонголтын ирээдүйд үүсэх бүхий л үр дагаврын өртгийг нэмж тооцно. Аливаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх эсэх талаар “эдийн засагч” шийдвэр гаргахын тулд алдагдсан боломжийн өртгийг зайлшгүй тооцоолдог. Төрөөс хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүдийг харьцуулах, төсөл хэрэгжүүлэх арга, санхүүжилтийн эх үүсвэрийг сонгох зэрэгт сонголтын өртгийг үзэл баримтлалыг ашигладаг. Жишээлбэл, ажилтнуудаа сургалтад хамруулах эсэх сонголтыг хийхэд сургалтын шууд болон шууд бус зардлаас гадна сургалтад хамрагдах хугацаанд тухайн ажилтныг оруулан ажиллуулах үеийн цалин хөлс, бүтээмжийн өөрчлөлтөөс үүдэлтэй орлогын ашиг/алдагдал

зэрэг алдагдсан боломжийн өртгийг нэмж сонголтын өртгийг тооцоолно. Хэрэв ажилтан сурч дадлагажсаны дараа бүтээмж нь өсөж урт хугацаанд байгууллагын ашиг, орлогод эерэг нөлөө үзүүлэх бол ажилтан сургах төслийг хэрэгжүүлнэ. (Б.Б)

БОНД (*Bond*) Тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн, эсвэл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаасыг ойлгоно. Өрийн бичиг гэж бас нэрлэдэг. бонд гаргагчийн эзэмшигчидтэй холбоотой өр төлбөрийн хэрэгсэл юм. Бондын хамгийн түгээмэл хэлбэрүүд нь хотын бонд болон корпорацын бондууд юм. Бонд нь хөрөнгө оруулалтын санд байж болно эсвэл тухайн компани эсвэл засгийн газарт зээл өгөх тохиолдолд хувийн хөрөнгө оруулалтад байж болно.

Энэхүү бонд нь өрийн үнэт цаас бөгөөд үүнд үнэт цаас гаргагч нь эзэмшигчдэд өртэй бөгөөд (бондын нөхцөлөөс хамаарч) тэдэнд хүү (купон) төлөх эсвэл үндсэн төлбөрийг дараа нь дуусгавар болгох үүрэгтэй. Хүүг ихэвчлэн тогтмол хугацаанд (хагас жил, жил, заримдаа сар бүр) төлдөг. Ихэнх тохиолдолд бондыг тохиролцох боломжтой ба уг хэрэгслийн өмчлөлийг хоёрдогч зах зээлд шилжүүлэх боломжтой. Энэ нь банкны медалион дахь шилжүүлэгчид бондыг тамгалсны дараа хоёрдогч зах зээл дээр хөрвөх чадвар өндөртэй гэсэн үг юм. Иймээс бонд нь зээлийн эсвэл ОУХБ-ын хэлбэр юм: бонд эзэмшигч нь зээлдэгч (зээлдүүлэгч), бонд гаргагч нь зээлдэгч (өр төлбөр), купон нь хүү юм. Бонд нь зээлдэгчид урт хугацааны хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, эсвэл

засгийн газрын бондын хувьд урсгал зардлыг санхүүжүүлэх зорилгоор гадны эх үүсвэрээр хангадаг. Бонд ба хувьцаа нь хоёул үнэт цаас боловч эдгээрийн хоорондох томоохон ялгаа нь (капиталын) хувьцаа эзэмшигчид компанид өөрийн хувьцаа эзэмшдэг (өөрөөр хэлбэл тэд өмчлөгчид) байдаг бол бонд эзэмшигчид компанийн зээлдүүлэгчийн хувьцаатай байдаг (өөрөөр хэлбэл тэд зээлдүүлэгчид). Бонд эзэмшигчид нь зээлдүүлэгчийн хувьд хувьцаа эзэмшигчдээс давуу эрх эдэлдэг. Энэ нь хувьцаа эзэмшигчдээс урьдчилж төлөгдөх боловч дампуурсан тохиолдолд баталгаат зээлдэгчдийн ард эрэмбэлэгдэнэ. Өөр нэг ялгаа нь бонд нь ихэвчлэн тодорхой хугацаатай байдаг тул бондыг эргүүлэн төлдөг бол хувьцаа ихэвчлэн тодорхойгүй хугацаагаар үлддэг. Үл хамаарах зүйл бол эргэлт буцалтгүй бонд, жишээлбэл консол гэх мэт мөнхийн шинжтэй, өөрөөр хэлбэл хугацаа нь дуусгаагүй бонд юм. (А.Э)

БРИТАНИЙН ЭЗЭНТ ГҮРНИЙ ЗАХИРГААНЫ УЛАМЖЛАЛ (*Tradition of the administration of British empire*) Британийн төр захиргааны түүх XI зууны үед буй болсон англи саксоны феодалын түрүү үеийн төрөөс эхтэй ажээ. Эхэн үедээ хааны эрх мэдэл бага, түүнийг цэргийн удирдагч маягаар хүлээн авч сонгодог байсан боловч хаан аажмаар эрх мэдлээ өргөтгөж зоос гаргах, татвар гувчуур авах болжээ. Хааны ордон аажмаар улс орныг удирдах төв, хааны ойрын хүмүүс төрийн албан тушаалтнууд болж хувирч байжээ. Газрын том эзэд харьяаны хүмүүсээ шүүх, торгох, татвар авах, газар нутгаа хамгаалах цэрэг байгуулах зэрэг эрхтэй байсан нь хааны эрх мэдлийг хязгаарлаж байв. Хаан

Тан хэмээх захиргааны тойргуудыг захирах төлөөлөгчдийг томилон ажиллуулдаг байжээ. Витанагемот хэмээн нэрлэдэг мэргэдийн зөвлөл төрийн дээд байгууллагад хаан эзнээс гадна сүм хийдийн томчууд, баян, нэр төртэй хүмүүс оролцож, төрийн чухал хэргүүдийг хэлэлцэн шийддэг байжээ. Англи Улс гол төлөв цэргийн зориулалттай 32 тойрогт хуваагдаж байжээ. X зууны үед орон нутгийн хамгийн бага нэгж нь зуут, аравтууд байсан бөгөөд зуутыг зуутын дарга удирдан сард нэг удаа цуглаж асуудлаа хэлэлцдэг байжээ. Зуут аравтад хуваагддаг, аравтын үүрэг нь хэв журам сахиулан, татвар тушаах зэрэг байв. Харин 1154-1189 онд хаанчилж байсан Генрих II хаан өөрийн эрх мэдлээ зузаатгахын зэрэгцээ мэргэжлийн захиргаа, шүүхийг буй болгож, удирдлагыг төвлөрүүлсэн байна. Орон нутагт зуут болон тойргууд хэвээр байж, тойргийг шерифүүд захирах болсон байна. Хаан болон том феодалуудын зөрчилдөөн 1258-1267 онд удаан үргэлжилсэн иргэний дайнд хүргэж, эцэст нь чөлөөт байдлын их Харти батлагдаж, улмаар 1295 онд Парламент буй болсон байна. Орон нутагт шерифүүдийн эрх мэдлийг хязгаарлаж, тойргуудад энхийг хамгаалагч хэмээх нэртэй шүүгчдийг томилон ажиллуулах болжээ. Орон нутгийн эрх мэдэл аажмаар тэдний гарт төвлөрчээ. ХҮИ зууны үед хэмжээгүй эрхт хаант засаг тогтсон боловч Парламент нь ажилласан хэвээр, орон нутагт өөрийгөө удирдах ёс зонхилсоор байсан учир Английн засаг захиргаа Европын орнуудтай харьцуулахад төвлөрөл багатай байв. Тэр ч байтугай байнгын том арми байгаагүй байна. (А.Ц)

БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ (Grant/aid)

Олон улсын байгууллага, хандивлагч орноос засгийн газрын шугамаар эргэн төлөгдөх нөхцөлгүй, хүмүүнлэгийн болон буцалтгүй, техник туслалцааны хэлбэрээр тухайн улсад олгож буй хөрөнгийн эх үүсвэрийг хэлнэ. Тусламжийг хүлээн авч байгаа тал эргэн төлөх ямарваа нэгэн төлбөрийн үүрэг, хариуцлага хүлээдэггүй ба тодорхой төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор авч байгаа хөрөнгийг хэлнэ. Мөн нэг улс нөгөөдөө сайн дураар шилжүүлсэн аливаа төрлийн тусламж, бэлэг, эд хөрөнгийг хэлдэг. Ихэнх хүмүүс буцалтгүй тусламжийг “хөрөнгө” гэж ойлгодог боловч хүмүүнлэгийн тусламж, хоол хүнсний тусламж, хангамж, үйлчилгээний хэлбэртэй байдаг. Хөгжингүй орнууд хөгжиж буй орнуудад байгалийн гамшиг, мөргөлдөөний үе, эдийн засгийн хямралын дараа гадаадын тусламжийг үзүүлдэг. Нэгдсэн Үндэстний Байгууллага хөгжингүй орнуудад Үндэстний нийт орлогынхоо 0.7 хувийг олон улсын тусламжид зарцуулахыг шаарддаг. Дээр дурдсан гадаадын тусламж нь аль нэг орны Засгийн газраас нөгөө улсын Засгийн газарт, үндсэндээ хөгжингүй орнуудаас хөгжиж байгаа орнуудад үзүүлэх аливаа төрлийн тусламж юм. Засгийн газар нь тусламжийг дараах хэлбэрээр гаргаж болдог. Үүнд: мөнгөн хөрөнгө; хоол хүнс, хангамж, эмч, эмнэлгийн тусламж үйлчилгээ; хүмүүнлэгийн тусламж болон тэдгээрийн ажилчид; хөдөө аж ахуйн сургалтыг багтаасан сургалтын үйлчилгээ; эрүүл мэндийн үйлчилгээ; боловсрол; дэд бүтэц барихад туслах зэрэг болно. Засгийн газар нь тусламж үзүүлдэг орнуудтай гэрээ байгуулж болно. Олон улсын байгууллага, хандивлагч орон зээл олгох, тусламж

үзүүлэхээ албан ёсоор илэрхийлсэн нөхцөлд тухайн гэрээ, хэлэлцээрийг байгуулна. Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын гишүүн орнууд 2019 онд 152.8 тэрбум ам.долларыг олон улсын тусламжид зарцуулсан байна.²⁵ (А.Э)

БҮЛГИЙН СЭТГЭЛГЭЭ (Groupthink)

Аливаа асуудлыг шийдвэрлэхэд хамтын хэлэлцүүлэг, зөвлөгөөн, зөвшилцөх үйл явц буюу тухайн үйл явц дахь бүлгийн гишүүдийн бодол санаа. Хүмүүс бие биедээ харилцан нөлөөлөх (interaction) нь зөвхөн орон зай, харилцаа, хүрээгээр биш, хамтын зорилгод хүрэх, хамтран ажиллах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэдэг. Бүлгийн сэтгэлгээний эх үүсвэр нь хувь хүний бодол санаа боловч бүлэгт нэгдэх замаар илүү зөв дүгнэлт гаргахад оршино²⁶. Учир нь бүлэгт шийдвэрийг олонхын саналаар гаргадаг. Ингэж гаргасан шийдвэр зөв байх магадлал өндөр. Гэхдээ бүлгийн сэтгэлгээ нь аливаа тулгамдсан асуудлын шийдлийг олохоос илүүтэй бусад гишүүдэд зөвшөөрөгдөхөд илүү анхаардаг учраас хувь хүний өвөрмөц байдал, шинэ санааг далдлах сул талтай. Ялангуяа бүлгийн шийдвэрт оновчтой шийдлийг гаргахад ихээхэн саад болох тал бий. Үүнээс урьдчилан сэргийлэхэд байгууллага нь гишүүдийнхээ олон янз байдлыг хүлээн зөвшөөрч, өөрсдийн зорилгоо шударгаар илэрхийлж чаддаг бүлгийн гишүүдийн санал бодлыг анхаарах хэрэгтэй²⁷. (Ц,Д)

БҮЛГЭРХЭХ ҮЗЭЛ (Sectionalism)

Байгууллагын дотор бүлэг (фракт)

25 OECD: Better Policies for Better Lives. "Aid by DAC members increases in 2019 with more aid to the poorest countries." Accessed Nov. 2, 2020.

26 Боловсрол судлалын нэр томьёоны тайлбар толь бичиг (1992). Улаанбаатар, х. 920.

27 김영중, 안희남 (1997). 행정학, 법문사. p. 543. (Ким Енг Жунг, Ан Хи Нам(1997). Төрийн захиргаа судлал, Побмүн хэвлэлийн газар, х. 543.)

үүсэх үзэл буюу байгууллага дахь чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой бий болдог албан ёсны бүлгээс ялгаатай төрсөн нутаг, гарал үүсэл, сургууль, хамаарагдах ойр дотно байдал зэрэгт үндэслэн байгууллагад албан бус бүлэг үүсгэх, улмаар бүлэг хэмээх хүмүүсийн нэгдлээс үүдсэн эрх мэдэл бий болдог үзэл юм. Үүнийг ойртон дотносох онол (proximity)-ын үүднээс авч үзвэл бодгалиуд орон зай, газар нутгийн хувьд ойр холбоотой байхыг эрмэлздэг. Нэг сургууль төгссөн, нэг салбарт ажилладаг ажилтан хоорондоо бүлэг үүсгэх нь хялбар тул ийм байдлаар үүссэн бүлэг эвлэлдэн нэгдсэнээ үндэслэлтэй тайлбарлаж чаддаггүйгээс гадна тулгарсан асуудал, зорилгоо хамтдаа шийдвэрлэх боломж бага байдаг. Хэн нэгэн эсвэл нөлөө бүхий гишүүн санаа дэвшүүлэхэд нөгөө нь дэмжвэл бусад нь дагадаг. Үүнийг сэтгэл зүйн дагалт гэж нэрлэдэг. Сэтгэл зүйн дагалтыг үүсгэгч субъектив хүч бол тухайн үеийн сэтгэл зүйн хөөрөл, бялдуучлал, бусдаас сондгойрох айдас зэргээс үүдэлтэй юм. Ийнхүү тэдний эсрэг чиглэсэн асуудлын эсрэг дуу нэгтэй саналаа өгдөг байна. Ингэснээр хамтын хүчээр өөрсдийгөө хамгаалах, эсрэг талтайгаа зөрчилддөг. Энэ нь тэдний ухамсарт сэтгэхүйд бус өөрийгөө хамгаалах зөн билэгт үндэслэсэн байдаг. Асуудлыг шийдэх энэхүү өрөөсгөл үйлдлийг судлаач Ирвинг Женис бүлгийн сэтгэхүйн эмгэг гэж нэрлэсэн²⁸. Бүлгэрхэх (sectionalism) гэдэг нь эхлээд улс төрийн зан үйлийн хэв маяг буюу өмнөх үед бие даасан хэд хэдэн хүчийг бий болгохыг эрмэлзсэн үзэгдэл байсан бол орчин үед фракцилал (factionalism) эсвэл бүлэглэлтэй бараг ижил утгаар ойлгогдох болсон. Фракцын

зан үйлийн хувьд бүлгэрхэх явдал нь голдуу хөгжиж буй орнууд, тэр дундаа призматик нийгэм бүхий улс орнуудын засгийн газар, улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл, эрдэм шинжилгээний болон бусад нийгмийн бүлгүүдэд түгээмэл ажиглагддаг. Бүлгэрхэх үзэгдэл нь албан ёсны байгууллагад хүний нөөцийн бүрдүүлэлтийн үйл явцад шударга байдал, байгууллагын үр ашигтай үйл ажиллагаанд саад болдог. (Ц.Д)

БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦОО *(Integrated Registration System)*

Төр, захиргааны бүх шатны болон нутгийн удирдлагын байгууллагын бүртгэл мэдээллийн санг үндэсний хэмжээнд нэгтгэн төвлөрүүлсэн тогтолцоо. “Монгол Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бий болгох тухай” Үндэсний хөтөлбөрт бүртгэл мэдээллийн санг улсын хэмжээнд нэгтгэн төвлөрүүлж бүрдүүлэх, ашиглахтай холбоотой хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааврын уялдаа холбоог хангах, тэдгээрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар зохион байгуулахад чиглэсэн төсөл, арга хэмжээ тусгасан хэрэгжүүлж байна. Энэхүү тогтолцоог бүрдүүлэн ашиглах нь улс орны хөгжлийн бодлогыг бүрэн, зөв, бодит мэдээлэлд тулгуурлан үр ашигтай хэрэгжүүлэх ач холбогдолтой. (Д.3; Ч.Л нар)

БҮРТГЭЛИЙН СИСТЕМ *(Accounting system)*

Нягтлан бодох, бүртгэлийн үйл явц, горим, хяналтын иж бүрэн тогтолцоог хэлнэ. Бүртгэлийн системийн үндсэн зорилго нь бизнесийн орлого, зарлага ба санхүүжилттэй холбоотой бүх гүйлгээг бүртгэж авах, тэдгээрийг нэгтгэх, тайлагнахад орших бөгөөд удирдлагын зүгээс хяналт тавин, дүн

28 П.Увш, Б.Хэрлэн (2017). Байгууллагын зан үйл. Улаанбаатар. х. 102.

шинжилгээ хийж, шийдвэр гаргах, үйл ажиллагаагаа сайжруулахад ашиглана. Бүртгэлийн мэдээлэл нь зөвхөн байгууллагын дотоод хэрэгцээнд бус мөн гадны оролцогч талууд (stakeholders) болох өмчийн эзэд, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, худалдан авагч, бэлтгэн нийлүүлэгч, цаашилбал татварын алба зэрэг этгээдүүдэд байгууллагын санхүүгийн байдлыг үнэн зөв хүргэх үүрэгтэй. Бүртгэлийн систем нь байгууллагын бүх үндсэн ажиллагааг хамардаг. Үүнд үндсэн хөрөнгө, цалин, өглөг, авлага, бараа материалын үлдэгдэл, нийт өр төлбөр, өмчлөгчийн хөрөнгийн эх үүсвэр зэрэг бүрэлдэхүүн хэсгүүд орно. Бүртгэлийн систем нь тодорхой стандартад суурилан олон улсын түвшинд мөрдөгддөг (international accounting standards). Ингэснээр мэдээлэл нь нэг аргачлалын дагуу, санхүүгийн тайлан мэдээ үнэн зөв гарах, харьцуулагдах болон ил тод болох давуу талтай. Маш жижиг бизнесээс бусад ихэнх тохиолдолд бүртгэлийн систем нь цаасан дээр бус, санхүүгийн стандартчилагдсан програм хангамж (software) эсвэл үүлэн (cloud-based) технологид суурилдаг. Ийнхүү автоматжуулснаар цаг болон зардал хэмнэх, алдаа ба эрсдэл багасах, санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдал, байгууллагын бүтээмж болон үр ашиг сайжрах боломжтой болсон. Үүнийг дагаад цахим аюулгүй байдлыг хангах шаардлага үүсдэг. (Ч.Н)

БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ (Restructuring) Үгийн утгыг авч үзвэл “re” нь “буцах, дахих” гэсэн утгатай ба үүнд “structure” буюу “бүтэц” гэсэн үгийг залгаснаар “дахин өөрөөр зохион байгуулах, өмнөхөөс нь өөр болгох” гэсэн утгыг илэрхийлдэг.

Бүтцийн өөрчлөлт нь аливаа зүйлийг улам сайжруулахын тулд хийж буй шинэ өөрчлөн байгуулалт юм. Байгууллагын дотоод нэгжүүдийн хоорондох тайлагнах, эрх мэдэл хэрэгжүүлэх албан ёсны харилцааг зориудаар өөрчлөх үйл явц. Бүтцийн өөрчлөлтийг нэгж, албад нэмж байгуулах, эсвэл сулруулах, байгууллагын бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын харилцааг шинэчлэн тодорхойлох замаар хийдэг. Бүтцийн өөрчлөлт гол төлөв шат дамжлагыг арилгах, үйл ажиллагааны дэг журмыг шинэчлэн тогтоох (уян хатан), орон тоог багасгах (цомхон) зэрэг хэлбэртэй. (Т.Т)

БҮТЭЭМЖ (Productivity) Бүтээмж нь үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийг хэмжих эдийн засгийн гол үзүүлэлт бөгөөд нэгж зардлаар хэчнээн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэж байгаагаар хэмждэг. Үүний адилаар төрийн байгууллагад ашиглах нөөцийн ашиглалтын үр ашгийг илэрхийлэх үзүүлэлт нь гарц (төрийн үйлчилгээний үр дүн) ба орц (хүний, санхүүгийн болон бусад нөөц)-ын харьцаагаар илэрхийлэгдэнэ. Уламжлалт ойлголтоор ихэнх улс орны бүтээмжийг тэгтэй тэнцүү буюу орц, гарц тэнцүү байна гэж үндэсний тооцооны системд авч үздэг. Гэвч Улсын салбарын шинэ удирдлага (New Public Management)-ын үзэл санаа нэвтэрснээр төрийн бүтээмжийг хэмжих, дээшлүүлэхэд анхаарах болсон. Төр, нэг талаас эдийн засгийн харилцаанд оролцогч гол ажил олгогч, худалдан авагч, нөгөө талаас, нийгмийн үйлчилгээний салбарын гол нийлүүлэгч буюу үйлчилгээ үзүүлэгч, мөн татварын эх үүсвэрээс бүрдсэн эдийн засгийн нөөцийг зарцуулагч учир төрийн бүтээмжийн өсөлт нь улсын эдийн засгийн өсөлтөд

чухал нөлөөтэй²⁹. Бүтээмж нь улс орны эдийн засгийн өсөлтийг болон иргэдийн амьдралын стандартыг хэмжих нэг чухал үзүүлэлт гэж тооцогддог. (Б.Б)

БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН (*Universal service obligation fund*) Төрийн бодлогын хүрээнд иргэд харилцаа холбооны үйлчилгээг газар нутаг, хүн амын ялгаваргүйгээр бүх нийтэд жигд ижил нөхцөлтэй хүргэхэд чиглэсэн төсөл арга хэмжээг санхүүжүүлэх зорилготой тусгай сан. Бүх нийтийн үүргийн сан нь харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах, харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, өргөтгөх, шинэчлэхэд зориулагддаг. Тус санд хөрөнгө төвлөрүүлэх, төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулахтай холбоотой харилцааг Засгийн газрын баталсан журмаар зохицуулдаг. Улсын хөгжлийн төлөвлөгөө, салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан тус сангийн зорилгод нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр хүн амын зорилтот бүлгийн нийгмийн асуудлыг зохистой байдлаар шийдвэрлэх боломжийг олгодог. (Д.З; Ч.Л нар)

БЮРОКРАТ ТОГТОЛЦОО (*Bureaucracy*) Бюрократ тогтолцоо нь “бюро” гэдэг Франц үгнээс гаралтай ширээ, цэмбэн бүтээлэг гэсэн утгатай. XVIII зууны эхэнд Баруун европын орнуудад энэ үгээр “албан газар, оффис, албан тасалгаа, бичгийн ширээ”-г нэрлэдэг байсан бөгөөд дараа нь “kratia, kratos” буюу “эрх

мэдэл, захирах” гэсэн утгатай грек дагавар залган хэрэглэгдэх болжээ.³⁰ Бюрократ тогтолцоо нь эрх мэдлийг хэрэгжүүлэх зохион байгуулалт, арга хэрэгслийг тодорхойлохдоо эмх цэгц, дүрэм журмыг мөрдөх санаанд тулгуурласан. Германы социологич Макс Вебер төрийн захиргааны шинжлэх ухааныг үндэслэгчийн нэг бөгөөд тэрээр эрх мэдлийн гурван хэв маяг (уламжлалт, харисмагик, рационал)-ийг тодорхойлж, бюрократ онолоо дэвшүүлсэн.

Макс Вебер эрх мэдлийг рационал байдлаар хэрэгжүүлдэг байгууллагыг захиргаа (бюрократ)-ны байгууллага гээд түүний онцлох шинжийг 1) хууль, дүрэм журамд захирагдах, 2) эрх мэдлийн тогтсон хүрээтэй, түүнийг хэрэгжүүлэх албадлагын тодорхой арга хэрэгсэл, механизмтай, 3) байгууллага, албан хаагчдын харилцаанд шатлан захирах зарчим үйлчилнэ, 4) албан харилцаанд хувийн ашиг сонирхол, хүсэл эрмэлзлээр хандах учиргүй, 5) төрийн байгууллагуудын хооронд төдийгүй байгууллага дотор бичиг хэргийн албан харилцаа тогтсон байдаг гэж тодорхойлжээ. Бюрократ тогтолцоог захиргааны байгууллагын үйл ажиллагааг хянах зорилгоор бий болгосон бүтэц, дүрэм журмын нэгдлийг харуулсан үр дүнтэй загвар гэж үздэг. (Т.Т)

БЮРОКРАТ ТҮШМЭЛ (*Bureaucrat*) Энэ үг нь Францын “бюро” гэсэн үгнээс үндэстэй.³¹ Бюрократ гэсэн нэр томьёог анх Германы эрдэмтэн Макс Вебер хэрэглэсэн бөгөөд төрийн албанд ажиллаж буй албан тушаалтан, түшмэл хүн (member of a bureau-

29 Paula Linna, Sanna Pekkola: “Defining and Measuring productivity in the public sector: Managerial perceptions, in International Journal of Public Sector management, July 2010, pp. 300-319.

30 Ц.Даваадулам (2010), Засаглалын үзэл баримтлал, нэр томьёоны тайлбар толь бичиг.

31 Ц.Даваадулам (2010), Засаглалын үзэл баримтлал, нэр томьёоны тайлбар толь бичиг.

сгасу)-ийг хэлдэг байна. Веберийн бюрократ тогтолцоо нь төрийн албанд түшмэл хүнийг томилохдоо дүрэм журамд үндэслэдэг болсноор эртний захиргаанаас ялгаатай юм. Хуучин тогтолцоонд хамаатан садан, найз нөхөд, танил талын хэлхээ холбоог үндэслэн төрийн албанд томилдог байсныг халж, дүрэм журмын дагуу мэдлэг чадвартай хүнийг сонгож төрийн албанд ажиллуулдаг болжээ. Энэ нь захиргааг илүү үр ашигтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлсэн. Тухайлбал, төрийн албаны түшмэл хүний байр суурийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

- Дүрэм, журмаар тодорхой үүрэг хүлээх;
- Энгийн иргэнийг бодвол нийгмийн төлөө зүтгэх, төрийн үйл хэргийг гүйцэтгэдэг албыг залгуулах;
- Дээд шатны албан тушаалтны шийдвэрээр томилогдох;
- Албан тушаалын шатлалын дагуу доод түвшнээс эхлэн дээд түвшний шатлал хүртэл дэвшин ажиллах;
- Төрийн албанд урт хугацаагаар тогтвортой ажиллах;
- Төрийн үйл хэргийг эрхлэн гүйцэтгэх эрх зүйн баталгаагаар хангагдах (үндэслэлгүйгээр ажлаас халагдахгүй байх);
- Төрийн албанд ажилласны төлөө төрөөс тогтмол цалин хөлс авах;
- Мэдлэг чадварт суурилсан мерит зарчмаар шатлан дэвших зэрэг болно (Г.Г)

В

ВАЛЮТЫН ХАНШНЫ ДЭГЛЭМ *(Exchange rate regim)*

Макро эдийн засгийн бодлогуудын нэг бөгөөд тухайн улс өөрийн үндэсний мөнгөн тэмдэгтийн үнэ цэнийг гадаад валют болон гадаад валютын зах зээлтэй харьцуулан удирдах арга хэлбэр юм. Энэ нь мөнгөний бодлоготой нягт холбоотой бөгөөд эдийн засгийн цар хүрээ, нээлттэй байдал, инфляцын түвшин, хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдал, санхүүгийн зах зээлийн хөгжил, хөрөнгийн хөдөлгөөн зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай. Валютын тогтмол ханшийн дэглэмийн үед тухайн улсын төв банк үндэсний валютын бусад улсын валюттай харьцах ханшийг тогтмол түвшинд барьдаг. Үүний тулд төв банк нь гадаад валютын хангалттай нөөцтэй байх шаардлагатай. Давуу тал нь валютын ханш тогтмол байх тул импортын барааны инфляцын дарамт харьцангуй бага байдаг. Харин сул тал нь мөнгөний бодлогын бие даасан байдал алдагдан төлбөрийн тэнцэл зах зээлийн зарчмын дагуу тэнцвэрждэггүй. Валютын ханшны дэглэм нь: чөлөөт хөвөгч болон зохицуулагчтай хөвөгч гэж ангилна. Чөлөөтэй хөвөгч ханшийн дэглэмийн үед Төв банк үндэсний валютын ханшийг зах зээлд чөлөөтэй хэлбэлзэж

байхыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд Төв банк валютын захад оролцдоггүй. Давуу тал нь: төв банк мөнгөний бодлогоо эдийн засгийн нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх боломжтой болсноор төлбөрийн тэнцэл зах зээлийн зарчмын дагуу тэнцвэржих нөхцөл бүрддэг. Сул тал нь: валютын зах зээлд огцом хэлбэлзэл бий болох эрсдэлтэй бөгөөд валютын ханш суларснаар импортын барааны инфляцын дарамт нэмэгддэг. Зохицуулалттай хөвөгч ханшийн дэглэмийн үед валютын ханш валютын эрэлт, нийлүүлэлт буюу валютын урсгалаар тодорхойлогдох боловч валютын захад ханшийн огцом хэлбэлзэл бий болсон үед Төв банк хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор гадаад валют худалдах, худалдан авах байдлаар зах зээлд оролцдог. Давуу тал нь зах зээлийн ханшийн өөрчлөлтөд дасан зохицох, хүлээлтээ удирдах боломжийг олгосноор ААН-үүд үйл ажиллагаагаа тогтвортой удирдан явуулах нөхцөлийг бүрдүүлдэг бөгөөд мөнгөний бодлого эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах чиглэлд үр дүнтэй хэрэгжих боломжтой. Харин сул тал нь Төв банк тодорхой хэмжээгээр гадаад валютын нөөцтэй байх шаардлагатай гэж үздэг. (А.Э)

ВЕБ 2.0 (Web 2.0) Мэдээллийн технологийн мэргэжлийн бус хүмүүсийн харилцааны шинэ хэрэгсэл болсон интернэтийн хоёр дахь үеийг тодорхойлсон нэр томьёо. Веб 2.0 нь блог, нийгмийн сүлжээний сайт, вики зэрэг веб сайт ашиглан онлайн орчинд харилцах, мэдээлэл солилцох урьд өмнө байгаагүй хялбар, интерактив байдлыг бий болгох боломжийг олгосон. Ялангуяа төрийн байгууллага хооронд болон төрийн байгууллага иргэн хоорондын харилцаанд энэхүү технологийг нэвтрүүлснээр үйлчилгээ, харилцааны арга хэлбэр, үр ашиг шинэ шатанд гарах боломжтой. Веб 2.0 гэх цахим хуудас хийх технологийн дэвшлийг 1999 онд Дэври Диниччи гэх хүн анх нэрлэн хэрэглэсэн бөгөөд улмаар 2004 оноос хүчтэй хэрэглэгдэж эхэлсэн. Веб 2.0 нь товчхондоо хэрэглэгч өөрөө цахим хуудас дээр агуулга үүсгэх боломжийг олгосон цахим хуудасны технологи бөгөөд үүнд бичиж нийтлэх, сэтгэгдэл үлдээх, харилцах ярилцах бололцоог олгосон юм. Веб 2.0 нь цахим хуудас хийх технологийг бүрэн өөрчилсөн өөрчлөлт биш боловч илүү интерактив болгосноороо онцлог юм. Гол онцлог нь нийгмийн сүлжээний цахим хуудаст байдаг хэрэглэгч зураг, дуу, бичлэг болон текст нийтлэх, түлхүүр үгээр шошго үүсгэх (tagging), сэтгэгдэл үлдээх болон сэтгэгдлээ товч дээр дарж илэрхийлэх болон тухайлсан хэсгийг салган өөр хуудас дээр холбох (bookmarking) боломжтой болсон зэрэг юм. (Д.З; Ч.Л нар)

ВЕБ АГУУЛГА (Webpage content)

Веб сайтад агуулагдаж буй бичвэр, зураглал, дуу, дүрс бичлэгийн олон хэлбэрт мэдээлэл. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд веб агуулгыг хэр зэрэг мэргэжлийн

түвшинд чанартай хийж чадсаны түвшнээс тухайн мэдээллүүд зорилтот хэсэгт амжилттай хүрэх эсэх нь шалтгаална. Сайтын веб агуулгын удирдлагын системийг амжилттай хөгжүүлснээр энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой. Түүгээр дагнан мэргэшсэн агуулгын менежерийг ажиллуулах, туслалцаа авах нь веб агуулгын үр нөлөөг дээшлүүлэх чухал хүчин зүйл юм. Дэлхий Даяарх Веб (World Wide Web)-ийн мэдээллийн архитектур баримт бичигт тодорхойлсноор “веб агуулга хэмээх өргөн утгаараа цахим хуудас дээр байгаа бүхий л зүйлийг хэлнэ” гэжээ. Үүнд тухайн цахим хуудас дээр байгаа бүх текст мэдээлэл, баримт материал, өгөгдөл, веб программ, электрон үйлчилгээ, зураг, дуу, хөдөлгөөнт зураг, дүрс бичлэгийн файлууд, хувийн хуудас зэрэг зүйлүүдийг веб агуулга гэж ойлгоно. Анхлан веб агуулга гэдэгт хуудас гэдэг ойлголт давамгайлж ирсэн байдаг. Орчин үед сая сая цахим хуудас нь төрөл бүрийн өгөгдөл, дуу болон дүрс, төрөл бүрийн мэдээллийг олон янзаар хүргэдэг болсон нь веб агуулгын ойлголтыг өөрчилсөөр байна. (Д.З; Ч.Л нар)

ВЕБ АППЛИКЕЙШН (Web application)

Веб серверт байршиж хөтөч дээр ажилладаг хэрэглээний программ. Веб аппликейшн нь хэрэглэгчийн төхөөрөмжид тусгайлан суулгах шаардлагагүй тул байгууллага хэрэглэгчийн төхөөрөмжөөс үл хамааран үйлчилгээгээ хүргэх боломжийг бүрдүүлдэг. Өргөн хэрэглэгддэг жишээ нь веб-цахим шуудан, онлайн худалдаа болон онлайн банкны үйлчилгээний веб программ юм. (Д.З; Ч.Л нар)

ВЕБЕР, МАКС (*Weber, Maximilian Karl Emil, 1864-1920*) Германы социологич, эрх зүйч, улс төрийн эдийн засагч. 1882 онд Хайделбергийн их сургуулийн хуулийн ангид элсэж, дараа нь Берлиний их сургуульд шилжин суралцсан байна. 1889 онд “дундад зууны үеийн худалдааны хамтын ажиллагааны түүх” гэсэн сэдвээр докторын зэрэг хамгаалжээ. Эрдмийн зэрэг хамгаалсны дараа нийгмийн бодлогын асуудлыг сонирхон судлах болжээ. 1888 онд “Verein für Socialpolitik” хэмээх мэргэжлийн эдийн засагчдын нийгэмлэгт элссэн байна. 1894 оноос Фрайбург дэх Альберт-Людвигийн их сургуульд, 1896 оноос Хайделбергийн их сургуульд профессороор ажиллах болжээ. Тэнд “Веберийн дугуйлан” гэж нэрлэгдэх болсон сэхээтнүүдийн бүлгийн голлох хүн болсон байна. Тэр дугуйланд түүний эхнэр Марианна, нэрт эрдэмтэд Г.Еллинек, Э.Торелш, В.Сомбарт, Р.Михельс нарын олон хүн оролцож байв. Вебер 1903 оноос нийгмийн амьдралын суурь асуудлуудыг судлах болжээ. Тэрбээр нийгмийн аливаа үзэгдэл зөвхөн ганц бус олон шалтгаантай байдаг хэмээн үзэж, 1904 алдарт бүтээл “протестант этик ба капитализмын эх булаг” хэмээх зохиолоо хэвлүүлжээ. 1909 онд Германы социологийн ассоциацийг байгуулсан байна. 1919 оноос эхлээд Венийн, дараа нь Мюнхений их сургуульд багшлах болжээ. Тэр үеийн лекцүүд нь эмхтгэгдэн “Эдийн засгийн түүх”, “Шинжлэх ухаан мэргэжил болох нь”, “Улс төр мэргэжил болох нь” нэртэйгээр хэвлэгджээ. Вебер дээр дурдсан зохиолууддаа захиргааны бюрократ загварын талаар онолыг дэвшүүлсэн нь захиргааны шинжлэх ухаанд оруулсан томоохон хувь нэмэр, арга зүйн ач холбогдол бүхий юм. (А.Ц)

ВЕБ САЙТ (*Web site*) Хамаарал бүхий веб хуудаснуудыг нэгтгэсэн нэг домэйн нэртэй бүрдэл. Байгууллагын веб хуудас нь өөрийн байгууллагын болон үйлчилгээнийхээ хэрэглэгчдэд шаардлагатай мэдээллийг ойлгомжтой, хялбар, хүртээмжтэй хүргэхээр бүтцээр зохион байгуулдаг. Төрийн байгууллагын хувьд веб сайтынхаа мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулснаар бүх иргэдэд хүртээмжтэй хүргэх нь чухал байдаг. Төрийн байгууллагын веб хуудсанд тавигдах нэгдсэн шаардлагуудыг стандарт хариуцсан төрийн захиргааны байгууллага баталдаг. (Д.З; Ч.Л нар)

ВЕБ САЙТЫН АРХИТЕКТУР (*Web-site architecture*) Веб сайтыг хөгжүүлэхээс өмнө түүний техникийн, үйл ажиллагааны болон харагдах байдлын бүрдлийг загварчлах, төлөвлөх үйл явц. Веб архитектурыг веб сайтын техникийн шаардлага, үйл ажиллагааны төрх, харагдах байдал, мэдээллийн аюулгүй байдлын шалгуурын хүчин зүйлээс хамааруулан хэрэглэгч болон бизнесийн шаардлагад нийцүүлж логик бүтцийг үүсгэхэд хэрэглэгддэг. Байгууллага нь веб архитектурыг чухалчилснаар өөрийн хэрэгцээнд бүрэн нийцсэн веб сайт хөгжүүлэх боломж бүрдэнэ. (Д.З; Ч.Л нар)

ВЕБ СТАНДАРТ (*Web standards*) Вебд суурилсан агуулга үүсгэх, тайлбарлах дүрэм, холбогдох удирдамж, протоколууд, албан ёсоор батлагдсан нэгдмэл шаардлагуудын цогц бүрдэл. Төрийн байгууллагын вебсайтын шаардлагыг стандартын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална. Төрийн байгууллагуудын веб сайтад нэгдмэл байдлаар тавих стандартад

мэдээллийн хамрах хүрээ, техникийн, агуулгын, гүйцэтгэлийн, хэрэглээний болон тусгай шаардлагууд багтана. Байгууллагууд веб сайт бүтээх, ашиглахдаа тэдгээр стандартын шаардлагуудыг ханган биелүүлэх үүрэг хүлээнэ. Байгууллага веб сайтыг ажиллуулахдаа веб стандартыг бүрэн баримталснаас мэдээллийн харилцан уялдаатай байдал болон түүний тогтвортой, найдвартай байдлын баталгаа шалтгаална. (Д.3; Ч.Л нар)

ВЕБ ҮЙЛЧИЛГЭЭ (*Web service*)

Мэдээлэл солилцох, харилцан ажиллах, холбогдох стандартчилсан веб протокол (HTTP эсвэл HTTPS)-ийг хангаж өгдөг аливаа аппликейшн, программ эсвэл үүлэн технологи. Байгууллагууд өөр хоорондоо ялгаатай төрөл бүрийн программ хангамжийн систем ашигладаг. Веб үйлчилгээ нь ялгаатай системтэй байгууллага хоорондоо өгөгдөл болон мэдээлэл интернетээр дамжуулан солилцох боломжийг олгодог арга хэлбэр юм. Веб үйлчилгээ нь нэг байгууллагын системээс дундаа ашиглах зорилгоор үүсгэсэн нийтлэг веб протоколыг ашиглан өгөгдөл авах хүсэлт илгээхэд нөгөө байгууллагын систем нь хэрэглэгчийн болон хандалтын эрхийн нарийн хяналтын доор хүсэлтийн хариуг илгээх зарчмаар ажилладаг. Төрийн мэдээлэл солилцооны систем нь веб үйлчилгээнд суурилсан бөгөөд төрийн нэг байгууллага нөгөө байгууллагынхаа системд өөрчлөлт оруулахгүйгээр хүсэлт илгээж өгөгдөл болон мэдээлэл авах боломжтой. (Д.3; Ч.Л нар)

ВЕБ ХУУДАС (*Web page*) Веб хөтөч ашиглан хэрэглэгч уншихаар бүтээсэн агуулга бүхий мэдээллийн бүрдэл. Веб хуудсыг үйлчилгээний

хүртээмжээр нь бүх зочид болон хэрэглэгчид үзэх боломж бүхий нээлттэй эсвэл зөвхөн бүртгүүлсэн хэрэглэгчид үзэх боломжтой хаалттай байдлаар зохион байгуулж болдог. Агуулгыг шинэчлэх хэлбэрээр нь статик болон динамик гэж ангилдаг. Статик веб хуудас нь хэрэглэгчдэд тогтмол мэдээллийг харуулдаг бөгөөд агуулгыг шинэчлэхийн тулд сервер дээрх мэдээллийг өөрчилдөг. Динамик веб хуудас нь мэдээллийн сангаас автоматаар шинэчлэгдэж байдаг бөгөөд агуулга шинээр оруулах, шинэчлэх, засварлахад хялбар бөгөөд мэдээлэл тогтмол шинэчлэгдэж байх боломжтой. (Д.3; Ч.Л нар)

ВЕБ ХУУДАСНЫ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ (*Web Accessibility*)

Аливаа хэрэглэгч веб технологийг ямар нэг бэрхшээлгүй ашиглах боломжит байдал. Веб хуудсыг ашиглахад орон зай, цаг хугацаа, хувь хүний ялгавартай байдлаас үл хамааран адил боломжтойгоор, хамгийн хялбар дөхөм байх нөхцөлийг хангасан технологийг хэрэглэнэ. Байгууллагууд веб хуудсаа сул хараатай болон харааны бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй хэрэглэгчдэд зориулсан хувилбарыг нэмж сайжруулах болсон. Төрийн байгууллага мэдээллийг нээлттэй байлгах, мэдээлэл авах хүний эрхийг хангах бодлогын үүднээс энэхүү технологийн нөхцөлийг хангах үүрэгтэй. (Д.3; Ч.Л нар)

ВИЛЬСОН, ТОМАС ВУДРО (*Wilson, Thomas Woodrow, 1856-1924*)

Америкийн улс төрч, эрдэмтэн. Тэрбээр 1913-1921 онд АНУ-ын 28 дахь ерөнхийлөгчөөр ажиллаж байжээ. 1883 онд Жон Хопкинсийн их сургуульд улс төр судлалаар докторын зэрэг хамгаалсан. 1885-

1888 онуудад Филадельпийн эмэгтэйчүүдийн коллежид түүх, улс төр судлалын хичээл зааж, 1890 онд Принцетоны их сургуулийн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогджээ. Вильсон түүх, улс төр судлалын сэдвээр өгүүлүүд бичиж байсан ба анхны томоохон бүтээл нь 1885 онд бичсэн “Конгрессын төр” юм. Түүндээ Америкийн төрийн тогтолцоог шүүмжлэн парламентын системд илүү дөхүү байх ёстой гэсэн саналыг дэвшүүлсэн байна. Хоёр дахь том бүтээл нь 1920-иод он хүртэл Америкийн бүх сургуулиудад судалдаг байсан “Төр” юм. Түүнд төр нь хүүхдийн хөдөлмөрийг хориглох, үйлдвэрүүдийн ариун цэврийн байдлыг хянах, хортой хүнд нөхцөлд эмэгтэйчүүдийг ажиллуулахыг хязгаарлах зэргээр аж амьдралыг сайжруулах ажлыг эрхлэх ёстой хэмээжээ. Түүнчлэн төр халамжийн асуудлыг хувийн хэвшлээс авч албан ёсны үүргээ болгох хэрэгтэй гэжээ. Гурав дахь ном болох “хуваагдал ба эргэн нэгдэлт” нь XIX зууны хоёр дугаар хагасын Америкийн түүхийн гол сурах бичиг болсон. Америкийн ард түмний түүх гэдэг дөрөв дэх ном нь таван ботиор хэвлэгдсэн ажээ. 1908 онд “АНУ-ын үндсэн хуульт төр” хэмээх сүүлчийн том бүтээлээ бичсэн байна. Тэр 1887 онд “захиргааг судлахуй” хэмээх алдарт өгүүлээ бичсэн нь захиргаа судалгааны эхлэл болжээ. Тиймээс энэ үеэс захиргааны шинжлэх ухаан үүссэн гэж үздэг байна. (А.Ц)

ВИРТУАЛ БАЙГУУЛЛАГА (*Virtual organization*) Виртуал байгууллага нь байгууллагуудад технологийн дэвшил, ялангуяа мэдээллийн технологийн давуу талыг ашиглах боломжийг олгодог зохион

байгуулалтын шинэ хэлбэр.¹ Виртуал байгууллага нь урт хугацаанд зорилгодоо хүрэхийн тулд гишүүд нь мэдээллийн технологийн тусламжтай харилцаж, үйл ажиллагаагаа явуулдаг, уламжлалт хил хязгаар буюу физик байршлаар хязгаарлагддаггүй байгууллагыг хэлнэ. Виртуал байгууллага нь “мэдлэг, технологи, харилцааны менежментийн нэгдсэн, уялдаатай арга барил”-д тулгуурладаг. Виртуал байгууллагууд ихэвчлэн виртуал оффис, виртуал баг, виртуал манлайлал гэх мэт нэр томьёотой холбоотой.² Виртуал байгууллагын эцсийн зорилго бол хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэлэг, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг нэн даруй үзүүлэх явдал юм. (З.А)

- 1 Cartwright, S. (2005). The Blackwell Encyclopedia of Management: Human resource management. Blackwell Publishing Ltd, pp. 417-418.
- 2 <https://www.encyclopedia.com/management/encyclopedias-almanacs-transcripts-and-maps/virtual-organizations>



ГАЗАР ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ (*Geographic Information System* (GIS))

Эх дэлхийн тухай дүрс буюу газарзүйн зурган болон дүрс биш (шинж чанарын өгөгдөл) мэдээг хооронд нь уялдуулж, улмаар төрөл бүрийн зориулалтаар дүн шинжилгээ хийх зориулалттай мэдээллийн сангуудын цогцолбор. Газар зүйн мэдээллийн систем нь нэг талаас хэрэглэгч, судлаач, сонирхогчдод шаардлагатай мэдээллийн сан (database), нөгөө талаас уг мэдээллийн санг удирдан зохион байгуулах компьютерын иж бүрдэл (hardware), программ хангамж (software) зэргээс бүрдэнэ. Газарзүйн мэдээллийн систем, газрын мэдээллийн систем, гамшгийн мэдээллийн системийг өргөн утгаар нь орон зайн мэдээллийн систем гэж нэрлэх нь ч бий. Орчин үед газарзүйн мэдээллийн системд суурилсан мэдээллийн сангийн үйлчилгээ төрийн болон олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн болон нийтийн хэрэглээнд өргөн нэвтэрч байна. (Д.З; Ч.Л нар)

ГАЗАР ЗҮЙН ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ (*Geographic decentralization*) Geographic гэдэг нь Францын “gйographic”, Латины “geographicus” гэсэн үгнээс гаралтай. Үгийн утга нь “орон зай, нутаг дэвсгэрийн

биет шинж”-ийг илэрхийлдэг. Газар зүйн төвлөрлийг сааруулах нь тухайн улсын нутаг дэвсгэрийг тодорхой нэгжүүдэд хуваах, тэдгээрийн эрх мэдлийн зааг хязгаарыг тогтоох үйл явц юм. Нутаг дэвсгэрийн хуваарийг тогтооход шалгуур нь хүн амын хэрэгцээг хангах бол суурьшлын бүтэц, үндэстэн угсаатны онцлог, соёлыг харгалзах бол хэл, зан заншил, үр ашгийг нэмэгдүүлэх бол тэлэлтийн үр ашгийг харгалзан үздэг.¹ (Т.Т)

ГНЕЙСТ, ХАЙНРИХ РУДОЛФ ФРИДРИХ ФОН (*Gneist, Heinrich Rudolf Friedrich von, 1816-1895*) Нэрт эрдэмтэн, нийтлэлч, Прусс, Германы төрийн зүтгэлтэн. Тэрээр иргэдийн өөрөө удирдах ёсны тухай онолын анхдагчийн нэг. Тэрээр Брокауз ба Ефроны нэвтэрхий тольд: тухайн үеийн Европын төрүүд согогтой болсон гэж үзэж байжээ. Түүний үзлээр тэр үеийн нийгэмд ажиглагдаж байсан гол үзэгдэл бол ядуусын хөрөнгөтнүүдээс хамааралтай байдал, тэдний хоорондын ширүүн тэмцэл байжээ. Гэтэл төр улс байх нь нэгдэл нягтралыг шаарддаг аж. Төр улсын нэгдмэл хүсэл зоригийг буй болгохын тулд: 1. Нийгмийн янз бүрийн бүлгүүд болон намууд бие биенийхээ хэрэгцээг мэдэх хүсэл эрмэлзэл

¹ Шиаво-Кампо, Сундарам (2011), Өрсөлдөөнт ертөнцөд төрийн захиргааг сайжруулах нь, х. 172.

болон боломжтой байх, 2. Тэд төрийн удирдлагын суурь болж болох ямар нэг ерөнхий зарчмын талаар нэгдэх. Эдгээр зорилгыг биелүүлэхийн тулд үндсэн хуулийн онол болон үйлдлэг нь байнгын хэвлэл, янз бүрийн хурал цуглаан, холбоо, нийгэмлэг буй болгох, нийгмийн итгэмжилсэн хүмүүсийг үндэсний хурлуудад оролцуулж ард түмний сонирхлыг илэрхийлэх боломж олгох зэргээр нийгмийн амьдралыг хөгжүүлэх ёстой гэж үзэж байжээ. Монтескьегийн үеэс үндсэн хуульт ёс нь эрх мэдлийн хуваарилалтад тогтдог гэж үзэж байсан бол Гнейст Англи улсаар жишээ болгон өөрөө удирдах ёс дээр тогтдог хэмээн үзэж байсан аж. (А.Ц)

ГОББС, ТОМАС (*Hobbes, Thomas, 1588-1679*) Английн философич, орчин үеийн улс төрийн философийг үндэслэгчдийн нэг. Оксфордын их сургуулийг 1608 онд төгссөний дараа язгууртнуудын хүүхдүүдийн багшаар ажилласан. Тэр Бэн Жонсон, Фрэнсис Бекон нарын зэрэг алдартай хүмүүстэй хамтарч байв. 1636 онд Италиар жуулчилж явахдаа Галилео Галилейтэй уулзаж явжээ. 1640 онд Лондонд өөрийн хамгийн том зохиол болох “Левиафан буюу сүм болон иргэний төрийн хэлбэр ба засаглал” гэдэг номоо хэвлүүлсэн байна. Түүний үзэл санаанд Ф.Бекон, Р.Декарт, Г.Галилей, П.Гассенди, И.Кеплер нар хүчтэй нөлөө үзүүлсэн. Тэрбээр механик материализмын системийг буй болгож, арга зүйг нь боловсруулсан байна. Жам ёсны хуульд үндэслэн ёс суртахууны тухай номлолоо гаргажээ. Гоббс бол төрийн үүслийн тухай “гэрээний онол”-ыг үндэслэгчийн нэг юм. Тэрбээр хүмүүс “бүгдээрээ бүгдийн эсрэг” дайны байдалд аж төрж байгаад, гэрээ хийн

төрийг буй болгож, тэрхүү аюултай байдлаасаа салсан гэж үзэж байв. Жам ёсны хууль нь энх амгаланд бус аюул заналд хөтөлдөг аж. Хуулийг зөвхөн хүчээр л хэрэгжүүлдэг болгож болох ба тийм албадагч хүч нь төр гэжээ. Дээр дурдсан зохиолоос гадна “Хуулийн жам ёсны болон улс төрийн элементүүд” (1640), “Хүний мөн чанарын талаарх өгүүлэл” (1650), “Төр ба нийгмийн тухай философийн хуучирсан үзлүүд” (1651), “Амьдралын философийн үндсүүд” (1641-1655), “Эрх чөлөө ба зайлшгүйн тухай захидал” (1654), “Эрх чөлөө, зайлшгүй ба боломжийн тухай асуудлууд” (1654) зэрэг гол бүтээлүүд туурвисан байна. (А.Ц)

ГОМДЛЫН МЕНЕЖМЕНТ (*Complaint management*)

Гомдлыг хүлээж авахаас эхлээд түүнийг шийдвэрлээд хариу мэдээлэх, тайлагнах, ирүүлсэн гомдол, санал, талархал зэрэгт шинжилгээ хийж, түүний мөрөөр ажлаа сайжруулах арга хэмжээг багтаасан системтэй үйл явц. Гомдол гаргагчийн зүгээс дэвшүүлэн тавьсан асуудлыг шуурхай, шударга шийдвэрлэх нь гомдлын менежментийн зөвхөн өнгөн хэсэг нь юм. Үүний цаана иргэд гомдол саналаа чөлөөтэй илэрхийлэх боломж, гомдол саналаа илэрхийлж байгаа субъектийг хүлээж авах хандлага, ёс зүй, соёл, гомдол гаргаж байгаа шалтгаан болон түүний агуулга зэргийн нарийн шинжилгээ, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний үр дагавар, гомдлыг ажил сайжруулах үндэс болгох арга зам гэх зэрэгтэй холбоотой цогц ажил, гүн гүнзгий агуулга бий. Гомдлын менежментийг актив, пассив гэсэн хоёр төрөлд хуваан үзнэ. 1980-аад оны эхээр төрийн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн олон ажлуудын нэг нь төрийн байгууллагууд гомдлын

менежментээ сайжруулж, актив менежментийг хэрэгжүүлсэн явдал байжээ². (М.А)

ГҮДНОВ, ФРЕНК ЖОНСОН (*Goodnow, Frank Johnson, 1859-1939*)

Америкийн эрх зүйч эрдэмтэн. Амхерст коллеж, Колумбын хуулийн сургуулийг төгссөн. Дараа нь Парис болон Берлиний их сургуульд улс төр судлалаар суралцсан байна. Колумбын их сургуульд түүх, АНУ-ын захиргааны эрх зүйн багшаар ажиллажээ. 1903 онд Америкийн улс төрийн шинжлэх ухааны ассоциацийн анхны ерөнхийлөгчөөр сонгогдсон. 1913-1914 онд Юань Ши Кайн зөвлөхөөр ажиллаж байжээ. Хятадаас буцаж ирсний дараа Жон Хопкинсийн их сургуулийн ерөнхийлөгч болжээ. Түүнийг захиргаа судлал болон захиргааны эрх зүйн салбарын эхэн үеийн нэртэй судлаач хэмээн тооцдог. Тэрбээр захиргаанд хуулийг баримтлах нь гол зарчим байх ёстой гэж үзэж байжээ. Захиргааны харьцуулсан эрх зүй хэмээх бүтээлдээ /1883/ АНУ, Франц, Германы захиргааны эрх зүйг харьцуулан судалсан нь захиргааг системтэй шинжилсэн анхны бүтээл болсноос гадна харьцуулсан шинжилгээний арга зүйг буй болоход ихээхэн түлхэц болжээ. 1900 онд түүний гол бүтээл болох “Улс төр ба захиргаа: төрийг судлахуй” номоо хэвлүүлсэн байна. Тэр төр, захиргааг судлахад үндсэн хууль болон хуулиудыг шинжлэх хэрэгтэй гэж байсан хандлагыг шүүмжилж, амьдрал дээр төр, захиргаа нь хуульд заасан шиг байдаггүйг нотолсон. Хэдийгээр судалж шинжлэхийн тулд парламент “төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг,

захиргааг уг хүсэл зоригийг хэрэгжүүлдэг” хэмээн салгаж болох боловч амьдрал дээр аль аль нь төрийн хүсэл зоригийг илэрхийлэх болон хэрэгжүүлэхэд оролцдог ажээ. (А.Ц)

ГҮЙЦЭТГЭЛ (*Performance*)

Гүйцэтгэл нь аливаа нэг үйл ажиллагаа, зорилгын хэрэгжилтийн үр дүн. Зорьсондоо хүрэх, хэрэгжилт, биелэлт гэсэн утгыг илэрхийлнэ. Гүйцэтгэл ямар (сайн эсвэл саар) байгааг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр тодорхойлох бөгөөд энд гарц, үр дагавар болон үр дүнг илэрхийлэх бусад үзүүлэлтийг ашиглана³. Хүлээгдэж буй гүйцэтгэлийг гүйцэтгэлийн стандартаар тодорхойлно. Гүйцэтгэлийн стандарт нь гүйцэтгэлийн шалгуур, хэмжүүрээр өгөгдсөн тодорхой зорилго байна⁴. Тухайн ажил эсвэл зорилго ямар түвшинд хүртэл гүйцэтгэгдвэл зохилтойг буюу гүйцэтгэлийн талаарх хүлээлтийг (ямар үр дүн, ололт амжилтад хүрэхээр зорьж буйг) гүйцэтгэлийн стандарт болгон төлөвлөгөөнд тусгаж тухайн төлөвлөсөн хэмжээндээ хүртэл гүйцэтгэгдэж чадсан эсэхээр гүйцэтгэлийн түвшин буюу биелэлтийн түвшин тодорхойлогдоно. (М.А)

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ (*Performance audit*)

Аудитад хамрагдах субъектийн хэрэгжүүлсэн бодлого, тогтолцоо, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үйл явц, үр дүн, гүйцэтгэлд аудит хийхийг⁵ хэлнэ. Засгийн газар, салбар, хөтөлбөр, байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах

2 Mame Fatou Diagne, Dena Ringold, Salman Zaidi, “Governance and Public Service Delivery in Europe and Central Asia: Unofficial Payments, Utilization and Satisfaction”, 2012, p. 1.

3 Anne Ketelaar, Nick Manning, Edouard Turkisch, “Performance based Arrangements for Senior Civil Servants OECD and other Country Experiences, p. 8.

4 Цэнд Н., Батхүрэл Г., Шуурав Я., ... нар, Менежмент, 2013, 220 дахь тал.

5 Төрийн аудитын тухай хууль

зорилгоор арвич хямгач, үр ашигтай, үр нөлөөтэй байх гурван зарчмын аль нэг ба заримынх нь байр сууринаас хараат бус, бодитой шалгадаг шалгалт юм. Гүйцэтгэлийн аудит нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг шалгахад чиглэгддэг. Үүнд дараах зүйл хамаарна: (а) захиргааны зохистой зарчим, практик, менежментийн бодлогын дагуу захиргааны үйл ажиллагааны арвилан хэмнэлтийг шалгах аудит; (б) хүн хүч, санхүүгийн болон бусад нөөц ашиглалтын үр ашгийг шалгах, үүний дотор мэдээллийн тогтолцоо, гүйцэтгэлийн хэмжүүр, хяналт шинжилгээний журам, дутагдлаа арилгах талаар гүйцэтгэж буй ажлыг шалгах аудит; (в) шалгагдагч байгууллагын үйл ажиллагаа нь тавьсан зорилтын биелэлттэй харьцуулахад хэр үр нөлөөтэй байгааг шалгах аудит, ба төлөвлөсөн үр өгөөжтэй харьцуулахад үйл ажиллагааны бодит үр өгөөж ямар байгааг шалгах аудит зэрэг болно. Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Байгууллага (INTOSAI): гүйцэтгэлийн аудит нь байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай ба үр дүнтэй байдалд хийж байгаа аудит юм. Энэ тодорхойлолттой уялдан гүйцэтгэлийн аудитын хүрээнд дараах асуудлыг багтаадаг. А) Байгууллагын баримтлах зарчим, үйл ажиллагаа, удирдлагаас хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд байгууллагын нөөцийн хэмнэлттэй эсэхэд аудит хийх; Б) Гүйцэтгэлийг хэмжих зарчим, мэдээллийн систем, мониторингийн үйл ажиллагаа, аудитаар илэрсэн асуудлыг засаж сайжруулах үйл явцыг шалгах ажлыг багтаан, байгууллагын хүний, санхүүгийн болон бусад нөөцүүдийг үр ашигтай зарцуулж байгаа эсэхэд аудит хийх; В) Байгууллагын

зорилго, зорилтыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн бодит үр дүнг хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулан аудит хийх.⁶ Гүйцэтгэлийн аудит: өртөг зардал, бүртгэлийг бус гүйцэтгэлийг илүү анхаардаг тул засгийн газар, салбар, тухайн байгууллагын түвшинд хийж болно. (А.Э)

ГҮЙЦЭТГЭЛИЙН ГЭРЭЭ (*Performance contract*) Өгөгдсөн хугацаанд урьдчилан тодорхойлсон гүйцэтгэлийн түвшинд хүрэх зорилгоор хувь хүн эсвэл байгууллагын гүйцэтгэх үүргийг албан ёсоор хуулийн хүрээнд баталгаажуулсан баримт бичиг. Энэхүү гэрээ нь төрийн байгууллага хооронд, төрийн байгууллагын дотор удирдах ажилтан болон албан хаагчийн хооронд, мөн түүнчлэн төрийн болон хувийн байгууллагын хооронд гэх мэтээр хэд хэдэн төрлөөр хийгдэнэ. Гэрээнд талуудын гүйцэтгэх үүрэг, эрх, хүлээх хариуцлага, хүрэхээр төлөвлөсөн зорилго, хүлээгдэж буй гүйцэтгэлийн түвшинг харилцан тохиролцсоны үндсэн дээр тодорхой тусгана. Гүйцэтгэлийн гэрээ нь төрийн шинэтгэлийн хүрээнд үр ашигтай, үр дүнтэй ажиллах шаардлагын улмаас хэрэглэгдэж буй менежментийн хэрэгсэл бөгөөд эзэн агентын онолд суурилна. (М.А)

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ (*Performance objective*) Төлөвлөсөн хугацаанд хүрэхээр тэмүүлж буй гүйцэтгэлийн үр дүн. Үүнийг өөрөөр “төлөвлөсөн хугацаанд хүлээгдэж буй үр дүн” эсвэл “гүйцэтгэлийн стандарт”⁷ гэж тодорхойлж болно. Гүйцэтгэлийн зорилтыг тодорхой, ойлгомжтой байх, хэмжигдэхүйц

6 Улсын салбарын дотоод аудитын аргачлал 2020 Сангийн яам, х. 123.

7 Гүйцэтгэлийн стандарт гэдэг нь гүйцэтгэлийн шалгуур, хэмжүүрээр өгөгдсөн тодорхой зорилго, зорилт байна.

байх, төлөвлөсөн нэг жилийн хугацаанд хүрэх боломжтой, бодитой байх буюу SMART шаардлагыг хангасан хэмжээнд тодорхойлж томьёолно. Хэрэв төрийн байгууллага, албан хаагчийн гүйцэтгэлийн зорилт хэт ерөнхий, хэмжигдэх боломжгүй тодорхойлсон бол тухайн зорилтын биелэлтийг дүгнэх боломжгүй болно. Тиймээс гүйцэтгэлийн зорилтод SMART байх шаардлага тавигддаг. Жишээлбэл сургуулийн өмнөх боловсрол олгодог байгууллагын хувьд “хамран сургах тойргийн хүүхдүүдийн 70 хувьд сургуулийн өмнөх боловсролыг олгоно” гэх мэт. Монгол Улсын төрийн албаны тухай хууль болон түүнийг дагаж гарсан журамд төрийн байгууллага, төрийн жинхэнэ албан хаагч бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй байх, уг төлөвлөгөөнд гүйцэтгэлийн зорилт болон зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тусгасан байх тухай заажээ. (М.А)

ГҮЙЦЭТГЭЛИЙН МЕНЕЖМЕНТ ЗАГВАР (*Performance management model*) Төрийн захиргаа нь нийгмийг манлайлах явцдаа түүчээлэн шинэчлэгдэж, өөрчлөгдөн хөгждөг. Нийгмийн хөгжлийн явцад “дэвшилтэт” байсан загвар цаг үеэ даган өөрчлөгдөнө. XIX зууны эцэс ХХ зууны эхээр төрийн захиргааны дэвшилтэт хэлбэрийн загвар нь өрнөдөд дэлгэрсэн. Загварын гол зорилго нь төрийн удирдлага дахь хээл хахууль, албан тушаал урвуулан ашиглах, хүнд суртал, мэргэжлийн чадваргүй байдал, үрэлгэн байдлыг арилгахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэ загварт байдаг 2 үндсэн ойлголт нь хувийн салбараас ангид оршиж улс төрийн албан тушаалтан, төрийн албан хаагч хоёрын хооронд тодорхой зааг хязгаартай байлгах явдал юм..

Үүний шалтгааныг: 1.Улс төрийн өндөр албан тушаалтан хээл хахууль эрх ямбанд дуртай төдийгүй ямар ч аргаар хамаагүй хөрөнгөжих сонирхолтой 2. Бизнес эрхлэгчид нийлэн олигархи ноёрхол тогтоох, хуулийн цоорхой ашиглан хууль гажуудуулахаас гадна ямагт олз, ашгийн төлөө явдаг хэмээн Б.Карлин тодорхойлжээ. Энэ загвар өрнөдийн орнуудын нийгмийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан. Төрийн захиргааны тогтолцоог бодлого боловсруулахаас илүүтэй менежментэд шилжүүлэн, үйл явцаас илүү үр дүнд шилжих, захиргаадсан удирдлагаас бүтээгдэхүүн үйлчилгээ, өрсөлдөөнд шилжүүлэн, цалингийн олон шатлалт хэлбэрт сүлжээг бий болгон тушаал, шийдвэрээс илүү гэрээт тогтолцоонд шилжсэн. Улсын салбарын удирдлага буюу төрийн захиргаанд шинэ менежментийн (ТЗШМ) загвар нэвтрүүлснээр төрийн захиргааны ажил үйлчилгээ олон нийтэд нээлттэй ил тод байх боломж бүрдэж, үйл ажиллагаанд нь иргэд хяналт тавих, үр дүнг гүйцэтгэлээр тооцох, бүтээгдэхүүний чанарыг тодорхойлох болсон. (А.Эц)

ГҮЙЦЭТГЭЛИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ОНОЛ (*Performance satisfaction theory*) Портер (L.W.Porter) ба Роллер (E.E.Lawler)⁸ нарын дэвшүүлсэн байгууллагын гишүүний ажилдаа хандах хандлага, гүйцэтгэл хоорондын уялдаа холбооны тухай сэдэлжүүлэлтийн онол юм. Энэ онол нь ажилтнуудын хүчин чармайлт (effort), гүйцэтгэл (performance), шагнал урамшуулал (reward), сэтгэл ханамж (satisfaction) гэсэн хувьсагчдын харилцан хамаарлыг голлон судалдаг учраас англи үгсийн эхний үсгийн

⁸ 한호섭 (1999). 행정학 용어사전. 서울, 행정학용어표준화연구회. 새 정보 미디어

товчлолоор түүнийг “EPRS онол” гэж нэрлэдэг байна. Мөн амжилтыг гүйцэтгэлийн үр дүнгээр хэмждэг учраас “Гүйцэтгэлийн сэтгэл ханамжийн онол” ч гэж нэрлэнэ. Гүйцэтгэлийн сэтгэл ханамжийн онолыг Бром (V.H.Vroom)-ын хүлээлтийн онол дээр үндэслэн боловсруулсан боловч тухайн онолоос ялгаатай нь сэтгэл ханамжийг гүйцэтгэлийн хүчин зүйл гэж үздэггүй. Харин эсрэгээрээ ажлын гүйцэтгэлийн үр дүн нь ажлын сэтгэл ханамжийн шалтгаан гэж үзэх бөгөөд сайн үнэлгээ, хүчин чармайлтын үр дүнд шагнал урамшуулал ирдэг гэсэн хүлээлтээр тодорхойлогддог байна. Тиймээс энэхүү онол нь шагнал урамшуулал байгууллагын гишүүдийн хичээл зүтгэл, амжилтад нөлөөлдөг гол хүчин зүйл гэж үздэг⁹. (Ц.Д)

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (Performance plan) Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх зорилго, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийн төлөвлөгөө зэргийг багтаасан баримт бичиг. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах нь гүйцэтгэлийн удирдлагын цикл үйл ажиллагааны эхний алхам. Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь байгууллага, түүний доторх нэгж эсвэл албан хаагчийн өсөлтийн төлөвлөгөө байна. Тухайлбал албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө нь 1) үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, 2) тодорхойгүй нөхцөл байдлаас зайлсхийх, 3) албан хаагчийн ажлаа гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг чадварыг тодорхойлсноор ажилтан илүү бүтээмжтэй ажиллахад дэмжлэг үзүүлэх, 4) албан хаагч илүү идэвх санаачилгатай ажиллахад чиглэсэн

карьерын хөгжлийн төлөвлөгөөг бий болгох ач холбогдолтой. (М.А)

ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГА (Performance management) Гүйцэтгэлийн удирдлага нь хувь хүн болон багийн гүйцэтгэлийг хөгжүүлэх замаар байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах системтэй үйл ажиллагаа юм¹⁰. Гүйцэтгэлийн удирдлага нь “гүйцэтгэлийг төлөвлөх”, “төлөвлөснийг хэрэгжүүлэх, хянах”, “гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх”, “үнэлгээний мөрөөр урамшуулах, хариуцлага тооцох” гэсэн дөрвөн үе шат бүхий үйл ажиллагаанаас бүрдэнэ¹¹. Монгол Улсын төрийн салбар дахь гүйцэтгэлийн удирдлагын хөгжлийг (1990 оноос хойших үе) дөрвөн үе шатанд хуваан үзсэн байдаг. Үүнд: 1) Орц, үйл ажиллагаанд суурилсан гүйцэтгэлийн удирдлагын үе (1990-1994), 2) Гүйцэтгэлийг зорилго, зорилтоор удирдахыг чухалчилсан үе (1995-2001), 3) Гарцад суурилсан гүйцэтгэлийн удирдлагын үе (2002-2011), 4) Үр дүнд суурилсан гүйцэтгэлийн удирдлагыг чухалчилсан үе (2012 оноос хойш) үе шатаар хөгжжээ¹². (Т.Т; М.А нар)

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (Performance appraisal) Ажилтан, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн болон байгууллагын стратеги зорилго, зорилтын хэрэгжилтэд оруулсан тухайн ажилтны хувь нэмрийг үнэлдэг системтэй үйл ажиллагаа. Гүйцэтгэлийг үнэлэх үйл явц нь тухайн ажилтан, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн

10 Michael Armstrong, “Armstrong’s Handbook of Performance management”, 2009, p. 9.

11 Удирдлагын Академи, “Төрийн захиргааны байгууллага дахь гүйцэтгэлийн удирдлагын хэрэгжилт”, 2017, 8 дахь тал.

12 Удирдлагын Академи, “Төрийн захиргааны байгууллага дахь гүйцэтгэлийн удирдлагын хэрэгжилт”, 2017, 47 дахь тал.

9 오석홍 (1990). 조직관리. 서울, p. 216.

өнөөгийн түвшинг хэмжиж, түүнийг гүйцэтгэлийн талаарх хүлээлт эсвэл гүйцэтгэлийн стандарттай харьцуулна. Тухайн ажилтан, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, ололт амжилт буюу ажил үүргийн биелэлтийг үнэлэхээс гадна тухайн албан хаагчийн мэдлэг, ур чадвар, ажилдаа хандах хандлага, цаашид хөгжих чадавх боломж, гаргасан санаачилга зэргийг гүйцэтгэлийн үнэлгээнд нэгтгэн дүгнэнэ. Ажилтан, албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг ихэвчлэн улирал, хагас жил, жилийн эцэст хийдэг. Энэхүү үнэлгээ нь тухайн ажилтан, албан хаагчийн цалинг нэмэгдүүлэх, урамшуулах, эсвэл албан тушаал дэвшүүлэх, ажлаас халах гэх зэрэг шийдвэрийг гаргахад ашиглагдана. Иймээс гүйцэтгэлийн үнэлгээ нь нэг талаас идэвхжүүлэл, нөгөө талаас хариуцлагыг сайжруулах хэрэгсэл болдог. (М.А; Т.Т; А.Э нар)

ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЭМЖИЛТ (*Performance measurement*) Зорилго, зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт ямар түвшинд байгааг шалгуур үзүүлэлтийн дагуу хэмжиж тодорхойлох үйл ажиллагаа. Энэ үйл ажиллагааны үр дүнд ахиц дэвшил гарч байгааг тодорхойлно. Гүйцэтгэлийн хэмжилт хийхэд шалгуур үзүүлэлт (хэмжих үзүүлэлт) шаардлагатай бөгөөд уг шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээ, мэдээлэл цуглуулж, түүнд шинжилгээ хийх замаар ахиц дэвшил гарч байгаа эсэхийг тодорхойлж тохирсон шийдвэрийг гаргана. Жишээлбэл: тариаланч хүний ажлын үр дүнг нэг га талбайгаас хэчнээн хэмжээний ургац авч байгаагаар хэмжинэ гэж үзвэл гүйцэтгэлийн хэмжилтийг хийхдээ га тутмаас авсан ургацын хэмжээ буюу тонн, центнерээр тодорхойлно. (М.А)

ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ (*Performance indicator*) Аливаа ажлын гүйцэтгэлийн үр дүнг тодорхойлодог үзүүлэлт. Зорилго, зорилт болон төлөвлөсөн ажил, арга хэмжээ амжилттай эсвэл амжилтгүй хэрэгжсэнийг тодорхойлоход юу хэмжээнийг тодорхойлох нь түүний шалгуур үзүүлэлт. Төрийн байгууллага, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг ямар шалгуур үзүүлэлтээр хэмжиж байгаагаас тухайн байгууллага, ажилтан юунд тэмүүлж, ямар үр дүнгийн төлөө ажиллах нь тодорхойлогдох учраас ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлох нь чухал. Жишээ нь: өргөдөл, гомдол хүлээн авч, шийдвэрлэдэг албан хаагчийн ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь хүлээн авч шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо байвал тухайн албан хаагч аль болох олон өргөдөл, гомдол хүлээн авахын төлөө чармайна. Харин нэгж өргөдөл гомдлыг шийдвэрлэж буй дундаж хугацаагаар ажлын үр дүнг нь хэмждэг бол тухайн албан хаагч өргөдөл, гомдол нэг бүрийг аль болох богино хугацаанд шийдвэрлэхийг чармайн ажиллана. Ажлын гүйцэтгэлийн үр дүнг хэмжиж болох олон шалгуур үзүүлэлт байх ч түүнээс гол, түлхүүр үзүүлэлтийг нь сонгон хэрэглэх нь чухал. Иймээс шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо гүйцэтгэлийн үр дүнг тухайн үзүүлэлтээр шууд, оновчтой илэрхийлэх боломж, тухайн үзүүлэлтийн дагуу хэмжилт хийж өөрчлөлтийг тодорхойлох боломж, шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээ, мэдээлэл цуглуулах боломж, мэдээлэл цуглуулахад гарч болох өртөг зардал зэргийг харгалзана. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт нь гүйцэтгэлийн удирдлагын үйл ажиллагааны бүхий л үе шатанд ашиглагдана. (М.А)

ГҮЙЦЭТГЭХ (Implementing) Хууль тогтоомж, дүрэм журам, удирдлагын өгсөн үүрэг даалгаврын дагуу үйл ажиллагаа явуулах, үйл явцыг гүйцэтгэх, сайжруулахад чиглэсэн тасралтгүй явагдаж буй үйл явц юм. Төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналт, үнэлгээ нь үйл явцын гурван хэмжигдэхүүний нэг бөгөөд засгийн газар бодлогыг төлөвлөх, хувилбарыг дэвшүүлэх, батлагдсан бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хэрэглэгддэг. Бодлого төлөвлөж, хэрэгжүүлэхээс гадна арга хэмжээ, тушаал шийдвэр, үүрэг даалгаврыг гүйцэтгэх гэх мэт “үйл явц”-тай уялдаатай бүхий л үйл ажиллагаанд “гүйцэтгэх” хэмээх үг нийтлэг ашиглагддаг. (Г.Б)

ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ (Executive governance) Гүйцэтгэх засаглал нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, албан тушаалтныг томилох, гадаад, дотоод бодлого боловсруулдаг хүмүүсээс бүрдсэн төр засгийн нэг салаа юм. Ардчилсан улсад гүйцэтгэх засаглал нь сонгуулиар ялалт байгуулан гарч ирсэн удирдагчдын зааврын дагуу ажилладаг бол дарангуй дэглэмд дарангуйлагчийн хэлсэн хүссэн бүхнийг биелүүлдэг. Гүйцэтгэх засаглал нь хууль тогтоох болон шүүх засаглалтай хяналт, тэнцвэртэйгээр хамтран ажилладаг. Энэхүү хяналт, тэнцвэр алдагдвал улс төрийн хямрал бий болох, цаашлаад мөргөлдөөн үүсэх нэг шалтгаан болдог. Парламентын засаглалын үед гүйцэтгэх засаглал нь хууль тогтоох байгууллагын өмнө хариуцлага хүлээж, хэрвээ хариуцлага алдвал итгэл үзүүлэх, эс үзүүлэх санал хураалт явуулдаг. Гүйцэтгэх засаглалын тэргүүн нь ерөнхийлөгчийн засаглалтай оронд ихэвчлэн ерөнхийлөгч, парламентын засаглалтай оронд ерөнхий сайд байдаг. (Ж.Ж)

ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД (Executive agencies)

Гүйцэтгэх засаглалын байгууллагууд нь төрийн үйл ажиллагааны залгамж чанарыг таслахгүй хангаж ажиллах үүрэгтэй. Гүйцэтгэх засаглалын байгууллагыг сонгуулиар гарч ирсэн улс төрийн албан тушаалтан, аль эсвэл тухайн салбарын өндөр мэдлэг, чадвартай мэргэжилтэн, экспертүүд удирддаг. Уг байгууллагууд улсын нийслэлд төвлөрөн байрлах боловч зарим байгууллагууд нь улс орон даяар нэгж, салбартай, мөн орон нутгийн захиргааны нэг хэсэг болж үйл ажиллагаа явуулдаг. Гүйцэтгэх засаглалын байгууллагууд нь сонгуулийн үр дүнгээс үл хамааран үйл ажиллагаа нь тасралтгүй явагдан бүтцийн томоохон өөрчлөлтүүд байнга хийгддэггүй. Гүйцэтгэх засаглалын байгууллагууд нь босоо болон хэвтээ түвшинд ажилладаг бөгөөд босоо түвшинд шийдвэр нь төвлөрсөн, түвшин бүрд хяналттай байдаг бол хэвтээ түвшний байгууллагын шийдвэр төвлөрсөн бус, хамтын хяналттай байдаг онцлогтой. Босоо түвшинд пирамидын оройд улс төрийн албан тушаалтнууд байх бөгөөд тэд юу хийх ёстойг шийдвэрлэнэ. Шийдвэр шат шатанд дээрээс доошоо хэрэгжсээр иргэнд төрийн бодлогын үр дүн болж хүрнэ. Судлаачид газар зүйн загварыг ашиглаж гүйцэтгэх засаглалыг өөрөөр тайлбарладаг. Өндөр, нам уул толгод, хөндийд иргэд амьдрах бөгөөд уул толгодын оройд гүйцэтгэх засаглалын байгууллагууд байрладаг ч гэж хэлдэг. (Ж.Ж)

ГУЛИК, ЛЮТЕР ХАЛСЕЙ (Gulick, Luther Halsey, 1892-1993) Америкийн улс төр судлалын эрдэмтэн, 1914 онд Оберлин коллеж төгсөж, 1920 онд Колумбын их сургуульд докторын

зэрэг хамгаалжээ. Колумбын их сургуульд багшилж байсан ба 1921 онд тус сургуулийн Нийтийн захиргааны институтын ерөнхийлөгч болж уг албыг 1962 он хүртэл хашсан. Улмаар институтын даргаар 1982 он хүртэл ажиллажээ. 1937 онд Ерөнхийлөгч У.Рузьвелт түүнд холбооны улсын гүйцэтгэх салбарт өөрчлөлт хийх ажлыг хариуцуулсан. Багшлахын зэрэгцээ янз бүрийн байгууллагад ажиллаж байснаас 1954-1956 онуудад Нью-Йорк хотын захирагчийн ажил хийж байжээ. Захиргааны чиглэлээр судалгаа хийж, олон бүтээл бичсэн байна. Тэр захиргааны чиг үүргийг тодорхойлсноороо нэрд гарсан. Англи нэрсийн дэс дарааллаар POSTCORB (Planning, Organizing, Staffing, Directing, Co-ordinating, Reporting, Budgeting) гэж товчилдог үүргүүдийг захиргааны чиг үүрэг гэж тодорхойлсон байна. Эдгээрийг монголчилбол, төлөвлөх, зохион байгуулах, чиглүүлэх, уялдуулах, илтгэх, төсөвлөх. Түүнчлэн улс төр ба захиргааг салгуу байлгах тухай яриа их өрнөж байх үед эдгээрийг салгах боломжгүй хэмээн үзэж байжээ. Дэлхийн 2-р дайны үед Кейнсийн үзэл бодлыг ихэд дэмжиж байсан. Гүликийн бүтээлүүдээс “Evolution of the Budget in Massachusetts 1920”, “Administrative Reflections from World War II.1948”, “American forest policy. 1951”, “The Metropolitan Problems and American Ideas. 1966” зэрэг ном болон “Notes on the Theory of Organization.” “Science, values and public administration” зэрэг өгүүллийг захиргааны шинжлэх ухаанд хувь нэмэр оруулсан онцлох бүтээл гэж үздэг ажээ. (А.Ц)

ГЭРЭЭЛЭХ (Contracting out) “Contract” нь Латины “contractus” үгнээс үндэстэй. Үгийн утга нь анх (XIV зууны сүүл) “to draw into a small-

er compass, become smaller” буюу “гортиг хүрээг хумих, илүү жижиг болгох”, XV зууны эхээр “make an agreement, enter into a contract” буюу “гэрээ хэлцэл хийх, хоёр тал харилцан үүрэг хүлээх” гэсэн санааг илэрхийлдэг байв. Гэрээ нь хоёр ба түүнээс дээш талын хооронд хийсэн тохиролцоо юм. Энэхүү тохиролцоо нь талуудын эрх, үүргийг бий болгох, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэгдэнэ. Гэрээлэх ойлголт нь 1980-1990-ээд онд ЭЗХАХБ-ын гишүүн орнууд, Тэтчерын засгийн газар 1979 оноос хойш төр нь үйлчилгээг хувийн салбараас илүү үр ашигтай нийлүүлж чаддаггүй хэмээн үзэж улсын салбарын үүрэг, хэмжээг багасгах бодлого тууштай баримталсан. Үүний дүнд төрийн шат шатны байгууллагууд үйлчилгээг шууд нийлүүлэх нь буурч, өрсөлдөөнт зах зээл, төрийн ба хувийн, түүнчлэн төрийн бус байгууллагуудын хоорондох гэрээний дагуу хүргэх болсон юм. Нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлах үзлийн гол үндэс нь зардал бууруулах (хэмнэлт), үр ашиг хоёр байв. Ийнхүү төрийн салбарт ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай ойлголт орж ирсэн нь өнөөгийн гэрээний удирдлагын тухай үзэл санааг бий болгожээ. Гэрээний удирдлага (contract management) нь хоёр тал гэрээ байгуулах журмаар төрийн ажил, үйлчилгээг хэрхэн үр дүнтэй удирдах, зохион байгуулах тухай арга ухаан юм. Гэрээний удирдлага нь засгийн газрын хэрэгжүүлж буй ажил, үйлчилгээг хувийн болон сайн дурын эсвэл засгийн газрын бусад байгууллагуудтай гэрээ байгуулах журмаар хүргэж болно гэж үздэг. Засгийн газраас урьд өмнө санхүүжүүлж, хэрэгжүүлж байсан үйл ажиллагааг хувийн салбарт шилжүүлэх үйл явцыг хамаатуулж

ойлгоно. Гэхдээ ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлснээр засгийн газар үйлчилгээ хүргэх, явцыг хянах, чанарын төлөөх хариуцлагаас чөлөөлөгддөггүй. (Т.Т)

ГЭРЭЭТ АЖИЛТАН (*Contract worker*)

Гэрээт ажилтан нь харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр шаардлагатай байгаа ажлыг гүйцэтгэж буй мэргэжлийн баг, ажилтанг хэлнэ. Лонгманы толь бичигт гэрээт ажилтан нь тухайн байгууллагад тодорхой нэг ажил хийх гэрээтэй боловч байгууллагын үндсэн ажилтанд тооцогдохгүй гэжээ. Гэрээний ажилтан ба үндсэн ажилтны ялгаа нь бие даасан гүйцэтгэгч ба ажилтанд ижил эсвэл ижил төстэй ажлын хөлс төлж болох боловч эрх зүйн ялгаатай. Гэрээт ажилтан нь ажил олгогчтой тохиролцсон цалин хөлсөөр тодорхой ажил гүйцэтгэхээр ажил олгогчтой гэрээ байгуулдаг ажлын төрөл юм. Байнгын ажилтнаас ялгаатай нь ихэвчлэн гэрээт ажилтан тодорхой хугацаанд ажилладаг. Ажилтны хувьд байгууллага нь цалин хөлснөөс орлогын албан татвар, нийгмийн ба эрүүл мэндийн даатгал суутгадаг. Хараат бус гэрээлэгчээс байгууллага татвар суутгахгүй. Төлбөр төлөгч нь юу хийх, хэрхэн хийхийг биш харин зөвхөн ажлын үр дүнг хянах эсвэл чиглүүлэх эрхтэй ба гэрээт ажилтан нь бие даасан гэрээт гүйцэтгэгч гэсэн ерөнхий дүрэм үйлчилнэ. Бие даасан гэрээт ажилтнаар ажиллаж байгаа хүний орлогоос хувиараа хөдөлмөр эрхлэх албан татвар ногдуулдаг. (А.Э.ц)

Д

ДААТГАЛ (*Insurance*) Эдийн засаг, нийгмийн амьдралын хэвийн үйл явцыг алдагдуулдаг, урьдчилан тооцоолох боломжгүй гэнэтийн тохиолдлын улмаас эдийн засгийн харилцаанд оролцогчдод учрах эрсдэлийг нөхөх, хуваалцах арга хэрэгсэл юм. Даатгалын харилцаа нь гэрээний үндсэн дээр зохицуулагдах бөгөөд нэг талаас даатгуулагч нь аливаа эрсдэлийн нөхцөлд өөрийн эд хөрөнгө, ашиг сонирхолд учирч болох хохирлыг нөхөх баталгаатай байхад урьдчилан тохиролцсон болзлоор нөхөн төлбөр авах зорилгоор даатгуулж, хураамж төлөх, нөгөө талаас даатгагч нь даатгуулагчид учирсан хохирлыг бүрэн буюу зарим хэсгийг төлөхөөр үүрэг хүлээж, эрх эдлэх харилцаа юм. Даатгалыг заавал, эсвэл сайн дураар даатгуулах гэж үндсэн хоёр хэлбэрт хуваана. Заавал даатгуулах даатгалын зохицуулагч нь төр байдаг бөгөөд ийнхүү зохицуулах, хянах эрхийг даатгалын асуудал хариуцсан зохицуулагч байгууллагаар дамжуулан хэрэгжүүлдэг. Түүнчлэн даатгалын төрөл, хариуцлагын хэлбэр, хүрээ, даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх харилцаа, түүний үр дагаврыг хуулиар зохицуулдаг. (Б.Б)

ДААТГАЛЫН ГЭРЭЭ (*Insurance contract*) Гэрээ нь хоёр буюу хэд хэдэн этгээд тодорхой асуудал, нөхцөлөөр харилцан үүрэг хүлээх талаар тохиролцож, хуулийн дагуу үйлдсэн бичиг баримт бөгөөд даатгалын гэрээний тухайд даатгуулагчийн зүгээс хураамж төлөх, даатгагчийн зүгээс даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд нөхөн төлбөр олгох харилцааг зохицуулдаг. Даатгалын гэрээнд хугацаа, даатгах зүйл, даатгах тохиолдол, хохирлыг тогтоож үнэлэх аргачлал, нөхөн төлбөр олгох нөхцөлийг нарийвчлан тусгадаг. Даатгалын гэрээ хүчин төгөлдөр болохыг баталж даатгалын баталгааны хуудсыг даатгагчаас бичиж олгоно. (Б.Б)

ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР (*Insurance Reimbursement*) Энэ нь даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд гэрээний дагуу даатгуулагчид олгох мөнгөн төлбөр юм. Өөрөөр хэлбэл, эд материал, үнэт зүйлс, хариуцлага, амь нас, эрүүл мэнд, ашиг сонирхол зэрэг даатгалын зүйлд учирсан хохирлыг нөхөн төлөх мөнгөн дүн юм. Даатгалын нөхөн төлбөр олгох нөхцөл, нөхөн төлбөрийн хэмжээг тооцох аргачлал, нотолж үндэслэх баримт зэргийг эрх зүйн актаар зохицуулсан байх бөгөөд

даатгалын үйл ажиллагаанд оролцогч талууд дагаж мөрддөг. Даатгалын гэрээнд заасан тохиолдолд нөхөн төлбөрийг даатгуулагчийн буруугаас хохирсон гуравдагч этгээдэд эсвэл өв залгамжлагчид олгож болох эсэхийг хуулиар зохицуулсан байдаг. (Б.Б)

ДАВХАР ДААТГАЛ (*Reinsurance*)

Даатгагч нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дахин даатгуулах, эрсдэлээ шилжүүлэх үйл ажиллагаа юм. Даатгалын үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ баталгаажуулах, өндөр эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд өөрийн эрсдэлээ хуваалцах зорилгоор давхар даатгалын гэрээ байгуулдаг. Монгол Улсад даатгалын үйл ажиллагаа эрхлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанид эсвэл гадаад улсын даатгалын компанид давхар даатгахыг хуулиар зөвшөөрдөг.¹ Агаарын тээвэр, уул уурхай зэрэг өндөр эрсдэлтэй салбарт хөрөнгийн зүйл болон ажил олгогчийн хариуцлага, үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндийг давхар даатгах тохиолдол их байдаг. (Б.Б)

ДАН (*танилт нэвтрэлтийн нэгдсэн систем*) DAN (*Integrated system of authentication*)

Цахим орчинд бүхий л төрлийн цахим үйлчилгээг авахад тухайн иргэнийг таньж баталгаажуулах боломжийг бүрдүүлэх, хувийн хэвшил болон төрийн үйлчилгээний өөр хоорондоо харилцан хамааралгүй системүүдтэй нягт уялдаатай ажиллах боломжтой платформ бүхий систем. Хэрэглэгч “Дан” танилт нэвтрэлтийн нэгдсэн системийг ашиглан нэвтэрснээр түүнд

холбогдсон бүх төрлийн системүүд рүү нэвтрэх эрхтэй болно. Дан танилт нэвтрэлтийн нэгдсэн системийн нэвтрэлтийг ашигласнаар иргэнийг цахим орчинд таньж баталгаажуулах хөгжүүлэлтийн давхардсан зардлыг бууруулах, мэдээллийн аюулгүй байдлыг нэг цэгээс хянах боломж бүрдэх зэрэг давуу талтай. (Д.З; Ч.Л нар)

ДАХИН ИНЖЕНЕРЧЛЭХҮЙ (*Reengineering*)

“Engineer” нь инженерчлэх гэсэн үйл үгийн утгаар 1818 оноос хойш хэрэглэгдэх болсон. Үгийн утга нь “эмхлэх, зохион байгуулах, загварчлах” юм. Энэ үг нь 1864 оноос улс төрийн хүрээнд хэрэглэгдэх болсон.² “Re” буюу “дахин”, “engineer” буюу “загварчлах” нь “дахин загварчлах” гэсэн утга илэрхийлж байна. Дахин загварчлал гэдгийг байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах зорилгоор түүний бүтэц, зохион байгуулалт болон үйл ажиллагаанд хийх зарчмын өөрчлөлтийг ойлгож болно. Үүнийг анх бизнесийн үйл ажиллагаа, өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэж эрс өөрчлөлт хийх зорилгоор боловсруулсан арга (Hammer and Champу, 1993) юм. Тухайлбал, сүүлийн жилүүдэд улс орнуудын засгийн газрын үйл ажиллагааны чиглэлийг шинэчлэн боловсруулах, бүтцийн ерөнхий тогтолцоог боловсронгуй болгоход дахин загварчлах аргыг ашиглах нь аливаа зүйлийг үндэс язгуураас нь сайтар судлан үзэж, зорилгодоо нийцүүлэн дахин шинээр загварчлах буюу дахин инженерчлэх ажиллагаа юм. (Т.Т)

ДАХИН ХУВААРИЛАЛТ (*Redistribution*)

Эдийн засгийн нөөц буюу баялгийг бодлогын хэрэгслээр

¹ Даатгалын тухай хууль

² Engineer (n). (n.d.). Retrieved from <https://www.etymonline.com/word/engineer>

нийгмийн тодорхой бүлгүүдэд дахин хуваарилах үйл явц юм. Дахин хуваарилалтыг ихэвчлэн татварын бодлогоор хэрэгжүүлдэг бөгөөд төлбөрийн чадвар сайтай, өндөр орлоготой хэсэгт татварыг өндөр тогтоох, орлого багатай, нийгмийн халамж шаардлагатай хэсэгт татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх замаар орлогын дахин хуваарилалтыг хийдэг. Түүнчлэн төсвийн орлогоос санхүүжүүлэн хэрэгжүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ нь мөн дахин хуваарилалтын бодлогын нэг хэлбэр. Дахин хуваарилалтын бодлого нь хүн амын тодорхой бүлэгт боловсрол, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, хүргээмжтэй үзүүлэх болон орон байр, хоол хүнсний хангамж зэрэг анхан шатны хэрэгцээг хангах, нийгмийн халамжийн бусад үйлчилгээг хүргэх чиглэлд хэрэгждэг.³ Хүн амын ажил эрхлэлтийн түвшин нэмэгдэж, орлогын татварын суурь өргөжихийн хэрээр дахин хуваарилалтын зардал буурдаг зүй тогтолтой. (Б.Б)

ДАЯАРШИЛ (Globalization) Энэ үг нь Францын “globe” буюу “бүх дэлхий, ертөнц даяар” гэсэн үгнээс үүдэлтэй. Даяаршил нь хүмүүс, байгууллагын харилцан ажиллагаа, нэгдэл, харилцан хамаарал үндэсний хил хязгаараас хальж буй хөдөлгөөн буюу улс хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа, хөрөнгө, хүн ам, технологийн болон мэдээллийн өсөн нэмэгдэж байгаа урсгал юм (Рондинэли, 2007). Дэлхийн улс орнуудын эдийн засгийн харилцаа нягтарч, харилцан хамаарал улам нэмэгдэх болсон нь даяаршил бий болоход нөлөөлжээ. Даяаршил нь дэлхий нийтийг хамарсан эдийн засаг,

оюун санаа, удирдлагын зохистой хослол юм. (Т.Т)

ДАЯАРШЛЫН ЕРТӨНЦ ДЭХ ЗАСАГЛАЛ (Governance in a Globalization World) Засаглал нь Грекийн “kubernbo” буюу “залуурдах, жолоодох” үгнээс гаралтай. Даяаршлын ертөнц дэх засаглалын тухай ойлголт нь иргэдийн эрх ашгийг хөндсөн аливаа асуудлыг шийдвэрлэхдээ төр, иргэн болон бусад оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааг чухалчилдаг. Өөрөөр хэлбэл, улс орнууд хүсэн хүлээсэн үр дүндээ хүрэхийн тулд өөр хоорондоо харилцаж, хамтран ажиллах тухай юм. Гадаад ертөнцийн нөлөөг харгалзахгүйгээр төрийн оролцоо, хэлбэрийн талаар дангааршин шийдэх боломжгүй болсон цаг үе иржээ. Даяаршил нь улс орнуудад нөлөөлөн засгийн газруудын бие дааж, дангааршин ажиллах чадварыг хязгаарладаг. (Т.Т)

ДИМОК, МАРШАЛЛ ЭДВАРД (Dimock, Marshall Edward, 1903-1991) Америкийн улс төр судлаач эрдэмтэн. 1925 онд Помона коллежийг түүхийн мэргэжлээр дүүргэж, 1928 онд Жон Хопкинсийн их сургуульд докторын зэрэг хамгаалсан. 1928-1941 онуудад Калифорнийн болон Чикагогийн их сургуульд ажиллаж байжээ. Тэрбээр АНУ-ын төрийн янз бүрийн байгууллагуудад алба хашихын зэрэгцээ их сургуулиуд, шашны байгууллага, сан, судалгааны байгууллагад сонгуульт ажил үүрэг гүйцэтгэж байсан байна. Хожим Нью Йоркийн их сургуульд багшилж байв. Тэр “The study of administration” (1937), “The executive in action” (1945), “ The meshing of line and staff” (1945) зэрэг байгууллага, public(олон түмний) захиргааны талаарх судалгааны олон

3 David Schultz: Encyclopedia of Public Administration and Public Policy, USA 2004, pp. 120-121.

ном бичжээ. Судалгааныхаа явцад захиргаа судлаачдын анхаарлыг зүй ёсоор татахуйц олон тодорхойлолт гаргаж байсныг тэмдэглүүштэй. М.Гаус, Л.Уайт нартай хамтран бичсэн номдоо “байгууллага бол зөвшилцсөн тодорхой зорилгуудыг хэрэгжүүлэхийн тулд чиг үүрэг болон хариуцлагыг хуваарилах замаар ажилтнуудыг зохион байгуулах явдал мөн”, Захиргаа судлал бүтээлдээ: “захиргаа судлалын судлах зүйл бол нэгд, төр юуг зөв бөгөөд амжилттай хийж чадахыг тодорхойлох, хоёрт, эдгээр зөв зүйлийг хэрхэн боломжийн түвшний амжилтаар, аль болох бага мөнгө, хүчээр хийх вэ гэдгийг нээн харуулах явдал юм” хэмээн тодорхойлсон нь одоо ч ач холбогдолтой байна. (А.Ц)

ДИНАМИК ШИНЖИЛГЭЭ (*Dynamic analysis*) Нэг тэнцвэрт байдал нөгөө төлөвт байдалд хэрхэн өөрчлөгдөж байгааг судалж шинжилдэг эдийн засгийн шинжилгээний арга юм. Динамик шинжилгээ нь эдийн засгийн үзүүлэлтүүдийг цаг хугацааны явцад буюу динамик, өөрчлөмтгий байдалд нь авч судалдаг. Динамик шинжилгээ нь статик шинжилгээний (судалж буй эдийн засгийн үзүүлэлтүүд нь статик буюу өөрчлөгддөггүй) эсрэг зүйл бөгөөд систем, түүний бүрэлдэхүүн хэсгийг үйл ажиллагааны явцад нь түүний төлөв байдалд үндэслэн үнэлэх үйл явц юм. Судалгааны асуудлыг хөгжлийн явцад нь авч үзсэнээр түүнийг ойлгох төдийгүй өөрчлөлтийн шалтгааныг олж мэдэх боломжтой. Динамик шинжилгээнд үнэмлэхүй өсөлт, өсөлтийн хурд зэрэг үзүүлэлтүүд тооцогдон хугацааны цуваан шинжилгээ хийгдэнэ. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд динамик шинжилгээг хийснээр байгууллагын санхүүгийн

гүйцэтгэлийг сайжруулах, оновчтой хувилбарыг боловсруулж хэрэгжүүлнэ. (Д.Ч)

ДОТООД АУДИТ (*Internal audit*)

Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой баталгаа өгөх, зөвлөх үйл ажиллагаа юм. Энэ нь системтэй, оновчтой арга хандлагаар байгууллагын эрсдэлийн удирдлага, засаглал ба дотоод хяналтын үйл явцыг үнэлэх ба сайжруулахад тусалдаг. Аливаа байгууллагын удирдлага нь эрсдэлийн удирдлага, хяналт, засаглалын үйл явц уршигтай байгаа эсэхийг дотоод аудитаас бодит мэдээлэл авдаг. Байгууллагын үйл ажиллагаа удирдлагын төлөвлөснөөр явагдаж байгаа эсэхэд баталгаа өгдөг. Түүнчлэн хяналт, эрсдэлийн удирдлагыг сайжруулах, зардлыг бууруулах, орлого, үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр зөвлөгөө өгч, үйл ажиллагаанд бодит үнэлгээ өгдөг. Дотоод аудит нь байгууллагад стратегийн болон үйл ажиллагааны, бас санхүүгийн зорилгодоо хүрэхэд нь эрсдэлийн удирдлага, хяналт, засаглалд баталгаажуулалт өгдөг. Дотоод аудит нь засаглалын 4 тулгуурын нэг болж (дээд шатны удирдлага, гүйцэтгэх удирдлага ба хөндлөнгийн аудитын хамт) байгууллагад хүчтэй хяналт тавин, үнэн зөв тайлантай байж эрсдэлийг бууруулан хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэхэд тусална. Дээд шатны удирдлага болон гүйцэтгэх удирдлагад эрсдэлийг илрүүлж удирдахад тусалдаг. Хяналтын үр ашигтай байдал болон дүрэм журмын даган мөрдөлтөд төвлөрч, сайжруулах арга замыг зөвлөнө.⁴ Дотоод аудитын олон

⁴ Дотоод Аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт.

улсын стандарт нь дотоод аудитыг байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцыг үнэлж, дүгнэхийг шаарддаг. Дотоод аудитын үйл ажиллагаа нь гол төлөв байгууллагын дотоод хяналтыг сайжруулахад чиглэгдэн үйл явцын үр нөлөөтэй ба үр ашигтай байдлыг үнэлэн, байнгын сайжруулалтыг санал болгох замаар удирдлагад туслалцаа үзүүлэх үүрэгтэй. (А.Э)

ДОТООД ХЯНАЛТ (Internal control)

Захиргааны нэг байгууллагын дотор хийгдэх бүх төрлийн хяналтыг хамаарсан ойлголт⁵. Байгууллагын дотоод бүтцийн болон харьяа байгууллагын үйл ажиллагаанд хийж буй хяналт нь дотоод хяналт⁶. Байгууллагын дотоод бүтцэд байгаа хяналтын асуудал хариуцсан нэгж, ажилтан нь дотоод хяналтыг хэрэгжүүлнэ. Тухайлбал: Монгол Улсын ЗГХЭГ-ын бүтцэд “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар”⁷, яамдуудын бүтцэд “Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар”⁸ эсвэл “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар”⁹ нэртэй нэгж, аймгийн ЗДТГ-ын бүтцэд “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс”¹⁰ ажилладаг бөгөөд тэд дотоод хяналтыг хэрэгжүүлдэг. Монгол Улсын төрийн байгууллагуудад дотоод хяналтыг “дотоод хяналт шалгалт”, “дотоод аудит”, “хяналт-шинжилгээ, үнэлгээ” нэрээр хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээр хяналтын төрөл тус бүр өөр өөрийн онцлогтой. (М.А)

5 Klaus Koenig, Heinrich Siedentopf, “Public administration in Germany”, 2001, p. 563.

6 Бурмаа Н., “Төрийн хяналт, хариуцлага”, 2018, 29 дэх тал.

7 2020 оны Засгийн газрын 62 дугаар тогтоол.

8 2020 оны Засгийн газрын 155 дугаар тогтоол.

9 2020 оны Засгийн газрын 50, 51 дүгээр тогтоол гэх мэтчилэнгээр яамдын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц орон тооны хязгаар батлах тухай шийдвэр.

10 2016 оны Засгийн газрын 09 дүгээр тогтоол.

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН –ДНБ (Gross domestic product-GDP)

Тодорхой хугацаанд тухайн оронд шинээр бүтээгдсэн бараа болон үйлчилгээнүүдийн зах зээлийн үнийн нийлбэр. Дотоодын нийт бүтээгдэхүүнд тухайн улсын хил дотор байгаа бүх үйлдвэрлэлийг оруулж тооцно. Нэг хүнд оногдох ДНБ нь улс орнуудын амьжиргааны түвшинг илэрхийлнэ. ДНБ-ийг үйлдвэрлэлт, ашиглалт, хуваарилалт гэсэн гурван аргаар тооцдог. Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хасаж нэмэгдэл өртгийн нийлбэр дүнгээр тооцохыг үйлдвэрлэлийн; эцсийн хэрэглээ, хөрөнгийн нийт хуримтлал, цэвэр экспортын (экспорт, импортын зөрүү) нийлбэрээр тооцохыг эцсийн ашиглалтын; ажиллагчдын цалин хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар (үйлдвэрлэл, импортын татвар, татаасын зөрүү), үйл ажиллагааны цэвэр ашиг/холимог орлого зэрэг орлогын үзүүлэлтүүдийн нийлбэрээр тооцохыг орлогын арга гэнэ. Үндэсний нийт бүтээгдэхүүн нь гадаадад байгаа тухайн улсын иргэн аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийг оруулж тооцно. Мөн түүнчлэн ДНБ-ийг тооцож байгаа арга зүйгээр нь бодит болон нэрлэсэн гэж хоёр аргаар тооцох ба бодит ДНБ гэж тухай жилийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн түвшний өсөлтийг ДНБ-ний дефлятортай харьцуулсныг хэлдэг. ДНБ-ний дефлятор нь ойролцоогоор тухай жилийн инфляцын түвшинтэй тэнцүү. Бодит ДНБ нь тухайн жилийн эдийн засгийн өсөлтийг илэрхийлдэг. (А.Э)

ДУНД ХУГАЦАА (Medium term)

Хоёроос долоон жилийг хамарсан хугацааг хэлдэг. Төрийн аливаа бодлого, хөтөлбөр, төсөл арга хэмжээг

төлөвлөхдөө дунд хугацаагаар ихэвчлэн тооцдог. Жишээ нь: засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 4 жилийн хугацаанд төлөвлөгддөг. Аливаа нэг салбар болон дэд салбарын стратеги болон мастер төлөвлөгөөнүүд 2-3 жилийн хугацаагаар тооцогдож төлөвлөдөг. Түүнчлэн улсын төсөв, төлөвлөгөө, стратеги, аюулгүй байдлын хугацааг тооцохдоо хэрэглэдэг. Дунд хугацаа ойлголтыг тодорхой нэг төлөвлөлт болон төсөвлөлтийг хийхэд өргөнөөр ашигладаг. Тухайлбал: Үндэсний дунд хугацааны бодлого, төлөвлөлт эсвэл Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл гэх мэт. Засгийн газрын дунд хугацааны бодлого төлөвлөлт нь 4 жилээр хэрэгжих дунд хугацааны мөрийн хөтөлбөр болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл зэрэг зүйлүүдээр төлөвлөгдөж тодорхой болдог. Стратегийн төлөвлөлтийн нэг жишээ бол дунд хугацааны төлөвлөлт бөгөөд улс орон болон аль нэг салбарын дунд хугацааны төлөвлөлт нь тухайн салбарын мастер төлөвлөгөө болох жишээ их байдаг. Өмнөх төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үед улс орны төлөвлөлтийг 5-н жилээр дундаж хугацаагаар төлөвлөж батлан хэрэгжүүлдэг байсан. Харин зах зээлийн эдийн засгийн системийн эхэн үед энэхүү төлөвлөлтийг больсон хэдий боловч сүүлийн жилүүдэд болон зах зээлийн эдийн засагтай хөгжилтэй орнуудад энэхүү төлөвлөлтийн систем хөгжлийн гол түлхүүр болсоор байна. (А.Э)

ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (*Medium-term Plan*) Төлөвлөгөөг хугацаагаар нь урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө хэмээн ангилдаг. Дунд хугацааны төлөвлөгөө

нь 2-7 хүртэлх жилийн хугацаатай байх бөгөөд практикт ихэнхдээ дунд хугацааны төлөвлөгөөг 4-5 жилийн хугацаагаар боловсруулагджээ¹¹. Дунд хугацааны төлөвлөгөө нь тактикийн шинжтэй бөгөөд урт болон богино хугацааны төлөвлөгөөг холбогчийн үүргийг гүйцэтгэнэ. Ихэнх улс оронд захиргааны байгууллагуудынх нь стратегийн төлөвлөгөө 4-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө байна. Монгол Улсын “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”-д 5-10¹² жилийн хугацааг дунд хугацаа хэмээн тооцож хөгжлийн төлөвлөлтөө хийхээр тусгажээ. (М.А)

ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ (*Medium term fiscal framework statement*)

Улс орны төсвийг дунд хугацаагаар төлөвлөж, энэхүү төлөвлөлтөөсөө тухайн жилийн төлөвлөлтийг хийдэг аргачлал. Тухайн төсвийн жилийн макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн хүлээгдэж байгаа төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичиг.¹³ Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь дараагийн 2 жилийн төсвийн төсөл боловсруулах суурь болж байдаг. Монгол Улсын хувьд 2010 оноос энэхүү төсвийн төлөвлөлтийг хэрэглэж ирсэн бөгөөд Улсын Их Хурал 2010 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталснаар хэрэглэж эхэлсэн. Баялаг ихтэй хөгжиж байгаа улсууд голланд өвчин болон баялгийн хараалаас сэрэмжлэхийн үүднээс энэхүү тогтолцоог хэрэглэж ирсэн байдаг

11 W.Arthur Lewis, Development Planning, 1966, p.140.

12 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль

13 Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

бөгөөд үүний тод жишээ нь Чили Улс. (А.Э)

ДҮРМИЙН САН (Equity fund)

Ашгийн төлөө байгууллагыг байгуулахад үүсгэн байгуулах баримт бичиг буюу хууль тогтоомжид тодорхойлсон хөрөнгийн хэмжээг хангах эд хөрөнгийн хуримтлалын (мөнгөн илэрхийллийн) нийлбэр. Дүрмийн сан нь компанийн эд хөрөнгийн доод хэмжээг тодорхойлж, түүний харилцагчдын эрх ашгийг баталгаажуулдаг¹⁴. (А.Э)

ДҮРЭМ, ЖУРМЫГ ХЯЛБАРШУУЛАХ (Deregulation)

“Deregulate” гэдэг үг нь “хязгаарлалтыг арилгах” утгатай. 1955 оноос “deregulation” буюу “тохиргоог болих, арилгах” гэсэн утгаар хэрэглэгдэх болсон.¹⁵ Үгийн гол утга нь “аливаа зүйлийг хялбар болгох” гэсэн санааг илтгэн “дүрэм журмыг хялбаршуулах, бүх хүнд төвөг багатай болгох”¹⁶ зорилготой юм. Тухайлбал: машин, механизмын үйл ажиллагаа доголдсон тохиолдолд оношилгоо, тохиргоо хийж засаж сайжруулдагтай адил төр засгийн үйл хэргийг дүрэм, журмаар зохицуулах шаардлага үүсдэг. Энэ нь улс орнуудад харилцан адилгүй байдаг бөгөөд төрийн үйлчилгээг сайжруулахад дүрэм журмыг хялбаршуулах, эсвэл журмыг хүчингүй болгох, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд шинийг нэвтрүүлэх хэлбэрээр илэрдэг байна. (Т.Т)

ДҮҮРЭГ (District) Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэсэг буюу Монгол Улсын засаг захиргааны дунд шатны нэгжийг дүүрэг гэнэ. Жнь: Монгол

¹⁴ С.Нарангэрэл “Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг”, Улаанбаатар 2015 он, дөрөв дэх хэвлэлт

¹⁵ Deregulate (v.). (n.d.). Retrieved October 27, 2020, from <https://www.etymonline.com/word/deregulate>

¹⁶ Шиава-Кампо, Сундарам (2000), өрсөлдөөнт ертөнцөд төрийн захиргааг сайжруулах нь, х. 139.

Улсын нийслэл нь есөн дүүрэгтэй: Багануур, Багахангай, Баянгол, Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул байна. Дүүрэг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, иргэдэд хуульд заасан үйлчилгээг үзүүлэх, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хороодын нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх нэгж мөн. Дүүрэг нь нийтийн эрх зүйн этгээд байна. (Ч.Э)

ДЭД БҮТЭЦ (Infrastructure)

Өрх гэр болон бизнесийн байгууллагуудын тогтвортой ажиллагаа, амьжиргааг хангахад чиглэсэн суурь байгууламж болон системүүдийн цогц. Үүнд биет дэд бүтэц болох зам, гүүр, цэвэр ба бохир усан хангамж, эрчим хүч, дулаан, хог хаягдлын менежмент, цахилгаан холбооны зэрэг байгууламж нэн түрүүнд багтдаг. Дэд бүтцийн эдгээр биет объектуудыг “хатуу” дэд бүтэц (hard infrastructure) гэж мөн нэрлэдэг. Цаг уурын өөрчлөлт, байгаль орчны бохирдол зэрэг асуудлаас үүдэн өнөө цагт биет дэд бүтэц нь тогтвортой хөгжлийг хангахад чиглэх чиг хандлага улс орнуудын засгийн газрын бодлогод давамгайлах болсон. Эрчим хүчний цэвэр эх үүсвэр, усны нөөцийн зохистой хэрэглээ, хог хаягдлын дахин боловсруулалт, шинэ материал ашиглалт, дэд бүтцийн нөөцийн “ухаалаг” менежмент зэрэгт төрийн бодлого чиглэж байна. Хүн амын төвлөрөл ихтэй хот суурин газарт эдгээр асуудал хурцаар тавигдах болсноор оновчтой, шинэлэг шийдлүүд гарсаар байна. Орчин цагт дэд бүтцийн талаарх ойлголт нь хатуу дэд бүтцээс халин иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд чухал үүрэгтэй “зөөлөн” дэд бүтцийг

багтаадаг болсон. Зөөлөн дэд бүтцэд улс орны эдийн засаг, эрүүл мэнд, нийгэм, хүрээлэн буй орчин болон соёлын тодорхой стандартыг хангахад чиглэсэн институц багтана. Үүнд боловсролын тогтолцоо, хөтөлбөрүүд, эрүүлийг хамгаалах үйлчилгээ, иргэдийн амралт, чөлөөт цагийг аятай өнгөрүүлэхийг дэмжих байгууламж, бүтэц зэрэг байна. Цаашилбал, төрийн оновчтой бодлого, бодлогыг хэрэгжүүлэх ухаалаг тогтолцоо, эрх зүйт төрийн үндэс болох хууль болон тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн институцийг багтааж ойлгож болно. Хатуу болон зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэх нь хөгжлийн үндэс суурь бөгөөд төрийн хамгийн чухал үүргүүдийн нэг юм. Төр, орон нутгийн санхүүжилтийн ихээхэн хэсэг энд зарцуулагддаг ба хувийн хэвшилтэй хамтарч ажиллах нь түгээмэл арга юм. (Ч.Н)

ДЭМЖИГЧ МАНЛАЙЛАЛ (*Supportive leadership*) Удирдагчийн зүгээс ажилтнуудын хүсэл зориг, эрэлт хэрэгцээг хангахад голлон анхаарч, бүх хүмүүст хүртээмжтэй, нээлттэй найрсаг байдлыг эрхэмлэх, багаар нягт хамтран ажиллах уур амьсгалыг бүрдүүлж чаддаг манлайллын нэг хэв маяг. Манлайлал нь ажилтнуудын санаа, хүсэл тэмүүллийг хүндэтгэх, тэдний үүрэг, хариуцлага, хөдөлмөрийн нөхцөлд санаа тавих, итгэлцэлд тулгуурласан харилцааг тогтоодог. Роберт Хаус (Robert J. House)-ын “Зам-зорилго” онолын үйлийг дэмжих, захирамжлах, зорилгод чиглэсэн, удирдлагад оролцуулах гэсэн 4 төрлийн манлайлах арга барилын нэг юм. Энэ онолоор манлайлагч манлайлах арга барилаа нөхцөл байдал, ажил үүрэг, ажилтнуудын онцлогт тохируулан сонгож болно гэж үздэг. Ажилчдын

гүйцэтгэлийн чадвар өндөр байх тусам удирдагчаас заавар зөвлөгөө авах дургүй байдаг. Мөн доод албан тушаалтанд бүтэцлэгдсэн үүрэг даалгавар (байнга, давтамжтай хийгддэг) өгөхөд үйлийг дэмжих манлайлал нь захирамжлах арга барилаас илүү үр дүнтэй байдаг. (Ц.Д)

ДЭМЧИГДОРЖ Ч. (*Demchigdorj Ch.*)

XX зууны эхэн үеийн их бичгийн хүн, соён гэгээрүүлэгч, эрдэмтэн орчуулагч 1863 онд төрсөн. Зостын чуулганы Харчин дунд хошууны хүн байжээ. 1911 оны хувьсгалын дараагаар Богд хаант Монгол Улсад монгол туургатны сэхээтнүүдээс олон хүн дагаар орж ирсний нэг нь юм. Тэрбээр 1914 онд Монгол Улсад иржээ. 1914-1921 онуудад гол төлөв ном судар орчуулж, шавь нартаа хичээл заадаг гэрийн багш байв. Соён гэгээрүүлэх ажил хийж “Монголын сонин бичиг”, “Шинэ толь хэмээх бичиг”, “Нийслэл хүрээний сонин бичиг”, “Монголын үнэн” зэрэг хэвлэлүүдэд өгүүлэл нийтлүүлж, ард олныг гэгээрүүлэх ажил хийхийн зэрэгцээ засгийн газарт зөвлөхийн ажил хийж байв. Улс орноо шинээр төвхнүүлэхэд эрдэм чадлаараа тус болохыг хичээж Улсын хуралд олон удаа өргөх бичиг барьж, санал дэвшүүлж байжээ. Өргөх бичигтээ улс төрийг засах ёс, үндсэн хууль, хууль цаазын асуудал, эдийн засаг, худалдаа, мөнгө санхүүгийн зэрэг улс орны амьдралын олон чухал асуудлаар санал дэвшүүлж байсан байна. Ардын хувьсгалын дараагаар Судар бичгийн хүрээлэнд арав гаруй жил ажиллан “Нэр томьёоны их комисс”-т ажиллаж байжээ. Дэмчигдорж дэлхий дахины байдлыг маш сайн мэддэг, улс орон мандах буурахын учир шалтгааныг ухаарсан хүн байсан аж. Тэрбээр шинэ Монгол Улсыг төвхнүүлэх, тусгаар тогтнолыг бэхжүүлэх талаар

үзэл бодлоо илэрхийлэхийн зэрэгцээ хуучныг халж, шинэ дэвшилт ёсыг тогтоохын ач тусыг ухаарсан хүн байв. Тийм ч учраас Монгол орны тэр үеийн байдлыг шүүмжилж, дэлхий дахины шинэ дэвшилтэт зүйлийг авч хэрэглэх санаа дэвшүүлж байв. Монголд ирэхээсээ өмнө “Эрдэнэт толь хэмээх сургаалын ном бичжээ. 1915 онд уг санаагаа гүнзгийрүүлэн “Шинэ засгийн зүйл хэмээх бичиг” хэмээх шүүмжлэлт сургаалын номоо бичсэн байна. Түүний гол бүтээлийн нэг бол “Шинэ засгийн гол ёс” хэмээх зохиол юм. Түүнчлэн сургуулиудад үзэхэд зориулсан “Гадаадын үг аялгууг тэмдэглэх үсгийн тухай” хэмээх номоо бичжээ. “Шинэ засгийн гол ёс” бүтээлдээ ардын төрийг дэмжиж, улс нийгмийг шинэчлэх үзэл санааг дэвшүүлсэн байна. Дэмчигдорж улс төр, төр судлалын чиглэлийн ном зохиол бичихийн зэрэгцээ хятад хэлнээс Юань Улсын судрыг монголчилсон гавьяатай хүн юм. Тэрбээр 1932 онд таалал төгсжээ. (А.Ц)

ДЭНДЭВ Л. (Dendev L.) XX зууны эхэн үеийн их бичгийн хүн, түүхч, эрдэмтэн, төрийн түшмэл. 1895 онд Түшээт хан аймгийн Дархан чин вангийн хошуу, одоогийн Төв аймгийн Баян сумын нутагт төржээ. Арван настайгаасаа нутгийн хүнээр бичиг үсэг заалган 1906 онд Хүрээнд байгуулагдсан манж-хятад бичгийн сургуульд 5-6 жил суралцсан байна. 1911 оноос Дотоод хэргийн яаманд бичээчээр ажиллаж байгаад, 1917 онд эх зохиох түшмэл болон дэвшиж 1919 он хүртэл ажилласан байна. Мөн үед Улсын хурлын гишүүнээр ажиллан 1919 онд гүнгийн зэрэг хүртсэн байна. 1921 онд ардын засаг байгуулагдахад Дотоод Яаманд эх зохиох түшмэлээр ажиллан эрхэлсэн түшмэлээр дэвшин

ажилласан байна. Энэ үедээ Цэргийн сурган боловсруулах газрын даргын ажлыг хавсран ажиллаж байжээ. Дэндэвийн Дотоод яаманд алба хашиж байсан үед төр захиргааны байгууллагыг ардчилсан үндсэн дээр шинэчлэхэд чиглэсэн хууль, дүрмүүд олон гарсан ба тэр болгонд оролцож боловсруулалцаж явжээ. Л. Дэндэв 1925 онд Шүүх яамны сайдаар томилогдсон байна. Мөн Улсын бага хурлын гишүүнээр сонгогдсон байна. Шүүх яамны сайдаар ажиллаж байхдаа шүүхийн тогтолцоог ардчилсан ёсны дагуу өөрчлөн байгуулах, төрийн хууль цаазны баримт бичгийг боловсруулахад шамдан ажилласан ба гавьяа зүтгэлийг үнэлж Аж үйлдвэрийн гавьяаны 1-р зэргийн одонгоор шагнажээ. Тэрбээр Улсын Бага хурлын гишүүнээр 4 удаа сонгогдсон байна. Дэндэв төрийн зүтгэлтэн төдийгүй шинжлэх ухааны зүтгэлтэн, судлаач эрдэмтэн. 1932 онд Шинжлэх ухааны хүрээлэнгийн орлогч дарга, 1934 онд жинхэнэ дарга болсон байна. Тэрбээр түүхийн чиглэлээр олон ном, өгүүлэл туурвиж, манж хэлнээс орчуулга хийсэн бүтээлүүдэд 1911-1919 он хүртэлх Монголын түүхийг багтаасан “Монголын товч түүх” чухал байр суурь эзэлдэг. Судлаачдын олж тогтоосноор Дэндэв нэгэн сэдэвт зохиол 8, судалгаа, сурталчилгааны өгүүлэл 13 –ыг бичиж, манж хэлнээс 12 зүйлийг орчуулсан ба бусдын 21 бүтээлийг хянан тохиолдуулжээ. 1940 онд гадаадын тагнуул хэмээн буруутгагдаж 10 жилээр таслагдсан боловч 1945 онд Бага хурлын тэргүүлэгчдийн шийдвэрээр суллагджээ. Суллагдсаны дараа Улсын төв архивт манж хэлний орчуулагчаар ажиллахын зэрэгцээ МУИС-д манж хэлний багшаар ажиллаж байжээ. 1957 оны эхээр хилс

хэргээс цагаатгагдаж мөн оны 2-р сард өвчний улмаас таалал төгсжээ. (А.Ц)

ДЭС ТҮШМЭЛ (*Associate officer*)

Төрийн захиргааны албан тушаалыг тэргүүн, эрхэлсэн, ахлах, дэс, туслах түшмэлийн албан тушаал хэмээн ангилна. Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээнд тодорхой асуудлаар бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах үүрэг хүлээж, ажлын гүйцэтгэл, үр дүнг эрхэлсэн түшмэлийн өмнө хариуцдаг албан тушаалыг дэс түшмэлийн албан тушаал гэнэ¹⁷. Дэс түшмэлийн албан тушаалд яамны ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, ахлах зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарах бөгөөд төрийн захиргааны ТЗ-4-өөс ТЗ-8 хүртэлх зэрэглэлийн албан тушаал юм. (М.А)

¹⁷ Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолын хавсралт.

Е

ЕВРОПЫН ЗАХИРГААНЫ УЛАМЖЛАЛ (*Administrative tradition of Europe*)

Европын захиргааны уламжлал бүр эртний Грек, Ромын үеэс эхтэй юм. Ромчууд шатлал бүхий захиргааны системийг шүүх, цэргийн хэрэг, санхүү ба татвар, гадаад, дотоод хэрэг гэх мэтээр ялгавартай байгуулж албан хаагчдыг ажиллуулж байжээ. Ромын эзэнт гүрнийг мөхсөний дараа энэхүү уламжлалыг Византын улс үргэлжлүүлсэн. Дундад зууны үед хаадын ордны албанаас захиргааны бүтцүүд үүсэж эхэлсэн байна. Гэвч XII зууны эцэс хүртэл албадын чиг үүрэг, ялгаа төдийлөн тодорхойгүй байжээ. Гагцхүү хааны ордны дарс хариуцагч, ёслол зохион байгуулагч, санхүүч, канцлер нарын үүрэг тодорхой байсан аж. XIII зууны үед яам, хааны зөвлөл гэсэн гурван алба ялгаран гарчээ. Орчин үеийн сайдын албад Хааны зөвлөлөөс үүсэн аж. Тэдгээр албыг хаан томилдог, хүч нөлөө бүхий язгууртнууд байжээ. Хааны нарийн бичгийн дарга хэмээх алба нь жинхэнэ захиргааны албаны шинжтэй байсан. Хаан түүнд санаа бодлоо хэлдэг, улсыг удирдах нарийн ширийн ажлаа даатгадаг байв. Нарийн бичгийн дарга нар нь өөрийн албадтай, нутаг дэвсгэрийг хуваарилан хариуцдаг байв. (нэмэлтээр Пруссын засаг захиргааг үзнэ үү) (А.Ц)

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАСАГЛАЛ (*Presidential government*)

Латин хэлний “praes” буюу өмнө, “sedereto sit” гэсэн үгнүүдээс бүтсэн praesidens “өмнө талд суух, тэргүүнд суух” хэмээх үгнээс гаралтай. Дундад зууны сүүл үеэс Англи хэлэнд president буюу ерөнхийлөгч утгаар хэрэглэгдэх болсон. Ерөнхийлөгчийн засаглалын тогтолцоо нь 1787 оны Америкийн Үндсэн хуулиас эхтэй бөгөөд гүйцэтгэх засаглал болон төрийн тэргүүний хувьд “Ерөнхийлөгч” гэсэн албан тушаалыг анх бий болгосон улс юм. Энэ үеэс ерөнхийлөгчийн засаглалын үзэл санаа дэлгэрч, XX зууны хоёрдугаар хагасаас хойш бусад улс орнуудад хэрэгжиж эхэлсэн. Бүгд найрамдах улсад төр, засгийн буюу төрийн тэргүүний албан тушаалыг ерөнхийлөгч гэж нэрлэдэг. Ерөнхийлөгч нь төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмын хувьд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлж, засгийн газрын үйл ажиллагааг удирддаг засаглалын нэг хэлбэр юм. Парламентын нэгэн адил бүх нийтийн сонгуулиар сонгогддог хэлбэр түгээмэл байна. Ерөнхийлөгчийн эрх мэдэл нь парламентын засаглалтай харьцуулахад илүү өргөн хүрээтэй, Үндсэн хуулийн дагуу парламентыг хугацаанаас нь өмнө тараах, хуульд хориг тавих, засгийн газар, танхимын гишүүдээ өөрөө бүрдүүлэх зэрэг бүрэн эрхээрээ ялгагдана. (Я.Т)

Ё

ЁС ЗҮЙ (Ethics) Монгол хэлнээ “ёс” нь хүний дагаж баримтлах хэв, хууль журам, зарчим, харин “зүй” нь аливаа юмны тогтоол жам ёс, сургаал онол гэсэн утгыг илэрхийлдэг². Иймээс ёс зүйг уггын хувьд “аливаа хүний баримтлах журам, зарчмын сургаал онол” гэж ойлгож болно. Ёс зүй хэмээх ойлголт эртний Грекийн “ethos” гэсэн үгнээ гаралтай, хүний сайн сайхан амьдрал, эрх хариуцлагын тогтолцоо, зөв буруу үйлдэл ба эс үйлдэхүй, сайн ба муу ёс зүйн шийдвэрийн талаар хариулт өгөх зорилготой үүсжээ. Эртний Грекийн гүн ухаантан Аристотель нь “Никомахын ёс зүй”, “Евдемийн ёс зүй”, “Дээд суртахуун” зэрэг цуврал бүтээлүүдийг туурвисан ёс зүйн салбарын үндэслэгч хэмээн тооцогддог бөгөөд тэрээр ёс зүй нь “Хүнд юуг хийх ёстой, юунаас татгалзах хэрэгтэйг танин мэдэхэд тусалдаг шинжлэх ухаан” хэмээн тодорхойлсон. Мөн АНУ-ын ёс зүй судлаач Дональд Мензел (Donald C.Menzel):³ “Ёс зүй бол зөв, буруу зан үйлийг ялгах, чиглүүлэх үнэт зүйлс болон зарчмын тогтолцоо” гэж тодорхойлоод үнэт зүйлс ба зарчим, зан үйл, зөв ба буруу гэсэн үндсэн элементүүдтэй хэмээсэн. (Ц.Д)

ЁС СУРТАХУУН (Morale) Уг ойлголтыг захиргаатай холбогдуулан авч үзвэл байгууллагын зорилгод хүрэхэд хувь нэмэр оруулах байгууллагын гишүүдийн чин сэтгэл, хүсэл эрмэлзэл юм. Тиймээс ёс суртахуун нь ажлаа амжилттай хийх сэдэл⁴ гэж болно. Энэ нь ихэвчлэн цэрэг армид хэрэглэгддэг байсан бол өнөөдөр захиргааны байгууллага, аж ахуйн нэгж болон бусад байгууллагуудад өргөн хэрэглэгддэг. Хүмүүс хоорондын харилцааны анхны онол нь нийгмийн хэрэгцээ хангагдаж, бүлэг доторх хүмүүсийн харилцаанд сэтгэл ханамжтай байх үед гишүүдийн ёс суртахуун аяндаа дээшилдэг гэж үздэг байжээ. Орчин үед хувь хүний ёс суртахуун бус, байгууллагын зорилгод хүрэхэд чиглэсэн хамтын ёс суртахуун гэж үздэг болжээ. Тиймээс ёс суртахууныг тухайн байгууллагын зорилгод хүрэхэд хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэл эсвэл тухайн байгууллагын гишүүн болох хувь хүн, бүлгийн сэтгэл зүйн байдал гэж тодорхойлсон нь зөвхөн сэтгэл ханамж бус харин ажлын гүйцэтгэлтэй холбоотой сэдэл, мөн хувь хүний болон хамт олны түвшний үзэгдэл, түүнчлэн сэтгэл санааны субъектив байдал гэдгийг тодотгож өгдөг. Ижил нөхцөлд ажиллаж байгаа хүмүүсийн ёс суртахуун харилцан

1 Авлигатай тэмцэх газар (2019). Төрийн албан хаагчийн ёс зүй: гарын авлага. Улаанбаатар, 2019, х. 8.

2 Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь”

3 Donald C.Menzel. 2010. “Ethics moments in Government: Cases and Controversies” CRC Press. p. 9.

4 백원기(1994). 행정학 연구. 서울, p. 678.

адилгүй тул түүнийг анхаарах нь чухал. Ёс суртахуун нь хүний хэрэгцээнд суурилсан тул хэрэгцээ хангагдахад ёс суртахуун дээшилж, хэрэгцээ хангагдаагүй тохиолдолд ёс суртахуун буурдаг. Ёс суртахуун нь дараах үүргийг гүйцэтгэнэ: байгууллага болон ажлаараа бахархах сэтгэл төрүүлэх; бүлгийн адилслыг хүчтэй болгох, нягтруулах; бүтээмж (productivity)-ийг дээшлүүлэх, ажлын чанарыг сайжруулахад түлхэц үзүүлэх; ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд түлхэц үзүүлэх; байгууллагын дүрэм журмын үр нөлөөг дээшлүүлэх зэрэг болно. (Ц,Д)

Ж

ЖАНЖИН /*аймгийн*/ (*Aimag general*) Богд хаант Монгол Улсын үед аймаг бүрд жанжин томилж, тухайн аймгийн цэргийг захируулж байв. Аймгийн жанжид тугтай байсан ба Түшээт хан аймгийн жанжин цагаан өнгийн, Сэцэн хан аймгийн жанжин шар өнгийн, Засагт хан аймгийн жанжин улаан өнгийн, Сайн ноён хан аймгийн жанжин шулуун хөх өнгийн, Дөрвөд далай ханы жанжин хөвөөт цагаан өнгийн, Дөрвөд үнэн зоригт ханы жанжин хөвөөт шар өнгийн тугтай байжээ. (А.Ц)

ЖЕНДЭР БА ХҮЙС (*Gender and Sex*) Хүйс нь хүмүүсийн биологийн ялгааг тодорхойлдог бол “жендэр” гэх ойлголт эрэгтэй, эмэгтэй, хүмүүсийг тодорхойлох нийгмийн хүлээлт, хандлагыг илэрхийлдэг. Эрэгтэй, эмэгтэй хүний улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, нийгэмд эзлэх байр суурийн ойлголт, үзэл, хандлага, түүний уламжлал, өөрчлөлтийн асуудлыг “жендэр”-ийн хүрээнд хөнддөг. Жендэр нь хүний бие махбод, биологийн ялгааны тухай ойлголт биш учир эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тухайн нийгэмд тогтсон уламжлалт ойлголт, хүлээлт цаг хугацааны явцад хувьсан өөрчлөгддөг. Тухайн

улс, бүс нутгийн хөгжлийн түвшин, шашин, соёлын уламжлалаас хамаарч жендэрийн асуудал өөр өөр байдаг. (Б.Б)

ЖЕНДЭРИЙН АСУУДЛЫГ БОДЛОГОД ТУСГАХ НЬ (*Gender mainstreaming*)

Жендэрийн асуудлыг бодлогод тусгах нь төрийн бодлого, шийдвэрт эрэгтэй, эмэгтэйчүүдийн ашиг сонирхлыг тэгш хангахтай холбоотой. Энэ асуудал анх 1985 онд Найроби хотод болсон дэлхийн эмэгтэйчүүдийн бага хурлаар яригджээ. Улмаар 1995 онд Бээжинд болсон НҮБ-ын эмэгтэйчүүдийн IV бага хурал дээр олон улсын жендэрийн тэгш эрхийг хангах стратеги болсон. 1998 онд Европын зөвлөлөөс жендэрийн асуудлыг бодлогод тусгах тухай тодорхойлохдоо: “Бодлого боловсруулахад ихэвчлэн холбогддог оролцогчид жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бүх түвшинд, бүх үе шатны бодлогод тусгаж бодлогын үйл явцыг дахин боловсруулах, хөгжүүлэх, үнэлэх үйл ажиллагаа юм” гэжээ¹. Монгол Улсад 2011 онд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг баталж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд

¹ Gender Mainstreaming: Policy Briefs and Council of Europe Activities. Gender Equality unit. 2016, p. 3.

жэндэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлсон. Хууль баглагдсанаас хойш Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021), Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт жэндэрийн талаар баримтлах бодлого (2018-2024) зэрэг баримт бичгүүд гарч жэндэрийн асуудал бодлогод тодорхой хэмжээнд тусгалаа олсоор байна. Жэндэрийн асуудлыг бодлогод тусгахад хүйс болон жэндэрээр ангилж ялгасан статистик мэдээлэл, эрэгтэй, эмэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээ, шаардлагыг анхаарах ёстой, хувь хүний амьдралын явцад олж авсан туршлага, өрөөсгөл таамаглал дээр үндэслэж шийдвэр гаргаж болохгүй. Худал мэдээлэл, батлагдаж нотлогдоогүй баримт дээр тулгуурлан бодлого боловсруулах нь жэндэрийн хувьд өрөөсгөл, тэгш байдал алдагдсан бодлого гарахад нөлөөлдөг. Жэндэрийн асуудлыг бодлогод тусгах нь байгууллагын түвшний өөрчлөлтийг давхар шаарддаг бөгөөд тухайн байгууллагын бүх түвшинд, бүх оролцогчдыг хамарсан өргөн хүрээтэй, нарийн тодорхой үе шат бүхий үйл ажиллагаа болж эцсийн үр дүнд нь хувь хүн, байгууллагын соёлд өөрчлөлт авчирна. (Ж.Ж)

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ (*Gender equality*) Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага, хүртэх боломж нь тэдний хүйсийн ялгаанаас үл хамаарч тэгш байх тухай ойлголт. Эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, нийгмийн хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд хувь нэмрээ оруулах тэгш боломж, нөхцөлөөр хангагдаж байх ёстой. Тодруулбал, жэндэрийн тэгш байдал

нь хүний эрхийн суурь асуудал бөгөөд сурч боловсрох, өмч эзэмших, орон байр, ажлын байртай болох, эрүүл мэнд, эрх ашгаа хамгаалуулах адил нөхцөлөөр хангагдах, эрх зүйн ижил чадамжтай байх ба эрх мэдлийг тэнцвэржүүлэх нийгмийн багалгаа болдог. Жэндэрийн тэгш байдлыг хангахад төрөөс хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах, үнэлэх бүхий л үе шатанд тухайн асуудлын талаарх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай хүлээлт, санаа бодол, мэдрэмж, туршлагыг харгалзан үзэх шаардлагатай. (Б.Б)

ЖЕНДЭРИЙН ХАРИЛЦАА (*Gender relations*) Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд эрх мэдлийн хуваарилалт хэрхэн хийгдэж тэдний нийгэмд эзлэх байр суурь хэрхэн тодорхойлогдох суурийг бүрдүүлж байдаг нийгмийн харилцааны хэлбэр. Жэндэрийн харилцаа нь биет болон биет бус нөөцийг хэн хүртэж, хэн хянахыг тодорхойлдог эрх мэдлийн харилцаанд суурилдаг ба нийгмийн бусад харилцааны адил нөөцийг хуваарилах, үүрэг хариуцлагыг ногдуулж үнэлэх, нөөц хүчийг дайчлах дүрэм журам, хэм хэмжээний дагуу үүсэн хөгждөг үйл явц.² (Б.Б)

ЖЕРРИМАНДЕРИЗМ (*Gerryman-dering*) Жерримандр гэдэг нь АНУ-ын тав дахь ерөнхий сайд Элбридж Жерригийн (1744-1814) нэрээс гаралтай сөрөг утгатай нэр томьёо. Сонгуулийн өмнөх ов мэх (ялангуяа тойргуудыг буруу хуваах) юм. Сонгуулийн тойргийг эрх баригчид өөрсдөдөө ашигтайгаар тогтоож, ялах магадлалаа нэмэгдүүлэх улс

2 Женнифер Малж, Ж.Чанцалдулам, Ц.Эрдэнэчимэг, "Жэндэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь", ЖҮХ, АХБ, 2014, х. 33.

төрийн бодлогыг хэлнэ. Анх АНУ-ын Конгрессын гишүүн Жерри санаачлан сонгуулийн түүхэндээ хэрэглэсэн ба өнөөдөр улс төрийн сөрөг үйл ажиллагааг нэрлэдэг ойлголт болсон. Улс төр судлаач Лерой Харди жерримандрыг “сонгуулийн ноёрхлоо тогтоосон тойргуудыг бий болгох, эсрэг хүчнүүдийг сулруулах зэрэг партизаны зорилгоор хууль бус арга ашиглан сонгуулийн тойргийг шинээр тогтоох замаар зорилгоо хэрэгжүүлдэг технологи юм” хэмээн тодорхойлжээ. “Жерримандр” бол эрх мэдлийг гартаа авсан улс төрийн нам, сөрөг хүчний зүгээс нөлөөлдөө оруулж чадахааргүй “аюулгүй суудал”-ыг бий болгож, эсрэг хүчнийхээ хүчийг хязгаарлаж буй хэрэг юм. Анх 1812 онд ашигласнаас хойш энэхүү нэр томьёог улс төрд ашиглах нь жирийн үзэгдэл болжээ. (Я.Т)

ЖИЛИЙН ТӨСВИЙН ДЭЭД ХЯЗГААР (*Annual budget ceiling*)

Энэ ойлголт улсын төсвийн төслийг боловсруулахад илүү хэрэглэгддэг бөгөөд тухайн жилийн төсөвт орж ирэх орлогоо урьдчилан тооцон түүн дээрээ хэдий хэмжээтэй алдагдалтай байхыг тооцон нийт зардлын хэмжээний дээд түвшинг гаргана гэж ойлгож болно. Энгийн жишээ: тухайн жилийн орлого 18 их наяд төгрөг байхаар бол төсвийн алдагдлаа 2 их наяд гэж тооцон төсвийн нийт зарлага хэмжээ 20 их наяд байна гэж үздэг. Үүнийг төсвийн дээд хязгаар гэж ойлгож болно. Гэхдээ макро эдийн засагт төсвийг төлөвлөж тооцохдоо ДНБ-тэй харьцуулсан төсвийн орлогын хувь, болон зарлага, алдагдлын хэмжээгээр тооцож гаргадаг. Өөрөөр хэлбэл, Төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн тухайн жилийн

төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээ³ хэлдэг. Сангийн яам макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт дээр үндэслэн дунд хугацааны Төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийг тооцдог бөгөөд ДНБ-тэй харьцуулсан төсвийн нийт зарлагын дүн багтдаг. Энэхүү төсвийн зарлагын нийт дүн нь цаашаа салбарын яамдын буюу төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн зарлагын хязгаар болон хуваагдаж жилийн төсвийн дээд хязгаар болдог бөгөөд энэхүү төсвийн хязгаар буюу дээд дүн нь түүний харьяа төсвийн байгууллагуудын төсвийн зарлагын дүн болж хуваагддаг. (А.Э)

³ Төсвийн тухай хуулийн 4.1.8. дахь заалт.

3

ЗАЙН СУРГАЛТ (*Distance learning*)

Нэг талаас багш эсвэл сургагч, нөгөө талаас суралцагч эсхүл сургалтад оролцогч тухайн цаг хугацаанд байрлаж байгаа газар зүйн байршлаас хамааралгүйгээр сургалтын үйл ажиллагааг алслагдсан зайнаас явуулах сургалтын хэлбэр. Зайн сургалтад мэдээлэл, харилцаа холбооны хэрэгсэл (цахим хэрэглэгдэхүүн, радио, телевиз, утас, захидал, компьютер, видео бичлэг) зэрэг технологийн төрөл бүрийн ололтыг өргөн ашигладаг. Зайн сургалт нь цаг хугацаа болон зардал хэмнэх, суралцагсдад илүү боломж олгох, хүртээмжтэй байдал зэргээрээ уламжлалт аргаас давуу талтай. Орчин үеийн ойлголтоор анх 1840 онд Исаак Питмэн (Isaac Pitman) суралцагчдаа шуудангаар даалгавар илгээн гүйцэтгэлийг эргүүлэн хүлээн авч засах зарчмаар гэдрэг холбоотой зайн сургалтын шинэлэг хэлбэрийг эхлүүлсэн. Технологийн хөгжлийн явцад үүссэн цахим сургалт (e-Learning), мобайл сургалт (m-Learning), онлайн сургалт (online learning) болон виртуал анги (virtual classroom) нь бүгд зайн сургалтын төрлүүд. Мөн зайн болон танхимын сургалтын холимог сургалт (blended learning), нийгэд нээлттэй онлайн хичээл (massive open online course-MOOC)

зэрэг шинэ хэлбэрүүд ч үүссэн. Зайн сургалт нь газар зүйн байршлаас үл хамааран сурах боломжийг олгодгоороо боловсролын тэгш хүртээмжийг сайжруулах, мөн насан туршийн суралцахуйн үр дүнтэй хэлбэр болдог. Тийм ч утгаараа улс орнууд зайн сургалт, холимог сургалтыг боловсролын системдээ нэвтрүүлэх бодлого хэрэгжүүлж байна. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед эргэлзээ, болгоомжлол дунд аажуу үе шаттай нэвтэрч байсан зайн сургалтыг боловсролын бүх шатанд хэрэглэж эхэллээ. Цар тахлын дараа ч цахим сургалт нь дангаар болон холимог хэлбэрээр боловсролын салшгүй хэсэг байна. (Д.З; Ч.Л нар)

ЗАНГИ (*Zangi-clerk in Manchu period*)

Манжийн болон Богд хаант Монгол Улсын үеийн сум, харуул, өртөөний даргын албан тушаал. (А.Ц)

ЗАН ҮЙЛ (*Behavior*) Энэ бол хүмүүс, организм, систем, хиймэл юмсын өөр хоорондоо болон бусад систем, организм болон физик орчинтой үйлчлэлцсэний үр дүнд хийдэг үйлдлийг илэрхийлдэг ойлголт. Монгол хэлний их тайлбар толь бичигт “хүний аж амьдралтай уялдан эвшиж тогтсон заншил, түүнтэй холбоотой элдэв үйл хөдлөл” гэж тайлбарласан.

Харин захиргааны хувьд иргэдийн үнэт зүйлийг бүтээх, төрийн үүргийг гүйцэтгэх, захиргааны шийдвэр гаргахад чиглэсэн хэвшсэн үйлдлүүд гэж ойлгож болно. А.Саймон¹ захиргаанд шийдвэр гаргах үйл явц, түүний сонголтод нөлөөлдөг логик болон сэтгэл зүйн хүчин зүйлс, зарчмууд, оновчтой шийдвэр гаргахад саад болдог зүйлс, ажилтнууд болон удирдлагын үүрэг, нөлөө зэрэг олон зүйл захиргааны зан үйлийг бүрэлдүүлдэг гэж тодорхойлжээ. (Ц.Д)

ЗАН ҮЙЛИЙН ОНОЛ (*Behavioral theory*) Манлайлагчийн оюун ухааны чанар, дотоод сэтгэл санаанд биш үйлдэлд нь анхаарал хандуулна. Тиймээс бихеворизмд суурилсан энэ онолыг баримтлагчид агуу манлайлагчид төрдөггүй, харин төлөвшиж бий болдог гэх буюу хүмүүс сургалт, ажиглалт, туршлагын замаар манлайлагч болж болно гэж үздэг. 1940-өөд оны үеэс манлайллын хэв шинжийн судалгааны явцад удирдах үйл ажиллагааны үр дүн нь удирдагчийн онцлог шинж чанар гэхээс илүү түүний зан үйлээс хамааралтай нь тогтоогдсон. Тиймээс зохих сургалтад хамрагдан манлайлах арга барилыг аливаа менежер эзэмших боломжтой гэж үздэг. Айовагийн Их Сургууль (Iowa), Мичиганы Их Сургууль (Michigan)-ийн гэх мэт судлаачдын боловсруулсан манлайллын зан үйлийн онолууд бий. 1950-иад оны дундуур Охайогийн Их Сургууль (Ohio)-ийн судлаачид удирдагчийн зан үйлийг ажилд анхаарал тавих, ажилтнууддаа анхаарал тавих гэсэн хоёр үзүүлэлтээр тодорхойлсон. Ажилтнууддаа анхаарал тавих хандлага нь удирдагчийн зүгээс

ажилтнуудын санаа, хүсэл сонирхлыг хүндэтгэх, үүрэг хариуцлага, ажлын нөхцөл байдалд нь санаа тавих зэрэг итгэлцэлд тулгуурласан харилцааг тогтоох хандлага юм. Энэ хэв шинжийн удирдагч найрсаг харилцаа хандлагатай, нээлттэй, багийн ажиллагааг эрхэмлэдэг, ажилтнуудынхаа сайн сайхны төлөө санаа тавьдаг онцлогтой. Харин ажилд анхаарал тавих хандлагатай удирдагч ажлын даалгаврын биелэлт, дэвшүүлсэн зорилгын биелэлтэд ажилтнуудын үйл ажиллагааг чиглүүлж ажиллагсаараа ялгаатай. Ийм зан үйлийг эрхэмлэдэг удирдагч ажилтнуудад зориулсан заавар, журам, ажил гүйцэтгэх төлөвлөгөө зэрэг ажлаа сайтар төлөвлөхөд илүү анхаарал хандуулдаг байна. (Ц.Д)

ЗАРДАЛ-ҮР АШГИЙН ШИНЖИЛГЭЭ (*Cost and benefit analysis*) Орчин үеийн эдийн засагт хөрөнгө оруулалтын аливаа шийдвэр гаргахад тухайн төсөл, хөтөлбөрийн үр ашгийн шинжилгээний асуудлыг чухлаар тавьж ирсэн. Зардал-үр ашгийн шинжилгээний арга зүйг нийтийн сайн сайхан байдлыг сайжруулахад хийж байгаа Засгийн газрын үйл ажиллагааны мэдээллийг бэлтгэх, бий болгох, үнэлэх нэг арга зам гэж үздэг. Мөн харьцангуй ашиг, алдагдлыг хэмжихэд зориулагдсан арга техник өөр бодлого эсвэл хөтөлбөрийн хувилбаруудаас тоон болон бусад нөхцөлөөр хамгийн ашигтай зардлын харьцааг тодорхойлдог. Зардал-үр ашгийн шинжилгээ нь мөнгөөр илэрхийлэгдсэн Засгийн газрын зарим үйл ажиллагаануудын үр дүнг хэмжих үйл явцын цогц. Зардал үр ашгийн шинжилгээ нь ихэвчлэн төслийн судалгаатай /техникайн, санхүүгийн, хуулийн, байгууллагын/ хамт хийгдэн эцсийн дүгнэлтийг бий болгодог. (А.Э)

¹ Herbert A. Simon. *Administrative behavior: A Study of Decision-Making Processes in Administrative Organization*, 1947.

ЗАРДЛЫГ НӨХӨХ (*Cost recovery*)

Байгууллагын гаргасан зардлыг нөхөх үйл явц. Аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэхэд зардал гардаг. Энэ нь хөрөнгө оруулалт болон урсгал зардлын нийлбэрээр тогтоогдоно. Гаргасан энэ зардлыг бүтээгдэхүүнээ борлуулж олсон орлогоороо нөхнө. Зардлаа нөхөх нь бизнес үргэлжлэн оршин тогтнох үндэс. Зардал нөхөх зарчмын дагуу юуны түүрүүнд байгууллын бүх зардал бүрэн нөхөгдөж байж л хөрөнгө оруулалт ашгаа өгч эхэллээ гэж үзэх боломжтой. Энэ арга нь байгууллагын санхүүгийн байдлыг бодитой тусгадаг, ашиг орлогыг хамгийн болгоомжтой буюу “консерватив” байдлаар хүлээн зөвшөөрдөг уламжлалт арга хэмээн тооцогддог. Нийт гарсан зардлыг богино хугацаанд нөхөх боломжгүй. Үндсэн хөрөнгө нь урт хугацаанд ашиглагдах учир хөрөнгө оруулалтын зардал мөн аажмаар урт хугацаанд нөхөгддөг. Нягтлан бодох бүртгэл болон татварын аргачлалын дагуу энэ зардлыг бүтээгдэхүүний өртөг болон байгууллагын зардалд элэгдэл хорогдлын (depreciation) хэмжээгээр нь шингээж тайлагнадаг. Хөрөнгө оруулалтын зардал бүрэн нөхөгдөж дуусахаас өмнө ашиг олсон хэмээн хүлээн зөвшөөрөх боломжгүй. (Ч.Н)

ЗАРДЛЫН ТӨВ (*Cost center*)

Байгууллагын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай боловч ашигт шууд нөлөөлдөггүй зөвхөн зардал гардаг нэгж эсвэл чиг үүрэг. Ашиг шууд олдог нэгж эсвэл чиг үүргийг ашгийн төв (profit center) гэнэ. Тухайлбал, байгууллагад хүний нөөц, мэдээллийн технологи, судалгаа ба боловсруулалт (R&D), бүртгэл санхүү, маркетинг, худалдан авалт, ложистик, чанарын хяналтын алба, хэрэглэгчтэй харилцах төв (буюу ийм чиг үүрэг бүхий үйл

ажиллагаа) зэрэг нэгж эсвэл чиг үүрэг байдаг. Үүнд тодорхой зардал гардаг ч үйлдвэрлэлийн шууд зардал биш учир ашигт шууд нөлөө үзүүлдэггүй. Зардлын төв нь байгууллагын үйл ажиллагааг илүү хэмнэлттэй, орцыг илүү оновчтой сонгож хослуулах, нөөцийг илүү ухаалгаар ашиглах, бүтээгдэхүүний үнэ цэнэ болон хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх замаар үйлдвэрлэл болон ашигт шууд бусаар нөлөө үзүүлнэ. Ашгийн төвийн үндсэн зорилго нь ашгийг хамгийн өндөр байлгах бол зардлын төвийн үүрэг нь зардлыг хамгийн бага байлгахад чиглэнэ. Зардлын төвийн гаргаж буй зардал нь байгууллагын зардлын нэг хэсэг учир бүтээгдэхүүний зардлын тооцоонд зайлшгүй орно. Эдгээр шууд бус зардлыг нэгж бүтээгдэхүүнд шингээж тооцоходоо тодорхой аргачлалын дагуу хуваарилна. (Ч.Н)

ЗАРЛАГА (*Expenditure*) Зарлага нь аливаа зүйл, үйлчилгээний төлбөрийг төлөх эсвэл зардлын ангилалд зориулж өөр хүн эсвэл бүлэгт мөнгө, эсвэл ерөнхийдөө аливаа хэлбэрийн эд хөрөнгийг гадагшлуулах явдал юм. Улсын төсвийн хувьд төсвийн зарлага хэмээх нэр томьёог өргөн хэрэглэгддэг. Төсвийн эдийн засгийн томсгосон ангиллаар нийт зарлага ба цэвэр зээлийн дүн гэсэн ойлголт бөгөөд энэ нь дотроо урсгал зарлага ба хөрөнгийн зарлага гэж хуваагдана. (А.Э)

ЗАРЛИГААР ТОГТООСОН МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙЛИЙН БИЧИГ (*Legislative document of Mongolia established by decree*) Богд хааны зарлигаар Монгол төрийн эрдэмт түшмэд, шашны зүтгэлтнүүд төрийн цааз хуулийн уламжлал болон дэлхий дахины цааз хуулийн жишигт тулгуурлан 65 дэвтэр бүхий Монгол

Улсын хууль зүйлийн бичгийг 1913-1918 онд боловсруулжээ. Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг бол Эзэн Чингисийн Их засаг, Монгол-Ойрадын Их цааз, Халх журам зэрэг болон Монголын бусад хууль цаазад суурилсан, тусгаар тогтносон Монгол Улсын нийгмийн амьдралыг бүхэлд нь зохицуулах зориулалт бүхий хуулийн цоморлиг юм. Уламжлал ёсоор 65 дэвтэртэй гэх боловч угтаа 65 бүлэгтэй хууль бөгөөд тэр үеийн засаг захиргааны хуваарь, төрийн төв байгууллагууд, төрийн албыг буй болгох, үйл ажиллагааг нь зохицуулах, төрийн ёслол, тайлга тахилга, лам нарын болон цэргийн хэрэг, эдийн засаг, санхүү, өргөөний алба, шүүх ажиллагаа болон эрүүгийн хэрэг зэрэг асуудлууд багтжээ. (А.Ц)

ЗАРЦУУЛАЛТЫН ЭРХ (*Spending authority*) Батлагдсан төсвийн хүрээнд төсвийн байгууллагын сар, улиралд зарцуулах төсвийн дээд хязгаарыг хэлнэ. Тухайн байгууллагын жилийн батлагдсан төсвийг сар, улиралд хуваан үзэж, санхүүгийн байгууллагаас шилжүүлэх хөрөнгийн зөвшөөрлийг олгодог. (А.Э)

ЗАСАГ БА ЗАСАГ БУС ВАН, ГҮНГҮҮДИЙН ЭРХ ХЭМЖЭЭНИЙ ДҮРЭМ (*Rules of legal status of governor and non-governor aristocrats*) Ардын засгийн газар 1922 оны гурван сард Хамжлагат ёсыг халах тухай тогтоол гаргажээ. Уг тогтоолоор ноёд, тайж нар болон тэдний хамжлага ба тайж нарыг хамжлагаас гаргаж бусад хүн амын адил сумын эрчүүдийн тоонд оруулах болжээ. Мөн оны 3 сарын 31 -нд Засаг ба засаг бус ван, гүнгүүдийн эрх хэмжээний дүрмийг гаргасан байна. Тухайн үед хошууны ноён хэмээх нэр, албан тушаалыг өөрчилж Засаг дарга хэмээн нэрлэх болсон байв. Язгууртнууд хошууг захирсан

хэвээр байсан тул тэдний эрх хэмжээг хязгаарлах шаардлагатайг харгалзан уг дүрмийг гаргажээ. Язгууртнуудыг хэвээр байлгахын зэрэгцээ хэргэмийг нь үр хүүхдэд нь залгамжлуулах ёсыг хэвээр үлдээж хэрэв үр хүүхэдгүй бол төрлийн хүнд залгамжлуулдаг ёсыг халжээ. Засаг дарга ба сул ван, гүнгүүдийн эрдэм чадлыг харгалзан улсын албандажилуулахыг зөвшөөрч, харин харьяат газраасаа татвар авч, хүмүүсийг зарцалж байсныг зогсоон хэрэв засаг дарга ард олны санаанд үл нийлэх бол шинээр сонгож байх журмыг тогтоожээ. Засаг дарга, сул ван гүнгүүд гэм хийвэл бусад ардын адил ял шийтгэл хүлээлгэх бөгөөд бусадтай адил эрх үүрэгтэй байна хэмээн ардуудыг харгислан дарлах, мөлжих, төр шашинд хорлол бүхий үйл үйлдэх, ардын засгийг үл ойшоох зэрэг үйлдэл гаргавал байцаан, үнэн нь тогтоогдвол засаг даргаас огцруулан шүүх яаманд шилжүүлж байхаар журамласан байна. Ардын засгийн газраас энэхүү дүрмийг тогтоож хэрэгжүүлсэн нь Монгол Улсад феодалын хамжлагат ёсыг халахад чиглэсэн чухал алхам болжээ. (А.Ц)

ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ (*Local administrative and territorial unit*) XX зууны 20-30 оноос захиргааны шинэтгэлийн үе эхэлсэн. Орчин үед орон нутгийн бие даасан байдлын анхны чухал санаа дэвшүүлсэн хүн бол Чарльз Тиебот. Түүний үзэл санаа орон нутгийн бие даасан бодлого, чадавч бүрдүүлэх арга замтай түлхүү холбоотой. Гордон Кларк орон нутгийн засаг захиргааны зорилго, түүнийгээ хэрэгжүүлэх эрх мэдлийн талаар өгүүлсэн бол Тед Роберт Гюрр Бесмонд Кинг нар хоёр хэв маяг бүхий орон нутгийн бие даасан байдлын үндсэн хэв шинжийн загвар гаргасан. Судлаач Б.Чимид засаг захиргаа, нутаг дэвсгэрийн

нэгжийн бүрдүүлбэр ойлголт бий болгож, нутаг дэвсгэрийн үндэс, хүн ам нийгэмшлийн үндэс, эдийн засгийн үндэс, засаг захиргаа, удирдлага, эрх зүйн үндэс гэсэн таван зүйлээр тодорхойлжээ.

Монгол Улс засаг захиргааны нэгжийн хувьд улсын нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороод, хороо нь хэсэгт, харин 21 аймаг нь сумдад, сум нь багт хуваагдана. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоо нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал ба тухайн Хурлын хуралдааны чөлөөт цагт хурлын Тэргүүлэгчид, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нар өдөр тутмын үйл ажлыг тасралтгүй явуулах үүрэгтэй. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмыг баримтлан ажиллана. (А.Э.ц)

ЗАСАГЛАЛ (Governance) Засаглалыг Грекийн “kubernáo” буюу “залуурдах, жолоодох” гэсэн үгнээс гаралтай. Монгол хэлний тайлбар тольд энэ үгийг “засаг төр барих” гэжээ. Энэ нь өргөн утгаараа, засгийн газар, орон нутгийн эрх мэдлийн байгууллагуудаас эрх мэдлийн хүрээндээ хэрэгжүүлж буй үйл ажиллагаа юм. Засаглал нь шууд утгаараа төр удирдахуйтай салшгүй холбоотой. Дэлхийн банкнаас 1989 онд эрхлэн гаргасан Дэлхийн хөгжлийн илтгэлд засаглал ойлголтыг эрх зүйт

төр, ардчиллын минимум түвшинг бий болгохгүйгээр эдийн засгийн хөгжил дэвшил ирэх боломжгүй гэсэн үзэлд суурилсан хөгжилд хандах шинэ хандлагыг илэрхийлжээ. Засаглалын үзэл баримтлал нь “олон түмний эрх ашгийг хөндсөн аливаа асуудлыг дан ганц төрийн байгууллагууд шийдвэрлэх боломжгүй бөгөөд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог чухалчилдаг”.² Засаглал нь “иргэд болон оролцогч талуудын хүсэн хүлээсэн сайн үр дүнд хүрэхэд хамтран ажиллах”³ явдал юм. Засаглал нь “Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн түншлэлээр эдийн засаг, улс төр, нийгмийн харилцааг удирдах үнэт зүйлс, бодлого, институцийн тогтолцоо” юм (НҮБХХ, 2010, хуудас. 10). Засаглал нь иргэд болон нийгмийн бүлгүүд ашиг сонирхол, өөр хоорондын ялгаатай байдлаа илэрхийлэх, хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх механизм, үйл явцтай холбоотой. Засаглал нь 1) тодорхой үр дүн гаргах чадвар, 2) тодорхой арга хэрэгслийн тусламжтайгаар бусдад нөлөөлөх гэсэн үндсэн хоёр агуулгыг багтаадаг. (Г.Б; Т.Т; Я.Т нар)

ЗАСАГЛАЛЫН АРГА ХЭРЭГСЭЛ (Governance tools)

Засаглалын арга хэрэгсэл нь өргөн агуулгатай ойлголт. Арга хэрэгсэл нь засгийн н эрх мэдлийг хэрэгжүүлэх явцад ашиглагдаж байгаа бүх төрлийн нөөц, арга зам, төр, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд зэрэг талуудын оролцоог хангаж, дэмжих, төрийн бодлого амжилттай хэрэгжих орчин нөхцөл. Засаглалын тухай уламжлалт ойлголт бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, иргэдтэй

2 Я.Долгоржав, Ш.Батсүх, Я.Бямбаяр (2015), Монгол улс дахь захиргааны шинжлэх ухааны парадигмын өөрчлөлт, сорилт, х. 3.

3 С.Зульфикар, Төрийн захиргааны хөгжлийн зарим асуудалд, Төрийн удирдлага, онол арга зүйн сэтгүүл, 2019, х. 35.

харилцах асуудлын хүрээнд эрчимтэй өөрчлөгдөх болсон. Мэдээлэл харилцааны технологи, иргэний нийгмийн хүрээнд явагдаж байгаа эрчимтэй хөгжил дэвшил нь төрөөс илүү хүртээмжтэй, үр ашигтай, сайн үйлчилгээг шаарддаг иргэдийг төлөвшүүлсэн. Цаг үеийн шаардлагыг дагаж төр засаглалын арга хэрэгслээ шинэчлэн сайжруулж иргэдийн оролцоо, нийгмийн сүлжээ, харилцааг дэмжсэн арга хэрэгслүүдийг сонгох болсон. Кристофер Хүүд: “Дижитал эрин үе дэх төрийн арга хэрэгслүүд”⁴ бүтээлдээ төр нь зангилааны төв, эрх мэдэл, эд баялаг, зохион байгуулалт гэсэн дөрвөн гол засаглалын арга хэрэгсэлтэй гэжээ. (Ж.Ж)

ЗАСАГЛАЛЫН ЧАНАР (*Quality of Governance*) Чанар нь Латин хэлний “qualitatem” гэсэн үгнээс үндэстэй бөгөөд үгийн гол утга нь аливаа юмны бодит шинж тэмдэг нөгөөгөөс ялгарах онцлог, найдвартай байдлыг илэрхийлдэг. Засаглал нь төр барих ухаан, чадвартай холбоотой. Засаглал нь төр, иргэн болон бусад оролцогч талуудын хамтын ажиллагаанд тулгуурлан төрийн үйл хэргийг гүйцэтгэх чадвартул засаглалын чанар нь иргэд, оролцогч талуудаас тавьж буй шаардлага, хүлээлтийг хангах үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно. Үүнд: хариуцлагын тогтолцоо, ил тод байдал, урьдаас тодорхой байдал, оролцоо зэрэг үзүүлэлтүүд болно. Хариуцлагын тогтолцоо нь төрийн албан хаагчдыг хийсэн үйлдлийнх нь төлөө хариуцлага хүлээлгэх чадвар, ил тод байдал нь холбогдох мэдээллийг өртөг багатайгаар хүртээх боломж, мэдээллийн нээлттэй байдал, урьдаас тодорхой байдал нь хууль, дүрэм журам тодорхой, урьдаас мэдэх боломжтой, нийтээр дагаж мөрддөг

байх, оролцоо нь найдвартай мэдээлэл түгээх, төр засгийн үйл ажиллагааны үнэн зөв байдлыг нягтлах тухай асуудал юм.⁵ Эдгээр бүрэлдэхүүн хэсгийн аль ч дангаараа орших боломжгүй өөр хоорондоо уялдаатай. (Т.Т)

ЗАСГИЙГ ШИНЭЧЛЭН БҮТЭЭХҮЙ (*Reinventing government*)

“Invent” гэдэг нь Латин хэлний “inventus” үгнээс гаралтай ба “бүтээх, урлах, шинийг сэдэх” гэсэн утгатай. “Re” буюу “дахин”, “invent” буюу “бүтээх” гэдгээс үзвэл дахин шинээр зохион бүтээх гэсэн утгатай. Энэ нь төрийн шинэ удирдлагын АНУ-ын шинэчлэлийн үзэл санаа юм. Шинэчлэлийн гол зорилго нь захиргааны үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэн гол төлөв орон нутагт хэрэгжсэн байдаг. Төрийн үүргүүдийг хувийнханд шилжүүлэх, бизнесийн байгууллагын арга барилыг төрд нэвтрүүлэх замаар төрийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад чиглэсэн үзэл баримтлалын санааг Дэвид Осборн, Тед Гэблер нар 1992 онд “Засгийг шинэчлэн бүтээх нь” бүтээлдээ тусгасан. Засгийг шинэчлэн бүтээх нь бизнес овсгоотой засгийн дүр зургийг гаргаж, түүнийг бүтээхэд тулгуур болж байгаа арван зарчмыг тодорхойлсон нь төрийн ажил хэргийг шинэ арга барилаар явуулах боломжийг тодорхойлжээ. Тухайлбал, 1) сэлүүрдэхийн оронд залуурдах, 2) иргэдийн идэвхийг дэмжих, 3) өрсөлдөөнийг бий болгох, 4) заавар журмын сэтгэлгээг даван туулах, 5) орцыг бус үр дүнг санхүүжүүлэх, 6) хэрэглэгчдэд чиглэж ажиллах, 7) зарцуулах бус, ашигт чиглэж ажиллах, 8) шатлалаас оролцоо ба багийн ажиллагаанд шилжих, 9)

4 Christopher C. Hood, Helen Z. Margetts, The Tools of Government in the Digital Age. Palgrave Macmillan. 2007.

5 Салвагор Шнаво-Кампо ба Пачампет Сундарам (2000), Өрсөлдөөнт ертөнцөд төрийн захиргааг сайжруулах нь, х. 11.

эмчлэхийн оронд урьдчилан харах, 10) зах зээлийн сэтгэлгээг нэвтрүүлэх зэрэг болно. (Т.Т)

ЗАСГИЙН ГАЗАР (Government)

Энэхүү ойлголт нь нэр томьёоны хэд хэдэн удаагийн өөрчлөлтөд орсноор ардчилсан улс орнуудын хувьд илүү чухал утга санааг агуулж иржээ. Улс төрийн шинжлэх ухааны зарим нэвтэрхий тольд “government” ойлголтыг төр буюу засаглал хуваарилах онолыг харгалзахгүйгээр, гурван салааг салгахгүй авч үзэж ойлгох тохиолдол байдаг бол захиргааны шинжлэх ухаанд засгийн газар гэсэн утгаар ойлгож орчуулдаг. Дундад зууны үед *regere* болон *gubernare* нь адил утгатай хэрэглэгдэж байв. Англи, Франц хэлтэй улсуудад *govern* болон *government* буюу *gouverner* болон *gouvernement* латин хэлний *gubernare*, герман хэлтэй орнуудад латин хэлний *regere*-ээс *Regierung* гэж үүссэн байна⁶. Засгийн газар (*government*) болон захиргаа (*administration*) ойлголтыг төдийлөн хооронд нь ялгаж салгадаггүй байв. Сүүлд засаглал хуваах онолын нөлөөгөөр гүйцэтгэх болон хууль тогтоох засаглал гэсэн ойлголтод нэгтгэгдсэн байна. Хэмжээгүй эрхт хаант засаглалын үед засгийн газар нь эзэн хаанд туслах институт гэсэн утгыг агуулж байв. Их Британийн ерөнхий сайд Бенжамин Дизрайли намын засгийн газар (*party government*) гэсэн ойлголтыг тухайн үед төр барьж байсан улс төрчдийн нэгдлийг илэрхийлэхэд хэрэглэж байв. Орчин үед Их Британид засгийн газар гэсэн ойлголтын хүрээнд кабинетын засгийн газар (*the cabinet*) -ыг авч үзэж сайдууд болон парламентын нарийн бичгийн дарга нарыг багтаадаг. Харин АНУ-д засгийн

газар нь захиргаа (*the administration*) эсвэл гүйцэтгэх засаглал (*the executive*) гэж тайлбарлагддаг. АНУ-д өргөн утгаар удирдлагын тогтолцоо гэсэн утгыг агуулдаг бөгөөд төв засгийн газар, холбооны муж бүрийн засгийн газар, дүүрэг, хотын захиргааг бүхэлд нь багтааж ойлгодог. Парламентын тогтолцоотой оронд засгийн газрын үндсэн үүрэг нь бодлого боловсруулах. Хууль тогтоох байгууллагад өргөн барих хуулийн төслийг ихэвчлэн гүйцэтгэх засаглалын байгууллагууд бэлтгэж боловсруулдаг. Хууль, бодлогын баримт бичиг батлагдсаны дараа хэрэгжүүлэх үүрэг гарч ирнэ. Засгийн газрын гурав дахь үүрэг нь зохицуулалт юм. 1990-ээд оноос хойш засгийн газар (*government*) нэр томьёог хэрэглэхээс аль болох зайлсхийж засаглал (*governance*) гэсэн ойлголтыг хэрэглэж байна. Нэвтэрхий толь бичгүүдэд “Засгийн газар” (*government*) гэсэн толгой үгийг “засаглал” буюу “*governance*”, засаглах чадвар буюу “*governability*” гэсэн үгээр солих болжээ. Орчин үеийн засгийн газрын талаарх судалгаанд гүйцэтгэх “засаглалын үндсэн загварууд”, “рационал сонголтын институционализм” болон “засаглалын судалгаанууд” гэсэн гурван үндсэн хандлага зонхилж байна⁷. (Ж.Ж)

ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН ХАРИЛЦАА (Intergovernmental relations)

Засгийн газрын харилцаа нь холбооны улсын доторх төв засгийн газар болон холбооны улсын доторх орон нутгийн засгийн газар хооронд явагдана. Энэхүү харилцаа нь хоёр талт, олон талт, салбарын, босоо түвшинд холбооны засгийн газар төв засгийн газартай, хэвтээ түвшинд бусад холбооны

6 International Encyclopedia of Political Science. Bertrand Badie. SAGE. 2011. Government. pp. 1035-1041.

7 International Encyclopedia of Political Science. Bertrand Badie. SAGE. 2011. Government. pp. 1035-1041.

засгийн газартай харилцана. Жишээ нь: Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улс юм. Босоо түвшинд Шотланд болон Их Британийн Засгийн газар, хэвтээ түвшинд Шотланд болон Уэльсийн засгийн газар харилцана. Ихэнх холбооны улсууд засгийн газрын байгууллагын хоорондын үйл ажиллагааг зохицуулах, санал солилцох, зөрчилтэй асуудлаар шийдэлд хүрэх албан ёсны үйл ажиллагааны тогтсон арга замтай байдаг. Жишээ нь Австралид салбарын асуудлыг шийдэхдээ холбооны болон төв засгийн газрын сайд нар, холбогдох албан тушаалтнуудаас бүрдсэн зөвлөл хуралддаг. Зарим оронд төв болон холбооны засгийн газар хооронд үүсдэг зөрчил, маргаан, нэгнийгээ үл хүндэтгэх, дарамт шахалт үзүүлэхээс сэргийлж харилцааны зарчмыг маш тодорхой заасан. Энэхүү зарчим нь Үндсэн хууль, бусад хууль, дүрэмд илрэлээ олсон байдаг. Сүүлийн жилүүдэд Австрали, АНУ зэрэг холбооны улсуудад төв засгийн газарт эрх мэдэл илүү төвлөрч эсрэгээр нэгдмэл улсууд илүү төвлөрсөн бус болох хандлага ажиглагдах болсон байна. Хөгжиж байгаа орнуудад тухайлбал, Хятад, Вьетнам, Индонез зэрэг улсуудад орон нутгийн захиргаа илүү бие даах, санхүүгийн болон шийдвэр гаргах эрх мэдэл нь нэмэгдэж байна⁸. Засгийн газар хоорондын харилцааг зөвхөн холбооны улсад байдаг гэж өрөөсгөл ойлгож болохгүй. Төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улсад төв засгийн газар болон нутгийн өөрөө удирдах байгууллага хоорондын харилцаанд мөн адил ижил төстэй асуудлууд тулгардаг. Гэхдээ нэгдмэл улсуудад байдаггүй харилцааны онцлог шинжүүд бий. Үндсэн хуулиар холбооны бүрэлдэхүүний хууль

тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг бататгаж өгснөөр нэгдмэл улсын орон нутгийн захиргаанд байдаггүй бие даасан байдал, хамгаалалт, эрх мэдэлтэй болдог. (Ж.Ж.)

ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭН ЭРХ (*Power of the government*)

Хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан технологийн талаарх хөгжлийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хүн амын нийгмийн хамгаалал, хүрээлэн буй орчин, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журам, үндэстний гадаад дотоод харилцаа, аюулгүй байдлыг хангах хуулиар хүлээсэн үүргийг биелүүлэхэд нийгмийн гэрээний хүрээнд олгогдсон эрх, түүнийг эдлэх явдал. Аливаа улс орны Засгийн газар дараах хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хууль, тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж хангах;
- Эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Нийгмийн хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хүн амын нийгмийн хамгааллыг хангах;
- Салбарын, салбар хоорондын, бүс нутгийн хөгжлийг хангах;
- Байгаль орчноо хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах;
- Төрийн байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;
- Батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах;
- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв жуармыг бэхжүүлэх;
- Гадаад бодлого хэрэгжүүлэх, гадаад улстай гэрээ, хэлэлцээр байгуулах.

8 John Phillimore, Understanding Intergovernmental Relations: Key Features and Trends. Australian Journal of Public Administration, vol. 72, no. 3, pp. 228-238.

Засгийн газар бүрэн эрхээ тодорхой хугацаатай хэрэгжүүлэх ба бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө уг эрхийг дуусгавар болгож болно. (Г.Б)

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (Government debt) Засгийн газар, Олон улсын банк, санхүүгийн байгууллага, эсвэл гадаад болон дотоод хувийн хэвшлийн пүүс компани, банк, санхүүгийн байгууллагаас тодорхой нөхцөлтэйгөөр гэрээ, хэлэлцээрийн үндсэн дээр ямар нэгэн өрийн хэрэгслийг ашиглан хүлээн авсан хөрөнгийн дүнг хэлдэг. Өрийн хэрэгсэлд бүх төрлийн зээл, үнэт цаас болон өр үүсгэх аливаа гэрээ, хэлцлийг ойлгоно. Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлээс бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг, мөн хууль болон гэрээнд заасны дагуу гаргасан Засгийн газрын өрийн баталгааны дүнг⁹ хэлдэг. Засгийн газрын өрийг эх үүсвэрээс шалтгаалан гадаад өр, дотоод өр гэж ангилдаг. Засгийн газрын гадаад өрд ихэвчлэн Олон улсын банк, санхүүгийн байгууллагууд болох Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк зэргээс авсан хөнгөлөлттэй зээлийн өр, мөн богино хугацаатай өндөр хүүтэй арилжааны зээлийн өрийг оруулан тооцдог. Харин дотоод өрд Засгийн газрын дотоод үнэт цаас болон Төв банкнаас авсан зээлийн өр орж тооцогддог. (А.Э)

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА (Government debt management) Засгийн газрын богино, дунд хугацааны санхүүгийн зардал, эрсдэлийн түвшинг тодорхойлсны үндсэн дээр стратеги боловсруулж хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангах, хяналт тавих үйл ажиллагаа.¹⁰ Засгийн газрын хөтөлбөр, арга хэмжээг дунд

⁹ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

¹⁰ Өрийн удирдлагын тухай хууль

болон урт хугацаанд тогтвортой, хамгийн оновчтой зардлаар (гадаад, дотоод эх үүсвэрээс) санхүүжүүлэх, түүнтэй холбогдон гарах эрсдэлийг урьдчилан тодорхойлсон, хүлээн зөвшөөрөхүйц хэмжээнд удирдахыг хэлнэ. Засгийн газрын өрийн удирдлагын бүрэлдэхүүн хэсгүүдэд 1) Засгийн газрын гадаад өрийн удирдлага, 2) Засгийн газрын дотоод өрийн удирдлага, 3) Төрийн сангийн бэлэн мөнгөний удирдлага, 4) Дамжуулан зээлдүүлсэн зээлийн удирдлага, 5) Төсвийн зээлийн удирдлага зэрэг асуудлууд багтана. (А.Э)

ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮГИЙН НЭГДСЭН ТАЙЛАН (Government financial statement) Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан нь

Засгийн газрын харьяа бүх салбар, байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг стандартын дагуу нэгтгэж тайлагнасан тайланг хэлдэг. Санхүүгийн тайлан нь төсвийн гүйцэтгэлийн тайлангаас ялгаатай нь цуглуулсан орлого, зарцуулсан дүнг харуулахаас гадна хөрөнгө, өр төлбөр, өмчийн дүнг нэгтгэн тайлагнадаг. Засгийн газрын санхүүгийн тайланд ихэвчлэн үйл ажиллагааны тайлан (хувийн хэвшлийн орлогын тайлантай адил), тайлан тэнцэл, ихэвчлэн зарим төрлийн нэгтгэлийг багтаасан байдаг. Орлогын эх үүсвэр, зардлыг харуулахын тулд бэлэн мөнгөний урсгалын тайланг оруулдаг. (А.Э)

ЗАСГИЙН ГАЗРЫН ТАНХИМ (Cabinet)

Засгийн газрын танхим гэсэн ойлголт нь улс орны онцлог, хэрэглээнээс хамаарч зарим тохиолдолд cabinet гэж орчуулагддаг бөгөөд хамгийн сонгодог жишээ нь Их Британийн Засгийн газрыг cabinet гэж нэрлэдэг. Засгийн газар нь тухайн улсын улс төрийн тогтолцооноос хамаарч

ерөнхийлөгч, парламентын өмнө эсвэл аль нэгнийх нь өмнө хариуцлага хүлээж төрийн албыг удирдан чиглүүлдэг төрийн гүйцэтгэх дээд байгууллага юм. Засгийн газрын тэргүүн нь улс төрийн тогтолцооноос хамаарч өөр өөр байдаг бөгөөд тухайлбал ерөнхийлөгч, ерөнхий сайд, канцлер, сайд нарын зөвлөлийн тэргүүн юм. Дэлхийн улс орон бүрийн засгийн газар нь хэмжээ, бүтэц, бүрэлдэхүүн, сайд нарын тоо, эрх мэдлийн хүрээ хязгаарын хувьд харилцан адилгүй. Сайд бүр тухайн засгийн газрын гишүүн болдоггүй. Тухайлбал, Их Британийн Засгийн газар 2021 оны байдлаар албан ёсны 116 сайдтай боловч засгийн газрын хуралдаанд суух эрхтэй “Засгийн газрын сайд” нь 22 байна. Засгийн газрын кабинетын тогтолцоо нь Их Британаас гарвалтай. XVII зуун, XVIII зууны эхэн үеэс хааны хувийн зөвлөл төрийг үр дүнтэй удирдахын тулд томрох хэрэгцээ үүссэнээр бий болсон байна. Английн хаан II Чарльз (1660-1685) өөрийн хувийн зөвлөлийн тэргүүлэх гол гишүүдтэй зөвлөл бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдахаас өмнө уулзаж гол асуудлаар шийдвэр гаргадаг байжээ. Дэлхийн улс орнуудын засгийн газруудын дотроос хамгийн алдартай нь Их Британи болон АНУ-ын засгийн газар юм. Орчин үеийн Их Британийн Засгийн газар 20-22 гишүүнтэй бөгөөд сайд нарыг ерөнхий сайд томилдог. Ерөнхий сайдыг нийтийн танхимаас олонхын саналаар дэмжсэн тохиолдолд эзэн хаан томилдог. Сайд нар нь хариуцсан яам, нэгжийнхээ өмнө хариуцлага хүлээнэ. Харин засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ парламентын өмнө хариуцлага хүлээдэг бөгөөд засгийн газрын гишүүн бүр засгийн газрынхаа бодлогыг олон нийтийн өмнө хамгаалахад бэлэн байх ёстой. Засгийн газрын гишүүд кабинетын

зарчмаар ажиллах бөгөөд засгийн газрын хуралдааны явцад харилцан санал зөрөлдөж болох боловч хуралдаан дууссаны дараа гарсан шийдвэрийн хүрээнд бүгд нэгдмэл байр суурин дээр нэгдэх ёстой. Эх газрын Европын засгийн газрын тухайд Британийн тогтолцооноос зарим талаар ялгаатай. Орчин үеийн Европын засгийн газрууд XIX зууны үеэс бий болсон байна. Итали, Франц зэрэг Европын ихэнх оронд засгийн эрхийн төлөө олон нам өрсөлдөж, сонгуулийн үр дүнгээс хамаарч эвслийн засгийн газар байгуулагдах нь түгээмэл үзэгдэл юм. АНУ-ын хувьд ерөнхийлөгч засгийн газрын тэргүүний үүргийг гүйцэтгэдэг. Ерөнхийлөгч гүйцэтгэх засаглалын нэгж, яамдын удирдлага буюу нарийн бичгийн дарга нарыг сенатын зөвшөөрлөөр томилдог. АНУ-ын Үндсэн хуулинд засгийн газрын хуралдаан хийх тухай заалт байдаггүй учир засгийн газар гэсэн бүтэц нь хуулинд гэхээсээ илүүтэй заншилд суурилсан байдаг. АНУ-ын анхны ерөнхийлөгч Жорж Вашингтон төрийн удирдах албан тушаалтнуудтай тогтмол уулздаг заншилтай байсан бөгөөд кабинет гэсэн нэр томьёог Жамес Мадисон 1793 онд анх хэрэглэсэн түүхтэй. (Ж.Ж)

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН *(Government special fund)*

Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зориулалттай төсвийн тусгай дансыг¹¹ хэлнэ. Засгийн газрын тусгай сан нь нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсгүүд. Засгийн газрын тусгай санг хуулиар байгуулж мөн татан буулгах бөгөөд сангийн төрлүүд янз бүр: байгаль орчин, уур амьсгалын тусгай сан, жижиг, дунд, үйлдвэрийг хөгжүүлэх тусгай сан,

11 Засгийн газрын тусгай сангийн тухай хууль.

боловсролын зээлийн тусгай сан гэх мэт. (А.Э)

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС (*Government securities*) Үнэт цаасны нэг төрөл бөгөөд эзэмшигч болон үнэт цаас гаргагч нь Засгийн газар байхыг хэлнэ. Энэ үнэт цаас нь эрсдэл багатай үнэт цаасанд тооцогддог тул зах зээлийн жишиг хүүтэй бөгөөд түүний өгөөжийн муруй нь дараах зорилгоор ашиглагддаг байна. Үүнд: хөрөнгө оруулагчдад тухайн зах зээлийн эрсдэлийг ойлгоход туслах, зах зээлийн ирээдүйн нөхцөл байдлын хүлээлтийг харуулах, шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтооход жишиг болох хүүтэй байх, бусад орны санхүүгийн зах зээлийн дундаж өгөөжийн хүүтэй харьцуулах зэрэг болно. Хөрөнгө оруулагчдад Засгийн газрын үнэт цаас нь хөрвөх чадвар өндөртэй, эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хэрэгсэл болдог, нөгөө талаар орлого, татвараас чөлөөлөгддөг учраас давуу талтай. (А.Э)

ЗАСГИЙН ГАЗРЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ (*Government response*)

Олон нийт, байгаль орчин, нийгэм, бүлгийн үйл ажиллагааны үр дагаварт чиглэсэн төрийн удирдлага, хяналт зохицуулалтын хариу үйлдэл бүхий шинж чанартай үйл ажиллагаа. Ихэнх тохиолдолд байгалийн гамшигт үзэгдэл, аюул ослын үед хариу арга хэмжээ авахад чиглэнэ. Хариу арга хэмжээ авах нь хямралын удирдлагын нэг үе шат¹². Энэ үе шатанд хямралын удирдлагын төлөвлөгөө болон хямралын удирдлагын багийг идэвхжүүлнэ. Хямралыг хохирол багатай даван туулах, учирсан хохирлыг нөлөөг арилгах арга хэмжээ

авахад оролцогч талуудыг зохистой оролцоо, тэдгээрийн хоорондын мэдээлэл дамжуулалт шаардлагатай. Оролцогчдын үйл ажиллагааг хямралын удирдлагын гишүүд хянах ба нөхцөл байдлыг бүхэлд нь хяналтад байлгахыг зорьдог. (Г.Б)

ЗАСГИЙН ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА (*Government procurement*)

Нөхцөл шалгуур тогтоож, төр, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, нийлүүлэгчийг сонгох үйл явц. Засгийн газар, төрийн өмчийн ажахуйн нэгж нь бизнесийн ба бусад иргэний нийгмийн байгууллага, иргэдээс зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг худалдан авч эдийн засаг дахь томоохон хэрэглэгч болдог. Монгол Улсад 2000 онд анх “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай” хууль батлагдсанаар худалдан авах ажиллагаа олон улсын стандартаар хийгдэх эхлэл тавигдсан. Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн зохион байгуулахаар хуульчилсан бөгөөд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулах үүргийг төрийн худалдан авах ажиллагаанд оролцогчид хүлээдэг. (Б.Б)

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭЛБЭРҮҮД (*Forms of Government*)

Төрийг байгууламж, дэглэм, удирдлагын хэлбэрээс хамаарч улс орнуудын засгийн газар нь өөр өөрийн онцлог хэлбэрүүдтэй байдаг. Төрийг байгууламжийн хувьд нэгдмэл

12 Tokakis, Polychroniou, Boustras: "Crisis management in public administration: The three phases model for safety incidents", Safety Science (2019), pp. 37-43.

(БНХАУ, Франц, Их Британи) улсад төвлөрсөн эрх мэдэлтэй, төв үндэсний засгийн газартай бол холбооны (ОХУ, Энэтхэг, АНУ, ХБНГУ) улсуудад төв засгийн газраас гадна холбооны муж, орон нутгийн засаг захиргаа нь өөрийн засгийн газар, хууль тогтоох байгууллагатай. Ерөнхийлөгчийн засаглалтай улс орнуудад засгийн газрыг ерөнхийлөгч өөрөө тэргүүлж танхимаа бүрдүүлдэг бол хагас ерөнхийлөгчийн болон парламентын засаглалтай улсад ерөнхий сайд засгийн газрыг удирддаг. Засгийн газрыг явуулж буй бодлого, үзэл суртлаар нь социалист, коммунист, халамжийн дэглэмийн онцлогоос хамаарч ардчилсан, авторитар, тоталитар, цэргийн засгийн газар гэж ангилж болно. (Ж.Ж)

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР (*Cabinet secretariat*)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь засгийн газрын шийдвэр, яам, нэгж, байгууллагуудын хоорондын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилладаг. Түүнчлэн тухайн улсын улс төрийн тогтолцооноос хамаарч засгийн газрын тэргүүн буюу ерөнхий сайд, ерөнхийлөгчийг мэдээллээр хангаж бүх талын дэмжлэг үзүүлэн, засгийн газрын хэвийн, үр дүнтэй үйл ажиллагааг хангана. Бусад үүргийн тухайд засгийн газрын хуралдааныг зохион байгуулах, бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавина. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь тухайн улсын төрийн бодлогын залгамж чанарыг алдагдуулахгүй, төрийн захиргааны үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг хангахад чухал үүрэгтэй. (Ж.Ж)

ЗАХ ЗЭЭЛ (*Market*) Бараа, ажил, үйлчилгээг худалдах, худалдан

авахтай холбоотой хэрэглэгч, нийлүүлэгчийн хоорондын харилцааны талбар. Зах зээл нь тогтолцоо, дүрэм журам, харилцаа ба оролцогч талуудын хооронд нөөцийг солилцох дэд бүтцийн нэгдэл гэж тодорхойлогдоно. Зах зээлийг арилжаалагдах эцсийн бүтээгдэхүүний шинж чанар (биет бүтээгдэхүүн, үйлчилгээ), үйлдвэрлэлийн хүчин зүйл (түүхий эд, ажиллах хүч), газар зүйн байршил (орон нутаг, олон улс, дотоод ба гадаад), төрөөс хэрэгжүүлэх зохицуулалтын нөхцөл (зохицуулалттай ба чөлөөт зах зээл), арилжааны хэлбэр (бөөний ба жижиглэнгийн), худалдан авагчийн бүлэг, үнийн хязгаар, мэдээллийн тэгш байдал зэрэг хүчин зүйлсээр ангилж болно. Нийтийн бараа үйлчилгээний хувьд нийлүүлэгчийн үүрэг гүйцэтгэхээс гадна төр аливаа зах зээлийн харилцаанд зохицуулагчийн үүрэгтэй оролцдог. Худалдааны тариф, нийлүүлэлтийн хориг тогтоох, патент зөвшөөрөл олгох зэрэг арга хэрэгслийг ашиглан зах зээлд өрсөлдөөнийг хязгаарлаж зохицуулалт хийнэ. Мөн гадаадын өрсөлдөгчдөөс дотоодын үйлдвэрлэгч, нийлүүлэгчийг хамгаалах зорилгоор татвар тогтоох, цахилгаан, дулаан, усан хангамж зэрэг суурь үйлчилгээний үнийг хянах зорилгоор нийлүүлэгчийн тоог хязгаарлах зэргээр зах зээлийн харилцааг төрөөс зохицуулдаг. (Б.Б)

ЗАХ ЗЭЭЛИЙН ЖОЛООДЛОГО (*Market driven*)

“Market” гэдэг нь Францын “marchiet (XII зуун)” буюу “мал, амьтны гаралтай бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах, борлуулах үйл явдал болдог газар” гэсэн утгатай үгнээс үүсэлтэй.¹³ Монгол хэлнээ “Market” гэдгийг

13 Market (n.). (n.d.). Retrieved from <https://www.etymonline.com/word/market>

“худалдаа арилжааны газар” гэх бөгөөд орчин цагт “зах зээл” гэсэн утгаар орчуулан хэрэглэдэг. “Drive” гэдэг нь эртний Английн “drifan” гэх үгнээс үүсэлтэй, үгийн утга нь “хөдөлгөх, жолоодох” санааг илэрхийлдэг. Үгийн нийлэмж нь зах зээлээр жолоодох гэсэн санааг илэрхийлж байна. 1980-аад оны төгсгөлөөр төрийн захиргаанд төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн туршлага, зах зээлийн механизмыг нэвтрүүлэх улсын салбарын шинэ удирдлагын үзэл санаа түрэн орж ирсэн байдаг. Энэ үеэс нийгмийн амьдралын олон талт үзэгдлийг өрсөлдөөн зах зээлийн механизмаар зохицуулах оролдлого хийж эхэлсэн. Зах зээлээр жолоодох нь төрийн байгууллагын үйл ажиллагааг өрсөлдөөнт зах зээлийн механизмаар зохицуулах үйл явц юм. Тухайлбал, төрийн оролцоог багасгах, төсөв хэмнэх зорилгоор төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх /хувьчлах/, тодорхой ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг сайжруулах зорилгоор бизнесийн салбарын менежментийн арга хэлбэрийг төрийн салбарт нэвтрүүлэх зэрэг болно. (ТТ)

ЗАХ ЗЭЭЛИЙН ХҮЧ (Market force)

Аливаа чөлөөт зах зээл дээр борлуулж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, тоо хэмжээнд өөрчлөлт оруулахуйц нөлөө үзүүлдэг эрэлт ба нийлүүлэлтийн өөрчлөлт. Жишээлбэл, байгалийн таагүй нөхцөлийн улмаас улаан буудайн ургац алдагдсан жил нийлүүлэлт нь буурч, улмаар улаан буудайн үнэ өснө. Нийлүүлэлтийн энэ өөрчлөлт нь зах зээл дээр борлогдох улаан буудайн тоо хэмжээг бууруулж,

үнийг өсгөж байгаа учир “зах зээлийн хүч”-ийн илэрхийлэл юм. Технологийн шинэ арга хэрэглэснээр нэг барааны үйлдвэрлэлийн зардал буурч, нийлүүлэлт нь нэмэгдсэн тохиолдолд тухайн барааны үнэ буурч, борлуулалт нэмэгдэнэ. Энэ мөн л зах зээлийн хүч “ажлаа хийж” буй хэрэг. Зах зээлийн хүч үйлчилж буй тохиолдолд тухайн барааны үнэ эрэлт ба нийлүүлэлтээр тогтоогдож, энэ үнэ нь тухайн барааны “харьцангуй хомс байдал”-ын илэрхийлэл болдог. Эрэлт эсвэл нийлүүлэлтэд өөрчлөлт орсноор тухайн бараа өмнөхөөсөө “илүү ховор” эсвэл “илүү элбэг” болох учир үнэ нь өөрчлөгддөг. Зах зээл өөрөө ийнхүү тэнцвэрт байдалд орох үзэгдлийг Адам Смит “үл үзэгдэгч гар”-ын нөлөө хэмээн нэрлэсэн нь үндсэндээ “зах зээлийн хүч” үйлчилж буйг илэрхийлнэ. Төр, барааны үнэ болон тоо хэмжээг тогтоосноор зах зээлийн хүчний үйлчлэл үгүй болж буйг илтгэнэ. (Ч.Н)

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ (Market economy)

Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтийн харилцан үйлчлэлийн нөлөөгөөр өөрчлөгдөх үнийн мэдээлэлд тулгуурлаж эдийн засгийн нөөцийн хуваарилалт, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, борлуулалтын талаарх шийдвэр гардаг онцлогтой зах зээлийн хэлбэр. Эдийн засгийн харилцаанд оролцох төрийн оролцооны түвшинг харгалзан зах зээлийн эдийн засгийг хэлбэрийг ангилж болдог. Оролцоог бага түвшинд байлгаж нийтийн бараа, үйлчилгээний нийлүүлэлтийг хангах болон эдийн засгийн аюулгүй байдлыг хамгаалах, зохицуулалт хийх чиг үүргээр төрийн оролцоог хязгаарладаг чөлөөт зах зээлийн эдийн засаг, зах зээлийн гажуудлыг засах, нийгмийн хамгааллыг дэмжих зэрэгт засгийн газар оролцоо их,

төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засаг гэсэн ялгаатай хэлбэрүүд байна. Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд төрөөс сангийн ба мөнгөний бодлогыг хэрэгжүүлж зохицуулалт хийдэг ба өмчийн харилцааны хувьд хувийн, төрийн, хувь нийлүүлсэн өмчийн аль ч хэлбэрийг хүлээн зөвшөөрч хувийн өмч давамгай байр суурьтай байдаг онцлогтой. (Б.Б)

ЗАХИРАХ, ЗАХИРАГДАХ ЁСНЫ ТУХАЙ (*Rules of subordination*)

1922 онд Засгийн газрын өргөтгөсөн хурлаас баталсан. Уг баримт бичигт түүнийг гаргасны учир шалтгааныг тодорхойлохдоо зарим хүмүүс эрх чөлөөтэй болсныг ерөөс хууль журамгүй болсон мэт буруу ойлгож, балмад түрэмгий явах болсон тул ардын эрхт хэмжээт цаазат засгийн ёс бол захирах, захирагдахын ёс ба эрүү шүүлт, яллах залхаахыг бүрэн устгасан биш, гагцхүү эдэдэс нь дордыг учиргүйгээр эзэрхэн дарлах, дордос нь тэдний эрх сүрд дарагдан зүдэж зовох муу суртлыг халж, ард түмэнд эрх чөлөө олгосон гэдгийг ухуулан сэнхрүүлэхийн зэрэгцээ энэ тухай дүрэм хэмжээг тогтоохоор болов гэжээ. Дашрамд дурдахад Монгол Улс 1924 онд Үндсэн хуулиа баталж Бүгд Найрамдах Улс болсноор Манжийн үеийн эрүү шүүлтийг халжээ. (А.Ц)

ЗАХИРГАА (*Administration*) Үг зүйн хувьд “захиргаа” нь захирах, засаглах гэсэн үйл үгнээс гаралтай нэр үг бөгөөд бусдад хүсэл зоригоос нь үл хамааран тушаах, даалгах, дагуулах гэсэн утгатай. Ямар нэгэн этгээдээс өөрийн хүсэл зоригоо бусдад тулган хүлээлгэж, хэрэгжүүлэх давуу байдлыг илэрхийлдэг. “Захиргаа” нэр томьёо дараах утгыг илэрхийлдэг. Үүнд: а) захирах үйлдлийг хийж буй этгээд; б) аливаа этгээдийн

захирах үйлдэл. Захиргааны дараах тодорхойлолтууд бий: өргөн утгаараа жолоодох, удирдах үйл ажиллагаа; хууль тогтоох болон шүүх эрх мэдлээс бусад төрийн байгууллагын удирдлагын гүйцэтгэн захирамжлах үйл ажиллагаа; гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын нэр; хүмүүсийн үйл ажиллагааг удирдаж, жолоодож байгаа аппарат, байгууллага, хүний нэгдэл. Захиргаа нь материаллаг утгаараа нийгэм болон түүний гишүүдийн олон талт, нөхцөл болзол бүхий эсхүл тодорхой зорилгод чиглэсэн, нийтийн үйл хэргийг хэрэгжүүлэхэд тусгайлан захиалагдсан, үйл ажиллагаандаа өөрөө оролцон шийдвэр гаргадаг, түүнийгээ биелүүлж хариуцдагаараа бусдын хувьд тодорхой нийгмийн үйл хэргийг гардан хэрэгжүүлэгч юм¹⁴. (Ч.Э)

ЗАХИРГААНЫ АКТЫН БИЧМЭЛ БУС ХЭЛБЭР (*Oral [unwritten] form of administrative act*)

Захиргааны акт бичмэл бус хэлбэртэй байж болно. Эдгээр акт нь бичмэл актын нэгэн адил захиргааны харилцаа үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэгдэнэ. Эдгээр акт гаргах нь хялбар тул шуурхай удирдлагын асуудлыг шийдвэрлэхэд тохиромжтой байдаг. Дараах тохиолдолд захиргааны актыг амаар, эсхүл бичмэл бус хэлбэрээр гаргаж болно. Үүнд: захиргааны актыг хойшлуулшгүй гаргах шаардлагатай бол (жишээ нь, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ жолоо барьж байгаа хүнийг цагдаагийн ажилтан илрүүлсэн тохиолдолд үүргийнхээ дагуу хойшлуулшгүй арга хэмжээ авна); хууль, захиргааны хэм хэмжээний актад тодорхой хэлбэрийг заасан бол (замын хөдөлгөөний төрөл бүрийн зохицуулалт, зогсохыг

¹⁴ П.Одгэрэл: Захиргааны эрх зүйн ерөнхий анги. Улаанбаатар, 2008, х. 25.

хориглох, хурд хязгаарлах, нэг урсгалт зам, эргэхийг хориглох зэрэгт замын тэмдэг, тэмдэглэгээ ашиглан хэрэгжүүлэхийг шаардсан байдаг); эрх зүйн ялимгүй үр дагавар бүхий асуудлыг шийдвэрлэх бол (жишээ нь, төрийн байгууллагын байранд нэвтрэх гэж буй хүнээс харуул хамгаалалтын ажилтан цүнхээ нээж шалгуулахыг шаардах); захиргааны актыг бичгээр гаргах боломжгүй, эсхүл тохиромжгүй бол (цагдаагийн хөдөлгөөн зохицуулж буй дохио нь бичгээр гаргахад тохиромжгүй). Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээдээс шаардвал захиргааны байгууллага амаар, эсхүл бичмэл бус хэлбэрээр гаргасан захиргааны актыг бичгээр баталгаажуулж болно. (Ч.Э)

ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧ (*Administrator*) Төрийн захиргааны байгууллагад ажиллаж, төрийн бодлого боловсруулах, бодлого, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг зохицуулах, хянах үүрэг, эрх мэдэлтэй захиргааны албан тушаалтан. Захиргааны албан хаагч нь хувийн эрх ашгийг тэвчин, ажилдаа хариуцлагатай, бусдад шударга, нээлттэй хандаж, манлайлал, үлгэр дуурайл үзүүлэх ёстой. Дэлхийн улс орнуудад төрийн захиргааны албанд ажиллаж байгаа захиргааны албан хаагчийн эрх, үүрэг, статус өөр өөр байдаг. Тухайлбал, Их Британид зөвхөн хааны албанд ажилладаг хүмүүс зэрэг дэв ахих боломжтой түшмэлийн тоонд ордог бөгөөд төрийн доод түвшинд ажиллаж байгаа албан хаагчид үүнд багтдаггүй. АНУ-д улсын болон орон нутгийн түвшинд ажиллаж байгаа бүх хүнийг хамруулж ойлгодог бол Францад улсын өмчит зарим нэг үйлдвэрийн газрын албан хаагчид багтана. (Ж.Ж)

ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА (*Administrative organization*) “Organization” гэх үг нь XV зууны эхээр “organisacioun” буюу “их биеийн бүтэц, түүний хэсгүүдийн бүтэц”, XV зууны дунд үеэс “зохион байгуулах үйл ажиллагаа” гэсэн утгаар хэрэглэгдэж байв. Латин хэлнээ “organum” буюу “хэрэгсэл, эрхтэн” утгыг мөн илэрхийлдэг.¹⁵ Үгийн ерөнхий утгаар буюу “хүмүүсийн нэгдсэн зохион байгуулалт” гэх утгаар 1829 оноос хэрэглэж эхэлжээ. Байгууллага нь тодорхой зорилго, зорилтод хүрэхийн тулд хөдөлмөрийн болон чиг үүргийн хуваарь, эрх мэдэл, хариуцлагын шатлалыг тогтоох замаар тодорхой тооны хүмүүсийн үйл ажиллагааг ухамсартайгаар уялдуулсан зохицуулалт¹⁶ юм. Төрийн захиргааны бюрократ байгууллагын талаар судалгаа хийсэн анхны эрдэмтэн бол Германы социологич Макс Вебер юм. Тэрбээр захиргааны байгууллагыг шаталсан байдлаар зохион байгуулагдах, байгууллага бүр өөр өөрийн бүрэн эрхийн хүрээтэй байх, албан хаагчдыг мэргэшлийн чадварт үндэслэн томилдог, албан хаагчид нь ангилал, зэрэг дэвэндээ тохирсон цалин авах, сахилга батыг сахиж хяналтан дор ажиллах гэсэн шинжээр тодорхойлсон байдаг. Ийм захиргааны байгууллага нь төрийн зорилт, чиг үүргийг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлдэг. Тухайлбал, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид захиргааны байгууллагыг “нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг”¹⁷ хэлнэ гэжээ. Захиргааны байгууллага нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх болон хууль тогтоомжийг

15 Organization (n.). (n.d.). Retrieved from <https://www.etymonline.com/word/organization>

16 А.Цанжид, 2009, Төрийн захиргаа, х. 289.

17 Захиргааны ерөнхий хууль

биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг. Төрийн захиргааны байгууллага нь төрийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг хэрэгжүүлдэг тул эрх мэдэл хуваарилах онолын дагуу төрийн эрх мэдлийн хууль тогтоох (парламент) – гүйцэтгэх (засгийн газар) – шүүх эрх мэдлийн гэсэн гурван хүрээнээс гүйцэтгэх эрх мэдэлд шууд хамаарах бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг агуулна. Захиргааны байгууллага нь гүйцэтгэх эрх мэдэл, түүнтэй уялдсан чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллагууд (Т.Т)

ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГААС ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД УЧРУУЛСАН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ (*Settling damage caused to citizens and legal entities by the administrative organ [body]*) Захиргааны байгууллага өөрийн хууль ёсны ажиллагаагаар, эсхүл хууль бус үйлдэл, эс үйлдэхүйгээр иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулж болно. Аль аль тохиолдолд захиргааны байгууллага иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулах үүрэг хүлээнэ. Хэрэв захиргааны байгууллагын хууль ёсны үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөний улмаас хохирол учирсан бол төрөөс нөхөх олговор олгож хохирлыг барагдуулна. Нөхөх олговрын хэмжээг иргэн, хуулийн этгээдтэй харилцан тохиролцож болно. Харин нөхөн олговрын хэмжээний талаар маргаан гарвал захиргааны журмаар хамтагтан нэхэмжлээгүй бол иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүднэ (ЗЕХ-ийн 104.1, 104.3, 104.4). Захиргааны байгууллагын нийтийн эрх зүйн харилцаанаас үүссэн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйгээс өөрт

учирсан хохирлыг арилгуулахаар иргэн, хуулийн этгээд шаардах эрхтэй. Захиргааны ерөнхий хуулийн 101.1, Иргэний хуулийн 498.2-т заасны дагуу захиргааны байгууллагын гаргасан алдааны улмаас учруулсан хохирлыг төр хариуцна. Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ. Гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж, хэрэв ийм нэгж байхгүй төрийн аудитын байгууллага тус тус хариуцна (ЗЕХ-ийн 103.1-103.3). (Ч.Э)

ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛӨХ (*Representation of administrative body*) Захиргааны байгууллагыг төлөөлөх, төлөөлж болохгүй харилцааг Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлд тухайлан зохицуулсан билээ. Захиргааны байгууллага эрх хэмжээгээ төлөөлүүлэх эрхтэй бөгөөд түүнийг хуулиар бүрэн эрх олгогдсон удирдах албан тушаалтан хуульд заасны дагуу итгэмжлэлгүйгээр, эсхүл хуулиар эрх олгогдсон удирдах албан тушаалтны шийдвэрээр итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлнө. Хамтын удирдлагатай захиргааны байгууллагын шийдвэрийг нэг гишүүн дангаар, цөөнхөөр, эсхүл эрх олгогдоогүй этгээд гаргахгүй гэсэн уг хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг нь нэгдүгээрт хамтын удирдлагын зарчмаар үйл ажиллагаа явуулдаг захиргааны байгууллагын шийдвэрийг олонхын саналаар баталгаажуулах, ийм байгууллагын шийдвэрийг хэн нэгэн дарга дангаар гаргахгүй байх, хоёрдугаарт, эрх

хэмжээ олгогдоогүй этгээд гаргахгүй байх гэсэн хоёр зарчмыг давхар агуулж байна¹⁸. Эрх хэмжээгээ төлөөлүүлсэн захиргааны байгууллага хэдийд ч төлөөллийг цуцлах эрхтэй (ЗЕХ-ийн 6.3). (Ч.Э)

ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ *(Administrative organization's structure)*

Захиргааны байгууллага зорилгодоо хүрэхийн тулд тодорхой үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлж байгааг харуулсан тогтолцооны зохион байгуулалтын бүтэц. Байгууллагын бүтцийн нэг төрөл нь захиргааны бүтэц бөгөөд үүнийг бюрократ зохион байгуулалтын бүтэц гэнэ. Захиргааны бүтцийн дээд хэсэгт бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны журмыг тодорхойлсон шийдвэр гаргах үүрэг бүхий хэд хэдэн удирдлага, нэгж байх ба эдгээр нь сонгогдсон эсвэл томилогдсон удирдлагад тайлагнана. Дараагийн түвшин дээд түвшний удирдлагын тодорхойлсон зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулдаг дунд түвшний менежерүүдээс бүрддэг бол доод түвшний албан тушаалтнууд үүрэг даалгаврыг биелүүлэхийн тулд хамгийн их ачааллыг үүрдэг техникийн туслалцаа ажилтнууд байдаг. Захиргааны байгууллагын бүтэц нь харилцан адилгүй зохицуулагдсан тохиолдлууд байдаг ч ихэнхдээ хяналт, зохицуулалтын үүргийг гүйцэтгэж хүний нөөцийн мэргэшсэн байдалд үндэслэнэ. (Г.Б)

ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЯЛДАА *(Coherence of the administrative organizations)*

Засгийн газрын бодлого, хөтөлбөр, чиг үүргийг хэрэгжүүлэгч бүх шатны төрийн байгууллага, агентлагуудын үйл

ажиллагааны системчилсэн эсвэл чиг үүргийн холбоо харилцаа оновчтой зохицуулалт, түүний хэрэгжилтийн үр дүн юм. Засгийн газрын стратеги, тэргүүлэх чиглэл, сайдын үйл ажиллагааны хүрээ, хязгаарыг тогтоох, сайд нарын харилцан санал зөрөлдөөнөөс зайлсхийж, тохиролцоог эрэлхийлэх, зөвлөлдөх, мэдээлэл солилцсоны үндсэн дээр бие даасан шийдвэр гаргах бүхий л үйл явц нь захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангахад чиглэдэг. Ингэж ажиллах нь системийн тогтвортой, оновчтой байдал, уялдаа холбоог илтгэж, үр дүнд нь нийгэмд тодорхой, хэмжигдэхүйц, эерэг үр дүнг бий болгосон байдлаар илэрхийлэгдэнэ. (Г.Б)

ЗАХИРГААНЫ ДҮРЭМ *(Administrative rule)*

Дүрэм (rule) нь Францын “règle” (1200 он) гэсэн үгнээс гаралтай. Хожим Латин хэлний “regula” буюу “шулуун, шугам, загвар модель, заавар”¹⁹ гэсэн утгыг илэрхийлэх болжээ. Энэ үгийн утга нь 1690 оноос аливаа зүйлийг удирдах, зохицуулах “тоглоомын дүрэм” гэсэн утгаар хэрэглэгдэх болсон. Дүрэм нь тодорхой байгууллагын үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй эрх зүйн хэм хэмжээний баримтын нэг хэлбэр, ямар нэгэн хэм хэмжээг тогтоосон заавар, журамласан зүйл юм. Захиргааны дүрэм журам нь дур зоргоор авирлах боломжийг багасгах, байгууллагын цэгцтэй, үр ашгтай үйл ажиллагааг дэмжих, хариуцан тайлагнах тогтолцооны үндсийг тавихын зэрэгцээ, шийдвэрийн талаар маргаан гарсан тохиолдолд байгууллагын байр суурийг хамгаалахад чиглэгдсэн байдаг.²⁰ (Т.Т)

18 Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар (судалгаа, хэрэглээний), Улаанбаатар, 2017, х. 85.

19 <https://www.etymonline.com/search?q=rule>

20 Шнаво & Сундарам (2000), Өрсөлдөөнт гэрлэн дэх төрийн захиргаа.

ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬ (*Basic Law on Administration*)

Монгол Улсад захиргааны үйл ажиллагааг тухайлсан хуулиар зохицуулах тулгамдсан хэрэгцээ, шаардлагыг үндэслэн 2015 онд захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлэх зорилго бүхий Захиргааны ерөнхий хуулийг баталсан. Уг хууль нь захиргааны байгууллагын үйл ажиллагааг эрх зүйн тодорхой зохицуулалттай болгон мөн иргэний /хүний/ эрх зүйн байдлыг тодорхойлсон билээ. Захиргааны үйл ажиллагааг зохицуулсан суурь хуультай болсноор захиргааны үйл ажиллагаа нийтлэг нэг зохицуулалтад орж, гомдлыг урьдчилан шийдвэрлэх захиргааны байгууллага болон захиргааны хэргийн шүүх эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд баримтлах эрх зүйн үндэслэл буй болж, захиргааны байгууллагын нийтлэг ерөнхий үйл ажиллагааг стандартчилан зохицуулах, хүний эрх, эрх чөлөө, хууль, ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх боломж бүрдсэн. Энэ хуулийн ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд: а) захиргааны ерөнхий хуулиар захиргааны байгууллагаас иргэдтэй харилцах суурь харилцаа нэгдсэн стандарттай болсон, б) иргэн, хуулийн этгээдийн хувьд захиргааны байгууллагын эрх мэдлийн хүрээнд эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах бололцоо бүрдсэн, в) захиргааны байгууллага шийдвэр гаргах явцад иргэдийн оролцох боломж нээгдсэнээр хүнд суртал,

авлигыг багасгах ач холбогдолтой.²¹ (Ч.Э)

ЗАХИРГААНЫ ЁС ЗҮЙ (*Administrative ethics*) Захиргааны үйл ажиллагааны шинж чанарыг тодорхойлдог албан ёсоор тогтоосон хэм хэмжээний цогц юм. Ихэвчлэн тусгай хууль дүрмээр тодорхойлогдоно. Захиргааны ёс зүйн талаар сонирхон судалдаг зарим эрдэмтэд захиргааны ёс зүй нь авлига, хээл хахуулийг арилгах хэм хэмжээ гэж тодорхойлсон бол, зарим нь авлига, хээл хахуулийг арилгах хэм хэмжээ төдийгүй хүний эрхэмлэх чанар, үнэт зүйлийг бүтээх үйл ажиллагааг цогц байдлаар авч үзнэ гэж тодорхойлжээ. Бусад нь захиргааны үйл ажиллагааг эрхлэхэд зайлшгүй дагаж мөрдөх ёстой үнэт зүйлийн хэм хэмжээ бөгөөд түүний хэргжилтийг хүртэл хамруулан ойлгоно гэжээ. Захиргааны ёс зүйд захиргааны бүхий л үүргийг зөв, шударга хэрэгжүүлэхэд чиглэсэн норматив үнэт зүйлийн хэм хэмжээ орно. Норматив үнэт зүйлийн хэм хэмжээ ойлголт нь захиргаа заавал мөрдөх ёстой болон хориглох зүйлийг багтааж байгааг илэрхийлнэ. Гэхдээ норматив утгын хэм хэмжээ нь үнэмлэхүй биш юм. Энэ нь цаг үе, нөхцөл байдлын өөрчлөлтөөс хамааран өөр байж болох бөгөөд улс орон бүр үндэсний үзэл, үзэл суртал, иргэдийн үнэт зүйл, захиргааны соёл зэргээс шалтгаалан өвөрмөц захиргааны ёс зүйтэй байдаг. Энэ нь захиргааны ёс зүйн онцлог юм. Үүний зэрэгцээ захиргааны ёс зүй нь цаг үеэс үл хамаарах түгээмэл шинж чанартай байдаг. (Ц.Д)

ЗАХИРГААНЫ ЗАН ҮЙЛ (*Administrative behavior*) Захиргааны дотоод үйл ажиллагаа хэрхэн явагддагийг илэрхийлдэг ойлголт юм. Захиргааны

21 Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар (судалгаа, хэрэглээний), Улаанбаатар, 2017, х. 29.

хийдэг үндсэн ажил бол шийдвэр гаргах. Иймээс захиргааны зан үйлийг судлах нь шийдвэр гаргах үйл явц, түүнд нөлөөлдөг хүчин зүйлсийг тодорхойлоход чиглэнэ. Ийм судалгааны сонгодог жишээ бол Херберт Саймон (Herbert A. Simon)-ы 1947 онд хэвлүүлсэн “Захиргааны зан үйл: захиргааны байгууллагад шийдвэр гаргах үйл явцын судалгаа”²² хэмээх бүтээл юм. Саймон: энэ бүтээл нь байгууллагын анатоми физиологийн тухай авч үзэж байгаа болохоос биш, захиргааны өвчнийг эмчлэх тухай биш хэмээсэн нь захиргааны зан үйл хэмээх ойлголтын хүрээг тодорхойлсон. Захиргаанд шийдвэр гаргах үйл явц, түүний сонголтод нөлөөлдөг логик болон сэтгэл зүйн хүчин зүйлс, зарчмууд, оновчтой шийдвэр гаргахад саад болдог зүйлс, ажилтнууд болон удирдлагын үүрэг, нөлөө зэрэг олон зүйл захиргааны зан үйлийг бүрэлдүүлж байдаг гэжээ. (Ц,Д)

ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ (*Administrative cost*) Аливаа байгууллагын үндсэн үйл ажиллагаа, үйлчилгээ, борлуулалтаас бусад буюу байгууллагын ерөнхий удирдлага, нийтлэг үйлчилгээнд хамаарах зардлыг захиргааны зардал гэсэн ангилалд хамруулна. Тухайлбал: удирдлагын цалин хөлс болон нийтлэг үйлчилгээнд хамаарах нягтлан бодох бүртгэл, мэдээллийн технологийн зардлыг захиргааны зардал гэсэн ангилалд оруулж нягтлан бодох бүртгэлд тусгадаг. Байгууллагын ба аливаа эдийн засгийн системийн нийт зардалд эзлэх захиргааны зардлын хувь хэмжээгээр удирдлага, зохицуулалтын ажлын үр дүнг үнэлдэг. Бүтэц зохион байгуулалтыг оновчлох, мэдээллийн технологийн шийдлийг нэвтрүүлэх

замаар захиргааны зардлыг бууруулж үйл ажиллагааны нийт үр ашгийг дээшлүүлнэ. (Б,Б)

ЗАХИРГААНЫ ЗӨВЛӨЛ (*Board of Directors*) Захиргааны зөвлөлийг бас удирдах буюу захирлуудын зөвлөл гэж нэрлэнэ. Захиргааны зөвлөл нь байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, зорилгыг хангах стратегийн чиг үүрэгтэй байж тухайн байгууллагын удирдах албан тушаалтнуудаас гадна захиргаа аж ахуйн төлөөлөл, нягтлан бодогч зэрэг ажилтнаас бүрдэж болно. Захиргааны зөвлөлөөр хэлэлцэх асуудлыг зөвлөлийн гишүүд санаачлан ажилладаг. Байгууллагын хэмжээнд шийдвэрлэх асуудлыг эрэмбэ, шатлалын дагуу мөн шуурхай нөхцөлийн хэрэгцээ шаардлага зэргийг хэлэлцэн шийдвэрлэнэ. Захиргааны зөвлөл хэлэлцэн асуудлаар тэмдэглэл хөтөлнө. Гаргасан шийдвэрийн гүйцэтгэлд зөвлөлийн дарга хяналт тавин ажиллана. Захиргааны зөвлөлийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг ихэвчлэн бичгээр ажил үүргийн тодорхойлолтод тусгасан байдаг. Зөвлөлийн гишүүд хөгжлийн зөв арга, гарцыг тодорхойлж, учирч болзошгүй хямрал, гажуудлаас урьдчилан сэргийлэхэд хувь нэмрээ оруулах үүрэгтэй манлайлагчид байдаг. (А,Э,ц)

ЗАХИРГААНЫ ОНОЛ (*Theory of administration*) Захиргааны шинжлэх ухаан бол захиргааны шийдвэр гаргах үйл явцыг судалдаг. Төрийн захиргааны шинжлэх ухааны онол нь XX зууны 60, 70-аад оны үеэс өрнийн орнуудад эрчтэй хөгжиж цоо шинэ онол, үзэл баримтлалууд гаргаж эхэлсэн. Төрийн захиргааны онол, үзэл баримтлалуудын заримаас дурдвал, 1. Шинэ институциональ онол нь эдийн

22 Мөн тэнд

засгийн ухааны сургаал хэлбэрээр хөгжихөд Англо-Америкийн эрдэмтэн “the Nature of the firm” (Пүүсийн мөн чанар) өгүүллийн зохиогч Рональд Коуз томоохон үүрэг гүйцэтгэсэн. Төрийн захиргааны шинжлэх ухаан нь нийгмийн, тэр дундаа улс төрийн шинжлэх ухаанаас салбарлан хөгжсөн харьцангуй залуу шинжлэх ухаан. Төрийн захиргааны шинжлэх ухаан дахь онолын бүрдэл нь өнөөг хүртэл тухайлсан юм, үзэгдлийн тусгаар, саланги шинж чанарт анхаарч ирсэн. Эдүгээ шинжлэх ухааны мэдлэг хөгжиж тэлэн, тусгаар саланги мэдлэгүүд ойртох, нэгдэх үйл явц эрчимжсэнээр төрийн захиргааны шинжлэх ухаанд цогц шинж чанар бүхий үзэл баримтлал түлхүү хөгжих болсны нэг илрэл нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлал билээ. (А.Э.ц)

ЗАХИРГААНЫ ПРОЦЕСС (*Administrative process*) Захиргааны байгууллагын захирамжилсан шийдвэр, үйл ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн эсэх талаар иргэн, хуулийн этгээд болон захиргааны байгууллагын хооронд үүссэн маргааныг дээд шатны захиргааны байгууллага болон зохих шатны захиргааны хэргийн шүүх харьяаллын дагуу хүлээн авч, хянан шийдвэрлэх ажиллагаа. Захиргааны процесс нь захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болон захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа гэсэн хоёр төрлөөс бүрдэнэ. (Ч.Э)

ЗАХИРГААНЫ СИСТЕМ (*Administrative system*) Макро түвшинд улс орон, микро түвшинд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад албан хаагчдын ухамсарлаж дагаж мөрдөх бичиг баримт бүрдүүлэх, бүртгэл хөтлөх, албан бичиг, дотоод,

гадаад харилцаа холбоо, санхүүгийн удирдлага болон бусад захиргааны ажил үүргийн системийг хэлнэ. Улс орон бүр өөрсдийн түүхэн туршлага, соёл, нийгэм, эдийн засаг, улс төрийн орчны өвөрмөц онцлогоос шалтгаалж өөр өөр захиргааны системтэй. Түүнчлэн нэг улсад үр дүнтэй ажиллаж байгаа захиргааны систем, нөгөө улсад амжилтад хүрч чадахгүй байж болох ба энэ нь авторитар засаглалын захиргааны систем, либерал, ардчилсан засаглалын системд тохирдоггүй байдлаар илэрдэг. Мөн захиргааны орчин нөхцөл байдлаас үүдэн өөрчлөгдөж болох ба тухайн нөхцөл байдалд тохируулан захиргааны системд өөрчлөлт оруулах хэрэгтэй болдог. (Г.Б)

ЗАХИРГААНЫ СОЁЛ (*Administrative culture*)²³ Төрийн албан хаагчдын ухамсар, үнэт зүйл, сэтгэлгээний хэв маяг, хандлага болон иргэдийн захиргаанд хандах хандлага, түүнд өгөх үнэлэлт зэргээс бүрдэх сэтгэл зүйн хэвшмэл байдлыг илэрхийлэх ойлголт юм. Мэдээж улс орон бүрийн захиргааны соёл нь өөр өөрийн онцлогтой. Авторитари (authoritarianism) шинж нь захиргааны харилцаанд дээд болон доод түвшний оролцогчдын давамгайлах, дуулгавартай байх харилцан хамааралд тулгуурласан соёл юм. Хамаарагдал холбоог эрхэмлэх үзэл (connectionism) нь нутгархах, цусан төрлийн холбоо, сургуулиараа бүлгэрхэх, явцуурхан бүлгэрхэх зэрэг онцгой харилцааг эрхэмлэн үздэг ба энэ харилцаанд оролцоогүй хүн эсвэл бүлэгт гадуурхагдах хандлага мэдрэгддэг. Патернал (paternalism) шинж нь хүмүүс хоорондын харилцааг ашиг сонирхолд үндэслэсэн гэрээт

23 한호섭 (1999). 행정학 용어 사전. 서울, 행정학용어표준화연구회. 새 정보 미디어.

харилцаа бус, хувь хүмүүс хоорондын дотносолд үндэслэсэн сэтгэл зүйн талын харилцаа юм. Хэлбэрдэлт давамгайлсан (formalism) соёлдаливаа асуудал, үйл ажиллагааны бодит агуулга, үр дүнг бус хууль, журмыг хэлбэр төдий мөрдөхийг илүүд үзэх хандлага юм. Ийм соёл давамгайлвал захиргаа консерватив шинжтэй болж, хөгжилд тэргүүлэх үүргээ гүйцэтгэж чадахгүй болно. Гэр бүлсэг (familism) соёл нь төр, нийгмийг гэр бүлийн нэг хэлбэр гэж ойлгодог. Ийм соёлтой захиргааны байгууллагуудад эв нэгдэл, гишүүдийн эрэмбэ дарааллыг чухалчлан үзэх бөгөөд хувийн болон албаны харилцаа холилдон байх нь түгээмэл юм. Захиргааны хөгжингүй бус соёлтой удирдагчид дангаар захирах үзэл (generalism)-д автдаг гэж үзнэ. Энгийн үгээр хэлбэл ганцаараа бүх зүйлийг хийх боломжтой гэж үзэх итгэл үнэмшилтэй болдог. Тиймээс албан тушаалтнуудыг мэргэжил, чадварыг нь үл харгалзан дураараа байршуулдаг бөгөөд тэдэнд ажил үүрэгт нь шаардагдах хэмжээний эрх мэдлийг олгохдоо хойрог байдаг. Энэ нь албан хаагчид мэргэших боломжийг төдийлэн бүрдүүлдэггүй байна. Рационал соёлтой захиргаанд хэн нэгэнд давуу тал олгох, өрөөсгөл хандлага бүхий бодлогын шийдвэр гарах нь бага байдаг. Амжилтад тэмүүлэх (achievism) соёлтой захиргааны байгууллагад хүний чадварыг үнэлэх, төрийн албанд томилоход тухайн хүний ололт амжилт, мэргэшил, ур чадвар зэрэг объектив хүчин зүйл дээр үндэслэдэг. Харин Реалитив (relativism) соёлд тогтсон үнэлэмж, хэм хэмжээг үхширтэл (dogmatically) баримтлахаас таггалзаж, бодит нөхцөл байдлыг харгалзан шалтгаан үрийн холбоог тодорхойлсны үндсэн дээр шийдвэр гаргана. Тиймээс хөгжингүй захиргааны соёлтой орнуудын

захиргаа нийгмийн өөрчлөлтөд сайн дасан зохицож, хариу үйлдэл үзүүлэх төдийгүй бодлогын сайн шийдлийг боловсруулах хандлагатай. Тиймээс хөгжингүй захиргааны соёлтой захиргаа нь илүү сайн зүйл хийхийг оролдох, алдаа эрсдэл гаргахаас үл эмээж, амжилтад тэмүүлэх хандлага (achievitism)-тай байдаг. (Ц.Д)

ЗАХИРГААНЫ СУУРЬ БҮТЭЦ (*Basic public administration structures*)

Төрийн захиргааны институцийн ерөнхий бүтэц. Төрийн захиргааны байгууллагын бүтцийн тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг Монгол Улсын Их Хурлаас тогтоол гарган 2016 онд баталж хэрэгцээ, шаардлагын дагуу тухай бүрд нь нэмэлт өөрчлөлт оруулдаг бол сүүлийн нэмэлт өөрчлөлт 2020 оны 5 сард оржээ. Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэнэ. Захиргааны байгууллага нь үндсэн шинж, үүрэг, ангилалтай байна. Захиргааны байгууллагад төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага, хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг захиргааны үйл ажиллагаанд шийдвэр чухал үүрэгтэй байдаг. Шийдвэр ойлголтод нийгмийн хэрэгцээ сонирхол, үнэлэмж, түүнийг хангах асуудал чухал байдаг. (А.Э.ц)

ЗАХИРГААНЫ ТӨВЛӨРЛИЙГ САА-РУУЛАХ (*Administrative decentralization*) “Decentralization” гэдэг үгийг анх 1835 онд Германд, дараа нь Франц, Англи хэлнээ ашиглах болжээ. “Decentralize” гэсэн үйл үг нь “төвөөс холдох, хуваарилах, тараах” (distribute or take away from a center) гэсэн утгыг илэрхийлдэг. Энэ үгийг улс төрийн шинжлэх ухаанд төв засгийн газрын

эрх мэдэл, хяналтыг доод буюу орон нутгийн түвшинд шилжүүлэх үйл явцтай холбон тайлбарладаг. Захиргааны төвлөрөл хэр зэрэг саарсан байх нь тухайн улсын улс төрийн тогтолцоотой нягт уялдаатай. Улс төрийн төвлөрлийг сааруулах нь шийдвэр гаргах эрх мэдлийг засгийн газрын доод түвшинд шилжүүлэх, иргэд, тэдгээрийн сонгууль төлөөлөгчдийг шийдвэр гаргах үйл явцад оролцуулах явдлыг нэмэгдүүлэх үйл явц болдог. Төвлөрөл бүрэн саарсан тогтолцоонд засгийн газрын доод түвшний байгууллагууд дээд түвшний оролцоогүйгээр бие дааж бодлого боловсруулах, хэрэгжүүлэх эрх мэдэлтэй байдаг. Захиргааны төвлөрлийг сааруулах ажиллагаанд гол төлөв байгууллагын гүйцэтгэх үүргийг боловсруулах, тэдгээр үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай захиргааны ажлуудыг тодорхойлох, уг ажлыг хийж гүйцэтгэх этгээдийг хуваарилалт орно. (Т.Т)

ЗАХИРГААНЫ ҮЗЭЛ САНАА (*Administrative concept*) Захиргааны зүгээс баримталдаг хамгийн дээд үнэт зүйл, үйл ажиллагааны үндсэн зарчмын тухай үзэл баримтлал юм. Захиргааны үндсэн үзэл санаа нь захиргааны сэтгэлгээнд давамгайлж байдаг тул захиргааны ёс зүйд хамаарах бөгөөд захиргааны философийн асуудал юм. Захиргааны үзэл баримтлал нь цаг үе, улс орнуудын онцлогоос хамааран харилцан адилгүй байх боловч хууль ёсны байдал, үр ашиг, ардчилал, үр нөлөө, төвийг сахисан байдал, эрх тэгш байдал зэрэг нь ардчилсан захиргааны нийтлэг шинж байдаг. Эдгээрийн дотроос "үр ашиг" ба "ардчилал"-ын аль нь тэргүүлэх чиглэл болох нь цаг үе, улс орнуудаас хамаарч ялгаатай байдаг. Заримдаа үр ашгийг, зарим үед ардчиллыг илүү

чухалчлах тохиолдол байдаг боловч захиргааны үйл ажиллагаа нь эдгээр үзүүлэлтийг ямар нэг хэмжээгээр хангаж байх ёстой. (Ц.Д)

ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА (*Administrative activity*) Захиргааг чиг үүргийнхээ хувьд гүйцэтгэн захирамжлах үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагын тогтолцоо гэж тодорхойлдог. Иймд захиргааны үйл ажиллагаа гэдэгт төрийн гүйцэтгэх эрх мэдлийн бүх шатны байгууллага болон Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд захиргааны байгууллага гэж тодорхойлогдсон бусад байгууллагаас хэрэгжүүлдэг захирамжлах үйл ажиллагааг ойлгоно. (Ч.Э)

ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛБЭР (*Forms of administrative activity*) Захиргаа хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ, иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны олон хэлбэрийг буюу арга хэрэгслийг ашигладаг. Захиргааны ерөнхий хуульд захиргааны үйл ажиллагааны нийтийн эрх зүйн хүрээнд, гадагшаа чиглэсэн төрөлд хамаарах хамгийн нийтлэг хэрэглэгддэг захиргааны акт, захиргааны гэрээ, захиргааны хэм хэмжээний актыг захиргааны үйл ажиллагааны хэлбэрт хамаарахаар хуульчилсан. *Захиргааны акт* гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно. Захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж, эсхүл дуусгавар болгохоор *захиргааны гэрээг* эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн байгуулж болно.

Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно. Нөгөөтгээгүүр, захиргааны үйл ажиллагааг зохицуулсан олон тооны салбарын хууль манай улсын хувьд үйлчилдэг бөгөөд тэдгээрт захиргааны үйл ажиллагааны хэлбэрийг өөрөөр зохицуулсан тохиолдолд тухайн тусгайлан хуульчилсан үйл ажиллагааны хэлбэрийг захиргаа ашиглах боломжийг хуулиар олгосон байна. Хуульд өөрөөр заагаагүй, эсхүл хуульд заасан хэлбэрээс хэрэглэхэд тохиромжгүй, эдгээр үйл ажиллагааны хэлбэрийн шинжийг агуулаагүйгээс сонгож хэрэглэх боломжгүй тохиолдолд захиргааны байгууллага хэрэгцээ шаардлагадаа тохируулан захиргааны үйл ажиллагааны өөр бусад хэлбэрийг өөрөө тогтоохыг хуулиар зөвшөөрчээ. (Ч.Э)

ЗАХИРГААНЫ ҮНЭТ ЗҮЙЛ (*Administrative value*) Захиргааны хамгийн дээд үнэт зүйл бол итгэл үнэмшилд суурилсан хүсэн хүлээж буй ирээдүй рүү чиглэсэн, захиргааны философи, захиргааг чиглүүлэгч чиг шугамыг хэлнэ²⁴. Захиргааны үнэт зүйл бол захиргааны хөгжлийн шалгуур болох “захиргаа ямар байх ёстой” эсвэл зөв захиргаа гэж “юу болох” талаар чиглэл, удирдамж өгдөг өргөн цар хүрээтэй ойлголт юм. Захиргааны үнэт зүйлийг зарим судлаачид захиргааны үзэл суртал гэж нэрлэн дотоод үнэт зүйл (intrinsic value), арга хэрэгслийн шинжтэй үнэт зүйл (instrumental value) гэж ангилдаг²⁵. Дотоод үнэт зүйлийг захиргааны

үйл ажиллагаагаар бий болох эерэг үр дүн гэж ойлгоно. Үүнд: олон нийтийн ашиг сонирхол, шударга ёс, тэгш байдал, эрх чөлөө зэрэг багтана. Эдгээр үнэт зүйлсийг захиргааны шинэ онол (New public administration)-д онцлон үздэг байна. Арга хэрэгслийн шинжтэй үнэт зүйлс нь дотоод үнэт зүйлсийг бий болгоход баримталдаг хэм хэмжээ, стандарт. Түүнд захиргааны үзэл суртал болох үр ашиг, үр нөлөө, хууль ёсны байдал, оновчтой байдал, ардчилал гэх мэт олон зүйл багтана. (Ц.Д)

ЗАХИРГААНЫ ҮҮСЭЛ (*Origins of public administration*) Хүмүүс хамтарч аж төрж эхэлсэн үеэс л хамтын үйл ажиллагааныхаа зорилгыг тодорхойлох, ан агнах, дайснаас өөрсдийгөө хамгаалах, нүүдэллэн шилжих гэх мэт олон асуудлыг шийдвэрлэж иржээ. Тийм учраас олон түмний захиргаа нь нэн эрт үед үүсжээ. Хожим ус ашиглах, гал түймрийн аюулаас хамгаалах гэх мэт хамтын шийдвэр, үйл ажиллагаа шаардсан олон асуудал үүссэний зэрэгцээ сүм хийд, худалдаачдын гильди гэх мэт хүмүүс сайн дураараа нэгдсэн байгууллагууд, улмаар хот тосгоны зөвлөл зэрэг олон түмний өөрийн удирдлагын шинэ шинэ бүтцүүд буй болсон байна. Эдгээр нь үйл ажиллагаагаа төрийн оролцоогүйгээр бие даан явуулдаг байжээ. Сургууль, сүм хийд, цэцэрлэг, гудамж талбай зэрэг өөрийн удирдлагын өмч буй болсон нь олон түмний захиргааны хөгжилд шинэ үеийг буй болгожээ. Тийм ч учраас Европын орнуудад олон түмний захиргаа нь төрийн захиргаанаас өмнө үүсэн хөгжсөн байна. Дэлхийн бусад бүс нутагт ч хамтын амьдралаа зохион байгуулах олон түмний өөрийн удирдлагын шинжтэй институтүүд буй болсон. Үндэсний төр улс буй болсон үеэс

24 M.E. Dimock, A Philosophy of Administration, 1958.

25 R.L.Ackoff, et al. A Prologue to National Development, 1981, p. 81.

эхлэн татвар, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийг хамгаалах, хүн амд боловсрол олгох, аюулаас хамгаалах гэх мэтээр нийтийн шинжтэй асуудлуудын хүрээ өргөжихийн хэрээр төр эдгээрийг гартаа авч, улмаар төрийн захиргаа үүсэн буй болжээ. (А.Ц)

ЗАХИРГААНЫ ФИЛОСОФИ (*Administrative philosophy*)²⁶ Захиргааны тэмүүлж, хэрэгжүүлэхийг зорьж буй дээд үнэт зүйлс, төрийн албан хаагчдын мөрдлөг болгосон үйл ажиллагааны хэм хэмжээ, үнэт зүйлсийг судалдаг философийн чиглэл юм. Ялангуяа захиргааны философийн судалгаа нь захиргааны актад шингэсэн төрийн албан хаагчдын итгэл үнэмшил, үзэл бодолсэтгэлгээ, үнэт зүйлсийг анхаардаг. Үүгээрээ захиргааны философи нь захиргааны шинжлэх ухаанаас ялгаатай. Захиргааны шинжлэх ухаан нь захиргааны бодит үзэгдлийг шинжлэх ухааны үүднээс судлахыг эрмэлздэг бол, захиргааны философи нь үнэт зүйлс, хүсэл тэмүүлэл зэрэг ухамсар, оюун санааны үзэгдэлд тулгуурлан захиргааг судлах зорилготой тул захиргааны философи, захиргааны шинжлэх ухаан ялгаатай боловч хоорондоо нягт уялдаатай. Захиргааны шинжлэх ухаанаас эхлэлтэй захиргааны философи нь захиргааны бодит үзэгдлээс хол хөндий мэт боловч захиргааны философигүйгээр захиргааны шинжлэх ухаан нь үйл ажиллагааныхаа мөн чанар, төлөв байдлыг ойлгох боломжгүй учир нь нийтийн эрх ашигт үйлчлэх чиг зорилгоосоо гажих аюул тохиолдож болно. Захиргааны философийг судалсан А.Саймон захиргааны гол үйлдэл нь шийдвэр гаргах явдал

бөгөөд шийдвэр гаргах нь янз бүрийн хувилбаруудын дотроос сонголт хийх үйлдэл тул шийдвэр бүр нь ёс зүй, үнэт зүйлсийн агуулгатай байдаг гэжээ. АНУ-ын эрдэмтэд Беллон (С.І. Bellone), Ходжинсон (С. Hodgkinson) нарын дөвшүүлсэн үнэт зүйл, ёс зүйт удирдлагыг онцолсон захиргааны шинэ онол (new public administration) захиргааны гүн ухаанд тулгуурлан 1960-аад оны сүүлч, 1970-аад оны үеэс дэлгэрч эхэлсэн юм. (Ц.Д)

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ (*Normative administrative act [regulation]*)

Захиргааны ерөнхий хуулийн 59.1 дүгээр зүйлд: захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг хэлнэ (ЗЕХ-ийн 59.1). Захиргааны хэм хэмжээний акт нь тухайн харилцаанд оролцогчдод чиглэсэн нийтлэг зохицуулалт агуулсан, шалгуур, үйл ажиллагааны шат дараалал, цаг хугацаа тогтоосон байдаг тул ирээдүйд үүсэх ижил тохиолдолд дахин давтагдан хэрэглэгдэх зэрэг шинжүүдээрээ хуультай адилтгаж болох боловч гагцхүү хуулиар тусгайлан заагдсан нөхцөлд гарах боломжтой шинжээрээ эрэмбийн хувьд хуулиас доогуур байна. Захиргааны хэм хэмжээний акт нь ихэвчлэн дүрэм, журам, зааварчилгаа, загвар, маягт, аргачлал, төлөвлөгөө зэрэг олон нэршилтэй. (Ч.Э)

ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР (*Administrative Decision*)

“Шийдвэр” нь асуудлыг шийдвэрлэх олон хувилбараас хийж буй сонголт бөгөөд шийдвэр гаргах ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн юм. Нэг зэрэг хэрэгжүүлэх боломжгүй олон

²⁶ 한호섭 (1999). 행정학 용어 사전 서울, 행정학용어표준화연구회. 새 정보 미디어.

янзын хувилбараас тухайн асуудалд хамаатай, хүмүүсийн нийтлэг сонирхол үнэлэмжид нийцүүлэн хийсэн сонголтыг захиргааны шийдвэр гэнэ²⁷. Захиргааны шийдвэрийг тодорхой үе шат бүхий үйл явцаар гаргах²⁸ бөгөөд энэхүү үйл явцын үе шат бүрд сонголт хийгдэнэ²⁹. Захиргааны байгууллага нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргана³⁰. Захиргааны шийдвэр нь бодит нөхцөлд тохирсон, хуулийн үндэслэлтэй³¹, хүний эрхэд үндэслэлгүй халдаагүй, оролцоог хангасан³² байх шаардлагатай. Шийдвэр гаргахад ямар арга техник хэрэглэж байгаагаас хамааруулан шийдвэрийг ганцаарчилсан болон хамтын, рационал, инкрементал болон холимог шийдвэр гэх мэт ангилна. (М.А)

ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГАРГАЛТ (*Administrative decision making*)

Энэ нь захиргааны шийдвэр³³-ийг гаргах үйл ажиллагаа юм. Захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаа нь 1) асуудлыг тодорхойлох, 2) хувилбаруудыг үнэлж сонголт хийх, 3) шийдвэрийн төсөл боловсруулах, баталгаажуулах 4) шийдвэрийг хэрэгжүүлэх ба хяналт тавих гэсэн дөрвөн үе шатны дагуу хийгдэнэ³⁴. Захиргааны шийдвэр гаргахад 1) хуульд үндэслэх, 2) хууль ёсны итгэлийг хамгаалах, 3) үр нөлөөтэй

байх, 4) шийдвэр нь үндэслэл бүхий байх, 5) шуурхай тасралтгүй байх, 6) ил тод, нээлттэй байх, 7) урьдчилан мэдэгдэх, оролцоог хангах, 8) ашиг сонирхлын зөрчилтэй захиргааны үйл ажиллагаанаас татгалзан гарах, татгалзан гарах боломжийг хангах зэрэг найман зарчмыг баримтална³⁵. (М.А)

ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГАРГАХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОГЧ (*Participant in administrative decision-making*)

Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны хүрээнд эрх эдэлж, үүрэг хүлээн оролцож байгаа этгээдийг оролцогч гэнэ. Захиргааны акт гаргах, захиргааны гэрээ байгуулахтай холбоотой шийдвэр гаргах ажиллагаанд нэг талаас захиргааны байгууллага, албан тушаалтан, эсхүл түүний өмнөөс захиргааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд, нөгөө талаас захиргааны үйл ажиллагаатай холбоотойгоор хүн, хуулийн этгээд субъект болдог. Захиргаа гадагш чиглэсэн үйл ажиллагаа явуулахдаа иргэдийн оролцоог хангах, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн болон зөрчигдөж болзошгүй тохиолдолд заавал тэднийг оролцуулахаар зохицуулсан байна. Иргэдийн оролцоог хангах захиргааны үүрэг нь хүний эрх, эрх чөлөөг зөрчигдсөний дараа нь бус харин зөрчигдөхөөс өмнө урьдчилан сэргийлэх нөхцөлийг бэхжүүлэхэд чиглэгдэнэ. Захиргааны байгууллагад өргөдөл, хүсэлт гаргасан этгээд, захиргааны акт, захиргааны гэрээний эрх зүйн үйлчлэл шууд болон шууд бусаар чиглэсэн этгээд болон захиргааны байгууллагаас шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулсан этгээд нь захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогч байна.

27 Батсүх Ш., “Захиргааны шинжлэх ухааны ерөнхий онолын зарим асуудал”, 1995.

28 “Захиргааны шийдвэр гаргалт” үгийн тайлбарыг харна уу.

29 Klaus Koenig, Heinrich Siedentopf (Hrsg), “Oeffentliche Verwaltung in Deutschland”, 1997, s. 436.

30 Захиргааны ерөнхий хуулийн 5.1 дэх хэсэг.

31 Klaus Koenig, Heinrich Siedentopf (Hrsg), “Oeffentliche Verwaltung in Deutschland”, 1997, s. 436.

32 Захиргааны ерөнхий хуулийн 4.2 дахь хэсэг.

33 “Захиргааны шийдвэр” үгийн тайлбарыг харна уу.

34 Mueller J. “Oeffentliche Verwaltung in der Bundesrepublik Deutschland.”, 1993.

35 Захиргааны ерөнхий хуулийн 4.2 дахь хэсэг.

Мөн захиргааны шийдвэр гаргах ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээд захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд гуравдагч этгээдээр оролцохын зэрэгцээ захиргааны шийдвэр гаргах ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдийг түүний хүсэлтээр, эсхүл захиргааны байгууллага өөрийн санаачилгаар, оролцогчийн зөвшөөрснөөр шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулна. Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн оролцох тохиолдолд дохио, зангаа, тусгай тэмдэгт ашиглан хэлмэрчийн тусламжтайгаар оролцоно. (Ч.Э)

ЗАХИРГААНЫ ШИНЖЛЭХ УХААН (*Public administration science*)

Төрийн захиргаа, удирдлага, үйл явц, менежмент давшингүй хөгжиж, түүнийгээ дагаад тухайн үзэгдэл, үйл явцыг танин мэдэх, ухан ойлгох болсон онолын суурь судалгаа өргөжсөөр байна. Эртний Грекийн сэтгэгч Аристотелийн сургаалд зарим талаар төрийн удирдлагын бие даасан утга байсан ч XVIII зуун хүртэл нийгмийн үзэгдэл, үйл явцын ойлголт нэгэн бүхэл тогтолцоо хэлбэрээр оршиж байгаад “Төрийн захиргаа”-ны шинжлэх ухааны эхлэл XIX зууны эхний хагаст тавигдсан гэж үздэг бөгөөд Германы эрх зүйн сургууль, 1880 оны Колумбын Их Сургуулийн Улс Төрийн Шинжлэх Ухааны Сургуулиудыг эхлэл нь гэж үздэг. XX зууны 60, 70-аад оны үед өрнөдөд төрийн захиргааны шинжлэх ухаан илүү сонирхолтой болж, шинэ онол, үзэл баримтлалууд хөгжиж эхэлсэн. Энэ хүрээнд шинэ институционал онол, улсын салбарын шинэ удирдлагын үзэл баримтлал, улс төрийн сүлжээ онол, хамжих

засаглалын онол, синергетик онол зэргийг нэрлэж болох юм. Тухайн үед төрийн захиргааны асуудал улс төрийн судалгааны хүрээнд хамрагдаж байв. 1887 онд Вудро Вильсон “Захиргаа судлал” бүтээлдээ: “Захиргааны шинжлэх ухаан нь засгийн газрын үйл ажиллагааг сайжруулах арга хэрэгслийг олж тогтооход голлон анхаарах” болно гэжээ. Улс төрийн удирдлага солигдсон ч захиргааны үйл ажиллагаанд нөлөөлөх ёсгүйг Вильсон онцлоод “төрийн захиргаа нь ‘үндэстний сонгогдсон төлөөлөгчид’ болох улс төрийн хошуучлагчдын гаргасан шийдвэрийг амьдралд хэрэгжүүлэх бүтэц болно” гэдгийг онцолсон. В.Вильсон төрийн захиргаанд бизнесийн байгууллагын удирдлагын арга барилыг нэвтрүүлэх замаар үр ашгийг дээшлүүлнэ гэж үзээд захиргааны үр ашгийн загварыг боловсруулжээ. Харин бюрократ маягийн захиргааг чиг үүргийн чанд хуваарилалт, шатлан захирах зарчимтай мэргэшсэн удирдлагын хэрэгсэл хэмээн ойлгож байв. В.Вильсоны үзэл санааг Ф.Гуднау хөгжүүлэн XIX зууны сүүл, XX зууны эхээр төрийн захиргааны удирдлагын Америк тогтолцооны талаар томоохон судалгаа хийн ардчилсан нийгэмд үр дүнтэй ажиллах бюрократ загвар боловсруулжээ. Хууль тогтоомж боловсруулах чиг үүрэгтэй улс төр, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий захиргаа хоёрын харилцаа засгийн газрын мөн чанарыг илэрхийлнэ гэж В.Вильсон үзсэн байна. Захиргаа, улс төр хоёр харилцан нэг нэгэндээ дэмжлэгтэй ажиллах ёстой юм. Засаглалын үйл ажиллагааны гол чиглэл нь асуудлын гарцыг олж шийдвэр гаргах байдаг бол захиргааны шинжлэх ухаан нь төрийн захиргааны асуудлыг судлахын зэрэгцээ шийдвэр гаргах, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд нийгмийг бүхэлд нь залуурдах явдал юм. (А.Э.ц)

ЗАХИРГААНЫ ШИНЖЛЭХ УХААНЫ ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ (*Origin and development of administrative science*)

Захиргаа буюу хүмүүсийн хамтын үйл ажиллагааг зохицуулдаг удирдлага эртний үеэс үүсэлтэй боловч захиргааг шинжлэх ухааны үүднээс судлах ажил нэгэн зуунаас хэтрэхгүй шахам түүхтэй гэж тооцдог. Анх 1880-аад онд В. Вильсон болон Америкийн бусад эрдэмтэд захиргааг судалж эхэлсэн гэж үздэг. Гэвч Европод түүнээс ч өмнө Камерализм үүсэж, их сургуулиудад эл хичээлийг үздэг байсан болохоор захиргаа судлал байсан гэж үзвэл зохилтой. Түүнчлэн Энэтхэг, Хятад мэтийн улс төр-захиргааны эртний уламжлалтай орнуудын түүхийг харгалзах хэрэгтэй гэж үзвэл захиргаа судлалыг эртний (Эртний Хятад, Энэтхэг, Грек, Ром г.м.), дунд үеийн (1800 –гаад оны 80-аад он хүртэлх), орчин үеийн хэмээн барагцаалан ялгаж болох юм.) Судлаачид публик(ард түмний) захиргааг судлах хэрэгцээг үндэслэх, тэр нь бизнесийн захиргаатай адилхан арга барилтай байж, үр ашгийг онцлон үзэх, түүнийг шинжлэх ухаанд тулгуурлах, захиргаа болон улс төрийг зааг ялгаатай байлгах, хүний хэрэгцээг харгалзах, захиргаа ба ардчиллын үнэлэмж гэх мэт маш олон асуудлыг тойрон хэлэлцэж, судалгаа хийж ирсэн бөгөөд захиргааны шинжлэх ухааны онолын парадигмууд байнга өөрчлөгдөж иржээ. (А.Ц)

ЗАХИРГААНЫ ШИНЭЧЛЭЛ (*Administrative reform*) “Reform” нь XII дугаар зууны эртний Францын “гй-форме”, Латины “reformare” гэсэн үгнээс үндэстэй. Үгийн утга нь Франц хэлнээ “дахин барих, байгуулах, бүтээх (“rebuild, reconstruct”); Латин хэлнээ “дахин хэлбэржүүлэх, өөрчлөх, шилжүүлэх (“to form again,

change, transform, alter) гэсэн утгыг илэрхийлдэг. 1660 оноос reform-г “ямар нэг зүйлийг илүү сайнаар өөрчлөх, эмх цэгцэд оруулах” үйл ажиллагаатай холбон тайлбарладаг болсон. Захиргааны шинэчлэл нь Их Британи, АНУ зэрэг барууны зарим орны төрийн байгууллагууд 1970 оны сүүлээр төсвийн алдагдалд орж, иргэдийн зүгээс төрийн байгууллагад итгэх итгэл буурч ихээхэн шүүмжлэлд өртөх болсонтой холбоотойгоор эхэлсэн байдаг. Английн эрдэмтэн С.Н.Паркинсон 1955 онд “The Economist” сэтгүүлд өгүүлэл бичиж, дараа нь 1958 онд “Паркинсоны хууль” нэртэй ном хэвлүүлсэн нь захиргааны шинэчлэлийг хийх гол хөшүүрэг болсон. Паркинсоны хуулиар “ажлыг хийж дуусахад шаардагдах хугацаа уртсах хэрээр ажил төдий чинээ нэмэгддэг” гэсэн санааг илэрхийлсэн юм. Захиргааны байгууллагын ажлын хэмжээ нэмэгдэхэд, түүний дагаад төрийн албан хаагчдын тоо, зардал өссөн нэмэгддэг гэж үзэн ажилтны тооны нийт өсөлтийг хянаж байдаг хүчин зүйлсийн задлан шинжилгээнд суурилдаг. Мөн “агентын онол (agency theory)”, “менежерализм (managerialism)”, “нийтийн сонголтын онол (public choice theory)”-ын үзэл санаа нь захиргааны шинэчлэлд чухал нөлөөг үзүүлсэн энэхүү шинэчлэл нь 1980-аад оны сүүл, 1990-ээд оны эхээр дэлхий нийтийг хамарсан. Гэхдээ улс орнуудад захиргааг шинэчлэх оролдлого тухайн үеийн нөхцөл байдлаас хамааран улс бүрд ялгаатай байсан ч дараах үндсэн зорилгыг агуулсан байв. Үүнд: захиргааны зардлыг багасгаж, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; хариуцлагын тогтолцоог сайжруулах; хэрэглэгчдийн хэрэгцээ сонирхлоор удирдлага болгох; үйл ажиллагааг бус, үр дүнг санхүүжүүлэх зэрэг болно. Нэгтгэвэл: захиргааны

шинэчлэл нь үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, менежментийг сайжруулахад үзэл баримтлал юм. Төрийн захиргааны шинэчлэлийн явцад улсын салбарын шинэ удирдлага, сайн засаглал, цахим засаглал, иргэдийн оролцоотой засаглал, ард түмний үнэт зүйл гэх мэт шинэ хандлага, альтернатив хувилбар бий болсон нь төрийн захиргааны уламжлалыг бүхэлд нь үгүйсгэх бус захиргааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ. Аливаа шинэчлэл нь цаг хугацааны шалгуурын үр дүнд бий болж буй өөрчлөлтийн илрэл. (Т.Т)

ЗАХИРГААТ ТӨР (*Administrative state*)

Дуайт Валдогийн 1948 онд нийтлүүлсэн нийтийн захиргааны салбарт сонгодог хэмээн тооцогддог бүтээл. Тэрбээр энэ зохиолоо Ялеийн их сургуульд докторын зэрэг хамгаалсан диссертацдаа суурилан бичжээ. Зохиогч: “ардчилсан төр нь мэргэжлийн болон улс төрийн аппараттай байх нь зайлшгүй, шинжлэх ухааны үндэстэй менежмент, үр ашиг зэрэг нь төрийн аппаратын үйл ажиллагааны үндсэн үзэл санаа байх төдийгүй, олон нийтэд үзүүлж буй үйлчилгээ мөн гэсэн санааг илэрхийлсэн байна. Улс төр ба захиргаа гэсэн эсрэгцэл бүхий ялгаа байдаг гэж үзэх нь буруу бөгөөд төрийн албан хаагчид нь зөвхөн хууль хэрэгжүүлэхээр зогсохгүй улс төрийн шинжтэй үүргийг бас гүйцэтгэдэг” гэжээ. Тэд үйл ажиллагааныхаа явцад ардчиллын зарчмуудыг хамгаалж байх үүрэгтэй, төрийн ажлыг зөвхөн үр ашиг, орлого хөөцөлддөг бизнестэй адил явуулж болохгүй хэмээн үзсэн байна. Уалдогийн энэ номыг хэвлэгдсэнээс хойш захиргааны шинжлэх ухааны салбарын суурь бүтээлийн нэг гэж үздэг. Захиргаат төр нь иргэдээс шууд сонгогдоогүй

боловч иргэдээс сонгогдсон төрийн институтийн (Жишээ нь: ерөнхийлөгчийн засаглалтай орны ерөнхийлөгч) бүтэц (Жишээ нь төрийн агентагууд) бүхий төр гэсэн агуулгатай. Гэвч зарим судлаачид, хуульчид төрийн албан хаагчид бодлого гаргахад оролцож, улс төрийн шинжтэй ажил хийдэг бол ийм төртэй байх нь ардчиллын зарчмыг зөрчиж байгаа хэрэг мөн хэмээн шүүмжилдэг. Захиргаа нь дээрээс тавих хяналт, хариуцан тайлагнах тогтолцоотой тул ардчилсан шинжтэй бөгөөд үндсэн хуулийг зөрчөөгүй гэж зарим нь үздэг байна. Амьдралд захиргаат төр оршин тогтнож байгаа нь бодитой зүйл юм. (А.Ц)

ЗОРИЛТОТ БҮЛЭГ (*Target group*)

Төрийн бодлого, төрийн үйлчилгээг үзүүлснээр үр нөлөөг нь шууд хүртэх нийгмийн тодорхой бүлгийг (хувь хүн, өрх, байгууллага гэх мэт) зорилтот бүлэг гэнэ. Төрийн бодлого, үйлчилгээ, үйл ажиллагаа бүр нийгмийн тодорхой зорилтот бүлэгт чиглэгдсэн тул тухайн бодлого, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлснээр зорилтот бүлэгт гарсан өөрчлөлтөөр нь түүний үр дүнг хэмжинэ. Нийгмийн гишүүн бүр, тодруулбал иргэн, өрх, аж ахуйн нэгж, байгууллага бүр өөр өөрийн онцлог бүхий хэрэгцээ шаардлага, тулгамдсан асуудалтай бөгөөд тэднийг ижил төстэй шинжээр нь бүлгүүд болгон хувааж, тэдгээр бүлгүүдийн онцлогт нь нийцүүлэн тодорхой төрийн бодлогыг боловсруулж, үйлчилгээг үзүүлдэг. Энэ нь иргэдээ ялгаварлаж байгаа хэрэг биш харин тэдний тусгай, онцлог хэрэгцээ, шаардлагад нь тохирсон арга хэмжээг хэрэгжүүлж тулгамдаж буй асуудлыг нь шийдвэрлэхийг зорьж буй хэрэг юм. Тухайлбал жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан

санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх бодлого, мэргэжилтэй хирнээ ажил олж чадахгүй байгаа иргэдэд зориулсан хөдөлмөр зуучлалын үйлчилгээ, зургаа хүртэлх насны хүүхдүүдэд зориулсан сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээ, ахмад настнуудад зориулсан халамжийн үйлчилгээ гэх мэт. Ийнхүү зөвхөн тодорхой нэг зорилтот бүлэгт чиглэсэн бодлого, үйлчилгээ байхаас гадна хэд хэдэн зорилтот бүлэгт чиглэсэн эсвэл нийгмийн нийт бүлгийг бүхэлд нь хамарсан бодлого, үйлчилгээ, үйл ажиллагаа бий. (М.А)

ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ **(Organizational structure)**

Байгууллагын зохион байгуулалтын бүтэц нь байгууллагын зорилгод хүрэхэд тодорхой үйл ажиллагааг хэрхэн чиглүүлэхийг тодорхойлсон систем. Эдгээр үйл ажиллагаанд дүрэм, үүрэг, хариуцлагыг багтааж болно. Зохион байгуулалтын бүтэц нь 1) шатлан захирах ёс, менежерүүдийн хяналтын хүрээг хамарсан албан ёсны тайлагнах харилцаа, 2) ажилтнуудыг нэг нэгжид, нэгжүүдийг байгууллагад нэгтгэсэн зохион байгуулалт, 3) бүх ажилтан, нэгжүүдийн хүчин чармайлтыг үр ашигтай уялдуулан холбох, зохицуулах, интеграцчилах систем гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн зохист нэгдэл юм. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн эхний хоёр нь зохион байгуулалтын бүтцийн үндэс буюу шаталсан босоо шугаман харилцаанд, харин гурав дахь нь нэгж, ажилтнуудын харилцан ажиллагаанд тус тус хамаарна³⁶. Байгууллагын дээд удирдлагын зорилт нь ажиллагчдынхаа хүч чармайлтыг үр өгөөжтэй, зүй зохистой хуваарилах, гадаад орчинтой үр ашигтай харилцан үйлчлэх, харилцагч түншүүдийнхээ

хэрэгцээг хангах, зорилго, зорилтуудаа үр ашигтай хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлсэн бүтцийг сонгох юм. Зохион байгуулалтын бүтэц нь байгууллагын түвшин хооронд мэдээлэл хэрхэн дамжихыг тодорхойлдог. Жишээ нь: төвлөрсөн бүтцэд шийдвэрүүд дээрээс доошоо дамждаг бол төвлөрсөн бус бүтцэд шийдвэр гаргах эрх мэдлийг байгууллагын янз бүрийн түвшинд хуваарилдаг. Байгууллага зохион байгуулалтын оновчтой бүтэцтэй байх нь компаниудад үр ашигтай байх, анхаарлаа төвлөрүүлэх боломжийг олгоно. Орчин үеийн удирдахуйн ухаанд байгууллагын зохион байгуулалтын бүтцийн сонголтыг хийхдээ стратегийн төлөвлөгөөнүүдэд суурилан боловсруулах ёстой гэсэн үзэл баримтлал зонхилох болсон. Стратегийн менежмент салбар ухааны судлаач Альфред Чандлер (Alfred Chandler) “Бүтэц нь стратегия дагана” гэсэн зарчмыг анх томьёолсон нь байгууллагын газар, хэлтэс, баг, үйл ажиллагаа, технологи нь байгууллагын стратегийг хэрэгжүүлэхээр загварчлагдана. Бүтэц нь стратегийг удирдах байгууллагын загвар тул стратегийг дагаж мөрдөхгүй бол үр ашиггүй байдал бий болно³⁷. (ДЧ)

ЗОХИОН БАЙГУУЛАХ (Organizing)

Уг үгийн үүсэл гарал нь эртний франц хэлнээ “зохион бүтээх, бий болгох” утгатай. Organizing буюу зохион байгуулах нь POSDCORB (Лютер Гулик, Линдалл Урвик нар, 1937) гэсэн товчлолт “О” үсгээр тэмдэглэгддэг. Гулук, Урвик нарын үзсэнээр зохион байгуулалт нь эрх мэдлийн бүтцийг тодорхойлох замаар ажлын нэгж хэсгүүдийг

36 Менежментийн шинжлэх ухааны нэр томьёоны тайлбар толь, Glossary of Management Science Terminology, Улаанбаатар, 2020, 103 дахь тал.

37 Chandler, Alfred D, Strategy and Structure: Chapters in the History of the Industrial Enterprise, 1962, Cambridge: M.I.T. Press, x. 14, 314.

тогтоож, өөр хооронд нь уялдуулан зохицуулсан үйл ажиллагаа явуулна. Зохион байгуулах нь “хийх зүйлээ тодорхойлох, ажлуудыг хэсэглэн хуваах, тэдгээрийг хийх хүмүүст нь хуваарилах, зохих нөөцөөр хангах, шаардлагатай бүтцийн шинжтэй харилцааг буй болгох” зэрэг үйл ажиллагааг багтаасан ойлголт³⁸. Байгууллага зорилгодоо хүрэхэд эдгээр таван үйл ажиллагааг хооронд нь уялдуулан зохицуулах тухай юм. Зохион байгуулалт нь байгууллагын бүтцэд хүмүүсийг зөв байршуулах, удирдлагын үйл явцыг зохицуулах, хянах гол хэрэгсэл. Зохион байгуулалт нь шатлал болон тогтвортой байдал гэсэн үндсэн хоёр хэмжигдэхүүнээр илэрхийлэгдэх ба шатлал нь байгууллагын хэрэгцээг хангахад чиг үүрэг, чиглэл, уялдаа холбооны дагуу давхаргажуулах бол тогтвортой байдал нь ээдрээтэй, нарийн төвөгтэй боловч эмх цэгцтэй зохион байгуулалтыг илтгэдэг. Тогтвортой зохион байгуулалт нь инновац, дасан зохицох чадвар зэргийг өөртөө агуулдаг онцлогтой. (Г.Б; Т.Т нар)

ЗОХИЦУУЛАЛТ (Coordination) Зохицуулалт гэх үгийн үндэс нь co-ordinate (coordinate) юм. Энэ нь 1660-аад онд "эмх цэгцтэй нэгдэл" утгаар хэрэглэгдэж эхэлсэн байна. Латин хэлнээ "coordinare" буюу "дарааллаар нь тохируулах, цэгцлэх" гэсэн утгыг илэрхийлдэг. 1847 оноос ерөнхий хэрэглээний утгаар "бие биетэй нь харьцангуй зөв байрлалд байрлуулах" хэрэглэх болжээ. Монгол хэлнээ зохицуулалт нь "харилцан эв эийг олуулах, найрамдуулах, хүмүүсийн маргааныг таслан эв эетэй болгох"³⁹ утгаар тайлбарлагддаг. "Зохицуулалт нь зөрчилдөөнийг тогтмол хянах гэсэн

үг (E.Morin,1977)" юм.⁴⁰ POSDCORB (Лютер Гулик, Линдалл Урвик нар, 1937) гэдэг товчлолын "Co-ordinating" буюу "зохицуулах" гэдэг нь ажлын хэсгүүдийн уялдааг илэрхийлсэн. Төрийн захиргааны шинжлэх ухааны хүрээнд зохицуулалт нь төрийн үйл хэрэгт оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг уялдуулж, зорилгод хүрэх нөхцөлийг бүрдүүлэх, уялдуулах үйл ажиллагаа юм. Зохицуулалт нь төрийн бодлогуудын давхардал, зөрчилдөөнийг хамгийн бага байлгах эсвэл түүнээс зайлсхийх, мөн бодлогын нэгж хэсгүүд задарч, хуваагдаж, хоорондоо уялдаа холбоогүй хэт тусгаарлагдахаас сэргийлэх" боломжийг олгоно. (Т.Т)

ЗӨВЛӨЛДӨХ ОРОЛЦОО (Participation

by consultation) Оролцоо нь хүмүүс иргэд санал бодлоо илэрхийлэх, санал өгөх, улс төрийн намд элсэх, нийтийн эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар хамтын шийдвэр гаргахад оролцох замаар нийгэм, улс төрийн үйл явцад оролцох арга хэлбэр⁴¹ юм. Оролцоо нь сайн засаглал, иргэний эрх үүрэг, төрийн хариуцлагатай уялдаж, эмзэг бүлгийнхнийг нийгмийн гадна орхигдуулалгүй эдийн засгийн тэгш өсөлтийг хангадаг бөгөөд төр ба иргэний харилцааг бэхжүүлэх үндэс суурь болж, хариуцлагын тогтолцоог бүрдүүлдэг⁴². Иргэний оролцооны хэв маяг, арга хэрэгсэл нь аливаа иргэдийн эрх ашиг хөндсөн, эсвэл тэдний сайн сайхны төлөө асуудлын

40 Giauque, David. (2003). New Public Management and Organizational Regulation: The Liberal Bureaucracy. International Review of Administrative Sciences - INT REV ADM SCI. 69. 567-592. <https://www.researchgate.net/publication/249688571> New Public Management and Organizational Regulation The Liberal Bureaucracy

41 Collin, P. H. (2004). *Dictionary of Politics and Government, 3rd edition*. London: Bloomsbury Publishing, p. 174.

42 Шафер-Преусс, У. (2012). *Хөгжлийн үр дүнд хүрэхийн төлөө оролцоог бэхжүүлэх нь*. Mandaluyong, Philippines: Азийн Хөгжлийн Банк, х. 4-31.

38 А.Цанжид, 2009, Төрийн захиргаа, х. 162.
39 <https://mongoltoli.mn/dictionary/detail/48207>

талаарх мэдээлэл авах, өгөх, санал асуулга авахаас эхлэн шийдвэр гаргах эрх олгож, иргэд хамтран шийдвэр гаргах хүртэлх олон янз байдаг. Эрдэмтэн Арнштейний (1969) боловсруулсан “Оролцооны шатлал” загварыг эрдэмтэн Претти (1995) хөгжүүлж оролцооны хэв маягийн загварыг боловсруулсан. Тэрээр нийгмийн харилцаанд иргэний оролцооны аргалах оролцоо, идэвхгүй оролцоо, зөвлөлдөх оролцоо, материаллаг урамшууллын оролцоо, функционал оролцоо, интерактив оролцоо, өөрийгөө дайчлах оролцоо гэсэн 7 хэлбэрийг тодорхойлжээ⁴³. Зөвлөлдөх оролцоо нь бодлого боловсруулагчид (шийдвэр гаргагчид) болон олон нийтийн хооронд хос урсгалтай харилцаа бий болгож улмаар тэдгээрийн хоорондын түншлэлийн суурь болдог оролцооны хэлбэр⁴⁴ юм. Зөвлөгөөнд оролцогчид өөрсдийн санал болдоо илэрхийлэх, оролцогч нарын санал бодлыг асуух, саналыг сонсох, уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах бүхий л хэлбэрүүд хамаарна. Зөвлөлдөх төлөвлөгөөг боловсруулахдаа зөвлөгөөний зорилго, оролцогчдын онцлог шаардагдах хугацаа/нөөцийг сайтар харгалзаж үзнэ. (З.А)

ЗӨВЛӨЛТИЙН ЗАХИРГАА (*Administration in Soviet Union*) 1917 оны хувьсгалын дараагаар төрийн том аппараттай байх нь хувьсгалын үйл хэрэгт саад болно гэсэн болгоомжлол байсан боловч эдийн засгийг төлөвлөж хөгжүүлэх, хүн амыг соёл боловсролтой болгож, соёлын хувьсгал хийх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхэд захиргаа зайлшгүй хэрэгтэй болохыг ухамсарлаж Зөвлөлт

маягийн захиргааг буй болгожээ. Коммунист нам ч өөрөө бюрократ ёсыг нэвтрүүлсэн нь эхэн үедээ хувьсгалчдаас гадна хуучин хаант засгийн үеийн мэргэжилтнүүдийг ажиллуулж байжээ. Улмаар салбар хариуцсан, мэргэжлийн аппарат бүхий яамд буюу Ардын комиссарын газрууд, орон нутагт зөвлөлүүд, тэдгээрийн гүйцэтгэх захиргааг байгуулжээ. Төрийн аппаратын бүх салбарт намын хатуу хяналттай байжээ. 1935 онд Төрийн албаны зөвлөлийг байгуулж Сангийн яаманд харьяалуулсан байна. Уг комисс захиргааны бүтцүүдийг тогтоон үйл ажиллагааны реформ хийж, ажилтнуудыг ажилд авах эрхийг түвшин бүрээр албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоож, хэрэггүй албан тушаал, орон тоог үгүй болгожээ. Уг комиссын ажлыг коммунист намын бодлогоор чиглүүлж, Ардын комиссаруудын зөвлөл түүнд шууд хяналт тавьж байжээ. Захиргааны болон техникийн өндөр албан тушаалд томилох асуудлыг Яамд шууд хариуцаж байв. Улмаар Коммунист нам өндөр албан тушаалд ажиллаж байгаа хүмүүс намын гишүүн байх ёстой гэж үзэх болсноор нам, төр холилдох, нам өөрөө захиргаа, удирдлагын элитүүдээс бүрдэхэд түлхэц болсон байна. Төр, захиргааны томоохон албан тушаалтныг бэлтгэх, шилэн сонгох номенклатурын гэж нэрлэгддэг тогтолцоо бүрдэж, коммунист нам гартаа атгах болжээ. Харин төрийн албаны дотоодод зэрэг дэв, цол зэрэг, дүрэмт хувцас зэрэг зарим зүйлээрээ Франц, Германы сонгодог загварыг дагасан ажээ. (А.Ц)

ЗӨВШИЛЦӨЛ (*Consensus*) Зөвшилцөл нь XVII зууны дунд үеэс хэрэглэгдэж ирсэн бөгөөд латин хэлний “consentire” буюу хэлэлцээрт хүрэх, харилцан

43 Jones, S., & et al. (2013). *Framework for Analyzing Participation in Development*. Oslo, Norway: Network Broking/Bjerch Trykker, pp. 10-12.

44 Анар-Эрлэнэ, Л & болон бусад. (2013). *Иргэдийн оролцооны эрх зүйн үнэлгээ*. Улаанбаатар: ‘Арвин сулар’, х. 9.

тохиролцох гэсэн үйл үгнээс гаралтай. Нийгмийн зөвшилцлийн гол үзэл санаа XX зуунд зуунд бий болж, О.Конт, А.Д.Токвиль, Э.Дюркгейм нарын бүтээлүүдэд тусгагдсан. Зарим гол санаануудаас дурдвал: зөвшилцлийн хамгийн найдвартай шалгуур нь хамтын шийдвэр гаргалт бөгөөд түүний нийгмийн үр дагавар, нөлөөлөл; зөвшилцөл хийх тохиолдлууд нь ихэнхдээ аливаа хямралын үед болон нийгмийн шилжилтийн явцад тулгарч, хурцадмал байдлыг намжаах зорилгоор хийж буй оролцогч талуудын үйлдэл бөгөөд зөвшилцлийн мөн чанарыг тодорхойлоход зөвшилцөл, харилцан буулт хийх үйлдлийн ялгааг мэдэх хэрэгтэй.

1) Харилцан буулт хийх нь талууд харилцан найр тавьсны үндсэн дээр бий болсон гэрээ юм. Шийдвэр гаргаж буй засаглагч субъектүүд хоорондоо эрс дайсагнасан харилцаанд хүрээгүй тохиолдол, талуудын сонирхол зарим үед давхцаж, зарим үед зөрчилдөж байгаа тохиолдолд тус тус харилцан буулт хийж болдог. Харилцан буулт хийсний үр дүн нь хэлэлцээрийг хийж буй оролцогч талуудын хоорондын хэлцэл, эрх ашиг, олонхын санал гэх мэт зүйлсээр үргэлжлүүлж болно.

2) Зөвшилцөл нь олонх хүлээн зөвшөөрсний үндсэн дээр шийдвэр гаргах арга юм. Зөвшилцөх явцад хэдийгээр хувийн ашиг сонирхол нь хангагдаагүй ч гэсэн бүх нийтийн эрх ашгийн төлөө гаргасан шийдвэрийг аль нэг тал ганцаар эсэргүүцэхгүй байх нь чухал. Зөвшилцлийн дараа шийдвэр гаргахдаа олонхын саналыг бус хэлэлцэж тохирсон журмыг баримтална. Зөвшилцөл нь талуудын бүхий л ашиг сонирхлыг бүрэн тусгахын тулд хүлээцтэй хандах, сонсох эрмэлзэл, оролцогчдын идэвхтэй оролцоо, ойлголцлын үр дүнд хэрэгждэг онцлогтой. Иймээс

зөвшилцлийн үр дүнд талууд нийтлэг байр суурь, нэгэн ойлголттой болж, дийлэнх олонхын хувьд сэтгэл ханамжтай үр дүн гаргахад чиглэсэн олонх гишүүдийн ойлголцол, тохиролцоо гэж үзэж болно. Гэхдээ зөвшилцлийн эсрэг тал нь зөрүүтэй байр суурьтай хүмүүсийн хоорондын саналын зөрөлдөөнийг илэрхийлэх боловч сөргөлдөөнтэй байх нь ижил үр дүнд хүргэхгүй гэсэн утга биш гэдгийг бас ойлгох хэрэгтэй. Учир нь өөр өөр байр суурьтай байгаа нь зөрчилдөх үндэслэл болдог ч нийтлэг зорилго, хүрэх үр дүн ижил бол түүнийхээ төлөө тэвчих, зөвшөөрөх, санал нэг байх, тохирох, батлах гэсэн үйлдэлд хөтөлдөг болно. Улс үндэстнүүд эв нэгдэл, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлаа хадгалахад “тулгагдаж зөвшөөрөх” байдлаас илүү “ухамсарт ойлголцол”-ын зарчмаар зэрэгцэн оршиход шилжсэн байна. Зөвшилцөл нь ардчилсан нийгэмд гурван үндсэн түвшинд хэрэгжиж, ач холбогдол, үүргээ гүйцэтгэдэг ажээ. Үүнд: 1) улс орны нийтлэг үнэт зүйлс, эрхэм зорилготой байж, энэ нь нийгмийн гишүүдийн суурь итгэл үнэмшил, чиг баримжаа болж бусдын бодлыг хүлээн зөвшөөрдөг, олон ургалч байдлыг дэмждэг ардчилсан засаглалын суурь үндсийг бүрдүүлэх түвшин; 2) “хамтын аж төрөх хэлбэр буюу тоглоомын дүрэм”-ээ зөвшилцөл хэмээн хуулийн засаглалаар баталгаажуулж, олонхоороо хүлээн зөвшөөрөх, хэвшүүлэх хандлагын түвшин; 3) дээд түвшинд хүрсэн нийгэм нь “цөөнхийн эрх ашгийг” тэргүүн ээлжид авч үзэж, төрийн удирдлага, засаглалын тогтолцоонд эрх барьж байгаа хүчин цөөнхөө хүндэтгэж, санаа бодлыг нь сонсох, ойлголцохыг эрхэмлэн ажилладаг. (Я.Т)

ЗҮТГЭЛГҮЙ ҮЙЛДЭХ ЁСОН (*Effortless action*) Эртний Хятадын Даосын сургаалаас гаралтай үзэл юм. Төрийн үйл ажиллагаатай холбогдуулан авч үзвэл аливаа бодлого, үйл ажиллагааг юмс, үзэгдлийн жам ёсны өөрчлөлт, шинж чанарт нийцүүлэн явуулах гэсэн санаа юм. Эдийн засгийг хөгжүүлэх, ашиг орлого олохын тулд байгаль орчинд хайр гамгүй хандаж, түүнийг “хүчирхийлэх” болсон өнөө үед уг сургаал, түүнээс ургуулсан орчин үеийн үзэл санааг харгалзах нь чухал. Оросын алдарт зохиолч Л.Н. Толстой “неделание” хэмээх үзэл санааг гаргасан нь зүтгэлгүй үйлдэх ёстой адил юм. Монгол төрийн зүтгэлтнүүд зүтгэлгүй үйлдэх ёсыг чухал гэж үзэж байжээ. Нэрт Эрдэмтэн Г. Лувсанцэрэн “тэнгэрлэг чанар юугаар илрэх вэ гэвэл, байгаль дэлхийдээ тулгуурлан язгуурын чанарыг түшиглэж, аливааг ёсоор нь байлгахыг эрхэмлэхээр илэрнэ. Энэ бол байгаль ёсыг, угийн зүй тогтлоо баримтлах үзэл юм. Үүнээс дорно дахины нийгмийн сэтгэхүйд зүтгэлгүй төрийн тухай ойлголт нь Монголын төрт ёсны төв голч уг чанар болно” хэмээн бичсэн байна. (А.Ц)

ЗЭМЛЭЛ (*Reprimand*)⁴⁵ Төрийн албан тушаалтныг ажил үүргээ гүйцэтгэх явцад алдаа гаргасан тохиолдолд засаж залруулахад чиглэсэн сахилгын арга хэмжээ юм. Төрийн албанд өдөр тутмын ажлын явцад төрийн албан хаагч алдаа гаргах тохиолдол бий. Алдаа гаргах бүрд хариуцлага тооцох дүрэм журам, зохицуулалт хийж журамлах боломжгүй. Тиймээс зэмлэл нь дээд албан тушаалтнаас зааварлах, алдааг залруулахад менежерийн удирдах хэв маягт багтах зэмлэлээр засах, сэтгэлээр дагуулах гэсэн сэтгэл зүйн болон гүн ухааны

сэтгэлгээнд суурилсан ойлголт юм. (Ц.Д)

ЗЭРЭГ ДЭВ (*Degree/Ranks*) Германы социологич Макс Веберийн “Аж ахуй ба нийгэм” зохиолыг төрийн захиргааны орчин үеийн судалгааны эхлэл гэж үздэг. Түүний боловсруулсан зарчимд, захиргааны байгууллага шаталсан хэлбэрээр зохион байгуулагдах, албан хаагчид зэрэг дэвэнд тохирсон цалин хөлс авах тухай дурдсан байдаг. Төрийн захиргааны язгуурлаг байдал нь Веберийн үзсэнээр: Насан туршийн статус-зэрэг дэв, зэрэг дэвд тохирсон мөнгөн урамшуулал, зэрэг дэвийн шатлалаар хөдлөх карьер юм. Төрийн захиргааны удирдлагад бэлтгэгдсэн, мэргэшсэн хүний нөөцийг сонгон шалгаруулалтаар эсвэл томилон ажиллуулна. Төрийн захиргааны мэргэшсэн албан хаагч нь цэгц шударга, оюуны өндөр чадвартай, орчин үеийн техникийн зохих мэдлэгтэй байх шаардлага тавигддаг. Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлд: төрийн захиргааны албан тушаал нь зэрэг дэвтэй байна. Үүнд: Тэргүүн, эрхэлсэн, ахлах, дэс, туслах түшмэлийн ангилалтай бөгөөд албан тушаалын зэрэг дэвийг дотор нь тэргүүн, дэд, гутгаар, дөтгөөр гэж хуваана. 1994 онд Монгол Улсын Төрийн албаны хууль, 1995 онд Төрийн албаны зөвлөл байгуулагдсанаар зэрэг дэвийн асуудал өнөөг хүртэл шинэчлэн сайжруулсаар байгаа билээ. 1996 оны Улсын Их Хурлын 38 дугаар тогтоол батлагдсанаар Монгол Улсад албан тушаалын зэрэг дэв, цалин урамшуулал, төрийн албаны тогтвортой байдлыг хангах уламжлалт карьерийн тогтолцоог хөгжүүлж ирсэн юм. Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар 2019 онд батлагдсан төрийн захиргааны албан хаагчид

45 한호섭 (1999). 행정학 용어 사전. 서울, 행정학용어표준화연구회, 새 창문 미디어.

албан тушаалын зэрэг дэв олгохтой холбогдсон харилцааг зохицуулах журам мөрдөгдөж байна. (А.Э.ц)

ЗЭЭЛ (Loan) Зээлдэгч нь тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг гэрээнд заасан хугацаа, нөхцөлийн дагуу зээлдүүлэгчээс хүлээн авч тохиролцсон хугацаанд хүүгийн хамт буцаан төлөх төлбөрийн үүрэг хүлээдэг, хоёр этгээдийн хооронд үүссэн гэрээний харилцаа. Энгийнээр тодорхойлбол, санхүүгийн байгууллага, хувь хүнээс хувийн хэрэгцээ болон бизнесийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг тодорхой хугацаатай, хүүтэй, эргүүлж төлөх нөхцөлтэй авахыг зээл гэнэ.⁴⁶ Улс орны эдийн засгийн хөгжилд чухал нөлөөтэй дэд бүтцийн болон нийгмийн салбарын төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн тодорхой эх үүсвэрийг Засгийн газар зээлийн эх үүсвэрээр бүрдүүлдэг бөгөөд Засгийн газрын гадаад зээл нь эргэн төлөгдөх хугацаа урт, харьцангуй бага хүүтэй, хөнгөлөлттэй нөхцөлтэй байдаг. Энэ төрлийн зээлийг Засгийн газар олон улсын санхүүгийн байгууллага, түншлэгч орнуудтай байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу авч ашигладаг бөгөөд гадаадын хөнгөлөлттэй зээл гэх ангилалд хамруулж бүртгэдэг. Мөн Засгийн газар олон улсын хөрөнгийн зах зээлээс богино хугацаатай, өндөр хүүтэй гадаад зээлийг татан авдаг бөгөөд үүнийг арилжааны (хөнгөлөлттэй бус) зээл гэж нэрлэдэг. Засгийн газрын гадаад зээлийн хэмжээ, зээлийн ашиглалтын талаар жил бүрийн Улсын төсвийн тухай хуульд тусгадаг. (Б.Б)

ЗЭЭЛЛЭГ (Borrowing) Тодорхой нөхцөлтэйгөөр мөнгөн зээл авах, өр үүсгэх санхүүгийн үйл ажиллагаа.⁴⁷ Төсвийн алдагдлыг нөхөх, хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор аливаа улс орны Засгийн газар нь боломжит санхүүгийн арга хэрэгслийг хэрэглэн өр үүсгэдэг.⁴⁸ Жишээ нь: Өрийн удирдлагын тухай Монгол Улсын хуульд⁴⁹ Засгийн газрын өрийн баталгаанаас бусад өрийн хэрэгслээр дамжуулан өр үүсгэхийг зээллэг гэж тодорхойлсон. Зээллэгийн эх үүсвэрийг гадаад болон дотоод зах зээлээс бүрдүүлдэг. (Б.Б)

46 Монгол банк: Зээл, гарын авлага <https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/07.pdf>

47 ШУА: Монгол хэлний их тайлбар толь

48 <https://www.britannica.com/topic/government-budget/Government-borrowing>

49 Legalinfo.mn

И

ИВЭЭХ БОДЛОГО (*Incentive policy*)

Энэ нь байгууллагууд болон иргэдийг урамшуулах замаар тодорхой үйл ажиллагааг явуулахад өдөөх шинжтэй бодлого юм. Ивээх бодлогын гол хэрэгсэл нь санхүүжүүлэх (татаас), гэрээ хийх, лиценз зөвшөөрөл олгох зэрэг болно. Тухайлбал, сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газар тариаланчдад хурааж авсан тонн будаа тутамд зохих хэмжээний санхүүжилт олгож байна. Мөнгө олгохоос гадна газрыг үнэ төлбөргүй эзэмшүүлэх зэрэг бусад арга ч байдаг. Түүнчлэн болзол (ажиллах хүчний тодорхой хувийг тухайн орон нутгаас авах, байгаль орчныг нөхөн сэргээх гэх мэт) зааж гэрээ хийх нь мөн ийм бодлогын төрөлд багтана. Манай оронд төрийн байгууллагаас лиценз зөвшөөрөл олгох аргыг өргөн хэрэглэдэг. Гэвч үүний үр дүн нь заримдаа эсрэг байдлаар, ямар нэг бэрхшээлтэй үйл ажиллагааг явуулахад түлхэц өгч урамшуулах бус, харин тэртэй тэргүй иргэд явуулах хүсэлтэй байгаа үйл ажиллагааг боогдуулах хэрэгсэл болгон ашиглагдах тал ч бий¹. (Ц,Д)

ИДЭВХГҮЙ ОРОЛЦОО (*Passive participation*) Төр, захиргааны шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах

нь зөв шийдвэр гаргах, хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлэхэд ихээхэн нөлөөлөх учир иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь нэн чухал. Идэвхгүй оролцоо нь иргэний оролцооны хэв маягийн нэг бөгөөд нийгмийн асуудал, үйл ажиллагаанд идэвхтэй ханддаггүй, олон нийтийн шийдсэн эсвэл аль болж өнгөрсөн зүйлийг сонсох замаар оролцох оролцооны хэлбэр юм². Энэ төрлийн оролцоог хөгжлийн бодит оролцоо гэж үзэхгүй. (3.А) [*Зөвлөлдөх оролцоо (Participation by consultation) гэсэн нэр томъёог үзнэ үү*]

И-МАЯГТ (*E-form*) И-маягт нь мэдээллийг оруулах, унших, засварлах, илгээх, хуулбарлах, хадгалах, хайх зориулалттай, тусгайлан загварлагдсан электрон маягт юм. И-маягт нь мэдээллийг оруулах, унших, засварлах, илгээх, хуулбарлах, хадгалах, хайх зориулалттай, тусгайлан загварлагдсан цахим маягт юм. Мэдээллийг цахим байдлаар авахад зориулсан тодорхой асуулт бүхий баримт бичгийн загвар. Ерөнхийдөө, цаасан маягтын компьютерт оруулсан хувилбар гэж ойлгоно. Төрийн захиргааны байгууллагад цахим баримт бичгийн загвар маягтад тавигдах шаардлага нь цаасан баримт бичигт тавигдах

¹ А.Цанжид (2009). Төрийн захиргаа. Сурах бичиг. Улаанбаатар. х. 130.

² Jones, S., & et al. (2013). *Framework for Analyzing Participation in Development*. Oslo, Norway: Network Broking/Bjerch Trykker, pp. 10-12.

шаардлагатай ижил байна. Байгууллага нь и-маягтыг ашиглан нэгж, хэлтэс, газар, байгууллага болон салбарын хэмжээнд мэдээллийг нэгтгэж, тайлан мэдээг гаргах, мөн эрх бүхий хэрэглэгч баримт бичгийн цахим загварыг шинээр үүсгэх, хадгалах, баримт бичгийн загвар файлын санг удирдан зохион байгуулж болно. (Д.Ч)

ИННОВАЦ (*Innovation*) Засгийн газрын болон нийгмийн бусад байгууллагын үйл ажиллагаанд урт хугацаанд бий болсон нөхцөл байдлыг үндсээр нь шинэчлэх эргэлтийн чанартай өөрчлөлтийг зориудаар, шинжлэх ухаанчаар хийх үйл явц юм. Эрс шинэчлэл нь уламжлал болон тогтсон хэв маягаас нэг татгалзаж, зан харилцаанд шинэ хэлбэр шаардах шинэ санаа, ажил хэргийн шинэ арга барил нэвтрүүлэхийг шаарддаг (Рондинэли, 2007). Фраскатын 1993 оны тодорхойлолтоор “Инновац нь шинэ ба шинэчилсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, технологийн процессыг боловсронгуй болгох, нийгмийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны эцсийн үр дүн” юм. Инновацын тухай олон тодорхойлолтоос: аливаа шинэ бүтээмж, шинэ санааг эдийн засгийн эргэлтэд оруулж, мөнгө олох үйл явц гэж ойлгож болно. Үйлдвэрлэл, үйлчилгээ, төрийн удирдлагад дэвшилтэт үр нөлөө авчрах шинэ буюу шинэчлэгдсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ технологийн процесс, мөн удирдлага, зохион байгуулалт, санхүү, эдийн засгийн болон бусад шийдлүүд нь инновацын үр нөлөө юм. Бодит амьдралд шинэ санаа, шинэ технологийг амьдралд хэрэглэх, хэрэгцээ нь түүнийг хэрэгжүүлэх мэдлэг чадвар бүхий хүн, технологи эцэст нь шинэ санааг

олон түмэнд хүргэх эдийн засгийн дэмжлэг гэсэн гурван нөхцөл нь инновац хөгжих үндсэн суурь. Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг бага зардлаар ашигтай болгоход шинэчилж, үйлдвэрлэлд шинэ технологи хэрэгжүүлдэг тул нэг талаас үйлдвэрлэгчид инновацыг түлхүү бий болгодог. Бүтээгдэхүүн тухайн хэрэглэгчийн шаардлагыг хангаагүй тохиолдолд хэрэглэгч өөртөө тааруулан бүтээгдэхүүнийг өөрчилснөөр инновац гаргах бас нэг шалтгаан болдог бол эрдэм шинжилгээний байгууллагууд, том компанийн олон жилийн судалгааны үр дүнд инновацыг бий болгон хөгжүүлдэг. (А.Эц)

ИНСТИТУЦ/ХҮРЭЭЛЭН³ (*Institution*)

Нийгмийг бүрдүүлж байгаа дэд хэсэг, субъект хоорондын харилцааг зохицуулах механизмыг нэгтгэн институт буюу хүрээлэн гэж тодорхойлдог. Төр эсвэл хувийн хэвшилд хамаарах байгууллага, нэгж тэдгээрийн харилцааг зохицуулах дэг жааг, дүрэм журмыг нэгтгэн ийнхүү тодорхойлдог. Аливаа институт нь эдийн засаг, нийгэм, улс төрийн хүрээнд тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэхээр албан ба албан бусаар зохион байгуулагддаг. Жишээлбэл, Засгийн газар нь төрийн *гүйцэтгэх* үндсэн чиг үүрэг, бусад харилцан хамаарал бүхий дэд үүргийг хэрэгжүүлэх байгууллагуудаас бүрдсэн, байгууллага хоорондын болон бусад оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулах эрх зүйн акттай, хуульчлан тогтоосон бүтэцтэй нэг институт буюу хүрээлэн юм. (Б.Б)

3 Профессор Я.Долгоржавын үзлээр хүрээ, хүрээлэн гэх манай язгуур үг институт гэх үгтэй утга нэг аж.

ИНСТИТУЦИЙН ЭДИЙН ЗАСАГ (*Institutional economics*) Нийгмийн сайн сайхан аж байдлын өөрчлөлтийг институцийн хүчин зүйлээр тайлбарладаг сэтгэлгээний чиглэл XX зууны эхэн үеэс үүсэлтэй ба шинэ институцийн эдийн засгийн онол 1980-аад оноос хүчтэй хөгжсөн. Эдийн засгийн хэлцлийн зардал, тэгш бус мэдээлэл, эзэн-төлөөлөл (агент)-ийн харилцааны нөхцөлд эдийн засгийн харилцаанд оролцогчдын зан үйл, шийдвэр гаргах онцлогийг судалдаг урсгалыг институцийн эдийн засаг гэдэг.⁴ Энэ онолын үүднээс аливаа улс орны болон салбар, байгууллагын хөгжлийн ялгаа нь институцийн ялгаатай холбоотой гэж тодорхойлдог. Институцийн эдийн засгийн үүднээс: засаглал сайтай, сайн институцтэй, бодлого сайтай, өмчлөх ба гүйцэтгэх эрх мэдлийг зааглаж баталгаажуулсан байгууллага нь капиталыг үр өгөөжтэй ашиглаж хөгжих боломжтой. “Институц нь улс төр, эдийн засаг, нийгмийн харилцааг эмхлэх, хязгаарлах дүрэм бөгөөд, хүмүүс хоорондын бүхий л төрлийн харилцааны хөшүүрэг болдог” гэж энэ онолын гол төлөөлөгчдийн нэг Дуглас Норт тодорхойлсон бөгөөд институц бол дүрэм, байгууллага бол уг дүрмээр тоглогч нь байх ёстой.⁵ Энэ онолыг баримтлагчид эдийн засгийн үйл явцыг зөвхөн эдийн засгийн хууль, ойлголтын хүрээнд судлах биш эдийн засгийн бус хүчин зүйлс, институцийг ашиглах хэрэгтэй гэж үздэг. (Б.Б)

ИРГЭДИЙН ИТГЭЛ (*Citizen trust*) “Итгэл” нь сэжиггүй үнэмшил, найдлага утгыг илэрхийлнэ⁶. Иргэдийн эерэг хүлээлтэд нийцэх үйлдлийг засгийн газар хийнэ гэсэн итгэл үнэмшил (итгэл найдвар)-ээр иргэдийн итгэл тодорхойлогдоно⁷. Итгэл бол засгийн газрын гүйцэтгэлийн гол хэмжүүрүүдийн нэг юм. Иргэдийн итгэл нь засгийн газар болон иргэд хоорондын харилцаанд нөлөөлөхийн зэрэгцээ төрийн бодлогын үр дүнд нөлөөлдөг. Тухайлбал иргэд иргэний үүргээ биелүүлэхдээ хойргоших хандлага ихсэх нь засгийн газрын үйл ажиллагаанд итгэх иргэдийн итгэл буурсны илрэл. Иргэдийн итгэлийг олох, нэгэнт олж авсан итгэлийг алдахгүй даах нь маш их ухаан, чармайлт, хугацаа шаардах хирнээ итгэл алдагдахад маш хурдан байдаг. Иймд иргэдийн Засгийн газарт итгэх итгэлийн түвшин хэрхэн өөрчлөгдөж байгааг тогтмол судлахыг улс орнууд эрмэлзэж байна. Иргэдийн Засгийн газарт итгэх итгэлийг тодорхойлдог олон улсын хэмжээнд өргөн түгсэн дараах судалгаа байна. Үүнд: Европын улс орнуудын харьцуулалтыг хийдэг Евробарометр (*Eurobarometer*)⁸, дэлхийн улс орнуудын харьцуулалтыг хийдэг Дэлхийн үнэт зүйлийн судалгаа (World Values Survey)⁹, Эделманы итгэлийн индекс¹⁰, ЭЗХАХБ-аас хийдэг Засгийн газарт итгэх иргэдийн итгэлийн судалгаа гэх мэт судалгаа байна. (М.А)

6 Монгол хэлний их тайлбар толь.

7 OECD, Guidelines on Measuring Trust, 2017, p. 42.

8 Stephan Grimmelikhuijsen, Eva Knies, “Validating a scale for citizen trust in government organizations”, International Review of Administrative Sciences, 2017, Vol.83 (3), p. 585.

9 Stephan Grimmelikhuijsen, Eva Knies, “Validating a scale for citizen trust in government organizations”, International Review of Administrative Sciences, 2017, Vol.83 (3), p. 585.

10 OECD, Government at Glance-2013, 2020, p. 23.

4 Oliver E. Williamson: The New Institutional Economics: Taking Stock, Looking Ahead, Journal of Economics Literature, 2000 (XXXVIII), pp. 595-613.

5 Douglass C. North: Institutions, Journal of Economic Perspectives, 1991, 5(1), pp. 97-112.

ИРГЭДИЙН НИЙГМИЙН ӨМНӨ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ (*Obligations of citizens to society*) “Obligation” гэдэг нь “obligacion (1300 оноос)” буюу “заавал биелүүлэх амлалт, амлалтаа биелүүлэх” гэсэн үгнээс гаралтай. Эртний Франц хэлэнд “obligacion” гэдэг нь “үүрэг, хариуцлага” гэсэн утгыг илэрхийлдэг байв. “Citizen” гэх үг нь мөн л 1300 оноос үүсэлтэй. Энэ нь Англи-Францын “citesein, citezein” буюу “хотын оршин суугч, хотын оршин суугч, иргэн” гэсэн утгыг илэрхийлдэг. Монгол хэлнээ үүрэг нь хүний биедээ дааж авсан (үүрч даахаар тогтоосон хэмжээ), хариуцан гүйцэтгэх зүйлийг илэрхийлдэг. Тиймээс үгийн нийлэмж нь иргэний үүрэг хариуцлагатай холбогддог. Иргэдийн нийгмийн өмнө хүлээх үүрэг нь тэдний нийгэмд эзлэх байр сууринд үндэслэн тодорхойлсон цогц¹¹ ойлголт юм. Учир нь хүн төрөлхтөн нийгэмшиж амьдрах нь үр ашигтай гэж олж тогтоосон боловч нийгмийн амьдралын хүндрэл бэрхшээл гарч, төр засгийн хэрэгцээ бий болдог. Үүний нэгэн адил иргэн хүн нийгмийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ ухамсарлан биелүүлэх шаардлага тулгардаг. (Т.Т)

ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ (*Citizen's Public Council*) Баг, хорооны нутгийн өөрөө удирдах байгууллага нь Иргэдийн Нийтийн Хурал байна. Баг, хорооны Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1) Хурлын хуралдааны дарга, Хурлын Тэргүүлэгчдийг сонгох, чөлөөлөх; 2) баг, хорооны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, чөлөөлөх, огцруулах санал болон Засаг даргын огцрох тухай хүсэлтийг хүлээж авах эсэхтэй холбогдсон саналыг хэлэлцэн сум, дүүргийн Засаг даргад уламжлах; 3)

Хурлын дотоод зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх; 4) баг, хорооны Засаг даргын тайланг хэлэлцэж ажилд нь үнэлэлт дүгнэлт өгөх; 5) баг, хорооны иргэдийг шагнаж урамшуулах, дэмжлэг, тусламж үзүүлэх саналыг сум, дүүргийн Хурал, Засаг даргад уламжлах; 6) өрхийг албан татвар, бусад ногдол үүргээс түр чөлөөлөх буюу хөнгөлөлт үзүүлэх тухай саналыг сум, дүүргийн Хурал, Засаг даргад оруулах; 7) харьяалах баг, хорооны иргэний үндсэн ба журамт үүргийн биелэлтийг хангуулах; 8) иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн нутаг дэвсгэрийн байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай хүсэлтийг хэлэлцэж саналаа сум, дүүргийн Хуралд уламжлах; 9) хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлэх; 10) хууль тогтоомжид заасан бусад бүрэн нэг Нийтийн Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно. Баг, хорооны Хурлын хуралдааныг хэсэгчлэн зохион байгуулж болно. (Ч.Э)

ИРГЭДИЙН ОРОЛЦОО (*Citizen's participation*) “Participation” гэдэг нь Францын “participacion (XIII дугаар зууны үе)”, Латины “participatio-nem” үгнээс үндэстэй. Үгийн утга нь

11 Монгол хэлний их тайлбар толь

“оролцоо (partaking)” гэсэн санааг илтгэдэг. Гэхдээ “participation” гэдэг нь доороос дээш чиглэсэн буюу иргэдийн санаачилгад тулгуурласан оролцооны хэлбэр юм. Ийм хэлбэрийн оролцоо нь албан ёсны дүрэм журмаар зохицуулагдахаасаа илүүтэй иргэд өөрсдийн идэвх санаачилгад тулгуурлан нэгдэж төрийн аливаа үйл хэрэгт оролцох, дуу хоолойгоо хүргэх үйл явц (оролцоо нь үйл явц болохоос арга хэмжээ биш)-тай холбоотой. Оролцоо нь янз бүрийн сонирхогч талын дуу хоолойг сонсож, шийдвэр гаргахдаа харгалзан үзэж тусгах үйл явц. Тухайлбал, иргэдийн санаачилгад тулгуурласан оролцоо нь засаглал дахь оролцогч талууд шийдвэр гаргах, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэгт оролцон өөрсдийн дуу хоолойгоо илэрхийлж, нөлөөлөх тухай юм. Шерри Арнштайн “Иргэдийн оролцоо бол иргэний засаг гэсэн нь улс төр, эдийн засгийн үйл явцаас хасагдсан иргэдэд ирээдүйд оролцох боломжийг нь нээж өгч буй засгийн эрх мэдлийн дахин хуваарилалт...” гэж тэмдэглэсэн байна (Бямбаяр Я., 2013, хуудас. 18). Иргэдийн оролцоо үл оролцох (идэвхгүй), хэлбэрдэх, иргэний засаг (идэвхтэй) гэсэн гурван үндсэн шатлалтай байдаг. Оролцоо нь бүхий л холбогдогч талуудын идэвх санаачилга, хүсэл эрмэлзлээс хамаарна. Иргэд сайн дурын бүлэг үүсгэж, зохион байгуулалтад орсноор шийдвэр гаргалтад оролцох, нөлөөлөх боломжийг илүү нэмэгдүүлдэг. Гэхдээ иргэдийн оролцоо нь мэдээллийн ил тод байдлаас хамаарах ба иргэнийг мэдээлэлтэй болгосноор иргэд нь засаглалын шийдвэрт бодитой оролцох, хариуцлага нэхэх боломжийг бүрдүүлдэг. (Г.Т)

ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ШИЙДВЭР ГАРГАЛТ (*Citizen participation in decision making*)

Иргэд, иргэний нийгмийн байгууллага болон бусад холбогдогч талуудыг шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцуулан, тэдний дуу хоолойг шийдвэр гаргалтад харгалзан үзэж тусгах үйл явц юм. Холбогдогч талуудыг шийдвэр гаргалтад оролцох, нөлөөлөх боломжоор хангах нь “Иргэдийн оролцоотой шийдвэр гаргалт”-ын үндэс. Захиргааны аливаа шийдвэр нь иргэдийн амьдралд ямар нэгэн хэмжээгээр нөлөөлдөг тул шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийг оролцуулах нь олон талын ач холбогдолтой. Тухайлбал, мэдээллийн өргөн эх сурвалж, асуудлын шийдлийн олон хувилбарыг ашиглах боломжийг засгийн газарт олгож, шийдвэр гаргалтыг чанартай болгох, төр, иргэдийн харилцааг хөнгөвчлөх, хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлэх, олон нийтийн итгэлийг бэхжүүлэх, засаглалыг сайжруулах зэрэг ач холбогдолтой. “Иргэний оролцоо нь улс төр, эдийн засаг, нийгмийн үйл явцад оролцох боломжийг иргэдэд нээн өгч буй засгийн эрх мэдлийн дахин хуваарилалт юм” гэж Шерри Арнштайн тэмдэглэсэн байдаг¹². (М.А)

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ (*Citizen's Representatives Council*)

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх нутгийн өөрөө удирдах байгууллага нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байна. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ. Нутгийн өөрөө удирдах

12 Бямбаяр Я., “Төвлөрлийг сааруулж нутгийн удирдлагыг бэхжүүлэх нь: уламжлал, шинэчлэл, сургамж”, дисс. Улаанбаатар, 2013, 18 дахь тал.

байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байна. Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна. (Ч.Э)

ИРГЭДИЙН ТӨСӨВ (*Citizen budget*)

Улсын төсвийн мөнгө бол нийт иргэдийн мөнгө юм. Засгийн газрын улсын төсвийн орлого нь татвар төлөгч нийт иргэдээс төлсөн татвар (орлого, борлуулалт эсвэл үл хөдлөх хөрөнгө) ба төлбөр гэж ойлгож болно. Энэ мөнгөний төлөө Засгийн газар нь иргэд, олон нийтийн өмнө хариуцлага хүлээдэг. Иймд иргэдээс Засгийн газрын төсвийн зарцуулалтад хяналт тавих, хариуцлага нэхэх хэрэгцээ байдаг ба төсвийн орлого, зарлагын урсгалыг ил тод байлгахыг шаарддаг. Засгийн газрын боловсруулсан жилийн төсвийг олон нийтэд нээлттэй болгох нь нэгэн арга зам нь түүнийг олон нийтэд ил болгох, мөн төсвийн хөрөнгө, эх үүсвэрийг зарцуулалтын санхүүгийн тайланг эсвэлэн нийтлэх, тараах, мэдээлэх асуудал байдаг. Төсвийн тоо, мэдээлэл нь ойлгоход нарийн төвөгтэй маш олон хэсгүүдээс бүрдсэн баримт бичиг бөгөөд

мэргэжлийн техникийн нэр томьёо агуулж гардаг учраас ихэнх энгийн иргэд түүнийг ойлгодоггүй. Энгийн иргэд төсвийн талаар ойлголт авах, улмаар төсвийг ойлгоход хүндрэлтэй байдал үүсдэг. Иймд мэргэжлийн нэр томьёо агуулсан тоо баримттай төсвийг энгийн байдлаар иргэдэд зориулан ойлгоход нь хялбар байдлаар нэгтгэн дүгнэж, төсвийн үндсэн мэдээллийг тайлбарлаж өгөх баримт бичиг хэрэгтэй тул иргэдийн төсөв гэсэн баримт бичгээр хангаж өгдөг. (А.Э)

ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭНИЙ КАРТ

(*Citizen evaluation card*) Иргэдийн үнэлгээний карт нь (CRC) төрөл бүрийн үйлчилгээнд хэрэглэгчдээс үнэлгээ авч, түүнийг үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг иргэдийн өмнө ил тод хариуцлага хүлээдэг болгоход ашигладаг арга хэрэгсэл. Энэ нь хэрэглэгчдийн санаа бодлыг судлах, засгийн газрын үйлчилгээ иргэд, түүний дотор амжиргаа тааруу иргэдэд хүрч байгаа талаар мэдээлэл олж авах өртөг багатай арга замын нэг юм. Иргэдийн үнэлгээний карт-ыг анх 1994 онд Энэтхэгийн Бангалор хотод боловсруулжээ. Төрийн үйлчилгээний нөхцөл тааруу байгаад бухимдсан хэсэг иргэд хэрэглэгчдийн санал хүсэлтийг цуглуулах оролдлого хийсэн нь үр дүнд хүрч тус хотод Олон нийттэй харилцах төв (Public Affairs Centre - PAC) төрийн бус байгууллага байгуулж байв. Түүнээс хойш тус төв нь өөрсдийн бие даасан түншлэлээр Бангалор хотод, Энэтхэг Улсдаа, улмаар дэлхийн өнцөг булан бүрд ийм олон тооны төвүүдийг байгуулж, үйл ажиллагаагаа өргөжүүлжээ. Энэ олон нийттэй харилцах төвийн аргачлалыг улс орны иргэний нийгмийн байгууллага, засгийн газар, хөгжлийн

агентлагууд баталж, хэрэгжүүлсээр байна¹³. (Д.Ч)

ИРГЭД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН ЦАХИМ ХАРИЛЦАА (*Citizen to Government relations (C2G)*)

Иргэд болон төрийн байгууллагууд мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглан харилцаа бүлсгэх, харилцан үйлчилгээ үзүүлэх боломжит байдлыг хэлнэ. Иргэд болон төрийн байгууллага хоорондын цахим харилцаанд технологийн хөгжил илүү их боломжийг үүсгэж төрийн үйлчилгээг цахимаар авах, төрийн байгууллагатай цахимаар холбогдох зэрэг боломж улам өргөжиж байна. Энэ нь иргэд ба төрийн байгууллага хоорондох мэдээллийн урсгал хоёр талын болох нөхцөлийг бүрдүүлж байгаа бөгөөд цахим засаглалын үндсэн чухал асуудалд тооцогддог. (Д.З; Ч.Л нар)

ИРГЭНД ЧИГЛЭСЭН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗЭЛ САНАА (*The concept of citizen oriented public service*)

Иргэдийг үйлчилгээ, үйл ажил-лагааны төвд тавих үзэл санаа юм. Иргэдийн хэрэгцээ, хүлээлт, эрхэмлэх зүйл, төрийн үйлчилгээ, үйл ажиллагаанд өгөх үнэлгээ, сайжруулах санал зэргийг тохирсон аргаар системтэй судлан, үр дүнг төрийн үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулахад ашиглан аль болох иргэнд чирэгдэлгүй, шуурхай, чанартай, тэгш, хүртээмжтэй үйлчлэхэд чиглүүлнэ гэсэн үг. “Иргэнд чиглэсэн төрийн үйлчилгээ” практик амьдралд “Иргэнд ойр төрийн үйлчилгээ”, “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” гэдэг нэр томьёог өргөн хэрэглэдэг. Судлаач Глүкийн тодорхойлсон “Иргэнд ойр байх”

үзэл санаа нь “Иргэнд чиглэсэн байх”-ын өмнөх алхам ажээ¹⁴. 1980-аад оны эхэн үеэс эхэлсэн төрийн салбарын шинэтгэлийн хүрээнд “Иргэнд чиглэсэн төрийн үйлчилгээ”-ний үзэл санаа хүчтэй хэлэлцэгдэх болсон байна. Улс орон бүрд өөрийн онцлогтой шинэтгэл хийгдсэн хэдий ч тэдгээр шинэтгэлийн үндсэн зарчим, зорилгод тусгагдсан нийтлэг зүйл нь “иргэнд чиглэсэн төрийн үйлчилгээ” байв. (М.А)

ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХ (*Civil and political right*)

Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблей баталсан.¹⁵ Багтагдсан өдрөөс хойш арван жилийн дараа буюу 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Энэ нь хүний амьд явах эрх, улс төрийн бүх эрхийг эрэгтэй, эмэгтэй тэгш эдлэх, боолын худалдааг хориглох, шүүхээр хамгаалуулах, шүүхийн өмнө адил тэгш байх, дайны аливаа хэлбэрийг хуулиар сурталчлахыг хориглох, цаазаар авах ялыг цуцлах, албадан хөдөлмөрлүүлэхгүй байх, дур мэдэн баривчлах, оршин суух газраа чөлөөтэй сонгох, өмгөөлүүлэх хугацаа хүрэлцээтэй байх, сонгож авсан өмгөөлөгчтэй харилцах, эх орондоо ирэх эрхийг дур мэдэн хасах, шашин шүтлэгийг хязгаарлах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, гэр бүл болох зэрэг иргэний болон улс төрийн суурь эрхүүдийг хамгаалсан баримт бичиг юм. Элсэн орсон улс бүрийн эрх, үүргийг 6 хэсэг, 53 зүйлээр тодорхойлсон англи, испани, орос, хятад, франц

14 Glueck M., “Vertrauen und Legitimation durch Buergierzufriedenheit: Eine Untersuchung der Aufgabenerfuellungszufriedenheit anhand deutscher Staedte und Gemeinden”, s. 310.

15 Ж.Бор нар, Дэлхийн дипломатын нэвтрэхий толь бичиг, Улаанбаатар 2018, х. 452.

13 UN, HABITAT, Citizen Report Card: <https://mirror.unhabitat.org/content.asp?typeid=19&catid=635&cid=7660>

хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй бөгөөд түүнийг Нэгдсэн Үндэстний байгууллагын архивт бий бөгөөд Монгол Улс 1974 оны 11 дүгээр сарын 18-нд нэгдэн орсон. (П.А)

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН УЛСЫН НЭГДСЭН СҮЛЖЭЭ (*Integrated citizen registration network*) Иргэний бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, төр, захиргаа, нийгмийн даатгал, гааль, татвар, цагдаа, хил хамгаалах зэрэг иргэний бүртгэлтэй холбоо бүхий бүх төрлийн мэдээллийн сангуудын үйл ажиллагааг нэг сүлжээнд оруулан зохион байгуулсан хэлбэр. Монгол Улсад иргэний бүртгэлийн нэгдсэн сүлжээний тогтолцоог бий болгох нь төрийн бодлогын нэгдмэл чанарыг хангах, үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх, төрийн ой санамжийг бүрдүүлэх, төрөөс иргэд болон бизнесийн байгууллагад үзүүлэх нийгмийн бүх салбарыг хамарсан үйлчилгээг хүртгээмжтэй, шуурхай, үр ашигтай болгож хүнд суртал, авлигаас урьдчилан сэргийлэх зэргээр сайн засаглалыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. (Д.З; Ч.Л нар)

ИРГЭНИЙ ЖОЛООДЛОГО (*Citizen driven*) “Citizen” гэдэг нь Францын “citizein” гэх үгнээс эхтэй бөгөөд үгийн утга нь “хотын оршин суугч (city/town-dweller)” гэсэн санааг илэрхийлдэг. Орчин цагт иргэн, иргэд гэсэн утгаар орчуулан хэрэглэдэг. Нийтийн ашиг сонирхол нь “хувь хүмүүсийн сонирхлын нийлбэрээс бус нэгдмэл үнэлэмжийн тухай яриа хэлэлцүүлгийн үр дүн (Жанет ба Роберт Денхардт, 2007)”¹⁶-гээс бий болдог. Төр засгийн үйл ажиллагаа нь иргэдийн хэрэгцээ шаардлагад

тулгуурласан, гарч буй үр дүн нь тэдний хүлээлтэд нийцсэн байна. Нийгмийн сайн сайхан байдал нь ард иргэдийн амьдралын чанартай салшгүй холбоотой тул төрийн байгууллага, албан тушаалтны аливаа үйл ажиллагаа нь тэдний амьдралын чанарыг сайжруулахад чиглэдэг утгаараа төрийн байгууллагын зорилго, хөгжлийн чиг хандлага нь хуучин дан ганц хуулиар зохицуулагдаж байсан уламжлалт тогтолцооноос өрсөлдөөнт зах зээлийн механизм руу шилжиж, иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд анхаарч байсан бол өдгөө төрийн үйл ажиллагаа нь иргэдийн хэрэгцээ шаардлага, хүлээлтэд нийцсэн байх зэргээр өөрчлөгдөж байна. Өөрөөр хэлбэл, иргэдэд хөтлөгдсөн гэдэг нь төр засгийн бодлого, шийдвэр нь иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан, тэднийг оролцоог хангасан байх явдал юм. Энэ нь төрийн байгууллага, албан тушаалтан иргэдийнхээ дуу хоолойг сонсдог байх, тэдний хэрэгцээ шаардлагыг мэдэрдэг байх, төрийн үйлчилгээ нь иргэдийн амьдралын хэв маяг, онцлогт тохирсон арга хэлбэрээр хүрдэг байхыг шаарддаг. (Т.Т)

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА (*Civil society organization*) Засгийн газар ба бизнесийн байгууллагаас ангид, гишүүдийн эсвэл олон нийтийн ашиг сонирхлын төлөө ажилладаг, иргэн ба төрийн хоорондын харилцаа, нийтийн засаглалд тодорхой үүрэгтэй оролцдог, зохион байгуулалтын хэлбэрт сайн дураараа нэгдсэн иргэдийн нэгдэл буюу зохион байгуулалттай бүлэг. Иргэний нийгмийн байгууллага нь нийтийн ашиг сонирхол эсвэл нийгмийн тодорхой бүлэг, хүмүүсийн нэгдмэл

16 В.Өлзийбаяр, 2011, төрийн шинэ албаны үзэл баримтлал, төрийн захиргаа сэтгүүл, №1, х. 15.

сонирхол, харилцаа холбоог төлөөлж яв, үндэс, шашин шүтлэг, мэргэжлийн эсвэл хувь хүний төрөл бүрийн сонирхлын нэгдэлд суурилж үүссэн төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, улс төрийн намууд, иргэдийн сонирхлын бүлэг зэрэг албан эсвэл албан бус байгууллагуудыг иргэний нийгмийн байгууллагад хамруулдаг. (Б.Б)

ИРГЭНИЙ НИЙГЭМ (Civil society)

Civil society буюу иргэний нийгэм нэр томьёог анх Английн философич А.Фергюсон XVIII зуунд нийгмийн шинжлэх ухааны судалгаанд оруулжээ. Иргэний нийгмийн үзэл санаа эртний сэтгэгчид Ж.Локк, Ш.Монтескье, Ж.Ж.Руссо, С.Милль, Р.Михельс, М.Дюверже, С.Пуфендорф, И.Кант нарын бүтээлд тусгагдаж, боловсруулсан. Энэ ойлголтыг тодорхойлсон онол, үзэл баримтлалын олон янзын хандлага байх боловч нэгдсэн ойлголтод хүрээгүй талаар судлаачид дурджээ¹⁷. Учир нь түүхийн янз бүрийн үеүдэд тухайн нийгмийн төрийн тогтолцооны онцлог, бодлого зэргээс хамаарч иргэний нийгмийн байгууллагыг авч үзэх хандлага өөрчлөгдөж байсантай холбоотой. Судлаач С.К.Вэиндик үзэхдээ иргэний нийгмийг тодорхойлох нь хялбар биш. “Иргэний нийгэм” нь 1980-аад оны үед Зүүн Европ, Латин Америк дахь авторитар дэглэмүүдийг эсэргүүцсэн иргэний хөдөлгөөнүүдээр илүү хүчтэй дэлгэрсэн гэж тэмдэглэжээ¹⁸. Дэлхийн банкны тодорхойлолтоор¹⁹: “Иргэний нийгэм: нэлээд өргөн хүрээний

олон нийтийн байгууллагуудыг багтааж, олон нийтийн бүлгүүд, төрийн бус байгууллагууд (ТББ), хөдөлмөрийн холбоод, орон нутаг дахь уугуул иргэдийн бүлгүүд, буяны байгууллагууд, итгэл үнэмшлээрээ нэгдсэн байгууллага, мэргэжлийн холбоод, сангуудыг авч үзсэн. CIVIL-CUS буюу Иргэний оролцоог дэмжих дэлхийн холбооны тодорхойлсноор: Иргэний нийгэм бол гэр бүл, төр, зах зээл зэргээс гадуур оршдог иргэдийн эвлэлдэн нэгдэж, нийтлэг эрх ашгийнхаа төлөө үйл ажиллагаа явуулдаг талбар” хэмээн иргэний нийгмийн индекс боловсруулахдаа баримталсан тодорхойлолт байдаг²⁰. Иймд иргэний нийгмийн орчин үеийн онол, үзэл баримтлалыг дараах үндсэн дөрвөн загварт хувааж, тодруулан судлах нь нийтлэг байна. Үүнд: коммунитаран, ардчилсан, либерал хувилбар, дискурс онолын хандлагаар (Юрген Хабермасын) ангилан үздэг. Дэлхийн Эдийн засгийн форумын (2012) “Иргэний нийгмийн байгууллагуудын ирээдүйн үүрэг” судалгааны тайланд түүний хөгжлийн хандлагыг²¹: иргэний нийгэм нь “ТББ давамгайлсан салбараас хавьгүй илүү өргөн хүрээтэйг хүлээн зөвшөөрсөн бөгөөд онлайн болон оффлайн орчны шинэ оролцогчдын тусламжтайгаар олон нийтийн бүлгүүдийн зохион байгуулалттай, зохион байгуулалтгүй олон үйл ажиллагаагаар салбар хоорондын хил хязгаарыг бүдгэрүүлж, нөлөөлөх цар хүрээ нь улам өргөн болж байна” хэмээн тэмдэглэжээ. Жонс Хопкинсийн Иргэний нийгэм судлалын төвийн мэдээлэлд (2017 он): Иргэний нийгмийн байгууллагууд өнөөдөр

17 Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт. (1990-2019 оны). Улаанбаатар, 2019, х. 158.

18 VanDyck, C., K. (2017). Concept and definition of civil society sustainability. Washington DC: Centre for Strategic and International Studies. p. 1.

19 Rachel Cooper. What is Civil Society, its role and value in 2018? University of Birmingham 15 October 2018. <https://assets.publishing.service.gov.uk>

20 Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт. (1990-2019 оны). Улаанбаатар, 2019, х. 160.

21 Rachel Cooper. What is Civil Society, its role and value in 2018? University of Birmingham 15 October 2018. <https://assets.publishing.service.gov.uk>

дэлхий даяар 350 сая мэргэжилтэн, сайн дурын ажилтнуудаас бүрдсэн нийгмийн маш том хөдөлмөрийн зах зээл болсныг дурджээ. Тодруулбал: “Ажиллах хүчний цар хүрээгээрээ болон нийгэм, эдийн засгийн амьдралд оруулсан хувь нэмрээрээ томоохон аж үйлдвэрүүдээс давж гарсан бөгөөд ”дэлхийн иргэний нийгмийн салбарын ажиллах хүчийг улс орон гэж төсөөлбөл, Хятад, Энэтхэгийн дараа хүн амын тоогоороо гуравдугаарт жагсаж байна” хэмээн онцлон бичжээ. Ийнхүү орчин үеийн төрийн удирдлагын салбарт ч иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг өсөн нэмэгдэж, төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх гурав дахь секторын байгууллагууд буюу түншлэлийн оролцогч гэж үзэж байна. (Я.Т)

ИРГЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ (*Citizen identification*) Хүний биометрийн давтагдахгүй өгөгдлөөр тухайн хүн мөн эсэхийг баталгаажуулах боломж олгосон технологи. Цахим орчинд иргэнийг таних, тодорхойлох технологийг ашиглахад урьдаар хүмүүсийн шаардлагатай өгөгдлүүдийг хадгалан сануулсан мэдээллийн сан бүрдүүлэх ба төрөл бүрийн зорилгоор баталгаажуулалтыг зөвхөн тухайн өгөгдлүүдийг харьцуулах замаар шийдвэрлэдэг. Энэ нь тухайн иргэнийг алдаагүй таньж тогтоох найдвартай арга төдийгүй, тухайн хүнд өөрийгөө шуурхай, хялбар баталгаажуулах боломжийг олгодог давуу талтай. (Д.З; Ч.Л нар)

ИРГЭНИЙ ҮҮРЭГ (*Citizen's obligation*) Тухайн улсын харьяат болохын хувьд төрийн өмнө хариуцан, заавал гүйцэтгэвэл зохих хэм хэмжээний цогцыг иргэний үүрэг гэнэ. Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол Улсын иргэнд оноосон үүргийг үндсэн ба

журамт үүрэг гэж ангилна. Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ. Үүнд: 1) хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх; 2) хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх; 3) хуулиар ногдуулсан албан татвар төлөх; 4) эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах зэрэг болно. Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн (Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1, 2). (Ч.Э)

ИРГЭНИЙ ЭРХЭД ШААРДЛАГАТАЙГААС ИЛҮҮ ХАЛДАХГҮЙ БАЙХ (*хэр хэмжээнд нийцсэн байх*) **ЗАРЧИМ** (*Principle of proportionality*) Хууль дээдлэх, хуульд үндэслэх зарчмын хүрээнд захиргаанаас хууль ёсны үүднээс иргэний эрхэд шаардлагатайгаас илүү хэмжээгээр халдахыг хориглодог. Энэхүү зарчим нь а) захиргааны шийдвэр цагаа олж гарч байх, захиргааны үйл ажиллагаа зөвхөн шаардлагатай үед хийгдэж байх, б) зорилгод нийцсэн байх, в) бодит нөхцөлд тохирсон тэнцвэртэй байх, өөрөөр хэлбэл хэмжээнээс хэтрэхгүй байх гурван агуулгаар илэрхийлэгдэнэ. (Ч.Э)

ИРЭЭДҮЙН ӨВ САН (*Wealth fund*) Нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор бий болгосон сан буюу баялгийн сантай утга агуулга нэг гэж ойлгож болно. Монгол Улсын Ирээдүйн өв сангийн тухай хуульд Ирээдүйн өв сан гэж нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт

төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилготой сан гэж тодорхойлсон байна. Ирээдүйн өв сан дараах үндсэн эх үүсвэрээс бүрдэнэ гэж заасан. Үүнд:

1. Ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчийн үйлдвэрийн газрын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;
2. Үүсмэл ордоос бусад орд ашигласнаас төсөвт төвлөрсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь;
3. Сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлогоос энэ хуулийн 9.6-д заасны дагуу буюу 2030 оноос эхлэн Сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлогын 10 хувийг улсын төсөвт шилжүүлсний дараа Санд үлдэх хэсэг;
4. 2018 оноос эхлэн дээр зааснаас бусад эрдэс баялгийн орлогын суурь жилийн орлогын гүйцэтгэлээс давсан хэсгийн 20 хувь.

Ирээдүйн өв сангийн засаглал нь дараах шинжүүдтэй байна.

1. Сан Монгол Улсын нийт ард түмний өмч байна.
2. Сан нь Засгийн газрын тусгай сан бөгөөд орлого, эх үүсвэр, хуримтлалын хувьд улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.
3. Сангийн хөрөнгийн удирдлагыг энэ хуулийн дагуу байгуулагдах

Корпорац хэрэгжүүлэх ба энэ нь Засгийн газрын өмч байна.

4. Сангийн хөрөнгийн удирдлагын бодлого тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих үүргийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хэрэгжүүлнэ.
5. Сан, төсвийн харилцаанд Монгол Улсын Ерөнхий аудитор хяналт тавина. (А.Э)

ИТГЭЛТЭЙ БАЙДАЛ (*Confidentiality*)

Энэ нь Латин хэлний *confidentia* буюу итгэлтэй, шударга байдал, нууцыг хадгалах утгыг илэрхийлдэг. Үгийн гол агуулга нь хувь хүн, мэргэжилтний ёс зүйтэй байдлыг тодорхойлох хэмжээстэй холбогддог (“confidentiality” as moral measure and codes to professionals) бусдын итгэлийг даах, найдлагыг алдахгүй байх тухай юм. Үүнийг монгол хэлний тайлбар толь бат нот, сэжиггүй үнэмшил, найдлага хэмээн тайлбарласан. Итгэлтэй байдал нь захиргааны шинжлэх ухаанд мэдээллийн нууцлал гэхээсээ төрийн албан хаагчдад тавигдах ёс зүйн шаардлага юм. Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэх явцаа иргэд, хувь хүнээс олж авсан нууцлалбал зохих мэдээллийг аливаа этгээдэд задруулахгүй, мэдээллийн нууцыг чандлан хадгалах утга агуулгыг илэрхийлнэ. Нийтэд үзүүлж, мэдэгдэж болохгүй далдалбал зохих зүйлийг өөр бусдад мэдэгдэхгүй байлгах төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлагатай холбогдоно. (Т.Т)

ИТГЭЛЦЛИЙН ОНОЛ (*Trust theory*)

Парсонс (T.Parsons)²²-ын дэвшүүлсэн байгууллагын гишүүдийн харилцан итгэлцэл, хамт олны мэдрэмж

22 Parsons, Talcott (1956). Suggestions for a Sociological Approach to the Theory of Organizations, Administrative Science Quarterly, vol. 1.

дээр суурилсан эрх мэдлийн тухай онол юм. Итгэлцлийн онолоор байгууллагын гишүүдийн хооронд харилцан итгэлцсэн хамтын ухамсар нь чухал нөөц болдог. Энэ нөөц нь хүмүүсийн хүчин чармайлтыг хүчтэй болгон хүчин чармайлт нэмэгдэх тусам эрх мэдэл нэмэгддэг байна. Тэгэхдээ оршихуйн онолын үүднээс энэ нь хэн нэгний бусдад байдгаас давуу эрх мэдэл бус, харин хамтын эрх мэдэл (power with others) гэж ойлгодог. Учир нь итгэлцэл нь хүй хамтлаг дотор гишүүд нь нийтлэг дагаж мөрдөх хэм хэмжээнийхээ дагуу мөрөөрөө, шударга, хамтран ажиллах зан аягтай байна гэж найддаг хүлээлт бөгөөд янз бүрийн соёлын хүрээнд сайн дурын хүй хамтлаг янз бүрийн эрэмбээр хөгждөг гэж үздэг. Итгэлцэл нь ажилтнуудын бүтээлч байдал, сэтгэл санааны тогтвортой байдал, өөрийгөө хянах, хамтран ажиллах хэм хэмжээ, хүрээлэн буй орчны аюулыг багасгах зэрэг мэдээллийг солилцох, үйл ажиллагааг дэмжиж, улмаар асуудлыг илүү үр дүнтэй шийдвэрлэхэд тусалдаг. (Ц.Д)

ИТГЭЛЦЭЛ БИЙ БОЛГОХ (Trust building) “Trust” нь 1200 оны үед “хэн нэгний, эсхүл ямар нэг зүйлийн үнэн зөв, бүрэн бүтэн байдал, эсхүл аливаа ариун журамд найдах; шашинд итгэх итгэл, үнэмшил” гэх утгаар хэрэглэгдэж байсан. Энэ үг нь эртний Норвегийн “traust” буюу “тусламж, итгэл үнэмшил, хамгаалалт, дэмжлэг”²³ үгнээс үндэстэй. Герман хэлнээ “trost” буюу “итгэлцэл, үнэнч байдал, тайтгарал” гэсэн утгыг илэрхийлдэг. Монгол хэлний тайлбар тольд итгэлцэл гэдгийг “баг нот, үнэмших санаа, найдлага” гэсэн утгаар илэрхийлжээ. Харин “Building” нь XIV зууны сүүлээр “барилга

барих эсвэл үйлдэх” гэх утгыг илэрхийлдэг байв. Үгийн нийлэмжийг үзвэл “trust building” гэдгийг монгол хэлнээ “итгэлцэл бий болгох” утгаар орчуулан хэрэглэвэл зохилтой. Орчин үед улс орнууд (ялангуяа хөгжиж буй орнууд)-ын хувьд төрд итгэх иргэдийн итгэлийн түвшин буурч байгаа дүр зураг ажиглагдаж байна. Энэ нь ядуурал, авлига, төр засгийн шударга бус үйл ажиллагаатай холбогдсон байдаг. Иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх боломж нь засаг барьж буй хүмүүсийн гарт байдаг бөгөөд “эдгээрт юуны өмнө эрх зүйт ёсыг чандлан сахих, авлигыг бууруулах, иргэдэд тэгш шударга хандах, төрийн албаны ёс зүйг хатуу мөрдөх, парламент, улс төрийн нам зэрэг ардчиллын төв институцийн соргог байдлыг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх явдал орно”.²⁴ Төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд иргэд, төрийн албан хаагчдын хамтын ажиллагаа, харилцан итгэлцэл чухал. Иргэдийн хүлээлтэд нийцсэн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд хялбар байдаг бол тэдний хүлээлтэд нийцээгүй үйл ажиллагаа нь эсрэгээрээ хүндрэлтэй. Итгэлцэл нь “хүй хамтлагт гишүүд нийтлэг дагаж мөрдөх хэм хэмжээгээр дагуу шударга, хамтран ажиллах зан аягтай байна гэж найддаг хүлээлт”²⁵. Итгэлцэл соёлоор тодорхойлогдох тул соёлын хүрээнд сайн дурын хүй хамтлаг янз бүрийн эрэмбээр хөгждөг. Итгэлцэл бий болгох нь төр засгийн үйл ажиллагаа нь иргэдийн хүлээлтэд нийцсэн, тэдний амьдралын чанарыг дээшлүүлэх боломжийг бүрдүүлэх явдал мөн. (Г.Т)

24 Даваадулам (2010) Засаглал үзэл баримтлал, нэр томьёоны тайлбар толь бичиг

25 Фрэнсис Фукуяма, (2014), Итгэлцэл: нийгмийн буян, хөгжин цэцэглэх зам, х. 37.

23 <https://www.etymonline.com/search?q=trust>

ИХ ЗАСАГ ХУУЛЬ (*Ikh Zasag law*)

XIII-XIV зууны үед Их Монгол улс болон Монголын эзэнт гүрний захиргаанд байсан улс орнуудад дагаж мөрдөж байсан хууль. 1206 онд Чингис хаан Шихихутагт Гүр иргэний хувь хувилсныг, зарга заргалсныг хөх дэвтэрт бичиж, дэвтэрлэж ургийн ургаар хүртэл Шихихутагийн надад этэж, ёсолж хөх бичиг цагаан цаасанд дэвтэрлэснийг бүү егүүтгэтүгэй. Егүүтгэх хүмүүн алдалтан болтугай хэмээн зарлиг болжээ. “Их засаг” хуульд хаан өргөмжлөх, их хуралдайг зарлан хуралдуулах, гадаад улс оронтой харилцах ёс, цэргийн болон иргэний үүрэг, алба татвар, эрүүгийн болон иргэний шинж чанартай олон асуудлыг хэрхэн зохицуулахыг хуульчилсан. “Их засаг” хуулийн зарчим эзэнт гүрний хэмжээнд үйлчилж байжээ. Их засаг хууль өнөөг хүртэл бичмэл байдлаар уламжлагдан ирээгүй боловч бичмэл байсан хэмээн олон судлаач үздэг. Их засаг хуулийн заалтуудыг Рашид ад Диний Судрын чуулган болон тэр үеийн зарим сурвалж Эрэнжин Хара-Даван нар зохиолдоо дурдсан байв. Тухайлбал, Эрэнжин Хара-Даван 80 зүйл жагсаажээ. Орчин үед МУИС-ын эрдэмтэн Б.Баярсайхан, Б.Батбаяр нар Чингис хааны өөрөө тогтоосон 68 зүйл, хожим Өгэдэй хааны нэмсэн 13 гэсэн нийт 81 заалтыг жагсаажээ. (А.Ц)

ИХ ӨГӨГДӨЛ (*Big data*) Тогтсон хугацаанд тогтмол баяждаг, үнэн зөв, үнэ цэнэтэй, олон янз байдалтай ялгамжит их хэмжээний өгөгдлийн бүрдэл. Уламжлалт өгөгдөл боловсруулалтын программ хангамжаар шийдвэрлэх боломжгүй, хэт их хэмжээний эсвэл нарийн төвөгтэй өгөгдлийн бүрдлийг боловсруулах, түүнээс системтэйгээр

мэдээлэл гарган авах, шинжлэх арга юм. Их өгөгдлийн шинжлэл нь өгөгдлийг олж авах, бүтээхээс эхлээд боловсруулах, хайх, түгээх, дамжуулах, шинжлэх, дүрслэн харуулах, хамгаалах зэрэг үйлдлүүд багтдаг. Их өгөгдлийг дараах 5 үндсэн шинж (товчилж 5V гэдэг)-ээр тодорхойлдог. Үүнд:

1. Хэмжээ (Volume) - Хангалттай их хэмжээний өгөгдөл үүсэж, хадгалагдаж байх;
2. Хурд (Velocity) - Тогтсон хугацаанд тогтмол баяждаг байх;
3. Үнэн зөв байдал (Veracity) - Анхдагч үүсвэрээс үнэн бодит өгөгдөл байх. Энэ нь өгөгдлийн чанарыг илэрхийлж их өгөгдлийг боловсруулж, шинжилж гарсан үр дүнгийн найдвартай байдал;
4. Үнэ цэнэ (Value) - Их өгөгдлийн бүрдлийг боловсруулж шинжилсэн үр дүн, мэдээлэл нь өгөөжтэй, үнэ цэнэтэй байх;
5. Олон янз байдал (Variety) - Янз бүрийн үүсвэрээс (мэдрүүл бүхий төхөөрөмж, бүртгэлийн файл, нийгмийн мэдээллийн хэрэгсэл г.м) олон төрлийн (бүтэцлэгдсэн, бүтэцлэгдээгүй, хагас бүтэцлэгдсэн г.м) олон хэлбэрийн (бичвэр, дүрс, дуу, видео г.м) өгөгдөл бүрдсэн байх;

Их өгөгдөл нэр томьёо 1990-ээд оноос өргөн хэрэглэгдсэн бөгөөд технологийн хөгжлийн явцад технологийн үйлдвэрлэгчид их өгөгдөлтэй ажиллах технологийн шийдэл, системийг бий болгож эхэлсэн. Цахим үйлчилгээний төрөл, хэрэглэгчдийн цахим хэрэглээний далайц мөн түүнчлэн юмсын интернет (IoT) технологийн нээсэн ухаалаг төхөөрөмжүүдийн үүсгэсэн өгөгдөл

огцом хурдтай нэмэгдсэнээр асар их өгөгдөл үүсэж байна. Бизнесийн байгууллагууд хэрэглэгчдийн сонирхол, зан төлөвийг тодорхойлж, бараа үйлчилгээний татан авалт болон маркетингийн оновчтой төлөвлөлт, эрсдэлийн шинжилгээнд ашигладаг бол төрийн байгууллагуудын хувьд нөхцөл байдлыг зөв үнэлж, төлөвлөн иргэдэд хүртээмжтэй, шуурхай, ил тод, инновацлаг үйлчилгээг хүргэх боломжийг олгодог. Бизнес шинжилгээ (Business Intelligence) нь “сүүлийн хагас жилд юу болов?”, “хэр их бараа, бүтээгдэхүүн зарагдав?”, “асуудал юунд байна вэ?” г.м асуултад хариулдаг бол Их өгөгдлийн шинжилгээ нь “дараа юу болох вэ?”, “хамгийн оновчтой хувилбар юу вэ?” г.м асуултад хариулж харилцан хамаарал, төлөв байдал болон үр дүнгийн таамаглалыг тодорхойлдог. Их өгөгдлийн шинжилгээнээс ялгаатай. Их өгөгдлийн шинжилгээний төсөл нь асуудлыг тодорхойлох, өгөгдлийг бэлтгэх, загвар боловсруулах, загвар хэрэгжүүлэх, үр дүн боловсруулах, хэрэглээнд нэвтрүүлэх гэсэн үе шаттай хэрэгждэг. (Д.З; Ч.Л нар)

ИХ ШАВИЙН ЗАХИРГАА (*Administration of Ikh Shabi*) 1922 оны 11-р сард Засгийн газраас Их шавийн лам нарын хамжлага захирах тамгыг аливаа бичиг баримтад дарахыг хориглох, улмаар хураах, дурсгал болгон хадгалахыг зөвшөөрөх, шинээр тамга олгохыг хориглох тухай шийдвэр гаргасан байна. Улмаар нутгийн захиргааны нэгэн адилаар Их шавийн захиргааг байгуулж, дүрмийг нь баталжээ. Тус дүрэмд Монгол Улсын нутгийн захиргааны дүрмийн нэгдүгээр зүйлийг баримтлан “арван гэрээс дээш баг, отог, харьяат шавийн яам хүртэл тус тус ардын

төлөөлөгчдийг сонгон хуралдуулж, дэс дараалан хурал байгуулан, элдэв хэрэг зүйлийг шүүмжлэн хэлэлцүүлж, олонхын саналаар таслан тогтоож, ардын эрхийг эрхэмлэн хүндэтгэвээс зохионо” хэмээн заажээ. Хурлуудаас шавь, отог, баг, арван гэрийн дарга сонгох журам тогтоожээ. (А.Ц)

К

КАМЕРАЛИЗМ (*Cameralism*) Төрийн удирдлагын ухаан. Бүх нийтийн оюуны сайн сайхны урьдач нөхцөл болдог тусгаар тогтнол, өөрийгөө хангах боломжийг бүрдүүлдэг мөнгө санхүүгийн нөөцийг хуримтлуулах бодлогыг судална. Уг нэр нь camera буюу төрийн санхүү, хааны мөнгөн хөрөнгийг зарцуулах, хандив, татварын асуудлыг хариуцдаг байгууллагын нэрнээс “Kameralwissenschaften” хэмээх нэртэй үүсэн хөгжиж XVIII зууны эхэн үеэс Европод түүнийг судалдаг тэнхимүүд их сургуулиудад буй болсон байна. Гол төлөв захиргаа, хууль, эдийн засгийн холбогдолтой хичээлүүдийг үздэг байжээ. Камерализм төрийн удирдлага нь чиг үүргийн шинжээр зохион байгуулагдаж байгууллага бүр тодорхой зүйлийг эрхэлдэг байх ёстой гэж үзэж байжээ. Санхүүгийн байгууллагууд гол үүргийг гүйцэтгэнэ. Бүх байгууллагуудад нэгдсэн стандарт бүхий бичиг баримтыг бүртгэх хөдөлгөөнийг нь хянах нэгдмэл журамтай байх ёстой. Камерализмын талаар анх 1656 онд Ф.Л. фон Зекендорф бичсэн байна. Улмаар уг ухааныг хөгжүүлэхэд Й.Бехер, Ф.Герниг, В.Шрёдер, И.Готлиб нар ихээхэн хувь нэмэр оруулсан. Камерализмын нэрт

төлөөлөгчид бол Георг Обрехт (1547—1612), Фейт Людвиг фон Зекендорф (1626—1692), Иоганн Иоахим Бехер (1635—1682), Вильгельм фон Шрлдер (1640—1688), Ганс Карл фон Карловиц (1645—1714), Пауль Якоб Марпергер (1656—1730), Иоахим-Георг Дарьес (1714—1791), Иоганн Генрих Готлиб фон Юсти (1717—1771), Йозеф Зонненфельс (1732—1817) нар. (А.Ц)

КАРЬЕР/ТЭРГҮҮР (*Career*) Хувь хүмүүсийн ажлын туршлага тасралтгүй нэмэгдэх үйл явц¹. Нэр төр, албан тушаал: нийлмэл үгээр карьер өсгөхийг эрэлхийлэх нь албан тушаал хөөцөлдөх, ахих дэвших арга эрэлхийлнэ. Үүнд: 1) ирээдүйн зорилгод хүрэх амжилттай алхмууд нь карьер төрийн албанд албан тушаалын шатлал ахин ажиллах нь тухайн албан хаагчийн карьер нэмэгдэхийг илэрхийлнэ. Энэ утгаараа тухайн хүний үйл ажиллагааны ерөнхий чиглэл болдог. 2) Тухайн хүний эзэмшсэн мэргэжилтэй холбоотойгоор ажил, амьдралын үе шатаар дамжин өгсөх хувь хүний ахиц дэвшилээр карьер тодорхойлогдоно. Аливаа хүн мэргэжлийн ур чадвараа дээшлүүлж, туршлага хуримтлуулах замаар нэр хүнд олох, өсөн нэмэгдэх зүй тогтлыг

¹ Arthur.M.B; Hall.D.T; Lawrence.B.S: Handbook of career theory, Cambridge University Press 1989, p. 8.

карьер гэж тодорхойлно. Үүсэл хөгжил: “карьер” гэдэг үг нь Латины “carrus” гэх үгнээс гаралтай бөгөөд “chariot” гэсэн утгыг илэрхийлдэг. 1803 оноос “карьер”-ийг “олон нийтийн болон ажил, амьдралын явц” гэсэн утга зүйн өргөтгөл гарч ирсэн. Энэхүү чиг хандлагыг Эдийн засагч Ричард Флорида “бүтээлч анги”-ийн дунд явагддаг үйл явц гэж тодруулжээ. (Г.Б)

- Аялалд анхаарлаа төвлөрүүл - Зөвхөн нэг очих газарт анхаарлаа хандуулах хэрэггүй. Карьерын аялал тань амьдралын туршид байх болно гэдгийг хүлээн зөвшөөр. Зам зуурын туршлага бүрийг үнэлж байх
- Өөрийгөө таньж, өөртөө итгэх зарчим - биелэл болох хүсэл эрмэлзэлдээ хөтлөгдөж, өөрийн сонирхлыг карьерын боломжуудтай хослуулах арга замыг олж мэдэх

Эрдэмтэн, судлаачдын үзсэнээр:

Parsons (1909)	Hughes (1958)	Wilensky (1961)
‘Ухаалаг карьер сонголт хийхэд гурван хүчин зүйл байдаг: 1) өөрийнхөө авьяас чадвар, ур чадвар, сонирхол, хүсэл эрмэлзэл, нөөц бололцоо, хязгаарлалт, тэдгээрийн шалтгааныг тодорхой ойлгох; 2) ажлын чиглэлд тавигдах янз бүрийн шаардлага, амжилтын нөхцөл, давуу ба сул тал, боломж, хэтийн төлөвийн талаарх мэдлэг; 3) эдгээр хоёр баримтын харилцан үйлчлэлийн бодит үндэслэлийг тогтоох	‘Субъектив үүднээс карьер нь хүмүүсийн нийгмийн захиалга, албан тушаалын ердийн дэс дараалал, уялдаа холбоог харгалзан чиглүүлж буй хөдөлгөөнт хэтийн төлөв юм.	‘Карьер нь нэр хүндийн шатлалаар зохион байгуулагдсан холбогдох ажлуудын дараалал бөгөөд хүмүүс шат дарааллын дагуу шилждэг.

КАРЬЕР/ТЭРГҮҮР ХӨГЖЛИЙН ЗАРЧИМ (*Career development principle*) Карьер хөгжил нь сурч боловсрох, ажиллах менежментийн насан туршийн үйл явц. Энэхүү үйл явцын зарчмыг карьер хөгжлийн зарчим гэнэ. Карьер хөгжлийн дараах зарчмууд байна. Үүнд:

- Өөрчлөлт тогтмол байх зарчим- Хүрээлэн буй орчин байнга өөрчлөгдөж байгааг хүлээн зөвшөөрнө. Өөрчлөлтөд нээлттэй байж, шинэ боломжуудын талаар сэргэг байх
- Тасралтгүй суралцах зарчим - Хувь хүн байнгын хөгжилд тэмүүлдэг. Шинэ ур чадвар хэзэмших, шинэ авьяас чадвараа хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх

- Гэр бүл, найз нөхөд, зөвлөгч, хамт олон, үе тэнгийнхнийхээ дэмжлэгт найд. Ажил мэргэжлийн амжилт нь багийн хүчин чармайлт байна. (Г.Б)

КАУТИЛЬЯ (*Kautilya-Sanskrit: चाणक्य* *Сайнакья, Чанакья, Вишнугупта, нтө. 283 он орчим*) Эртний Энэтхэгийн төрийн зүтгэлтэн, сэтгэгч тэрээр Нитишастра, Арташастра хэмээх хоёр бүтээлийг туурвисан. Гэхдээ зарим судлаач Арташастра хожим бичигдсэн гэж үзэх нь бий. Каутилья төрийг удирдахад хатуу прагматист байр суурь баримтлах ёстой хэмээн үздэг байжээ. Тэрбээр улс төрийн ашиг хонжоо олохын тулд ёс суртахууны хэм хэмжээ болон хуулийг зөрчиж болох, мөн



Цагдаагийн албыг хөгжүүлэх, матаас, мөрдлөг, худалдан авах зэрэг бохир аргыг хэрэглэх, нууц албыг хөгжүүлэх зэрэг асуудлаар хаанд зөвлөдөг байжээ. Түүнийг Энэтхэгийн Макиавелли гэж нэрлэдэг. (А.Ц)

КЛЕВЕЛАНД, ФРЕДЕРИК АЛЬБЕРТ (Cleveland, Frederick Albert, 1865-1946)

Америкийн эдийн засагч. 1890 онд ДеПоугийн их сургуулийг хуулийн мэргэжлээр төгсөж, Чикаго болон Пенсильванийн их сургуульд эдийн засгаар тусгай сургалтыг төгсжээ. 1903 оноос Нью Йоркийн их сургуульд профессороор ажиллажээ. Олон байгууллагад эдийн засгийн шинжээчээр ажиллаж байсны дотор Ерөнхийлөгч Тафтын үндэсний төсвийн талаар санал дэвшүүлэх үүрэг бүхий эдийн засаг, үр ашгийн комисст ажиллаж байв. 1911 онд Хотын судалгааны товчооны захирал, 1919 оноос Бостоны их сургуулийн профессороор ажилласан байна. Тэр ардчиллын институтүүд нь бизнесийн институтүүдийн тулгуурлагад тэр л зарчмууд дээр бараг адилхан суурилдаг хэмээн үзэж байжээ. Тэрбээр гадна талаас сонгогчид хяналт тавьж, дээрээс нь сонгогдсон төлөөлөгчид нийтийн хүсэл зоригийг илэрхийлсэн хууль гаргаж байгаа нөхцөлд захиргаа нь улс төрд оролцдоггүй, тэр хүсэл зоригийг хэрэгжүүлдэг мэргэжлийн алба байх ёстой хэмээн үзэж байжээ. Тэрээр ардчилал, захиргааны үйл ажиллагааны зарчим, төрийн санхүүтэй холбоотой томоохон бүтээлүүдийг (*Growth of Democracy in the United States, 1898; Funds and their Uses, 1902; The Bank and the Treasury, 1905; Chapters on Municipal Administration and Accounting, 1909; Organized Democracy, 1913; Railroad Capitalization and Promotion, with Fred*

Wilbur Powell, 1908; Railroad Finance, with Fred Wilbur Powell, 1912; American Citizenship, 1927; Modern Scientific Knowledge, 1929;) туурвисан. (А.Ц)

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ (Corporate governance)

“Corporate” нь Латины “corporatus (XV зуун)” гэх үгнээс үндэстэй. Үгийн утга нь “нэг байгууллагад нэгдэх, хийх, загварчлах, корпорацийн гишүүн” гэсэн санааг илэрхийлдэг. 1600 оноос “Аж ахуйн нэгж байгууллага” утгаар хэрэглэгдэх болжээ.² “Corporate governance”-г монгол хэлнээ компанийн засаглал гэж орчуулан хэрэглэдэг. Компанийн засаглал нь компанийг удирдан чиглүүлэх, хянах тогтолцоо (Corporate governance is the system by which companies are directed and controlled).³ Компанийн засаглал нь компанийн хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, бизнесийн санхүүгийн чадавхыг хангах зорилго бүхий компанийн бизнесийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэг бүхий бүтэц, үйл ажиллагаа. Үүнд мөн компанийн үйл ажиллагаанд оролцогч талууд (хувьцаа эзэмшигчид, компанийн удирдлага, удирдах зөвлөл, бусад оролцогчдод ажиллагч, хэрэглэгч, зээлүүлэгч, нийлүүлэгч, зохицуулагч гэх мэт)-ын харилцааг хамааруулан ойлгодог. Компанийн сайн засаглалын гол элементэд үнэнч шударга байх, итгэлцэл, шударга, нээлттэй байдал, үр дүнд чиглүүлэх, хариуцлага ба хариуцан тайлагнах, харилцан бие биеэ хүндэтгэх, байгууллагадаа үнэнч байх зарчмууд багтдаг⁴ утгаараа

2 Corporate (adj.). (n.d.). Retrieved October 27, 2020, from <https://www.etymonline.com/word/corporate>

3 Corporate Governance - Overview, Principles, Importance. (2020, April 29). Retrieved from <https://corporatefinanceinstitute.com/resources/knowledge/other/corporate-governance/>

4 Даваадулам (2010) Засаглал үзэл баримтлал, нэр томьёоны тайлбар толь бичиг: Улаанбаатар.

төрийн захиргааны шинэчлэлийн хүрээнд засаглалын чухал үзэл санаа болон төрийн удирдлагад нэвтэрсэн байдаг. (Т.Т)

КОНСЕРВАТИЗМ (*Conservatism*)

Латин хэлний "com+servare" үгнээс гаралтай "хадгалах, хамгаалах" гэсэн утгатай Франц үг юм. Францын хувьсгалаас үүдэлтэй нийгмийн уламжлалт сэтгэлгээнд тулгуурласан XVIII зууны сүүлээр бий болсон үзэл суртал. Английн сэтгэгч Эдмунд Беркийн “Франц дахь хувьсгалын тухай эргэцүүлэл” бүтээлд консерватизмийн суурь үзэл санаа, баримтлалуудыг боловсруулсан. Өрнөдийн шинэ үеийн түүхэнд нийгмийн дэвшилд нөлөөлж ирсэн үзэл сурталын нэг гол урсгал бол консерватизм юм. Нийгэмд тогтсон харилцаа нь нийгмийн амьдрал, оршин тогтнолыг хангаж чадаж байгаа бол түүнийг өөрчлөх тэр тусмаа үндсээр нь бүрэн өөрчлөгдөхийн эсрэг чиглэсэн үзэл санааг консерватизм гэдэг. Консерватизм нь Их Британи Швейцарт бол гарч болох өөрчлөлт нь нийгэмд тогтсон хэм хэмжээ, ёс суртахуун, соёл, шашны уламжлалт хэв заншлыг хөндөхгүйгээр амьдралын жамаараа хэрэгждэг байх ёстой гэж үздэг. Мод ургаж байгаатай адил нийгэм өөрөө хөгжих учиртай хэмээн үзэл санаагаа зүйрлэн тайлбарладаг. Консерватизмын суурь үзэл санаа: хүмүүс хоорондоо байгалийн жам ёсоор ялгаатай, өөр боловч тэдгээрийн тэгш байдал бол зайлшгүй зүйл, нийгмийн зохион байгуулалт энэ ялгаа болон тэгш байдалд зохицсон нийцүүлэх хэлбэрээр оршин тогтнох ёстой, хүмүүс уг зохион байгуулалтад захирагдаж, улмаар нийгмийн уламжлалт байдал хадгалагдах зэрэг болно. Дээрх үзэл санаанд

тулгуурлан хүчтэй төр, нийгмийн дэг журам, уламжлалт элитийн үүргийг онцгойлон авч үздэг. Консерватизм нь хүн бүр өөрт ногдсон, хагуу чанд тогтоогдсон байраа эзэлдэг нийгмийн шаталсан бүтэц, чөлөөт зах зээл, чөлөөт өрсөлдөөн, хувь хүний эрс тэс өөрчлөлтийн боломж гэхээсээ илүү жам ёсны өөрчлөлтөд итгэдэг байна. Консерватизмийн гол үнэт зүйлс нь эмх журам, тогтвортой байдал, уламжлалын үзэл санаа бөгөөд нийгэм өөрийн жам ёсны зүй тогтлоороо хөгждөг гэж үздэг. (Я.Т)

КОНЦЕСС (*Concess*) Төрийн, эсхүл орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэх зорилгоор тодорхой нөхцөл, журмын дагуу гэрээний үндсэн дээр эзэмших, ашиглах, шинээр бий болгох, шинэчлэн сайжруулах онцгой эрхийг⁵ эхлэнэ. Монгол Улсын хувьд концесс нь “Барих - ашиглах-шилжүүлэх”, “Барих - шилжүүлэх”, “Барих - өмчлөх - ашиглах”, “Барих - өмчлөх - ашиглах - шилжүүлэх”, “Барих - түрээслэх - шилжүүлэх”, “Зураг төсөл боловсруулах - барих - санхүүжүүлэх - ашиглах”, “Шинэчлэн сайжруулах - ашиглах - шилжүүлэх” гэсэн төрлүүдтэй. (А.Э)

КРИПТОГРАФ (*Cryptography*) Харилцаа холбоон дахь мэдээллийг нууцлах арга хэрэгсэл. Криптограф нь *cryptus* (далдалсан, нууц)+*graphein*(бичих) гэсэн эртний грек үгнээс гаралтай. Криптограф нь өгөгдлийн утгат агуулгыг нуух эсвэл тэдгээрийг зөвшөөрөлгүй ашиглах болон тэдгээрийн мэдэгдээгүй өөрчлөлтөөс сэргийлэх зорилгоор мэдээллийг түлхүүр код бүхий нууцлах алгоритмаар хувиргах зориулалттай.

5 Концессын тухай хууль

Ингэснээр кодыг тайлах алгоритмыг мэдэхгүйгээр хэн ч мэдээллийг унших боломжгүй болно. Орчин үеийн криптограф нь математик, компьютерын ухаан, электроник, харилцаа холбооны технологи болон физик зэрэг олон салбар дундын огтлолцолд оршдог. Криптографыг цахим худалдаа, чиптэй төлбөрийн карт, дижитал валют, компьютерын нууц үг болон цэргийн холбоонд өргөн хэрэглэдэг. Төрийн үйл ажиллагаанд криптографыг өргөн хэрэглэдэг бөгөөд түүнийг зөвшөөрөлгүй тайлж мэдээлэлд нэвтрэх эрсдэлээс хамгаалах шаардлага тавигддаг. (Д.З; Ч.Л нар)

КСЕНОФОБИ (*Xenophobia*) “Xenos+phobos” гэсэн Грек үгнээс гаралтай, XIX зууны сүүлээр англи хэлэнд “харийн буюу гадаад хүнээс айн, жийрхэх” гэсэн утга агуулж байв. Гаднынхныг дайсагнах, тэднийг үзэн ядах, ялгаварлан гадуурхах үзлийг хэлнэ. Ксенофоб соёлын үүднээс: хүний бүхий л үйлдэл нь өмнөх үеүдээсээ өвлөн авсан ойлголт хандлагын үргэлжлэл. Энэ нь нутгийн уугуул эзэн гэх хэт хуучинсаг сэтгэлгээ ба хатуу чанга дэг жаягт баригдсан уламжлалт сэтгэлгээнд суурилсан нийгэм шинээр шилжин ирж буй иргэдийг хардаж сэрдэх, болгоомжлох, тэдэнд дургүйцэх байдлаар хандахад хүргэдэг. Шашин шүтлэг нь мөн харийнханд хандах энэхүү дайсагнасан хандлагад хүчтэй нөлөөтэй. Ксенофоби нь тухайлбал, дараах байдлаар илэрдэг: Германофоби (германтай холбоотой бүхнийг үзэн ядах), хомофоби (ижил хүйстний харьцааг жигшин, түүнээс хэт айх), изамофоби (лалын шашинтнуудаас айх), антисемитизм (еврей нарыг үзэн ядах үзэл гэх мэт). (Я.Т)

КҮНЗ (*Confucius, 孔子*; нмө. 551 - нмө. 479) Цюйфу хэмээх газар 63 настай цэргийн эрх дархтан Шулян, түүний 17 настай бага эхнэр Янь Чэньцзай нарын гэр бүлд төржээ. Нэг настай байхад нь эцэг нь өөд болж, эцгийн бусад эхнэрүүдийн хавчлагаас болж, эхийн хамт эцгийн гэрээс явсан байна. Ядуу зүүдүүгээсээ болж бага насандаа их ажилладаг байжээ. Түүний зэрэгцээ бие даан суралцаж эхэлжээ. Хичээл зүтгэл нь амжилтад хүрч, залуу наснаас эхлэн үр тариа, мал сүрэг хариуцдаг түшмэл зэрэг ажил хийж байжээ. Чжоугийн хаант улсын хямралын үеэр ажлаасаа гарч, шавь нарын хамтаар Хятад орноор хэсүүчлэн үзэл санаагаа янз бүрийн мужуудын эздэд танилцуулж явжээ. Жаран насандаа нутагтаа буцан иржээ. Тэр үедээ Шүлэглэлт ном болон хувьслын ном зэрэг дээр үеийн утга зохиолын өвийг сэргээн системчилсэн байна. Күнзийн сургаал нь нийгмийн философи болон ёс зүйн чиглэлтэй. Шавь нар нь багшийнхаа яриа, сургаалыг эмхтгэн “Лунь Юй” буюу “шүүмжлэлт өгүүлэл”-ийг бичиж үлдээжээ. Сонгодог зохиолуудаас “Хавар, намар”, “Лу мужийн нтө. 722-481 оны он дарааллын бичиг” зэргийг Күнзийн жинхэнэ өөрийн бүтээл гэж үздэг ажээ. Күнзийн сургаалыг заримдаа шашин хэмээн үздэг боловч шашин биш юм. Түүний үзэл санааны гол агуулга нь хүн бүр өөрийн үүрэгтэй байдаг төгс нийгмийг эртний загвараар байгуулахад чиглэж байжээ. Төгс нийгэм нь захирагч ба захирагдагчийн үнэнч харилцаанд тулгуурлах ёстой ажээ. Күнзийн үзэл санаа Хятад ба зүүн Азийн улс түмнүүдэд ихээхэн нөлөөтэй байж, орчин үед дэлхийн бусад орны хүмүүсийн анхаарлыг татах болжээ. . (А.Ц)

Л

ЛАБАНД, ПАУЛ (*Laband, Paul, 1838-1918*) Германы хуульч. Кенисберг, Страсбургийн их сургуульд төр, эрх зүйн багшаар ажиллаж байв. 1886 онд Ф. Штёрктой хамтран «Archiv für öffentliches Recht» хэмээх сэтгүүлийг үндэслэсэн байна. П.Лабанд төр бол эрх зүйн субъект, хуулийн этгээд хэмээн үздэг төр судлалын чиглэлийн гол төлөөлөгчдийн нэг юм. Төр бол түүний гишүүдээс ялгаатай хүсэл зориг, үйл ажиллагаатай бие даасан субъект ажээ. Тэрбээр “Швабын толь”, “Магдебургийн эрх” хэмээх дундад зууны эрх зүйг судалж, хэвлүүлсэн нь одоо ч ач холбогдолтой хэмээн үздэг байна. П.Лабанд холбооны улсын тухай асуудлыг хөндөх явцдаа өөрөө удирдах ёсны тухай асуудлыг хөндөж холбооны төв засгийн газар зарим салбарт бүрэн эрхтэй байх бол зарим салбарт түүнийг бүрдүүлэгч субъектүүд бие даасан байдалтай байна хэмээн үзэж байжээ. Р.Гнейст өөрөө удирдах ёсны мөн чанар нь төрд хүндэтгэлтэй хандаж, эргэлт буцалтгүй үйлчлэхэд оршино хэмээн үзэж байсан бол П. Лабанд төр зарим эрхээ тусдаа өөрийн гэсэн эрх зүйн байдал бүхий доод талын субъектүүдээрээ дамжуулан хэрэгжүүлнэ хэмээн үзэж байжээ. Түүнийг Р. Гнейстын нэгэн адил өөрөө удирдах ёсны анхны онолчдын нэг хэмээн үздэг. (А.Ц)

ЛЕВИТАН, ДЕВИД М. (*Levitan, David M.1915-2011*) Литвад төрж, 12 насандаа Америкт ирсэн байна. Нордвестерн их сургуульд сурч, Чикагогийн их сургуульд докторын зэрэг хамгаалжээ. Төрийн олон байгууллагад зөвлөхөөр ажиллаж Чикаго, Колумбын их сургуульд багшилж байжээ. Тэрбээр ардчилсан улсад төр нь ардчилсан зарчимд суурилах төдийгүй, нийгмийг ардчилсан ёсоор удирдах ёстой, ардчиллын философи нь түүний захиргаанаас ч үнэртэж байх ёстой хэмээн үзэж байжээ. Энэ үзлээ 1942 онд бичсэн “Улс төрийн зорилго ба захиргааны арга хэрэгсэл” (Political Ends and Administrative Means) хэмээх өгүүлэлдээ дэвшүүлжээ. (А.Ц)

ЛИБЕРАЛИЗМ (*Liberalism*) Либерализм нь “liber” эрх чөлөө гэсэн утгатай латин гаралтай үг. Улс төр, нийгмийн үйл явцад маш олон утгатай хэрэглэгдэж ирсэн. Либерал онолын үүсэл хөгжил нь Английн Ж.Локк, Т.Гоббс, сонгодог эдийн засагч А.Смит зэрэг эрдэмтэдтэй холбоотой. 1776 онд Адам Смитийн “Үндэстнүүдийн баялаг” ном хэвлэгдсэн нь эдийн засгийн либерал онолын үндсийг тавихад чухал үүрэг гүйцэтгэсэн юм. А.Смит өөрийн энэхүү бүтээлдээ чөлөөт зах зээлийн гөл зарчмыг дэвшүүлсэн. Уг бүтээлд хөдөлмөрийн

хуваарь, мөнгөний үүсэл, хэрэглээ, хөдөлмөрийн хөлс, хөрөнгөнд ногдох ашгийн тухай, газрын рент болон капитал, түүний хуримтлал, хэрэглээний мөн чанарын тухай авч үзсэн. Либералчууд хувь хүний эрх чөлөөг хангах үндэс бол хувийн өмч болон чөлөөт өрсөлдөөний эрх чөлөөг хүлээн зөвшөөрч уг эрхийг хуулиар хамгаалах явдал чухал гэж үздэг. Либерал ардчилсан үзэл баримтлалд хүний эрх, эрх чөлөө, өөрийн амьдрал, бусад хүмүүстэй харилцах дүрмээ тодорхойлох ёс суртахууны бие даасан байдал чухал гэж үздэг. Иймд уг үзэл санаа нь бие даасан хувь хүний ойлголтод үндэслэж, нийгэм нь чөлөөт хувь хүмүүсийн нийлбэр, нийгмийн сонирхол нь бүхний нийтлэг сонирхол гэж тайлбарладаг. Либерал үзлийн хувьд хувь хүний амьдрал нь нийгмийнхээс, эрх нь нийтийн эрх ашгаас дээгүүрт тавигддаг билээ. Либерал ойлголтоор хүмүүсийн эдийн засгийн үйл ажиллагаа, тэдний өөрсдийнх нь үйл хэрэг байж, хувь хүн аж ахуйн үйл ажиллагаа явуулахдаа хэнээс ч үл хамаарах ёстой хэмээн гол зарчмаа тайлбарладаг. Бүхэлдээ либерализм нь хувь хүний жам ёсны хэрэгцээнээс үүдэлтэй улс төр, эдийн засгийн эрхүүдийг шүтсэн нийгмийн амьдралын оюун ухаан, ёс суртахууны зохион байгуулалтын үзэл санаанд тулгуурлана. Хүний жам ёсны эрх болон иргэний эрхийг тунхаглан хамгаалж, хууль ёсыг дээдлэн тогтоох явдлыг чухалчлан үздэг бөгөөд хувь хүний эдийн засгийн эрх чөлөө, зах зээлийн харилцаа бол тэдний улс төрийн эрх, эрх чөлөөг хангаж, нийгмийн ардчилсан тогтолцоо байгуулах баталгаа болно гэж либерализм номлодог байна. Либерализмын тулгуур үзэл санаа нь: -Хувь хүн өөрөө туйлын үнэт зүйл, тэгш байдлын үндэс болно.

Тодруулбал, хүн бүр харилцан адилгүй чадвартай байдаг. Гэхдээ ёс суртахууны хувьд хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй;

- Бодгаль хүний юунаас ч үл хамаарах хүсэл зориг, бие даасан байдал чухал тул хүмүүсийн итгэл үнэмшил, хүсэл сонирхолд хүндэтгэлтэй хандаж, хүлээн зөвшөөрөх;
- Хувь хүний эрх чөлөө, өмчтэй байх зэрэг нь салшгүй, жам ёсны эрх болно;
- Хүний жам ёсны эрхийг хамгаалах нь төрийн цорын ганц үүрэг;
- Хувь хүн ба төрийн хоорондын харилцаа гэрээ хэлцэлд тулгуурлана;
- Төрийн эрх мэдэл хязгаарлагдмал шинжтэй байна;
- Хууль нийгмийн харилцааг давамгайлан зохицуулна гэсэн үзэл санаануудыг баримталдаг үзэл суртал юм. (Я.Т)

ЛИЦЕНЗ (Licence) Дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу лиценз олгож явуулбал зохих үйл ажиллагааны төрлийг (жишээ нь банк, хуулийн эмнэлэг, хэвлэлийн үйл ажиллагаа зэрэг) хэрэгжүүлэхэд бүрэн эрх бүхий төрийн захиргааны буюу нутгийн удирдлагын байгууллагаас тусгайлан олгодог зөвшөөрөл. Патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, гэрчилгээ бүхий ашигтай загварыг бусад этгээдэд ашиглуулах болзолтой өгч байгаа зөвшөөрөл. Лицензийг энгийн, онцгой эрхийн ба иж бүрэн гэж ангилдаг (Патентын туухай хуулийн 3.1.13). Онцгой лиценз гэж патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, гэрчилгээ бүхий ашигтай загварыг патент, гэрчилгээ эзэмшигч нь гуравдагч

этгээдэд нэгэн зэрэг ашиглуулахгүй байх болзолтой, гэрээний үндсэн дээр бусдад ашиглуулах зөвшөөрлийг; албадан лиценз гэж үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, хүн амын хүнсний хангамж, эрүүлийг хамгаалах зэрэг нийгмийн зайлшгүй хэрэгцээ болон хуульд заасан бусад нөхцөлийн дагуу зохиогч буюу эрх эзэмшигчид зохих төлбөр төлж төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг бусад этгээдэд ашиглуулах зөвшөөрлийг тус тус хэлнэ (Патентын туухай хуулийн 3.1.14, 3.1.15). (Ч.Э)

ЛОББИДОХ (*ятган ухуулах*) (*Lobbying*)

Лоббидох нь хувь хүн, бүлэг, байгууллагын зүгээс засгийн газрын одоогийн бодлогод нөлөөлөх, эсвэл ирээдүйн бодлогыг бүрдүүлэх боломжтой нөхцөлийг бий болгох харилцаа юм. Лоббидох нь ардчилсан болон дарангуй дэглэмийн (авторитар, тоталитар) аль алинд нь түгээмэл байдаг улс төрийн үзэгдэл болно. Лобби нь анх хууль тогтоох хурлын гадна үүдний өрөөнд хууль тогтоогчдыг саналд нөлөөдүүлэх зорилгоор тэдэнтэй уулздаг байсан явдлыг хэлдэг байв. Лобби нь аливаа улс төрийн тогтолцоонд зайлшгүй гардаг үзэгдэл ажээ. 1950-иад оны үед лоббиг зөвхөн АНУ-д байдаг үзэгдэл гэж судлаачид үздэг байсан бөгөөд Их Британи, Франц, Германд лобби бүлэг, сонирхлын бүлэг, шахалтын бүлэг зэрэг ойлголтыг хэрэглэдэггүй байв. Энэхүү ойлголтыг Латин Америк, Африк, Азийн орнуудад одоо ч түгээмэл хэрэглэдэггүй хэвээр байна. Лоббиг өргөн хүрээтэй судалсан боловч түүний тухай ямар нэгэн ерөнхий онол гараагүй байна. Лобби явагдах орчин нөхцөл нь улс төрийн олон ургалч байдлын

түвшин, авторитаризм, засгийн газрын бүтэц нь төвлөрсөн, эсвэл төвлөрсөн бус эсэх, мөн улс төрийн соёлтой холбоотой. Лоббидох үйл явц нь гурван үе шатнаас бүрдэнэ. Үүнд: 1) шийдвэр гаргах хүн, бүлэг хүмүүстэй холбоо тогтоох арга замыг олох, 2) тухайн хүмүүстэй харилцаа холбоо тогтоож уулзах, 3) тэдэнд нөлөөлөх, эрх мэдлийг ашиглах явдал юм. Эртний Грек, Ром, Дундад зууны хэмжээгүй эрхт хаант засаглал, ЗСБНХУ, орчин үеийн АНУ, Ази, Африкийн аль ч улс, хамгийн дарангуй дэглэмтэй Хойд Солонгост хүртэл лоббидох энэхүү гурван үе шат ямар нэгэн байдлаар явагддаг байна. АНУ-д лобби сайн хөгжсөн нь түүнийг албан ёсоор Үндсэн хууль болон бусад эрх зүйн баримт бичгүүдэд хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой. Лобби хийдэг хүнийг лоббист гэх бөгөөд хувь хүн, хамт олон, бүлгийн ашиг сонирхлыг төлөөлж ажилладаг. Лоббист нь төрийн албан хаагчид, улс төрчидтэй шууд холбогддог, төрийн үйл ажиллагаа, улс төрийн орчинг байнга ажигладаг, улс төрийн стратеги, тактикийн талаар зөвлөгөө өгдөг, лоббидох ажлыг боловсруулж, зохион байгуулах үүрэгтэй. Лобби нь хүн төрөлхтний түүхийн явцад ямар нэгэн байдлаар оршиж байсан ч ардчиллын гурав дахь давлагаа, даяаршлын нөлөөгөөр 1980-аад оны дунд үеэс эрчимтэй хөгжсөн байна. (Ж.Ж)

ЛОКК, ЖОН (*Locke, John, 1632-1704*) Английн философич, сурган хүмүүжүүлэгч, Эмпирист болон либераль философийн төлөөлөгч. 1646 онд Вестминстерийн сургуульд орж, улмаар шилдэг сурагч тул 1652 онд Оксфордын их сургуульд элссэн байна. Тус сургуулийг 1656 онд бакалавр, 1658 онд магистрын зэрэгтэй

төгсөж 1667 онд Лорд Эшлийн (хожмын Шефтсбери гүн) гэр бүлийн эмч, хүүгийн нь хүмүүжүүлэгч болсон. 1668 онд Хааны нийгэмлэгийн гишүүн, 1669 онд түүний зөвлөлийн гишүүнээр сонгогджээ. 1672-1679 онуудад Английн төрийн дээд байгууллагуудад янз бүрийн алба хааж байв. Локк философи, сурган хүмүүжүүлэх ухаан, танин мэдэхүйн онол, улс төр судлалын салбарт хамаарах бүтээлүүд туурвижээ. Түүний бүтээлийг хожмын их сэтгэгчид Д. Юм, И. Кант нар өндөр үнэлсэн. Локк төрийн үүслийн тухай гэрээний онолыг үндэслэгчдийн нэг. Төр нь хүний амь нас, эрх чөлөө, өмч зэрэг жам ёсны эрхийг хамгаалахын тулд л үүссэн хэмээн үзэж байв. Тиймээс төр нь хүний эрх чөлөөг хамгаалах зарчимд үндэслэн байгуулагдах ёстой ажээ. Хэдийгээр үндсэн хуульт хаант засгийн үзэл санааг дэмждэг байсан ч, хаанд тайлагнадаг иргэний эрх зүйт нийгмийн тухай онолч юм. Тэрбээр төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, холбооны хэмээн хуваарилах санал дэвшүүлж байв. Локк ардчилсан хувьсгалын онолыг боловсруулж дарангуйлагчдын эсрэг босох ард түмний эрхийг онолын талаар үндэслэн, ямар нэг шашны давуу эрхтэй байхыг эсэргүүцэхийн зэрэгцээ сүм хийдийг төрөөс тусгаарлах нь зүйтэй гэж байв. Шашны хувьд ямар ч шашинд тэвчээртэй хандах зарчмыг сурталчилж байжээ. Тэрээр дээр дурдсан асуудлуудаар олон зохиол (1689. A Letter Concerning Toleration; 1690. A Second Letter Concerning Toleration; 1692. A Third Letter for Toleration; 1689/90. Two Treatises of Government; 1689/90. An Essay Concerning Human Understanding; 1691. Some Considerations on the consequences of the Lowering of Interest

and the Raising of the Value of Money; 1693. Some Thoughts Concerning Education; 1695. The Reasonableness of Christianity, as Delivered in the Scriptures; 1695. A Vindication of the Reasonableness of Christianity) бичсэн нь ач холбогдолтой хэвээр байна. (А.Ц)

М

МАЖОРИТАР ТОГТОЛЦОО (*Majority system*) Олонхын саналаар сонгох буюу мажоритар тогтолцоо нь ихэвчлэн нэг мандаттай тойргоор сонгууль явагддаг онцлогтой. Энэ тогтолцоо нь дотроо *харьцангуй олонхын, энгийн олонхын, дийлэнх олонхын* саналаар гэсэн гурван хувилбартай.

-*Харьцангуй олонхын*-сонгуульд оролцсон нэр дэвшигчдээс хамгийн их санал авсан нь ялалт байгуулдаг.

-*Энгийн олонхын*-нэр дэвшигчдээс 50-иас дээш хувийн санал авсан байхыг шаарддаг. Энэ болзлыг аль нэг өрсөлдөгч хангаагүй тохиолдолд 2 дахь шатны сонголтыг дахин явуулна. Эхний шатны сонгуульд хамгийн их санал авсан хоёр нэр дэвшигч дараагийн шатны сонгуульд оролцдог зарчимтай.

-*Дийлэнх олонхын*-нэр дэвшигчдээс 60-аас дээш хувийн санал авсан байхыг шаарддаг. Энэ хувилбар практикт төдийлөн хэрэглэгддэггүй.

Сонгуулийн тогтолцоо бүр давуу ба сул талтай. Мажоритар тогтолцооны хувьд сонгуулийн үр дүн нь шууд гардаг, иргэдэд ойлгомжтой, засгийн газар тогтвортой ажиллах нөхцөл бүрдэх боломжтой зэрэг давуу

талуудтай. Харин нэр дэвшигчдээс хамгийн их саналаар ялалт байгуулах зарчим нь иргэдийн санал гээгдэх, саналын зөрүүтэй ялалт байгуулах, үүнээс болж олон тооны сонгогчид төлөөлөлгүй үлдэх зэрэг сул талуудтай. Мөн сонгуулийн тогтолцооны үр дүнд намын тогтолцооны төлөвшил, төрийн эрх барих байгууллагуудад өрсөлдөх чадвар шууд хамааралтай. (Я.Т)

МАНДАТ/ХУУЛЬ ЁСНЫ ТӨЛӨӨЛӨХ ЭРХИЙН БАТАЛГАА (*Mandate*)

“Mandate” нь Латин хэлний “mandatum” буюу “комисс, тушаал” үгнээс гаралтай. Хожмоо үгийн утга нь “захиалга, үүрэг хүлээх” гэж тайлбарлагдах болсон. Энэ нь хэн нэгэнд ямар нэг зүйлийг хийх эрх, зөвшөөрөл өгөх үйл явцтай холбоотой. Өөрөөр хэлбэл, нэг хүн нөгөөд өөрийг нь төлөөлөх, түүний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрх олгох үйлдэл (төлөөлөх эрх). Улс төрийн шинжлэх ухаанд “ард иргэдийг төлөөлөх” гэх утгаар 1796 оноос эхлэн хэрэглэсэн.¹ Улс төрийн хувьд мандат нь сонгогчдоос улс төрчдөд олгосон эрх юм. Сонгуулийн үр дүнд, үнэмлэхүй ялалт байгуулсан нөхцөлд шинээр сонгогдсон засгийн

¹ Mandate: Search Online Etymology Dictionary. Retrieved from <https://www.etymonline.com/search?q=mandate>

газар, сонгогдсон төлөөлөгчдөд тодорхой бодлого хэрэгжүүлэх мандаттай болсон гэж үздэг. Мөн засгийн газрын үйл ажиллагааны сонгуулийн хоорондох хугацааг мандат (эрх барих)-ын хугацаа гэх буюу тухайн засгийн газар шинээр сонгууль зарласан тохиолдолд “шинэ мандат” шаардлагатай боллоо хэмээн ярьдаг.² Гэхдээ бодлого боловсруулж, хэрэгжүүлэх эрх авч байгаа нь түүний дагасан үүрэг хариуцлагыг шаарддаг. Эрх зүйн хэрэглээнд мандат гэдгийг төлөөлөгчийн хууль ёсны гэдгийг баталсан баримт бичгийг ойлгодог. Мандат нь парламентын гишүүний бүрэн эрх, үүргийг хуулиар тодорхойлсны баталгаа болдог. Тухайлбал, ардчилсан орнуудад парламентын гишүүний мандатад тэдний халдашгүй эрх, үйл ажиллагааныхаа төлөө авах хангамж, сонгогчидтой харьцах харилцаанууд баталгаажсан байдаг. Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурлын гишүүн нь ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална хэмээх санааг тусгасан. (Т.Т; Я.Т нар)

МАНЛАЙЛАЛ (*leadership*) Leadership үгийг манлайлал, манлайлах шинж гэсэн утгаар орчуулж хэрэглэдэг боловч эх хэлийг нь байгаагаар нь ашиглах нь элбэг. Манлайллын сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухаан, удирдах ур чадвар, хүний зан үйл зэрэг олон сонирхолтой сэдвийг хамарсан судлагдахуун. Хүн-зорилго-нөлөөлөл гэсэн гурван зүйлийн хүрээнд манлайлагч-дагалдагч хоёрын хоорондын харилцаа, харилцан үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх замаар манлайллын асуудлыг илүү гүнзгий ойлгох боломжтой юм. Гэхдээ

манлайллын тодорхойлолтуудын нийтлэг шинжүүдийг нэгтгэн үзвэл манлайлал нь “манлайлагч болоод түүний дагагчдын сэдэл, хэрэгцээ, хүсэл, итгэл найдвар, сэтгэл ханамжтай байдал буюу хүсэн хүлээж буй үр дүн зэргийг төлөөлсөн зорилго, зорилтуудыг хангахад манлайлагчийн зүгээс дагагчдын үйл ажиллагаанд нөлөөлөх хүний нийтлэг үйлдэл юм” гэж тодорхойлж болно. Энэ тодорхойлолтын хувьд хүмүүсийг “зорилго - хамтын ажиллагаа” манлайлахад хүргэдэг ‘ур чадвар, нөлөө’ нь албадлагаар биш харин сайн дураараа хийхэд түлхэц болдог. Манлайлагч дагагчаа өөрийн хүсэж буй арга замаар ажиллах хэмжээнд хүртэл нөлөөлөхийн тулд зорилго, сэдэл, эрхэмлэн дээдлэх зүйлсийг нь дагаж мөрдөхийг уриалдаг. Энэ уриалгыг дагагчид хүлээн зөвшөөрснөөр тэдний хооронд харилцан ашигтай харилцаа бий болж, манлайлагч, дагагч нар аливаа үйл ажиллагаанд хамтран оролцож эхэлдэг. Манлайлал нь зорилго, чиглэл бүхий болгох, итгэл үнэмшил, хүсэл сонирхлыг төрүүлж хүлээн зөвшөөрүүлэх, эрч хүчийг бий болгох, бүтээлч санаачилгыг дэмжих, хамгийн чухал нь итгэлцлийг бий болгон, хадгалахад оршино. Тиймээс манлайлал нь албан тушаалд тулгуурлан байгууллага дахь хүмүүсийг албадан захирдаг дарга буюу менежер (*headship*)-ээс ялгаатай байдаг. (Ц.Д; Г.Б нар)

МАРКС, КАРЛ ХАЙНРИХ (*Karl Heinrich Marx, 1818-1883*) Германы философич, улс төрийн эдийн засагч, коммунист үзэл санааг үндэслэгч. Карл Маркс, Макс Вебер, Зигмунд Фройд зэрэг цөхөн хүнийг орчин үеийн нийгмийн шинжлэх ухааны арга зүй, үзэл санааны суурийг тавьсан

2 Даваадулам (2010) Засаглал үзэл баримтлал, нэр томьёоны тайлбар толь бичиг. Улаанбаатар.

сэтгэгчид хэмээн үздэг. Маркс Бонн, Берлиний их сургуульд суралцан хуулийн болон эдийн засгийн боловсрол эзэмшжээ. Гегелийн философийн нөлөөлөл дор философи, эрхийн судалгаа хийж, “Демократ ба Эпикурын натурфилософийн ялгаа” сэдвээр 1841 онд Иенийн их сургуульд философийн ухааны докторын зэрэг хамгаалжээ. Тухайн үеийн Пруссийн хаант засаглалтай үзэл санааны зөрөлдөөнтэй байсан болохоор их сургуульд багшлах сонирхлоо орхиж, чөлөөт сэтгүүлчийн ажлыг дагнан эрхлэх болжээ. К.Маркс 1847 онд Шударгачуудын холбоонд (хожим нь Коммунистуудын холбоо болсон) Энгельсийн хамт гишүүнээр элсэж, 1848 онд Коммунистуудын төв хороог удирдаж байсан бөгөөд тэр үед алдарт “Коммунист намын тунхаг”-ийг Энгельстэй хамтарч зохиосон. 1864 онд “Олон улсын ажилчдын нөхөрлөл” буюу Нэгдүгээр Интернационалыг байгуулахад идэвхтэй оролдож, удирдагч нь байв. Нэгдүгээр интернационалын “Зохион байгуулалтын тунхаг”, “Түр дүрэм” зэрэг олон баримт бичгийг боловсруулжээ. 1949 онд хоёр дахь эх орон болох Англид суурьшин насан эцэс болтлоо амьдарчээ. Маркс: шинжлэх ухааны олон салбарт хамаарах сэдвээр олон бүтээл туурвисны дотор хамгийн алдартай нь капиталист нийгмийг бүхэлд нь шинжилсэн “Капитал” зохиол юм. Тэрбээр капитализм мөхөж коммунизм буй болохын зайлшгүй нотлох оролдлого хийхийн зэрэгцээ шинжлэх ухааны олон салбарт хамаарах арга зүйг боловсруулжээ. Орчин үед эдийн засаг, социологи, улс төр судлаачдын хамгийн олон удаа эшлэл авдаг зохиол юм. (А.Ц)

МАСЛОУ, АБРАХАМ (*Maslow, Abraham Harold, 1908-1970*) Украин гаралтай, Америкийн сэтгэл зүйч. Висконсиний их сургуулийг сэтгэл зүйч мэргэжлээр төгссөн. 1931 онд мэргэжлээрээ магистрын зэрэг авчээ. Мөн эл сэдвээрээ Колумбын их сургуульд судалгаа хийжээ. Дэлхийн 2-р дайны дараагаас эхлэн тэр үеийн сэтгэл зүйчдийн арга барилд эргэлзэж эхэлснээр хүний сэтгэцийн талаар шинэ чиглэл гаргасан ба түүнийгээ гуманист сэтгэл судлал хэмээн нэрлэжээ. Маслоу хүний хэрэгцээний таван шатлалт онолыг боловсруулснаараа алдартай болсон. Гуманист сэтгэл судлал: 1) хүний одоогийн үйл ажиллагаа маш чухал. Өнгөрсөн үеийг шинжлэх болон ирээдүйг таах гэж оролдохын оронд энд, одоо байгааг шинжлэх, 2) сэтгэл санааны хувьд эрүүл байхын тулд хүн сайн, муу, аль ч үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх, 3) ямар ч хүн “хүн” мөн болох учраас л үнэ цэнэтэй, ямар ч муу үйл хийсэн бай, тэр нь уг хүний үнэ цэнийг үгүй хийхгүй, дөрөвт, амьдралын эцсийн зорилго бол бие хүний хувьд өсөж хөгжих гэсэн үзэл санаанд тулгуурладаг. (А.Ц)

МАТЕРИАЛЛАГ УРАМШУУЛАЛ (*Extrinsic rewards*) Материаллаг урамшуулал нь нэг талаас хүнд дутагдаж байгаа материаллаг хэрэгцээг хангах, нөгөө талаас материаллаг эд зүйлсээр хүний сэтгэл санаанд нөлөөлж сэтгэл зүйн ханамж өгч идэвхжүүлэх нөлөөллийн арга хэрэгсэл юм. Цалингийн нэмэгдэл, бонус, борлуулалтын шагналт цалин гэх зэрэг бодит хэмжигдэхүйц зүйлс материаллаг урамшуулалд багтана. Материаллаг урамшууллын түгээмэл хэлбэр бол мөнгө. Хүнд мөнгөний хэрэглээ байнга гарч байдаг, тэр бүр

материаллаг эд зүйлсээр хүмүүсийн хэрэгцээнд тааруулан шагнаж чаддаггүй. Мөнгөөр шагнагдсан хүн өөртөө хэрэгцээтэй зүйлээ авч материаллаг хэрэгцээгээ хангах замаар сэтгэл зүйн ханамж авна. Учир нь мөнгө бол байгууллагын өгч чадах цорын ганц үйлчилгээ сайтай өдөөгч юм. Жишээ нь, байгууллагын зүгээс ажилтанд, “Энэ оны ажлын төлөвлөгөөгөө биелүүлж ажиллаарай. Тэгвэл чамайг бид илүү хүндэлье” гэж хэлэх амаргүй. Харин түүний оронд “хэрэв чи энэ онд төлөвлөсөн төлөвлөгөөгөө хангаж ажиллавал, 5 мянган долларын шагнал хүлээж байгаа шүү” гэж хэлэхэд илүү хялбар байдаг байна. Харвардын Бизнесийн Сургуулийн профессор Брайн Холл “материаллаг болон сэтгэл санаа дэмжлэг аль аль нь өөрийн гэсэн ач холбогдолтой, ажилтан энэ хоёр урамшууллын аль алинд нь сэдэлждэг” гэжээ³. Тэгээд ч ихэнх байгууллагын урамшууллын системд материаллаг урамшууллыг түлхүү ашигладаг байна. Шагнал урамшууллыг хамт олонд олгохдоо байгууллагын ашигт ажиллагаа, бизнесийн хөгжил, амжилтад хамт олноос оруулсан бодит хувь нэмрийг нь үндэслэн ажлын гүйцэтгэлийг сайжруулах хөшүүрэг болгон ашиглах нь зүйтэй. (Ц.Д)

МЕНЕЖЕР (*Manager*) Хамт олныг зохион байгуулах зорилго бүхий, ажлын гүйцэтгэлийг хянан туслах, удирдан зохицуулах үүрэг бүхий ажилтан юм. Байгууллагын зорилго, зорилт хэрэгжүүлэх өдөр тутмын гүйцэтгэх үйл ажиллагааг менежер зохицуулна. Зах зээлийн эдийн засгийн өнөөгийн нөхцөлд ажиллах менежер нь мэргэжлийн өндөр төвшинд бэлтгэгдсэн удирдах,

манлайлах чадвар сайтай үлгэрлэн дуурайлал үзүүлэх чадвар бүхий үлгэр жишээ хүн байна. Менежер нь хувийн зохион байгуулалт, цагийн менежмент сайтай, албан бичиг хөтлөх, төлөвлөх чадвар бүхий, харьцааны соёлтой, багаар ажиллах чадвартай, гарсан зөрчлийг шуурхай арилгах, урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ мэргэжлийн олон ажлыг өдөр тутамд нэгэн зэрэг гүйцэтгэх чадвар бүхий хүн байдаг. Менежер хүн дээрх шинж чанаруудыг өөртөө бий болгоход уйгагүй хөдөлмөрлөхөөс гадна мэдрэмж болон сэтгэл судлалын мэдлэг шаардагддаг. Төлөвлөсөн ажил, ажлын хуваарилалт нь аливаа ажлын гол цөм бөгөөд хамтын зорилго, зорилтыг биелүүлэхийн тулд хувь хүмүүсийн хүчин чармайлтыг зохицуулж байдаг удирдлагын мөн чанар менежерт нэвт шингэсэн байх ёстой байдаг. (А.Э.ц)

МЕНЕЖЕРИАЛИЗМ (*Managerialism*)

Энэ нь улсын салбарын шинэ удирдлагын үзэл санаа бөгөөд “менежмент” гэгдэх тодорхой үйл ажиллагаа төрийн болон хувийн бизнест адил хэрэглэгдэж болно гэсэн ойлголтод тулгуурладаг. Энэ нь орцын хяналт, дүрэм журмаас татгалзаж, гарцын хэмжүүр, гүйцэтгэлийн зорилт, хариуцлагын тогтолцоонд чиглэх, менежментийн хяналтын эрх мэдлийг шилжүүлэх, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг чухалчилдаг. Энэ хандлага нь төрийн үйл ажиллагааг үйлдвэрлэлийн үйл явц гэх бөгөөд оргод чиглэсэн удирдлагаас татгалзаж, зорилго дэвшүүлж, үрдүнд хяналт тавих санааг илэрхийлсэн. Менежериализмын зорилго нь ажлын үр дүн болон төсвийн хариуцлагыг хослуулан захиргааны үйл ажиллагааны зардал хэмнэхэд анхаардаг. (Т.Т)

³ Гүйцэтгэлийн удирдлага. Орчуулагч Н.Хашбат, Сүүн Сувд ХХК. Улаанбаатар, 2015, х. 23-25.

МЕНЕЖМЕНТИЙН ТҮВШИН (*Hierarchy of management*)

Систем, байгууллагын удирдлага асуудлыг шийдвэрлэхэд зориулагдсан олон төрлийн ажил, чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын хүчин чармайлтыг уялдаат шатлал буюу түвшин. Бюрократ онолын дагуу төрийн байгууллага дээрээс доош чиглэсэн босоо чиглэлд үйл ажиллагаагаа төлөвлөж хэрэгжүүлнэ. Ихэнхдээ менежментийн түвшин нь пирамидтай төстэй ба энэ нь системийн, институцийн, байгууллагын, байгууллагын нэгжийн түвшинд тодорхойлогдоно. (Г.Б)

МЕРИТ ЗАРЧИМ (*Merit principle*)

Мерит зарчим нь үр ашиг, үр дүнтэй, шударга хүн бүрд нээлттэй, улс төрийн оролцоогүй, ур чадвартай албан хаагчтай байх төрийн албаны тогтолцоо. II. “чадахуйн зарчим /мерит/” нь иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулахад хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах систем юм. Мерит систем нь төрийн албан хаагчдыг улс төрийн холбоо хамаарлаас илүүтэйгээр, тухайн ажлыг гүйцэтгэх чадварыг харгалзан сонгон шалгаруулах, ажил авах үйл явц бөгөөд спойл системийн эсрэг санаа агуулдаг. Энэхүү системийн зарчмыг “мерит буюу чадахуйн зарчим” гэнэ. “Мерит” нь “гавьяа зүтгэл, чанар чансаа, сайн тал, хүлээн зөвшөөрөгдсөн байдал” утгыг агуулдаг бөгөөд хүний нөөцийн тухайд энэ ойлголт нь төрийн аливаа албан тушаалд түүний зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зайлшгүй хэрэгцээтэй шалгуур шаардлагуудыг

бүх талаараа хангасан хүн томилогдох үйл явцыг илэрхийлдэг⁴. Мерит системийн зарчмууд⁵:

- Ажилд авах, албан тушаал дэвшүүлэхдээ нээлттэй, шударга өрсөлдөөний зарчмыг баримтлах
- Ажилтан болон ажил горилочдод тэгш, шударга хандах
- Ижил төрлийн ажилд адил хэмжээний цалин олгох, ажлын гүйцэтгэлийг урамшуулах
- Шударга байдлын эрхэмлэх, олон нийтийн ашиг сонирхлыг харгалзах
- Албан хаагчдыг үр дүнтэй, үр ашигтай удирдах
- Ажилтнуудын аливаа асуудлыг шийдэхэд (цалин нэмэх, бууруулах, шагнах, шийтгэх, албан тушаал дэвшүүлэх, бууруулах, халах гэх мэт) ажлын гүйцэтгэлийг харгалзах
- Байгууллагын болон хувь хүний гүйцэтгэлийг сайжруулахын тулд ажилтнуудыг байнга сургаж хөгжүүлэх
- Ажилтнуудыг улс төрийн сөрөг нөлөөллөөс хамгаалах зэрэг болно. (Г.Б)

МЕРИТ САЙН ҮЙЛС, ҮЙЛЧИЛГЭЭ (*Merit goods and services*)

Мерит үгийн утга нь сайн, магтаал хүртэх чанар, эсвэл ямар нэг зүйлтэй харьцуулахад давуу талыг илэрхийлнэ⁶. Мерит сайн үйл, үйлчилгээ нь нийгэмд эрэлттэй, үр өгөөж өндөртэй хэдий ч зах зээлд бүрэн хүрч чаддаггүй бараа, үйлчилгээ юм. Мерит бус эд, үйлчилгээ нь үүний эсрэг буюу хязгаарлаагүй тохиолдолд хүмүүс хэт их хэрэглэж болох, нийгмийн

4 Д.Зүмбэрэлхам: “Монгол Улсын төрийн албанд мерит зарчмыг төлөвшүүлэх нь”, Төрийн захиргаа сэтгүүл, 2011 оны тусгай дугаар (18), х. 26.

5 Д.Байгаль: “Төрийн албаны тогтолцоо”, Улаанбаатар 2017, х. 12.

6 Cambridge Dictionary, <https://dictionary.cambridge.org/dictionary/english/merit>

хор уршиг ихтэй бараа, үйлчилгээ (гамхи, архийг хэтрүүлэн хэрэглэх гэх мэт) юм. Мерит ба мерит бус бараа, үйлчилгээний нийгэмд үзүүлэх үр нөлөөний улмаас төрийн оролцоо бараа, үйлчилгээг хүргэхэд шаардлагатай байдаг⁷. Хэрэглээ нь нийгэмд үр өгөөжөө (гадагшаа эерэг нөлөөлөл) өгдөг гэж үздэг бараа, үйлчилгээ нь хэрэглэгчдийн өөрсдийнх нь хүссэн хэмжээнээс хамаагүй их байдаг. Бараа, үйлчилгээ нь гадагшаа эерэг нөлөөллийг бий болгодог бол түүнийг мерит гэж ангилж болно. Засгийн газрын оролцоогүй тохиолдолд хувь хүний сонголт нь бараа, үйлчилгээг хангалттай хүргэж чадахгүйд хүргэж, гадагшаа эерэг нөлөөллийг бий болгодог. Ийм мерит бараа, үйлчилгээнд төрөөс шууд болон шууд бус татаас өгдөг, эсвэл үнэ төлбөргүй олгодог. Төр, хувийн хэвшил аль аль нь мерит бараагаар хангадаг. Төрөөс халамжаар дамжуулсан бараа, үйлчилгээг мерит гэж ойлгож болно. Жишээ нь, иргэдэд ашигтай, шаардлагатай байгаа зүйлийн талаар засгийн газар нь хэрэглэгчдээс илүү сайн мэдээлэлтэй гэж үзээд шийдвэр гаргаж, нийгмийн ашгийн үүднээс тухайн хэрэглээг хангахын тулд буянт сайн үйл үй, үйлчилгээг хүргэдэг. Жишээ нь, заавал бага боловсрол эзэмших, хүүхдийг вакцинжуулах гэх мэт⁸. (Д.Ч)

МКГРЕГОР, ДУГЛАС (*Douglas McGregor, 1906-1964*) Америкийн нийгмийн сэтгэл судлаач. 1935 онд Харвардын их сургуульд докторын зэрэг хамгаалж, 1937 оноос Массачусетсын технологийн институтэд ажиллаж

эхэлсэн. Тэнд бусад хүмүүстэй хамтран үйлдвэрлэлийн харилцааны салбарыг үндэслэн байгуулжээ. 1948 онд Антиохын коллежийн захирал болсон. 1954 онд Массачусетсын технологийн институтэд профессороор насан эцэс хүртлээ ажилласан байна. 1950 –иад онд “Үйлдвэр дэх хүний асуудал” «The Human Side of Enterprise» хэмээх өгүүллээ бичсэн нь 1960 онд хэвлэгдэн гарчээ. МкГрегор менежментийн хоёр хэв маяг бий бөгөөд “Х”, “У” онолд үндэслэдэг хэмээн үзжээ. Амьдралынхаа сүүлийн жилүүдэд хувь хүний болон байгууллагын хэрэгцээ сонирхлыг хослуулсан “Z” онолыг боловсруулж байсан боловч дуусгаж амжаагүй байна. Түүнийг нь хожим Уильям Оучи (William Ouchi) үргэлжлүүлэн бичсэн байна. (А.Ц)

МОДЕРНИЗАЦИ (*Modernization*)

Модернизацийн онол нь нийгмийн шинжлэх ухааны хэд хэдэн онолуудад хэрэглэгдэн уламжлалт байдлаас шинэчлэл рүү шилжих нийгмийн үйл явцыг тайлбарладаг. 1960-аад оны цэцэглэлтийн үед модернизацийн онол нь АНУ-ын засгийн газрын бодлогод хэрэгжиж эхэлсэн бөгөөд гадаадын улс орнуудад үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийн үзэл баримтлал нь энхтайвны корпусыг байгуулахад ихээхэн нөлөөлсөн байна.

Модернизацийн онолчид нь нийгмийн хөгжлийг дэмжих ирээдүйн өөдрөг үзлийн талаар хэлэлцдэг бөгөөд эхэн үеийн онолчид нь бүгд нэг зүгт харахыг уриалж, нийгэмд гарч буй хөдөлмөрийн хуваарилалтын улам нарийн өөрчлөлтүүд нь (ажлын байрны мэргэшсэн мэргэжилтэн байх) ирээдүйн хөгжлийн илрэл гэж үзэж байв. Модернизацийн онолоор нийгмийн шинэчлэлийн гол

7 Ц.Даваадулам, Засаглалын үзэл баримтлал, нэр томьёоны тайлбар толь бичиг, Glossary Of Concepts And Terms In Governance, 2010, х. 62.

8 Оксфорд лавлах, <https://www.oxfordreference.com/view/10.1093/oi/authority.201110803100151458>

чиглүүлэгч хувь хүний хандлагын өөрчлөлтийг нэгэн зэрэг хамт хийхийг онцолдог. Харин албан ёсны боловсролын үйлчилгээ нь хандлагын өөрчлөлтийг хийх хэрэгсэл болно хэмээн үзэж тухайн газар нутаг ба нийгмийн бүлгүүдэд үнэт зүйлсийн тархалт нь тодорхой бүс эсвэл хэсэг бүлгээс илүү давамгайлан гарч ирдгийг мөн анхаарах хэрэгтэй гэж тэмдэглэжээ. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ч шинэчлэл өөрчлөлтийн үзэл санаа, үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэхэд үр дүнтэй хэмээн үздэг. Тархалт, түгээн дэлгэрүүлэлт нь модернизацийн онолын төвд байна. Модернизацийн онолчид хувь хүмүүс нь өөрчлөлт, шинэчлэлийн үзэл санаа, үнэт зүйлсийн хандлагад уламжлалт нийгмийн бүтэц, хэм хэмжээг дагаж мөрдөхөөс илүү өөрт нь бий болох улс төр, эдийн засгийн давуу талуудыг илүүд үздэг эсэхэд эргэлздэг гэж үздэг ажээ. Иймд шинэчлэл хийхэд хүлээн авагч гэж хэн бэ, хэн шинэчлэлийг эхлүүлдэг вэ, хэнээс хэнд шинэчлэлийн тархалт үйлчлэх вэ зэрэг субъект талын асуултаар түүний тархалт, түгээн дэлгэрүүлэх онолын үзэл баримтлалыг авч үздэг. (Я.Т)

МОНГОЛ ЖУРГААН (*Mongol Jurgan-Manchu administrative authority for Mongolian affairs*) Манжийн төрөөс Ар Монголын хэргийг эрхэлж, шууд захирч байсан дээд байгууллага бөгөөд зургаан хэлтэстэй байжээ. Тэр Улиастайн жанжин, Их хүрээ, Ховдод суух сайдуудаар Ар Монголд улс төрийн хяналт тавьж, үйл ажиллагаагаа явуулж байв. Аймгийн чуулганы дарга, аймгийн жанжин, Их шавийн Эрдэнэ шанзавыг томилох, Манжийн төрийн хуулиудад Монголын талаарх заалтыг

боловсруулах, засаг ноёдын хэргэм зэрэг бүхий л асуудлыг шийдвэрлэдэг байжээ. Өөрийн эрх мэдлээс давсан том асуудлуудыг Манжийн хаанд айлтган шийтгэдэг байжээ. (А.Ц)

МОНГОЛ ОЙРАДЫН ИХ ЦААЗ (*Mongol-Oirat great code*)

Ойрадын Эрдэнэбаатар хунтайжийн санаачилгаар Халх, Ойрад, Хөх нуурын монгол, Ижил мөрний торгуудын төлөөлөгчид 1640 онд Тарвагатайн Улаанбураа хэмээх газар хуралдаж баталсан хууль. Халимагаас тод үсгээр бичсэн нэгэн хувилбар олдсон байна. Тэр үед Халхыг “Дөчин түмэн”, Ойрадыг “Дөрвөн түмэн” хэмээн нэрийддэг байсан тул угийн хуулийг “Дөчин дөрвөн хоёрын их цааз” гэж нэрлэх нь бий. Тэр үед Манж улс хүчирхэж байсны зэрэгцээ Монголд феодалын бутрал хэмээх хямрал болж байсан тул хямралыг гэтлэн давж, улс үндэстнээ нэгтгэх, тусгаар тогтнолоо хамгаалах үзэл санаагаар энэхүү чуулганыг зохион байгуулсан байна. Их цааз ч бас эл үзэл санааг агуулсан ажээ. Уг хуулийг Галдан бошигт, Халимагийн Дондогдаш хааны үед нэмж засварласан ажээ. Уг хуулийн эхний хэсэгт Монгол, Ойрадад дайсан халдвас хэрхэх тухай нэлээд заалт орсноос гадна, эрүү, иргэний харилцааг зохицуулах заалтууд орсон байна. (А.Ц)

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН (*Citizen of Mongolia*)

Иргэн–тодорхой улсад албан ёсоор харьяалагдаж, тухайн улсын харьяат болохыг нь гэрчлэх баримт бичиг бүхий хүн. Монгол Улсын иргэний харьяалал нь Монгол Улс, түүний иргэн хоёрын хооронд үргэлжилсэн, тогтвортой эрх зүйн холбоогоор илэрнэ. Монгол Улсын иргэн улс орны дотоод болон

хилийн чанадад байгаагаас үл хамааран төрийн ивээлд багтаж, төрийн бүрэн эрхт байдал, засаглалыг хүлээн зөвшөөрч, Үндсэн хууль болон бусад хуулиар тогтоосон эрх, эрх чөлөөг эдэлж, үүргээ биелүүлэн, хууль ёсныхоо ашиг сонирхлыг төрөөр хамгаалуулдаг. Монгол Улсын иргэний харьяаллын агуулга нь иргэний харьяалал хийгээд Монгол Улсын харьяат болох, иргэний харьяаллыг сэргээн тогтоох, харьяаллаас гарахтай холбогдсон харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээгээр илэрхийлэгдэнэ. Монгол Улсын Үндсэн хуулийн 15 дугаар зүйлд “Монгол Улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно” гэж заасан. *Хоёрдмол харьяаллыг* үл зөвшөөрөх нь Монгол Улсын иргэний харьяаллын үндсэн зарчим мөн. Монгол Улсын иргэнийг харьяаллаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлж өгөхийг хуулиар хориглосон нь Монгол Улсын иргэний харьяаллын онцлог шинж юм. (Ч.Э)

МОНГОЛ УЛСЫН ШАСТИР (*Mongolian genealogical chronicle*) ХҮИ – ХХ зууны эхэн үеийн Ар Монголын ноёд, тайж, хутагт хувилгаадын намтрыг тодорхойлон гаргасан ургийн бичгийн шинжтэй зохиол юм. Түүнийг 1919-1919 онд Богд хааны зарлигаар Нийслэл хүрээний урьд тушаалын дэд сайд, да лам Цэрэндэндэв, Их хүрээний да лам, хурц билэгт Гомбоцэрэн, Сэцэн хан аймгийн хурц гүн Галсандонхой нар ахлан зохиожээ. Мөн гавж Зава Дамдин, гүүш Сумъяа, гүн Дашням, Намсрайжав, Тогтох нарын эрдэмтэй хүмүүс оролцсон байна. Нийт 11 дэвтрээр зохиосон гэх боловч одоогоор 7 дэвтэр байгаа ажээ. Уг шастираас сурвалжтануудын удам

угсаанаас гадна, тэр үеийн Монгол Улсын засаг захиргаа, хошуу, сүм хийдийн талаар мэдэж болох түүх, захиргаа судлалын чухал эх сурвалж юм. (А.Ц)

МОНОПОЛ (*Monopoly*) Орлуулах боломж багатай бүтээгдэхүүн үйлдвэр-лэдэг, тухайн бүтээгдэхүүнийг өөр ямар нэгэн пүүс борлуулахаас ямар нэгэн хориг саадаар хамгаалагдсан пүүсийг хэлдэг. Монополын хувьд компани нь тухайн салбарт ганцаар оршдог. (А.Э)

МОНТЕСКЬЕ, ШАРЛЬ ЛУЙ (*фр. Charles Louis de Seconda, Baron de La Brude et de Montesquieu; 1689 - 1755*) Францын эрх зүй судлаач, философич, зохиолч. 1705 онд коллежээ төгсөж Бордо болон Парист хууль судалж байжээ. 1714 онд Бордогийн парламентын зөвлөхөөр ажилласан байна. 1716 онд нас барсан авга ахынхаа хашиж байсан Бордогийн парламентын дэд ерөнхийлөгчийн албыг, Бароны зэрэгтэй нь хамт өвлөн авсан. 1726 оноос төрийн албаа орхиж шинжлэх ухаанд өөрийгөө зориулан төрийн эрх мэдлийг зааглаж хуваарилах онолыг боловсруулсан ажээ. Монтескьегийн улс төрийн онолын гол санаа нь нэгд, эрх чөлөөг зөвхөн хуулиар л баталгаажуулж болно, хоёрт ямар ч улсад төрийн эрх мэдэл хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх гэсэн гурван салбарт хуваагдаж байх ёстой, дөрөвт, цаг уурын янз бүрийн нөхцөлд аж төрж буй хүмүүсийн амьдралын нөхцөл өөр өөр тул хууль нь ч бас өөр байдаг, тавд, засаглалын зарчим нь дэглэм бүрд өөр байдаг, тухайлбал, бүгд найрамдах улсад сайн үйл, хаант засагт нэр хүнд, дарангуйлагч дэглэмд айдас төрүүлэх зэрэг нь засаглалын арга, суурь байдаг хэмээн үзжээ. Тэрбээр “Персийн захидлууд” (1721) роман, “Книдийн сүм”(1725),

“Ромчуудын мандалт, бууралтын шалтгааны талаарх бодрол”(1734), “Хуулийн санааны тухай”(1748), “Амгын талаарх туршлага” (1753) зэрэг бүтээл туурвижээ. (А.Ц)

МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (*Cash transaction*) Аливаа бараа, ажил үйлчилгээ, хөрөнгө худалдан авах, зардал санхүүжүүлэхтэй холбоотой мөнгөн төлбөр, мөнгө хүлээн авах, шилжүүлэхтэй холбогдох санхүүгийн гүйлгээг хэлнэ. Мөнгөн гүйлгээ нь мөнгө хүлээн авагч, шилжүүлэгч, төлбөр тооцооны систем гэсэн бүрэлдэхүүнтэй бөгөөд төлбөр тооцооны системийн ялгаа, арга хэрэгслээс хамаарч мөнгөн гүйлгээг ангилдаг. Мэдээллийн технологийн хурдацтай өөрчлөлт, технологийн шийдлийг мөнгөн гүйлгээнд ашигласнаар төлбөр тооцооны хэрэгсэл, мөнгөн гүйлгээний төрөлд өөрчлөлт гарахаас гадна ажил гүйлгээний зардал буурч зарцуулах хугацаа богиносж байна. (Б.Б)

МӨНГӨНИЙ БОДЛОГО (*Monetary policy*) Улс орны эдийн засгийн хөгжлийг удирдах макро эдийн засгийн бодлогын нэг бөгөөд мөнгөөр дамжуулан эдийн засгийн өсөлт, үнэ, төлбөрийн тэнцэл, ажилгүйдэл зэрэг макро эдийн засгийн орчны үзүүлэлтэд нөлөөлөх Төв банкнаас хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг хэлнэ. Хөгжиж буй эсвэл шилжилтийн эдийн засагтай орнуудад мөнгөний бодлого нь ихэвчлэн үндэсний валютын худалдан авах чадварыг тогтворжуулахад чиглэдэг. Мөнгөний бодлогыг тэлэх ба хумих бодлого гэж хоёр ангилна. Ажилгүйдлийг бууруулж эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор эдийн засагдахь мөнгөний нийлүүлэлтийг өсгөх бодлогыг тэлэх буюу зөөлөн

бодлого гэнэ. Харин үнийн ерөнхий түвшний өсөлтийг бууруулах, инфляцаас урьдчилан сэргийлэх зорилгоор мөнгөний нийлүүлэлтийг бууруулах бодлогыг хумих буюу хатуу бодлого гэдэг.⁹ Мөнгөний хатуу бодлого нь инфляцыг бууруулсан ч үйлдвэрлэлийн өсөлтийг хязгаарлаж ажилгүйдлийг нэмэгдүүлэх нөлөөтэй учир эдийн засгийн бодлогын бусад арга хэрэгсэлтэй хослуулан хэрэгжүүлж зэрэг үр дүн гаргахыг зорьдог. (Б.Б)

МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ (*Money market*)

Нэг жилээс богино хугацаатай, хөрвөх чадвартай үнэт цаас арилжаалагддаг зах зээлийг мөнгөний зах зээл гэх бөгөөд уг зах зээлд мөнгөний үнэ буюу зээлийн хүүгийн хувь хэмжээ тодорхойлогддог. Мөнгөний зах зээлд хийгдэх арилжаанд Засгийн газар, арилжааны банк, бизнесийн байгууллага, хувь хүмүүс оролцоно. Нэг талаас Засгийн газар болон Төв банк санхүүгийн эх үүсвэр босгох зорилгоор богино хугацаатай үнэт цаас гаргаж арилжаалан нөгөө талаас арилжааны банк, бизнесийн байгууллага, хувь хүмүүс болон бусад хөрөнгө оруулагчид түүнийг худалдан авч богино хугацааны буюу эргэлтийн хөрөнгөө мөнгөний зах зээлд байршуулж, хөрөнгөө өсгөдөг. Мөнгөний зах зээл дэх нөөцийг удирдах замаар Төв банк зах зээлийн нийлүүлэлтэд нөлөөлнө. (Б.Б)

МӨНГӨНИЙ ҮНЭ ЦЭНЭ (*Value of Money*)

Цаг хугацааны ялгаатай үедэд мөнгөний үнэ цэнэ ялгаатай буюу өнөөдрийн нэг төгрөгийн үнэ цэнэ (худалдан авах чадвар) ирээдүйн нэг төгрөгийн үнэ цэнээс ялгаатай юм. Иймд үнэ цэнийн тооцоолол нь санхүүгийн шийдвэр гаргалтад

⁹ David Schultz: Encyclopedia of Public Administration and Public Policy, USA 2004, p. 272.

ач холбогдолтой. Өнөөдрийн мөнгө тодорхой хугацааны эцэст хэрхэн өөрчлөгдөх буюу ирээдүйн үнэ цэнэ ямар байх, ирээдүйд орох орлого, мөнгөн урсгал өнөөдрийн хэчнээн төгрөгтэй тэнцэх буюу өнөөгийн үнэ цэнэ хэд болох нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн тооцоололд тулгуурлан хийгддэг. Засгийн газар хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн үр ашгийг тооцоолохдоо мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг үнэлэх арга зүйг ашиглана. (Б.Б)

МӨНГӨН УРСГАЛЫН ТАЙЛАН (*Cash flow statement*) Тайлангийн хугацаанд аливаа эдийн засгийн систем (байгууллага, салбар, засгийн газар)-ийн хамгийн хөрвөх чадвар сайтай хөрөнгө болох мөнгө болон түргэн хөрвөх үнэт цаас хэрхэн өөрчлөгдсөн, энэхүү мөнгөний урсгалд үндсэн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн мөнгөн урсгал хэрхэн нөлөөлснийг нэгтгэн харуулдаг санхүүгийн тайланг хэлнэ. Мөнгөн урсгалын тайлан нь үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны ба санхүүжилтийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэсэн гурван хэсгээс бүрддэг. Мөнгөн хөрөнгө орж ирэх урсгалыг эерэг урсгал, мөнгөн төлбөр хийгдэж мөнгө гадагш шилжүүлэхийг сөрөг урсгал гэж нэрлэхээс гадна хугацааны хүчин зүйлийг харгалзан өнөөгийн мөнгөн урсгал, ирээдүйн мөнгөн урсгал гэж ангилна. Мөнгөн урсгалын тайлан мэдээг богино хугацаанд үнэн зөв гаргаснаар байгууллагынхаа мөнгөний илүүдэл болон хомсдолыг хянаж удирдах боломжтой. (Б.Б)

МӨРГӨЛДӨӨН СУДЛАЛ (*Conflictology*) Мөргөлдөөн нь латин хэлний “conflictus” буюу мөргөлдөөн, сөргөлдөөн, зөрчилдөөн хэмээх

үгнээс эхтэй. Нийгмийн давхаргууд, орлого, эрх мэдэл, нэр хүндийн ялгаа нь мөргөлдөөн үүсгэж байдаг. Иймд мөргөлдөөн нь нийгмийн амьдралын салшгүй хэсэг. Энэхүү үзэгдэл аливаа нийгэмд өргөн тархсан нь “конфликтологи” буюу “мөргөлдөөн судлал” хэмээх нийгмийн шинжлэх ухааны салбар чиглэлийг хөгжүүлсэн. Мөргөлдөөн судлал нь улс төр, социологи, эрх зүй, эдийн засаг, угсаатны зүй, түүх, хэл судлал, удирдахуйн ухаан гэх мэт нийгмийн шинжлэх ухааны олон салбаруудад судлагддаг ойлголт юм. Английн социологич Э.Гидденс мөргөлдөөнийг хэл зүйн талаас тодорхойлохдоо: “Мөргөлдөөн нь эх сурвалж, арга хэрэгслээс үл хамааран хүмүүс, бүлгүүдийн хооронд явагдаж буй бодит тэмцэл” гэж үзсэн. Нийгмийн мөргөлдөөнийг илрэх хүрээгээр нь эдийн засаг, нийгэм, соёлын, шашны, улс төрийн мөргөлдөөн гэж ангилдаг. Улс төрийн мөргөлдөөн нь улс төрийн зорилго, ашиг сонирхол, үнэт зүйл, байр сууриараа өөр хоорондоо тэрсэлдэгч субъектүүдийн зөрөлдөөн, тэмцэл юм. Улс төрийн мөргөлдөөний нэг шалтгаан нь улс төрийн субъектүүд, тэдний байр суурь, зорилго, үйл ажиллагаа, хэрэгцээ, ашиг сонирхлын зөрүүг тодорхойлогч нийгмийн давхаргуудын ялгаа. Түүнчлэн мөргөлдөөнд төрийн аппарат, парламентын фракцууд, шахалт үзүүлэгч бүлэглэлүүд гэх мэт улс төрийн байгууллагууд шууд оролцдог. Улс төрийн мөргөлдөөний ойлголт нь улс төрийн харилцааны системд нөлөөлөх, баялгийг захиран зарцуулах, ашиг сонирхлоо биелүүлж, үзэл баримтлалаа нийгмээр хүлээн зөвшөөрүүлэхийн төлөөх хэсэг бүлэг субъектүүдийн хоорондын тэмцлийг агуулна. (Я.Т)

МЭДЛЭГ, УР ЧАДВАР (*Knowledge and skills*)

Мэдлэг бол танин мэдэхүйн үйл явцын үр дүн, нийгмийн болоод хүний ой санамжийн хэлбэр юм. Танин мэдэхүй зөвхөн шинжлэх ухааны хүрээгээр хязгаарлагдахгүй, гагцхүү шинжлэх ухааны мэдлэгийг бодитой, оновчтой, ертөнцийн талаарх үнэн зөв тусгал, зураглал болдог хэмээн үзэх нь түгээмэл. Мэдлэг бол бодит байдалд бидний санаа бүрэн дүүрэн давхцан, тохирч байхыг хэлэх тухай эртний грекийн үеэс эхлээд объект субъектийн харилцаанаас үүдэлтэйг тэмдэглэж ирсэн билээ. Түүнийг судалдаг танин мэдэхүйн ерөнхий онолыг гносеологи, шинжлэх ухааны танин мэдэхүйг эпистемологи хэмээн нэрлэдэг. Орчин үед нийгмийн эпистемологи (social epistemology) хэмээх нэрээр нийгмийн шинжлэх ухаануудад судалгааны арга зүй, онол, зарчмын үүрэгтэйгээр энэ судлагдахуун өргөн дэлгэрсэн. Шинжлэх ухааны мэдлэг өөрийн гэсэн тусгаар, шинжлэх ухааны тогтсон ойлголт, ухагдахуун, нэр томьёогоор илэрхийлэгддэг онцлогтой. Мэдлэгийн төрөл зүйл олон янз бөгөөд ердийн, шинжлэх ухааны бус, шинжлэх ухааны мэдлэг хэмээн зааглаж, онолын болоод сорил туршилтын түвшинд тус тус хуваан үздэг бөгөөд энэхүү хязгаарлалтыг мэдлэгийн демаркацигэнэ. Товчхондоо шинжлэх ухааны мэдлэгийг шинжлэх ухааны бус мэдлэгээс ялгах үзэгдлийг хэлдэг байна. Дижитал эрин үеийг мэдлэгийн нийгэм хэмээн нэрлэх явдал олонтой тохиолдох бөгөөд аж үйлдвэржилтийн дөрөвдүгээр хувьсгал, хиймэл оюун ухаан, ухаалаг технологийн эрин үе хэмээх агуулгыг илэрхийлж байх ба мэдэхээс эхлэлтэй мэдлэгийн ертөнцийг ийнхүү нэрлэдэг. Шинжлэх ухаан, улс төр, шашин, философи зэрэг нийгмийн

ухамсрын хэлбэр бүрд мэдлэгийн харьцангуй бие даасан ертөнц бодитой оршин тогтноно. Түүнчлэн мэдлэгт, тэр дундаа шинжлэх ухааны мэдлэгт үнэн худлын шалгуур онцгой чухал байр суурь эзэлнэ. Мэдлэг шинээр бий болох явц тасралтгүй өсөн нэмэгдэж хуримтлагдах буюу кумулятив, кумулятив бус замаар явагдахын зэрэгцээ түүний хөгжилд гадаад буюу экстерналист, дотоод буюу интерналист хүчин зүйл ихээхэн нөлөөтэй болох нь шинжлэх ухааны түүхэнд улс төр судлал, төрийн удирдлага, захиргааны шинжлэх ухаанд мэдлэгийн өвөрмөц шинж чанарууд илрэлээ олсон. Шинжлэх ухааны мэдлэгийн гол шалгуур бол үнэн байх явдал бөгөөд нийгэм-хүмүүнлэгийн мэдлэгт нийгмийн туршлагыг дамжуулах, үзэгдэл болон баримтыг зөв тайлбарлах, тогтолцооны хүрээнд нь ойлгох явдал чухал байр суурь эзэлдэг. ХХ зууны шинжлэх ухааны нэрт түүхчид болох К.Поппер, Т.Кун, И.Лакатос, П.Фейерабанд, С.Тулмин болон Л.Витгенштейн нарын бүтээлд мэдлэг, баримт, хэллэг, өгүүлбэр, баталгаа ба няцаалт, хэл, ертөнц, боломжит ертөнц зэрэг шинжлэх ухааны үнэн магадтай мэдлэгийг хэрхэн зааглах, шалгах, мэдлэгийн илэрхийллийн оновчтой арга хэлбэрүүдийг задлан шинжилсэн зохиол бүтээлүүд гарчээ. Мэдлэг нь ямар нэгэн зүйлийн талаар мэддэг байдал; аливаа сэдвийг судалж, олж авсан ойлголт мэдээлэл; туршлага, судалгаагаар олж авсан ур чадвар, эзэмшсэн мэдлэгийн тухай ойлголтыг агуулдаг. Байгууллагын стратегийн зорилгод хүрэх үйл ажиллагааг оновчтой төлөвлөх, амжилттай хэрэгжүүлэхэд шаардагдах ур чадварыг төрийн албан хаагчид эзэмших нь зүйтэй. Тэдэнд хэрэгцээтэй мэдлэг ур чадварыг

төрийн албан хаагчийн сургалт, давтан сургалтаар олгох ба үүний үр дүнд албан хаагчид шинэ санал санаачилгыг хэрэгжүүлэх боломжтой. (Б.П; Г.Б нар)

МЭДЭЭЛЛИЙГ ЗАДРУУЛАХ (*Disclosure of information*) Энэ ойлголтын дор аюулгүй байдлын эрх ашгийг хамгаалахын тулд хувь хүн, байгууллага, төрийн болон албаны нууцад хамааруулахаар хуульчлан тогтоосон жагсаалтад хамаарах мэдээллийг зохих зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах гэмт хэрэг, эсхүл зөрчлийг ойлгодог. Мэдээлэл задруулахыг хориглосон аливаа хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд задруулсан мэдээллийн шинж чанараас хамааран үүсэх үр дагаврыг нь харгалзан холбогдох хуулиар тодорхойлсон хариуцлагыг хүлээлгэнэ. Задруулахыг хориглосон мэдээлэлтэй харьцах тохиолдолд тухайн этгээд тусгай журмын дагуу уг мэдээллийг задруулахгүй тухай баталгаа гаргана. Ийм мэдээлэлтэй танилцсан болон ажил үүргээ гүйцэтгэх явцад мэдсэн тухайн ажиллах хугацаанд төдийгүй ажлаас халагдсан, чөлөөлөгдсөний дараа уг мэдээллийг албан ёсоор ил болгох хүртэл хугацаанд задруулахгүй байх үүрэг хүлээдэг. (Д.З; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙГ ӨМЧЛӨГЧ (*Information owner*) Аливаа мэдээллийг үүсгэх, цуглуулах, боловсруулах, түгээх, устгах эрхийг өөртөө хууль ёсоор хадгалж байгаа этгээд. Монгол Улсын хууль тогтоомжид зааснаар гадаад улс, олон улсын байгууллагаас шилжүүлэн өгснөөс бусад төрийн болон албаны нууц нь Монгол Улсын төрийн өмч байна. Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд, албан тушаалтан, иргэн хариуцсан,

эсхүл өөрт байгаа төрийн болон албаны нууцыг хууль тогтоомжийн дагуу эзэмшиж, ашиглаж хамгаалах үүрэг хүлээдэг. Иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа үндэсний ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой, эсхүл хохирол учруулах мэдээлэл, түүний тээгчийг нууцлах шаардлагатай гэж үзвэл өмчлөгчтэй зөвшилцөн түүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр нөхөн төлбөртэй болон төлбөргүйгээр төрийн өмчид авч болох нөхцөлтэйгөөр манай улсын холбогдох хууль тогтоомжид тусгагдсан байдаг. (Д.З; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙН АЛБАН ЁСНЫ ЭХ СУРВАЛЖ (*Official source of information*) Иргэний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор өгөх мэдээллийн бодит байдлыг илэрхийлэх хууль ёсны эх үүсвэр. Монгол Улсын Үндсэн хуульд иргэн “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэж заасан бөгөөд иргэн, иргэдийн байгуулсан хуулийн этгээдэд өгч байгаа мэдээлэл албан ёсны эх сурвалжаар баталгаажсан байх нь уг эрхийн гол баталгаа болдог. Энэхүү баталгааг хангаж чадах албан ёсны эх сурвалж нь уг мэдээллийн эх үүсвэр болсон төр, түүний байгууллага байх ба мэдээлэл өгөх ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн хэлбэрээр явагдах шаардлагатай. (Д.З; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ (*Information security*) Үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, байгууллагын мэдээллийн бүрэн бүтэн болон, үнэн зөв, хамгаалалттай, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах цогц тогтолцоо.

Энэхүү цогц тогтолцоо нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хууль эрх зүйн зохицуулалтын орчин, мэдээллийн системийн техникийн нөхцөл, шаардлагын стандарт, үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах зэрэг кибер гэмт хэрэгтэй тэмцэх чадавх, төрийн болон онц чухал дэд бүтэц бүхий байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах мэргэжлийн байгууллагуудын сүлжээ, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон улсын хамтын ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай иргэдийн мэдлэг, боловсрол зэрэг олон талт бүтэцтэй. (Д.3; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО (*Information Security Policy*) Байгууллагын мэдээллийн бүрэн бүтэн байдал, нууцлал, хүртээмжтэй байдлыг ханган ажиллах талаар мэдээллийн системийн найдвартай байдлыг хамгаалах тогтолцоог урт хугацаанд тодорхойлсон баримт бичиг. Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын бодлого Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартад нийцэж байх ёстой бөгөөд энэ шаардлагын үүднээс тухай бүр шинэчлэн мөрдүүлдэг. Байгууллагын мэдээллийн тогтолцоо аюулгүй байдлын бодлогын дагуу зохион байгуулагддаг. (Д.3; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙН БОЛОВСРОЛ (*Information literacy*) Шийдвэр гаргах, асуудлыг шийдвэрлэх болон мэдлэгтэй болоход бүх төрлийн мэдээллийг хайж олох, үнэлэх, зохион байгуулах, хэрэглэх болон дамжуулах цогц чадамж. Энэ нь судалгааны чадвар (research skill), шүүмжит сэтгэлгээ (critical thinking), мэдээллийн технологийн чадвар (information

technology skill) болон харилцааны чадвар (communication skill)-ын хослол юм. Мэдлэгтэй иргэний хувиар нийгмийн харилцаанд оролцох, ажлын байранд үр дүнтэй ажиллах, эрдмийн амжилт гаргах болон насан туршийн суралцахууд мэдээллийн боловсрол нь зайлшгүй хэрэгцээ юм. Мэдээллийн боловсролтой байснаараа худал, хуурмаг, буруу мэдээллээс зайлсхийж, мэдээллийн үнэн зөвийг шүүн тунгаах чадвартай болно. Тийм ч учраас мэдээллийн боловсрол нь XXI зууны иргэн хүний заавал эзэмших боловсрол гэж тодорхойлдог. Ялангуяа төрийн албан хаагчийн зайлшгүй эзэмших чадвар юм. (Д.3; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙН БОЛОН КИБЕР ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ (*Information and cyber security*) Кибер гэмт хэрэг болон бусад аливаа төрлийн кибер халдлагаас систем, сүлжээ, өгөгдлийг хамгаалахад зориулагдсан технологи, үйл явц, арга хэмжээний цогц тогтолцоо. Төр, иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн болон түүний кибер орчны аюулгүй байдлыг хангах гол үүргийг төр хүлээнэ. Мэдээлэл, холбооны технологийн хөгжлөөс шалтгаалсан нөхцөл байдлын өөрчлөлттэй холбоотойгоор Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд энэ асуудал чухал байр суурь эзэлдэг. (Д.3; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ (*Confidentiality of information*) Төрийн болон албаны нууцад хамааруулсан мэдээлэлтэй танилцах, эсхүл тараахад хязгаарлалт тогтоох арга хэмжээ. Энэхүү хязгаарлалтыг зөвхөн хуулийн хүрээнд тогтоох ба Монгол Улсад Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний

нууцын тухай хуулиудаар тус тусын хамааралтай харилцааг зохицуулж байна. Мөн хуульд заасны дагуу төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тэдгээрийн нууцын зэрэглэл, нууцлах хугацааг зааж Засгийн газрын тогтоолоор тогтоодог. Түүнээс гадна Төрийн болон албаны нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүнийг ашиглах журмыг Засгийн газрын тогтоолоор батлан мөрдүүлдэг. (Д.3; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙН САН (*Information hub*) Тодорхой сэдвээр мэдээллийн эх сурвалжуудыг цуглуулан тэдгээрээс хайж олох боломжтойгоор нэгтгэн зохион байгуулсан бүртгэлийн тогтолцоо. Төрийн мэдээллийн сангийн тогтолцоо нь уялдаа холбоо бүхий олон чиглэл, салбарын мэдээллийн сангуудаас бүрдэнэ. Статистикийн, иргэний болон аж ахуйн нэгжийн бүртгэлийн, төрийн албаны хүний нөөцийн бүртгэлийн, эрх зүйн, эд хөрөнгийн, хот байгуулалтын, газрын, байгаль орчны гэх мэт мэдээллийн олон тооны төрөлжсөн сангууд байх ба тус тусын хууль тогтоомжоор үйл ажиллагаа нь зохицуулагддаг. Мэдээллийн технологийн ололтыг ашиглаж мэдээллийн сангуудыг нэгтгэн зохион байгуулснаар мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцох, иргэд, аж ахуйн нэгжийн мэдээлэл авах боломж, хэлбэр улам бүр хялбаршиж байна. (Д.3; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ (*Information system*) Аливаа байгууллагын удирдлага, шийдвэр гаргах, хяналт тавихад чиглэсэн мэдээлэл цуглуулах, боловсруулах, хадгалах, түгээх харилцан уялдаатай бүрэлдэхүүн хэсгүүдийн цогц бүрдэл (технологи, процесс ба хүмүүс). Мэдээллийн

систем нь зөвхөн мэдээллийг боловсруулах технологи биш, түүнийг хариуцан ажиллуулах, хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах, улмаар удирдан зохион байгуулах хүмүүсийг, системийн бий болгосон өгөгдөл болон мэдээлэл, мэдлэгийг ашиглахад чиглэсэн бизнесийн үйл ажиллагаа, дүрэм журмуудыг агуулдаг. Компьютерт суурилсан мэдээллийн систем нь техник хангамж, программ хангамж, өгөгдлийн сан, сүлжээ, үйл ажиллагааны дүрэм гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Мэдээллийн систем нь байгууллага, бизнесийн үйл ажиллагааг дэмжих, автоматжуулах, удирдлагыг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах, мэдээлэл боловсруулалтыг боловсронгуй болгох нэгэн төрлийн хэрэгсэл юм. (Д.3; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ДЭД БҮТЭЦ (*Information system infrastructure*) Харилцаа холбооны үндсэн сүлжээ, мэдээллийн сан, мэдээллийн агуулах, программ хангамж, техник хангамж зэргээс бүрдсэн бүтэц. Мэдээллийн системийн дэд бүтцийг бий болгох, хадгалах нь байгууллагын стратегийн бодлого, өргөн цар хүрээтэй төлөвлөлт, тэдгээрийн гүйцэтгэлийг тооцоход чухал ач холбогдолтой. Байгууллагын ирээдүйн хөгжилд шаардлагатай хувилбаруудыг бий болгохын тулд үүнд зориулсан мэдээллийн системийн дэд бүтцийг бий болгох хэрэгтэй байдаг. (Д.3; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ (*Information system vulnerability*) Мэдээллийн систем, системийн аюулгүй байдлын процедур, дотоод хяналт, хэрэгжүүлэлтэд гарсан гаднын халдлагад өртөхүйц сул тал. Халдлага үйлдэгчид системийн

эмзэг байдлыг ашиглан зорилгодоо хүрэх боломжтой учраас энэ талын үнэлгээг тогтмол хийлгэж, сул талыг арилгах талаар шаардлагатай арга хэмжээг даруй авч байх хэрэгтэй байдаг. Төрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой энэ шаардлага чухал тавигддаг. (Д.З; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ (Information technology) Цахим тооцоолуурт суурилсан мэдээллийг хадгалах, бүтээх, дамжуулах, солилцоход зориулсан мэдээллийн систем, программ хангамж, техник хангамжийн дизайн, хөгжүүлэлт, хэрэгжүүлэлт болон удирдлага судлал. Мэдээллийн технологи нь мэдээлэл, харилцаа холбооны технологи (information, communication technology-ICT)-ийн дэд олонлог юм. МЭӨ 3000 орчим жилийн тэртээ Месопотами дахь Шумерчууд бичиг үсэг хэрэглэх болсноос хүн төрөлхтөн мэдээллийг хадгалах, олборлох, ашиглах болон солилцох болсон ч орчин үеийн мэдээллийн технологи гэх нэр томьёог анх хэрэглэсэн нь Харолд Ж Леавит болон Томас Л Вислер нар 1958 онд “Харвард Бизнесийн тойм” сэтгүүлийн нийтлэлдээ “энэ шинэ технологид одоогоор ямар нэг тогтсон нэр алга. Үүнийг мэдээллийн технологи гэж нэрлэж болох юм” гэжээ. Тэдний тодорхойлолт нь боловсруулах арга техник, шийдвэр гаргахад статистик болон математик аргыг хэрэглэх, компьютерын программаар дээд эрэмбийн сэтгэлгээг загварчлах гэсэн гурван төрөлтэй байв. (Leavitt, Harold J.; Whisler, Thomas L. 1958). Мэдээлэл, харилцаа холбооны технологийн чадвар нь XXI зууны иргэний заавал эзэмших ур чадварын нэг. Мэдээллийн технологи нь дараах давуу талуудыг

бий болгож байна. Үүнд: -Харилцаа холбооны шуурхай, хямд, үр өгөөжтэй шинэ хэлбэр, боломжийг нээсэн; -хэл, газар зүйн байршил, соёлын зааг багасаж ялгаатай улс орны өөр хэл, соёлтой хүмүүс маш хялбараар хоорондоо мэдээлэл, мэдлэг солилцох, хамтрах болсон; -Бизнес дэлхий даяар 7 хоногийн турш өдрийн 24 цагаар (24/7) нээлттэй байх боломж; -Байгууллага шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангагдаж, өөрийн үйл ажиллагаа, үйлчилгээг автоматжуулснаар зардлыг бууруулж, бүтээмжийг өсгөж, үйлчилгээ шуурхай хүртээмжтэй болсон; Мэдээллийн технологийн тусламжтай олон шинэ ажлын байр үүсэх болсон; -Орон зайнаас үл хамааран харилцах, ажиллах боломж бодит болсон, -Боловсролын салбарт МХХТ-г ашиглах болсноор цахим сургалт, холимог сургалтын хэлбэрүүд албан болон албан бус, насан туршид суралцахууд нэвтэрсэн зэргийг нэрлэж болно. Энэ салбар хөгжихийн хэрээр хүмүүс, албан байгууллагын дунд мэдээллийн өрсөлдөөн бий болсноор ашигтай мэдээлэл түрүүлж авсан тал амжилтад хүрэх хандлага бий болов. (Д.З; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АСУУДАЛ ЭРХЭСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА (Government Agency of Information Technology) Харилцаа холбоо, мэдээллийн технологи, шуудан, өргөн нэвтрүүлэг, сансрын технологи, инновац, мэдээллийн аюулгүй байдал, цахим засаглалын талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн төсөл боловсруулах, салбарын хөгжлийн стратегийг тодорхойлох, бодлогын удирдамжаар хангах үүрэгтэй Засгийн газрын тохируулагч агентлаг. Анх 2004 онд Засгийн Газрын

бүтцийг шинээр батлахдаа мэдээлэл, харилцаа холбооны асуудлыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд засгийн газрын тохируулагч агентлаг – Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар байгуулж байв. (Д.З; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ДЭД БҮТЭЦ (*Information technology infrastructure*) Мэдээллийн технологийг ашиглах, удирдахад шаардлагатай техник хангамж, программ хангамж, сүлжээ, тэдгээрийг ашиглан хүргэж байгаа үйлчилгээ зэргээс бүрдэх бүтэц. Байгууллагын мэдээллийн технологийн дэд бүтэц нь байгууллагад ажиллагсад, хамтрагчид, үйлчлүүлэгчдэдээ энэ талын шийдэл, үйлчилгээг хүргэх боломжийг олгодог бөгөөд ихэвчлэн байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой. (Д.З; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (*One stop IT Service*) Хэрэглэгч мэдээллийн нэгдсэн цахим санд хандан хэрэгцээт мэдээлэл, үйлчилгээгээ мэдээллийн технологийг ашиглан нэг дороос авах боломжит тогтолцоо. Мэдээлэл, үйлчилгээг цахим хэлбэрээр болон бусад олон эх сурвалжаас олж авахад бэрхшээл учирдаг тул мэдээллийн технологийн нэг цэгийн үйлчилгээг бий болгох замаар хэрэглэгчийн энэхүү бэрхшээлийг арилгаж, үйл ажиллагааг нь хөнгөвчлөхийн зорилгоор нэг цахим хаягаар хандаж, нэг дороос үйлчлүүлэх боломжийг хангах үүднээс үндэсний хэмжээнд чухал эрэлт хэрэгцээтэй мэдээллийг нэгтгэн төрөлжүүлж нэг санд байршуулан хүргэх тогтолцоог бүрдүүлдэг. (Д.З; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙН ТУНГАЛАГ БАЙДАЛ (*Information transparency*) Иргэн, хуулийн этгээд мэдээлэл авах эрхийнхээ хүрээнд төрийн байгууллагын бодлого, шийдвэр, үйл ажиллагааны нууцад үл хамаарах мэдээллийг чөлөөтэй авах боломжит нөхцөл. Мэдээллийн ил тод байдал нь сайн засаглалын үндсэн ойлголтуудын нэг бөгөөд ардчилсан нийгэмд төрийн бодлого, үйл ажиллагаа олон нийтийн хяналттай, шударга, оновчтой байх баталгаа болдог. Иргэд хуулийн этгээдэд тэдгээр мэдээлэл ил тод байх эрх зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг төр хүлээнэ. Манай улсад Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар энэхүү харилцааг зохицуулж байна. (Д.З; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛИЙН ХУВИЙН НУУЦЛАЛ-ЫН АСУУДАЛ (*Information Privacy Concerns*) Цахим орчинд бусадтай хуваалцахыг хүсээгүй мэдээллийн нууцлалаа хадгалах нөхцөл бүрдүүлэх талаар хувь хүний зүгээс анхаарах асуудал. Цахим орчинд ажиллаж, мэдээлэл үүсгэж байхад янз бүрийн зорилгоор тухайн мэдээлэлд халдах, хулгайлан олж авах оролдлого гардаг тул мэдээллийн хувийн нууцлалыг хадгалахад халдлагын арга хэлбэр болон түүнээс хамгаалах арга ажиллагааны талаар мэдлэг, чадвар эзэмших нь чухал. Төрийн албанд цахим технологийг ашигласан мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах нь тухайн мэдээлэлтэй харьцаж байгаа ажилтан бүрийн үүрэг ба байгууллага энэ талаар холбогдох арга хэмжээ авах үүрэгтэй. (Д.З; Ч.Л нар)

МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ АЖИЛЛАГАА (*Information provision*) Ямар нэг зорилгод нийцүүлсэн байдлаар

өөрчлөөгүй мэдээллээр хэрэглэгчдийг хангах үйл ажиллагаа. Монголд Улсад төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахтай холбогдсон харилцааг мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар зохицуулдаг. Чөлөөт өрсөлдөөнд суурилсан ардчилсан нийгмийн харилцаанд оролцож байгаа бүх талууд мэдээлэл олж авах, хүртэх, ашиглах таатай нөхцөлөөр хангагдаж байж тус тусын хэрэгцээгээ ханган биелүүлэх боломжтой. Бодит мэдээллээр бүрэн хангагдаагүйгээс алдаатай бодлого явуулах, шийдвэр буруу гаргах, бололцоогоо бүрэн ашиглахгүйд хүрэх, өрсөлдөөнд эн тэнцүү оролцож чадахгүй болох, үл ойлголцол үүсэх зэрэг олон төрлийн таагүй үр дагаврууд үүсэх эрсдэлтэй. Ялангуяа мэдээллийн технологийн хурд, багтаамж, цар хүрээ, ач холбогдол өсөхийн хэрээр шаардлагатай мэдээллээр цаг алдалгүй хангах, хангагдах хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. (Д.З; Ч.Л нар)

МЭДЭЭЛЭЛ (*Information*) Аливаа харилцаа, эсвэл өгөгдөл, баримтын талаарх мэдлэгийг илэрхийлж байгаа бичвэр, тоо, график, дуу, дүрс, хүүрнэсэн болон газрын зураг зэрэг юм. Мэдээлэл нь мэдээлэл (*informare*) гэдэг латин үгнээс гаралтай бөгөөд ямар нэг асуултын хариулт болдог. Түүнчлэн мэдээлэл нь өгөгдөл ба мэдлэгтэй холбогдоно. Өгөгдсөн агуулгын хүрээнд өгөгдлийг боловсруулж, зохион байгуулж, бүтэцлэж үзүүлэн хэрэглэхэд бэлэн болгосныг мэдээлэл гэнэ. Өгөгдөл, мэдээлэл, мэдлэгийн хамаарлыг дүрсэлсэн мэдлэгийн суварга (*knowledge pyramid*)-д

боловсруулсан өгөгдлийг мэдээлэл (*informtion*), цэгцэлсэн мэдээллийг мэдлэг (*knowledge*), үнэн зөвийг тунгаасан мэдлэгийг эцэ (*wisdom*) гэж тодорхойлжээ. Төрийн ил тод байдлын зарчмыг хангах зарчмаар иргэн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хуулиар зохицуулдаг. Төр өөрт байгаа мэдээллээр үйлчлэх зорилгоор төрийн мэдээллийн санг цогцоор нь болон салбар бүрээр мэдээллийн сангийн платформ үүсгэдэг. Сүүлийн үед мэдээллийн гаргаж авсан түүхий эд болох өгөгдлийг нээлттэй нийтлэх төрийн нээлттэй өгөгдлийн санаачилгууд хэрэгжиж буй. (Д.З; Ч.Л нар)

МЭДЭЭЛЭЛ АВАХ ЖУРАМ (*Access to information act*) Иргэн, хуулийн этгээд нь хууль ёсны эрхийнхээ хүрээнд төрийн болон бусад байгууллагаас мэдээлэл авах харилцаа болон баталгааг зохицуулсан эрх зүйн баримт бичиг. Хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг иргэн, хуулийн этгээд авахыг мэдээлэл авах журмаар хязгаарлахгүй бөгөөд уг эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн байх ёстой. (Д.З; Ч.Л нар)

МЭДЭЭЛЭЛ АВАХ ХҮСЭЛТ (*Application for information*) Иргэн, хуулийн этгээд хууль ёсны эрхийнхээ хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагаас мэдээлэл авахыг хүссэн өргөдөл. Мэдээлэл авах хүсэлтийг амаар, бичгээр гаргаж болох бөгөөд хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд

мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллээр хүсэлтийн дагуу хангах үүргийг төрийн байгууллага хүлээнэ. (Д.3; Ч.Л нар)

МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ (*Right to information*) Төрийн бодлого, шийдвэр, үйл ажиллагааны талаар болон бөөмжөөр хангуулах иргэний эрх зүйн байдал. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “17/төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.”, гэж заасан бөгөөд Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн тухай Олон улсын гэрээнүүдэд мэдээлэл авах эрхийн талаар баталгаажуулан тусгасан. Манай улсад иргэн, хуулийн этгээд мэдээлэл авах эрхийн баталгааг мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар зохицуулдаг. Энэхүү эрхийг хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор зөвхөн хуулиар хязгаарлах боломжтой. (Д.3; Ч.Л нар)

МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ (*Law of right to information*) Төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулсан хууль. Монгол Улсад Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар иргэний мэдээлэл авах эрхийг хангах харилцааг зохицуулдаг бөгөөд энэ хуулиар тухайн эрхийг баталгаатай хангах үүргийг төр хариуцахаар заасан. Мэдээлэл авах төрийн байгууллага, албан хаагчид хуульд заасан журмын дагуу иргэн,

хуулийн этгээд хүсэлт гаргаж болно. Хүсэлтийг хүлээж авсан тал хууль ёсны хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн хариу мэдэгдэх үүрэг хүлээдэг. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар хүсэлтэд тавигдах шаардлага болон хүсэлтийг шийдвэрлэх ажиллагааны талаар зохицуулсан. Төрийн байгууллагаас хүний эрхийг хангах зорилгоор мэдээлэл хүсэгчид заавал өгөх нэн шаардлагатай мэдээлэл үнэ төлбөргүй байна. Харин мэдээлэл хүсэгчийн тусгай хэрэгцээнд зориулагдсан зарим мэдээллийг өгөхтэй холбоотой гарах зардлыг өөрөөс нь гаргуулахыг журамлан хэрэгжүүлж болохыг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар зөвшөөрсөн. (Д.3; Ч.Л нар)

МЭДЭЭЛЭЛ ЗҮЙ (*Informatics*) Тооцоолох машины тусламжтайгаар мэдээллийг системтэй дүрслэх, хадгалах, боловсруулах, дамжуулахыг судалдаг шинжлэх ухааны салбар. Германы эрдэмтэн Карл Штейнбух 1957 онд “Информатик: Мэдээллийн автомат боловсруулалт” хэмээх эрдэм шинжилгээний өгүүлэлдээ информатик гэдэг үгийг анх хэрэглэжээ. Информатик (Informatik) гэдэг герман үгийг англиар информатикс (informatics) хэмээн хөрвүүлдэг ч компьютерын ухаан (computer science) нэр томьёогоор ихэвчлэн хэрэглэдэг. Монголд мэдээлэл зүйг информатик нэршлээр нь бас хэрэглэдэг. Мэдээлэл зүй буюу информатикыг онолын, хэрэглээний болон техникийн гэж ангилдаг. Мэдээлэл зүй нь онолын асуудлыг шийдвэрлэхээс гадна нийгмийн болон бусад салбарын өгөгдөл, мэдээлэл, мэдлэгийг боловсруулахад өргөнөөр ашиглагдах болсноор

бизнесийн мэдээлэл зүй, анагаахын мэдээлэл зүй, гео-мэдээлэл зүй, биоинформатик г.м салбарууд үүссэн. Даяаршил цахим шилжилтийн өнөө үед Төрийн удирдлагын үйл ажиллагаанд мэдээлэл зүйн ухааны ололтыг өргөнөөр хэрэглэх шаардлага зүй ёсоор тавигдан мэдээллийн урсгалыг нэгтгэн бодлого болгож боловсруулах, үр нөлөөг тооцоолон үйл ажиллагаагаа зохион байгуулахад мэдээлэл зүйн шинжлэх ухааны арга, аргачлалд үндэслэх явдал амжилт олохын гол баталгаа болж байна. (Д.З; Ч.Л нар)

МЭДЭЭЛЭЛ ХАЙХ ЭРХ (*Right to seek information*) Иргэн, хуулийн этгээд үндсэн эрхийнхээ хүрээнд хуулиар хязгаарлаагүй арга хэлбэрээр мэдээлэл олж авахад хэрэгцээтэй мэдээллээ чөлөөтэй эрэн сурвалжлах боломжийн талаар баталгаагаар хангагдсан эрх зүйн байдал. Мэдээллийг хайх, олж авах, түгээх үе шат нь бие биетэйгээ нягт уялдаа холбоотой үйл явц бөгөөд энэхүү үйл явц, үе шатыг дамжиж мэдээлэл олон нийтэд хүрч нийтийн хүртээл болдог тул мэдээлэл хайх нь хүний мэдээлэл авах эрхийн салшгүй хэсэг нь юм. Манай улсад Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн зорилтын хэсэгт энэ талаар тусгасан байдаг. (Д.З; Ч.Л нар)

МЭДЭЭЛЭЛ ХҮСЭГЧИЙН ЭРХ (*Rights of information applicant*) Мэдээлэл хүсэгч хүссэн мэдээллээ авах эрх зүйн баталгаа. Мэдээлэл хүсэгчийн эрх, түүнийг хангах эрх зүйн болон бусад боломж нөхцөл бүрдсэн үед мэдээлэл авах эрх нь хангагдана. Ардчилсан нийгэмд төр энэ талаар бүх талын арга хэмжээ авах үүрэг хүлээнэ. Монгол Улсад Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар энэ харилцааг зохицуулсан. Энэ хуульд: мэдээлэл хүсэгч нь эрх тэгш

байх, мэдээлэл авах хэлбэрээ сонгох, мэдээлэл авах болсон шаардлага, үндэслэлээ тайлбарлахгүй байх, мэдээллийн агуулгын талаар амаар тайлбарлуулах, мэдээллийн албан ёсны эх сурвалжийг мэдэх, мэдээлэл авах эрхийг нь зөрчсөн гэж үзвэл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах зэрэг эрхийг эдэлнэ. (Д.З; Ч.Л нар)

МЭРГЭЖЛИЙН БАЙДАЛ (*Professionalism*) Энэ нь Латины “*professionem*” үгнээс үүдэлтэй бөгөөд үгийн үндэс нь “*profession*” юм. Үгийн утга нь анхандаа “ямар нэг зүйлийн албан ёсны мэдүүлэг (*any solemn declaration*) (XIV зуун)” гэсэн санааг илэрхийлж байсан. Харин XV зууны эхээр “тодорхой ажил мэргэжлийг эрхлэх хэн нэгний эзэмшсэн мэргэжлийн ур чадвар” гэсэн утгыг илэрхийлэх болжээ. Мэргэжлийн хүн (буюу мэргэжилтэн) гэдгийг тодорхойлох шинж чанар (мэдлэг, чадвар, хандлагатай холбоотой)-ыг илэрхийлсэн нэр юм. Гэхдээ энд шинжлэх ухааны аль нэг салбарыг тусгай хөтөлбөрийн дагуу суралцаж (учир нь мэргэжил бүхний агуулга өөр өөр байдаг) эзэмшсэн мэдлэг, түүнийгээ амьдралд хэрэглэх чадварыг хамаатуулж ойлгоно. Энэхүү хөтөлбөрийн дагуу суралцаж, тухайн мэргэжилд зайлшгүй шаардлагатай мэдлэг чадвар, дадлыг эзэмшсэн нөхцөлд мэргэжлийн диплом олгож албан ёсоор баталгаажуулдаг. “Мэргэжил нь эзэмшсэн хүндээ материаллаг болон оюуны баялаг, үнэ цэнийг бүтээж, орлого олж амьдрах хэрэгсэл тул тухайн ажил мэргэжилд зайлшгүй шаардлагатай мэдлэг чадвар, дадлыг эзэмшүүлж, шинж чанарыг төлөвшүүлэхэд чиглэнэ”.¹⁰ (Т.Т)

¹⁰ Д.Гомбо (2013), Мэргэжлээ сонгох нь, х. 5.

МЭРГЭЖЛИЙН ЛОББИ БҮЛЭГ

(Lobbies, professional) Лобби нь гудамж, хонгил, үүдний өрөө гэсэн утгатай англи үг бөгөөд улс төрийн хэллэгт “парламентад нөлөөлөх” үйлдэл гэсэн утгаар хэрэглэгддэг. Тодорхой бүлэг хүмүүсээс өөрсдийн эрх ашигт нийцсэн шийдвэрийг эрх мэдэл бүхий хүмүүсээр гаргуулахыг оролдсон нөлөөллийн үйл ажиллагааг лобби гэнэ. Лобби хийх нь сонирхлын бүлгийн зүгээс тодорхой нэг улс төрийн шийдвэрийг дэмжих, эс дэмжих зорилгоор хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудад үзүүлж буй хууль ёсны нөлөөлөл гэж тодорхойлно. Лоббизмийн судалгаанд нийгмийн бодлогод нөлөөлөх оролдлогуудаас мэргэжлийн лобби нь хийх үйл явцыг ялган авч үздэг. Америк болон Европын холбооны улсуудад лобби фирмүүдийн тодорхойлолтод мэргэжлийн бүлгүүд төр, нийгмийн бодлогод нөлөөлөх оролдлыг лобби ажиллагаанд багтааж үздэггүй. Бодлогын судалгааны байгууллагууд буюу заримдаа тинк танк гэж нэрлэдэг мэргэжлийн бүлгүүд нь төрийн байгууллагуудад лобби хийх зөвшөөрөл байдаггүй, харин төрийн бодлого боловсруулагчдад дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангахад чиглэгддэг. Эдгээр бүлгүүд ихэнхдээ “special interest group буюу тусгай сонирхлын бүлэг” хэмээх нэршилтэй. Эдгээр байгууллагууд нь тодорхой асуудлыг судалж, тайлан гаргадаг, ашгийн бус, гишүүнчлэлгүй, татвараас чөлөөлөгдсөн байна. Мөн эрдэмтэн, судлаачдын оролцоотойгоор төрийн бодлогын давуу болон сул талуудыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл хийх, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг хийдэг. Америкт мэргэжлийн лоббистууд ажиллах нөхцөл бүрдсэн

бөгөөд тэдний үйл ажиллагааг хууль ёсоор хүлээн зөвшөөрч, албан ёсны бүртгэлтэй болгох нь лобби ажиллагааны талаарх сөрөг хандлага, үйлдлүүд хязгаарлагддаг болсон. (Я.Т)

МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА (Professional assistance)

Тухайн үйл ажиллагаатай холбоотой боловч хэрэгжүүлэхэд төвөгтэй, өөр төрлийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар ихээхэн шаарддаг үйл явцад хэрэгцээт мэргэжил, арга зүйгээр дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ. Энэ нь харилцан ялгаатай үүрэг чиглэл бүхий төрийн байгууллагуудад төрийн албаны төв байгууллагаас төрийн албаны хүний нөөцийн удирдлага, албан хаагчдын сургалт хөгжил, хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, томилгоо, хүний нөөцийн аудиттай холбоотой мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэргэжил, мэргэжлийн арга зүйн сургалт зохион байгуулах, түүнийг ашиглах зэрэг бусад ижил төстэй харилцааг тайлбарлах, тодорхойлоход хэрэглэгдэнэ. (Г.Б)

МЭРГЭШСЭН БАЙДАЛ (Qualification)

Энэ үгийн үндэс нь “qualify” буюу Латины “qualis” гэх үгнээс гаралтай. Үгийн утга нь анхандаа “хязгаарлах (limit), сайжруулах/ өөрчлөх (modify)” санааг илтгэж байв. Үгийн ерөнхий утга нь 1580 оноос “ажилд тохирох/таарах (be fit for a job)”, 1723 оноос “зайлшгүй урьдач нөхцөл/бэлэн байдал (necessary precondition)” гэсэн санааг илэрхийлэх болжээ. Монгол хэлний тайлбар толь мэргэших гэдгийг ямар нэг юманд “чадмаг, сурмаг болох, дадамгайрах” гэж тайлбарласан байснаас үзвэл мэргэшсэн байдал нь тодорхой шинжлэх ухааны аль нэг салбарыг

нь дагнан судалж, аливаа зүйлийг гаргууд сайн хийдэг болох чадварыг хэлнэ. Ерөнхий мэргэжлийн хүрээнд тодорхой чиглэлийг гүнзгийрүүлэн суралцаж нэмэлт мэдлэг, чадвар, дадлыг олж авсан байдал юм. Төрийн албан хаагчийн мэргэшсэн байдал нь өөрийн эрхэлж буй ажил үүргээ чадмаг, сурамгай хийх дадал зуршилтай холбоотой. Энэхүү мэргэшлийн байдал нь ажлын байранд тавигдах шаардлага, стандартад нийцсэн байна. Монгол Улсын Төрийн албаны тухай (шинэчилсэн найруулга, 2017) хуулиар төрийн жинхэнэ алба нь мерит зарчимд үндэслэх, мэргэшсэн байх, тогтвортой ажиллах, шатлан дэвших тогтолцоогоор ажиллахаар тогтоосон. Төрийн албанд мэргэшсэн байхын нэг үндэс нь мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалт гэдгийг энэ хуулиар тодорхойлсон. Төрийн захиргааны албан тушаалын ангилал бүрд нийцсэн мэргэшүүлэх сургалт байх бөгөөд төрийн албан хаагчийг ангилал дэвшүүлэн тодорхой албан тушаалд томилохоос өмнө тухайн ангиллын мэргэшүүлэх багц сургалтад хамруулсан байх, харин тодорхой албан тушаалд томилогдсоны дараа тухайн албан тушаалын онцлог, чиг үүрэгт нийцсэн богино болон дунд хугацааны сургалтаар мэргэшүүлэх, чадавхжуулах шаардлагатай болж байна. (Г.Т)

МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ (*Professional trainings*) Төрийн захиргааны ахлах болон түүнээс дээш албан тушаалын ангилалд хамаарах албан тушаалд ажиллах болзол хангасан албан хаагчдыг давтан сургах, мэргэшүүлэхэд чиглэсэн сургалтын агуулгыг багтаасан хөтөлбөр. Мэргэшүүлэх сургалт нь нэгдсэн бодлого, зохион байгуулалт,

төвлөрсөн тогтолцоогоор хэрэгжинэ¹¹. Үүнд тухайн байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэг, хэрэгцээ шаардлагад нийцсэн мэдлэг чадварыг бий болгоход анхаарна. Мэргэшүүлэх сургалтын шаталсан, тасралтгүй байдлыг хангаж, мэргэшүүлэх түвшний уялдаа, холбоог хангана. (Г.Б)

¹¹ Д.Цэдэв: “Төрийн албан хаагчдын сургалтын бодлого, чиг хандлага”, Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөн 2018, х. 15.

Н

НАМ (*Party*) “Party” хэмээх үг нь латин гаралтай (*pars*) гэсэн үг бөгөөд хуваагдах, салах гэсэн утгатай. Англи-Франц хэлний “*partie, part*” хэсэг, тал хэмээх утгатай мөн холбогддог байна. 1919 оны үеэс орчин үеийн улс төрийн нам гэдэг утгаар хэрэглэгдэх болсон. Улс төрийн нам бол улс төрийн харилцааны гол институт юм. Ж.Сартори улс төрийн намыг “Улс төрийн үзэл санаа, үзэл баримтлал, сонирхлоороо нэгдсэн хүмүүсийн бүлэг”¹ гэж тодорхойлсон. Улс төрийн сурах бичгүүдэд “Нам гэдэг нь нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхол, зорилго, эрмэлзлийг нэгтгэн илэрхийлж, өөрийн үзэл баримтлалд тулгуурлан нийгмээ хөгжүүлэх удаан хугацааны бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх чадавх, мэдлэг бүхий идэвхтэй хэсгээс бүрдэж, төрийн эрх мэдлийг олж авах, хэрэгжүүлэхэд тэднийг удирдан зохион байгуулдаг улс төрийн нэгдэл юм” хэмээх тодорхойлсон нь нийтлэг байна. Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн нэгдүгээр зүйлд “Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах

зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн” гэж тодорхойлжээ. Улс төрийн намыг тодорхойлохдоо дараах шалгуурыг баримтална. Үүнд хэр удаан оршиж байна, цаашид оршиж чадах эсэх, нутаг дэвсгэрийн хувьд хэр зохион байгуулагдсан, сонгуулиар шаардлагатай санал авч чадах лидер, гишүүд, дэмжигчтэй байгаа эсэх, сонгуульд ялж төрийн шийдвэр гаргах түвшинд төлөөлөлтэй болох эрмэлзэлтэй эсэх зэрэг шалгууруудыг багтаадаг. Америкийн улс төр судлаач Ла.Паломбара, М.Винер нар “Улс төрийн нам ба улс төрийн хөгжил” бүтээлдээ: орчин үеийн намыг улс төрийн бусад байгууллага, институтээс ялган үзэх дараах дөрвөн бүлэг шалгуурыг боловсруулсан: 1) Улс төрийн нам нь урт удаан хугацааны туршид оршин тогтнох чадвартай байх. Тухайлбал, нам нь өөрийгөө үндэслэн байгуулагчаас хойш урт хугацааны турш оршин тогтнох чадвартай болохоо харуулсан байх. 2) Нам нь нийт үндэсний болон орон нутгийн түвшинд зохион байгуулагдсан бүтэцтэй байх. Тус байгууллага нь зөвхөн хот, төв суурин газарт бус тухайн нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарч, хүн амын олонход хүрч ажиллаж чадахуйц зохион байгуулалтын бүтэцтэй байх.

¹ Sartori G. Parties and Party System. London. 1976. p. 23.

3) Удирдах төв болон орон нутгийн байгууллага нь засгийн эрхийг авч хэрэгжүүлэх зорилго, эрмэлзэлтэй байх. 4) Сонгуулийн, эсхүл улс төрийн бусад аргаар намын гишүүд, сонгогч олон түмний зүгээс үлэмжхэн дэмжлэг авсан байх зэрэг шалгуур үзүүлэлтүүдэд тохирч байгаа аливаа олон нийтийн байгууллагыг нам хэмээн үзэж болно хэмээн тэмдэглэсэн. Үүнээс гадна намын талаарх үндсэн ойлголтод түүний нийгэмд гүйцэтгэх үүрэг түүний хөгжлийн өөрчлөлтүүдийг дурдах хэрэгтэй. Нам нь чиг үүргийн хувьд дотоод, гадаад үндсэн долоон үүргийг гүйцэтгэж, эдгээр үүргүүдээр дамжуулан нийгэм, улс төрийн харилцаанд эзлэх байр суурь, төлөвшил, үнэлэмжийг тодорхойлж байдаг.

1. Нам дэмжигчдээ улс төрийн талаар гэгээрүүлэх, гишүүн элсүүлэх,
2. Сургалт, семинар, уулзалт зэргийг зохион байгуулж, анхан шатны байгууллагаа идэвхжүүлэх,
3. Улс төрийн боловсон хүчнийг шилж сонгох, элит лидерүүдийг бэлтгэх үүргүүдийг дотоод чиг үүрэгт багтаана,
4. Иргэдийн улс төрийн идэвхийг сэргээх, улс төржүүлэх,,
5. Бусад нам, эвсэл, холбоодтой хамтран ажиллах
6. Намын хяналтыг өргөжүүлэх,

Улс орныг хамарсан улс төрийн бодлого боловсруулах үүргүүдийг гадаад чиг үүрэгт багтаан үздэг.

Улс төрийн намуудыг зохион байгуулалтын бүтэц, гишүүнчлэл, үзэл суртал, байр суурь, нийгмийн бааз бүлэг, үйл ажиллагааны чиглэл зэрэг үзүүлэлтийн шалгуураар ангилна. (Я.Т)

НАМЫН УДИРДЛАГА (*Party leadership*)

Энэ нь нийгмийн социалист тогтолцооны үед хэрэглэгдэж байсан нэр томьёо юм. БНМАУ-ын Үндсэн хуульд (1960) “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төр, нийгмийг удирдан чиглүүлэгч хүч бол бүхнийг ялагч марксист-ленинист онолыг үйл ажиллагаандаа удирдлага болгодог Монгол Ардын Хувьсгалт Нам мөн” хэмээн заажээ. Үндсэн хуулийн дагуу МАХН улс орныг удирдан залж, Программ, Намын их, бүгд хурал, Улс төрийн товчооны шийдвэрээр улсыг хөгжүүлэх зорилт, олон нийтийн байгууллага, хөдөлмөрчдийн үйл ажиллагааны зарчим чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтэд нь үнэлэлт дүгнэлт өгч, боловсон хүчнийг шилж сонгох ажлыг эрх мэдэлдээ төвлөрүүлж байв. Энэ нь нам, төрийн зааг ялгааг үгүй хийж, улсын бүхий л эрх мэдлийг нэг намын гарт төвлөрүүлэх хүчирхэг хэрэгсэл болж байв. МАХН-ын байгууллагууд үйлдвэрлэл, нутаг дэвсгэрийн зарчмаар байгуулагддаг байсан учир засаг захиргааны бүх нэгжүүд, үйлдвэр аж ахуйн газруудад намын үүр, хороод ажилладаг байв. Эдгээр байгууллагууд түшиглэсэн газрынхаа бүхий л үйл ажиллагаанд оролцохын зэрэгцээ ялангуяа боловсон хүчний асуудлыг дагнан эрхэлдэг байжээ. МАХН улс төрийн өөр хүчин буй болсон бодит байдлыг харгалзан улс орны удирдан чиглүүлэгч хүчин гэсэн Үндсэн хуулийн заалтаас татгалзсан юм. (А.Ц)

НИЙГМИЙН БАЯЛАГ (*Public goods*)

Төрөөс нийлүүлдэг, нийгмийн гишүүд тэгш эрхтэйгээр хэрэглэдэг, хэн нэгний хэрэглээг ялгаруулан хасаж, хязгаарлах боломжгүй тийм баялаг, үйлчилгээг нийгмийн баялаг гэнэ. Нийгмийн баялгийн онолыг анх

1954 онд Паул Сэмүэлсон (Paul Samuelson) судлаачийн дэвшүүлснээр² уг ойлголт хурдацтай судлагдаж эхэлсэн. Нийгмийн баялаг нь нийгмийн сайн сайханд чиглэсэн олон нийтэд ач тус өгдөг шинж чанартай. Тухайлбал, батлан хамгаалах, хууль сахиулах үйлчилгээ, дэд бүтцийн хангамж, суурь боловсролын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ зэрэг нь үүний жишээ юм. Хэрэв хэн нэгэн бусдын хэрэглээг бууруулахгүйгээр өөрийн хэрэглээг нэмэгдүүлж чадвал энэ нь өрсөлдөөнийг бий болгож чаддаггүй. Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн энэ төрлийн бараа, үйлчилгээг зах зээлд нийлүүлэхэд богино хугацаанд зардлаа нөхөж, ашиг олоход хүндрэлтэй учир ихэвчлэн төр нийлүүлэгчийн үүргийг гүйцэтгэдэг. Түүний бусад зах зээлд болон нийт эдийн засгийн хөгжилд үзүүлэх гадаад зэрэг нөлөө өндөр байдаг. Жишээлбэл, зам, харилцаа холбоо зэрэг дэд бүтэц сайн байх нь бусад салбарт бизнес эрхлэгчдийн зардлыг бууруулах, иргэдийн суурь боловсролын түвшин, эрүүл мэндийн үзүүлэлт сайн байх нь бүтээмжид эерэгээр нөлөөлж эдийн засгийн хөгжлийг дэмжинэ. (Б.Б; Г.Б нар)

НИЙГМИЙН БАЯЛАГ БА ҮЙЛЧИЛГЭЭ **(Public goods and services)**

Нийгмийн баялаг нь хоёр үндсэн шинж чанарыг агуулдаг. Нэгдүгээрт, энэхүү баялаг, үйлчилгээг олон хүн нэгэн зэрэг хэрэглэх боломжтой, нэмэгдэл нэг хүн хэрэглэхэд илүү зардал гардаггүй буюу хэрэглээ нь өрсөлдөөнгүй (non-rival consumption) байдаг. Нэгэнт зардал гаргаад үйлдвэрлэхсэн нийгмийн баялгийг аль болох

олон хүн хэрэглэх тусам нийгмийн сайн сайхан байдал дээшилнэ. Хоёрдугаарт, нийгмийн баялаг, үйлчилгээг хэн нэгэнд онцгойлон хэрэглүүлэхгүй байх, хэрэглээг нь хязгаарлах боломжгүй (non-excludable consumption). Нийгмийн баялгийг нийлүүлсэн л бол бүх хүмүүс хэрэглэх боломжтой. Төлбөр төлсөн эсэхээс үл хамааран хүмүүс хэрэглэх нь нээлттэй учир “туулайчлах” бэрхшээл (free-rider problem) үүсдэг. Энэ шалтгааны улмаас хувийн хэвшил нийгмийн баялгийг нийлүүлэх нь ховор. Иймээс түүнийг огт нийлүүлэхгүй байх эсвэл хэт бага нийлүүлэх нөхцөл үүсдэг. Энэ байдлыг төр эсвэл тодорхой хүй хамтлаг (community) оролцож “засахаас” аргагүй болно. Олон түмэнд зориулсан нийгмийн баялгийг бүрдүүлэх нь орчин цагийн төрийн үндсэн үүргүүдийн нэг юм. Гэрэлт цамхаг, батлан хамгаалах, гудамжны гэрэлтүүлэг, үерийн хамгаалал, ёслолын буудлага, цэцгийн мандал, радио долгион зэрэг нь тэдгээрийн жишээнд орно. Эдгээрт дээрх хоёр шинж бүрэн утгаараа оршдог учир “цэвэр” ард түмний баялаг (pure public good) гэнэ. Нийгмийн баялгийн шинжийг бүрэн биш ч тодорхой хэмжээнд эсвэл зөвхөн тодорхой нөхцөл байдалд агуулсан баялаг, үйлчилгээ байдаг. Эдгээрийг “цэвэр бус” (impure) нийгмийн баялаг гэнэ. Тухайлбал: зам, кабелийн телевиз, музей үүнд багтана. Википедиа цахим тайлбар толь яг өнөөгийн байгаа хэлбэрээрээ цэвэр нийгмийн баялаг болж байна. Хэрэв түүнийг зөвхөн эрх бүхий хэрэглэгч (жишээлбэл, төлбөр төлсөн) хэрэглэдэг зохицуулалтад шилжвэл энэ нь цэвэр нийгмийн баялгийн шинжээ алдана. “Нийгмийн шинж” нь тухайн баялаг, үйлчилгээний өгөгдсөн суурь шинж чанар биш, харин технологийн

2 Cornes, Richard and Todd Sandler: The Theory of Externalities, Public Goods, and Club Goods. Cambridge: Cambridge University Press, 1986.

түвшин, зах зээлийн нөхцөл байдлаас хамаарна. Нийгмийн баялгийг газарзүйн хувьд хамрах хүрээгээр нь тодорхой хүй хамтлаг, орон нутаг, улс үндэстэн, дэлхийн гэж ангилж болно. Шинжлэх ухааны мэдлэг, шинэ нээлт, хэрэгтэй мэдээлэл (жишээ нь цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ эсвэл албан ёсны статистикийн мэдээлэл), цэвэр агаар, соёлын өв зэрэг нь нийт нийгмийн баялгийн шинж чанарыг агуулдаг. Жишээ нь: сайн засаглал, нийгэм дэх итгэлцлийн түвшин, вирусийн эсрэг дархлаажуулалт нь нийт нийгмийн баялгийн шинжтэй зүйлс юм. (Ч.Н)

НИЙГМИЙН БОДЛОГО (*Social policy*)

Хүн амын амьдралын чанар, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн төрөөс хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний цогц юм. Төрөөс хэрэгжүүлэх нийгмийн бодлого нь хүний аюулгүй байдал, эрүүл мэнд, боловсрол, сайн сайхан аж байдлын хэрэгцээг хангахад чиглэдэг. Сүүлийн жилүүдэд улс орнуудын хэрэгжүүлэх нийгмийн бодлого нь глобалчлал, улс хооронд болон бүс нутгийн хооронд хийгдэх шилжилт хөдөлгөөн, ядуурал болон нийгэм, хүн ам зүй, эдийн засгийн ба хүрээлэн буй орчны өөрчлөлтөөс үүдэлтэй сорилтуудыг даван туулах арга замыг хайхад голчлон төвлөрч байна. Боловсрол, эрүүл мэнд, соёл, спорт, аялал жуулчлал, орон сууцны хангамж, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, нийгмийн хамгаалал, халамж, нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмжийн асуудлууд нь бүгд нийгмийн бодлогод тусгагддаг тул олон талт шинжтэй. (Б.Б)

НИЙГМИЙН ДААТГАЛ (*Social insurance*) Нийгмийн даатгал нь төрөөс хэрэгжүүлэх нийгмийн бодлогын нэг хэрэгсэл бөгөөд төрөөс даатгалын зах

зээлд оролцон нийгмийн тодорхой бүлэг, хувь хүмүүст ирээдүйд тулгарах аливаа эрсдэлээс үүдэлтэй санхүүгийн хүндрэлийг давж туулахад туслах, эрсдэлийг хуваалцах зорилгоор сан бүрдүүлэх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаа юм. Нийгмийн даатгалын санд даатгуулагч хураамж төлснөөр эв санааны нэгдлийн зарчмаар сан бүрдүүлж даатгуулагч нь өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, ажилгүй болох зэрэг даатгалын тохиолдол үүсэхэд сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгч түүнийг эрсдэлээс хамгаалдаг. Нийгмийн даатгал нь ихэнхдээ заавал даатгуулах шинжтэй байдаг ба ийм хэлбэрийн даатгалын тогтолцоо анх 1883 онд Германд үүссэн.³ Монгол Улсын хувьд нийгмийн даатгал: тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний ба ажилгүйдлийн даатгал гэсэн төрөлтэй байх бөгөөд албан журмаар даатгуулах, сайн дураар даатгуулах гэсэн хэлбэртэй.⁴ Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг даатгуулагчийн төлсөн шимтгэл болон хуульд заасан бусад эх үүсвэрээс бүрдүүлж даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох үйл ажиллагааг эрхэлдэг, төрийн үйлчилгээний байгууллагыг нийгмийн даатгалын байгууллага гэнэ. (Б.Б)

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН (*Social Insurance Fund*)

Нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагдсан даатгуулагчдын төлсөн хураамж, шимтгэлээс хуримтлуулсан хөрөнгөөс бүрдсэн тусгай зориулалтын сан. Нийгмийн даатгалын сангийн орлого нь даатгуулагчийн төлсөн шимтгэл, хураамж, сангийн чөлөөт

³ <https://www.britannica.com/topic/social-insurance>

⁴ Нийгмийн даатгалын тухай хууль

үлдэгдлийг санхүүгийн зах зээлд байршуулснаас олсон орлого, улсын төсвөөс шилжүүлсэн дэмжлэг, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Харин сангийн хөрөнгийг даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмж олгох болон санг удирдах үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зарцуулдаг. Нийгмийн даатгалын сангийн ашиг, алдагдалд нийгмийн даатгалд хамрагдагчийн тоо, хүн амын дундаж наслалт, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн түвшин зэрэг нийгэм, хүн ам зүйн хүчин зүйлс, даатгалын санд төлөх шимтгэл, даатгуулагчдад төлөх тэтгэвэр, тэтгэмжийн хувь хэмжээ, даатгалд хамрагдах нөхцөл зэрэг бодлогын хүчин зүйлс нөлөөлнө. (Б.Б)

НИЙГМИЙН ЗАСАГЛАЛ (*Social governance*) Олон нийтийн нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай бүхий л бүлгийг шийдвэр гаргах үйл явцад татан оролцуулах, тэдний оролцоог хангах тухай хөнддөг засаглалын хэлбэр⁵. Засаглалын бусад хэлбэрүүдээс ялгагдах нэг онцлог нь халамж, анхаарал илүү шаардлагатай эмзэг бүлэг, эмэгтэйчүүд, хүүхдүүд, байгаль экологийн онцлогтой бүс нутгийн иргэд зэрэг төрийн бодлогын үйл явцад шууд оролцох боломж хязгаарлагдмал бүлгүүдийн оролцоог дээшлүүлэхэд анхаардаг. (Б.Б)

НИЙГМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛ (*Social engineering*) Нийгмийн инженерчлэл бол нийгмийн өөрчлөлтийг тайлбарлах арга, үзэл баримтлалыг илэрхийлсэн ихэвчлэн нийгмийн сэтгэл зүй, мэдлэгийн социологи, нийгмийн удирдлагын технологийн хүрээний ойлголт. Зарим тохиолдолд нийгмийн инженеринг нь нийгмийн технологи хэмээх ойлголттой

ихээхэн ойр хэрэглэгддэг. Нийгмийн инженерчлэл бол тэрхүү нийгмийн өөрчлөлтийн удирдах хүрээний арга, хэрэгсэл, технологи бөгөөд түүнийг хэрэглэхэд мэргэших явдал юм. Бүхэлд нь аваад үзвэл нийгмийн технологиуд юм. Энэхүү нэр томьёог хэрэглэх нь онол үзлийн төлөөлөгчдөд К.Попперд, Ф.А.фон Хайкийг нар хамаарна. К.Попперд “Түүхчлэх үзлийн гуйланчлал” бүтээлдээ нийгмийн инженерчлэлийг “тусгаар болон аажим шинэчлэл, өөрчлөлтөөр хэдийнээ бий болсон нийгмийн институтүүдийг удирдах, өөрчлөн байгуулах болон шинэ нийгмийн институтүүдийг төлөвлөх үйл ажиллагаа” хэмээсэн.

Өөрчлөлтийг удирдах нь бүхэлдээ инженерингийн асуудал бөгөөд өөрчлөлтийг саатуулах, тогтоон барих боломжгүй тул “төлөвлөгдсөн” байх ёстой гэж үздэг. Энэ нь хэсэгчилсэн болон үе шаттай нийгмийн инженерчлэл хийх урьдах нөхцөл болдог. Нийгмийн инженерчлэл хүний зан төлөвийг удирдах, хянахад зориулагдсан зохион байгуулалтын бүтэц бүхий инженеринг тул социологичид, сэтгэл зүйчдийн хувьд захиргааны бүтэц, зохион байгуулалт, удирдлагын арга хэмжээ бүхий удирдах үйл ажиллагааны олон янз байдлын илрэл гэж үзэн нийгмийн инженерчлэл захиргааны үйл явцтай холбогдох гол сэжүүр болдог. Харин нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн бүлэг, институтүүдийг өөрчлөгдөж буй нөхцөлд дасан зохицох, нийгмийн инновацыг нэвтрүүлэхэд ашигладаг тусгай арга, хэрэгсэл, технологи болох хувьдаа олон нийтийн санаа бодолд нөлөөлөх буюу “тархи угаах” зэрэг улс төрийн технологи, пиар, нийгмийн технологи болдог байна. (Б.П)

⁵ Nora Milotay, “Social Governance in the European Union: Managing Complex System”, 2020, pp. 1-2.

НИЙГМИЙН ИННОВАЦ (*Social innovation*)

Нийгмийн инновац бол инновацын үйл ажиллагааны нэгэн төрөл хэв маяг юм. Нийгэмд тулгамдаж буй асуудал, сорил, хүлээгдэж буй шийдэл нь бүхэлдээ нийгмийн өөрчлөлтийг үүсгэдэг. Чухам энэхүү зорилгын үүднээс асуудлыг шийдвэрлэх, гарц гаргалгаа хайж буй шинэ санаа, стратеги, технологийг нийгмийн инновац гэнэ. Нийгмийн инновацыг янз бүрээр тодорхойлдог ч тэдгээр нь прагматик, системийн, удирдлагын байр сууринаас, шүүн шинжлэхүйн, эдийн засгийн, харьцуулсан, түгээмэл зэрэг хандлагуудын үүднээс ихэвчлэн хандсан байдаг. Монгол Улсад Инновацын тухай хуулийг 2012 онд анх баталсан бөгөөд “инновац” гэж шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, маркетинг, зохион байгуулалтын арга, шийдэл хэмээн тодорхойлсон. “Нийгмийн инновац” хэмээх ойлголт шилдэг инноватор, гарамгай энтрепренерүүдийн нийгмийн салбар дахь шинэчлэлийн төлөө явуулсан үйл хэрэг, үр дүнтэй холбоотой бөгөөд тэр дундаа ядуурлыг бууруулах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж, бичил санхүүгийн салбарт алдаршсан Грамен банкыг үндэслэгч, Нобелийн шагналт Мухаммед Юнусын нэртэй илүү нягт холбоотой. Эдүгээ нийгмийн инновац нийгмийн уламжлалт тогтолцооны элдэв саад бэрхшээлүүдийг даван туулах, шинэ орчин нөхцөлд илүү дэвшилтэт, үр нөлөөтэй арга барил, технологийг нутагшуулах өргөн цар хүрээтэй үйл хэрэг болон хөгжиж хандлага хэмээн ойлгогдох болжээ. Иймд нийгмийн инновац нь нийгмийн хэрэгцээг хангах илүү дэвшилтэт шинэ шийдэл, нөөц болон хөрөнгийг

оновчтой ашиглах чадвар, харилцаа болж байна. Инновац ойлголтыг эдийн засагч И.Шумпетер судалгааны эргэлтэд анх оруулсан хэмээн үздэг бөгөөд онол үзэл баримтлалын хувьд нийгмийн инновац нь П.Друкер нарын менежментийн онолчид, Жак Фурниер, Жак Аталли нарын Францын зохиолчид, Роберт Оуэн зэрэг олон эрс шинэчлэгчид, Макс Вебер, Карл Маркс, Эмил Дюркгейм нарын социологичид нийгмийн өөрчлөлтийн талаар онол, үзэл баримтлал, үйл ажиллагаагаа чиглүүлж байсан түүхтэй. Нийгмийн инновацыг илүү амжилттай хэрэгжүүлэхэд нийгмийн салбар бүр, салбар хоорондын уялдаа холбоо, хөгжлийн төлөөх нэгдсэн бодлого, нийгмийн бүлэг нийтлэгүүдийн хувьд үе хоорондын харилцан ойлголцол, соёлын диалоги нэн чухал ач холбогдолтой юм. Мөн төр, хувийн хэвшлийн түншлэл ч үүнд хамаарах бөгөөд нийгмийн инновацын соёл, дэд бүтцийг хэрхэн бэхжүүлж хэрэгжүүлснээр хэмжигдэнэ. (Б.П)

НИЙГМИЙН КАПИТАЛ (*Social capital*)

Нийгмийн баялаг нь хүмүүс хоорондын харилцан үйлчлэл болон сүлжээ, хамтын үнэт зүйлс, нөөц юм. Нийгмийн капиталын онолоор нийгмийн харилцаа нь хүмүүн капиталыг хөгжүүлэх, хуримтлуулахад хөтөлдөг нөөц бололцоо гэж үздэг. Эртний Грекийн гүн ухаантан Аристотель “хүн бол уг чанараараа нийгмийн амьтан” болох тухай өгүүлсэн нь нийгмийн капиталын онолтой хамаатай. Социологич Пьер Бурдье (Bourdieu) 1970-аад оны сүүлчээр тодорхой бүлэглэлүүдийн гишүүнчлэлээр хүмүүст хуримтлагдах давуу тал болон боломжуудыг тодорхойлох зорилгоор анх хэрэглэсэн нэр томьёо

юм. Социологич Жеймс С.Коулман (Coleman) энэ нэр томьёог хүмүүс хоорондын харилцааны үр дүнд ямар нөөц боломж бий болдгийг тайлбарлахад ашиглан “нийгмийн капиталыг нийгмийн бүтэц дэх үүргүүдийн дагуу хувь хүмүүсийн хоорондын харилцааг өөрчилснөөр амжилт гаргахад хүргэдэг мөнгөн болон биет эсвэл хүмүүн капиталаас дутуугүй чухал капиталын хэлбэрийг бий болгодог хэмээн үзсэн. Дэлхийн банк нийгмийн баялгийг: “хүмүүст үйл ажиллагаагаа зохицуулах, уялдуулах, хүссэн зорилгодоо хүрэх боломжийг олгодог нийгмийн бүтэцэд агуулагдсан хэм хэмжээ, нийгмийн харилцаа” гэжээ. Дэлхийн эдийн засгийн форумаас эдийн засгийн баялаг, орлогоос гадна хүмүүн баялаг (Human capital), байгалийн баялаг (Natural Capital), нийгмийн баялаг (Social Capital)” гэсэн хүчин зүйлээр улсынхаа жинхэнэ бодит хөгжлийг хэмжихийн ач холбогдлыг өгүүлсэн⁶. Ийнхүү нийгмийн баялаг буюу капитал гэдэгт хүмүүс хоорондын харилцаа, сүлжээ, итгэлцэл, хамтын ажиллагаа, зах зээлийн мэдээлэл, мэдлэгийн коммунити, инновацын хүртээмж, үндэстэн хоорондын өгөөжийг ойлгож иржээ. Аливаа нийгмийн харилцаа, сүлжээнүүдийн хамтын үнэт зүйл, тэдгээрийн хүрээнд бий болгосон итгэлцэл, харилцан үйлчлэл, мэдээлэл, хамтын ажиллагаа ийнхүү нийгмийн капитал болон хувирдаг байна. Биет капитал нь материаллаг зүйлсэд, хүмүүн капитал нь хувь хүний чадвар, шинж чанарт хамаарах бол нийгмийн капитал нь “хүмүүс хоорондын харилцаа холбоо, нийгмийн сүлжээ, харилцан

солилцооны хэм хэмжээ, тэдгээрээс бий болдог харилцан итгэлцэл”-д суурилдаг. Иймд хүмүүс хоорондын харилцан хамаарал буурах тусам нийгмийн капитал буурч байдаг байна. Нийгмийн капиталын голлох хоёр төрөл байдаг. Энэ нь *нэгдүгээрт*, бэхжүүлэгч (bonding) нийгмийн капитал буюу харьцангуй нэгэн төрлийн бүлгүүдийн дотор эсвэл тэдгээрийн хоорондын харилцаа, дотоод холбоог батжуулагч капитал хоёрдугаарт, уялдуулагч (bridging) нийгмийн капитал буюу нэг сүлжээг нөгөө сүлжээтэй холбож, мэдээлэл тархаалт, харилцан солилцоог хөгжүүлэх боломжийг өргөжүүлдэг, янз бүрийн шаталсан түвшний хүмүүс эсвэл бүлгүүдийн хоорондын харилцааг илтгэдэг капитал юм. Үүнийг заримдаа холбогч (linking) нийгмийн капитал хэмээн бас нэрлэдэг. Роберт Путнам нийгмийн капиталыг хөгжүүлэхэд шаардлагатай гурван элемент болох итгэлцэл, харилцан үйлчлэл, нийгмийн сүлжээ хэмээн үзсэн байдаг. Итгэлцэл нь нийгмийн капиталыг бий болгох үндэс суурийг бүрдүүлдэг бол харилцан үйлчлэл нь хувь хүмүүс болон бүлгүүдийн хооронд өгөх ба авах харилцааг хэлнэ. Нийгмийн капитал нь хуримтлалын чиг хандлагатай, харилцан үйлчлэл бүрийн үр дүнгээр нэмэгдэж байдаг. Америкийн нийгэм дэх иргэний оролцоо сүүлийн дөчин жилийн хугацаанд буурсан гэж үздэг. Жнь: Шашны хурал цуглаан, үйлдвэрчний эвлэл, скаут, улаан загалмай, багш-эцэг эхчүүдийн нийгэмлэгүүд дэх гишүүнчлэл тогтвортой буурч байна. Даяаршмал үнэт зүйлсийн холбоо хамаарал, харилцан нэвтрэлцэхүй өрнөхийн хирээр нийгмийн капиталын орчин үеийн загварт оюуны урсгалын (brain drain) хэлхээ холбоо, хамтдаа хожих (win-win) эсвэл

6 GDP is no longer an accurate measure of economic progress. Here's why // <https://www.weforum.org/agenda/2018/11/forget-gdp-for-the-21st-century-we-need-a-modern-economic-measure/>

эцсийн дүндээ эерэг байх, алдаж байж хожих, диаспорагийн оролцооны бодлогыг тус тус оновчтой хэрэглэх хандлагатай байна. Монголчууд олны хүч оломгүй далай хэмээдэг бол орчин үед авьяасын төвлөрөл хэмээх ойлголтыг ч бас үүнд хамаатуулан хэрэглэж болох юм. (Б.П)

НИЙГМИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

(Social media) Нийгмийн мэдээллийн хэрэгсэл гэдэг нь цахим сүлжээ болон нийтийн сүлжээгээр холбогдсон хийсвэр олон нийтийн бүлгүүдэд мэдээлэл хуваалцах, үүсгэх, санаа болон сонирхлоо илүү интерактив байдлаар илэрхийлэх боломжийг олгож байгаа технологиудыг хэлнэ. Нийгмийн мэдээллийн хэрэгсэл нь дараах шинж чанаруудыг багтаасан байхаар авч үздэг. Үүнд: Нийгмийн мэдээллийн хэрэгсэл нь интернетэд суурилсан веб 2.0 технологи ашигласан интерактив программ байх; олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хэрэглэгч өөрийн веб агуулга үүсгэж түгээх боломжтой байх; хэрэглэгч нь өөрийн үзүүлэх үйлчилгээнд зориулсан тусгайлсан нийгмийн мэдээллийн хэрэгсэл бий болгох боломжтой байх; нийгмийн мэдээллийн хэрэгсэл нь нийгмийн сүлжээний хөгжилд тусалдаг буюу хэрэглэгчийн профайлыг бусад хуваалцах боломжтой байна. Хэрэглэгчид нь нийгмийн мэдээллийн хэрэгслийг вебэд суурилсан программ, ухаалаг утасны аппликэйшн эсвэл компьютерын программ ашиглан ханддаг. Зуун саяас дээш хэрэглэгчтэй хамгийн том нийгмийн мэдээллийн хэрэгслийн жишээ нь Facebook, TikTok, WeChat, Instagram, Qzone, Weibo, Twitter, Tumblr зэрэг болно. Харин нийгмийн мэдээллийн хэрэгслийн зарим нэг шинж чанарыг агуулсан олон нийтэд

танигдсан үйлчилгээнүүд гэвэл, YouTube, Telegram, WhatsApp, Discord зэрэг юм. Нийгмийн мэдээллийн хэрэгсэл нь уламжлалт мэдээллийн хэрэгслээс ялгаа нь чанар, хамрах хүрээ, давтамж, хэрэглэх боломж, найдвартай байдал болон тогтвортой байдлаар илүү байдаг. Мөн уламжлалт мэдээллийн хэрэгсэл нь зөвхөн нэг чиглэлтэй мэдээллийг дамжуулдаг, эсвэл нийгмийн мэдээллийн хэрэгсэл нь хоёр чиглэлтэй эргэн холбогдож харилцах боломжтой байдгаараа ялгардаг. (Д.З; Ч.Л нар)

НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ

(Social well-being) Сайн сайхан байдал /well-being/ нь ихэвчлэн философи, нийгмийн сэтгэл зүй, нийгмийн халамжийн ойлголт бөгөөд ёс суртахууны онол, хөгжлийн, эмнэлзүйн, бие хүний сэтгэл зүйн салбаруудаар авч үздэг. Нийгмийн сайн сайхан байдал нь анх италийн «benessere» гэдэг үгнээс XVI зууны үед үүссэн ба эрүүл мэнд, аз жаргал, үнэлэмж, хөгжил цэцэглэлтээр тодорхойлогддог хүний оршихуйн сайн бөгөөд сэтгэл ханамжтай төлөв байдлыг ихэвчлэн илэрхийлдэг ойлголт. Эдүгээ төрийн бодлогын чиглэл, улс төрийн зорилго болгон хэрэглэх болжээ. Иймд сайн сайхан байдал нь аз жаргал, цэнгэл баяр, таашаал, сэтгэл зэрэг ойлголттой ихээхэн ойр, хоршиж хэрэглэгдэх, цаашилбал үнэт зүйлс, амьдралын чанар, сэтгэлийн амар амгалан, ёс зүйн үзэл баримтлалууд болох гедонизм, эвдемонизм, утилитаризм, велфаризм (welfarism) зэрэг үзэл баримтлалуудтай уялдана. Сайн сайхан байдал чухам юунаас үүсэл, бүрдэлтэй байж болох талаар энэ бүх үзэл санаанууд харилцан адилгүй үндэслэл дэвшүүлдэг ч угтаа хүний амьдралын чанар, хүртээмж, сэтгэл

зүйн эерэг төлөв байдлыг илэрхийлнэ. Дж.Мурын утилитарист үзэлд сайн сайхан байдал бол хүний хувьд хамгийн чухал зүйл хэмээн илүү ач холбогдол өгөн үндэслэж нотлохыг хичээдэг. Нийгмийн сайн сайхан байдалд хамаарал бүхий онолуудыг багцлан авч үзвэл гедонист буюу жаргал цэнгэлийн, дур хүслийн, хүсэл эрмэлзлийн онолууд хэмээн бүлэглэж болно. Аз жаргал агшин зуурын үзэгдэл гэх эртний грекийн уламжлал сайн сайхан байдлыг тодорхойлох эвдемонист хандлага болдог шиг өнөө үед Велфаризм хэмээх үзэл нэлээд ашиглагдах болжээ. Велфаризмын хувьд сайн сайхан байдал нь цорын ганц үнэт зүйл юм. Сайн сайхан байдлын сэтгэл зүйн эвдемонист чиглэлийн үзэл онолын анхны төлөөлөгч бол М.Чиксентмихай бөгөөд энэ хандлагын хүрээнд хамгийн их нэрд гарсан судлаачид бол энэ К.Рифф, Э.Деси, Р.Райан нар юм. Ер нь сэтгэл судлалын хувьд хөгжлийн, бие хүний, клиник хэмээн гурван салбар сайн сайхан байдлыг түлхүү судалдаг салбарууд юм. К.Риффийн үзэл баримтлал нь хүмүүнлэг, позитив, хөгжлийн болон эрүүл мэндийн сэтгэл судлалын уулзвар дээр үүссэн бөгөөд хүний эерэг үйл ажиллагааг тайлбарласан философи, сэтгэл зүйн янз бүрийн онолыг хослуулснаараа (С.Бюллер, А.Маслоу, Г.Аллпорт, К.Рожерс, Э.Эриксон, К.Г.Жунг болон бусад) онцлогтой. Хожим К.Риффийн сэтгэл зүйн сайн сайхан байдлын зургаан шкал хэмээн нэрлэгдэх болсон наян дөрвөн зүйл бүхий арга зүй боловсруулагдсан. Түүний эерэг хандлага, бие даасан байдал, орчиндоо дасах, бие хүний өсөлт, амьдралын зорилго, өөрийгөө хүлээн зөвшөөрөх гэсэн бүрэлдэхүүнээр сайн сайхан байдлыг авч үзэх тухай өгүүлсэн. (Б.П)

НИЙГМИЙН САЙН САЙХНЫ ЗОРИУЛАЛТТАЙ ЗҮЙЛС (*Common good*) Улс төрийн энгийн хэллэгт “Нийгмийн сайн сайхны зориулалттай зүйлс” гэдэг нь нийгмийн гишүүд тэдэнд нийтэд нь байдаг тодорхой сонирхлыг хангахын тулд буй болгодог, өөр хоорондын харилцаандаа үүрэг хүлээж, санаа тавьдаг материаллаг соёлын болон институцийн шинжтэй зүйлсийг хэлнэ. Либерал ардчиллын үүднээс авч үзвэл эдгээрт зам харилцаа, нийтийн цэцэрлэгт хүрээлэн, дэг журам, цагдаагийн хамгаалал, шүүх, шүүхийн систем, төрийн сургууль, музей, соёлын байгууллагууд, нийтийн тээвэр, иргэний эрх, эрх чөлөө, цэвэр агаар, ус, үндэсний аюулгүй байдал гэх мэт олон зүйлс багтана. Өөрөөр хэлбэл, нийтлэг сонирхол, түүнийг хангахад чиглэсэн зүйлсийг хэлнэ. Нийтийн номын сан нь нийт хүмүүсийн тусын тулд үйлчилдэг, түүний нэг хэсэг мөн. (Ц.Д)

НИЙГМИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ХАНДЛАГА (*Social psychological approach*) Энэ нь хувь хүнийг багтаасан нийгмийн бүлгийн дотор үүссэн мэдрэмж, сэтгэл хөдлөл, зуршил, хандлага, хүсэл зориг, мэдрэмж, бодлын цогц юм. Нийгмийн сэтгэл зүйд зан үйлийн сэдэл, хүмүүсийн амьдралын тодорхой хэв маягт дассан байдал орно. Мөн бүрэн тодорхой, нарийн боловсруулж, системчилж амжаагүй байгаа бодол, санаанууд бас багтана. Нийгмийн сэтгэл зүйн хүрээнд дараах зүйлс бүрэлдэж байдаг. Үүнд:

- Олон янзын сонирхол (ухамсартай хүсэл, хэрэгцээгээ хангах хүсэл эрмэлзэл);
- Үнэлэмжийн чиг баримжаа

- (үзэгдлийн үнэ цэнийг ойлгох, хэрэгцээг хаана, хэрхэн хангаж болохыг ойлгох);
- Ирээдүйн талаарх санаа, хүссэн зүйлийн дүр төрх, хүрэх ёстой зүйл (жишээлбэл, сайн сайхан байдал, шударга ёс, эрх чөлөөнд хүрэх боломжийг мэдрэх гэх мэт);
 - Амьдралын утга учир, ямар зорилгод тэмүүлэх ёстой талаарх үзэл. Амьдралын утга учир нь тодорхой хүнтэй холбоотой байдаг боловч амьдралын утга учиртай холбоотой асуултад хувь хүнийг ямар нэг бүлгийн зорилго, ашиг сонирхолтой холбож өгдөг, хувь хүнээс дээгүүр ямар нэг хүчин зүйл байдаг. Амьдралын утга санаа нь тодорхой үзэл суртлын (шашны эсвэл гүн ухааны) үндсэн дээр хэрэгждэг;
 - Аз жаргал эсвэл аз жаргалгүй байдал (амьдралын зорилго, утга учир нь биелэгдэхүйц буюу хэрэгжих боломжгүй болохыг ойлгосноос);
 - Хүсэл зориг (зорилгодоо хүрэх чадвар, тууштай байдал, эр зориг, итгэл үнэмшилтэй байдал) эсвэл хүсэл зориггүй байх (шийдэмгий бус байдал, хулчгар байдал);
 - Итгэл үнэмшил, нийгмийн хандлага (зорилгодоо хүрэхийн тулд практик арга хэмжээ авахад бэлэн байх).

Нийгмийн сэтгэл зүйн хандлагын дээр дурдсан шинж чанарууд нь нарийн төвөгтэй харилцаатай. Нийгмийн бүлгийн хүмүүс нийгмийн янз бүрийн үзэгдэл, өөрсдийн болон бусад нийгмийн бүлгүүдийн үйл ажиллагааг байнга мэдэрч, ойлгож, үнэлж байдаг. Нийгмийн бүлэг бүр энэ бүлгийн онцлог хэрэгцээнд үндэслэн бий болсон өөрийн гэсэн нийгмийн мэдрэмж, үзэл бодолтой байдаг.

Нийгмийн сэтгэл зүй хандлага нь: амьдралын нөхцөл байдал, үйл явцын үр дүнд ухамсарлагдахгүйгээр аяндаа бүрдэх. Хүмүүсийн ухамсарт өөрийн нь хамаарагддаг нийгмийн бүлэг, хот, тосгод дахь амьдралын нөхцөл байдал, улс орны түүх, зан заншил уламжлал зэрэг олон зүйл нөлөөлнө. (Ц.Д)

НИЙГМИЙН СЭТГЭЛ СУДЛАЛ (*Social psychology*) Нийгмийн орчны хувь хүнд үзүүлдэг нөлөөллийг судалдаг сэтгэл судлалын шинжлэх ухаан юм. Тэрбээр хувь хүн болон түүний орчин хоёр нягт холбоотой байдаг зарчимд суурилна. Орчин нь хүний амьдралын бүхий л хугацаанд янз бүрийн байдлаар түүнд нөлөөлнө. Нийгмийн нөхцөл байдал хүмүүсийн зан үйлд үзүүлж байгаа нөлөөлөл нь нийгмийн сэтгэл судлалын судалгааны нэг гол элемент. Нийгмийн сэтгэл судлал нь нэг талаас сэтгэл судлалтай, нөгөө талаас социологийн шинжлэх ухаантай холбоотой. Сэтгэл судлалын ухаан хувь хүний сэтгэцийн талаарх үнэлэлт дүгнэлтийг, социологийн ухаанд суурилан хувь хүн нийгмийн орчинд бусад хүмүүстэй хэрхэн харилцдаг тухай судалдаг. Нийгмийн сэтгэл судлалыг нийгмийн сэтгэл зүйн хандлагаас ялган үзэх хэрэгтэй. (Ц.Д)

НИЙГМИЙН ТЭГШ БУС БАЙДАЛ (*Social inequality*) Орлогыг сайн сайхны илэрхийлэл хэмээн үздэг байсан уламжлалт хандлагаас тэгш бус байдлын тухай ойлголт анх гарчээ. Харин боломжид чиглэсэн хандлага нь хүнийг төрөх үеэс эхлэлтэй гэж үзэх явдал. Боломжийн тэгш байдал нь хүн бүрд гарааны тэгш байдал байх ёстой гэж үздэг. Үүнээс үзвэл орчин үед тэгш бус байдлыг орлогоос үүдэлтэйгээр тайлбарлахаас

илүү үр дүн (outcome), боломжид (opportunity) суурилсан тэгш бус байдал хэмээн авч үзэх болсон. Тэгш бус байдлын талаар янз бүрийн онол, үзэл баримтлал байдаг ч ихэнх тохиолдолд орлогын тэгш бус байдлаар үнэлж дүгнэх хандлага байдаг. Эдийн засгийн тэгш бус байдлын хувьд хоёр янзын үзлийг голлон авч үздэг. Үүнд: 1) хүний сайн сайхан байдлыг материаллаг хэмжигдэхүүн ба түүний үр дүнгээс хамаарсан тэгш бус байдал. 2) боломжийн тэгш бус байдалтай илүү холбогддог. Энэ нь хувь хүний боломжоос давсан нөхцөл байдал (ex-ante), түүний үр дүнд хэрхэн нөлөөлж буйд илүү чиглэдэг. Энэ нь хүрч болох ололт амжилтын хандлага юм. (Б.П)

НИЙГМИЙН УДИРДЛАГА (Social management)

Нийгэм нээлттэй, зохион байгуулалт бүхий систем учраас түүнийг удирдах менежментийн арга хэлбэр түүхэн цаг үе бүхэнд төрийн бодлого шийдвэрээс хамаарч харилцан адилгүй. Нийгмийн бүтэц, зохион байгуулалтад гарч буй өөрчлөлт үндсэндээ системийн өөрчлөлт шилжилтийн агуулгатай бол нийгмийн менежментийн хувьд нийгмийн хамгаалал, нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх үйл хэрэгт голчлон анхаардаг. Нийгмийн менежментийг хөгжүүлэхэд менежментийн онолын сонгодог төлөөлөгчид болон социологич М.Вебер, нийгмийн бүтэц, системийн анализын төлөөлөгчид зэрэг америк, япон зэрэг орны судлаачид гол нөлөө үзүүлсэн байна. Нийгмийн өөрчлөлтөөс нийгмийн шилжилт хамаарна. Нийгмийн шилжилтийн онолын гол төлөөлөгчдийн нэг Э.Тоффлер: “өөрчлөлт бол бидний ирээдүйн амьдралыг эзэгнэх үйл явц юм” хэмээн үзээд мэдлэг, мөнгө,

төрийн албадлагын хүрээнд эрх мэдэл шилждэг тухай өгүүлсэн. Энэ бүгдийг удирдах нь эдүгээ мэдлэг, санхүүгийн менежмент, төрийн болон төрийн захиргааны удирдлага гэх мэт удирдлагын салбаруудад дэлгэрэнгүй авч үздэг ч бүхэлд нь нийгмийн удирдлага нэрийн доор нэгдмэл байдлаар үзэж болно. Нийгмийн шилжилтийн талаар нийгмийн философич, удирдлагын социологич, улс төрийн технологи судлаач, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн менежерүүд, бодлогын нийгмийн ажилтнууд, төрийн бодлого судлаачид гол тоглогчид. Аж үйлдвэржилтийн дараах нийгэмд мэдлэгийн хүч нөлөө огцом өссөн ч аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал нь ухаалаг технологи, хиймэл оюун ухаанд тулгуурлах шилжилтийн үе эхэлсэн болох талаар Дэлхийн эдийн засгийн форумыг үндэслэгч эрдэмтэн Шварцаас эхтэйгээр тунхаглах болов. Иймд шинэ мянган, шинэ зууны иргэд нь Э.Тоффлерийнхээр: бичиг үсэггүй, уншиж, бичиж чадаагүй хүмүүс биш харин сураагүй, сурахыг хүсээгүй, дахин сурч чадаагүй хүмүүс л байх болно” хэмээн сануулжээ. Нийгмийн менежмент нь системийн зохион байгуулалтыг оновчтой болгох, хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах, тогтолцоог бүхэлд нь болон түүний дэд, бие даасан хэсгүүдэд зорилготойгоор нөлөөлөх явдал. Нийгмийн менежмент тодорхой утгаараа орчин үед үйлдвэрлэлийн болон хөдөлмөрийн харилцааны асуудлыг зохицуулахад чиглэсэн онолын болон хэрэглээний шинжтэй салбар менежмент болон хөгжиж байна. (Б.П)

НИЙГМИЙН ХАЛАМЖ (Social welfare) Иргэдийг орлого, хөрөнгө, амьжиргааны түвшин, амьдралын

нөхцөлөөр нь, тогтоосон шалгуур, үзүүлэлтээр ангилж халамж шаардлагатай бүлэгт төрөөс үзүүлэх санхүүгийн болон бусад хэлбэрийн дэмжлэгийг нийгмийн халамж гэнэ. Дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэнд анхдагч хэрэгцээгээ хангахад туслах, тэтгэвэр тэтгэмж, хүнсний талон олгох, төрөөс үзүүлдэг, үнэ төлбөргүй, тусгайлсан үйлчилгээг халамжийн үйлчилгээнд хамруулдаг. Хүмүүнлэг нийгэм бүхий улсын төрөөс халамж шаардлагатай иргэдийн бүлэгт зориулж халамжлах бодлого боловсруулж хэрэгжүүлдэг ч халамжийн үйлчилгээний үр дүн, өгөөж харилцан адилгүй байдаг. Нийгмийн халамжийн зорилтот бүлэг, хамрах хүрээ, санхүүжилттэй уялдуулан үзвэл, халамжийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхэд шударга байдал, үр ашиг, хөдөлмөр эрхлэлтийг урамшуулах хандлага гэсэн гурван талт зарчмыг баримтлах шаардлагатай.⁷ Шударга байдлын зарчим нь аливаа давхардал, гадуурхал, алагчлалгүйгээр, хүлээлт үүсгэхгүйгээр нийгмийн халамжийн сангийн үйлчилгээг зохих эзэнд нь хүргэх асуудлыг хамарна. Үр ашгийн зарчим нь халамжийн сангийн хөрөнгийг оновчтой зүйлд зөв зарцуулсан эсэхээр тодорхойлогдоно. Нийгэмд хөдөлмөр эрхэлж байгаа хэсэг дэмжих тэдний төлсөн татвар хураамжаар нийгмийн халамж шаардлагатай эмзэг хэсгийг хамгаалахаас гадна халамжийн үр шим хүртэгчдэд хөдөлмөр эрхлэх нөхцөл, боломж бүрдүүлж байх нь халамжийн бодлогын хөдөлмөр эрхлэлтийг урамшуулах зарчмын гол агуулга юм. (Б.Б)

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН (*Social welfare fund*)

Төрөөс хэрэгжүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг санхүүжүүлэх зорилготой мөнгөн хөрөнгийн сан. Нийгмийн халамжийн сан нь улс, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө, олон улсын болон үндэсний байгууллага, иргэдийн хандив тусламж, сангийн хөрөнгийг санхүүгийн зах зээлд байрлуулснаас олох орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Халамжийн бодлогоор тодорхойлсон халамж, үйлчилгээг хүргэхэд сангийн хөрөнгийг зарцуулах бөгөөд санг зориулалтаар нь тэтгэвэр тэтгэмжийн сан, нийгмийн үйлчилгээний сан гэж ангилдаг. Тэтгэвэр, тэтгэмж олгохоос бусад халамжийн үйлчилгээ буюу төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээ, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, нийгмийн ажилтны сургалт, хөгжлийн зардал, нийгмийн халамжийн талаарх судалгаа, шинжилгээ, үнэлгээний зардал зэргийг нийгмийн үйлчилгээний сангаас санхүүжүүлнэ. (Б.Б)

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (*Social welfare programs/ser-vice*)

Нийгмийн халамж шаардлагатай иргэдийн бүлэг, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа иргэн, эдгэршгүй хүнд өвчтэй иргэн, орон гэргүй иргэн, өрх толгойлсон эцэг, эх, ядуу өрх зэрэг халамж шаардлагатай иргэдэд чиглэсэн санхүүгийн дэмжлэг, бусад төрөлжсөн үйлчилгээг халамжийн үйлчилгээ гэнэ. Хоол хүнс, орон байраар хангах зэрэг суурь хэрэгцээнээс гадна нийгмийн хөгжлийн үйлчилгээ буюу боловсрол, эрүүл мэндийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг

⁷ Удирдлагын академи, “Нийгмийн халамжийн бодлогын үр нөлөө” Судалгааны тайлан, 2010.

зорилтот бүлэгт үзүүлэхийг мөн халамжийн үйлчилгээнд хамруулна. Засгийн газраас шинэчлэн баталдаг амьжиргааны доод түвшингээс бага орлоготой иргэн, ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй иргэддээ төрөөс үзүүлэх, үнэ төлбөргүй халамжийн үйлчилгээг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэх ба үйлчилгээний төрөл, хэлбэрийг судалгаанд үндэслэн бодлогоор тодорхойлж хуульчилдаг. (Б.Б)

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА (*Social responsibility*) Нийгмийн хариуцлага бол ёс суртахууны тогтолцоо бөгөөд эдийн засаг, экосистемийн тэнцвэрийг хадгалахын тулд хувь хүн, байгууллагын биелүүлэх ёстой үүрэг юм. Энэ нь зөвхөн бизнесийн байгууллагуудад төдийгүй аливаа үйлдэл нь байгаль орчинд нөлөөлж буй хэн бүхэнд хамаатай ойлголт юм. Хувь хүн, байгууллагууд иргэний үүргээ биелүүлж, өдөр тутмын үйл ажиллагаандаа нийгмийн сайн сайхны төлөө санаа тавьж, нийгэмд ашиг тус хүргэх үүрэг хүлээхийг санал болгодог ёс зүйн хүрээг нийгмийн хариуцлага гэнэ. Нийгмийн хариуцлага нь улс орон нийгэм, ард иргэдийнхээ ашиг сонирхлыг дээдэлж, түүнийг хангахын төлөө ажиллаж нийгэм, хүрээлэн буй орчин, амьдрах чадвартай эдийн засаг гурвын тэнцвэрийг хангахад чиглэгдсэн байр суурь, зан үйл, ажиллагааг илэрхийлэх ойлголт юм (Ундрам & болон бусад, 2020). Нийгмийн хариуцлага ойлголт стандарттай тогтолцоо болж өргөжин 2011 онд Нийгмийн хариуцлагын олон улсын стандарт ISO-26000⁸, 2012 онд Монгол Улсын үндэсний стандарт MNS ISO-26000⁹ батлагдсан. Нийгмийн хариуцлагаа ухамсарлан

ажиллах үүрэг хүлээсэн аж ахуйн нэгж, байгууллагуудын хувьд ISO 26000 хэрэгжүүлдэг. (З.А)

НИЙГМИЙН ШУДАРГА ЁС (*Social Justice*) Шударга ёс (justice) бол соёл бүрд өөр өөрөөр ойлгогддог хэдий ч өргөн утгаараа ёс зүй, ухаалаг байдал, хууль, шашин шүтлэг, тэгш байдал, зүй ёсонд суурилсан зан суртахууны голч үзэл баримтлалууд бүхий үзэл бодол, тэрхүү үзэл бодлуудаас тухайн тохиолдолд олон салбарт зохистой хэмээн тайлбарлагдаж, нөлөө үзүүлж байгаа хэмээн зөвшөөрөгдсөн, хүмүүс хүлээн авдаг зарчим юм. Нийгмийн шударга ёс нь улс төрийн болон эдийн засгийн гэсэн хоёр гол төрөлтэй. Энэхүү ойлголтыг зарим судлаач зүй ёс хэмээх нь илүү оновчтой гэж үзсэн ч нийтийн соёл хэрэглээнд хэвшсэн байдлыг харгалзан шударга ёс гэдгээр хэрэглэв. Нийгмийн шударга ёс бол сайн сайхан байдлыг цогцоор илэрхийлэх үзэл баримтлалд хэрэглэгддэг ухаалаг сонголтын зарчим нь чухам юунд хүргэх талаар төрт ёсны онол үзэл сургаалуудад олонтаа өгүүлсэн. Аристотелийн ёс зүйд хэлэлцэгдсэн “хэдийгээр найз нөхөр ч, үнэнч аль аль нь надад эрхэм боловч үнэнийг илүү дээдлэн эрхэмлэх нь ариун нэр төрийн үүрэг юм” хэмээсэн нь хожмоо Платон: “миний найз гэвч үнэн илүү эрхэм” гэсэн хэллэгээр өргөн зүйр үг болтлоо тархсан билээ. Сайн сайхан бол туйлын, тэгэхлээр хүнээс үл хамааран оршино хэмээснийг сайн сайханд хүрэх нь хүний зорилго хэмээх Платоны үзлийг эсрэгээр нь Аристотель сайн сайхан бол хүнээс өөрөөс нь хамаарна гэж нотолсон байна. “... Албан тушаал хүнийг илчлэн харуулдаг” хэмээн хуулийн дагуу авирладаг, бусад бүх хүнд адил тэгш ханддаг тэр хүнийг шударга

8 <https://www.iso.org/iso-26000-social-responsibility.html>

9 <https://standard.gov.mn/standard/v/3182>

гэж нэрлэх нь тодорхой гэх зэргээр үзсэн. Дж.Роулз “Шударга ёсны онол” бүтээлдээ: эрх чөлөөний зарчим, ялгаат байдлын зарчим хэмээх хоёр зарчмыг гаргасан нь *нэгдүгээрт*, хүн бүрийн эрх чөлөөг дээдэлсэн адил төсөө бүхий тогтолцоотой нийцэх суурь тэгш эрхийн хамгийн түгээмэл тогтолцоонд хүн бүр ижил тэгш эрхтэй байх ёстой. *Хоёрдугаарт*, нийгэм, эдийн засгийн тэгш бус байдлыг халах шаардлагатай, ингэж байж (хадгалах зарчим-Роулз) шударга ёсонд нийцсэн ижил тэгш, шударга боломж бүхий нөхцөлд бүх хүн ажил албан тушаал эрхлэх тэгш боломжтой байж, нийгэм, эдийн засгийн өгөөжийг ижил тэнцүү хүртэнэ хэмээсэн. Шударга ёсны аль ч онолд хууль дээдлэх зарчим, тэгш байдлын зарчим ямагт агуулагдаж байсан. Монголчуудын хувьд Их засаг буюу их яса хуулиас эхлээд олон олон бичмэл хуулиудад төрт ёс, хууль ёсыг хэрхэн сахих талаар өгүүлсэн бол үлгэр домог, билэг сургаалуудад шударга ёс, зүй ёс, хүн ёсыг чандлан сахихыг сургаж ирсэн түүхтэй. (Б.П)

НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГА (*Social accountability*) Нийгмийн сайн сайхан байдлыг бий болгоход чиглэсэн үүргээ төр хэрхэн биелүүлж байгаад иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс хяналт тавих, төрийн үйл ажиллагаанд бүтээлчээр оролцож засаглалын хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллах үйл явцыг нийгмийн эгэх хариуцлага гэнэ¹⁰. Энэ нь засаглалд оролцогч талуудын хоорондын харилцаанд бий болох бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтан нь “хариуцлага үүрэх”, “хариуцлага хүлээх”, хариуцан тайлагнах” үүргийг хүлээж байхад засаглалын

бусад оролцогч талууд нь “оролцох”, “хариуцлага нэхэж, шахаж шаардах” эрх/үүрэгтэй холбоотой ойлголт юм. Тиймээс үүнийг зөвхөн нэг талынх нь үүргийг чухалчилсан агуулгаар тайлбарлавал өрөөсгөл болно. Нийгмийн эгэх хариуцлага хэмээх ойлголт нь таван үзэл баримтлалын хүрээнд хөгжсөн байна. Үүнд: 1) Эзэн агентын онолыг үндэс болгосон уламжлалт үзэл баримтлалын үе, 2) Эзэн агентын хоорондын харилцааг “шууд ба шууд бус харилцах харилцаа” гэдэг агуулгаар тайлбарлах болсон үе, 3) “Эрэлтийн болон нийлүүлэлтийн талын нийгмийн эгэх хариуцлага” хэмээх ойлголтыг хэрэглэх болсон үе, 4) Харилцаанд оролцогч талуудын үүргийн шинж байдлаар нь хэвтээ, босоо хэмээн ангилж тодорхойлох болсон үе, 5) Тактикийн болон стратегийн хандлагатай нийгмийн эгэх хариуцлага хэмээх ойлголтыг оруулж ирсэн үе хамаарна¹¹. Нийгмийн эгэх хариуцлагын олон санаачилгыг хөгжиж буй орнууд засаглалаа бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлдэг. Гэвч хэрэгжүүлсэн санаачилга бүр амжилттай хэрэгжиж чаддаггүй. Судлаач Ж.Фокс нийгмийн эгэх хариуцлагын санаачилгууд анхны хүлээсэн үр дүндээ хүрч, амжилттай хэрэгжиж чадахгүй байгаа шалтгааныг судалж, түүндээ тулгуурлан нийгмийн эгэх хариуцлагын хэрэгжиж буй санаачилгуудыг тактикийн болон стратегийн гэсэн хоёр хандлагад хуваан авч үзжээ¹². Тактикийн хандлагаар хэрэгжүүлж буй нийгмийн

10 Түмэнцогтоо Т., ... нар, “Нийгмийн эгэх хариуцлагын үндсэн ойлголт” гарын авлага 1, 2017, 19 дэх тал.

11 Зульфикар С., ... нар, “Нийгмийн эгэх хариуцлага ба сайн засаглал”, Зүүн, өмнөд Азийн улс орнуудын нийгмийн эгэх хариуцлага: туршлага, сургаж, сорилт” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, 2018, 16 дахь тал.

12 Зульфикар С., ... нар, “Нийгмийн эгэх хариуцлага ба сайн засаглал”, Зүүн, өмнөд Азийн улс орнуудын нийгмийн эгэх хариуцлага: туршлага, сургаж, сорилт” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, 2018, 17 дахь тал.

эгэх хариуцлагын санаачилга амжилттай хэрэгжих магадлал бага, харин стратегийн хандлагаар хэрэгжүүлж буй санаачилга амжилттай хэрэгжих боломжтой гэж дүгнэсэн байна. Ийнхүү нийгмийн эгэх хариуцлагын санаачилгыг тактикийн болон стратегийн гэж хоёр ялган хийсэн тайлбар нь нийгмийн эгэх хариуцлагын судалгаанд чухал хувь нэмрийг оруулсан байна. Нийгмийн эгэх хариуцлагын санаачилгыг хэрэгжүүлэхэд тодорхой урьдач нөхцөл шаардлагатай байхын зэрэгцээ энэ төрлийн санаачилгыг хэрэгжүүлэхэд ашиглах тодорхой арга хэрэгслүүд бий¹³. (М.А)

НИЙГМИЙН ЭНТРЕПЕНЕРШИП (*Social entrepreneurship*) Энтрепренершип ойлголт нь шинэ бизнес эрхлэх, шинэ санааг оновчтой хэрэгжүүлэх, үнэ цэнийг шинээр бүтээх, стартап буюу гарааны шинэ бизнес эхлүүлэх үйл хэрэгтэй холбоо бүхий эрсдэлийг давах үйл явц, харилцаа, хандлага, соёл юм. Нийгэм, соёл, байгаль орчны асуудлыг шийдвэрлэх зорилготой, ашиг олж болохуйц бизнесийн загварыг социал энтерпрайз гэж нэрлэдэг. Ийм аж ахуйн нэгжийг удирдан авч яваа хүнийг социал энтерпренер гэнэ. Зөвхөн ашиг олохын төлөө ажиллаж буй хуулийн этгээдийг компани гэдэг бол нийгмийн асуудлыг шийдэх зорилготой ажиллаж буй ашгийн төлөөх байгууллагыг социал энтерпрайз гэж болно. Хүн төрөлхтний хөгжил, аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалаас өмнөх бүх үед үйлдвэр, аж ахуйн нэгж, компаниуд мөнгөн ашгийг эн тэргүүнд тавьдаг байсан. Гэвч өнөөгийн нийгэмд тогтвортой хөгжлийн асуудал хүчтэй тавигдаж эхэлсэн тул байгаль, нийгэм, эдийн

засгийн тэгш боломж, экологийн асуудлууд тавигдахын хирээр компанийн нийгмийн хариуцлага, нийгмийн энтерпренер соёл, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх урт хугацааны үзэл баримтлалд суурилсан бизнес эрхлэлт чухлаар дэвшигдэн гарч ирсэн. Гэхдээ бизнес, энтерпренершип, компанийн нийгмийн хариуцлага бүгд тусдаа өөр өөр ойлголт болохыг энд онцлов. Нийгмийн энтерпренер хүний хувьд ихэвчлэн шинэ санааны хайгуулчин, шинийг санаачлагч, тууштай, эрсдэлээс үл бэрхшээгч нэгэн гэдгээрээ ердийн бизнесменээс ялгарч байна. Энтрепренершип нь үндсэн дөрвөн төрөлтэй бөгөөд гэр бүлийн шинжтэй жижиг бизнесийн энтерпренершип, өргөтгөх боломжтой, хурдан өсөлттэй, хөрөнгө оруулалт татах боломжтой гарааны бизнесийн энтерпренершип, томоохон компанийн энтерпренершип, нийгмийн энтерпренершип багтана. Нийгмийн энтерпренершип нь нийгмийн хэрэгцээ, асуудлыг шийдвэрлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэхэд чиглэгддэг. Тэдний зорилго нь: нийгмийн төлөө ажиллах явдал. Энтрепренершипийн гол шинж чанаруудыг тоймлон авч үзвэл эрсдэл хийх чадвар нэн тэргүүнд тавигдана. Цаашилбал нээлттэй, уян хатан байх, бүтээгдэхүүн болоод өөрчлөлтийн чиг хандлагын талаар мэдлэг мэдээлэлтэй байх, хариуцлагатай байснаар энтерпренер хүн нийгэмд сайн сайхан байдал, өөрчлөлт, баялаг, ажил эрхлэлт, судалгаа хөгжил, бүтээн байгуулалт, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, соёлыг бүтээж хөгжүүлж байдаг. (Б.П)

НИЙГЭМЛЭГ/ХҮЙ ЭЛГЭН (*Community*) Үнэт зүйл, соёл, шашин шүтлэг, мөрдөх нийгмийн хэм хэмжээний

¹³ Түмэнцогтоо Т., ... нар, "Нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгслүүд" гарын авлага, 2017.

хувьд хүйлэн хамтарч нэгдэлтэй болсон бүлэг хүмүүс. Энэ нь ихэвчлэн оршин суугаа газар зүйн байршил, засаг захиргааны харьяалал, амьдрах экологийн нөхцөл, яс үндэс, угсаатны бүлэгт хамаарах байдлаараа тодорхойлогддог. Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэг нэгжид харьяалагдахгүй боловч тодорхой ашиг сонирхол, итгэл үнэмшил бүхий мэргэжлийн холбоо, зөвлөл, клуб зэрэг ч хүй элгэн, нийгэмлэгийн хэлбэр юм. (Б.Б)

НИЙТИЙН ДОМАЙН (*Public domain*)

Зохиогчийн эрхийн зөвшөөрөл шаардахгүйгээр олон нийт ашиглах боломжтой аливаа бүтээлийг “нийтийн домайн” гэх ойлголтод багтаадаг. Тухайн улсын оюуны болон зохиогчийн эрхийн хуулиар ашиглах эрх хязгаарлагдаагүй бүтээл, эсвэл зохиогч нь тодорхойгүй “ард, нийтийн” гэх тодотголтой бүтээл, туурвил, зохиогчийн эрхийн эрх зүйн зохицуулалт гарахаас цаг хугацааны өмнө бүтээгдсэн сонгодог, биет ба биет бус өвийн бүтээл, эсвэл зохиогч нь олон нийт ашиглахаар зөвшөөрсөн бүтээлүүдийг нийтийн домайнд хамаарах бүтээл бөгөөд эдгээрийг ашиглахад ямар нэг зөвшөөрөл шаардахгүй ашиглах боломжтой. (Б.Б)

НИЙТИЙН СОЁЛ (*Mass culture*)

Нийгмийн өдөр тутмын амьдрал зонхилох байр суурьтай үзвэр үйлчилгээ, мэдээлэл, хэрэглээний соёлын хэв маягийг нийтийн соёл (mass culture) гэнэ. Нийтийн соёлын үзэл санаа Франкфуртын дэг сургуулиас үүдэлтэй бөгөөд М.Хоркхаймер эхлэлтэй бөгөөд түүний гол хамтран зүтгэгч нь Адорно байсан түүхтэй. Цаашилбал XX зуунд олон түмний нийгмийн

талаарх янз бүрийн үзэл санаа гарч ирсний нэг нь Хосе Ортега и Гассет (Олон түмний бослого, 1930) тэрээр, “олон нийт гэдэг бол дундаж хүмүүс” хэмээгээд, “нийтийн хүн гэдэг бол эгэл амьдралынх эгэл хэрэгцээ тасралтгүй өсөн нэмэгдэж байдаг хүн” хэмээн бичсэн байдаг. Нийтийн соёл нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, спорт, кино театр, хөгжим, дүрслэх урлаг, утга зохиол зэрэг энтертаймент төрлөөр дамжин стандартчиллыг түгээх замаар дэлгэрдэг онцлогтой. Ийм учраас нийтийн соёл нь соёлын маркетинг, менежменттэй нягт холбоотой зүйл. Соёлын удирдлага макро түвшиндээ төрийн соёлын бодлогоор тодорхойлогдох ба бүс нутгийн хувьд соёлын бодлогын модернизацийн төслүүд, улс орны хувьд соёлын бодлогын хэрэгжилт төсвийн санхүүжилт зэргээс хамаарч биеллээ олдог. Эдүгээ соёлыг өргөн агуулгаар нь тогтвортой хөгжлийг хангах нийгэм-эдийн хүчин зүйлсийн нэг. Соёлын байгууллагуудын маркетингийн стратеги нь нийгмийн маркетинг дээр тулгуурлах явдал түгээмэл бол соёлын салбарын стратегийн менежмент нь нийгмийн баялаг, түүний боломж, төр хувийн хэвшлийн түншлэл, түүхэн ой санамж, соёлын бэлгэдэл, түүнийг бренджүүлэх чиглэлээр тодорхойлогдоно. Орчин үеийн аж үйлдвэржсэн нийгэмд нийтийн соёл хэмээх ойлголт поп соёл, энтертаймент соёл, хэрэглээний соёл зэрэг үгтэй ойролцоо утгаар ойлгогдох бөгөөд нийтлэг үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Нийтийн соёл олон түмний нийгэм, түүний модернизацийн үр дүн гэж үздэг ба цаашилбал хотжилт, үйлдвэржилт, стандартчилал зэрэг

нь хэрэглээнд суурилсан нийгмийн харилцаанд нэвтрэлцэхүйн үндэс болсон. Технологийн хөгжлийн үсрэнгүй амжилт, нийгэм-соёлын модернизацийн үйл явцын үр дүнд нийтийн соёл өөрийн гэсэн тодорхой өнгө төрхийг олж, эдүгээ соёлын туршлагыг мултимедиа хэрэгслийн тусламжтайгаар виртуал орон зайд даяаршуулан, уугуул соёлын орон зайдаа дангаарших замаар өрнөн цэцэглэх хандлагатай болж байна. (Б.П)

НИЙТИЙН СОНИРХОЛ (Public interest) Ерөнхий утгаар нь авч үзвэл нийтийн сонирхол нь нийт ард түмэн ба нийгмийн сайн сайхан байдлыг хангах хэмээн хэлж болно. Уг ойлголтыг нарийвчлан тодорхойлоход бэрхшээлтэй. Эрдэмтэн судлаачид янз бүрийн санал дэвшүүлснийг гурван үндсэн загварт авч үздэг. Нэгд, нийтийн сонирхол давамгайлах загвар, хоёрт, нийлбэр сонирхлын загвар, гуравт, нэгдмэл сонирхлын загвар. Эхний загвар нь нийтийн сонирхол хувь хүний сонирхлоос дээгүүр байж, илүү ач холбогдолтой гэж үздэг бол хоёр дахь загварын төлөөлөгчид нийтийн сонирхол бол хувь хүмүүсийн сонирхлын нийлбэр гэдэг. Харин гуравдахь буюу нэгдмэл сонирхлын загварыг баримтлагчид нийтийн сонирхол гэдэг бол тодорхой суурь зарчмуудад суурилсан янз бүрийн сонирхлын өрсөлдөөний явцад тодорхойлогдоно хэмээн үздэг. Нийтийн сонирхол нь хүн бүрийн сонирхлын нийлбэр байх боломжгүй гэдэг нь ойлгомжтой. Учир нь бүх хүний сонирхлыг хангах боломжгүй юм. Нэгдмэл загвар нь орчин үеийн либерал ардчиллын шинж чанартай холбоотой. (Ц.Д)

НИЙТИЙН СОНСГОЛ (Public hearing)

Нийтийн сонсгол нь хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг тогтоох, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийг үнэлэх, нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахын өмнө төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээчээс санал сонсох, мэдээлэл авах зорилготой. Нийтийн сонсгол дараах шинж чанартай: Үүнд (I) албан үйл явц, (II) стандарт хэлбэрийн дагуу явагдах, (III) олон сонсголыг хамруулах, (IV) саналууд шийдвэр гаргалтад ашиглагдах, (V) нийтийн сонсголын тэмдэглэл хөтөлнө. Нийтийн сонсголыг эрх бүхий этгээдээс боловсруулах хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт; нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал; хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд тавих хяналт, татварын хууль тогтоомж болон төсөв батлах, төсвийн орлого ба зарцуулалтад тавих хяналт; парламентаас томилогдох албан тушаалтны асуудлыг хэлэлцэх, шийдвэр гаргахын өмнө зохион байгуулна. (Г.Б)

НИЙТИЙН ҮҮЛЭН ТООЦООЛОЛ (Public Cloud)

Интернетээр дамжуулж гуравдагч талаас хүссэн хүн бүрд тооцон бодох нөөцийг ашиглах боломжийг санал болгох үйлчилгээ. Эдгээр үйлчилгээ нь үнэгүй байж болохоос гадна хэрэглэгч хэрэгцээндээ тааруулан процессор, хадгалуур болон сувгийн өргөнийг хэрэглэснээрээ төлөх боломжтой байдаг. Хувийн үүлэн тооцооллоос ялгаатай нь нийтийн

үүлэн тооцоолол нь техник хангамж, программ хангамжийг худалдан авах, зохион байгуулах, засвар үйлчилгээг хийх зардлыг хэрэглэгч байгууллага хэмнэдэг явдал юм. Нийтийн үүлэн тооцооллын үйлчилгээ үзүүлэгч байгууллага системийг зохион байгуулалт, засвар үйлчилгээний үүргийг хүлээдэг. Нийтийн үүлэн тооцоолол нь урьдчилан тооцоолсон цар хүрээний дэд бүтцийг шуурхай байршуулж явдаа платформоо бараг хязгааргүй өргөтгөх боломжийг олгодог. Байгууллагын хувьд урьдчилсан хөрөнгө оруулалт шаардахгүй, ашиглалтын болон засвар үйлчилгээний зардал гаргахгүйгээр өөрийн платформуо хэрэгцээндээ нийцүүлэн шуурхай байршуулж хэрэглээнд нэвтрүүлэх боломжийг нийтийн үүлэн тооцоолол олгодог. (Д.3; Ч.Л нар)

НИЙЦЛИЙН АУДИТ (Compliance audit) Шалгалдагч этгээдийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэлд аудит хийхийг¹⁴ хэлнэ. Монгол Улсын хувьд Үндэсний Аудитын газраас хууль, тогтоомжийн хэрэгжилтийн байдалд аудит хийдэг бөгөөд тухайлбал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийдэг. (А.Э)

НИЙЦТЭЙ БАЙДАЛ (Propriety) Энэ нь зан үйл болон ёс суртахууны нийтээрээ хүлээн зөвшөөрдөг стандартыг дагаж мөрдөх, зохицохыг хэлнэ. Ингэснээр хувь хүний зан үйл, үйл ажиллагааг нийгмийн зүгээс зөв зүйтэй хэмээн үнэлнэ. (Ц.Д)

НОГДОЛ АШИГ (Dividend) Компанийн хувьцаанд ногдох жил бүрийн ашгийн хуваарилалтыг ногдол ашиг гэх бөгөөд хуваарилах ногдол ашгийн хэмжээ, зарчмыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэдэг. Хувьцаа эзэмшигчийн хувьд ногдол ашиг нь хөрөнгө оруулалтын өгөөж юм. Төрийн өмчийн компанийн хувьд ногдол ашиг нь төсвийн орлого бүрдүүлэх нэг эх үүсвэр болно. Иймд төрийн өмчийн компанийн ашгийн зорилтот түвшингээс гадна ногдол ашгийн хуваарилалтын зорилтот харьцааг нь баталж гүйцэтгэх захирлын ажлыг дүгнэх гэрээнд тусгадаг. Ногдол ашиг олгож байгаа хэлбэрээс нь хамааруулж мөнгөн хөрөнгөөр олгох, хөрөнгөөр олгох, хувьцаагаар олгох, өрийн бичиг хэлбэрээр олгох ногдол ашиг гэж ангилна. Давуу эрхтэй хувьцаа эзэмшигч нь энгийн хувьцааны ногдол ашгаас түрүүлж ногдол ашиг авах эрхтэй байдаг. (Б.Б)

НӨӨЦ (Resource) Бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил, үйлчилгээг хүргэхэд шаардлагатай, энэ үйл явцад ашиглагдах үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг нөөц гэх ба хөдөлмөрийн, байгалийн, санхүү, хөрөнгө оруулалтын, мэдлэг мэдээллийн нөөц гэж ангилдаг. Нөөцийг нөхөн сэргээгдэх ба сэргээгдэхгүй гэж шинж чанарын хувьд ангилна. Нөхөн сэргээгдэхгүй нөөцийн ашиглалтаас ирээдүй үедээ хуваарилах зорилгоор мөн ирээдүйд үүсэж болох эрсдэлээс улс орны эдийн засаг, иргэдээ хамгаалах зорилгоор төрөөс нөөцийн сан бүрдүүлдэг. (Б.Б)

НӨХӨН ТӨЛБӨР (Compensation) Төрийн байгууллагад оруулсан хувь нэмрийн хариуд албан хаагчид олгож буй мөнгөн болон мөнгөн бус

14 Төрийн аудитын тухай хууль

хэлбэрийн төлбөр ба албан хаагчдыг урамшуулах, байгууллагын үр ашгийг дээшлүүлдэг хүний нөөцийг удирдлагын арга хэрэгсэл юм. Энэхүү нөхөн төлбөрийн системийн удирдлага нь нарийн төвөгтэй үйл явц бөгөөд ажил, чиг үүргийн үнэ цэнийг хэмжих, цалин хөлсний бүтцийг боловсруулах, хадгалах, гүйцэтгэл, үр чадвар, түүний төлбөр, ажиллагсдын тэдгэмжийг бүрдүүлэх үйл явцыг хамрах ба хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвортой хадгалахад ашиглагддаг¹⁵ санхүүгийн болон санхүүгийн бус¹⁶ арга хэрэгсэл байна. (Г.Б)

НӨХЦӨЛ БАЙДЛЫН ОНОЛ (*Situational theory*)

Манлайллын хэв шинж, ажлын тодорхой нөхцөл байдлын хоорондын харилцан хамаарлыг судалдаг онол юм. Үүссэн нөхцөл байдал ба манлайллын хэв шинжийг нарийвчлан судалж, оношлох замаар манлайллын хэв шинжийг тодорхойлоход энэ онолын үзэл баримтлалын зорилго оршдог. Нөхцөл байдлын өөрчлөлтөөр манлайлагч бас өөрчлөгдөж байх ёстой хэмээх санаанд тулгуурлажээ. Эдгээр онолуудад: хамгийн өргөн тархсан нь Ф.Фидлер (Fred E.Fiedler)-ийн нөхцөл байдлын загвар, Пола Херси болон Кеннет Бланчард (Paul Hersey & Kenneth Blanchard) нарын нөхцөл байдлын онол болон Мартин Эванс, Роберт Хаус (Martin John Evans & Robert J.House) нарын Зам-зорилго хэмээх онолууд орно. Ф.Фидлерийн нөхцөл байдлын онолд удирдагч хүмүүсийн харилцаа, зорилтын гүйцэтгэл хоёрын алинд нь илүү анхаарч байгааг тулгуур үндэс болгодог. Харилцааг эрхэмлэж байгаа манлайлагч юуны өмнө ажилтнуудын

хэрэгцээ, ашиг сонирхлыг харгалзан үзэхийг чармайдаг. Харин зорилтын чухалчилдаг манлайлагч өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд голлон анхаардаг байна. Пола Херси, Кеннет Бланчард нарын боловсруулсан нөхцөл байдлын онол нь менежерийн удирдлагад ажиллаж байгаа хүмүүсийн шинж чанарт онцгой анхаарал хандуулжээ. Тэд өгөгдсөн үүрэг, даалгаврыг биелүүлэхэд ажилтнууд бэлэн байгаа эсэх нь өргөн хүрээнд хэлбэлздэг болохыг тэмдэглээд бэлэн байдлын түвшин доогуур байдаг ажилтнуудын хувьд суралцах чадвар сул, найдваргүй байдаг учраас манлайллын өөр хэв шинж үр нөлөөтэй байдаг гэжээ. П.Херси, К.Бланчард нар нөхцөл байдлын онолын хүрээнд манлайллын 4 арга барил байж болно гэж үзээд тэдгээрийг удирдамжийн, итгүүлж үнэмшүүлэх, оролцуулах, бүрэн эрх шилжүүлэх гэж ангилсан байдаг. Мартин Эванс, Роберт Хаус нарын “зам-зорилго” загварын гол санаа нь ажилтнуудын хувийн болон зохион байгуулалтын зорилгыг ханган биелүүлэхэд чиглүүлэн тэднийг идэвхжүүлэх хариуцлагыг манлайлагч шууд хариуцахад оршдог. Ажилтнуудын хүртэх шагналын хэмжээг нэмэгдүүлэх боломжийг эрж хайх, түүгээр урамшуулалд хүрэхэд нь дэмжлэг үзүүлэх нь манлайлагчийн хийх гол ажил юм. Бий болсон нөхцөл байдлыг харгалзан манлайллын хэв шинжийг зохистой сонгох санаанд тулгуурласан Ф.Фидлерийн онолын загвартай харьцуулахад “Зам-зорилго” загвар нь удирдагч ажилтнуудынхаа хамт нөхцөл байдлыг өөрчлөхөд чиглэдгээрээ ялгаатай байдаг. (Ц.Д)

15 Anyebe, A: The Nigerian Civil Service; Issues in structure and operation, journal of professional administration, 2003, Vol.5; pp. 11-17.

16 Bob, N: Making employees suggestions Count, Journal of personnel management, 2011, Vol.17; pp. 20-41.

НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

(Situational analysis) Байгууллагын (салбар, орон нутаг гэх мэт) үйл ажиллагааны дотоод нөхцөл байдал болон түүнд нөлөөлж буй гадаад хүчин зүйлийн талаарх мэдээллийг цуглуулж байгууллагын өнөөгийн нөхцөл байдал ямар байгааг тодорхойлдог шинжилгээ. Энэхүү шинжилгээ нь аливаа төлөвлөлт хийхийн өмнөх гарааны (өнөөгийн) нөхцөл байдлыг тодорхойлоход чиглэгдэх учраас төлөвлөгөө боловсруулах ажил нөхцөл байдлын шинжилгээгээр эхэлнэ. Нөхцөл байдлын шинжилгээ нь макро, микро, дотоод орчин гэсэн гурван орчны хүрээнд хийгдэнэ. Макро болон микро орчин нь байгууллагын гадаад орчин бөгөөд гадаад орчны шинжилгээний үр дүнд байгууллагад ямар боломж байна, ямар эрсдэл, аюул учирч болзошгүй вэ гэдэг нь тодорхойлогддог бол дотоод орчны шинжилгээний үр дүнд байгууллагын давуу тал болон сул тал тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл гадаад болон дотоод нөхцөл байдлын шинжилгээний нэгтгэл дүгнэлт нь давуу, сул тал, боломж, аюулыг тодорхойлсон SWOT (SWOT) шинжилгээ болно. Нөхцөл байдлын шинжилгээнд олон төрлийн арга, аргачлал ашиглагдах бөгөөд үүний нэг нь энэхүү SWOT шинжилгээ юм. SWOT шинжилгээ нь хаанаас гаралтай вэ гэдэг талаар судлаачид хоёр янзын байр суурьтай байдаг. Нэг хэсэг нь 1950-аад оны эхээр Харвардын бизнесийн сургуулийн профессор Жорж Алберт Смит болон Роналд Кристенсен нар байгууллагын стратегийг түүний орчинтой нь уялдуулан судалсан судалгаагаар тодорхойлсон гэж үзэж байхад зарим нь 1960-аад онд Стэнфордын судалгааны институтийн профессор Алберт Хампрей өөрчлөлтийн менежмент ба

хяналтын шинэ системийг хөгжүүлэх зорилгоор 500 компанид хийсэн шинжилгээнээс эхтэй хэмээн үздэг байна¹⁷. 1963 онд Харвардад үзсэн “Бизнесийн бодлогын зөвлөгөө”-ний үеэр стратегич сэтгэлгээний гол нөхцөл нь SWOT шинжилгээ гэсэн өргөн хэлэлцүүлэг болж стратегийн төлөвлөгөөний чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэн, судлаачид SWOT шинжилгээг өргөн ашиглах болжээ. 1990-ээд онд SWOT шинжилгээ нь стратегийн менежментэд голлох байр суурийг эзлэн олон салбарт ашигласан төдийгүй шинжилгээний бусад техникүүдтэй хослуулан хэрэглэх болов. Тухайлбал PESTEL, АНР, таван хүчин зүйлийн загвар гэх мэт. Ингээг хослуулсан шинжилгээ нь илүү хүчирхэг стратегийн шийдвэр, баталгаатай үр дүнд хүргэх болжээ¹⁸. (М.А)

НУТГИЙН ЗАХИРГАА (*Local administration*) Тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд төрийн бодлогыг хэрэгжүүлж, удирдах эрх бүхий иргэдийн нийтлэг ашиг сонирхолд чиглэгддэг үйл ажиллагаа. Аливаа улсын засаг захиргааны нэгжийн бүтэц тогтолцооноос хамааран нутгийн захиргаа, нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн хүрээнд зохицуулагдана. Тухайлбал “Орон нутгийн удирдлагын тухай хууль” –ын дагуу Япон Улсын нутгийн захиргааны байгууллагын тогтолцоо, засаг даргын эрх, чиг үүргийг тодорхойлсон¹⁹. Засаг захиргааны

17 Mostafa Ali Benzaghta, Abdulaziz Elwalda et al, SWOT analysis application: An integrative literature review, Journal of Global Business Insights, 2021 Vol.6, p. 57.

18 Mostafa Ali Benzaghta, Abdulaziz Elwalda et al, SWOT analysis application: An integrative literature review, Journal of Global Business Insights, 2021 Vol.6, p. 57.

19 Konrad Adenauer Stiftung: “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь: Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж”, Улаанбаатар хот 2019, х. 74.

нэгжээс хамааран захиргааны анхан шатны нэгжүүдийн хүрээнд төрийн бодлого хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх нь засаглалын зарчмуудыг хангаж ажиллах шаардлагатай. (Г.Б)

НУТГИЙН ЗАХИРГААНЫ ДҮРЭМ *(Rules of local administration)*

1921 оны ардын хувьсгалын дараагаар ноёд толгойлдог байсан орон нутгийн захиргааг ардчилсан ёсоор зохион байгуулах зорилгоор гаргасан. 1923 оны гуравдугаар сард гарсан. 6 бүлэг, 58 зүйлтэй. Түүний нэгдүгээр зүйлд “Бидний Монгол Улс нэгэнт ардын эрхтэй хэмжээт цаазат улсын засгийг байгуулсны тулд, арван гэрээс дээш баг, сум, хошуу, аймаг, улсын засгийн газар хүртэл тус тусын ардын төлөөлөгчдийг сонгон хуралдуулж, дэс дараалан хурал байгуулан, элдэв хэрэг зүйлийг хэлэлцүүлж, олонхын саналаар таслан тогтоож, ардын эрхийг эрхэмлэн хүндэтгэвэл зохино” хэмээн заажээ. Уг дүрэм нийтлэг зүйлээс гадна арван гэрийн, багийн, сумын, хошууны хурал, засаг дарга ба хошууны тамгын газрын дүрмийг багтаасан байна. Аймгийн захиргааны дүрмийг тусад гаргасан байна. Мөн оны 1 сард Ховдын харьяат газрын нутгийн захиргааны дүрмийг жич гаргажээ. (А.Ц)

НУТГИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГА *(Local self-governance organizations)*

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид орон нутгийн шинжтэй асуудлыг зохион байгуулж удирдах, улс орны хэмжээнд явуулж буй бодлогыг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий бие даасан, эрх зүйн хэм хэмжээний хүрээнд эрх мэдлийг нутгийн өөрийн удирдлагын байгууллага хэрэгжүүлнэ. Нутгийн өөрийн удирдлагын байгууллага нь

орон нутгийн хэмжээний нийгэм, эдийн засгийн асуудлаа өөрөө бие даан шийдвэрлэж хэрэгжүүлж ажилладаг онцлогтой. Орон нутгийн түвшинд иргэд шийдвэр гаргах хэрэгжүүлэх боломжийг нутгийн өөрөө удирдах байгууллага олгоно. Орон нутгийн иргэдийн өмнөөс сонгогдсон байгууллага, албан тушаалтнууд ажиллах ба нутгийн өөрөө удирдах байгууллага төр, засгийн бодлогыг орон нутгийн ашиг сонирхолтой зохистой хослуулах нь чухал. (Г.Б)

НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁС *(Local self-government)*

Нутгийн өөрөө удирдах ёс болард түмэн засгийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх нэг хэлбэр юм. Түүний мөн чанар нь ард түмэн шууд буюу орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаараа уламжлан орон нутгийн ач холбогдолтой эдийн засаг, нийгмийн асуудлыг бие даан зохион байгуулж шийдвэрлэхэд оршино. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь аймаг, нийслэл, сум дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн хурал байна. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ (Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг). Нутгийн өөрөө удирдах ёс нь Монгол Улсын Үндсэн хуулийн байгууллын нэгэн үндэс бөгөөд Монгол Улсын бүх нутаг дэвсгэрт хэрэгжинэ. (Ч.Э)

НУТГИЙН УДИРДЛАГА *(Local government)*

Тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд тодорхой арга хэмжээг шийдвэрлэх, тодорхойлох эрх бүхий төрийн удирдлагын хэлбэр. Нутгийн

өөрөө удирдах ёс XIII зууны сүүл, XIX зууны эхэнд Францын их хувьсгалын эед орон нутгийн бие даасан байдлаар илэрхийлэгдэх ба улмаар нутгийн өөрөө удирдах ёс үүссэн хөгжсөн нь хөрөнгөтний хувьсгал хийгдэж, феодалын нийгмээс аж үйлдвэржсэн, төвлөрсөн хөгжлийн замд шилжин, хотууд үүсэж, орон нутаг төв засгийн хяналтаас хамааралгүй, бие даан хөгжих нөхцөл үүссэн²⁰. Нутгийн удирдлага нь тодорхой хүн ам, газар нутаг, гуравдагч этгээдтэй харилцаа холбоо тогтоох эрх зүйн актаар тогтоосон эрх мэдэлтэй, зохион байгуулалттай, санхүүгийн функцийг хэрэгжүүлэх /тагвар авах, төсөв тодорхойлох/ чадавхтай байх зэрэг онцлог шинж чанартай байх ёстой²¹. Нутгийн өөрөө удирдах ёсны онолын үндэслэлийг боловсруулахад Alexis de Tocqueville, Rudolf von Gneist, Lorenz von Stein, Paul Laband нар гол үүрэг гүйцэтгэсэн. Нутгийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааг нэгтгэсэн өргөн хүрээний ойлголт юм. (Г.Б)

НЭГДСЭН СТРАТЕГИ (*Grand strategy*)

Өргөн хүрээнд тодорхойлогдсон байгууллагын урт хугацааны чиглэл²² буюу нэгдсэн стратеги гэнэ. Гол агуулга нь тухайн улсын эрэлхийлж буй зорилтуудыг тодорхойлж, түүнд хэрхэн хүрэх зааварчилгаа өгдөг²³ оршино. Нэгдсэн стратеги ойлголтын олон үзэл баримтлал бий. Түүхчид тэр дундаа цэргийн түүхчид

ихэвчлэн нэгдсэн стратегийн үзэл баримтлалын талаар судалдаг байна. “Нэгдсэн стратеги”-г мастер стратеги хэмээн зарим тохиолдолд нэрлэдэг бөгөөд сайтар боловсруулсан, нарийвчилсан төлөвлөгөө гэж үздэг. Лидделл Харт (Liddell Hart) дайны явцад стратегийн “илүү өндөр” түвшин байгааг тодорхойлж түүнийг “нэгдсэн стратеги” гэж нэрлэн, дайны ажиллагааг удирдан чиглүүлдэг бодлоготой ижил утгатай боловч ялгаа нь “хэрэгжүүлж буй бодлого” гэж тодорхойлсон. Судлаач Д.Фиавер (D. Feaver)-ын үзэж байгаагаар нэгдсэн стратеги нь бодлоготой нарийвчилсан төлөвлөгөө бөгөөд тухайн улсын үндэсний ашиг сонирхлыг хангахын тулд улс төр, цэрэг, дипломат, эдийн засгийн арга хэрэгслийг хамтран ашиглах төрийн хүчин чармайлтыг багтаасан төлөвлөгөө, бодлогын цогц юм. Колин Дюк (Colin Dueck), Чарльз Н.Эдель (Charles N. Edel) нарын үзэл баримтлалаар нэгдсэн стратеги гэсэн ойлголт нь төлөвлөгөө биш, зохион байгуулалтын зарчим гэж батлахыг зорьсон байдаг. Эдель жишээ болгон АНУ-ын ерөнхийлөгч Ж.К.Адамс (J.Q. Adams)-ийг “дотоодоо эв нэгдэлтэй байх, гадаад харилцаанд төвийг сахих” хоёр санааг шийдвэр гаргахдаа удирдан чиглүүлэх зарчим болгон хэрэгжүүлж байсан гэж тайлбарладаг. Нэгдсэн стратеги нь зан төлөвийн хэв маяг, загвар гэж үзэх өөр нэг үзэл баримтлал бий. Зарим тохиолдолд зарчим, төлөвлөгөөг зан төлөвийн хэв маягийг харуулах нотлох баримт болгон ашигладаг гэж тайлбарлах нь ч бий. Судлаач Н.Луттвак (*N. Luttwak*)-ийн үзсэнээр нэгдсэн стратеги бол цэргийн хүч, дипломат ажиллагаа, тагнуул зэрэг улсын нөөцийг бусад улсын эдгээр нөөцийг ашиглахтай харилцан уялдаатай ашиглах явдал юм. Хенри

20 Konrad Adenauer Stiftung: “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь: Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж”, Улаанбаатар хот 2019, х. 26.

21 Humes, S., & Martin, E. M.: “The structure of local governments throughout the world”, Martinus Nijhoff 1961.

22 David H. Holt, Management Principles and Practices, 1990, 194 дахь тал.

23 Nina Silove, Beyond the Buzzword: The Three Meanings of “Grand Strategy”, Volume 27, 2018 - Issue 1

Минцберг (Henry Mintzberg): стратеги нь “хэв маяг, загвар, хэсэг хугацааны зан төлөвийн тогтвортой байдал” хэмээн “хэрэгжүүлсэн стратеги” гэж нэрлэсэн²⁴. (Д.Ч)

НЭГДСЭН ТӨСӨВ (Consolidation budget) Бүх харьяа байгууллагуудын төсвийн орлого, зарлагыг бүлэглэн, нэгтгэн харуулсан төсвийг хэлдэг. Тухайлбал; аливаа нэг улсын Засгийн газрын хувьд өөрийн мэдлийн орон нутаг болон төрийн өмчтэй аж ахуйн нэгж байгууллагууд болон сангуудын төсвийн орлого зарлагыг нэгтгэсэн байдлаар харуулсан төсвийг хэлнэ. Жишээ нь, улсын төсвөөс гадна эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын сангийн, мөн түүнчлэн орон нутгийн төсөв тэдгээрийг нэгтгэн харуулах гэсэн үг. (А.Э)

НЭГДСЭН УДИРДЛАГААР ХАНГАХ (Providing integrated management)

Төрийн байгууллагын үйл ажиллагааг тухайн байгууллагын зорилго, зорилтуудад төвлөрүүлэн чиглүүлсэн төлөвлөснөөр хэрэгжүүлэлтийн шатанд стратегийн болон хяналт зохицуулалт, менежментийн хослолыг ашигласан удирдлагын арга хэрэгсэл бүхий үйл ажиллагаа. Энэ нь нийтийн салбарт төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоо, дэд системүүдийг харилцан хамааралтай холбоотой бөгөөд төв засгийн газраас төрийн байгууллагуудыг, эсвэл салбарын яамнаас харьяа агентлаг, нэгжийг, орон нутгийн захиргааны байгууллагаас засгийн газрын бүрэн эрхийн төлөөлөгчийн шууд удирдлагад багтах байгууллагыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, тодорхой зорилгод чиглүүлж,

үр дүнг бий болгож байгаа эсэхэд чиглэгдэнэ. (Г.Б)

НЭГ ИРГЭН-НЭГ БҮРТГЭЛ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (National program-“One Citizen-One Registration”)

Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, эх нотлох баримтыг бүрэн цахимжуулж, цахим хэрэглээг нэмэгдүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, төрийн ой санамжийг бэхжүүлэх зорилго бүхий бодлогын баримт бичиг. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 144 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Нэг иргэн-нэг бүртгэл" үндэсний хөтөлбөр нь 2018-2021 онд хэрэгжих ба иргэд хаана байгаагаас үл хамааран бүртгэлийн мэдээлэл, үйлчилгээг цахим хэлбэрээр чирэгдэлгүйгээр, шуурхай авах нөхцөл бүрдсэнээр үр дүн нь хэмжигдэнэ. (Д.3; Ч.Л нар)

НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (One-stop service)

Нэг цэгийн үйлчилгээ нь нэг байршилд төрийн болон хувийн салбарын олон төрлийн үйлчилгээг нэгтгэн нэг эсвэл хэд хэдэн сувгаар дамжуулан иргэд, аж ахуйн нэгжид хүргэхэд зориулсан үйлчилгээний төв юм²⁵. Дэлхийн банкны судалгаагаар 82 улс орон нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан төрөөс иргэдэд зориулсан үйлчилгээг хүргэж байна²⁶. Нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлсэн улс орнуудад төрийн үйлчилгээг хүргэх ажил илүү үр ашигтай болж, авлига буурсан, иргэдийн сэтгэл ханамж нэмэгдсэн гэх зэрэг эерэг үр дүн гарсан байна. Монгол Улсын хувьд төрийн үйлчилгээг ил тод, шуурхай хүргэх,

24 Nina Silove (2018) Beyond the Buzzword: The Three Meanings of “Grand Strategy”, Security Studies, 27:1, 27-57, DOI: [10.1080/09636412.2017.1360073](https://doi.org/10.1080/09636412.2017.1360073)

25 World bank, GCPCE, UNDP, “Re-inventing service delivery through one stop shops”, 2017, p. 7.

26 World bank, GCPCE, UNDP, “Re-inventing service delivery through one stop shops”, 2017, p. 7.

хүнд суртал, авлигын эсрэг тэмцлийг хүчтэй болгох зорилгоор “Төрийн захиргааны бүх шатны байгууллагын түвшинд “Нэг цэгийн үйлчилгээ”-г нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж эрчимжүүлэх” шийдвэрийг Засгийн газар 2007 онд 03 дугаар тогтоолоороо гаргаж анх нийслэлийн Сүхбаатар дүүрэгт жишиг байдлаар нэвтрүүлж эхэлжээ. Үүнээс хойш нийслэлийн бүх дүүрэг, аймгууд, зарим сум болон хороод, зарим байгууллагуудад нэг цэгийн үйлчилгээ нь “нэг цонхны үйлчилгээ”, “төрийн үйлчилгээний нэгдсэн төв” нэрээр хэрэгжсэн байна. (М.А)

НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ (Openness)

Үгийн үндэс нь “open” буюу “илэрхий, онгорхой” гэх утгатай. “Openness” гэдэг нь нэр үг бөгөөд “эд хөрөнгө эсвэл ямар нэг байдал нийтэд нээлттэй” гэсэн утгыг илэрхийлдэг. Монгол хэлний тайлбар тольд нээлттэй гэдгийг “төрийн үйл ажиллагаа олон түмэнд ил тод байлгах” гэж тайлбарлажээ. Монгол хэлнээ “openness” гэдгийг нээлттэй байдал гэж орчуулдаг бөгөөд энэ нь төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй болон мэдээллийн ил тод байдалтай холбогддог. Тухайлбал, мэдээллийн ил тод байдал нь “нийтэд зориулагдсан мэдээлэл хүртээмжтэй, иргэд нь мэдээлэл олж авах боломжоор хангагдсан, өгч буй мэдээлэл нь үнэн зөв, алдаа мадаггүй, энгийн иргэнд ойлгогдохуйц, мөн ашиглагдахуйц, цаг үеэсээ хоцроогүй байх”-ыг шаарддаг. Төрийн захиргааны ил тод, нээлттэй байдал нь холбогдох мэдээлэл хэрэглэж болохуйц хэлбэрээр иргэдийн гар дээр байх, төр засгийн зохицуулалт, шийдвэрийг иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй түгээн дэлгэрүүлдэг

байхыг хэлдэг.²⁷ Нээлттэй байдал нь хариуцлагын тогтолцоог жинхэнэ утгаар хэрэгжүүлэх урьдах нөхцөл байж, урьдаас тодорхой байдлыг бататгаж өгдөг. Энэ нь иргэд болон бусад оролцогч талуудыг харилцан ярилцах, хараат бус хяналт-шинжилгээ хийх, олон нийтийн оролцоот хяналт тавих зэргээр хамтын ажиллагааг дэмжсэн эхний алхам юм. Иргэд мэдээлэлгүй бол дуу хоолойгоо төрд хүргэж чадахгүй. Нээлттэй хариуцлагатай байдлыг бий болгосноор нийгэмд итгэлцэл бүрдэж, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл буурдаг байна. Төрийн захиргааны ил тод нээлттэй байдал нь төр засгаас олон нийттэй харилцах харилцаа, иргэдийн мэдээлэл олж авах эрх гэсэн хоёр үндсэн талтай байдаг. Олон нийтийн харилцаа нь төр засгийн зүгээс холбогдох мэдээлэл, үйл ажиллагааг ил болгох, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн тусгай хүчин чармайлт шаарддаг. Төр засгаас мэдээлэл авах иргэд олон нийтийн эрхийг гол төлөв мэдээллийн эрх чөлөөний хуулиар зохицуулдаг. Засаглалын чанар муудах тусам төр засгийн шийдвэр гаргах үйл явц, мэдээлэл ил тод бус болж, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд хязгаарлагдмал үйл ажиллагаатай болдог. (Г.Т)

НЭЭЛТТЭЙ ЗАСАГ (Open Government)

Төрийн бодлого, үйл ажиллагаа, тэдгээртэй холбоотой баримт, мэдээллийг олон нийтэд ил тод байлгаж, эдгээр үйл ажиллагаанд иргэд чөлөөтэй оролцох боломж нөхцөлийг бүрдүүлдэг удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо. Нээлттэй буюу “open” гэх үг нь эртний англи хэлнээ “хаагаагүй”, мөн “ил, тод, олонд танигдсан, олон

27 Шиаво Кампо, Сундарам, 2000, өрсөлдөөнт ертөнцөд төрийн захиргааг сайжруулах нь, х. 250.

нийтэд" гэх ойлголтоор хэрэглэгддэг байв. Government (буюу засгийн газар) гэдэг нь XIV зууны сүүлчээр "удирдах буюу захирах үйлдэл", 1550-аад оны үед "аливаа зүйлийг удирддаг тогтолцоо" гэх утгаар хэрэглэгддэг байжээ. Монгол хэлнээ Open government гэдгийг нээлттэй засгийн газар гэж орчуулан хэрэглэдэг. Төрийн үйл ажиллагаанд нээлттэй засгийн тогтолцоонд баримтлах зарчмуудыг хэрэгжүүлж чадсанаар нэг талаас иргэд төлсөн татвараа зөв зарцуулагдаж байгааг болон төр засгийн бодлого үйл ажиллагаа өөрсдийнх нь эрх ашгийн төлөө байгааг ойлгож дэмжих, нөгөө талаас төр иргэдийнхээ итгэлийг хүлээж, үйлчилгээ болон үйл ажиллагаа нь бүхэлдээ үр ашигтай болох үр дүнд хүрэх бодит боломжтой гэж үздэг. Сүүлийн жилүүдэд улс орнууд нээлттэй засгийн газрыг бий болгох зорилгоор орчин үеийн мэдээлэл технологийн шийдлийг ашиглах явдал түгээмэл болов. (Д.З; Ч.Л, Т.Т нар)

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ (*Open society*)

Иргэд нь төрийн бодлого, нийгэмд үүссэн аливаа асуудлын талаар санаа бодлоо чөлөөтэй илэрхийлдэг, амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөрөнгө өмчлөх, сурч боловсрох, хөрөнгө үйл хэрэгт оролцох, шашин шүтэх, эвлэлдэн нэгдэх зэрэг хүний үндсэн эрх, эрх чөлөө нь хуулиар хамгаалагдсан, иргэн бүрийг хамгаалах тогтолцоо бүхий нийгмийг хэлнэ. “Нээлттэй нийгэм” гэх томьёоллыг философич К.Поппер 1945 онд бичсэн “Нээлттэй нийгэм ба түүний дайсан” бүтээлдээ дурдсан ба бие хүмүүс нь шийдвэрээ бие даан гаргадаг нийгмийг нээлттэй нийгэм хэмээн нэрлэх санааг дэвшүүлсэн юм. (Б.Б)

НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ПОРТАЛ (*Open data portal*)

Засгийн газар, агентлаг, байгууллагаас нийтэлж буй нээлттэй өгөгдөлд нэг цэгээс хандах, хайх боломжийг олон нийтэд олгодог, каталогийн үйлчилгээ үзүүлдэг платформ (ихэвчлэн веб сайтаар ханддаг). Ингэснээр төрийн өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулж судалгаа хийж, шинжилж баялаг бүтээх болон төрийн үйл ажиллагаанд шинэ, шинэлэг шийдэл нэвтрүүлж төртэй бүтээлч, инновацлаг хамтран ажиллах боломжийг иргэд, бизнесийн байгууллагууд, төрийн бус байгууллагуудад нээдэг. Монгол Улсын Засгийн газрын портал нь Ухаалаг засаг төслийн хүрээнд хөгжүүлсэн opendata.gov.mn болно. (Д.З; Ч.Л нар)

НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ЭКОСИСТЕМ (*Open data ecosystem*)

Эдийн засаг, бодлого, эрх зүйн систем зэргийг хамарсан өргөн орчинд нээлттэй өгөгдлөөс мэдээлэл нэгтгэн цуглуулах, шинжлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд төр, инноваторууд, иргэдийн харилцан хамаарал. Өгөгдлийг нийтэд нээлттэй болгох нь өгөгдлийн хэрэглээг бий болгоход хангалтгүй байдаг. Экосистемийн оролцогч талуудын өгөгдлийг сонирхох, боломжит өгөгдөл болон мэдээллийг ашиглан үйлчилгээг сайжруулах, шинэ үйлчилгээ бий болгох сонирхлыг төрүүлж идэвхжүүлэх шаардлагатай. Нээлттэй өгөгдлийн идэвхтэй сүлжээ, нийгэмлэг үүсгэн байгуулах, төрийн өгөгдлийг ашиглан шинэ инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээ бүтээх уралдаан, уулзалт, арга хэмжээ зохион байгуулах нь нээлттэй өгөгдлийн экосистемийг дэмждэг. (Д.З; Ч.Л нар)

НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ (Open data)

Хэн ч чөлөөтэй ашиглаж, өөр зорилгоор хэрэглэж, дахин түгээж болдог, нээлттэй лицензтэй өгөгдөл. Нээлттэй өгөгдөл нь анхдагч эх сурвалжаас цуглуулсан байх, үнэн зөв байх, хэсэгчлээгүй бүрэн гүйцэд байх, тогтмол шинэчлэгддэг байх, төлбөргүй байх, машинаар уншигдахуйц бүтэцлэгдсэн форматтай байх, цахим хэлбэрээр онлайнаар татаж авах боломжтой байх, нээлттэй лицензтэй байх гэсэн үндсэн шинжтэй байх шаардлагатай. Аливаа байгууллага өөрийн өгөгдлөө нээлттэй болгосноор өөрийн үйл ажиллагаа, үйлчилгээгээ сайжруулах шинэ санал, санаачилгыг нээж хамтран ажиллах, инновацыг нэвтрүүлэх, харилцан ашигтай түншлэлийг дэмжих боломж бүрддэг. Сүүлийн жилүүдэд нээлттэй өгөгдлийг дэлгэрүүлэх санаачилгууд нэмэгдэж, нээлттэй өгөгдлийг ашиглан шинэ санаа, санаачилга, бүтээгдэхүүн гаргах уралдаан (хакатон) ихээр зохиогдож байна. (Д.З; Ч.Л нар)

НЭЭЛТТЭЙ СИСТЕМ (Open system)

Систем нь өөр хоорондоо харилцан уялдаатай хэсгүүдийн нэгдэл. Энэхүү системийг хүрээлж буй орчныг системийн орчин гэнэ. Орчноос хамаарах байдлаар нь нээлттэй ба хаалттай систем гэж ангилна. Орчны нөлөөнд орж, орчиндоо нөлөө үзүүлдэг системийг нээлттэй систем гэнэ²⁸ Нээлттэй систем нь орчныхоо хэсгүүдтэй харилцан үйлчлэлцдэг бол хаалттай систем нь орчноосоо тусгаарлагдсан байдаг. Нээлттэй системийн жишээ нь байгууллага юм. Байгууллага нь хоорондоо харилцан хамаарал бүхий хэсгүүдтэй, эдгээр нь

нэгдэж нэг том системийг бүрдүүлэх бөгөөд хэсэг бүр нь нэгдсэн системээс ямар нэг зүйлийг авч, өгч байдаг, эргээд нэгдсэн систем нь илүү том орчинтой харилцан хамааралтай байдаг нээлттэй систем юм. Нарийн төвөгтэй байгууллагуудыг судлах нэг арга нь тэдгээрийг нээлттэй эсвэл хаалттай системийн хандлагаар үзэх юм. (Д.Ч)

НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ (Open selection)

Албан тушаалын сул орон тоо гарсныг олон нийтэд нээлттэй зарлаж, тухайн албан тушаалд тавигдах мэдлэг чадварын шаардлагыг хангасан хүн бүрд тэгш боломж олгосон сонгон шалгаруулалт юм. Сонгон шалгаруулалтын үйл явц нь ажил горилөгчийн талаар мэдээлэл цуглуулах, тэднийг тогтоосон журам, зохицуулалтын дагуу үнэлэх, шийдвэр гаргах ажлуудаас бүрдэнэ²⁹. Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд “төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоог тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчаас, эсхүл холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагчаас, түүнчлэн төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс нөхөх боломжгүй тохиолдолд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах”³⁰-аар заасан. (М.А)

НЭЭЛТТЭЙ СТАНДАРТ (Open standard)

Олон нийт ашиглах боломжтой, ашгийн бус, роялти байхгүй стандарт. Оюуны өмчийн эзэмшил, боловсруулалтын явцын нээлттэй байдал, тодорхойлолтын нээлттэй байдлаас хамаарч нээлттэй стандартын янз бүрийн тодорхойлолт

28 Менежментийн шинжлэх ухааны нэр томьёоны тайлбар толь, Glossary of Management Science Terminology, Улаанбаатар, 2020, 218 дахь тал.

29 Пүрэвдагва Х., Батхурэл Г., “Хүний нөөцийн менежмент”, 2015, 187 дахь тал.

30 Төрийн албаны тухай хуулийн 27.1.4 дэх заалт.

байдаг. Нээлттэй стандартыг нээлттэй, ил тод байдлаар, олон хүний оролцоотойгоор хөгжүүлдэг. Веб (world wide web -WWW), флаш дискийн интерфейс (USB), шуурхайн санах ой (SDRAM, DDRAM), файлын нээлттэй формат (PNG, PDF, HTML г.м), интернетийн протокол (IP, TCP г.м) нь нээлттэй стандартын түгээмэл хэрэглээ болсон жишээ юм. Нээлттэй стандарт зарчмыг баримтлан хөгжүүлсэн стандартууд нь нээлттэй болон оролцоог хангасан байдал, харилцан үйлчлэх боломж ба глобал өрсөлдөөнийг дэмжсэнээр аажмаар ОУ-ын түвшинд зах зээл болон хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээ хөгждөг. Энэ нь шинэ зах зээл үүсэх болон одоо байгаа зах зээл өргөжин тэлэх инновацад хөтөлнө. (Д.З; Ч.Л нар)

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР (*Open tendering*) Нээлттэй тендер гэдэг нь бараа, үйлчилгээ, дэд бүтцийн ажлыг олж авахад хэрэглэгддэг, нийлүүлэгчдийн дунд өрсөлдөөнийг дэмждэг төрийн худалдан авах ажиллагааны арга юм. Худалдан авах ажиллагааны удирдамжид заасан, тендерийн стандарт баримт бичигт нарийвчлан тогтоосон журмын дагуу гүйцэтгэнэ. Нээлттэй тендер шалгаруулалтыг нээлттэй өрсөлдөөнт тендер, нээлттэй өрсөлдөөн, нээлттэй дуудлага гэж ангилдаг. (А.Э)

НЭЭЛТТЭЙ ФОРМАТ (*Open format*) Дурын хүн хэрэглэж болохоор тодорхойлолтын хамт нийтэлсэн файлын формат. Нээлттэй формат нь нэг файлыг төрөл бүрийн программ нээх боломжтой болгодог. Жишээ нь энгийн бичвэр (.txt өргөтгөлтэй) файлыг бичвэр боловсруулах төрөл бүрийн программ (Notepad, MS Word г.м) нээх боломжтой. Үүний

эсрэг нь нэг байгууллагын өмчлөлд байдаг зөвхөн тухайн байгууллагын программын тусламжтай л нээгддэг хаалттай буюу өмчийн формат юм. Байгууллага хооронд солилцох, бусадтай хуваалцах, нийтэд нээлттэй нийтлэх файлыг нээлттэй форматтай үүсгэх нь зохимжтой байдаг. Энэ нь төрийн болон бизнесийн байгууллагын мэдээллийн хүртээмжтэй байдлын нэгэн нөхцөл юм. (Д.З; Ч.Л нар)

НЭЭЛТТЭЙ ХЭРЭГЛЭГЧИЙН НЭР (*Open ID*) Веб сайтад өөрийн нэвтрэх систем шаардлагагүйгээр гуравдагч итгэмжлэгдсэн этгээдийн үйлчилгээг ашиглан хэрэглэгчээ таньж нэвтрүүлэх нээлттэй стандарт бөгөөд төвлөрсөн бус нэвтрэлт танилтын протокол. Нээлттэй хэрэглэгчийн нэрийг ашигласнаар олон төрлийн таних тэмдэг, нууц үг оруулахгүйгээр хоорондоо холбоогүй олон вебсайт руу нэвтрэх боломжийг хэрэглэгчид олгодог. (Д.З; Ч.Л нар)

НЭЭЛТТЭЙ ЭХ БҮХИЙ ПРОГРАММ (*Open source software*) Эх кодыг нь хэн ч ямар ч зорилгоор хэрэглэж, судалж, өөрчилж, түгээж болох эрх олгосон лицензтэйгээр нийтэд нээлттэй болгосон программ хангамж. Нээлттэй эх бүхий программ нь нийтийн хамтын ажиллагаагаар хөгжүүлэгдэж болдог бөгөөд энэ нь нээлттэй хамтын ажиллагааны тод жишээ юм. Нээлттэй эх гэдэг нэр томъёог 1998 оноос түгээмэл хэрэглэгдэж тухайн жилд Эрик Рэймонд (Eric Raymond) ба Брюс Перенс (Bruce Perens) нар Нээлттэй эхийн санаачилга байгууллагыг байгуулсан. Нээлттэй эх бүхий программ хангамж нь байгууллагын системийн ашиглалтын зардлыг бууруулах болон анхны хөрөнгө

оруулалт багатайгаар шинэ систем нэвтрүүлэх боломж олгодгоороо давуу талтай. Нээлттэй эх бүхий цахим сургалтад зориулсан платформ (Moodle, open edX г.м), байгууллагын нөөцийн удирдлагын систем (Odoo г.м), компьютерын болон гар утасны үйлдлийн систем (Linux, Android) нь түгээмэл хэрэглээтэй байдаг. Зарим улсын засгийн газрууд төрийн байгууллагуудын компьютерын үйлдлийн системээ нээлттэй эх бүхий үйлдлийн систем рүү шилжүүлэх санаачилгуудыг хэрэгжүүлж байна. Энэ нь зардлыг бууруулахаас гадна эх кодыг өөрчилж өөрийн хувилбарыг үүсгэх боломжтой нь аюулгүй байдлыг хангах ач холбогдолтой. (Д.З; Ч.Л нар)

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

(Accounting) Аливаа эдийн засгийн систем (байгууллага, салбар, Засгийн газар)-ийн үйл ажиллагаа ба нөөцийн урсгалд холбогдох санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг хэмжиж, бүртгэн, мэдээллийг боловсруулж тайлагнах үйл ажиллагааг хэлнэ. Нягтлан бодох бүртгэлийг “бизнесийн хэл” хэмээн нэрлэдэг ба аливаа эдийн засгийн үйл ажиллагааны үр дүнг хэмжиж бүртгэн бодлого боловсруулагч, удирдлага, хөрөнгө оруулагч, зохицуулагч, хяналт хэрэгжүүлэгч зэрэг харилцаанд оролцогч талуудыг шаардлагатай мэдээллээр хангадаг. Нягтлан бодох бүртгэлийг зорилгоос нь хамаарч санхүүгийн, удирдлагын, татварын, зардлын нягтлан бодох бүртгэл гэхчлэн ангилдаг. Санхүүгийн нягтлан бодох бүртгэл нь нийтээр хүлээн зөвшөөрсөн стандартын дагуу, бодит баримтад тулгуурлан байгууллага, нэгжийн санхүүгийн мэдээллийг боловсруулж нийтэд тайлагнадаг бүртгэлийн систем юм.

Удирдлагын бүртгэл нь эдийн засгийн системд хамаарах мэдээллийн боломжит бүх эх үүсвэрийг ашиглан эдийн засгийн үзүүлэлт, санхүүгийн нөөцийн урсгалд судалгаа, шинжилгээ хийж, өртөг зардлыг тооцоолон бүртгэж удирдлагыг оновчтой шийдвэр гаргахад туслах мэдээллээр хангах зорилготой систем юм. Татварын бүртгэл нь хууль, тогтоомжид нийцүүлэн татварын тооцоолол, тайлангийн зорилгоор хөтөлдөг бүртгэл. Байгууллага, аж ахуйн нэгжийн мөрдөх нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж хуульчлан үндэсний стандарт, холбогдох заавар, журмыг баталж мөрдүүлэх үүргийг төр хэрэгжүүлдэг. (Б.Б)

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (Accounting policy)

Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь санхүүгийн тайлан бэлтгэх, тайлагнахад баримтлах бүртгэлийн суурь, зарчим, үндэслэл, хөрөнгө, эх үүсвэр, орлого, зардал, үр дүн, тэдгээрийн бүрэлдэхүүнийг хүлээн зөвшөөрч хэмжих, бүртгэх шалгуур, бусад холбогдох дүрэм, журам, заавар, аргачлалыг багтаах бөгөөд бодлогыг байгууллагын эрх зүйн орчин, олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн тодорхойлж эрх бүхий этгээд баталдаг. Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь байгууллагын хэмжээнд зайлшгүй мөрдөгдөх хэм хэмжээг тогтоосон баримт бичиг бөгөөд нягтлан бодох бүртгэлийг хөтлөх гол үндэслэл болно. Түүнчлэн бодлогын баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэхэд оролцогч болон бусад сонирхогч талууд байгууллагын санхүүг ойлгох үндсэн нөхцөл болдог. (Б.Б)

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СТАНДАРТ (*Accounting standard*)

Улс орны хил дамнан хийгдэх санхүүгийн ба санхүүгийн бус ажил, гүйлгээ, хөрөнгийн урсгал нэмэгдэж байгаагаас шалтгаалан нийтээр хүлээн зөвшөөрсөн нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журмуудыг баталж мөрдүүлдэг ба эдгээрийг нэгтгэн нягтлан бодох бүртгэлийн стандарт гэж нэрлэдэг. Стандарт нь санхүүгийн ажил гүйлгээг харьцуулах боломж олгох болон нягтлан бодох бүртгэл, тайланг нэг хэв загварт ойртуулах зорилгоор боловсруулагддаг. Жишээлбэл, Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт нь дэлхийн санхүүгийн зах зээлд ил тод, хариуцлагатай байдлыг дэмжиж үр ашгийг дээшлүүлэх зорилготой.³¹ Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллага нь санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын аль тохирохыг мөрдөхөөр хуульчилсан.³² (Б.Б)

НЯГТРАЛЫГ СИЙРЭГЖҮҮЛЭХ (*Deconcentration*)

Уг үгийн үндэс нь “deconcentrate” гэх бөгөөд concentrate гэдэг үгийг эсрэг утгаар нь анх 1879 онд хэрэглэсэн байдаг. Үгийн утга нь “төвөөс тараах/задраах/, сарниах (spread or scatter from a point or center)” гэсэн утгыг илэрхийлдэг. Нягтралыг сийрэгжүүлэх нь захиргааны ажлын ачааллыг улсын нийслэл дэх төрийн захиргааны төв байгууллагуудаас тэдгээрийн харьяа бүс, орон нутаг, байгууллага, ажилтнуудад шилжүүлэх үйл явц юм. Гэхдээ эрх мэдлийг тараах нь үр ашгийг

нэмэгдүүлэх зорилгоор төрийн захиргааны төв байгууллагын дотор хэрэгжүүлж буй арга хэмжээ болохоос шийдвэр гаргах эрх мэдэл, өөртөө засах эрхийг төв засгийн газраас доод түвшинд шилжүүлэх үйл явцыг агуулдаггүй. Гэхдээ засгийн газрын үйл ажиллагааг иргэдэд ойртуулах утгаараа ялангуяа шилжилтийн эдийн засагтай, төвлөрөл ихтэй засгийн газруудын хувьд төвлөрлийг сааруулах эхний алхам гэж үздэг. (Т.Т)

31 <https://www.ifrs.org/use-around-the-world/why-global-accounting-standards/>

32 Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль



ОВСГООТ ЧАНАР (*Intrapreneurship*)

Эл нэр томьёог анх 1978 онд Гиффорд Пинчот III, Элизабет Пинчот (Gifford Pinchot III & Elizabeth Pinchot) нар “Intra-Corporate Entrepreneurship” илтгэлдээ хэрэглэсэн байна. Эл нэр томьёоны агуулга нь ажилтан байгууллагынхаа дотоодод энтрепренер шинжтэй үйл ажиллагаа явуулах бололцоо нөхцөл хангагдсан байх гэсэн үг юм. Овсгоот тогтолцооны үед ажилтан нь идэвхтэй, өөрийгөө сэдэлжүүлдэг, инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргахын тулд санал санаачилга гаргадаг байна. Энтрепренер нь байгууллагадаа инновац хийж байгууллагынхаа мэдэлд байгаа болон хараахан түүний мэдэлд бус боловч олж авах боломжтой нөөцүүдийг ашиглан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг буй болгох үйл ажиллагаа бол овсгоот байдал нь байгууллагын мэдэлд байгаа нөөцийг ашиглан инновац хийдэг. Стратеги, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, энтрепренер чанарын судлаач Майкл Кусаманогийн үзэж байгаагаар интрапренер нь ямар нэг урьд өмнө хийж байгаагүй зүйлийг, эсхүл хийдэг байсан ч өөрөөр хийдэг байсныг нь өөрчилж хийх явдал ажээ. Ажилтнуудын бүтээлч, шинэчлэгч шинж чанарыг төлөвшүүлэх, зан үйлийг нь хөхиүлэн дэмжих, хам

нөхцөлийг Овсгоот тогтолцоо гэнэ. Нэгэнт оршин байгаа байгууллагад тийм чанарыг хөгжүүлэх нь шинээр стартап буюу гарааны шинэ бизнес буй болгохоос төвөгтэй байдаг аж. Учир нь стартап бизнест эрсдэл хүлээсэн тохиолдолд алдах зүйл бага байдаг бол байгууллага дотор инновац хийхэд зах зээлээс эхлэн алдах зүйл ихтэй байдаг ажээ. Нөгөө талаар шинэчлэл нь нэгэнт хэвшсэн бизнест хохирол учруулах тохиолдол ч гардаг байна. Мөн байгууллагын хуучин соёл гэх зэрэг олон зүйл саад болно. Нөгөө талаас ажилтан бүр овсгоот чадваргүй ч байх нь бий. Тийм учраас байгууллагын дотоодод овсгоот тогтолцоог буй болгох нь судалгаа их шаарддаг. (Ц.Д).

ОЛИГАРХИ (*Oligarchy*) Эртний Грекийн “oligo” буюу зарим, цөөн гэсэн, харин “arch” нь удирдлага, эрх мэдэл гэсэн утгатай үгнээс гаралтай. Олигархи гэдэг нь “цөөнхийн засаглал, ноёрхол” буюу засаглал, эрх мэдэл хэсэг бүлэг хүмүүсийн гарт, нийгмийн баялаг цөөн гэр бүлийн хүрээнд төвлөрсөн улс төрийн дэглэм болохыг тольбичгүүдэд тодорхойлсон. Аристотелийн бүтээлд төрийн эрхийг барьж буй засаглалын хэв шинжид олигархийг язгууртны ноёрхлын төрөл арилжсан, ялзран унаж буй



гажуудсан цөөнхийн ноёрхлын нэгэн хэлбэр гэж тодорхойлсон. Орчин үеийн ардчилсан нийгэмд хууль ёсны дагуу хүлээн зөвшөөрөгдөөгүй хирнээ засгийн эрх барьж буй эдийн засгийн бүлэглэл бүхий авлигын утга хамт илэрхийлэгддэг улс төрийн системийг олигархийн засаглал хэмээн нэрлэдэг. Төрийн бүх эрх мэдэл харьцангуй цөөн тооны бүлэгт төвлөрдгөөс олигарх засаглал нь хөрөнгө чинээлэг, баячуудын бүлэг, давхаргын эрх ашигт үйлчилж, энэ нь нээлттэй илэрдэггүй, харин эдийн засгийн аргаар хяналт тогтоож байдгаараа онцлогтой юм. Түүгээр зогсохгүй олигархууд төр засгийн бодлого, шийдвэрийг өөрсдийн эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлдэг тул нийгмийн бүх салбар, түвшинд бий болдог сөрөг үзэгдэл. Улмаар эдийн засаг, санхүү, цэрэг арми, төрийн засаг захиргааны байгууллагууд төдийгүй шинжлэх ухааны салбарт ч бүрэлдэж, халдварлан тархах аюултай. Манай улс төрийн практикт 2000 оноос хойш нэлээдгүй дурдагдаж, танил хэрэглэгдэж байгаа нэр томьёо. (Я.Т)

ОЛОН НИЙТИЙН БАЙГУУЛЛАГА (БНМАУ) (*Public organizations in MPR*) Социализмын үеийн төрийн бус байгууллагуудын ерөнхий нэр. МҮЭ, МХЗЭ, Эрдэм дэлгэрүүлэх нийгэмлэг, Эмэгтэйчүүдийн холбоо, Найрамдлын нийгэмлэг гэх мэт маш олон байгууллага ажилладаг байв. Эдгээрийг социалист нийгмийн улс төрийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг, намыг олон түмэнтэй холбох үүрэг бүхий туслагч байгууллагууд хэмээдэг байв. Эдгээр байгууллагыг бас хөдөлмөрчдийн өөрөө удирдах ёсны байгууллага хэмээн үйлдвэрчний эвлэл бол коммунизмын сургууль, өөрөөр хэлбэл төр устсан үеийн хөдөлмөрчдийн өөрийгөө удирдах

байгууллагуын үүсэл хэмээн үздэг байжээ. Олон нийтийн байгууллагууд дотроос МХЗЭ намын дайчин туслах, бэлтгэл хүчин гэж үзэгддэг байсан учраас онцгой байр эзэлдэг байв. Хэдийгээр эдгээр байгууллага өөр өөрийн дүрэмтэй, зорилготой боловч социализм байгуулах үйлсэд бүхий л үйл ажиллагаагаа зориулах ёстой байв. Дүрмийн дагуу өөрийгөө зохион байгуулах, удирдлагаа сонгох эрхтэй боловч эдгээр нь намын байгууллагын зааврын дагуу шийдвэрлэгддэг байв. Дотоод харилцаандаа мөн ардчилсан төвлөн удирдах зарчмыг мөрдлөг болгоно. (А.Ц)

ОЛОН НИЙТИЙН САНАА БОДОЛ (*Public opinion*)

Олон нийтийн санаа бодол нь тодорхой асуудал, үйл явдал, хувь хүний тухай хүмүүсийн үнэлэмж, хандлага. Энэ нь тэдний итгэл үнэмшлийн илэрхийллээр тодорхойлогддог эдийн засаг, нийгмийн янз бүрийн нэгжүүдийн хоорондын харилцаа холбооны төрөл юм. Энэ талаар олон онол, үзэл баримтлал байдаг учраас энэхүү ойлголтыг нэг мөр тодорхойлох боломжгүй. “Олон нийтийн санаа бодол” гэсэн үгний гарал нь Латин хэлний “Opinio” гэдэг үгтэй холбоотой бөгөөд үүнийг шууд утгаар нь “view”, “publicus” гэж орчуулдаг байна. Энэхүү үзэл баримтлалын гарал үүсэл нь Европын соён гэгээрийн үеэс эхлэлтэй бөгөөд XVIII зууны үеэс ашиглагдаж эхэлжээ. Олон нийтийн санал бодлын чанарыг тухайн нийгмийн соёл, уламжлал, хэвшмэл ойлголтын нөлөө, мэдээллийн хэмжээ, урсгал зэргээр голчлон тодорхойлдог. Олон нийтийн санаа бодолтой холбоотой орчин үеийн онолуудыг хоёр төрөлд ангилдаг. Эхнийх нь тухайн субъектийн янз бүрийн асуудлын талаарх санаа бодлын

ерөнхий илэрхийлэл юм. Энэ нь илүү урт хугацаанд бий болдог ба үүний жишээ нь үзэл суртал. Хоёр дахь төрөл нь илүү тодорхой, хувийн шинжтэй бөгөөд энэ нь хүний үе үе өөрчлөгдөж болох өөрийн итгэл үнэмшлийг илэрхийлдэг. Ямар нэг үзэгдлийг олон нийтийн санаа бодол мөн хэмээн хүлээн зөвшөөрөхийн тулд дор хаяж дараах дөрвөн нөхцөл хангагдсан байна. Үүнд: ямар нэг асуудал байх ёстой, энэ талаар санал бодлоо илэрхийлж буй олон тооны хүмүүс байх, эдгээр санал бодлын ядаж зарим нь ижил байх, ийм ижилдүү санаа бодол нь шууд ба дам нөлөөтэй байна. Эдгээр нь олон нийтийн санаа бодол бүрэлдсэн эсэхийг тодорхойлох болон цаашид түүнийг шинжлэхэд ашиглах хүчин зүйлүүд юм. Олон нийтийн санаа бодлыг шашин, үзэл суртал, соёл, олон янзын хувийн үзэл бодол зэрэг олон хүчин зүйлээр дамжуулан төлөвшүүлдэг. Хүмүүс ихэнхдээ олж авах боломжтой бүх мэдээллээ ашигладаггүй тул олон нийтийн тодорхой бодлыг тодорхойлоход бэрхшээлтэй, санаа бодол төлөвших үйл явц нь ихэвчлэн нарийн, системтэй байдаггүй. Ихэнх тохиолдолд олон нийтийн санаа бодлыг бий болгоход маш чухал хүчин зүйл бол тодорхой сэдвийн талаарх зөрчилдөж буй үзэл бодол юм. Тэдгээр нь асуудлын талаарх олон түмний мэдлэгийг дээшлүүлж, ингэснээр тодорхой сэдвээр олон нийтийн санаа бодол илүү гүнзгий байх болно. Олон нийтийн санаа бодлын хэд хэдэн үндсэн шинж чанаруудыг ялган үздэг. Үүнд: боломжит хэд хэдэн хувилбараас сонгох, энэ бол түр зуурын, өөрчлөгдөж буй хүчин зүйл юм. Энэ бол хамтран “үйлдвэрлэсэн” хамгийн нийтлэг үзэл бодол юм.

Санал бодлоо илэрхийлж, хэвлэн нийтэлдэг, хэвлэл мэдээлэл, технологид нэвтрэх чадвартай, нийгмийн нөлөө өндөртэй элит үзэл бодлын удирдагчид, санал асуулга, санал асуулгаар цуглуулсан үзэл бодлыг илэрхийлэх, хэмжих статистик бүртгэл, нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр үзэл бодол нь давамгайлахын зэрэгцээ бусдын үзэл бодолтой ижил байгаа хүмүүс, хэвлэл мэдээллийн хэрэгсэл хамтран буй болгодог. Технологийн дэвшил нь хүмүүст хүрэх мэдээллийн хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүлж, цар хүрээг тэлж, мэдээллийг олж авах явцыг хурдасгасан нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн хөгжилд ч тусгалаа олсон. Хэвлэл мэдээлэл нь хэвлэл, радио, телевиз, кино, театр, ном, үйлчилгээ зэрэг хэд хэдэн нөлөө бүхий төрлөөр дамжуулан олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Одоогийн байдлаар ихэнх төрлийн медиа хэрэгслийг маш өргөн хүрээнд боловсруулж байгаа тул хүлээн авагчид тэдгээрт нэвтрэхэд хялбар байдаг. Эдгээр нь орчин үеийн үйл явдлыг ойлгоход маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Хэвлэл мэдээлэл нь олон нийтийн санаа бодлын уялдаа холбоо, бүрэн бүтэн байдалд нөлөөлж, улс төр, нийгэм, соёл, эдийн засгийн янз бүрийн асуудалтай холбодог. Олон нийтийн санаа бодлыг хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй зөв харьцуулахын тулд юуны өмнө гурван үндсэн хэрэглээг ялгах хэрэгтэй.

- Танин мэдэхүйн зорилготой
- Зугаа цэнгэлийн зорилготой
- Боловсролын зорилготой

Танин мэдэхүйн хөтөлбөрүүд нь хүмүүсийг янз бүрийн мэдээлэл авах хэрэгцээ шаардлагыг бий болгож, бас тэр хэрэгцээг хангана. Энэ нь

олон нийтийн санаа бодлыг ихээхэн өргөжүүлж чадна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өөр нэг чухал зүйл бол хүлээн авагчдад зориулсан зугаа цэнгэл юм. Энэ нь ихэвчлэн хэвлэл мэдээллийн тодорхой хэрэгслийн давамгайлал, хүн амын тодорхой бүлэгт хаяглах зэрэгтэй холбоотой байдаг. Гурав дахь программ нь боловсрол бөгөөд энэ нь хүлээн авагчийн авьяас чадварын төлөв байдалд нөлөөлдөг байна. (Ц.Д)

ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ (*Social network*) Хувь хүмүүс өөрийн нэгдмэл сонирхлоороо нэгдсэн нийгмийн бүтэц. Нийгмийн мэдээллийн хэрэгслийн технологи хөгжсөнөөр цахим орчин дахь нийгмийн сүлжээ бодит зүйл болсон. Энэ ойлголтыг Жэймс Барнес (James Barnes) 1951 онд анх хэрэглэж байсан бол 1990-ээд онд технологийн олон боломж үүсэж интернет нийтийн хэрэглээнд нэвтэртэл төдийлөн ашиглагдаагүй юм. Орчин үеийн анхны нийгмийн сүлжээ нь 1995 Рэнди Конрад (Randy Conrad)-ын үүсгэсэн Classmates.com юм. Улмаар 2002 оноос эрчимтэй хөгжиж эхлээд өдгөө нийгмийн сүлжээ нь олон нийтийн салшгүй нэг хэрэглээ болж цахим орчин дахь хоёрдогч нийгмийн харилцаа болоод байна. Байгууллага нь нийгмийн сүлжээг зөв зохистой, үр ашигтай ашигласнаар өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэрэгжүүлж буй бодлогоо сурталчлах, олон нийтэд нөлөөлөх, хэрэглэгч болон иргэдийн сэтгэл ханамж, санаа бодлыг тандан судлах боломжтой. (Д.З; Ч.Л нар)

ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТ (*Public control*) Ихэнхдээ улс төрийн нам, төрийн бус байгууллага, иргэдийн санаачилгаар хийгддэг хуулиар олгосон хүний эрх, эрх чөлөөг

хамгаалан илэрхийлэх хяналтын төрөл. Иргэд төрийн байгууллагын үйл ажиллагааг хянах, үнэлэх албан ёсны үнэлгээний багийн гишүүнээр оролцох, эсвэл аливаа хөндлөнгийн хяналтын багт ажиллах нь олон нийтийн шууд хяналтын хэлбэрт багтдаг бол олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээ, хувь хүн, төлөөлөгч буюу гуравдагч этгээд, техник хэрэгслээр дамжуулан хяналт тавих эрхээ эдлэх, хяналтын үйл ажиллагааг эрхэлж байгаа тохиолдолд энэ нь шууд бус хяналтын хэлбэр болдог ба олон нийтийн хяналт сул эсвэл хүчтэй байх нь тухайн улсын төрийн дэглэмтэй холбоотой. (Г.Б)

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА (*Public relations*)

Байгууллага болон олон нийт хоорондын харилцан ойлголцол, хүлээн зөвшөөрөлт, хамтын ажиллагааг бий болгох, хадгалахад тусалдаг удирдлагын өвөрмөц чиг үүрэг. Олон нийтийн санаа бодлын талаар мэдээлэлтэй байж, хариу үйлдэл үзүүлэх, нийтийн ашиг сонирхолд үйлчлэх удирдлагын хариуцлагыг тодорхойлоход хэрэглэгдэх үндсэн арга хэрэгсэл нь олон нийттэй харилцах харилцаа юм. Улс орныхоо хөгжлийн үр дүнг сайжруулах зорилгоор шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг иргэнд олгох ба улс төр, эдийн засгийн үйл явцаас гадуурхагдсан иргэдийн хувьд эдгээр үйл явц ирээдүйд оролцуулах боломжийг бүрдүүлдэг эрх мэдлийн дахин хуваарилалт хийх боломжийг иргэдийн оролцоо хангана. Иргэний оролцоо нь захиргааны шийдвэр, үйл ажиллагаанд илүү хамааралтай буюу гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд нэн түгээмэл. (Г.Б)

ОЛОН ТҮМНИЙ ТӨЛӨӨХ СОНГОЛТЫН ОНОЛ (*Public choice theory*)

1963 онд Жеймс Буханан (James Buchanan), Гордан Таллок (Gordan Tullock) нарын эрдэмтэд уг онолыг үндэслэсэн байдаг. Тэдний үзсэнээр олон түмний төлөөх сонголт гэдгийг “хайр сэтгэлгүй улс төр” хэмээн тодорхойлсон нь уг онолын гол үзэл санааг илэрхийлжээ. Энэ онолоор улс төрийн шийдвэр гаргах үйл ажиллагааг эдийн засгийн харилцаагаар тодорхойлох оролдлого хийсэн. Өөрөөр хэлбэл, уг онолын зорилго нь нийгмийн амьдралд иргэдийн хүсэл сонирхлыг илэрхийлдэг олон түмний төлөөх сонголтын цаад мөн чанарыг тодорхойлоход чиглэсэн байна. Тухайлбал, уг онолд “улс төрийн амлалтаар жолоодуулан нэр дэвшигчид, зах зээлд амиа бодон ажиллаж байгаа жирийн бизнес эрхлэгчийн хооронд ялгаа байдаггүй гэж үзжээ. Хэрэв ялгаа байдаг бол хувийн сэдлээ бусдаас нууж чадаж байгаа эсэхээр ялгагдана. Улс төрчид амин хувиа бодож улс төрд ордог бөгөөд тэд хоорондоо хуйвалдаж хуулийг өөртөө үйлчлүүлэх замаар өөрсдийн эрх мэдлийг, ашиг орлогыг яг л зах зээлийн арилжаа наймаа эрхэлдэг худалдаачид шиг нэмэгдүүлж байдаг”¹ (А.Цанжид, 2009). Иймээс онолын үндэслэгчид нь улс төрчдийг эдийн засгийн сонирхолтой байдаг гэж үзжээ. Энэ нь хүмүүс аливаа үйл ажиллагаанд хувийн эрх ашгаа удирдлага болгож, өөрийн ашигт байдлын төлөө шийдвэр гаргадаг гэдгийг илэрхийлсэн. Товчоор хэлбэл, олон түмний эрх ашигт нийцсэн шийдвэр гаргах шаардлага тулгардаг хэдий ч энэ нь бодит байдалд хүмүүсийн сонголт дандаа хувийн эрх ашигт

үндэслэдэг байна. Нэгэнт хүний зан төлөвт хувийн ашиг сонирхол нь давамгайлдаг бол төрийн захиргаанд ажиллагсдын хувьд ч мөн адил хувийн сонирхол байдаг гэжээ. Ийм хувийн сонирхлыг чухалчилдаг хүмүүс эзэн-агентын харилцаанд ордог бөгөөд үүний үр дүнд хамтын ажиллагаа, ажлын үр дүн сайн байж чаддаггүй тул төрийн захиргааг шинэчлэх, үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад хувь хүмүүсийн сонголтын онцлогийг харгалзах зайлшгүй шаардлага байгааг уг онолоор тайлбарласан байна (Т.Т).

ОЛОН УЛСЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА (*International non-governmental organization*)

Олон улсын төрийн бус байгууллага (International NGOs) бол төрийн бус байгууллага (NGOs) хэмээх ойлголтын өргөтгөсөн хувилбар юм. Төрийн бус байгууллагын талаар олон янзын тодорхойлолт байх бөгөөд төр болон олон улсын төр засгийн байгууллагуудаас хараат бус, ашгийн бус байгууллага (Wikipedia), “орон нутаг, үндэсний болон олон улсын түвшинд иргэдийн сайн дурын үндсэн дээр нэгдсэн ашгийн бус байгууллага (UN NGO global network), төрөөс хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага бөгөөд ихэвчлэн нийгэм, улс төрийн асуудлуудыг шийдвэрлэхэд анхаардаг байгууллага (Oxford dictionary), ихэвчлэн ашгийн бус, шашны бус сайн дурын үндсэн дээр байгуулагдсан хувийн сектор бөгөөд боловсрол, сургалт, хүмүүнлэгийн болон “хоточ нохой” (watchdog) зэрэг үйл ажиллагаануудад хувь нэмрээ оруулах, хамтран оролцдог байгууллагыг хэлнэ (Business dictionary), нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн амьдралын чанарыг

¹ А.Цанжид, Төрийн захиргаа, 2009, х. 266.

дээшлүүлэхэд чиглэсэн өөрөө удирдах, хувийн, ашгийн төлөө бус байгууллагууд юм (Anna C.Vakil) гэх зэргээр тодорхойлсон байдаг. Ийнхүү өргөтгөсөн тохиолдолдоо ТББ нь олон улсын байгууллагуудын нэг хэлбэр онцлогтой. Олон улсын байгууллага нь дотроо даян дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг НҮБ, ОУВС гэх мэт олон улсын төр засгийн байгууллага (IGOs), төрийн бус байгууллага гэсэн хэлбэрийг олдог байна. Эдүгээ олон улсын шинжтэй 6000 орчим ТББ (Британика) үйл ажиллагаа явуулж байсан бол 1990 оноос хойш тасралтгүй өсөн нэмэгдсээр 40 мянгад (Wikipedia) хүрсэн байна. Олон улсын байгууллагууд ихэвчлэн байгаль орчин, хүний эрх, эмэгтэйчүүд болон жендэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах нь элбэг бөгөөд Монгол Улсын хувьд ч гэсэн энэ чиглэлийн ТББ статистик үзүүлэлтээр хамгийн олон байна. Монгол Улсад олон улсын, ашгийн бус зорилго чиглэлтэй байгууллагын голлох хэлбэрүүд болох салбар дундын төсөл, эрүүл мэнд, хүүхэд залуучууд, боловсрол, хүний эрх, шашин, технологийн зэрэг бүхий л байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, Олон улсын хүүхдийг ивээх сан, SOS хүүхдийн хотхон, Скаутын холбоо, Дэлхийн зөн, Эмнести интернэйшнл байгууллага, Соросын сан гэх мэт олон байгууллага үйл ажиллагаа явуулж байсан болон одоо ч үргэлжлүүлэн ажиллаж байна. (Б.П)

ОЛОН УРГАЛЧ ҮЗЭЛ (Pluralism) Олон ургалч үзэл нь өргөн утгаараа аливаа нэгэн ойлголт баримтлалыг туйлчлан үздэггүй ба нэг зүйлийн талаарх өөр өөр үзэл бодолд адил тэгш хандах зарчмыг илэрхийлсэн үзэл санаанд тулгуурлана. Үндсэн агуулгаараа нэг

ишт үзэл, нэг үзэл суртлыг шүтэх байр суурийн эсрэг чиглэсэн хандлага юм. Хүний нийгэм олон янзын үзэл бодлыг уралдуулах, өрсөлдүүлэх замаар тэдгээрээс аль оновчтой, ашигтайг нь шилэн авч хөгжих ёстой гэж энэ үзлийг баримтлагчид үздэг. Олон ургалч үзэл нь ашиг сонирхлоороо ялгаатай бөгөөд өөр хоорондоо өрсөлдөгч нийгмийн олон бүлэг үйл ажиллагаа явуулдаг, төрийн бодлого нь харилцан буулт хийх үндсэн дээр тодорхойлогддог, намуудын нэр дэвшигчдийн дундаас сонгогч сонголт хийж улс төрийн бодлогод оролцдог тийм системийн ардчилсан үнэт зүйлсийг илэрхийлэх үзэл баримтлал юм. (Я.Т)

ОМБУДСМЭН (Ombudsman)

Омбудсмэн нь гүйцэтгэх засаглал хууль дүрэм баримталж байгаа эсэх хийгээд төрийн алба, албан тушаалтантай холбоотой гомдлыг шалгах эрхтэй хууль тогтоох байгууллагаас томилогдсон хүн юм. Омбудсмэний алба нь Шведэд XIX зууны эхэн үед үүссэн бөгөөд улмаар дэлхийн бусад улс орнуудад байгуулагдаж эхэлжээ. Гэхдээ омбудсмэнтэй төстэй алба эртний Хятад, Ромын эзэнт улсын үед ч байсан ажээ. Парламентаас омбудсмэнийг томилдог ч үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцох эрхгүй. Омбудсмэн нь төр иргэн хоёрын хоорондын зөрчил, гомдлын хүрээнд бие даасан дундын зуучлагч, шалгагчийн үүргийг гүйцэтгэнэ. Тэрээр гарсан зөрчлийг арилгуулах, гомдлыг шийдвэрлүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудад тодорхой санал, зөвлөмж өгнө. Хэрэв хувь хүн, байгууллагын зүгээс омбудсмэнийн эрх мэдэл, мандатаас давсан өргөдөл, гомдол ирвэл хаана, хэнд, хэрхэн хандах талаар чиглэл өгдөг. Үндэсний

түвшинд ажиллах омбудсмэнийг хууль тогтоох хурал, орон нутаг, хоугн түвшинд ажиллах бол тухайн түвшний төрийн байгууллагаас томилдог. Омбудсмэн нь зөвхөн төрийн байгууллагад ажилладаггүй, хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд ч омбудсмэнтэй байдаг. Хувийн хэвшлийн омбудсмэн нь санхүү болон хэрэглэгчийн эрхтэй холбоотой гомдлыг хариуцдаг. Омбудсмэнд гомдол, хэрэг ирснээр тухайн хэргийг мөрдөн шалгах бөгөөд зарим тохиолдолд хугацаа их шаардагдана. Хэрэв гомдлыг шалгаад үндэслэлтэй гэж үзвэл байгууллагад асуудлыг шийдэхийн тулд юу хийх ёстойг санал болгоно. Омбудсмэн нь зөрчил гаргасан албан тушаалтан, байгууллагын зөвлөмжийг нь дагаж мөрдөхийг албадаж чаддаггүй боловч тэд ихэнхдээ дагадаг. Хэрэв гомдол гаргагчдад омбудсмэний шийдвэр таалагдахгүй бол шүүхэд хандаж болно. Гэхдээ шүүх ихэнх тохиолдолд омбудсмэний шийдвэрийг дагах хандлагатай байдаг. (Ж.Ж)

ОНЦ БАЙДАЛ (*State of emergency*)

Улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт онцгой нөхцөл бий болсон үед энэхүү нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор иргэдийн эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж, тэдэнд нэмэгдэл үүрэг хариуцуулан төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар тогтоосон эрх зүйн онцгой дэглэмийг *онц байдал* гэнэ. Онц байдлын үед авах арга хэмжээ нь иргэдийн аюулгүй байдлыг хангах, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах үүднээс буй болсон нөхцөл байдлыг даруй хэвийн болгох, хууль ёс, дэг журмыг тогтоох, иргэдийн

аюулгүй байдалд учирсан аюул, ослыг арилгах, тэдэнд шаардлагатай тусламж үзүүлэхэд чиглэгдэнэ. Нөхцөл байдал хэвийн болонгуут онц байдлыг цуцална. Монгол Улсын Үндсэн хуульд заасан ёсоор дор дурдсан онцгой нөхцөл бий болсон үед онц байдал зарлаж болно.

- Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц гамшиг, гамшгийн бусад аюул тохиолдсон;
- Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон (Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэг).

Онц байдал үргэлжлэх хугацааг Улсын Их Хурал тогтооно. Онц байдал зарлахад хүргэсэн нөхцөл бүрэн арилагүй тохиолдолд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал онц байдлын үргэлжлэх хугацааг сунгаж болно. Онц байдал тогтооход хүргэсэн онцгой нөхцөл бүрэн арилсан тохиолдолд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал онц байдлыг хугацаанаас нь өмнө цуцална. Онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах онцгой чиг үүргийг Монгол Улсын Үндэсний

аюулгүй байдлын зөвлөл эрхлэн гүйцэтгэнэ. Онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх талаарх Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засаг дарга, бүрэн эрхт төлөөлөгчийн онцгой бүрэн эрхийг хуулиар тогтоосон. (Ч.Э)

ОРЛОГО (Revenue) Бараа бүтээгдэхүүн борлуулах, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулалтын өгөөж хүртэхэд бий болсон эдийн засгийн өгөөжийн дотогшлох урсгал буюу өмчийн өсөлт юм. Орлого нь ихэвчлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн хэлбэрээр байгууллага, өрх гэрт орж нягтлан бодох бүртгэлд тусгагддаг. Мөнгөн хэлбэрээс гадна бусад бараа, ажил, үйлчилгээ, хөрөнгийн солилцоогоор үнэлэгдэх орлого ч байна. Мөн төрөөс орлого хуваарилалтад оролцдог ба хувь хүн, байгууллага иргэдээс бүрдүүлсэн татварын орлогод дахин хуваарилалт хийж халамж шаардлагатай хүн амын бүлэгт тэтгэвэр, тэтгэмжийн орлого хэлбэрээр хуваарилдаг. Орлогыг бодит ба нэрлэсэн орлого гэж эдийн засгийн утгаар ангилна. Нэрлэсэн орлого өссөн ч инфляц түүнээс илүү хурдтай өссөн бол иргэдийн бодит орлого буурах ба иргэдийнхээ бодит орлогыг өсгөх нь төрийн бодлогын гол зорилт байдаг. (Б.Б)

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН (Income statement) Эдийн засгийн нэгж (байгууллага, салбар, засгийн газар)-ийн тайлангийн хугацааны үйл ажиллагааны үр дүнг санхүүгийн хэлээр илэрхийлдэг тайлан. Орлого/үр дүнгийн тайлангаас санхүүгийн тайлангийн хугацааны үндсэн ба үндсэн бус үйл ажиллагааны орлого, зардал, орлого, зардлын зөрүүгээр тодорхойлогдох ашиг буюу үр дүнгийн мэдээллийг авч болно. Төрийн

үйлчилгээ үзүүлэх байгууллагын эдийн засгийн зорилго нь ашигт төвлөрдөггүй учир орлого, зардлын зөрүүг “үр дүн” гэж тодорхойлон санхүүгийн тайланд тусгадаг. Харин төрийн өмчийн компаниудын хувьд санхүүгийн үр дүн, ашгийн үзүүлэлт нь төрийн өмч, хөрөнгийн өгөөжийг илэрхийлэх гол үзүүлэлт болно. (Б.Б)

ОРЛОГЫН ТАТВАР (Income tax) Хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагын жилийн орлогод хувь тооцож тогтоосон татвар бөгөөд улсын төсвийг бүрдүүлэх, эдийн засгийн болон бусад зохицуулалтын зорилгоор татварын хувь хэмжээг тогтоодог. Орлогын албан татвар тогтоох анхдагч зорилго нь төсвийн орлогыг бүрдүүлэх бөгөөд татвараар бүрдүүлсэн орлогоор батлан хамгаалах, хууль сахиулах, анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, суурь боловсрол зэрэг төрөөс иргэдэд үзүүлэх нийтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүжүүлдэг. Түүнчлэн орлогын албан татвар нь төрөөс эдийн засгийн ба нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл болдог. Орлогын албан татварыг бууруулах нь бизнес эрхлэгчдийг урамшуулах хөшүүрэг болдог. Өөрөөр хэлбэл, татварын хэмнэлтээр бий болсон эх үүсвэрээр үйлдвэрлэлээ өсгөх, эдийн засагт оруулах хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхийг урамшуулдаг. Мөн орлогын албан татварыг тодорхой үйл ажиллагааг дэмжих хэрэгсэл болгон ашиглаж болно. Тухайлбал, боловсрол, эрүүл мэндийн салбарт оруулсан хөрөнгө, буяны үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийг орлогын албан татвараас чөлөөлөх зэргээр нийгэм, хүмүүнлэгийн салбарын хөгжлийг татварын бодлогоор дэмжиж болно.² (Б.Б)

² David Schultz: Encyclopedia of Public Administration and Public Policy, USA 2004, p. 226.

ОРЛОГЫН ҮР НӨЛӨӨ (*Income effect*)

Хэрэглэгч, худалдан авагчдын бодит орлогоос үүдэлтэй худалдан авах чадварын өсөлт, бууралтын нөлөөгөөр аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтэд гарч байгаа өөрчлөлтийг орлогын үр нөлөө гэдэг. Орлогын үр нөлөөнөөс үүдэн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд гарах өөрчлөлтийг тооцоолон төрөөс хэрэгжүүлэх мөнгөний бодлого болон бусад бодлогын шийдвэрт харгалзана. Эдийн засагт үзүүлэх орлогын ба орлуулалтын үр нөлөөг тодорхойлж бодлогын шийдвэрт харгалзахын тулд хэрэглэгчийн зан төлөвийг мөн судлах шаардлагатай ба эдгээр судалгааны үр дүнг төрөөс хэрэгжүүлэх хөдөлмөр-халамжийн бодлого, татварын хяналтын бодлого тодорхойлоход ашигладаг. (Б.Б)

ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ (*Income transfer/transfer payment*)

Ямар нэг бүтээгдэхүүн, үйлчилгээний солилцоо, арилжаа, баялаг бүтээх үйл явцтай хамааралгүйгээр төрөөс орлого ба баялгийн дахин хуваарилалт хийх үйл явц. Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор дээд шатны төсвийн орлогоос доод шатны төсөвт тооцож шилжүүлэх хөрөнгийг орлогын шилжүүлэг гэж тодорхойлдог. Мөн бусад урсгал шилжүүлэгт бүх төрлийн тэтгэвэр тэтгэмж, төрөөс болон ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал, нэг удаагийн бусад тэтгэмж, шагнал урамшуулал багтана. (Б.Б)

ОРОЛЦОГЧ ТАЛУУД (*Stakeholders*)

"Stakeholder" нь "stake+hold" гэх хоёр үгнээс бүтсэн бөгөөд 1708 онд "бооцоо тавих үед бооцоогоо байршуулдаг", 1965 онд "алдах юмтай хүн", "сонирхдог зүйлтэй

нэгэн" гэх утгатай байсан. Монгол хэлнээ "stakeholder" гэдгийг оролцогч талууд хэмээн орчуулан хэрэглэдэг. Оролцогч талууд гэдэгт "бодлогын шийдвэр гаргахад оролцож байгаа болон түүний үр дүн нь тусах хүмүүс, эсвэл сонирхлын бүлгүүд"³-ийг хамааруулж ойлгоно. Тухайлбал, бодлого боловсруулж, шийдвэр гаргах үйл явцад янз бүрийн сонирхлын бүлгүүд (төрийн байгууллага, албан тушаалтан, иргэд, иргэний нийгмийн байгууллага, бодлогын зөвлөхүүд, төрийн бус байгууллага, улс төрийн намууд, нийгмийн бүлгүүд, иргэдийн бүлэг гэх мэт) оролцох бөгөөд эдгээр бүлэг, хувь хүмүүс нь бодлого, шийдвэрийн үр дүнг шууд болон шууд бусаар сонирхож байдаг. Төрийн бодлогын хувьд оролцогч талуудыг тодорхойлохдоо бодлого санаачлагч, бодлого боловсруулагч, бодлогыг хэрэгжүүлэгч, бодлогыг үнэлэгч, бодлогын үр дүнг хүртэгч нарын оролцоог хангах нь чухал. (Т.Т)

ОРОЛЦОО (*Participation*)

Аливаа асуудлын сониргогч талуудын санаа бодлыг сонсож, шийдвэр гаргах үйл явцад оролцуулах үйл явц юм. Иргэдийн идэвхтэй оролцоо нь ардчилал, нээлттэй нийгмийн гол баталгаа болдог. Олон түмний эрх ашгийг хөндсөн асуудлаар иргэд хамтын шийдвэр гаргах, сайн дураараа, албан бусаар үйлдэл хийж төрийн бодлого шийдвэрт нөлөөлөхийг оролдох, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих үйл явцыг иргэдийн оролцоо гэдэг. Иргэний оролцоог идэвхтэй, хариу үйлдэлтэй, идэвхгүй гэж ангилдаг ба хөндөж байгаа асуудлаас хамаарч улс төрийн, эдийн засгийн, нийгэм, соёлын оролцоо гэж ангилж болно. (Б.Б)

3 Даваадулам (2010) Засаглал үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг.

ОРОЛЦООГ ОГООРОХ ҮЗЭЛ (*Absenteeism*) Оролцоо гэдэг ойлголтын утгыг латин хэлний “*absentia*” байхгүй, эзгүй, оролцохгүй байх гэсэн утгатай үгтэй холбон тайлбарладаг. 1800-аад оны үеэс орчин үеийн утгаараа “сонгуулийн үл оролцоо” гэсэн утгыг илэрхийлдэг. Сонгуулийн эрх бүхий сонгогчдоос сонгуульд сайн дураараа оролцохгүй байх үзэгдлийг нэрлэдэг нэр томьёо юм. Энэ нь ардчилсан орнуудын хувьд сонгуулийн бичигдээгүй оролцооны нэг хэлбэр юм. Улс төрчид сонгуульд оролцохгүй сонгогчдын тодорхой хувийг тооцож сонгуулийн үйл явцад урьдчилан төлөвлөлт хийдэг. Мөн судлаач, мэргэжилтнүүд ч сонгуулийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, сонгогчдын аль хэсэг бүлэг сонгуульд оролцохгүй байх талаар ойролцоогоор урьдчилсан таамаглал дэвшүүлдэг. Сонгогчид сонгуульд оролцохгүй байх нь олон шалтгаантай боловч оролцоогүй хувь тодорхой хэмжээнээс хэтрээгүй тохиолдолд сонгуулийн үйл ажиллагаанд нөлөөлдөггүй гэж үздэг. (Я.Т)

ОРОЛЦООТ ЗАСАГЛАЛ (*Participatory governance*) Улс орныг удирдах, төрийн бодлогыг оновчтой тодорхойлж үр дүнтэй хэрэгжүүлэхэд иргэдийг оролцуулан нийгмийн бүхий л бүлгийн тэгш оролцоог хангах арга хэрэгслийг ашиглан гүйцэддүүлэхийг оролцоот засаглал гэнэ. Засаглал дахь иргэдийн оролцооны нэг хэлбэр болох улс төрийн сонгуулиас гадна иргэдийн оролцоот төсөвлөлт, хяналтыг хэрэгжүүлэх, нийтийн сонголт, нийтийн санал асуулга зэрэг аргыг хэрэглэж оролцоот засаглалыг хэрэгжүүлдэг. (Б.Б)

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР (*Locally owned enterprise*) Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулан тухайн орон нутгийн түвшинд төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч субьектэд шилжүүлэн өгсөн үйлдвэрлэл, ажил үйлчилгээ эрхэлдэг цогцолборыг хэлнэ. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн эрхийн байдлаар “өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд орох эрхтэй”, эсвэл “төсвийн хөрөнгөөр санхүүжиж орон нутгийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг” онцлог шинж чанартай. (Г.Б)

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН (*Local development fund*) Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангасны үндсэн дээр иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин бүрдүүлэхэд оршдог. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангуудын эх үүсвэрийн бүрдэлтийг дахин хянан үзэж, эдгээр сангуудыг орон нутгийн төсвийн алдагдлыг арилгах, төсвийн орлогын баазыг өргөтгөх нэг гол хэрэгсэл болгон ашиглах боломжтой. Монгол Улсын Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн индекс; хүн амын

тоо; хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ; орон нутгийн татварын идэвх санаачилга гэсэн итгэлцүүрийг харгалзан хуваарилна. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутагт хуваарилахдаа ашигт малтмалын олборлолт хийгдсэн тухайн орон нутгийн нэг хүнд ногдох хэмжээг бусад орон нутгийн нэг хүнд ногдох хэмжээнээс 10 хүртэл хувиар нэмэгдүүлэн тогтооно. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлалыг Засгийн газар батална. (А.Э)

ОРЦ (*Input*) Аливаа эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаанд ашиглагдах нөөцийн зарцуулалтыг системийн хандлагаар тайлбарлахдаа “орц” гэсэн ерөнхий нэршлийг ашигладаг. Орцыг мөн үйлдвэрлэлийн хүчин зүйлс гэж нэрлэх ба эдийн засгийн үйл ажиллагааны үр дүнг нь гарц гэж нэрлэнэ. Төрөөс эдийн засгийн системийг жигд хөгжүүлэхийн тулд салбар хоорондын холбоо, хэлхээг орц-гарцын загвараар шинжилдэг ба эдийн засгийн бодит ба бодит бус сектороос гадна үйлдвэрлэлийн хаягдал ба түүний дахин ашиглалт зэрэг хүчин зүйлсийг ч орц-гарцын загварт оруулж тооцон шинжилгээний үр дүнг төрийн бодлогод харгалздаг болсон. (Б.Б)

ОТОГ (*Otog- historical administrative unit*) Отог нь эрт үеэс уламжлагдан ирсэн засаг захиргааны нэгж юм. Богд хаант Монгол Улсын үед ихэвчлэн Богд болон хутагт хувилгаадын шавь нарыг отгоор зохион байгуулж байжээ. Нийт 43 отог байснаас Богдын шавь нарын 30 отог байжээ. (А.Ц)

ОЮУН ТҮЛХҮҮР (*Oyun tulkhuur- The key to the mind*) Монголчуудын дунд ихэд дэлгэрсэн сургаалын цоморлиг. XIII зууны үеэс олон янзын хувилбартайгаар бичгээр уламжлан иржээ. Түүний зарим хувилбар нь “Эртний Богд Чингисийн зохиосон шастирыг өчүүхэн сануулахын учир” хэмээн эхэлдэг. Ц.Дамдинсүрэн “Энэ зохиол ... хувьсгалаас урьдах үеийн Монголд түшмэл бичээч нарыг хүмүүжүүлэх сургаал болгож байжээ. Олон бичээч нарын гарыг дамжин хуулагдсаар ирсэн тулд үүнд завсрын үеийн нөлөө, тухайлбал, шарын шашны нөлөө баахан халдсан байна” гэжээ. Ш.Чоймаа “уг зохиолын агуулгыг нягтлан үзвээс XIII зууны үеийн монголчуудын төр ёсны зохиолын дурсгал бичиг, Их засаг хэмээх хууль зүйн бичиг болон эзэн Чингисийн зарлиг сургаал буюу Чингисийн билиг зэрэг зохиолын гол санааг уламжлан авч улмаар XIV зууны үеэс монгол утга зохиолд нэвтэрч ирсэн Рашааны дусал, Субашид зэрэг хос ёсны сургаалын нөлөө тусгалаар баяжиж ирсэн байдал ажиглагддаг хэмээн тэмдэглэжээ. “Оюун түлхүүр”-т буй төрийн ёс, түшмэл хүний баримталбал зохих хэм хэмжээ, төрд ажиллуулах хүнийг сонгох шалгаруулах зэрэг төрийн үйл ажиллагаатай сургаалууд нь өнөө ч ач холбогдолтой хэвээр байгаа нь Монголын төрт ёсны чухал зарчмууд юм. (А.Ц)

ОЮУН УХААН (*Intellect*)⁴ Хүний сэтгэл бодол болоод ухаан ухамсрын цогц мэдрэмж буюу аливаа зүйлийн утга учир, зорилго, оршин буйг ухааран буй ухамсар нь өөрөө оюун ухаан юм. Бидний бие яс, мах, булчин, шөрмөс, цус илдэс, амин хүчил гэх

4 한호섭 (1999). 행정학 용어 사전. 서울, 행정학용어표준화연구회. 새 정보 미디어

мэт зүйлсээс бүтсэн бол оюун ухаан нь хайр, нинжин сэтгэл, баяр хөөр, урам зориг, эрч хүч. Бодгалийн таних, мэдэх, хийх аливаа үйл ажиллагааны цогц, явцуу утгаараа сэтгэхүйн нэгэн орчил гэж тодорхойлж болно⁵. Орчин үеийн техник технологийн дэвшилтэт хөгжил, амжилтын үр дүнд хүн төрөлхтөн хиймэл оюун ухааныг бүтээн, төр, нийгмийн бүхий л салбарт өргөнөөр ашиглаж байна. Ялангуяа төрийн салбарт төрийн үйлчилгээг хүргэх, түүний хүртээмжийг нэмэгдүүлэхэд энэхүү технологийн шийдлийг ашиглаж байна (Энэ талаар хиймэл оюун ухаан хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү). (Ц.Д)

ОЮУНЫ УРСГАЛ (*Brain drain*) Хүн амьдралын хэрэгцээ шаардлага, өөрийн хүсэл сонирхол, амьдрах арга болон амьдралын хэв маяг зэргээс хамааран нийгмийн янз бүрийн харилцаа, хөдөлгөөнд оролцож байдаг. Түүний нэг нь шилжих хөдөлгөөн (migration) юм. Шилжих хөдөлгөөний нэгэн илрэл бол энэхүү оюуны урсгал (brain drain) бөгөөд түүний эсрэг үзэгдэл нь оюуны олз (brain gain). Оюуны урсгал хэмээх нь боловсролтой, өндөр ур чадвар бүхий хүмүүс амьдралын чанар сайн, хөдөлмөрийн үнэлгээ буюу өндөр цалинтай өөр улс оронд, тэр дундаа гуравдагч ертөнцийн орнуудад олноороо ажиллаж амьдрахаар эх орноосоо явж буй үзэгдэл юм. Оюуны урсгал нь гадаад шилжих хөдөлгөөний үзэгдэлтэй шууд хамааралтай бөгөөд энэ гадаад улс орнуудад ажиллаж амьдарч буй нийт ажилтнуудын хувьд бус харин өндөр ур чадвар бүхий ажилчдын шилжилтийг илэрхийлдэг ажээ. Товчоор: өндөр ур чадвар бүхий (high skill person) авьяаслаг

мэргэжилтнүүдийн гадагшаа чиглэсэн шилжих хөдөлгөөн, дайжилтыг оюуны урсгал хэмээн нэрлэдэг. Иймд оюуны урсгал нь хүмүүн капитал буюу боловсрол, ур чадвар, ажлын туршлагыг өндрөөр үнэлэх, нөгөө талаар ажил мэргэжлийн сүлжээ, харилцаа холбооны өгөөж, мэдээлэл солилцох боломж зэрэг нийгмийн баялгаас хамаарч өрнөдөг үзэгдэл. Энэ нь хүлээн авагч орны зүгээс хэрэгжүүлж буй авьяасын төвлөрөл бүхий төрийн бодлого, менежментээс үндсэндээ хамаарна. Оюуны урсгал явагдах олон шалтгаан байх бөгөөд улс төрийн хувьсгал, улс орны дотоод дахь үймээн самуун болон иргэний дайн, эдийн засгийн хямрал, үзэл суртал зэргээс нийтлэг шалтгаалж байсан бол эдүгээ тухайн улс орны энтрепренершип нийгэм-соёлын таатай байдал, сайн засаглал, нийгмийн болон хүмүүн капитал, эдийн засгийн боломж нөхцөл зэргээс хамаарч байна. Оюуны урсгалын шинэ загварын хувьд “хүчтэй тархи”-ийг оюуны хувьд нь олзлох, тогтоон барих төдийгүй, тэдгээрийг улам хүчтэй болгохын тулд “тархины холбоос” (brain linkages) хийх нь илүү чухал хэмээн үзэж байна. Энэ утгаараа шилжих хөдөлгөөн бол нийгэм-эдийн засгийн болон хүн ам зүйн хөгжлийн нөөц мөн болно. (Б.П)

5 Д.Ванчигүрэн, Б.Энхтүвшин. Боловсрол судлалын ухагдахууны товч тайлбар толь, 1994, Улаанбаатар. х. 37.



ӨГЛӨГ, ӨР ТӨЛБӨР (*Payable/liabilities*)

Эдийн засгийн харилцаанд оролцогчид (хувь хүн, байгууллага, Засгийн газар)-ын бусдын өмнө хүлээсэн санхүүгийн хариуцлага буюу өнгөрсөн хугацааны үйл ажиллагааны үр дүнд бий болсон, бусдад хөрөнгө шилжүүлэх, үйлчилгээ үзүүлэх хариуцлага юм. Өглөг, өр төлбөрийг барагдуулах хугацаанаас хамаарч богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөр гэж ангилан нягтлан бодох бүртгэлд тусгадаг. Мөн төлөгдөх шинж байдлаар нь тодорхой өр төлбөр, тооцоолсон өр төлбөр, болзошгүй өр төлбөр гэж ангилна. Засгийн газар төсвийн алдагдлыг нөхөх, шаардлагатай хөрөнгө оруулалтын төслийг санхүүжүүлэх, нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлэх зэрэг зорилгоор өр үүсгэдэг бөгөөд урт хугацаанд Засгийн газрын өр нь эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлдэг. (Б.Б)

ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЭЦ (*Data infrastructure*)

Үнэ цэнэтэй өгөгдлийн цуглуулга, цуглуулсан өгөгдлийг арчлах болон ашиглах зааварчилгааг хариуцсан газрыг хамруулсан дэд бүтэц. Технологийн хурдацтай хөгжил, түүний хэрэглээ нь өгөгдлийг шинэ арга замаар цуглуулж,

боловсруулахад тусалж, хэмжээ нь тасралтгүй нэмэгдэж байна. Эрүүл мэнд, боловсрол, банк санхүүгийн салбарт шинэ өгөгдлийн дэд бүтэц үүссэн. Эдгээр салбарын өгөгдлийн дэд бүтцийг хожим нь хоорондоо холбогдон өгөгдөл солилцдог байхаар хэрхэн загварчлах талаар ухаалаг шийдэл гаргах нь чухал. (Д.З; Ч.Л нар)

ӨГӨГДЛИЙН САН (*Database*)

Өгөгдлийн сан нь зохион байгуулалттайгаар хадгалсан өгөгдлийн цуглуулга. Өгөгдлийн санд хандах, засварлах болон нэмэхэд хялбар байдлаар зохион байгуулдаг. Хэр оновчтой зохион байгуулахаас өгөгдлийн сантай ажиллах хурд хамаардаг. Өгөгдлийн сантай харьцаж өгөгдөл хайх, шинжлэх болон өгөгдлийн санг зохион байгуулах, удирдах үндсэн үүргийг гүйцэтгэдэг программ хангамжийг өгөгдлийн сангийн удирдлагын систем (database management system - DBMS) гэдэг. (Д.З; Ч.Л нар)

ӨГӨГДЛИЙН УДИРДЛАГА (*Data management*)

Өгөгдлийн үнэ цэнэ, мэдээллийн өгөөжийг нэмэгдүүлэх, хадгалах, цуглуулах системийн төлөвлөх, хөгжүүлэх, хэрэгжүүлэх, удирдах үйл явц. Үүнд өгөгдлийн чанар, нарийвчлал, хүртээмж,

нууцлал, нийцэл зэрэг асуудлыг шийдвэрлэх бас багтдаг. Өгөгдлөөс мэдээлэл, мэдлэгийг бүтээдэг учраас өгөгдлийн удирдлага нь мэдээллийн удирдлага, мэдлэгийн удирдлага гэж орлуулан хэрэглэх болсон. (Д.3; Ч.Л нар)

ӨГӨГДЛИЙН ЧАНАР (*Data quality*)

Үнэн зөв, бүрэн бүтэн, найдвартай байдал, тогтмол шинэчлэгддэг эсэх зэрэг хүчин зүйлүүдэд үндэслэсэн өгөгдлийн төлөв байдлын хэмжүүр. Өгөгдлийн чанар нь оновчтой шийдвэр гаргах, зөв төлөвлөх зорилгод нийцсэн байх шаардлагатай. Стандартчиллын олон улсын байгууллагаас 2004 онд өгөгдлийн чанарын стандарт ISO8000 -г баталсан. (Д.3; Ч.Л нар)

ӨГӨГДЛИЙН ШИНЖИЛГЭЭ (*Data analysis*)

Хэрэгцээт мэдээллийг олох, дүгнэх, шийдвэр гаргахад дэмжих зорилгоор өгөгдлийг магадлах, цэвэрлэх, хувиргах, шинжлэх болон загварчлах үйл явц. Өгөгдлийн шинжилгээ нь бизнес, шинжлэх ухаан болон нийгмийн ухааны салбар зэрэг ялгаатай салбарт янз бүрийн нэршилтэйгээр ялгамжтай арга техник, аргачлалтай хэрэглэгддэг. Орчин үед төр болон хувийн хэвшлийн байгууллагуудад шинжлэх ухаанч шийдвэр гаргах болон үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгоход өгөгдлийн шинжилгээ чухал үүрэг гүйцэтгэх болжээ. (Д.3; Ч.Л нар)

ӨГӨГДӨЛ (*Data*) Аливаа үйл явдал, баримтыг илэрхийлсэн, тодорхой бүтэцтэй бичвэр эсвэл тоон утгын цуглуулга. Өөрөөр боловсруулах шаардлагатай зохион байгуулаагүй баримт буюу түүхий эд юм. Өгөгдлийг утгыг ялгах, агуулгыг гарган авах зорилгоор шинжлэх, бусад өгөгдөлтэй боломжит байдлаар

хослуулсан хэрэглэснээр мэдээлэл болдог. Мэдээллийг бусдаас түрүүлж олж авсан байгууллагад давуу тал үүсдэг байсан бол өдгөө өгөгдөлтэй байх нь чухал болсон. Өгөгдлөө өөрөө боловсруулж бусдаас түрүүлж өөрт хэрэгтэй мэдээлэлтэй болох боломжийг бүрдүүлдэг. Тэр ч утгаараа өгөгдөл бол шинэ зууны түүхий эд юм. Өгөгдлийн боловсрол (*data literacy*)-ын үнэ цэнэ нэмэгдэж өгөгдлийн шинжээч (*data analyst*), өгөгдлийн инженер (*data engineer*), өгөгдлийн судлаач (*data scientist*) хамгийн эрэлттэй мэргэжлийн жагсаалтыг тэргүүлж байна. (Д.3; Ч.Л нар)

ӨГӨГДӨЛД ТУЛГУУРЛАСАН УДИРДЛАГА (*Data-driven management*)

Үйлчилгээний чанарыг сайжруулах, гол үр дүнд хүрэхийн тулд өгөгдлийг байнгын хэрэглээ болгох стратеги. Орчин үеийн бизнес шинжилгээний хэрэгслүүд нь хялбарчилж байгууллагын удирдлага мэдээллийн технологийн хэлтсийн тусламжгүйгээр хянах самбарт ямар мэдээллийг ямар төрлөөр харахаа тохируулахад л хангалттай болсон. Ингэснээр байгууллагын гүйцэтгэх удирдлага технологиор мэргэшээгүй байсан ч өгөгдлийн шинжилгээний хэрэгслүүдтэй ажиллаж өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргах бололцоотой болсон. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага нь өгөгдөлд тулгуурласан удирдлагыг хэрэгжүүлснээр байгууллагын өрсөлдөх чадвар дээшилж, бүтээмж болон ашигтай ажиллагаа сайжирдаг. (Д.3; Ч.Л нар)

ӨГӨГДӨЛД ТУЛГУУРЛАСАН ШИЙДВЭР (*Data-driven decision*)

Аливаа шийдвэрийг өгөгдлийн шинжилгээнд суурилан гаргах үйл явц. Өгөгдөлд тулгуурласан шийдвэр

бодит байдалд нийцэх шалгуурыг хамгийн сайн хангаж чаддаг. Иймд шийдвэр гаргах ажиллагаанд хангалттай өгөгдөл цуглуулах, түүнд тохирох аргачлалаар шинжилгээхийх, гарсан үр дүнг нь үндэслэн шийдвэр гарах дарааллыг баримталдаг. Өгөгдөлд нь тулгуурласан шийдвэр нь үйл ажиллагаагаа оновчтой болгох, борлуулалтаа нэмэгдүүлэх, ирээдүйн чиг хандлагаа таамаглах, хэрэгжихүйц шинэ санаа гаргах, шинэ боломж үүсгэх бололцоог байгууллагад олгодгоороо тасралтгүй, тууштай өсөлтийг үүсгэдгээрээ чухал юм. (Д.З; Ч.Л нар)

ӨМНӨХ ҮЕ (*Previous generation*)

Нийгмийн шинжлэх ухааны хөгжилд М.Вебер, В.Вильсон, Ф.Гуднау зэрэг эрдэмтдийн үзэл санаа нь өрнөдийн орнуудад төрийн захиргааны онолын хөгжилд даацтай хувь нэмэр оруулсан тул энэ шинжлэх ухаанд тэднийг “өмнөх үеийнхэн” гэж үздэг. Эдгээр эрдэмтдийн бүтээлд төрийн захиргааны шинжлэх ухааны үндсэн хоёр агуулга болох удирдлагыг өөрчлөх, шинэчлэхийн тулд түүнийг сайн ойлгох хэрэгтэй бөгөөд үүний тулд шинжлэх ухааны үүднээс судлах, мөн төрийн захиргааны удирдлага улс төрөөс ангид байх ёстой гэсэн санаа оршдог. Үеийн онолыг Уильям Страусс, Нил Хоу нар боловсруулсан. 1991 онд тэдний хамтарсан “Үе үеийнхэн” ном хэвлэгдэн гарсны дараа энэ онолын тухай ярьж эхэлсэн юм. 1980-аад оны сүүлчээр АНУ-ын түүхийг үе үеийн дараалал гэж үзээд Үеийнхэн дээр ажиллаж эхэлснээс хойш хамтран 1997 онд “Дөрөв дэх эргэлт” номондоо зохиогчид онолын тухай болон АНУ-ын түүхэн дэх дөрвөн хэсгээс бүрдэх мөчлөг, зан үйлийн хэв маягийн талаар бичжээ. Үеийн онол

нь АНУ-ын түүхийг тодорхойлдог бол Страусс, Хау нар мөн бусад орны үе үеийн чиг хандлагыг судалж, зарим хөгжингүй орнуудаас ижил төстэй мөчлөгүүдийг олж тогтоосон. Өнгөрсөн ба өнөө үеийнхний хооронд түүхэн ижил төстэй, мөн үе үеийн зан үйлийн давтагдашгүй хэв маягийг судлаачид олж илрүүлсэн бөгөөд тус бүр нь тодорхой хамтын дүр төрхтэй, эрин үеийн өөр төрлийн харгалзах мөчлөгтэй, өөр өөрийн гэсэн сэтгэл хөдлөлтэй гэж онолын үндэс суурийг гаргасан байдаг. (А.Э.ц)

ӨМЧ (*Property*) Аливаа субъектийн мэдэлд байх, ашиглах, эзэмших, захиран зарцуулах боломжтой биет ба биет бус хэлбэртэй, үнэ цэнэ бүхий зүйлийг хэлнэ. Өмчийг өмчлөх эрхийн байдлаар нь хувийн, нийтийн, хамтын гэж ерөнхийд нь ангилна.¹ Нийтийн өмч нь төрийн өмч, төрийн бус байгууллагын өмч, шашны байгууллагын өмч зэрэг хэлбэртэй байх бөгөөд төр өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална. Өмч эзэмших эрх нь НҮБ-ийн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 17-р зүйлд баталгаажсан. Тунхаглалд: хүн бүр эд хөрөнгийг ганцаараа буюу бусадтай хамтран өмчлөх эрхтэй бөгөөд хэний ч өмч хөрөнгийг дураар хураан авч болохгүй гэж заасан нь чөлөөт нийгэмд хувийн өмчтэй байх, өмч чөлөөтэй олж авах, худалдах, өмчөө чөлөөтэй ашиглах боломжоор хангадаг болохыг нотолж байна. (Б.Б)

ӨНЧИДИЙН АВЛИГА БУЮУ САН

(*Orphan funds*) Чингис хаан дайн тулалдаанд амь эрсэдсэн цэрэг эрсийн ар гэрт тусламж дэмжлэг үзүүлдэг

¹ Gregory, Paul R.; Stuart, Robert C. (2003). Comparing Economic Systems in the Twenty-First Century. Boston: Houghton Mifflin. p. 27.

байсныг өнчидийн авлига хэмээн нэрлэж байжээ. Түүнээс хойш баяр ёслол, хаан өргөмжлөгдөх зэрэг тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан настангуудад бэлэг өгдөг ёс шинээр тогтсон байна. Монголын нууц товчоонд: Өгэдэй хаан зуун хониноос нэг хонийг үгээгүй ядууст өгч байх зарлиг буулгажээ. Хожим Богд хаан ширээнд заларсны дараа настай хүмүүст мөнгө, таяг бэлэглэж байжээ. (А.Ц)

ӨӨРТӨӨ ЗАСАХ ЭРХ (*Autonomy*)

Өөртөө засах эрх гэдэг нь хэн нэгний амьдралыг өөрийнх нь жинхэнэ хүсэл, үнэт зүйл, шалтгааны дагуу удирдах эсвэл өөрийгөө удирдах нөхцөл байдал юм. Грек хэлний *autos* буюу өөрөө, *nomos* буюу хууль удирдах гэсэн үгнээс үүсэлтэй. Үзэл баримтлалын онолын суурийг И.Кант болон Ж.С.Милль нар XVIII, XIX зууны үед тавьсан. Кант: хувь хүн, түүний сонголт, үйлдэл нь гадны хүчин зүйлсийн нөлөөгүй эсвэл өөрт нь ач холбогдол багатай үедээ бие даасан хараат бус байна. Орчин үеийн ардчилсан улсуудын хувьд төрийн байгууллагууд нь өргөн хүрээтэй асуудлыг хариуцдаг бөгөөд тэр бүрийг сонгогдсон улс төрчид, хууль тогтоох, гүйцэтгэх засаглалаас хянах боломжгүй учир тодорхой хэмжээний өөртөө засах эрхийг өгдөг. Төрийн захиргааны байгууллагууд өөртөө засах эрхгүй үед улс төрчид жижиг асуудлыг ч үлдээлгүй удирдах эрсдэлтэй нөхцөл рүү орно. Захиргааны өөртөө засах хэт их эрх нь ардчилсан сонголт, иргэд, улс төрчдийн өмнө үүрэг хариуцлага хүлээдэггүй, хариу үзүүлдэггүй төрийн байгууллагуудтай болох аюултай. Өөртөө засах эрх нь төрийн захиргааны ухааны нэг гол үзэл баримтлалын нэг бөгөөд иргэн, улс төрч, төрийн албан хаагч

гурвын харилцааны асуудал дээр төвлөрдөг. П.Кларк, Ж.Вилсон нарын үзлээр өөртөө засах эрх нь төрийн байгууллагуудын хувьд “амьд үлдэх”-д шаардлагатай нөөцийн төлөөх тэмцэл юм. Нөөц нь хязгаарлагдмал тул өөртөө засах эрхийг олж авах нь хамгийн чухал. Учир нь өөртөө засах эрхтэй болсноор нөөцийн төлөөх өрсөлдөөнд илүү тайван, итгэлтэй оролцох нөхцөл бүрддэг байна.² Өөртөө засах эрх илүү өргөн агуулгаар аль нэгэн төр улс, ихэнх тохиолдолд холбооны бүгд найрамдах хийгээд олон үндэстэн угсаатантай, тэдгээр нь тодорхой нутаг оронд бөөнөөрөө нягт оршин суудаг харьяат хүн ард, эсвэл холбооны бүгд найрамдах улсын бүрэлдэхүүнд орсон субъектэд үндсэн хуулийн хүрээнд олгосон өөрийгөө бие дааж засаглан удирдах эрх юм. Өөрөө засах эрхтэй субъект нь нэлээд тохиолдолд өөрийн үндсэн хуультай, төрийн захиргааны байгууллагуудтай байдаг бөгөөд эдийн засаг, аж ахуйн хөгжил нь холбооны төр засгийн нэгдмэл бодлого, төлөвлөгөөгөөр хэрэгжинэ. 2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд нутгийн удирдлагын эрх болон хотын статусын асуудлыг тодорхой шийдэж өгснөөр төрийн үйлчилгээ иргэдэд ойртон, эдийн засгийн хувьд бие даан хөгжих үндэс суурь тавигдсан. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарим нэгэн чиг үүргүүд шилжсэнээр төрийн болон өөрийн удирдлагын давхардал багасах боломж гарна. Аймаг, нийслэл, сум, дүүргүүд эдийн засгийн хувьд хуулиар тусгайлан олгосон чиг үүрэгтэй болох нөхцөл бүрдсэн нь нутгийн өөрөө удирдах

² International Encyclopedia of Political Science. Bertrand Badie. SAGE. 2011. Government. pp. 118-123.

байгууллагын цаашдын хөгжилд чухал алхам болсон. (Ж.Ж)

ӨӨРЧЛӨЛТИЙН УДИРДЛАГА (*Change management*)

Байгууллагын өнөөгийн төлөв байдлыг хувьсах орчны нөхцөл байдалд зохицуулан, ирээдүйн зорилго, стратегид чиглүүлэн өөрчлөхөд чиглэсэн удирдлагын системтэй үйл ажиллагаа³. Өөрчлөлтийн удирдлага нь өөрчлөлтийн үйл явцад хүмүүсийг удирдах, шаардлагатай үр дүнд хүрэх, өөрчлөлтийг хувь хүн, баг, өргөн хүрээний системд үр дүнтэй хэрэгжүүлэх үйл явц, хэрэгсэл, арга техник юм. Байгууллагын өөрчлөлтийн удирдлагад дараах зарчмуудыг баримтална. Үүнд, өөрчлөлтийн дараа байгууллага ирээдүйд төлөвлөж таамагласан төлөв байдалдаа шилжсэн байх, байгууллагын ирээдүйн төлөв байдал, түүний үйл ажиллагаа нь хүмүүсийн хүсэн хүлээж байсан итгэл найдварыг хангах, байгууллагын өөрчлөлт нь аль болох бага өртөг зардлаар хэрэгжих, өөрчлөлтөөр гарах үр дүн, ашиг нь аль болох өндөр байх зэрэг болно⁴. (Д.Ч)

ӨР (Debt) Өр нь нэг тал нь зээлдэгчээс нөгөө тал болох зээлдүүлэгчид мөнгө эсвэл бусад тохиролцсон үнэ цэнийг төлөхийг шаарддаг үүрэг юм. Өр нь хойшлогдсон төлбөр буюу цуврал төлбөр бөгөөд үүнийг шууд худалдан авалтаас ялгаж өгдөг. Энэ өрийг Засгийн газар эсвэл улс орон, орон нутгийн засаг захиргаа, компани эсвэл хувь хүн төлөх ёстой. Макро түвшинд өрийг эх үүсвэрээс нь шалтгаалан гадаад өр болон дотоод өр гэж ангилдаг. Түүнчлэн Улсын

өр эсвэл Засгийн газрын өр, Төв банкны өр, арилжааны банкны өр, хувийн секторын өр гэх мэт ангилдаг. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд “Улсын өр” гэж Засгийн газрын дотоод, гадаад зээл, санхүүгийн түрээс, Засгийн газрын гаргасан баталгаа, өрийн бичиг, төрийн болон орон нутгийн өмчит болон тэдгээрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн ирээдүйд эргэн төлөх үүрэг хүлээсэн санхүүгийн бүх төрлийн төлбөрийн үүргийн мөнгөн дүн, түүнд ногдох хугацаа хэтэрсэн хүү, алданги, торгуулийн нийлбэрийг хэлнэ.⁵ Монгол Улсын Төсвийн тухай хуульд “уул уурхайн салбарын гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн дүрмийн санд хувь оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ирээдүйн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгааг хамааруулахгүйгээр тооцсон улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй байх”⁶ гэж заасан. Дэлхийн банк: Засгийн газрын болон засгийн газрын нэгжүүд, мөн засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчдийн урт хугацаанд гадаад улсад төлөхөөр үүрэг хүлээсэн болон Засгийн газрын баталгаа гаргасан хувийн хэвшлийн байгууллагын гадаад улсад төлөхөөр үүрэг хүлээсэн өрийн нийлбэрийг Засгийн газрын гадаад өр гэнэ. Харин ОУВС-ийн тодорхойлсноор: Гадаад өр гэж тухай оронд оршин суугч нь гадаад улсруу шилжүүлэх үүрэг хүлээсэн төлбөрүүдийн нийлбэр гэжээ. (А.Э)

3 Менежментийн шинжлэх ухааны нэр томьёоны тайлбар толь, Glossary of Management Science Terminology, Улаанбаатар, 2020 х. 176.

4 Т.Дорж, Менежмент, сурах бичиг, 2018, х. 493

5 Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8

6 Төсвийн тухай хуулийн 6.1.4 дэх заалт.

ӨРИЙН БАТАЛГАА (*Guarantee of debt*) Зээлдүүлэгчээс авсан мөнгө эсвэл хөрөнгийг зээлдэг ч тал төлөх боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд тухайн өрийг төлөх үүргийг хүлээх субъектийн гаргасан баталгааг хэлнэ. Тухайлбал, Засгийн газрын үнэт цаасны өрийн баталгаа нь Сангийн яам буюу улсын төсөв болдог. (А.Э)

ӨРСӨЛДӨӨН (*Competition*) Зах зээлийн харилцааны нөхцөлд оршин тогтнох арга буюу эдийн засгийн харилцаанд оролцогчид зах зээлд эзлэх байр сууриа бататгах, нэмэгдүүлэхийн тулд харилцагчдаа хамгийн сайн нөхцөлийг санал болгох болон, аливаа давуу байдал олж авахын төлөөх үйл явцыг хэлнэ. Шударга бус өрсөлдөөний сөрөг үр дагавар нь эдийн засагт олон хэлбэрээр илэрдэг тул зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хориглон хязгаарлах, өрсөлдөөнийг зохицуулах бодлогыг төрөөс хэрэгжүүлдэг. Чөлөөт өрсөлдөөн нь үйлдвэрлэлийн зардлыг бууруулах, үр ашгийг дээшлүүлэх, шинэ технологийг нэвтрүүлэх зэрэг эерэг нөлөөг бий болгож улмаар зах зээлийн үнэ буурах, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар дээшлэх нөхцөл бүрдүүлдэг тул төрөөс шударгаар өрсөлдөхийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ. Өрсөлдөөнийг зах зээлийн үнэнд нөлөөлөх байдлаар нь төгс ба төгс бус өрсөлдөөн, өрсөлдөх хүчин зүйлээр нь үнийн ба үнийн бус өрсөлдөөн, өрсөлдөх шинж байдлаар нь шударга ба шударга бус өрсөлдөөн гэж ангилдаг. (Б.Б)

ӨРСӨЛДӨӨНИЙ ЗОХИЦУУЛАЛТ (*Competition law/regulation*) Шударга бус өрсөлдөөнийг хязгаарлаж, эдийн

засгийн харилцаанд оролцогчдын шударга өрсөлдөөнийг дэмжих төрийн оролцооны хэлбэрийг хэлнэ. Глобалчлалын үед улс орнуудад өрсөлдөөний зохицуулалт нь эдийн засгийн харилцааг зохицуулах гол хэрэгсэл болсон. Жишээ нь: Европын холбооноос баталсан өрсөлдөөний дүрмийг гишүүн орнууд, бүс нутагт эдийн засгийн харилцаанд оролцож байгаа бизнес эрхлэгч, мэргэжлийн холбоод, эдийн засгийн бүлэглэл дагаж мөрдөхөөр зохицуулсан.⁷ Төрөөс хэрэгжүүлэх өрсөлдөөний бодлого нь өрсөлдөөнийг дэмжих хууль эрх зүйн орчинг тодорхойлж түүнийг хэрэгжүүлэх институцийг бүрдүүлэхэд чиглэнэ. Монгол Улсад өрсөлдөөний зохицуулалтыг Өрсөлдөөний тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актын хүрээнд хэрэгжүүлдэг. (Б.Б)

ӨРТГИЙН ТООЦООЛОЛ (*Costing*) Бүтээгдэхүүн, үйлчилгээ, эсвэл аль нэг субъектэд хамаарах зардлыг хуримтлуулан бүртгэж тооцох үйл ажиллагааг өртөг тооцох гэнэ. Үр дүн, гарцад суурилсан санхүүжилтийг төрийн салбарт нэвтрүүлэхийн тулд төрийн үйлчилгээний өртгийг үндэслэлтэй тооцоолох шаардлагатай. Өртөг тооцох уламжлалт арга, үйл ажиллагаанд суурилсан арга, стандарт зардалд суурилсан өртөг тооцох зэрэг аргыг түгээмэл хэрэглэдэг.⁸ Байгууллага үйл ажиллагааны онцлог, бүтэц зохион байгуулалтын хэлбэр зэргээ харгалзан өртөг тооцох аль аргыг хэрэглэхээ шийдэх ба өртөг тооцох аргачлалаа тодорхойлж бодлогын баримт бичиг, санхүүгийн лавлахад тусгаж мөрдүүлдэг. Төрийн

⁷ https://europa.eu/youreurope/business/selling-in-eu/competition-between-businesses/competition-rules-eu/index_en.htm

⁸ Robert S. Kaplan and Steven R. Anderson: Time Driven-Activity Based Costing, 2004, Harvard Business Review

үйлчилгээ, хөтөлбөрийн өртгийг тооцсоноор төсвийн хөрөнгийг үр ашигтай хуваарилах шийдвэрийг гаргана. (Б.Б)

ӨРТӨГ (*Cost*) Бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоход зарцуулагдсан нөөцийн мөнгөн дүн буюу бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгосон үнэ цэнэ. Өөрөөр хэлбэл, зардлыг бүтээгдэхүүн, үйл ажиллагаа эсвэл субъект (ажилтан, нэгж хэсэг, байгууллага)-д тодорхой шалгуур үзүүлэлтээр хамааруулан, хугацаагаар зааглан хуримтлуулан бүртгэснийг өртөг гэнэ. Өртгийг тодорхойлох нь бүтээгдэхүүн, үйл ажиллагааг үнэлэх буюу үнэ тогтоох, санхүүжүүлэх үндэслэл болдог. Төрийн салбарт хэрэгжүүлэх хөтөлбөр, иргэдэд хүргэх үйлчилгээний өртгийг тодорхойлсноор төсвийн хөрөнгийг үр ашигтай хуваарилж санхүүжүүлэх шийдвэр гаргах, нийгмийн салбар хооронд нөөц, ажиллах хүчийг үндэслэлтэйгээр хуваарилах нөхцөл бүрдэнэ. (Б.Б)

ӨРТӨӨ (*Urtuu-post system*) Монголчуудын дэлхийн соёлд оруулсан томоохон хувь нэмэр бол өртөө юм. Өртөөг байгуулсан цаг хугацаа тодорхойгүй. Чаньчун бомбо Чингис хаантай уулзахаар явахдаа өртөөгөөр явснаас үзвэл Чингис хааны үед ч өртөө байжээ. Монголын нууц товчоонд: Өгэдэй өртөө буюу зам байгуулах саналаа Цагаадай ахдаа хэлүүлэхэд ах нь сайшаан өөрөө угтуулан өртөө байгуульга гээд, бас Батад хэлж зам тавиульга гэсэн байдаг. Энэ нь Монголын нутагт нэгэнт байгуулагдаад байсан өртөөг эзэлсэн газар орон руу үргэлжлүүлэн байгуулах шийдвэр байжээ. Хожим Монголын Их гүрнийг бүхэлд нь хамарсан өртөөний сүлжээ

байгуулагдаж, элч, худалдаачин гэх мэт олон хүн өртөөгөөр аюулгүй зорчин явах болжээ. Өртөөгөөр дамжиж яваа хүн хоногт 300 гаруй км зам туулах бололцоотой байжээ. Өртөө нь өртөөгөөр зорчин явагсад амарч унтах гэр, сэлгэх унаа морь, хүнсний хангамж, улаач бүхий буудалтай, ойролцоогоор 30 км тутамд байгуулдаг байжээ. Хожим өртөөгөөр бичиг захидал дамждаг байсан ба тэдгээрийг яаралтай болон яаралтай бус журмаар хүргэдэг байжээ. Яаралтай нугалбар болон захидлын дугтуй дээр довтолгож буй морьтой хүн, шувуу зурж “нис”, “нис” хэмээн бичдэг байв. Өртөө элч, зочныг зэрэг дэвээр нь хүлээн авах, хангамж, үйлчилгээ үзүүлэх зэрэг тусгайлсан олон ёс жаягтай болсон. Тухайлбал, яаралтай мэдээ хүргэх буухиа элч мордоход буу буудаж ёсолдог байжээ. Өртөө бүр XX зууны дунд үе хүртэл ард түмний залгуулах хүнд хүчир алба. 1949 онд Ардын аж ахуйтныг өртөөний албанаас чөлөөлж, улмаар морин өртөөг бүрмөсөн халж машинаар шуудан хүргэх болжээ. (А.Ц)

П

ПАРАДИГМ (*Paradigm*) Парадигм гэдэг грек гаралтай энэ үг анх ямар нэгэн юмны жишээ загвар, шаблон гэсэн утгаар хэрэглэгдэж байсан. Уг үгийг шинжлэх ухааны утга агуулгатайгаар хэрэглэж, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан хүн бол Томас Кун (Thomas Kuhn) юм. Тэрээр шинжлэх ухааны салбар бүр өөрийн хөгжилд: NS (normal science) – RS (revolutionary science) – NS (normal science) циклээр хөгждөг. Шинжлэх ухаан бүр өөрийн гэсэн үзэл баримтлал, онолын цогц системтэй ч яваандаа шинээр гарч байгаа аномаль (хэвийн бус) үзэгдлүүдийг тайлбарлаж чадахгүйд хүрч хямран парадигмаа солиход (revolutionary science) хүрдэг байна. Тэгэхдээ шинээр гарч ирж байгаа парадигм өмнөх парадигм хоёрын хооронд өвлөн уламжлагдах рационал логик холбоогүй учир парадигмын өөрчлөлт бол шинжлэх ухаанд гарч байгаа хувьсгалт өөрчлөлт гэж үздэг. Куны тодорхойлсноор парадигм бол “тухайн шинжлэх ухааны эрдмийн хамт олны гишүүд л зөвхөн өөр хоорондоо хуваалцаж, хүлээн зөвшөөрч байгаа зүйл” (a paradigm is what members of a scientific community, and the alone share) ажээ. Шинжлэх ухааны энэхүү хувьсгалт өөрчлөлт гарах хүртэл тухайн парадигм нь эрдэмтэн, судлаачдад асуудлыг шийдвэрлэх, эрэлхийлэх

загвар, жишээ болдог байна. Шинжлэх ухаанд асуудал үүссэн /буюу шийдэгдээгүй асуудал гарсан/ тохиолдолд энэ нь шинэ мэдлэг бий болгох урьдач нөхцөл болдог нь П.Фейерабанд, Э.Нагель, Г.Р.Нойес нарын үзсэнээр верификаци эсвэл фальсификаци хийхийг шаарддаг аж. Товчхондоо, парадигмын өөрчлөлт нь шинжлэх ухааны хувьсгал юм. (Т.Т; Б.П нар)

ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛ (*Parliamentary government / system*)

Парламент нь “*parler*” ярих, хэлэлцэх гэсэн утгатай Франц үгнээс гаралтай. Парламент нь хууль тогтоох засаглалыг бүрдүүлдэг, өөрөөр хэлбэл хууль боловсруулах, батлах хамгийн дээд эрх эдэлдэг байгууллага юм. Парламентат ёс нь олон зууны түүхтэй. “*Парламент*” гэсэн нэр томьёо нийгэм улс төрийн хэллэгт эртнээс орсон бөгөөд “*Хууль тогтоох төлөөлөгчдийн байгууллага*” гэдэг утгаараа анх 1265 онд Англид хэрэглэгдсэн. Төрийн эрх барих эрх мэдэл үндсэн хуулийн дагуу парламентад хадгалагдсан засгийн хэлбэрийг хэлнэ. Тодруулбал, засаглалын тогтолцоо нь парламентад хамгийн их төлөөлөлтэй нам, эсвэл намуудын эвсэл засгийн газраа байгуулж, ерөнхий сайдаар гүйцэтгэх засаглалыг удирдуулдаг

хэлбэр юм. Парламент нь засгийн газраа бүрдүүлэх, ерөнхий сайд, засгийн газрын бусад гишүүн, сайд нарыг томилох бүрэн эрхтэй ба үндсэн хуулийн шүүх зэрэг төрийн бусад гол институцийн албан тушаалтнуудыг сонгож томилно. Парламентын засаглалтай ихэнх улсад төрийн тэргүүнийг хууль тогтоох байгууллагаасаа сонгодог бөгөөд энэ нь эргээд парламентын үйл ажиллагааг үндсэн хуульд нийцэж буй эсэхэд хяналт тавих нөхцөл болдог. Парламентын болон Ерөнхийлөгчийн засаглалын аль ч үед төрийн алба нь нийтийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэх үндсэн шинжээ хадгалж, төвийг сахисан, захирах захирагдах зарчимд тулгуурлан мэргэжлийн ур чадвар, бие даасан эрх чөлөөт байдал, төрийн албаны мэргэжлийн ёс зүйг сахиж ажиллах нийтлэг зарчим үйлчилдэг. (Я.Т)

ПАТРОНАЖ/ИВЭЭЛД АВАХ ҮЗЭЛ (*Patronage*) Латин хэлний “patronus” буюу хамгаалах, ивээх, тэтгэх гэсэн утгатай. Хувь хүн, бүлэг, байгууллагыг ивээлдээ байлгаж, давуу байдал бий болгох гэсэн үзэгдэл юм. Улс төрийн патронаж нь төрийн албан тушаалд өөрийн аялдан дагалдагчид болон өөрийн намын гишүүдийг албан тушаалд томилох, томилуулахыг хэлнэ. Патронажийн нэг төрөл нь нутгархах үзэл бөгөөд өөрийн нутгийнхныг гаргасан амжилт, үйлдлээр нь бус гарал угсаагаар нь голлон үзэж албан тушаалд томилох, дэвшүүлэх зэргээр илт дэмжих явдлыг багтаадаг. Ийм үзэгдэл ихэнхдээ аж үйлдвэр сул хөгжсөн, уламжлалт соёлтой, иргэний нийгэм болон улс төрийн байгууллагууд нь институцийн төлөвшилийг хангаагүй үед ажиглагддаг байна. Монголын нөхцөлд 1990 оноос хойш “жалга,

довны үзэл-неопотизм, ах дүү, хамаатан садан, найз нөхдөө тэтгэх үзэл-фаворитизм, намын гишүүддээ хайр халамж үзүүлэх-клиентелизм” гэх мэт үзэгдлүүд дэлгэрч байгаад шүүмжлэлтэй хандах болсон. Улмаар энэ үзэгдэл нь төрийн албаны хүний нөөцийн бүрдүүлэлтэд нөлөөлж, мерит зарчим, шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх зарчмууд алдагдах, төрийн удирдлагын тогтворгүй байдлыг бий болгох сөрөг үр дагавартай үзэгдэл юм. (Я.Т)

ПОПУЛИЗМ (*Populism*) Популизм гэдэг нь хоосон лоозогнож хүн амын зарим хэсгийн сэтгэл дундуур байдлыг ашиглах замаар улс төрийн ашиг хонжоо хайх гэсэн утгатай үг. Ард түмэн, ард түмний эрх ашгийн төлөө гэсэн утгатай “populous” хэмээх латин гаралтай үг боловч ард түмний дунд нэр нөлөө олох зорилгоор ул үндэсгүй, хоосон амлалт, хуурамч уриа лоозон хэрэглэн тэднийг өөртөө татах зорилготой үйл ажиллагаа юм. Тухайлбал, зөвхөн сонгуулийн өмнө цалин, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх, татварыг уян хатан болгох зэрэг алхмууд нь популизмын илрэл болно. Иймэрхүү популист үйл ажиллагаа нь улс орны хөгжил, ардчилсан системд сөргөөр нөлөөлдөг. Популизмыг танихын тулд түүний шинж тэмдгүүдийг мэдэх шаардлагатай. Судлаач Гита Ионеску, Эрнест Геллнер (1969) нар “Populism: Its Meanings and National Characteristics” бүтээлдээ популизмын шинж чанаруудын талаар тодорхой дурджээ: “популизм нь дотроо үзэл суртал, хөдөлгөөн, синдром гэсэн төрөлтэй байх бөгөөд гол агуулга нь нийгмийг “энгийн хүмүүс” ба “хөрөнгө чинээтэй баячууд, улс төрч, авлигад өртсөн цөөнх/элит гэсэн хоёр хэсэгт хуваан авч үзжээ. Энгийн

иргэд популизм хийх хэрэгцээ, сонирхол байхгүй бол эсрэгээр нөгөө цөөнх хэсэгт түр зуурын улс төрийн ашиг хонжоо олох, олонход таалагдах хүсэл сонирхол өндөр байдаг. Энэ цөөнх хэсгийн энгийн олонх руу чиглэсэн популист үйл ажиллагааны тухай юм. Популизмын эдгээр үзэгдлүүдийг тайлбарлахад маргаантай асуудлууд байдаг боловч тухайн улс орны онцлогтой болохыг онцолжээ. Жишээлбэл, Европын орнуудад популизмыг ихэвчлэн цагаачлалын эсрэг болон ксенофоби¹ үзэлтэй холбон хэрэглэдэг бол Латин Америкт популизмыг клиентелизм, эдийн засгийн буруу менежменттэй холбон ашигладаг байна. Гэхдээ нийтлэг нь хэн нэгэн улс төрч популист амлалт өгөх, мөнгө санхүүгийн асуудалд хэт дөрөөлөх, улс төрчид бие биенийхээ эсрэг сэтгэл хөөрлийг өөртөө ашигтайгаар эргүүлэхийг оролдох, үзэл санаа нь цэгцтэй бус, өөрөөр хэлбэл яг юуг зорьж, юуг бүтээн босгох, арга зам нь тодорхойгүйгээр иргэдийн хүсэл эрмэлзлийг биелүүлэх тухай амлалт өгөх гэх мэт шинж тэмдгүүдээр илэрдэг. Популист улс төрч өөрийгөө “ард түмний хүсэл зориг”-ийг төлөөлж байна гэж мэдэгддэг. Тэд ихэнхдээ тухайн үеийнхээ нам болон бүлгүүдийн доторх дайснуудын эсрэг сөргөлдөн зогсож, “намаг шалбааг” эсвэл “хөрөнгө чинээтэй” бүлэгтэй тэмцэх зорилготой байгаагаа мэдэгдэж тодорхой байр сууриа илэрхийлдэг. Судлаачдын бүтээлд: “Популизм” нь “сөрөг утгатай үг” бөгөөд түүнд улс орны бодлогын, үзэл санааны, эсвэл ардчиллын эсрэг гэсэн түлхүүр санаанууд багтдаг. Харин популизмын нэг давуу тал нь хувьсан өөрчлөгдөх олон талт шинж

чанартай юм. Энэ нь популизмыг “бүх нөхцөл байдалд дасан зохицож чаддаг ер бусын хүчтэй” гэж тэмдэглэсэн байна. Популист улс төрчдийн бас нэг нийтлэг зүйл нь тэд орчин үеийн засаглалын “ардчилсан төвөгтэй тогтолцоо”-нд дургүйцэх хандлагатай тул үүний оронд шууд ардчиллыг илүүд үздэг гэжээ. Популистуудын санааг шинжлэн үзэхэд хамтын нийгэмд үл итгэх үзлийг дэвэргэх замаар хүчтэй удирдагчийг хүсэмжилдэг нь авторитаризмтай холбох үндэслэл болдог. Мөн популистууд аливаа шийдвэрийг зөвхөн лидерүүд гаргадаг гэдэгт итгэдэг байна. Венесуэлийн Ерөнхийлөгч Уго Чавес нэгэн удаа “*Би хувь хүн биш - Би ард түмэн*” гэж хэлсэн үг болон “*Эцсийн эцэст хэрэв та ‘хүмүүстэй’ хамт байхгүй бол тэд бидний эсрэг байх болно*” гэж хэлсэн үгнүүдээс популизмын агуулгыг мэдэх боломжтой юм. Тийм ч учраас сүүлийн үед хэт их амласан улс төрчийг популист хэмээн сэжиглэж доромж маягийн утгатай энэхүү нэр томьёог ашиглах болжээ. Тэд ард иргэдээс дэмжлэг авахын тулд намаасаа болон бусдаас өрсөж илүү хурдан санал дэвшүүлж, боломжгүй зүйл гэж байхгүй мэтээр юуг ч өөрчлөх амлалт өгдөг ч уугаа нарийвчлан үзвэл хэрэгжих боломжгүй зүйлийг амлахыг популистууд гэж нэрлэдэг байна. Сүүлийн 25-30 жилийн хугацаанд улс төр судлаачид популизмыг судалж буй боловч маш хурдацтай тархаж байгааг хүлээн зөвшөөрч байна. Судлаач Мйну, Surel (2000) нар: популизм үүсэхэд улс төрийн гурван нөхцөл нөлөөлдөг болохыг тодорхойлжээ. Үүнд: улс төрийн зуучлагч байгууллагын бүтцийн хямрал, улс төрийн эрх мэдлийг илүү хувийн ашиг сонирхол болгох нөхцөл, улс төрийн амьдралд

1 Ксенофоби үгний тайлбараас утгыг дэлгэрүүлэн харарх

хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг нэмэгдэж байгаа нөхцөлүүдийг холбон үзжээ. Иймд популизм бол нийгэм, улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал, мэдээллийн тодорхой бус байдал, сонгууль, бүх нийтийн санал асуулга гэх зэрэг нөхцөлүүдийн үед хүчээ авдаг нийгмийн сөрөг үзэгдэл юм. (Я.Т)

ПРОКУРОРЫН ХЯНАЛТ (*Prosecutor's supervision [control]*) Прокурорын хяналт-прокурорын байгууллагаас хууль ёсыг хангах, хуулийн зөрчлийг илрүүлэх, арилгах, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааны хэлбэр. Прокурорын хяналтын үндэс нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулахад оршино. Прокурорын байгууллага хяналтаа дараах чиглэлээр хэрэгжүүлнэ. Үүнд:

- хэрэг бүртгэх ажиллагаа,
- мөрдөн байцаах ажиллагаа,
- ял эдлүүлэх ажиллагаа.

Үүнээс гадна прокурор шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно. Прокурор үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална: а) хуулийг нэг мөр хэрэглэх; б) хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах; в) нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх; г) хараат бус, бие даасан байх; д) ил тод, нээлттэй байх. Прокурор хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад тогтоол, даалгавар, зөвшөөрөл, шаардлага, мэдэгдэл, дүгнэлт, санал, эсэргүүцэл, хүсэлт, нэхэмжлэл, тайлбар, гомдол гаргана. (Ч.Э)

ПРУССЫН ЗАХИРГАА (*Prussian administration*) Орчин үеийн Европын захиргааны үндэс суурь Пруссет ХҮИ зууны сүүлчээс ХҮИИ зууны үед тавигджээ. Хаад хотуудын бие даасан байдлыг арилгах, феодал язгууртны давуу байдлыг арилгаж хатуу төвлөрсөн төрийг буй болгохыг оролдож байв. Мужуудыг захирах албан хаагчдыг төв засгийн газар томилдог болсон байна. Хааны эзэмшлийн газар болон цэргийн хэргийг нэгтгэн Дайн ба хааны газрын албанд (“Office of War and Crown Lands”) хотууд болон коммуныг захирдаг татварын албыг (Steuergräte) захируулсан байна. Эдгээр бүх албан тушаалтныг төвөөс томилдог байжээ. Засаг засаг захиргааны эл том цацын оройд хаан өөрөө байдаг байсан. Төрийн албаны тусгай хэсгийг байгуулснаар төвлөрөл улам хүчтэй болсноор албан хаагчид Берлинээс орон нутаг руу явж цэргийн албанд хүнийг шилж сонгох болон бусад асуудлыг гүйцэтгэдэг байснаа аажмаар иргэний салбарын асуудлуудыг хамаарах болжээ. 1722 ба 1748 онуудад төрийн албан хаагчдыг шилэн сонгож, томилох талаар зарлиг гарчээ. XVIII зууны туршид эдгээр системийг улам боловсронгуй болгон 1794 онд эдгээр зарлиг шийдвэрүүдийг нэгтгэн тусгай хууль гаргажээ. Бүх албан тушаалд мерит системд үндэслэн хүмүүсийг томилох болсноор өндөр тушаалын албанд орохын тулд камерализмаар их сургуулийн зэрэгтэй болсон байх ёстой байв. Тэгэхдээ их сургууль төгссөний дараа төрийн ямар нэг албанд дадлага хийж, дахин ам, бичгийн шалгалт өгөх ёстой байжээ. Пруссын энэхүү хууль, түүгээр буй болгосон хэм хэмжээ нь орчин үеийн төрийн албаны хуулиудад ч тусгалаа олсон байдаг. (А.Ц)

С

САЙМОН, ХЕРБЕРТ АЛЕКСАНДР (*Simon, Herbert Alexander, 1916-2001*) Америкийн эдийн засагч, улс төр судлаач, танин мэдэхүйн сэтгэл судлаач. Ерөнхий боловсролын сургуульд байх үеэсээ шашингүйн үзлийг баримталж, шинжлэх ухааныг сонирхож эхэлжээ. 1933 онд Чикагогийн их сургуульд орж 1936 онд төгсжээ. 1943 онд улс төрийн шинжлэх ухаанаар докторын зэрэг хамгаалсан байна. Сургуулиа төгссөний дараа Хотын захиргааны зөвлөх, Калифорнын их сургуулийн захирал, Иллинойсын их сургуулийн улс төрийн шинжлэх ухааны тэнхимийн эрхлэгчээр ажиллажээ. 1949-2001 онуудад Карнеги Тех-д профессороор ажилласан байна. Тэрээр 1978 онд Эдийн засгийн салбарын Нобелийн шагнал хүртжээ. Тэр гол төлөв байгууллагад шийдвэр гаргах тухай асуудлыг судалж байсан боловч түүний судалгаа олон шинжлэх ухааныг хамарч байсан ажээ. Орчин үеийн хиймэл оюун ухаан, мэдээллийн боловсруулалт, асуудал шийдвэрлэх, байгууллагын онол, комплекситийн онол зэргийг ярьж эхэлсэн хүний нэг аж. Тэрээр (*Administrative Behavior: A Study of Decision-Making Processes in Administrative Organization, 1947; Models of Man, 1957; The Sciences of the Artifi-*

cial, 1969; Human Problem Solving, / with Allen Newell/, 1972; Models of Discovery : and other topics in the methods of science, 1977; Models of Bounded Rationality, 1982; Scientific Discovery: computational explorations of the creative processes. /with P. Langley, G. Bradshaw, and J. Zytkow/, 1987 гэх мэт) бүтээлүүдийг туурвижээ. (А.Ц)

САЙН ЗАСАГЛАЛ (*Good governance*) “Good” гэдэг нь эртний англи хэлний “god” гэсэн үгнээс үндэстэй. Үгийн утга нь “сайн зүйл, сайн тал” гэсэн агуулгатай бөгөөд XV зууны эхээр Англи хэлнээ “good” хэмээн хэрэглэгдэх болсон. 1989 оны үед Дэлхийн банкны ерөнхийлөгч Конабле: “төрийн үйлчилгээ үр ашигтай байх”, “хуулийн систем баталгаатай байх”, “захиргаа нь иргэдийн өмнө хариуцлагатай байх буюу эгэх хариуцлагатай байх” гэдэгтэй холбон “Сайн засаглал” хэмээх нэр томьёог анх хэрэглэсэн (Малдоналдо, 2010, хуудас. 5). 1991 онд Дэлхийн Банк “Хөгжлийн эдийн засгийн” асуудлаарх бага хурлаа “Сайн засаглал” сэдвийн дор зохион байгуулсан нь сайн засаглал дэлхий нийтийн анхаарал татсан асуудал болон хөгжих үндэс болжээ (НҮБХХ, 2010, хуудас. 9). “Сайн засаглал” (Good governance) хэмээх нэр томьёог

англи хэлнээс монгол хэлнээ хэрхэн хөрвүүлэн хэрэглэх талаар судлаачид янз бүрийн байр суурьтай байж “Сайн засаглал”, “Үр ашигтай удирдлага”, “Эрүүл засаглал”, “Зөв засаглал” гэх мэтээр томьёолон хэрэглэж байжээ (ХАБХСЗХ, 2003, хуудас. 9). Өнөөдөр “Сайн засаглал” хэмээх нэр томьёо нь тогтсон хэллэг болсон байна. Сайн засаглал нь “тогтвортой хөгжлийн төлөө нөөц, баялгийг ил тод, хариуцлагатай удирдах” (Европын комисс), “иргэдэд тэгш боломж олгох, нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй байдлыг бий болгох талаар нийгэм өөрийгөө зөв зохион байгуулах асуудал”, “оролцоо, ил тод байдал, эгэх хариуцлагатай байх зарчимд тулгуурласан удирдлагын арга” (НҮБХХЭЗХАХБ) гэсэн санаа гол байр суурийг эзэлж байна. Сайн засаглалыг хөгжүүлэх, бэхжүүлэхэд засаглалын гол оролцогч хоёр тал нь төр, иргэн юм. Нийгмийн сайн сайхан байдал хангагдах, төрийн үйлчилгээ нь чанартай, хүртээмжтэй, хуулийг дээдэлдэг сайхан нийгмийг цогцлоход “Сайн засаглалын” зорилго оршино. Сайн засаглал нь хариуцлагын тогтолцоо (төрийн албан хаагчдыг хийсэн үйлдлийнх нь төлөө хариуцлага хүлээлгэх чадвар), тунгалаг байдал (мэдээллийн ил тод нээлттэй байдал), оролцоо (иргэд санал бодлоо илэрхийлэх, оролцох үйл явц) гэсэн гурван тулгууртай. (Т.Т)

САЛА ЗАГВАР (*Sala model*) 1964 онд Америкийн эрдэмтэн Риггс (F.W.Riggs) хөгжиж буй орнуудын төрийн захиргааны тухай “олон талстат нийгэм” хэмээх үзэл баримтлалыг гаргаж ирсэн. Риггс төрийн алба гэдэг нэр томьёог захиргааны байгууллагууд ажил үүргээ гүйцэтгэх гэхээс илүү өргөн

хүрээтэй газар утгаар ашиглажээ. Тэрээр уламжлалт хэв маяг бүхий нийгэм дэх албан байгууллагууд (chamber)-ыг танхим, орчин үеийн нийгэмд албан газар (office) гэж ангилсан ба өнгөрсөн нийгмийг олон талст бүхий нийгэм хэмээн нэрлэжээ. Учир нь гэрэл эхлээд цагаан өнгөтэй байдаг бол түүнийг олон талстгаар дамжуулах юм бол гэрэл задарч солонгын долоон өнгөөр тусдаг. Үүнтэй адил хөгжиж буй орнууд нь ялгарал багатай байснаа хөгжлийнхөө явцад цагаан гэрэл задарч 7 өнгө болдог шиг эхлээд цөөхөн институт олон үүрэг гүйцэтгэдэг байснаа хөгжлийн явцад янз бүрийн өвөрмөц чиг үүргийг гүйцэтгэдэг олон институттэй болдог. Ийм олон талст лугаа нийгэм нь хэлбэрдэл (онол ба практикийн зөрөө), олон янз байдал (уламжлалт болон орчин үеийн зүйлсийн аль аль нь байх), чиг үүргийн давхцал (ижилдүү үүргийг хэд хэдэн байгууллага гүйцэтгэх) зэрэг шинж чанартай гэж үздэг. Ийм байдалд нөлөөлдөг зүйл нь нийгэм хүй элгэн болж бүрэн төлөвшгүй байдал (өөр хоорондоо үл итгэх, хардлага сэрдлэг), эдийн засаг нь хар захын маягтай, юмны үнэ зах зээлийн бус зарчмаар тодорхойлогддог, үйл ажиллагаанд рационал болон рационал бус шалгуур хэрэглэдэг зэрэг болно. Нийгэмд өмнө нь хамтач үзэл ихтэй байснаа хагас үйл элэгний маягтай болж задрах үед хардлага сэрдлэг, үл итгэх байдал нийгэмд буй болдог аж. Мөн юмны үнэд хүмүүсийн нийгмийн байдал, төрийн оролцоо нөлөөлж зах зээлийн зарчмаар тогтоогдох саад болдог байна. Рационал ба рационал бус гэдэг бол хуулиас гадна бусад олон хэм хэмжээ үйлчилдэг гэсэн үг. Ийм захиргаанд нийтлэг, албан ёсны хэм хэмжээ болон уламжлалыг баримталдаг, төрийн

албанд ороход авьяас чадвараас гадна гэр бүлийн нөлөө зэрэг бусад зүйл ч нөлөөлдөг байна². Ийм нийгэм дэх төрийн захиргааг Риггс сала (sala) загвар гэж нэрлэсэн байна. Сала хэмээх үг нь испани хэлээр “хайрын өрөө” гэсэн утгатай, нийгэмд шударга бус байдлаар олгогдсон удирдлагын эрх ашгийг ашигладаг гэсэн утгыг хайрлан халамжилж, хууль бусаар давуу эрх олгодог учир ийн нэрийджээ. (Ц,Д)

САЛБАР ДУНДЫН ШИНЖИЛГЭЭ (*Cross-Sectoral analysis*) Шинжлэх ухааны судалгаанд шинжилгээний арга зүй нэн түгээмэл хэрэглэгддэг. Шинжилгээ нь аливаа зүйлийг бүрэлдэхүүн хэсэг болгон задлах үйл явц боловч шинжилгээний процедурын явцад илүү суурь элементүүдийг нарийвчлах, үзэл баримтлалыг энгийн хэсэг болгон задлах, үүний үр дүнд логик бүтцийг нь тодруулах үйл явц мөн хэмээн тодорхойлдог. Шинжилгээний хамрах хүрээг хязгаарлаж, “логик бүтэц”-ийг тодорхойлохыг дурдсан нь аливаа зүйлийг хэсэгчлэн задлах гэсэн санаа ямагт хадгалагдаж байдаг. Иймд шинжилгээ хийх үйл явц төрийн бодлогын судалгаанд ямагт тэргүүн эгнээнд зүй ёсоор хэрэглэгддэг төдийгүй орчин үеийн судалгаа шинжилгээнд салбар дундын анализын хэлбэр чухлаар тавигдаж байна. Салбар дундын шинжилгээ бөгөөд хандлага нь шинжлэх ухааны мэдлэгийн интеграц, дифференциаци, түүний дотоод конкурент чанар, системийн сэтгэлгээ болоод шинжилгээний хэрэгцээ, шаардлага, нийгмийн болоод мэдлэгийн инженерчлэл, даяаршил болон дангааршлын үйл явцад татагдан

оролцоухой доор шинжлэх ухааны судалгааны хүрээнд үүссэн шинэлэг хандлага, арга зүй, шилжилтийн шинэ хандлага хэмээн үзэж болно. Энэ нь судалгаа шинжилгээний хамтын ажиллагаа, зорилгодоо хүрэхийн тулд нэг объектыг янз бүрийн мэргэжлийн судлаачид зэрэгцэн судлах, хэд хэдэн аргыг хослуулах, зэрэгцүүлэн хэрэглэх зэрэг судалгааны зохион байгуулалтын арга юм. Орчин үед салбар дундын судалгаа ихэвчлэн шинжлэх ухааны бүтээлч сэтгэлгээний шинэ хэв маягийг тогтоох, хүн, нийгэм, хүн төрөлхөнд тулгарч буй томоохон асуудлыг томьёолох, түүнд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг боловсруулах, судалгааны үр дүнг мэдлэгийн тогтолцоонд шилжүүлэхэд голлон анхаарч байна. Үүний зэрэгцээ шинжлэх ухааны салбар дундын судалгаа шинжилгээ нь уламжлалт философи, шинжлэх ухааны философи дахь нийтлэг арга зүйн байр суурьтай төдийлөн хутгалдаагүй, постмодернизмын хүрээнд дискурс-анализ, герменевтик тайлбарлал зэргээр аналитик философийн хүрээнд анализын төрөл хэлбэрүүд хөгжин, хөгжүүлсээр байна. (Б,П)

САНХҮҮГИЙН БОДЛОГО (*Financial policy*) Санхүүгийн тогтвортой байдал, зах зээлийн үр ашиг, үйлчлүүлэгчдийн хөрөнгө, хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгоор санхүүгийн болон төлбөр тооцооны систем, түүний дотор санхүүгийн зах зээл, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, хянаж шалгахад чиглэсэн бодлогыг хэлнэ. Санхүүгийн зах зээл нь мөнгө, даатгал, үнэт цаас (хувьцаа, бонд, дериватив, түүхий эдийн фьючерс гэх мэт), гадаад валют, сүүлийн үед крипто валют

2 Fred W. Riggs, Administration in Developing Countries: The theory of Prismatic Society, 1964.

зэрэг олон төрлийн санхүүгийн арга хэрэгслийн (instruments) арилжааг хамарч зах зээл дээр банк, хөрөнгийн бирж, брокерын пүүс, даатгалын компани, банк бус санхүүгийн байгууллага, валют солих цэг, ломбард гээд маш олон байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Санхүүгийн бодлого нь эдгээр зах зээл болон байгууллагуудын үйл ажиллагааг нэг талаас дэмжих, нөгөө талаас тодорхой хязгаарлалтууд тавих, хянах үүрэгтэй. Энэ нь холбогдох хууль, эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журмаар зохицуулагдана. Санхүүгийн бодлогын үндсэн зорилго нь төлбөр тооцоо болон гүйлгээний аюулгүй байдлыг хангах, банк ба санхүүгийн хямралаас сэргийлэх, орлогч талуудын эрх ашгийг хамгаалах, ингэснээр санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангана. Ихэнх улс оронд санхүүгийн бодлогыг хэрэгжүүлж, санхүүгийн салбарыг хянах үүрэг хариуцлагыг хэд хэдэн агентлагуудад хуваарилдаг. Тухайлбал, банкны зохицуулалт, хяналт шалгалт, банкны хадгаламжийн даатгалын бодлогыг гол төлөв төв банк хариуцдаг. Бусад төрлийн үйл ажиллагааг төрөлжсөн байгууллагад даалгадаг. Монгол Улсад Санхүүгийн зохицуулах хороо банкны биш бүх төрлийн санхүүгийн үйл ажиллагааг хянах үүрэгтэй. Санхүүгийн зах зээл өргөжин хөгжих, илүү төвөгтэй болох хэрээр зохицуулалт нь илүү нарийн болж, мэргэшсэн бөгөөд төрөлжсөн байгууллага хариуцах нь илүү оновчтой байдаг. (Ч.Н)

САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ (*Financial support*) Орон нутгийн төсвийн тэнцэл буюу зарлага нь орлогоос давж гарсан тохиолдолд Төв Засгийн газраас буюу улсын төсвөө тухайн

төсвийн алдагдлыг хаах зорилгоор өгч байгаа мөнгөн хөрөнгийг хэлдэг. Монгол Улсын Төсвийн тухай хуулиар Төв засгийн газрын төсвөөс орон нутгийн төсөв рүү шилжүүлэх үндсэн 3 шилжүүлгийн нэг нь санхүүгийн дэмжлэг юм. (А.Э)

САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ (*Financial transparency*) Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих боломж бүхий мэдээллийн тогтолцоо. Манай улсад улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд зорилгоор Шилэн дансны тухай хуулийг 2014 онд батлан мөрдүүлсэн. (Д.З; Ч.Л нар)

САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ЗАРЧИМ (*Financial transparency principles*) Санхүүгийн ил тод байдлыг хангахын тулд баримталдаг нийтлэг зарчмууд. Эдгээр зарчмуудад санхүүгийн мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх; тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлэлдэг байх; хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх гэсэн үндсэн дөрвөн зарчим багтана. Шилэн дансны тухай хуульд санхүүгийн ил тод байдлын зарчмыг “Шилэн дансны стандарт” гэсэн бүлэгт тусгайлан заасан. (Д.З; Ч.Л нар)

САНХҮҮГИЙН САХИЛГА БАТ (*Financial discipline*)

Зорилгодоо хүрэхэд төлөвлөсөн хөрөнгө, мөнгөний төсвийг төлөвлөгөөндөө зохицуулан зарцуулж, хэр хуримтлал үүсгэн, ямар хэмнэлттэй ажиллах чадварыг хэлнэ. Санхүүгийн сахилга бат нь мөнгөө хянах гэсэн утгатай бөгөөд төлөвлөөгүй, гэнэтийн зардлаас зайлсхийж, бүх мөнгөө үрэхгүй сайн талтай. Санхүүгийн сахилга баттай байснаар мөнгө хэмнэн хуримтлал үүсгэх боломж гарна. 1. Санхүү нь орлого, зарлагын удирдлага, банк, хөрөнгө оруулалтын салбар дахь мөнгөний ажил, гүйлгээ, гүйлгээ нь ерөнхийдөө олон нийтэд үйлчлэх, 2. Засгийн газар, компани, байгууллага, хувь хүний санхүүгийн байдал, мөнгөний нөөц, орлого гэх мэт. Сахилга бат нь дүрмийн дагуу үйлдэл хийх, цэргийн сахилга бат, ур чадвар хөгжүүлэх, үйл ажиллагаа сайжруулах, дасгал хөдөлгөөн, дэглэм сахих, дэг жаяг, сайн хүмүүжил, засах, сургах замаар ногдуулсан шийтгэл, хатуу сургалтын үр нөлөө гэх мэт утга агуулна. Санхүүгийн сахилга бат, хариуцлага бүх түвшинд байна. Бизнес эрхэлж байгаа хэн бүхэнд урт хугацаанд, тогтвортой, ашигтай ажиллах нь туйлын зорилго байдаг тул зорилгодоо хүрэхэд хамгийн чухал зүйлийн нэг бол “санхүүгийн сахилга бат”. Төрийн захиргааны байгууллагын хариуцан тайлагнах ажлын 4 үндсэн бүрэлдэхүүн хэсгийн эхэнд нь санхүүгийн хариуцлага байдаг. Энд эх үүсвэрийг захиран зарцуулах эрх бүхий этгээд, засгийн газрын байгууллага, төрийн албаны албан тушаалтан нь байгууллагынхаа санхүүгийн эх үүсвэрийг зарцуулах төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар тайлагнах үүрэгтэй гэж заасан байдаг. (А.Э.ц)

САНХҮҮГИЙН ТАЙЛАН (*Financial statement*)

Эдийн засгийн харилцаанд оролцогчид-(өрх гэр, байгууллага, засгийн газар)-ын үйл ажиллагааны үр дүнг санхүүгийн “хэл”-ээр илэрхийлсэн, гадаад, дотоод хэрэглэгчдийг эдийн засгийн шийдвэр гаргахад туслах мэдээллээр хангах хэрэгсэл. Санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын, орлого, үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлан ба тайлангийн тодруулгаас бүрдэнэ. Санхүүгийн тайлангийн хэрэглэгч нь байгууллагын удирдлага, төр, хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч, ажилтнууд болон бусад сонирхогч тал байдаг. Татварын тайлан баталгаажуулах, хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгчийг баталгаат мэдээллээр хангах зорилгоор санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитын байгууллага болон төрийн санхүүгийн хяналт, шалгалтын байгууллагуудаас шалгаж баталгаажуулна. Байгууллага, аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчим, мөрдөх стандарт, хугацаа, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тавих хяналттай холбоотой нийтлэг зохицуулалтыг төрөөс тодорхойлж хуульчилдаг. (Б.Б)

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ (*Financial statement audit*)

Шалгадагч этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажуулахыг³ хэлнэ. Санхүүгийн аудитыг "санхүүгийн тайлан" (баталгаажуулж буй мэдээлэл)-г заасан шалгуурын дагуу мэдэгдсэн эсэх талаар санал өгөх

3 Төрийн аудитын тухай хууль

зорилгоор явуулдаг. Ер нь шалгуур үзүүлэлтүүд нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартууд байдаг боловч аудиторуд тухайн байгууллагад тохирох бэлэн мөнгөний болон нягтлан бодох бүртгэлийн бусад үндэслэлийг ашиглан хийсэн санхүүгийн тайланд аудит хийж болно. Санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу шударгаар тайлагнасан эсэх талаар дүгнэлт өгөхдөө аудитор нь тайлан нь ноцтой алдаа эсвэл бусад алдаатай эсэхийг нотлох баримт цуглуулдаг. (А.Э)

САНХҮҮГИЙН ТҮРЭЭС (*Financial lease*) Түрээслүүлэгч нь түрээслэгчийн захиалгын дагуу түрээсийн зүйлийг санхүүжүүлэн гуравдагч этгээдээр үйлдвэрлүүлэх эсвэл худалдан авч гэрээний үндсэн дээр тодорхой хугацаанд, төлбөртэйгөөр түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад шилжүүлж гэрээний хугацаа дуусгавар болоход түрээсийн зүйлийн өмчлөлийг түрээслэгчид шилжүүлэх нөхцөл бүхий түрээсийг санхүүгийн түрээс гэнэ. Санхүүгийн түрээс нь гэрээний хугацаа харьцангуй урт, түрээсээр төлөх нийт төлбөр нь хөрөнгийн бодит үнээс арай өндөр, хөрөнгийн зүйлийн засвар үйлчилгээ, даатгал, эрсдэл зэргийг түрээслүүлэгч тал хариуцдаг зэрэг онцлогтой түрээсийн хэлбэр юм. Санхүүгийн түрээстэй холбогдох харилцаа, тухайлбал, санхүүгийн түрээсийн зүйлд тавигдах шаардлага, түрээслэгч, түрээслүүлэгч талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлага, түрээсийн зүйлийн баталгаа, барьцаа, эрхийн бүртгэл зэргийн ерөнхий зохицуулалтыг төрөөс хуулиар тодорхойлдог. Ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдах төслийг санхүүжүүлэх, өндөр дүнтэй, эхний

хөрөнгө оруулалт шаардагдахгүйгээр орчин үеийн техник, технологийг эзэмших нэг боломжит хувилбар нь санхүүгийн түрээс юм. (Б.Б)

САНХҮҮГИЙН УДИРДЛАГА (*Financial management*) Мөнгө, хөрөнгийг бий болгох, төвлөрүүлэх, хуваарилах, дахин хуваарилах, ашиглах, захиран зарцуулах, хяналт тавих үйл ажиллагааны удирдлага. Аливаа эдийн засгийн нэгжийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд ашиглах хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийг удирдахтай холбоотой шийдвэр болон энэхүү хөрөнгө, санхүүгийн нөөц, эх үүсвэрийг үр ашигтай төлөвлөх, хуваарилах, зарцуулах, зарцуулалтыг бүртгэж тайлагнах, хянах, хөрөнгө оруулалтын оновчтой багц бүрдүүлэх, эрсдэлийг тодорхойлж удирдах шийдвэрүүдийг хамарна. Үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээний болон хүний нөөцийн удирдлагын үр дүн нь санхүүгийн удирдлагыг хэр оновчтой хэрэгжүүлсэнээ мөн шалтгаалдаг учир санхүүгийн удирдлага нь байгууллага, салбар, улс орны удирдлагын хамгийн чухал талбар гэж тооцогддог. Санхүүгийн удирдлага нь нөөцийн төлөвлөлт, зарцуулалт, бүртгэл, тайлан хяналт гэсэн үндсэн үе шатаар хэрэгждэг. Санхүүгийн шинжилгээ, нягтлан бодох бүртгэл, тайлан, дотоод хяналт, аудитын удирдлага, үйл явцтай нягт уялдаатай хэрэгждэг. (Б.Б)

САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЛҮҮД (*Financial derivatives*) Санхүүгийн зохицуулалттай зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн, үнэ цэнэ нь суурь активын үнэ цэнээс хамаардаг санхүүгийн хэрэгслийг хэлнэ. Санхүүгийн хэрэгсэл нь мөнгөн хөрөнгийн төлбөр төлөх болох хүлээн авах үүргийг баталгаажуулсан,

төрөл бүрийн худалдаалагддаг актив бөгөөд засгийн газар бонд, өрийн бичиг зэрэг санхүүгийн хэрэгслийг түгээмэл ашигладаг. Санхүүгийн үүсмэл хэрэгсэлд опцион гэрээ, фючерс гэрээ, хадгаламжийн бичиг болон зохицуулалттай зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгслүүд багтдаг. Санхүүгийн үүсмэл хэрэгслийг ашиглах нь санхүүгийн зах зээлд оролцогчдыг эрсдэлээс хамгаалах, тэдний төлбөр түргэн гүйцэтгэх чадвар сайжрахад нөлөөлөх болон хөрөнгөө үр ашигтай байршуулж удирдах боломжийг олгох ач холбогдолтой. (Б.Б)

САНХҮҮГИЙН ХЭЛЦЭЛ (*Financial agreement/deal*) Санхүүгийн харилцаанд оролцогчдын хооронд эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн үйлдэл (эс үйлдэл)-ийг санхүүгийн хэлцэл гэнэ. Санхүүгийн зах зээлд валют, үнэт цаас, үнэт металл нефть зэрэг хөрөнгийг худалдах, худалдан авах нөхцөл, үнэ, хугацаа зэргийг тохиролцож хэлцэл хийгддэг. Санхүүгийн хэлцлийн дагуу хийгдэх үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа нь биржийн ба биржийн бус хэлбэрээр хийгдэх ба энэ зах зээлд тусгай зөвшөөрөл бүхий иргэд, байгууллагууд хөрөнгийн үнийн эрсдэлээс хамгаалахын тулд харилцагч санхүүгийн байгууллагаар дамжин оролцдог. (Б.Б)

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ (*Financial control*) Санхүүгийн нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт, ашиглалт, зарцуулалт, тайлан нь тогтоосон дүрэм, журам, бодлоготой нийцэж буйг шалгах үйл ажиллагааг санхүүгийн хяналт гэнэ. Санхүүгийн хяналт нь байгууллага үйл

ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, бодлого, стандартыг дагаж мөрдөх зорилтыг хангах үйл явц юм. Санхүүгийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь эдийн засгийн нөөцийг үр ашигтай байршуулж удирдах, үйлдвэрлэл, үйл ажиллагааны үр ашгийн зорилтын биелэлтийг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэй. Санхүүгийн хяналтыг дотоод ба хөндлөнгийн хяналт гэж ангилна. Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нь тухайн байгууллага, нэгжид мөрдөгдөх дүрэм, журам, ажил үйлчилгээнд мөрдөх горим, стандарт зэрэг эрх актууд бөгөөд дотоод хяналт нь тасралтгүй үйл явц байдаг. Хөндлөнгийн хяналтыг хууль, дүрэм, журмын хүрээнд эрх олгогдсон харьцангуй хараат бус субъектүүд хэрэгжүүлдэг. (Б.Б; А.Э нар)

САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ (*Financial analysis*) Санхүүгийн нөөцийг үр ашигтай удирдах, санхүүгийн үр дүн, хөрөнгө оруулалтын үр ашгийг хэмжих, өнгөрсөн ба одоогийн санхүүгийн үр дүнг харьцуулах, нөхцөл байдалд дүгнэлт хийх, ирээдүйг төлөвлөх, нөөцийн урсгалын талаарх аливаа шийдвэр гаргахад туслах мэдээллээр хангах үйл ажиллагаа. Санхүүгийн шинжилгээний шамгийн түгээмэл хэлбэр нь санхүүгийн тайлангийн шинжилгээ юм. Санхүүгийн шинжилгээнд хөрөнгө, эх үүсвэрийн бүтэц, динамик өөрчлөлтийг тодорхойлох, төлбөрийн чадвар, санхүүгийн тогтвортой байдлыг тодорхойлох, хөрөнгийн эргэц ба ашиглалтын үр ашгийг тодорхойлох, бүтээмжийг тооцох, орлого, үр дүн, ашигт ажиллагааг тооцох, зах зээлийн байр, суурь идэвхжлийг тооцох,

нөөцийн урсгалыг тодорхойлох зэрэг шинжилгээ хамаардаг. Тухайлбал, улс орны хувьд шинжилгээгээр тодорхойлсон санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлт нь хөгжлийн гол үзүүлэлт болох бөгөөд тогтвортой байдалд дотоод эдийн засгийн орчин, санхүүгийн салбарын төлөвшил, хөрш орнуудын эдийн засгийн харилцаа зэрэг хүчин зүйл голлон нөлөөлнө. (Б.Б)

САХИЛГА, ХАРИУЦЛАГА (*Discipline and responsibility*) Өөрийн эрх мэдэл, хяналт, удирдлагад хамаарах зүйлийг хариуцах, дүрэм ёс зүйн дагуу хариуцлага хүлээх, хариуцлага хүлээх чадварыг илэрхийлдэг. Сахилга, хариуцлагын тогтолцоо нь төрийн байгууллага, албан тушаалтны хувьд аливаа шийдвэр, үйл ажиллагааныхаа төлөө иргэд болон бусад талуудын өмнө хариуцлага хүлээх чадвар мөн бөгөөд төрийн албан хаагчийн сахилга гэдэг нь ёс зүйтэй байх, нийгмийн хэм хэмжээг сахих үүргийг сануулдаг бол хариуцлага гэдэг нь өөрийн үйлдэл, үйл ажиллагаандаа ур чадвараа шингээсэн байх, энэ тухайгаа чадварлагаар хариуцах гэсэн утгатай. Монгол хэлний товч тайлбар толь бичигт “хариуцлага”-ыг хариуцах үйлийн нэр, хариуцсан үүрэг, биедээ хариуцах гэж тайлбарласан байна. Төрийн албанд бол төрийн албан хаагч нь дээд зэргийн сахилга баттай, ажил үүргээ гүйцэтгэх чадавхтай байх бөгөөд аливаа хариуцсан үйл ажлаа тайлагнах буюу хариуцлага хүлээх чадвартай байх ёстой. Түүнчлэн хариуцлага бол ёс суртахууныг илэрхийлэх бөгөөд төрийн байгууллагын хувьд “хариуцлага” хэмээх ойлголт нь “хариуцан тайлагнах”, “хариуцан тайлагнах чадвар” зэргээр ажилтан хүлээсэн үүргээ ухамсарлах, биелүүлэх, дагаж

мөрдөх, алдаа дутагдлаа хүлээх гэх мэт цогц үйл юм гэж судлаачид үздэг. (А.Э.ц)

СИСТЕМИЙН АНАЛИЗ (*System analysis*) Системийн анализ нь хэрэгжсэн хөтөлбөрүүдийн үр дүн нөлөөллийг тодорхойлох, тайлбарлахын зэрэгцээ цаашид хэрэгжих хөтөлбөрүүдийн үр дагаврыг урьдчилан таамаглахад хэрэглэгдэж буй арга хэрэгсэл юм. Энэ нь бодлогын салбаруудыг системүүд хэмээн үзээд тэдгээрийн доторх шалтгаан үр дагаврын холбоосыг загварчлах явдал юм. Бодлогын салбар нь нарийн нийлмэл үед системийн анализ нь бүрдэл хэсгүүдийг тодорхойлох, тэдгээр нь хоорондоо хэрхэн харилцан үйлчилж буйг судлах, улмаар бодлогын салбаруудыг илүү сайн ойлгох, тухайн чиглэлээр хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах үйл явцыг чиглүүлдгээрээ бодлого боловсруулагчдад хэрэгтэй байдаг. Энэхүү арга нь оновчтой шийдвэр гаргах онолын үндэс болж байсан бол эдүгээ гүйцэтгэлийн менежмент болон төсөвлөлтөд түлхүү хэрэглэгдэж байна. Бодлогын салбарууд үлэмж нарийн нийлмэл болохын хэрээр дүн шинжилгээ хийх нь төвөгтэй болж, шийдвэр гаргагчдад ирэх цэвэр улс төрийн шахалт дарамт нэмэгдэн, түүнд хариулах шаардлага өсөж системийн шинжилгээний хэрэглээ ач тус нь хязгаарлагдаж ирсэн байдаг. Системийн анализ нь системийн онолоос өөр хэдий ч төрийн бодлого судлалд нийгмийг хэд хэдэн системүүдээс бүрдэн бодлогын суурь асуудал, засгийн газрын бодлогын хөтөлбөрүүд харилцан үйлчилж нийгмийн үзэгдэл, үр дүнг бий болгоно гэж үздэг. Системийн анализын гол шинж чанар бол зөвхөн оршин буй нийгмийн үзэгдлийн шинж

чанаруудыг тодорхойлоод зогсохгүй тухайн үзэгдлийг бий болгосон шалтгааныг олж илрүүлэхийг эрмэлздэгт оршино. Системийн шинжилгээний энэ шинж чанарын үндэс нь бодлогын системүүдийн бүрдэл, холбоо хамаарал, уялдааг судалж, шалтгаант холбоог олж тогтоодог каузел буюу учир шалтгааны онол байдаг. Энэ загвараар нийгмийн үзэгдлүүдийг бий болгож буй суурь асуудлыг тайлбарлаж, тодорхой хөтөлбөрүүдийн нийгэмд үзэгдэлд үзүүлж буй үр нөлөөг тодорхойлоход энэхүү каузел онолыг ашигладаг. Системийн анализын хоёр үндсэн хэрэглээ байна: *Нэгдүгээрт*, нийгмийн тодорхой нэг үзэгдэл нь засгийн газрын олон янзын хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн нөлөө, олон янзын суурь асуудлын үр дагавар хэмээн загварчлах явдал. *Хоёрдугаарт*, тухайн засгийн газрын хөтөлбөр нь тэрхүү олон янзын суурь асуудалтай хэрхэн уялдаж, бусад засгийн газрын хөтөлбөрүүдийн нөлөө нийгмийн үзэгдэлд хэрхэн нөлөөлж буйг загварчлах явдал юм. Эдгээр загварууд шийдвэр гаргагчдад бодлогын асуудлууд, түүний шалтгаан, боломжуудыг мэдэх төдийгүй түүнийг илүү сайн ойлгоход тусалдаг. Гэвч системийн анализ нь бодлогын тухайлсан асуудал, зарим үр дүнг олж харах, хэмжих, нарийвчилсан дүн шинжилгээ хийхэд хязгаарлагдмал шинжтэй. (Б.И)

СИСТЕМИЙН ӨӨРЧЛӨЛТ (*Systemic change*) Системийн өөрчлөлт нэр томьёо нь боловсролын тогтолцоо, дэлхийн хүнсний систем, орон нутгийн хог хаягдлын систем гэх мэт аливаа тогтолцооны өөрчлөлт юм. Системийн нэг талыг өөрчлөх гэж оролдох нь асуудлыг оновчтой шийдэхгүй тул системийг бүхэлд нь

өөрчлөх шаардлагатай. Системийн өөрчлөлт нь улс төр, нийгэм, эдийн засгийн тогтолцооны тогтсон заншил, институцитэй холбоотой системийн бүх хэсгүүдийг хамарсан, тэдний харилцан хамаарлыг харгалзсан өөрчлөлт юм. Системийн өөрчлөлт нь үндсэн бүтэц, системийг ажиллуулах механизмыг өөрчлөх замаар байнгын өөрчлөлтийг бий болгох зорилготой юм. Үүнд бодлого, дэг журам, харилцаа, нөөц, хүчний бүтэц, үнэт зүйлс багтана.⁴ Системийн өөрчлөлт нь нийгмийн асуудлыг шийдвэрлэх цорын ганц арга зам биш боловч тэдгээрийг ойлгох, үнэлэх, өөрчлөлтөд хүрэх зарчмуудыг тодорхойлох боломжийг олгодог. (З.А)

СИСТЕМИЙН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА (*Systems technical requirements*)

Программ хангамж хөгжүүлэлт, системийн инженерчлэлийн ажлын хүрээнд хэрэглэгчийн хэрэгцээ, стандартыг хангахад системээс хүссэн үйл ажиллагаа, төлөв байдлыг үзүүлэхэд шаардлагатай хүчин зүйлсийн бүрдэл. Байгууллага нь өөрийн хэрэгцээнд систем захиалан хийлгэх болон худалдан авахад системийн техникийн шаардлагыг хэр судалгаа сайтай сайн боловсруулснаас захиалагч, нийлүүлэгчийн ойлголцлын зөрүү бага үүсэж хугацаандаа хүссэн системээ хүлээн авах нөхцөл бүрддэг. Төрийн байгууллага нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулиар тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод системийн техникийн системийн шаардлагыг тусгадаг. (Д.3; Ч.Л нар)

⁴ Taylor, B. (2016). *Systems and Systemic Change – Clarity in Concept, Briefing Paper*. The Springfield Centre, p. 2.

СИСТЕМИЙН ҮЗҮҮЛЭЛТ (*System specification*)

Системийн үзүүлэлтийн болон ажиллагааны шаардлагын тодорхойлолт. Мэдээллийн системийн хувьд системийн бүрэлдэхүүн хэсэг, бүтээгдэхүүн, үр дүн, үйлчилгээний шаардлага, дизайн, бусад шинж чанаруудын талаар бүрэн, нарийвчлалтай, баталгаажуулсан мэдэгдэл; заалтууд хангагдсан эсэхийг тодорхойлох журмыг хэлнэ. Аливаа байгууллага программ хангамж эсвэл компьютер худалдан авах тохиолдолд системийн үзүүлэлтийг үнэлгээний явцад шалгаж, худалдан авах гэрээний явцад баталгаажуулдаг. Төрийн байгууллагын хувьд байнга худалдан авдаг системийн хувьд жишиг үзүүлэлтийг тодорхойлсон заавартай байх нь үр дүнтэй арга юм. (Д.З; Ч.Л нар)

СОЁЛЫН ХЭМ ХЭМЖЭЭ (*Cultural norms*)

Соёл нь Латин хэлний “cultura” буюу “газар хагалах, тариалах, боловсруулах” гэсэн үгнээс үндэстэй. Хэм хэмжээ (norm) нь Франц хэлний “norme” буюу “стандарт, загвар, тогтоосон хэм хэмжээ” гэсэн утгыг илэрхийлдэг. Соёл нь нийгмийн хөгжлийн явцад хүн төрөлхтний бүтээсэн эд баялаг, оюун ухааны ололтын цогц бөгөөд энэ нь нийгмийн хөгжлийн түвшинг харуулдаг. Соёлын хэм хэмжээ нь хүний нийгэмд дагаж баримтлах ёс зүйн стандарт, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүсийн зан үйлийн хүлээлт юм. Соёлын хэм хэмжээ нь хүмүүсийн итгэл үнэмшил, үнэт зүйлсийн цогцоор тодорхойлогддог бөгөөд энэ нь уламжлагдаж байдаг зан үйл юм. Учир нь соёлын хэм хэмжээ нь тодорхой бүлэг хүмүүсийг тухайн нийгэмд төлөвшүүлэх, хөгжүүлэх үүргийг гүйцэтгэдэг хүмүүс хоорондын нийгмийн харилцааг зохицуулах жам ёсны арга хэрэгсэл болдог. (Т.Т)

СОЛОНГОСЫН ЗАХИРГААНЫ УЛАМЖЛАЛ (*Korean administrative tradition*)

Солонгосын нутаг дахь анхны улсыг н.т.ө. ХХIY-XII зууны үед Тангун гэгч байгуулсан хэмээн домоглодог. Гэвч YII зууны эхээр нэгдмэл Силла Улсын үед олон салбар бүхий төрийн аппарат, байнгын арми буй болжээ. Тус улс 9 муж (чу), 5 жижиг нийслэл (соген), 116 тойрог, 293 сумаас бүрдэж байжээ. Төрийн хүрээнд Күнзийн сургаал их нөлөөтэй байсан ба бурхны шашны сүм хийд төрийн ёслол зэрэг зарим ажилд оролцдог байв. 682 онд түшмэдүүдийг бэлтгэх Күнзийн сургууль байгуулагдсан ба 788 оноос түшмэл болох хүмүүсээс шалгалт авдаг болжээ. Шалгалтын үеэр Хятадын сонгодог зохиолын мэдлэгийг гол болгодог байжээ. Силлагийн дараа буй болсон Корё Улс X зууны эцэс гэхэд захиргааны нэгдмэл систем буй болгож салан тусгаарлах оролдлогыг хазаарласан байна. XI зуунд төвлөрлийг хүчтэй болгосон захиргааны шинэ системийг нэвтрүүлж, түшмэдийн нэг хэв маягийн системийг нэвтрүүлсэн байна. “То” хэмээх шинэ мужлалтай болсон ба тэр нь жижиг нэгжүүдэд хуваагдах болсон байна. XIY зууны эцсээр Чосон улсын эрин үе эхэлжээ. “Төрийг захирах их хууль” (Кенгук тэчжон)-ийг тогтоож төв, орон нутгийн захиргааны реформ хийсэн байна. Төрийн зөвлөл (Ыйджонбу) төрийн дээд эрхийг барих болж, түүнд захирагддаг тус бүр өөрийн чиг үүрэг бүхий 6 танхимыг буй болгосон байна. Улс 8 муж, 350 сумтай болжээ. Төр газрыг өмчлөхийн зэрэгцээ, цэргийн болон төрийн албан хаагчдад зэрэг дэвийг нь харгалзан газар олгож байжээ. Тэдгээр нь улмаар харьяа тариачиддаа хуваан өгч тариалан эхэлдэг байжээ. Тэр үеэс хойш Солонгосын оюун санааны

хүрээнд бурхны шашны нөлөө багасаж күнзийн сургаал давамгайлах болсон байна. Күнзийн сургаалын сургуулиуд олноор байгуулагдаж төрийн албан хаагчдыг бэлтгэдэг болжээ. (А.Ц)

СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО (*Electoral system*)

Сонгуулийн тогтолцоог ихэвчлэн санал өгөх систем гэж нэрлэдэг бөгөөд төрийн төлөөллийн байгууллагад нэр дэвшигчдийг сонгох ажлыг системчлэн явуулж буй арга юм. Өргөн утгаараа сонгуулийн тогтолцоо нь сонгууль явуулах, санал авах, дүн гаргах, парламентын суудал хуваарилахад чиглэсэн арга, дүрмүүдийн нийлбэр цогцыг хэлнэ. Хамгийн энгийн утгаараа аливаа сонгуульд иргэдийн өгсөн саналыг нам, нэр дэвшигчдийн авах суудлын тоонд шилжүүлэх арга зам ч гэж хэлдэг. Эдгээр тодорхойлолтуудаас сонгуулийн тогтолцоог тодорхойлох гол үзүүлэлтүүд нь сонгуулийн тогтолцооны хувилбар, суудал хуваарилах томьёо, саналын хуудасны бүтэц, сонгуулийн тойргийн цар хүрээ зэргийг багтаадаг. Эдгээр үзүүлэлтүүд нь аливаа нэг сонгуулийн тогтолцоо бусад хувилбаруудаас ялгагдах хэмжүүр нь болно. Тиймээс улс орнуудын сонгуулийн тогтолцоо болон сонгуулийн тухай хуулийн зохицуулалтаас хамаарч сонгуулийн үр дүнгүүд харилцан адилгүй. Сонгуулийн тогтолцоо нь сонгуулийн хуулийн зохицуулалтад шууд нөлөөлөх бөгөөд сонгуулийн тогтолцооны ямар хувилбарыг сонгож авснаас шалтгаалаад тойргийн хил хязгаар тогтоох арга, сонгогчдыг бүртгэх байдал, саналын хуудасны бүтэц, санал тоолох ажиллагаа болон бусад сонгуулийн олон асуудал янз бүрээр шийдэж, зохицуулагддаг. Сонгуулийн тогтолцооны хувилбараа

зөв сонгох нь тухайн улс орны улс төрийн харилцааны гол дүрмийг буюу тоглоомын дүрмээ тодорхойлж байна гэсэн үг. Иймд сонгуулийн тогтолцооны талаар шийдвэр гаргахад юуны өмнө ямар үр дүнд хүрэх, юунаас зайлсхийх, ямар хэв шинжтэй хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалтай байх эрмэлзэл зэргээ эрэмбэлж шалгууруудаа үнэлэх нь хувилбар сонгох зөв арга юм. Сонгуулийн тогтолцооны олон хувилбар байдаг ч, мажоритар буюу олонхын, пропорционал буюу хувь тэнцүүлсэн эсвэл холимог буюу аль алиных нь шинжийг агуулсан гэж гурван ерөнхий ангилалд авч үздэг. Сонгуулийн тогтолцоо бол зөвхөн төр дээд байгууллагыг бүрдүүлэх арга зам төдийгүй төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, бодлого, шийдвэр гаргах үйл явцад нөлөөлж, нийгэмд оршиж буй зөрчлийг зохицуулах арга хэрэгсэл. Сонгуулийн тогтолцооны онцлог нь төрийн үйл ажиллагаа явуулах тогтвортой, хариуцлагатай, хяналттай, бүтээмжтэй байх бусад шалгуурт нөлөөлж, төрийн албан хаагчидтай хамтран ажиллах, эвлэрэн зохицох, төрийн бодлогыг нийтэд хүртээмжтэй болгох нөхцөл болдог. Мөн төрийн захиргааны байгууллагууд нь сонгуулийн үйл явцад төвийг сахиж, сонгуулийн өмнөх болон дараах өрсөлдөөн, маргаанд үл оролцох зарчим нь дэлхийн улс орнуудад түгээмэл хэрэгжсээр ирсэн. (Я.Т)

СОНГУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ (*Electoral reform*)

Сонгуулийн шинэчлэл нь сонгуулийн эрх, парламентын суудлын тоо, сонгуулийн тойрог дахь суудлын квот, суудал хуваарилах, ялагчийг тодруулах томьёонд өөрчлөлт оруулах тухай асуудал юм.

Дэлхийн улс орнууд сонгогчдын санал гээгдэх, жендэрийн харьцаа, сонгуулийн луйвар, хүн ам зүй, улс төрийн тогтолцооны өөрчлөлт зэрэг олон шалтгааны улмаас сонгуулийн тогтолцоонд шинэчлэл хийдэг. Итали Улс 1993 онд олон нийтийн санал асуулга зохион байгуулснаар хувь тэнцүүлсэн тогтолцоонд шилжсэн түүхээс хойш олон улсад сонгуулийн тогтолцооны шинэчлэлүүд эхэлсэн байдаг. Шинэчлэлийн явцад суудал хуваарилах аргаа солих, сонгуулийн тойргуудыг өөрчлөн зохион байгуулах, хууль тогтоох байгууллагад суудал нэмэх зэрэг олон өөрчлөлтүүд хийгдсэн байна. Улмаар 20 гаруй улс сонгуулийн тогтолцоогоо бүрэн шинэчилжээ. Шинэчлэлийн явцад олонхын тогтолцоотой орнууд холимог, эсвэл хувь тэнцүүлсэн загварт шилжсэн байна. Сонгуулийн тогтолцооны нийтлэг 10 гаруй сонгодог хувилбар бий боловч улс бүр сонгуулийн тогтолцоог хэрэглэхдээ өөрийн орны онцлог, нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшин, улс төрийн тогтвортой байдал, иргэдийн зан төлөв, үйл байдал зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үздэг. Улс орнуудын хувьд сонгуулийн тогтолцоогоо өөрчилж байгаа өөр нэг шалтгаан нь сонгогчдын идэвх оролцоо буурч байгаатай холбоотой. Сонгуулийн идэвх оролцоо жил бүр буурч байгаатай холбоотойгоор сонгуульд оролцож санал өгөх насыг Австри, Бразил, Шотланд, Аргентин зэрэг оронд 16 нас, Индонез, Суданд 17 нас болгон бууруулжээ⁵. Орчин үед мэдээлэл харилцааны технологи эрчимтэй хөгжиж байгаатай холбоотойгоор саналын хуудсыг санал тоолох машин ашиглан тоолж байна. Энэтхэг Улс

2004 оноос, Филиппин Улс 2010 онд сонгуулиа автомат машинаар тоолсон нь хугацаа хэмнэж, иргэдийн сонгуульд итгэх итгэл ч дээшилсэн нь судалгаагаар нотлогдсон. Монгол Улсын сонгуулийн шинэчлэлийн хүрээнд 1992 оноос хойш олонхын тогтолцооны хоёр өөр хувилбараар 6 удаа, намын нэрсийн жагсаалтаар хувь тэнцүүлэн сонгох болон тухайн тойрогт хамгийн олон санал авсан нь сонгогдох олонхын хосолсон параллель тогтолцоогоор 1 удаа сонгууль явуулжээ. Энэ хугацаанд саналын хуудсыг автомат машинаар тоолох, ТББ-ууд санал авах үйл ажиллагааг ажиглах, эмэгтэй нэр дэвшигчдийн квот тогтоож өгсөн зэрэг дэвшилтэт өөрчлөлтүүд гарсан. Эмэгтэй нэр дэвшигчдийн тоо сонгуулиас сонгуульд тодорхой хэмжээнд өссөн. Сонгуулийн шинэчлэлийн хүрээнд суудал хуваарилах аргууд олон янз хувилбартай хөгжиж байна. Нээлттэй нэрсийн жагсаалтын хувь тэнцүүлсэн тогтолцоонд суудал хуваарилах олон аргууд бий. Үүнд: Хамгийн их дунджийн арга (Хондтын арга – D'Hondt method, Жеферсоны арга – Jefferson's method), Хамгийн их үлдэгдлийн арга (Хейрийн квот – Hare quota, Друпын квот – Droop quota) юм. Аль аргыг ашигласнаас хамаарч парламент дахь намуудын суудлын хуваарилалт ялгаатай гардаг. (Ж.Ж)

СОНГУУЛЬ (*Elections*) Сонгууль нь иргэдийн дунд санал хураалт явуулах замаар хоёр ба түүнээс дээш тооны нэр дэвшигч, улс төрийн нам, эвслээс улс төрийн сонголт хийх явдал юм. Анхны сонгууль нь эртний Афин, Ромд болж байв. Орчин үед сонгууль нь иргэдийн зүгээс төрийн өндөр албан тушаалтнууд, улс төрчдөд хариуцлага хүлээлгэх, хянах гол

5 <https://www.idea.int/data-tools/question-view/130355>

арга хэрэгсэл болсон. Ардчилсан засаглалын хөгжилд сонгууль чухал үүрэгтэй байдаг. Улс орон бүр өөрийн онцлогт тохирсон сонгуулийн тогтолцоотой бөгөөд тэр нь ардчилсан нийгэмд иргэдийн эрх чөлөөний баталгаа болж улс төрийн системийн эргэх холбоонд хяналтыг бүрдүүлэх боломжийг олгож, улс төрийн намын хөгжилд голлох үүргийг гүйцэтгэдэг. Сонгууль нь төрийн эрх мэдлийн легитим буюу хүлээн зөвшөөрөгдөх байдлыг бэхжүүлж, улс төрийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй, иргэдэд улс төрд оролцох, өөрийн үзэл бодлоо илэрхийлэх боломжийг олгож өөрийгөө үнэлэх, хүндэтгэх байдлыг бэхжүүлдэг. Сонгуулийн кампанит ажлын үед иргэдийн улс төрийн идэвх, оролцоо сэргэж, нэмэгддэг бөгөөд улс орны өнгөрсөн хугацаанд олсон ололт амжилт, алдаа, оноог цэгнэх, ирээдүйд хийх бүтээн байгуулалт, хөгжлийн бодлогыг хэлэлцэх боломж бий болдог хэдий ч сонгууль нь тэр бүр ардчилсан зарчмаар явагддаггүй. Дарангуй дэглэмтэй орнуудад ардчилсан бус сонгууль явагдах нь түгээмэл үзэгдэл. Ардчилсан сонгуулийн гол зарчим нь бүх нийтээр оролцох, эрх тэгш оролцох, саналаа шууд, чөлөөтэй, нууцаар гаргах явдал юм. Сонгууль явуулах, зохион байгуулах, санал авах, дүнг бодож тооцоолох олон арга хувилбарууд байдаг. Эдгээрээс хамгийн түгээмэл нь олонхын болон хувь тэнцүүлэх сонгуулийн систем юм. Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн (IDEA) судалгаа: нэрсийн жагсаалтаар сонгох хувь тэнцүүлсэн тогтолцоог 86 улс, олонхын тогтолцоог 60 улс, параллель тогтолцоог 24 улс, хоёр шатлал бүхий тогтолцоог 18 улс, блок саналыг 15 улс, холимог хувь тэнцүүлсэн тогтолцоог 8 улс хэрэглэж

байна⁶ гэжээ. Олон улсын чиг хандлага нь нээлттэй нэрсийн жагсаалт болон олонхын саналын тогтолцоог хэрэглэж байна. Улс орнууд сонгуулийн ямар тогтолцооны аль хувилбарыг сонгосноос шалтгаалан улс төрийн намын систем уялдан төлөвшдөгийг онцлох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, сонгуулийн тогтолцоо нь улс төрийн намын тогтолцооны төлөвшилд нөлөөлдөг гол хүчин зүйл болдог. Хувь тэнцүүлсэн тогтолцоо нь хоёр намын тогтолцоо руу, олонхын тогтолцоо нь хоёр хүчирхэг намын тогтолцоо руу хөтөлдөг. Монгол Улс Их Хурлын сонгуулийг 1992, 2008, 2020 онд олон мандаттай томсгосон тойрог бүхий олонхын тогтолцоогоор, 1996, 2000, 2004, 2016 онуудад нэг мандаттай тойрог бүхий олонхын тогтолцоогоор, 2012 оны сонгуулийг 2011 онд баталсан 48/28 бүхий сонгуулийн холимог тогтолцоогоор тус тус зохион байгуулжээ. (Ж.Ж)

СОНИРХЛЫН БҮЛЭГ (*Interest group*)

Сонирхлын бүлэг “interest group” хэмээх нэр томьёонд “сонирхол”, “бүлэг” хэмээх хоёр утга санаа агуулагддаг. “Сонирхол” гэсэн санаа илүү бүлгийн улс төрийн агуулга, ойлголтыг тодорхойлж, ижил эрх ашиг, сонирхол, нэг зорилготой байгааг илэрхийлдэг. Бүлэг нь хоорондоо эвлэлдэн нэгдсэн хоёр ба түүнээс дээш тооны хүмүүс байгааг илэрхийлдэг тул нэг эрх ашиг, адил сонирхлын улмаас хамтран үйл ажиллагаа явуулж буй хоёр ба түүнээс дээш тооны хүмүүсийг илэрхийлсэн ойлголт юм.

Сонирхлын бүлгийн судалгааг ихэнхдээ улс төрийн оролцоо, сонгууль, сонгуулийн улс төр, түүний кампанит ажлуудтай холбоотой

⁶ <https://www.idea.int/data-tools/question-view/130355>

судалдаг. Америкт сонирхлын бүлгийн нийтлэг ойлголт нь улс төрд нөлөөлөх засгийн газрын бус байгууллага гэж тодорхойлсон байдаг. Харин Япон болон Европын орнуудад сонирхлын бүлгийн судлагдахуун нь төр болон нийгмийн хоорондын уялдаа холбоог тайлбарлах улс төрийн эдийн засгийн ухааны хэлбэр болох талаас нь авч үздэг. Сонирхлын бүлэг нь засаглалын үйл ажиллагаанд төртэй хамтрагчийн байр суурьтай байж, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох боломжтой гэж үздэг. Сонирхлын бүлгийн утга агуулга нь амбиц, шахалтын бүлэг, ашиг сонирхлоороо нэгдсэн бүлэг, улс төр болон засаглалд нөлөөлөх бүлэг гэх мэтээр тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаарх ойлголт зонхилдог. Орчин үед сонирхлын бүлгийн хэв шинж өөрчлөгдөж өвөрмөц сонирхол, зорилго, эрмэлзэл бүхий нийгмийн болон хүн ам зүйн тодорхой бүлэгт тулгуурлах олон чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Тухайлбал:

- Сонгуулийн кампанит ажлын үед аль нэг нам, эвсэл холбоо, нэр дэвшигчийн төлөө өөрсдийн гишүүд дэмжигчийг зохион байгуулан оролцох, хөрөнгө санхүүгийн дэм-жлэг тусалцаа үзүүлэх,
- Төр, түүний байгууллагуудтай хамтран ажиллах,
- Олон нийтийн санаа бодолд нөлөөлөх, тэдний дэмжлэгийг авах,
- Хэвлэлмэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах,
- Төр засагт хандсан шаардлага хүргүүлэх, шахалт үзүүлэх,
- Ухуулга сурталчилгаа хийх,
- Гадаад, дотоодын ижил төстэй байгууллагуудтай холбоо тогтоож

ажиллаж, тэдний дэмжлэгийг олох зэрэг үйл ажиллагаа явуулдаг. (Я.Т)

СОНИРХОЛ (*Interest*) Сонирхол нь хүний ухамсарлагдсан хэрэгцээ. Хүн аливаа юмс үзэгдэлтэй учрахдаа юуны өмнө түүнийг танин мэдэх өөртөө ашигтай эсэх, зорилгодоо хүрэхэд түүнийг ашиглаж болох эсэхийг тодруулахыг хичээдэг. Сэтгэл судлалын үүднээс: хүний танин мэдэхүйн үйл явц юм. Хүний сонирхол түр зуурын ба тогтвортой гэсэн 2 янз байж болно. Сонирхлын энэ хоёр янз байдал нь өөр хоорондоо харилцан шүтэлцээтэй байх бөгөөд түр зуурын сонирхлоос байнгын тогтвортой сонирхол буй болно. (Ц.Д)

СОЦИАЛ ДЕМОКРАТ ҮЗЭЛ (*Social democracy*) Социал демократ үзэл баримтлал нь “нийгмийн ардчилал” гэж монгол хэлээр хөрвүүлэгддэг. Эрх чөлөө, шударга ёс, эвсанааны нэгдэл нь нийгмийн ардчиллын гол үнэт зүйлс нь юм. Нийгмийн ардчилал нь эдгээр үнэлэмжүүд хэрэгжсэн нийгмийг байгуулахыг зорьж, үнэт зүйлс нь ач холбогдлын хувьд эн тэнцүү, нэг нь нөгөөгийнхөө хэрэгжих нөхцөлийг бүрдүүлдэг харилцан шүтэлцээтэй, бие биенээ дэмжиж мөн хязгаарлаж байдаг онцлогтой. XX зууны эхээр марксизмын эрс хувьсгалт шинж, үл эвлэрэх байдлыг шүүмжлэн гарч ирсэн улс төрийн үзэл баримтлалын нэг. Үндэслэгчид нь Э.Бернштейн, К.Каутский, К.Маркс, Р.Гильфердинг, Ж.Кенс зэрэг олон эрдэмтдийг дурдаж болно. Капитализмыг илүү шударга нийгмийн байгууллаар халах ёстой, гэхдээ хувьсгалт хүчирхийллийн аргаар хийхийг үгүйсгэдэг. Үзэл санааны гол баримталдаг зарчмууд нь:

- Тавьсан зорилтыг ардчилсан тайван арга замаар хэрэгжүүлэх,
- Хүмүүнлэг үзэл санаа, байр суурийг дээдлэх,
- Аливаа асуудалд олон нийтийн ашиг сонирхлын үүднээс хандах,
- Хамт олны үзэл санааг дээдлэх,
- Парламентаг ёсыг бэхжүүлэх,
- Улс орнуудын эв нэгдлийг хангах,
- Олонургалч байдал хөгжүүлэх нь уг үзэл санааны гол агуулга юм.

Дээрх үзэл санааны хүрээнд нийгмийн бүлэг давхаргын хоорондын зөрчлийг зөвшилцөх аргаар шийдэж, нийгмийн хамгааллыг сайжруулж, ажиллагсдын санаачилгыг чухал хэмээн үздэг. Нийгмийн ардчиллын зорилтуудыг хангахын тулд эдгээр гурван зарчмыг эдийн засгийн бодлогод тэгш эрхтэйгээр харгалзан үзэх ёстой. Ийнхүү дээрх гурван зарчмыг тэгш эрхтэйгээр харгалздаг тул нийгмийн ардчилал нь зөвхөн нэг үзэл санаа, үнэт зүйл дээр төвлөрдөг либертари үзлийг баримтлагсад болон зүүний популистуудаас ялгардаг. (Я.Т)

СОЦИАЛИЗМ (*Socialism*) Социализм нь латин хэлний *Socialis*, франц хэлний *Socialisme* - нийгэм, нийгмийн гэсэн утгатай үгнээс үүссэн. Социализм нь *нэгдүгээрт*, хүн төрөлхтний түүхэнд анх удаа нийгмийн шударга ёс, эрх чөлөө, тэгш байдлыг хангаж хэрэгжүүлэх, хүн хүнийг эдийн засгийн хувьд мөлжих, улс төрийн хувьд дарангуйлах, нийгмийн хувьд дарлах, оюун санааны хувьд мунхруулан төөрөгдүүлэх явдлыг устгаж, даван туулах замаар нийгээрээ зол жаргалтай, хүнлэг сайхан нийгэм байгуулахыг үндсэн гол зорилго, эрхэмлэл болгож тунхагласан үл гүйцэлдэх чанартай нийгмийн онол, сургаалын цогцлол,

хоёрдугаарт, энэхүү онол, сургаалыг нийгэм - улс төрийн социалист хувьсгал ба өргөн хүрээний социалист өөрчлөн байгуулалт хийх язгуур чанартай арга зам бүхий нийгмийн инженерчлэлээр амьдрал практикт хэрэгжүүлэх оролдлого, нийгмийн туршилт хийсний үр дүнд хуучны ЗХУ болон дэлхийн арав гаруй бусад оронд XX зуунд бий болж оршин тогтнож байсан нийгмийн социалист байгуулалт юм гэсэн үндсэн хоёр утгаар ойлгож хэрэглэдэг. Социализм онол, сургаалын хувьд XIX зууны хоёрдугаар хагаст Европт либерализм ба капиталист нийгмийн шүүмжлэл болж үүсжээ. Социализм нь өмч, байгалийн баялаг нь хувьд биш, харин нийтийн өмчлөлд байх ёстой гэж үздэг. Социализм үүсэх урьдач нөхцөл нь Их Британийн аж үйлдвэрийн, Францын хөрөнгөтний хувьсгал байв. Гэхдээ Эртний Грек, түрүү үеийн Христийн сургаалд эд хөрөнгө, ажил үүргээ дундаа хуваалцах тухай үзэл санаа гардаг. Социализм нь либерализмтай харьцуулахад өөр өөр утга агуулга, үзэл санаа бүхий олон хувилбартай гэрч иржээ. Гэхдээ тэдгээр бүх хувилбар нь дэлхий ертөнцөд капитализмаас өөр хамтач үзэл, эгалитаризмийн зарчим дээр суурилсан, нийгэм ямар байгаа, ямар болох, ямар байвал зохих тухай үзэл санааг гол чиг шугам болгож байснаараа нийтлэг утга агуулгатай байв. Социализмын онолыг үндэслэн боловсруулсан сэтгэгчдээс хамгийн алдартай нь К.Маркс бөгөөд тэрээр Ф.Энгельстэй хамтран 1848 онд бичсэн “Коммунист намын тунхаг” бүтээлд социализм, коммунизмын тухай онолын үндсийг бүрэн томьёолон гаргасан байдаг⁷. Тэрээр социалист хувьсгал бол шинэ нийгэмд

⁷ Маркс К.Энгельс Ф. Коммунист намын тунхаг. Улаанбаатар, 1968.

хүрэх гол арга зам гэж үзсэн. Марксын социализмын онолын араас Христийн социализм, анархи - коммунизм, Фабианы социализм, ардчилсан социализм зэрэг олон урсгалууд гарсан байна. 1970-аад оноос хойш социализмын онол ба практик нь хүчтэй шүүмжлэлд өртөж 1989 онд Зүүн Европ, улмаар ЗХУ-д коммунист тоталитар дэглэм нуран унаснаар урьдын хүч нөлөөгөө алдсан юм. Орчин үед социализмын үзэл санаа Скандинавын хойгийн орнуудын Нордик загварт зарим талаар туссан байдаг. Түүнчлэн Латин Америкийн орнуудад Венесуэлийн Ерөнхийлөгч асан Уго Чавес, Никарагуагийн Ерөнхийлөгч Д.Ортега, Боливийн Ерөнхийлөгч асан Эво Моралес зэрэг социалист чиг баримжаатай төрийн тэргүүнүүд улс орноо удирдаж байв. Социализмын уламжлалт үзэл санаа орчин үеийн даяаршсан нийгмийн хөрсөнд шингэхэд бэрхшээлтэй болсон ч зах зээлийн эдийн засаг дахь төрийн оролцоог нэмэгдүүлэх, өмчийн хяналтын тухай үзэл санаа оршоор байна. В.И.Ленин тэргүүтэй оросын большевик хувьсгалчид 1917 онд Орос оронд төрийн социалист хувьсгалаар засгийн эрхийг булаан авч улмаар нийгмийн амьдралын өргөн хүрээнд язгуур чанартай социалист өөрчлөн байгуулалт хийснээр тус оронд зөвлөлтийн хэв маягтай социалист нийгэм байгуулагдаж 1991 он хүртэл 70 гаруй жил оршин тогтносон юм. Социалист өөрчлөн байгуулалтын гол зорилго, үндсэн чиглэлүүд бол пролетарийн диктатур тогтоож улмаар ардын төр засаг байгуулах, хувийн өмчийг устгаж нийгэм, нийтийн өмч бий болгох, хөдөө аж ахуйг хамтралжуулах, улсын аж ахуйг нэгдмэл удирдлагаар төвлөрсөн төлөвлөгөөгөөр удирдаж хөгжүүлэх, социалист соёлын

хувьсгал хийх, хүн ардыг социалист үзэл ухамсартай болгож зөвлөлтийн хүнийг төлөвшүүлэн хүмүүжүүлэх, коммунист нам нийгэм, төрийг удирдан жолоодох зорилтуудыг хэрэгжүүлэх явдал байв. Эдгээр зорилт бодитой хэрэгжжээ. Харамсалтай нь тэдгээрийн эцсийн үр дүн, мөн чанар нь асар их гажуудалтай, сөрөг үр дагавартай байв. ЗХУ-д хэрэг дээрээ төрийн өмчийн монополь хэлбэр бий болж ноёрхсон, нам төрийн аппаратын дээд давхрааны ноёрхол, дэглэм тогтож ардчилал хумигдсан, нийгмийн амьдралын бүх хүрээ салбарт удирдлагын нэг төвөөс захиран тушаах арга хэлбэр тогтсон, иргэдийн шашин шүтэх эрх чөлөө хязгаарлагдсан, үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэж нэгдэх, жагсаал цуглаан зохион байгуулах эрх, эрх чөлөө боогдмол байдалтай болсон байна. ЗХУ-ын эдийн засаг, цэрэг - улс төр, үзэл суртлын хүч нөлөөгөөр дэлхийн арав гаруй оронд ХХ зууны хоёр дахь хагаст мөн адил социалист байгуулал бүрэлдэн тогтож байв. Түүний гол шинж, мөн чанар нь ЗХУ-д байгуулагдсан социалист нийгмийнхтэй үндсэндээ адил байв. Орчин үед социализмын үзэл санаа ямар нэг хэлбэр, илрэлээр оршоор байгаа боловч социализм нь нийгмийн байгуулал болохын хувьд нийгэм - түүхийн туршилт, практикаас арилан буужээ. (Ж.Ж)

СОЦИОЛОГИЧ (*Sociologist*) Энэ мэргэжлийн нэрийн гарал үүсэл нь “socius” социологи буюу нийгэм гэсэн утгатай. Латин хэлний socius (“хамтрагч” эсвэл “холбоо”) гэсэн үгэнд Грек хэлний λόγος, logos -ологи “мэдлэг” гэсэн үгнээс “судлах” гэсэн утга оржээ. Социологи гэдэг үгийг 1830 онд Францын философич Исидор

Огюст Конт (1798-1857) гаргасан. Анхны эмэгтэй социологич Харриет Мартино (1802-1876), марксист социологийн үндэслэгч Карл Маркс (1818-1883) юм. Социологич нь нийгмийн харилцаа, тэдгээрийн зүй тогтол, хөгжил, хүмүүсийн хоорондох харилцаа, нийгмийн бүтэц, зохион байгуулалт, хувь хүн ба нийгмийн хоорондын харилцааг судалж, нийгмийн нөхцөл байдалд дүгнэлт хийх, удирдлагын ашигтай хэлбэр сонгох гэх мэт өргөн хэмжээний ажлыг гүйцэтгэнэ. Нийгэмд тулгамдсан асуудлыг судлан тэдгээрийг шийдвэрлэх арга зам, шийдлийн загварыг тодорхойлж нийгмийн бүхий л давхаргын гишүүдийн дунд төрөл бүрийн сэдвээр судалгаа хийн хүний зан байдал, хамтын харилцаа, зохион байгуулалтыг судлахаас гадна нийгэм, шашин, улс төр, эдийн засгийн бүлэг, байгууллага, байгууллагуудын үйл ажиллагааг ажиглахаас гадна нийгмийн нөлөөлөл, түүний дотор байгууллага, хувь хүн, бүлэгт хэрхэн нөлөөлж буйг судалж үздэг. Социологийн шинжлэх ухаан нь хүний нийгмийн үүсэл, хөгжил, зохион байгуулалт, нийгмийн харилцааны үндсэн хууль, институц гэх мэт үйл ажиллагааны талаар судлахын зэрэгцээ шинжлэх ухааны баримтаг судалгааг хөгжүүлдэг судалгааны шинжлэх ухаан мөн. (А.Э.ц)

СОЦИАЛ ТӨЛБӨР (Social payment)

Нийгмийн сүлжээний бүртгэл болон гар утасны дугаараар банкны нэмэлт мэдээлэл оруулахгүйгээр хувь хүн эсвэл байгууллагад хоромхон хугацаанд шилжүүлэх төлбөрийн нэгэн хэлбэр. Социал төлбөрийн чиг хандлагыг Пэй Пал (PayPal) компаниас анх нийтийн хэрэглээ болгож улмаар бусад технологийн

тэргүүлэх компаниуд Гүүгэл Воллет (Google Wallet), Айпэл Пэй (Apple Pay), Твиттер Бай (Twitter Buy) г.м өөрсдийн хувилбарыг гаргасан. Монголд банкны болон үүрэн холбооны оператор компаниуд энэ төрлийн төлбөрийг хэрэглээнд нэвтрүүлж эхлээд байна. (Д.З; Ч.Л нар)

СӨРГӨЛДӨӨН (Conflict) Хоёр буюу түүнээс дээш талуудын хүсэл, хэрэгцээ, эрхэмлэн дээдлэх зүйлс нь хоорондоо таарч тохирохгүй буюу ямар нэг арга замаар нэг нь нөгөөдөө саад учруулсан нөхцөл байдлыг хэлнэ. Хувь хүн буюу бүлэг хувийн сонирхлынхоо дагуу эрж хайсан, өөрсдийн сонирхсон, хүссэн зүйлээ олж аваагүй үед тохиолддог. Сөргөлдөөн нь ил ба далд хэлбэртэй байж болно. Харин хэд хэдэн өөр төрөлтэй байдаг. Тухайлбал, хувь хүний дотоод сөргөлдөөн, хүмүүс хоорондын сөргөлдөөн, бүлэг хоорондын сөргөлдөөн, улс орнуудын хоорондох сөргөлдөөн гэж хуваан авч үзэж болно. Байгууллагад санал бодлын зөрөө, сонирхол ялгаатай байдал, асуудал дутуу, эсхүл буруу ойлгосноос болж сөргөлдөөн гарах нь элбэг байдаг. Сөргөлдөөн нь асуудлыг илрүүлж шийдвэрлэдэг, ажил хэрэг явуулах илүү сайн арга олохын төлөө эрэл хайгуул хийхэд хүргэдэг зэрэг сайн талтай. Гэвч зөрчил, сөргөлдөөнийг шийдвэрлэхгүй байх нь байгууллагын дотоод харилцаанд муугаар нөлөөлдөг. (Ц.Д)

СӨРГӨЛДӨӨНИЙ УДИРДЛАГА (Conflict management)

Тодорхой ажил, зорилгод саналын зөрүүтэй оролцогч талуудын үзэл бодол дээр тулгуурлан сайжруулалт хийх үйл явц буюу сөрөг зөрчлийг эерэг тал руу нь хөтлөх стратегийг

хэрэгжүүлэхтэй холбоотой үйл явц гэж ойлгож болно. Тус удирдлагын зорилго нь асуудлыг шийдэх замаар тасралтгүй суралцах, бүтээмжийг байнга дээшлүүлэхэд чиглэгддэг. Зөрчлийг бүтээлч ба бүтээлч бус гэж ангилна. Байгууллагын зорилгыг хэрэгжүүлэхэд эерэг нөлөөтэй зөрчлийг бүтээлч бус гэнэ. Удирдлагын үүрэг бол бүтээлч бус зөрчлийг бүтээлч болгож хувиргах, улмаар шийдвэрлэх явдал юм. Зөрчлийг шийдвэрлэх таван янзын арга барилыг судлаачид ялган үзсэн байна. *Нэгд*, Хүчээр шийдэх арга: хамтран ажиллахыг үгүйсгэж, асуудлыг захиргаадах байдлаар шийдэх арга юм. Зайлшгүй шаардлагатай зарим үед хэрэглэгдэнэ. Гэвч энэ аргыг их хэрэглэх нь талууд дайснагах байдалд хүргэдэг. *Хоёрт*, Зөрчлийг тойрох арга: Зөрчлийг ажиглаагүй мэт өнгөрөөх идэвхгүй арга юм. Шийдвэрлэхэд тохиромжтой цаг хугацааг хүлээх, нөхцөл байдлын өөрчлөлтийг хүлээх маягаар энэ аргыг хэрэглэж болох юм. *Гуравт*, Эвлэрэх арга: маргалдагч талын нэг идэвхгүй байр суурь баримталж нөгөөдөө бууж өгөх байдлаар зөрчлийг зохицуулах арга юм. Харилцаа хэвээр үргэлжлэн зөрчил шийдвэрлэгдэх боловч буруутай талын саналаар асуудлыг шийдвэл зөрчил шийдвэрлэгдсэнээс гарах үр дүн бага байна. Хэтрүүлэн хэрэглэвэл байнгын дарамтлагч буй болох талтай. *Дөрөвт*, Зөвшилцлөөр шийдвэрлэх арга: маргалдагч талууд аль нэг асуудлаар буулт хийж, өөр асуудлаар өөртөө ашигтай шийдлийг зөвшөөрүүлэх замаар шийддэг байна. Ингэснээр зөрчлийг шийдвэрлэж харилцааг хэвийн болгох сайн талтай. *Тавд*, Хамтран ажиллах арга: Маргалдагч бүх талуудын хүлээн зөвшөөрөхүйц хамгийн сайн шийдлийг олохын тулд хамтдаа

чармайлт гаргаж зөрчлийг шийднэ. Энэ арга нь зөвхөн зөрчлийг арилгаад зогсохгүй бэрхшээлтэй асуудлыг шийдэхэд хамтран суралцдаг сайн талтай. Удирдлага байгууллагынхаа зорилгыг хэрэгжүүлэхэд хамгийн их нөлөөтэй аргыг олох, байгууллагын ажил үйлс сайн байснаас маргалдагч талуудад бүгдэд ашиг тус гарах нөхцөл байдлыг бий болгоход зөрчлийг шийдвэрлэх хамтын ажиллагааны арга тустай юм. (ЦД)

СПОЙЛ ТОГТОЛЦОО (*Spoil system*)

Мэдлэг, ур чадварт тулгуурласан мерит тогтолцооны эсрэг буюу “ялагчдад олз очно” гэсэн үзэл санаатай тогтолцоог спойл тогтолцоо гэнэ. Ур чадвар, хичээл зүтгэлээс илүү улс төрийн намд үнэнч байдлыг эрхэмлэдэг, дэмждэг энэхүү тогтолцоо нь 1880-аад оноос өмнө байсан АНУ-ын Ерөнхийлөгч Жексоны бодлогыг тодорхойлоход ашиглагдаж байсан. Төрийн байгууллагын хүний нөөцийн сонгон шалгаруулалт, ажилд авах үйл ажиллагаа намын гишүүнчлэл, намд гүйцэтгэж буй үүрэг, улс төрийн үзэл бодол, байр суурь, хэлхээ холбоонд үндэслэгдэн хийгдэх тогтолцоог хэлнэ⁸. Спойл тогтолцоог дэмжигчид “Хэрвээ сонгуульд ялсны дараа өөрийн намын дэмжигчдээр багаа бүрдүүлээгүй тохиолдолд сөрөг хүчний гишүүд нэг талаас маш муу хамтарч ажиллах бөгөөд нөгөө талаас тэд сонгуульд ялагдсан хорсол, хариугаа ажил цалгардуулах, гацаах байдлаар авдаг” гэжээ. 1828 онд А.Жексон АНУ-ын Ерөнхийлөгч болмогцоо өөрийн намын гишүүд, дэмжигчдээр төрийн албыг бүрдүүлж эхэлсэн бөгөөд энэ нь спойл тогтолцоо бүрэн ноёсны баталгаа болсон. 1854-1883 он хүртэлх хугацаа бол АНУ-ын төрийн албанд спойл тогтолцоо ноёлсон оргил үе

⁸ Н.Отгонбаяр: “Төрийн захиргааны шинжлэх ухаан”, Улаанбаатар 2019, х. 99.

байсан ба тухайн үеийн Ерөнхийлөгч нар сонгуулийн дараа өөрийн талын хүмүүсээр төрийн албыг бүрдүүлэхийн тулд асар их халаа, сэлгээ хийж байсан⁹. (Г.Б)

СТАНДАРТ (*Standard*) Тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичиг¹⁰. Улс орон бүрд өөрийн үндэсний стандарт байхаас гадна олон улсын болон бүс нутгийн, мөн түүнчлэн байгууллагын стандарт гэж бий. Монгол Улсын төрийн байгууллагад чанарын удирдлагыг хэрэгжүүлэх, үйлчилгээний стандарт бий болгох чиглэлээр 2008 онд Засгийн газрын 265 дугаар тогтоол гарч энэ хүрээнд төрийн байгууллагууд олон улсын ИСО (ISO) стандартыг нэвтрүүлэх, мөн төрийн зарим байгууллагад зөвхөн тухайн байгууллагын хүрээнд хэрэгжүүлдэг үйлчилгээний стандартыг шинээр боловсруулах чиглэлээр тодорхой ажлууд хийгдсэн байдаг. Жишээлбэл: Улсын бүртгэлийн байгууллага 2009 онд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлагыг тусгасан стандартыг шинээр боловсруулан хэрэгжүүлэн 2019 онд дахин шинэчилсэн байна¹¹. (М.А)

СТРАТЕГИ (*Strategy*) Стратеги нь 1680-90 онд үүссэн strategos гэсэн грек гаралтай үг юм. 1. Урт хугацааны буюу ерөнхий зорилгод хүрэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө, 2. Цэрэг дайны стратеги буюу дайн байлдаан эсвэл тулаанд цэргийн ерөнхий ажиллагаа, хөдөлгөөнийг төлөвлөх,

удирдах урлаг гэдэг утгатай ба ижил утга нь тодорхой зорилго, үр дүнд хүрэх төлөвлөгөө, мастер төлөвлөгөө, бодлого, үйлжиллэгааны төлөвлөгөө, арга, цуврал арга буюу стратеги, дэлхийд тэргүүлэх стратеги гэх утга заана. Стратегийн тухай ерөнхий ойлголт нь зорилгодоо хүрэх хүн хүч, эдийн засаг, улс төр, ёс суртахуун, оюуны гэх мэт нөөц боломжийг ямар аргаар хэрхэн удирдан зохицуулах тухай хамгийн өргөн ойлголтыг багтаадаг. Төрийн захиргаанд энэ ойлголт нь өнөөдөр урт хугацааны ажлын төлөвлөгөө эсвэл стратегийн хүрээнд тодорхойлсон ажлын зорилго, зорилтдоо хүрэх үндсэн ажлын явц болж байна. Илүү үр дүнд хүрэхэд нөөц боломж, шинэ арга, тактик болон нарийн боловсруулсан стратеги хэрэгтэй. Стратеги нь төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн гол зорилго, зорилт мөн. Зорилго, зорилтууд болон зорилтот бүлгүүд болох хүмүүс, байгууллага, хууль журам зэргээ зөв сонгосноор стратеги оновчтой болж, богино хугацааны тусгай зорилтуудын талаар тодорхой ойлголтод хүрэх ба нөөц, эх үүсвэрээ нарийн нягтлан шалгаснаар хамтрагч эсвэл сөрөг хүчин зүйлс тухайлбал, хүмүүс, цаг хугацаа, хөрөнгө зэргийг зөв тодорхойлсноор сонгосон тактикаа хэзээ, хаана, хэрхэн ашиглахаа шийдэж хэрэгжүүлж болно. (А.Эц)

СТРАТЕГИЙН АЛСЫН ХАРАА (*Strategic vision*) Байгууллагын үйл ажиллагааны хөгжлийн чиглэлийн талаарх алс хэтийн төлөв байдал бөгөөд байгууллага юу хийж, ямар зорилгод хүрэх вэ гэдгийг тодорхойлсон стратегийн эрмэлзэл¹². Стратегийн алсын хараа нь байгууллагын амжилт ямар

9 Д.Байгаль: "Төрийн албаны тогтолцоо", Улаанбаатар 2017, х. 14.

10 Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль

11 УБЕГ-ын даргын 2019 оны А/685 дугаар тушаал.

12 Менежментийн шинжлэх ухааны нэр томьёоны тайлбар толь, Glossary of Management Science Terminology, Улаанбаатар, 2020, х. 50.

байх дүр төрхийг агуулсан, түүний нийгэмд үзүүлэх хувь нэмрийг илэрхийлнэ. Алсын хараанд эрхэм зорилгоос илүүтэйгээр байгууллагын ажиллагчдад хамтран ажиллах урам зориг, амжилтын дүр төрхийг бий болгохыг зорино. Энэ нь байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлстэй нийцсэн, бодитой, үнэмшилтэй байна. Байгууллагын стратегийн алсын хараа нь стратеги, гүйцэтгэлийн шалгуур үзүүдэлт, шийдвэр гаргах чухал дүрэм, ёс зүйн хэм хэмжээг агуулна. Алсын хараа нь тухайн байгууллагын үйлчилдэг, оршин тогтнохоо зөвтгөдөг нийгмийн чухал зорилгуудыг онцлон тэмдэглэнэ. Алсын харааг богино, урам зориг өгсөн, товч тодорхой, ойлгоход хялбар байдлаар тодорхойлно. Байгууллага эрхэм зорилго, алсын харааг нэгтгэж томьёолох нь бий. Энэ нь байж болох ч эрхэм зорилго нь ихэвчлэн тухайн байгууллагын одоогийн асуудал, сорилтуудад хэрхэн хариулах талаар төвлөрнө, харин алсын хараа нь хамт олныг илүү өндөр түвшинд хүрэхийг эрмэлзэх, байгууллагын бүтэц, үйл явцад шаардлагатай өөрчлөлтийг өдөөх, урт хугацааны сайжруулалт, нийгэмд илүү өргөн хүрээнд хувь нэмэр оруулах зорилгод анхаарах тул тусдаа байх нь илүү оновчтой.¹³ (ДЧ)

СТРАТЕГИЙН ИДЭВХЖҮҮЛЭЛТ (Strategy activation) Стратеги идэвхжүүлэлт нь урт хугацааны үзэл баримтлалыг агуулсан, стратегийн шинэ зорилгын үзэл баримтлалаас эхлээд өөрчлөлтийг хэрэгжүүлэх, стратегийн хөгжил, хэрэгжилтийг нэгтгэхэд чухал үүрэгтэй.¹⁴

Стратеги боловсруулахад маш цөөн тооны хүмүүс оролцдог боловч хэрэгжүүлэхэд байгууллагын бүх ажиллагсад оролцдог тул стратегийг идэвхжүүлэх шаардлагатай. Учир нь стратеги идэвхжих хүртэл стратеги нь зөвхөн стратеги боловсруулагчдын оюун санаанд үлддэг. ‘Atomic Habits’ номын зохиолч James Clear ‘Хичээл зүтгэлгүйгээр агуу стратеги ч мөрөөдөл хэвээр үлддэг. Агуу стратеги байхгүй бол хичээл зүтгэл нь хар дарсан зүүд болж хувирдаг’¹⁵ гэж стратегийн идэвхжүүлэлт чухал болохыг онцолсон. Шинэ стратеги идэвхэжсэн үед, өөрөөр хэлбэл хүмүүс стратегийн логикийг ойлгож, тэргүүлэх чиглэлүүдийнхээ дагуу хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй, чадвартай байх үед стратеги амжилттай хэрэгжих нөхцөл бүрэлддэг. Стратеги идэвхжүүлэхийг хүсэж буй удирдагчид хүмүүсийг чадавхжуулах асуудалд нухацтай хандах хэрэгтэй. Ингэснээр хүмүүст “хийж чадна” гэсэн хандлагатай болж асуудлыг шийдвэрлэх, шинэлэг санаа гаргах, хамтрах ажиллах хүсэл эрмэлзэлтэй болдог байна. (З.А)

СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (Strategic plan) Стратегийн төлөвлөгөө нь төрийн байгууллагын мандат, алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилго, зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх баримт бичиг¹⁶. Стратегийн төлөвлөгөө бол дунд болон урт хугацаанд гүйцэтгэлээ сайжруулах, ирээдүйд илүү сайн амжилттай ажиллахад нь байгууллагад тусалдаг менежментийн хэрэгсэл юм¹⁷. Стратегийн төлөвлөгөө нь XIX зууны хот, мужийн төлөвлөгөө

13 Alan Walter Steiss, *Strategic Management for Public and Nonprofit Organizations*, Marcel Dekker, Inc., 2010, x. 63, 64.

14 Economides, V., & Picciola, M. (2014). *Strategy Activation: Improving the Effectiveness and Reducing the Costs of Strategic Change*. *Executive insights*, 16(40), 1-5.

15 <https://twitter.com/jamesclear/status/1235020963361804289>

16 Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоол.

17 Judson J.Lawrie, "Strategic Planning and Management in Transit Agencies, 2005, p. 4.

хийх хөдөлгөөнөөс эхтэй бөгөөд хожим 1920-нод онд Зөвлөлт Орост эхэлж, 1945 оноос хойш социалист болон бусад оронд дэлгэрсэн аж үйлдвэрийн төлөвлөлтөөс улбаатай¹⁸. Монгол улсад 1948 оноос Улс ардын аж ахуйг бүхэлд нь төвлөрсөн байдлаар 5 жилийн хугацаатай төлөвлөж эхэлсэн бөгөөд энэ үеэс хойш төрийн салбарт стратегийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ирсэн түүхийг таван шатанд хуваан үзнэ¹⁹. Үүнд: Төвлөрсөн төлөвлөгөөт үе (1948-1989), Шилжилтийн үе (1990-2001), Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хуульд зааснаар төвлөрсөн бус байдлаар 3 жилийн стратегийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн үе (2002-2011), Завсрын үе (2012-2018), Төрийн албаны тухай хуульд зааснаар 4 жилийн стратегийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн үе (2019 оноос хойш) гэсэн таван үе шат хамаарна²⁰. (М.А)

СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨЛТ (*Strategic planning*) “Strategy” буюу стратеги хэмээх нэр томъёо нь эртний Грекийн цэрэг (stratos), ялах (ago) гэсэн үгсийн нийлэмж “strategos” буюу “генералын урлаг” хэмээх утгатай. Энэ нь цэрэг дайны үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх урлаг, арга ухаан гэсэн санааг агуулдаг. Төлөвлөлт гэдэг нь Латины “planum (1700-аад он)” буюу “ямар нэг зүйлийг хавтгай дээр зураглах (anything drawn on a plane, a drawing on a flat surface)” гэсэн үгнээс гаралтай. Өөрөөр хэлбэл, стратегийн төлөвлөлт гэдэг нь дэвшүүлсэн зорилгыг хангах стратеги, түүнийг

хэрэгжүүлэхийн тулд авч явуулах үйл ажиллагаа, шаардлагатай нөөцийг тодорхойлох, хуваарилах үйл явц юм.²¹ Энэхүү төлөвлөлтийн үр дүнд стратеги төлөвлөгөө бий болдог. 1980-аад оны сүүлээр төрийн салбарт удирдлагын шинэ арга барил болох орц, үйл явцаас гарц, үр дүнг чухалчлах хандлага бий болсон. Энэ нь төрийн салбарт стратегийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх үндсэн суурийг тавьсан юм. Стратеги төлөвлөлтийн эцсийн зорилго нь төрийн байгууллагын гүйцэтгэлийг сайжруулахад чиглэдэг. (Т.Т)

СТРАТЕГИЙН ТҮНШЛЭГЧ (*Strategic partner*) Байгууллагын зорилго, зорилгод хүрэх үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр нөөцийг хамтран зарцуулдаг этгээдийг стратегийн түншлэгч гэнэ. Стратегийн түншлэгч тухайн байгууллагын янз бүрийн оролцогч талууд (үйлчлүүлэгчид, албан хаагчид, удирдлагууд, олон нийт, засгийн газар г.м)-ын шаардлага, хүлээлтийг хангах, сөрөг үр дагаврыг бууруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэх, зорилгодоо хүрэхэд тус болохуйц бүхий л дэмжлэг, нөөцөөр ханган хамтарч ажилладаг талыг хэлнэ. Стратегийн түншлэгчид ижил үнэ цэнэд тулгуурласан адил төстэй зорилготой байх ба харилцан түншлэлийн дагуу хамтын шийдвэр гаргана. Түншлэгч байгууллагатай хамтарсан хөрөнгө санхүү, хүний нөөц, мэдээлэлд тулгуурлан хамтын шийдвэрийг хэрэгжүүлнэ. Түншлэгчдийн үйл ажиллагаа харилцан итгэлцэлд суурилах ба эрх мэдлийн зохистой байдал, мэдээлэл солилцоо нь уг илтгэлийг тогтворжуулах хүчин зүйлс байна. (Г.Б)

18 Тони Бовейрд, Элке Лөйффлер, Улсын салбарын менежмент, засаглал, 2014, 57 дахь тал.

19 Удирдлагын Академи, Төрийн захиргааны байгууллагын стратегийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хийсэн шинжилгээ, 2019, 24 дэх тал.

20 Удирдлагын Академи, Төрийн захиргааны байгууллагын стратегийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хийсэн шинжилгээ, 2019, 24 дэх тал.

21 Я.Бямбасүрэн, Т.Түмэнцогтоо нар 2019, төрийн захиргааны байгууллагын стратегийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хийсэн шинжилгээ, х. 4.

СТРАТЕГИЙН УДИРДЛАГА (Strategic management) “Strategy” гэдэг нь цэрэг дайны үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх урлаг, арга ухаан гэсэн агуулгыг илэрхийлдэг. Харин management гэдэг үгийн үндэс нь “manage” юм. Энэ нь Латины “manus” буюу “өөрийн гараар хянах, удирдах” гэсэн үгнээс үндэстэй. Үгсийн нийлэмж нь “стратегийн удирдан чиглүүлэх” гэсэн ерөнхий агуулгыг илэрхийлэх ба “strategic management” гэдгийг “стратегийн удирдлага” хэмээн орчуулан хэрэглэдэг. Стратегийн удирдлагын үзэл санаа 1980-аад оны сүүлээр төрийн салбарт хэрэглэгдэх болсноор 1990-ээд оны дунд үеэс төрийн салбарт удирдлагын шинэ арга барил болох орц, үйл явцаас гарц, үр дүнг чухалчлах чиг хандлага төрийн стратегийн удирдлагын үзэл санааг хөгжин дэлгэрэх үндэс суурийг тавьжээ. Стратегийн удирдлага гэдэг нь “аливаа байгууллага стратегиа зөв тодорхойлж, байгууллагын хэмжээнд түүний төлөө ажиллах явдлыг хангаж байдаг үйл ажиллагааны цогц нэгдэл” юм (Рей С. Рист, Мари-Хелен Бойли, Фредерик Мартин, 2014, хуудас. 58). Товчхондоо, стратегийн удирдлага нь байгууллагыг ирээдүйд нь чиглүүлэн удирдах үйл явцтай холбоотой юм. Стратегийн удирдлага нь стратегийн төлөвлөлт, стратегийн хэрэгжилт, стратегийн хяналт, үнэлгээ гэсэн гурван үндсэн үе шатаас бүрддэг. Тухайлбал, Америкийн эрдэмтэн Брайсон (2004) стратегийн удирдлагын хүрээнд төрийн байгууллага нь мандат, эрхэм зорилго, алсын хараагаа тодорхойлох, гадаад ба дотоод орчны шинжилгээ хийх, стратегиа тодорхойлох, стратегийн хэрэгжилтийг хангах, стратегийн хяналт, үнэлгээг хийх гэсэн үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлэх шаардлагатайг дурдсан

байдаг (Bryson, J. M, 2004). Төрийн байгууллагын практикт стратегийн удирдлага нь стратегийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаагаар дамжин хангагддаг. Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлд төрийн байгууллага 4 жилийн стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулахаар тусгасан байдаг. (Т.Т)

СТРАТЕГИЙН ҮНЭЛГЭЭ (Strategic evaluation) Стратегийн үнэлгээ нь хэрэгжүүлж буй стратеги, бодлого, хөтөлбөрийн гадаад болон дотоод хүчин зүйлсийг судлах, стратегийн төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийх, стратегийн зорилгодоо хэр хүрч чадах эсэх, хэрэгжүүлж буй стратеги нь зорилгод нийцэж байгаа эсэхийг тодорхойлох үйл явц юм. Стратегийн үнэлгээ нь стратеги, бодлого, төсөл, хөтөлбөрийн үр нөлөөг үнэлэх стратегийн удирдлагын үйл явцын нэг үе шаг юм. Стратегийн үнэлгээг стратегийн хяналт ба үйл ажиллагааны хяналт гэсэн хоёр түвшинд явуулдаг. Стратеги хяналт, үнэлгээний гол үйл ажиллагаа нь²²:

1. Нөөцийн хуваарилалтын талаар шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх,
2. Асуудлын шалтгааныг дахин авч үзэх,
3. Шинээр гарч буй асуудлыг тодорхойлох,
4. Өрсөлдөх, эсвэл хамгийн оновчтой хувилбарын талаар шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх,
5. Төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлтийн үйл явцад дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

22 ЗГХЭГ. (2019). Стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний биеллтийг тайлагнах, үнэлэх аргачлал. Улаанбаатар: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, х. 3.

Стратегийн үнэлгээний төрөл: Эрдэмтэн Perkins стратегийн үнэлгээний үндсэн зургаан төрлийг тодорхойлжээ.²³

- Нөлөөллийн үнэлгээ: Төсөл, хөтөлбөрийг хүргэх систем, хөтөлбөрийн үр дүн, зорилгын хоорондын хамаарлыг үнэлнэ.
- Удирдлагын үнэлгээ: Төсөл, хөтөлбөрийн зорилгод хүрэх нөөцийн ашиглалт, үр ашгийг үнэлнэ.
- Загварын үнэлгээ: Төсөл, хөтөлбөрийн таамаглалын хэмжигдэхүүн, хандлагын ерөнхий логик, үр дүнгийн хариуцлага, хариуцлагын хуваарилалтыг үнэлнэ.
- Хөндлөнгийн оролцооны үр нөлөөг үнэлэх: Төсөл, хөтөлбөрийн оролцоо, үр дүн, үр дүнд хүрэх үйл явцыг үнэлнэ.
- Нийцтэй байдлын үнэлгээ: Төсөл, хөтөлбөрийн зорилтууд нь хууль тогтоомжийн зорилттой нийцэж байгаа эсэхийг судалж, бодлогын удирдамжийн дагуу хөрөнгө хуваарилалтыг үнэлнэ.
- Стратегийн үнэлгээ: Нийгмийн асуудлын үндсэн шалтгаан, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг үр дүн, нөлөөллийг үнэлнэ. (3.A)

СТРАТЕГИЙН ХОЛБОО (*Strategic alliance*) Стратегийн холбоо нь үндсэн стратегитэйгээ уялдуулан зорилго, зорилтоо биелүүлэхэд хувь харилцан нэмэр оруулдаг хоёр ба түүнээс дээш байгууллагын хоорондын хамтын ажиллагаа юм (Howarth & et al, 1995). Стратегийн холбоо нь улс хооронд, улс болон олон улсын байгууллага

хооронд, корпорац, компаниудын хооронд гээд олон янзаар оршиж болно. Стратегийн түншлэгчид гэж нийтлэг зорилгодоо хүрэхийн тулд бодит болон оюун санааны нөөцийг харилцан хуваалцах урт хугацааны гэрээ хийж хамтран ажиллаж байгаа талууд юм²⁴. Стратегийн холбоо буюу түншлэл нь аливаа улс орны эдийн засаг, стратегийн нийтлэг зорилгыг хэрэгжүүлэхийн тулд илүү хүчирхэг, том хэмжээтэй бусад улс орнуудын хамтын ажиллагааг хэлнэ. Стратегийн түншлэлийн харилцаа нь урт хугацааны үзэгдэл юм. Стратегийн холбоо нь одоо байгаа хамтын ажиллагаагаа бусад салбарт өргөжүүлэх, дипломат харилцаагаа бэхжүүлэх, урт хугацааны цэргийн болон стратегийн хамтын ажиллагааг бий болгох, бүс нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор байгуулагдсан эвсэл, холбоонд улс төрийн хүрээгээр тэлэх чиглэлээр байгуулагддаг²⁵. Стратегийн холбоо нь гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын импорт, экспортыг хөгжүүлэх, технологийн түнштэй болох боломжийг бүрдүүлэх зэрэг олон давуу талтай. (3.A)

СТРЕСС (*Stress*) Хувь хүнд бие сэтгэлийн шаардлага болон тавигдаж, улмаар түүнийг тодорхойгүй байдалд орж, өөрийн хяналтаа алдахад хүргэдэг өдөөгчдөө үзүүлэх сэтгэл зүйн болон сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийг хэлнэ²⁶. Төрийн байгууллагад ажлын ачаалал, шийдвэрлэх асуудлын төвөгтэй байдал, зөрчил маргаан, иргэдээс

23 Steiss, A. W. (2003). *Strategic Management for Public and Nonprofit Organizations*. New York: Marcel Dekker, Inc. p. 341-342.

24 Kinderis, R., & Jucevicius, G. (2013). Strategic alliances – Their definition and formation. *Latgale National Economy Research*, 1(5), pp. 106-128.

25 Kinderis, R., & Jucevicius, G. (2013). Strategic alliances – Their definition and formation. *Latgale National Economy Research*, 1(5), pp. 106-128.

26 А.Цанжид (2009). Төрийн захиргаа, х. 105, Улаанбаатар, х. 105.

байнга гардаг гомдол, шүүмжлэл, улс төрчдийн зүгээс учирдаг дарамт шахалт, хэвлэл мэдээллийнхний үйл ажиллагаа зэрэг гаднын нөлөөнөөс стресс байнга үүсдэг. Гэхдээ стресс нь зарим тохиолдолд ажлын гүйцэтгэлд сайнаар нөлөөлдөг. Удирдлагын шахалт шаардлага, ажил гүйцэтгэх хугацаа тулсан зэрэг нөхцөл байдал нь стресс үүсгэх боловч ажлаа эрчимтэй хийж дуусгахад нөлөөлнө. Гэвч байнгын стресс нь хувь хүнд ч байгууллагад ч хортой. Ханс Селье “стресс гэдэг бол гаднаас ирсэн шаардлагад хүний биеийн үзүүлж буй хэвийн бус хариу үйлдэл” гэж тодорхойлжээ. Сельегийн тодорхойлсноор: стресс хэд хэдэн үе шат дамжин бий болдог аж. Стресс үүсгэгчийн зүгээс хүнийг стресст оруулахуйц үйлдэл хийхэд анхны үе шат буюу түгшүүр бий болно. Сэтгэл тавгүйтэх, айх, уурлаж бухимдах, булчин шөрмөс чангарах, зүрхний цохилт нэмэгдэх, цусны даралт өсөх мэтийн өөрчлөлт гарч болно. Сэтгэл зүйн хувьд өөрийгөө хамгаалах байдал бий болно. Хэрвээ стресс үргэлжилбэл хоёр дахь үе шатандаа шилжиж эсэргүүцлийн байдал үүсгэдэг аж. Энэ үед стресс үүсгэгч рүү дайрах, эсвэл зай тавьж өгч үйл ажиллагаанаас татгалзах гэх мэт байдал үүсдэг байна. Стресс үүссэн шалтгаан үүнээс цааш үргэлжлэн хүнд хэт дарамт учруулбал хүн “хоосрох” буюу сэтгэл санааны хувьд итгэлгүй болж бүх юмнаас хөндийрөх байдал үүсэх ба үүнээс болж хямрах, зүрхний өвчинтэй болох, архинд орох мэтээр өөрт нь өөрчлөлт орохоос гадна бусадтай байнга зөрчилдөх, ажил албандаа хайхрамжгүй хандах зэрэг сөрөг үзэгдэл гардаг байна. Ажлын байранд стресс үүсгэдэг дөрвөн гол зүйл байдаг нь бие хүний хэв маяг, байгууллагын уур амьсгал,

удирдлагын арга барил, ажлын сэтгэл ханамж зэрэг юм. Бие хүний хэв маягийн хувьд А болон В хэв маяг гэж хоёр ангилна. А хэв маягийн нь түргэн хөдөлгөөнтэй, тэсвэр муутай, байнга ажилд дарагдаж байдаг, өрсөлдөөнт шинжтэй хүмүүс байдаг. Ийм хүн стресст орох нь амархан байдаг. Харин В хэв маягийн хүн үүний эсрэг тайван, шунаж ажилладаггүй, тэвчээртэй аж. Удирдлагын арга барилын хувьд байнга дарамталдаг, хэрэгцээгүй олон хяналт шалгалт хийдэг захиргаадгалтын шинжтэй арга барил хамгийн ихээр стресс үүсгэдэг байна. Байгууллагын уур амьсгал муу байвал мэдээж ажиллагчид стресстэй байна. Хүн ажилдаа сонирхол багатай байх нь түүний ажлаа сайн хийх сэдэл тэмүүллийг багасгаад зогсохгүй өөрт нь стресс үүсгэж байдаг байна. (ЦД)

СУМ (Sum-local administrative unit)

Монгол Улсын засаг захиргааны анхан шатны нэгж. 1691 онд Манжаас Халх Монголд засаг захиргааны хуваарийг шинэчилснээр сум гэдэг нэгж үүссэн. Манжийн үед Ар Монгол нь Дарьгангыг оролцуулахгүйгээр 250 орчим сумтай байжээ. Манж болон Богд хаант Монгол Улсын үед сум нь цэрэг дайчилгааны зохион байгуулалтын нэгж байв. 150 эр бүхий бол сум, эрийн тоо 150 хүрэхгүй бол хондого хэмээн нэрлэж байжээ. Ардын хувьсгалын дараа хэрэгжүүлсэн засаг захиргааны өөрчлөлтөөр 1923 онд Монгол Улс арван гэр, баг, сум, хошуу, аймаг гэсэн нутгийн захиргааны шатлалтай болжээ. Социализмын үед сумын эрх барих байгууллага нь сумын Ардын депутатуудын хурал байсан ба хурлын чөлөө цагт түүнээс сонгогдсон АДХГЗ-ны дарга удирддаг байв. Сум бүрд хөдөө аж ахуйн нэгдэл байсан учраас сумын дарга нь нэгдлийн даргыг хавсран

ажилладаг байжээ. Тиймээс сумын бүх ажил амьдрал нэгдлийн аж ахуйн ажил, улсын төлөвлөгөөг биелүүлэхэд чиглэдэг байв. Сумын хэмжээнд төрийн шинжтэй чиг үүргүүдийг чухамдаа сумын АДХГЗ-ны нарийн бичгийн дарга хэрэгжүүлдэг байв. Өдгөө сум нь цэвэр засаг захиргааны нэгж бөгөөд багт хуваагдана. Монгол Улсын Үндсэн хуульд “аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тогтоосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг, захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” хэмээн тодорхойлсон байна. (А.Ц)

СУРАЛЦАГЧ БАЙГУУЛЛАГА (*Learning organization*)

Бүтээлч ур чадварыг хөгжүүлэх, шинэ мэдлэг эзэмших, түгээх, эзэмшсэн мэдлэг, ур чадвараа үйл ажиллагаандаа хэвшил болгож, цаашид улам өргөжүүлэх хүсэл эрмэлзэл бүхий хамт олон, байгууллага. Энэ нь хамгийн энгийн бөгөөд ерөнхий тодорхойлолт юм. Эрдэмтэн судлаачдын үзэл бодлын зөрүү болон ойлголтын цар хүрээтэй холбоотой. Зарим эрдэмтэд “зан төлөвийн өөрчлөлт нь сурах үйлийг шаарддаг бөгөөд “self - serving” буюу өөрөө өөртөө үйлчилж байгаа хэрэг” гэж үзэж байхад зарим нь “байгууллага зорилго болон түүнд хүрэх арга замыг тодорхойлох нь хангалттай бөгөөд үүний тулд ажилчдыг мэдээллээр хангахад л болно, илүү зүйл хэрэггүй” гэж үзэх хандлагатай байдаг. Эрдэмтэд байгууллага, түүний суралцаж, хөгжиж буй төлөвийг тал бүрээс нь ажиглан судалж, харилцан адилгүй тодорхойлдог нь тэдний суралцах үйл явцын хугацаа, сурч эзэмших гэж буй объект-мэдлэгийн ялгаатай байдал, гарах үр дүн, гүйцэтгэлийн үзүүлэлтүүд өөр өөрсдийн онцлогтой байдагт оршдог гэж үздэг. Суралцагч

байгууллагын онолыг үндэслэгч эрдэмтэд²⁷ “байгууллагын хамгийн жижиг элемент бол хүн”, “хувь хүнээс байгууллага эхлэн суралцдаг”, “багаар суралцах эхний алхам нь хувь хүний сургалт, хувь хүмүүс нийтлэг зорилгынхоо төлөө бусадтай мэдлэгээ хуваалцдаг”, “хувь хүн суралцсанаар багаар сурах үйл эхэлнэ”, “багийн сурах үйлдлээс байгууллагын суралцах үйл явц руу шилжинэ” гэсэн санаануудыг дэвшүүлж суралцагч байгууллагын суурь ойлголтыг тодорхойлжээ. (Г.Б)

СУРГУУЛЬ (ТҮШМЭДИЙН) (*School of administrators in Royal Mongolia*)

Монгол Улсад төрийн түшмэлийг сургуулиар бэлтгэх эхлэл Богд Хаант Монгол Улсын үед тавигджээ. Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичигт “нийслэл хүрээ ба олон хошуу шавийн газраа бага, дунд, дээд зэргийн сургуулийн танхим байгуулж, бага сургуулиас үүсгэн зүйл бүрийн эрдэм чадлыг сургах” тухай заажээ. Шат бүрд заах хичээлийг тодорхойлсон байна. Тухайлбал, бага сургуульд монгол бичиг үсэг, энгийн зэрэг тоо бодох, монгол ба бусад олон газрын байдал, төлөв, аж төрөхийг сайжруулах ёс, элдэв зүйлийн сургаал соёл, сурвалжит үг бичгийг зааж сургах ёстой байжээ. Суралцаж буй хүмүүсээс тогтмол хугацаанд шалгалт авч зэрэглэн яамд, хошуу тамгын газарт бичээч зэрэг албан тушаалд томилон ажиллуулахаар тогтоожээ. Анхны бага сургуулийг 1912 оны 3-р сарын 24-нд 47 сурагчтай Гадаад Яамны дэргэд байгуулжээ. Тэр үеэс эхлэн аймаг хошуудад 60 гаруй бага сургуулийг байгуулжээ. Хэдийгээр харьяат ардын хүүхдийг сургах тухай бичиг баримтад тусгагдсан боловч

27 Крис Аргурис/Chris Argyris/, Дональд Шоён / Donald Schön/, Маргарет Вэйтли /Mar-garet Wheatley/ болон Петер Сэнж /Peter Senge/ нар.

Дотоод Яамнаас Богдод өргөсөн бичгээс үзвэл "... олон ноёд ба ноёдын хөвгүүдийг сургууль хийлгэхийг урьдал болговоос зохино" гэж үзэж байжээ. 1921 оны ардын хувьсгалын дараа нам төрийн ажилтан бэлтгэхэд анхаарч анхны ийм сургуулийг 1924 онд байгуулжээ. 1924 оны IY сарын 5-нд Халхын дөрвөн аймаг, шавиас зарлан дуудаж ирүүлсэн 18-30 насны 60 орчим залуучуудаас бүрэлдсэн "Нам, улсын түр сургууль"-ийг байгуулсан байна. Энэхүү түр сургуулийг байнгын болгох асуудлыг шийдвэрлэж 1925 оны IY сарын 28-нд Богд хааны зуны Хайстай ордон буюу одоогийн Удирдлагын Академи байрлаж буй газарт МАХН-ын төв хорооны дэргэдэх "Намын төв сургууль"-ийг байгуулжээ. Анхдугаар Төв сургуульд Монгол Улсын аймаг, хошууд болон Тагна Урианхай, Баргаас хүрэлцэн ирсэн 130 залуус суралцсан байна. Тус сургуульд Хятад, Өвөр Монгол, Түвд, Тува зэрэг улсын хүсэлтээр тэдэнд шаардлагатай нэлээд тооны мэргэжлийн боловсон хүчин бэлтгэжээ. 1941 оны долдугаар сарын 24-ний өдрийн МАХН-ын ГХ-ны Тэргүүлэгчдийн 37 дугаар хуралдааны тогтоолоор Намын төв сургуулийг өөрчилж, МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын шинэ хүчний дээд сургууль байгуулжээ. Ийнхүү Монголд дээд боловсролын тогтолцооны үндэс суурь тавигдсан байна. Намын дээд сургуульд нам, төр, олон нийтийн болон аж ахуйн байгууллагын удирдах ажилтныг бэлтгэж байв. (А.Ц)

СУРТАЛ УХУУЛГА (*Propaganda*)

Улс төр, захиргаа, нийгмийн чухал асуудлыг олон түмэнд сэнхрүүлэн ойлгуулахын тулд хийж буй зохион байгуулалттай үйл ажиллагааг²⁸

хэлнэ. Энэ нь олон нийтэд тодорхой итгэл үнэмшил, хандлагыг бий болгох зорилготой нөлөөлөл үзүүлэх үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, суртал ухуулга гэдэг нь өргөн утгаараа хүмүүсийн зан үйлд нөлөө үзүүлдэг сэтгэлийн хөдөлгөөн ба тодорхой төсөөлөл, үзэл бодлыг төлөвшүүлэх зорилгоор мэдлэг, үнэт зүйлс болон бусад мэдээллийг түгээн тараах нийгмийн үйл ажиллагааны үндсэн төрөл, явцуу утгаар тодорхой нэг анги, нам, улсын үзэл санааны ба улс төрийн бодлогыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа. (Ц.Д)

СУУРЬ ЗОХИЦУУЛАЛТ БА ХЭМ ХЭМЖЭЭ (*Basics and norms*)

Захиргааны үйл ажиллагаатай холбоотой хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна Иргэний хуульд заасан гэрээний суурь зохицуулалтын нэгэн адил захиргааны хэм хэмжээ байхгүй тохиолдолд нөхөн тохируулж хэрэглэнэ. Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль нь захиргааны байгууллагын гүйцэтгэх эрх мэдлийн эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлж өгсөн юм. Төрийн захиргааны байгууллага захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээнд суурилан иргэн, хуулийн этгээдтэй ажиллана. Захиргааны үйл ажиллагааны зарчмыг ерөнхий шинжээр нь хоёр ангилж үзэж болно. Нэгдүгээрт, захиргааны байгууллагаас үйл ажиллагаа явуулахдаа баримтлах зарчмууд, хоёрдугаарт, захиргааны шийдвэрээр эрх нь хөндөгдөх иргэд, захиргааны үйл ажиллагаанд оролцогчдын эрхийг аль болох хангахад чиглэсэн зарчмууд гэх зэргээр. Захиргааны байгууллага үйл ажиллагаа явуулахдаа баримтлах зарчмууд нь захиргааны шийдвэрийн хэлбэр, үйл ажиллагаа тодорхой байх,

²⁸ Монгол хэлний их тайлбар толь бичиг: <https://mongoltoli.mn>

шийдвэр үндэслэлтэй байх, төвийг сахих, ил тод, нээлттэй байх, үйл ажиллагаа шаардлагатай тохиолдолд л хийгдэх, зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон байх, захиргааны үйл ажиллагаа шуурхай, тасралтгүй байх, үйл ажиллагаа нь эдийн засгийн үр ашигтай мөн хэмнэлттэй байх хэрэгтэй байдаг. Эрх зүйн хэм хэмжээ нь төрийн хүсэл зоригийн илэрхийлэл, нийгмийн харилцааг зохицуулагч, төрөөс хамгаалсан, бүх нийтээр дагаж мөрдөх журам байдаг. Захиргааны эрх зүйн хэм хэмжээ гипотез, диспозит, санцаас бүрэлдэнэ. Эрх зүй, ёс суртахууны үүднээс нийгмийн суурь хэм хэмжээний тухай онолын түүх, гүн ухаан, мөн чанар, утга учир, зорилгын талаар эрх зүйн тогтолцооны хүрээнд гүн гүнзгий судалж, дүн шинжилгээ хийж, орчин үеийн хууль боловсруулах, тогтоох, хэрэгжүүлэх, дүгнэлт хийх үндэс суурь болгох зарчмыг судлаач Б.Чимид: нийгмийн эрх, ёс зүйн “анатоми” болсон “хэм хэмжээ” ойлголтыг эрх зүйн философи, эрх зүйн онол, үндсэн хуулийн эрх зүйн үүднээс гүнзгийрүүлэн тайлбарласан байдаг. Нийгмийн нэгдсэн суурь хэм хэмжээ нь урт хугацааны туршид нэгэн утгаар ашиглагддаг бөгөөд шинэ нөхцөл байдлыг тусгах шаардлагагүй, өөрчлөгддөггүй стандартууд юм. Түүхэн уламжлалаас өвлөгдөн ирсэн бичигдээгүй хуулийн суурь нь ёс зүйн хэм хэмжээ мөн. (А.Эц)

СУУРЬ ТҮВШИНД ҮНДЭСЛЭСЭН ТӨСӨВ (*Base line budget*) Макро эдийн засгийн таамаглалд нийцүүлж, тухайн төсөв хэрэгжих жилд хууль тогтоомж, эсхүл төрийн бодлогод өөрчлөлт орохгүй байхаар тооцсон төсвийн тооцоог²⁹ хэлнэ. Суурь төсөвлөлт бол ирэх жилүүдийн

төсвийг боловсруулахад ашигладаг нягтлан бодох бүртгэлийн арга юм. Суурь төсөвлөлт нь одоогийн зардлын түвшинг ирээдүйн санхүүжилтийн шаардлагыг бий болгох “суурь шугам” болгон ашиглаж, ирээдүйн төсөв нь одоогийн төсвийн инфляцын түвшингээс хүн амын өсөлтийн түвшинтэй тэнцүү байхаар тооцдог. (А.Э)

СҮҮДРИЙН ЭДИЙН ЗАСАГ (*Shadow economy*) Сүүдрийн эдийн засаг гэсэн тодорхойлолт нь маш өргөн хүрээтэй, олон янз байдаг (үүнийг мөн албан бус эдийн засаг буюу хар, саарал, далд, бэлэн мөнгөний, нууц эдийн засаг гэж нэрлэдэг) боловч ерөнхийдөө татварын тогтолцооноос гадна бизнесийн үйл ажиллагаа явуулах, бүртгэлтэй аж ахуйн нэгжүүд татвар болон нийгмийн даатгалыг төлөхөөс зайлсхийж нуун дарагдуулах, эсхүл хэрэглэгчийн эрх ашиг болон аюулгүй ажиллах нөхцөлтэй холбоотой хууль эрх зүйн зардлаас зайлсхийхийг хэлдэг. Заримдаа иймэрхүү хэлцэл, үйл ажиллагаануудыг бүгдийг нь биш ч гэсэн хэсэгчилсэн байдлаар орлогоо нуун дарагдуулж, бодит төлөх ёстой татварын хэмжээнээс хамаагүй бага орлогыг татвар болон статистикийн газарт тайлагнадаг. Харин зарим тохиолдолд тухайн бизнесийн үйл ажиллагаа, хэлцлийг огт тайлагнадаггүй ба татвараас нуугдах зорилгоор төлбөрийг магадгүй бэлэн мөнгөөр хийдэг. “Сүүдрийн эдийн засаг”-ийн үр дагаврын улмаас ихэнх улс орнуудад боломжит татварын орлогын алдагдал нь нийт татварын зөрүү (бодит ба боломжит татварын орлогын хоорондын зөрүү гэх мэт)-ний дийлэнх хувийг бүрдүүлж байдаг.³⁰ (А.Э)

30 Барри Расселл, “Орлогыг удирдлага: Сүүдрийн эдийн засгийн удирдах нь” Олон Улсын Валютын Сан, 2010, х. 1.

29 Төсвийн тухай хууль

СЭДЭЛ-ЭРҮҮЛ АХУЙН ХҮЧИН ЗҮЙЛИЙН ОНОЛ (*Motivator-Hygiene theory*)


1950-иад оны үед Маслоугийн хэрэгцээний шатлалын онолын санааг үргэлжлүүлэн Герцберг (F.Herzberg)³¹ нар “Сэдэл-эрүүл ахуйн хүчин зүйлийн онол” нь тухайн байгууллага дахь сэтгэл ханамжтай болон сэтгэл ханамжгүй байдлыг бий болгодог хүчин зүйлүүд нь тусдаа хүчин зүйлсээр өдөөгдөн бий болдог хэмээх онолоо дэвшүүлжээ.

Тэрээр ажилтнуудын сэтгэл ханамжийг бий болгож зүйлсийг сэдэлжүүлэх хүчин зүйлс, байгаа ажлын агуулгатай хүчин сэтгэл ханамжгүй байдлыг үүсгэдэг, ажлын орчин нөхцөлтэй холбоотой хүчин зүйлсийг эрүүл ахуйн хүчин зүйлс гэж нэрлэжээ.

Байгууллагад эрүүл ахуйн хүчин зүйлс сайн бүрдсэн тохиолдолд ажил хөдөлмөртөө хэвийн хандах, таагүй сэтгэгдэл өвөртлөхгүй байх нөхцөл бүрдэнэ. Герцбергийн онол нь: Ажлын орчин нөхцөлтэй холбоотой эрүүл ахуйн хүчин зүйлс нь Маслоугийн онолын доод түвшний хэрэгцээнүүдтэй холбогдоно. Сэдэлжүүлэх хүчин зүйлс болох амжилт, хүлээн зөвшөөрүүлэх, албан тушаал ахих, хөгжин дэвших зэрэг нь дээд түвшний хэрэгцээтэй ойролцоо утгыг илэрхийлдэг байна.

Энэхүү онолыг сэтгэл ханамжтай болон сэтгэл ханамжгүй байдал гэсэн хоёр хүчин зүйлийг голлон судалдаг нь “Хоёр хүчин зүйлийн онол”, нөгөө талаар хүмүүсийг хөдөлмөрлөхөд юу сэдэлжүүлдэг вэ гэдгийг голлон судалдаг нь “Сэдэл-эрүүл ахуйн хүчин зүйлийн онол” ч гэж нэрлэдэг. (Ц,Д)

Зураг 2. Сэдэл-эрүүл ахуйн хүчин зүйлсийн ялгаа



Эх сурвалж: П.Увш, Б.Хэрлэн (2017). Байгууллагын зан үйл. Улаанбаатар. х. 58

31 П.Увш, Б.Хэрлэн (2017). Байгууллагын зан үйл. Улаанбаатар.

СЭДЭЛЖҮҮЛЭЛТ (Motivation) Сэдэл нь хүний дотоод сэтгэл зүйн байдал (internal condition), сэтгэл хөдлөлтэй холбоотой юм. Сэдэл нь хүнийг идэвхжүүлж, ямар нэгэн үйл хөдлөлийг хийхэд хүргэж, сэтгэл хөдлөх зэрэг дотоод сэтгэл зүй нь зорилгод чиглэсэн үйл хөдлөлийг сэдэлжүүлдэг. Өөрөөр хэлбэл, хүний дотоод сэтгэл ба гадна оршиж, хийж бүтээх зан үйлийг өдөөн, улмаар түүнийг тогтоон барьж байдаг үйл явц, хүчин зүйлүүдийн цогц нэгдлийг сэдэл гэж ойлгоно. Бежаворист үзлийн давалгаа хувийн хэвшлийн салбарыг хамарч байсны нэгэн адил төрийн салбарт ч нөлөөлөл үзүүлэх болсноор 1980-аад оны дунд хагаст төрийн салбарт хувь хүнийг сэдэлжүүлэхэд дотоод болон гадаад урамшууллын үр нөлөөг төрийн удирдлагын аргад нэвтрүүлэн, ашиглах болжээ. Өрсөлдөөн болон үр ашгийг онцлон үзэх хувийн хэвшлийн хүний нөөцийн удирдлагын тогтолцоо нь төрийн салбарт ч үр нөлөөтэй байж болох юм гэсэн таамаглалаар төрийн захиргаанд хэрэглэсэн. Төр болон хувийн хэвшлийн харьцуулсан судалгаа ихээр хийгдэх болсноор төрийн захиргааны байгууллагын амжилтад ихээхэн нөлөөлөх төрийн байгууллагын ажиллагчдын сэдэлд нөлөөлөх хүчин зүйлийн онцлог шинж нь төрийн захиргааны ухааны гол судлагдахуун болсон. (Ц.Д)

СЭТГЭЛ САНААНЫ ДЭМЖЛЭГ (Intrinsic rewards) Амжилтад хүрсэн мэдрэмж, хийсэн ажлаараа бусдаас үнэлэлт хүндлэл хүлээж буй мэдрэмж юм. Өөрөөр хэлбэл, ажилтан албан үүргээ сайн гүйцэтгэж, гарах үр дүн нь эерэг байх тохиолдолд хийсэн ажлыг нь хүмүүс үнэлж сайшаах, ажлын үр дүн нь бусдад ашиг тус өгч байгааг мэдрэх, амжилтад хүрснээр

мэдэрснээр өөрөөрөө бахархах сэтгэл төрдөг нь түүнийг сэдэлжүүлж байдаг байна. Англи нэр томьёог үгчлэн авч үзвэл дотоод урамшуулал гэж орчуулагдах боловч хүний сэтгэл зүйд нөлөөлөх шинжээр нь сэтгэл санааны дэмжлэг гэсэн нэр томьёог хэрэглэж болно. Сэтгэл санааны дэмжлэгийг ажилтнуудын ажлын сэтгэл ханамжаар хэмждэг. Практикт материаллаг урамшууллаас гадна сэтгэл санааны дэмжлэг буюу магтаал, сайшаал зэрэг ёс суртахууны урамшууллыг зөв хэрэглэх нь илүү урт хугацаанд үйлчилдэг зардал багатай байдаг гэж үздэг. Фредерик Гербцергийн 1968 онд “Ахин нэг асууя: Та ажилтнаа яаж сэдэлжүүлдэг вэ? (One More Time: How Do You Motivate Employees?)”³² хэмээх сонгодог өгүүллэгт материаллаг урамшуулал нь ажилтны гүйцэтгэлд сайнаар нөлөөлж, сэдэлжүүлэх боловч үйлчилгээ нь богино байдаг. Харин хүрэлцэхүйц цалин дээр магтаал сайшаал, багийн эерэг уур амьсгал зэрэг сэтгэл санааны дэмжлэгийг нэмбэл тэнд сэтгэл зүтгэлтэй хамт олон бүрддэг гэжээ. (Ц.Д)

СЭТГЭЛ СУДЛАЛ (Psychology)³³

Хүний сэтгэцийн хөгжлийн бодит зүй тогтол, сэтгэхүйн үйл явц, бие хүний сэтгэцийн шинж чанар, үүргийн түгээмэл зүй тогтол болон хүний үйл ажиллагааны сэтгэл зүйн онцлогийг судалдаг шинжлэх ухаан юм. Хүнийг тойрон байгаа гадаад ертөнцөөс ялгагдах дотоод ертөнцөд бодит үйл явдал, мэдээ баримтын эсрэг тавигдах оюун ухааны хүрээнд үздэг. Сэтгэл судлал нь хөгжлийнхөө явцад сүнс, сэтгэл санаа, ухамсар, зан байдал,

32 Frederick Herzberg. One More Time: How Do You Motivate Employees?. Harvard Business review. 2003.

33 한호섭 (1999). 행정학 용어 사전. 서울, 행정학용어표준화연구회. 새 정보 미디어

сэтгэц, түүний зүй тогтол, тэдгээртэй холбоотой асуудлыг судалсаар ирсэн. Орчин үеийн сэтгэл судлал нь хүний мөн чанарыг ойлгож танихад голлон анхаарч байна. Ингэхдээ хүний ухамсарласан болон ухамсарлаагүй үзэгдэл, үйл явц, байдлын хийсвэр ертөнцийг судалдаг. Сэтгэл судлал нь хүнийг судалдаг шинжлэх ухаан болохын хувьд хүний ажиллаж, үйл ажиллагаа явуулж байгаа салбар бүхэнд хөгжиж байна. Төрийн албан хаагчдын санаа бодол, үйлдэл, зан төлөв, хандлага болон нийгэм сэтгэл зүйн онцлог, бусад хүмүүс, бүлэгтэй харилцах харилцаа, хүмүүсийн сэтгэл зүйн нийц, бүлэг дэх хүний нийгэм-сэтгэл зүйн илрэл зэрэг тэдний гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлсийг түлхүү анхааран судалдаг. (Ц.Д)

СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЗАГВАР (*Satisficing model*) Сэтгэл ханамж (*Satisficing*) бол шийдвэр гаргах стратеги буюу танин мэдэхүйн эвристик арга бөгөөд бодлогын боломжит хувилбаруудын дотроос хүлээн авч болохуйц босго үзүүлэлт хангагдах хүртэл хайлт хийж оновчтой хувилбарыг сонгохыг шаарддаг. Ханасан, хангалттай гэсэн утга бүхий “satisficing” хэмээх нэр томьёог 1956 онд Герберт А.Саймон (H.Simon) нэвтрүүлсэн. А.Саймон уг концепцыг оновчтой сонголтын шинэ онолын хүрээнд сэтгэл зүйн бодит байдлыг харгалзан сонголт хийх зарчимд тулгуурлан боловсруулсан. Тэрээр энэхүү хандлагыг хязгаарлагдмал оновчтой байдал гэж нэрлэсэн. Саймон энэ санаагаа лавшруулан Марч (J.March)-тай хамтран сэтгэл ханамжийн загварыг боловсруулжээ. Энэхүү загвар нь хязгаарлагдмал оновчтой байдлын загварын төрөлд хамаарна. Хязгаарлагдмал оновчтой байдал

(bounded rationality) гэдэг нь хүмүүс хязгаарлагдмал чадвараараа хүрч чадахуйц түвшний оновчтой байдлыг хэлдэг. Бодлого боловсруулагч өөрийн субъектив дүгнэлтээр хамгийн сайн гэж үзэж буй хувилбараа сонгодог учраас оновчтой байдал нь субъектив шинжтэй боловч уг загварын давуу тал нь зохион байгуулалтын онолын нийгмийн сэтгэл зүйн элементүүд дээр суурилдаг учраас практикт хэрэглэхэд хялбар байдагт оршино. Хүн бүрийн сэтгэл ханамжийн түвшин янз бүр байдаг учраас уг загварыг бодитой бус гэж шүүмжлэх тал бий. (Ц.Д)

СЭТГЭЛ ХӨДЛӨЛ (*Emotion*) Сэтгэл хөдлөл бол янз бүрийн бодол, мэдрэмж, зан үйлийн хариу үйлдэл, сэтгэлийн таашаал, дургүйцэлтэй холбоотой нейрофизиологийн өөрчлөлтөөс үүдэлтэй мэдрэлийн системийн биологийн төлөв байдал юм. Тодорхойлолтын талаар одоогоор шинжлэх ухааны нэгдсэн ойлголт байхгүй байна. Сэтгэл хөдлөлийг ихэвчлэн ааш зан, темперамент, бүтээлч байдал, хүсэл эрмэлзэлтэй хольж хутган хэрэглэх нь ажиглагддаг. Ертөнцийн аливаа үзэгдлүүдэд чиглэсэн хандлагыг илэрхийлсэн хүний дотоод сэтгэцийн процессыг сэтгэл хөдлөл гэнэ. Хүний сэтгэл хөдлөлд түүний бие махбодын байдал, түүнээс гадаад ертөнцийн үзэгдэлд хандах субъектив харьцаа тусгагдсан байдаг. Хүн хүрээлэн байгаа орчин, бусад хүмүүс түүнчлэн өөрийгөө тусгаж авч түүнд хариу үйлдэл үзүүлэх, дотоод хандлагаа илэрхийлэх байдал тул хүн бүрийн сэтгэл хөдлөл харилцан адилгүй байдаг. Учир нь хүн аливааг хэрэгтэй, хэрэггүй, сайхан муухай, таалагдах, таалагдахгүй гэх мэтээр үнэлэн дүгнэж өөрийн хандлагаа илэрхийлж

байдаг. Ингэж орчин тойрноо баримжаалах баримжааг өөртөө бий болгох нь сэтгэл хөдлөлийн нэг үүрэг юм. Мөн сэтгэл хөдлөл нь хүн хүрээлэн байгаа орчинтойгоо харьцах туршлагыг амьдралынхаа туршид хуримтлуулах явцдаа хожим ижил төстэй нөхцөлд хэрхэн хандах, даван туулахыг чиглүүлж сэтгэлийн огцом хөөрлөөс хамгаалж байдаг. Энэ нь сэтгэл хөдлөлийн зохицуулан чиглүүлэх дараах гол үүрэг юм. Сэтгэл хөдлөл, мэдрэмж хоёр нягт холбоотой. Эргэн тойрноо хэрхэн хүртэж, тэдгээрт хэрхэн хандаж байгаа нь сэтгэл хөдлөлөөр илэрч байдаг. Харин мэдрэмж нь сэтгэл хөдлөлд үндэслэн бий болдог. (Ц,Д)

СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН ИНДЕКС **(Emotional quotient)³⁴**

Бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох, өөрийн сэтгэл хөдлөлөө хянах чадварыг илэрхийлэх суурь түвшинг хэлнэ. Америкийн сэтгэл судлаач Голмэн (Daniel Goleman) 1995 онд “Сэтгэлийн оюун ухаан (Emotional Intelligence)” хэмээх бүтээлээрээ IQ хэмээх ойлголтыг шинэчилж Emotional Quotient (EQ) буюу сэтгэл хөдлөлийн индекс хэмээх чухал ойлголтыг гаргасан. Голмэны тодорхойлсноор “өөрийн болон бусдын ашигтай үйл ажиллагааг бие махбодоор бус сэтгэлтэй нь харьцан зохицуулах, удирдах хийгээд хүмүүсийг идэвхжүүлдэг, тэднийг чин сэтгэлээсээ ойлгох чадвар юм” гэжээ. EQ нь өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, сэтгэл хөдлөлөө зохистой илэрхийлэх, өөрийгөө урамшуулах, тэвчээртэй байх, үргэлж сэтгэл өөдрөг явах зэрэг цогц чадварыг харуулдаг. EQ өндөртэй хүн өөрийнхөө сэтгэлийн дотоод хөдлөлд автахгүй, биеэ барих чадвар эзэмшсэн байх бөгөөд орчинтойгоо

зохицон, ажлаа амжилттай явуулдаг байна. Ховард Гардсерын онолоор хүмүүсийн оюун ухааны хурд, авхаалж самбааг тодорхойлдог байсан нь хуучирч албан байгууллага ашигтай ажиллахын тулд хүмүүсийн хэр хурдтай сэтгэж, ажиллаж байгаа нь чухал бус, харин ажилдаа өөриймсөг хандах хандлагатай хүмүүсийг чухалчлах болсон бөгөөд тэднийг олж илрүүлэхийн тулд сэтгэл хөдлөлийн индекс (EQ)-ийг ашиглах нь түгээмэл болсон. (Ц,Д)

34 한호섭 (1999), 행정학 용어사전 서울, 행정학용어표준화연구회, 새 정보 미디어

T

ТАЙЛАГНАХ (Reporting) Энэ үг нь Францын “report/reporter” үгнээс үндэстэй ба XIV зууны сүүлээр хэрэглэж эхэлсэн байдаг. Нэр үгийн утга нь “нэг хүний нөгөөд авчирсан хэрэг, цуу яриа”, “гунхаглал, шүүлт, мэдээ” гэсэн санааг илэрхийлдэг. Харин үйл үг нь “мэдэгдэх, хэлэх, холбогдох” “мэдээлэл (данс) бичих эсвэл тэмдэглэх” гэх утгатай.¹ Америкийн улс төр судлаач Лютер Гулик, английн менежментийн зөвлөх Линдалл Урвик нар 1937 онд хэвлүүлсэн “Notes on theory of Organization” бүтээлдээ Хэнри Файолын менежментийн санааг үндэслэн POSDCORB гэх товчлол гаргасан ба үүний R нь Reporting гэх үгний эхний үсэг юм. Тухайн бүтээлд тайлагнах гэдгийг бүртгэл, судалгаа, хяналт шалгалтаар дамжуулан юу болж байгааг гүйцэтгэх удирдлагад мэдээлэхийг хэлнэ гэжээ.² Тайлагнах гэдэгт ажлын бүхий л дэвшилд гарч байгаа өөрчлөлтийн (баримт, мэдээлэл цуглуулах замаар) талаар удирдлагыг мэдээллээр хангах явдал юм.³ Өөрөөр

хэлбэл, тайлагнах гэдэг нь төрийн албан хаагч, төрийн байгууллага нийгэмд явуулсан үйл ажиллагааны төлөө дээд шатны байгууллагын өмнө тайлагнаж ямар хэмжээний хариуцлагатай байснаа дүгнүүлэхийг хэлдэг. Тайлагнахын утга учир нь үйл ажиллагаа хууль ёсны байсан эсэх, байгууллагын зорилго, зорилтын хэрэгжилт, үр дүнг үнэлж холбогдох арга хэмжээг авах явдал байдаг. Эерэг сайн үнэлгээ нь урамшуулал, сайшаалыг дагуулдаг бол сөрөг муу үнэлгээ нь ажлаас чөлөөлөх, цалин урамшууллыг хасах гэх мэт арга хэмжээг бас дагуулдаг. Үр дүнгүй тайлан нь хүмүүсийн дутагдлыг хаацайлах хэрэгсэл болдог. (Т.Т)

ТАМГА (Stamp) Монгол төрийн ёсонд албан бичгийг албажуулах аргын нэг нь тамга дарах байв. Тамга хэрэглэх нь бүр Хүннүгийн үеэс уламжлалтай. Хаан төрийн тамга хэрэглэх ёс нь Найман аймгийг эзэлсэн үеэс Монгол төрийн уламжлал болж, Хубилай хааны үе хүртэл их хааны тамгыг хэрэглэж байжээ. Хубилай хаан ширээнд сууснаасаа хойш өөрийн гэсэн шинэ тамгыг цутган хэрэглэх болсон бөгөөд энэ үеэс Чингис хааны тамга сураг тасарсан аж. 1271 онд улсынхаа нэрийг сольж, Их Юань улс хэмээх болсон ба энэ үеэс Пагва

- 1 Report (n.). (n.d.). Retrieved November 07, 2020, from <https://www.etymonline.com/word/report>
- 2 Nangpuhan II, J. B., & Song, C. G. (2011, October 22). The Notes on the Theory of Organization (Luther Gulick) Retrieved 2020, from <http://paissues.blogspot.com/2011/10/notes-on-theory-of-organization-luther.html>
- 3 Нигроу, Ф.А., Нигроу, Л.Ж. (1998). Орчин үеийн төрийн удирдлага. Улаанбаатар.

ламын зохиосон дөрвөлжин үсгээр бичсэн бичээс бүхий шинэ тамга хэрэглэх болжээ. Тамга нь зориулалт, хийсэн эд, хэмжээ, хэрэглэж байгаа эзний зэрэг дэв зэргээсээ хамааран янз бүр байжээ. Хааны, хатны, хун тайжийн, сайдын зэрэг олон тамга байжээ. Тамгыг хас, ган, алт, мөнгө зэрэг эдээр төө, сөөм, 3, 4 хуруу хэмжээтэй үйлддэг байжээ. Монгол хаадын тамган дээр их хааны сүр хүчийг илтгэсэн бичээс байдаг байжээ. Тухайлбал, Гуге хааны тамган дээр “Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол Улсын далай хааны зарлиг ил болгон иргэн дор хүрвээс биширтүгэй, аюутугай” гэсэн бичээс байжээ. 2007 онд төрийн тамганы хөшөөг төрийн ордны цэцэрлэгт хүрээлэнд босгожээ. Түүний дөрвөн талд хаадын тамганы бичээсийг товойлгон бичжээ. Тамгыг хэрэглэх нарийн ёс жаягтай байжээ. Тамгыг тусгай хайрцагт хадгалах ба хайрцагнаас авахын өмнө, мөргөх, адис авах зэрэг ёслол үйлдэнэ. Хуучны ёсонд тамгыг бичиг хүлээн авагчийн нэр, цаасны залгаас, бичвэрийн төгсгөлд дардаг байв. Амралт баяр ёслол зэрэг тамгыг удаан хугацаагаар хэрэглээгүй үед түүнийг битүүмжилдэг ёстой байжээ. Түүнчлэн тамгыг бичээсээр нь наран зүгт харуулан тавьж, цай идээ барьж, хүндэтгэл үзүүлдэг байсныг тамга амраах ёс хэмээн нэрлэж байв. Тамгыг дараагүй, дутуу, хазгай муруй дарсан бол торгох, ажлаас халах гэх мэтээр шийтгэдэг байсан байна. (А.Ц)

ТАМГЫН ГАЗАР (*Хошуу*) (*Administration of khoshuu*) Хошуудын төрийн хэргийг эрхлэн явуулах газар. Хошууны засаг ноёны тамгыг тэнд хадгалдаг байсан учир ийнхүү нэрлэдэг байжээ. 1992 оны шинэ Үндсэн хуулиар төрийн шинэ тогтолцоог буй болгоход тамгын

газар гэдэг нэрийг дахин хэрэглэжээ. Хошуу тамгын газар нь хошууны албан хэргийг хөтлөн явуулдаг газар тул тэнд ноёд ээлжлэн сууж албан хэргийг толгойлон шийдвэрлэдэг /жасаалдаг/, дээд газраас ирсэн тушаал зааврыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохиодог, тараах ёстой бичгийг хуулбарлан тараадаг, ирсэн, явсан бичгийг тусгай дансанд бүртгэж хошууны албан хэргийг хөтлөн явуулдаг газар байжээ. Шүүхийн шинжтэй үүргүүдийг ч гүйцэтгэдэг байсан байна. Харин өнөө үеийн тамгын газрууд нь Үндсэн хуулиар тодорхойлогдсон төрийн институцүүдийн үйл ажиллагааг дэмжих үүрэг бүхий байгууллагууд юм. Ерөнхийлөгчийн Тамгын газар, аймаг, сум, нийслэл, дүүргүүдийн Засаг дарга тамгын газартай. Эдгээр нь тухайн институцэд мэргэжлийн болон бусад үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй ажээ. Ерөнхийлөгчийн Тамгын газар, засаг даргын тамгын газар гэх мэт тамгын газрууд нь тухайн албан тушаалтанд, мэргэжлийн болон бусад үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй ажээ. (А.Ц)

ТАРИФЫН БОДЛОГО (*Tariff policy*)

Олон улсын худалдааг зохицуулах арга хэрэгсэл бөгөөд анхдагч зорилго нь дотоодын зах зээл, дотоодын үйлдвэрлэгчдийг гадаадаас импортлох, ижил төстэй, хямд үнэтэй бүтээгдэхүүний өрсөлдөөнөөс хамгаалах зорилготой. Тарифын бодлого нь гадаад худалдааны нөхцөл, тоо хэмжээ, цар хүрээг хамарч тодорхойлогддог. Төрөөс тарифын бодлогыг тодорхойлох нь төсвийн орлогыг нэмэгдүүлэх, тодорхой бараа, үйлчилгээний хувьд дотоодын зах зээл, үйлдвэрлэгчийг хамгаалах зорилготойгоос гадна энэхүү арга хэрэгсэл нь улс төр, эдийн засгийн

харилцааны гадаад түншлэлийг өргөн ба хязгаарлагдмал хүрээгээр хэрэгжүүлэхэд ашиглагдана. Тарифын бодлогын үр дүнг урьдчилан үнэлж оновчтой хэрэгжүүлээгүй тохиолдолд дотоодын үйлдвэрлэгчдийг өрсөлдөөнгүй, үр ашиггүй байдалд хүргэх, хэрэглэгчид өндөр үнээр бүтээгдэхүүн, үйлчилгээг авах, аль нэг оронд тарифын хязгаарлалт хэрэгжүүлснээр иргэний дайн, сөргөлдөөн үүсэх зэрэг сөрөг үр дагаварт хүргэдэг.⁴ Тухайлбал, төрөөс импортын гаалийн тарифыг импортын барааны оновчтой бүтцийг бүрдүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, гадаад худалдааны зэрэг тэнцлийг хангах, чөлөөт худалдааны бүсийг хөгжүүлэх, валютын ханшид нөлөөлөх зэрэг зорилгоор тогтооно. (Б.Б)

ТАРХИНЫ ДАЙРАЛТ (*Brainstorming*) Санаа гаргах эсвэл асуудлыг шийдвэрлэх зорилготой бүлгийн хэлэлцүүлэг⁵. Энэхүү бүлгийн хэлэлцүүлэг буюу тархины дайралт ойлголтыг 1950-иад оны бизнесийн орчинд “бүлгийн бүх гишүүдийн санаа бодлыг агуулсан, бүлгийн асуудлыг шийдвэрлэх арга техник, мөн нэг эсвэл хэд хэдэн хүмүүсийн санаа бодлыг нэгтгэж, шийдвэрлэх арга замыг хайж олох” арга гэж томьёолж⁶ байв. Түүнчлэн, дэвшүүлсэн асуудлын талаар санаагаа чөлөөтэй илэрхийлэх боломжтой, үйл ажиллагааг хөгжилтэй, энгийн байхаар нарийн төлөвлөж, зохион байгуулдаг, асуудлыг шийддэг, эсвэл бүтээлч санаануудыг гаргадаг

арга⁷ гэж үзэж болно. Байгууллагын ажилтнууд энэ аргыг хэрэглэхдээ зорилгоо тодорхойлж, оролцогч хүмүүсийн олон талт байдлыг хангах нь чухал юм. Хэлэлцүүлгийг албан бус хэлбэртэй зохион байгуулна. Оролцогч бүр санаагаа хэлж, гарсан санаа, хувилбарыг аливаа шүүмжлэл, үнэлгээ өгөхгүйгээр хүлээн авч, саналуудын жагсаалтыг гаргах нь илүү үр дүнд хүргэнэ. Бүлгийн хэлэлцүүлгийг ажлын байрнаас гадуур төлөвлөх нь үйл ажиллагааг илүү хөгжилтэй болгохоос гадна хайрцагнаас гадуурх сэтгэлгээг хөгжүүлэхэд тусална. Цаг хугацааны хувьд оролцогчид хурдтай боловч яаран сандрахгүй байх хангалттай цаг гарган, зохион байгуулснаар бүлгийн ажиллагаа амжилттай болно⁸. Энэ аргыг бүтээлч сэтгэлгээг өдөөх зорилгоор бодлого, бодлогын арга хэмжээ, зохион байгуулалтын өөрчлөлт хийхэд өргөн хэрэглэдэг. (Д.Ч)

ТАСРАЛТГҮЙ САЙЖРУУЛАЛТ (*Continuous improvement*) Үйл явц, үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах, өсөлт хөгжлийг дэмжих, одоо байгаа түвшнээс үе шаттайгаар дээшлүүлэх, нэмэгдүүлэх байнгын үйл явц нь тасралтгүй сайжруулалт юм. Тасралтгүй сайжруулалт нь аливаа байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг чанарыг хангах явцад нөөцийг хамгийн оновчтой байдлаар хуваарилах зорилготой. Үйл ажиллагаанд хэмжиж болохуйц жижиг ахиц дэвшлийг бий болгон замаар тасралтгүй сайжруулалтыг хангана. Тухайн байгууллагын

4 <https://www.investopedia.com/terms/t/tariff.asp>

5 Оксфорд тайлбар толь, <https://www.lexico.com/en/definition/brainstorming>

6 Мерриам-вэбстер(merriam-webster) тайлбар толь, <https://www.merriam-webster.com/dictionary/brainstorm> How 'Brainstorm' Got Better, <https://www.merriam-webster.com/words-at-play/definition-of-brainstorming>

7 Оксфорд тайлбар толь, <https://www.oxfordlearnersdictionaries.com/definition/english/brainstorming>

8 Knowledge network for government. How To Run Brainstorming Sessions In Government, <https://www.govloop.com/run-brainstorming-sessions-government/>

ажиллагсдын оролцоог сайжруулан үйл ажиллагааны эргэх холбоог хангах нь тасралтгүй сайжруулалтын гол цөм. Байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хадгалагдахын зэрэгцээ, сөрөг нөлөөллийн хамаарлыг тооцоолон даван туулах чадвартай, одоогийн түвшинг үргэлж ахиулах явдал бөгөөд нийтийн салбар энэ нь бодлогын залгамж холбоотой байдал, системийн оролт, гаралтын харилцан хамаарал бүхий эргэх холбоог ханган ажиллах шаардлагатай. Төрийн байгууллагын үйл ажиллагааны чанар, ахиц дэвшил, бүтээгдэхүүн үйлчилгээний үр дүнгийн бодит үр дагавар, төрийн албан хаагчийн ур чадвар, хөгжил, албан тушаалын чиг үүрэгтэй холбоотой дэвшлийг тодорхойлох нь тасралтгүй сайжруулалтын ач холбогдлыг илэрхийлнэ. (Г.Б)

ТАТААС (Subsidy) Төрөөс иргэд, үйлдвэрлэгч эсвэл аль нэг бүс нутагт эдийн засгийн эсвэл нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор хариу төлбөр нэхэхгүйгээр өгч буй санхүүгийн тусламж, дэмжлэгийг хэлнэ. Үйлдвэрлэлийн тодорхой салбар эсвэл үйлдвэрлэгчийн үйлдвэрлэл, тухайн бүтээгдэхүүний хэрэглээг дэмжих зорилгоор татаас өгдөг. Татаас нь шууд ба шууд бус хэлбэртэй. Шууд татаас нь мөнгөн дэмжлэг эсвэл зээлийн хүүг чөлөөлөх зэрэг хэлбэртэй байдаг бол шууд бус татаас нь татвар, хураамжаас чөлөөлөх, татвар, хураамжийн хөнгөлөх, хөнгөлөлттэй зээл, даатгалд хамруулах, ажиллах нөхцөлийн хөнгөлөлт үзүүлэх зэрэг хэлбэртэй байна. Татаас олгож буй субъектээр нь хэрэглэгчид олгох, үйлдвэрлэгчид шууд олгох татаас гэж ангилах ба хэрэглэгчид олгох татаас нь эрэлтийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэгчид олгох

татаас нь нийлүүлэлтийг нэмэгдүүлэх нөлөөтэй. Улс орны аюулгүй байдалд нөлөөлөх стратегийн шинжтэй бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтийг зохицуулах, эсвэл эдийн засгийн тогтворгүй байдал, бусад зах зээлийн үнийн хэлбэлзэлд шууд нөлөөлөх бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг тогтворжуулах зорилгоор ихэвчлэн татаас олгодог. Жишээлбэл, шатахууны үнийг тогтворжуулах зорилгоор импортлогчдоо хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, улаан буудайны нөөц бүрдүүлэх зорилгоор тариаланчдад урамшуулал олгох зэрэг нь татаасын хэлбэр юм. (Б.Б)

ТАТВАР (Tax) Энэ нь Засгийн газрын зардлыг санхүүжүүлэх, өөрөөр хэлбэл улсын төсвийн янз бүрийн зардлыг санхүүжүүлэх зорилгоор төрийн байгууллагаас хувь хүн, хуулийн этгээдэд ногдуулдаг санхүүгийн албадлагын төлбөрийг хэлдэг. Төлбөрөө төлөөгүй тохиолдолд татвараас зайлсхийх буюу эсэргүүцэхийг хуулийн дагуу шийтгэдэг. Татвар нь шууд болон шууд бус татвараас бүрдэх бөгөөд мөнгөөр эсвэл хөдөлмөрийн дүйцэхүйц хэлбэрээр төлж болно. Ихэнх улс орнууд нийтийн, нийтлэг, эсвэл тохиролцсон үндэсний хэрэгцээ, Засгийн газрын чиг үүргийг төлөх татварын тогтолцоотой байдаг. Зарим нь жилийн хувийн орлогоос татварын тогтмол хувийг авдаг боловч жилийн орлогын дүнгээс хамаарч ихэнх татварыг хуваарилдаг. Ихэнх улс орнууд хувь хүний орлогоос гадна аж ахуйн нэгжийн орлогоос татвар авдаг. Улс орнуудад ихэвчлэн эд баялгийн татвар, өв залгамжлалын татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар, бэлэг дурсгалын зүйл, борлуулалтын татвар, цалингийн татвар зэрэг

байдаг. Эдийн засгийн үүднээс авч үзвэл татвар нь өрх, аж ахуйн нэгжүүдээс эд хөрөнгийг Засгийн газарт шилжүүлдэг. Энэ нь эдийн засгийн өсөлт, эдийн засгийн халамжийг нэмэгдүүлэх, бууруулах боломж бүхий үр нөлөөтэй юм. (А.Э)

ТАТВАРЫН АЧААЛАЛ (*Tax burden*)

Худалдан авагч болон худалдагчийн хоорондох татварын дарамтын хуваарилалт юм. Ямар нэг зүйлд татвар оногдуулбал, түүний үнэ татварын хэмжээгээр, эсвэл түүнээс бага хэмжээгээр өсөж болох ба эсвэл огт өсөхгүй байж болох юм. Хэрэв татварын нийт хэмжээгээр үнэ өсвөл худалдан авагч татварыг төлдөг. Үнэ татварын хэмжээнээс багаар өсвөл худалдагч болон худалдан авагч хоёул татварын ачааллыг хувааж үүрнэ. Үнэ нь тэр хэмжээгээр өөрчлөгдөхгүй бол худалдагч татварыг төлнө. Эдийн засгийн хувьд татварын ачаалал нь тухайн татварын эдийн засгийн халамжийн хуваарилалтад үзүүлэх нөлөө юм. Эдийн засагчид эцэст нь татварын ачааллыг үүрч байгаа байгууллагууд болон анх татвар ногдуулдаг байгууллагуудыг ялгаж салгадаг. Татварын дарамт нь татварыг ногдуулахаас өмнө ба дараа нь бодит орлого, үйлчилгээний хоорондох зөрүүгээр хэмжигддэг татварын бодит эдийн засгийн жинг хэмжэдэг бөгөөд татвар нь үнийг хэрхэн өөрчлөхөд хүргэж байгааг харгалзан үздэг. (А.Э)

ТАТВАРЫН БОДЛОГО (*Tax policy*)

Засгийн газраас ямар төрлийн татварыг, ямар хэмжээгээр, хэнд ногдуулахаа сонгох явдал юм. Энэ нь микро, макро эдийн засгийн хувьд харилцан адилгүй нөлөөллийг үзүүлдэг. Макро эдийн засгийн хувьд төвлөрүүлэх татварын нийт тоонд

хамаарах бөгөөд энэ нь эдийн засгийн үйл ажиллагааны түвшинд урвуугаар нөлөөлж болзошгүй юм. Энэ бол төсвийн бодлогын нэг бүрэлдэхүүн хэсэг болдог. Микро эдийн засгийн хувьд шударга байдал (хэнд татвар ногдуулах) ба хуваарилалтын үр ашиг (өөр татварууд нь эдийн засгийн янз бүрийн үйл ажиллагааны хэмжээгээр ямар гажуудалтай нөлөө үзүүлэх вэ) зэрэг асуудлуудтай холбоотой байдаг. (А.Э)

ТАТВАРЫН ОРЛОГО/ЗАРЛАГА (*Tax revenue/expenditure*)

Татварын орлого гэдэг нь улсын төсвийн урсгал орлогыг бүрдүүлэх зорилгоор хуулиар тогтоосон хувь хэмжээгээр татвар төлөгчдөд ногдуулсан төлбөрийн хуримтлагдсан орлого юм. Татвар бол Засгийн газрын орлогын анхдагч эх үүсвэр юм. Орлогыг хувь хүмүүс, аж ахуйн нэгж, худалдаа, байгалийн баялгийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон эсвэл гадаадын тусламж зэрэг эх үүсвэрээс гаргаж болно. (А.Э)

ТАТВАРЫН ЦАХИМ ТАЙЛАНГИЙН СИСТЕМ (*e-Tax system*)

Хувь хүн, албан байгууллага өөрийн тайлангаа татварын албанд цахим хэлбэрээр илгээх тогтолцоо. Татварын албаны үйл ажиллагаанд цахим тайлангийн системийг нэвтрүүлснээр тайланг санхүүгийн программаас шууд илгээх, цахим төлбөрийн баримтын системийн өгөгдлөөс хялбаршуулсан тайланг бэлтгэх, цахим гарын үсгийг ашиглах боломжийг бүрдүүлэх, ингэснээр татварын мэдээллийн шуурхай, бодит байдлыг хангахад үр нөлөөгөө үзүүлдэг. (Д.З; Ч.Л нар)

ТЕМПЕРАМЕНТ (*Temperament*)

Хүний үйл явдал, төрх байдал, зан аашинд илрэн гарч буй сэтгэл зүйн

төрөлхийн шинж чанар. Темперамент бол динамик талаас нь авч үзвэл хувь хүний салшгүй хэсэг болох сэтгэл зүйн хамгийн өөрчлөгддөггүй шинж чанаруудын цуглуулга гэж ойлгож болно. Эдгээр шинж чанаруудын цогцолбор нь хүний сэтгэл зүйн болон сэтгэл хөдлөлийн хариу үйлдлүүдээр ихэвчлэн мэдэгддэг. Темперамент нь зан авирт хоёр үндсэн нөхцөлөөр нөлөөлдөг. Урвалын түр зуурын параметр ба түүний эрч хүч юм. Ихэнх тохиолдолд хүн хүрээлэн буй орчинд хэр зэрэг дасан зохицох нь түүнээс хамаардаг. МЭӨ IV зуунд Грекийн гүн ухаантан Гипократын (МЭӨ 460-370) тайлбарт үндэслэн бие махбод, сэтгэл хөдлөл, зан байдлын хооронд шууд холбоо байдаг гэж үздэг өнөөгийн темпераментын онолын суурийг Гален тавьжээ. Гипократ-Галены онолын дагуу хүний бие махбодод темпераментын төрлөөс хамааран хүн бүрд 4 төрлийн “шингэн /цус, салс, цөс, хар цөс/” гэж нэрлэгддэг тодорхой бодисууд байдаг. Энэ онолын дагуу темпераментын 4 төрлийг ялгаж үздэг. Гипократ:⁹ Сангвиник (Латин хэлэнд (Sanguis) - цус): зүрхнээс гарах цус их хүмүүс нүүрний баясгалантай, дооно золбоотой, сэргэлэн, түргэн авхаалжтай. Флегматик (Латин хэлэнд (Phlegmatikos) - салс): тархинаас ялгаруулах салс ихтэй хүн сэтгэлийн хөдөлгөөн багатай, гөлгөр, удаан залхуу. Холерик (Латин хэлэнд (Khole) - цөс): элгэнээс ялгарах цөс ихтэй хүн шаралхуу, ууртай, түргэн, гөжүүд. Меланхолик (Латин хэлэнд (Melasses) - хар, цөс - цөс): цөсний уутнаас ялгарах хар цөс ихтэй хүн гунигтай, өлбөгөр, сул хартай гэжээ. Темпераментын гадаад илрэлийг Гипократ зөв тодорхойлсон боловч түүний физиологийн үндсийг

тайлбарлахдаа төөрөлдсөн гэж эрдэмтэд үздэг. Темпераментын физиологийн үндсийг анх удаа оросын эрдэмтэн И.П.Павлов нээсэн бөгөөд тэрээр хувь хүний зан үйлийн үндэс нь темперамент гэж үзэн үндсэн 4 темпераментийг тодорхойлсон байдаг. Үүнд: Сангвиник темпераментын хүн хүмүүстэй амархан үг хэлээ ололцож, амьдралын баяр баясгалантай, нэг төрлийн үйл ажиллагаанаас нөгөөд амархан шилжин ордог, нэгэн хэвийн ажилд дургүй, сэтгэл хөдлөлөө амархан барьж шинэ орчинд амархан дасан зохицдог. Хурдан, чанга, тод яриатай, нүүрний хувирал, гарын дохио зангааг өргөн хэрэглэдэг. Флегматик темпераменттай хүний зан үйлдэл их төвшин, нэг үйл ажиллагаанаас нөгөөд удаан шилждэг, идэвх султай, үйл ажиллагаанд өдөөхийн тулд дотоодоос нь ямар нэг түлхэц өгөх хүч хэрэгтэй байдаг. Өөрийгөө эзэмдэх чадвартай, тэвчээртэй, сэтгэлийн хөдлөлөө хурцаар илэрхийлдэггүй, тогтуун яриатай. Холерик темпераменттай хүмүүс ажлын өндөр эрч хүчтэй, идэвхтэй. Тэд аливаа саад бэрхшээлийг туулан эрчтэй дайчин ажиллаж чаддаг. Маш их эрч хүч гаргасны дараа туйлдах, хямралд орох нь бий. Сэтгэл хөдлөл тогтворгүй. Дүрсхийсэн, шулуухан өөрийгөө дөвийлгөх хандлагатай. Хурдан түргэн ярьдаг. Меланхолик темпераментын хүмүүс маш эмзэг сэтгэлтэй, сэтгэл хөдлөл тогтворгүй, Шинэ нөхцөлд удаан дасан зохицдог. Бүтэлгүйтлийг эмзэг хүлээн авдаг. Аливаа зүйлд болгоомжтой ханддаг, ичимхий, шийдмэг бус. Гэхдээ тэдэнд бусад хэв шинжээс илүү гойд сайн мэдрэмж заяасан байдаг тул аливаа зүйлийг бодитойгоор үнэлэх чадвартай. Эдгээр 4 хэв шинж бүгд

9 П.Увш, Б.Хэрлэн (2017). Байгууллагын зан үйл. Улаанбаатар. х. 27.

сайн ба муу талтай тул сайн муу гэж ялгах аргагүй. Темпераментын аль нэг шинж дангаараа хэн нэгэнд агуулагдах нь үгүй. Аль нэг голлох шинжээр нь тухайн хүний темпераментыг тодорхойлдог байна. Тиймээс менежер үүрэг даалгаврыг оноох явцдаа ажилтнуудынхаа сэтгэл зүйн шинж чанаруудаас темпераментын онцлогийг анхаарах нь зүйтэй юм. (Ц.Д)

ТЕНДЕР (Tender) Энэ нь бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ эсвэл ямар нэгэн зүйл хийхийг шаардсан хувь хүн эсвэл аж ахуйн нэгжийн үнийн шошгыг тогтоох санал (ихэвчлэн өрсөлдөөнтэй) юм. Тендерийг ямар нэг зүйлийн өртөг эсвэл үнэ цэнийг тодорхойлоход ашигладаг. Тендерийг тухайн нөхцөл байдлын нөхцөл байдалд үндэслэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөлөөн дор хүн гүйцэтгэж болно. Дуудлага худалдаа, хөрөнгийн бирж, үл хөдлөх хөрөнгийн хүрээнд тухайн бизнес эсвэл хувь хүн төлөхийг хүсэж буй үнийн саналыг тендер гэж бас нэрлэдэг. (А.Э)

ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ (Tender document) Захиалагчаас тендерг оролцогчид зориулан гаргасан тендер шалгаруулалтын нөхцөл, шаардлагыг тодорхойлсон баримт бичгийг¹⁰ хэлнэ. (А.Э)

ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА (Technical cooperation) Техникийн хамтын ажиллагаа нь хөгжиж буй орнуудад тусламж үзүүлэх гол хэлбэрүүдийн нэг бөгөөд энэхүү үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудад үзүүлэх боломжтой байдаг. Техникийн хамтын ажиллагааг дараах байдлаар

тодорхойлно¹¹: хөгжиж буй орнуудын хүмүүсийн мэдлэг, ур чадвар, техникийн мэдлэг, бүтээмж чадавхыг дээшлүүлэх үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг зөвлөх үйлчилгээ, техникийн дэмжлэг, ноухау өгөх зэрэг үйлчилгээ зэрэг болно. Техникийн хамтын ажиллагааны үндсэн хоёр төрөл байдаг.¹²

-Ямар нэгэн тодорхой хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэхгүйгээр үндэсний ерөнхий чадавхыг бэхжүүлэх зорилгоор техникийн болон менежментийн ур чадвар, технологийг шилжүүлэхэд чиглэсэн эх үүсвэрээр хангах чөлөөт техникийн хамтын ажиллагаа

-Тодорхой хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай техникийн үйлчилгээ үзүүлж буй хөрөнгө оруулалттай холбоотой техникийн хамтын ажиллагаа юм. (З.А)

ТИНК ТАНК (Think tank) Тинк танк нь төр засгийн үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг хувийн болон төрийн байгууллага юм. Тинк танк нь байгууллага, корпорац, зохион байгуулалттай бүлэг хэлбэрээр үйл ажиллагаа явуулах бөгөөд улс төрийн бодлогын өргөн хүрээтэй асуудлаар бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг. Тэдний үйлчлүүлэгчдэд зөвхөн төр, засгийн байгууллагаар хязгаарлагдахгүй хувийн хэвшлийн-хэн ч багтана. Тинк танк нь дэлхийн II дайны үед цэргийнхний дунд стратеги, төлөвлөгөө хэлэлцэх аюулгүй газар гэсэн утгаар анх хэрэглээнд оржээ.

11 Rob, T. (2013). Technical cooperation: Investments to End Poverty discussion paper. Development Initiatives, p.2.

12 IMF. (2014). External Debt Statistics: Guide for Compilers and Users – Appendix III, Glossary. Washington DC: International Monetary Fund, p. 249.

10 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

АНУ-д 1960-аад оноос бодлогын судалгаа хийдэг ашгийн бус байгууллагуудыг нэрлэх болсон байна. Канад, Их Британи, Австрали, Германд мөн адил тинк танкууд хүчтэй хөгжсөн байдаг. Европын тинк танкууд АНУ-аас өөр бүтэц, зохион байгуулалттай. Тухайбал: Германы тинк танкууд нь ихэвчлэн төрөөс санхүүждэг, ямар нэгэн улс төрийн нам, их сургуулийг түшиглэсэн байдаг. Олон улсад алдартай томоохон тинк танкууд: “Олон улс, стратегийн судалгааны хүрээлэн” (CSIS), РАНД (RAND) төр, засаг, олон улсын байгууллагууд, хувийн компаниудад зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд Брукингийн институт (BROOKINGS) нь засаглал, гадаад бодлого, дэлхийн эдийн засаг, эдийн засгийн хөгжлийн чиглэлээр бодлогын судалгаа хийдэг, Германы олон улс, аюулгүй байдлын хүрээлэн (SWP) зэргийг нэрлэж болно. Тинк танкуудын нийтлэг шинж нь бодлогын асуудлуудад төвлөрч ажлын шаардлагатай мэдлэгийг бүтээж бий болгох, бодлого боловсруулах үе шатанд идэвхтэй оролцон шаардлагатай нөхцөлд бодлогын үйл явцад нөлөөлөх явдал юм. Тинк танк нь мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн судлаач, шинжээчдээс бүрдэх бөгөөд энэ нь тэдний хийдэг судалгааны үнэ цэнэ, хүлээн зөвшөөрөгдөх байдлыг нэмэгдүүлдэг. Өөр нэг чухал шинж чанар нь байнгын идэвхтэй үйл ажиллагаа явуулж хурал, семинарт оролцох, судалгааны бүтээл хэвлүүлдэг. (Ж.Ж)

ТОГЛООМЫН ОНОЛ (*Game Theory*)

Эдийн засгийн харилцаанд оролцогчдын үйлдвэрлэлийн хэрэгсэл, гарцын талаарх сонголт, шийдвэрийн хувилбарыг судалдаг ухаан бөгөөд анх 1944 онд Жон вон Нойманн (John von Neuman) ба Оскар Моргенштерн (Os-

kar Morgenstern) нарын боловсруулсан математикийн томьёоллоос үүсэлтэй. Тоглоомын онолд авч үздэг хийсвэр загвар нь хэд, хэдэн оролцогч байх, оролцогч нь тодорхой нөхцөлд өөрийн зорилгыг биелүүлэх үйлдлийг сонгоно, уг үйлдэл нь бусад оролцогч болон зах зээлийн нөхцөлд нөлөөлнө, оролцогчдын зорилго, хийх үйлдэл, сонголт нь математик загвараар илэрхийлэгдэнэ гэсэн үндсэн нөхцөлтэй байдаг. Нэг зах зээлд ажиллах хоёр болон түүнээс олон оролцогч өөрсдийн хязгаарлагдмал нөөцөө хамгийн үр ашигтай ашиглах зорилго бүхий стратегийн шийдвэр гаргаж хэрэгжүүлснээр харилцан ашиг, орлогодоо нөлөөлдөг ба оролцогчдын шийдвэр гаргах хувилбаруудыг загварчлан тус бүрдээ олох ашиг, алдагдал болон нийт зах зээлийн ашиг, алдагдлыг тооцоолж болно. Энэчлэн тоглоомын онол, загварыг ашиглан шийдэл шаардаж байгаа асуудал, нөхцөл байдлыг загварчлан цаашид уг “тоглоом” үргэлжилбэл ямар үр дүн гарах, оролцогчид ямар шийдвэр гаргах зэргийг таамаглан төрөөс хэрэгжүүлэх аливаа бодлогын үр нөлөөг урьдчилан тооцож бодлогын хувилбарыг үндэслэлтэй боловсруулахад энэ аргыг ашиглана. Төрийн бодлогын шинжилгээнд тоглоомын онолыг ашиглахаас гадна улс төрийн сонгуулийн стратеги боловсруулах, хөрөнгө оруулалтын хэлцэл хийх зэрэгт ч тоглоомын онолыг ашиглаж болно. (Б.Б)

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ (*Stability*)

Аливаа үзэгдлийн төлөв байдал, чанар, оршихуйн хэлбэр нь хэлбэлзэл багатай, тогтуун байхыг тогтвортой байдал гэнэ. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн хувьд тогтвортой байдлын зарчим, шалгуур үзүүлэлтийг

тодорхойлж төрийн бодлогод тусгаж хэрэгжүүлдэг. Байгаль орчин, нийгэм, эдийн засаг гэсэн үндсэн тулгуур асуудалд харилцан уялдаатай, жигд ач холбогдол өгч хөгжүүлснээр тогтвортой хөгжлийн зарчим биелдэг. Тухайлбал, эдийн засгийн тогтвортой байдал гэдэг нь эдийн засгийн голлох үзүүлэлтүүд болох бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн ерөнхий түвшин, үйлдвэрлэл, засгийн газрын зардал өндөр хэлбэлзэлгүйгээр жигд өсөхийг хэлнэ. Тогтвортой эдийн засгийн хувьд дотоодын нийт бүтээгдэхүүн жигд өсөлттэй, инфляц тогтвортой бага, зээлийн хүү тогтвортой, улсын төсвийн өсөлт, бууралт жигд тогтвортой байх зэрэг шалгуурыг хангаж байдаг. Түүнчлэн нийгэмд ядуурал, ажилгүйдэл эрс багассан, хүн амын дундаж давхарга давамгайлсан нөхцөлд эдийн засаг тогтвортой хөгжинө. Энэхүү нийгэм, эдийн засгийн хөгжлийн суурь хүчин зүйл нь байгаль орчны асуудал бөгөөд байгалийн нөөцийг зохистой ашиглаж хүрээлэн буй орчинд ээлтэй байх нь тогтвортой байдал, тогтвортой хөгжлийн гол шалгуур болдог. (Б.Б)

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ (*Sustainable Development*) Тогтвортой хөгжил бол хойч үеийнхнийг хангах боломжийг алдагдуулахгүйгээр өнөөдрийн хэрэгцээг хангах тухай хөгжлийн үзэл баримтлал, даян дэлхийн тунхаг. 1987 оны Брунтландын Комиссын тунхаглалаас эхтэйгээр 1992 оны Рио де Жанейрогийн “Байгаль орчин ба хөгжил” нэртэй Риогийн чуулга уулзалтаар бүрэн утгаа олж Монгол Улс ч нэгдэн орсон билээ.

Энэ цагаас эхлэн гишүүн орнууд өөр өөрсдийн XXI зуунд баримтлах тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрөө боловсруулах үүрэг

авч, түүний дагуу ажиллаж эхэлсэн. Тогтвортой хөгжил бол байгалийн баялаг, технологийн хөгжил, хөрөнгө оруулалт ба засаглалын өөрчлөлтийг ашиглан одоо болон ирээдүй үеийнхээ төлөөэрэлтхэрэгцээгхохиороохгүйгээр нийгэм бүхэлдээ хөгжих үйл явц юм. Хөгжил бол тасралтгүй үйл явц бөгөөд байнгын төгөлдөршихүйд чиглэсэн хөдөлгөөний үр дүн юм. Ийм учраас хөгжил хөдөлгөөний зохистой үр дүн болсон тогтвортой хөгжил бол уг чанараараа тултай хөгжил мөн. Хөгжил хөдөлгөөнгүй орон цагийн хүрэн дэх юмс үзэгдэл гэж үгүй билээ. “Амьдрал хэмээх нь эцэс төгсгөлгүй төгөлдөршилт юм. Өөрийгөө төгөлдөр гэж бодвоос биеэ хөнөөж байгаа хэрэг” /Гегель/ бөгөөд, тэр хирээрээ эрх чөлөөт амьдралын чанар руу тэмүүлж байдаг. Энэ утгаараа “хөгжил бол эрх чөлөө” /Амарти Сен/ бөгөөд “эрх чөлөө нь ухамсарлагдсан зайлшгүй” /Спиноза/ байдаг.

Монгол Улсын “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоол 2020 оны 05 сарын 13-нд гарсантай холбогдуулан өмнө баталсан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” урт хугацааны бодлогын баримт бичгийг цуцалсан. Ийнхүү хөгжилд чиглэсэн үзэл баримтлал, бодлого, бодлогын үндэс, стратеги, үндсэн чиглэл, үндэсний хөтөлбөр, хөтөлбөр, төлөвлөгөө, дэд хөтөлбөр, төсөл гэсэн хөгжлийн баримт бичгүүд олноор батлагдаж эдүгээ тэдгээрийн тоо 168-д хүрээд байна. Энэ бүгдийг хэрэгжүүлснээр Монгол Улс 2030 он гэхэд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсөж байгаа эдийн засгийн

олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан улс болох ёстой юм. Хөгжил бол юмс үзэгдэл өөрөө өөрөөсөө салаалан цэцэглэж, салаалсан нь бие даан төгөлдөржиж, улмаар эргээд нэгдмэл холбоонд орж харилцан уялдан зохицолдож найрсах үйл явц хэмээн үзсэн байх ба нийгмийн хөгжил нэг найрслаас нөгөө дэвшилтэт найрсал руу шилжих хөдөлгөөн /Б.Даш-Ёндон/ юм. Энэ утгаараа тогтвортой хөгжил бол нэгдмэл, хамтын, нийгмийн тэр дундаа хөгжлийн тулгуур салбаруудын хоорондоо зохицолдсон, шүтэн барилдсан хөгжил, хөдөлгөөн болж байна. (Б.П)

ТОГТОЛЦООНЫ ЗАГВАРЧЛАЛ *(System design)*

Мэдээллийн системийг хөгжүүлэх үндсэн үе шат бөгөөд тухайн системийн тогтоосон шаардлагыг хангах архитектур, бүтээгдэхүүний загвар, бүрэлдэхүүн хэсэг, интерфейс болон өгөгдлийг тодорхойлох үйл явц. Зарим талаараа системийн шинжилгээ, системийн архитектур болон системийн инженерчлэлтэй давхцадаг. Аливаа байгууллагын хувьд систем захиалан хийлгэхэд хэрэгцээгээ зөв шинжилж, хэрэглэгчийн хувьд системийн шаардлагаа сайн тодорхойлох нь системийн дизайн бүрэн зөв тодорхойлох нөхцөл болдог. Ингэснээр системийн хөгжүүлт төлөвлөгөөний дагуу дуусаж захиалагчийн шаардлагад нийцэх нөхцөл болдог. Төрийн байгууллага өөрийн захиалан гүйцэтгүүлэх системийн хувьд хэрэгцээ шаардлагыг шинжлэх, шаардлагыг тодорхойлох, системийн дизайныг боловсруулах шат, хөгжүүлэх, турших, зүгшрүүлэх

шат гэж хоёр үе шаттай хэрэгжүүлэх нь төсөл амжилттай хэрэгжих үндэс болно. (Д.З, Ч.Л нар)

ТОДОРХОЙ БУС БАЙДАЛ (*Uncertainty*) Мэдэгдэж эсвэл үл мэдэгдэж байгаа зүйлтэй холбоотой мэдлэгийн хязгаарт тархаж буй шинж тэмдэг¹³. Тодорхойгүй байдал нь хангалтгүй мэдээллийн нөхцөл байдал¹⁴. Тодорхойгүй байдал нь бодит бус байдал, найдваргүй байдал, мэдлэггүй байдалтай гэсэн гурван хэлбэртэй холбоотой. Маш их мэдээлэлтэй үед эргэлзээ давамгайлж болно¹⁵. Цаашилбал, шинэ мэдээлэл нь тодорхой бус байдлыг бууруулж эсвэл нэмэгдүүлэх боломжтой. Нарийн төвөгтэй үйл явцын талаарх шинэ мэдлэг нь урьд өмнө мэдэгдээгүй эсвэл дутуу үнэлэгдэж байсан тодорхойгүй байдлыг илрүүлж болзошгүй юм. Тодорхой бус байдлын гурван хэмжээсийг ялгасан байдаг¹⁶. Үүнд: байршлын тодорхойгүй байдал - тодорхойгүй байдал нь загвар, цогцолбор дотор илэрдэг газар; тодорхойгүй байдлын түвшин - тодорхой бус байдал нь мэдлэгийн дөрүүтэй байдалд илэрдэг; тодорхойгүй байдлын мөн чанар - тодорхой бус байдал нь мэдлэгийн төгс бус байдал эсвэл тайлбарлаж буй үзэгдлүүдийн мөн чанар өөрчлөгдөх байдалтай холбоотой эсэх. (Г.Б)

ТОКВИЛЬ, АЛЕКСИС ДЕ (*Alexis Charles Henri Clerel, comte de Tocqueville, 1805-1859*) Францын

- 13 Joshua Wakeham: Uncertainty: History of the Concept, Tuscaloosa 2015, p. 716.
- 14 Funtowicz, S.O. and Ravetz, J.R.: Uncertainty and Quality in Science for Policy. Kluwer Academic Publishers, Dordrecht, 1990.
- 15 Van Asselt, M.B.A. and Rotmans, J.: Uncertainty in Integrated Assessment Modelling: from Positivism to Pluralism. Clim. Change 54 (2002), pp. 75-105.
- 16 W.E. Walker, P. Harremoes...: Defining Uncertainty A Conceptual Basis for Uncertainty Management in Model-Based Decision Support, Netherlands 2003, p. 6.

язгууртан, дипломатч, улс төр судлаач, түүхч. Мецийн лицейд суралцсан. 1839 оноос улс төрд оролцож 1851 онд Манче мужийн доод танхимын гишүүн болжээ. 1847 оноос залуу зүүнийхний намд орж цалин нэмэх, өсөн нэмэгдэх татвар тогтоох асуудлыг дэмжих болжээ. 1849- 1852 онуудад Манчийн ерөнхий захирагч болсноор тухайн үеийн улс төрийн нөхцөл байдлаас болоод баруун ба зүүн жигүүрийн алинд ч итгэхээ больж Францаас гадагш явах болсон байна. 1848 оны хувьсгалын дараа парламентын гишүүн болж 2-р бүгд найрамдах улсын үндсэн хуулийг боловсруулах комисст орж ажиллажээ. Тэрбээр хоёр танхимтай парламент байх, ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар сонгох асуудлыг дэмжиж байсан байна. 1849 онд Гадаад хэргийн сайд болжээ. Тэр бүр 1831 онд АНУ дахь шорон гяндангийн байдалтай танилцах үүрэг авч найз Густав Бемонтой хамтран уг үүргийг гүйцэтгэжээ. Энэ явцдаа шоронгоос гадна Америкийн нутгаар аялж, Канадын Монреал, Квебек хотуудаар очсон ажээ. Америкаас буцаж ирснийхээ дараа “Америк дахь ардчилал” (De la démocratie en Amérique) гэсэн гарчигтай тайлан бичсэн нь 1835 онд хэвлэгдсэн. Түүндээ Америкт буй болж байгаа хөрөнгөтний ардчиллын талаар шинжилгээ хийн: хувь хүмүүсийн амьдралын дээшлэлт, тэдний зах зээл болон төрд хандах хандлага зэргийг шинжлэн ардчиллын давуу талыг харуулсан байна. Токвиль хэд хэдэн ном бичсэний дотор дурдсан зохиолоос гадна “Хуучин дэглэм ба хувьсгал” зохиол нь бас алдартай ажээ. Тэрээр өөрийгөө аль ч намын тал биш харин эрх чөлөөг шүтэгч хэмээн зарлаж байсан боловч хожим клубуудын эрх чөлөө, хэвлэлийн эрх

чөлөөг хязгаарлах хуулийг дэмжиж байсан нь тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалсан хэрэг байв. (А.Ц)

ТОЛИЛУУЛГА-ТОДРУУЛГА (*санхүүгийн тайлангийн*) (*Disclosure of financial statements*) Санхүүгийн тайлан нь байгууллагын санхүүгийн төлөв байдлыг гадаад ба дотоод хэрэглэгчдэд бүрэн мэдээлэх үүрэгтэй. Иймд хэрэглэгчдэд иж бүрэн ойлгомжтой мэдээлэл өгөх зорилгоор санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн үзүүлэлтийн тайлбар, нэмэлт мэдээлэл нь толилуулга-тодруулгад тусгагддаг. Тайлангийн тодруулгад тайлангийн хугацааны өмнөх үеийн үйл явдалд хийсэн залруулга, актлагдсан хөрөнгө, даатгалын гэрээнд орсон өөрчлөлт, байнгын давтамжтай биш ч тухайн тайлангийн хугацаанд байгууллагын санхүүгийн үр дүнд нөлөө үзүүлэхүйц үйл явдал, ажил гүйлгээний талаарх мэдээлэл зэрэг тайланд үзүүлсэн тоон мэдээллийг тодруулж тайлбарлахуйц, тайлангийн хэрэглэгч (төр, хөрөнгө оруулагч, удирдлага)-д хандсан мэдээллийг тусгадаг. (Б.Б)

Т **ТООН ГАРЫН ҮСЭГ** (*Digital signature*)

Цахим баримт бичгийг хуурамчаар үйлдэх, хууль бусаар өөрчлөхөөс хамгаалах зорилгоор тоон гарын үсгийн хувийн түлхүүр ашиглан мэдээллийг криптограф хувиргалтад оруулж үүсгэсэн, уг баримт бичгийн бүрдэл болох цахим гарын үсгийн төрөл. (Тоон гарын үсгийн тухай хууль) Тоон гарын үсгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс олгосон тоон гарын үсгийн гэрчилгээ бүхий иргэн, хуулийн этгээд хэрэглэж болно. Төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээд цахим баримт

бичгийг бусдад шилжүүлэх, дамжуулахдаа зөвхөн тоон гарын үсэг хэрэглэнэ. (Д.З; Ч.Л нар)

ТООН ТЕХНОЛОГИЙН БОЛОВСРОЛ *(Digital literacy)*

Танин мэдэхүйн болон техникийн ур чадвар шаардсан мэдээллийг хайх, үнэлэх, бий болгох, бусадтай харилцахад харилцаа холбооны технологийг ашиглах чадвар. Тоон технологийн төрөл бүрийн платформыг зөв зохистой ашиглахад тоон технологийн боловсрол нэн чухал бол орчин үеийн ажлын байрны шаардлагад ч үүнийг шаардах болжээ. Ялангуяа төрийн албан хаагчдын ажлын байрны зайлшгүй шаардлага байх ёстой. Монгол Улсын зарим бодлогын баримт бичигт тоон бичиг үсэгтэн, тоон бичиг үсэгт тайлагдсан байдал гэдэг нэр томьёог хэрэглэсэн байдаг. Улс орнуудын засгийн газар бүх нийтийн тоон технологийн боловсролыг олгох төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газраас 2012-2016 онд хэрэгжүүлсэн Цахим Засаг үндэсний хөтөлбөрийн нэг зорилт нь “Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, төрийн цахим үйлчилгээг ашиглах мэдлэг иргэдэд олгох” байсан. Мөн 2021 оноос хэрэгжүүлэх Цахим үндэстэн болох стратегийн зорилготой цогц арга хэмжээний нэг зорилт нь “Тоон бичиг үсэгтэн” бөгөөд энэхүү зорилтыг хэрэгжүүлэх үүднээс “Цахим орчин дахь хэрэглээний ур чадвар, боловсролыг дэмжих” үндэсний хөтөлбөрийг боловсруулж байна. (Д.З; Ч.Л нар)

ТОТАЛИТАРИЗМ *(Totalitarianism)*

Латин хэлний “totalitas” буюу бүхэл, бүтэн, нийлбэр гэсэн утгатай үг

бөгөөд улс төрийн дэглэмийн нэгэн хэлбэр. Төр засгийн зүгээс хувь хүний бүхий л үйл ажиллагаа, үзэл бодлыг бүхэлд нь хянаж, дээрээс тогтоосон нэг үзэл сурталд захируулах засаглалын тогтолцооны мөн чанар, арга хэлбэрийг хэлнэ. Тоталитар дэглэм цорын ганц үзэл суртал, түүнийг үндэс болгосон нэг намын дарангуйлал, нийгмийг хянах, тагнах, албадах үүрэгтэй цэрэг, цагдаа, нууц албадын хүчирхэг тогтолцоо, нийгмийн гишүүдийг зэрэглэн дугаарлах хатуу дэглэм. Тухайлбал, коммунист нийгэмд ажилчин анги, фашист нийгэмд арми, үндэстэн бүхнээс дээгүүр байж, хувийн өмчийг үгүйсгэсэн, эдийн засгийг төрөөс хатуу хянаж, тэр байтугай хувь хүн, гэр бүлийн амьдралд хутгалдан ордог зэрэг үндсэн шинжүүдээр илэрдэг. Энэ дэглэмийн үед төрийн удирдлага бүх түвшиндээ шатлан захирах, дарангуйлах, хянах, албадах, хүчирхийлэх зэрэг үйл ажиллагааны хэлбэрүүд зонхилж, төвлөрсөн удирдлагаас шууд хамааралтай болдог. (Я.Т)

ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ *(Regulatory agencies)*

Тохируулагч агентлагууд нь засгийн газрын тодорхой салбар, хүрээний бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй яамны харьяа, эсвэл бие даасан төрийн захиргааны байгууллага юм. Агентлаг нь тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүргээрээ ялгаатай ажилладаг. Тохируулагч агентлагууд нь хууль тогтоомж, ерөнхийлөгчийн зарлиг, засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих, салбарын асуудлын хүрээнд дүрэм, журам, стандарт тогтоох, хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх арга

хэмжээ авах зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг. Тохируулагч агентлагийн үзэл санаа анх түрүүн АНУ-д бүрэлдсэн бөгөөд хамгийн анхны тохируулагч агентлаг нь муж хоорондын худалдааны комисс байв. Уг комисс төмөр замын тээвэр, улмаар усан зам, нефтийн компаниудын үйл ажиллагааг зохицуулж байв. АНУ-аас бусад бараг бүх оронд тохируулагч агентлагийн үүргийг засгийн газрын ерөнхий захиргааны нэгж, газрууд хариуцдаг. Монгол Улсад агентлаг нь тохируулах болон хэрэгжүүлэх гэсэн хоёр чиг үүрэгтэйгээр хуваагддаг бөгөөд Тагнуулын ерөнхий газар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Үндэсний хөгжлийн газар, Төрийн тусгай хамгаалалтын газар, Биений тамир, спортын улсын хороо, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Стандарт, хэмжил зүйн газар, Зэвсэгт хүчний жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар гэсэн 12 тохируулагч агентлаг ажиллаж байна. (Ж.Ж)

ТОХИРУУЛГА (Regulation) Энэ үг нь Латины “regulatus” (XV зуун) гэх үгнээс үндэстэй. Үгийн утга нь “дүрмээр тохируулах, хянах (adjust by rule, control)” юм. Regulation(n.) нэр үг нь 1670 оноос “зохицуулах акт (act of regulating)”, 1715 оноос “менежментийн дүрэм (rule for management)” гэх утгаар хэрэглэгдэх болсон.¹⁷ Энэ үгийн гол утга нь ямар нэг зүйлийг “дүрмээр зохицуулах, хянах” үйл ажиллагаатай холбоотой. Гэхдээ энд зохицуулалт бүхий дүрэм нь тухайн нөхцөл байдалдаа тохирохоо больсон тохиолдолд түүнд өөрчлөлт оруулах

үйл явцыг мөн хамаатуулж ойлгоно. Тухайлбал, бодлого зохицуулалт (policy coordination) нь засгийн газрын бодлогын тууштай, ил тод, урьдаас тодорхой байдалд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг хэдий ч бодлогын үр нөлөөтэй зохицуулалтыг дангаараа хангаж чаддаггүй. Ажиллагааны өдөр тутмын зохицуулалтын дийлэнх нь захиргааны доод түвшинд хийгддэг. Иймээс улс орнууд тохируулах чиг үүрэг бүхий байгууллагыг олон шалтгаан (иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих гэх мэт)-аар бий болгодог. Эдгээр байгууллагууд тохируулах чиг үүрэг гүйцэтгэхийн сацуу үйлчилгээ үзүүлж болдог. Монгол Улсад Засгийн газрын тохируулагч (regulatory agency) ба хэрэгжүүлэгч агентлаг (implementing agency) гэж байдаг. Тохируулагч агентлаг нь хууль тогтоомж, стандартыг сахиулах, харин хэрэгжүүлэгч агентлаг нь иргэд, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хүргэх замаар бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байдаг. Төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журмыг боловсруулж, нийгмийн амьдралын олон талт байдлын балансыг тохируулах, үйл ажиллагааг нь зохицуулах шаардлагатай болдог. (Т.Т)

ТӨВ ЗАСГИЙН ГАЗАР (Central Government) Төв засгийн газар нь улсын хэмжээнд эдийн засаг, нийгмийн асуудлыг эрхлэн хариуцдаг төрийн захиргааны бүх байгууллага, холбогдох агентлаг, газруудаас бүрдсэн бүхэл цогц бүтэц юм. Төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улсын засаг захиргааг төв засгийн газар хянадаг. Төв засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн нь тухайн улсын хүн амын тоо, газар нутгийн хэмжээ

17 Online Etymology Dictionary. Regulation. Retrieved from <http://www.etymonline.com/search?q=regulation>

болон бусад, онцлогоос хамаарч өөр өөр байх боловч гол шинж нь нийт улсын хэмжээнд төрийн хууль, бодлого хүчин төгөлдөр үйлчилнэ. Холбооны улсын хувьд үүний эсрэгээр орон нутгийн засаг захиргаа нь өөрийн нутаг дэвсгэрт төв засгийн газраас харьцангуй хараат бус үйл ажиллагаа явуулж, өөрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагатай байдаг. Аливаа улсын төв засгийн газрын эрх мэдэл нь улс орны бүх нутаг дэвсгэрийг хамардаг. Төв засгийн газар нь улсыг батлан хамгаалах, төсөв санхүүг батлах, захиран зарцуулах, гадаад харилцаа, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангах, тухайн улсын нийгэм, эдийн засгийн тогтолцоог зохицуулах зэрэг өргөн хүрээтэй төрийн үйлчилгээг үзүүлнэ. Бүх нийтийн боловсрол, эрүүл мэнд, халамжийн үйлчилгээ үзүүлэх зардлыг засгийн газар хариуцдаг. (Ж.Ж)

ТӨВИЙГ САХИХ (Neutrality) Төвийг сахих тухай ойлголт нь төрийн захиргааны ухаанд төрийн албан хаагч нь хувийн улс төрийн чиг хандлага, ашиг сонирхлоос үл хамааран иргэдэд шударга, эрх тэгш хандах урьдчилсан нөхцөл байдал юм. Их Британид XIX зууны дунд, АНУ-д XIX зууны сүүлч үед төрийн албаны шинэчлэлийн хүрээнд улс төрийн ивээл, тэтгэмжийн буюу патроны (patronage) харилцааг багасгасан байдаг. Үүний дараа Британийн колони орнуудад үүнтэй адил төрийн захиргаанд төвийг сахих зарчмыг нэвтрүүлж, хамгаалахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч байв. АНУ-ын 28 дахь ерөнхийлөгч байсан нэрт судлаач В.Вилсон (1887) төрийн захиргааг улс төрөөс ангид байлгах үзлийг дэмжигчдийн анхдагч байв. Төрийн албанд төвийг сахих зарчмыг

мэргэжлийн ёс зүй, мерит зарчим, ур чадварыг төрийн албан хаагчдад төлөвшүүлэх замаар нэвтрүүлэх боломжтой. Энэ нь төрийн албан хаагч улс төрийн ямар нэгэн үйл ажиллагаанд огт оролцож болохгүй гэсэн үг биш боловч, тодорхой хязгаарлалтууд байх ёстой. Төр нь нөгөө талаас төрийн албан хаагчдыг улс төрийн шахалт, нөлөөнөөс ангид ажиллах нөхцөл, цалин хангамжийг бүрдүүлж, нийгмийн баталгааг хангах шаардлагатай. Бельги, Франц, Итали, Их Британи, АНУ зэрэг орнууд төрийн захиргааны үйл ажиллагаанд төвийг сахих тухай үзэл санааг үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид тусган оруулсан байдаг¹⁸. (Ж.Ж)

ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ (Decentralization) “Decentralization” гэдэг үгийг анх 1835 онд Германд, дараа нь Франц, Англи хэлнээ ашиглах болжээ. Үгийн үндэс нь “Decentralize” гэх бөгөөд утга нь “төвөөс холдох” (away from a center) гэсэн санааг илэрхийлдэг. Төвлөрлийг сааруулах гэдгийг “аливаа төвлөрсөн эрх мэдэл, хяналтыг өөр хэсгүүд, үнд үйл ажиллагаа явагддаг хэсэг рүү шилжүүлэх (Вэбстэр, 1995)” хэмээн тодорхойлдог. Энэ үгийг улс төрийн шинжлэх ухаанд төв засгийн газрын эрх мэдэл, хяналтыг доод буюу орон нутгийн түвшинд шилжүүлэх үйл явцтай холбон тайлбарладаг. Өөрөөр хэлбэл, төвлөрлийг сааруулах нь төрийн эрх мэдэл, үүрэг хариуцлага, хөрөнгө нөөцийг засаг захиргааны нэгж дэх төрийн байгууллага, эсхүл төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэх үйл явц гэж ойлгож болно. Төвлөрлийг сааруулах бодлого нь дэлхийн олон улс оронд

18 Study on the Political Involvement in Senior Staffing and on the Delineation of Responsibilities Between Ministers and Senior Civil Servants. Alex Matheson, Boris Weber. OECD Publishing. 2007, p. 14.

хэрэгжиж ирсэн шинэчлэлийн үйл явц бөгөөд тухайн улс өөрийн орны нөхцөл байдал, түүх, улс төрийн дэглэм, төрийн байгууламж, соёл, үнэт зүйлс, шинэчлэлийн агуулга, хэлбэр зэргээс хамааран харилцан адилгүй хэрэгждэг. Төвлөрлийг сааруулахад дараах нийтлэг зарчмыг баримталдаг. Үүнд:

1. Субсидиар буюу иргэдэд хамгийн ойр байгаа тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх чадавч бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хуваарилах
2. Тодорхой байх буюу төрийн байгууллагын эрх хэмжээ, чиг үүрэг, хариуцлагыг төрийн байгууллагын түвшин хооронд давхардалгүйгээр хуваарилах
3. Чиг үүрэг санхүүжилтийн эх үүсвэртэй байх буюу чиг үүргийг тухайн түвшинд хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн хамт хуваарилах
4. Бүх талын оролцоог хангах буюу төвлөрлийг сааруулах бодлогыг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангаж, харилцан зөвшилцөх
5. Нотолгоо, баримтад тулгуурлах буюу шинжлэх ухааны онол, арга зүй, судалгаа, дүн шинжилгээ, олон улсын сайн туршлагад тулгуурлах зарчим тус тус хамаарна.

Төвлөрөл хэр саарсныг орон нутгийн захиргаад төв засгийн газраас хараат бус байдал хэр зэрэг дээшилснээр хэмждэг. Төвлөрлийг сааруулах Нягтралыг сааруулах (deconcentration), Эрх мэдэл төлөөлүүлэх (delegation), Эрх мэдэл бүрэн шилжүүлэх (devolution) гэсэн гурван түвшин байдаг. Ийнхүү төвлөрлийг сааруулах асуудал нь төрийн захиргааны болон

нутгийн удирдлагын бүх шатны байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын идэвхтэй хамтын ажиллагаа, оролцоог агуулсан өргөн хүрээтэй ойлголт бөгөөд эцсийн үр дүн нь төрийн үйлчилгээг иргэдэд илүү үр дүнтэй, шуурхай, хүртээмжтэй, тэгш хүргэхэд оршдог. (Г.Б; Т.Т)

ТӨВЛӨРӨЛ (Centralization) “Centralization” үгийн үндэс нь “centralize” гэх бөгөөд Францын “centralizer (1790)” гэсэн үгнээс гаралтай. Үгийн утга нь “төв цэгт авчрах, төв цэгийг зурах (to bring to a center, draw to a central point /1795 он/)” гэсэн санааг илэрхийлдэг. Үгийн утга нь 1800 оноос “төв цэгт ирэх (come to a center)” гэсэн утгаар хэрэглэгдэх болсон. Өөрөөр хэлбэл, аливаа зүйлийг олон цэгт хийхийн оронд нэг цэгт цуглуулахыг хичээх үйлдэл юм. Үгийн ерөнхий утга нь Францын хувьсгалын дараа бий болсон бөгөөд “орон нутгийн захиргааг төв засгийн газар руу шилжүүлэх” гэсэн утгатай. Төрийн салбарт төвлөрөл гэдгийг шийдвэр гаргах эрх мэдэл, хариуцлага, хяналтын механизмыг байгууллагын дээд шатанд барих үйл ажиллагаатай холбоотой байдаг. Төрийн эрх мэдлийг дангаар хэрэгжүүлдэг төв засгийн газрын ноёрхол гэж ойлгож болно. (Т.Т)

ТӨЛБӨР (Payment) Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ хүлээн авч түүний үнэ цэнэтэй тэнцэхүйц дүнгээр, эсвэл хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхээр шилжүүлэх мөнгө, эсвэл бараа, үйлчилгээний дүнг төлбөр гэнэ. Төлбөр нь тухайн ажил, гүйлгээнд оролцогч талууд арилжааны нөхцөлөө хүлээн зөвшөөрснөөр хийгддэг. Төлбөрийн хэрэгсэл нь мөнгө, үнэт цаас, эсвэл харилцан

солилцох бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ байж болно. Мөнгөн төлбөрийг бэлэн ба бэлэн бус тооцоо гэж ангилах бөгөөд банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээ өргөжиж төлбөр тооцоонд мэдээллийн технологийн ололт, шийдлийг ашиглах болсноор бэлэн бус төлбөр тооцоо давамгайлах болсон. Төрөөс бэлэн ба бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл, төлбөр төлөх харилцааны аюулгүй байдалд тавих шаардлага, стандартыг баталж мөрдүүлэн эдийн засгийн харилцаанд оролцогчдын эрх ашгийг хамгаалдаг. (Б.Б)

ТӨЛБӨРИЙН ЧАДВАР (Solvency/Liquidity) Хүлээгдэж байгаа өр төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулах санхүүгийн нөөц хүрэлцээтэй эсэхээр төлбөрийн чадвар тодорхойлогдоно. Төлбөрийн чадварыг богино хугацаанд төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, урт хугацааны төлбөрийн чадвар гэж ялгаатайгаар үнэлдэг ба төлбөрийн чадварын үзүүлэлт нь байгууллагын санхүүгийн төлөв байдлын зохистой түвшинг илтгэх гол үзүүлэлт болдог. Эдийн засгийн харилцаанд оролцогчдыг төлбөрийн чадварын түвшингээр нь төлбөрийн чадвар сайтай, хэвийн, эрсдэлтэй, төлбөрийн чадваргүй гэж ангилна. Төлбөрийн чадварын үзүүлэлтийг татварыг ялгаатай тогтооход харгалзахаас гадна төрийн худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгоход нэг шалгуур болгож авч үздэг. (Б.Б)

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ЭРСДЭЛ (Solvency/Liquidity risk) Байгууллага өөрийн эзэмшилд байх хөрөнгөөрөө өр төлбөрөө төлж барагдуулах чадваргүй болох эрсдэлийг хэлнэ. Төлбөрийн чадварын эрсдэл нь зээлийн нөхцөл, хүүгийн хэлбэлзэл,

хөрөнгийн үнэ цэнийн бууралт, валютын ханшийн хэлбэлзэл, эргэлтийн ба эргэлтийн бус хөрөнгийн бүтцийн алдагдал зэрэг хүчин зүйлээс ихээхэн хамааралтай байдаг ба эдгээр нь төлбөрийн чадварыг сулруулах сөрөг нөлөөтэй байдаг. Байгууллагын төлбөрийн чадварын эрсдэлийг үнэлэхдээ санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдээр тооцдог хөрвөх чадварын харьцаагаар үнэлэх боломжтой. Тухайлбал, эргэлтийн хөрөнгө ба богино хугацаат өр төлбөрийн харьцаагаар тодорхойлогдох эргэлтийн харьцаа нь байгууллагын богино хугацаанд төлбөр гүйцэтгэх чадварыг илэрхийлдэг. Төлбөрийн чадварын эрсдэл нь байгууллагын үндсэн үйл ажиллагааны тогтвортой байдал, худалдан авалт, нийлүүлэлтийн чанарт шууд нөлөөлнө. (Б.Б)

ТӨЛӨВЛӨГӨӨ (Plan) Төлөвлөх үйл явцын үр дүнд бий болсон бүтээгдэхүүн буюу дэвшүүлсэн зорилго, стратегийн хүрээнд хэн, хэзээ, юуг, ямар нөөцөөр хийхийг тодорхойлж өгсөн баримт бичиг юм. Төлөвлөлт нь “захиргааны шийдвэр гаргах үйл явц”, төлөвлөгөө нь “захиргааны шийдвэр” хэмээн тодорхойлсон байдаг¹⁹. Төлөвлөгөөг хугацаагаар нь урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө, түвшингээр нь макро болон микро түвшний төлөвлөгөө, хугацаа, төвлөрч буй асуудал зэргээс нь хамааруулан стратегийн болон тактикийн гэх мэтээр ангилна. (М.А)

ТӨЛӨВЛӨЛТ (Planning) Төлөвлөлт нь менежментийн үндсэн чиг үүргийн (функц)²⁰ нэг бөгөөд зорилго, стратеги

19 Батсүх Ш. (п.д.). *Захиргааны шинжлэх ухааны ерөнхий онолын зарим асуудлууд, 60 дахь тал.*

20 Энэ тольд буй “Түлик, Лютер-POSDCORB” үгийн тайлбар харна уу.

тодорхойлох, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнд шаардлагатай нөөцийг тодорхойлох, хуваарилах үйл явц юм. Захиргааны төлөвлөлтийг улс төр, бодлогын шийдвэрээр тодорхойлогдсон ирээдүйд болон зорилгод чиглэсэн үйл ажиллагаа²¹ хэмээн тодорхойлсон байдаг. Төлөвлөлт бол хамгийн энгийнээр төлөвлөгөө боловсруулах үйл явц. Төлөвлөгөөг боловсруулна гэдэг нь ирээдүйд болох үйл явцыг урьдчилан харж шийдвэрлэнэ гэсэн агуулгыг илэрхийлэх учраас “төлөвлөлт”-ийг “захиргааны шийдвэр гаргах үйл явц” хэмээн үзнэ²². (М.А; Т.Т нар)

ТӨРД БУЮУ УЛСАД УЧРУУЛСАН ХОХИРОЛ (*Harm to the state*)

Иргэн, төрийн байгууллага, албан хаагч, компани гэх мэт тодорхой нэг болон хэд хэдэн субъектийн үйл ажиллагааны үр дүнд төрд буюу улсад санхүүгийн болон санхүүгийн бус аливаа нөхөн сэргээгдэх боломжтой сөрөг нөлөөлөл. Тухайлбал, төрийн удирдах албан хаагч гүйцэтгэх түвшний албан хаагчийг хууль бус үндэслэлээр ажлаас нь халснаас шалтгаалж, хохирогч уг хэргийг шүүхээр шийдвэрлүүлж албан тушаалтны буруутай үйлдлийг тогтоолговол хууль бусаар халагдсан албан хаагчийн ажилгүй байсны нөхөн төлбөр, сул орон тоог нөхөхөд зарцуулсан зардал, зохион байгуулалтын арга хэмжээ, цаг хугацаа, эргэн ажилд авах шаардлага зэрэг эдийн болон эдийн бус хохирлыг хамруулна. Төрд учирсан хохирлыг барагдуулан улмаар зохих хариуцлагыг хүлээлгэх

зохицуулалттай. (Г.Б)

ТӨРИЙН АЛБА (*Governmental service*) Төрийн байгууллагын зорилт, чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх төрийн байгууллага, албан тушаалтан, тэдний эрх үүргээ хэрэгжүүлэхэд зориулсан эдийн болон эдийн бус баялаг төрийн алба гэж тодорхойлогд²³. “Төрийн алба” нэр томьёог civil service-төрийн иргэний алба, төрийн алба, олон улсын байгууллагын аппарат, яамны аппаратын түшмэл, засгийн газрын аппарат, governmental service-төрийн, засгийн газрын алба, public service- олон нийтийн үйлчилгээ, нийтийн аж ахуйн үйлчилгээ, төрийн үйлчилгээ, нийтийн чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн алба, state service- төрийн алба²⁴ зэрэг хэд хэдэн утгаар хэрэглэдэг. Эдгээрээс түгээмэл хэрэглэгддэг civil service, public service ойлголтууд Кембрижийн тайлбар толь:

- Civil service: Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг хариуцдаг засгийн газрын алба, хэлтсүүд, цэргийн бүрэлдэхүүнд ороогүй засгийн газрын нэгж, алба, ажиллагсад,
- Public service: Эмнэлэг, сургууль, цагдаа гэх мэт засгийн газраас үзүүлж буй үйлчилгээ, Засгийн газар, түүний алба, хэлтсийн хийж буй ажил, ашиг олохын тулд биш

21 Klaus Koenig, Heinrich Siedentopf (Hrsg), “Oeffentliche Verwaltung in Deutschland”, 1997, s. 378.

22 Батсүх Ш. (n.d.). *Захиргааны шинжлэх ухааны ерөнхий онолын зарим асуудлууд, 60 дахь тал.*

23 Н.Лүндэндорж: Төрийн онол гарын авлага, Улаанбаатар 2007, х. 58.

24 С.Нарангэрэл, Хууль зүй судлалын англи-монгол тайлбар толь, 2005, 2012.

олон нийтэд зориулж хийсэн зүйл, сонгогдсон албан тушаалтнууд болон төрийн албан хаагчдын хийж буй ажил үйлчилгээ хэмээн тайлбарласан.

Манай улсын тухайд төрийн алба гэж төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг хэлнэ (Төрийн албаны тухай хуулийн 3.1.1).

Төрийн албыг доор дурдсанаар ангилна:

- төрийн улс төрийн алба;
- төрийн захиргааны алба;
- төрийн тусгай алба;
- төрийн үйлчилгээний алба.

Төрийн захиргааны алба, төрийн тусгай албыг төрийн жинхэнэ алба гэнэ (Төрийн албаны тухай хуулийн 6.1, 6.2). (Ч.Э; Г.Б нар)

ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ (*Classification of governmental positions*) Төрийн байгууллагад албан хаагчийн эзлэх байр, гүйцэтгэх үүргийг тодорхойлогч албаны үүрэг, эрх, хариуцлагын нэгдлийг албан тушаал хэмээн ойлгоно. Энэ нь хуулиар хүлээсэн төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх ялгаатай байдлаар илэрхийлэгдэнэ. Албан тушаалын тодорхойлолт боловсруулан, албан тушаалын шинжилгээ, үнэлгээ хийхэд:

1. Харьцангуй байдал /Relativity/ - ижил төрлийн чиг үүрэг бүхий албан тушаалын түвшинтэй ижил төстэй ангилалд хамруулах

2. Нийцтэй байдал /Consistency/ - засгийн газрын бүх түвшний албан хаагчдад тэгш байх
3. Үндэслэлтэй байдал /Reasonableness/ - үнэлгээ нь баримт, бодит нотолгоонд тулгуурлах зэрэг зохицуулалтын зарчмыг баримталдаг²⁵.

Төрийн албан тушаалын ангиллын зорилго нь төрийн байгууллагын зорилт, чиг үүргийг тухайн албанаас хэрэгжүүлэхэд шаардлагатай албан тушаалын хүрээ, зааг, зэрэг зиндаа, орон тоо, түүнд тавигдах шаардлагыг ялгавартайгаар тогтоон мөрдүүлэхэд оршино²⁶.

- Төрийн албан тушаалыг доор дурдсанаар ангилна:
- төрийн улс төрийн албан тушаал;
- төрийн захиргааны албан тушаал;
- төрийн тусгай албан тушаал;
- төрийн үйлчилгээний албан тушаал (Төрийн албаны тухай хуулийн 10.1)

Төрийн захиргааны албан тушаал болон төрийн тусгай албан тушаалыг төрийн жинхэнэ албан тушаал гэнэ (Төрийн албаны тухай хуулийн 10.3). Албан тушаалын ангиллыг тухайн албан тушаалын ажил, үүргийн үнэлгээнд үндэслэдэг бөгөөд албан тушаалын харьцангуй, уялдаа холбоотой, үндэслэлтэй байдлыг хангах зорилгоор ангиллын системийг төрийн албанд зохистой ашиглана. Албан тушаалын ангиллын шийдвэрийг ангиллын үзүүлэлтүүд эсвэл тодорхой багцад

25 Civil Service Act Regulations 4(1)(2), 5, 22 and 14 Acting Status: "Principles & Policies for Managing Human Resources", Government Employees master agreement, Canada, 2009.

26 Ж.Долгорсүрэн, Г.Буянхшиг: Монгол Улсын захиргааны эрх зүй, Улаанбаатар, 2008, х. 155-156.

хамаарах ажлын харьцуулалт, албан тушаалын зэрэглэлд үндэслэн гаргана. Албан тушаалд хамаарах эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлох үүргийг хүний нөөцийн менежерүүд гүйцэтгэдэг. (Ч.Э; Г.Б нар)

ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛ (*Grade of civil service position*)

Албан тушаалын хүрээнд хэрэгжүүлэх үүрэг, эрх мэдэл, хариуцлага, хариуцаж буй ажлын цар хүрээ, тухайн албан тушаалын харьяалагдах салбар, байгууллага зэргийг харгалзан албан тушаалын үнэлгээ хийх замаар тогтоосон зэрэглэл. Албан тушаалын зэрэглэлд үндэслэн цалин хөлсний хязгаарыг шатлан тогтооно. Монгол Улсын төрийн албанд зургаан бүлэг албан тушаалын зэрэглэл бий. Үүнд: 1) Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа нь ТӨ-I-ээс ТӨ-УI гэж зургаан, 2) Төрийн өндөр албан тушаалтай адилтгах албан тушаал нь ТӨ-IYA, ТӨ-YA, ТӨ-YIA гэж гурван зэрэглэлд, 3) Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, СЕХ болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаал нь AA-11-ээс AA-1 хүртэл арван нэгэн, 4) Төрийн захиргааны албан тушаал нь ТЗ-1-ээс ТЗ-15 хүртэл арван таван, 4) Төрийн тусгай албан тушаал нь ТТ-1-ээс ТТ-18 хүртэл арван найман, 5) төрийн үйлчилгээний албан тушаал нь ТҮ1-ээс ТҮ12 хүртэл арван хоёр (дотроо зургаан бүлэгтэй) зэрэглэлтэй²⁷. (М.А)

ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН МЭРГЭЖЛИЙН ШААРДЛАГА (*Professional requirements for the civil service*)

Тухайн төрийн албан тушаалд тохирохуйц мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар батлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан мэдлэг, мэргэшил, туршлага, ур чадварын нарийн шаардлагыг хэлнэ. Төрийн алба, албан хаагч нь нийгэмд хяналт зохицуулалт, удирдлагын чиг үүргийг ихэвчлэн хэрэгжүүлдэг ба салбар бүрийн мэргэшсэн, чадварлаг хүмүүсийг олж, сонгон шалгаруулан, тухайн төрийн албан тушаалд томилох замаар энэхүү үүргээ хэрэгжүүлэх боломжтой байдаг. Тиймээс улс орнуудын төрийн албан тушаалын тодорхойлолтын мэргэжлийн шаардлагад мэргэжлээрээ 2 болон түүнээс дээш жил ажилласан байх, мэргэжлийн сургалтын байгууллагад суралцаж төгссөн, албан ёсны зөвшөөрөл олгох эрх бүхий мэргэжлийн байгууллагын шалгалт, шаардлагад нийцэж үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх зэрэг нарийн шаардлагуудыг заасан. (Г.Б)

ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН ТӨРӨЛ (*Types of governmental positions*)

Төрийн албан тушаалыг төрөлжүүлэх нь түүнд тавигдах шаардлагыг ялгавартайгаар тогтоон мөрдүүлэхэд чиглэгдэнэ.

Төрийн албан тушаалыг дараах байдлаар төрөлжүүлнэ. Үүнд:

- Удирдах албан тушаал
- Гүйцэтгэх албан тушаал
- Туслах албан тушаал (Төрийн албаны тухай хуулийн 10.2).

27 Улсын Их Хурлын 2019 оны 63 дугаар тогтоол болон Засгийн Газрын 2019 оны 472 дугаар тогтоол.

Удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын төрөлд хамаарах төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын жагсаалтыг Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална. (Ч.Э)

ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН ШААРДЛАГА (*Requirements for governmental position*)

Төрийн албан тушаалд ажиллах иргэний хангасан байвал зохих нийтлэг, тусгай шаардлагуудыг хэлнэ. Тухайн албан тушаалд хамаарах эрх үүргийг хэрэгжүүлж ажиллахад хэрэгцээтэй боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлага тавигдана. Түүнчлэн албан тушаалын шаардлага нь тухайн албан тушаалын ерөнхий мэдээлэл, зорилго, чиг үүрэг, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хариуцлага оролцооны хэлбэр, албан тушаалын харилцах субъектүүдтэй харилцан уялдаатай байна. Төрийн албан тушаалын нийтлэг шаардлага /General requirements of public position/: Иргэний харьяалал, боловсрол, бичгийн чадвар, хөдөлмөрийн чадамжтай байдал зэрэг мэдлэг, ур чадварын анхан шатны нийтлэг шаардлагыг хэлнэ. Төрийн албан тушаалын тусгай шаардлага /Special requirements of public position/: Төрийн албан тушаалд хуулиар тусгайлан тогтоосон нэмэлт шаардлагыг хэлнэ. Үүнд ажилласан жил, сургалтад хамрагдсан байдал зэргийг хамруулна. (Г.Б)

ТӨРИЙН АЛБАН ХААГЧ (*Civil servant*)

Төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг хэлнэ²⁸. Төрийн

албан хаагчид нь төрийг төлөөлж иргэдэд үйлчилгээ үзүүлж, үйл ажиллагаа явуулж байгаа учраас тэдэнд тавигдах онцлог шаардлагууд байхын зэрэгцээ хийх үйлдлийг нь хязгаарласан хязгаарлалтууд ч бий. Тэдний хашиж буй ажил албаны онцлог нь хууль эрх зүйн онцлог зохицуулалтуудыг шаарддаг. Тиймээс төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцаа тусгай хууль эрх зүйн актаар зохицуулагдах бөгөөд тэднийг ажилд авах (албан тушаалд томилох), төрийн албанаас халах асуудлыг зөвхөн Төрийн албаны тухай хуулиар эрх олгогдсон байгууллага, албан тушаалтан шийдвэрлэдэг онцлогтой. Монгол Улсын төрийн албаны тухай хуульд төрийн улс төрийн, төрийн үйлчилгээний, төрийн жинхэнэ албан хаагч гэсэн нэр томьёо ашиглагддаг бөгөөд энэ нь төрийн албан хаагчийн хашиж буй алба, албан тушаалын ангиллаас нь хамааруулсан нэр томьёо юм. Монгол Улсын хэмжээнд 2019 оны байдлаар 198.5 мянган төрийн албан хаагч ажиллаж байгаагийн 69.1% нь төрийн үйлчилгээний албанд, 19.4% нь төрийн тусгай албанд, 9.6% нь төрийн захиргааны албанд, 1.8% нь төрийн улс төрийн албанд ажиллаж байна²⁹. (М.А)

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЗАН ҮЙЛ (*Behavior of civil servants*)

Захиргааны зорилго болох ард түмний үнэт зүйлийг бүтээх, төрийн үүргийг гүйцэтгэх, захиргааны шийдвэр гаргахад чиглэсэн хэвшсэн үйлдлүүд гэж ойлгож болно (Зан үйл гэдгээс үзэх). (Ц.Д)

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ҮҮРЭГ (*Official duty of civil servants*)

Төрийн албан хаагч хашиж буй албан тушаалынхаа хүрээнд хариуцан

²⁸ Төрийн албаны тухай хуулийн 3.1.2 дахь заалт.

²⁹ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, <https://1212.mn/>, үзсэн 2020.11.29.

гүйцэтгэх ажил буюу хэрэгжүүлэх чиг үүрэг юм. Энэ үүрэг нь төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан байна. Төрийн албан хаагч нь албан үүргээ хэрэгжүүлэх тодорхой эрх мэдэлтэй байх бөгөөд үүрэг, эрх мэдлийнхээ хэмжээнд нийцсэн хариуцлага хүлээнэ. (М.А)

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙ (*Ethics of civil servants*) Албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд баримталбал зохих үнэт зүйлс, зарчим, зан үйлийн нийлбэр цогц юм³⁰. Агуу их сэтгэгч Аристотелийн тодорхойлсноор “ёс зүй гэдэг нь хүнд юуг хийх ёстой, юунаас татгалзах хэрэгтэйг танин мэдэхэд тусалдаг шинжлэх ухаан”³¹ гэжээ. Тиймээс төрийн албан хаагчийн юуг хийх ёстой, юунаас татгалзах хэрэгтэйг төрийн албан хаагчийн ёс зүйн код, дүрмээр тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл, төрийн үүргийг хэрэгжүүлж, ард иргэдэд үйлчлэх төрийн албан хаагчийн баримтлах ёстой мэргэжлийн үйл ажиллагааны хэм хэмжээ юм. Төрийн албан хаагчийн ёс зүйг дараах байдлаар ангилна. Үүнд³²:

- *Албан тушаалынхаа эрх мэдлийг ашиглахтай холбогдсон ёс зүй:* Албан тушаалынхаа эрх мэдлийг ашиглан өөртөө болон гэр бүл, танил талдаа ашиг хонжоо, давуу байдлыг олж авахыг цээрлэх явдлаар илэрнэ. Албан тушаалтан албан үүргээ шударга биелүүлэхэд саад болохуйц хувийн болон санхүүгийн сонирхолтой байхыг

сонирхлын зөрчил гэнэ.

- *Албан үүргээ биелүүлэх нөхцөлийг хангаж төрөөс олгосон боломжийг ашиглахтай холбогдсон ёс зүй:* Албан тушаалтан албан үүргээ биелүүлэх боломжтой байхын тулд хашиж байгаа албан тушаалын шинж чанараас хамаарч албан тасалгаа, унаа, холбооны хэрэгсэл гэх мэт олон төрлийн боломжоор хангагдсан байдаг. Үүнийг ажилдаа хэрэглэхийн зэрэгцээ хувийн зорилгоор ашиглах нь ёс зүйн зөрчлийн нэг хэлбэр юм.
- *Хамтран ажилладаг хүмүүстэйгээ харилцахтай холбогдох ёс зүй:* Албан тушаалтны удирдлагад ажиллаж буй хүмүүс түүнтэй яг ижил төрд зүтгэж буй албан хаагчид бөгөөд, тэд зөвхөн албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой үүрэг даалгавар биелүүлнэ. /жолооч, үйлчлэгч, нарийн бичгийн дарга/ Хамтран ажиллагчдаа хүндлэх, нэр төрийг нь үл хайрлах, гутаах, доромжлох зэргээр хувь хүнийх нь хувьд нэр хүндэд нь харшлах үйлдэл хийх нь ёс зүйн зөрчил юм.
- *Иргэдтэй харилцах ёс зүй:* Иргэд хууль ёсны эрхийнхээ дагуу төрийн байгууллага, албан хаагчид ханддаг. Тиймээс тухайн хүний хөрөнгө чинээ, нас хүйс зэргийг үл харгалзан чирэгдэлгүй үйлчлэх, мэдээллээр хангах нь төрийн албан хаагчдын үүрэг. Иргэнийг дорд үзэх, албан тушаалын эрх мэдлээр далайлгах, сүрдүүлэх, худал мэдээлэл өгөх зэрэг нь энэ төрлийн ёс зүйн зөрчил юм.
- *Төрийн эрх ашиг, нэр хүндийг хамгаалахтай холбогдох ёс зүй:* Төрийн албан хаагч төрийн нэр хүндийг ямагт өндөрт өргөж,

30 Удирдлагын Академи, “Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх” сургалтын гарын авлага, 2019, 16 дахь тал.

31 Удирдлагын Академи, “Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх” сургалтын гарын авлага, 2019, 6 дахь тал.

32 А.Цанжид (2009). Төрийн захиргаа. Улаанбаатар. х. 251-253.

түүнд харшлах үйлдэл гаргахгүй байх ёстой. Хууль тогтоомжийг байхгүй ч гэсэн зөрчихгүй байх, албан үүргээ хэрэгжүүлэх үедээ согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, ажилладаг байгууллага, албан үүргийнхээ талаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх, албаны нууцыг чандлан хамгаалах зэрэг асуудлыг энд багтаан үзнэ.

Бодит байдал дээр захиргааны ёс зүйг захиргааны асуудал эрхэлсэн төрийн албан тушаалтнууд тогтоож хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, захиргааны ёс зүйн субъект нь төрийн албан хаагчид гэсэн үг юм. Төрийн албан хаагчид нь хэсэг бүлэг хүмүүст үйлчилдэг биш харин нийтийн ашиг сонирхлыг бүхэлд нь хамарсан үйл ажиллагаа явуулдаг төрийн албан хаагч учир ёс суртахууны өндөр хэм хэмжээ нь жирийн хүмүүс эсвэл корпорацын ажилчдаас илүү өндөр шаардлага тавигддаг бөгөөд тэдгээрт тохирсон янз бүрийн журамд захирагдана. Олон улсын түвшинд ч үүнийг зохицуулсан зохицуулалт бий. НҮБ-ийн ерөнхий ассамблейн 1996 оны 51/59 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн олон улсын ёс зүйн код”-ын хавсралтаар баталжээ³³. Дэлхийн ихэнх улс оронд төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлыг холбогдох хуулиас гадна “Төрийн албан хаагчийн ёс зүйн код”-оор зохицуулдгийн нэгэн адил Монгол Улсад Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан байдаг. (ЦД; М.А нар)

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ (*Code of conduct for civil servants*)

Төрийн албан хаагчийн биеэ авч явах зан суртахууны стандартууд, юуг хийх ёстой, юунаас татгалзах хэрэгтэйг тогтоосон тодорхой хэм хэмжээг заасан баримт бичиг юм. Өөрөөр хэлбэл, ёс зүйн дүрмийн хүрээнд албан хаагчийн хувийн амьдралыг бус харин албан үүргээ гүйцэтгэхдээ баримтлах ёс суртахууны үндсэн шаардлага, зарчмыг тодорхойлж, албаны талаар биеэ авч явах ёс зүйн тодорхой хэм хэмжээг заасан зохицуулалт юм³⁴. Дэлхийн ихэнх улс орон төрийн албан хаагчийн ёс зүйн асуудалтай холбогдох бусад хуулиас гадна “Төрийн албан хаагчийн зан үйлийн стандартыг ёс зүйн дүрэм” (code of conduct)-ээр зохицуулдаг нийтлэг жишиг бий. Мөн НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1996 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 51/59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн олон улсын ёс зүйн код (International Code of Conduct for Public Officials)”³⁵-д төрийн албаны үндсэн зарчмуудыг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

-Төрийн байгууллага нь нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллах итгэл даасан байгууллага байхаар дотоодын хууль тогтоомжоор тодорхойлогдсон байна. Иймээс, төрийн ардчилсан ёсонд илэрхийлснээр албан хаагчдын үнэнч шударга байдал нь улс орныхоо эрх ашиг сонирхлын төлөө байх,

-Төрийн албан хаагчид хуулийн болон захиргааны бодлогын хүрээнд үүргээ үр дүнтэй, үр ашигтай байх зарчмын

33 Удирдлагын Академи, “Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх” сургалтын гарын авлага, 2019, 16 дахь тал.

34 Авлигатай тэмцэх газар (2019). Төрийн албан хаагчийн ёс зүй: Гарын авлага. Улаанбаатар, 2019, х. 26.

35 <http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/un/unpan010930.pdf>

дагуу шударгаар гүйцэтгэнэ. Тэд төрийн нөөцийг хамгийн үр дүнтэй, үр ашигтай зарцуулж түүнийхээ төлөө хариуцлага хүлээх чадвартай байх,

-Албан хаагчид чиг үүргээ гүйцэтгэхдээ, ялангуяа олон нийттэй харилцахдаа анхааралтай, алагчлахгүй, шударга байх ба хувийн ашиг сонирхлын үүднээс хандах ёсгүй. Тэд хэзээ ч өөрсдийн боломж, эрх мэдлээ ашиглаж хувь хүн эсвэл нийгмийн аль нэг бүлгийг ялгаварлан үйлчлэх болон үзэл суртлын үүднээс хандаж болохгүй хэмээн тодорхойлсон байна. Олон оронд төрийн албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээг нэгээс илүү хууль тогтоомжоор зохицуулдаг. Жишээлбэл, АНУ-ын Засгийн газрын ёс зүйн хууль (1978), Мөрдөн байцаагчийн хууль (1978), Ёс зүйн шинэтгэлийн тухай хууль (1989), Лобби, ил тод байдлын тухай хууль (1995) зэргийг дурдаж болно. Харин төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хувьд Австралид “Төрийн албан хаагчийн ёс суртахууны зан үйлийн удирдамж”, Их Британид “Төрийн албан хаагчийн ёс зүйн стандарт (Ethical Standards for Providers of Public Services)”, АНУ-д гүйцэтгэх засаглалд ажиллагсдын ёс зүйн зан үйлийн стандарт (Standard of ethical conduct for employees of the executive branch), Канадад “Төрийн албан хаагчийн үнэт зүйл ба ёс зүйн код (Values and ethics code for the public service)”, Шинэ Зеландад “Төрийн албан хаагчийн зан үйлийн код (New Zealand public service code of conduct)”, БНСУ-д “Төрийн албан хаагчийн шударга байдлыг хангах зан үйлийн стандарт (Code of conduct for maintaining the integrity of public officials)” зэрэг нэршилтэй ёс зүйн кодыг баримтлан ажилладаг байна.

Монгол Улс төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой асуудлыг “Монгол Улсын Үндсэн хууль (1992 онд анх баталж, 2000, 2019 онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан)”, “Төрийн албаны тухай хууль” (1994 онд анх баталж, 2003, 2008, 2011 онд нэмэлт өөрчлөлт оруулж, 2017 онд шинэчлэн найруулсан), “Монгол Улсын Авлигын эсрэг хууль” (2006 онд анх баталж, 2008, 2012, 2014, 2015, 2016, 2017, 2019, 2020 онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан), “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” (2012 онд анх баталж 2017, 2020, 2021 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) болон “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрэм” (2019 он), төрийн бусад ажил үйлчилгээ, мэргэжлийн албан хаагчдын 30 гаруй ёс зүйн дүрэм зэрэг эрх зүйн актуудаар зохицуулж байна³⁶. (Ц,Д)

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ (Ethical norms of state servants) Төрийн албан хаагчийн ёс зүй гэж төрийн алба эрхэлж, бүрэн эрх хэрэгжүүлэхтэй холбогдсон зарчим, хэм хэмжээ, шаардлагын нийлбэрийг ойлгоно. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагчид үнэнч шударга, өрсөлдөх чадвартай, олон нийтийн эрх ашгийн төлөө ажиллах сэдэлтэй, өөрсдийн хүч чадлаа дайчлан ажилладаг байхын зэрэгцээ хариуцлагатай, ёс зүйтэй гэх мэт зан чанарыг эзэмшсэн байх шаардлага тавигдаж байна. Улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтооно. Захиргааны болон үйлчилгээний албан тушаал

³⁶ Удирдлагын академи (2019). Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх. Гарын авлага.

эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. (Ч.Э)

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН МЭРГЭШИЛ (*Qualification of civil servants*)

Төрийн албан хаагчийн албан тушаалынхаа чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэргэжлийн мэдлэг, чадвар, дадлыг эзэмшсэн түвшин³⁷. Төрийн албан хаагчийн албан тушаалын нийтлэг болон тусгай шаардлага нь тухайн албан хаагчийг ямар чиглэлээр, ямар түвшинд хүртэл мэргэшсэн байх шаардлагатай вэ гэдгийг тодорхойлогч нь байна. Өнөөгийн хурдацтай өөрчлөгдөж буй орчин нь төрийн албан хаагчдыг мэргэшлийн түвшингээ байнга ахиулж, хөгжүүлж байхыг шаардах бөгөөд энд мэргэшүүлэх сургалт чухал байр суурийг эзэлнэ. Төрийн албаны тухай хуулиар төрийн албан хаагчид тодорхой хугацаанд мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад, албан тушаал дэвшихийн тулд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх шаардлага тавигдаж байна. (М.А)

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ БАТАЛГАА (*Common guarantees of state servants*)

Төрийн албан хаагчийг албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх бодит нөхцөл бололцоогоор хангах үүргийг төр хүлээдэг. Үүнийг төрийн албан хаагчийн баталгаа гэдэг. Төрөөс хуулиар тогтоосон төрийн албан хаагчийн баталгааг нийтлэг баталгаа болон нэмэгдэл баталгаа гэж ангилна. Нийтлэг баталгаа нь төрийн нийт албан хаагчдад хамааралтай байдаг. Төрөөс төрийн албан хаагчийн дараах

нийтлэг баталгааг хуулиар тогтоосон. Үүнд: 1) албан тушаалын цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж авах; 2) албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах; 3) гүйцэтгэж байгаа албан үүргийн шинж байдлаас хамааран зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах төрийн тээврийн хэрэгслийн зардлын зохих хэсгийг нөхөн авах; 4) албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг тухайн ажиллаж байгаа байгууллага, эсхүл цагдаагийн байгууллагаар хамгаалуулах; 5) орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх; 6) Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралт эдлэх; 7) төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалын цалинж авах; 8) үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс албан хаагчид учирсан эд хөрөнгийн хохирлыг төр хариуцаж, гэм буруутай этгээдээр хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлэх; 9) ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох; 10) хууль тогтоомжоор тогтоосон бусад баталгаа (Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг). (Ч.Э)

³⁷ Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН УЛСЫН НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛ (*State general registration of civil servants*)

Төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдын судалгааг байгууллага нэг бүрээр улсын хэмжээнд нэгтгэсэн нэгдмэл бүртгэл. Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн зорилго нь төрийн албаны төлөв байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх мэдээллийг бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх чиглэл, сургалтын хэрэгцээг оновчтой тодорхойлоход оршино. Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл нь төрийн албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн бүрэлдэхүүний бүтэц, ажил хэргийн мэдлэг чадвар, хөдөлгөөнийг харуулах цогц үзүүлэлтээс бүрдэнэ. (Д.З; Ч.Л нар)

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН УЛСЫН НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, МЭДЭЭЛЭЛ АВАХ ЖУРАМ (*Procedure for maintaining National integrated registration of civil servants*)

Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хэрхэн хөтлөх, холбогдох мэдээллийг ямар арга хэлбэрээр авахтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан эрх зүйн баримт бичиг. Төрийн албаны тухай хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд Засгийн газар төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журмыг баталдаг. Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийг хөтөлж, улсын нэгдсэн сан бүрдүүлэх болон тус сангаас мэдээлэл солилцоход энэ журмыг баримтална. (Д.З; Ч.Л нар)

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН УЛСЫН НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН (*Database of National integrated registration of civil servants*)

Төрийн албан хаагчийн мэдээллийг шаардлагатай үзүүлэлтүүдийн дагуу бүртгэсэн бүртгэлүүдийг улсын хэмжээнд нэгтгэн бүх албан хаагчийн мэдээллийг нэгдсэн ангилал, арга зүй, стандартаар ижилтгэн боловсруулж хадгалсан өгөгдлүүдийн цогц бүрдэл. Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн сан нь хүний нөөцийн удирдлага зохион байгуулалтыг судалгаа, шинжилгээнд тулгуурлан шинжлэх ухааны үндэстэй явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд оршино. Энэхүү санг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албаны төв байгууллага буюу Төрийн албаны зөвлөл эрхэлдэг. (Д.З; Ч.Л нар)

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ХАРИУЦЛАГА (*Responsibilities of civil servants*)

Төрийн албан хаагчийн хүлээсэн үүрэг, түүний үйл ажиллагааны үр дагавар, албан тушаалд оногдсон үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн албан хаагчдын ажилдаа хандах хандлага. II. Төрийн албан хаагчийн хууль тогтоомж, дүрэм журмаар олгогдсон үүргийг биелүүлэхтэй холбоотой үүссэн сөрөг үйлдэл, эс үйлдэхүйд тооцсон санкцийн хэлбэр. “Хариуцлага” гэх ойлголт нь “accountability” буюу “хариуцлагатай байдал” гэх нэгдүгээр тодорхойлолтод заасан төрийн албан хаагч аливаа үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ “хариуцлагатай хандах” хандлагын илэрхийлэл болж байна.

Хоёрдугаарт төрийн албан хаагч үүргээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомж, салбар болон байгууллагын түвшний аливаа хэм хэмжээг зөрчсөн үйлдэл хийх эсвэл үйлдэл хийхгүй байх нь зөрчилд тооцогдох үр дагаварт хүргэсэн тохиолдолд тухайн төрийн албан хаагч сахилгын болон захиргааны шийтгэл хүлээх нь “responsibility” буюу “хариуцлага” хүлээж буй байдал юм. Эдгээр хоёр түвшинд “төрийн албан хаагчийн хариуцлага” гэх ойлголт тайлбарлагдах бөгөөд зарим тохиолдолд ялгаатай байдлаар эсвэл ижил төстэй байдлаар хэрэглэдэг. (Г.Б)

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ХУВИЙН ХЭРЭГ (*Personal files of civil servants*) “Төрийн албан хаагчийн тухай болон түүний төрийн албан тушаал эрхэлсэн байдал, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнтэй холбогдсон мэдээллийг агуулсан судалгаа, лавлагааны үндсэн баримт бичиг”³⁸ юм. Төрийн албан хаагчид зөвхөн нэг хувийн хэрэг байна³⁹. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг нь төрийн алба, төрийн албан хаагчтай холбогдсон бүртгэл, судалгаа, мэдээллийн нэгдсэн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хувийн хэрэгт бүрдүүлсэн мэдээлэл нь төрийн албан хаагчийг албан тушаалд томилох, шатлан дэвшүүлэх, шагнаж урамшуулах, хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлаар эрх бүхий этгээд шийдвэр гаргахад тулгуурлах үндэслэл, эх сурвалж болно⁴⁰. (М.А)

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЦАЛИН ХӨЛС (*Salary of civil servants*) Төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс авч буй хөдөлмөрийг хөлс. Төрийн албан хаагчийн цалин хөлс нь хэд хэдэн бүрэлдэхүүн хэсэгтэй ба өнөөгийн шагнал, ирээдүйн хүлээлт, гэрээний болон гэрээний бус урамшууллын хослол юм.

Тодорхой албан тушаалд хамаарах цалин хөлсийг бусад байгууллагын ижил түвшний ажиллагсдын цалингийн хэмжээтэй харьцуулан мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн засгийн газраас тогтоодог бөгөөд тухайн ажил, үүргийн чиглэл, агуулга, албан хаагчдын туршлага, мэдлэг, ур чадвар, гүйцэтгэлд суурилан харилцан адилгүй тогтоодог.

Зах зээлийн эдийн засаг өндөр хөгжсөн олон оронд төрийн албан хаагчдын цалин жил бүр эсвэл хоёр жилд нэг удаа шинэчилдэг. Харин хөгжиж буй орнуудад ийм хэлбэрийн тохируулга байдаггүй, зөвхөн засгийн газрын тэргүүлэх чиглэлүүдийн дагуу өөрчлөгдөж байдаг тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллага тогтоосон. Хөгжиж буй орнуудын засгийн газар 1960-1970-аад оны үед ‘үлгэр жишээ’ ажил олгогч байхаар зорьж байсан боловч одоо хөгжиж буй орнуудын цөөн хэдэн засгийн газар энэ зорилгыг эрэлхийлэх болж⁴¹ засгийн газрын тэргүүлэх чиглэлүүд нь тэгш байдал, гүйцэтгэлийг гол үнэ цэнэ болгосон. (Г.Б)

38 Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам, ТАЗ-ийн 2019 оны 05 дугаар тогтоол.

39 Төрийн албаны тухай хуулийн 15.2 дахь заалт.

40 Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам, ТАЗ-ийн 2019 оны 05 дугаар тогтоол.

41 Chew, David C. E.: Civil Service Pay in the Asian-Pacific Region. Asian Pacific Economic Literature 7(1), 1993.

		Гэрээний дагуу		Гэрээний бус
		Мөнгөн	Бодит	
Өнөөгийн шагнал	Үндсэн шагнал	1. Үндсэн цалин	2. Эрүүл мэндийн даатгал	3. Ажлын аюулгүй байдал, нэр хүнд, нийгмийн давуу эрх
	Тэтгэмж	4. Унаа, орон байр, хоол, утас, аялал, амьдралын өртөг	5. Унаа, байр, хоол, аялал	6. Гадаад хийх аялал, ирээдүйн эрэлт, хүлээлтэд суурилсан сургах
Ирээдүйн хүлээлт		7. Тэтгэвэр	8. Орон сууц, газар г.м	9. Нэр хүнд, тэтгэвэрт гарсны дараа ажилд орох

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ *(Rights of civil servants)*

Төрийн алба хашиж байгаагийн төлөө хуулиар олгосон эрх. Эрх гэдэг нь тодорхой нөхцөл байдалд үйлчлэл үзүүлэх чадвар, нөлөөлөх боломж бөгөөд тодорхой албан тушаалд эрх зүйн актаар олгогдоно. Төрийн албан хаагчийн эрхийг Төрийн албаны тухай хуулиар зохицуулна. Эрх нь үүрэг, хариуцлага гэдэгтэй уялдаатай байна. (М.А)

ТӨРИЙН АЛБАНЫ АНГИЛАЛ *(Civil service classification)*

Төрийн байгууллагын үйл ажиллагааны чиг үүргийн дагуу нийтлэг шинж чанарыг тодорхойлж, бүлэглэсээр ижил төстэй үүрэг хариуцлага бүхий албан тушаалыг системчлэх, ялгах нь төрийн албаны ангилал юм. Ангилал нь системд эмх цэгцтэй байдлыг бий болгодог ба төрийн албанд ангилал тогтоосноор бүгдэд жигд хандах боломжийг олгох ба тодорхой ангилалд олгосон ялгавартай давуу эрхийн үндэслэлийг бий болгодог. Төрийн албан тушаалтны үүрэг хариуцлага, мэргэшлийн шаардлага, шаардлага хангасан байдал, цалин хөлс, статус, эрх мэдэл нь төрийн албаны ангиллын зөв тогтолцооноос ихээхэн хамаардаг тул зохион

байгуулалтын ач холбогдол бүхий хэрэгсэл болдог. (Г.Б)

ТӨРИЙН АЛБАНЫ ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ *(General civil service examination)*

Төрийн албаны нөөц бүрдүүлэх зорилготой төрийн албанд орох хүсэлтэй иргэдийн наад захын мэдлэгийг шалгах шалгалтыг хэлнэ. Төрийн албаны ерөнхий шалгалт төрийн албанд ажиллах хүсэлтэй иргэний удирдан зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, манлайлах, бичгийн болон ярианы, багаар ажиллах зэрэг чадварыг илэрхийлэх агуулга бүхий байна. Ерөнхий шалгалтад төрийн жинхэнэ алба хаах хүсэлтэй, төрийн жинхэнэ албан тушаалд тавих нийтлэг шаардлагыг хангасан бүх иргэн орох эрхтэй. (Г.Б)

ТӨРИЙН АЛБАНЫ ЗАРЧИМ *(Principles of state service)*

Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн албаны үйл ажиллагаанд удирдлага болгох үзэл баримтлалыг төрийн албаны зарчим гэнэ. Төрийн албаны зарчмыг үндсэн ба тусгай гэж ангилна.

Төрийн албанд баримтлах үндсэн зарчим нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь

хэсэгт зааснаар:

- ардчилсан ёсны зарчим;
- шударга ёсны зарчим;
- эрх чөлөө, тэгш байдлын зарчим;
- үндэсний эв нэгдлийг хангах зарчим;
- хууль дээдлэх зарчим байна.

Үүнээс гадна төрийн албанд Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан дараах тусгай зарчмыг баримтална. Үүнд:

- ард түмэнд үйлчлэх зарчим;
- мэргэшсэн, тогтвортой байх зарчим;
- улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх зарчим;
- Монгол Улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах зарчим;
- төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах зарчим;
- ил тод байх зарчим;
- ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчим;
- захирах, захирагдах ёсыг баримтлах зарчим эдгээр болно. (Ч.Э)

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ (State Service Council) Төрийн албаны төв байгууллага нь Төрийн албаны зөвлөл байна. Зөвлөл нь хараат бус, бие даасан байгууллага бөгөөд Зөвлөлийн үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, нам, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч

хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно. Зөвлөлийн шийдвэрийг холбогдох этгээд заавал биелүүлнэ. Зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд орон тооны таван гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөл дэргэдээ ажлын алба, салбар зөвлөл, сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжтэй байна. Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1) хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах; 2) төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэшил, арга зүйн туслалцаа үзүүлэх, төрийн албатай холбогдсон судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах; 3) иргэн, байгууллага, албан хаагчийн гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай шаардлага хүргүүлэх, хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох; 4) төрийн албаны тухай хууль тогтоомж, чадахуйн зарчмын хэрэгжилтийн талаар төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх; 5) төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, төрийн алба, албан хаагчтай холбогдолтой мэдээллээр Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, бусад сонирхогч этгээдийг хангах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх; 6) хууль тогтоомжид нийцүүлэн эрх хэмжээнийхээ асуудлаар шийдвэр гаргах, өөрчлөх,

биелэлтийг хангах; 7) төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг боловсруулан батлахад Улсын Их Хурал, Засгийн газарт санал өгөх, төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийхэд мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх; 8) төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах, улсын болон орон нутгийн төсвийн удирдлагын зардлын төслийг боловсруулах, хянаж батлахад зохих журмын дагуу санал гаргах; 9) төрийн албаны шинэтгэл болон сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх, өөрчлөлтийн менежмент, төрийн захиргааны болон хүний нөөцийн менежментийн асуудлаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн удирдах ажилтныг мэргэшил, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээгээр хангах; 10) төрийн албаны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тухай мэдээллийг судлан боловсруулж, тэдгээрийн давхардал, хийдлийг арилгах, үр нөлөөг дээшлүүлэх талаар зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх; 11) төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт / тухайн албан тушаалын/-ыг зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах, холбогдох журмыг батлах; 12) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. (Ч.Э)

ТӨРИЙН АЛБАНЫ ИЛ ТОД БАЙДАЛ **(Civil service transparency)**

Төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагаа, тэдгээрийн нөөц буюу нийтийн нөөцийн ашиглалт, гүйцэтгэлийн зорилт, биелэлтийн тайлан, мэдээллийн найдвартай, хязгаарлалтгүй байдал бөгөөд олон нийтэд тайлагнахыг хэлнэ. Төрийн албаны мэдээллийн ил тод байдалд төрийн байгууллагын үйл ажиллагааны (төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, үр дүн г.м), хүний нөөцийн (бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, сургалт хөгжил, хариуцлага г.м), төсөв санхүүгийн (төсвийн төлөвлөлт, зарцуулалт, үр ашиг, орлогын бүрдүүлэлт г.м), төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлаас гадна аудитын тайлан, дүгнэлтийг олон нийтэд тайлагнасан байдлыг хамруулж үздэг. Хямралын үеийн эдийн засгийн тогтворгүй байдал нь санхүүгийн системийн тогтвортой байдалд нөлөөлдөг учир төрийн албаны ил тод байдал нь тогтвортой байдалд хувь нэмэр оруулдаг учир ач холбогдолтой⁴². (Г.Б)

ТӨРИЙН АЛБАНЫ МАНЛАЙЛАЛ **(Public service leadership)**

Шударга байдал, алсын хараа, бусдад урам зориг төрүүлэх чадвар, өөрийн хүч боломжийг гүнзгий таньж мэдэх, шинэ зүйлийг урамшуулах зориг, богино хугацаанд оновчтой шийдвэр гаргах чадвар зэрэг давуу талын хослол юм. Төрийн үйлчилгээний манлайлагчид тодорхой бус байдлыг хүлээн зөвшөөрөх, бүхнийг мэдэгч байх боломжгүйг ойлгох, хувь хүний үзэл хандлага, мэдлэгийг дэмжих,

42 Bonvard, M; Chaignean, P; Motta, A: "Transparency in the Financial System: Rollover Risks and Crises", Journal of Economics and Finance 2012.

нөхцөл байдал өөрчлөгдөхийн хэрээр манлайлах арга барилцаа өөрчилж байх, байгууллага, орон нутагт нийцсэн манлайлал, манлайлагч бий болгох, харилцан хамааралтай соёлыг харгалзан үзэх, манлайлах болон суралцах үйл явцыг салгах боломжгүйг ойлгох чадваруудыг эзэмших ёстой⁴³. Төрийн байгууллагын нарийн нийлмэл үйл ажиллагаа нь удирдагчдаас манлайлахын хамт суралцахыг шаардана. Төрийн байгууллагын манлайлагчид хийж буй ажилдаа шүүмжлэлтэй хандах нь чухал ба Төрийн үйлчилгээ хурдацтай өөрчлөгдөхийн хэрээр манлайлагч хувь хүний мэдлэг, өөртөө итгэх итгэлийг бүрдүүлэгч байх үүргээ улам сайн хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Түүнчлэн төрийн албаны бүтэц, зохион байгуулалтын оновчтой зохицуулалт, дэд системүүдийн харилцан хамаарал, уялдаа холбоотой байдал, системийн үйл явцын гаралт, үр дүн нийгэмд тодорхой эерэг үр дагаврыг бий болгохыг чухалчилна. (Г.Б)

ТӨРИЙН АЛБАНЫ СТАНДАРТ (*Standards of civil service*) Стандарт гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг хэлнэ (Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4.1.2). Төрийн албаны стандарт нь төрийн албыг үр дүнтэй удирдах, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахад чиглэнэ. Төрийн албаны стандарт нь төрийн байгууллага чиг үүргээ, төрийн албан хаагч албан

тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн менежментийн үйл ажиллагаанд тавих шаардлагыг тогтооно. Төрийн албаны стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу боловсруулан баталж, мөрдүүлнэ (Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйл. (Ч.Э)

ТӨРИЙН АЛБАНЫ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА (*Civil service training institution*) Төрийн албан тушаалын шаардлагад нийцсэн мэдлэг, ур чадвар, хандлагатай хүний нөөцийг залгамж холбоотой бэлтгэх, ажиллаж буй төрийн албан хаагчдын сургалт, хөгжлийг хангах зорилгоор давтан болон мэргэшүүлэх сургалтыг хариуцан зохион байгуулдаг сургалтын байгууллага. Төрийн албаны сургалтын байгууллага нь их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрөөс гадна төрийн албан хаагчдыг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх сургалт зэргийг хариуцсан тусгайлсан чиг үүрэг бүхий засгийн газрын дэргэдэх байгууллагын хэлбэртэй. Төрийн албаны хүний нөөцийн эрэлт хэрэгцээ их, нөөц хомс, зорилгодоо хүрэхэд шахалт өндөр, хурдацтай өөрчлөгдөж буй нөхцөлд төрийн албаны сургалтын байгууллагын үүрэг чухал. (Г.Б)

ТӨРИЙН АЛБАНЫ СЭДЭЛЖҮҮЛЭЛТ (*Public service motivation*)⁴⁴ Орон нутгийн нэгдэл, ард түмэн ба төр болон хүн төрөлхтний төлөө сайн дураар үйлчлэх гэсэн энгийн нэг бусдын төлөөх сэдлийг хэлнэ. Энэхүү ойлголт нь төрийн албан хаагчидтай

⁴⁴ Ц.Дэлгэржаргал: Төрийн албан хаагчдын сэдэл ба шинэчлэгч зан үйлийн харилцан нөлөөлөл. Төрийн захиргаа сэтгүүл, 2014/№04 (33), Улаанбаатар, х. 58-60.

⁴³ Тони Бовэйрд, Элке Лойффлер “Улсын салбарын менежмент, засаглал” 2014, х. 244.

хамааралтай учраас монгол хэлээр төрийн албан хаагчийн сэдэл гэсэн утгаар хэрэглэх нь оновчтой юм. Ийм сэдэл нь амь хайргүй зүтгэх зүтгэл болоод сэтгэл зүрхээрээ өөрийгөө зориулан ажиллах хүслээр илэрч, нийтийн эрх ашгийг нэмэгдүүлэхийн төлөөх чухал ажлыг хийх гэсэн албан хаагчдын хүсэл эрмэлзлийг багтаадаг. 1990 онд Перри болон Вайс (Perry, J.L. & L.R. Wise)⁴⁵ нар төрийн захиргааныхан дунд илэрдэг өвөрмөц сэдлийг судалсан нь төрийн албан хаагчийн сэдэл (Public Service Motivation) юм. Тэд төрийн албан хаагчийн сэдлийг 3 төрлийн үндэслэлд суурилсан гэж үзээд оновчит (rational) хэмжигдэхүүн, нийгэм ба байгууллагын дүрэм журмыг мөрдөх гэсэн зүтгэлд суурилсан дүрэм журам (norm-based) хэмжигдэхүүн, нийгмийн янз бүрийн нөхцөл байдалд сэтгэл зүйн байр сууринаас хандах сэтгэл зүйн (affective) хэмжигдэхүүн гэж ангилжээ. Перри (Perry, J.L., 1996)⁴⁶ нь өмнөх 3 төрлийн хэм хэмжээнд үндэслэн бодлого төлөвлөлтийн талаарх эерэг сэтгэл (attraction to public policy making), төрийн албанд зүтгэх зүтгэл (commitment to public interest), энэрэх сэтгэл (compassion), өөрийгөө зориулах (self-sacrifice) зэрэг 4 төрлийн дэд үзүүлэлтийг гаргасан ба төрийн албан хаагчийн сэдлийг эдгээр дөрвөн үзүүлэлтийг ашиглан хэмжиж болно гэжээ. (Ц.Д)

Лавшруулж үзэх материал: Ц.Дэлгэржаргал (2014). Төрийн албан хаагчдын сэдэл ба шинэчлэгч зан үйлийн харилцан нөлөөлөл. Төрийн захиргаа сэтгүүл. Улаанбаатар. 2014/№04(33). хуудас 58-60.

45 Perry, J.L. & L.R. Wise. (1990). The motivational basis of public service. *Public Administration Review*.

46 Perry, J.L. (1996). Measuring Public Service Motivation: An Assessment of Construct Reliability and Validity. *Journal of Public Administration Research and Theory*. 61(1):5-22

ТӨРИЙН АЛБАНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГА (*Central authority in charge of civil service*)

Төрийн албан хаагчийн стандартын удирдлагыг хэрэгжүүлэх, төрийн алба, албан хаагчтай холбоотой хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэг бүхий хараат бус, бие даасан⁴⁷ байгууллага юм. Төрийн албаны төв байгууллага нь улс орны засаглал эрх мэдэл, бүтэц зохион байгуулалтаас хамаарч ялгаатай чиглэлээр чиг үүрэг нь тодорхойлогдох, үйл ажиллагааны хүрээ нь хязгаарлагдмал байж болно. Төрийн албаны төв байгууллагын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжигдэх ба батлагдсан бүтэц, зохион байгуулалт, орон тооны дагуу үйл ажиллагааны тайланг хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт, төрийн албаны хууль тогтоомжийг сайжруулах санал, мэдлэг, ур чадвар туршлагад суурилсан, улс төрөөс хараат бус, шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааны талаар цаашид авах арга хэмжээний санал боловсруулан гаргана. (Г.Б)

ТӨРИЙН АЛБАНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ (*Position and suggestion of the public organization in charge of civil service*)

Засгийн газар болон бусад төрийн байгууллагаас гаргах төрийн албаны төв байгууллагын хариуцсан чиг үүрэгтэй уялдаа холбоотой шийдвэр, үйлдлийг судалгаа мэдээллээр хангах, боломжит бусад хувилбарыг дэвшүүлэх, санал болгохоор танилцуулсан албан харилцаа болон баримт бичгээр хэлбэржсэн байр

47 Ц.Энхмандах: “Төрийн албаны төв байгууллага, түүний чиг үүрэг”, Улаанбаатар, 2017, х. 69.

суурь юм. Улс орны төрийн албаны төв байгууллагын хуулиар олгогдсон эрх мэдэл, үүрэг нь харилцан адилгүй байж болох ба төрийн албаны төв байгууллага нь төрийн албаны хүний нөөцийн тоо хэмжээ, статистик, хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, сургалт хөгжил, цалин хөлс, ёс зүй, харууцлага, сахилгын шийтгэл, хүний нөөцийн аудит зэрэгтэй холбоотой захиргааны хэм хэмжээгээр тогтоосон дүрэм журмыг боловсруулахад засгийн газарт санал хүргүүлэх, мэргэжлийн салбарын шинэ мэдээлэл, судалгаа нотолгоонд үндэслэн хувилбар дэвшүүлэх эрхтэй байх нь нийтлэг. Зарим улс оронд энэхүү харилцааг хуулиар зохицуулдаг ба засгийн эрх мэдэл, үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор парламентын институцэд шууд харьяалагдаж түүнд тайлагнах байдлаар төрийн албаны төв байгууллагын эрх зүйн байдлаар тогтоосон байх ба энэ тохиолдолд төрийн албаны төв байгууллагын санал, парламентын санал байж болно. (Г.Б)

ТӨРИЙН АЛБАНЫ ТУСГАЙ ШАЛГАЛТ *(Special civil service examination)*

Төрийн албаны сул орон тоог нөхөх зорилгоор төрийн албаны нөөцөд буй иргэдээс авах шалгалтын хэлбэрийг хэлнэ. Тусгай шалгалт нь шатлан дэвших зарчмын дагуу явагдана. Төрийн албаны тусгай шалгалт нээлттэй бус хязгаарлагдмал шинж чанартай. Гэхдээ Төрийн жинхэнэ албаны албан тушаалын дээд ангилалд хамаарах албан тушаал хашиж байсан хүн доод ангилалд хамаарах албан тушаалын сул орон тоонд ажиллах бол тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан боловсрол, мэргэжил, мэргэшлийн

шаардлагыг хангаж байвал тухайн албан тушаалын шалгалт өгөхгүйгээр уг албан тушаалд орох эрхтэй. (Г.Б)

ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦ *(Civil service human resources)*

Төрийн байгууллагын ажиллах хүчийг бүрдүүлэгч хүмүүсийн цогц мөн. Төрийн албан хаагчдын үнэт баялаг, мэдлэг, ур чадвар юм. Энэ нь засгийн газрын байгууллага, агентлаг, төрийн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын нөөцөөр илэрхийлэгдэнэ. Авьяас чадварын менежмент, ажиллагсдын болон салбарын харилцаа, сургалт ба хөгжил, урамшуулал, цалин хөлс, бусад олговор, гүйцэтгэлийн менежмент, ажлаас чөлөөлөх, гомдлын менежмент, стратеги, хэмжих үзүүлэлтүүд, зарчим, бодлого шийдвэр, үйл ажиллагаа, практик арга барил зэрэг асуудлууд хүний нөөцийн менежментэд багтана. (Г.Б)

ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН АУДИТ *(Civil service human resource audit)*

Төрийн байгууллагын хүний нөөцийн өнөөгийн тогтолцоо, бодлого, стратеги, үйл ажиллагаа, дүрэм, журам, баримт бичиг зэргийг бодитой, системтэйгээр нягтлан шалгаж, “өнөөгийн төлөв”-ийн бодит байдал, практик туршлагын хангалттай байдал, хууль ёсны, үр дүнтэй эсэхийг үнэлдэг цогц арга хэрэгсэл юм. Түүнчлэн хүний нөөцийн аудит нь төрийн байгууллагын хүний нөөцийн чиг үүргийн үр ашгийг үнэлэх, хүний нөөцийн мэдээллээ шалгах, хүний нөөцтэй холбоотой гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан илрүүлэх, засаж сайжруулах, ирээдүйгээ төлөвлөх, байгууллагын зорилгод хүрэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Мөн

төрийн албаны хүний нөөцийн аудит нь төрийн албаны хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтад дүн шинжилгээ хийх, үнэлэх, сайжруулах хэрэгсэл болохоос гадна хүний нөөцийн үйлчилгээг системчилсэн байдлаар үнэлэх явдал юм. (Г.Б)

ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО (*Civil service human resource policy*)

Төрийн байгууллага үйл ажиллагааны хүрээнд шаардлагатай мэдлэг, ур чадвар бүхий хүний нөөцөөр тасралтгүй хангагдах бодлого баримтална. Улс орнуудын төрийн албан хаагчийн бодлого ялгаатай. Албан тушаалд шаардагдах мэдлэг, ур чадвар бүхий хүнийг сонгон шалгаруулах, төрийн албан хаагчийн мэдлэг ур чадварыг сайжруулах, тэдний ажлын үр дүнд суурилан цалин, урамшуулал олгох, ажиллах эрүүл аюулгүй орчныг бүрдүүлснээр идэвхжүүлэх, сэдэлжүүлэх бодлого хэрэгжүүлнэ. Улс орны хүний нөөцийн бодлого тогтвортой, улс төрөөс хараат бус байхыг чухалчилна. (Г.Б)

ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БҮРДҮҮЛЭЛТ (*Recruitment of civil service*)

Төрийн албаны нөөц эсвэл хөдөлмөрийн зах зээлээс чадварлаг ажил горилогчдыг олох, цуглуулах, тухайн нээлттэй албан тушаалд тохирохуйц хүмүүсийг бүртгэх, судлах зэргээр шилж сонгох үйл ажиллагаа. Хүний нөөцийн удирдлагын функц нь төрийн болон хувийн байгууллагаас үл хамааран онолын үзэл баримтлалын дагуу явагддаг бөгөөд функцийн нэг нь “хүний нөөцийн бүрдүүлэлт” байдаг. Энэ нь тухайн албан тушаалын чиг үүрэгт тавигдах нийтлэг болон тусгай шаардлага, ажлын зорилго,

зорилтууд, хүлээх үүрэг хариуцлага, албан үүргийн мөн чанар, агуулгыг гаргаж, хариуцах эзний чадвар, чадамж, мэргэжлийн болон бусад шаардлагыг тодорхойлсон төрийн албаны тушаалын тодорхойлолтын боловсруулалт, баталгаажуулалтаас эхлэн төрийн албаны сул орон тоог нөхөх зорилгоор зарласан нээлттэй сонгон шалгаруулалт, түүний бүртгэл, бүртгэлд хамрагдсан нэр дэвшигчдээс шилж сонгох хүртэлх үйл явцыг хамруулдаг. (Г.Б)

ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЛИЙН САН (*Human resource database for civil service*)

Төрийн албанд ажиллаж байгаа, төрийн албанд ажиллахаар нөөцөд бүртгүүлсэн хүмүүсийн холбогдох судалгаа, сонгон шалгаруулалт, сургалт хөгжил, ажлын гүйцэтгэл зэрэг шаардлагатай бүх мэдээллийг агуулсан бүртгэл, ашиглалтад хамаарах өгөгдлүүдийн цогц бүрдэл. Манай улсын хувьд Төрийн албаны хуульд зааснаар төрийн албаны төв байгууллага буюу Төрийн албаны зөвлөл төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн санг хөтлөн явуулдаг. Төрийн албанд хамаарах бүх байгууллагууд хүний нөөцийн мэдээллээ энэхүү санд төвлөрүүлэх ба сангийн бодлого, ашиглалт, зохион байгуулалттай холбоотой асуудлыг Төрийн албаны зөвлөл хариуцна. (Д.З; Ч.Л нар)

ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ (*Selection process of civil service*)

Төрийн албанд ажиллах хувь хүний ур чадвар, мэдлэг мэргэжил, мэргэшил, оюуны болоод биеийн хүчний чадавх, ёс зүй харилцаа хандлагыг үнэлэх процесс юм⁴⁸.

48 Н.Бурмаа, Ц.Батболд, Stefan Hanselmann... “Нийтийн удирдлагын үндэс”, Улаанбаатар 2018, х. 399.

Төрийн албанд сул орон тоо гарсан үед шатлан дэвших зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсвэл ерөнхий шалгалт өгч тэнцсэн төрийн албаны нөөцөд буй иргэдээс уг орон тоог нөхөн ажиллуулна. Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх ба туслах албан тушаал (ахлах шинжээч, шинжээч, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, ахлах зохион байгуулагч, зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал)-ын сул орон тоог тухайн байгууллагад ажиллаж байгаа, эсхүл холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас сонгон шалгаруулах боломжгүй тохиолдолд нээлттэй сонгон шалгаруулалт явуулна. (Г.Б)

ТӨРИЙН АЛБАНЫ ШАЛГАЛТ (*Civil service examination*) Төрийн албаны нөөц бүрдүүлэх, төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах, төрийн жинхэнэ албаны зорилт, чиг үүргийг үр ашигтай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн албаны мэргэшлийн шалгалт авна. Төрийн албаны шалгалтын хамгийн эртний жишээ нь “Хятадын эзэн хааны шалгалт” гэж судлаачид тэмдэглэдэг бөгөөд XIX зуунд Оросын эзэнт гүрэн энэхүү журмыг хэрэгжүүлж байсан түүхтэй. Төрийн албаны шалгалт нь мерит систем дээр суурилсан үр дүнтэй, оновчтой төрийн захиргаанд хүрэх арга хэрэгсэл болгон ашиглахад чиглэгдсэн. (Г.Б)

ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭЧЛЭЛ (*Civil service reform*) Төрийн алба буюу “civil service” гэдэг нь анх цэргийн бус алба, цэргийн бус албан хаагч гэсэн утгыг илэрхийлдэг байв. Өнөө цагт энэ нь төрийн алба гэсэн утгаар хэрэглэгдэх

болсон. Өөрөөр хэлбэл, “civil” гэдэг нь Латин хэлний “civilis” буюу “нийгэм, иргэд” гэсэн агуулгатай холбогдон гарч ирсэн байдаг. Харин “service” нь эртний Францын “servise” буюу “ширээний ардаас үйлчлэх (service at table)” гэсэн утгатай. Үгийн нийлэмжийг үзвэл иргэдэд үйлчлэх алба буюу төрийн алба гэсэн утгыг илэрхийлж байна. Төрийн алба нь төрийн зорилт, чиг үүргийг хуулийн хүрээнд хэрэгжүүлэх, бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй хэрэгцээтэй үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг хэлнэ⁴⁹. Төрийн алба нь Монгол Улсын Төрийн албаны тухай хуулиар тогтоосон дүрэм журмаар эрх, үүрэг нь зохицуулагддаг албан хаагчдаас бүрддэг. Төрийн албаны шинэчлэл нь мэргэшсэн, тогтвортой байх (“мерит”) зарчимд суурилсан, улс төрийн намуудаас хараат бус төрийн албыг байгуулах буюу бэхжүүлэх явдлыг гол зорилгоо болгосон. Монгол Улсын төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл хэд хэдэн үе шаттай явж ирсэн. Энэхүү өөрчлөлт, шинэчлэлийн үе тус бүр нь өөрийн онцлогтой чиглэсэн тодорхой зорилго, зайлшгүй хэрэгжүүлэх үйл ажиллагаатай байсан. Тухайлбал,

1. Төрийн байгууллын шинэ тогтолцоог бүрдүүлэх нэгдүгээр үе шат (1990-1993). Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг баталж, Монгол Улсын ардчилсан төрийн байгууллагын шинэ тогтолцоо бүрдэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн төрийн байгууллын шинэ тогтолцоо бий болж, төрийн

⁴⁹ Д.Байгал, Төрийн албаны шинэчлэл ба манлайлал, Шинэ толь №.66, 2009.

албаны бүтэц, үйл ажиллагааны үндсэн эхлэл тавигдсан.

2. Төрийн захиргаа, төрийн албаны шинэ тогтолцоог бүрдүүлэх хоёрдугаар үе шат (1994-2000). Монгол Улсын түүхэнд анх удаа төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх зарчимд суурилсан “Төрийн албаны тухай” хууль 1994 онд батлагдсан нь өнөөгийн төрийн албаны эрх зүйн орчинг бүрдүүлж өгсөн. Мөн энэ үед Засгийн газрын “Удирдлагын хөгжлийн хөтөлбөр”-ийг 1993-1996 онд хэрэгжүүлж, энэ хүрээнд “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг боловсруулан Улсын Их Хурлын 1996 оны 38-р тогтоолоор батлан хэрэгжүүлж эхэлсэн. Энэ нь Монгол Улсын төрийн захиргааг шинэтгэх эхлэлийг тавьсан юм.
3. Төрийн албаны чадавх, үйл ажиллагааных нь үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх гуравдугаар үе шат (2000-2008). Дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж байгаа төрийн захиргааг өөрчлөн шинэчилж буй нийтлэг хандлага, чиглэл (менежментийн арга барил, механизм)-ийг баримжаалан Монгол Улсын төрийн захиргаа, төрийн албанд шинэтгэлийн үйл явцыг хэрэгжүүлэх бодлого, чиглэл энэ үе шатанд тодорхойлогдсон болно. Тухайлбал, 2002 онд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль батлагдаж үүнтэй нийцүүлэн Төрийн албаны тухай хуулийг шинэчлэн баталсан. Мөн 2004 онд Монголын улсын төрийн

албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн баримт бичгийг Улсын Их Хурлаас баталсан нь үр дүнд чиглэсэн төрийн албыг төлөвшүүлэхэд чиглэн стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлага, хүний нөөц, санхүүгийн удирдлагын арга, механизмыг бэхжүүлэх ёстой гэдэгт анхаарах шаардлагатайг онцолсон.

Улс төрийн нөлөөллөөс ангид төрийн мэргэшсэн, тогтвортой албыг төлөвшүүлэх үе шат (2008 оноос хойших хугацааг хамарч байгаа). Төрийн албаны тухай хуульд 2008 онд нэмэлт өөрчлөлт оруулж төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчдын улс төрийн намын гишүүн байх явдлыг хязгаарласан юм. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь төрийн албыг улс төрөөс хараат бус байлган төрийн албаны мэргэшсэн тогтвортой байх зарчмыг баталгаажуулан төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах, төрийн албаны гүйцэтгэлийг сайжруулах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, төрийн албаны нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн. Мөн “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ыг тодорхойлж, Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан юм. Энэхүү “цогц бодлого”-ын Монгол Улсын хөгжлийн 6 дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд Монгол Улсын төрийн захиргаа, төрийн албаны шинэтгэлийн бодлогыг тусгаж өгсөн байдаг. (Т.Т)

ТӨРИЙН АЛБА ХААХ НАСНЫ ДЭЭД ХЯЗГААР (*Upper age limit for governmental servants*)

Төрийн албанд насны үзүүлэлтийг харгалзах нь төрийн албан хаагчийн

эзэмшсэн ур чадвар, ажлын гүйцэтгэл, байгууллагын соёл зэрэгт ихээхэн нөлөөлнө. Дийлэнхдээ улс орнууд төрийн албан тушаалд ажиллах насны доод хязгаарыг заана. Мөн тухайн улсын хөдөлмөрийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд төрийн албанд ажиллах насны дээд хязгаарыг зарим улс орнууд зааж өгнө. Энэ нь тус улсын хүн амын дундаж наслалт, албан тушаалын чиг үүргийн онцлогоос шалтгаалан харилцан адилгүй тогтоогдоно. Тухайлбал улс орны дундаж наслалт нэмэгдэхийн хирээр төрийн албанд ажиллах насны дээд хязгаарыг нэмэгдүүлж болно. Төрийн албан хаагч алба хаах насны дээд хязгаарт хүрсэн хэдий ч өөрийн санаачилгаар хүсэлт гаргавал тухайн байгууллагын удирдлага хүсэлтийн дагуу үргэлжлүүлэн ажиллуулахаар шийдвэрлэх ба энэхүү харилцааг хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна. (Г.Б)

ТӨРИЙН АППАРАТ (*Governmental apparatus*) Төрийн нэрийн өмнөөс төрийн удирдлага, чиг үүрэг, бүрэн эрхийг амьдралд хэрэгжүүлдэг, хуулийн дагуу байгуулагдаж тогтвортой үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагын тогтолцоог төрийн аппарат гэнэ. Төрийн аппаратад: а) тодорхой хэмжээгээр бие даасан үйл ажиллагаа явуулдаг бүтцийн нэгжүүд бүхий төрийн байгууллагууд (нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, түүний хэлтэс, тасаг, албад г.м.), б) олгогдсон хэм хэмжээгээ бие даан хэрэгжүүлэх эрх бүхий тодорхой албан тушаалтныг (дээд шатны байгууллагаас томилогдсон засаг дарга) хамруулан ойлгоно.⁵⁰ Явцуу утгаар төрийн аппарат гэж төрийн өдөр тутмын удирдлагыг хэрэгжүүлэх

50 Д.Солонго: Төрийн эрх зүйн тайлбар толь, Улаанбаатар, 2003, х. 118.

засаг төрийн гүйцэтгэх (захиргааны) байгууллагын нийлбэр цогцыг ойлгоно. (Ч.Э)

ТӨРИЙН АУДИТ (*Supreme Audit*)

Байгууллагын санхүүгийн бүртгэл, тайлан нь үнэн зөв эсэхийг хараат бус мэргэшсэн нягтлан бодогчид шалгаж нотлох үйл ажиллагааг аудит гэж тодорхойлдог.⁵¹ Үүнээс өргөн хүрээгээр тодорхойлбол, аудит нь эдийн засгийн үйл ажиллагаа, үйл явдлын талаарх батламж, мэдэгдлүүд нь тогтоосон шалгууртай нь хэр нийцэж буйг тодорхойлж үр дүнг нь сонирхогч талуудад танилцуулах зорилгоор нотолгоог цуглуулж үнэлэх системчилсэн үйл явц.⁵² Төрийн аудит нь төрийн салбарын санхүүгийн бодлого, зохицуулалтын тогтолцооны нэг хэсэг бөгөөд хөндлөнгийн аудитын нэг хэлбэр юм. Хувь хүмүүс, хөрөнгө оруулагчдын хөрөнгө мөнгөний зарцуулалтад хөндлөнгийн аудит шаардлагатай бол нийтийн хөрөнгө буюу татвар төлөгчдийн мөнгөөр бүрдсэн улс, орон нутгийн төсвийн хөрөнгийн зарцуулалтад хөндлөнгийн аудитын хяналт, дүгнэлт шаардагдах нь гарцаагүй юм. Энэ үүргийг төрийн аудит хэрэгжүүлдэг. 1977 онд Перу Улсын нийслэл Лима хотод хуралдсан Олон улсын Төрийн санхүүгийн хяналтын дээд байгууллага (International Organization of Supreme Audit Institutions)-ын 9-р их хурлаас гаргасан тогтоолд тусгаснаар “Төрийн аудитын зорилго нь тогтсон стандартаас гажсан, хууль ёс, санхүүгийн удирдлагын үр ашигтай, үр нөлөөтэй, арвич хямгач зарчмыг зөрчсөн тохиолдлыг илрүүлэн залруулах боломж олгох,

51 The New Encyclopedia Britannica, 15th edition, 1988, p. 695.

52 The Report of the Committee on Basic Auditing Concepts of the American Accounting Association (AAA)

холбогдох этгээдэд хариуцлага хүлээлгэх, хохирлыг барагдуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах явдал” гэж тусгасан.⁵³ Төрийн аудитын хараат бус зарчим хэрэгжиж байж үр дүнтэй байх бөгөөд санхүүгийн тайлангийн, нийцлийн, гүйцэтгэлийн гэсэн аудитын төрлүүд байна. (Б.Б)

ТӨРИЙН АУДИТОР (*State auditor*)

Төрийн санхүүгийн, хүний нөөцийн болон бусад үйл ажиллагаа зөв, зохистой, бүрэн тусгагдсан эсэхийг тогтоох зорилгоор шалгалт хийх эрх бүхий албан тушаалтанг хэлнэ. Аудитор нь төрийн байгууллагын бодлого, стратеги, үйл ажиллагаа, дүрэм журам, холбогдох санхүүгийн болон бусад баримт бичгүүдтэй танилцан, бүрдүүлэлт, тайланд шалгалт хийн, эрсдэлтэй нөхцөл байдлыг илрүүлэх, эсвэл ахиц дэвшлийг гаргаж дэвшүүлэн дүгнэлт үйлдэх эрх бүхий албан тушаалтан байна. (Г.Б)

ТӨРИЙН БАЙГУУЛАМЖ (*State formation*)

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарилалт, төрийн дээд, төв, орон нутгийн байгууллагуудын хоорондын харилцааны эрх зүйн байдал нь тухайн улсын төрийн байгууламжийн хэлбэрийг илэрхийлдэг ойлголтууд юм. Төрийг байгууламжийнх нь хувьд нэгдмэл, холбооны, улсуудын холбоо / конфедераци/ гэж ангилдаг.

Нэгдмэл улс гэдэг нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн нэг тогтолцоотой, улсын хэмжээнд үйлчлэх хүчин чадал бүхий нэг Үндсэн хууль, хууль тогтоомж, санхүү, албан татвар, мөнгөний нэгдмэл нэг тогтолцоотой, өөрийн

зэвсэгт хүчинтэй, төрийн бэлгэ тэмдэг болох улсын сүлд, туг, далбаа, дуулал нэгтэй, орон нутгийн төрийн байгууллагууд нь тус тусдаа бие даасан улсын хэлбэрээр биш засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваариар зохион байгуулагддаг улс юм.

Үндсэн шинж нь:

- Улсын нутаг дэвсгэр нь засаг захиргааны нэгжээс бүрдэнэ.
- Нэг үндсэн хууль, эрх зүйн нэгдмэл тогтолцоотой
- Төрийн байгууллагын нэгдмэл тогтолцоотой
- Татвар мөнгөний нэг тогтолцоотой
- Иргэний нэг харьяалалтай
- Хэл, соёл, шашин зэргээр ижил угсаатан хүн ам зонхилох онцлогтой.

Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.⁵⁴

Холбооны улс нь өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд эрх зүйн бие даасан байдлаа хадгалсан статус бүхий хоёр буюу хэд хэдэн улс нэгдэж улсуудын холбоог сайн дурын гэрээний үндсэн дээр байгуулсан төрийн байгууламжийн хэлбэр юм. Тодруулбал, холбооны ёс нь засгийн газрын үйл ажиллагааг бүс нутгийн болон төв засгийн хооронд хуваасан улс төрийн байгууллага мөн бөгөөд тэр хуваарийн дагуу засгийн түвшин бүрд эцсийн шийдвэр гаргах ямар нэгэн үйл ажиллагаа оногддог” гэж тодорхойлжээ. Газар нутаг нь холбооны улсын нутаг дэвсгэр, гишүүн улсын нутаг дэвсгэрээс бүрдэнэ. Төрийн байгууллын хоёрдмол тогтолцоотой байна. Холбооны улсын иргэд иргэний хоёрдмол

53 Н.Бурмаа: Төрийн хяналт, Улаанбаатар 2016, х. 77-с дам эшлэв.

54 Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

харьяалалтай байж болдог. Мөн холбооны болон гишүүн улсын татварын тогтолцоо зэрэгцэн оршдог онцлог бас бий.

Холбооны улс нь эрх мэдлийн хуваарилалтын хувьд анхдагч болон хоёрдогч шинж чанаруудтай. Анхдагч шинж нь төрийн эрх мэдлийн хуваарилалтын үл төвлөрүүлэх болон саармагжуулахад оршино. Хоёрдогч шинж нь бүс нутгийн сонгогчдыг төлөөлөх холбооны хос танхимт парламент, нэмэлт өөрчлөлт оруулах боломж багатай бичмэл Үндсэн хууль, Дээд шүүх, Үндсэн хуулийн шүүхтэй байх зэрэг шинж чанарууд багтана. Улсуудын холбоо буюу конфедерацийг тусад нь тайлбарласан учир тэндээс үзнэ үү. (Ч.Э; Я.Т)

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА (*Public organization*)

Төрийн засаглан захирах бүрэн эрх бүхий, тодорхой салбарт түүний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх эрхтэй, олгогдсон эрх хэмжээний хүрээнд төрөөс тогтоосон журмын дагуу төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг нийтийн эрх зүйн субъектийг төрийн байгууллага гэнэ. Энэ нь хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг боловсруулж, хэрэгжүүлж үндсэн чиг үүрэг бүхий, тодорхой дүрэм, журмаар зохицуулагдсан зохион байгуулалтын албан ёсны бүтцийн нэгж байна⁵⁵. Төрийн байгууллагын үндсэн шинж: а) Үндсэн хууль, бусад хуульд заасан журмаар байгуулагддаг, б) төрийн тодорхой чиг үүрэг буюу түүний аль нэг хэсгийг эрхлэн хариуцдаг, в) төрийн албан хаагчдаас бүрддэг, бие даасан дотоод зохион байгуулалтын бүтэцтэй байдаг, г) үйл ажиллагаа нь төсвөөс санхүүждэг, д) өөрийн

эрх хэмжээний хүрээнд тодорхой асуудал шийдвэрлэх, төрийн бусад байгууллага, албан тушаалтан, иргэд, хүмүүс заавал дагаж биелүүлэх хүчин чадалтай хэм хэмжээний акт батлан гаргадаг, е) чиг үүрэгтээ тохирсон материаллаг нөөцтэй байдаг. Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ (Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.1). Төрийн байгууллага төрийн албан хаагчдаас бүрдэж, түүний үйл ажиллагаагаар зорилго, зорилгоо хэрэгжүүлдэг тул төрийн байгууллагын үйл ажиллагааны орчин нь онцлог шинж чанарт хамаардаг. Олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлага, олон чиглэл бүхий зорилго, эрх, бүрэн эрх, үүрэг хариуцлага, хууль тогтоомжоор тогтоосон үйл ажиллагааны болон санхүүгийн хүрээ, төсвийн ач холбогдол, засаглалын бүтэц нь төрийн байгууллагын гол шинж чанар юм. (Ч.Э; Г.Б нар)

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД ХООРОНД-ЫН ЦАХИМ ХАРИЛЦАА (*Government to government relations (G2G)*)

Төрийн байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлэх тодорхой шаардлагын үүднээс өөр хоорондоо хэрэглэдэг цахим технологид суурилсан харилцааны хэлбэр. Уламжлалт цаасан суурьтай харилцааг өөрчилж, цаг хугацаа, зардал, чирэгдлийн хэмнэлттэй мэдээллийн технологид суурилсан цахим харилцааг дэмжин хөгжүүлэх явдал цахим засаглалын бодлогын нэг чухал хэсэг юм. (Д.З; Ч.Л нар)

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БЭЛЭГ ТЭМДЭГ (*Symbol in public organization*)

Төрийн байгууллагын чиг үүрэг, үндсэн чиглэлтэй холбоотой

⁵⁵ Н.Отгонбаяр: “Төрийн захиргааны шинжлэх ухаан”, Улаанбаатар 2019, х. 59.

боловсруулагдсан тэмдэгт дүрслэлтэй, тодорхой утга санаа, холбоо харилцаа, мөн чанарыг илтгэсэн агуулгатай оюун санааны биет үнэлэмж юм. Тухайн бэлэг тэмдэг нь тухайн төрийн байгууллагын лого, далбаа, албан бланк байж болох ба эдгээр нь тухайн байгууллагын үйл ажиллагааны албан ёсны, тодорхой байдлыг илтгэхээс гадна бэлэг тэмдгийг ашиглах, хадгалах, байршуулах журмыг байгууллагын дотоод дүрэм журмаар зохицуулдаг. Бэлэг тэмдгийг оновчтой тодорхойлсноор:

- тухайн байгууллагын ажиллагсдын урам зоригийг нэмэгдүүлэх, эв нэгдлийг хангах, идэвхжүүлэх;
- нийгэмд эзлэх байр суурийг бэхжүүлэх;
- улс орны хэмжээнд төрийн албаны нэр хүндийг сайжруулах, үнэт зүйлийг гүнзгийрүүлэх ач холбогдолтой.

Байгууллагын бэлэг тэмдэг тухайн байгууллагын онцлог, үйл ажиллагааг илэрхийлэх хийсвэр утга, концепцыг агуулна. (Г.Б)

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОО (Gov2Gov e-interaction)

Төрийн байгууллагууд хариуцсан чиг үүргийн дагуу эзэмшиж байгаа мэдээллээ нэгдмэл зорилгын үүднээс, эрэлт шаардлагад нийцүүлэн харилцан уялдуулж ашиглах үйл ажиллагаа. Төрийн нэгдсэн бодлогыг нэгдмэл байдлаар хэрэгжүүлэх нь төрийн байгууллагуудын нийтлэг үүрэг учраас байгууллагууд мэдээллээ солилцож хамтран ажиллах нь төрийн үйл ажиллагааны цогц байдлын чухал илэрхийлэл юм. Төрийн байгууллага хооронд аливаа өгөгдлийг анхдагч сурвалжаас нь чөлөөтэй солилцдог болсноор Төр өөртөө байгаа

мэдээллийг иргэд, байгууллагаас шаардахгүй болж төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай, хүртээмжтэй байх үндэс болдог. (Д.З; Ч.Л нар)

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ (Government information service)

Төрийн байгууллагаас иргэд, аж ахуйн нэгж болон бусад хуулийн этгээдийн мэдээлэл авах эрэлт хэрэгцээг аль болох хүртээмжтэй, шуурхай, бүрэн хангахын тулд хэрэглэдэг цахим технологи. Манай улсын хувьд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд төрийн байгууллагууд үйл ажиллагааныхаа болон хүний нөөцийн хөдөлгөөний тухай мэдээллээ тухайн байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт тавьж мэдээлэх ба тухай бүр шинэчилж байхаар тусгасан байдаг. Байгууллагын цахим хуудас нь төрийн байгууллагын мэдээллийн үндсэн хэрэгсэл юм. (Д.З; Ч.Л нар)

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНД ХОЛБОГДСОН БАЙДАЛ (Connected E-Government)

Иргэд, бизнес эрхлэгчид болон бусад салбаруудад үйлчилгээ үзүүлэх, засгийн газрын үйл ажиллагааг дэмжих зэрэг нийтлэг зорилгоор засгийн газрын түвшин, нэгж, агентлагуудыг хооронд нь уялдуулах байдлаар бодож, ажиллах байдлыг илэрхийлдэг ойлголт юм. (Д.З; Ч.Л нар)

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ (Public organizations function)

Төрийн байгууллага нь төрийн эрх мэдлийн хүрээнд бүрэн эрх эдэлж, чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага болохын хувьд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Эдгээр нь төрийн байгууллагын чиг үүрэг мөн.

Төрийн байгууллага нь нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээг тогтоох үндсэн чиг үүргээс гадна тухайн хэм хэмжээ, хууль тогтоомжийг биелүүлэх, хэрэгжилтийг хангах байдлаар бодлого тодорхойлох, зохион байгуулах, төлөвлөх, хүний нөөцийг бүрдүүлэх, идэвхжүүлэх, хянан шалгах, мөн иргэд, байгууллага, бусад оролцогч талуудын хоорондын аливаа хэрэг, маргааныг шударга ёс, төрийн хуулийн дагуу шүүн шийдвэрлэх чиг үүрэгтэй. Төрийн эрх мэдлийн хүрээнээс гадна төрийн байгууллага нь улс орноо батлах хамгаалах, гадаад улс оронтой найрсаг, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагатай харилцах гэх мэт гадаад чиг үүрэг, нийгмийн эмх журмыг хангах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинг бий болгох, хамгаалах, боловсрол, эрүүл мэндийн нийгмийн аливаа үйлчилгээг үзүүлэх, орон нутаг, хотын бүсийг бий болгох, нэгдсэн удирдлагаар хангах, дэд бүтцийг байгуулах зэрэг дотоод чиг үүрэгтэй байдаг. (Г.Б)

ТӨРИЙН БОДЛОГО (*Public Policy*)

Төрийн бодлого нь ямар нэгэн нийгмийн асуудлыг шийдэхийн тулд төрөөс явуулж буй үйл ажиллагааны үйлдэл, эс үйлдэл юм. Нийгмийн асуудал гэдэг нь олон нийтийн эрх ашигт үл нийцэхүйц эсвэл асуудал нь ужгирсан, олон сөрөг үр дагавар, нөлөөллийг бий болгож тодорхой арга хэмжээ авах шаардлагатай болсон нөхцөл байдал юм. Нөгөө талаар төрийн бодлого нь засгийн газраас хэрэгжиж буй улс төрийн алсын хараа, түүний бодит өөрчлөлт “үр нөлөөнд хүрэх” хөтөлбөрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх үйл явц юм гэж тодорхойлдог. Аливаа нийгмийн асуудлын хүрээнд төрийн

бодлогын удирдамж нь одоогийн болон ирээдүйн олон нийт, хувь хүн, хувийн бизнесийн байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрийн зан үйлийг тодорхойлдог шийдвэр юм. Тодруулбал, төрийн бодлого нь нийгмийн асуудлыг шийдэхэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг тодорхойлогч нь болно. Төрийн бодлого бол угтаа засгийн газрын үйл ажиллагааны тодорхой зорилго, стратеги төлөвлөлтөд хүрэхэд чиглэсэн арга хэмжээ, үйл ажиллагааны нэгдэл байх бөгөөд төрийн бодлогын салбаруудад хамааралтай асуудлуудыг багтаадаг. Тухайлбал, эрүүл мэнд, боловсрол, тээвэр, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хамгааллын бодлого гэх мэт юм. Аливаа бодлогод төрийн аль ч түвшний байгууллагууд (төв, орон нутгийн) оролцож, асуудлыг боломж, хөгжил болгон хувиргах шийдлүүдийг боловсруулах нь чухал байдаг. Учир нь нийгмийн асуудал болон түүнийг шийдвэрлэх үйл явц нь олон нийтээс, орон нутгийн байгууллага, улмаар төрийн төв байгууллагуудад ч хамааралтай тул түүний оролцогч талууд болоод мэргэшсэн байгууллага шинжээчид нь бодлогын асуудалд нийцэхүйц хувилбаруудыг гаргаж, сонголт хийх, үнэлэх чадамжтай байдаг. Жишээлбэл, орон нутгийн түвшинд сургууль, цэцэрлэг гэх мэт нийгмийн дэд бүтцийн асуудлууд хөндөгдөх боловч улмаар үндэсний хэмжээний асуудал болтлоо өргөжиж болно. Иймд асуудлын цар хүрээ, оролцогч талууд, шийдлийн хувилбарууд боловсруулах зэрэг үйл явцуудад нарийн мэргэжилтнүүдийн үүрэг, оролцоо чухал юм. Үүнээс гадна төрийн бодлогыг боловсруулах үйл


явцаас гадна бодлогын хэрэгсэл хэмээх ойлголтоороо бусад бодлогын мөн чанараас ялгагдаж байдаг. Учир нь төрийн бодлогын хэрэгсэл нь түүний хэрэгжилтийн үйл явцтай холбоотой бөгөөд үндсэн болон дагалдах шинж бүхий хэрэгслүүдээс гадна, нөөц, үр дагавар, нөлөөлөх цар хүрээгээрээ ялгаатай юм. Тухайлбал, төрийн бодлогод түгээмэл ашиглагддаг хэрэгслүүдийг дурдвал:

- Зохицуулалтын хэрэгсэл (хориг, зөвшөөрөл, шийдвэр, дүрэм, журам, тушаал, тогтоол, хууль гэх мэт)
- Төрийн менежмент (үр дүн, хүний нөөц, бүтэц, бүрэлдэхүүний гэх мэт)
- Санхүүгийн хэрэгсэл (татвар, тэтгэлэг, тэтгэмж, халамж, хураамж гэх мэт)
- Зах зээлийн механизмууд (эрэлт, нийлүүлэлт, нөөц, хангалт, төлөвлөлт)
- Мэдээлэл, харилцааны хэрэгсэл (ухуулга, сурталчилгаа, мэдээлэл, уламжлалт болон орчин үеийн мэдээллийн сувгууд бүгд багтана. (Я.Т)

Төрийн бодлого боловсруулах үйл явц

Сүүлийн жилүүдэд төрийн бодлого боловсруулах нь шийдвэр гаргалттай холбогдон судлагдаж, шийдвэрийн онол, арга зүйд тулгуурласан судалгааны хэлэлцүүлгүүд өргөжиж байна. Иймд шийдвэрийн онолын үндсэн зарчим болох олон ургалч байдал, олон талт оролцооны талаарх тайлбар, үндэслэлийг ашигладаг болжээ. Бодлого боловсруулах нь асуудал болон бэрхшээлийг тодорхойлох үе шат, түүний арга зүйд гол анхаарлаа хандуулах боловч үр ашигтай шийдлийг санал болгох, хэрэгжүүлэх, үнэлэх шалгуур

үзүүлэлтүүдийг бий болгох зэрэг цогц үйл ажиллагааг шаарддаг үйл явц юм. Түүнчлэн бодлого боловсруулахад хэрэглэгдэх хамгийн сайн туслагч гэж үздэг хэд хэдэн түлхүүр асуултууд байдаг. Хэнд зориулж, яагаад, ямар үндэслэлээр, юуг, хэзээ, хаана гэх мэт асуултуудыг ашигладаг байна. Иймд бодлого боловсруулах үйл явц нь тодорхой онол, арга зүйд тулгуурлахаас гадна бодлогын орчин, нөхцөл байдал, бодлогын зорилго, зорилтуудын тухай авч үзэх хэрэгтэй юм. Бодлогын асуудлын томьёоллын дараа бодлогын зорилго, дэд зорилтыг тодорхойлох үндсэн зарчим нь судалгааны найдвартай байдлын үндэслэл болдог. Бодлогын зорилго, зорилт нь асуудлыг хэсэгчлэн болон бүрэн шийдвэрлэхэд чиглэсэн Засгийн газраас аливаа бодлогын хүрээнд дэвшүүлсэн оновчтой, хэмжиж болохуйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц зэрэг өөрчлөлтийг хэлнэ. Бодлогын зорилго, зорилт нь тухай бодлогыг хэрэгжүүлэх урт, дунд хугацааны нийгэм эдийн засгийн хөгжилд бий болохоор хүлээгдэж байгаа өөрчлөлтийг хийсэн бодлогын үр нөлөөнд шийдэл болохуйц байх нь чухал юм. Иймд бодлого боловсруулах үе шат бүр тодорхой арга, аргачлалтай, түүнийг хэмжих үзүүлэлтүүдийг шаардаж байдаг. Бодлого боловсруулахад агуулга, зорилгоосоо хамааран янз бүрийн загварууд байдаг ч бодлогын шинжлэх ухааны салбарт нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн дараах загварыг авч үздэг. Энэхүү загварын нийтлэг шинж чанарт тулгуурлан түүнийг бодлогын орчил буюу бодлого боловсруулах тогтсон дараалал, үйл явцын эргэлт гэж нэрлэдэг (Үр нөлөө бүхий бодлогын баримт бичиг боловсруулах нь гарын авлага. 2012). Эдгээр бодлого

Бодлого боловсруулах үе шат

боловсруулах таван үйл явцын бүхий л үе шатуудад асуудал тодорхойлох, асуудлын үндсэн шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлсийг олж илрүүлэх нь шинжилгээний чухал алхам бөгөөд бодлогын хувилбаруудыг гаргах, сонголт хийх, үнэлэхэд суурь нөхцөл нь болдог. Иймд асуудлыг тодорхойлох арга зүйд суралцах нь бодлогын шинжилгээний эхний бөгөөд сүүлийн үе шат хүртэлх оновчтой, зөв сонголтын арга зүйн илэрхийлэл болдог байна. (Я.Т)

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧ (State and local property)

Төрийн болон орон нутгийн засаг захиргааны эзэмшил буй газар болон барилга, тоног төхөөрөмж зэрэг нь төрийн өмч юм. Төрийн өмч нийтийн зориулалттай ашиглах гудамж, цэцэрлэг, явган хүний зам зэрэг “нийтийн” өмч болон хязгаарлагдмал зориулалтаар ашиглагдах армийн бааз, тусгай лаборатори хэмээн ангилна. Төрийн болон орон нутгийн өмчийг ердийн байдлаар болон уралдаант шалгаруулалтаар худалдан авна. Нийтийн зориулалтаар ашиглагдах хөрөнгийг улсын татварын хөрөнгөөр санхүүжүүлдэг бол цахилгаан станц, авто зам зэрэг нь хөрөнгө иргэдээс хураамж, төлбөр

авах хэлбэрээр санхүүжигдэнэ. Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг нэгдсэн бодлогын хүрээнд хуулиар зохицуулах ба нэгдсэн мэдээллээр ханган бүртгэлжүүлж, тайлагнана. Ингэснээр төрийн болон орон нутгийн өмчийг зохистой захиран зарцуулалт, хадгалалт, хамгаалалт, хяналт үнэлгээ хийх боломжтой. (Г.Б)

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА (Non-governmental organization)

Иргэд, төрийн байгууллага /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг төрийн бус байгууллага гэнэ. Төрийн бус байгууллагыг нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага гэж ангилдаг. Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага гэж соёл, урлаг, боловсрол, хүмүүжил, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт, байгаль орчин, орчин ахуйн хөгжил, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг,

давхаргын эрх ашгийг хамгаалах, энэрлийн зэрэг чиглэлээр нийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг; гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага гэж өөрийн гишүүдэд үйлчилдэг, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой, нийгэмд үйлчилдгээс бусад төрийн бус байгууллагыг тус тус ойлгоно (Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйл). (Ч.Э)

ТӨРИЙН БУЮУ ОЛОН ТҮМНИЙ ӨМЧИТ КОРПОРАЦ (*Public corporation*) Төрийн болон орон нутгийн өмчит корпорац нь эрх мэдэл, үүрэг даалгавар үйл ажиллагаа, засаглалын бүтцийг тодорхойлсон тусгай хууль тогтоомжийн дагуу бие даасан нэгж хэлбэрээр байгуулсан хуулийн этгээд юм. Рузвельт: ‘Төрийн өмчит корпорац нь засгийн газрын эрх мэдэлд байх боловч хувийн аж ахуйн нэгжийн уян хатан чадвартай байгууллага’ гэжээ (Upadhyay, 2017). Хербет Моррисон ‘Төрийн өмчит корпорац нь төрийн өмч, төрийн хариуцлага, бизнесийн болон төрийн удирдлагын хослол’ хэмээн тодорхойлсон (Amatori, Millward, & Toninelli, 2011). Төрийн өмчит корпорацууд нь төрийн мэдэлд байдаг боловч санхүүгийн хувьд хараат бус. Төрийн өмчит корпорацууд нь үндэсний өмч болсон үйлдвэр, бизнесийг удирдах зорилгоор байгуулагдана. Засгийн газрын үйлчилгээний олон байгууллагууд корпорац хэлбэрээр зохион байгуулагдсан байдаг. Төрийн өмчит корпорац нь дараах гол онцлог шинжүүдтэй⁵⁶.

Үүсгэн байгуулах: Хууль тогтоох байгууллагаас баталсан тусгай хуулиар зохицуулагдана.

Хууль эрх зүйн байдал: Эрх зүйн бие даасан субьект

Хөрөнгө: Засгийн газраас бүрэн хангадаг

Удирдлага: Төлөөлөн удирдах зөвлөл

Хяналт ба хариуцлага: Парламент

Бие даасан байдал: Засгийн газар өдөр тутмын ажилд хөндлөнгөөс оролцдоггүй. (З.А)

ТӨРИЙН БУЮУ УЛСЫН ӨМЧ (*State property*) Улс хийгээд төрийн чиг үүргийг хэрэгжүүлж иргэдэд үйлчлэх үүрэгтэй аливаа субьектийн мэдэлд байгаа, ашиглах, эзэмших, захиран зарцуулах боломжтой, биет ба биет бус хэлбэртэй, үнэ цэнэ бүхий зүйл бөгөөд ард түмний өмчийн нэг хэлбэр юм. Төр нийгэм, эдийн засагт гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхийн тулд өөрийн буюу нийтийн өмчлөлийн эд хөрөнгө бий болгодог. Өөрөөр хэлбэл, төр хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд ард иргэд, нийгмийн гишүүд хувийн өмчөөсөө тодорхой хэсгийг сайн дурын үндсэн дээр төрийн мэдэлд шилжүүлэх замаар төрийн өмчийг бий болгодог. Төрийн өмч бүрдэж бий болох анхдагч суурь нь нийгмийн гишүүдийн төлөх татвар болдог. Төрийн өмч нь төрийн нийтийн зориулалттай өмч, төрийн өөрийн өмч гэж ангилагдана. Төрийн нийтийн зориулалттай өмчид: иргэдэд өмчлүүлснээс бусад газар; газрын хэвлий, түүний баялаг; ус, түүний баялаг; ой, түүний дагалдах баялаг; ургамал, ан амьтны нөөц; түүх, соёлын үнэт цогцолбор, хөшөө дурсгал; археологийн болон палеонтологийн олдвор; хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар тогтоосон бусад эд хөрөнгө байна. Төрийн өөрийн өмчид: төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө; төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлсэн эд

56 <http://old.nios.ac.in/srsec319new/319EL8.pdf>

хөрөнгө; төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрд ногдох хувь хөрөнгө; улсын төсвийн хөрөнгө болон төрийн бусад тусгай сан; төрийн тусгай хэрэгцээний бэлтгэл нөөц; хуульд заасан бусад төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө багтана. Төрийн өмч Иргэний хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөнд хуваагдана. Төрийн өмчийн харилцааг хуулиар зохицуулах бөгөөд харилцаа нь өмчийн объект, субъект, өмчийг эзэмших хэлбэр гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. (Ч.Э; Б.Б нар)

ТӨРИЙН БУЮУ УЛСЫН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГӨ (*State property*) Төрийн эзэмшилд буй ашиглагдах, захиран зарцуулагдах боломжтой биет эд зүйлс.

- Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт: төрийн эзэмшилд буй ашиглагдах, захиран зарцуулагдах боломжтой биет эд зүйлсийг ашиглаж, үр дүн бий болгох үйл ажиллагаа
- Төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тайлан: төрийн эзэмшилд буй ашиглагдах, захиран зарцуулагдах боломжтой биет эд зүйлсийн жагсаалтыг бүрдүүлэх, боловсруулах, танилцуулахад бэлтгэн эмхтгэсэн байдал
- Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт: төрийн эзэмшилд буй ашиглагдах, захиран зарцуулагдах боломжтой биет эд зүйлсийн мөн чанар, хэлбэр, хэмжээг өөрчлөхгүйгээр хэвийн түвшинд байлгах үйл ажиллагаа
- Төрийн өмчийн эд хөрөнгийн хамгаалалт: төрийн эзэмшилд буй ашиглагдах, захиран зарцуулагдах боломжтой биет эд зүйлсийг гаднын

нөлөөнөөс хамгаалах, эрсдэлтэй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үйл ажиллагаа. (Г.Б)

ТӨРИЙН БУЮУ УЛСЫН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД (*State owned legal entity*)

Төрийн болон орон нутгийн засаг захиргааны эзэмшил газар болон хөрөнгийг удирдан, зохицуулах чиг үүрэгтэй, төсвийн хөрөнгөөр эсвэл өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг, өмчийн ашиглалт, захиран зарцуулалтад төрөөс тодорхой хэмжээгээр хяналт тавьдаг байгууллагыг хэлнэ. Төрийн өмчит хуулийн этгээдийг нийгмийн ажил, үйлчилгээг эрхлэх зорилгоор ихэвчлэн бий болгож болох ба тэдгээр нь хог хаягдлыг зөөвөрлөх, устгах, дахин боловсруулах, авто замын гэрэлтүүлэг, түүний засвар үйлчилгээ, хэвийн ажиллагааг хангах, нийтийн усны шугам сүлжээ, засвар үйлчилгээ, өргөжүүлэлтийг хангах, хариуцах, нийтийн нэгдсэн цэвэрлэх байгууламжийг хариуцах чиглэлд ажиллаж болно. Төрийн өмчит хуулийн этгээд нь ажил үйлчилгээг эрхлэх чиг үүргээс гадна олон төрөлд хуваагддаг бөгөөд төрийн өмчит үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоот газар гэж ангилагддаг. (Г.Б)

ТӨРИЙН БҮТЭЭМЖ (*State productivity*)

Төрийн бүтээмж нь иргэдийн хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхлыг хангах төрийн үйлчилгээнд зарцуулах нөөц ба захиргааны байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийн харьцаагаар илэрхийлэгдэнэ. Төрийн салбарт бүтээмжийг үйлчилгээний үр дүн, үр ашиг, үр нөлөө гэсэн гүйцэтгэлийн үзүүлэлтээр хэмжинэ. Бүтээмжийг бодитойгоор хэмжихэд хүндрэл гарах боловч зарцуулах

нөөцийн зарцуулалтыг ил тод болгох, иргэдэд үзүүлэх үйлчилгээний түвшинг тайлагнаж түүнд нийцүүлэн санхүүжүүлэх, урт ба богино хугацаанд хүрэх үр дүнг тодорхойлж хэмжих зарчмыг нэвтрүүлэх замаар бүтээмжийг дээшлүүлэх зорилтод хүрдэг. Жишээлбэл, боловсролын салбарт зарцуулах цалин хөлс, сургалтын хэрэглэгдэхүүний зарцуулалтыг оновчтой болгон суралцагчийн тоо, сургалтын цаг, мэдлэгийн түвшингийн ахиц зэрэг үзүүлэлтээр гүйцэтгэлийг тайлагнаж бичиг үсгийн боловсрол дээшилсэн байдал, дундаж орлогын өсөлт зэрэг үзүүлэлтээр үр дүнг хэмжиж салбарын нийт бүтээмжийг дээшлүүлэх зорилгыг хэрэгжүүлнэ. (Б.Б)

ТӨРИЙН ГАДААД БОДЛОГО (*State foreign policy*)

Төрөөс явуулах бодлогыг ерөнхийд нь дотоод, гадаад гэж хуваан үздэг. Төрөөс гадаад бодлого явуулах зайлшгүй шаардлага нь хоёр зүйлээр тодорхойлогддог. *Нэгдүгээрт*, аль ч орон бусад улс, хөрш зэргэлдээ улс орнуудтайгаа олон талын харилцаатай байдаг. *Хоёрдугаарт*, ямар ч улс орон төрийн дотоод бодлогоороо нийгмийн хөгжлийн хэрэгцээг бүрэн дүүрэн хангах бололцоо чадавх хомс байдаг. Учир нь нийгмийн дотоод дахь хязгаарлагдмал нөөц баялгийг бусдын нөөцөөр хангах нийлүүлэх зорилгоор гадаад бодлогыг боловсруулдаг. Үүнтэй уялдаатай гадаад улс гүрэнтэй зайлшгүй харилцаж байж дотоод хэрэгцээгээ хангах үйл ажиллагааг шаарддаг байна. Ийм учраас дотоод бодлого нь гадаад бодлогоо тодорхойлох шинжтэй, харин гадаад бодлого нь түүнээс хараат, үүсмэл байдалтай, түүний үргэлжлэл болдог

юм. Нөгөө талаар төрийн бодлогыг дотоод, гадаад гэж эрс зааглах боломжгүй байх тохиолдол ч гардаг. Энэ нь улс төрийн бодлогын зарим асуудал дотоод болон гадаад бодлогын аль алиных нь шинж агуулна гэсэн үг юм. Тухайлбал, батлан хамгаалах асуудал, түүний зардал нь төрийн гадаад аюулгүй байдалтай нягт холбоотой боловч улсын төсөвт хүндрэл учруулж улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хязгаарладаг байна. Төрийн гадаад бодлогын гол зорилго нь тухайн улс орны аюулгүй байдлыг хангах, хамгаалахад оршино. Гадаад бодлогын зорилго нь тодорхой зэрэглэлтэй. Энэ нь нийгэм-улс төрийн байгуулал, төрийн хэлбэр, түүхэн уламжлал, газар зүй-улс төрийн нөхцөл, бусад улстай тогтоосон холбоо гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаална. Төрийн гадаад бодлого нь батлан хамгаалах, төлөөлөх, хэлэлцээр хийх гэсэн үндсэн гурван үүрэгтэй. Гадаад улс төрийн үйл ажиллагаанд дотоод бодлогод байдаг шиг төрийн засаглалд нэгжүүдийг захируулах, дээрээс тушаах, заах явдлыг хэрэглэдэггүй. (Я.Т)

ТӨРИЙН ЁСЛОЛ (*State ceremony*)

Монгол төрд хуралдай хурах, дайн байлдаанд мордох, хаан өргөмжлөх, дөрвөн цагийн баяр, найр хийх, их хааны сургаалыг сонсгох, уул ус тахиx, элчин мордуулах, хүлээн авах зэрэг олон үйл явдлын үеэр нарийн дэгтэй ёслол үйлддэг байжээ. П.Карпини Гүег хааныг хаан ширээнд суух үед Хар Хорумд очсон тухай дурдатгалдаа энэ үед болсон үйл явдал, ёслолын талаар тодорхой өгүүлсэн байна. Юань улсын сударт байгаагаас үзвэл тус улсад янз бүрийн тэмдэглэлт үйл явдлын үеэр нарийн дэг журамтай ёслол үйлддэг

байжээ. “Ёслол хэмээгч тэнгэр газрын дэс болой. Хөгжим хэмээгч тэнгэр газрын найрамдах болой” хэмээн үздэг байжээ. Цагаан сараар их хаанд бараалхах ёслол, түмэн өлзийн баярын ёслол, Хаан сууринд суусны дараа бараалхах ёс, өвгөдийн сүмийг тайх ёслол, навчит өргөмжлөлөөр хуанху байгуулах үеийн ёс, ёслол, хуантайзи байгуулах ёс, ёслол гэх мэт ёсыг нарийн заасан байдаг ба түүнд оролцогчдын үүрэг, мөргөх, ёслох, алхах гэх мэт олон зүйлийг маш нарийн зохицуулдаг байжээ. Ёслолын үеэр хөгжим, бүжиг үүсгэх ба чухам хэзээ ямар аялгуу байхыг мөн тодорхойлон заасан байдаг ажээ. Богд хаант Монгол Улсын үеийн ёслолын журмыг Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичигт хуульчлан заасан байна. Уг хуулиар цагаалах, бат оршил өргөх, хаанд бараа болон явах, төрийн жагсаал хийх, цагаан өмсөх, цам, майдар эргэх гэх мэт тухайн үеийн төрийн тэмдэглэлт үйл явдлын үеэр хийх ёслол, баримтлах ёсыг хуульчлан заасан байдаг. Хуулиар тогтоосноос гадна зан заншлын шинжтэй ёс, ёслол ч бас байжээ. Тухайлбал, цагаан сарын шинийн нэгэнд орон нутгийн ноёд Манжийн үед Бээжин зүг, Богд хаант Монгол Улсын үед Нийслэл хүрээний зүгт мөргөдөг байжээ. Монгол Улсын гал голомт хэмээн үздэг байсан Баруун өргөөний галыг шинийн нэгний өдөр Түшээт хан аймгийн харьяат тайж хүн эхнэрийн хамт бадраадаг заншилтай байжээ. (А.Ц)

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБА (*Real civil service*) Төрийн тусгай болон төрийн захиргааны албыг хамруулна. Төрийн алба нэгдмэл байх, алагчлахгүй эрх тэгш, шударга байх, мерит зарчимд тулгуурласан байх нь аливаа улсын

төрийн албаны зарчим⁵⁷ байдаг. Ер нь “төрийн алба үр ашигтай, итгэлцэлд суурилсан, үнэнч шударга байх зарчимд суурилахыг⁵⁸ ихэнх улс чухалчилдаг байна. Төрийн жинхэнэ албанд ажиллах албан хаагч нийтийн эрх ашгийг дээдлэх, ёс зүйн хэм хэмжээг чандлах сахиж ажиллахаа илэрхийлэн тангараг өргөдөг. Зарим улс оронд энэхүү хэм хэмжээг төрийн албанд ажиллахаа больсны дараа мөн адил мөрдөж ажиллахыг шаардана. (Г.Б)

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛД ТАВИХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА (*Common requirements for governmental real positions*) Төрийн жинхэнэ албан тушаалд тавих нийтлэг шаардлагыг хуулиар тогтооно. Тухайлбал, Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалд дараах нийтлэг шаардлагыг хангасан иргэнийг томилно: а) Монгол Улсын иргэн байх; б) дээд боловсролтой байх (энэ шаардлага төрийн туслах албан тушаалд хамаарахгүй); в) Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх; г) монгол хэлний ярианы болон бичгийн чадвартай байх; д) сэтгэцийн өвчин, эмгэггүй байх; е) хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх.⁵⁹ Үүнээс өөр шаардлагыг хуулиар тогтоож болно. (Ч.Э)

57 Ganesh@ Rajarajan, Jayashankar Singh, “Mahesh Sherkhane; System of civil services in India and it’s comparison with few selected countries”, 2014, p. 3.

58 Shamsul Arefin, “Civil Service in Developed & Developing Countries - A Comparative Study”, 2013, p. 15.

59 Хуулийн тайлбар: энэ шаардлага 2008 оны 6 дугаар сарын 3-ны өдрөөс өмнө 18 нас хүрсэн, түүнчлэн эмнэлгийн магадлагаагаар эрүүл мэндээр тэнцээгүй, хуульд заасан бусад үндэслэлээр цэргийн жинхэнэ албанаас түр буюу бүрмөсөн чөлөөлөгдсөн иргэнд хамаарахгүй.

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ АЛБАН ТУШААЛААС НЬ ТҮР ЧӨЛӨӨЛӨХ, ЧӨЛӨӨЛӨХ

(Relieving of real civil servant from duty [position]) Төрийн жинхэнэ албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдөж буюу түр чөлөөлөгдөж болно. Ийнхүү чөлөөлөгдөх, түр чөлөөлөгдөх журмыг Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлээр тогтоосон. Төрийн албанаас түр чөлөөлөгдөнө гэж төрийн албанд эргэн орох болзолтойгоор түр хугацаагаар чөлөөлөгдөхийг, харин чөлөөлөгдөх гэж ямар нэг болзолгүйгээр, хугацаагүйгээр төрийн албыг орхихыг ойлгоно. Төрийн жинхэнэ албан хаагч төрийн албанаас түр чөлөөлөгдөх дараах дөрвөн үндэслэл байна. Үүнд: 1) хуульд өөрөөр заагаагүй бол биений эрүүл мэндийн байдлын улмаас 3 сараас дээш хугацаагаар албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон; 2) зургаан сараас дээш хугацааны сургалтаар (шинэ дадлага, туршлага эзэмших сургалтыг оролцуулан) бэлтгэгдэх болсон; 3) цэргийн жинхэнэ алба хаах болсон; 4) Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан. Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн иргэн төрийн албан хаагчийн нөөцөд байгаад тооцогдоно. Төрийн жинхэнэ албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдөх дараах дөрвөн үндэслэл байдаг. Үүнд: 1) Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын, түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвших болсон; 2) тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн; 3) төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн; 4) өөрийн санаачилгаар төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт

гаргасан; хуульд заасан бусад үндэслэл. Төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь түр чөлөөлөх ба чөлөөлөх шийдвэрийг хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн шууд захирагч гаргана. Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн төрийн жинхэнэ албан хаагч төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд ажиллах хүсэлт гаргах боломжтой. Хүсэлт гаргасан тохиолдолд тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан уг албан хаагчийг төрийн албанаас чөлөөлөх, эсхүл түүний үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн ажиллуулах шийдвэрийн аль нэгийг гаргаж болно. (Ч.Э)

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ АЛБАН ТУШААЛААС НЬ ХАЛАХ *(Dismissal from the governmental position of a real civil servant)*

Төрийн жинхэнэ албан хаагчийг дараах үндэслэлээр төрийн албанаас хална:

- хуульд өөрөөр заагаагүй бол удаа дараа /3 ба түүнээс дээш/ албан үүргээ хангалтгүй биелүүлсэн;
- гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;
- Монгол Улсын харьяатаас гарсан;
- Энэ хуульд заасан бусад үндэслэл.

Төрийн жинхэнэ албан хаагчийг халах шийдвэрийг хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн шууд захирагч гаргана (Төрийн албаны тухай хуулийн 47 дугаар зүйл). (Ч.Э)

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ЗАХИРГААНЫ САНААЧИЛГААР АЛБАН ТУШААЛ БУУРУУЛАХ (*Reducing the position of a real civil servant by the administration*)

Албан тушаал бууруулах гэж тодорхой үндэслэлээр захиргааны санаачилгаар төрийн жинхэнэ албан хаагчийн албан тушаалыг доошлуулахыг хэлнэ. Төрийн жинхэнэ албан хаагчийн албан тушаалыг захиргааны санаачилгаар бууруулах үндэслэл нь: а) хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлсэн; б) үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин нь тухайн албан тушаал эрхлэх шаардлага хангахгүй болсон; в) хуульд заасан бусад үндэслэл байна (Төрийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйл). (Ч.Э)

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ӨӨР АЛБАН ТУШААЛД ШИЛЖҮҮЛЭХ (*Transferring a real civil servant to another position*)

Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх журмыг хуулиар тогтоодог. Тухайн байгууллагад шаардлагатай байгаа мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага бүхий хүний нөөцийг бүрдүүлэх, онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлэх, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах зэрэг албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцож, эсхүл тухайн байгууллагад 10 ба түүнээс дээш жил нэг албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийг удирдлагын санаачилгаар төрийн албаны нэг байгууллагаас нөгөө байгууллагад тэдгээрийн удирдлагын хооронд харилцан тохиролцсоны

дагуу эрхэлж байгаа албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хөлс, зэрэг дэвийг бууруулахгүйгээр шилжүүлэн ажиллуулахыг зөвшөөрдөг. Түүнчлэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалах арга хэмжээнд хамрагдсан албан хаагчийг түүнтэй тохиролцож төрийн нэг байгууллагаас нөгөө байгууллагад өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулж болно (Төрийн албаны тухай хуулийн 44.1, 44.3, 44.6). (Ч.Э)

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ (*Rotating a real civil servant [between positions]*)

Төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулах журмыг хуулиар тогтоодог. Төрийн жинхэнэ албан хаагчийг өөрийнх нь зөвшөөрснөөр төрийн байгууллага буюу тухайн байгууллагын нэгж хооронд тэдгээрийн удирдлагын харилцан тохиролцсоны дагуу ажлын тодорхой чиглэлээр 2 жил хүртэл хугацаагаар эрхэлж байгаа албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хөлс, зэрэг дэвийг бууруулахгүйгээр сэлгэн ажиллуулж болно. Төрийн албан хаагчийн буюу түүнийг сэлгэн ажиллуулж байгаа байгууллагын хүсэлтээр анх илгээсэн төрийн байгууллага энэ хугацааг 1 жил хүртэл сунгана. Сэлгэн ажиллуулах хугацаа дуусмагц төрийн жинхэнэ албан хаагчийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь шууд үргэлжлүүлэн ажиллуулна (Төрийн албаны тухай хуулийн 44.2, 44.3, 44.4). (Ч.Э)

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭХ ҮНДЭСЛЭЛ (*Temporary substitution of the position of a real civil servant*)

Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэнэ гэж албан тушаал

нь хэвээр хадгалагдаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчийг ажилдаа эргэж орох хүртэл түүний үүргийг өөр төрийн жинхэнэ албан тушаалтан түр орлон гүйцэтгэхийг хэлнэ. Дараах тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно: 1) ээлжийн амралттай; 2) эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар чөлөөтэй; 3) дотоод, гадаад албан томилолттой; 4) зургаан сар хүртэл хугацаагаар мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан, 2 жил хүртэл хугацаагаар өндөр хөгжилтэй оронд магистр, докторын сургалтад хамрагдсан; 5) удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрээр өөр ажил үүрэг гүйцэтгэж байгаа; 6) жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй; 7) албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсантай холбоотой асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гараагүй; 8) албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсан; 9) албан хаагч өөр албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон; 10) албан хаагч нас барсан. Түр орлон гүйцэтгэгч нь тухайн албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг хэрэгжүүлнэ. Шийдвэрт түр орлон гүйцэтгэх хугацаа болон шаардлагатай бол зарим бүрэн эрхийг хязгаарлах талаар тусгана. (Ч.Э)

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (*Performance plan of a real civil servant*) Нэг жилийн хугацаанд тухайн албан хаагчаас хүлээж буй үр дүн (гүйцэтгэлийн стандарт⁶⁰),

60 Зорилго, зорилтоор тодорхойлогдсон үр дүн.

түүнчлэн байгууллагын гүйцэтгэлийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд албан хаагчийн оруулах хувь нэмэр юу болохыг тусган харуулсан баримт бичиг. Монгол Улсын төрийн албанд 2002 оноос гарцад суурилсан гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэж төрийн албан хаагчид 2003 оноос үр дүнгийн гэрээ байгуулан ажиллах болсон бөгөөд уг гэрээндээ нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө (гүйцэтгэлийн төлөвлөгөө)-гөө тусган хэрэгжүүлж ирсэн. 2017 онд Монгол Улсын төрийн албаны тухай хууль шинэчлэгдсэнээр 2019 оноос төрийн жинхэнэ албан хаагчид үр дүнгийн гэрээ байгуулахаа больж гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэг жилийн хугацаагаар боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх болов⁶¹. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд гүйцэтгэлийн зорилт, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилт, арга хэмжээний биелэлтийг хэмжих шалгуур үзүүлэлт, түүний хүрэх түвшинг тусгана. (М.А)

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРЭГ (*Common obligations of a real civil servant*)

Төрийн албан хаагч төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүрэг хүлээдэг. Төрийн албан хаагчийн хүлээх үүргийг хуулиар тогтоодог бөгөөд нийтлэг ба тусгай үүрэг гэж ангилдаг. Төрийн жинхэнэ албан хаагчийн хүлээх нийтлэг үүргийг Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлээр тогтоосон. Үүнд: 1) Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх; 2) өргөсөн тангарагтаа үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус,

61 Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйл.

шударга бус явдалтай эвлэрэхгүй байх; 3) эх орон, ард түмнийхээ тусын тулд иргэний ёсоор үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллах, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх; 4) улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам, эвсэл, хөдөлгөөний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байх; 5) хэрэв улс төрийн намын гишүүн бол намын гишүүнээс түдгэлзэж, тухайн төрийн албан тушаалд томилогдсон өдрөөс хойш долоо хоногийн дотор байгууллагын захиргаа болон харьяалах намдаа бичгээр албан ёсоор мэдэгдэх; 6) харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх; 7) төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх; 8) өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх; 9) албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалыг эрхлэхээ зогсоосноос хойших хугацаанд төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх; 10) албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх; 11) холбогдох хуульд заасан журмын дагуу ашиг сонирхлын болон

хөрөнгө орлогын мэдүүлгийг зохих байгууллагад мэдүүлэх; 12) төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх; 13) албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах; 14) удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагаврыг урьдчилан анхааруулж байх; 15) харьяа дээд шатны албан тушаалтныг төрийн бодлого боловсруулах, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөгөөр хангах; 16) Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах; 17) үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх; 18) хууль тогтоомжид заасан бусад үүрэг. (Ч.Э)

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ЭРХ (*Common rights of a real civil servant*)

Төрийн албан хаагч төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүрэг хүлээдэг. Төрийн албан хаагчийн эдлэх эрхийг хуулиар тогтоодог. Төрийн жинхэнэ албан хаагчийн эдлэх нийтлэг эрхийг Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлээр тогтоосон. Үүнд: 1) албан тушаалд тавигдах шаардлага болон ажиллах нөхцөл, албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг тогтоосон албан тушаалын тодорхойлолттой тухайн албан тушаалд томилогдмогц албан ёсоор танилцах, түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг шаардах; 2) энэ хуульд

заасны дагуу үйл ажиллагааны үр дүнг үнэлэхийг харьяалах дээд шатны удирдах ажилтнаас шаардах, үнэлгээг зөвшөөрөх, эс зөвшөөрөх; 3) цалин хөлсөө нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэглэл дэвших, ажиллах нөхцөл, баталгаагаа сайжруулахтай холбогдсон саналыг дээд шатны албан хаагчид бичгээр тавих; 4) хувийн хэрэг, ажил байдлын тодорхойлолт, холбогдох баримт бичигтэй танилцах, шаардлагатай гэж үзвэл хувийн хэрэгтэй нэмэлт тайлбар хийх; 5) өөрийн хууль ёсны ашиг сонирхлыг шүүх болон холбогдох бусад байгууллагаар хамгаалуулах; 6) багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх; 7) хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх, аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллагааг өөрийн итгэмжлэгдсэн хүнээр хөтлүүлэх зэргээр орлого олох; 8) төрийн албанаас чөлөөлөгдөх; 9) мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор сургалтад хамрагдах; 10) хууль тогтоомжид заасан бусад эрх. (Ч.Э)

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НЭМЭГДЭЛ БАТАЛГАА

(Additional guarantees of real civil servant) Төрийн албан хаагчийг албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх бодит нөхцөл бололцоогоор хангах үүргийг төр хүлээдэг. Үүнийг төрийн албан хаагчийн баталгаа гэдэг. Төрөөс хуулиар тогтоосон төрийн албан хаагчийн баталгааг нийтлэг баталгаа болон нэмэгдэл баталгаа гэж ангилна. Нийтлэг баталгаа нь төрийн нийт албан хаагчдад хамааралтай бол нэмэгдэл баталгаа нь дээрх баталгаанаас гадна тухайн төрийн албанаас хамааралтайгаар тодорхой албан хаагчдад тусгайлан олгогдож байгаа

нэмэгдэл нөхцөл бололцоог ойлгоно. Төрийн жинхэнэ албан хаагч нь төрийн албан хаагчийн нийтлэг баталгаанаас гадна дараах баталгаагаар хангагдана: 1) хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөхгүй, халагдахгүй байх; 2) Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг даргын бүрэн эрх дуусгавар болох, мөн энэ хуульд заасан улс төрийн албан тушаалтан уг албан тушаалаас өөрчлөгдөх, төрийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч болон шууд захирагч өөрчлөгдөх нь төрийн албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй байх; 3) төрийн байгууллага өөрчлөн байгуулагдсан (нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх), эсхүл зохион байгуулалтын бүтэц нь өөрчлөгдсөн боловч төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол түүнийг уг албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах, хэрэв тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал (ажлын байр)-ын орон тоо цөөрсөн бол уг албан тушаалыг эрхэлж байсан албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, мэдлэг, ур чадвар, ажлын дадлага, туршлага зэргийг нь харгалзан тухайн албан тушаалд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа албан хаагчийг томилох эрх бүхий албан тушаалтан шалгаруулж авах; 4) төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд цалин хөлсөө бууруулахгүйгээр

мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжих буюу төрийн хөрөнгөөр 6 сар хүртэл хугацаагаар дахин мэргэшиж болох бөгөөд энэ хугацаанд урьд нь эрхэлж байсан албан тушаалынхаа цалин хөлсийг авч, хууль тогтоомжид заасан журмын дагуу ажлын байраар хангуулах, эсхүл 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлгийг тухайн байгууллагаас олгох. (Ч.Э)

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ (*Training for real civil servant*)

Төрийн албаны зорилгыг хэрэгжүүлэхэд чиглүүлж албан хаагчдын мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх үйл явц. Төрийн албанд анх томилогдсон цагаасаа эхлэн албан хаагчид тодорхой системтэйгээр шаталсан сургалтуудад хамрагдаж байх шаардлагатайг Монгол Улсын төрийн албаны тухай хуульд тусгажээ. Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагчийн сургалтыг албан тушаалын ангилал, ажлын онцлог, чиг үүрэгтэй нь уялдуулж, сургалтын бодлого тогтолцоог шатлан дэвших зарчимтай нь нийцүүлэн нэгдсэн бодлого, төвлөрсөн тогтолцоогоор хэрэгжүүлнэ⁶². Хуульд заасны дагуу 1) төрийн албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалт, 2) төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалт, 3) төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт, 4) төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт, 5) мэргэшүүлэх багц сургалтыг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага (Удирдлагын Академи) зохион байгуулна. (М.А)

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРАГ (*Oath of real civil servant*)

Тангараг нь “үнэн шударга, бат нотыг амласан андгайлал үг, бичиг”⁶³ юм. Төрийн жинхэнэ албан хаагч “эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, Монгол Улсын хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан албан үүргээ үнэнч шударгаар биелүүлнэ”⁶⁴ гэдгээ андгайлж тангараг өргөдөг. Төрийн албан хаагч тангаргийг цээжээр дуудахын зэрэгцээ Монгол Улсын төрийн захиргааны албан хаагчийн тангаргийн бүрэн бичвэр бүхий “тангаргийн бичиг”-г гарын үсэг зурж баталгаажуулна⁶⁵. Төрийн захиргааны албан хаагч төрийн захиргаанаас бусад төрийн албан тушаалд шилжин ажилласны дараа төрийн захиргааны албан тушаалд эргэж томилогдвол тангараг дахин өргөхгүй⁶⁶. (М.А)

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ШАЛГАЛТ (*Real civil servants' examination*)

Төрийн үйлчилгээний болон төрийн улс төрийн албанаас бусад төрийн алба буюу хуулиар олгогдсон тусгай чиг үүрэг бүхий төрийн захиргааны, төрийн тусгай албанд ороход шаардагдах мэргэжлийн мэдлэг, ур чадварын сорилтыг шалгах аман, бичгийн, бусад хэлбэрийн шалгалтыг хэлнэ. Төрийн жинхэнэ албан хаагчийн шалгалт нь тухайн улс орны “төрийн жинхэнэ алба” гэж үзэж буй төрийн албаны ангилалд хамаарагдах албанд орох хүсэлтэй, түүнийгээ илэрхийлж, төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөх зорилготой нээлттэй сонгон шалгаруулалтад

63 Монгол хэлний их тайлбар толь, <https://mongol.toli.mn/dictionary/detail/84358>, үзсэн 2020.11.27.

64 Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйл.

65 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлиг.

66 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлиг.

62 Цэдэв Д., Байгал Д., “Төрийн албаны сургалтын бодлого, тогтолцоо, хандлага”, Төрийн удирдлага сэтгүүд, 2019 III №08, 4 дэх тал.

оролцох бүртгүүлсэн, тухайн албан тушаалтын тодорхойлолтод заасан мэргэжлийн, мэргэшлийн, туршлага, ур чадварын шаардлагыг хангасан нэр дэвшигчээс бүрдүүлэх материалд дурдагдсан мэдээллийг баталгаажуулах, эсвэл бусад ур чадвар, хандлагыг тодорхойлох зорилготой нэмэлт сорилтыг агуулж буй шилж сонгох үйл явц юм. (Г.Б)

ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ БУСАД БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ *(Transferring some state functions to other organizations)*

Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлэх бөгөөд төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж, тэр тухайдаа улсын төсвөөс санхүүжиж байгаа байгууллага нь Засгийн газрын шийдвэрийг биелүүлж, уг ажлаа Монгол Улсын зохих сайдын өмнө хариуцна (Засгийн газрын тухай хуулийн 19.1, 19.2). Төвлөрлийг сааруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийсний үндсэн дээр зарим чиг үүргийг засаг захиргааны түвшин буюу тодорхой салбар хооронд, эсхүл төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэхэд мөрдөгдөх “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ыг

Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан байна. (Ч.Э)

ТӨРИЙН ЗАХИРГАА (*Public administration*) “Public” гэдэг нь латинаар “Publicus” буюу “хоёроос дээш хүн, бүлэг хүмүүс, төр засагтай холбоотой үйл ажиллагаа” гэсэн утга санаа илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, “Public” гэсэн үгээр бүгд, нэгдмэл цул, ард түмэн, тодорхой улс оронд оршин суугаа ард түмэн, засаг төртэй холбоотой гэсэн төсөөтэй болон салаа утга санааг илэрхийлжээ.⁶⁷ Оксфордын англи хэлний толь бичигт *administere* (*administration*) гэсэн үгээр хүмүүсийг харж хандах, тодорхой асуудлыг шийдвэрлэх, засаг захиргааны алба гэсэн утга илэрхийлжээ. Захиргаа нь хэн нэгэнд үйлчлэх, зарцлагдах гэсэн утга бүхий “ad-minisrare” гэх латин үгнээс гаралтай. *Minisrare* гэх үг нь *ministris* буюу зарц гэх үгийн бүтээвэр. Минус гэх язгуур тээж байгаа нь захиргаа ямагт захирагдмал шинжтэй, түүний дээр төрийн эрх баригчид байдаг гэдгийг илтгэнэ. Гэхдээ захиргаа хэмээх ойлголт нь үйлчлэх гэсэн утгыг өөртөө илүү агуулдаг. Өнөө цагт захиргаа гэдгийг төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнийг эрхлэх байгууллага гэж ойлгодог. Доктор, профессор Я.Долгоржав төрийг, улс төрхт төлөв байдал (*statehood*) хэмээх ойлголтыг бүрдүүлэгч болохынх нь хувьд нутаг дэвсгэр, бүрэн эрх мэдэл, ард түмэн гэх ойлголтуудтай хамтад нь авч үзэн, ард түмэн улс төрийн болоод засаглалын эрх мэдлээ хэрэгжүүлэх зохион байгуулалт гэж ойлгоно” хэмээн бичсэн байдаг. Энэ ч утгаараа ард түмэн өөрөө төр мөн бөгөөд эрх мэдэл хэрэгжүүлэх зохион байгуулалт нь төрийн институтүүд

⁶⁷ С.Зульфикар, Төрийн захиргааны хөгжлийн зарим асуудал, Төрийн удирдлага, онол арга зүйн сэтгүүл, 2019.

юм. Энэ бүгдээс үзвэл “Public Administration” нь манай хэлнээ ард түмнээс үүдэлтэй төрийн захиргаа гэж ойлгогдог. Төрийн захиргаа гэдэг нь ард иргэдтэй хамаатай аливаа хэргийг эрхлэх засаг төрийн үйл ажиллагаа юм. Төрийн захиргааны байгууллагууд үйл ажиллагааны тасралтгүй, залгамж шинж чанараа хадгалж, талуудад алагчлалгүй тэгш хандаж, үйлчлэх үүрэгтэй. Судлаачдын олонх нь төрийн захиргаа бол захиргааны шинжлэх ухааны салбар судлагдахуун гэдэгтэй санал нэгддэг. (Т.Т)

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБА (Public administrative service) Төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг захиргааны удирдлагаар хангах, зохион байгуулах чиг үүргийг бүхий төрийн алба. Төрийн байгууллага стратегийн зорилго, эрхэм зорилго, зорилтууддаа хүрэхэд болон үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг хангаж ажиллахад мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангана. Төрийн захиргааны албанд тодорхой шаардлага хангасан албан хаагчийг сонгон шалгаруулж ажиллуулна.

-Төрийн захиргааны албан тушаал / Public Administration positions/: Төрийн бодлого боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий албан тушаал юм. Захиргааны албан тушаал нь албан тушаалын ангиллаар болон зэрэг дэвээр хуваагдана. Захиргааны албан тушаалыг удирдах, гүйцэтгэх, туслах түвшний албан тушаалд ангилна. Дараагийн түвшний албан тушаалд дэвшин ажиллахын тулд өмнөх албан тушаалд ажилласан байх хамгийн бага хугацааны шалгуурыг хангасан байхыг шаардана. (Г.Б)

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛ (Public administrative position) Төрийн албан тушаалыг төрийн улс төрийн албан тушаал, төрийн захиргааны албан тушаал, төрийн тусгай албан тушаал, төрийн үйлчилгээний албан тушаал хэмээн ангилна. Төрийн захиргааны албан тушаалд төрийн бодлого боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий албан тушаал хамаарна⁶⁸. (М.А)

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛД ТАВИХ ТУСГАЙ ШААРДЛАГА (Special requirements of state administrative position) Тодорхой төрийн албан тушаалын онцлогийг харгалзан төрийн албан тушаалд тавих нийтлэг шаардлагаас гадна нэмэлт өндөржүүлсэн шаардлага тавихыг тусгай шаардлага гэнэ.

Төрийн захиргааны албан тушаалд дараах тусгай шаардлагыг хангасан иргэнийг томилно:

Тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 16-аас доошгүй жил, үүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 8-аас доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх;

Эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх;

68 Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл.

Ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх (Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэг).

Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмыг төрийн албаны төв байгууллага батална (Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсэг). (Ч.Э)

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ТЭДГЭЭРИЙН ЗЭРЭГ ДЭВ (*Classification of the public administrative positions and their ranking*)⁶⁹ Төрийн албан тушаалын ангиллын зорилго нь төрийн байгууллагын зорилт, чиг үүргийг тухайн албанаас хэрэгжүүлэхэд шаардлагатай албан тушаалын хүрээ, зааг, зэрэг зиндаа, орон тоо, түүнд тавигдах шаардлагыг ялгавартайгаар тогтоон мөрдүүлэхэд оршино.⁷⁰ Төрийн захиргааны албан тушаалыг дотор нь тэргүүн түшмэл; эрхэлсэн түшмэл; ахлах түшмэл; дэс түшмэл; туслах түшмэлийн албан тушаал гэж ангилна.⁷¹ Тэргүүн түшмэлийн албан тушаалд яамны Төрийн нарийн бичгийн дарга, түүнтэй адилтгах бусад албан тушаал, эрхэлсэн түшмэлийн албан тушаалд яамны газрын дарга, хэлтсийн дарга, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал, ахлах түшмэлийн албан тушаалд яамны тасгийн дарга,

ахлах шинжээч, шинжээч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал, дэс түшмэлийн албан тушаалд яамны ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, ахлах зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал, туслах түшмэлийн албан тушаалд яамны зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал тус тус хамаарна. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокурорын газар, Түний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэлийг Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал, яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тус тус тогтооно.

Төрийн захиргааны албан тушаалын ангилал (тэргүүн, эрхэлсэн, ахлах, дэс, туслах түшмэл) тус бүр дотроо тэргүүн, дэд, гутгаар, дөтгөөр гэсэн зэрэг дэвтэй байна⁷². Зэрэг дэв нь төрийн захиргааны албан хаагчийн төрийн албанд болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан жил, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээс хамааруулан олгодог хэргэм юм. Тэргүүн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхийлөгч, эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхий сайд, ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан

69 Ж.Долгорсүрэн, Г.Буянхшиг: Монгол Улсын захиргааны эрх зүй, Улаанбаатар, 2008, х. 155-156.

70 Ж.Долгорсүрэн, Г.Буянхшиг: Монгол Улсын захиргааны эрх зүй, Улаанбаатар, 2008, х. 155-156.

71 Төрийн албаны тухай хуулийн 18.1 дэх хэсэг.

72 Төрийн албаны тухай хуулийн 21.1 дэх хэсэг.

тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан тус тус олгоно.⁷³ Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүдсэнээр Улсын Их Хурал тогтоодог. Төрийн албаны зарим онцлог салбарын албан тушаалын зэрэг дэвийг Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн хуулиар тогтоож болно.⁷⁴ Албан хаагчид эрхэлж буй албан тушаал болон зэрэг дэвээс нь хамааруулан цалингийн 10-48 хувьтай⁷⁵ тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлсийг олгодог. (М.А; Ч.Э нар)

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛ (*Executive position in public administration*) Төрийн албан тушаал нь удирдах, гүйцэтгэх, туслах гэсэн төрөлтэй⁷⁶. Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээнд тодорхой асуудлаар бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах үүрэг хүлээж, ажлын гүйцэтгэл, үр дүнг эрхэлсэн түшмэлийн өмнө хариуцдаг албан тушаал нь төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаал байна⁷⁷. Энд дэс түшмэлийн албан тушаалын ихэнх нь, мөн ахлах түшмэл болон туслах түшмэлийн зарим албан тушаал хамаарна⁷⁸. (М.А)

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТУСЛАХ АЛБАН ТУШААЛ (*Support position in public administration*) Төрийн албан тушаал нь удирдах, гүйцэтгэх,

туслах гэсэн төрөлтэй⁷⁹. Бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэхүйц мэдээллийг сурвалжлан судалж, задлан шинжилгээ хийж, гүйцэтгэсэн ажлын чанарын талаар хариуцлага хүлээж нийтлэг үйлчилгээний ажилтнуудын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй албан тушаал нь төрийн захиргааны туслах албан тушаал юм⁸⁰. Энд туслах түшмэлийн албан тушаал хамаарна. Жишээлбэл баг, хороо, сумын нийгмийн ажилтан энд багтана. (М.А)

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДАХ АЛБАН ТУШААЛ (*Managerial position in public administration*) Төрийн албан тушаал нь удирдах, гүйцэтгэх, туслах гэсэн төрөлтэй⁸¹. Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагыг болон тухайн байгууллагын бүтцийн нэгжийг удирддаг, түүнчлэн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд мэргэжил, мэргэшлийн талаар тэргүүлэх үүрэг хүлээн ажилладаг албан тушаал нь төрийн захиргааны удирдах албан тушаалд хамаарна. Энд тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн албан тушаал, ахлах түшмэлийн албан тушаалын ихэнх нь, мөн дэс түшмэлийн зарим албан тушаал хамаарна⁸². (М.А)

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ШИНЭТГЭЛ (*Public administration reform*) Төрийн захиргааны шинэтгэл нь өргөн хүрээтэй үйл явц бөгөөд зохион байгуулалтын бүтэц, төвлөрлийг сааруулах, хүний нөөцийн менежмент, төрийн санхүү, үр дүнд-чиглэсэн удирдлага, зохицуулалтын шинэчлэл,

73 Төрийн албаны тухай хуулийн 21.2 дахь хэсэг.

74 Төрийн албаны тухай хуулийн 21.4, 21.5 дахь хэсэг

75 Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоол.

76 Төрийн албаны тухай хуулийн 10.2 дахь хэсэг.

77 Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолын хавсралт.

78 Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолын хавсралт.

79 Төрийн албаны тухай хуулийн 10.2 дахь хэсэг.

80 Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолын хавсралт.

81 Төрийн албаны тухай хуулийн 10.2 дахь хэсэг.

82 Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолын хавсралт.

төрийн албаны дүрмийг шинэчлэх гэх мэт маш олон асуудлуудыг агуулдаг. Төрийн захиргааны шинэчлэл нь ерөнхийдөө хүнд сурталгүй төрийн албыг хөгжүүлэх, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, төрийн удирдлагыг бэхжүүлэхэд чиглэгддэг. (З.А)

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР (*Public Administration, Management Department*) Төрийн захиргаа, удирдлагын газар нь байгууллагын удирдлагын манлайллыг хангах, эрх зүйт орчинг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, санхүү, эдийн засгийн төлөвлөлтийн үр дүнг дээшлүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх үндсэн үүргийн сацуу энэ хүрээнд төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, салбарын ажиллах хүч, мэргэжилтний хэрэгцээг тодорхойлох, судалгаа хийх, мэдээллийн сан байгуулах; салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэх; хуулийн үзэл баримтлал, төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч тайлагнах; төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэрээр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах, тайлан, баланс гаргах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Тухайн байгууллагын нэгжийн зарим чиг үүргийн хүрээнд гадаад хамтын ажиллагааны, хуулийн болон санхүүгийн нэгж ажиллана. Мөн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий бүтцээр төрийн захиргааны байгууллагын

тасралтгүй, хэвийн, жигд ажиллагааг хангахад оршино. Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь удирдлага, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна. (А.Эц)

ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН САН (*Government database*) Төрийн байгууллага чиг үүргийнхээ хүрээний болон чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллүүдийг нэгтгэн ангилал, арга зүй, стандартын хувьд ижилтгэн хадгалсан өгөгдлүүдийн бүрдэл. Төрийн байгууллага болгон чиг үүргээ үр ашигтай гүйцэтгэхийн тулд тэр талаар шаардлагатай мэдээллүүдийг үүсгэх, цуглуулах, түгээх үйл ажиллагаа явуулж байдаг бөгөөд энэ бүгдийг мэдээллийн сандаа төвлөрүүлэн ашигладаг. (Д.3; Ч.Л нар)

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ "ХУР" СИСТЕМ (*"KHUR" Governmental information exchange system*) Төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийг төрийн мэдээлэл солилцооны системд холбох, төрийн үйлчилгээний нэгдсэн портал болон төрийн үйлчилгээний платформуор дамжин хүрэх үйлчилгээ. Мэдээллийг хоёр төрийн байгууллага хооронд шууд солилцдог, мэдээллийн санг хуулбарлаж, шинэчлэх байдлаар үйлчилгээ үзүүлж буй төрийн байгууллагуудын үйлчилгээний уламжлалт шийдлийг бүрэн халж, мэдээллийг илүү уян хатан шийдэлтэйгээр шуурхай, аюулгүй, найдвартай харилцан солилцуулах боломжийг бүрдүүлсэн Монгол Улсын бие даасан төрийн мэдээлэл солилцооны систем юм. Тус системд

хувийн байгууллагууд ч холбогдох боломжтой бөгөөд энэ нь иргэд төрийн байгууллага болон бусад үйлчилгээний байгууллагуудаас үйлчилгээ авахад шаардлагатай лавлагаа, тодорхойлолтуудыг бүрдүүлэхэд учирдаг хүндрэлүүдийг бүрэн арилгахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Хувийн байгууллагуудаас "ХУР" системийг банк болон үүрэн холбооны оператор компаниуд түрүүлж нэвтрүүлсэн. (Д.З; Ч.Л нар)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА **(State secretary)**

Монгол Улсын яам Төрийн нарийн бичгийн даргатай байна. Төрийн нарийн бичгийн дарга нь яамны аппаратын ажлыг мэргэшлийн үндсэн дээр зохион байгуулан удирдаж, сайд үйл ажиллагаагаа шуурхай явуулахад шууд туслах үндсэн чиг үүрэгтэй. Төрийн нарийн бичгийн дарга үйл ажиллагаандаа хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, тэдгээрт нийцсэн сайдын тушаал, үүрэг даалгаврыг удирдлага болгож, яамны аппаратын ажлын үр дүнг сайдын өмнө хариуцах бөгөөд бүрэн эрхээ хэрэгжүүлэх асуудлаар хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрт нийцүүлэн яамны хэмжээнд мөрдөх тушаал гаргаж, биелэлтийг хангуулна (Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9.4). Яамны төрийн нарийн бичгийн даргыг Төрийн албаны тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлд заасан журмын дагуу сонгон шалгаруулж, Засгийн газар 6 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө. Яамны төрийн нарийн бичгийн даргыг улируулан томилж болно. Хуулиар яамыг татан буулгасан нь яамны төрийн нарийн бичгийн даргыг үүрэгт ажлаас чөлөөлөх үндэслэл болно. Яамны

төрийн нарийн бичгийн даргын бүрэн эрхийн хугацаа хуулиар тогтоосон хугацаанаас өмнө дуусгавар болсон бол дараагийн томилогдсон этгээдийн бүрэн эрхийн хугацаа өмнөх төрийн нарийн бичгийн даргын бүрэн эрхийн хугацааны үлдсэн хугацаатай адил байна (Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7, 18.8). (Ч.Э)

ТӨРИЙН НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ **ӨМЧ (State public property)**

Аливаа улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч байна. Төрийн нийтийн өмчийг захиран зарцуулах эрхийг хууль тогтоох субъект эдэлнэ. Төрийн нийтийн өмч нь иргэдийн амьдралын чанарыг нэмэгдүүлэх ба төрийн нийтийн зориулалтын өмчийг удирдахад иргэд ёс суртахуунтай, хэмнэлттэй байх зарчмыг баримтлах ёстой. (Г.Б)

ТӨРИЙН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ **(Open government data)**

Төрийн байгууллага болон төрийн өмчит үйлдвэрийн газрын үйлдвэрлэж эсвэл захиалж үүсгэж нээлттэй лицензээр нийтэлсэн өгөгдөл. Төрийн нээлттэй өгөгдлийг хөгжүүлснээр төрийн ил тод байдлыг сайжруулж, төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, үр ашигтай болгон засаглалыг сайжруулах, нийгмийн өөрчлөлт болон оновчтой шийдвэр гаргахад иргэд, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд өгөгдөлд түшиглэсэн үнэлгээ, өгөгдөлд түшиглэсэн түншлэлийг ашиглах, инновацыг дэмжих, эдийн засгийн өсөлтийг хангах шинэ боломжуудыг үүсгэх ач холбогдолтой. Төрийн

нээлттэй өгөгдлийн санаачилгаар төрийн өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, судалж, шинжлэн баялаг бүтээх боломж иргэд, бизнесийн байгууллагууд, төрийн бус байгууллагуудад нээгдэн төр болон иргэд, байгууллага хоорондын харилцан ашигтай хамтын ажиллагаа үүсэж, өргөждөг. Ухаалаг засаг төслийн хүрээнд хөгжүүлсэн төрийн нээлттэй өгөгдлийн үндэсний портал нь <http://www.opendata.gov.mn/> юм. (Д.З; Ч.Л нар)

ТӨРИЙН ОРОЛЦОО (*Government intervention*) Нийгэм, эдийн засгийн суудлаар хувь хүн, бүлэг, байгууллагаас гаргасан шийдвэрийг өөрчлөхийг зорьж буй засгийн газрын хэрэгжүүлж буй зохицуулалтын арга хэмжээ юм. II. Чөлөөт зах зээлийн тэнцвэр/ үр дүнг өөрчлөх зорилгоор засгийн газраас зах зээлд нөлөөлөх аливаа үйл ажиллагааг хэлнэ. Төрийн оролцооны дараах хэлбэрүүд байж болно. Үүнд: Бараа үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлэх, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд татаас олгох, зах зээлд хэрэгцээтэй бараа үйлчилгээг үйлдвэрлэх, болон хувийн салбарын үйл ажиллагааг зохицуулах, шаардлагатай үед хориглох багтана. (Г.Б)

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ (*Policy and regulation on state property*) Төрийн өмчийн аль ч хэлбэрээс үл хамааран, өмчийн талаар засгийн газрын баримтлах үндсэн чиглэл, үйл ажиллагааны үр дүн, хууль тогтоомж, дүрэм журмын хяналт, зохион байгуулалт. Өмчийн ашиглалтын хугацааны туршид тогтвортой, санхүүгийн хариуцлагатай байдлаар төрийн өмчийг удирдана. Түүнчлэн төрийн өмчийг хэмнэлттэй,

үр ашигтай зарцуулах ба тэдгээрийг зөвхөн тухайн байгууллагын зорилго, зорилтуудыг биелүүлэхэд ашиглана. (Г.Б)

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА (*State property management*) Төрийн эзэмшилд буй газар, хөрөнгийн үр ашигтай, үр нөлөөтэй байдлыг хангахад чиглэсэн удирдлагын түвшний үйл ажиллагаа, түүний үр дүн. Төрийн өмчийн удирдлагад төрийн өмчийг олж авах, эзэмших ашиглах, үнэлэх бүртгэх зэргийг хамруулна. 1980-аад онд зарим улс орнууд төрийн өмчийг үр дүнтэй удирдаж чадахгүй байгааг илэрхийлсэн⁸³. Төрийн өмчийн удирдлагыг сайжруулахад мэдээлэл дамжуулалт, мэдээллийн ил тод байдлыг хангах нь хамгийн чухал. Төрийн өмчийг ил тод байдлаар удирдах нь үйл ажиллагааны хүрээнд авлигаас ангид байх боломжийг бүрдүүлнэ. (Г.Б)

ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖ (*State owned enterprise*) Төр чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор, өөрийн өмчөөр байгуулсан хуулийн этгээдийн нэг хэлбэр. Зах зээлийн бус аргаар буюу төрийн оролцоотойгоор бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нийлүүлэх нэг арга нь төрийн өмчтэй аж ахуйн нэгж байгуулах юм. Төрийн өмчит аж ахуйн нэгжээр дамжуулан иргэд, олон нийтэд шаардлагатай бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх арга нь ард иргэдэд үйлчилгээг хүртэх тэгш боломж бүрдүүлэх, нийгмийн ашиг тусыг нэмэгдүүлэх зэрэг талтай. Гэвч төрөлхийн монопол бий болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтэд доголдол үүсэх, эзэн, агентын зөрчил үүсэх зэрэг эрсдэл

83 Carlo Vermiglio: "Public Property Management in Italian municipalities: Frame". *Public Property Management* 2011, p. 439.

бий. Дэлхийн улс орнууд 1930 оны эхэн үеэс төсвийн алдагдлыг нөхөх, хөрөнгийн хомстлоос сэргийлэх, эдийн засгийн хөгжлийг дэмжих, их хэмжээний ажилгүйдлийг багасгах, үндэсний хэмжээнд эдийн засгийн хөгжлийн ерөнхий чиглэл, баримжааг тогтооход дэмжлэг үзүүлэх зорилгоор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газруудыг олноор байгуулж эхэлсэн түүхтэй. Төрийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь төрөөс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад оршдог. Сүүлийн жилүүдэд стратегийн тэргүүлэх салбарт ажиллах төрийн өмчит аж ахуйн нэгж нь тухайн улсынхаа хөгжлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд гол дэмжлэг болдог гэсэн үзэл өсөн нэмэгдсээр байна. (Б.Б)

ТӨРИЙН САН (State treasury) Засгийн газрын байгууллагуудын доторх төсвийн мөнгөн урсгалын менежмент юм. Төрийн сангийн үйл ажиллагааг гурван үндсэн чиглэлээр хувааж болно. Үүнд; бэлэн мөнгөний менежмент, эрсдэлийн удирдлага, аж ахуйн нэгжийн санхүү гэж хуваадаг. Төрийн сангаар дамжуулан улсын төсвийн хэрэгжилт, төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааг хангахтай холбоотой төсвийн ерөнхий данс болон бүртгэлийн дансны бэлэн, бэлэн бус төлбөр тооцоо болон бусад харилцааг зохицуулдаг. (А.Э)

ТӨРИЙН САНГИЙН НЭГДСЭН ДАНС (State treasury single account) Засгийн газрын нэгдсэн зохицуулалт бүхий төсвийн ерөнхий данс болон Төв банканд байрших мөнгөн хөрөнгийн харилцах дансыг⁸⁴ хэлдэг. Монгол

Улсын хувьд төрийн сангийн нэгдсэн сан нь Монголбанкинд төгрөгөөр байршдаг. (А.Э)

ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА (State treasury activities) Төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахыг⁸⁵ хэлнэ. Төрийн сан нь төсвийн байгууллагын орлого, зарлагын өдөр тутмын үйлгээг багтагдсан төсвийн хуваарийн дагуу хянаж, төлбөр тооцоог хийж гүйцэтгэдэг. (А.Э)

ТӨРИЙН САНХҮҮ (Public finance) Засгийн газрын эдийн засагт гүйцэтгэх үүргийг судалдаг бөгөөд Засгийн газрын төсвийн орлого, төрийн захиргааны байгууллагуудын зардлыг үнэлэх, хүссэн үр дүнд хүрэх, хүсээгүй үр дагавраас зайлсхийхийн тулд аль нэгийг нь тохируулахыг үнэлдэг. (А.Э)

ТӨРИЙН САНХҮҮГИЙН УДИРДЛАГА (Public financial management) Улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, нийтийн хөрөнгийг хуваарилах, төсвийн зарлага гаргах, санхүүжилт хийх, түүнийг тайлагнах, хянах зорилгоор засгийн газрын ашигладаг хууль тогтоомж, дүрэм, систем, үйл явцын цогцыг хэлнэ. Энэ үйл явц нь санхүүгийн менежментээс илүү өргөн хүрээний чиг үүргийг багтаасан бөгөөд зургаан үе шаттай мөчлөг хэлбэрээр явагддаг. Үүнд: (1) бодлого боловсруулах, (2) тэдгээрийг улсын төсөвт тусгаж, төсөв боловсруулах, (3) төсөв багтах, (4) баталсан төсвийг хэрэгжүүлэх, (5) төсвийн орлого ба зарлагыг бүртгэж тайлагнах, (6) санхүү болон гүйцэтгэлд хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргах гэсэн үе шатууд орно. Энэ үйл явцад засгийн газар, сангийн яамнаас гадна, хууль тогтоох

84 Төсвийн тухай хууль

85 Төсвийн тухай хууль

байгууллага (парламент), судалгааны байгууллага, аудитын газар, иргэний нийгэм зэрэг олон тоглогч оролцдог. Төрийн санхүүгийн удирдлага нь нийтийн хөрөнгийг бүрдүүлж буй арга хэрэгсэл, үүнд ялангуяа татварын бодлого нь оновчтой бөгөөд шударгаар хэрэгжиж, татварыг үр ашигтай хурдан цуглуулж буй эсэх, зарлага талаасаа нийтийн хөрөнгийг тавьсан бодлогын зорилго, хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулан чухал салбарт зарцуулж буй эсэх, төрийн үйлчилгээ нь чанартай, хүртээмжтэй эсэх, бараа үйлчилгээний худалдан авалт нь хуулийн хүрээнд шударга явагдаж, санхүүгийн болон бусад мэдээлэл нь ил тод, олон нийтэд ойлгомжтой байх, тайлан нь үнэн зөв байхад чиглэгдэх ёстой. Товчхон хэлбэл, төрийн санхүү нь нийгмийн хэмжээгээр хүсэж буй *үр дүнд* (effectiveness) хүрэхийн тулд татвар төлөгчийн мөнгийг хамгийн зардал багатай, *үр ашигтай* (efficiency) аргаар зарцуулахад чиглэсэн тогтолцоо юм. (Ч.Н)

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБА (*Special governmental service*) Үндэсний болон иргэдийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбоотой төрийн чиг үүрэг⁸⁶.

- Төрийн тусгай албан тушаал / Special positions/: Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх бүх шатны шүүх, прокурор; үндэсний аюулгүй байдал, зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагын

удирдлага зэрэг албан тушаал хамаарна. (Г.Б)

ТӨРИЙН УДИРДЛАГА (*Public management*) “Public” гэдэг үгийг Англи, Турк хэлэнд “олон нийт, төр засаг” гэсэн утгатай хэрэглэдэг. Харин монгол хэлнээ “Монголын төрт ёсны уламжлал, онцлогийг эш үндэс болгон “төр” гэсэн агуулгыг баримтлал болгон орчуулсан”⁸⁷ байдаг. Захиргааны шинжлэх ухааны парадигмын хөгжлийн хүрээнд 1956-1970 онд “төрийн захиргаа бол менежмент” гэсэн үзэл санаа бүрэлдэн тогтжээ. Менежмент нь manus буюу “өөрийн гараар хянах, удирдах/жолоодох” гэсэн үгнээс гаралтай. Харин захиргаа (administere/administration) нь хэн нэгэнд үйлчлэх, зарцлагдах гэсэн утга бүхий “ad-minisrare” гэх латин үгнээс үндэстэй. Энэ хоёр үгийн утгыг мөшгөн харвал захиргаа нь “үйлчлэх”, харин менежмент нь “хянах, үр дүнд хүрэх” болж байна. Судлаачдын олонх нь төрийн удирдлага нь төрийн захиргаанаас илүү өргөн агуулгатай гэдэгт санал нэгддэг. Тухайлбал, Henri Fayol (1930) “захиргаа бол менежментийн функцний нэг”⁸⁸, Hyde and Shafritz (1991) нар “төрийн удирдлага бол төрийн захиргаанаас илүү өргөн ойлголт”⁸⁹ гэж тайлбарласан байдаг. Төрийн удирдлага (public management) нь захиргааны шинжлэх ухаанд “менежмент (удирдах ухаан, урлаг)”⁹⁰-ийн үзэл санааг нэвтрүүлснээрээ орчин цагийн төрийн

87 Я.Долгоржав, Төрийн захиргаа гэсэн ойлголтыг үг, нэршлийн хувьд хэрхэн авч үзэх вэ?, Төрийн удирдлага сэтгүүл, 2019.

88 Guy Peters and Jon Pierre, 2003, Handbook of public administration, p. 15.

89 Guy Peters and Jon Pierre, 2003, Handbook of public administration, p. 15.

90 Менежмент гэдэг нь байгууллагын зорилгыг үр дүн, үр ашигтайгаар хэрэгжүүлэхийн тулд хүмүүс болон бусад нөөцийг төлөвлөх, зохион байгуулах, манлайлах, идэвхжүүлэх, хянах, шийдвэр гаргах тухай мэдлэгийг хэрэглэх арга ухаан юм.

86 Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйл, <https://www.legalinfo.mn/law/details/13025?lawid=13025>

захиргааны чиг хандлага (төрийн захиргаа гэдэг нэр томьёо нь төрийн удирдлага гэсэн санааг агуулдаг⁹¹) тодорхойлогдсон юм. Өөрөөр хэлбэл, төрийн удирдлага нь төрийн захиргааны уламжлалт загвараас эрс татгалзаж үр дүн, хариуцлагад илүүтэй анхаарал хандуулж төрийн захиргааг шинээр манлайлан удирдах болсон нь төрийн захиргааны удирдлагын тухай үзэл санааг бий болгосон юм. Төрийн захиргааны шинжлэх ухааныг илэрхийлэх нэр томьёо болон түгээмэл хэрэглэгдэж буй латин гаралтай public administration (ард түмний захиргаа) гэх үг хэллэг нь “ард түмний хэргийг захиран зохицуулж удирдах”⁹² үйл явцтай холбоотой. Энэ ч утгаараа “Төрийн захиргаа бол төр, засгийн үйл хэргийг хэрэгжүүлэх зорилготой шинжлэх ухааны мэдлэг, урлаг мөн (Dwight Waldo, 1994⁹³)” гэж тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, “төрийн захиргааны удирдлага бол нэгэн зэрэг шинжлэх ухаан болоод урлаг”⁹⁴ юм. “Улсыг засаж, төрөөр төвшитгөн удирдах асуудлыг эрхэлдэг төрийн удирдлагын ухаан нь өөрөө бусад шинжлэх ухаан, урлагийн дотор онцгой эрх, эрэмбэтэй, засаглах, “даргалах” байр суурьтай”⁹⁵ байдаг. (Т.Т)

ТӨРИЙН УЛАМЖЛАЛТ АЛБАН БИЧИГ *(Traditional government official letter)*

Монгол төрийн албан бичиг Хүннү Улсаас эхтэй юм. Хятадын түүхэн сурвалжуудад Хүннүгийн шаньюйгаас Хятадын хаадад захидал хүргүүлж байсан тухай олонтаа дурддаг. Албан бичиг нь захидал болон гэрээнээс

анхлан үүссэн байна. Монголчууд мэдээлэл дамжуулахдаа алдагдан үрэгдэхээс болгоомжлон захидлын агуулгыг шүлэглэсэн хэлбэрээр зохиож, элчид цээжлүүлэн явуулдаг байжээ. Үүнийг “дуу бариулах” гэж нэрлэж байсан байна. Дуу бариулахаас гадна бичгээр мэдээлэл хүргэдэг байжээ. XIII-XIV зууны үед Монголын хаад Ромын Пап лам, Францын ван нарт илгээсэн бичиг захидлууд одоо ч эдгээр орны архивд хадгалагдсаар байна. Албан бичиг бичих, хадгалах нарийн дэг ёстой байжээ. Хожим XVIII зууны үеэс төрийн албан хэрэг хөтлөлт улам бүр нарийсаж, ирсэн явсан бичиг, захидлыг тусгай дансанд бүртгэн хадгалдаг байжээ. Мөр тэтгэж бичих, хэнд, ямар зорилгоор уг бичгийг илгээж байгааг илтгэх, тамга дарах зэрэг нь нарийн дэг журамтай байжээ. Бичгийг бичихдээ цаасыг хонин, морин, тайлангийн хэмээн гурав хувааж Хонин хэсэгт бичгийн толгойг, морин хэсэгт үндсэн бичвэрээ, тайлангийн хэсэгт явуулж байгаа хүний нэр цол, тамгалж баталгаажуулах зүйлээ байрлуулан бичдэг байжээ. Албан бичиг нь айлтгах, өргөх, тушаах, явуулах, нугалбар, гэрийн үеийн бичиг, гэрээс гарсан бичиг, зураг, цэс, данс гэх мэт олон төрөлтэй байсан байна. Албан бичгийг үйлдэх журмыг зөрсөн тохиолдолд бичээч, түшмэл нарт арга хэмжээ авдаг байжээ. Албан бичигт тухайн асуудлын түүх, зарим үед агуулга санаагаа тодотгохын тулд үлгэр домог, эртний түүх зэргийг оруулан бичдэг байжээ. Албан бичгийн эл хуучин уламжлалыг Ардын хувьсгал ялсны дараа 1930-аад оны үед халж, шинэ заавар гаргасан байна. (А.Ц)

ТӨРИЙН УЛС ТӨРИЙН АЛБА (*State political service*) Хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу

91 А.Цанжид, Төрийн захиргаа, 2009, х. 13.

92 Я.Долгоржав (2020), Төрийн удирдлага сэтгүүл, х. 8.

93 Waldo, D (1994), What is Public Administration? In D.G. David H. Rosenbloom, Contemporary Public Administration, pp. 3-5.

94 Я.Долгоржав, 2020, төрийн удирдлага сэтгүүл, х. 7.

95 Я.Долгоржав, 2020, төрийн удирдлага сэтгүүл, х. 8.

сонгогддог болон уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажиллах алба ба, түүний бүрэн эрхийн хугацаанд түүнд өөрт нь үйлчлэх алба.

- Төрийн улс төрийн албан тушаал /Political position/: Дээрх улс төрийн албыг хэрэгжүүлэх албан тушаалыг багтаана. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд болон тэдгээр үйлчлэх алба болон орон нутагт тухайн шагна Засаг дарга, түүний орлогч улс төрийн албан хаагч байна. (Г.Б)

ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТЕХНОЛОГИЙН ШИЙДЛЭЭР ОНОВЧ-ЛОХУЙ (*Government enterprise architecture*) Төрийн үйл ажиллагаа нэг бүрийг судалж, иргэн төвтэй төрийн үйлчилгээг хөгжүүлэх технологийн боломжуудыг оновчтой үр дүнтэй ашиглахад чиглэсэн үйл ажиллагааны цогц бүрдэл. Төрийн энтерпрайз архитектур нь мэдээллийн технологийн шийдлүүд, хүний нөөц, бусад нөөцүүд, чиг үүргийн уялдаа холбоог бүрдүүлсний үр дүнд төрийн үйл ажиллагааг илүү үр дүнтэй, хэмнэлттэй удирдах, зохион байгуулах нөхцөлөөр хангах үндсэн зорилгыг агуулна. (Д.З; Ч.Л нар)

ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЗАРЧИМ (*Fundamental principles of state activity*) Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон бөгөөд төрийн үйл ажиллагаанд удирдлага болгох үзэл баримтлалыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим гэнэ. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн (Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2). (Ч.Э)

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (*Public service*) Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд төрийн зорилт, чиг үүргийг ард иргэдэд бүтээгдэхүүн нийлүүлж, үйлчилгээ үзүүлэх замаар хэрэгжүүлж байгаа Засгийн газар, нутгийн удирдлагын байгууллагуудаас хариуцан гүйцэтгэх үйл ажиллагаа⁹⁶. Төрийн үйлчилгээ нь захиргааны үүрэгтэй шууд холбогдох бөгөөд захиргаа нь үүргээ төрийн үйлчилгээгээр дамжуулан хэрэгжүүлнэ. Захиргаа ямар үүрэгтэй вэ гэдгээс ямар үйлчилгээг иргэддээ үзүүлэх вэ гэдэг нь тодорхойлогдоно. Тухайлбал, манай улсын Үндсэн хуулийн 16.7-д “Монгол Улсын иргэн сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. ...”⁹⁷ гэж заасан байдаг. Энэ бол “иргэдийн сурч боловсрох эрхийг хангах” нь төрийн захиргааны үүрэг гэдгийг хуульчлан зааж өгсөн хэрэг бөгөөд энэхүү үүргээ “боловсролын үйлчилгээ” үзүүлэх замаар захиргаа нь хэрэгжүүлнэ гэсэн агуулга юм. Төрийн үйлчилгээ нь хүний үндсэн эрхийг хангах, нийтийн эрх ашгийг хамгаалах, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, хүний хөгжлийг хангахад чиглэгдэнэ. (М.А)

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ (*Contracting for public services*) Захиргааны чиг үүрэгт хамаарах зарим үйлчилгээ, үйл ажиллагааг Засгийн газрын бус (хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллага) байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхийг хэлнэ. Гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй үйлчилгээ, үйл ажиллагааг Засгийн

96 Долгоржав Я., ... нар, “Монгол улсад нутгийн өөрийн удирдлагын чадавхыг дээшлүүлэх нь”, 2003, 115-133 дахь тал.

97 Монгол Улсын Үндсэн хууль

газар санхүүжүүлнэ. Захиргааны шинэчлэлийн хүрээнд захиргааны үүргийн хэрэгжилтэд шүүмжлэлтэй⁹⁸ хандах болж үүргийг илүү үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэх боломжит нэг хувилбар болгон “төрийн зарим үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх” хувилбарыг улс орнууд сонгон хэрэгжүүлсэн байдаг. Монгол Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан бодлогын баримт бичигт “... Бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийн заримыг төрийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, эсхүл хувийн хэвшлийн буюу Засгийн газрын бус байгууллагад улсын төсвөөс санхүүжилт олгох замаар гүйцэтгүүлж болно” гэж заасан нь төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх суурийг тавьж өгсөн байна. (М.А)

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭХ АРГА (*Public service delivery method*)

Нийлүүлэгчээс хэрэглэгчид үйлчилгээг хүргэхэд ашиглаж буй арга, механизмыг хэлнэ. Өөрөөр хэлбэл төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хүргэхэд ашиглаж буй арга механизмыг төрийн үйлчилгээг хүргэх арга хэмээн тодорхойлно. Төрийн салбарт хийгдэж байгаа шинэчлэлийн шаардлага, эдийн засаг, нийгмийн болон техник, технологийн хөгжлийн шаардлага зэргээс улбаалан төрийн үйлчилгээг иргэдэд олон хувилбарт арга замаар хүргэх хэрэгцээ үүсэж байна. Монгол улсад интернетийн сүлжээ ашиглан онлайнаар үйлчилгээ үзүүлэх, төрийн үйлчилгээний ТҮЦ машинаар үйлчилгээ үзүүлэх, алслагдсан нутаг дэвсгэрт амьдарч байгаа иргэдэд явуулаар үйлчилгээг хүргэх, олон төрлийн үйлчилгээг нэг цэгт төвлөрүүлэн нэг цэгээр үйлчилгээг

хүргэх, олон нийтийн оролцоотойгоор буюу олон нийтийн оролцоонд түшиглэн үйлчилгээг хүргэх, гэрээгээр хувийн болон төрийн бус байгууллагаар дамжуулан үйлчилгээг хүргэх гэх мэтчилэн төрөл бүрийн аргыг төрийн үйлчилгээг хүргэхэд ашиглаж байна. (М.А)

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА (*Public service office*)

Төрийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх чиг үүрэг бүхий алба. Төрийн байгууллагын боловсрол, эрүүл мэнд, соёл, урлаг, спортын үйлчилгээг иргэдэд үзүүлнэ. Төрийн үйлчилгээний албаны үр дүн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үзүүлэлтээр илэрхийлэгдэх ба үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах хугацаа, үйлчилгээ үзүүлэгч албан хаагчийн харилцаа, хандлага, ёс зүйн элементүүдээр үйлчилгээний чанар илэрхийлэгдэнэ.

-Төрийн үйлчилгээний албан тушаал /Service position /: Төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах албан тушаалыг хэлнэ. Төрийн үйлчилгээний байгууллага батлагдсан төсвөөс Засгийн газраас батлагдсан албан тушаалын зэрэглэлийн дагуу албан хаагчдыг цалинжуулна. (Г.Б)

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА (*Public service provider*)

Төрийн бодлогоор оршин тогтнож, олон нийтэд үйлчилгээ үзүүлж, дахин хуваарилалтыг үүргийг гүйцэтгэдэг төрийн байгууллагын нэг төрөл нь төрийн үйлчилгээний байгууллага юм. Төрийн үйлчилгээний байгууллага нийгмийн гишүүдийн эрх ашгийг хангах үйл ажиллагаа явуулах тул

98 “Үүргийн шүүмжлэл”-ийн тайлбарыг харна уу.

ашиг, орлогод чиглэсэн бус байдгаараа хувийн байгууллагаас ялгагдана. Мөн төрийн байгууллаганы үйл ажиллагааны үр дүнгээр иргэдийн сэтгэл ханамж, төрд итгэх итгэл тодорхойлогддог онцлогтой. Төрийн үйлчилгээний байгууллагыг “public” буюу “нийт ард түмэндээ үйлчлэх байгууллага” хэмээн илэрхийлэх ба эдгээр байгууллага нь нь эрүүл мэнд, боловсрол зэрэг үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллана. Зарим төрийн үйлчилгээг засгийн газрын өмчлөлд хамаардаггүй, хяналтад байдаггүй хараат бус, сайн дурын болон ашгийн бус байгууллагууд бий болгож, үйлчилгээ үзүүлдэг тул үйлчилгээ нь нийт ард түмэнд үйлчлэх салбарынхантай ижил зүйл биш хэмээн үздэг. Тиймээс орчин үед олон түмний төлөө үйлчилгээ эрхэлдэг байгууллагууд төрийн, хувийн хэвшлийн болон бусад өмчлөлийн хэлбэрийн дагуу ялгаатай арга хэрэгслийг нэвтрүүлж ажиллах, иргэдэд илүү сайн үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх анхаарах болсон. (Г.Б)

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОПЕРАТОРЫН БОЛОН НЭГДСЭН ПОРТАЛ (*Service operator's system and integrated portal for government services*) Энэ нь төрийн зарим үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд цахим болон операторын горимоор үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн портал систем юм. “Төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн портал” www.e-mongolia.mn системийг бий болгосноор харилцан ялгаатай чиг үүрэг бүхий олон төрлийн төрийн байгууллагуудын зохион байгуулалтыг сайжруулах, үйл ажиллагааны зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд хүргэж буй үйлчилгээг ил тод,

түргэн шуурхай, чирэгдэлгүй болгох боломжтойгоос гадна том төрөөс ухаалаг төр рүү шилжих, улмаар иргэн төвтэй төрийн үйлчилгээг хөгжүүлэх ач холбогдолтой. (Д.З; Ч.Л нар)

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ (*Accessibility of public service*)

Иргэд авбал зохих үйлчилгээгээ цаг тухайд нь авч чадаж байгаа эсэхийг болон иргэн бүр төрийн үйлчилгээг тэгш, шударга хүргэх хүрэлцээтэй нөхцөл бүрдсэн эсэх нь төрийн үйлчилгээний хүртээмжийг тодорхойлно. Төрийн үйлчилгээний хүртээмжийг тодорхойлох үзүүлэлт салбар бүрийн онцлогоос хамааран ялгаатай байна. Тухайлбал боловсролын салбарт үйлчилгээний хүртээмжийг хамран сургалтын цэвэр жин, хамрагдалтын индекс, сургуулийн ээлжийн коэффициент, нэг багшид ногдох хүүхдийн тоо, нэг хүүхдэд ногдох ашигтай талбайн хэмжээ гэх мэт үзүүлэлтээр тодорхойлно. Төрийн үйлчилгээний хүртээмж нь засгийн газрын гүйцэтгэлийн нэг шалгуур үзүүлэлт байна. Энэ нь засгийн газрын иргэдийнхээ хэрэгцээний өвөрмөц, ялгаатай байдлыг мэдэрч түүнд нийцүүлэн үйлчилгээг хүргэх арга болон харилцааны сувгийг бий болгох чадвар, мөн түүнчлэн үйлчилгээг шударга, тэгш үзүүлэх баталгааг гаргах чадвар зэрэгтэй холбоотой⁹⁹. (М.А)

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМЖИЛТ (*Digitalization of Government services*)

Мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглан хэрэглэгчдэд ээлтэй төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх үйл явц. Төрийн үйлчилгээг цахимжуулахад засгийн газрын санаачилгаас гадна төрийн байгууллага болон иргэдийн

99 OECD, Government at Glance, 2013, p. 150.

бэлэн байдал чухал юм. Хэдийгээр сорилтуудтай тулгардаг боловч төрийн үйлчилгээг цахимжуулснаар иргэдийн цахим орчинд ажиллах чадвар сайжирч, иргэдийн оролцоо нэмэгдэхийн зэрэгцээ төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа сайжирч захиргааны зардал буурах давуу тал үүснэ. Монгол Улсад сүүлийн жилүүдэд төрийн үйлчилгээг эрчимтэй цахимжуулж төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн порталаар иргэдэд хүргэж байна. (Д.З; Ч.Л нар)

ТӨРИЙН ХАР ХҮН (Civil man) Лам биш, гээгтэй хүнийг ийн нэрлэж байжээ. Нарийн утгыг нь хөөвөл төрд зүтгэх ёстой хүн гэсэн үг юм. Монгол оронд бурхны шашин дэлгэрсэн цагаас хойш хүмүүсийг “хар, шар” хэмээн ялгаж ирсэн байдаг. Шарын талын хүн бол сахил санваар хүргэж, шарын шашны лам хувраг болох, буяны мөр хөөж “эх болсон зургаан зүйлийн хамаг амьтны тусын тулд” бодьсадва болох замаар замнаж буй хүн юм. Бурхны шашны “гурван эрдэнэ” гэдгийн нэг нь болох хуврагийн чуулганы нэг эд эс юм. Харин хар хүн бол хэдийгээр шашин шүтдэг боловч сахил, санвааргүй, гэр бүл болж, төрдөө “өрх өсгөж, сум сунгах” цэргийн алба хаах үүрэгтэй эр хүн юм. Энгийн ярианы хэлэнд эрэгтэй хүнийг эмэгтэй хүнээс ялган төрийн хар хүн хэмээн нэрлэх тохиолдол байдаг нь уг нэр томьёоны жинхэнэ утга биш юм. Төрийн хар хүн гэдэг ойлголтод энгийн иргэнээс эхлэн төрийн түшмэд, зүтгэлтэн нар багтана. Монголчууд төрд алба хашиж, төрийн төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр зүтгэдэг хүнийг “жинхэнэ төрийн хар хүн” хэмээн нэрлэдэг. Энэ утгаар нь Б.Чимид “төрийн хар хүн гэдэг бол мөнгөнд харам, хуульд нарийн, цэргийн эрдэмд гарамгай байх ёстой” хэмээн тодорхойлжээ. (А.Ц)

ТӨРИЙН ХЭЛБЭР (Forms of state)

Үндсэн хуулийн эрх зүйн онолд төрийн хэлбэр гэж удирдлагын (засаглалын) хэлбэр, төрийн байгууламжийн хэлбэр ба улс төрийн дэглэмийн нийлбэрийг ойлгодог. *Удирдлагын (засаглалын) хэлбэр* гэж засаг төрийн дээд байгууллагын (парламент, төрийн тэргүүн, засгийн газар) бүтэц ба эрх зүйн байдал, тэдгээрийн хоорондын харилцааг, *төрийн байгууламж* гэж төрийн засаглалын төв, орон нутгийн байгууллагуудын хоорондын харилцаа, эрх хэмжээ, зохион байгуулалтыг, *улс төрийн дэглэм* гэж нийгэм дэх төрийн ба улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх арга хэлбэрийн тогтолцоог тус тус ойлгоно. (Ч.Э)

ТӨРИЙН ХЯНАЛТ (State control)¹⁰⁰

Засаглалын үйл ажиллагаанд төрөөс хяналт тавих бодлого юм. Нөгөөтгээгүүр салбар, байгууллага, хөтөлбөр, санаачилга, хувь хүмүүсийг зохицуулах, захирах эрх мэдэл (засаглах эрх мэдэл) юм. (С.Ц)

ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНД БЭЛЭН ИРГЭН (e-Ready Citizen)

Төрөөс цахим хэлбэрээр хүргэж байгаа үйлчилгээг ашиглахад шаардлагатай мэдлэг чадвар бүхий иргэн. Төрийн үйлчилгээг цахимжуулахын өмнө иргэдийн бэлэн байдлын судалгааг явуулж төрийн үйлчилгээг хүртэх боломжгүй иргэдэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах нь цахимжуулах үйл явцын хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх ач холбогдолтой. Төрийн цахим үйлчилгээнд хамрагдахгүй хоцрох бүлэгт настай иргэд, суурь боловсролын үйлчилгээнд дутуу хамрагдсан иргэд, удаан хугацаанд ажил хөдөлмөр эрхлээгүй

¹⁰⁰ <https://www.google.com/search?q=state+control+definition+history&oeq=&aqs=chrome.2.69i59i4.5018.481240406j0j7&sourceid=chrome&ie=UTF-8>

иргэдийн тодорхой хэсэг болон хувийн нууцлалаа алдахаас болгоомжилж цахим үйлчилгээ авахаас тагталзсан иргэд байдаг. (Д.3; Ч.Л нар)

ТӨРИЙН ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭГЧ *(Contractor of work and services that belong to state functions)*

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний дагуу гүйцэтгэж, тухайн ажил, үйлчилгээний чанар, тоо хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх хариуцлагыг бие даан хүлээх этгээдийг¹⁰¹ хэлнэ. Тодорхой гэрээний үндсэн дээр төрийн гүйцэтгэх чиг үүргийг хувь хүн хуулийн этгээд явуулах үйл ажиллагаа гэж ойлгож болно. Тухайлбал, Монгол Улсын хувьд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ болох Өрхийн эмнэлгийн үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр төсвөөс санхүүжилт авч төрийн бус байгууллагууд гүйцэтгэдэг. (А.Э)

ТӨРИЙН ЭРХ МЭДЭЛ ХУВААРИЛАХ ЗАРЧИМ (үзэл баримтлал) (The principle [concept] of the separation of powers)

Төрийн эрх мэдэл хуваарилах зарчим нь төрийн тогтолцооны суурь зарчим юм. Энэ зарчмын дагуу төрийн эрх мэдлийг гурван салаанд (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх) хуваарилснаар тэдгээрийн эрхлэх асуудал, бүрэн эрхийнх нь үйлчлэх цар хүрээг зааглан тогтоож, төрийн байгууллагуудын аль нь ч төрийн эрх мэдлийг бүх хүрээнд дангаар ноёрхох явдлыг хориглохын зэрэгцээ, төрийн эрх мэдлийн гурван салаа нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бие даасан, харааг бус байх, өөр хоорондоо харилцан хамаарах, хяналт тавих боломжтой байх нөхцөлийг хангаж өгдөг. Ингэснээр төрийн институцүүдийн эрх мэдлийг хооронд нь тэнцвэржүүлж төрийн тогтолцооны

тогтвортой байдлыг хангах үндсэн нөхцөл бүрддэг тул төрийн эрх мэдэл хуваарилах зарчим нь аливаа ардчилсан үндсэн хуулийн үзэл баримтлалын суурь нь болдог. Төрийн эрх мэдэл хуваарилах зарчмын гол ач холбогдол нь төрийн эрх мэдлийн бүх салаа, түүний үйл ажиллагаа ард түмний эрх, ашиг сонирхол, хууль дээдлэх ёсонд захирагдмал байх нөхцөлийг бүрдүүлж өгдөгт оршино. Монгол Улсад төрийн эрх мэдэл хуваарилах зарчмын үзэл баримтлалыг 1992 оны Үндсэн хуульдаа бэхжүүлсэн. (Ч.Э)

ТӨРТ ЁС (Statehood) Үндэстний улс төрийн соёлыг бүрэлдүүлж байдаг, үзэл, дадал хэвшил юм. Олон үеэр боловсрогдож, баримталж ирсэн үндэстний төрт ёс нь төр улсынхаа тусгаар тогтнолыг дээдлэх, түүний илэрхийлэл болсон төрөө дээдлэх үзэл, төрийн үйл хэргийг эрхлэх зарчим, арга хэрэгсэл, төрийн хэл, ёс ёслол, түшмэл ёс, төрийн билэг тэмдэг зэрэг зүйлсийг багтаж байдаг. Төрт ёс бүхий үндэстэн нь төр улсыг цогцлоон байгуулах, түүний хамгаалах, ямар нэг шалтгаанаар алдарвал сэргээн босгох чадвартай байдаг. Ингэж үзвэл төрт ёс гэдэг нь улс төрийн талаар зохион байгуулагдаж, улс төрийн бие даасан нийгэмлэгийг бүтээж, хамгаалж, түүхийн сорил шалгалтыг даван туулж чадсан үндэстний улс төрийн олон талт уламжлалаар илэрхийлэгддэг улс төрийн хөгжлийн түвшин, чадвар юм. (А.Ц)

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ (Public and private partnership)

Түншлэл хэмээх үгийг Латины “partner” буюу “гал,түнш, хоршоо” гэсэн үгтэй хоршуулж үздэг. Энэ үгийг 1700 оноос эхлэн “тодорхой ажил үйлчилгээг хэрэгжүүлэх зорилгоор

101 Төсвийн тухай хууль

хоёр ба түүнээс олон хүмүүс нэгдэх үйл явц” гэдэг утгаар хэрэглэдэг байв. Түншлэл гэдгийг “байгууллага, хувь хүмүүс хамтран ажиллах үйл ажиллагааны хэлбэр” хэмээн монгол хэлний их тайлбарт тусгасан байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн эхлэл нь АНУ-д тавигдсан гэж үздэг. 1938 онд холбооны засгийн газар орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор төр, хувийн салбарын түншлэлийг эхлүүлсэн байдаг. Төр, хувийн хэвшлийн тухай ойлголт нь төрийн захиргааны шинэчлэлийн үндсэн бүрэлдэхүүний нэг юм. Тухайлбал, төр, хувийн хэвшлийн түншлэлийг “төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд гэрээ байгуулсны үндсэн дээр хувийн хэвшлийн нэгж төсөлд оролцох, Засгийн газрын үйлчилгээг төрийн нэрийн өмнөөс гүйцэтгэх боломжоор хангагдах үйл ажиллагаа” хэмээн тодорхойлсон байдаг. Энэ нь төр ба хувийн хэвшил хамтран бүтээгдэхүүн нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэхээр харилцан үр ашигтай, үр дүнтэй хамтран ажиллах хэлбэр. Олон улсын туршлагаас үзвэл төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэд бүтэц болон нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмж, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор ашигладаг. Нэгдүгээрт, их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай нөхцөлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дайчлах, хоёрдугаарт, хувийн хэвшлийн менежментийн туршлагыг ашиглан нөөцийг илүү үр дүнтэй ашиглах, гуравдугаарт, чиг үүргийг шилжүүлж, дахин хуваарилах, хариуцлагыг дээшлүүлэх замаар тухайн салбарт өөрчлөлтийг хийх зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлийн

аргыг нэвтрүүлдэг.¹⁰² Төр, хувийн хэвшлийн түншлэлийн аргын тухайд хувьчлал, төрийн үйлчилгээг хувийн хэвшилээр гэрээгээр гүйцэтгүүлэх зэрэг хэлбэрээс ялгагдах гол шинж нь түншлэгч талууд эрсдэлээ хуваалцаж үр дүн, гүйцэтгэлийг сайжруулах замаар зардлыг бууруулах зорилгыг хэрэгжүүлдэгт оршино. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хувьд үйлчилгээний гэрээ, удирдлагын гэрээ, түрээсийн гэрээ, барих-ашиглах-шилжүүлэх ба түүнтэй адилтгах зохицуулалтууд, концесс ба хамтарсан аж ахуйн нэгж байгуулах зэрэг түгээмэл хэлбэрүүд байдаг.¹⁰³ Өөрөөр хэлбэл, түншлэл нь оролцооны хүрээг өргөтгөж өгдөг. Түншлэл нь төрийн байгууллага болон хувийн хэвшил, ашгийн бус ба сайн дурын байгууллага, иргэний нийгмийн холбоо, иргэдийн байгууллагын санаачилгаас үүсч бий болдог. Түншлэлд оролцогч тал бүр хөрөнгө хүч (санхүүгийн, хүний, технологийн) болон мэдээлэл, зохион байгуулалтын дэмжлэг зэрэг хувь нэмрээ оруулахаас гадна шийдвэр гаргах, хэрэгжүүлэх ажиллагаанд харилцан тохиролцсоны үндсэн дээр оролцдог. (Б.Б. Т.Т)

ТӨСВИЙН АШИГ/АЛДАГДАЛ (*Budget surplus/deficit*) Төсвийн зарлагаас давсан орлогыг болон төсвийн орлогоос давсан зарлагыг¹⁰⁴ хэлнэ. Улсын болон орон нутгийн төсвийн хувьд хэрэглэгддэг ойлголт бөгөөд төсвийн байгууллагуудын хувьд энэ нэр томьёо хэрэглэгдэхгүй. Аль ч улсад эдийн засгийн тогтворжилтыг тодорхойлох макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн нэг нь төсвийн алдагдал юм. Тухайн улсын Засгийн газрын мэдэлд байгаа

102 ADB, Public-Private Partnership Handbook, pp. 2-4.

103 ADB, Public-Private Partnership Handbook, pp. 27-28.

104 Төсвийн тухай хууль

мөнгөн хөрөнгийн сан нь нийгэм, эдийн засгийн салбаруудад хийсэн санхүүжилтээ гүйцэж чадахгүй тохиолдолд төсвийн алдагдал үүснэ. Өөрөөр хэлбэл, төсвийн алдагдал гэдэг нь улсын төсвийн зарлага нь орлогоосоо давах үзэгдэл юм. Төсвийн алдагдал нь дараах 2 шалтгааны улмаас үүснэ. Үүнд: 1. Төсвийн орлого буурснаас 2. Төсвийн зарлага нэмэгдсэнээс. Улсын төсвийн алдагдал нь Үндэсний нийт бүтээгдэхүүнийхээ 3 хүртэлх хувьтай тэнцэж байвал үүнийг улс орны эдийн засагт хүндрэлтэй биш гэж үзээд хэвийн төсөв гэж нэрлэх бөгөөд харин энэ хэмжээнээс давбал мөнгө зээлийн тогтолцоо болон эдийн засагт бүхэлдээ сөрөг үр дагавартай гэж тооцдог. Төсвийн алдагдлыг дараах байдлаар удирдана. Үүнд: 1. Төгрөгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн санхүүгийн тодорхой хөтөлбөр боловсруулах. Мөнгө нь тогтвортой байна гэдэг нь эдийн засгийн сэргэлтийн үндэс юм. Байнгын өсөж буй, хяналт тавьж боломгүй инфляцын нөхцөлд үйлдвэрлэлийн хөгжлийн хэвийн түвшин хангагдаж чадахгүйгээс гадна хүн амын амьдралын түвшин өсөхгүй. Яагаад гэвэл инфляц нь хуримтлалыг устгаж, хөрөнгө оруулалтын үнэ цэнийг алдагдуулж, баян хоосны ялгааг улам нэмэгдүүлдэг. 2. Төсвийн алдагдлыг хаах үр дүнтэй эх үүсвэрийг хайх. Үүнд: Төсвийн алдагдлыг бий болгоход нөлөөлж буй эдийн засгийн нөхцөл байдалд хяналт тавих Улсын төсвийн хөрөнгөөр санхүүждэг улс байгууллагуудын санхүүжилтийг хорогдуулах Цэрэг баглан хамгаалах зардлыг хорогдуулах Төсвийн зарлагыг бууруулах гэх мэт. Төсвийн алдагдлыг бууруулах арга 1. Эмиссийн арга. Энэ нь цаасан мөнгө гүйлгээнд нэмж гаргах арга бөгөөд төсвийн

зарлагыг санхүүжүүлэх нэг эх үүсвэр юм. Энэ арга нь маш энгийн мэт боловч инфляцын түвшинг хөөрөгдөх аюултай байдаг. Эмисси нь дотроо 2 янз байдаг. 1. Бэлэн мөнгөний эмисси. 2. Зээлийн эмисси. 2. Таналтын арга. Өөрөөр хэлбэл төсвөөс гуйсан бүхэнд толгой дараалан мөнгө өгөхөө болих, гэхдээ зориулалтын санхүүжилтийг ядуурал болон төсвийн дэмжлэг бүхий бүтцийн өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай бүсүүдэд нь хэвээр үлдээх нь зүйтэй юм. 3. Хувьчлал. Энэ нь улс өөрийнхөө мэдлийн хөрөнгө, үйлдвэрийн газруудыг хувь хүнд худалдах үйл явц юм. Жишээ нь манай орны хувьд 1997 оны өмч хувьчлалын үр дүнд их хэмжээний мөнгө улсын төсөвт орсон. 4. Удирдлагын зардалд хяналт тавих 5. Эдийн засгийн шинэчлэл хийх зэрэг замаар бууруулж болно. Төсвийн алдагдлыг бууруулах, зохистой түвшинд барих чиглэлээр төсвийн шинэчлэлийг хийдэг. Монгол Улсын хувьд улсын төсөв алдагдалтай гардаг бөгөөд харин зарим орон нутгийн хувьд төсөв нь ашигтай буюу илүүдэлтэй гардаг. Энэ тохиолдолд төсөв нь ашигтай гарсан орон нутгийн төсвийн ашгийг улсын төсөвт татан төвлөрүүлдэг. (А.Э)

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА (*Budgetary entity*) Хууль тогтоох төрийн дээд байгууллагаас баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг¹⁰⁵ хэлнэ. (А.Э)

ТӨСВИЙН БОДЛОГО (*Fiscal policy*) Зарим тохиолдолд Сангийн бодлого гэж нэрлэдэг бөгөөд тухайн улсын нийт эдийн засагт Засгийн газрын

105 Төсвийн тухай хууль

төсвийн орлогыг ихэсгэх эсвэл бууруулах (татвар эсвэл татварын хөнгөлөлт), зарлагыг өсгөх багасгах замаар нөлөөлөх үйл ажиллагаа юм. Төсвийн бодлого нь Английн эдийн засагч Жон Мейнард Кейнсийн онол дээр үндэслэсэн бөгөөд Кейнсийн эдийн засагт Засгийн газрын татварын хэмжээ болон Засгийн газрын зардлын өөрчлөлт нь нийт эрэлт, эдийн засгийн үйл ажиллагааны түвшинд нөлөөлдөг гэж онол дэвшүүлсэн. Төсвийн бодлогоор дамжуулан тухайн улсын Засгийн газар, Сангийн яамнаас макро эдийн засгийн эдийн засгийн нөхцөл байдалд нөлөөлж, өөрийн дэвшүүлсэн зорилгоо хэрэгжүүлэхэд ашигладаг гол арга зам болдог. Засгийн газрын зүгээс төсвийн бодлогыг хэрэгжүүлдэг бөгөөд ингэхдээ төсвийн зардал, татвар зэргийг өөрчлөх замаар нийт эрэлтэд нөлөөлдөг. Эдийн засаг дахь нийт эрэлт потенциалт үйлдвэрлэлийн түвшнээс доогуур болох үед зарим үйлдвэрлэх боломжтой байсан бүтээгдэхүүний хэмжээ орхигдож үйлдвэрлэлийн зөрүү үүсдэг. Татварыг бууруулснаар хувь хүний хэрэглээг нэмэгдүүлэх боломжтой бөгөөд энэ нь нийт эрэлтийг өсгөх шалтгаан болж өгдөг. Татварын хөнгөлөлт, засгийн газрын зардал зэрэг нь бүгд үржүүлэгчийн нөлөөтэй бөгөөд бодлогын нөлөөнөөс үүссэн анхдагч эрэлтийн өсөлт нь зах зээлд нэмэлт өсөлтийг бий болгож байдаг. Хэрэв эдийн засагт үйлдвэрлэлийн зөрүү байхгүй бол потенциал үйлдвэрлэлийн хэмжээнд хүрэх бөгөөд илүүдэл үйлдвэрлэлийн нөөц гарахгүй. (А.Э)

ТӨСВИЙН ЕРӨНХИЙ ДАНС (*General budget account*) Тухайн шатны төсвийн мөнгөн гүйлгээг нэгтгэн бүртгэх харилцах дансыг¹⁰⁶ хэлнэ. Энэ данс

¹⁰⁶ Төсвийн тухай хууль

ихэвчлэн тухайн улсын Төрийн сан эсвэл Төв банк дээр байршдаг. (А.Э)

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ (*Portfolio minister*) Өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг¹⁰⁷ хэлнэ. Монгол Улсын хувьд энэ ойлголтын хүрээнд Засгийн газрын бүх сайд нар болон Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалтнууд, шүүх прокурор, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нар багтдаг бөгөөд улс орон нутгийн төсвөөс өөрийн хариуцах чиг үүргийг хэрэгжүүлэх үүднээс тодорхой төсвийн санхүүжилт авч захиран зарцуулах шийдвэр гаргадаг албан тушаалтнуудыг хэлнэ. (А.Э)

ТӨСВИЙН ЖИЛ (*Fiscal year*) Аливаа улс орны хувьд Хууль тогтоох дээд байгууллагаас баталсан Засгийн газрын захиран зарцуулах төсөв нь тодорхой хугацааг хамардаг бөгөөд ихэнхдээ нэг жил байх ба түүнийг төсвийн жил (эсвэл санхүүгийн жил, эсвэл заримдаа төсвийн жил) гэж нэрлэнэ. Улс орнуудын төсвийн жил нь харилцан адилгүй байдаг бөгөөд тухайлбал, АНУ-ын Засгийн газрын төсвийн жил аравдугаар сарын 1-нээс эхэлдэг бол Япон Улсын хувьд тухай орны 4-р сарын 1-ний өдрөөс тооцогддог. Монгол Улсын хувьд Төсвийн жил нь 1-р сарын 1-нээс эхлэн 12-р сарын 31-нээр дуусгавар болдог. (А.Э)

ТӨСВИЙН ЗАРЧИМ (*Fiscal principle*) Төсвийн төслийг бэлтгэх, боловсруулах, хэлэлцүүлэх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үе шатанд баримтлах үндсэн дүрмийг хэлнэ.

¹⁰⁷ Төсвийн тухай хууль

Тухайлбал; төсвийн тогтвортой байдлыг хангасан байх, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангасан байх, хариуцлагатай байх гэсэн зарчмууд төсөвт үйлчилдэг. (А.Э)

ТӨСВИЙН ЗАХИРАГЧ (*Budget governor*) Тухайн байгууллагын зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулан багалсан төсвийг хуулийн дагуу зарцуулах эрх бүхий албан тушаалтан. Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагч нар нь эрх үүрэг болон хүлээх хариуцлагаараа ялгаатай. (С.Ц)

ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ (*Fiscal transparency*) Засгийн газар нь улсын төсвийн орлого, зарлагыг хэрхэн өсгөх, зарцуулах, удирдах талаарх мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй нийтлэхийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, Засгийн газар татвараа хэрхэн өсгөх, зээлэх, зарцуулах, хөрөнгө оруулалт хийх, олон нийтийн хөрөнгө, өр төлбөрийг хэрхэн удирдах талаар өндөр чанартай мэдээллийг нийтлэхийг хэлнэ. Төсвийн ил тод байдал нь улсын санхүүгийн өнгөрсөн, одоо, ирээдүйн төлөв байдлын талаар олон нийтэд тайлагнах үйл ажиллагааг багтаана. (А.Э)

ТӨСВИЙН ОРЛОГО/ЗАРЛАГА (*Budget expenditure/revenue*) Төсвийн орлого гэж хууль, тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг¹⁰⁸ хэлдэг бол төсвийн зарлага гэж төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвөөс хуваарилан, зарцуулах хөрөнгийг хэлнэ. (А.Э)

ТӨСВИЙН СУДАЛГАА (*Budget research and analysis*) Төсвийн орлого, зарлага, улсын хөрөнгө оруулалтын үр ашигт гарч буй ололтыг багатган, алдагдлыг бууруулах шаардлагаар улсын төсөвт судалгаа хийдэг. Төсөв бол төрийн мөнгө болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын үүрэг, чиг үүргийг санхүүгийн хувьд дэмжихэд зориулагдсан сан бүрдүүлэх, зарцуулах хэлбэр юм. Тооцоо, улсын орлого, зардлын жагсаалт, хэмжээ, ашиглалт, хугацаа, бие биетэйгээ харилцан тохиролцсон. Төсвийн судалгааг олон төрлийн (салбар хоорондын, нутаг дэвсгэрийн гэх мэт) болон олон түвшний (засгийн газрын, хот, бүс нутгийн гэх мэт) хөрөнгийг дахин хуваарилах ажил хэр оновчтой байгааг судлан дүн шинжилгээ хийдэг. Манай улс Дэлхийн банкны дэмжлэгээр “Өрийн дарамтгүй, тогтвортой бөгөөд хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгох нь” судалгааг хийсэн юм. 2018 онд хийсэн төсвийн хөрөнгө, төсвийн зардлын тойм судалгаа (ТЗТС) нь эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийн суурийг бэхжүүлэхэд тэргүүлэх чиглэлийг тодорхойлох үүднээс төсвийн орлого, зардлын сүүлийн үеийн хандлагад дүн шинжилгээ хийсэн байна. ТЗТС нь улс орны урт хугацааны хөгжил, ядуурлын эсрэг тэмцэлд амин чухал үүрэгтэй боловсрол, эрүүл мэнд зэрэг гол салбаруудын зарлагын тусгай шаардлага, хэрэгцээг мөн судалсан юм. Дэлхийн зах зээлийн түүхий эдийн үнийн савлагаанаас шалтгаалан Монгол Улс нь эдийн засгийн хүчтэй цочролд өртдөг. Үүний эсрэг манай улс төсвийн нарийн төвөгтэй багц бодлого боловсруулсны дотор мөчлөгийн эсрэг төсвийн бодлогыг дэмжих, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан дүрмүүдийг дагаж мөрдөх,

¹⁰⁸ Төсвийн тухай хууль

бараа, түүхий эдийн үнийн өсөлтийн үед хуримтлал үүсгэх, нөөц бүрдүүлэх арга хэмжээнүүд ордог. Энэ нь тогтвортой өсөлтийг хангахад дэмжлэг болох ч өр зээлийн дарамт, төсвийн алдагдал ихтэй, төсвийн дүрмийн биелэлт сул хэвээр байгаа нь тэр бүр нааштай үр дүн гарахгүй байсаар байгаа. Энэ нь төсвийн сахилга батыг сайжруулах аливаа оролдлогоос давсан улс төрийн сэдэлтэй шийдвэрүүд гарсаар байгаа, засгийн газар ойрхон солигдож төсвийн сайн бодлого үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг алдагдуулж байгаа бодит байдлын шалтгаан нөхцөлийг тодорхойлохоор төсвийн судалгаа хийдэг. (А.Э.ц)

ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО/ЗАРЛАГА (*Base line budget revenue/ expenditure*)

Тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь, хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг төсвийн суурь орлого гэж нэрлэдэг. Харин төсвийн суурь зарлага гэж төрийн тодорхой чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлагыг хэлдэг. Эдгээрийн ихэвчлэн орон нутгийн төсвийн хувьд авч үздэг. (А.Э)

ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН (*Stabilization fund*)

Тогтворжуулалтын сан гэдэг нь дотоодын эдийн засгийн газрын тос, түүхий эд гэх мэт томоохон орлогын урсгалаас тусгаарлах зорилгоор Засгийн газар эсвэл Төв банкнаас байгуулдаг механизм юм. Үндсэн шалтгаан нь түүхий эдийн үнийн томоохон хэлбэлзэлтэй тулгарсан үед Засгийн газрын төсвийн орлогын түвшинг тогтвортой байлгах явдал юм. Энэ нь ерөнхийдөө гадаад өр, төлбөрийг худалдан авахтай холбоотой, ялангуяа дотоодын эдийн засагт хэт халалтаас урьдчилан

сэргийлэх зорилготой юм. Энэ ойлголт нь бие даасан баялгийн сантай давхцаж магадгүй юм. (А.Э)

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ (*Fiscal stability*)

Дунд болон богино хугацаанд төсвийн үндсэн үзүүлэлтүүд болох төсвийн алдагдал болон Засгийн газрын өрийн хэмжээг Дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулсан харьцаа тогтвортой байх нөхцөлийг хангахыг хэлдэг. (А.Э)

ТӨСВИЙН ТОДОТГОЛ (*Budget amendment*)

Тухайн жилийн төсвийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулахыг¹⁰⁹ хэлнэ. (А.Э)

ТӨСВИЙН ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ (*Fiscal decentralization*)

"Fiscal" гэдэг нь дундад Францын "fiscal", Латины "fiscalis" гэсэн үгнээс үүдэлтэй. Үгийн утга нь "иргэдийн төсөв/орлого (public revenue)", "улсын сан хөмрөг (state treasury)", "мөнгөний цүнх (money bag)" гэж тайлбарлагддаг. Энэ үгийн ерөнхий утга (financial) нь 1865 оноос санхүүгийн хэрэглээнд орсон байдаг. Төсвийн төвлөрлийг сааруулах нь төсвийн зарлага, орлогын хариуцлагыг төв засгийн газраас орон нутгийн захиргаанд шилжүүлэх үйл явц юм. Төсвийн төвлөрлийг сааруулах хэлбэрүүд нь 1) төлбөр, хураамжаар дамжуулан өөрөө өөрийгөө санхүүжүүлэх, эсвэл өртгөө нөхөх, 2) хувийн салбартай хамтарч санхүүжүүлэх, эсвэл үйлдвэрлэх, 3) орон нутгийн татвар, татварын бус орлогыг нэмэгдүүлэх, 4) төв, орон нутаг хоорондын санхүүгийн шилжүүлэг, 5) орон нутгийн зээл ордог байна. (Т.Т)

¹⁰⁹ Төсвийн тухай хууль

ТӨСВИЙН ТӨЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

(Central budget governor) Төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг¹¹⁰ хэлнэ. (А.Э)

ТӨСВИЙН ТӨСӨЛ (Draft of budget)

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн, хуульд заасан шаардлагын дагуу төсвийн шатлал бүрээр төсвийн ангилал ашиглан бэлтгэсэн төсвийн саналыг хэлнэ. (А.Э)

ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГА (Fiscal special requirements)

Төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн, төсвийн богино, дунд, урт хугацааны бодлого, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг тодорхойлоход баримтлах, тогтоосон зохистой үзүүлэлтийн түвшин, харьцаа, хязгаарлалтыг¹¹¹ хэлнэ. (А.Э)

ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО/ТЭНЦЭЛ (Balance of fiscal equalization)

Гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого, нэгдсэн төсвийн суурь орлогын нийлбэрээс тухайн төсвийн жилд Ирээдүйн өв санд хуримтлагдсан төсвийн орлогыг хассан дүнг хэлнэ. (А.Э)

ТӨСВИЙН УДИРДЛАГЫН ШИНЭЧЛЭЛ (Fiscal management reform)

Төсвийн хязгаарлагдмал эх үүсвэрийн менежментийг сайжруулах нь засгийн газрын гол зорилтын нэг тул төсвийн алдагдлыг багасгах, зүй зохистой, оновчтой төлөвлөлт нь

төрийн санхүүгийн менежментийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд чиглэдэг. Төсвийн удирдлагыг хэрэгжүүлэхэд төсвийн богино, дунд хугацааны бодлого, стратеги зорилт, урт хугацааны чиг хандлагын төсөөлөл, тэдгээрийн агуулга, хэрэгжилт нь ил тод байх, төсвийн бодлого, стратегийн зорилт нь макро эдийн засгийн болон татварын тогтвортой орчныг бүрдүүлэх, инфляцыг хязгаарлахад чиглэсэн байх зарчмыг баримталдаг. Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжих явц нь улсын хөрөнгийн зарцуулалтын удирдлагын шинэчлэл хийгдэх гол хүчин зүйл болсон бөгөөд 1996 оноос Засгийн газраас төсвийн шинэчлэл хэрэгжүүлж эхэлсэн нь төрийн захиргаа, удирдлагын тогтолцоог шинэчлэх шинэчлэлийн ололт амжилтад суурилав. Монгол Улсад хэрэгжсэн төсвийн удирдлагын шинэтгэл нь ядуурлыг бууруулах стратегийн хөтөлбөр (ЯБСХ), эдийн засгийн өсөлт, төрийн албаны шинэчлэлд тулгуурласан юм. Төсвийн төлөвлөлтийн шинэчлэл нь удирдлагын зарчмыг баримтлан улсын салбарын болон төрийн албаны шинэчлэлтэй уялдаж орцоос гарцад/бүтээгдэхүүнд эрх мэдэлд хариуцлага ногдуулах зарчмаар төсвийн менежерүүдийг хүрэх үр дүнгийнхээ төлөө хариуцлага хүлээдэг болгохын тулд орцод тавих хяналтын талаар хангалттай эрх мэдэл олгохын зэрэгцээ эрх мэдлийг зохих түвшинд олгох хэрэгтэй гэж үзэв. Хариуцлагын тогтолцоо нь үүрэг, хариуцлагын зааг ялгааг тодорхой болгосон үед л биелэгддэг. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар төсвийн төлөвлөлтийн шинэчлэлийг төрийн албаны шинэчлэлтэй уялдуулж төсвийн хөрөнгийн зарцуулалтын удирдлагын хэрэгслийг бий болгосон. Тухайлбал,

110 Төсвийн тухай хууль

111 Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

бүтээгдэхүүнд суурилсан төсөвлөлт (гэрээнд тулгуурлан санхүүжилт авах), үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг багтаасан үр дүнгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн стандартууд, байгууллагуудын үүрэг, хариуцлага (яамд, агентлагууд, аймаг, нийслэл, сум болон дүүргүүд). 2010 онд улсын нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихад төрийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, эрдэс баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар төсвийн тогтвортой байдлын хууль баталсан. Өнөөгийн төсвийн удирдлагын шинэчлэл нь Менежментийн Мэдээллийн Систем (MIS) ба журам өөрөөр хэлбэл “цахим засаглал”-д суурилсан шийдвэр гаргах, бодлого боловсруулах болно. Тодруулбал, Санхүүгийн Менежментийн Мэдээллийн Систем (FMIS) нь төсөв, төлөвлөлтийг засгийн газраас баталсан стратегитай уялдуулан сайжруулах, засгийн газар, яам, холбогдох байгууллагууд, олон нийтэд тогтмол тайлагнаж, нээлттэй, хариуцлагатай, ил тод байдлыг сайжруулах зорилгоор зарлага, орлогын гүйцэтгэл, бүртгэлийг сайжруулах зорилготой юм. (А.Э.ц)

ТӨСВИЙН УРСГАЛ ТЭНЦЭЛ (*Current account of budget*) Төсвийн нийт урсгал орлогын дүнгээс төсвийн нийт урсгал зарлагын дүнг хассан зөрүүг хэлнэ. Төсвийн урсгал орлогод татварын

орлого, татварын бус орлогууд багтдаг бөгөөд татварын орлогод нь хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар гэх зэрэг багтдаг. Харин төсвийн урсгал зардалд төсвийг захиран зарцуулах хуулийн этгээдүүдийн усгал хэрэглээг санхүүжүүлэхэд төсвийн хөрөнгийг олгохтой холбогдсон зардлын хэсэг орно. Өөрөөр хэлбэл дахин ашиглагдахгүй, нэг удаа зарцуулаад өнгөрөх, өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай, тогтмол гарах зардлыг урсгал зардал гэнэ. Үүнд: 1) улсын хэрэглээний зардлууд. Үүнд: төрийн өмчийн байгууллагуудыг санхүүжүүлэхэд гарах зардлууд орно. 2) төрийн доод түвшинд байгаа эрх бүхий байгууллага, улсын болоод хувийн байгууллагуудад олгох мөнгөн тусламж 3) улсын зээлийн хүүг олгоход зарцуулах зардал 4) бусад зардал. Төсвийн урсгал зардлыг бууруулж чадсанаар зарлагын идэвхтэй хэсэг буюу нийгмийн цаашдын хөгжлийг тодорхойлогч хөрөнгийн зардалд илүүтэй анхаарах боломжтой бий болно. (А.Э)

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ (*Budget funds*)

Улсын төсөв буюу төсвийн хөрөнгө гэдэг нь нийгэм, эдийн засгийн зорилгыг хэрэгжүүлэх хэрэгсэл бөгөөд улсын мөнгөн хөрөнгийн төвлөрсөн хуримтлалыг бий болгож хуваарилах үйл явц мөн. Энэ нь төсвийн буюу мөнгөн хөрөнгө юм. Төсвийн хөрөнгийг Улсын Их Хурлаар баталж, Засгийн газар бүрдүүлэн зарцуулна. Улсын төсвийн нийт орлогыг дотор нь: 1. Урсгал орлого 2. Тусламжийн орлого гэж 2 ангилна. Төрөөс өөрийн үүргийг гүйцэтгэх чухал хэрэгсэл болгож төсвийн ашиглалттай холбон авч үзвэл төрийн үүсэлтэй уялдан

төсөв анх бий болсон гэж үзэж болно. Дэлхийд анх удаа Англи Улс /1686-1689/ төсөв зохиож түүнийгээ хууль тогтоох байгууллагаар батлуулан хэрэгжүүлсэн байдаг. Харин Монгол Улсад 1921 оны ардын хувьсгалын дараа Ардын Засгийн газар өөрийн төсвийг бий болгож улмаар 1925 оноос Улсын бага Хурлаар батлах болсон байна. 1921 оны анхны төрийн таван яамны нэг нь Сангийн яам бөгөөд тус яамны үндсэн үүрэгт төсөв зохиох, түүнийг хэрэгжүүлэх явдал байсан юм. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заагдсан 2021 оны тэнцвэржүүлсэн орлого, нийт зарлага болон тэнцвэржүүлсэн тэнцлийн хэмжээнд Монгол Улсын 2021 оны төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг бүрэн нийцүүлж хуулийн төслийг боловсруулсан ба төсвийн төслийн үндсэн үзүүлэлтүүд нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудыг бүрэн хангаж байна. Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 11,797.8 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 27.9 хувь, нийт зарлагын хэмжээг 13,951.6 тэрбум төгрөг буюу 30.0 хувь, төсвийн алдагдлыг 2,692.8 тэрбум төгрөгөөр бууруулж, -2,153.7 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний -5.1 хувь байхаар төлөвлөж, төсвийн төслийг боловсруулсан байна. Мөн 2021 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар улсын хэмжээнд нийт 3,763.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,390.9 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 1100 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр баталжээ. (А.Э.ц)

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

(Capital budgeting) Томоохон хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээг хэлнэ. Эдийн засгийг өргөжүүлэх замаар тогтвортой өсөлтийг хангах гол механизмуудын нэг бол дэд бүтэц, боловсрол, эрүүл мэндийн салбарт төсвийн хөрөнгө оруулалт хийх, бүтээгдэхүүнээр хангах, зах зээлийг уналтыг хазаарлах, хувийн хөрөнгө оруулалтын бөөгнөрлийг задлах, дахин хуваарилалтын зорилгод хүрэх нөхцөл бүрэлдэнэ.¹¹² Манай улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын хууль эрхзүйн үндсийг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Татварын багц хууль, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл зэрэг эрхзүйн баримт бичгүүд бүрдүүлж байна. (А.Э)

ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛ *(Budget reform)*

“Budget” нь Францын “bouge (XV зуун)” буюу “савхин цунх, түрийвч” гэсэн үгнээс үндэстэй. Энэ үг нь “төрийн сангийн сайд төсвийн төлөвлөгөөгөө хэтэвчинд хадгалдаг”¹¹³ гэсэн ойлголтоос үүдэлтэй бөгөөд 1733 оноос орчин цагийн санхүүгийн утга илэрхийлдэг болсон байна. Төсвийн

112 ОУВС [2012] -д байгалийн баялаг ихтэй хөгжиж байгаа орнуудын хувьд өгөх бодлогын зөвлөмжийн стандартыг эргэн харах нь зүйтэй гэж санал болгосон. Ийм орнуудад хөрөнгө хомс, дотоодын хөрөнгө оруулалтын ашиг өндөр байх магадлалтай, нооцийг хуваарилах стратеги нь дотоодын хөрөнгө оруулалтын бүтэц их үүрэгтэй. Тийм учраас Чили, Норвеги шиг гадаад хөрөнгийн шууд хадгаламжийг бүрдүүлэх шаардлагагүй байж болох юм.

113 Budget (n.). (n.d.). Retrieved October 28, 2020, from <https://www.etymonline.com/word/budget>

шинэчлэлийн тухай ойлголт нь захиргааны шинэчлэлийн бүрэлдэхүүн хэсгийн нэг юм. Энэ ойлголт түгэн дэлгэрэхэд “transaction cost theory” буюу “ажил үйлчилгээний өртгийн онол” чухал хувь нэмэр оруулсан байдаг. Энэ онолын үзэл санаа нь аливаа ажил үйлчилгээг явуулахад зориулагдсан удирдлагын зохистой бүтэц, үүний дотор бараа, үйлчилгээний үйлдвэрлэл, солилцоог зохион байгуулах шилдэг арга замыг эрэлхийлдэг. Энэ ч утгаараа шийдвэр гаргагчид үйлдвэрлэл, ажил үйлчилгээний нийт өртгийг хамгийн бага байлгахыг хүсдэг. Төсвийн шинэчлэл нь төсвийн зарлагын удирдлагын үйл явц бөгөөд энэ нь үр ашигтай (нэгж бүтээгдэхүүний өртгийг хамгийн бага байлгах), үр нөлөөтэй (тухайн бүтээгдэхүүнээр хүрэх гэсэн үр дүндээ хүрэх) байхыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, төсвийн шинэчлэл нь хамгийн бага зардлаар хамгийн сайн үр дүнд хүрэх тухай юм. Энэ ч утгаараа нь төсвийн сахилга бат (зарцуулалтад тавих хяналт), хөрөнгө нөөцийг бодлогын тэргүүлэх чиглэлд нийцүүлэн хуваарилах (стратегийг баримжаалах), үйл ажиллагааны удирдлагыг сайжруулах үйл явцтай холбогддог. (Т.Т)

ТӨСЛИЙН УДИРДЛАГА (Project management) Төслийн удирдлага гэдэг нь төслийн зорилгод хүрч, амжилттай хэрэгжүүлэхийн тулд тухайн төслийн шаардлагад нийцүүлэн нөөцүүдийг оновчтой төлөвлөх, ажиллагаануудыг зөв зохион байгуулах, хэрэгжүүлэх, хянах төслийн хүрээний бүхий л үйл ажиллагааг хэлнэ. Төслийн шаардлага, төслийн оролцогчдын хүлээлтийг хангахын тулд төслийн зорилго, хугацаа, зардал, чанар, бусад шинж чанаруудын хоорондох оновчтой хослолыг олох шаардлагатай. Төслийн

удирдлага нь нэг талаас удирдлагын онол, нөгөө талаас практик үйл ажиллагаа учир энэ нь шинжлэх ухааны арга, хэрэгсэл, мэдлэг, практик туршлага ур чадварын аль алин дээр суурилдаг¹¹⁴. Төслийн удирдлага нь төслийн тодорхойлох, төлөвлөх, гүйцэтгэх, дуусгах гэсэн дөрвөн үе шатаас бүрдэх бөгөөд хамрах хүрээ, цаг хугацаа, чанар, төсвийн үндсэн хязгаарлалтын хүрээнд хэрэгждэг. (З.А)

ТӨСӨВ (Budget) Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг¹¹⁵ хэлнэ. (А.Э)

ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ (Budgeting process) Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэр нь “төсөв” мөн. Төсвийг төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, холбогдох санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн цогц үйл явцыг төсөв бүрдүүлэх гэнэ. Засгийн газраас Улсын Их Хуралд түүнчлэн бүх шатны Засаг даргаас тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн төсвийн саналыг, “улсын төсөв” гэж Улсын Их Хурлаас баталдаг Монгол Улсын төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн дунд

114 Дорж, Т. (2018). Менежмент, МУИС Пресс хэвлэлийн газар, Улаанбаатар, х. 343.

115 Төсвийн тухай хууль

хугацааны төсөөлөл болон жилийн төсвийн төлөвлөгөөний төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн орлого, зарлагын болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг бэхжүүлэх, төсвийн үйл явцыг бодлогын удирдамжаар хангах, төсвийн холбогдол бүхий үндэслэл тооцоо, тайлбар танилцуулга, заавар журам, илтгэл мэдээлэл бэлтгэх ажлыг төрийн төв байгууллага болох Сангийн яам гүйцэтгэж, тухайн жилийн төсөв боловсруулах үйл явц нь баталсан хугацааг цаглабарын дагуу явагддаг. Төсөв боловсруулахад баримталдаг бодлогын баримт бичгүүдэд Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үндэсний хөтөлбөрүүд орно. (А.Э.ц)

ТӨСӨВЛӨЛТ (Budgeting) Энэ үг нь захиргааны функцийг тодорхойлсон “POSDCORB” гэсэн нэр томьёоны хамгийн сүүлийн “B” буюу “Budgeting” гэх үг юм. Үгийн агуулгад “төсвийн төлөвлөлт, тооцоо, хяналт шалгалтын ажил”-ыг хамаатуулж ойлгодог. Төсөвлөлтийн үндсэн зорилго нь хязгаарлагдмал хэмжээний мөнгөн хөрөнгийг оновчтой хуваарилахад оршдог. Өөрөөр хэлбэл, төсөвлөлт нь засгийн газрын бодлоготой уялдуулан хөрөнгө нөөцийг хуваарилах, зарцуулах үйл ажиллагааг төлөвлөх үйл явц юм. Гүйцэтгэлд чиглэсэн төсөвлөлт нь үйл явцад, хөтөлбөрт чиглэсэн төсөвлөлт нь эцсийн үр дүнд чиглэсэн байдаг. Улсын төсөв нь нэг талаас албан татвараас бүрддэг орлого, нөгөө талаас төрийн өөрийн нь үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилго бүхий зарлагаас бүрддэг. Улсын төсөв гэдгийг “төрийн зорилт, чиг үүргийг

хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор орлого, зарлага ба тэдгээрийн тэнцэл” гэж тодорхойлдог. (Т.Т)

ТӨСӨЛ (Project) Тодорхой зорилгын төлөө тусгайлан бүрдүүлсэн мэргэшсэн багийн хүчээр, өгөгдсөн цаг хугацаанд хязгаарлагдмал нөөцүүдийг ашиглан урьдчилан төлөвлөсөн үр дүнд хүрэх харилцан уялдаа бүхий цогц үйл ажиллагааг төсөл гэнэ. Өргөн утгаараа төслийг тодорхой, урьдчилан тогтоосон шаардлагын дагуу хэмжигдэхүйц үр дүнд хүргэдэг тодорхой, хязгаарлагдмал үйл ажиллагаа гэж тодорхойлдог. Төсөл нь зорилгодоо илүү үр дүнтэй хүрэхийн тулд байгууллага, хувь хүмүүст өөрчлөлтийг хэрэгжүүлэх боломж олгодог бөгөөд хүссэн өөрчлөлтийг зохион байгуулалттай хийхэд тусалдаг. Төслийн нийтлэг дараах шинж чанаруудтай¹¹⁶.

1. Тодорхой зорилготой
2. Эхлэл, төгсгөлийг тодорхойлсон тодорхой хугацаатай
3. Ихэвчлэн хэд хэдэн хэлтэс, мэргэжлийн хүмүүсийн оролцоотой хийгддэг
4. Ерөнхийдөө өвөрмөц, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилготой
5. Цаг хугацаа, зардал, гүйцэтгэлийн тодорхой шаардлагуудтай. (З.А)

ТӨХӨӨРӨМЖИЙН ЗОХИЦОЛDOO (Interoperability) Ялгаатай үйлдлийн систем, техник хангамж дээр ажиллаж байгаа программ хангамжийн системийн мэдээлэл солилцох чадвар. Ихэвчлэн файлын формат, мессежний протоколын ялгаатай байдал, хэрхэн

¹¹⁶ Larson, E. W., & Gray, C. F. (2018). *Project management: the managerial process*. 7th edition. New York: McGraw Hill/Irwin.

хамтран ажиллахыг тодорхойлсон техникийн үзүүлэлтүүдийг дагаж мөрддөг. Төхөөрөмжийн зохицолдоо нь иргэдийн ямар төхөөрөмж (хуучин эвсэл онцлог техник хангамж болон программ хангамж, туслах технологи, гар утасны хайлтын хөтөч гэх мэт) хэрэглэж байгаагаас үл хамааран орон нутаг, бүс нутаг, үндэсний шатны төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцоход иргэд бүрэн хамрагдах боломжийг дэмждэг. (Д.З; Ч.Л нар)

ТУНГАЛАГ БАЙДАЛ (*Transparency*)

“Transparency” гэдэг нь Латины “transparente” (XV зууны эхэн үе) гэсэн үгнээс үндэстэй. Үгийн утга нь “гэрэл нэвт / шууд/ харагдах (show light through)” гэснээс үзвэл “тунгалаг” байдлыг илэрхийлж байна. Монгол хэлний тайлбар тольд тунгалаг байдал нь “хиргүй, булинггаргүй, цэвэр, аливаа юм гэрэл гэгээ нэвт харагдах чанар” гэж тодорхойлжээ. (Гэхдээ манай улсын хувьд “transparency” гэдгийг “ил тод байдал” хэмээн орчуулан хэрэглэх тохиолдол байдаг). Тунгалаг байдал нь авлига үүсэхгүй байх орчинг бүрдүүлж, цаашлаад авлигыг бууруулна гэж үздэг. Өөрөөр хэлбэл, авлига, ёс зүйгүй үйлдэлтэй гэмцэхэд төрийн албаны тунгалаг байдал онцгой ач холбогдолтой байдаг. Төрийн албаны тунгалаг байдлыг өргөжүүлэх үүднээс ЭЗХАХБ-ын гишүүн орнууд засгийн газрын мэдээллийг гурав дахь этгээд авч болох “мэдээллийн эрх чөлөөний” хууль баталсан байдаг. Ихэнх тохиолдолд иргэд тэдний мэдээлэл авах эрх чөлөөг хязгаарлаж байна гэсэн гомдлыг шүүх болон хяналтын байгууллагад тавьдаг. Төрийн албаны тунгалаг байх зарчим нь тухайн улс үндэстний соёлоос хамааралтай байдаг. Ардчилсан засаглалын үндэс нь иргэд, тэднийг

төлөөлж байгаа улс төрчдийн итгэлцэл дээр тогтдог бөгөөд ялангуяа төрийн албаны тунгалаг байдал нь үүний суурь нөхцөл болдог. Тухайлбал, Шведэд “олон нийтийн оролцооны зарчим” нь засгийн газар, орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагаанд хяналт, ажиглалт тавих боломжийг олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд олгосон байдаг. Улс орнууд сайн засаглалын үзэл санааг хэрэгжүүлж эхэлснээр тунгалаг байдлын тухай ойлголт хүчтэй яригдах болсон. Өөрөөр хэлбэл, энэ нь сайн засаглалын гурван тулгуур ойлголт (хариуцлага, тунгалаг байдал, оролцоо)-ын нэг юм. Сайн засаглалын хүрээнд тунгалаг байдлыг мэдээллийн нээлттэй, хүртээмжтэй байдалтай холбон тайлбарладаг. (Т.Т)

ТУРШИЛТЫН СУДАЛГАА (*Pilot study*)

Шинэ бодлого, хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэхээс өмнө үргэлжлэх хугацаа, зардлыг тооцоолох, эрсдэл, тодорхойгүй байдлыг бууруулах зорилгоор урьдчилсан, бага хэмжээний судалгаа хийх нь чухал. Туршилт судалгаа нь бодлого, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэхээс өмнө цаг хугацаа, нөөцийг зарцуулж, улс төрийн эрсдэлтэй байж болзошгүй боловч тухайн бодлого, хөтөлбөртэй холбоотой урьдчилан сэргийлэх боломжтой алдаа, эрсдэлийг илрүүлэх, засаж сайжруулах боломж олгодог хяналт, үнэлгээ хийх чухал алхам юм. Туршилтын төсөл, судалгааг өртөг өндөртэй байж болох ч бодлогын шинэчлэлийг дэмжих зорилгоор ашиглах ёстой. Туршилтын төсөл, судалгаа нь цаг хугацаа, төсөв бага гэх мэт саад тогтор учруулах хүчин зүйлээс хамаарч шинж чанар, цар хүрээгээрээ ялгаатай байх ёстой. Засгийн газрын хүрээнд туршилт, судалгааг ихэвчлэн

дараах хоёр чиглэлээр хийдэг¹¹⁷.

- Нөлөөллийн туршилт, судалгаа нь бодлого, хөтөлбөрийн болзошгүй үр нөлөөг туршиж, анхны үр дүнг нь хэмжих, үнэлэх зорилготой.
- Үйл явцын туршилт, судалгаа нь тухайн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ямар арга нь илүү үр дүнтэй, үр ашигтай болохыг үнэлэх, судлах зорилготой хийгддэг. (З.А)

ТУСГАЙ ГАЗАР [төрийн]- (State special department) БНМАУ-ын төрийн захиргааны төв байгууллагын нэг төрөл. Гол төлөв үнэ, стандарт, цалин гэх мэт салбар хоорондын, улс ардын аж ахуйн нийт байгууллагад хамаатай асуудлыг хариуцсан чиг үүрэгтэй байжээ. Тухайлбал, Улсын төлөвлөгөөний комисс, Үнэ, стандартын улсын хороо, Хөдөлмөр, цалин хөлсний улсын хороо, Шинжлэх ухаан, технологийн улсын хороо гэх мэт тусгай газрууд байжээ. Социализмын үед хэдийгээр онолын хувьд өөр хоорондоо ялгаатай гэж болох боловч төрийн яам, төрийн тусгай газар, олон нийтийн төв байгууллага гэсэн үндсэндээ яамтай дүйх хэмжээний байгууллагууд ажиллаж байлаа. Яамд нь улс ардын аж ахуйн салбаруудыг хариуцан ажилладаг байсан бол төрийн тусгай газрууд нь салбар бүрд түгээмэл байдаг асуудлуудыг зохицуулдаг мэргэшсэн удирдлагын байгууллагууд байв. Харин олон нийтийн байгууллагууд нь иргэдийг нас, хүйс, мэргэжлийн гэх мэт янз бүрийн шинж чанараар нь сайн дурын үндсэн дээр нэгтгэж тэдний эрх ашгийг хамгаалах, социалист байгуулалтад

зоригжуулан идэвхжүүлэх зорилготой байгууллагууд байжээ. (А.Ц)

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ (Special purpose transfers) Засгийн газрын тодорхой “чиг үүргийг санхүүжүүлэх зорилгоор тусгайлан тогтоосон зориулалт, нөхцөл, шаардлагын дагуу аймаг, нийслэлийн төсөвт улсын төсвөөс олгох хөрөнгийг”¹¹⁸ хэлнэ. (А.Э)

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ (Special permission) Тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг тусгай зөвшөөрөл гэнэ.

Эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрөл олгохдоо дараах зарчмыг баримтална:

- Улс орныг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах, нийтийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- Аж ахуй эрхлэх таатай орчныг бүрдүүлэх;
- Ил тод, шуурхай байх ;
- Зөвхөн хуульд заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох (Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл). (Ч.Э)

ТУСЛАХ ТЕХНОЛОГИ (Assistive technology) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өдөр тутмын амьдралаа үргэлжлүүлэхэд нь туслах төхөөрөмж. Технологийн орчинд энэ нэр томъёог ихэвчлэн АТ-ийн нэр томъёо гэж нэрлэдэг бөгөөд хөгжлийн

117 Jowell, R. (2003). *The Role of 'Pilots' in Policy-Making*. London: Government Chief Social Researcher's Office, pp. 9-12.

118 Төсвийн тухай хууль

бэрхшээлтэй хүмүүс компьютерт нэвтрэх программ хангамж эсвэл техник хангамжийн төхөөрөмжийг хэлдэг. Туслах технологи нь орлуулах гар, хулгана, дуу таних программ хангамж, дэлгэцийг томруулах программ хангамж, олон унтраалгатай жойстик, текстээс ярианы харилцааны хэрэгсэл зэрэг төхөөрөмжүүдийг багтааж болно. (Д.З; Ч.Л нар)

ТУСЛАХ ТҮШМЭЛ (*Assistant officer*)

Төрийн захиргааны албан тушаалыг тэргүүн, эрхэлсэн, ахлах, дэс, туслах түшмэлийн албан тушаал хэмээн ангилна. Бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэхүйц мэдээллийг сурвалжлан судалж, задлан шинжилгээ хийж, гүйцэтгэсэн ажлын чанарын талаар хариуцлага хүлээж, нийтлэг үйлчилгээний ажилтнуудын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй албан тушаалыг туслах түшмэлийн албан тушаал гэнэ¹¹⁹. Туслах түшмэлийн албан тушаалд яам, агентлагийн зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарах бөгөөд төрийн захиргааны ТЗ-1, ТЗ-2, ТЗ-3 дугаар зэрэглэлийн албан тушаал юм. (М.А)

ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ (*Lease contract*)

Нэг субъектийн өмчлөлд байгаа хөрөнгийг нөгөө этгээд түрээслэхээр харилцан тохиролцож байгуулсан гэрээ. Түрээсийн гэрээ буюу эрх зүйн баримт бичигт түрээслэгч, түрээслүүлэгчийн эрх, үүрэг, түрээсийн төлбөр болон бусад нөхцөл, талуудын хүлээх хариуцлагыг тусгасан байна. Гэрээний хугацаанд эд хөрөнгийг өмчлөх эрх түрээслүүлэгчид, харин түүнийг ашиглах эрх түрээслэгчид хадгалагдана. Түрээсийн гэрээнд тусгагдах заалтууд нь эдийн засагт энэ төрлийн харилцааг зохицуулахаар

тогтоосон нийтлэг хэм хэмжээ буюу Иргэний хуульд нийцэж байх ёстой. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээслүүлэх харилцааг журмаар зохицуулах ба түрээсийн төлбөр, төлбөрөөс улсын төсөвт төвлөрүүлэх хувь хэмжээг Засгийн газраас баталдаг. (Б.Б)

ТҮШМЭЛ (*Tushmel-clerk, state official*)

Монгол төрт ёсонд түшмэл хүн бол төрийн ноён нуруу хэмээн нэн чухалд үздэг байжээ. Тиймээс түшмэлийн эрдэм чадал ёс зүйд ихээхэн анхаарал тавьж түшмэл хүн 9 эрдэмтэй байх ёстойг сурвалж бичигт онцлон тэмдэглэдэг байсан. Сурвалжуудад эл 9 эрдмийг яг жагсаан бичсэн зүйл хараахан олдоогүй. Хаан хүн 35 эрдэмтэй байж харьяат улсаа хайрлан “хөл хөсөр, гар газарт” байлгах, ноёд ард олны амьжиргааг бодон алба татвар бага авах, түшмэл хүн төрийн өдөр тутмын албыг авлига авалгүй чин шударгаар хаадаг байх ёстой байв. Оюун түлхүүр нэрт шастирт,

Түшмэл хүний есөн эрдмийн дотор
Төвшин сэтгэл нэн эрдэм ...
Түшмэл хүн есөн эрдмийн төгсөвч
Төвшин сэтгэл үгүй болвоос
Хорт чоно мэт жигшигдэх... хэмээжээ.

Түүнчлэн Чингисийн билиг сургаалд “аван идэгч түшмэл төрийн чөтгөр”, Инжаннаши “эрхт сайн түшмэл төрийн эрдэнэ” хэмээн тодорхойлсон байна. Ч.Бат-Очир, Ч.Дэмчигдорж нарын зэрэг бичгийн эрдэмтэд ч зохиолдоо түшмэдийн үүрэг, ач холбогдлын талаар олонтаа бичиж байжээ. Ч.Бат-очир “Улс төрийн засаг дор байгуулсан түшмэл хэмээгч улс төрийн дам нуруу ... түшмэл болсон хүмүүн нэгэнтээ улсын пүнлүүг хүртсэний тулд биеийн амрыг эрж залхууран осолдож үл болохын дээр төрд зүтгэхээр хүчин

¹¹⁹ Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолын хавсралт.

үнэлж худалдсан бие хэмээн мэдвээс зохимой” гэжээ. (А.Ц)

ТҮШМЭЛИЙГ ШАЛГАН БАЙЦААХ НЬ (*Examination of state officials*) Монгол төрийн нэг чухал зарчим бол чадварлаг сайн хүнийг шилэн сонгож төрд зүтгүүлэх явдал юм. Уг ёс наанадаж Чингис хааны үеэс уламжлагдан иржээ. Монгол хаад эрдэм чадал сайтай сайн хүнийг биед ойр байлган шадарлуулж, төрд зүтгүүлэхийг маш чухал хэмээн үздэг байжээ. Энэ талаар Чингисийн билэг, Оюун түлхүүр зэрэг ном сударт маш тодорхой өгүүлсэн байдаг. Богд хаант Монгол Улсын үед энэ ажлыг хуулиар зохицуулсан байна. Монгол Улсын Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичигт түшмэлийг шалган байцаах журмыг тогтоосон байна. Таван яамны дэс түшмэлээс доошлон түшмэдийг гурван жилд нэг удаа байцаан шалгаж дэвшүүлэх, бууруулах, агуулах, байлгахыг тогтоох журамтай байв. Шалгахдаа эрдэм, сахилга, ажил хэрэг, насыг үзүүлэлт болгон харгалздаг байжээ. Буруушаах найман зүйл байсанд ховдог, харгис, зөөлөн, үхээнц, чадалгүй, хичээнгүй үгүй, өвчтэй, долгин хатан, эрдэм дорой зэрэг шинж чанарууд багтдаг байжээ. Дээр дурдсан 4 үзүүлэлтээр шалгарсдыг дэвшүүлдэг, 8 үзүүлэлтээр буруушаагдагсдыг хэлэлцээд ажилд нь хэвээр үлдээх эсэхийг шийдвэрлэдэг байжээ. Шалгарсан хүмүүст тэргүүн, дэс зэрэг олгох үзүүлэлтүүдийг бас хуулиар тодорхойлсон байна. Харин дээрх найман үзүүлэлтээр тааруу хэмээн дүгнэгдсэн хүмүүсийг ажлаас чөлөөлөх, дараагийн шалгалт хүртэл тушаал бууруулах гэх мэт арга хэмжээг авдаг байсан байна. Нас хөгширсөн ч гэсэн тэнхлүүн эрдэм чадал сайтай бол төрд хэвээр хадгалж ажиллуулах нь зүйтэй хэмээн үздэг байжээ. (А.Ц)

ТЭГ СУУРТ ТӨСӨВ (*Zero-based budgeting*)

1977 онд АНУ-ын холбооны засгийн газар тэг суурьт төсөвлөлтийн хэлбэрийг анх нэвтрүүлсэн. Тэг суурьт төсөв гэдэг нь төсвийг жил бүр ихэвчлэн “шинэ хуудаснаас” боловсруулдаг нөөцийг хуваарилах систем юм¹²⁰. Тэг суурьт төсөв нь бүх зардлыг үндэслэлтэй болгож, урьд хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг харгалзахгүйгээр аливаа санхүүжилтийг тооцон төлөвлөх төсвийн төлөвлөлтийн нэг арга. Тэг суурьт төсвийн үйл явц нь ерөнхийдөө засгийн газрын санал болгож буй зардлыг үнэлж, үндэслэлтэй байхыг шаарддаг бөгөөд их хэмжээний санхүүжилтийг тэргүүлэх шинэ чиглэлд хуваарилах шаардлагатай бол тэг суурьт төсвийг ашиглах хандлагатай байдаг. Төсөв бүрийг эхнээс нь “тэг суурь” -аас эхлэн төсөвлөж, байгууллагын үйл ажиллагаа бүрийн хэрэгцээ, зардлыг шинжилж, тухайн үйл ажиллагаа өмнө нь хэчнээн төсөвтэй байсныг үл харгалзан хөрөнгө хуваарилдаг. Энэ арга нь төрөл бүрийн төсөл, хөтөлбөрүүдийн давуу талыг харгалзан харьцуулах, дээд түвшний стратегийн зорилтуудыг тодорхой функционал чиглэлүүдтэй уялдуулж хэрэгжүүлэх боломжийг олгодог.¹²¹ Тэг суурьт төсвийн давуу тал:

- Төлөвлөх, зорилго тодорхойлох, төсөв боловсруулах, шийдвэр гаргах үйл явцыг нэгтгэн төлөвлөлт, төсөвлөлтийг сайжруулахад тусалдаг.
- Тэргүүлэх чиглэлүүдийг тогтоох, зорилтыг нарийвчлан

¹²⁰ Schultz, D. (2004). *Encyclopedia of Public Administration and Public Policy*. New York: Facts on File, pp. 467-468.

¹²¹ Berry-Johnson, J. (2021, May 31). *Zero-Based Budgeting (ZBB)*. Retrieved from Investopedia: <https://www.investopedia.com/terms/z/zbb.asp>

тодорхойлох, тэдгээрт нийцүүлэн төсвийн зарлагыг бууруулах нөхцөлийг бүрдүүлдэг. (З.А)

ТЭГШ БАЙДАЛ (*Equality*) Ардчилсан нийгмийн гишүүдийн эрх, оршин байх, амьдрах нөхцөл байдал эн тэнцүү байх зарчмыг тэгш байдал гэх ба тэгш байдлыг эдийн засгийн (орлого, нөөцийн хуваарилалтын тэгш байдал) ба нийгмийн (анги, жэндэр, арьс өнгө, хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй тэгш байдал) агуулгаар ялгаатай тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, хүн бүр нас, хүйс, угсаа гарал, шашин шүтлэг, итгэл үнэмшил, нийгмийн байр суурь зэргээс үл хамааран өөрийн амьдрал, авьяас чадвараа боломжит түвшинд ашиглах тэгш боломжоор хангагдах явдлыг хэлнэ. Нийгмийн ялгаатай бүлгүүдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр тэдний хэрэгцээнд чиглэсэн бодлого явуулах, бүх бүлгүүдэд шударга хандах үзэл баримтлалыг тусгах хандлага тэгш байдлын талаарх бодлогод нэмэгдэж байна¹²². Төрийн бодлого, үйл ажиллагаа иргэдэд тэгш боломжоор хангах зарчмын дагуу бүхий л иргэдийг хармуулдаг хэдий ч тэгш байдлын зарчим нь хүний үзэл бодлын үр дүн, харьцуулах эсвэл тэнцүүлэх зарим сонирхлыг илэрхийлдэг учир бодит байдалд бүрэн хэрэгждэггүй, тодорхой ялгаатай нөхцөл байдал бий болдог учир харьцангуй ойлголт юм. (Б.Б; Г.Б)

ТЭЙЛОР, ФРИДРИХ УИНСЛОУ (*Taylor, Frederick Winslow, 1856-1915*) Америкийн шинийг санаачлагч, инженер. Шинжлэх ухааны үндэслэлтэй менежментийн онолыг үндэслэгч. Франц, Германд сургуульд сууж, дараа нь Нью Хэмпшир дахь Филлипсийн

Академид суралцжээ. 1874 онд Харвардын их сургуулийг төгссөн боловч нүд нь муудсанаа боловсролоо цаашид үргэлжлүүлсэнгүй. 1878 онд Миввельскийн гангийн үйлдвэрт ажилчнаар оржээ. 1882-1883 онуудад механик цехийн мастераар ажиллахын зэрэгцээ Стивенсийн технологийн институтэд сурч инженер болжээ. 1884 онд ерөнхий инженер болсон үеэсээ хөдөлмөрийн бүтээмжээс хамааралтай ялгаварт хөлсний системийн хэрэглэж эхэлжээ. Хожим Мэн, Висконсен дахь цаасны шахуургын эзэн болж удирдлагын дамжаа хичээллүүлж байжээ. 1906 онд Америкийн механик инженерүүдийн нийгэмлэгийн ерөнхийлөгч болжээ. 1895 оноос хөдөлмөрийг шинжлэх ухаанчаар зохион байгуулах тухай судалгаагаа хийж эхэлжээ. Ажилчны хөдөлмөрийг шинжлэн системчилж, хамгийн оновчтой аргуудыг хэрэглэж болно гэж үзэж байжээ. Мөн тийм аргуудыг ажилчдад заан сургаж болно гэж үзэж байв. Тейлорын үзэл санааг үйлдвэрчний эвлэлүүд, хөрөнгөтнүүд ихэд шүүмжилж байсан байсан боловч орон даяар дэлгэрсэн байна. Тейлорын үзэл санаанаас орчин үеийн техник мэргэжлийн сургалт эх үндэстэй гэж үздэг байна. (А.Ц)

ТЭРГҮҮЛЭН УДИРДАХ (*Headship*)

Албан тушаал, эрх мэдэлд суурилсан албан ёсны удирдагч. Энэ нь зарим талаараа орчин үед хэрэглэж буй менежмент хэмээх ойлголттой төстэй юм. Байгууллагад хашиж буй албан тушаалд суурилан байгууллага дахь ажилтнуудын зан үйлд нөлөөлөх чадамжийг эрх мэдэл гэж үздэг¹²³. Тэргүүлэн удирдах, манлайлах чадвар хоёулаа эрх мэдэл (authority)-д

122 Ц.Давадулам: Засаглалын үзэл баримтлал, нэр томьёоны тайлбар, толь бичиг, Улаанбаатар 2010, х. 40.

123 김규정(1998). 행정학기초이론, 서울, p. 534 (*Ким Гюг Жонг(1998). Төрийн захиргааны ерөнхий онол, Сөүл, х. 534.*)

суурилдаг. Гэхдээ эрх мэдэл юунд суурилж буй болж байгаагаас хамаарч өөр байна. Тэргүүлэн удирдах (headship) нь байгууллагын удирдлага (захирал эсвэл менежер гэх мэт) гэх менежментийн албан ёсны эрх мэдэлд суурилдаг бол манлайлал (leadership) нь албан тушаалаас үл хамааран дагалдагчиддаа нөлөөлөх нөлөөгөөр дамжин хэрэгждэгээрээ ялгаатай¹²⁴. Тэргүүлэн удирдах орон тоог байгууллагаас зориуд бий болгон, албан тушаалын тодорхойлолт, гэрээний үндсэн дээр албан ёсоор зөвшилцөж, хүлээн зөвшөөрсөн байдаг. (Ц,Д)

ТЭРГҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТ (Leading management) Захиргааны уламжлалт загвар тухайн үеийн шаардлага хангахгүй байсан тул 1980-1990 онд хувийн салбарын менежментийн шинэ хандлага улсын ба төрийн захиргааны салбарт нэвтэрснийг Камарк: "Төрийн захиргаанд зарчмын том хувьсгал гарлаа" гэж үзжээ. XX зууны Менежментийн онолын урсгал хоёр үндсэн хэсэгт хуваагддаг. Үүнд: 1. Сонгодог, 2. Орчин үеийн чиглэл. Эхний чиглэлд XIX зууны дунд үеэс 1950 он хүртэл, дараагийн чиглэл нь 1950-иаас одоог хүртэлх хугацааг багтаадаг бол орчин үеийн урсгалын менежментэд тооны ухаанаас хандах урсгал, байгууллагын төлөв байдал, системийн онол, орчин үеийн чиглэл гэсэн хандлагууд орно. Төрийн захиргааны уламжлалт загвар менежментийн загварт байр сууриа тавьсан хэдий ч менежментийн загвар нь маргаантай хэвээр байсаар байна. Менежментийн үндсэн чиг үүрэг ба стратеги: 1. Байгууллагын зорилго,

тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, 2. Зорилгоо биелүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зэрэг багтана. Байгууллагын төлөв байдал гэх урсгал нь хувь хүн, бүлэг, байгууллагын үйл явцыг ойлгосноор ажилтны үр ашиг, бүтээмжийг идэвхжүүлэн удирдах үйл ажиллагаагаар тодорхойлогддог байна. Америкийн судлаач Дуглас Мак Грегорын боловсруулсан Х, Y онол энэ урсгалд зүй ёсоор багтдаг юм. XX зууны эхэн үед удирдлага ба манлайлал нь судалгааны гол объект болсон байна. 1930-50 онд манлайллыг системийн үүднээс маш өргөн хүрээнд авч үзсэн юм. Манлайллын талаарх хамгийн эртний судалгаа нь үр ашигтай удирдагчдын хувийн шинж чанарыг тодорхойлох зорилготой байв. Энэ урсгалыг хувь хүний манлайллын шинж чанарын хандлага буюу суут хүмүүсийн онол ч гэж нэрлэдэг. Манлайллын арга барилын хандлага ёсоор удирдлагын үр ашиг нь удирдагчийн хувийн шинж чанараар биш удирдлага дор /Я.Долгоржав. Төрийн захиргааны В.Вильсоны үечлэл, түүгээр Монгол Улсын төрийн захиргааг авч үзэх нь. Төрийн удирдлага, эрх зүйн онол-практикийн өгүүлүүд. Улаанбаатар 2019./ ажиллагсад хандах арга барилын хэв маягаар тодорхойлогддог билээ. Гэвч хувийн шинж чанар нь удирдлагад ач холбогдолгүй гэсэн үг биш, энэ нь амжилтад хүрэх чухал элемент. Удирдлагын арга барилыг авторитар (захирангуй), ардчилсан, ажилд чиглэсэн, хүнд чиглэсэн, либерал гэж ангилан үзсэн байдаг. Лайкертын систем: Мичиганы Их Сургуулийн Рэжис Лайкерт ба хамтрагчид нь олон орны янз бүрийн байгууллагын хөдөлмөрийн бүтээмжийг системтэй судалснаар дээрх арга барилыг хүн ба ажилд чиглэсэн гэсэн 2 хэлбэр

124 송문석 (2012). 신뢰중심의 조직관리. 서울, 아람기획. (Сүнг Ун Сог (2012). Итгэлд суурилсан байгууллагын удирдлага, Соул, Арим хэвлэлийн газар)

боловсруулжээ. Ажилд чиглэсэн удирдагч нь хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд урамшууллын системийг өргөн ашигладаг юм. Ийм маягийн сонгодог жишээ нь Фредерик У.Тейлорын арга билээ. (А.Э.ц)

ТЭРГҮҮН ТҮШМЭЛ (*Senior principal officer*) Төрийн захиргааны албан тушаалыг тэргүүн, эрхэлсэн, ахлах, дэс, туслах түшмэлийн албан тушаал хэмээн ангилна. Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагын ажлын гүйцэтгэл, үр дүнг төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө хариуцах ба байгууллагын төсөв болон төрийн тусгай сангийн ашиглалтын талаар хариуцлага хүлээдэг төрийн захиргааны удирдах албан тушаал юм¹²⁵. Тэргүүн түшмэлийн албан тушаалд яамны Төрийн нарийн бичгийн дарга, түүнтэй адилтгах бусад албан тушаал хамаарна. Тэргүүн түшмэлийн ангилалд төрийн албанд 16-аас доошгүй жил, үүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 8-аас доошгүй жил ажилласан, тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн албан хаагч томилогдоно¹²⁶. (М.А)

125 Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоол.

126 Төрийн албаны тухай хуулийн 23.2.1 дэх заалт.

У

УАЙТ, ЛЕОНАРД ДЮПИ (*White, Leonard Dupee, 1991-1958*) АНУ-ын нийтийн захиргааны салбарт мэргэшсэн эдийн засагч. Дармоузын их сургуулийг төгсөж, бакалавр, улмаар магистр болсон. 1921 онд Чикагогийн их сургуульд докторын зэрэг хамгаалсан. АНУ-ын төрийн албаны зөвлөл, Статистикийн төв товчоонд ажиллаж байжээ. Америкийн Нийтийн захиргааны нийгэмлэгийн 1940-1943 онд гарч байсан Public Administration Review сэтгүүлийг үндэслэгчдийн нэг аж. Нийтийн захиргааны чиглэлээр олон бүтээл (The Origin of Utility Commissions in Massachusetts 1921; Conditions of Municipal Employment in Chicago: A Study in Morale, 1925; Introduction to the Study of Public Administration 1926, The Frontiers of Public Administration, 2 vols., /with John Merriman Gaus and Marshall Edward Dimock/1936; Defense and War Administration, 1939–1942. 1942; The Federalists: A Study in Administrative History 1789–1801, 1948; The Jeffersonians: A Study in Administrative History 1801–1829 1951; The Jacksonians: A Study in Administrative History 1829–1861. 1954; The Republican Era, 1869–1901: A Study in Administrative History. 1958; Leonard D.) туурвижээ. Уайт бодлого гаргах болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны харилцан холбоо, нөлөөллийн талаар бичихдээ эдгээр

нь огт салгуу биш бөгөөд тогтвортой ажилладаг мэргэжилтнүүдийн бүлэг буюу захиргааны ажилтнууд жинхэнэ бодлого гаргахад зөвлөгөө өгч чадна хэмээн үзэж байжээ. (А.Ц)

УАЛДО, КЛИФФОРД ДУАЙТ (*Waldo, Clifford Dwight, 1913-2000*) Америкийн улс төр судлаач, орчин үеийн нийтийн захиргааны нэрт онолч. Небраскагийн их сургуулийг дүүргэж Ялегийн их сургуульд докторын зэрэг хамгаалжээ. Калифорнийн их сургууль, Сиракусын их сургуульд багшилж байжээ. Түүний “Захиргаат төр” (Administrative State) сэдэвтэй докторын диссертаци нь орчин үеийн нийтийн захиргааны онолын сонгодог зохиолын нэг болсон байна. Тэр диссертацидаа тэр үед давамгайлж байсан захиргааны шинжлэх ухаан бол нам бус, үнэлэмжгүй (administration as a value-free, non-partisan social science that promised to make government more efficient and effective), төрийн ажлыг илүү үр нөлөөтэй, үр ашигтай болгоход туслах ёстой нийгмийн шинжлэх ухаан мөн гэсэн үзлийг шүүмжилсэн байна. Тэрбээр энэ ухаан нь улс төрийн онол бөгөөд алдаа дутагдлыг илрүүлэн боломжийг хайж, шүүмжлэлтэй хандаж, дүгнэлт гаргахаас илүү санаа өгөх ёстой хэмээн үзсэн байна. Үр ашиг гэдэг бол үнэлэмж мөн учраас нийтийн захиргааны ухаан бол үнэлэмжгүй гэж

болохгүй, тиймээс ардчилал гэх мэт бусад үнэлэмжтэй зөрчилдөж болно гэдгийг анхааруулсан байна. Тэрбээр олон бүтээл туурвиснаас заримыг нь (The Administrative State: a Study of the Political Theory of American Public Administration 1948; The study of public administration 1955; Perspectives on administration, 1956; The novelist on organization & administration; an inquiry into the relationship between two worlds, 1968; Ideas and Issues in Public Administration. 1953; Comparative Public Administration – Prologue Problems and Promise; The Enterprise of Public Administration; Temporal Dimensions of Development Administration. 1970 – editor) онцлон үздэг байна. (Захиргааг төр-ийг үз) (А.Ц)

УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ (Managing)

Албан болон албан бус манлайлал, удирдлагын хэрэгслийг ашиглах байгууллага, бүлэг, түүний үйл ажиллагааг чиглүүлэх, зааварлах, зорилгод хүрэхэд чиглэсэн ухамсарт үйл ажиллагаа юм. “Зохион байгуулалт” нь үйл ажиллагаатай тайлбар, утга, хэрэглээний хувьд ижил төстэй боловч “удирдах” гэсэн дээрээс доош чиглэсэн шууд хамаарлын нөлөөний утгыг агуулдагаараа ялгаатай. Энэ нь нэгдсэн удирдлагад оруулах, тодорхой чиглэл, үүргүүд хоорондын уялдаа холбоог хангах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөх, тодорхой арга зүйгээр чиглүүлэх, туршлага мэдлэг суурилсан удирдлагын үйл ажиллагаа юм. Харин зохион байгуулалтыг заавал удирдлагаас хэрэгжүүлэх шаардлагагүй бөгөөд систем дотроо бүтэцлэгдэж, зөвшилцлийн үндсэн дээр зохицуулалт хийгдэж болно. Байгууллага үйл ажиллагаагаа төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, эргэх холбоог хангах байдлаар удирдан зохион байгуулна. Ингэснээр байгууллагын үйл ажиллагаа үр дүн, үр ашгийг чиглэгдэнэ. (Г.Б)

УДИРДАН ЧИГЛҮҮЛЭХ (Directing)

Энэ үг нь захиргааны функцийг тодорхойлсон “POSDCORB” гэсэн товчлолын “D” буюу Directing гэх үг юм. Үйл үгийн үндэс нь “direct” буюу “удирдах/чиглүүлэх” гэсэн утгыг илэрхийлдэг. Үгийн агуулга нь “шийдвэр гаргах, тэдгээрийг бодлого, арга ажиллагаанд хэвшүүлэх зэрэг байгууллагын өмнө тулгарч байгаа зорилтуудыг шийдвэрлэхтэй холбоотой удирдах бүх ажил”-ыг багтаасан байдаг. Төрийн байгууллагын удирдах ажилтан нь албан ёсны эрх мэдэлд тулгуурлан байгууллагын зорилгыг хангахын тулд хамтын олныг залж, чиглүүлэн удирддаг. Удирдан чиглүүлэх үйл ажиллагааны гол үүрэг нь байгууллагыг дээд зэргийн зохион байгуулалттай болгох, хамт олныг нэгтгэх, тэднийг үүргээ биелүүлэх боломжоор хангах, бүлгийн зарчмаар ажиллах зэргээр байгууллагын зорилгынхоо төлөө нэг хүн шиг чармайлт гаргадаг болгох явдал юм. Товчхондоо, удирдан чиглүүлэх гэдэг нь бусдыг жолоодон залж явах үйл ажиллагаатай холбоотой. (Т.Т)

УДИРДЛАГА (Management)

Удирдахуй буюу удирдах арга, урлаг нь аливаа зүйлийг (бизнес гэх мэт) удирдан зохион байгуулах эсвэл хянах, мөн зорилгоо биелүүлэх арга хэрэгслийг зохистой ашиглах гэж тайлбарлана. Мөн аж ахуйн нэгжийг удирдаж, удирдан чиглүүлдэг хүмүүсийн хамтын байгууллага юм. Захиргаа, төлбөр, зан байдал, хяналт, удирдамж, засаглал, засгийн газар, харьцах, төлөвлөгөө, үйл ажиллагаа, хяналт, ерөнхийлөгчийн засаглал, зохицуулалт, ажиллуулах, удирдан зохион байгуулах, ахлах удирдлага, ахлах удирдлага, хяналт зэрэг нь ижил утгатай. Захиргааны

1 Нигроу, Ф.А., Нигроу, Л.Ж. (1998). Орчин үеийн төрийн удирдлага. Улаанбаатар. х. 5.

шинжлэх ухаанд хувийн салбараас орж ирсэн ойлголт бөгөөд 1950-1970 онд өрнөдийн орнуудад ихээхэн бүтээн байгуулалт өрнөж, нийгэм эдийн засгийн хөгжлийн оргил үедээ хүрсэн ч орц, зардал ихсэж, байгалийн баялгийн хомстлоос хэмнэлтийн горимд шилжих, ажлыг зөв зохион байгуулах шаардлага өссөнөөр төрийн захиргаанд хувийн салбарын менежментийн арга барилыг түлхүү хэрэглэсэн нь тодорхой амжилт үзүүлсэн байна. 1980-аад онуудад Их Британи, Канад, Шинэ Зеланд, Австрали зэрэг орнуудын шинэ засгийн газрын улс төрийн удирдагчдаас шинэчлэлийн бодлого хэрэгжүүлсэн нь улсын салбарт эргэлт үзүүлсэн байна. Эдийн засгаа босгохын тулд өрсөлдөх чадвар, менежментийг сайжруулах зайлшгүй шаардлага байв. Энэ шинэчлэл нь улсын салбарт менежментийн шинэ элемент бий болгох, төрийн салбарыг өөрчлөх, төр засгаас нийгэмтэй харилцах харилцаанд шинэчлэл хийхэд чиглэж байлаа. (А.Э.ц)

УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ (*Management information system*)

Байгууллагын өгөгдлийг цуглуулах, хадгалах, боловсруулах, шинжлэх, мэдээлэл болгон хөрвүүлэх болон тайлан гаргах зорилготой мэдээллийн систем. Байгууллагын удирдлагын мэдээллийн системийг судалгаанд суурилсан оновчтой шийдвэр гаргахад туслах үндсэн зорилгоор бүтээдэг. Энэхүү системийг бодлогын түвшинд шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашигласнаар тухайн шийдвэрийн хэрэгжилтэд алдаа гарахгүй, үр нөлөө нь өндөр байх нөхцөл бүрдэнэ. Удирдлагын мэдээллийн системийг ашиглах үндсэн зорилго нь үр ашгийг нэмэгдүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх, инновац нэвтрүүлэх байдаг. Тэрхүү зорилгын

хүрээнд тухайн байгууллагын удирдлага богино хугацаанд зөв цагтаа, зөв мэдээлэл дээр үндэслэн шийдвэр гаргах боломжтой байх явдал юм. Өөрөөр хэлбэл бусад мэдээллийн системүүдээс ялгарах онцлог нь аливаа байгууллагын бүх түвшний удирдлагын ашиглах мэдээллийн систем юм. Удирдлагын мэдээллийн системийг ашиглах нь дараах давуу талыг бий болгодог

- Байгууллагын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг олгодог. Тухайлбал өөрсдийн бүтээгдэхүүний нэмүү өртгийг нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт болон инновац нэвтрүүлэх шаардлагатай эсэх шийдвэрийг бүх түвшний удирдлагад гаргахад тусалдаг;
- Байгууллага өөрийн үйл ажиллагааны үзүүлэлтээ харж, давуу болон сул талаа тайлан мэдээнээс дүгнэх боломжтой болно;
- Байгууллагын үйл ажиллагааныхаа ерөнхий дүр төрх, чиг хандлагыг харах боломжтой болдог;
- Шийдвэр гаргалтын хурдыг нэмдэг;
- Өрсөлдөөний давуу байдлыг бий болгодог;

Харин сул тал нь ашиглаж байгаа мэдээлэл нь техник хангамж болон программ хангамжаас хамаардаг. (Д.З; Ч.Л нар)

УИЛЛОУБИ, УИЛЪЯМ ФРАНКЛИН (*Willoughby, William Franklin, 1867-1960*) 1885 онд Жон Хопкинсийн их сургуулийг төгсжээ. АНУ-ын төрийн олон байгууллагад алба хааж байжээ. Түүнчлэн Принцетоны их сургуулийн профессор, Төрийн судалгааны институтын захирал зэрэг ажил хийж

байжээ. 1931-1932 онд Америкийн Улс төрийн шинжлэх ухааны ассоциацийн ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байжээ. Судалгааныхаа сэдвийн дагуу хэд хэдэн онцлог бүтээл (The Government of Modern States, 1919; Government Organization in War Time and After: A Survey of the Federal Civil Agencies Created for the Prosecution of the War, 1919; The National Budget System, With Suggestions for Its Improvement, 1927; Financial Condition and Operations of the National Government 1921-1930, 1931; The Movement for Budgetary Reform in the States, 1918) туурвисан байна. Уиллоби төрийн эрх мэдлийн салбар нь гурав биш, хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх, сонгогчдын, болон захиргааны гэсэн таван салбартай гэсэн санал дэвшүүлж, үндэслэгээ гаргаж байжээ. Тэрбээр хууль тогтоох буюу бодлого гаргах, гүйцэтгэх эрх мэдлийн холбоо харилцаа зөвхөн нэг нь хууль тогтоодог, нөгөө нь түүнийг хэрэгжүүлдэг гэдгээс илүү нарийн, олон талтай гэж үзэж байжээ. Түүнчлэн гүйцэтгэх засгийн тэргүүн захиргааны бүхий л системийг нэгтгэн зангидаж, аль болохоор үр ашигтай ажиллуулах ёстой гэсэн байр суурийг баримталж байжээ. (А.Ц)

УЛАМЖЛАЛТ ЭРХ МЭДЭЛ (*Traditional authority*)

Удирдахуйн зарчимд энэ эрх мэдэл нь уламжлагдан мөрдөгдөж ирсэн дэг жаяг, журамд үндэслэгддэг. Тухайлбал, олон зуун жилийн өмнөөс улбаатай шашин, соёлын тогтолцоо тэдгээрийн үнэлэмжийг баримжаалсан, зан заншил, ёс суртахууны хэм хэмжээнд суурилсан дэг журам аль ч улс орны удирдлагын хэв шинжийг тодорхойлж ирсэн байдаг. М.Вебер “уламжлалт эрх мэдлийн мөн чанар нь эрх мэдлийг хэрэгжүүлэгчид нь хууль эрх зүйд бус уламжлалд суурилдаг бол албан хаагчид нь эрх мэдэлтнүүдийн

ойрын хүрээллээс бүрддэг” хэмээн дэг жаягт үндэслэн тодорхойлжээ. Улс төрийн социологи нь эрх мэдлийн тухай Вебер тушаал, захирагдах байдалд тулгуурласан эрх мэдлийг “ноёрхол” гэж үзээд харизм, рационал буюу хууль ёсны эрх мэдэл, уламжлалт гэсэн 3 хэв маягийг ангилан аливаа ноёрхлын үндсэн асуудал нь легитимт шинж буюу удирдуулах, захирагдахыг ард иргэд хүлээн зөвшөөрсөн байх явдал юм гэж үзжээ. Орчин үед удирдагчдын уламжлалт ноёрхох хэв хадгалах, мөн хувийн амьдралын хангамжийн тогтолцоог хязгаарлах журмыг хатуу чанд хэрэгжүүлж байгаа ч олон орон сууц эзэмших, стандартаас хэтэрсэн буюу хэд хэдэн албан тасалгаа эзэгнэх, албаны унаа хэрэглэх, журам зөрчих, дүрэм журмаас гадуур нүсэр хамгаалалттай байх, хэт үнэтэй зүйлс хэрэглэх болон хэр хэмжээнээс хэтэрсэн эрх мэдэл эдлэх явдал мэр сэр байсаар байна. Удирдлагын төрөл садан, хамаатан бизнес эрхлэх, хариуцлагатай албан тушаал хаших болон нийтийн ба төрийн албанд ажиллах, гадаадад оршин суух зэрэг холбогдох бүх дүрэм журмыг боловсонгуй болгон тууштай хэрэгжүүлж, удирдлагын албан тушаалын эрх мэдэл, нэр нөлөөгөө ашиглаж төрөл садан болон онцгой харилцаатай хүнд ашиг хонжоо олгохоос урьдчилан сэргийлж байгаа ч тусгай эрх эдлэх үзэл бодол, арга барил оршооор байгаа нь уламжлалт эрх мэдлийн жишээ байсаар байгааг харуулсаар байна. (А.Э.ц)

УЛС (*State*) Монгол хэлний улс гэдэг үгийг англиар (state), герман хэлэнд (staat), франц хэлэнд “etat” оросоор (государство) гэх мэтээр хэрэглэдэг. Улс нь “status” буюу нөхцөл байдал, тогтворт байдлыг хангах арга зам, хэв маяг хэмээх латин үгнээс гаралтай.

XIII зууны үед хамгийн анх “state” гэсэн үгийг хэрэглэж эхэлсэн гэж үзжээ.² Харин өнөөгийн агуулгаараа XVII зууны дунд үеэс хэрэглэгдэж эхэлсэн байна³.

“Улс” гэдэг ойлголт нь нийгмийн олон талт үзэгдэл тул түүний агуулгыг илэрхийлэх ‘улс орон, газар нутаг, үндэстэн, тусгаар тогтнол’ гэсэн түлхүүр үгүүдтэй хамт хэрэглэгддэг. Эртний Грек, Ромын хот улсуудад улсын тухай ойлголтод нутаг дэвсгэрээс илүү түүн дээр оршин амьдарч буй хүмүүс, ард иргэдийг илүүд авч үздэг байжээ. Ийнхүү улсын үүсэл хөгжлийн явцад түүнийг олон янзаар тодорхойлж байсан ч анхдагч утга санаа нь төдийлөн алдагдаагүй байна. Улс гэдэг бол хамгийн ерөнхий агуулгаараа тодорхой газар нутагтай, улс төрийн удирдлага, зохион байгуулалт бүхий бүлэг хүмүүсийн хууль ёсны нэгдэл бүхий улс орон бол явцуу утгаараа улс орныг удирдах байгууллагатай дүйцэн илэрхийлэгддэг байна. Мөн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх институтийн удирдлага дор хэрэгжих төрийн захиргаа, хууль тогтоох, батлан хамгаалах, цагдан сэргийлэх улс төрийн эрх мэдлийг бүхэлд нь багтаасан ойлголт юм.

Орчин үед улсыг тодорхойлохдоо: Хүн ам, хил хязгаар, газар нутаг, төрийн байгуулал, эрх зүйн тогтолцоо, үндэстний ижилсэл, соёлын онцлог зэргээс бүрдсэн цогц ойлголт гэж үзжээ⁴. Ийнхүү улсыг олон талаас нь тодорхойлох хандлагууд байх боловч түүнийг судлах онол, үзэл баримтлалын объектив, субъектив ангиллын талаар

мэдэх хэрэгтэй (Германы улс төр судлаач, эрх зүйч Георг Еллинек⁵). Үүнд:

Объектив арга: Улсыг шууд хүргэн мэдрэх гадаад дүр төрх, үзэгдэл, үйл явдал, биет зүйл талаас нь судалдаг арга юм. Энэхүү аргын хүрээнд “Улс бол факт”, “Улс-төлөв байдал”, “Улс-ард түмэн”, “Улс-эрх мэдэл, ард түмэн” гэсэн онолууд үүссэн.

Субъектив арга: Улсыг биет зүйл болох талаас нь бус, харин хүний дотоод ертөнц, сэтгэл зүйн үйлдлийн тусламжтайгаар тодорхойлдог арга юм. Энэ аргад тулгуурлан “Улс-оюун ухаан, ёс суртахууны организм мөн”, “Улс-хамт олон эвсэл холбооны нэгдэл мөн” гэсэн онолын үзэл баримтлалууд үүссэн байна.

Улсын зорилго бол олон нийтийн эрх ашигт үйлчлэх бөгөөд зөвхөн нэг хэрэглэгч, харилцагч руу чиглэсэн захиргааны үйлчилгээ үзүүлдэггүй. Аливаа улсын нэг гол атрибут нь төр юм. Төрийн байгууллага нь төрийн албан хаагчдаас бүрдэж, тэдний үйл ажиллагаагаар зорилго, зорилтоо хэрэгжүүлдэг⁶. Орчин үеийн нийгмийн хөгжлийн шинэ хандлага, хурдацтай өөрчлөлтүүд нь төрийг илүү уян хатан ажиллах, хэвшмэл ойлголтоосоо салж ухаалаг, өрсөлдөөнт, бизнес овсгоотой үйлчилгээ үзүүлэх, түншлэлийн зарчмаар төрийн үйлчилгээг хүргэх зэрэг шинэчлэлүүд тулгарч байна. Түүнчлэн орчин үеийн төрийн байгууллагуудыг оролтоос илүү үр дүнд төвлөрч гүйцэтгэлийг хэмждэг, дүрэм журмаас илүү зорилго, эрхэм зорилгодоо хөтлөгддөг болохыг шаардаж байна. Мөн хүмүүсийг иргэн

2 “State.” *Merriam-Webster.com Dictionary*, Merriam-Webster, <https://www.merriam-webster.com/dictionary/state>.

3 <https://dictionary.cambridge.org/dictionary/english/state>.

4 Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг: Улаанбаатар, 2020. х. 541.

5 Kelly, D. (2004). Revisiting the Rights of Man: Georg Jellinek on Rights and the State. *Law and History Review*, 22(3), 493.

6 Нийтийн удирдлагын үндэс. МУИС. Улаанбаатар, 2018. х. 509.

гэж тодорхойлохоос илүү татвар төлөгч, сэтгэл ханамж авах эрхтэй хэрэглэгч, үйлчлүүлэгч гэж томьёолох, төрийн ажил хэргийг асуудал үүсэхээс өмнө урьдчилан сэргийлдэг арга барил руу чиглүүлэх, төрийн удирдлагыг хамтын оролцоот хэлбэрт шилжүүлэх замаар эрх мэдлийн төвлөрлийг сааруулах зэрэг шинэ парадигмүүд төрийн удирдлагад нэвтэрч байна. Иймд “Төр зөвхөн үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй биш, харин үйлчилгээ хүрсэн гэдгийг мэдэж байх ёстой” шинэ хандлага хэрэгжиж байна. Төр нь энэ утгаараа шүтэж бишрэх зүйл ерөөс биш бөгөөд харин иргэдийн аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалагч, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо юм. (Я.Т)

УЛС ТӨР (Politics) “Улс төр” хэмээх нэр томьёо нь эртний грек хэлний “*politika*” (төрийн, нийгмийн үйл хэрэг) гэсэн үгнээс гаралтай. Улс төр хэмээх ойлголт олон янзын утгыг илэрхийлдэг. Улс төр нь эрдэмтэн судлаачдын хувьд судалгааны нэгэн ухаан, өөр хэн нэгний хувьд өдөр тутмын үйл хэрэг, мэргэжил нь болдог. Улс төр нь үйл ажиллагааны шинж чанартай бөгөөд тэрээр нийгмийн томоохон анги, давхраа, бүлгүүдийн эдийн засаг, нийгэм, улс төрийн язгуур эрх ашиг, хүсэл зоригийг улс төрийн засаглалаар дамжуулж хамгаалах, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа мөн гэж ойлгож болно. Улс төрийн бүтэц нь хэлбэр, агуулга, үйл явцад хуваагддаг. Улс төрийн хэлбэр нь түүний зохион байгуулалтын бүтэц (төр, улс төрийн нам) мөн түүнчлэн уян хатан, тогтвортой байдлыг бий болгох, хүмүүсийн улс төрийн үйл байдлыг зохицуулах боломж олгодог хэм хэмжээ, хуулиудаас тогтоно. Улс төрийн агуулга нь түүний зорилго, үнэт зүйлс, шийдэж байгаа асуудлууд, улс төрийн шийдвэр гаргах механизм,

сэдэлд тусгалаа олдог байна. Улс төрийн үйл явцад улс төрийн үйл ажиллагааны олон субъект, тэдгээрийн мөргөлдөөнт шинж, янз бүрийн нийгмийн бүлгүүд, байгууллага, хувь хүмүүсийн харилцаа илэрч тусгалаа олдог. Захиргааны ухаанд Вудро Вилсон улс төр - захиргааны дихотомид гэсэн онолын ойлголтыг боловсруулан оруулсан байдаг. Тэрээр улс төр, захиргаа хоёрыг салах ёстой гэж үзэж байв. Тэрээр “Захиргааны салбар бол ажил хэргийн салбар юм. Улс төрийн өрсөлдөөн, тэмцлээс салангид байна... Захиргаа нь улс төрийн хүрээний гадна оршино. Захиргааны асуудлууд нь улс төрийн асуудлууд биш юм. Хэдийгээр улс төр захиргаанд үүрэг даалгавар өгдөг боловч, төрийн байгууллагуудыг овжноор ашиглаж зөвхөн учиргүй”⁷ гэж хэлсэн байдаг. Түүний энэхүү хэлсэн үгнүүд нь хожим захиргааны ухаан дахь улс төр, захиргааны асуудлуудын судалгааны эх үндэс, маргаан хэлэлцүүлгийн сэдэв болсон юм. (Ж.Ж)

УЛС ТӨР ДЭХ ЖЕНДЭР (Gender in politics) 1970-аад оны эхэн үеэс нийгмийн шинжлэх ухаанд жендэр хэмээх ойлголтыг түгээмэл хэрэглэх болсон. Анн Оэклэй “*Sex, Gender and Society*” номондоо анх удаа жендэрийг нийгмийн ойлголт талаас нь судалж, өрнөдийн нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай байр суурь, эмэгтэйчүүдийн нийгмийн дүр, үүргийн талаар тодорхойлж бичсэн билээ. Жендэр бол түүхэн үйл явцад хувьсах шинжтэй судлагдахуун бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн биологийн ялгаанаас улбаалан соёл, түүхийн хэлхээсэнд тодорхойлогдож буй нийгмийн ойлголт юм. Жендэрийн

⁷ Wilson, W., 1887, *The Study of Administration*. Political Science Quarterly, Reprinted in 1997 in *Classics of Public Administration*, 2d ed. Shafritz, J. and Hyde, A., Chicago. Dorsey Press

дүн шинжилгээний аргууд нь эрэгтэй эмэгтэй хүйсийн тэгш эрх, тэгш байдлын үзэл баримтлалыг эдийн засаг, улс төр, соёл, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа зэрэг нийгмийн бүхий л салбарт хэрэглэгдэж, ардчилсан систем болон улс орны хөгжлийн үзүүлэлтийн шалгуур үзүүлэлт болдог. Улс төрийн харилцаанд жендэрийн асуудал нь улс төрийн сонгох, сонгогдох эрхтэй холбоотой бөгөөд улс төрийн эрх мэдэл, шийдвэр гаргах түвшинд эрэгтэй, эмэгтэй хүйсийн ялгаатай оролцоо, боломж, хязгаарлалт, хамтын түншлэлийн асуудлыг хөндөн судалдаг. Өдгөө жендэрт суурилсан судалгаа шинжилгээ нь төрийн захиргаа, удирдлагын хүрээнд ч хэрэгжиж байна. Тухайлбал, төрийн албаны хүний нөөцийн бүрдүүлэлтийг жендэрийн мэдрэмжтэй хэрэгжүүлэх үүднээс төрийн захиргааны байгууллагуудын бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын түвшний чухал үзүүлэлтээр тооцох болсон. Монгол Улсын хувьд нийгэм, улс төрийн харилцаанд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах төрийн бодлогыг 1924 оны анхны Үндсэн хуулиас эхлэн одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Үндсэн хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар эрх зүйн орчны үндэс бүрэлдэж, хэрэгжиж байна. (Я.Т)

УЛС ТӨРИЙН АМЛАЛТ (*Political commitment*) Улс төрийн амлалт гэдэг нь улс төрч, төр засаг, олон улсын байгууллагын зүгээс тодорхой асуудлын хүрээнд ямар нэгэн зорилгод хүрэхийн тулд үүрэг хүлээх, амлаж оролцох, ямар нэгэн шийдвэр гаргах явдал юм. Улс төрийн амлалт нь тодорхой стратегийн үйл ажиллагааны хүрээнд хийгдэх цаг хугацаа шаардсан үйл ажиллагаа юм. Тухайлбал, НҮБ хүнс тэжээлийн дутагдлаас 2025

он гэхэд гарч болох бүх төрлийн тэжээлийн дутагдлын асуудлыг шийдвэрлэх амлалтыг “Хүнс тэжээлийн талаар авах арван жилийн арга хэмжээ (2016-2025)” хөтөлбөрт өгсөн байдаг. АНУ-ын 45 дахь Ерөнхийлөгч Доналд Трамп Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлын үеэр хэд хэдэн онцлох амлалтуудыг өгч байсан. Түүний улс орондоо ашиггүй гадаад худалдааны гэрээнээс таггалзах, хууль бус цагаачдын эсрэг арга хэмжээ авах зэрэг улс төрийн амлалтууд нь амжилттай биелсэн. Ямар нэгэн амлалтад хүрэхийн тулд холбогдох бодлогын баримт бичгүүдийг баталж, оролцогч талуудын идэвх чармайлтыг нэмэгдүүлэх, боломжит нөөцийг зөв хуваарилах, удирдлага, зохион байгуулалтаар хангах зэрэг ажлууд хийгдэнэ. Улс төрийн амлалтыг улс төрчид, нэр дэвшигчид, улс орны төрийн тэргүүнүүд өгөх нь түгээмэл байдаг. Амлалт нь авлигатай тэмцэх, эдийн засгийн хямралаас гарах, төрийн албанд шинэчлэл хийх, ямар нэгэн тулгамдсан асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэхтэй холбоотой байж болно. (Ж.Ж)

УЛС ТӨРИЙН БОДЛОГО (*Political policy*) Францын улс төр судлаач Ф.Бро “Улс төр бол зорилт тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргаж, арга хэмжээ авч байдаг улс төрийн бодлого юм” гэжээ. Мөн Бисмаркийн “Улс төр бол эрх мэдлийг хэрэгжүүлэх урлаг” эсвэл М.Веберийн “Засаглалд оролцох тэмүүлэл, бүлэг хүмүүсийн хоорондын засаглал хуваарилалтад нөлөө үзүүлэх явдал” зэрэг олон тодорхойлолтуудын нийтлэг агуулгын хүрээнд улс төрийн бодлогын үндэслэл оршино.

Эрх мэдлийг хэрэгжүүлэх нарийн эдрээтэй тогтолцоог бүрдүүлж байгаа талуудын эрх үүрэг, өөр хоорондын

харилцаа нь улс төрийн хамрах хүрээг тодорхойлно. Тухайлбал, парламент, засгийн газар, ерөнхийлөгч, улс төрийн нам, улс төрийн манлайлагчид, сонгогчид, сонгуулийн тогтолцоо зэрэг нь улс төрийн хамрах хүрээг тодорхойлох гол үзүүлэлтүүд нь юм. Гэтэл нөгөө талаар тухайн улсад улс төрийн ямар дэглэм, засаглалын хэлбэр тохиромжтой болохыг тодорхойлох шаардлагатай бол хүн амын бүтэц, соёл, зан заншил, төрт ёсны уламжлал, хөрш орнуудын байдал гэх мэт олон талт харилцааг судлах, тодорхойлох хэрэгцээ урган гардаг нь улс төрийн хамрах хүрээг нарийн ээдрээтэй болгодог. Иймд энэ бүгдийг харгалзан эрх мэдлийг хэрэгжүүлэх улс төрийн институтүүдийн харилцааг зохицуулах нь улс төрийн бодлогын үндэслэл болох юм. Улс төрийн бодлогыг томьёолох нь орчин үеийн аль ч төр улс нийгмийн амьдралын улс төрийн үйл явцын гол үзэгдэл юм. Иймд улс төрийн институтүүдийн гол үүрэг нь улс орны болоод орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх нийгэм-эдийн засаг, засаглалын бодлогыг тодорхойлох явдал байдаг. Тухайлбал, уул уурхайн салбарын өсөлт ДНБ, улсын төсвийн дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа улс тухайн салбарт гаднын хөрөнгө оруулалтыг татах, байгаль орчны сөрөг нөлөөг бууруулах, бүс нутгийн хөгжлийг дэмжих, дэд бүтэц бий болгох гэх мэт нийгэм-эдийн засгийн шинж чанартай бодлого тодорхойлж хэрэгжүүлэх шаардлага тулгардаг. Гаднын хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай, тогтвортой орчин бүрдүүлэхийн зэрэгцээ байгаль орчинд сөрөг нөлөө багатай уул уурхайн технологи нэвтрүүлж, бүс нутгийн хөгжлийг дэмжсэн бүтээн байгуулалт хийх, харилцан ашигтай бодлого тодорхойлж чадах эсэх нь улс төрийн бодлогоор илэрхийлэгдэх боломжтой

юм. Улс төрийн бодлогыг томьёолоход нийгэм, улс төр, эдийн засаг, оюун санааны болоод хувь хүний зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг боловч дараах дөрвөн гол хүчин зүйлийг нийтлэг авч үздэг. Үүнд:

- Объектив болон субъектив хүчин зүйлс
- Үзэл баримтлалын хүчин зүйлс
- Хугацааны хүчин зүйлс
- Нийгмийн хөгжлийн хүчин зүйлсийг багтаадаг.

Улс төрийн бодлогын бүтэц, түүний цар хүрээг тайлбарлах олон онол байдаг бөгөөд эдгээр онолын хандлагууд нь улс төрийн бодлого боловсруулах үзэл баримтлалын олон ургалч хандлагын илэрхийлэл нь болно. (Я.Т)

УЛС ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ (*Political symbol*) Улс үндэстний адил төстэй байдал, соёлын адилслыг илэрхийлэх нийгмийн соёлын нэг элемент нь улс төрийн бэлгэ тэмдэг юм. Зарим судлаачид бэлгэ тэмдгийг тухайн улс төрийн системийн соёлыг бэхжүүлэгч гэж үздэг. Улс төрийн бэлгэ тэмдгийг илэрхийлэгч гол талбар нь:

- Төрийн үүсэл, түүний оршин байх ойлголттой хамт үүссэн бэлгэ тэмдэг, эрхэмнэлтэй холбон үздэг.
- Улс төрийн нам болон лидерүүдийн бусдаасаа ялгарах хэв шинж, дүр дүрслэл, бэлгэдэл зэргийг багтаана.

Симбол буюу бэлгэ тэмдэг нь өөрийн гэсэн үзэл санааны илэрхийлэл, дүр дүрслэлийн хэлбэртэй байж, холбогдох далд санааг агуулсан цогц илэрхийллийн илэрхий бус тэмдэг гэж тодорхойлдог. Товчоор ойлговол симбол нь дүр дүрслэл, илэрхийлэл юм. Дүр дүрслэл нь ямагт тодорхой утга санааг илэрхийлж байх

бэлгэдлийн агуулгатай бөгөөд өөрийн гэсэн дүртэйгээ холбоотой байдлаар оршдог. Гэхдээ зарим тохиолдолд эдгээр нь хоорондоо яг нийцэх албагүй. Иймд симбол буюу улс төрийн бэлгэ тэмдэг нь:

- Дүр дүрслэл
- Тодорхой утга санаа гэсэн бүтэцтэй байна.

Улс төрийн бэлгэ тэмдэг нь олон давхар утга санаатай байдаг учраас түүнийг ойлгоход заримдаа бэрхшээл тулгардаг. Улс төрийн бэлгэ тэмдгийг маш олон янзаар дүрслэн илэрхийлж болдог бөгөөд график дүрслэл (христийн загалмай, алх, хадуур, араа хүрд гэх мэт) тэмдэг, биет зүйлээр дүрслэн үзүүлдэг. Мөн хүний фигурийг ашиглаж бэлгэ тэмдгийг илэрхийлж болдог. Жишээлбэл АНУ-д өвгөн Сем, Англид Жон Буль, Францид Марианна зэрэг хүний фигурийг ашигласан байдаг.

Улсын бэлгэ тэмдэг нь цэрэг, сэлэм, ордон, засгийн газрын ордон зэргийг багтаана. Мөн улс орны туг далбаа нь симболын төрөл болно. Туг далбаа нь ямар нэг зүйлд уриалан дуудсан утга санааг агуулна. Гэхдээ аливаа улс үндэстний бэлгэ тэмдэг нь ихэвчлэн ард түмэн өөрсдөө бий болгодог бөгөөд янз бүрийн бэлгэдэл болох туг, сүлд, тамга зэрэг бүх төрлийн дүрслэлийг багтаадаг. Зарим нэг бэлгэ тэмдгийг улс төрийн зүтгэлтнүүд эсвэл нийгэмд явагдах тодорхой зорилготой үйл ажиллагаанд зориулан шинээр бүтээдэг байна.

Улс төрийн лидерүүд төр засгийг удирдахдаа төрийн туг, далбаа, дуулал, баяр наадам, шагнал урамшуулал, өнгө, дүр дүрслэл зэрэг бэлгэ тэмдгүүдийг ашиглаж иргэдийг уриалан дуудах, нэгтгэх, улс төрийн үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор

хэрэглэгддэг нь улс төрийн уламжлалт соёл юм.

Дэлхийн түүхээс үзэхэд Цезарь, Наполеон, Линкольн, Сталин, Гитлер, Кастро зэрэг удирдагчид бэлгэ тэмдгийн улс төрийг ашиглахдаа гаргууд байж, өөрсдийн дүр төрх, ялгарах байдлаа илэрхийлж байжээ (Сахал, навчин тамхи, гаанс, таяг, цэргийн хувцас гэх мэтээр). (Я.Т)

УЛС ТӨРИЙН ДЭГЛЭМ (*Political regime*) Франц хэлний “regimen” удирдах хэлбэр болон латин хэлний “regimin, regimen” дүрэм журам, хэм хэмжээ гэсэн үгнүүдээс гаралтай. XVIII зууны сүүл үеэс энэ үгийг хэрэглэх болжээ. Улс төрийн системийн шинж чанар, нийгмийн улс төрийн харилцааны хөгжлийн чиглэл, түвшинг тодорхойлоход улс төрийн дэглэмийг авч үздэг. Улс төрийн дэглэм нь засгийн эрх мэдлийг олж авч буй арга, хэлбэр, улс төрийн институцийн бүтэц, зохион байгуулалт, төр, нийгэм хоорондын болон нийгмийн бүлгүүд хоорондын харилцааны шинж чанарыг тодорхойлдог ойлголт юм. Улс төрийн дэглэмийг ерөнхийд нь тоталитар, авторитар, ардчилсан гэж ангилдаг бөгөөд дараах шинж чанарыг гол шалгуур болгодог. Үүнд:

- Нийгэм дэх иргэн хүний байдал, хүний эрх, эрх чөлөөний асуудал, хүн өөрийн эрх ашиг сонирхлыг илэрхийлэх боломж
- Нийгмийн гишүүд улс төрийн бодлого, нийгмийн удирдлагад оролцож байгаа байдал, шинж чанар, түвшин
- Төрийн удирдлага болон нийгмийн өөрөө удирдах ёсны харилцан хамаарал
- Нийгмийн амьдрал дахь үзэл суртлын үүрэг

- Улс төрийн эрх мэдлийг олж авч байгаа болон хэрэгжүүлж буй арга, хэлбэр зэрэг орно.

Аливаа улс төрийн дэглэмийн мөн чанар, үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зам нь төрийн захиргааны байгууллагуудад шууд нөлөөтэй бөгөөд ямар дэглэм хэрэгжихээс хамаарч төрийн бодлого, шийдвэр гаргалт, хэрэгжилт, хяналт болон бүхий л систем, тэдгээрийн хэлбэрт илэрч байдаг. Тухайлбал, нийгмийг бүхэлд нь захирахгүй ч эдийн засгаас бусад нийгмийн салбарыг төрөөс бүрэн хяналтад авах авторитар дэглэм нь төрийн байгууллагын үйл ажиллагааг хянах, захиран чиглүүлэх, ардчилсан бус хэв шинжтэй болно. Түүнчлэн авторитар төрийн үндсэн зорилго нь зөвхөн хэсэг бүлгийн эрх ашгийн төлөө төрийн байгууллага, албан хаагчдыг ашиглаж, өөрсдийн хүсэл зорилгоо хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгох бүрэн боломжтой дарангуйллын дэглэмийн нэг юм (Авторитари, тоталитари дэглэмээс дэлгэрэнгүй мэдээлэл харна уу). (Я.Т)

УЛС ТӨРИЙН ЁС ЗҮЙ (*Political ethics*) Улс төрийн ёс зүй гэдэг нь улс төрийн үйл явц, агентуудад ёс суртахууны шалгуураар хандан үнэлгээ өгөх практик ажиллагаа гэж түгээмэл байдлаар ойлгодог. Орчин үеийн ардчилсан нийгэмд улс төрийн агентад хувь хүн-иргэнээс эхлээд сонгогдсон төр, засгийн албан тушаалтнууд, цаашлаад лоббичид хүртэл багтана. Гэвч орчин үеийн төлөөллийн ардчиллын зарчмаар бол улс төрийн ёс зүйн үндсэн агент нь иргэдийг төлөөлөхөөр сонгогдсон буюу томилогдсон төрийн албан хаагч байна. Аливаа мэргэжил, үйл ажиллагаа нь сайн үйлийн зорилготой байдаг. Төлөөллийн ардчилал бүхий нийгэмд улс төрийн алба нь түүнийг

эрхэлж буй албан тушаалтны ашиг тусын төлөө бус, нийтийн сайн сайхны төлөө ажилладаг байх ёстой. Улс төрчдийн ёс зүйгүй үйлдэл авлига хээл хахууль болон даамжирснаар авлига нь нэг удаагийн үйлдлээс тогтмол үзэгдэл, улмаар улс орныг хамарсан хямрал болон тэлнэ. Улс төрийн авлигын тархац, хэв шинжээр нь улс орнуудыг клептократ төр, хоёр туйлтай монополийн төр, өрсөлдөөнт хээл хахуультай улс, мафид ноёлуулсан улс гэхчлэн ангилж байна. (Я.Т)

УЛС ТӨРИЙН ЛЕГИТИМ БАЙДАЛ (*Political legitimacy*) Энэ нь Францын хууль ёсны, хүлээн зөвшөөрөгдсөн, хуульчлагдсан гэсэн утгаар илэрхийлэгддэг. Хүн амаас төрийн засаглалын ноёрхлыг хууль ёсны хэмээн хүлээн авах нөгөө талаас удирдуулах, захирагдах ёсыг ард түмний зүгээс хүлээн зөвшөөрөх явдал нь эрх мэдлийн легитим гэж үзнэ. Улс төрийн легитим байдал нь засаглал, түүний эрх мэдэл, нэг нь нөгөөдөө захирагдах харилцаа, ардчилсан аргаар хяналт тавих үйл явцыг тодорхойлох арга зүйн категори юм. Легитим байдал нь төрийн засаглалын эрх мэдэл институужиж, тогтвортой харилцаа бий болох, шийдвэр гаргах, тушаах, зөвшөөрөх, хориглох биелүүлэх үед бий болдог. Засаглалын легитимийн онолыг хөгжүүлэхэд М.Вебер гол хувь нэмэр оруулсан бөгөөд түүний онолыг ардчиллын шалгуур үзүүлэлттэй холбон легитимт байдлыг судалдаг юм. М.Вебер легитимийн гурван хэв маяг бүхий ангиллыг дэвшүүлсэн.

Уламжлалт легитим - Захирах захирагдах уламжлалт заншилд тулгуурласан урт удаан хугацаанд оршин тогтнодог ихэвчлэн хаант засаглалтай улс орнуудад ажиглагддаг легитим юм. Нөгөө талаар төрөө шүтэх

үзэл санаа (этатист)-гай салшгүй холбоотой.

Харизматик легитим - Энэ нь хувь хүний онцгой чадвар, авьяаст итгэх олон нийтийн итгэл, сэтгэл хөдлөл, хувийн харилцаанд ихэвчлэн түшиглэн захирагддаг хэлбэр.

Хууль ёсны буюу рационал легитим - Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн дагуу оршин байдаг олон ургалч үзлийн үр дүн болсон хүлээн зөвшөөрөгдсөн байдал бөгөөд үүнийг институтжсэн легитим гэж нэрлэх тохиолдол бий. (Я.Т)

УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО (*Political participation*)

“Улс төрийн оролцоо гэдэг нь иргэдээс төрийн байгууллага, төрийн бодлого шийдвэр түүний үйл ажиллагааг дэмжих болон нөлөөлөх талаар хийж буй аливаа оролдлого”-ыг хэлдэг. Өргөн утгаараа улс төрийн оролцоо нь иргэдийн улс төрд нөлөөлж буй үйлдэл, улс төрийн субъект болох иргэн, нийгмийн жижиг, том бүлэг, байгууллага, институтүүдийн явуулж буй үйл ажиллагаа юм. Иймд улс төрийн оролцоо нь иргэдийн оролцооны нэгэн бүрэлдэхүүн хэсэг болдог бөгөөд энэ нь иргэдээс төрийн байгууллага, төрийн ажилтны бодлого шийдвэр, үйл ажиллагааг дэмжих болон тэдгээрт нөлөөлөхийн төлөө хийж байгаа аливаа үйлдлийг тодорхойлдог ойлголт юм. Иргэдийн улс төрийн шийдвэр гаргах болон улс төрийн бодлогын хэрэгжилтэд оролцох үйл явц, улс төрийн мэдээллээр хангагдах, улс төрийн хариу үйлдлийн түвшин, улс төрийн үйл байдлын тэнцвэр, улс төрийн мэдээллийн эх сурвалж ашиглах зэргээр улс төрийн оролцоо илэрч байдаг. Улс төрийн оролцоо нь зорилго, чиглэл, агуулгаасаа хамааран маш олон төрөл зүйл хэлбэртэй. Ихэнх тохиолдолд нийцтэй ба нийцгүй, идэвхтэй ба идэвхгүй гэх зэргээр авч

үзэх нь түгээмэл байдаг. Улс төрийн оролцооны хэлбэрүүд нь сонгуульд санал өгөх, улс төрийн намуудын үйл ажиллагаанд оролцох, орон нутгийн түвшинд улс төрийн амьдралд оролцох, янз бүрийн түвшинд төр засгийн олон төлөөлөгчидтэй харилцах, жагсаал цуглаанд оролцох, эсэргүүцлийн цуглаанд нэгдэх, төрөл бүрийн хөдөлгөөнд нэгдэх, үймээн самуун, хувьсгалд оролцох гэх зэрэг хэлбэрүүдээр илэрдэг. Нийцтэй оролцооны хамгийн түгээмэл хэлбэр бол иргэдийн сонгуульд оролцох оролцоо юм. Төр, нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрдөггүй тийм оролцоог нийцгүй оролцоо гэх бөгөөд хэлбэр нь нийтийн эд хөрөнгөнд хохирол учруулахуйц жагсаал, цуглаан хийх, ажил хаялтад оролцох, татвар төлөхөөс зохион байгуулалттай татгалзах, замын хөдөлгөөнд саад хийх, эсэргүүцлийн уриа бичих, нийтийн хэрэгцээний эд зүйлийг эвдэх зэргээр илрэн гардаг. (Я.Т)

УЛС ТӨРИЙН СОЁЛ (*Political culture*)

XVIII зуунд Германы гүн ухаантан И.Гердер “Хүн төрөлхтний философийн үзэл санааны тухайд” бүтээлдээ ‘Улс төрийн соёл’ хэмээх ойлголтыг анх хэрэглэсэн. Гэсэн хэдий ч XX зуунаас улс төрийн соёлын талаарх онол, парадигмын төлөвшил эхэлсэн түүхтэй. Улс төрийн соёл нь нийт үндэсний соёлын нэгэн бүрэлдэхүүн хэсэг юм. Аливаа үндэстний соёл нь нийгмийн бүлгүүдийн түүхэн хөгжлийн явцад олж авдаг улс төрийн туршлагаар илэрдэг. Улс төрийн туршлага нь тодорхой байдлаар оршин тогтнож, хүмүүсийн улс төрийн ухамсрын төлөвшилд нөлөөлж, улмаар улс төрийн зан үйлээр илрэх улс төрийн чиг баримжаа, үзэл баримтлалуудаар илэрхийлэгддэг.

Улс төрийн соёлын бүтэц нь дараах гурван элементүүдтэй байдаг. Үүнд:

1. **Улс төрийн турилага:** улс төрийн түүхэн ой санамж, уламжлалын агуулгаар илэрхийлэгдэнэ.
2. **Улс төрийн үзэл суртал:** улс төрийн мэдлэг, үнэт зүйлс, итгэл үнэмшил, чиг баримжаагаар илэрхийлэгдэнэ.
3. **Улс төрийн зан үйл:** улс төрийн оролцооны аль нэг хэлбэрээр илэрхийлэгдэнэ.

“Улс төрийн соёлыг нийгмийн гишүүдийн дийлэнхийнх нь итгэл үнэмшил, дадал заншил болсон, тэдгээрээс улс төрийн систем, төр засагтаа хандах байдлыг илэрхийлсэн ойлголт” хэмээн тодорхойлдог. Судлаач Г.Алмонд. С.Верба нар улс төрийн соёлын харьцуулсан судалгааны томоохон бүтээл болох “Иргэний соёл” номондоо олон сонирхолтой судалгааны үр дүн, улс төрийн соёлын онол, арга зүйн үндсийг боловсруулж, улс орнуудын ялгаатай соёлыг нийтлэг байдлаар нь хуваан ангилсан. Судлаачдын дэвшүүлсэн зарим чухал ангиллаас дурдахад улс төрийн соёлыг хүмүүсийн улс төрийн талаарх ойлголт, төсөөлөл, чиг баримжаа зэрэгт үндэслэн дараах байдлаар ангилан авч үзсэн байдаг. Үүнд:

- Танин мэдэхүйн чиг баримжаатай - улс төрийн систем, түүний үүрэг роль, системийн гаралт, оролт, түүнийг хэрэгжүүлдэг хүмүүсийн тухай анхны мэдэгдэхүүнээрээ тайлбарлах оролдлогыг хэлнэ.
- Сэтгэл хөдлөлийн чиг баримжаатай - асуудалд яаж хандахаа мэддэггүй, бусдыг даган дуурайх хандлагыг хэлнэ. Мөн улс төрийн системийн бүрдэл, төрийн албаны хүмүүс, тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон мэдрэмж.

- Үнэлэмжийн чиг баримжаатай - танин мэдэх, судлан үзэх замаар улс төрийн үзэгдэл, үйл явцын үнэн зөвийг тайлбарлах оролдлого бүхий хүмүүсийн хандлагыг хэлдэг.

Мөн судлаачид улс төрийн соёлыг хуучин буюу уламжлалт, албадлагын, оролцооны гэсэн гурван нийтлэг хэв маягтай болохыг тогтоосон юм. Гэхдээ аль нэг хэв маяг нь дангаар орших нь ховор тохиолддог бөгөөд ихэвчлэн зэрэгцсэн болон хослон оршдог гэж үзээд түүнийг улс төрийн соёлын холимог хэв маяг гэж нэрлэсэн.

Монгол Улсын хувьд 1990-ээд оноос хойш улс төрийн соёлын онол, практикийн асуудлаар багагүй судалгаа шинжилгээ хийгдсэн байна. Эдгээрээс 2000 оны Д.Содномгомбо, Ч.Найдансүрэн нарын “Улс төрийн соёл, түүний Монгол дахь төлөвшлийн асуудал” 2017-2019 оны ШУА-ийн Философийн хүрээлэнгийн улс төр, эрх зүйн салбарын судлаачид “Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг” сэдэвт суурь судалгааны төсөл хэрэгжүүлж, Монголын улс төрийн соёлын төлөв байдал, хэв маягийг тодорхойлох судалгаа хийгджээ. Судалгааны зарим дүгнэлтээс дурдахад ерөнхийдөө манай улсын улс төрийн соёлын төлөвшил дундаас доош буюу бүрэлдэх шатандаа явж байна гэсэн тааруу дүгнэлтэд хүрчээ⁸. Мөн улс төрийн соёлын хэв маягийн хувьд холимог буюу оролцооны улс төрийн хэв маяг хамгийн бага байгааг онцолж⁹, идэвхтэй оролцоо хангалтгүй байгааг дүгнэн тодорхойлсон. Улс төрийн соёлын төлөвшилд хамгийн чухал үүрэгтэй субъектэд “нам”

⁸ Монгол дахь улс төрийн соёл: Уламжлал, орчин үе. ШУА-ийн Философийн хүрээлэн. Улаанбаатар 2020 он, х. 289.

⁹ Мөн гэнд

тэргүүлэх үүрэгтэй боловч иргэдийн улс төрийн үйл ажиллагаанд оролцох идэвх, иргэний нийгмийн оролцоо, хэвлэл мэдээлэл, төр засагтаа хандах хандлага, төрийн байгууллагууд, төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, тэдний ажилдаа хандах байдал зэрэг олон хүчин зүйлээр илэрхийлэгдэнэ. Иймд шинээр төлөвшин тогтож буй эсвэл уламжлагдан ирсэн улс төрийн соёлын зарим итгэл үнэмшил, хандлага нь тухайн улс орны төрийн захиргааны байгууллага, үйл ажиллагаанд ч илэрч, байгууллагын зонхилох соёлын хэв маягт нөлөөлөх хүчин зүйл болно. (Я.Т)

УЛС ТӨРИЙН СЭТГЭЛ ЗҮЙ (*Political Psychology*) Бие хүний улс төрийн зан үйл, зорилго чиглэл, таашаал сонирхол, итгэл үнэмшил зэрэг сэтгэл зүйн хүчин зүйлсийг судалдаг улс төр судлал, сэтгэл судлалын заагт орших салбар шинжлэх ухаан юм. Хувь хүний аливаа үйлдэл орчноос хамаардгийн адил төрийн үйл ажиллагаа мөн орчноос шалтгаалдаг гэдгийг улс төрийн сэтгэл зүй үндэс болгон судалдаг. Иймээс улс төрийн шинжилгээ нь орчны нөлөөлөлд хүний өгөх хариу үйлдлийг тайлбарладаг ойлголт, танин мэдэхүйн процесс, хүлээлт, сэдэл зэрэг сэтгэл зүйн хүчин зүйлсийг анхааран судалдаг бөгөөд сонгогчдын зан төлөв, улс төрийн нийгэмшилт, улс төрийн манлайлал, олон нийтийн санаа бодол зэргийг судлахад сэтгэл зүйн талаас нь ихэвчлэн шинжлэн үздэг байна. Улс төрийн сэтгэл зүй нь 1950-60 оны үед улс төр судлалд “бихевиорист хандлага”-аас эх аван эрчимтэй хөгжсөн. Орчин үед нийгмийн шинжлэх ухааны бусад салбаруудад сэтгэл зүйн асуудал ихээхэн дэлгэрч, салбар дундын судлагдахуун болон хөгжиж байна. Тухайлбал, төрийн албан хаагчид болон манлайллын

судалгаанд сэтгэл зүйн асуудлыг авч үзэж, байгууллагад хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн сэтгэл зүйн асуудал, хөдөлмөрлөх орчны нөлөөлөл, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэгт сэтгэл зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх зорилготой хэрэглээний сэтгэл судлалын нэгэн чиглэл болж хөгжиж байна. (Я.Т)

УЛС ТӨРИЙН ТОГТОЛЦОО (*Political system*) Шинжлэх ухааны түүхэнд хоорондоо уялдаатай үзэгдлийг судлах зорилгоор анх системийн хандлага үүсэн хөгжжээ. Нээлттэй системийн онолыг анх биологийн шинжлэх ухааны эрдэмтэн Л.Вон Бергланфи (1920-иод онд) нээсэн. Системийн хандлага нь аливаа юмс үзэгдлийг бүрдүүлж буй элементүүд, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог иж бүрнээр нь ойлгох арга барил юм. Өөрөөр хэлбэл аливаа үзэгдлийг механикаар авч үздэг аргачлалын эсрэг ойлголт билээ. Системийн хандлага нь аливаа юмс үзэгдлийн элементүүдийн тасралтгүй хөдөлгөөн, өөрчлөлтийг бүхэлд нь “цогц” ойлголтоор авч үздэг бөгөөд үзэгдлийн гадаад, дотоод хүчин зүйлүүдийн шүтэлцээг тооцож, судлан шинжилдэг судалгаа шинжилгээний арга юм. Хожим нь энэхүү онол, арга зүйн загварыг олон шинжлэх ухаанд хэрэглэж эхэлсэн бөгөөд улс төрийн шинжлэх ухаанд XX зууны дунд үеэс Америкийн улс төр судлаач Дэвид Истон 1953 оны “Улс төрийн систем”, 1956 оны “Улс төрийн шинжилгээний хязгаар” 1965 оны “Улс төрийн амьдралыг судлах системийн шинжилгээ” хэмээх бүтээлүүддээ “Улс төрийн системийн онол буюу “хар хайрцагны онол”-ыг боловсруулснаар эхэлсэн түүхтэй. Д.Истон улс төрийн системийг тодорхойлохдоо улс төрийн амьдрал бол нийгмийн орчноос тод ялгарах хил хязгаар бүхий систем

гэж үзээд “Улс төрийн систем нь эрх мэдлийг ашиглан нийгмийн дотор үнэт зүйлийг байршуулах үйл ажиллагаа” хэмээжээ. Улс төр системийг гүгээмэл байдлаар авч үзвэл нийгэм, улс төрийн байгууллагуудын хоорондын харилцааны эрх зүй, улс төрийн соёл, улс төрийн орчны хамаарлыг илэрхийлсэн, нийгэмд засаглалыг хэрэгжүүлэх арга хэрэгслийн нийлбэр цогц гэж тайлбарладаг.

Системийн шинжилгээний арга зүйн байр сууринаас үзвэл ямар ч систем өөртөө дараах шинжийг агуулна. Өөрөөр хэлбэл улс төрийн систем ч дараах үндсэн шинжийг агуулдаг байна. Үүнд:

1. Систем олон хэсгээс бүрдэнэ.
2. Хэсгүүд нь нэгдмэл нэг бүхлийг бий болгоно.
3. Систем нь хил хязгаартай байна үндсэн шинжүүдийг агуулдаг.

Түүнчлэн аливаа системийн эргэх хуулийн зарчмаар харилцан уялдаатай үйл явцыг гурван үед хуваадаг. Энэ зарчмаар улс төрийн системийн загвар нь оролт, системийн дотоод орчин, гаралт гэсэн үйл ажиллагааны гурван үе шаттай байна.

Улс төрийн системд ард түмэн, төр, улс төрийн нам, сонирхлын бүлэг хэмээх субъектүүдийг үндсэн бүрдэл хэсэг гэх буюу түүний гаднах янз бүрийн үүрэг гүйцэтгэгч олон төрлийн дэд бүрдүүлэгч хэсгүүдээс тогтсон бүтэц гэж үздэг. Үүнд:

- **Нийгэм улс төрийн институт, байгууллагаас бүрдсэн институционал хэсэг** (Төр, түүний байгууллагууд, нам, нийгэм-улс төрийн хөдөлгөөн, нэгдэл, төлөөллийн болон шууд ардчиллын байгууллагууд, олон

нийтийн мэдээллийн хэрэгслүүд, сүм хийд гэх мэт).

- **Тодорхой нийгэм, улс төрийн институт болон түүний бүлгүүдийн үйл ажиллагаагаар хэрэгждэг үүргүүдээс цогцлон бүрддэг функционал хэсгүүд** (Улс төрийн үйл ажиллагааны хэлбэр, засаглалыг хэрэгжүүлэх механизм, арга зүй, нийгмийн амьдралд нөлөөлөх зэрэг).
- **Улс төрийн системийн субъектүүдийн хоорондох харилцаа холбоог зохицуулах хэрэгсэл болон улс төр, эрх зүйн хэм хэмжээ болох регулятив хэсгүүд** (Үндсэн хууль болон бусад хууль, уламжлалт зан заншил, улс төрийн зарчим, үзэл санаа зэрэг).

Улс төрийн систем нь өөрийн өвөрмөц хэрэгслийн тусламжтайгаар нийгэмд материаллаг болон оюун санааны үнэт зүйлсийг албадан хуваарилсны үндсэн дээр нийгмийн гишүүд болон бүлэг хоорондын зөрчил мөргөлдөөн, түгшүүртэй байдлыг арилгах, зохицуулах, өөрчлөх зэрэг олон талт үйл ажиллагааны цогц байна. Энэ үүднээс байнга өөрчлөгдөж буй орчинд улс төрийн систем нь өөрийн тогтвортой байдлыг хангах, хадгалагдаж үлдэх нь түүний гол зорилт гэдгийг Д.Истон онцлон тэмдэглэсэн байдаг. (Я.Т)

УЛС ТӨРИЙН ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ (Political decentralization) “Political” гэдэг үгийн үндэс нь “politic” бөгөөд энэ нь Грекийн “polis” буюу “хот-улс” гэсэн үгнээс үндэстэй. XV зууны дунд үеэс political буюу улс төрийн гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ. Улс төрийн хувьд төвлөрлийг сааруулах нь шийдвэр гаргах эрх мэдлийг засгийн газрын доод түвшинд шилжүүлэх, иргэд,

тэдгээрийн сонгууль төлөөлөгчдийг шийдвэр гаргах үйл явцад оролцуулах явдлыг нэмэгдүүлэх үйл явц болдог. Учир нь захиргааны төвлөрөл хэр зэрэг саарсан байх нь тухайн улсын улс төрийн тогтолцоотой нягт уялдаатай байдаг. Төвлөрөл бүрэн саарсан тогтолцоонд засгийн газрын доод түвшний байгууллагууд дээд түвшний оролцоогүйгээр бие дааж бодлого боловсруулах, хэрэгжүүлэх эрх мэдэлтэй байдаг. Захиргааны төвлөрлийг сааруулах ажиллагаанд гол төлөв байгууллагын гүйцэтгэх үүргийг боловсруулах, тэдгээр үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай захиргааны ажлуудыг тодорхойлох, уг ажлыг хийж гүйцэтгэх этгээдийг хуваарилах явдал орно. (Т.Т)

УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ СУРТАЛ (*Political ideology*) “Ideology буюу үзэл суртал” гэдэг нэр томьёог анх XVII зууны эцсээр Францын гүн ухаантан Дестют Де Траси хэрэглэсэн байдаг. Грекийн “idea+logos” гэсэн үгнүүдээс гаралтай. Үзэл суртал нь нийгэм улс төрийн бүлэг, нам, холбоодын үйл ажиллагаандаа баримтлах үнэт зүйл, зарчмуудын цогц юм. Үзэл сурталын мөн чанарыг нийгэм, эдийн засаг, соёл, шашин, улс төрийн үзэл баримтлал, сэтгэл зүй гэх мэт олон хүчин зүйлтэй холбон тайлбарладаг. Улс төрийн үзэл суртал нь нэг талаас тодорхой бүлгийн илэрхийлэн хамгаалсан үзэл санаа, үзэл баримтлалуудын нийлбэр цогц бөгөөд нөгөө талаас улс төрийн засаглалын хүлээн зөвшөөрөгдсөн шинжийг хангах үнэт зүйлсийн илэрхийлэл гэж үздэг. Энэ утгаараа үзэл баримтлал (концепц) гэдэг нь үзэл сурталтай адил утгаар хэрэглэгдэх боловч үзэл суртал нь онол, арга зүйн харьцангуй өндөр түвшинд боловсруулагдсан байдгаараа ялгагддаг. Улс төрийн үзэл суртал нь нам, хөдөлгөөн, холбоодоор дамжин

институтийн түвшинд хэрэгжиж иргэдийн улс төрийн үйл байдлыг залж чиглүүлэх үүднээс гурван түвшинд авч үздэг. Үүнд:

- онолын,
- улс төрийн мөрийн хөтөлбөрийн,
- үйл байдлын түвшинд.

Онолын түвшинд анги давхарга, улс үндэстний эрхэм зорилго, үнэт зүйлсүүд томьёологддог бол дараа нь нийгмийн үндсэн үзэл, зарчмууд, улс төрийн мөрийн хөтөлбөр, уриа, шаардлага болон хувирдаг. Улс төрийн үзэл суртал нь нийгмийн тодорхой бүлэг давхаргын сонирхол, хэрэгцээ, зорилго, үнэт зүйлсийн үүднээс бодит байдлыг нэгтгэн дүгнэсэн үзэл санаа, төсөөлөл, үзэл баримтлалуудын систем болдог. XX зууны дэлхийн улс төрд үзэл суртал хоорондын тэмцэл хурцдаж, дэлхийн дайн дэгдэх аюул тулгарч байсныг түүх гэрчилдэг. Гэхдээ үзэл суртал нь үзэл санааны өндөр түвшинд системчлэгдэн боловсруулагдсан нь улс төрийн номлол болж, аль нэг намын мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны зорилго, арга замыг тодорхойлох үзэл баримтлал болж бусад баримт бичгүүдэд тусгагдаж олон нийтийн хүртээл болж байдаг онцлогтой. Нийгмийн амьдралд үзэл суртал чиглүүлэн заах, нэгтгэн нягтруулах, дайчлах, бүлгийн эрх ашгийг илэрхийлэх, хамгаалах үүрэгтэй байдаг. Үзэл суртал нь нийгэм, эдийн засаг, төр болон иргэдийн хамтын аж төрөх байдлын талаарх итгэл үнэмшил, үнэт зүйлс, сонирхлоос хамааран агуулга, зорилгоороо ялгаатай олон янзын хандлагуудтай. Улс төрийн чиг баримжаагаар нь барууны, зүүний, төвийн гэж ангилдаг. Харин нийгмийн хөгжилд хандах хандлага, зорилгоо хэрэгжүүлэх арга барилын хувьд консерватив, реформист, радикал хэмээн ангилдаг. (Я.Т)

УЛС ТӨРИЙН ХЯМРАЛ (*Political crisis*)

Улс төрийн хямрал гэдэг нь бүлэг, улс төрийн хүчнүүдийн хоорондын мөргөлдөөн тэмцэл асар гүнзгийрсэн, улс төрийн байдал нь хурцадсан улс төрийн системийн тодорхой нөхцөл байдал юм. Улс төрийн хямралыг олон улсын мөргөлдөөн, зөрчлөөс улбаалсан улс төрийн гадаад хямрал, засгийн газар, парламент, үндсэн хууль зэргээс үүдсэн улс төрийн дотоод хямрал гэж хоёр ангилдаг. *Засгийн газрын хямрал гэдэг нь засгийн газар гүйцэтгэх засаглалын үүргээ гүйцэтгэх чадваргүй болж, нэр хүндээ алдахыг хэлнэ. Хэрвээ засгийн газар энэ байдлыг засаж чадахгүй бол парламент итгэл үзүүлэхээс татгалзан засгийн газрыг огцруулж болно. Засгийн газрын хямрал нь лидерүүдийг солих юм уу бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулснаар дуусгавар болдог. Парламентын хямрал нь парламентын шийдвэр улс орны иргэдийн олонхын эрх ашигт нийцэхээ больж хууль тогтоох байгууллага дахь хүчний харьцаа өөрчлөгдөхийг хэлнэ. Үүний улмаас парламент тарж, шинэ сонгууль явагдана. Парламентын хямрал нь мөн парламент дахь зөрчилдөгч фракц, хүчнүүдийн харьцаа адил байгаагийн улмаас хууль тогтоох, шийдвэр гаргах үйл явцад бэрхшээл учирсан үед ч үүсэж болдог. Үндсэн хуулийн хямрал гэдэг нь оршин буй үндсэн хуульд засвар өөрчлөлт хийгээгүй, хүчингүй болгоогүй хэдий ч улс төрийн үйл ажиллагаанд оролцогч субъектүүд түүнийг дагаж мөрдөхөөс татгалзахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, үндсэн хууль нэр хүндээ алдаж хэрэгжиж чадахгүй болох явдал юм. Улс төрийн хямрал нь засаглалын институтийн холбоо сул, нийгэм улс төрийн зохицуулалт, хяналт муу, үр дүнгүй, цуглаан, ажил хаялт, улс төрийн эсэргүүцэл хүчтэй өрнөсөн үед гол төлөв үүсэж, төрийн*

удирдлагын тогтолцооны хямралд нөлөөлөх эрсдэлтэй байдаг.

Улс төрийн хямралыг илрэх онцлог, шалтгаан зэргээр нь:

1. Легитимт байдлын хямрал
2. Адилслын хямрал
3. Улс төрийн оролцооны хямрал
4. Хуваарилалтын хямрал гэж ангилна.

Легитимт байдлын хямрал эрх баригчдын дэглэм олон түмний зүгээс дэмжлэг авч чадахаа байсан үед үүснэ. Адилслын хямрал нь үндэс угсаатны болон шашин шүтлэгийн гэх мэт нийгмийн бүлгүүдийн ялгарал хүчтэй болж нийт улс төрийн системийн асуудлыг шийдэхэд бэрхшээл учруулах үед үүснэ. Улс төрийн оролцооны хямрал засаглалын төлөөх тэмцэлд оролцох хүсэлтэй нийгмийн бүлгийг эрх баригч элитийн зүгээс хавчин шахах, оролцуулахгүй байх үед үүсдэг. Түүнчлэн нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэстний эв нэгдэл, улс төрийн системийн тогтвортой байдлын эсрэг чиглэсэн бүлэглэлүүдийн улс төрийн оролцоо эрс идэвхжсэн үед дээрх хямрал үүсдэг байна. Хуваарилалтын хямрал гэдэг нь эрх баригч элитүүд нийгмийн материаллаг баялгийг хүртээмжтэй хуваарилах чадвар муу, хүн амын бүх давхарга нийгмийн баялгаас хувь хүртэж чадахгүй байхыг хэлнэ. (Я.Т)

УЛС ТӨРИЙН ЭЛИТ (*Political elite*)

Elite буюу сонгомол, шигшмэл гэсэн утгатай Франц үгнээс гаралтай. Плато, Макиавелли, Моска, Парето, Михельс, Лассуэлл зэрэг олон эрдэмтэд нийгэм дэх зэрэг дэвийн дээд хэсэг, төрийн удирдлагын дээд албан тушаалд буй хэсэг хүмүүсийг улс төрийн элит хэмээн үзэж байсан. Элит гэдэг бол оюун ухаан, сэтгэхүйн болоод сэтгэл

зүйн хувьд бусдаас илүү чадвартай, өндөр ёс суртахуунтай түүнийгээ ашиглаж чаддаг хүмүүсийг хэлнэ. Элитүүдийг дотор нь эдийн засаг, урлаг соёлын, цэрэг, оюуны элитүүд гэж ангилдаг ба эдгээрээс нийгэмд эзлэх байр сууриар нь улс төрийн элитүүдийг засаглагч буюу төрийн эрх мэдлийг эзэмшигч, хадгалах чадвартай элит гэж үздэг. Орчин үеийн элитийн онол, үзэл баримтлалд В.Парето, Г.Моска, Р.Михельс нар чухал хувь нэмэр оруулсан билээ. Г.Москагийн үзэл баримтлалд элитийг шилж сонгох, тэдний оюун чадамж, сэтгэхүйн өндөр чадавх, удирдан зохион байгуулах чадвар, ёс суртахууны асуудлыг тусгаж элитүүдийг үзэл бодлынх нь хөгжил өөрчлөлтөөр сурвалжтаны, ардчилсан гэсэн хандлагад хуваасан байдаг.

Зарим судлаачид одоог хүртэл оршин байгаа бүх нийгмийн түүх бол ангийн тэмцлийн түүх биш, харин элитүүдийн тэмцлийн түүх байсан гэж үздэг. Улс төрийн элит гэдэг ойлголт нь ерөнхийдөө хоёрдмол утгатай, бүрхэг, маргаантай байгаа зүйл юм. Үйл ажиллагааны аль ч салбарт элит байдгийн адил улс төрд ч мэргэжсэн хүмүүс байх нь зүйн хэрэг. Гэхдээ эдгээр хүмүүсийн ажил хэргийн чанар нь бүх талаар бусдаас илүү дээр, шилэгдмэл хүмүүс болгож чадахгүй хэмээн шүүмжлэлтэй хандлагууд байдаг. Р.Михельсийн (1876-1936) үзсэнээр элитүүд нь зүй тогтолтой, нөхөн эсгэлт хийж байдаг үзэгдэл бөгөөд түүний шалтгаан нь нийгмийн зохион байгуулалт гэж үзсэн. Олон түмэн улс төрийн мэдлэг хомс, идэвхгүй, тоомжиргүй байдгаас төрийн удирдлагын дээд албан тушаалтнууд олигарх болдгийг Р.Михельс “Олигархийн төмөр хууль”-иар тайлбарласан байдаг. (Я.Т)

УЛС ТӨРИЙН ЭРХ ЗҮЙ (Political Law) Улс төрийн эрх зүйн салбар нь төр болон засаглалын судалгаанд хэрэглэгддэг болсон бөгөөд үүнд:

1. Үндсэн хуулиас гадна төрийн бүтцийн болон засаглалын удирдах үйл явцыг шийдвэрлэх бүхий л эрх зүйн болон бусад төрлийн хэрэгслүүдийг судлах,
2. Хууль, төрийн бодлого, удирдлага, улс төрийн хоорондын харилцааг судлах,
3. Ардчилсан засаглалын харилцаа түүний хүчин зүйлсэд хуулийн үр нөлөөг судлах ойлголтууд багтдаг байна.

Улс төрийн эрх зүй нь хууль ба улс төрийн шинжлэх ухааны хоорондох оюун ухааны хил хязгаарыг даван, аль ч чиглэлээр зураглал хийдгээрээ онцлогтой. Улс төрийн эрх зүй нь улс орныг жолоодохтой холбоотой хууль, эрх зүйн асуудлыг шийдвэрлэх хуулийн үйл ажиллагааны орон зайг тодорхойлно.

Улс төрийн эрх зүй нь үндсэн хууль, захиргааны эрх зүйтэй салшгүй холбоотой байдаг. Улс төрийн эрх зүй нь нэг талдаа улс төрийн шинжлэх ухаан, нөгөө талдаа төрийн бодлого, удирдлагатай холбоотой судалгаа хийдэг. Хэдийгээр эдгээр салбаруудтай уялдаатай боловч ардчилсан засаглалын бусад судалгааны салбаруудтай харьцуулахад улс төрийн эрх зүй нь харьцангуй бие даасан, ялгаатай ойлголт гэж үздэг. (Я.Т)

УЛС ТӨРЧ (Politician) Улс төрийн мэргэжил эзэмшсэн хүнээс гадна улс төрд идэвх зүтгэлтэй оролцож шийдвэр гаргадаг, ялангуяа сонгогдсон албан тушаал хашдаг, өдөр тутамд улс төрийн үйл ажиллагаанд оролцож байгаа хүн. Монгол Улсад 1992 оны

Үндсэн хуулиар орчин үеийн эрх зүйт төрийн шаардлагаас бий болсон Улсын Их Хурлын гишүүд нь улс төрчид гэж хэлнэ. XVIII-XX зууны эхэн үед улс төрийн байгуулалд хэрэглэгдэх болсон Commonwealth-ийн хамгийн явцуу, гэнэн тайлбар болох улс төрийн хэрэглээнд бүдүүлэг утга болон хувирсан “нийтээр нийгэмчлэгдсэн амьдрал” буюу нийтийн дотуур байр шиг л орчингоор нийгмийн үйл ажиллагааг үнэлж, улс төрийн ухамсраа зарим нэгэн улс төрчид бүрдүүлэх болсноор массын ухамсарлахуйд нэг цул үнэлэмж бий болгож нийгэмд хэвийн бус нөлөөлөх боллоо. Гэхдээ энэ хэвийн бус гэж үзэх шалгуур нь Үндсэн хуульт ёс, эрх зүйт төрийн үзэл зарчмууд хөгжин бүрдсэн нь түүхэнд ардчилсан тогтолцоо дангаараа хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хангах төгс хэрэгсэл бус гэдгийг харууллаа. (А.Э.ц)

УЛСЫН БАГА ХУРАЛ (*State Small Khural*) Улсын их хурлын чөлөө цагт БНМАУ-ын төрийн эрхийг хэрэгжүүлж байсан дээд байгууллага. 1924 онд Улсын анхдугаар их хурлаас 30 гишүүнтэй байгуулжээ. 1949 он хүртэл 8 удаагийн сонгуулиар 40-100 гишүүнтэйгээр байгуулж байжээ. Энэ хугацаанд төрийн хууль тогтоох, гадаад дотоод бодлогын талаарх засгийн газрын үйл ажиллагааг чиглүүлэх, хянах үүрэгтэйгээр ажиллаж байв. 1990 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр дахин буй болж, 53 гишүүнтэй байгуулагдаж, 1992 оны Үндсэн хуулийн дагуу Улсын их хурал буй болсноор тус улсад Улсын бага хурал гэсэн институц үгүй болжээ. (А.Ц)

УЛСЫН БАЙЦААГЧ (*State inspector*) Аливаа мэргэжлийн чиглэлд өндөр мэргэшсэн, туршлагатай, хуулиар

олгосон хяналт, шалгалт хийх эрх бүхий албан тушаалтанг улсын байцаагч гэнэ. Энэ нь нийтийн салбарт улсын хилээр нэвтэрч буй зорчигч, бараа, тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд хяналт тавьж, гаалийн бүрдүүлэлт хийх, татвар хураамж ногдуулах зэрэг ажлыг эрхлэх эрх бүхий гаалийн байцаагч, татвар ногдуулах, төлөх үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хууль тогтоомжийн хүрээнд зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, албан татвар, төлбөр, хураамж, алданги, торгуулийг хуульд заасан хугацаанд хурааж төсөвт оруулах татварын байцаагч, санхүүгийн зах зээлийн харилцааг дүрэм журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, аливаа илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, таслан зогсоох, холбогдох этгээдэд шаардлага тавьж, үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хангуулах үүрэг бүхий санхүүгийн байцаагч зэрэг албан тушаалтнууд байна. (Г.Б)

УЛСЫН ИХ ХУРАЛ (*State Great Khural*) Монгол Улсын Их Хурал - Ард түмнээс сонгогдсон Монгол Улсын төлөөллийн дээд байгууллага. Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд зааснаар, Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална. Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурал хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахаас гадна төрийн дотоод, гадаад бодлогыг тодорхойлох, төрийн бусад байгууллагыг байгуулах, албан тушаалтныг томилох, төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогыг тодорхойлж, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг гүйцэтгэдэг. (Ч.Э)

УЛСЫН САЛБАРЫН ШИНЭ УДИРДЛАГА (*New public management*)

Эртний Английн “*nīwe*” буюу “анх удаа, цэвэр, шинэ (*first time, fresh, novel*)” гэсэн үгнээс үндэстэй. Судлаачдын олонх нь “Public” гэдгийг монгол хэлнээ “төр” гэсэн агуулгаар орчуулан хэрэглэдэг. Харин “management” нь “manus” буюу “өөрийн гараар хянах” гэсэн үгнээс гаралтай. Үгийн утга нь “үйл хэргийн явцыг удирдах/жолоодох, хянах” гэсэн санааг илтгэдэг. Орчин цагт менежмент гэдгийг аливаа үйл хэргийг удирдах гэсэн утгаар орчуулан хэрэглэдэг. Эдгээр үгсийн утгын нийлэмжийг харвал төрийн шинэ удирдлага (монгол хэлнээ улсын салбарын шинэ удирдлага гэж орчуулах нь элбэг байдаг) гэсэн агуулгыг илэрхийлж байна. Тодруулбал, захиргааны уламжлалт загвар орчин үеийн шаардлага хангахгүй болсон талаар ихээхэн шүүмжлэх болсны хариуд 1980-1990 ээд оноос менежментийн шинэ хандлага төрийн салбарт нэвтэрч эхэлсэн. Төрийн шинэ удирдлагын агуулгад өмчийг хувьчлах, төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдах ёсны чадавхыг бэхжүүлэх, гүйцэтгэлийг сайжруулах, гэрээлэх, үр дүнт чухалчлах, өрсөлдөөнийг дэмжих үзэл санаа багтсан байдаг. Төрийн салбар дахь менежеризм (*Managerialism*)-ын энэ үзэл санаа нь дүрэм журамд захирагдах гэхээсээ илүүтэй үр дүнд чиглүүлэн удирдах үйл явцтай холбоотой юм. Энэ ч утгаараа захиргааны үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг дээшлүүлэх, үйлчилгээг иргэдэд ойртуулах, захиргааны үйл ажиллагааг ил тод болгох, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд гол зорилго нь оршдог. Тухайлбал, Их Британи, Австрали, Шинэ Зеланд, Нидерланд болон Швед зэрэг Скандинавын зарим орнууд 1970-

аад оны сүүлчээс улсын салбартаа өөр өөрийн өнгө аястай шинэчлэл хийж эхэлсэн. Дээрх орнууд төрийн байгууллага, албан хаагчдаа хувийн хэвшлээс суралцаж, үйл ажиллагаагаа үр дүнтэй, үр ашигтай, ил тод болгохыг уриалсан байна. “Энэ үзэл санаа 1990-ээд оны эхээр дэлхий нийтийг хамарсан захиргааны шинэчлэлийн давлагаа болон өргөжсөн. Төрийн шинэ удирдлага нь 1) ажлын үр дүнд чиглүүлэх, түүнийг хэмжих, хянах, 2) захиргааны нэгжүүдийг бие даалгах, 3) өрсөлдөөний сэтгэлгээг хүчтэй болгох, 4) санхүүгийн удирдлагыг сайжруулах, 5) хариуцлагад тулгуурласан удирдлагыг чиг баримжаа болгоход чиглэдэг. (Т.Т)

УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР (*Public budget entities*)

Талаас илүү хувь нь төрийн шууд болон шууд бус эзэмшилд байдаг үйлдвэр, аж ахуйн газрыг хэлнэ. 1980-аад оны сүүлээс энэ тодорхойлолтод хүрсэн. Хөгжиж буй орнуудад үлэмж улсын үйлдвэрийн газруудын тоо 1960-1970-аад онуудад үлэмж өссөн бөгөөд зах зээл төгс болоогүй нөхцөлтэй холбож тайлбарладаг. 1980-аад оноос эхлэн зарим улсын үйлдвэрийн газрыг хаах, оновчтой болгох, хувьчлах зайлшгүй нөхцөл байдал үүссэн байдаг¹⁰. Улсын төсөв үйлдвэрийн газрууд нь уул уурхай, газрын тос, сэргээгдэх эрчим хүч гэх мэт байгалийн сэргээгдэхүй болон сэргээгдэх нөөцийг ашиглах, олборлох, түгээх, экспортлох, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн бий болгох, үйлдвэрлэх, зах зээлд нийлүүлэх, ашиг олох зэргээр стратегийн ач холбогдол бүхий салбарт ихэвчлэн үйлдвэрлэл, ажил эрхэлдэг ба үүнийг төрөөс тодорхой хяналт тавих,

¹⁰ Салватор Шиаво-Кампо, Пачампет Сундарам: “Иргэддээ үйлчилж, төрт ёсны үнэт зүйлсээ хадгалах: Өрсөлдөөнт ертөнцөд төрийн захиргааг сайжруулах нь”, Улаанбаатар 2011, х. 216.

эсвэл ашгаас хувь хүртэх зэргээр оролцдог. (Г.Б)

УРВИК, ЛИНДОЛ ФОУНС (*Urwick, Lyndall Fownes, 1891-1983*) Британийн менежментийн зөвлөх ба бизнесийн сэтгэгч. Оксфордын Нью коллежид түүх судалж байжээ. Дэлхийн 1-р дайны үед цэргийн алба хааж ахмад цол авч, Цэргийн загалмай одонгоор шагнуулж байжээ. Дайны дараагаар эцгийн бизнест богино хугацаагаар оролцож байснаа Йоркийн шоколадны үйлдвэрт ажиллах болжээ. Тэнд компанийг шинэчлэх ажил хийхийн зэрэгцээ менежментийн талаар судалгаа хийж эхэлсэн байна. Түүнд Тайлорын шинжлэх ухаанч менежмент болон Мэри Фоллетийн менежментийн хүмүүнлэгийн үзэл санаа ихэд нөлөөлсөн гэдэг. 1928 онд Женев дахь Олон улсын менежментийн институтын захирал болжээ. Энэ институт удаан оршоогүй боловч Урвик судалгаагаа үргэлжлүүлсээр 1929 онд “рационалчлалын агуулга” (The Meaning of Rationalisation), 1933 онд “маргаашийн менежмент” (The Management of Tomorrow) хэмээх бүтээлүүдээ хэвлүүлжээ. Түүний зэрэгцээ Элтон Маёогийн Хотгорны туршилтын талаар судалж, түүнийг сурталчлан дэлгэрүүлэх ажил хийжээ. 1934 онд Англид буцаж ирснийхээ дараа Жон Орртой хамтран Urwick, Orr & Partners (UOP) хэмээх нэртэй менежментийн зөвлөгөө өгөх газрыг нээсэн байна. 1950 он гэхэд энэ байгууллага Европын ийм төрлийн дөрвөн том байгууллагын нэг болжээ. Урвик Хэнри Фаёол болон өмнөх үеийн бусад онолчдын үзэл санааг нэгтгэн менежментийн цэгцтэй онол буй болгосон ажээ. Үүний гол санаа нь түүний 1943 онд хэвлүүлсэн “Бизнесийн удирдлагын элементүүд” хэмээх номд тусгалаа олжээ. Урвик

олон ном зохиол (Urwick, Lyndall Fownes. Organization as a technical problem. 1933; Metcalf, Henry C., and Lyndall Urwick, eds. Dynamic administration: the collected papers of Mary Parker Follett. Vol. 31942/2003; Urwick, Lyndall Fownes. The elements of administration. 1944; Urwick, Lyndall Fownes. Notes on the Theory of Organization. 1952; Urwick, Lyndall Fownes and Edward Brech. The making of scientific management. 1954/1994; Urwick, Lyndall Fownes. The Pattern of Management. 1956; Urwick, Lyndall Fownes. The Golden Book of Management: A Historical Record of the Life and Work of Seventy Pioneers, 1956; Gulick, Luther, and Lyndall Urwick, eds. Papers on the Science of Administration. 2012.) туурвисан байна. Тэрбээр Лютер Гуликтэй хамтран Administrative Science Quarterly сэтгүүлийг үндэслэсэн аж. (А.Ц)

УРСГАЛ ОРЛОГО/ЗАРЛАГА (*Current income/expense*) Төсөв, санхүүгийн урсгалын нэг циклийн хугацаанд буюу богино хугацаанд тухайн байгууллага, эдийн засгийн нэгжийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой бүрдсэн орлого, гарсан зарлагыг хэлнэ. Улсын төсөв болон орон нутгийн төсвийн хувьд урсгал орлого болон урсгал зарлага нь төсвийн эдийн засгийн ангиллын нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд эдгээрийн зөрүүгээр урсгал тэнцлийг тодорхойлно. Урсгал орлогод татварын орлого, татварын бус орлого багтдаг бол урсгал зарлага нь бараа, үйлчилгээний зардал, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлээс бүрддэг. (Б.Б)

УРТ ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (*Long term plan*) Төлөвлөгөөг хугацаагаар нь урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө хэмээн ангилна.

Урт хугацааны төлөвлөгөөг арав¹¹ болон түүнээс дээш (Артур Левисийн тодорхойлсноор 20 жил хүртэл¹², Монгол Улсын хуульд зааснаар 30 жил хүртэл¹³) хугацаагаар боловсруулах бөгөөд урт хугацааны эсвэл алс хэтийн төлөвлөгөө хэмээн нэрлэнэ¹⁴. Монгол Улс 2050 он хүртэл хэрэгжүүлэх “Алсын хараа-2050”¹⁵ нэртэй урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг 2020 онд баталсан байгаа нь урт хугацааны төлөвлөгөөний жишээ юм. Урт хугацааны төлөвлөгөө нь нэгдүгээрт, алс хэтийн хандлага төлөвийг тодорхойлсон, багадаа 10 жилээр урагш харсан, хоёрдугаарт, тогтвортой өсөлт, хөгжлийг баримжаалсан бодлогын шийдэл бүхий, гуравдугаарт, цэвэр улс төрийн шийдвэр байдгаараа онцлог байна¹⁶. Урт хугацааны алс хэтийн төлөвлөгөө нь шийдвэр гаргагчдын хөгөч нь болдог¹⁷. (М.А)

УХААЛАГ ЗАСАГ (*Smart government*)

Засгийн бодлого болон төлөвлөлтийг ухаалгаар тооцоолох технологийн ололтод тулгуурлан явуулах шинэтгэлийн арга хэлбэр.

Ухаалаг засгийн аргаар улс орныг удирдсанаар төрөөс иргэн төвтэй үйлчилгээг ардчиллын зарчимд нийцүүлэн хэрэглэгчид хүргэх нөхцөл бүрдэх ач холбогдолтой. Ухаалаг засаг нь харилцаа холбооны сүлжээ болон мэдээллийн нэгдсэн системд үндэслэдэг. Ухаалаг засаглал бол төрийн үйлчилгээний ирээдүй юм.

Энэ нь мэргэжлийн нийгэмлэг болон иргэний нийгмийн байгууллагын манлайлал, илүү үр ашигтай байх болон инновацыг нэвтрүүлэн тасралтгүй сайжирч байх ойлголт юм. Монгол Улсад ухаалаг засаглалыг нэвтрүүлэхээр 2015-2020 онд Дэлхийн Банкны Олон улсын ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагаар “Ухаалаг засаг” төслийг хэрэгжүүлсэн. Уг төслийн зорилго нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг төрийн үйл ажиллагаанд оновчтой ашиглах замаар төрийн үйлчилгээг илүү үр ашигтай, ил тод, хүртээмжтэй болгох юм. Төслийн хүрээнд Иргэдийн оролцоог дэмжих бүрдэлд Иргэдээ санал, хүсэлт, гомдол авах төвүүдийн үйл ажиллагааг дэмжих техникийн зөвлөх үйлчилгээ; Иргэдээ Засгийн газарт ирүүлсэн санал, хүсэлт, гомдолд дүн шинжилгээ хийх системийг хөгжүүлэх техникийн зөвлөх үйлчилгээ; Төрийн мэдээллийн технологийн нэгдсэн тогтолцоог бий болгох бүрдэлд Төрийн бизнес процессын оновчлол, нэгдсэн архитектур нэвтрүүлэх; Үндэсний дата төвийн нөөцийн төвийг байгуулах; Инновацыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх; Эд хөрөнгийн цахим бүртгэлийн системийг улс орон даяар нэвтрүүлэх; Төрийн өгөгдөл мэдээллийн нээлттэй орчныг бий болгох бүрдэлд Төрийн нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх; Бүртгэл, статистикийн ерөнхий газрын өгөгдөл боловсруулалтын системийн чадавхыг бэхжүүлэх ажлуудыг хэрэгжүүлсэн. (Д.З; Ч.Л нар)

УХААЛАГ ЗАСАГ ТӨСӨЛ (*Smart government project*)

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг төрийн үйл ажиллагаанд оновчтой ашиглах замаар төрийн үйлчилгээг

11 Монгол Улсын “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай (2020) хууль”-иар 10 жилийн төлөвлөгөө нь дунд хугацааны гэдэг ангилалд хамаарагдаж байна.

12 W.Arthur Lewis, Development Planning, 1966, p. 140.

13 Монгол Улсын “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.2 дахь хэсэг.

14 W.Arthur Lewis, Development Planning, 1966, p. 140.

15 Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол.

16 W.Arthur Lewis, Development Planning, 1966, p. 141.

17 W.Arthur Lewis, Development Planning, 1966, p. 141.

илүү үр ашигтай, ил тод, хүртээмжтэй болгох зорилготой Дэлхийн Банкны Олон улсын ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагаар 2015-2020 онд хэрэгжсэн төсөл. Төслийн хүрээнд Иргэдийн оролцоог дэмжих бүрдэлд Иргэдээс санал, хүсэлт, гомдол авах төвүүдийн үйл ажиллагааг дэмжих техникийн зөвлөх үйлчилгээ; Иргэдээс Засгийн газарт ирүүлсэн санал, хүсэлт, гомдолд дүн шинжилгээ хийх системийг хөгжүүлэх техникийн зөвлөх үйлчилгээ; Төрийн мэдээллийн технологийн нэгдсэн тогтолцоог бий болгох бүрдэлд Төрийн бизнес процессын оновчлол, нэгдсэн архитектур нэвтрүүлэх; Үндэсний дата төвийн нөөцийн төвийг байгуулах; Инновацыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх; Эд хөрөнгийн цахим бүртгэлийн системийг улс орон даяар нэвтрүүлэх; Төрийн өгөгдөл мэдээллийн нээлттэй орчныг бий болгох бүрдэлд Төрийн нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх; Бүртгэл, статистикийн ерөнхий газрын өгөгдөл боловсруулалтын системийн чадавхыг бэхжүүлэх ажлууд хэрэгжсэн. (Д.З; Ч.Л нар)

УХААЛАГ УЛААНБААТАР ХӨТӨЛБӨР

(Smart Ulaanbaatar project) 2014 онд нийслэл Улаанбаатар хотоос баталсан "Шинэ зууны хотын хөгжлийн чиг хандлага, технологийн дэвшил, иргэдийн хүсэл шаардлага, бизнесийн орчны өөрчлөлт зэргийг оновчтой шийдвэрлэж байх захиргааны цомхон бүтэцтэй, ойлгомжтой дүрэм журамтай, соёлтой шуурхай үйлчилгээтэй, технологижсон, ажиллаж амьдрахад таатай, аюулгүй ухаалаг хотыг бий болгох" зорилготой хөтөлбөр.

Ухаалаг Улаанбаатар төслийн үндсэн чиглэлийг дараах байдлаар

дэвшүүлсэн. Үүнд:

- Ухаалаг засаглал - Нээлттэй, ил тод, иргэдийн оролцоог хангасан засаглалын тогтолцоог бүрдүүлэх, хууль эрх зүйн шинэтгэл хийх, цахим засаглалыг нэвтрүүлэх
- Ухаалаг эдийн засаг - Төр бизнесийн харилцааг сайжруулах, хотын тогтвортой хөгжлийг хангахуйц, мэдлэгт суурилсан эдийн засагт шилжихэд бизнесийн байгууллагуудад туслал
- Ухаалаг иргэд - Үндэсний оюуны чадавхад тулгуурласан, шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлэх орчин бүрдүүлэх
- Ухаалаг үйлчилгээ - Хотын мэдээллийн орчин, дэд бүтцийг уян хатан, хүртээмжтэй, найдвартай болгон хөгжүүлж, төрийн үйлчилгээг хялбаршуулах цогц шийдлийг хэрэгжүүлэх
- Ухаалаг орчин - Ая тухтай, эрүүл, аюулгүй орчинд таатай ажиллаж, амьдрах боломжийг бүрдүүлэх.
- Ухаалаг амьдрал - Иргэд шаардлагатай мэдээлэл үйлчилгээг гэрээсээ шууд авах нөхцөл бүрдсэн орон сууц, барилга байгууламж, амьдрах орчин, үйлчилгээний дэд бүтцийг бий болгох. (Д.З; Ч.Л нар)

УЯН ХАТАН ТӨСӨВ (Flexible budget)

Төсвийн зарлага нь үйл ажиллагаа болон орлогодоо уян хатан зохицох хэлбэрээр зохион байгуулагдсан төсвийг хэлнэ. Орлого бага байхад зарлагыг мөн бага байлгаж, царцаах, орлого нэмэгдэх эсвэл төсөөлж буйгаас илүү ихээр орж ирсэн тохиолдолд зарлагаа мөн дагуулан нэмэгдүүлэх, шинэ төрлийг зарлага гаргах боломжийг олгодог. Төсвийн уян хатан байдлыг ялгавартай тогтоож болдог.

Тухайлбал, орсон орлогыг ямар нэг хязгаарлалтгүй зарцуулах эрхтэй төсөв байж болно. Эсвэл орсон орлогын төрлөөр болон орлогын тодорхой хувиар зарцуулалтад хязгаар тавихаар зохицуулалт хийж болно. Ихэнх тохиолдолд тодорхой төрлийн зарлага нь орж ирсэн орлогын заасан хувиар эсвэл үйлдвэрлэсэн (борлуулсан) нэгж бүтээгдэхүүнд ногдох зарлагын эрхээр хязгаарлагддаг. Ямар ч тохиолдолд тухайн байгууллагын тогтмол зардлыг (fixed costs), жишээлбэл түрээсийн төлбөр, өмчийн татвар, халаалтын гэх мэт зардлыг байгууллага зайлшгүй төлөх учир энэ хэсэг нь “уян хатан” байдлаар зохицуулагдахгүй бөгөөд нэн тэргүүнд төлөгдөх ёстой байдаг. Харин хувьсах зардал (variable costs) дээр дээрх зохицуулалтыг ашиглана. Уян хатан төсөв нь хөдөлгөөнгүй төсөвтэй (static budget) харьцуулахад зах зээлийн болон бусад нөхцөл байдалд зохицох чадвар илүү өндөр, бодит байдалд илүү нийцсэн, орлого олох болон гүйцэтгэлээ сайжруулах хөшүүрэг илүү хүчтэй, нөөцийг илүү үр ашигтай зарцуулах боломжоор давуу байдаг. Нөгөө талаас, төсвийн тооцооллыг байнга шинэчлэх шаардлагатай болдог бөгөөд жилийн эцэст төсвийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн хооронд ялгаа байхгүй учир үйл ажиллагаандаа хяналт тавих, хариуцлага тооцох боломж суларна. Энэ утгаараа зөвхөн тодорхой төрлийн бизнест ашиглагддаг. (Ч.Н)

Ү

ҮЗЭЛ САНАА (*Idea*) Сэтгэл судлалд хүрээлж байгаа бодитой, тодорхой юмс үзэгдлийн талаарх хүний санаа бодол, ухаанд буух тусгалын хэлбэр юм. Оксфордын англи хэлний толь бичигт XVIII зууны “ideologie” гэсэн нь Франц үг бөгөөд Грек хэлний хэв, загвар (*idea*) ба эмхтгэл, хууль (*logos*) гэсэн үгнээс үүссэн гэж тайлбарлажээ¹. Ер нь шинжлэх ухаанд үзэл санаа гэдэг нь юмс үзэгдлийг танин мэдэхэд чиглэсэн шинэ санаа, санал гэдэг утгаар хэрэглэгдэнэ. Ийм үзэл санаа улмаар үзэл баримтлалын шинжтэй болж хувирч болно. Захиргааны шинжлэх ухаанд захиргаа, улс төрөөс ангид байх, захиргааны үйл ажиллагаанд ардчилал болон үр ашгийн шалгуурыг хэрэглэх гэх мэт нь захиргааны мөн чанарыг тодорхойлох талаар гарч байсан үзэл санаа юм. (Ц.Д)

ҮЗЭЛ СУРТАЛ (*Ideology*) Нийгмийн бүлгийн үзэл санаа, сонирхол, хүсэл зорилгыг илэрхийлэх замаар нийгмийн харилцаа, үйлдэл, амьдралын хэв маягийг өөрчлөх буюу бататгахад туслах үзэл бодол, итгэл үнэмшлийн тогтолцоо юм. Өөрөөр хэлбэл, үзэл суртал гэдэг нь хүмүүсийн дотооддоо байнга баримталдаг улс төр, эдийн засаг, нийгэм, шашин гэх мэт янз бүрийн итгэл үнэмшил, ертөнцийг үзэх

үзэл, үзэл баримтлалыг хэлнэ. Монгол хэл дээр үүнийг үзэл санаа, суртал гэх хэлбэр буюу ухамсрын хэлбэрт хөрвүүлдэг боловч үүнийг “ideology” гэж эх хэлний дуудлагаар нь ашиглах нь элбэг байдаг. Үзэл суртал хэмээх нэр томьёоны анхны академик хэрэглээ нь XVIII зууны сүүлчээр Францын сэтгэгч Трейси (D.Tracy)-гийн 1801 онд хэвлүүлсэн “Үзэл суртлын танилцуулга” гэдэг ном байв. Тэр үед үзэл суртлыг идеализм, өөрөөр хэлбэл үзэл бодлын шинжлэх ухаан (*science of ideas*) гэх утгаар ашиглаж байжээ. XIX зуунд Маркс (K.Marx), Энгельс (F.Engels) нарын олон нийтэд танигдсан “Германы үзэл суртал” хэмээх бүтээл 1845 онд хэвлэгдэж, нийгмийн ерөнхий бүтэцтэй холбоотойгоор хэрэглэж эхэлсэн байна. Түүнээс хойш өнөөг хүртэл “нийгмийн тухай ойлголт” гэсэн утга руу ойртон өөрчлөгдөж иржээ. (Ц.Д)

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ (*Operational planning*) Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт нь байгууллага юунд хүрэхийг хүсэж байгаага олж мэдэх, түүнд хэрхэн хүрэхээ шийдэх үйл явц² юм. Энэ нь байгууллагын стратегид үндэслэн удирдлагын үйл ажиллагааг үр дүнтэй явуулах нөхцөлийг бүрдүүлэх,

¹ Б.Үүрцайх (2020). Улс төрийн либерал үзэл санааны хөгжлийн тухайд. Төрийн удирдлага сэтгүүд, III/№12. Улаанбаатар. х. 133.

² Кембриж тайлбар толь, <https://dictionary.cambridge.org/dictionary/english/organizational-planning>

хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Үйл ажиллагааны төлөвлөлтэд нь байгууллагын стратегийг хэрэгжүүлэх удирдлагыг оновчтой зохион байгуулах, бүтцийг бий болгох, хэлтэс, нэгж, албан тушаал бүрээр хариуцан гүйцэтгэх үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэр гаргах, хянах эрхийн харьцааг тогтоох, үйл ажиллагааны харилцааг зохицуулах, эрх зүйн баримт, дүрэм, журам тогтоох зэрэг асуудлыг багтаасан байна. Үйл ажиллагааны төлөвлөлтийг хийхдээ хүний нөөц, хангамж, бүрдүүлэлтийн зохион байгуулалт, цалин хөлсний зохион байгуулалт, мэргэжил дээшлүүлэлт, нийгмийн асуудал, удирдлага, захиргааны нийт зардал зэрэг гол асуудлуудад анхаарна. (Д.Ч)

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОНОВЧТОЙ ХЭМЖЭЭ (*Optimal production level*)

Үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг хэрэглээний болон хөрөнгө оруулалтын зүйл болгон хувиргах үйл ажиллагааг үйлдвэрлэл гэж ерөнхийд нь нэрлэх ба үйлдвэрлэлийн эдийн засгийн зорилгод хүрэх үеийн үйлдвэрлэлийн хэмжээг оновчтой хэмжээ гэж тодорхойлно. Эдийн засгийн зорилго нь “хамгийн их ашигтай ажиллах” гэж тодорхойлогдох үед ашгийг хамгийн их түвшинд хүргэх үеийн үйлдвэрлэлийн хэмжээ буюу үйлдвэрлэлийн ахиу орлого нь ахиу зардалтай тэнцүү байх үеийн үйлдвэрлэлийн хэмжээ юм. Харин төрийн салбарт буюу ашгийн төлөө бус байгууллагад үйлдвэрлэлийн оновчтой хэмжээ нь өгөгдсөн төсвийн хязгаарт багтаан үзүүлэх гарц (үйлчилгээний түвшин)-ын зорилтот хэмжээгээр тодорхойлогдоно. Түүнчлэн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын дагуу үйлдвэрлэлийн оновчтой хэмжээг тодорхойлоход байгалийн нөөцийн зохистой ашиглалт, байгаль орчинд ээлтэй технологийн нэвтрүүлэлтийг

гол шалгуур болгох хандлага нэмэгдсэн. (Б.Б)

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛ (*Service culture*)

Байгууллагын бүх гишүүдийн итгэл үнэмшил, үнэт зүйлд шингэсэн үйлчлүүлэгчидтэй харилцах харилцаанд баримтлах зарчим, хэм хэмжээ, хандлага, зан үйлийн цогц бөгөөд үйлчилгээний ажилтны сэтгэлгээний болон зан үйлийн хэвшиж тогтсон хэв маяг юм. Үйлчилгээний соёл нь үйлчилгээний ажилтан үйлчлүүлэгчтэй харилцах харилцаанд итгэлцлийн уур амьсгалыг хэр зэрэг бүрдүүлж чадаж байгаагаар тодорхойлогдоно. Энэ соёл нь байгууллагын гишүүн бүрийн зан үйл, дүр төрхийн бодит илрэл болохоос биш цаасан дээр бичигдсэн дүрэм журам биш юм. Төрийн албанд хийгдэж буй шинэчлэлүүд нь “үйлчлүүлэгч төвтэй”, “үйлчлүүлэгчдийг хүндэтгэсэн”, “үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээг чухалчилсан” шинэлэг соёлыг төлөвшүүлэхийг ихээхэн чухалчилж байна. (М.А)

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР (*Service quality*)

Эдвард Демингийн тодорхойлсноор “Чанар нь найдвартай, нэг хэвийн байдлыг урьдчилан хэлж болох хэм хэмжээ бөгөөд хэрэглэгчийн зүгээс тавьж буй шаардлагыг хангах шинжүүдийн цогцолбор” юм. 1950-иад оныг хүртэл чанар нь стандарт, техникийн хэм хэмжээг хангаж байгаагаар тодорхойлогддог байсан бол 1960-аад оноос хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа эсэхээр, харин 1980-аад оноос чанарыг “хэрэглэгчийн сэтгэл ханамж”-аар³ тодорхойлох болжээ⁴. Тиймээс үйлчилгээний чанарыг “хэрэглэгчийн

3 Elke Loeffler, “Defining Quality in Public Administration”, p. 3.

4 Elke Loeffler, “Defining Quality in Public Administration”, p. 3.

хүлээлтэд нийцсэн үйлчилгээ үзүүлж чадсан эсэхээр” тодорхойлох хандлага давамгайл болж үүнтэй уялдан хэрэглэгчийн хүлээлтийг бодит гүйцэтгэлтэй харьцуулан сэтгэл ханамжийг болон үйлчилгээний чанарыг тодорхойлдог “Сэрвквал” аргыг судалгаанд, тухайлбал төрийн үйлчилгээний чанар, иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд өргөн ашиглах болсон байна. Энэ үүднээс төрийн үйлчилгээний чанарыг үйлчилгээний найдвартай байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай байдал, төрийн албан хаагчийн итгэл төрүүлэхүйц байдал, бусдад хүндэтгэлтэй хандах байдал, үйлчилгээний материаллаг болон бодит орчны үзүүлэлтээр нийтлэг тодорхойлно⁵. Үүнээс гадна судлаач Донабединий боловсруулсан гурван хэмжээст загвар аргачлалыг үйлчилгээний чанарыг тодорхойлоход мөн ашигладаг. Түүний боловсруулсан загвар аргачлалаар үйлчилгээний чанар нь потенциалын чанар, үйл явцын чанар, үр дүнгийн чанар гэсэн гурван хэмжээсээр тодорхойлогдоно⁶. Чанар нь аливаа ажлын гүйцэтгэлийн үр дүн, чансааг тодорхойлох цогцолбор үзүүлэлт юм. Үйлчилгээ бүр нь тодорхой зориулалт, зорилготой хэрэгжих бөгөөд үүнтэй нь уялдаад гүйцэтгэлийн үр дүн буюу чанарыг нь тодорхойлох үзүүлэлт ялгаатай байж болно. Тухайлбал аливаа сургалтын чанарыг суралцагчдынх нь олж авсан мэдлэг, ур чадвараар болон мэдлэг, ур чадварт гарсан өөрчлөлтөөр, мөн суралцагчийн хэрэгцээг хангаж чадсан эсэхээр, харин эмнэлгийн

тусламж үйлчилгээний чанарыг үйлчлүүлэгч эдгэрсэн эсвэл биеийн амин үзүүлэлтэд гарсан өөрчлөлтөөр, мөн үйлчлүүлэгчийн сэтгэлд хүртэл үйлчилж чадсан эсэхээр хэмжиж болох юм. (М.А)

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ (Customer) Үйлчилгээг хүртэгч байгууллага эсвэл хувь хүн. Төрийн байгууллагын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээний онцлогоос хамааран үйлчлүүлэгч нь хувь хүн, өрх, гэр бүл эсвэл аж ахуйн нэгж, байгууллага аль аль нь байж болно. Төрийн салбарт иргэдийг зөвхөн пассив байр суурьтай хэрэглэгч, үйлчлүүлэгч гэдэг байр сууринаас хандах нь өрөөсгөл болох талаар зарим судлаачид байр сууриа илэрхийлсэн байдаг. Учир нь төрийн үйлчилгээ үйл ажиллагаанд иргэд санхүүжүүлэгч (татвараар дамжуулан), шийдвэр гаргагч (оролцоот шийдвэрээр дамжуулан), түншлэгч гэх мэт олон янзын дүрээр (байр сууринаас) оролцдогт оршино. (М.А)

ҮЙЛ ЯВЦЫН ОНОЛ (Process theories) Хүмүүсийн хувийн хэрэгцээгээ хангахын тулд зан үйлийн ямар хэв загварыг сонголтынхоо үр ашгийг үнэлэх үйл явцыг тайлбарладаг онол юм⁷. Үйл явцын онолын хамгийн чухалд тооцогддог онолууд бол Шударга ёсны ба хүлээлтийн онол юм. Стейс Адамс (J.Stacy Adams) шударга ёсны онол (equity theory)-ыг боловсруулсан. Тэрээр ажилтны оруулсан хөдөлмөрийн хувь нэмрийг бусад хүмүүсийнхтэй харьцуулахад удирдлагын зүгээс бодитой үнэлж байгаа эсэх талаар ажилтнуудын төсөөллийг судалсан. Байгууллагын ажилтнууд хөдөлмөрийн үр дүнгийнхээ төлөө авсан цалин, урамшууллаа үнэлэх замаар нийгмийн тэгш байдлыг хангахыг эрмэлздэг

5 Амартүвшин М.,” Орон нутаг дахь төрийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамж, түүнд нөлөөлөх хүчин зүйлс”, дисс. 2015, 52-53 дахь тал.

6 Christian Homburg, Harley Krohmer, “Marketingmanagement: Strategie-Instrumente-Umsetzung-Unternehmensfuehrung”, 2006, S.982 und Stefanie Hohn,“Public Marketing: Marketing-Management fuer den oeffentlichen Sektor”, 2006, s. 217.

7 Д.Ганбаатар, Я.Шуурав, Д.Сэржамц. Менежмент. 2019. х. 373.

гэж шударга ёсны онолд үздэг. Энэ нь ажилтан өөрийн хүрсэн үр дүнгийн төлөө авч байгаа цалин, урамшуулал нь ижил түвшний гүйцэтгэлтэй бусад хүмүүсийнхтэй ойролцоо байх үед удирдлагын зүгээс өөрт нь алагчлалгүй, чин шударга хандаж байна гэж үздэг. Цалин урамшууллын тэгш байдлыг хувь хүний хөдөлмөрийн “орц” болон “гарц”-ын харьцаагаар үнэлдэг. Цалин урамшуулал олгох, хичээл зүтгэлийг нь хүлээн зөвшөөрөх, албан тушаал ахиулах болон бусад хожоог хувь хүний хөдөлмөрийн гарц гэнэ. Боловсрол, мэргэшил, туршлага, ур чадвар, чармайлт нь хувь хүний хөдөлмөрийн орц юм. Хувь хүний орц, гарцын харьцааг ажлын багийн бусад гишүүдийнхтэй буюу тухайн бүлгийн дундаж үзүүлэлттэй харьцуулна. Ийнхүү өөрийнх нь орц, гарцын харьцаа хамтран ажилладаг хүмүүсийнхтэй нь ойролцоо байх үед ажилтан шударга ёсыг мэдэрдэг байна. (Ц.Д)

ҮЙЛ ЯВЦЫН УДИРДЛАГА (*Process management*) Аливаа үйл явцыг шинжлэх, тодорхойлох, оновчтой болгох, хянах, харилцан хамааралтай үйл явцыг сайжруулах, гүйцэтгэлийг хэмжих, жолоодох хэрэгсэл бүхий байгууллагын үйл ажиллагаа. Үйл явцын удирдлага нь хувийн салбарт үүсэж, хөгжсөн ба төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор ашиглах болсон. Үйл явцын удирдлагад анхаарал хандуулснаар төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, үйлчлүүлэгчид чиглэх, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зэрэг давуу талтай. Түүнчлэн төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд тасралтгүй, байнгын сайжруулалтад тулгуурлана. (Г.Б)

ҮНДСЭН ХӨРӨНГӨ (*Capital assets*)

Бизнесийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах удаан хугацаанд (2 болон түүнээс дээш жил) хэрэглэдэг хөрөнгийг хэлнэ. Үүнд газар, барилга байгууламж, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, автомашин зэрэг биет зүйлс багтаххаас гадна патент, барааны тэмдэг болон оюуны өмчийн бусад эрх, үнэт цаас зэрэг биет бус зүйлс, цаашилбал урлагийн бүтээл, үнэт эдлэл зэрэг үнэ бүхий зүйлс мөн орно. Бизнесийн байгууллагаас гадна хувь хүн мөн үндсэн хөрөнгөтэй байна. Үндсэн хөрөнгө нь ашиг олох үйл ажиллагаанд ашиглагддаг учир бүтээгдэхүүний өртөгт шингэдэг, ингэснээр цаг хугацааны явцад хөрөнгийн үнэлгээ буурна. Энэ нь тухайн үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын (*depreciation*) хэмжээгээр гол төлөв тооцогдоно. Элэгдлийн хэмжээг тухайн үндсэн хөрөнгийн ашиглах нийт хугацаанд үндэслэн нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу тооцдог. Барилга байгууламжийг гол төлөв олон жилийн турш, тухайлбал 10 болон түүнээс дээш жил, ашиглах учир өртөг нь аажмаар шингэдэг бол хурдан хоцрогдох технологи, компьютер зэрэг хөрөнгийг 3 жил ашигласны дараа солих шаардлагатай болдог. Тиймээс эдгээрийн элэгдэл болон бүтээгдэхүүнд өртөг нь шингэж буй хугацаа нь ихээхэн ялгаатай. Биет бус хөрөнгө болох оюуны өмчийн эрхийг тодорхой хугацаагаар олгодог бөгөөд энэ хугацаанд тухайн оюуны өмчийг ашиглан үйлдвэрлэл явуулж буй тохиолдолд үнэлгээ нь мөн бараанд шингэж тооцогдох ёстой. Ингэж шингэж тооцох үйл явц нь биет хөрөнгийн элэгдэлтэй адил бөгөөд “амортизац” (*amortization*) гэж нэрлэдэг. Зарим нэг үндсэн хөрөнгийн өртөг бүтээгдэхүүнд шингэдэггүй,

улмаар үнэлгээ нь буурахгүй байж болно. Жишээлбэл компанийн эзэмшилд буй үнэт цаас болон урлагийн бүтээл үйлдвэрлэлийн явцад элэгдэл ордоггүй. Энэхүү хөрөнгийн үнэлгээ нь тухайн үеийн зах зээлийн үнэлгээгээр тогтоогдоно. (Ч.Н)

ҮНДСЭН ХУУЛИЙН ХЯНАЛТ (*Монгол Улсын Үндсэн хуулийн цэц*) (*Constitutional supervision [Constitutional Tssets of Mongolia]*) Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь хараат бус байх, Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, гишүүд нь эрх тэгш байх, асуудлыг шударгаар шийдвэрлэх, үйл ажиллагаа нь ил тод байх зарчмыг баримтална.

Үндсэн хуулийн цэцийн хяналт дараах онцлог шинжтэй. Үүнд:

1. Цэцийн хяналтын зүйл нь хууль зүйн хамгийн дээд хүчин чадалтай Үндсэн хууль байдаг.
2. Цэцийн хяналтын объект нь төрийн дээд байгууллага, түүний өндөр албан тушаалтнуудын үйл ажиллагаа байдаг. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийг биелүүлэх талаар мэргэжлийн өөр ямар ч байгууллагад харьяалагддаггүй байгууллага, албан тушаалтнуудад хяналт тавьдаг.
3. Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэрийг давж заалдах, өөрчлөх, хүчингүй болгох, эрх бүхий байгууллага, албан тушаалтан байдаггүй.

Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай дараах маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэж, дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна:

1. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;
2. Зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;
3. Ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;
4. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;
5. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх;
6. Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана. Хууль, зарлиг, Улсын Их Хурал,

Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, багламж, шийдвэр хүчингүй болно. Цэц шийдвэрээ Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс гаргадаг. Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болдог. Үндсэн хуулийн цэц нь есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилдог. Цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно. Шинээр буюу нөхөн томилогдсон Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрх томилогдсон өдрөөсөө эхлэн Үндсэн хуульд заасан бүрэн эрхийн хугацаа дуустал үргэлжилнэ. Үндсэн хуулийн цэцийн даргаар есөн гишүүний аль нэгийг гурван жилийн хугацаагаар олонхын саналаар 3 жилийн хугацаатай сонгоно. Түүнийг нэг удаа улируулан сонгож болно. Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч орж үл болно. Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг сонгон томилохдоо өндөр шаардлага тавихын зэрэгцээ тэдний харааг бус байдлыг хангах, бүрэн эрхийнхээ хугацаанд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, бололцоог бүрдүүлэх талаар төрөөс онцгой анхаарал тавьдаг. (Ч.Э)

ҮНДЭСНИЙ АДИЛСАЛ (*National identity*) Энэ бол аливаа үндэстний төлөөлөгчид өөрсдийгөө өвөрмөц, уламжлал, соёл, хэлээрээ нэгдмэл цогц бүхэллэг мөн гэдгийг ухамсарласныг

илэрхийлдэг ойлголт юм. Үндэсний адилсал нь хувь хүн өөрийгөө тодорхой улс, эсхүл үндэстэнд хамаарагддаг гэдгийг ухамсарлах мэдрэмж мөн. Үндэсний адилсал нь тухайн үндэстний хамтын бүтээл юм. Нийгэмшүүлэлтээр итгэл үнэмшил, үнэт зүйл, таамаглал, хүлээлтийн тогтолцоог бүлгийн гишүүдэд дамжуулдаг. Үндэсний адилслын нийтлэг зүйлс нь үндэсний бэлгэдэл, уламжлал, үндэсний туршлага, ололт амжилтын дурсамжийг багтааж болно. Эдгээр нь үндэстний түүхээр бүтээгдэн бүрэлдсэн байдаг. Энэ тогтолцоог нийгэмшүүлэх үйл явцад хувь хүн хэр их өртөж байгаагаас хамааран хүмүүс үндэсний онцлог шинж чанараа хувь хүний онцлог шинж чанартаа янз бүрийн түвшинд, янз бүрээр шингээж өгдөг бөгөөд үндэсний адилслын нийтлэг зүйлс нь хувь хүний өөрийгөө тодорхойлох тодорхойлолтын чухал хэсэг болдог. Хүн хэдийгээр тухайн үндэсний улсын иргэн биш байлаа ч гэсэн түүний иргэдтэй үндэсний талаар адилсал бүхий байж болно. (Ц.Д)

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ (*National Data Center*) Монгол Улсын үндэсний цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, боловсруулалтын үйлчилгээ эрхлэх үндсэн үүрэг бүхий улсын төсөвт үйлдвэрийн газар. Цахим монгол, Бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох, Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөгөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2009 онд Монгол Улсын Засгийн Газрын тогтоолоор байгуулагдсан Үндэсний дата төв нь Төрийн цахим мэдээлэл, өгөгдлийн сан, мэдээллийн технологийг зориулалтын нөхцөлд хадгалах, хүртээмжтэй байлгах, бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хангах, Төрийн цахим мэдээлэл, өгөгдлийн сангуудын

нэгдмэл байдал, уялдаа холбоог хангах үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй ажилладаг. (Д.З; Ч.Л нар)

ҮНДЭСНИЙ УХАМСАР (*National consciousness*)

Үндэсний адилслын мэдрэмж, хүний хамаарагдаж байгаа үндэсний бүлэг нийтлэг хэл, соёлтой болохыг ухамсарласныг илэрхийлэх ойлголт юм. Үндэсний ухамсар нь үндэстэн төлөвших үеэс буй болдог. Хамт олны оршин байгааг, хувь заяа нэгдмэл болохыг, бүлгийн бусад хүмүүс байхгүй бол би, эсхүл бид гэж байхгүй болохыг ухамсарласан байдал юм. Үндэстэнд хамаарах бүх хүн нийтлэг зан заншил, итгэл үнэмшилтэй байж, аливаа зүйлд хандах хандлага нь төстэй болохыг ухамсарлаж хамтын адилсал бүхий гэдгээ мэдэрдэг. Энэ бүхний үндсэн дээр өөрсдийгөө бусдаас ялгаж “бид” гэсэн мэдрэмжтэй болно. Үндэсний ухамсарт нийгмийн янз бүрийн үнэт зүйлд хандах бүлгийн хандлага, түүхэн хөгжлийн явц, өнгөрсөн ололт амжилт, ирээдүйн зорилтуудыг туссан байдаг. Үүнээс гадна үндэсний ухамсрын гол бүрэлдэхүүн хэсгүүдэд үндэстний материаллаг ба оюун санааны үнэт зүйлд хандах ухамсартай хандлага, тэдгээрийг арвижуулахын төлөө бүтээх чадвар, үндэсний ашиг сонирхлыг хангах, бусад үндэстэн-угсаатны бүлгүүдтэй амжилттай харилцах шаардлагатайг ухамсарлах зэрэг олон зүйл багтана. Энэ бүхнийг харгалзан үзвэл үндэсний ухамсар бол тухайн үндэстний оюун санааны хөгжлийн түвшинг тодорхойлдог нийгэм, улс төр, эдийн засаг, ёс суртахуун, гоо зүй, философи, шашин болон бусад үзэл бодол, итгэл үнэмшлийн цогц юм. Үндэсний ухамсар бол угсаатны нийгэмлэгийн урт хугацааны соёл, түүхэн хөгжлийн бүтээгдэхүүн юм. Нийгмийн ухамсрын бусад хэлбэрийн

нэгэн адил үндэсний ухамсар нь онолын ухамсар ба ердийн ухамсар гэсэн хоорондоо харилцан уялдаатай хоёр бүрэлдэхүүн хэсгийн цогц юм. Энгийн үндэсний ухамсар гэдэг нь үндэсний өргөн олон түмний өдөр тутмын ухамсарт бодит байдлыг аяндаа, эмпирик байдлаар туссаны үр дүнд бүрэлдсэн үндэсний ухамсрын эмпирик түвшин юм. Энгийн ухамсрын хамгийн чухал шинж чанар бол хамгийн энгийн, “анхдагч” ухамсар учраас тодорхой үндэсний-угсаатны бүлгэмд харьяалагддагаа мэдэрдэг хүмүүсийн ухамсар хэлбэрээр илэрхийлэгддэг явдал юм. Үндэстэн, угсаатны сэтгэл хөдлөл, мэдрэмж, үзэл бодол, төлөв байдал, зан үйлийн хэм хэмжээ нь үндэсний үнэт зүйлийг дагаж мөрдөхийг ахуйн түвшинд зайлшгүй болгодог. Тэдгээрийг голчлон хүмүүсийн нийтлэг газар нутаг, хэл соёл, зан заншил, ерөнхийдөө өдөр тутмын амьдралын нийтлэг нөхцөл бий болгодог. Энгийн үндэсний ухамсар нь халдварлах чадвар ихтэй бөгөөд энэ нь түүний тархалтыг эрчимтэй болгодог. Нотолгоонууд нь хар ухаанаас үүдэлтэй “өдөр тутмын үнэмшилтэй байдал”-аар ялгагдана. Энгийнээс ялгаатай нь онолын үндэсний ухамсар нь үндэсний ухамсрын гол чухал зүйлсийг шинжлэх ухаанаар боловсруулж, нийгэм, улс төрийн хувьд тодорхой байдлаар нэгтгэн дүгнэх явдал юм. Энэ бол түүх, орчин үеийн байдал, улс үндэстний хөгжлийн зорилтуудын ерөнхий эерэг үнэлгээ, үндэсний-угсаатны бүлгийн төлөөлөгчид бүрийн заавал дагаж мөрдөх үнэлэмж, зан үйлийн хэв шинжийг багтаасан үндэсний, угсаатны үзэл суртал юм. (Ц.Д)

ҮНИЙН ХЯНАЛТ (*Price control*)

Төрөөс бүтээгдэхүүн үйлчилгээний зах зээлийн үнэнд тавих хязгаарлалтын хэлбэр бөгөөд бараа, үйлчилгээний

хомстол үүсэхээс сэргийлэх, инфляцыг хязгаарлах, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлдэг. Бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд худалдаалах дээд үнийг тогтоох эсвэл доод үнийг тогтоох гэсэн үнийн хяналтын үндсэн хэлбэр байна. Түүнчлэн зах зээлийн гажуудлыг засах зорилгоор зарим нэр төрлийн бүтээгдэхүүний хувьд Засгийн газраас худалдан авах үнэ тогтоох, тодорхой хугацаанд тогтмол үнэ тогтоох зэрэг хяналтын хэлбэрийг ч ашигладаг.⁸ (Б.Б)

ҮНЭЛГЭЭ (Evaluation) “Бодлого эсвэл хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааны үнэ цэнэ, ач холбогдлыг тодорхойлох үйл явц. Бодлого хэрэгжсэнээр ямар үнэ цэнэ бий болсон бэ, эсвэл бий болох вэ? гэдэг асуултад хариулах зорилготой бодлогын шинжилгээний нэг арга хэрэгсэл нь бодлогын үнэлгээ юм⁹. Өөрөөр хэлбэл тухайн бодлого, хөтөлбөр, төсөл, үйл ажиллагаа хэрэгжсэнээр бий болсон үр дүн ямар үнэ цэнэтэй зүйлийг бүтээв, энэ үнэ цэнэтэй зүйл нь анхны тавьсан зорилго, зорилттой хэр зэрэг нийцтэй байна вэ гэдэг асуултад хариулна. Үнэлгээг урьдчилсан, явцын, нэгтгэн дүгнэх гэж гурав ангилал бөгөөд энэ ангилал нь бодлого, хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааны аль үед нь үнэлгээ хийгдэж байгаагаас хамаарна¹⁰. Үнэлгээг хийхэд үнэлгээний шалгуур үзүүлэлт чухал үүргийг гүйцэтгэнэ. “Хяналт-шинжилгээ, үнэлгээ” гэдэг хоршоо үгийг практикт өргөн хэрэглэдэг ч үүний цаана “Хяналт-шинжилгээ” ба “Үнэлгээ” гэсэн хоёр ялгаатай хяналтын төрөл бий. (М.А)

ҮНЭНЧ БАЙДАЛ (Loyalty) Аливаа хэм хэмжээ, үзэл санаа, үйлсэд хүн үнэнч байж, чин сэтгэлээсээ зүтгэхийг хэлнэ. Монголчууд “төр түмнийхээ төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр зүтгэх” гэж ярилцдаг нь үнэнч байдал хэмээх энэ ойлголтын агуулгыг илэрхийлнэ. Үнэнч байдал нь уг хүний чин сэтгэл (honesty)- эс урган гарч болно. Өөрөөр хэлбэл итгэл үнэмшлийнхээ үүднээс аливаа хүн байгууллага, зорилго, үйл хэрэгт үнэнч байж, бие сэтгэл, хүчин чадлаа зориулдаг байж болно. Нөгөө талаас хууль, эсхүл ямар нэг хэм хэмжээгээр оноосон үүргийн дагуу үнэнч байж болно. Үнэнч байдал бол төрийн албан хаагчийн нэг онцлог шинж байх учиртай. Энэ бол Монголын төрт ёсны уламжлалт хэм хэмжээний нэг юм. Монголын төрт ёсны уламжлалд “төрийн түшмэл нь нэгэнт цалин пүнлүү авч буйн учир өөрийгөө төрд худалдагдсан бие” хэмээн үзэж, төр улсдаа зүтгэх ёстой гэсэн зарчим байдаг. Энэ бол нэгэнт өөрөө төрийн албыг сонгож, алба хашиж байгаа бол чин сэтгэлээсээ төрийн хууль дүрмийг биелүүлж, нийтийн сайн сайхны төлөө ажиллах ёстой гэсэн үг юм. Орчин үед төрийн албан хаагч нь Үндсэн хуулиар тодорхойлсон төрийн үйл ажиллагааны зарчмууд, Төрийн албаны тухай хууль, ТАХ-ийн ёс зүйн дүрмийг чандлан сахиж, нийтийн сайн сайхны төлөө гэсэн сэтгэлээр ажилладаг байх ёстой. Аливаа явцуу эрх ашигт үйлчлэх, улс төрийн нам хүчинд үйлчлэх, төр түмний эрх ашигт хохирол учруулах үйлдэл гаргаж үл болно (Ц.Д).

ҮНЭНЧ ШУДАРГА ЗАН (Honesty)¹¹

Энэхүү нэр томьёонд шинжлэх ухааны үүднээс оноосон нэр томьёо монгол хэлэнд хараахан байхгүй байна. Англи монгол хэлний олон толь бичигт

8 Stephanie Laguerodie and Francisco Vergara: Theory of Price Control, Review of Political Economy, 2008.

9 Амартүвшин М., Амарбаясгалан Д., Бямбасүрэн Я., ... нар, “Төрийн бодлогод хөндлөнгийн үнэлгээ хийх нь” гарын авлага 5, 2020, 110 дахь тал.

10 Амартүвшин М., Амарбаясгалан Д., Бямбасүрэн Я., ... нар, “Төрийн бодлогод хөндлөнгийн үнэлгээ хийх нь” гарын авлага 5, 2020, 110 дахь тал.

11 Pediaa (2016). Difference Between Hoesty ans Integrity. Pediaa.com/difference-between-Hoesty-and-Integrity/

түүнийг “шулуун шударга зан, илэн далангүй байх, эрс зан, үнэн сэтгэл” гэх мэтээр орчуулдаг. Нэр томьёоны утгыг авч үзвэл үнэнч, чин сэтгэлээсээ хандах, хуурч мэхлэхийг цээрлэдэг зан чанар юм. Итгэж болохуйц зан ааштай хүн гэсэнтэй ижил юм. Хүний хувийн шинж чанарын нэг үзүүлэлт юм. Гэхдээ ихэвчлэн үг яриатай холбоотой байдаг. Ийм зан чанартай хүн ямар нэг ёс зүйн код/дүрмийг сахиж ёстой учраас үнэнч, чин сэтгэлтэй байгаа бус өөрийн итгэл үнэмшил, хүмүүжил, дадлын улмаас л чин сэтгэлээсээ шударга, үнэнийг эрхэмлэдэг гэсэн үг юм. Гэвч үнэнч зан нь шударга байдлын баталгаа болдоггүй. Өөрөөр хэлбэл, үг ярианы хувьд үнэнч занг илэрхийлдэг боловч үйлдэл нь адил байдаг гэсэн үг биш юм (Ц.Д).

ҮНЭТ ЗҮЙЛ (Value) Үнэт шилдэг чанар, аливаа зүйлийн үнэлэмжийн эх загвар болж чадах юмс үзэгдэл, объект, санаа бодлыг илэрхийлдэг ойлголт¹² юм. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн хэрэгцээтэй, хүсүүштэй, итгэл найдвар болж буй зүйлийн тухай ойлголт юм. Юмс үзэгдлийн үнэт зүйл нь гурван үндсэн хэлбэртэй байж болно. Нэгд, нийгмийн амьдралын хүрээнд бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, нийгмийн ухамсрын үр дүнд төлөвшин буй болсон хүсэл эрмэлзлийн хэлбэр, Тухайлбал, шударга ёс, ардчилал, тэгш эрх гэх мэт Хоёрт, материаллаг болон оюуны бодит бүтээгдэхүүний хэлбэрээр оршин байж болно. Ёс зүй, гоо сайхны, улс төрийн, эрхийн гэх мэт. Гуравт, нийгэм, бие хүнийг холбох нэгж сажим болох тухайн хүний хувийн онцлог чанар, үнэт чиг хандлага, зан төлөвийн хэлбэртэй байж болно. Гэхдээ үнэт зүйлийг үнэлэх үнэлэмж нь түүнийг хэрхэн ойлгохоос хамааран ялгаатай байдаг. Философийн хувьд хүний оюун

санааны хүчин чармайлтын зорилго болох үнэнч, сайн сайхан байдал, гоо зүй гэх мэтийг бодитойгоор зөвтгөхийг хэлнэ. Сэтгэл зүйн хувьд хүний хэрэгцээ, ялангуяа оюуны, сэтгэл хөдлөл, хүсэл зоригийн хэрэгцээг хангаж чадах шинжтэй байна гэсэн үг юм. Эдийн засгийн хувьд хүний хэрэгцээг хангахуйц бүтээгдэхүүний ашигт чанарын түвшинг хэлнэ. Гэхдээ үнэт зүйл нь үнэс ялгаатай байдаг. Эрэлт, нийлүүлэлтийн тооноос хамаарч үнэ үргэлж хэлбэлзэж байдаг бол үнэт зүйлийн үнэлэмж нь харьцангуй тогтвортой байдаг. Ямар ч тохиолдолд үнэт зүйлс нь хувь хүн эсвэл бүлгийн үйлдлийн үндэс суурь болдог. (Ц.Д)

ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ЭРХЭМЛЭХ ҮЗЭЛ

(Valueism)¹³ Бодит үзэгдэл гэхээсээ илүү агуулагдаж буй болон түүнд байх ёстой үнэт зүйлд ач холбогдол өгдөг хандлага юм. Өөрөөр хэлбэл, үнэт зүйлийг эрхэмлэх гэдэг нь философи, ёс зүй, эдийн засаг, сэтгэл зүй зэрэг салбарт өргөн хүрээнд авч үздэг үнэт зүйлийн онолын нотолгоо буюу үзэл суртлыг хэлнэ. Төрийн захиргааны шинжлэх ухаанд үнэт зүйлийг эрхэмлэх үзэл нь 1970-аад оны үед гарч ирсэн захиргааны зан үйлийн онол (administrative behaviorism) -ыг шүүмжилсэн шинэ удирдлагын сургуулийн гэгдэх нотолгоонуудыг системчилсэн онол юм. Энэ онол нь хэрвээ захиргааны зан үйлийн онол үнэт зүйл, үнэн баримтыг үгүйсгэх юм бол хоосон савтай адил гэж үздэг. Тиймээс захиргаа өөрөө үнэт зүйлийг агуулдаггүй ойлголт тул зорилго, үйл ажиллагаанаас нь үнэт зүйлийг хасах юм бол залуургүй хөвж буй завьтай адил ажээ. Захиргааны үнэт зүйлс нь үнэмшил төрүүлэхүйц байдлаар үндэслэгдсэн байх шаардлагатай. Үнэт зүйлийн онолын үүднээс авч үзвэл

¹² 한호섭(1999). 행정학 용어 사전. 서울, 행정학용어표준화연구회, 새 정보 미디어, p. 6.

¹³ Мөн гэнд, p. 7.

үндэслэл гэдэг нь үнэлгээний функц өөрөө дагаж мөрдөх шалгуур болох хэм хэмжээг хэлдэг бөгөөд нийтээр хүчин төгөлдөр дагах үнэт зүйлсийн суурийг бүрдүүлдэг. Тиймээс шинэ захиргааны онолыг голлон анхаардаг зүйл нь хэм хэмжээ буюу дүрэм журам, гүн ухаан, үнэт зүйлсийг олж илрүүлэх, практик туршлага, хувь хүн болон байгууллагын ёс зүй, иргэн төвтэй захиргаа, нийгмийн тэгш байдлыг хангах явдал юм. Төрийн удирдлага дахь үнэт зүйлийг эрхэмлэх үзлийг эрдэмтэн Вальдо (D.Waldo) болон түүний удирдлага дор Фредериксон (H.G.Frederickson), Хамонг (M.M. Hammon), Марини (F.Marini) зэрэг эрдэмтэд хөгжүүлэн дэлгэрүүлсэн. (Ц.Д)

ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ (Decline in value) Биет ба биет бус хөрөнгийн зах зээлийн үнэ нь түүний нягтлан бодох бүртгэлд тусгагдсан бүртгэлийн үнээс бага байх тохиолдлыг үнэ цэнийн бууралт гэж нэрлэнэ. Хөрөнгө оруулагчид, хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцогчид аливаа үнэт цаас, санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнийн бууралтыг тооцож хөрөнгө оруулах эсэх шийдвэр гаргадаг. Харин байгууллага санхүүгийн тайландаа тусгагдсан бараа, бүтээгдэхүүн, авлага зэрэг эргэлтийн хөрөнгө ба эргэлтийн бус хөрөнгийнхөө үнэ цэнийн бууралтыг тооцож хөрөнгийнхөө бодит үнэ цэнийг тодорхойлж бүртгэдэг. Үнэ цэнийн бууралт тооцоход баримтлах бодлого, аргачлалаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ тусгана. Ийнхүү үнэ цэнийн бууралтыг стандартын дагуу тооцоолж бүртгэх нь байгууллагын санхүүгийн төлөв байдлыг үнэн зөв илэрхийлэх, санхүүгийн тайлангийн мэдээллийг хэрэглэгчдэд үнэн, бодит мэдээлэл өгөх ач холбогдолтой. (Б.Б)

ҮР АШИГ (Efficiency) Орц (нөөцийн зарцуулалт) ба гарц (бүтээгдэхүүн, үйлчилгээ)-ын харьцаагаар тодорхойлогдох үзүүлэлт бөгөөд нөөцийн зарцуулалтын нэгж тутмаас хүртэх өгөөж. Төрийн салбарын хувьд иргэдэд хүргэх зорилтот үйлчилгээг хамгийн бага боломжит зардлаар хэрэгжүүлэх зорилгын биелэлтээр үр ашгийг тодорхойлдог. Жишээлбэл, эрүүл мэндийн салбарт хэрэгжих төслийн эдийн засгийн үр ашгийг нэг хүнд ногдох эмчилгээний тоног төхөөрөмжийн хүртээмж, нэг эмчид ногдох үйлчлүүлэгчийн тоо, өвчлөлийг бууруулсан үзүүлэлт, нэг өвчтөнд ногдох орны тоо зэрэг үзүүлэлтээр хэмжиж болно. Эдийн засгийн үр ашгийг дотор нь хуваарилалтын үр ашиг, үйлдвэрлэлийн, нийгмийн, динамик үр ашиг гэх зэргээр ангилж үздэг. Төсвийн хөрөнгийн хуваарилалтын үр ашиг нь төрийн бодлогын тэргүүлэх чиглэлд хөрөнгийг хуваарилахдаа иргэдэд үйлчлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгыг хангахуйцаар оновчтой хуваарилж чадсан эсэхээр хэмжигдэнэ. (Б.Б)

ҮР ДҮН (Result/Outcome) Аливаа үйл явц, үйл ажиллагааны эцэст хүрсэн түвшин, хүртэх ашиг тус эсвэл сөрөг нөлөөлөл, зорилго, зорилтын биелэлтийг хэлнэ. Үр дүн нь гарц (output)-аас ялгаатай ойлголт бөгөөд гарц нь хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээг илэрхийлэх бол үр дүн нь тухайн үйл ажиллагаа, үйлчилгээнээс иргэдийн хүртсэн ашиг тус, өгөөж, эсвэл сөрөг нөлөөллийг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, үр дүн нь аливаа төсөл хөтөлбөр, үйл ажиллагааны зорилгын хэрэгжилтийг илэрхийлэх үзүүлэлт байдаг. Жишээлбэл, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх

төслийн хувьд төсөлд хамрагдсан албан хаагчдын тоо нь гарцын үзүүлэлт бол үр чадварт ахиц гарсан албан хаагчдын тоо нь үр дүнгийн үзүүлэлт болно. Үр дүн нь үйлдэл, үйл ажиллагааны хэрэгжилтийн төгсгөлд шалтгаан, үр дагаврын холбооноос үүдэлтэйгээр аливаа төлөв, нөхцөл байдалд гарсан өөрчлөлт юм.¹⁴ (Б.Б)

ҮР ДҮНГИЙН ТЭГШ БУС БАЙДАЛ (*Inequality Result*) Хүмүүс ижил түвшний материал баялаг буюу амьжиргааны ижил түвшний нөхцөлийг эзэмшихгүй байгаагаас болж үүссэн тэгш бус байдал юм. Хөгжлийн онол нь орлого, эд баялаг, боловсрол, эрүүл мэнд, хоол тэжээл зэрэг амьдралын чанар, стандартын тэгш бус байдалтай холбон авч үздэг. Гэсэн хэдий боловч эдийн засагчид ахиц дэвшлийг ихэвчлэн орлого болон хэрэглээгээр хэмждэг. Тухайлбал, Кузнецийн муруй, жини коэффициент. Эхэн үедээ нэг хүнд ногдох орлогын дундаж өсөлтөөс хамаарсан орлогын тэгш бус байдлыг авч үздэг байсан. Орлогын өсөлт нь аажимдаа “бүх завийг өргөнө” хэмээн үздэг байсан учраас хуваарилалтын асуудлыг хойш тавьдаг байв. Гэвч эдийн засгийн өсөлт нь тэгш бус байдалд найдвартай нөлөөлдөггүй, харин орлогын тэгш бус байдал нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байгааг судалгаанууд харуулж эхэлсэн. Цаашилбал орлогын тэгш бус байдал өссөн нь эдийн засгийн өсөлтөд хуваарилалтын асуудал байгааг тодорхой харуулсан. (Б.П)

ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ (*Result based monitoring and evaluation*) Тодорхой төрийн бодлого, хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааг хэрэгжүүлснээр ямар ахиц дэвшил гарч байгааг болон

төлөвлөсөн үр дүндээ хүрч, тодорхой үнэ цэнийг бий болгож чадаж байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгдсэн үйл ажиллагаа бөгөөд захиргааны хяналтын нэг төрөл юм. Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ нь “үр дүнд нь юу болов?”, “засгийн газар бодлого, хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлсэн боловч тэд үнэхээр бодитой, хүсэн хүлээсэн үр дүнд бий болгож чадсан уу?” гэсэн асуултад хариулт өгнө¹⁵. Тухайлбал стандартад нийцсэн, сайн чанарын замтай болох нэг хэрэг ч түүний үр дүнд иргэдийн болон орон нутгийн амьдралд ямар нөлөө (үр дагавар, үр нөлөө) үзүүлсэн бэ гэдгээр үр дүн хэмжигдэнэ. Тиймээс анхнаасаа бодлого, хөтөлбөрийг боловсруулахдаа тогтоосон хугацаанд хүрэх үр дүн (хүсэн хүлээж буй үр дүн)-г тодорхой тусгаагүй бол үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл үр дүнгийн төлөвлөлт хийгдээгүй бол үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжгүй юм. Уламжлалт ойлголтоор хяналт-шинжилгээ, үнэлгээ нь хэрэгжилтэд илүү анхаарч, тухайн бодлого, хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааны орц, үйл явц, гарцад төвлөрөн хийгддэг байсан бол орчин үед үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг (орц, үйл явц, гарцаас гадна үр дагавар, үр нөлөөг багтаасан) төрийн захиргааны практикт чухалчлах болсон байна. Энэ нь захиргаа бүхэлдээ үр дүнд суурилсан менежментийг хэрэгжүүлэх болсонтой уялдаатай. (“Хяналт-шинжилгээ”, “Үнэлгээ” гэдэг үгийн тайлбарыг харна уу.) (М.А)

ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН (*Results oriented*)

“Result” гэдэг нь XV зууны эхээр латины “resultare” үгнээс гаралтай.

¹⁵ Жоди Золл Кусек, Рей С.Рист, “Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх 10 алхам”, 2010, 9 дэх тал.

¹⁴ UN Development Group, Result Based Management Handbook, 2012

Үгийн утга нь “урагшаа үсрэх, үсрэлт (to spring forward, rebound)” гэсэн утгатай. “Orient” гэдэг нь Латины “orientem” буюу “нар мандах (the rising sun)/нар мандах зүг (part of the sky where the sun rises)” гэсэн санааг илтгэх бөгөөд энэ үгийн ерөнхий утга нь “зүг чигээ олох” юм. Үгийн нийлэмжийн авч үзвэл “result oriented” гэдэг нь урагшаа явах чигээ олох гэсэн санаа байна. Монгол хэлнээ үүнийг “үр дүн (эцсийн ашиг тус, нийлбэр дүн монгол хэлний талбар толь)-д чиглэсэн” гэх утгаар ойлгож байна. Үр дүнд чиглэсэн гэх нэр томьёо нь төрийн захиргааны шинэчлэлийн үйл явцтай холбогдон гарч ирсэн ойлголт юм. Төрийн салбар, төрийн үйлчилгээ, захиргааны үйл ажиллагаанд “үр дүн” “үр нөлөө”-г чухалчилж үзэх хандлага бөгөөд үндсэндээ төрөөс үзүүлж байгаа үйлчилгээ нь иргэддээ хүрч, үр дүнтэй байж чадсан уу гэдэгт анхаарал хандуулдаг. Энэ нь дүрэм журам, зааварт хэт баригдах гэхээсээ илүү үр дүн, үр нөлөөг чухалчилж үздэг. Байгууллага, нэгж, албан хаагч нь зорилго, хүрэх үр дүнгээ тодорхой томьёолж, үр дүнг нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр хэмждэг болж эхэлсэн. Засгийн газар, төрийн байгууллага нь дэвшүүлсэн зорилгодоо хүрч чадсан эсэхийг үнэлдэг болсонтой холбоотой. Үр дүнд чиглэсэн удирдлага нь гүйцэтгэлийн үр дүн (үр дагавар, үр нөлөө)-д гол анхаарал хандуулдаг гүйцэтгэлийн удирдлагыг сайжруулахад чиглэсэн төрийн салбарын удирдлагын стратеги юм. Үр дүнд чиглэсэн удирдлагын тогтолцоо нь бүхэлдээ улс орны хөгжил, иргэдийн сайн сайхан байдлын төлөө төрийн салбарын бүх нэгжийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх зорилготой. Үр дүнд чиглэсэн удирдлагын гол цөм нь гүйцэтгэл ба хариуцлагын асуудал байдаг.

Өөрөөр хэлбэл, энэ нь гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх шинэлэг стратеги бөгөөд үр дүнг хэмжихийг чухалчилж үздэг. (Т.Т)

ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН ТӨСӨВЛӨЛТ (Result based budgeting)

Төсвийг төлөвлөх нэг арга зүй бөгөөд төрийн үйлчилгээний үр дагавар, үр нөлөөг чухалчлан үздэг. Энэ аргыг хэрэглэх үед төрийн байгууллага, салбарын үйл ажиллагаанаас хүлээгдэж буй үр дүн (үр дагавар, үр нөлөө)-г тодорхойлж түүнийг харгалзан нөөцийг хуваарилж төсөвлөнө. Үр дүнд чиглэсэн төсөвлөлтийн үед орц болон үр дүнгийн харьцаагаар төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр өгөөжийг тодорхойлно. Үр дүнд чиглэсэн төсөвлөлт нь үр дүн, гүйцэтгэлийн удирдлагын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Үр дүнд чиглэсэн төсөвлөлт нь стратегийн зорилго, зорилгоо, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хэрэгжилтийн эцэст хүрэх үр дүнгээ урьдчилан тооцох, үр дүн, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, шалгуур үзүүлэлтээ хэмжих арга зүй, мэдээллийн эх үүсвэрээ тогтоох, хүлээгдэж буй үр дүнд нөлөөлж болзошгүй эрсдэлийн хүчин зүйл, түүний нөлөөллийг үнэлэх, эцэст нь эдгээрийг харгалзан зорилгод хүрэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг тооцож төсөвлөх гэсэн харилцан уялдаатай үе шатаар хэрэгждэг. (Б.Б)

ҮР НӨЛӨӨ (Effectiveness) Төрийн үйлчилгээ, үйл ажиллагаанд дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэр амжилттай биелүүлснийг илтгэх нэг үзүүлэлт. Үр нөлөөг төрийн бодлого, төсөл, хөтөлбөрийн урт хугацааны үр дүн гэж тодорхойлох бөгөөд эерэг үр дүнд хүргэх зөв зүйлийг хийсэн эсэхээр хэмжигдэнэ. Жишээлбэл,

эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлсэн төслийн үр нөлөөг өвчнөөс урьдчилан сэргийлсэн хүний тооны өсөлт, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн өсөлт, амьдралын чанар дээшилсэн байдал зэрэг үзүүлэлтээр хэмжинэ. Төрийн бодлогын үр нөлөөг илэрхийлэхэд нийгмийн гишүүдийн эрх тэгш байдал, амьдрах орчин, нөхцөл, үйлчилгээ авах боломж, хүртээмжийн тэнцвэрт байдал, тухайн төсөл, хөтөлбөр хэрэгжсэнээр хойч үедээ үзүүлэх эерэг болон сөрөг нөлөө, урт хугацааны хөгжлийн зорилгод нийцтэй байдал, байгаль орчин, хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдал зэрэг нийтлэг үзүүлэлтийг ашигладаг. Урт хугацаанд хэрэгжих төсөл, хөтөлбөрийн үр нөлөөг илэрхийлэх, хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, түүний биелэлтийг тогтвортой хэмжих тогтолцоог бүрдүүлэх нь чухал байдаг ба энэхүү тогтолцоо нь үнэлгээнд ашиглах мэдээлэл сан, мэдээллийг цуглуулах арга зүй, оролцогч талууд, тэдгээрийн харилцаа, чиг үүргийн хуваарилалт зэргээс бүрдэнэ. (Б.Б)

ҮР ӨГӨӨЖ ХҮРТЭГЧ (*Beneficiaries*)

Төрөөс хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт хамрагдаж гарц, үр дүнг нь хүлээн авч байгаа зорилтот бүлэг, иргэд. Төсвийн санхүүжилтээр эсвэл олон улсын байгууллагын тусламж, дэмжлэгтэйгээр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн шууд хүлээн авагч тал (хувь хүн, иргэдийн бүлэг, байгууллага, бүс нутаг гэх мэт) нь тухайн төсөл, хөтөлбөрийн үр өгөөж хүртэгч болдог. Үр өгөөж шууд ба шууд бус хүртэгч гэж ангилдаг. Төрийн үйлчилгээний чанар бүхэлдээ сайжирч эерэг хандлага гарснаар ард иргэд төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр өгөөжийг хүртэгч болно. (Б.Б)

ҮҮЛЭН ТООЦООЛОЛ (*Cloud computing*)

Хаанаас ч өөрт тохиромжтой сүлжээний хандалтаар бусадтай хуваалцахад зориулсан тооцоолох нөөц (сүлжээ, сервер, хадгалуур, программ хангамж болон үйлчилгээ)-өөс өөрийн хэрэгцээнд тохируулан ашиглах бололцоог олгодог загвар. Энэ загвараар нэгэн зэрэг олон холбогдогч төв тооцооллын нөөцөд интернетээр дамжуулан шууд холбогдож ажилладаг. Үүлэн тооцооллын хүчин чадал ба мэдээлэл хадгалах нөөц чадал нь хувь хүн ба байгууллагын хэрэглэгчдэд хэрэглэснээрээ төлөх, хөрөнгө оруулалт болон мэдээллийн технологийн ашиглалт, үйлчилгээний хүний нөөцийн хэмнэлт зэрэг чухал давуу боломжуудыг өөрийн мэдээллийн төвүүдээрээ (data center) олгодог. Үүлэн тооцооллын үндэслэл нь нийтийг хамарсан дэд бүтэц болон бусадтай хуваалцах үйлчилгээ гэсэн өргөн хүрээтэй зарчим юм. Үүлэн тооцоолол нь нэг байгууллагаар хязгаарлагдсан байгууллагын (enterprise cloud) эсвэл олон байгууллага ашиглах боломжтой нийтийн (public cloud) хэлбэртэй байж болдог. (Д.З; Ч.Л нар)

ҮҮЛЭН ТООЦООЛОЛД СУУРИЛСАН БАЙГУУЛЛАГЫН НӨӨЦ УДИРДАХ СИСТЕМ (*Cloud ERP*)

Нөөц удирдлагын системийг үүлэн тооцооллын системд модуль болгон оруулж үйлчилгээ хэлбэрээр санал болгодог загвар. Энэ загварт нөөц удирдлагын системийг үүлэн тооцоолол бүрэн хариуцдаг. Том биш байгууллагын хувьд нөөц удирдлагын системээ үүлэн тооцоололд суурилсан загвараар шийдэх нь хүний нөөц бага, маш бага дэд бүтцийн зардал, цар хүрээгээ хялбар өөрчлөх боломжтой зэрэг давуу тал үүсдэг. (Д.З; Ч.Л нар)

ҮҮЛЭН ТООЦООЛОЛД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭ (*Cloud computing services*)

Сервер, хадгалуур, өгөгдлийн сан, сүлжээ, програм хангамж, шинжилгээ болон хиймэл оюуныг багтаасан тооцоолох үйлчилгээг интернет (үүлэн тооцоолол)-ийн тусламжтай хүргэж уян хатан нөөц, хурдтай инновац ба эдийн засгийн үр ашгийг санал болгодог үйлчилгээ. Үүлэн тооцоололд суурилсан үйлчилгээг хувь хүн, байгууллага нь хэрэглэснээрээ төлдөг зарчим нь ашиглалтын зардал бага, дэд бүтцийг илүү үр ашигтай байлгадаг болон үйл ажиллагаагаа хэрэгцээнийхээ өөрчлөлтөөр өргөтгөх боломжтой байхад тусална. Мөн системийн найдвартай байдал, аюулгүй байдлыг үүлэн тооцооллын үйлчилгээ үзүүлэгч байгууллага хариуцдаг. Ихэнх үүлэн тооцоололд суурилсан үйлчилгээнүүд нь дэд бүтцийн үйлчилгээ (infrastructure as a service - IaaS), платформын үйлчилгээ (platform as a service - PaaS), сервергүй тооцоолох, программ хангамжийн үйлчилгээ (software as a service - SaaS) гэж өргөн дөрвөн ангилалд хуваагддаг. Сүүлийн үед бизнес шинжилгээ болон хиймэл оюун, машин сургалтын үүлэн тооцоололд суурилсан үйлчилгээний хэрэглээ өсөн нэмэгдэж байна. (Д.З; Ч.Л нар)

ҮҮРГИЙН ЗӨРЧИЛДӨӨН (*Role conflict*)

Хүн өдөр тутмын амьдралдаа ажил, амьдралын олон дүрд олон янзын үүрэг гүйцэтгэх шаардлагатай байдаг бөгөөд нэгэн зэрэг бүх үүргийг тэнцвэржүүлж чаддаггүй. Ихэнх тохиолдолд эдгээр үүрэг нь хоорондоо зөрчилддөг.¹⁶ Эрдэмтэн Katz болон Kahn (1978) нар тухайн хүний өдөр тутмын амьдралдаа гүйцэтгэдэг хувийн болон ажил албаны

өөр өөр үүргүүд нэг нь нөгөөгөө биелүүлэхэд хүндрэл учруулахыг үүргийн зөрчилдөөн гэнэ хэмээн тодорхойлсон. Үүргийн зөрчилдөөн нь үүргүүд хоорондоо зөрчилдөх, эсрэг шаардлага тулгарах, үүрэг, үнэт зүйлсийн хоорондоо зөрчилдөх үед үүсдэг.¹⁷ Байгууллагад ажиллагсдын ажлын хариуцлага, тэдний чадвар, цаг хугацаа, нөөцийн хооронд үл нийцэх байдал нь үүргийн зөрчилдөөн үүсэх нэг шалтгаан болдог. *Жишээлбэл:* Үүрэг даалгавраа биелүүлэхэд хангалттай цаг байхгүй, шаардлагатай техник, хэрэгсэл байхгүй, ажлын хэт ачаалал зэрэг нь үүргийн зөрчилдөөнийг бий болгодог. (З.А)

ҮҮРЭГ-ЗОРИЛГЫГ ДАХИН ХЯНАХ

(*Task Review*) Захиргааны үүргийг зорилго, үр дүн, үр ашиг талаас нь системтэйгээр шинжлэх арга юм¹⁸. Энэхүү шинжилгээ нь нэг удаагийн арга хэмжээ биш тасралтгүй үйл явц байх ёстойг онцлон тэмдэглэсэн байдаг. Шинжилгээг захиргааны үүрэг тус бүрээр хийх бөгөөд үүний үр дүнд захиргааны үйл ажиллагааг хэрхэн сайжруулах вэ гэдэгтэй холбоотой шийдвэр гарна. Захиргааны үүрэг-зорилгыг дахин хянах нь захиргааны үйл ажиллагааг сайжруулах, үүргийг оновчлох, үүргийн хэрэгжилтийг сайжруулахад чиглэгдэнэ. Захиргааны үүргийн шүүмжлэлийг зорилгын (уг үүрэг нь захиргааны үүрэг мөн үү?, бид зөв зүйлийг хийж байна уу? гэдэг асуултад хариулах) болон хэрэгжүүлэлтийн шүүмжлэл (үүргээ зөв хэрэгжүүлж байна уу? гэдэг асуултад хариулах) хэмээн хоёр ангилж үзнэ. 1970-аад оноос захиргааны шинэтгэлийн хүрээнд “захиргааны

16 Palomino, M.N., & Frezatti, F. (2016). Role conflict, role ambiguity and job satisfaction: Perceptions of the Brazilian controllers, *Revista de Administraçao*, 15(2), 165-181.

17 Bhatta, G. (2015). *International Dictionary of Public Management and Governance*. New York: Routledge, p. 555.

18 Klaus Koenig, Heinrich Siedentopf (Hrsg), “Oeffentliche Verwaltung in Deutschland”, 1997, s. 350.

үүргийг дахин хянахуй” хэмээх сэдэв чухлаар яригдах болж захиргааны шинэтгэлийн чухал аспект, удирдлагын нэг хэрэгсэл болон ашиглагдах болжээ. Зарим бүтээлд “захиргааны үүрэгт шүүмжлэлтэй хандах нь” гэдэг нэр томьёог хэрэглэсэн байдаг. (М.А)

ҮҮРЭГ ХҮЛЭЭЛТ (Engagement) “Engagement” гэх үгийн үндэс нь “engage (+ment)” “үүрэг авах, амлах” гэсэн утгатай үгнээс үүдэлтэй бөгөөд (хэрэглээнд нилээд эртнээс орсон)” гэдэг нь “дээрээс доош чиглэсэн санаачилгыг тосон үүрэг хүлээж оролцох орон нутгийн оролцооны хэлбэр” юм. Өөрөөр хэлбэл, энэ нь төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцох боломжийг хангах төрийн байгууллагын албан ёсны үйл ажиллагаатай холбоотой аж. Төрийн зүгээс иргэнийхээ үгийг сонсдог, тэдэнд шуурхай үйлчилдэг, ажлаа ил тод, нээлттэй явуулах, иргэдийн оролцоог хангах үйл ажиллагааг энд хамаатуулж ойлгоно. Ийм хэлбэрийн оролцоо нь төрийн байгууллага, албан тушаалтныг иргэдийнхээ санаа бодол, санал санаачилгыг бодлого, шийдвэртэй тусгах, иргэний нийгмийг төлөвшүүлэхийн төлөө анхаарч ажиллахыг шаарддаг. Энэ хүрээнд төвлөрлийг сааруулах, орон нутгийн төсвийн эрхийг нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад өгөх, төсвийг төлөвлөх, зарцуулах, хяналт тавих боломжийг өгдөг. Тухайлбал, манай улсын хувьд иргэдийн оролцооны үндсэн хэлбэр буюу мэдээлэх, зөвлөлдөх, идэвхтэй оролцоо, иргэдийн хяналт боломжийг холбогдох хууль эрх зүйн зохицуулалт (жишээ нь: орон нутгийн хөгжлийн сангийн тухай журам, 2018)-аар хангасан байдаг. Төрөөс санаачилсан орон нутгийн хөгжлийн сангийн журам нь “аймаг,

сумдад байгаа Засаг захиргааны хэт их эрх мэдлийг иргэдийн гарт шилжүүлж ингэснээр тэдний оролцоотой сум орон нутгийг хөгжүүлэх таатай боломжийг олгох зорилготой” юм. Энэ нь нөгөө талаас орон нутгийн өөртөө хүлээх үүргийг бий болгодог. (Т.Т)

ҮҮРЭН ХОЛБООНЫ ДУГААРААР БАТАЛГААЖУУЛАХ (Mobile verification) Төрийн болон бизнесийн байгууллагын цахим үйлчилгээнд хэрэглэгчийг системд бүртгэхэд эсвэл нэвтрэхэд үүрэн холбооны дугаараар баталгаажуулах үйл явц. Баталгаажуулалтын явц нь хэрэглэгчийн бүртгэлтэй үүрэн холбооны дугаарт мессеж эсвэл дуун мессежээр илгээсэн нэг удаагийн баталгаажуулах кодыг оруулснаар системд нэвтрэх эрх олгох эсвэл системийн бүртгэлийг хүчин төгөлдөр болгох дараалалтай. Үүрэн холбооны дугаар олгохдоо иргэний бүртгэлийн мэдээллийг тулгаж баталгаажуулдаг тул иргэнийг цахим орчинд таньж баталгаажуулах найдвартай хэлбэр юм. Монгол Улсад төрийн үйлчилгээний нэгдсэн порталд нэвтрэхэд үүрэн холбооны дугаараар баталгаажуулдаг. (Д.З; Ч.Л нар)



ФАЁЛ, ХЭНРИ (*Fayol, Henri, 1841-1925*) Францын инженер. 1860 онд Сент Этиений уул уурхайн сургуульд (École Nationale Supérieure des Mines) элсэн оржээ. Уул уурхайн компанид инженерээс эхлэн гүйцэтгэх захирал хүртэл албан хашиж байжээ. Тэрбээр “аж үйлдвэрийн ерөнхий менежмент” (Administration Industrielle et Gynйгale) хэмээх нэртэй номыг Ф. Тейлор менежментийн шинжлэх ухаанч зарчмууд (Principles of Scientific Management) номоо гаргаж байхтай нэгэн зэрэг гаргасан байна. Түүнийг бизнесийн удирдлагын ерөнхий онолыг (фаёолизм ч гэж нэрлэдэг) үндэслэгчдийн нэг гэж үздэг байна. Фаёол менежмент нь төлөвлөх, зохион байгуулах, чиглүүлэх, уялдуулах, хянах гэсэн таван үндсэн чиг үүрэгтэй хэмээн тодорхойлжээ. Түүнчлэн менежментийн арван дөрвөн зарчмыг тодорхойлж тайлбарласан байна. Удирдлагын чиг үүрэг болон зарчмын талаарх түүний үзэл санаа одоо ч ач холбогдолтой хэвээр байгаа ба орчин үеийн менежментэд зарим талаар хэрэглэгддэг байна. Ерөнхий онолын эдгээр үндэслэлүүд захиргааны удирдлагад ч хамааралтай юм. (А.Ц)

ФЕМИНИЗМ (*Feminism*) Феминизмийн үзэл баримтлалын гол агуулга нь аль ч улс орны эдийн засаг, улс

төр, нийгмийн харилцаанд эмэгтэй хүйсийн тэгш байдлын тухай авч үздэг. Феминизм нь эмэгтэйчүүдийн амьдрах арга замыг тодорхойлох, иргэн хэмээх ойлголтод нийцэх эмэгтэй хүйсийн эрх, эрх чөлөө, тэгш байдал, мөн хүйс, жендэрийн ялгаатай хандлагуудад шүүмжлэлтэй ханддаг онолын үзэл баримтлал, судлагдахуун юм. Феминизм хэмээх нэр томьёо нь олон янзын утгаар илэрхийлэгдэж ирсэн. Жишээлбэл Америк болон Европын зарим судлаачид феминизмийг түүхэн талаас нь улс төрийн хөдөлгөөн гэж нэрлэдэг. Зарим судлаачид ялангуяа, Францад феминизм бол нийгэм дэх эмэгтэйчүүдийн шударга бус байдлын талаарх итгэл үнэмшил, үзэл санааны чиг хандлага гэж үздэг. XX зууны эхэн үеэс Америкийн Мичиганы их сургуулийн улс төр судлалын төвөөс эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог сонгуультай холбоотойгоор судалж эхэлснээр феминист хандлагатай судалгааны чиглэл шинжлэх ухааны эргэлтэд орсон байдаг. Феминизмийн тухай дэлгэрэнгүй танин мэдэхэд барууны улс орнуудад түгэн дэлгэрсэн улс төрийн хөдөлгөөн, феминизмийн давлагаануудтай шууд холбоотой юм. Феминизм нь 1960-аад оны эхэн үеэс өнөөдрийг хүртэл гэр бүл, боловсрол, ажил эрхлэлтэд эмэгтэй хүйсийн эрх чөлөө, тэгш эрхтэй



холбоотой байсан бол XXI зууны эхэн үеэс нийгмийн шударга ёс, тэгш байдал, эмэгтэйчүүдийн манлайлал, улс төрийн сонгогдох эрхийн тухай асуудлууд илүү анхаарлаа хандуулж байна. Феминизмийн онолын судалгаа нь эмэгтэйчүүдийн хүчирхийлэлд өртөж буй бүх асуудалд анхаарч, хэрэгжүүлэх хоёр гол арга зам нь олон нийт-бүлэг, хувийн амьдралын харилцаанд өөрчлөлт оруулах, улмаар нийгмийн бүхий л харилцаанд хүйсийн эрхэд суурилсан агуулгын өөрчлөлт оруулахад чиглэгдэж байна. (Я.Т)

Фоллет, Мэри Паркер (Follett, Mary Parker, 1868-1933) Америкийн нийгмийн ажилтан, менежментийн зөвлөх бөгөөд байгууллагын онолын анхдагч эмэгтэй эрдэмтэн. Брейнтри дахь коллежийн бэлтгэл сургуульд сурч байгаад 1885 онд Анна Тикнорын гэрээр сургах сургуульд элсжээ. 1890-91 онд Кембрижийн их сургуульд суралцаж байгаад мөн тэндхийн Эмэгтэйчүүдийн сургуульд шилжин суралцжээ. Харвардын их сургуульд элсэх гэсэн боловч эмэгтэй хүн гэдгээр нь элсүүлж аваагүй байна. Маш олон бүтээл туурвиж хэвлүүлж байжээ. Тэрбээр Лондонгийн Эдийн засгийн сургуульд уригдан менежментийн лекц уншсан анхны эмэгтэйчүүдийн нэг аж. Хожим Ерөнхийлөгч Теодор Рузвельт түүнийг урин, төрийн бус, ашгийн бус байгууллагын менежментийн талаар зөвлөгөө авч байжээ. Тэр 1900-1908 онуудад нийгмийн ажилтнаар ажиллаж байсан нь үзэл санаанд нь ихэд нөлөөлсөн байна. Мэргэжлийн болон оройн сургалт зэргийг удирдаж байхдаа бүлгийн тухай онолоо боловсруулж байжээ. Мөн оролцоот ардчилал, “нэгдмэл” нийгмийн тухай үзэл санаагаа дэвшүүлжээ. Хувь хүн болон нийгэм нь харилцан бие биедээ нөлөөлж төлөвшүүлж байдаг ажээ.

Фоллет шатлал бүхий байгууллагын дотоод үйл явцыг судлан албан бус үйл явц чухал болохыг тогтоожээ. Түүний бүтээлд бүлэг дэх харилцан ашигтай хамтын ажиллагааны философи, шинэчлэгч хошуучлалын тухай гэх мэт менежментийн ухааны олон үзэл санаа агуулагдаж байдаг байна. Тэрбээр менежментийн салбарт хамаарах хэд хэдэн бүтээл (The Speaker of the House of Representatives 1896; The New State 1918; Creative Experience 1924; Dynamic Administration: The Collected Papers of Mary Parker Follett 1942) туурвисан байна. (А.Ц)

ФРАНЦЫН ЗАХИРГААНЫ УЛАМЖЛАЛ (Administrative tradition of France) Францын захиргааны хөгжил 1789 оны хувьсгалаас эхтэй. Бүгд найрамдах засаг тогтсон учраас албан хаагчид хааны бус, төрийн албан хаагчид болон хувирчээ. Гэвч удалгүй хаант засаглал эргэн сэргэж, зуу шахам жил болсон ч гэсэн албан хаагч нь нэг хүний бус нийтийн эрх ашгийн төлөө үйлчилдэг зарчим хадгалагдан үлджээ. Ийнхүү төрийг нэг хүнээр төлөөлүүлэхээ больсон нь зохион байгуулалт, үүрэг хариуцлага, эрх хэмжээ зэргийг хөндсөн нийтийн эрхийн олон хууль гаргахад түлхэц өгсөн байна. Пруссийн засаг захиргааны бүтцийг авснаас гадна захиргааны эрх зүйн шинэ хэм хэмжээнүүд нэмэгдсэн байна. Наполеон I захиргааг хөгжүүлэх талаар олон арга хэмжээг авсан байна. Албан хаагчдын захирах захирагдах шатлал, удирдлагын цэгцтэй систем, байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгожээ. Засаг захиргааны шинэ хуваарь буй болгож улс орноо департаментуудад хуваасан байна. Нэгж бүрийн захиргаа нь нийтийн хэв журам сахиулах, эрүүл мэндийг хамгаалах, ёс суртахууныг сахих үүрэгтэй болсон байна. Техникийн

болон төрийн албан хаагчдыг бэлтгэх зориулалттай Политехникийн сургууль байгуулжээ. Европын анхны захиргааны шүүхийг буй болгожээ. Энэ үед Францын захиргаанд бүрдсэн олон шинж чанарыг Европын болон дэлхийн бусад орны захиргаа тусган авсан ажээ. Гуравдугаар бүгд найрамдах улсын үе буюу 1870-1940 -өөд оны үед Францын захиргаа хэт томорсны дээр ажиллах чадвар доройтож, улс төрийн нөлөөлөлд орсон аж. 1946 онд захиргааны реформ хийжээ. Төв засгийн газрын захиргааны албаны бүтцийг өөрчилж, албан хаагчдыг шилэн сонгох ажлыг төвлөрүүлж төрийн албыг хариуцсан тусгай яам байгуулжээ. Мөн төрийн дээд түвшний албан хаагчдыг бэлтгэх зориулалттай тусгай сургууль- Йcole National d'Administration - ийг байгуулсан байна. (А.Ц)

ФРОЙД, ЗИГМУНД (*Freud, Sigmund Schlomo, 1856-1939*) Австрийн сэтгэл зүйч, мэдрэлийн эмч. Психоанализийг үндэслэгч. Зигмунд багадаа утга зохиол, философийг ихэд сонирхон, Шекспир, Гегель, Шопенгаур, Ницше нарын бүтээлийг уншдаг байжээ. Тэрбээр олон хэл мэддэг байсан байна. Гётегийн байгалийн тухай бүтээлүүдийн нөлөөгөөр анагаахын сургуульд оржээ. Венийн их сургуулийн анагаахын салбарт сурч байхдаа бусад оюутнаас хичээл зүтгэл, амжилтаараа ялгаран тэтгэлэг авч, судалгаа туршилтын ажилд удаа дараа оролцож байжээ. 1881 онд төгсөлтийн шалгалтыг онц дүнтэй өгч, докторын зэрэг авчээ. Гэр бүлийн санхүүгийн байдлаас болоод судалгааны ажлаа орхиж, эмчийн ажил хийж эхэлжээ. Эхлээд мэс засалчаар, дараа нь мэдрэлийн эмчээр ажилласан байна. Удалгүй хүүхдийн саа, хэл ярианы өөрчлөлт зэрэг өвчнийг оношлох талаар

амжилтад хүрч, эдгээр сэдвээр бүтээл гаргах болжээ. 1885 онд өрсөлдөөнд ялж алдарт сэтгэл зүйч Жан Шаркын удирдлагын дор дадлагажихаар Парист очсон байна. Дараа жил нь Парисаас Берлинд очиж Адольф Багинскийн хүүхдийн эмнэлэгт дадлагажсан байна. Венад буцаж ирсний дараа судалгааны ажлын хажуугаар эмчийн ажлаа хийх болжээ. Түүний эмчилгээний арга, судалгааны бүтээлүүдийг тэр үеийн судлаачид, эмч нар шүүмжилж байсан ч, ажлаа шаргуу хийсний үр дүнд одоо үед психонанализ хэмээн нэрлэдэг шинжлэх ухааны чиглэл болон эмчилгээний аргыг үндэслэсэн байна. Фройдын бүтээлүүдийн дотроос сэтгэцийн гурван бүрэлдэхүүнт загварыг боловсруулсан, хувь хүний сэтгэц-бэлгийн хөгжлийн өвөрмөц үеүдийг ялган тогтоосон, Эдипын өвчний тухай онолыг үндэслэсэн, сэтгэцийн хамгаалалтын механизм болон далд ухамсрын тухай ойлголтыг сэтгэцийн талаас нь тайлбарласан, зүүдний тайллын тухай онолыг нээсэн зэргийг гол амжилт нь хэмээн үздэг байна. Тэрбээр асар олон бүтээл туурвисан нь 26 боть болдог байна. Түүний эрдмийн өв уламжлал сэтгэл судлал, анагаах ухаан, социологи, антропологи, утга зохиол, урлаг зэрэг XX зууны мэдлэг ухааны олон салбарт нөлөөлсөн байна. Фройдын бие хүний тухай онол, хүний зан үйл, бүлгийн сэтгэл зүй, хувь хүний бие даасан байдал болон соёлын хамаарлын тухай онол, үзэл санаа нь бизнес, захиргааны удирдлагын ухаанд арга зүйн ач холбогдолтой ажээ. (А.Ц)

ФУНКЦИОНАЛ ЭРХ МЭДЭЛ (*Functional authority*) Функционал эрх мэдэл нь хязгаарлагдмал төрийн эрх мэдэл юм. Хэн нэгэн албан тушаалтанд хязгаарлагдмал шугаман хэлбэрийн эрх мэдэл өгснөөр зөвхөн өөрийн

хариуцсан ажил үүргийн хүрээнд бусад албан хаагчдад тодорхой шаардлага тавих, хууль, дүрэм журам сахиулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй болдог. Өөрөөр хэлбэл өөрийн эрх мэдлийн хүрээ хязгаарыг давахгүйгээр бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Тухайлбал, байгууллагыг удирдаж буй хүн байгууллагын хүрээний бүх асуудлыг хянах, зохицуулах бүрэн эрх мэдэлтэй боловч тодорхой асуудлууд, чиглэлийн хүрээнд уг асуудлыг хариуцсан хүмүүсийг ажиллуулж байвал энэ нь функционал эрх мэдэл юм. (Ж.Ж)

X

ХААЛТТАЙ ТОГТОЛЦОО (*Closed system*)

Төрийн захиргааны байгууллагын судалгаанд хаалттай болон нээлттэй гэсэн хоёр загварын хандлага байдаг. Хаалттай тогтолцоо нь Макс Веберийн бюрократ онол дээр суурилдаг бөгөөд шаталсан, чадахуй буюу мерит зарчим, ур чадвараар албан тушаал дэвших, карьерын зарчмаар хөгжих, дүрэм журам, зохицуулалт дээр тулгуурлах, төрийн албан хаагчдын дунд болон үйлчлүүлэгчидтэй харилцахдаа хувийн ашиг сонирхлоор асуудалд ханддаггүй зэрэг онцлог шинжтэй. Хаалттай тогтолцооны хамгийн гол шинж нь шаталсан пирамид бүтэц бөгөөд түүний үе шат бүрийн толгойд эрх мэдэл бүхий албан тушаалтан ажиллана. Хэвтээ харилцаа байхгүй, зөвхөн босоо түвшинд харилцаа явагдана. Хаалттай тогтолцоонд ажиллаж байгаа хүн бүрийн үүрэг хариуцлага тодорхой, алдаа гаргавал хариуцлага заавал хүлээнэ. Байгууллага болон удирдлагадаа үнэнч байж тушаалыг даган биелүүлэх бөгөөд бүхэлдээ хүлцэнгүй, дуулгавартай байна. (Ж.Ж)

ХААЛТТАЙ ФОРМАТ (*Proprietary format*)

Нууцалж загварчлан кодолсон зөвхөн тухайн байгууллагын хөгжүүлсэн программ эсвэл техник хангамжаар задалж, хөрвүүлэн нээх боломжтой файлын формат. Ийм

файлын өгөгдлийг кодолсон форматын тодорхойлолтыг дэлгэдэггүй, үл задлах гэрээгээр хамгаалсан байдаг. Сүүлийн жилүүдэд программ хангамжийн компаниуд хаалттай форматаас нээлттэй формат руу шилжих болсон. Майкрософт компани нь 2007 онд баримт боловсруулах хаалттай формат (.DOC, .XLS, .PPT)-аа нээлттэй формат (.DOCX, .XLSX, .PPTX)-тай болгосон. Хаалттай форматыг зах зээлээ хамгаалах эсвэл мэдээллийн нууцлалыг хангах зорилгоор ашигладаг. Төрийн байгууллага дотроо өөрийн үүсгэсэн хаалттай форматыг ашиглах нь мэдээллийн аюулгүй байдлыг сайтар хангадаг боловч хөгжүүлэлтийн болон ашиглалтын нэмэлт зардал үүсдэг. (Д.З; Ч.Л нар)

ХАКЕР (*Hacker*) Мэдээллийн систем, дэд бүтцэд зөвшөөрөлгүйгээр хандах зорилго бүхий хорт үйлдэл хийгч хэрэглэгч. Хакер нь техникийн өндөр мэдлэгтэй мэргэжилтэн байдаг бөгөөд системийн алдаа, цоорхойг илрүүлэн системийн хамгаалалтыг эвдэн нэвтэрдэг. Хакерын үйлдлийг хууль ёсны этгээд хуулийн хүрээнд хийх тохиолдол бий. Жишээ нь хууль сахиулах байгууллагууд заримдаа гэмт хэрэгтэн болон хорлон сүйтгэгчдийн нотолгоог цуглуулах зорилгоор хакерын техникийг ашигладаг. Хакер

нь дараах төрлүүдтэй байдаг: Үүнд:

Цагаан хакер (White hat hacker) нь бусад хакеруудаас өгөгдлийн найдвартай байлгах зорилгоор системийн эмзэг байдлыг илрүүлэх үйлдлийг системийн эзний захиалгаар ажлын хөлстэйгөөр гүйцэтгэдэг. Системийн эзний зөвшөөрөлтэйгөөр гүйцэтгэдэг учраас тэдний үйлдэл нь хууль бус гэж тооцогддоггүй.

Хар хакер (Black hat hacker) нь хувийн хонжооны сэдэлтэй өгөгдлийг хулгайлж, ашиглаж, зарах хорлон сүйтгэх үйлдэл хийдэг. Тэдний үйлдэл нь хууль бус юм.

Саарал хакер (Grey hat hacker) нь зугаацах зорилгоор эдийн засгийн хонжоогүйгээр эмзэг байдлыг ашиглаад буцааж засдаг. Хэдийгээр энэ нь хорлон сүйтгэх ажиллагаа биш ч системийн эзний зөвшөөрөлгүй тул хууль бус байдаг. Тэд ихэвчлэн хар хакертай холбогддог. (Д.З; Ч.Л нар)

ХАЛАМЖИЙН УЛС (Welfare state)

Халамжийн улс нь иргэдийн эдийн засаг, нийгмийн амьдралын баталгааг хангаж, хамгаалахад гол үүрэг гүйцэтгэнэ. Халамжийн улсын бодлого нь баялгийн тэгш хуваарилалт, тэгш боломжийн зарчим дээр суурилж, амьжиргааны доод түвшинд байгаа иргэдийн өмнө хариуцлага хүлээн, тэднийг сайн сайхан амьдралын нөхцөл боломжоор хангахыг зорьдог. Халамжийн улсын тухай ойлголт нь янз бүрийн улс орнуудад өөр өөр утгыг илэрхийлдэг. Тухайлбал, АНУ-д төрөөс олгож буй халамж шууд утгаараа буудаг бол зарим оронд иргэддээ цогц, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангахын төлөө ажилладаг төрийн төгс загвар, Европын орнуудад нийгмийн хамгаалал гэсэн утгаар зөвхөн улс хариуцахгүй, сайн дурын, бие даасан оролцогч талууд төрийн үйлчилгээг

хамтран хүргэдэг нийгмийн халамжийн тогтолцоо болж хөгжсөн байна. Халамжийн улсын тухай үзэл санаа Европын улс орнуудад XVII зууны үеэс бий болж тавигдсан бөгөөд ядуу иргэдэд тусламж үзүүлдэг байв. Төрийн бодлогын түвшинд тусгайлан тусгаж нэвтрүүлсэн улс нь Герман (1890-1914) байв. 1883 онд өвчний даатгал, 1884 онд ажлын байран дахь ослын даатгал, 1889 онд тэтгэврийн даатгалыг тус тус нэвтрүүлсэн байна¹. Дэлхийн I дайн дуусах үед Европын ихэнх оронд даатгалын ямар нэгэн хэлбэр нэвтэрсэн бөгөөд АНУ, Канадад 1920-1930-аад онд мөн нэвтэрсэн байна. 1980-аад оноос хойш даяаршлын нөлөөгөөр олон улсын зах зээлүүд нэгдэж, улс орнууд нээлттэй болох, үндэстэн дамнасан корпорацуудын тэлэлт, олон улсын санхүүгийн байгууллагуудын үүрэг оролцоо, нөлөө нэмэгдсэнээр халамжийн төрийн бодлого хумигдах, шүүмжлэлд өртөх болсон байна. Ялангуяа хөгжиж байгаа орнуудын хувьд баян хоосны ялгаа нэмэгдэх, нийгмийн доод давхаргад амьдарч байгаа иргэдийн нийгмийн хамгааллын асуудал улам хурцаар тавигдах болжээ. Нэг үгээр хэлбэл даяаршил нь төрийн халамжийн бодлогыг хязгаарласан байна. 2020 онд эхэлсэн Ковид-19 цар тахал нь дэлхийн улс орнуудыг нийгмийн хамгаалал, халамжийн бодлогоо эргэн харах, сэргээх, цар тахлын улмаас ажилгүй, орлогогүй болсон нийгмийн дунд, доод давхарга руу чиглэсэн арга хэмжээнүүд авахад нөлөөлсөн юм. (Ж.Ж)

ХАЛХ ЖУРАМ (Khalkh procedure)

1709 оноос эхлэн Халхын ноёдын чуулганаар баталсан гурван хошууны их цааз гэдэг хууль юм. Уг хуулийн эхэнд оролцсон 32 хүний нэрийг заагаад Бүрэн Ханы өвөр, Ивэнгийн

¹ International Encyclopedia of Political Science. Bertrand Badie. SAGE. 2011. Government, p. 2747.

гол дээр шороон үхэр жил зун дунд сарын 28-ны өдөр хэлэлцэн тогтов хэмээн тэмдэглэсэн байдаг. Хожим хэд хэдэн удаа нэмэлт оруулжээ. Тэр үеийн Монголын нийгмийн гол гол харилцааг зохицуулах хэрэгцээг үндэслэн зохиосон эрүү, иргэн, гэр бүлийн зэрэг 200 орчим зүйлийн харилцааг хуульчилсан аж. Уг хууль Баруун хүрээний халх журам, Их хүрээний шувь яамны халх журмын дүрэм гэсэн хоёр хувилбартай. 1789 оноос Манжийн хууль дүрмийг хэрэглэх болсон учраас Халх журмыг зөвхөн Богдын шавийн дотор мөрдөх болжээ. (А.Ц)

ХАМААРАЛ БҮХИЙ ТАЛУУД (*Related parties*)

Хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгжийн хувьд нэг тал нь нөгөө талаа хянах чадвартай буюу санхүүгийн болон үйл ажиллагааны шийдвэр гаргахдаа нөгөө талдаа нөлөөлөх чадвартай бол хамаарал бүхий талууд гэж үздэг. Хамаарал бүхий, холбоотой талуудыг тодорхойлох нь эдийн засгийн бодлого, хууль эрх зүйн зохицуулалтыг оновчлоход ач холбогдолтой. Санхүүгийн хувьд холбоотой талуудын хооронд хийгдсэн эдийн засгийн ажил гүйлгээнд ач холбогдол өгч, зохицуулалт хийх нь түгээмэл. Тайлагнагч аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн төлөв байдал, ашиг алдагдалд холбоотой талуудын хийсэн эдийн засгийн ажил гүйлгээ нөлөөлсөн эсэхийг тодруулж тайлагнахыг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар шаарддаг. Түүнчлэн төрийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг хангах зорилгоор албан тушаалтны хувьд хамаарал бүхий талуудыг тодорхойлсон байдаг. Хуулийн нэр томьёонд тусгаснаар

тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг “хамаарал бүхий этгээд” гэж тодорхойлсон². (Б.Б)

ХАМЖИХ ЗАСАГЛАЛ (*Collaborative governance*)

Энэ үгийн үндэс нь “collaborate” гэх бөгөөд Латины “collaboratus” (1845 онд) үгнээс үндэстэй. Үгийн утга нь “бусадтай хамтран ажиллах (to work with another or others)” гэсэн санааг илтгэдэг. Үгийн ерөнхий утга нь “нэг зорилгын төлөө аливаа зүйлийг хамтарч эвсэж хийх (to work together with somebody in order to achieve a single shared goal)” санааг илэрхийлдэг. Гэхдээ харилцаанд орж буй талууд нь эцсийн зорилгодоо хүрэхийн тулд өөр өөрийн эрх ашиг, зорилгыг гүйцэлдүүлэх тухай ойлголт энд багтахгүй.

Доктор, профессор А.Цанжид “collaborative” гэдэг үгийг монгол хэлээр “хамтын, хамтарсан” гэж орчуулдаг боловч үгийн бус утгыг шүтвэл “хамжих” гэдэг нь монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд тайлбарласнаар “туслах, элбэх, хүч хавсрах, хамтрах, хамсан хийх” гэсэн утгатай гэжээ. Ийнхүү “Collaborative governance” гэдгийг монгол хэлнээ “хамжих засаглал”³ хэмээн орчуулан хэрэглэж байна. “Хамжих засаглал” гэдэг нь иргэд шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг бүрдүүлдэг засаглалын хэлбэр юм. Хамжих засаглал нь “төрийн байгууллага нь төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор иргэд, төрийн

2 Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

3 А.Цанжид, 2015 хамжил засаглал, илтгэлүүдийн эмхтгэл, удирдлагын академи, х. 241.

бус байгууллагуудтай албан ёсоор хамтран ажиллах, зөвшилцөлд суурилсан шийдвэр гаргах үйл явц⁴ юм. А.Цанжид (2015, хуудас 242) хамжих засаглал нь дараах агуулгыг багтаадаг гэжээ. Үүнд:

- Зөвлөлдөх үйл ажиллагааг төрийн байгууллага, газар санаачлах
- Түүнд төрийн бус оролцогчдыг татан оролцуулах
- Оролцогчид нь зөвхөн зөвлөх төдий бус шийдвэр гаргахад шууд оролцох
- Зөвлөлдөх үйл ажиллагаа нь албан ёсны байх ба хамтарсан уулзалт хэлбэртэй байх
- Зөвлөлдөх уулзалт нь шийдвэрийг зөвшилцөлд суурилан гаргах зорилго агуулах
- Зөвлөлдөх үйл ажиллагаа нь төрийн бодлого, төрийн менежментийн асуудлыг хамарсан байх

Хамжих засаглалын онцлог нь нэгд, нээлттэй засаглал, хоёрт, энэ нь хааяа болдог хурал цуглаан биш, гуравт, үйл явцад иргэд өргөнөөр оролцох, дөрөвт, сайн дурын оролцоонд тулгуурладаг⁵ байна. (Г.Т)

ХАМТЫН АЖИЛЛАГАА (Cooperation)

Хамтын ажиллагаа гэдэг үг нь “co-operate” буюу “бусадтай хамтран ажиллах “to operate jointly with others to the same end,”. 1600 онд Латины “co-operatus” гэх үгнээс үндэстэй, үгийн утга нь хамтран ажиллах “to work together with” юм. Ерөнхий зорилго (common goal)-ын хүрээнд хэн нэгэн этгээд өөрийн зорилгыг (one’s own goal) хангах үүднээс бусадтай хамтран ажиллах тухай юм. Монгол хэлний тайлбар тольд хамтын ажиллагаа гэдгийг “ямар нэг байгууллага, хүнтэй

хамтран хийх хөдөлмөр, нэгдэж ажиллах явдал” гэжээ. Төрийн салбарт хамтын ажиллагааны тухай ойлголтыг нь 1990 оны сүүлчээр Их Британид “хамтрагч төр”, 2000 оноос хойш Австралид “цогц засгийн газар”, 1990 онд Америкт “франчайз засгийн газар” зэрэг санал санаачилгатай адилтган үздэг. Өөрөөр хэлбэл, энэ нь төрийн захиргааны шинэчлэлийн үйл явцын нэг бөгөөд үүнд төр, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг хамаатуулж ойлгодог. Энэ нь өнөөгийн бидний хэллэгээр төр, хувийн хэвшлийн түншлэл юм. Төр, хувийн хэвшлийн түншлэл нь хоёр талын хамтын ажиллагаанд тулгуурладаг. Эдгээр хоёр тал нийтийн эрх ашгийг хангахад чиглэсэн ерөнхий зорилгын хүрээнд тодорхой ажил үйлчилгээг хамтран гүйцэтгэдэг. Ингэхдээ хоёр тал өөр өөрийн эрх ашиг, зорилгыг хангах үүднээс гэрээ байгуулан хамтран ажилладаг. Эндээс хамтын ажиллагаа гэдэг нь ерөнхий зорилгын хүрээнд хоёр тал өөр өөрийн эрх ашиг, зорилгоо гүйцэлдүүлэх үүднээс гэрээ байгуулан хамтран ажиллаж байгаа хэлбэр юм. Төр тодорхой ажил үйлчилгээг бусдаар гүйцэтгүүлэх сонирхолтой, харин хувийн хэвшил нь тухайн ажлыг гүйцэтгэсний төлөө мөнгө /эсвэл ашигтай зүйл/ олж авах эрмэлзэлтэй байдаг. Гэвч хоёр тал хоёулаа өөр өөрийн эрх ашгийг хамгийн их байлгахын төлөө ажиллах болдог. Иймээс хоёр тал эрх ашгаа хэрэгжүүлэхийн тулд хамтын ажиллагааны гэрээ байгуулах зарчмаар түншлэн ажилладаг. Энэ нь эцсийн дүндээ нийтийн эрх ашгийн төлөө буюу нийгмийн сайн сайхан байдлыг бий болгоход чиглэдэг. (Г.Т)

ХАМТЫН ХОЛБОО (Confederation)

Холбоо гэсэн утгатай латин үг. Хоёр ба түүнээс дээш тооны эрх тэгш,

4 Chris ansell, alison gash, collaborative governance in theory and practice, journal of public administration research and theory, 2007, p. 544.

5 А.Цанжид, 2015 хамжил засаглал, илтгэлүүдийн эмхтгэл, удирдлагын академи, х. 243.

цаашдаа ч тусгаар тогтносон хэвээр байх улсууд нэгдэн байгуулсан холбоог хэлнэ. Конфедераци нь төвлөрсөн төртэй нэг улсын, эсвэл нэг төртэй холбооны муж улсуудын эсрэг утгыг илэрхийлэх бөгөөд хэд хэдэн тусгаар тогтносон улсууд улс төр, эдийн засгийн ба баглан хамгаалах зэрэг ерөнхий асуудлаар нэгдэн байгуулсан улсуудын холбоог хэлнэ. Энэхүү байгууламж, томьёолол нь Их Британи, Швейцар, Канад зэрэг улсуудын түүхэнд тод илэрч байсан бол эдүгээ Европын холбооны конфедераци тод жишээ болно. (Я.Т)

ХАМТЫН ХҮЧ/СИЕРГИ (Synergy)

Стратегийн удирдлагад ихэвчлэн ашигладаг энэхүү нэр томьёо нь Грек хэлний synergos үгнээс гаралтай ‘хамтын ажиллагаа’, ‘хамтын хүч’ гэсэн утга илэрхийлдэг. Хамтын хүч буюу синерги гэдэг талуудын хамтын ажиллагаа, хичээл зүтгэлийн үр нөлөө юм. Энэ нь оролцогч талууд өөрсдийн хүчин чармайлт, мэдлэг ур чадвар, нөөц боломжоо нэгтгэж тус тусдаа хийж чадахаасаа илүү ихийг хамтдаа бүтээж, илүү өндөр гүйцэтгэл, үр дүнд хүрнэ гэсэн санааг илэрхийлдэг.⁶ Өөрөөр хэлбэл талуудын хамтран хийсэн бүтээмж нь тус тусдаа хийсэн бүтээмжээс ямагт илүү байх үзэгдэл. Аливаа үйл ажиллагаанд оролцогчид өөрсдийн туршлага, мэдлэг ур чадвар, технологи зэрэг нөөцийг хуваалцах замаар нэгдмэл байдлыг бий болгож чадвал илүү амжилт гаргаж, зорилгодоо хүрч чаддаг байна. (З.А)

ХАНДЛАГА (Attitudes) Бусад юмс үзэгдэл, хүмүүсийн талаарх хувь хүний үзэл бодлыг хандлага гэнэ. Өөрөөр хэлбэл, нөхцөл байдал, бусад

хүмүүсийг тааламжтай, тааламжгүйн аль нэгээр нь үнэлэх хувь хүний үнэлэлт⁷ юм. Танин мэдэх, мэдрэмж, сэтгэгдэл, зан үйл гэсэн гурван бүрдэл хэсгээс хандлага бүрддэг гэж хүмүүсийн харилцааг судалдаг эрдэмтэд үзсэн байдаг. Хандлагын эргэцүүлэн бодож, танин мэдэх бүрдэл хэсэг нь мэдээлэл, итгэл үнэмшил, санаа бодол гэсэн бүтэцтэй. Мэдрэмж сэтгэгдэл гэсэн бүрдэл хэсэг нь хандлагын объектын талаарх мэдрэмжийг, тухайлбал, ажилдаа сэтгэл ханамжтай эсвэл сэтгэл дундуур байх хандлагыг илэрхийлнэ. Харин зан үйлийн бүрдэл хэсэг нь хандлагын объектод урьдчилан хандах төлөв байдал бөгөөд зан үйлээр илэрдэг байна. (Ц.Д)

ХАРААТ БАЙДАЛ (Dependent)

Шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд хоёрдогч этгээд буюу бусдын эрх мэдэл, үзэл бодол, дарамт шахалт, нөлөөлөлд автагдах хүрээ, хүрээнд оршин байх явдал юм. Төрийн байгууллага, албан тушаалтны аливаа үйлдэл, шийдвэр нь шууд харьяалах албан тушаалтан, эсвэл бусад субъектээс хэт хамааралтай байх нөхцөлийг “хараат байдал” гэж тодорхойлох ба энэ нөхцөлд байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа шударга, хариуцлагатай, хяналттай байх давуу талтай боловч үйл ажиллагааны хэвийн байдал алдагдаж, тогтоосон хэм хэмжээнээс хазайх, сөрөг үр дагавар бий болгох сул талтай. (Г.Б)

ХАРААТ БУС БАЙДАЛ (Independent)

Шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд хоёрдогч этгээд буюу бусдын эрх мэдэл, үзэл бодол, дарамт шахалтаас үл хамааран бодит байдал, баримт нотолгоо, судалгаа шинжилгээ, дүгнэлтэд, баримтад

6 Hitt, M. A., Ireland, R. D., & Hoskisson, R. E. (2007). Strategic Management: Competitiveness and Globalization (Concepts and Cases), 7th edition. Mason: Thomson South-Western, pp. 211-212.

7 한호섭 (1999). 행정학 용어 사전. 서울, 행정학용어표준화연구회. 새 정보 미디어

үндэслэх байдлыг илтгэдэг. Төрийн байгууллага, албан тушаалтны аливаа үйлдэл, шийдвэр нь бусад субъектээс хамааралгүй байх нөхцөлийг “хараат бус байдал” гэж тодорхойлох ба энэ нөхцөлд байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа хэвийн явагдах, гаднын нөлөөнөөс ангид бие даасан байх давуу талтай ч дур зоргоор авирлах, эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах зэрэг сул талтай. (Г.Б)

ХАРИЗМ (Charisma) Эл нэр томьёоны уг гарал нь эртний грекийн *χάρις* хэмээх үгнээс үүсэлтэй бөгөөд эртний Грекийн домогт “бусдыг өөртөө татах чадвар” гэсэн утгаар хэрэглэгдэж байжээ. Тийм ч учраас эртний Грекийн гоо сайхны охин тэнгэрийг *Χαρμ* хэмээн нэрлэдэг байжээ. Харин Христийн шашинд бурхны бэлэг (God’s gift) гэж үзэж байсан аж. Бурхны эл бэлэг нь “Хүн бүрд заяагддаггүй чадвар, хүч”, “Давтагдашгүй зүйл”, “Бусдыг татах бурхны хүч, сүр жавхлан”, “Хүмүүний сэтгэлийг дагуулах хувь хүний онцгой хүч (personal idiosyncratic power)” зэрэг утгатай ажээ. Эхэн үед анхны утгаараа хэрэглэгдэж, Бурхан эзний ач ивээлийг хүртэж, удирдан зохион байгуулах чадвар заяагдсан “бурхны бэлэг”-тэй Христийн шашны ажилтнууд Ариун Сүнсний оршихуйг тайлбарлахад ашигладаг байжээ. Социологид эл нэр томьёог анх Эрнст Трельч оруулсан юм. Германы эрдэмтэн Вебер (M.Weber) эрх мэдлийн төрлийг уламжлалт эрх мэдэл, хууль ёсны эрх мэдэл, харизмт эрх мэдэл гэж гурван төрөлд ангилан тайлбарласнаар харизмт эрх мэдлийн тухай социологийн ойлголт бий болжээ. Вебер өөрөө «Харизм гэдэг бол ер бусын, хүн бусын гэж юмуу ядахдаа л бусад хүнд байдаггүй өвөрмөц хүч, шинж чанартай хэмээн үнэлэгдэхэд хүргэдэг бие хүний хэвийн бус шинж

чанар юм” хэмээн тодорхойлсон юм. Энэ бол харизм нь бие хүнд төрөлхөөс заяасан байдаг хэмээх үзэл юм. Нөгөө талаас харизмт шинжид хүн багаасаа суралцдаг бөгөөд хожим дадал зуршил байдлаар илэрхийлэгддэг гэсэн үзэл байдаг. Харизм бүхий бие хүмүүс нийгэмд сэтгэл зүйн нөхцөл бүрдсэн үед тодорч гарах бөгөөд хүмүүс ялангуяа ямар нэг зорилго, үзэл санааг тойрон нэгдэн нягтрах үед, хямралт үед илүү их тодрон гардаг байна. Харизм гэдгийг монгол хэлэнд суу заль хэмээн хөрвүүлэх нь зүйтэй гэсэн саналыг Ш.Бира нарын зэрэг эрдэмтэд илэрхийлсэн байдаг. (Ц.Д)

ХАРИЗМАТИК МАНЛАЙЛАЛ (Charismatic leadership) Бусдын урам зоригийг бадраах, эрч хүчтэй зан үйл рүү сэдэлжүүлэх, саад бэрхшээлийг даван туулах илүү чадвартай манлайллын хэв шинж юм. Ийм хандлагатай манлайллын үед ажилтнууд байгууллага, хамт олны эрх ашгийг хувийнхаас ямагт дээгүүр тавьж ажилладаг байна. Харизматик манлайлагчийн бусад нөлөөлөх арга хэрэгсэл нь *нэгд*, хүлээн зөвшөөрөгдсөн алсын хараатай, *хоёрт*, хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг үнэт зүйлтэй, *гуравт*, манлайлагч дагалдагчдын харилцаа итгэлцэлд суурилсан байх явдал юм. Ийм хэв шинжтэй манлайлагч өөрчлөлтийн уур амьсгалыг бүрдүүлж, хүмүүсийг өдөөж зоригжуулах, урамшуулах, хүчээ нөөлгүй ажиллах сэдэл төрүүлж чаддаг байна. Мөн харизматик манлайлагч алсын хараагаа хүмүүст хүргэж ойлгуулах ур чадвар эзэмшсэн байдаг. Ийм манлайлагч бий болсон нөхцөл байдлын хүрэннээс хальж, ирээдүйд үйл явдал өрнөх боломжтой хувилбаруудыг боловсруулж, үр дүнтэй стратеги гаргах чадвартай байдаг аж. Дж.Коттер менежмент нь төлөвлөх,

төсөвлөх, ажлыг хуваарилах, хүн хүчийг сонгох, үр дүнг тооцох мэтийн хэвшиж тогтсон ажиллагаануудтай холбоотой бол манлайлал нь хүний зан үйлтэй холбоотой огт өөр зүйл юм гэж үзсэн байна. Үүнээс үүдэн манлайлагчийн шинж чанаруудыг тодорхойлжээ. Үүнд:

- Өөрийн санаа бодол, чадвартаа бараг л бүрэн итгэлтэй байх
- Ирээдүйн хандлагыг бусдаас илүү харж чаддаг байх
- Хүмүүст санаа бодлоо чадварлагаар тайлбарлан ойлгуулж үнэмшүүлж чадсанаар хүмүүсийг үзэл санаагаараа дагуулж чаддаг байх
- Үзэл санаа үнэнч, эрсдэл хийх, хариуцлагыг хүлээхэд бэлэн байх
- Заримдаа хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээтэй зөрчилдөхөөр өвөрмөц зан үйлтэй байх /хэрвээ ингэх нь бусдын гайхшралын төрүүлэн дагуулж үр дүнд хүрэхээр бол/
- Нөхцөл байдлыг соргог мэдэрч, нөөцийг олж чаддаг байх зэрэг ажээ⁸.
- Хүн төрөлхтний түүхэнд Чингис хаан, Наполеон, Мартин Лютер Кинг, Далай лам зэрэг харизм бүхий олон бие хүн төрөн гарчээ. (Ц,Д)

ХАРИЗМТ ЭРХ МЭДЭЛ (*Charismatic authority*) Германы эрдэмтэн Мах Вебер эрх мэдлийг нэр хүндийн оновчтой шинжийг хууль ёсны шинжид тулгуурласан оновчтой, хууль ёсны эрх мэдэл, сонгодог болон уламжлалт зан үйлд суурилсан уламжлалт эрх мэдэл, харизмат суурилсан харизмт эрх мэдэл

8 <http://www.elitarium.ru/liderstvo-harizma-kachestva-rukovoditel-vlijanie-priznanie-sposobnosti/> Kotter, John P. 1996. Leading change. 2012. Aufl. Boston, Mass: Harvard Business

гэж ангилсан. Харизмт эрх мэдэл гэдэг бол нийгэм эсвэл байгууллагын гишүүд (дагалдагчид) удирдагч (манлайлагч)-ийн онцгой чадварыг өндрөөр үнэлж, итгэж, ийм чадвартай хүнийг дагалдах нь зөв гэж үзэх үед бий болдог эрх мэдэл юм. Харизмт эрх мэдэл нь ардчилсан болон ардчилсан бус нийгэмд ялгаатай байна. Ардчилсан нийгэмд харизмт эрх мэдэл нь Үндсэн хууль болон бусад хуулиудын хүрээнд хэрэгждэг бол ардчилсан бус нийгэмд эсрэгээрээ манлайлагчийн санаа бодол хэлсэн үгийг мухар сохроор дагах, хууль дүрмийг үл тоомсорлох байдлаар илэрнэ. Энэ нь яваандаа нэг хүний гарт эрх мэдэл төвлөрөх, ганц хүнийг тахин шүтэх үзэгдлийг буй болгодог. Харизмт эрх мэдэл болон харизмт манлайлал хоёр нь хоорондоо төстэй ойлголт боловч ялгаатай. Харизмт манлайлал гол төлөв манлайлагчийн хувийн шинж чанарын тухай асуудал бол харизмт эрх мэдэл нь манлайлагч болон түүнийг дагалдагчийн хоорондын харилцаатай холбоотой юм. Өөрөөр хэлбэл харизмт эрх мэдэл нь зүй ёсны хэмээн зөвшөөрөгдсөн байдаг нь эл харилцааны шинж болдог байна. (Ц,Д)

ХАРИЗМЫН ИНДЕКС (*Charisma quotient*)⁹ Энэ нь хувь хүний нийгэмших чадварын зэргийг тодорхойлох хэмжүүр юм. Оюун ухааны чадварын индекс (IQ) ба сэтгэл хөдлөлөө удирдах чадварын индекс (EQ)-ийг дагаж гарч ирсэн шинэ ойлголт юм. Ихэнх тохиолдолд хувь хүний амжилтын хэмжүүр болгон ашигладаг. Энд харизм гэдэгт бусдыг өөртөө татах нөлөө болон байгууллага дахь итгэлцэл, манлайлал, хамтын ажиллагааг цогцоор нь багтааж ойлгоно. Өмнөд Калифорнийн Их сургуулийн манлайлын хүрээлэнгийн захирал Жэй Комер харизматик

9 한호섭 (1999). 행정학 용어 사전. 서울, 행정학용어표준화연구회. 새 정보 미디어

манлайлагчид тавигдах шаардлагыг дараах байдлаар томьёолжээ. *Нэгд*, өөрөө болон түүний эргэн тойронд байгаа хүмүүс тэмүүлэх хөгжлийн зорилгыг тодорхойлж чаддаг байх, *Хоёрт*, итгэлцэл, мэргэжлийн итгэл үнэмшлийг төрүүлдэг байх, *Гуравт*, байгууллагын зорилгод бусдыг татан оролцуулах, тэднийг үнэмшүүлэх хүч нөлөөтэй байх ёстой гэжээ. Сүүлийн үед амжилтад хүрэх магадлалын хэмжүүр болох харизмын индекс (CQ)-ийг их сонирхох болсон нь далд ухамсраас үүдэлтэй. Учир нь хүмүүс хувийн амжилтын талаарх тодорхой ойлголтой байх нь их хэмжээний мэдээлэлд дарагдаж өөрийгөө ухамсарлах чадвар, чиг баримжаагаа алдахаас сэргийлж, тэдний чиг баримжаа болно гэж үздэг. (Ц,Д)


ХАРИЛЦАА (Communication)

Байгууллагын доторх хувь хүмүүс эсвэл байгууллагын нэгжүүдийн хооронд тодорхой баримт, санал бодол, мэдрэмжийг хэл, дохио, үйлдлээр дамжуулан харилцан солилцох үйл явц юм.

Communication хэмээх энэхүү үг нь монгол хэлэнд “хүмүүс хоорондын харилцаа”, “санал бодлоо илэрхийлэх” эсвэл “санал бодлоо солилцох”, бүр цаашилбал “мэдээллийн урсгал” гэсэн утгыг агуулж байгаа бөгөөд энэ нь нэг чиглэлд чиглэсэн урсгалыг бус харин хоёр талын харилцах үйл явц (two way process) гэсэн утгыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, илгээгч мэдээллийг хүлээн авагчид дамжуулах, хүлээн авагч тал уг мэдээллийг тайлж ойлгох, улмаар хариу илгээх үйл явцыг харилцаа гэнэ¹⁰. Харилцааны чадвартай байхын тулд хэн (илгээгч), юу (илгээх агуулга), ямар арга замаар (суваг), хэнд (хүлээн авагч), ямар хүлээлт (хүрэх үр дүн)-ээр харилцах гэсэн таван зүйлийг хангасан байх ёстой.

Энд харилцааны үндсэн оролцогчид нь илгээгч болон хүлээн авагч тал юм. Илгээгч тал (transmitter) нь хэн нэгэн хүнд эсвэл бүлэг хүмүүст өөрийн санаа, үзэл бодлоо хүргэх, улмаар шаардлагатай мэдээлэл олж авах, өөрийн санал, бодлоо илэрхийлэх гэсэн зорилго бүхий хүн юм.

Зураг 3. Харилцааны үйл явц



Эх сурвалж: Д.Ганбаатар, Я.Шуурав, Д.Сэржамц (2019). Менежмент. Улаанбаатар. х. 393.

10 Д.Ганбаатар, Я.Шуурав, Д.Сэржамц (2019). Менежмент. х. 392, Улаанбаатар.

Хариу илгээж буй мэдээлэл, илгээх агуулга (message) гэдэг илгээгчийн бусдад хүргэхийг хүссэн санаа, үзэл бодол, зааврыг хэлнэ. Тухайн агуулгыг хүргэж, хүлээн авагч тал тухайн агуулгаар нь ойлгон, хариу үйлдэл үзүүлж байвал харилцааг амжилттай боллоо гэж үзнэ. Мөн суваг (avenue) гэдэг нь илгээгч, хүлээн авагч талуудын хооронд мэдээллийг хүргэх, буцаах гэсэн эргэх холбоог хангаж байгаа орчин (media) юм. Хоёр тал харилцахдаа өөрт нь тохиромжтой, илгээж буй мэдээллийн агуулгатай нийцсэн суваг сонгож авах нь чухал юм. (Ц,Д)

ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ ЧАДВАР (Responsiveness)

“Responsiveness” гэдгийн үгийн үндэс нь “responsive” буюу “хариулт бий болгох, хариулах” гэсэн утгатай. Үгийн ерөнхий утга нь “хариу үйлдэл түргэн шуурхай үзүүлэх боломж (being able to react quickly)” гэсэн санааг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, хариу үйлдэл үзүүлэх чадвар гэдэг нь төрийн байгууллагууд орчны өөрчлөлт, нөхцөл байдлыг бүрэн мэдэрч, уян хатан, дасан зохицох чадвартай байхыг хэлнэ. Ялангуяа, иргэдийн хэрэгцээ, шаардлагыг соргогоор мэдэрсний үндсэн дээр тэдний хүлээлтэд нийцсэн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх явдал юм. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад иргэдийн дуу хоолой чухал үүрэгтэй гэдгийг энд онцлон анхаарах хэрэгтэй. Иргэдэд төрийн үйлчилгээг хүргэхдээ тэдний хэрэгцээ, шаардлага юу байгааг сайтар тодорхойлон түүнд нийцсэн үйл ажиллагааг явуулах нь чухал юм. Энэхүү төрийн байгууллагын хариу үйлдэл нь төрийн үйлчилгээний бодит гүйцэтгэл ба иргэдийн хүлээлт хоёрын зөрүүг багасгахад чиглэдэг. (Т,Т)

ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ (Accountability) Оногдсон үүргээ хэрхэн биелүүлсэн тайлбар, үндэслэл тооцоог гаргаж, үйлдлийнхээ үр дагаврыг хүлээх үйл явц юм¹¹. Ухамсарлагдсан үүрэг бол хариуцлага¹². “Хариуцлага” хэмээх үгийн утгын хувьд тайлбарлах, тайлагнах, хариуцлага хүлээх, хариуцах, тооцоо хийх зэрэг утга бүхий “account” гэсэн үгнээс гаралтай, утгачлан орчуулбал хариуцлага, хариуцлага хүлээх чадвар, хариуцлагатай байх утгыг илэрхийлнэ¹³. Өргөн утгаараа удирдлагын шийдвэрийн үр дүн, тооцоолол, үр ашиг, үр нөлөө, олон сонголтот хувилбаруудаас оновчтойг сонгох сонголт зэрэг үзүүлэлтүүдтэй холбоотой шийдвэр гаргах үр чадварыг илэрхийлнэ. “Responsibility” нь оногдсон, хуваарилагдсан үүргээ биелүүлэхтэй холбоотой хувь хүний ёс зүй, чадавх, чадвар, хариуцлага, мэргэжлийн ёс зүйн асуудлыг мөн агуулдаг. (Г,Б)

ХАРЬЦУУЛСАН ДАВУУ ТАЛ (Comparative advantage)

Өөр үйлдвэрлэгчээс хямд өртгөөр бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадвар. Харьцангуй давуу тал нь байгууллагад бараа, үйлчилгээгээ өрсөлдөгчдөөсөө хямд үнээр борлуулах, борлуулалтын илүү өндөр ашиг олох боломжийг олгоно. Харьцангуй давуу талын сонгодог онолыг английн эдийн засагч Дэвид Рикардо (David Ricardo) 1817 онд боловсруулахдаа: нэгэн улс бараа тус бүрийг үйлдвэрлэхдээ илүү үр ашигтай ажилладаг ч, бусад улс орнууд яагаад олон улсын худалдаа

11 Л.Сарангэрэл: “Зүүн Ази Номхон Далайн бүс нутгийн түвшинд нийгмийн хариуцлага тооцож буй арга механизм”, Улаанбаатар 2012, х. 1.

12 Х. Пүрэвдагва, Г.Батхүрэл: “Менежмент сурах бичиг”, Улаанбаатар 2009, х. 56.

13 Л.Сарангэрэл: “Зүүн Ази Номхон Далайн бүс нутгийн түвшинд нийгмийн хариуцлага тооцож буй арга механизм”, Улаанбаатар, 2012, х. 1.

эрхэлдэг болохыг судалж үзжээ. Д.Рикардо хоёр бараа (дарс, даавуу), хоёр орон (Англи, Португал) өөр өөрсдийн харьцангуй давуу тал дээр тулгуурлан худалдаагаа нээснээр ашиг олох боломжтойг харуулсан. Хоёр төрлийн бараа үйлдвэрлэх чадвартай, хөдөлмөрийн бүтээмжийн ялгаатай хоёр улс чөлөөт зах зээлд оролцвол, улс орон тус бүр харьцангуй давуу талтай бүтээгдэхүүнээ экспортолж, нөгөө бараагаа импортлох замаар нийт хэрэглээгээ нэмэгдүүлэх боломжтой. (Д.Ч)

ХАРЬАА ДЭЭД ШАТНЫ АЛБАН ТУШААЛТАН (*Corresponding senior officer*)

Өөрийн гүйцэтгэж буй төрийн албаны чиг үүрэгтэй холбоотойгоор заавар чиглэл авах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, эргэж тайлагнах харилцаанд үндэслэсэн албан тушаалын тодорхойлолтод заасан шууд болон шууд бусаар харьяалах албан тушаалтанг хэлнэ. Төрийн байгууллагын бюрократ тогтолцооны онцлогоос шалтгаалан ихэнх төрийн байгууллагууд босоо буюу шаталсан удирдлагын хэлбэртэй байдаг ба энэ нь гүйцэтгэх албан тушаалтанг захирах, түүнд үүрэг чиглэл өгөх, даалгавар гүйцэтгүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих эрхийг хэрэгжүүлэх харьяалах дээд шатны албан тушаалтан заавал бүхий бүтцийг бий болгодог. (Г.Б)

ХИЙМЭЛ ОЮУН УХААН (*Artificial intelligence*)

Хиймэл оюун ухаан бол аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалын гол үзэгдэл бөгөөд түүнийг хэрэглэх ашиглах, түүний дагуу ажиллах чадвар нь эдийн засаг, бизнес, боловсрол, эрүүл мэнд, хууль сахиулах, төрийн удирдлага гэсэн аливаа мэргэжлийн заавал биелүүлэх шаардлага болж байна. Үүнийг өнөө цахим засаглал, дижитал эдийн засаг, е-бизнес болон

онлайн худалдаа, цахим гэмт явдал судлал зэргээр нэрлэдэг билээ. Хиймэл оюун ухаан (AI) бол урьдчилан өгөгдсөн алгоритмгүйгээр шийдлийг эрж хайх, танин мэдэх чадварыг агуулсан хүний ухамсар, сэтгэлгээг дуурайх боломжийг олгодог технологийн иж бүрдэл юм. Энэ нь энгийнээр хэлбэл хүний зан байдлыг дуурайж цуглуулсан мэдээллээсээ даалгавраа биелүүлж чаддаг систем буюу машин юм. Улс орны удирдагч, тэргүүнүүдийн дээд хэмжээний уулзалтын гол сэдэв нь шинэ технологиуд, тэр дундаа хиймэл оюун ухаан (AI) нь дэлхийн нийтийн удирдлага, нийгэм эдийн засгийн үйл явцын ирээдүйд хэр нөлөө үзүүлэх талаар хэлэлцэх болсон бөгөөд уг асуудлыг хариуцсан удирдлагын платформ бий болж байна. Үүний нэг жишээ бол Монгол Улсын Их Хурал 2020 онд Инновац, цахим бодлогын байнгын хороог байгуулсан явдал юм. Оюун ухаан хүний тархинд өсөж бойждог байсан бол одоо “Цахиурын хөндий”-д мэндэлдэг болсноороо онцлогтой бөгөөд хиймэл оюун ухааныг хөгжүүлэх, зохицуулах зорилго бүхий яамыг хүртэл улс орнууд байгуулж эхлэв. Сэтгэхүйн загварчлал, тооцоолох үйлийн бүтээмжийг эрс дээшлүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны энэхүү чиглэл нь эдүгээ “оюун ухаанжсан” элдэв программ, механизм, төхөөрөмж болон амьдрал үйл ажиллагаанд нэвтэрч байна. Энэ нь шинжлэх ухааны эвристик болон кумулятив шинжийн үр дүн бөгөөд түүхэн дэх ертөнцийг оюун ухаанаар төгс танин мэдэж болох рационалист-аналитик төсөөлөл, хүнээс үл хамаарах объектив мэдлэгийн тухай төсөөлөл, боломжгүй боломжит ертөнц зэрэг виртуалистикуудын үзэл санаа өнөөгийн хиймэл оюуны онолын болоод онтологийн үндэс болсон байна. Ийнхүү машиныг “сэтгэдэг”

болгосноор эдүгээ квантум компьютер, супер роботын ирээдүй хүн төрөлхтний өмнө залрах цаг нь айсуу. Олон хүмүүс “хиймэл оюун ухаан” гэдэгт дэлхий ертөнцийг байлдан дагуулах ухаалаг хүн дүрст роботуудыг төсөөлдөг боловч хиймэл оюун ухаан нь хүнийг орлох зорилгогүй. Түүний зорилго бол хүний ур чадвар, өрсөлдөх чадварыг өргөжүүлэх, тэлэх явдал юм. Тиймээс энэ технологи нь бизнесийн үнэ цэнтэй нөөц юм. Ийнхүү ойрын ирээдүйд хиймэл оюуны авчрах эрс өөрчлөлтөөр цахим засаглал төрийн удирдлагын салбар хүнд суртлыг арилгах, субъектив нөлөөллийг бууруулах, шинэ, инновацлаг ажлын байр буй болох, өвчнийг арилгах тал дээр эерэг үр нөлөө үзүүлнэ гэдэгт эргэлзэх зүйлгүй болж байна. Онгод хөлөглөсөн оюун ухаанаар жигүүрлэвч хамтын ёс суртахууны шинэ ухамсарт уягдсан амьдрал хувь заяа хүлээж буй тухай К.Шваб өгүүлдэг. (Б.П)

ХИЛИЙН ЦАХИМ ГАРЦ (*Electronic immigration gate (E-gate)*) Улсын хилээр орох, гарах эрхийн хүчин төгөлдөр баримт бичиг бүхий дотоодын болон гадаад улсын иргэнийг биеийн давхцахгүй өгөгдөл (хурууны хээ, царай)-ийн тоон мэдээллээр таних цахим технологийг ашиглан улсын хил нэвтрүүлэх гарц. Хилийн цахим гарцаар үйлчлүүлэхийн тулд зорчигч нь өөрийн хурууны хээ, нүүрний зураг, гадаад паспорт, иргэний үнэмлэх эсвэл оршин суух үнэмлэхийн мэдээллийг урьдчилан бүртгүүлсэн байх шаардлагатай. Хилийн цахим гарц нь төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэх нэгэн жишээ юм. (Д.3; Ч.Л нар)

ХОЁР ХЭМЖЭЭСТ КОДООР ХИЙХ ТӨЛБӨР (*QR payment*) Нэхэмжлэлийн мэдээллийг QR коджуулан хэрэглэгчдэд

түгээх, хэрэглэгч интернет банкны аппликейшн ашиглан QR код унших замаар төлбөр төлөх, төлбөр хүлээн авах, шилжүүлэг хийх боломжийг олгодог үйлчилгээг ашиглан төлбөр хийх үйл явц. Хоёр хэмжээст кодын системийг анх 1994 онд Японы Дэнсо Вэйф (Denso Wave) компанийн Масахиро Хара (Masahiro Hara) зохион бүтээжээ.

Өдгөө хоёр хэмжээст кодыг ашиглан дэлгүүр, ресторан, такси зэрэг олон үйлчилгээний байгууллагуудад төлбөрийг хялбар, шуурхай гүйцэтгэх болжээ. БНХАУ-ын хувьд нийтлэг хэрэглэгддэг ВиЧат (WeChat) аппликейшнд холбосноор өдгөө хамгийн их хэрэглэгддэг төлбөрийн хэлбэр нь хоёр хэмжээст кодоор хийх болоод байна.

Зөвхөн төлбөр биш үзвэр, урлаг соёлын арга хэмжээний тасалбар хоёр хэмжээст кодтой болсноор зочдыг бүртгэж оруулах үйл ажиллагаа хөнгөвчлөгдсөн.

Төрийн байгууллагын хувьд ч цар тахлын үе дэх бүртгэл, хяналтыг хийх зохицуулалтад хоёр хэмжээст кодыг ашиглаж байна. Цар тахлын үед энэ кодын систем нь шууд хүрэлцдэггүй учраас эрсдэлээс зайлсхийх нэг хэлбэр юм. (Д.3; Ч.Л нар)

ХОЁР ХЭМЖЭЭСТ КОДТОЙ ТӨЛБӨРИЙН БАРИМТ (*QR receipt*) Төлбөрийн баримтын мэдээллийг QR кодуулсан баримт. Монгол Улсад цахим төлбөрийн баримтын систем (ebarimt) нэвтэрсэнтэй уялдаж төлбөрийн баримт хоёр хэмжээст кодтой болсон. Ингэснээр төлбөрийн баримтаа цахим төлбөрийн баримтын системд шуурхай, чирэгдэлгүй бүртгүүлэх боломж бүрдсэн. (Д.3; Ч.Л нар)

ХОЛИМОГ ЭДИЙН ЗАСАГ (*Mixed economy*)

Чөлөөт зах зээл болон төрийн оролцоог хослуулсан зах зээлийн эдийн засгийн тогтолцоог хэлнэ. Холимог эдийн засгийн суурь нь хувийн хэвшил болон зах зээл байдаг. Харин төрийн оролцооны цар хүрээ, хэм хэмжээ нь холимог эдийн засагтай улс орнуудад ялгаатай байна. Зарим улс оронд төрийн зохицуулалт илүү хүчтэй байдаг. Үүнд Баруун Европ болон ялангуяа Скандинавын орнуудыг дурдаж болно. Зарим оронд төр хязгаарлагдмал хүрээнд оролцдог. Тухайлбал, АНУ-ын эдийн засгийн тогтолцоо үүний нэг жишээ юм. Холимог эдийн засгийн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас (central-planned economy) ялгагдах онцлог нь үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн хувийн өмч давамгайлж, хувийн компаниудыг ашиг олох сонирхол болон хувийн хөрөнгө болох капиталын хуримтлалд суурилдагт оршино. Үндсэндээ дэлхийн бүх орныг өнөөдөр холимог эдийн засагтай гэж хэлж болно. Дэлхийн эдийн засгийн түүхийг авч үзвэл төрийн оролцоо нь ХХ зууны эхэн үеэс улам бүр өргөжиж ирсэн байдаг. Ялангуяа улс орон хөгжиж, татвар хураалт сайжирч, төр нь чадваржихын хэрээр өөртөө илүү олон үүргийг хүлээдэг. Орчин цагийн төрийн үүрэг иргэдийн аюулгүй байдал, дэд бүтэц зэрэг суурь үйлчилгээнээс хэдийнээ халин боловсрол, эрүүл мэнд, халамж гэх мэт олон салбарт төр өргөнөөр оролцдог болсон байна. Гэхдээ төрийн оролцоо нь тасралтгүй нэмэгдэхгүй, тодорхой түвшин хүрээд тогтворждог. Учир нь төрийн хэт их оролцоо эдийн засагт сөргөөр нөлөөлж эхэлнэ. Төрийн оролцоог хэмжих нэг арга нь дотоодын нийт бүтээгдэхүүнд (ДНБ) нийтийн буюу улсын төсвийн зарлагын эзлэх хувийн жингээр тооцох арга байдаг. Энэ үзүүлэлтийг авч үзвэл ихэнх улс

орнуудын хувьд 30-50 хувийн хооронд хэлбэлзэж байна. (Ч.Н)

ХОМС БАЙДАЛ (*Scarcity*)

Хүний хэрэгцээ хязгааргүй ба түүнийг хангах эдийн засгийн нөөц хязгаарлагдмал байдгаас үүсэх хүндрэл, сорилт. Хүсэл, хэрэгцээг нь хангаж чадахуйц нөөц бэлэн биш байх нь шийдвэр гаргагчдыг ямагт эдийн засагч шийдвэр гаргахад чиглүүлж байдаг. Энэхүү шийдвэрийг хэр оновчтой гаргаж хэр сайн хэрэгжүүлснээс ашиг эсвэл алдагдал хүлээнэ. Иймд ховор хомс байдал нь эдийн засгийн ухаан үүсэж хөгжих урьдач нөхцөл гэж үзэж болно. Ховор, хомс байдал үүсдэг учир эдийн засгийн харилцаанд оролцогч хувь хүн, байгууллагын удирдлага, төрийн бодлого тодорхойлогчид хязгаарлагдмал нөөцийг хамгийн үр ашигтайгаар хуваарилах шийдвэр гаргаж байдаг. Жишээлбэл, төсвийн эх үүсвэр хязгаарлагдмал учир бодлогын тэргүүлэх чиглэлд, улс орны хамгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгод нийцүүлж нөөцийг хуваарилах зарчим баримталж байгаа нь ховор хомс байдлын нөхцөлд гаргаж байгаа төрийн шийдвэр юм. (Б.Б)

ХОРОО (*Khoroo*)

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.” гэж заасны дагуу *хороо* нь дүүргийн засаг захиргааны нэгж мөн. Хороо нь нийтийн эрх зүйн этгээд байна. Хороо нь иргэдэд хуульд заасан үйлчилгээ хүргэх, нутгийн өөрийн удирдлагад иргэдийн оролцоог хангах чиг үүрэгтэй бөгөөд хэсгийн зохион байгуулалттай байна. Хэсгийн хуваарийг хүн амын суурьшил, өрхийн тоог харгалзан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно. (Ч.Э)

ХОСОЛМОЛ ҮҮЛЭН ТООЦООЛОЛ

(Hybrid cloud) Тусгай программаар ялгаатай үйлчилгээ хоорондоо холбогддог хувийн үүлэн платформ нэг буюу хэд хэдэн нийтийн үүлэн платформыг хослуулсан шийдэл. Хосолсон үүлэн тооцооллын үйлчилгээ нь байгууллагуудад хувийн өгөгдлөөр илүү сайн тооцоолол хийх боломж олгодог ороо хүчирхэг байдаг. Байгууллага нь эмзэг өгөгдлөө хувийн үүлэн платформ эсвэл дотоод дата төвд байршуулахын зэрэгцээ нийтийн үүлэн тооцооллын удирддаг найдвартай тооцоолох нөөцийг ашигладаг. Энэ төрлийн жишээ нь: Amazon Virtual Private Cloud, Google Cloud, VMware. (Д.3; Ч.Л нар)

ХОТ (Town; city) *Хот* гэж 15000-аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газрыг хэлнэ. Хотыг улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот гэж ангилна. Ийнхүү ангилахдаа оршин суугчдын тоо, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшин, улсын болон тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүргийг үндэс болгоно. Одоогийн дагаж мөрдөгдөж байгаа Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд 50000-аас дээш /шаардлагатай гэж үзвэл 50000 хүртэл/ оршин суугчтай хотод улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэж байгаа үүрэг, хотжилт, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшинг харгалзан улсын зэрэглэл тогтоож болно гэж заажээ. Хот нь засаг захиргааны хувьд оршин байгаа тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт харьяалагдана. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд орсон нэмэлт,

өөрчлөлтийн дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтоох бөгөөд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг хотод шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэх болсон (Монгол Улсын Үндсэн хуулийн 57.2). (Ч.Э)

ХОТ, ХӨДӨӨ (ТОСГОН)-ГИЙН САЙН ЗАСАГЛАЛ (Good urban and rural governance)¹⁴

Дэлхийн хөгжингүй болон хөгжиж буй орнуудад хот, тосгоны харилцаа, харилцан нөлөөллийг судлах улмаар орон зайн хөгжлийг иж бүрэн авч үзэх болсон. Хөдөө нь зөвхөн хотыг харсан, түүний нөлөөнд оршдог гэсэн ойлголт хуучирч хотоос хөдөөд, хөдөөгийн хотод үзүүлдэг нөлөөг харгалзан үзэх нь хөгжлийн бодлогын нэг чухал зарчим болж байна. Хот хөдөөгийн хоорондын хүн амын бүрэн болон түр шилжин суурьшилт, хот хөдөөгийн нийгэм, эдийн засаг, соёлын харилцааны өөрчлөлт, хот тосгоны хүрээлэн буй орчинд үзүүлж буй хам нөлөө, экологийн асуудал зэрэг нь хот болон тосгоныг тус тусдаа бие даасан систем бус, бүс нутгийн нэгэн бүхэл сүлжээ гэж үзэхэд хүргэж байна. Хүн жилийн тодорхой хугацаанд хотод, бусад үед тосгонд амьдрах шинэ үзэгдэл буй болжээ. Үйлдвэрлэл, үйлчилгээний төвлөрлийн сааралт, мэдээллийн технологийн хөгжил гэх мэт олон хүчин зүйл хот хөдөөгийн харилцааг шинэ шинж төрхтэй болгож байгаа учраас хот-хөдөөг хамарсан бодлого, засаглал чухал болж байна. Монгол Улсад ч хот суурин газарт хүн ам бөөгнөрөх, үүнээс үүдэн хот суурин

14 Network Governance Arrangements and Rural-Urban Synergy Ulla Ovaska, Hilikka Viñinen, Henk Oostindie, Joaquin Farinys, Mojca Hrabar, Emils Kilis, Jurij Kobal, Talis Tisenkopfs and Hans Vulto

газарг төрийн үйлчилгээ доголдох, экологийн доройтол, замын түгжрэл зэрэг олон бэрхшээл тулгарч байгаа юм. Хот-хөдөөгийн сайн засаглалын нийтлэг хэм хэмжээг илэрхийлэх үзүүлэлтүүд нь тогтвортой байдал, төвлөрлийн сааралт, субсидиар зарчим, тэгш, шударга байдал, үр нөлөө, ил тод байдал, тайлан, иргэний оролцоо, аюулгүй байдал зэрэг гэдгийг дэлхий дахинаа улам бүр хүлээн зөвшөөрч байгаа ажээ. Хот-хөдөөгийн сайн засаглал гэдэг ойлголт нь бүс нутгийн хөгжлийн шинэ хандлагыг илэрхийлнэ¹⁵. Бүс нутгийн хөгжилд хот хөдөөгийн тэнцвэрт харилцааг буй болгоход эл хандлага чиглэж байгаа юм. Тийм ч учраас төлөвлөлтөд хот хөдөөгийн хөгжлийн асуудлыг хамтад нь тусгах, өөр хооронд нь харилцан уялдаатай хэрэгжүүлэх, хүмүүст зохистой сонголт хийх боломж олгох замаар эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бүс нутгийн амьдралын бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд, улмаар хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах боломж олгоход хот хөдөөгийн сайн засаглалын мөн чанар оршино¹⁶. Хот хөдөөгийн хөгжлийн ялгаа нь хот хөдөөгийн засаглалын үр нөлөөний ялгаатай ихэд холбоотой юм. Одоогийн байдлаар хөгжиж байгаа орнуудад хот, тосгоны засаглалын төвшинд ихээхэн ялгаатай байдаг байна. Тийм учраас хөдөөгийн засаглалын чанарыг сайжруулах нь нэн чухал юм. Тосгонд засаглалын дорой байдлаас үүдэн иргэдийн оролцоо, ил тод байдал, тайлан, авлигын хяналт, түүнтэй тэмцэх ажил зэрэг олон үзүүлэлт хангалтгүй байдаг байна. Түүнээс

гадна төрийн байгууллагын ажлын соёл, зохион байгуулалт хангалтгүй, төрийн үйлчилгээний хүртээмж, чанар ч доголдож байдаг. Энэ бүхнийг сайжруулахад хот, тосгоны хэлхээ холбоо, засаглалын уялдааг сайжруулах, тосгоны засаглалын түвшинг хотын засаглалд ойртуулах хэрэгтэй юм¹⁷. Хот, хөдөөгийн хам хөгжил, үүний дотор хот, хөдөөгийн засаглалын чанарын ялгааг арилгах, ойртуулах нь Монгол Улсын хувьд ч тулгамдсан асуудал болж байна. (Ц,Д)

ХОТЫН ЗАХИРГАА (*Municipality*)

Хотын захиргаа нь хил хязгаар нь тогтоогдсон бүс нутаг дахь хүн амын тодорхой төвлөрөлд орон нутгийн удирдлагын үйлчилгээг үзүүлэх зорилгоор байгуулагдсан улсын доторх орон нутгийн удирдлагын нэг хэсэг юм. Хотын захиргаа нь орон нутгийн төв хот, орон нутгийн зэрэглэлтэй хот, дагуул жижиг хот, тосгонд зориулагдсан байж болно. Хотын захиргаа нь орон нутгийн удирдлагын байгууллагын нэг юм. Хотын захиргааны бүтэц, эрх зүйн статус, чиг үүрэг нь улс бүрд өөр өөрийн онцлогтой байдаг. Европын орнуудад хотын захиргаа гэсэн нэр томьёо нь өөр өөр утга, нэршилтэй. Францад коммун – *commune*, Италид коммун – *commune*, Скандинавын орнуудад жемеенте – *gemeente* гэсэн нэр томьёог хэрэглэдэг. Европын бусад орнуудад, тухайлбал Их Британи, Герман улс орон нутгийн удирдлагын харилцан ялгаатай тогтолцоотой бөгөөд хэд хэдэн ангилал үйлчилдэг. (Ж,Ж)

ХӨГЖИЛ (*Development*)

Development гэдэг нь “develop” гэсэн үгнээс үүдэлтэй бөгөөд үгийн утга нь “өргөжих, өсөх” юм. Монгол хэлний

15 Network Governance Arrangements and Rural-Urban Synergy Ulla Ovaska, Hilkka Vihinen, Henk Oostindie, Joaquin Farinys, Mojca Hrabar, Emils Kilis, Jurij Kobal, Talis Tisenkopfs and Hans Vulto Acuna-Alfaro Jairo, Cuong Nguyen, Anh Tran and Tung Phung. The urban-rural gap in governance and public administration: evidence from Vietnam. IPMN Conference Paper. 2015.

16

17 Цанжид А. Хөдөөгийн хөгжлийн бодлого: Онол, загвар, туршлага, сургажм. Улаанбаатар, 2020. х. 153.

тайлбар тольд хөгжил гэдгийг “давшил, дэвшил, цэцэглэл, бадрал” хэмээн тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, хөгжил гэдэг нь дэвшин өөдлөх явдал болж байна. Энэтхэгийн эрдэмтэн Амартия Сен хөгжил гэдгийг “нийгмийн гишүүд өөрсдийн эдэлж буй бодит эрх, эрх чөлөөгөө өргөжүүлэх үйл явц”¹⁸ хэмээн тодорхойлжээ. Хөгжлийн зорилго бол байнгын хомстлыг алга хийх, огцом үгүйрэхээс сэргийлэх явдал. Энэ ч утгаараа “хөгжил бол эрх чөлөөний олгож буй боломжуудын хүчирхэг зангилаанд оршдог”.¹⁹ Хөгжил бол үгүйрэл хоосрол, дарангуйлал, эдийн засгийн боломжийн хомстол, нийгэм дэх байнгын хяслан, хүн амд үйлчилж буй бүтцүүдийн хямсгнал, хүчний байгууллагуудын дарамт юм уу, хэт идэвхжилт зэрэг эрх чөлөөг боомилгогч гол эх сурвалжуудыг үгүй хийхийг шаарддаг. Хүмүүсийн хөгжих чадамж нь нийгмийн боломж, улс төрийн эрх чөлөө, олон нийтийн хөдөлгөөнүүдийн хөгжсөн байдал, эмнэлгийн тусламж хүртэх, суурь боловсрол олгох нөхцөл тэрчлэн хүмүүсийн үйл ажиллагааг нийгмийн зүгээс дэмжих, урамшуулах зэргээс хамаардаг. Мөн боломжуудыг нөхцөлдүүлж буй институтжсэн бүтцүүдийн хөгжил өөрөө бас эдгээр нөхцөлийг хөгжихөд дэм болдог. (Т.Т)

ХӨДӨЛГӨӨНТ ХОЛБОО (*Mobile communication*) Илгээгч болон хүлээн авагч нь биет (утсан) холболтоос хамааралгүйгээр мэдээллийг нэг байршлаас нөгөөд дамжуулах боломжтой харилцаа холбооны хэлбэр. Германы эрдэмтэн, судлаач Йохэн Шиллер (Jochen Schiller) хөдөлгөөнт холбоо нь гурван талтайгаар авч үзэж, дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Хэрэглэгчийн хөдөлгөөнт байдал (user mobility): “хэзээ ч, хаана ч,

хэнтэй ч” холбогдох боломж,

- Төхөөрөмжийн зөөвөрлөгддөг байдал (device portability): төхөөрөмж нь авсаархан бөгөөд зөөвөрлөгдөх боломжтой сүлжээнд холбогдох боломж,
- Утасгүй холбогдох (wireless connectivity): төхөөрөмж нь “хаанаас ч” утасгүй технологиор холбогдох боломж.

Хөдөлгөөнт холбоо үүрэн холбоо гэдэг нэршлээрээ нийтэд танил болсон байдаг. Үүрэн холбоо нь хамрах хүрээг үүрүүдэд хувааж үүр тус бүрд радио станц байрлуулах байдлаар зохион байгуулсан хөдөлгөөнт холбоо юм. Хөдөлгөөнт холбооны эхний үеийн арилжааны үүрэн холбооны сүлжээг 1979 онд Японы Ти Эн Ти (TNT) Токио хотыг хамарсан байдлаар нэвтрүүлсэн. Утасгүй технологийн хувьсгал нь 1990-ээд оны эхэн үеэс аналогоос тоон сүлжээнд шилжсэнээр эхэлж хоёрдугаар үе (2G)-ийн анхны арилжааны тоон үүрэн сүлжээ нь 1991 онд үүсжээ. Үүрэн холбооны дөрөвдүгээр үеийн (4G) сүлжээ хэрэглээнд нэвтэрснээр дуу, дүрс, видеог өндөр хурдтай дамжуулах болж хөдөлгөөнт холбоонд суурилсан үйлчилгээний олон боломж нээгдсэн. Одоо зарим улс орнууд тавдугаар үеийн (5G) үүрэн холбоог нэвтрүүлж эхлээд байна. Монголын анхны үүрэн холбооны үйлчилгээг 1996 онд Монголын Ньюком групп, Японы Сумитомо (Sumitomo), Кэй Ди Ди Ай (KDDI) групп компаниуд хамтран Монгол-Японы хамтарсан хөрөнгө оруулалттай Мобиком компанийг байгуулснаар эхэлсэн. Одоо Монгол Улсад Мобиком, Юнител, Скайтел, Жи Мобайл гэсэн дөрвөн компани үүрэн холбооны операторын үйлчилгээ үзүүлж байна. (Д.З; Ч.Л нар)

18 Амартия Сен (2014), Хөгжил бол эрх чөлөө, х. 11.

19 Амартия Сен (2014), Хөгжил бол эрх чөлөө, х. 268.

ХӨДӨЛГӨӨНТ ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (*Mobile government /Government/ service*)

Хөдөлгөөнт холбооны технологид суурилсан гар утас, зөврийн компьютер болон утасгүй интернет дэд бүтэц ашиглан хүргэх төрийн үйлчилгээ. Төрийн үйлчилгээг хөдөлгөөнт холбооны технологид суурилсан төхөөрөмжид зориулан өргөтгөснөөр иргэд хаанаас ч хэдийд ч мэдээлэл хүлээн авах, үйлчилгээнд хамрагдах боломжтой болгож, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлдэг. Энэ үйлчилгээний энгийн жишээ нь онцгой байдлын үед иргэдийн утсанд анхааруулах мессеж илгээх үйлчилгээ юм. Хөдөлгөөнт буюу мобайл Засаг (Mobile Government - mGovernment), Засаглал (mGovernance) гэдэг нэр томьёо үүсэж Засгийн хөдөлгөөнт Засаг санаачилга, хөтөлбөр хэрэгжүүлэх болжээ. Хөдөлгөөнт Засаг нь цахим засагт иргэд, хувийн хэвшил, төрийн бүх байгууллага зэрэг талуудын үр ашигтай оролцоог нэмэгдүүлэх зорилгоор бүх төрлийн утасгүй ба хөдөлгөөнт технологи, үйлчилгээ, аппликейшн болон төхөөрөмжийг ашиглах стратеги, түүний хэрэгжүүлэлт юм. (Д.З; Ч.Л нар)

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН (*Employment Assistance Fund*)

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор бүрдүүлсэн хөрөнгийн эх үүсвэр. Сангийн орлого нь улсын ба орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр олон улсын болон дотоодын байгууллага, иргэдээс олгосон хандив тусламж, зээл, сангийн хөрөнгийг санхүүгийн зах зээлд байршуулснаас олох орлого ба бусад эх үүсвэрээс бүрддэг. Улс орнууд

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эх үүсвэрээр хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт иргэдэд болон тодорхой шалгуур хангасан тохиолдолд жижиг, дунд аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид ажлын байр бий болгох, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх зэрэгт дэмжлэг үзүүлдэг. Монгол Улсын хувьд хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих сангийн эх үүсвэрээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах, хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах, ажил олгогчийг дэмжих, нийтийг хамарсан ажил зохион байгуулах, ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний бүртгэл, мэдээлэл, зохион байгуулалт, удирдлагыг сайжруулах ажлуудыг санхүүжүүлэхээр хуульчилсан. (Б.Б)

ХӨРӨНГИЙН ТӨСӨВ (*Capital budget*)

Улсын төсвийн хувьд нэг гол ангилал бөгөөд хөрөнгийн орлого болон зарлага нь хөрөнгийн төсвийг бүрдүүлдэг. Хөрөнгийн орлого нь тодорхой хөрөнгө эзэмшсэний орлогууд төсөвт ордог бөгөөд харин хөрөнгийн зарлага хөрөнгө оруулалт хэлбэрээр төсвөөс хөрөнгө гадагшлах үйл явц юм. Байгууллагын хувьд Капиталын төсөвлөлт, хөрөнгө оруулалтын үнэлгээ нь байгууллагын урт хугацааны хөрөнгө оруулалт болох шинэ техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг солих, шинэ үйлдвэр, шинэ бүтээгдэхүүн, судалгаа шинжилгээний төсөл зэрэг бэлэн мөнгөөр санхүүжүүлж байгаа эсэхийг тодорхойлоход ашигладаг төлөвлөлтийн үйл явц юм. (өр, өмч эсвэл хуримтлагдсан ашиг). Энэ нь томоохон хөрөнгө буюу хөрөнгө оруулалтын зардалд нөөцийг хуваарилах үйл явц юм. Хөрөнгийн зардал гэдэг бол

үндсэн хөрөнгө ба нөөцийн өсөлтөд оруулахтай холбогдон гарсан зардал юм. Өөрөөр хэлбэл төсвийн хөрөнгөөр санхүүжигддэг, үндсэн капиталыг өсгөх гэх мэт эргээд үр өгөөж авчрах зүйлд зарцуулагддаг зардлыг хөрөнгийн зардал гэнэ. Хөрөнгийн зардалд: 1. Төсвийн хөрөнгөөс аж ахуйн янз бүрийн салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалтын зардал 2. Урт хугацааны төсвийн зээл 3. Улсын нөөц бүрдүүлэх зардал 4. Газар, биет бус зүйлсийн зардал 5. Хөрөнгийн шилжүүлэг гэх мэт зардлууд орно. (А.Э)

ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА (*Capital management*) Хөрөнгийн удирдлага гэдэг нь үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнэ, ашиг орлогыг хөрөнгө оруулагч, эзэмшигчдэд нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэлнэ. (А.Э)

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ (*Capital evaluation*) Хууль эрх зүй, стандартыг үндэслэн янз бүрийн зориулалтаар хөрөнгийн үнэ, цэнийг тодорхойлоход зайлшгүй шаардагдах өгөгдлүүдийг системчлэн цуглуулж, судалгаа, тооцоолол хийж, нэгтгэн дүгнэлт гаргах үйл ажиллагааг хэлнэ. (А.Э)

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (*Investment*) Хөрөнгө оруулалтын менежмент (эсвэл санхүүгийн менежмент) нь хөрөнгө оруулагчдын ашиг тусын тулд тодорхой хөрөнгө оруулалтын зорилгод хүрэхийн тулд төрөл бүрийн үнэт цаас (хувьцаа, бонд болон бусад үнэт цаас) болон бусад хөрөнгийг (жишээлбэл, үл хөдлөх хөрөнгө) удирдахыг хэлнэ. Хөрөнгө оруулагчид нь байгууллага (даатгалын компаниуд, тэтгэврийн сан, корпорацууд, буяны байгууллагууд, боловсролын байгууллагууд гэх мэт) эсвэл хувийн хөрөнгө оруулагчид (шууд хөрөнгө оруулалтын гэрээгээр,

ихэвчлэн хөрөнгө оруулалтын хамтын схемээр дамжуулан хөрөнгө оруулалтын сангууд эсвэл биржээр арилжаалагддаг сангуудаар) байж болно. (А.Э)

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (*Investment and net lending*) Төсвийн эдийн засгийн ангиллаар хөрөнгийн зардлыг хөрөнгө оруулалт ба цэвэр зээл гэж ангилдаг. (А.Э)

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ (*Return on investment*) Хөрөнгө оруулалтын үр ашиг буюу ашигт байдлыг хэмждэг гүйцэтгэлийн үзүүлэлт. Хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцохдоо тухайн хөрөнгө оруулалтаас олсон цэвэр ашиг эсвэл цэвэр алдагдлыг оруулсан нийт хөрөнгө оруулалтын анхны дүнд харьцуулна. Энэхүү харьцаа нь хувиар илэрхийлэгдэх бөгөөд тухайн хөрөнгө оруулалт нь хэр ашигтай байгааг илэрхийлнэ. Нэг багц (portfolio) дахь хөрөнгө оруулалтын төслүүдийг хооронд нь харьцуулах, эрэмбэлэхэд мөн хэрэглэнэ. Хөрөнгө оруулалтын цэвэр ашгийг тооцохдоо тухайн хөрөнгө оруулалтын өнөөгийн үнэлгээ нь анх хийж байх үеийн үнэлгээтэй харьцуулахад яаж өөрчлөгдсөнийг мөн тооцдог. Тухайлбал та 100 төгрөгийн хувьцаа худалдаж аваад нэг жилийн дараа 5 төгрөгийн ногдол ашиг авсан, мөн энэ хугацаанд хувьцааны үнэ нь өсөөд 150 төгрөг болсон бол таны хөрөнгө оруулалтын өгөөж 55% байна. Хэрэв хувьцааны үнэ энэ хугацаанд 85 төгрөг болтлоо буурсан, дээр нь та 5 төгрөгийн ногдол ашгаа авсан бол таны цэвэр ашиг (-10) төгрөг болж та 10% алдагдалтай байна. Дэлхийн томоохон бизнесийн хөрөнгө оруулалтын өгөөжийн дундаж хувь 10 орчим байдаг. Энэ үзүүлэлт

нь энгийн бөгөөд ойлгомжтой, тооцоолоход хялбар, гүйцэтгэлийн анхан шатны үзүүлэлт учир маш өргөн хэрэглэгддэг. Гэвч үүгээр хөрөнгө оруулалт болон пүүсийн байгаль орчин, нийгэм, засаглалын нөхцөл байдал, эрсдэл болон үнэлгээг бүрэн дүүрэн илэрхийлэх боломжгүй байдаг. Ингэхийн тулд илүү нарийвчилсан үнэлгээний аргачлалыг хэрэглэдэг. (Ч.Н)

ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ХЭРЭГСЭЛ (*Instrument of investment*) Хөрөнгө оруулагчийн зүгээс хөрөнгө оруулж болох санхүүгийн болон таваарын захын бүтээгдэхүүнийг хэлнэ. (А.Э)

ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА (*Program management*) Байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор ихэвчлэн холбогдох хэд хэдэн төслийг удирдах үйл явц юм. Практикт болон түүний зорилгын хүрээнд хөтөлбөрийн менежмент нь ихэвчлэн системийн инженерчлэл, үйлдвэрлэлийн инженерчлэл, өөрчлөлтийн менежмент, бизнесийн өөрчлөлттэй нягт холбоотой байдаг. (А.Э)

ХӨТӨЛБӨРТ ТӨСӨВ (*Program based budgeting*) Хөтөлбөр гэдэг нь бодлогын зорилгыг хангахад чиглэсэн өөр хоорондоо уялдаа бүхий багц үйл ажиллагааг хэлдэг. Хөтөлбөрийн төсөвлөлтөөр тэдгээр бодлогын зорилгуудыг хамгийн сайн хангах Засгийн газрын хөтөлбөрүүдэд төсвийн хөрөнгийг хуваарилдаг. Төсвийн хөрөнгийг хэр зэрэг оновчтой зөв хуваарилсан бэ гэдгийг үнэлэхийн тулд зорилгыг тодорхой гаргах, Засгийн газраас хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудын талаарх мэдээллийг цуглуулах болон тэдгээр үйл ажиллагаа нь бодлогын зорилгыг хэр зэрэг хангаж байна вэ гэдгийг тогтоох шаардлагатай байдаг. Хөтөлбөрийн төсөвлөлт

нь дунд хугацааны төсөвлөлттэй маш нягт уялдаатай байдаг бөгөөд дунд хугацааны төсөвлөлттэй адил зорилгыг хангахад чиглэгддэг. Бүтээгдэхүүний төсөвлөлт нь “юуг” буюу төр “ямар” үйлчилгээг иргэдэд хүргэж байна вэ гэдгийг харуулахыг зорьдог бол Хөтөлбөрийн төсөвлөлт нь бүтээгдэхүүнд чиглүүлэн төсөвлөхийн зэрэгцээ төр “Яагаад” эдгээр үйлчилгээг иргэдэд хүргэж байна вэ? гэдэгт ач холбогдол өгдөг. Тиймээс хөтөлбөрийн төсөвлөлт нь төрийн үйлчилгээний үр өгөөж ба өртгийг тодорхойлохыг чухалчилдаг. Гэхдээ төрийн үйлчилгээний хэлбэр, оновчтой тоо хэмжээг тодорхойлон шийдвэр гаргах нь төрийн зарим тодорхой үйлчилгээг хамгийн хямд өртгөөр үзүүлэхээс илүү ач холбогдолтой байдаг. Хөтөлбөрийн төсөвлөлтийн үед “бодлого” гэдэгт төрийн үйлчилгээнд нөлөөлж буй бодлогыг авч үздэг бөгөөд энэ нь “цалингийн талаарх бодлого” (орц) ч биш “төсвийн бодлого” ч биш юм. Хөтөлбөрийн төсөвлөлтөд тухайн төсвийн бодлогын нөхцөлд зөвшөөрөгдсөн нийт төсвийн хүрээнд мөнгийг хэрхэн ашиглах хуваарилахад голлон анхаардаг. Төсвийн ердийн үйл явцын үед ирүүлсэн мэдээллийг ашигласан ихэнх дүн шинжилгээ мөн чанарын хувьд төдийлөн ач холбогдолтой бус байдаг. Хөтөлбөрийн үр дүнг тодорхойлох зэрэг гол өөрчлөлтүүдийг хийхэд төсвийн саналыг хүргүүлэх ердийн процессын үед ирүүлдэг мэдээллээс хол давсан их хэмжээний мэдээлэл шаардагддаг. Ийм мэдээллийг аудит хийх үед болон засгийн газрын байгууллага эсвэл их дээд сургууль, ТББ-аас хийсэн тусгай судалгаанаас олж болдог. Засгийн газрын хэд хэдэн арга хэмжээ ба зарлагууд нь мөн чанарын хувьд захиргааны зардлууд байдаг. Өөрөөр хэлбэл, ард түмэн ашгийг нь хүртдэг

төрийн үйлчилгээтэй холбож үзэхэд нэлээд төвөгтэй. Өртөг хуваарилах маш нарийн системүүд эдгээр зардлыг ард түмэнд хүргэж буй шууд үйлчилгээний өртөгт хуваарилж үйлчилгээний нийт өртгийг гаргадаг. Хөтөлбөрийн ангилалд эдгээр өртгүүдийг "захиргааны" эсвэл "туслах" чанарын үйлчилгээ гэж тодорхойлдог. (А.Э)

ХУВИЙН АШИГ СОНИРХОЛ (*Private interests*) Хувийн ашиг сонирхол нь хүмүүс болон хувийн хэвшил бусдад олгогдохгүй ашиг, тусгай эрх, төрийн байгууллага эсвэл төрийн албан хаагчийн үйлдлийн үр дүнд давуу тал, эсвэл тусгай хөнгөлөлтийг олж авахыг хэлнэ. Үүнд зөвхөн санхүүгийн ашиг сонирхлоор хязгаарлагдахгүй бүх төрлийн ашиг сонирхол багтана. Хувийн ашиг сонирхол нь тухайн хүний бие хүний амьдралын хүсэл зориг, үйл ажиллагааны зорилго, чиглэлийг нөхцөлдүүлэн тодорхойлдог бөгөөд хувь хүн оршин тогтнох, хөгжих, ажиллаж амьдрахад шаардлагатай нөхцөлүүдийн цогц юм. Хувийн ашиг сонирхол нь төрийн захиргаанд ашиг сонирхлын зөрчил гэсэн ойлголттой шууд холбогдоно. Төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхол нь ажлын үүрэг, хариуцлага, үр дүнд зүй бусаар нөлөөлж эхэлбэл ашиг сонирхлын зөрчил болж хувирдаг. Төрийн албанд ажиллаж байгаа бүх албан хаагч иргэн хүнийхээ хувьд тодорхой хэмжээнд хувийн ашиг сонирхолтой байдаг. Гагцхүү ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлалтай нөхцөл байдлыг зөв илрүүлэн тодруулж, урьдчилан сэргийлэх, зохицуулах, итгэл алдахгүй байх нь чухал юм. (Ж.Ж)

ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ (*Information privacy*) Задруулбал хувь хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтгэд хохирол

учруулж болзошгүй мэдээ, баримтын нууцлалыг хууль тогтоомжоор баталгаажуулах, хадгалах, хамгаалах үйл ажиллагаа. Хувь хүний нууцлалбал зохих мэдээлэлд нэн тэргүүнд захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө, гэр бүлийн нууц хамаарна. Мэдээллийн хувийн нууцыг хувь хүн өөрөө хамгаалах үүрэгтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд төр түүнийг хамгаалалтад авч болдог. Хувь хүний нууцад хамаарах мэдээллийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглодог. Манай улсад мэдээллийн хувийн нууцыг хамгаалахтай холбогдох харилцааг Хувь хүний нууцын тухай хуулиар зохицуулж байна. (Д.З; Ч.Л нар)

ХУВИЙН ӨГӨГДӨЛ ХАМГААЛАЛ (*Data Privacy*) Хэрэв тухайн өгөгдөл нь хувь хүнийг тодорхойлсон байвал хувь хүний өгөгдөл хамгаалал болно. Харин аливаа хэлбэрийн байгууллагад хамаардаг түүнийг тодорхойлсон байдаг бол байгууллагын өгөгдөл хамгааллын журмаар зохицуулагдана. Өгөгдлийн хамгаалалтай холбоотой нийтлэг харилцааг Мэдээллийн аюулгүй байдлын тухай, Байгууллагын болон хувь хүний нууцын тухай, Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн хүрээнд зохицуулдаг. (Д.З; Ч.Л нар)

ХУВИЙН ТҮЛХҮҮР (*Private key*) Зөвхөн эзэмшигч нь хэрэглэх нууцлах эсвэл код тайлах ажиллагааг удирдах тэмдэгтийн дараалал. Тоон гарын үсгийн хувийн түлхүүр гэж тоон гарын үсгийг үүсгэх, өгөгдлийг тайлах зориулалттай тэмдэгтийн давтагдашгүй дарааллыг хэлнэ. (Тоон гарын үсгийн тухай хууль) Криптографын алгоритмд нийтийн түлхүүрийг тооцоолох, тоон гарын үсэг тооцоолох, нууц мэдээллийг тайлах зэргээр ашиглана. (Д.З; Ч.Л нар)

ХУВИЙН ҮҮЛЭН ТООЦООЛОЛ (*Private Cloud*)

Удирдлага нь дотроосоо эсвэл гуравдагч этгээдээс, эзэмшил нь өөрөө эсвэл гаднаас байхаас үл хамааран нэг байгууллага дангаараа эзэмшдэг үүлэн тооцооллын дэд бүтэц. Хувийн үүлэн тооцооллын төсөл хэрэгжүүлэхэд байгууллага үйл ажиллагааны орчноо виртуал болгох бодитой санаачилга болон одоогийн нөөцүүдийг эргэн үнэлэх шаардлагатай болдог. Энэ нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулдаг боловч төслийн үе шат бүрд мэдээллийн эмзэг байдал үүсэхээс сэргийлэх аюулгүй байдлын асуудлууд тулгардаг. (Д.З; Ч.Л нар)

ХУВИЙН ХЭВШИЛ (*Private sector*)

Иргэд болон аж ахуйн нэгжийн мэдэлд байгаа, ашиг олохын төлөө оршин тогтнодог нийт эдийн засгийн нэг хэсэг юм. Хувийн хэвшил нь иргэд болон хувийн компаниудын өмчлөл, хяналт, удирдлагад байдаг. Компаниуд өргөжих, шинээр хувийн аж ахуйн нэгж байгуулах, төрийн нийтийн өмчийн аж ахуйн нэгжийн хувьчлах замаар хувийн хэвшил тэлдэг. Зах зээлийн эдийн засагтай улс орнуудад хувийн хэвшил давамгайлах шинж чанартай байдаг. Нийт эдийн засагт эзэмшиж буй хөрөнгө болон ажил эрхлэлтийн хувьд хамгийн том хувийн жин энэ хэвшилд оногдоно. Хөгжиж буй орнуудад хувийн хэвшлийн ажил эрхлэлт нийт ажил эрхлэлтийн 90 орчим хувийг эзэлж байна²⁰.

Хувийн хэвшил нь төрийн үйлчилгээ болох нийгмийн аюулгүй байдал, зэвсэгт хүчин, хуульт ёс, боловсрол, эрүүл мэнд, төрийн захиргааны алба зэрэг цөөн хэдэн салбараас бусад бүх салбарт ноёрхох шинж чанартай. Хувийн хэвшлийн үйл ажиллагааг төрийн зүгээс хуулиар зохицуулдаг.

Компанийн тухай хуулиас эхлэн, бүртгэл, үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, бүтээгдэхүүний болон бусад стандарт, ажлын байрны аюулгүй байдал, байгаль орчин, татвар ба гадаад худалдаа зэрэг ихэнх үйл ажиллагааг төрөөс хянаж, зохицуулалт хийдэг. Хувийн хэвшлийн аливаа байгууллага эдгээр хуулийн хүрээнд ажиллах үүрэгтэй. Хувийн хэвшил нь эдийн засагт хамгийн нөлөөтэй том тоглогч. Ажлын байр бий болгох, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, инновац болон технологийн дэвшлийг авчрах, эдийн засгийг солонгоруулах зэрэг улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийг түүчээлэх чухал үүрэгтэй. Хувийн хэвшлийг дэмжиж, чөлөөтэй өрсөлдөх, хөгжих боломж олгосон улс орнууд хөгжлийн илүү өндөр түвшинд гарсан байна. (Ч.Н)

ХУВИЙН ХЭВШЛИЙН ТОГТОЛЦОО (*Private enterprise system*)

Хувийн хэвшлийн тогтолцоо нь хувь хүмүүс болон бүлгүүд хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэж ашиг орлого олдог, үйлдвэрлэл, бизнест шаардлагатай нөөц, хэрэгслийг өмчилж хянадаг, өмчөө бусадтай чөлөөтэй солилцох боломжтой эдийн засгийн тогтолцоо юм. Энэхүү тогтолцооны оршин тогтнох үндэс нь хувийн өмчид тулгуурласан чөлөөт зах зээл, өрсөлдөөн бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаан дахь засгийн газрын хөндлөнгийн оролцоог багасгадаг. Энэхүү тогтолцоо нь дараах дөрвөн зарчимд суурилдаг²¹.

Хувийн өмчлөх эрх: Хувь хүмүүс хүссэнээрээ үл хөдлөх хөрөнгө худалдаж авах, эзэмших, ашиглах,

21 Write, S. (2020, April 7). *What Is a Private Enterprise System?* Retrieved from <https://www.reference.com/world-view/private-enterprise-system-a47cb873ded19658>

20 <https://openknowledge.worldbank.org/handle/10986/16979>

худалдах эрхтэй. Энэхүү өмчлөх эрхэд газар, барилга, тоног төхөөрөмж, шинэ бүтээл, биет бус эд хөрөнгө орно.

Сонголт хийх эрх чөлөө: Тухайн хүн ямар ажил хийх, хаана ажиллах, мөнгөө хэрхэн, хаана зарцуулахаа өөрөө шийдэх эрхтэй. Өөрөөр хэлбэл хүмүүс хүсвэл бусдын төлөө эсвэл өөрийнхөө төлөө ажиллах боломжтой гэсэн үг юм. Түүнчлэн, эдийн засгийн байр сууриа дээшлүүлэхийн тулд ажлаа сольж, чөлөөтэй ажиллах боломж юм.

Ашиг орлого олох эрх: Хөрөнгө оруулалт хийх замаар бизнес эхлүүлж түүнээсээ ашиг орлого олох боломж нь бизнес эхлүүлэхэд гол хөшүүрэг, бизнесийн гол зорилгуудын нэг юм.

Өрсөлдөх эрх: Хүмүүс бусадтай өрсөлдөх эрх чөлөөтэй байдаг. Өрсөлдөөн, ашиг орлого нь энэ тогтолцооны үндэс суурь. Бизнес эрхлэгчид чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэн үнээ тогтоож, өвөрмөц маркетингийн үйл ажиллагаа явуулж өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ өрсөлддөг. Өрсөлдөөн нь хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, илүү чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлэхэд нөлөөлнө. Энэхүү тогтолцоонд хөрөнгө оруулагчид болон түүнийг ашиглаж буй хүмүүсийн хоорондын харилцааг гэрээгээр зохицуулагддаг эсэх, энэхүү гэрээний зохицуулалтыг хангах зохицуулалтын тогтолцоо бүрэлдсэн эсэх, хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулах хөшүүрэг болох өрсөлдөөн байгаа эсэх нь чухал нөлөөтэй²². Хувийн аж ахуйн нэгжүүд нь эдийн засгийн хөгжил, тогтвортой өсөлтийг хангах аливаа Засгийн газрын хэтийн зорилгын нэгэн хэсэг

болж байдаг. Иймээс хувийн хэвшлийн өсөлт, хөгжил нь урт хугацааны хөгжлийн чадавх, тогтвортой өсөлт, ажлын байр бий болгох Засгийн газрын үүргийг гүйцэлдүүлэхэд зайлшгүй чухал байдаг. (З.А)

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ (*Joint stock*) Тодорхой тооны хувьцаанд хуваагддаг хөрөнгийг хэлнэ. Компанийн давуу эрхийн болон энгийн хувьцааны тоо ширхгийг нэрлэсэн үнээр нь үржүүлсэн нийт үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрх, түүний нотолгоо нь хувьцаа бөгөөд хувьцаа гаргасан компанийн нэр, өмчлөх өмчийн хувь хэмжээ, хувьцааны хэлбэр зэргийг заасан үнэт цаасыг хувьцааны сертификат гэдэг. Төр аливаа компанид хөрөнгө оруулсныхаа төлөө эзэмшиж байгаа хувьцааныхаа эрхээ хэрэгжүүлэхдээ дүрэмдээ заасан эрх бүхий этгээдээс томилсон төлөөлөгчөөр дамжуулан төлөөллөө хэрэгжүүлэхээр хуульчилсан. (Б.Б)

ХУВЬ ТЭНЦҮҮЛСЭН БУЮУ ПРОПОРЦИОНАЛ ТОГТОЛЦОО (*Proportional system*) Энэ тогтолцооны үндсэн зарчим нь парламентын суудлыг улс төрийн намуудад сонгуульд авсан саналтай нь хувь тэнцүүлэн хуваарилахад оршдог ба сонгогчийн санал үл гээгдэх зарчим үйлчилнэ. Пропорционал систем нь дотроо мөн өөрийн олон хувилбартай байдаг. Гэхдээ

- Намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоо
- Санал шилжүүлэх тогтолцоо гэсэн хоёр гол хувилбартай.

Сонгуулийг заавал нэгээс дээш мандаттай тойрогт зохион байгуулахыг шаарддаг. Тойргийн мандатын тоо

22 Bhatta, G. (2015). *International Dictionary of Public Management and Governance*. New York: Routledge, pp. 491-492.

хэдийчинээ олон байна төдийчинээ сонгуулиас гарах үр дүн нь хувь тэнцүүлсэн байх болно. Хувь тэнцүүлсэн тогтолцоонд сонгогчдын санал өгөлт нь улс төрийн намуудаас, нэр дэвшигч хувь хүмүүсээс эсвэл хоёулангаас нь сонголт хийх боломжтой байдгаараа ялгардаг. Энэ тогтолцооны гол давуу тал нь мажоритар тогтолцооны гол сул талуудаас зайлсхийж, хууль тогтоох байгууллагад иргэдийн төлөөллийг хангах, санал үл гээгдэх зарчмыг баримталдаг.

Шинэ, жижиг намуудад ээлтэй, сонгуулийн тойрогт ганц нам бүх суудлыг авах магадлал бага байдаг тул тодорхой бүс нутагт тархан суурьшсан цөөнхийн сонгогчид төлөөллөө сонгох боломжтой зэрэг давуу талуудтай юм. Харин олон нам хууль тогтоох байгууллагад орж ирснээр зөвшилцөлд үл хүрэх, шийдвэр гаргалт удаан, эвслийн засгийн газар байгуулагдаж, улс төрийн тогтворгүй байдал үүсэх, мөн сонгуулийн үр дүнг тооцох үйл явц олон шатлалтай, эцсийн үр дүн гаргахад хугацаа авдаг тул иргэдэд ойлгомжгүй байдал үүсэх зэрэг сул талуудтай. (Я.Т)

ХУВЬ ХҮНИЙ ӨГӨГДӨЛ (*Personal data*) Физикийн, оюун ухааны, физиологийн, эдийн засаг соёл эсвэл нийгмийн онцлог, харилцаа холбоогоор нь лавлан тодорхойлсон эсвэл тодорхойлж болохтой холбоотой тухайн хүний талаарх цогц мэдээлэл. Хувь хүнийг тодорхойлох өгөгдлийг төрөл бүрийн зорилгоор боловсруулж болох бөгөөд аль ч тохиолдолд хүний эрхийн үүднээс өгөгдлийн эзэн болох хүнээс зөвшөөрөл авах бөгөөд хамаарах мэдээллийн нууцлалыг өгөгдөл боловсруулагч хадгалах үүрэг хүлээнэ. Тус өгөгдлийг боловсруулах,

хадгалах, ашиглах харилцааг ихэнхдээ хуулиар зохицуулдаг. (Д.З; Ч.Л нар)

ХУВЬЧЛАЛ (*Privatization*) Төрийн өмчийн үйлдвэрлэл, үйлчилгээний газрын өмч буюу үндсэн хөрөнгийг эсвэл түүнтэй адилтгах үнэ цэнэ бүхий зүйлийг хувийн хэвшлийн эзэмшилд шилжүүлэх үйл явцыг хэлнэ. Үүнийг бас өмч хувьчлал ч гэж нэрлэгдэг. Хувьчлал нь өмчийн зүйлийг шилжүүлэхээс гадна үйл ажиллагаа эрхлэх эрхийг, удирдлагын эрхийг хувийн хэвшилд шилжүүлэх зэрэг хэлбэрүүдтэй байдаг. БНМАУ-ын өмч хувьчлах тухай хууль 1991 оны тавдугаар сард батлагдаж, мөн оны зургадугаар сард Засгийн газрын тогтоолоор төрийн өмчид үлдэх болон төрийн өмч давамгайлсан өмчийн хэлбэртэй байх салбар, үйлдвэрийн газруудыг дараах байдлаар тусгасан байв. Үүнд: нэгдүгээрт, төрийн өмчид төмөр зам, иргэний агаарын тээврийн байгууллага, ой, ангийн аж ахуй, малын аюулаас хамгаалах тэжээлийн сан, мал эмнэлгийн шинжилгээний лаборатори, эмийн үйлдвэр, газар тариалангийн үрийн улсын нөөц, сорилтын газар, аймаг хотын ус сувгийн газар, авто зам, улсын геологийн сан, алт олборлох уурхай зэрэг хориод төрлийн салбар байгууллагыг үлдээхээр, хоёрдугаарт, төрийн өмч давамгайлсан байдлаар хувь оролцоо салбар, газрын бүрэлдэхүүнд цахилгаан станц, нүүрсний уурхай, хар ба өнгөт металлын уурхай, боловсруулах үйлдвэр, холбооны газар, зарим гурил, мах, хүнсний үйлдвэр, нийтийн хэрэгцээний авто тээврийн зарим бааз, сайн үүлдэр угсааны мал үржлийн аж ахуй, ферм зэрэг 40 гаруй үйлдвэр аж ахуйн газрыг хамруулах нь зүйтэй гэж үзжээ. Өмч хувьчлалаар иргэд өмч, хөрөнгийн эх үүсвэртэй болж хувийн хэвшил үүсэн бүрэлдэж, эдийн засагт тодорхой үүрэг гүйцэтгэж эхэлсэн. (Б.Б)

ХУВЬЧЛАЛЫН БОДЛОГО (*Privatization policy*)

Үйлдвэрлэлийн хэрэгсэл дэх хувийн өмчийн хэлбэрийг бий болгох, дэмжих, эдийн засагт үр ашигтай өрсөлдөөний системийг бүрдүүлэх зорилгоор монополыг задлах ба төрийн өмчийг хувийн хэвшилд шилжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого. Улс орнууд хувьчлалыг хэрэгжүүлэхдээ өөрийн онцлогт нийцүүлэн ялгаатай бодлого, загварыг ашигласан байдаг. Тухайлбал, бага хувьчлал буюу тээвэр, барилга, худалдааны салбарын жижиг, дунд үйлдвэрийг ажилтнуудад давуу эрхтэйгээр хувьчлах, эдгээр салбарт шинээр аж ахуйн нэгж үүсгэх, хувьчлагдсан аж ахуйн нэгжүүд хуваагдах замаар шинэ ажлын байр бий болох үйл явц; их хувьчлал буюу томоохон үйлдвэр аж ахуйн газрын хувьцааг хувь хүмүүст худалдаалан хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх, ваучер, үнэт цаасаар хувьчлах замаар хөрөнгийн тодорхой хувийг эзэмших боломж иргэдэд олгох буюу бүх нийтийн хувьчлал²³ гэсэн аргуудыг түгээмэл хэрэглэсэн. (Б.Б)

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМ (*e-Government Procurement (e-GP) system*)

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан цахим худалдан авах ажиллагаа зохион байгуулах, хэрэгжилтийг хангах, тендер шалгаруулалтын урилга, үр дүн, тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдол шийдвэрлэлтийг мэдээллэхтэй холбоотой харилцааг зохицуулахад зориулагдсан систем. Энэ нь төр бизнесийн цахим харилцаа (G2B)-г хэрэгжүүлэх платформын жишээ юм.

Төрийн худалдан авах ажиллагаанд бүрэн цахим систем хэрэглэх нь уг ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгж тэгш боломжтой оролцох, ашиг сонирхлын зөрчлөөс ангид явагдах, шударгаар шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой. Мөн төрийн худалдан авалтад хувийн хэвшлийн оролцох сонирхлыг нэмэгдүүлж, худалдан авах ажиллагаатай холбоотой захиргааны зардлыг бууруулна. (Д.З; Ч.Л нар)

ХУУЛЬ (*Law*) Хууль гэж бүх нийт заавал дагаж мөрдөхөөр төрөөс батлан гаргаж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон дээд хүчин чадал бүхий баримт бичгийг хэлнэ. Хууль нь нийгмийн чухал харилцааг зохицуулж, хүн амын хүсэл зоригийн шууд илэрхийлэл болж парламентаас онцгой журмаар, эсхүл ард нийтийн асуулгаар батлагдан гардаг. Хуулийг Үндсэн хууль, ердийн хууль гэж ангилна. Үндсэн хуулиар үндсэн хуульт байгуулал, нийгэм, эдийн засгийн харилцааны суурь үндэс, төрийн эрх мэдэл, хүний эрх, төр иргэний харилцааны суурь зарчмыг тодорхойлон тогтоодог бол нийгмийн тодорхой төрлийн харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор салбар хуулиуд гардаг. Тухайлбал, Монгол Улсад Иргэний хууль, Эрүүгийн хууль, Боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Татварын тухай хууль зэрэг хуулиуд хүчин төгөлдөр үйлчилж байна. Монгол Улсын Их Хурлаас батлан гаргаж байгаа бүх хууль Үндсэн хуульд нийцсэн байх хууль зүйн шаардлага тавигддаг. Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно. (Ч.Э)

23 Ханс-Георг Петерсен: Төрийн эдийн засаг, Улаанбаатар, 2008, х. 259-260.

ХУУЛЬ БУС ЗАХИРГААНЫ АКТ (*Illegal administrative act*)

Эрх зүйн зөрчилтэй захиргааны актыг хууль бус захиргааны акт гэнэ. Өөрөөр хэлбэл, эрх хэмжээгээ хэтрүүлсэн, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, сонгох боломжийг буруу хэрэглэсэн зэрэг хуулийг ямар нэг байдлаар зөрчсөнийг эрх бүхий байгууллагаас хянан шийдвэрлэсэнээр захиргааны акт хууль бус акт болно. Хууль бус захиргааны актыг нөлөөллийн шинжээр ялгаж салгах нь чухал байдаг. Учир нь үүнээс хамаарч уг актыг хэрхэх тухай асуудал шалтгаална. Нөлөөллийн шинжээр захиргааны актыг эерэг нөлөөлөл бүхий захиргааны акт, сөрөг нөлөөлөл бүхий захиргааны акт гэж ангилна [Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 4,5 дахь хэсэг]. Эерэг нөлөөлөл бүхий захиргааны акт гэж эрх зүйн үйлчлэл чиглэсэн этгээдэд эрх олгосон, эсхүл ашигтай нөхцөл байдлыг бий болгосон захиргааны актыг ойлгох бол сөрөг нөлөөлөл бүхий захиргааны акт нь тухайн этгээдэд үүрэг бий болгох, эсхүл түүнийг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарлах байдлаар эрх зүйн байдлыг дордуулсан акт байдаг. Эерэг нөлөөлөл бүхий хууль бус захиргааны актыг гагцхүү хууль, захиргааны хэм хэмжээний актаар, эсхүл захиргааны актад түүнийг хүчингүй болгохоор заасан, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, эсхүл нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлсөн, захиргааны актаар олгосон эрхийг хэрэгжүүлээгүй, захиргааны актыг гаргуулахдаа хууран мэхлэх, айлган сүрдүүлэх, авлига өгөх буюу бусад хууль бус аргыг хэрэглэсэн, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан тохиолдолд хүчингүй болгодог бол сөрөг нөлөөлөл бүхий хууль бус захиргааны актад гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа

өнгөрснөөс үл хамааран захиргааны байгууллага тухайн захиргааны актыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгоно. (Ч.Э)

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЗАРЧИМ (*The Rule of law*)

Хууль дээдлэх зарчим нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг. Нийгмийн амьдралын суурь харилцаанууд хуулиар зохицуулагдаж, төрийн аль ч байгууллага үйл ажиллагаандаа Үндсэн хууль, бусад хуулийг тэргүүн зэрэгт тавьж, ягштал баримталж, гуйвалтгүй сахин биелүүлэх нь хууль дээдлэх зарчмын гол агуулга болно. Зөвхөн хуулиар олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн байгууллага эрх зүйн актыг батлан гаргах, эрх зүйн акт бүр хуульд үндэслэсэн байх учиртай. Хуулийг заавал биелүүлэхээс гадна хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх нь төр ба иргэний харилцааг тодорхойлогч зарчим мөн. Хуулийн өмнө бүх байгууллага, аж ахуйн нэгж, бүгд адил тэгш байж түүнд нэг зарчмаар захирагдана гэдэг хууль дээдэлж байгаагийн бас нэг илрэл юм. Онолын хувьд "Rule of Law" буюу гагцхүү эрх зүйт хууль дээдлэгдэх, хүлээн зөвшөөрөгдөх зарчмыг "Rule by Law" буюу төрийн албадлагаар хамгаалагдсаных нь хувьд хуулийг дагаж мөрдөх зарчмаас ялгадаг. Эрх зүйт хууль [правовой закон] нь бусад хуулиас ялгагдах гол шинж нь Үндсэн хуулийн зөрчигдөж болохгүй зарчмуудад үндэслэсэн хууль байдагт оршино. (Ч.Э)

ХУУЛЬ ЁСНЫ РАЦИОНАЛ ЭРХ МЭДЭЛ (*Rational legal authority*)

"Authority" гэдэг нь Францын "autorité" гэсэн үгнээс үндэстэй. Үгийн утга нь "эрх, зөвшөөрөл олгох (right, permission)" юм. Харин Rational гэдэг нь Латины "rationalis" буюу "үндэслэл, шалтгаан (reason, reasonable)" гэх үгнээс

үндэстэй. Монгол хэлнээ Rational authority гэдгийг рационал эрх мэдэл хэмээн орчуулан хэрэглэдэг. Макс Вебер орчин үеийн төр улсад хууль ёсны буюу рационал эрх мэдэл тогтсон байх бөгөөд түүнтэй уялдсан зохион байгуулалт, харилцаа аяндаа бий болно гэжээ. Энэ нь албан ёсны бичмэл эрх зүйд тулгуурласан байдаг. Өөрөөр хэлбэл, рационал эрх мэдэл нь хуулиар баталгаажсан эрх мэдэл юм. Захиргааны байгууллагын үйл ажиллагаа нь урьдчилан тогтсон нарийн үйл явцаар зохицуулагддаг. Захиргааны албан тушаалтнуудад рационал эрх мэдэл олгогддог бөгөөд энэхүү эрх мэдэл нь хязгаарлагдмал буюу “тэднийг алба хашиж байх хугацаанд үйлчилдэг”-ээрээ онцлог юм. Рационал эрх мэдлийг хувь хүн, нийгмийн бүлэг, шат шатны төрийн байгууллага, төрийн албан хаагч зайлшгүй дагаж мөрдөх учиртай. Энэ ч утгаараа захиргааны үйл явц нь хувь хүний ашиг сонирхолд үл хөтлөгдөх, ажил үүргийг хийж гүйцэтгэх мэдлэг чадварыг шалгуур болгох, хуульд захирагдах байдлаар бие даасан байдлаа хадгалах, албан тушаалтны өгсөн үүрэг даалгавар нь шатлан захирах зарчимд үндэслэх шинж чанарыг өөртөө агуулдаг. (Т.Т)

ХУУЛЬ ТОГТООМЖ (Legislation)

Онолын хувьд хууль тогтоомж гэдэгт нэгдүгээрт, хууль батлан гаргах үйл ажиллагааг ойлгоно. Хоёрдугаарт, өргөн утгаар нийгмийн харилцааг бүхэлд нь буюу түүний алив нэг төрлийг нь зохицуулдаг эрх зүйн хэм хэмжээний нийлбэрийг хууль тогтоомж гэнэ. Жишээ нь эрүүгийн хууль тогтоомж, иргэний хууль тогтоомж, хөдөлмөрийн хууль тогтоомж г.м. Хууль тогтоомжид Үндсэн хууль, хуулиуд, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, хэм

хэмжээ тогтоосон бусад акт хамаарна. Харин явцуу утгаар хууль тогтоомжид зөвхөн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хамруулдаг.²⁴ (Ч.Э)

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН АКТЫН ЭРЭМБЭЛЭЛ (Hierarchy of legislative acts [regulations])

Тухайн улсын дагаж мөрдөж буй эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд зохицуулж байгаа нийгмийн харилцааны шинж чанар, түүнчлэн хэм хэмжээний актыг батлан гаргасан байгууллагаас шалтгаалан хүчин чадлын хувьд шатлан эрэмбэлэгдэнэ. Аль ч улсад хамгийн дээд хүчин чадалтай акт нь тухайн улсын Үндсэн хууль байдаг. Эрх зүйн хэм хэмжээ тогтоосон аливаа акт Үндсэн хуулийг зөрчих ёсгүй. Хүчин чадлын хувьд Үндсэн хуулийн дараа хууль ордог. Хууль гэж нийгмийн амин чухал харилцааг зохицуулж, хүн амын хүсэл зоригийн шууд илэрхийлэл болж парламентаас онцгой журмаар, эсхүл ард нийтийн асуулгаар батлагдсан, төрийн байгууллагын хэм хэмжээ тогтоосон бусад эрх зүйн акттай харьцуулахад хууль зүйн дээд хүчин чадалтай хууль зүйн акт юм. Монгол Улсад хуулийн дараа хэм хэмжээ тогтоосон хууль тогтоомжийн акт болох Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг орно. Эдгээр хууль тогтоомжийн актаас гадна яам, агентлагийн дүрэм, журам, заавар зэрэг хэм хэмжээ тогтоосон актууд байдаг. Эдгээр актууд дээр дурдсан хууль тогтоомжийн актыг дагуу, тэдгээрийг хэрэгжүүлэх үндсэн дээр гарна. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан хэм хэмжээ тогтоосон актууд нь тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх бөгөөд дээд хүчин чадалтай актуудад захирагдмал байна. (Ч.Э)

²⁴ Хууль тогтоомжийн тухай хууль

ХУУЛЬ ТОГТООХ ЭРХ МЭДЭЛ (*Legislative power*) Хууль тогтоох эрх мэдэл гэж төрийн эрх мэдэл хуваарилах онолын дагуу төрийн эрх мэдлийн бие биетэйгээ эн тэнцвэртэй байх гурван эрх мэдлийн нэг нь юм. Хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү хууль батлах бүрэн эрхийг хэрэгжүүлэгч тусгай байгууллага-парламент төлөөлнө. Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд зааснаар, Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална. Улсын Их Хурал нь хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, дуусгавар болгохын зэрэгцээ төрийн хэргийг удирдах, төрийн бусад байгууллагыг байгуулах, албан тушаалтныг томилох, төсөв, санхүү, мөнгө зээлийн бодлогыг тодорхойлох, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг гүйцэтгэдэг. (Ч.Э)

ХУУЛЬД ҮНДЭСЛЭХ ЗАРЧИМ (*Principle of rooting on law*) Захиргаа бол нийтийн эрх зүйн хүрээнд ард түмнээс дамжуулан эрх авсан, иргэнд төрийн үйлчилгээг хүргэхийн тулд л үйл ажиллагаа явуулдаг нийтийн эрх зүйн этгээд мөн. Иймд Захиргааны бүх үйл ажиллагаа хуулийн шаардлагад нийцэж, түүний хүрээнд явагдах учиртай. Энэ нь Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг нь хууль дээдлэх зарчим байна гэснээс үүдэлтэй. Энэ зарчмын хүрээнд захиргааны байгууллагын хувьд дараах шаардлага тавигдана.

Захиргаанаас хууль зөрчсөн ямар нэг үйлдэл хийхийг хориглоно.

Захиргаанаас хуульгүйгээр дур мэдэн аливаа үйлдэл хийхийг хориглоно.

Захиргаанаас хууль ёсны зорилгын үүднээс иргэний эрхэд шаардлагатайгаас илүү хэмжээгээр халдахыг хориглоно. Хууль дээдлэх зарчмын хүрээнд захиргаанаас хууль зөрчсөн ямарваа нэг үйлдэл хийхийг хориглохын дээр түүнээс журам гаргаж байгаа бол хуулиас давсан хэм хэмжээ тогтоох ёсгүй. (Ч.Э)

ХҮЙТЭН ДАЙН (*Cold war*) Энэхүү нэр томъёогоор Дэлхийн II Дайны дараа АНУ болон ЗХУ хоёрын хооронд бий болсон хурц сөргөлдөөний үеийг нэрлэдэг. Энэхүү сөргөлдөөн 1990-ээд он хүртэл үргэлжилсэн бөгөөд коммунист эвслийн орнууд болон өрнөдийн орнуудын хоорондох үзэл суртлын тэмцэл буюу коммунизм ба ардчиллын хоорондох “зарлаагүй дайн” байсан гэж үздэг. Цэрэг зэвсгийн хүчээр бус үзэл суртлын аргаар өрсөлдөж байсан “хүчтэй дайн” хэмээн нэрлэж болно.

Олон улсын харилцааны судлаачид “Хүйтэн дайн” хэд хэдэн үе шаттай гэж үздэг (Д.Баярхүү). Үүнд:

1. 1947-1953 он. Эртний түүхт Европ дундуураа хуваагдаж төмөр хөшиг татагдлаа хэмээн Британийн Ерөнхий сайд асан Черчилль 1946.03.05-нд АНУ-ын Фултон хотод мэдэгдэл хийснээр “Хүйтэн дайн” эхэлжээ.
2. 1953-1962 он. “Хүйтэн дайн”-ы жинхэнэ автор Сталин нас нөгчлөө, АНУ-д Трумэн улс төрөөс явлаа. Солонгосын дайн дууслаа.
3. 1962-1979 он. Гуравдагч ертөнц бодитой хүч болон дэлхийд буй боллоо. Колонийн дэглэмүүд нурлаа. Африкийн голдуу улс орнууд тусгаар тогтнолоо олж авлаа.

4. 1979-1985 он. “Хүйтэн дайн”-ы үлэмж хурцхан үе. 1979 онд СССР хөрш жижиг Афганистандаа цэрэглэн халдаж, намжмал байдлын ололтуудаа бусниуллаа. 1980 оны Москвагийн олимпыг өрнөд боож, анх удаа АНУ, Япон, ХБНГУ-гүйгээр спортын наадам өрнөлөө.
5. 1985-1991 он. “Хүйтэн дайн”-ы төгсгөл үе шат. Бидэнд хамгийн ойр, хамгийн сайн мэдэх СССР-т өрнөсөн перестройка гэх үйлсээр илэрхийлэгдэнэ.

Манай улсын хувьд Хүйтэн дайны нэг дэх үе шатанд БНМАУ-ын гадаад байдал бэхжиж, НҮБ-д хууль ёсны суудлаа эзэлж, Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлд элсэж, нийгэм, улс төрийн байгууламжийг харгалзахгүйгээр энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үүднээс дипломат харилцаа тогтоох нь 1960-аад оноос өргөжин тэлсэн билээ. (Я.Т)

ХҮЛЭЭЛТИЙН ОНОЛ (*Expectancy theory*) Байгууллагын гишүүд сайн дураараа ажил хийхэд хүргэх сэдлийг бий болгох үйл явцыг голлон судалдаг онол юм. Өөрөөр хэлбэл, хүн үйлдлийг гүйцэтгэснээр хүртэж болох урамшууллын талаарх сэтгэхүйн үйл явцыг шинжлэн судалдаг. Сонгодог эдийн засгийн ашгийн тухай онол, зан үйлийн сонголтын онол, Курт Левин, Эдуард Толмен нарын танин мэдэхүйн үйл явцын онолуудад үндэслэсэн хүний хөдөлмөрийн сэдэлжих үйл явцыг тайлбарладаг онол юм. Энэ онолыг анх Виктор Врум (V.Vroom) боловсруулжээ. Тэрээр хүн үйлдлийг хийснээр тодорхой үр дүнд хүрч, улмаар өөрийнхөө хувьд үнэ цэнэтэй зүйлийг хүртэнэ гэж найдах нь хамгийн чухал гэж үздэг. Үнэ цэнэтэй зүйл гэдэг нь хүн бүрд харилцан адилгүй байх ба мөнгө, эд баялаг,

нэр хүнд, алдар цуу, хэргэм зэрэг, амар тайван байдал зэрэг олон янзын зүйлийг хүн хүсэж, түүндээ хүрэхийг эсвэл хэвээр нь хадгалахыг эрмэлздэг. Ингэж зорилго тавин үйлдэл хийхдээ хүн тодорхой хүлээлтийг бий болгодог гэжээ. Энэ онол нь хүний гаргаж байгаа хүчин чармайлт, түүний тухайн ажлыг гүйцэтгэх түвшин, хүсэн хүлээж буй өндөр үр дүн гэсэн элементүүдийн уялдаа хамааралд тулгуурладаг. Гаргаж буй хүчин чармайлт, гүйцэтгэлийн түвшин, үр дүн ба түүний үнэ цэнийн талаарх хувь хүний субъектив үнэлгээ бол хүлээлт юм. Тиймээс хүлээлтийн онолыг сэдэлжүүлэлтийн үйл явцын онол ч гэж нэрлэдэг. Мөн хүлээлтийн онолд Рулло (E.Lawer)-ийн “Ажлын байр, сэтгэл ханамжийн онол”, Жого Паулус (B.Georgopoulos)-ын “Зам-зорилгын онол” багтана. (Ц.Д)


ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ (*Human security*) Аюулгүй байдал гэдэг нь Латин хэлний “*securus*” буюу “ямар нэг зүйлийг хамгаалах” гэсэн үгнээс үндэстэй бөгөөд 1941 оноос улсын аюулгүй байдал, хүний аюулгүй байдал гэсэн утгаар хэрэглэгдэх болсон. Хүний аюулгүй байдал нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үйл ажиллагаатай шууд холбогддог. Энэ нь хүн айдасгүй, дутагдах зүйлгүй, сүр жавхлантай амьдрах нөхцөл боломжоор хангагдах тухай юм. Хүний аюулгүй байдал нь дараах таван зарчимд тулгуурласан байдаг. Үүнд:

- Хүн төвтэй байх. Хүний (ялангуяа, нийгмийн эмзэг бүлгийн иргэд) эрүүл, аюулгүй орчинд амьдрахад хор хөнөөл, айдас түгшүүр учруулж буй байдалд нэн тэргүүнд анхаарах;
- Иж бүрэн, цогц байх. Хүний аюулгүй байдлыг хангахад тулгарсан сорилт, аливаа асуудлыг цогц байдлаар харж аюул заналыг

арилгах, оролцогч талуудын хамтын ажиллагааг чухалчлах;

- Онцлогт тохирсон байх. Хүний аюулгүй байдлыг хангахдаа тухайн улс орны болоод иргэдийн онцлогийг харгалзах, түүнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Урьдчилан сэргийлэх. Хүний эрх, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ нь урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх, тэгш боломжоор хангах;
- Хамгаалах, хүчирхэгжүүлэх. Иргэд (ялангуяа ядуу иргэд) өөрөө өөрсдийгөө чадавхжуулах, тэсвэрлэшгүй зүйлсээс өөрсдийгөө хамгаалах, эрхээ эдлэх боломжоор хангах.

Хүний хөгжил нь хүний аюулгүй байдлыг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүний аюулгүй байдал нь эдийн засгийн аюулгүй байдал (орлого, хөдөлмөр эрхлэлт), хүнс тэжээлийн аюулгүй байдал (хоол, хүнс), эрүүл мэндийн аюулгүй байдал (эрүүл мэнд, амьдралын хэв маяг), хүрээлэн буй орчны аюулгүй байдал (ус, агаар), хувь хүний аюулгүй байдал (бие махбод, хүчирхийлэл), хүй элэгний аюулгүй байдал (шашин, үндэстний ялгаварлал), улс төрийн аюулгүй байдал (улс төрийн гадуурхал) гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг. Төр засгийн үндсэн үүрэг нь эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдааг хангаж, иргэдээ ядуурлаас ангид, хөгжих тэгш боломжоор хангах явдал байдаг. Энэ утгаараа хүний аюулгүй байдал нь засгийн газар хоорондын болоод олон улсын, бүс нутгийн төрийн байгууллага, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, түншлэлийг чухалд үздэг. (Т.Т)



ХҮНИЙ НӨӨЦ (*Human resource*)²⁵

Тухайн байгууллага, төр, хувийн хэвшлийн болон бизнес, аж үйлдвэр, эдийн засгийн салбарт ажиллах хүчийг бүрдүүлэгч хүмүүсийн цогц юм. Төрийн албаны хүний нөөцийг уг албанд ажиллаж байгаа төрийн албан хаагчид бүрдүүлнэ. (С.Ц)

ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЭХ

(Staffing) Англи хэлний staffing үгийн үндэс нь герман хэлний “stæb”, эртний англи хэлний “stæf” (олон тоо stafas) үгийн утга нь “таяг, хүнд зүйл өргөхөд хэрэглэгддэг шон, зэвсэг болгон ашигладаг саваа, бэлчээрийн аж ахуйн ажилтнууд” гэх нэр үгийн утгаар хэрэглэгддэг байжээ. Харин үйл үгийн утга 1859 онд англи хэлэнд нэвтэрсэн “туслах ажилтнуудаар хангах” гэсэн утгатай байна.²⁶ Америкийн улс төр судлаач Лютер Гулик, английн менежментийн зөвлөх Линдалл Урвик нар 1937 онд хэвлүүлсэн “Notes on theory of Organization” бүтээлдээ Хэнри Файолын менежментийн санааг үндэслэн POSDCORB гэх товчлол гаргасан ба үүний S нь Staffing гэх үгний эхний үсэг юм. Staffing гэдгийг орчин цагт боловсон

²⁵ https://en.wikipedia.org/wiki/Human_resources

²⁶ Online Etymology Dictionary. Staff. Retrieved from <https://www.etymonline.com/word/staff>

хүчнийг бүрдүүлэх үйл ажиллагаатай холбон тайлбарладаг. Хүний нөөцийн бүрдүүлэлт нь аливаа байгууллагад ажлын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн ажлын шаардлагад нийцсэн чадварлаг хүмүүсийг сонгож авах, мөн хүмүүсийн тухайн байгууллагад ажиллах тэмүүллийг бий болгох үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, энэ нь зөв цагт нь тухайн ажлын байранд хамгийн сайн тохирох хүмүүсийг шилж сонгох боломжийг олгодог хүний нөөцийн удирдлагын чухал үйл ажиллагааны нэг юм. Мөн хүний нөөцийн бүрдүүлэлт нь байгууллагын ажлын байрны шинжилгээ хийх, боломжит нөөцийг төлөвлөх, ажилд сонгон шалгаруулж авах, байршуулах, шилжүүлэх зэрэг үйл ажиллагаатай холбоотой байдаг. Төрийн албаны хувьд хүний нөөцийн бүрдүүлэлтийг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулдаг. Тухайлбал, төрийн албанд албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн албан тушаалд тавигдах шаардлага хангасан иргэнийг төрийн албанд шалгаруулан авдаг. Албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй бөгөөд холбогдох байгууллага, “албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлдэг”²⁷. Ийнхүү төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэхдээ шатлан дэвших зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас эсхүл, төрийн албаны нөөцөд бүртгэгдсэн иргэдээс сонгон шалгаруулж авдаг. (Т.Т)

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА **(Human resource management)**

Хүний нөөцийн удирдлага нь байгууллагын түвшинд ажиллагсдынхаа мэдлэг, ур чадвар, чадавхыг зөв удирдах, ашиглах, хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааны цогц юм. Хүний нөөцийн удирдлага нь менежментийн шинжлэх ухааны салбар мөн²⁸. Төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлага нь албан тушаалын шаардлагад нийцүүлэн хүмүүсийг сонгон авах, сургах, хөгжүүлэх, ашиглах, тогтвортой ажиллуулах, цалин урамшуулал олгох зэрэг төлөвлөсөн үйл ажиллагааны цогц байдаг²⁹. Монгол Улсад 1994 онд батлагдсан, 2017 онд шинэчлэн найруулсан Төрийн албаны тухай хуульд төрийн албанд горилогчийг ажлын туршлага, мэдлэг чадварыг үнэлж, албан тушаалд дэвшүүлэн ажиллуулахдаа чадахуйн буюу мерит зарчмыг баримтлахаар заасан. (Д.Ч)

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨРӨНГИЙН **БҮРТГЭЛ (Human asset accounting)**

Байгууллагын санхүүгийн тайланд “хүний нөөцийг хөрөнгө” хэмээн бүртгэх талаарх үзэл баримтлал ба хандлагыг хэлнэ. Орчин цагт хүний нөөц нь хамгийн чухал хүчин зүйл тул үүнийг байгууллагын санхүүгийн тайланд тусгах асуудал тавигдаж байна. Хүний нөөц нь барилга байгууламж, тоног төхөөрөмж, патент гэх мэт хөрөнгийн нэгэн адил тухайн байгууллагын үнэ цэнийг тодорхойлдог нэгэн төрлийн “хөрөнгө” гэсэн ойлголт сүүлийн жилүүдэд дэлгэрсээр байна. Иймээс энэ үнэ цэнэтэй зүйлийг зөв зүйтэй бүртгэж, санхүүгийн тайланд тусгах талаар бүртгэл, санхүүгийн

27 Төрийн албаны тухай хууль

28 Менежментийн шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь, Glossary of Management Science Terminology, Улаанбаатар, 2020, 168 дахь тал.

29 Н.Отгонбаяр “Төрийн захиргааны шинжлэх ухаан; Сурах бичиг”, Улаанбаатар, 2019, 240 дахь тал.

салбарынхан ярилцах болсон. Мэдлэгийн эдийн засаг (knowledge economy) хурдацтай тэлж буй өнөө үед энэ асуудал улам бүр хүчээ авах болсон нь зүй ёсны хэрэг юм. Гэвч хэрхэн, яаж нягтлан бодох бүртгэлд бүртгэх асуудал өнөөг хүртэл практикт амжилттай хэрэгжээгүй хэвээр байна. Хувь хүмүүс нь эрх зүйн утгаараа байгууллагын “өмч” биш, тэдгээр нь хувь хүний эрх чөлөөгөө (free will) бүрэн элдэх эрхтэй учир хүний нөөцийг бусад хөрөнгийн адил хянах, захиран зарцуулах боломжгүй, улмаар “хөрөнгө” гэж бүртгэх нь зохимжгүй гэсэн үзэл мөн байдаг. Энэ мэт эрх зүй болон ёс зүйн асуудлаас гадна хүний нөөцийг хэрхэн яаж үнэлэх асуудал мэргэжлийн хүмүүсийн хувьд мөн л тавигддаг. Үнэлгээний аргын хувьд хүний нөөцийг зардлаар нь хэмжих буюу цалин урамшуулал гэх мэт зардлын нийлбэрээр (cost approach), энэхүү нөөцийг нөхөж олоход гарах зардал (replacement cost approach) буюу хүний шинэ нөөцтэй болоход гарах бүх төрлийн зардал (эрэл хайгуул, сонгон шалгаруулалт, цалин, сургалт гэх мэт), мөн ажилтны ирээдүйд олох боломжтой орлогын өнөөгийн үнэ цэнээр (present value of future earnings) зэрэг хэмжих аргуудын дурдаж болох боловч бүгд сул талтай байна. Хүний нөөц нь хувь хүний мэдлэг, ур чадвар, авьяас, туршлага, хандлагын цогц учир мөнгөөр хэмжихэд бэрхшээлтэй маш олон хүчин зүйлийн нийлбэр юм. Цаашилбал, хүний нөөц дээр бусад хөрөнгөтэй харьцуулахад тодорхой бус байдал илүү өндөр байдаг. Хувь хүний эрүүл мэнд, амь нас, авьяас чадварт учирч болзошгүй эрсдэл их. Өнөөгийн байдлаар хөл бөмбөг зэрэг спортын салбарт хүний нөөц буюу тоглогч нарыг тодорхой хэмжээнд үнэлж, тухайн клубын үнэ цэнийг тодорхойлоход ашиглаж эхлээд байна. Бусад салбарын

хувьд үндэслэл сайтай, найдвартай, итгэл үнэмшил бүхий хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний загварыг өнөөг хүртэл боловсруулаагүй байгаа нь энэ бүртгэлийн асуудал илүү өргөн хүрээнд ашиглагдахгүй байгаагийн нэг шалтгаан юм. (Ч.Н)

ХҮНИЙСЭЛ (Alienation) Англи хэлний “alienation” хэмээх нэр томьёо нь философи, социологи, эдийн засаг гэх мэт мэдлэгийн салбар бүрд өөр өөр агуулгатай байдаг. Тийм учраас уг нэр томьёоны орчуулга нь өөр өөр байдаг. Карл Маркс капиталист үйлдвэрлэлийн явцад ажилчны буй болгосон нэмүү өртөг өмчийн эзэнд очдог учраас ажилчны хөдөлмөр, түүний үр дүн уг эзнээсээ “хүнийсэж” бусдынх болж байна гэсэн утгаар хэрэглэсэн байдаг. Сэтгэл судлалд уг ойлголтыг тайлбарлах гэсэн онолын янз бүрийн чиглэлүүд буй болсон. Ерөнхийдөө эл нэр томьёо хүний орчинтойгоо харьцах байдалд гарсан гажгийг илэрхийлнэ. Фрейд хөндийрөх гэдэг санааг илүү хэрэглэсэн бөгөөд энэ бол хүн бодит байдал, болж байгаа үйл явдлыг мэдрэх чадваргүй болох, өөрийн бие хүний шинж чанараа алдах явдал гэж үзсэн байна. Судлаачид марксист сэтгэл судлал, экзистенциализм, феноменолог зэрэг олон ухааны үүднээс энэ асуудлыг судалсан боловч маргаантай хэвээр байгаа юм. Судлаачдын илэрхийлсэн санааг эмпирик талаас нь авч үзвэл ойролцоо байдаг бөгөөд энэ ойлголт нь амьдралдаа, эсхүл түүний аль нэгэн салбарт сэтгэл ханамжгүй болох, хүчин мөхөсдөх мэдрэмж төрөх, ганцаардах, нийгмийн үнэт зүйлийг үгүйсгэх, амьдралын болон эрхэлж байгаа ажлын учир утгыг үгүйсгэх зэрэг байдлаар илэрдэг сэтгэл зүйн гажиг ажээ. Хүний сэтгэл санааны ийм байдал нь хүрээлэн байгаа орчноос хөндийрч, өөрийгөө түгжих, улмаар

сэтгэл санааны хямралд орж нийгмийн эсрэг үйлдэл гаргах, амиа хорлох зэрэг таагүй байдалд хүргэдэг байна. (Ц,Д)

ХҮНИЙ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ (Sustainable human development) Хүний хөгжил нь эрх чөлөөнд суурилсан утга учиртай амьдралын төлөө өөрийн замаар явах боломжийг хүмүүст олгох явдал юм (Conceizgo & et al, 2020). Хөгжлийн үндсэн зорилго нь хүнийг эрүүл саруул байж, урт удаан наслалт, бүтээлчээр ажиллаж амьдрах таатай орчин, нөхцөлийг хүмүүст бүрдүүлж өгөх явдал юм (Тунгалаг & болон бусад, 2019). Тиймээс хүний хөгжил нь энгийн ойлголт атлаа алс хэгийн ач холбогдолтой. Хүний хөгжил нь хүмүүсийг хөгжүүлэх, хөгжлийг хүмүүст зориулах, хүмүүсийн өөрсдийнх нь оролцоотойгоор хөгжлийг хангана гэсэн үг. НҮБ -ын Хөгжлийн хөтөлбөрийн Захирагч ноён Mr. James Gustave Speth хэлснээр ‘Хүний тогтвортой хөгжил нь өсөлтийг бий болгоод зогсохгүй үр ашгийг нь шударгаар хуваарилдаг хөгжил. Энэ нь байгаль орчныг сүйтгэхээс илүүтэйгээр нөхөн сэргээдэг, хүмүүсийг гадуурхахаас илүү хүчирхэгжүүлэхэд чиглэсэн хөгжил. Энэ нь ядуучуудад тэргүүлэх ач холбогдол өгч, тэдний сонголт, боломжийг өргөжүүлж, тэдэнд нөлөөлж буй шийдвэр гаргалтад оролцох боломжийг олгоход чиглэсэн. Мөн ядуурлыг бууруулахад чиглэсэн, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн, ажлын байр, эмэгтэйчүүд, хүүхдүүдийг дэмжсэн хөгжил’ юм (Klugman & et al, 2011). Хүний тогтвортой хөгжил нь ‘ирээдүй хойч үеийн хэрэгцээг алдагдуулахгүйгээр өнөөгийн үеийн хэрэгцээг аль болох шударга, тэгш хангахын тулд нийгмийн капиталыг бүрдүүлэх замаар хүмүүсийн сонголт, чадавхыг дээшлүүлэх’ явдал. (З.А)

ХҮНИЙ ХӨГЖИЛ (Human development) Хүний сонголтуудыг өргөжүүлэх үйл явц хийгээд сонголтыг өргөжүүлснээр хүрэх үр дүн юм³⁰. Хүний хөгжил нь хүмүүсийн сонголтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн баялгийг бус хүний амьдралын баялаг хэв маягийг онцлох ойлголт³¹. Хүний хөгжлийн ерөнхий шалгуур үзүүлэлт болгон хүний хөгжлийн индексийг³² ашигладаг. Хүний хөгжлийн суурь нь урт удаан эрүүл амьдрах, мэдлэгтэй байх, амьдралын зохистой стандартад хүрэлцэхүйц нөөцтэй байх тухай асуудал бөгөөд хүний хөгжлийн таатай, зөв орчин бий болгоход хүрээлэн буй орчны тогтвортой байдал, улс төр, нийгмийн амьдралд оролцох боломж, хүний эрх, баталгааг хангах, жендэрийн тэнцвэрт байдал, нийгмийн шударга ёсыг бэхжүүлэх зэрэг нь гол нөлөөтэй байна³³. Улс орны хөгжлийн үндсэн зорилго нь хүнээ эрүүл саруул байлгаж урт удаан наслуулах, бүтээлчээр ажиллаж амьдрах таатай орчин, нөхцөлийг иргэддээ бүрдүүлж өгөх явдал юм³⁴. Энэ агуулгаар улс орны хөгжлийг иргэдийнх нь хөгжлөөр тодорхойлох бөгөөд хөгжлийн бодлогын суурь нь хүн төвтэй бодлого байх юм. Иймээс улс орнууд хүн төвтэй бодлого, иргэн төвтэй төрийн алба, үйлчилгээ, үйл ажиллагааг чухалчлах болсон байна. 1990 онд дэлхийн анхны хүний хөгжлийн илтгэл гарч “хүний хөгжлийн индекс”-ийг танилцуулсан нь өсөлтийг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмэйдэг байсныг өөрчилж хүнд чиглэсэн хөгжлийн загвар руу шилжүүлсэн байна. Энд чухал үүрэг

30 Жакан С., Долгоржав Я., Сувд Б., “Хүний хөгжил”, 2006, 15 дахь тал.

31 UNDP, Хүний хөгжлийн илтгэл 2015: Хүний хөгжлийн төлөө хөдөлмөрлөх нь, 11 дэх тал.

32 “Хүний хөгжлийн индекс”-ийн тайлбарыг харна уу.

33 UNDP, Хүний хөгжлийн илтгэл 2015: Хүний хөгжлийн төлөө хөдөлмөрлөх нь, 10 дахь тал.

34 Үндэсний статистикийн хороо, “Хүний хөгжил-2018”, 2019, 7 дахь тал.

гүйцэтгэсэн эрдэмтэн нь нобелийн шагналт эдийн засагч Амартия Сэн байх бөгөөд түүний “Чадамжийн талаарх үзэл баримтлал” нь хүний хөгжлийн үзэл баримтлалын онолын суурь болжээ. (М.А)

ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС (*Human development index*) Хүний урт удаан, эрүүл амьдарч байгаа байдлыг нь наслалтаар, мэдлэг эзэмших чадварыг нь суралцсан бодит болон суралцах хугацаагаар, зохистой амьдралын түвшинд хүрэх чадварыг нь нэг хүнд ногдох үндэсний орлогоор тооцож эдгээр үндсэн гурван үзүүлэлтийг нэгтгэн дүгнэдэг цогц индекс юм³⁵. Монгол Улс 2000 оноос хүний хөгжил, түүний бүрэлдэхүүн индексүүдийг тооцож эхэлсэн бөгөөд 2014 онд Олон улсын аргачлалын шинэчлэлтэй холбоотойгоор индекс тооцдог аргачлалаа шинэчилсэн байна. Монгол Улсын хүний хөгжлийн индексийг Монгол Улсын Үндэсний статистикийн хороо гаргаж олон нийтэд мэдээлж байна. (М.А)

ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ (*Human rights and freedoms*) Хүн хүсэл зоригоо хэрэгжүүлэн биелүүлэхийн тулд явуулж буй үйл ажиллагааны боломжийн хүрээг эрх, эрх чөлөө гэнэ. Хүний эрх, эрх чөлөөг дээдэлж хангах, түүнийг хамгаалж баталгаажуулах тухай асуудал бол дэлхий нийтийг хамарсан асуудал болоод байна. Монгол Улс ардчиллын замаар эргэлт буцалтгүй замнаж, дэлхийд явагдаж буй их интеграцтай хөл нийлүүлэн алхахын тулд хүний болон иргэний эрх, эрх чөлөөг хангах нь зайлшгүй юм. 1992 оны Үндсэн хуулиар хүний эрх, эрх чөлөөний асуудлыг бие даасан бүлэг институтийн хүрээнд хуульчлахдаа дэлхийн ардчилсан

улсуудын үндсэн хуулийн үзэл баримтлалыг үндэс болгон, хүний ба иргэний эрх, эрх чөлөөг ардчилсан нийгэм, эрх зүйт төрийн мөн чанарт нийцүүлэн тодорхойлж, өргөн баталгаа тогтоосон юм. Түүнчлэн Монгол Улс хүний эрхийн талаарх олон улсын гэрээ конвенцод нэгдэн орж, дотоодын хууль тогтоомжид энэ талаар тусгаж улмаар сахин мөрдөж байна. (Ч.Э)

ХҮННҮГИЙН ЭЗЭНТ ГҮРНИЙ ЗАХИРГАА (*Administration of Hunnu empire*) Хүннү Улс бол өнөөгийн монгол нутгаар голлосон, Төв Азид тогтож байсан төр улсуудын дотроос түүх, соёл нь мэдэгдэж байгаа хамгийн эртний улс болно. Хүннү Улс газар нутгаа зүүн, төв, баруун хэмээн гурав хувааж, дотор нь аравтын системээр зохион байгуулалт хийдэг байжээ. Төв мужийг шаньюй өөрөө захирдаг байжээ. Зүүн гарыг нь угсаа залгамжлах хан хүү, баруун гарыг баруун гарын гуули ван захирдаг байжээ. Зүүн, баруун гарын ван шанюйд захирагдах ба тус бүрдээ 24 түмт цэрэг бүхий аймгуудын ноёдыг захирдаг байжээ. Хүннү гүрэн хүчирхэгжин газар нутаг тэлэхийн хэрээр эзлэгдсэн, дагаар орсон улс аймаг, газар нутгийг захирах шинэ албад буй болж захиргааны аппарат томорч байжээ. Хүннүгийн захиргааг ерөнхийд нь бүдүүвчилбэл шаньюй, зүүн, баруун мэргэн ван, зүүн баруун гули ван, зүүн, баруун их жанжин, зүүн баруун их дувэй, зүүн, баруун их данху, зүүн, баруун гудухоу зэрэг албан тушаалтантай байжээ. Том ноёдыг шаньюй өөрөө томило. Хорин дөрвөн түмтийн ноёд мянгат, зуут, аравтын ноён, мөн жижиг ван, данху, зезной нарыг томилдог байжээ. Хятад сурвалжид дурдсанаар том ноёдын дотроос зүүн гарын мэргэн ван, дараа нь зүүн гарын гуули ван, Баруун гарын мэргэн ван, баруун гарын гуули

³⁵ Үндэсний статистикийн хороо, “Хүний хөгжил-2018”, 2019, 7 дахь тал.

ван нар хамгийн нөлөөтэй том ноёд байжээ. Тэдгээрийг дөрвөн эвэртэн гэдэг байжээ. Мөн тэдний дор байдаг нэрэндээ их гэсэн тодотголтой зургаан ноёныг зургаан эвэртэн гэдэг байжээ. (А.Ц)

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ХАМГААЛАЛ *(Environmental protection)*

Байгаль орчныг бүх төрлийн бохирдлоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, байгалийн нөөцийг илүү үр ашигтай ашиглах, эрчим хүч хэмнэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах, тэдгээрт хяналт тавих үйл ажиллагааг хүрээлэн буй орчны хамгаалал гэнэ. Байгаль орчны хамгааллын асуудалд экосистем ба тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хүний үйл ажиллагаатай холбоотой өөрчлөлтөөс хамгаалах болон байгалийн хүсээгүй өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа багтана.

Байгаль орчныг хамгаалах систем нь дараах арга хэмжээ, нөхцөл, хэрэгслийг агуулсан байна³⁶.

- тогтвортой менежмент, байгалийн тэнцвэрт байдал, бүрэн бүтэн байдал, олон талт байдал, байгалийн үнэт зүйлсийн чанар, бүх амьд амьтдын оршин тогтнох нөхцөлийг хадгалах;
- байгаль орчны бүх төрлийн бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах, бууруулах, нөхөн сэргээх; (З.А)

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДЛУУД *(Economic facet of the environment)*

Үйлдвэрлэлийн явцад ашиглаж буй хүрээлэн буй орчны нөөцийн (environmental goods) эдийн засгийн үнэ цэнэ, өртгийг тооцох,

³⁶ Hamilton, C., & et al. (2008). Environmental Protection and Ecology. In G. Zurliini, & F. Muller, Environmental Security (pp. 1342-1350). Lecce, Italy: Elsevier B.V

үнэлэхтэй холбоотой асуудлуудыг хэлнэ. Хүн төрөлхтөн байгалийн нөөцийг үйлдвэрлэлийн хүчин зүйл болгон өөрийн хэрэгцээг хангаж, үйлдвэрлэлийн явцад гарсан хаягдлыг эргээд байгальд шингээдэг. Энэхүү үйл явц нь урт хугацаанд тогтвортой байхын тулд нөөцийн ашиглалт болон хаягдал нь байгалийн өөрийгөө нөхөх хүчин чадлаас хэтрэхгүй байх ёстой. Эдийн засгийн үйл ажиллагаа нь байгаль орчинд нөлөөлдөг. Зарим нэг салбар, тухайлбал газар тариалан, мал аж ахуй, уул уурхай зэрэг нь байгалийн нөөцөөс шууд хамааралтай байдаг учир байгаль орчинд илүү их нөлөөтэй. Энэ нь агаар, ус, хөрсний болон бэлчээрийн доройтол, усны хомстол, ой мод, ан амьтан, ургамал зэрэг зарим нөөц устгах аюул, экологийн тэнцвэрийн алдагдалд хүргэдэг. Хүрээлэн буй орчинд гарч буй эдгээр өөрчлөлтийг үнэлэх, байгаль орчин болон нөөцийн доройтлыг хэмжих, байгалийн нөөц болон орчныг хамгаалах, нөхөн сэргээх зэрэгт гарах зардлыг тооцох, эдгээрийг бүтээгдэхүүн болон үйлчилгээний өртөгт шингээх зэрэг асуудал нь хүрээлэн буй орчны эдийн засгийн чухал асуудал болдог. Эдгээр асуудлыг улс орнууд, дэлхий нийтийн хэмжээнд байгаль орчныг хамгаалах бодлогын хүрээнд авч үздэг. Бодлого нь татвар, татаас, квот, хориг хязгаарлалт зэрэг төрийн зохицуулалтаар дамжин хэрэгждэг бөгөөд эдийн засгийн үр дагавартай байдаг. (Ч.Н)

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТАН *(Press officer)*

Олон нийтэд мэдээлэл түгээх, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай энэ талаар хамтран ажиллах чиг үүрэг бүхий орон тооны албан хаагч. Төрийн болон төрийн өмчит байгууллагууд бодлого, шийдвэр, үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй байлгахын тулд

тэдгээрийн талаар байнгын мэдээлэл түгээж байх үүрэг хүлээдэг бөгөөд энэ чиг үүргийг хэвлэл мэдээллийн ажилтнаар дагнан хариуцуулж гүйцэтгүүлэх нь элбэг байдаг. (Д.З; Ч.Л нар)

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

(Media) Хэвлэл мэдээлэл нь нийгмийн харилцааны нэг чухал хэрэгсэл юм. Хэвлэл мэдээллийг уламжлалт болон орчин үеийн гэж ангилж болно. Уламжлалт хэвлэл мэдээлэлд сонин, сэтгүүл, радио, телевиз зэрэг орно. Орчин үеийн хэвлэл мэдээлэлд интернетэд суурилсан радио болон телевизийн нэвтрүүлэг, цахим сэтгүүл, нийгмийн сүлжээ болох Facebook, Twitter, LinkedIn зэрэг орно. Хэвлэл мэдээлэл нь төрийн бодлого болон засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, төрийн бодлого, түүний хэрэгжилтэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй.³⁷ (Д.Ч)

ХЭЛЦЛИЙН ЗАРДАЛ (Transaction cost)

Эдийн засгийн харилцаанд оролцогчдын харилцаа, хамтын ажиллагаанаас үүсдэг зардлыг хэлцлийн зардал гэдэг. Хэлцлийн зардал нь үйлдвэрлэлийн зардлын адил байгууллагын болон зах зээлийн үр ашигт чухал нөлөөтэй. Төрийн үйлчилгээний шаг дамжлага, зохицуулалтын оновчгүй байдал зэрэг нь бизнес эрхлэгчдийн хувьд хэлцлийн зардлыг нэмэгдүүлнэ. Бизнесийг бүртгүүлэх, тусгай зөвшөөрөл авах, тайлагнах, татвар төлөх зэрэг төрийн үйлчилгээ шаг дамжлага ихтэй, дүрэм журам, зохицуулалт нүсэр, ойлгомжгүй байвал шууд зардлаас гадна цаг хугацааны зарцуулалт нэмэгдэх, орлогын боломжоо алдах зэргээр хэлцлийн зардлыг өсгөдөг. Ийнхүү

хэлцлийн зардал өндөр байх нь далд эдийн засгийг өсгөх, эдийн засгийн өсөлтийг хязгаарлах нөхцөл болно. Хэлцлийн зардлыг мэдээлэл хайх, олж авахтай холбоотой, хэлэлцээ хийж гэрээ, хамтын ажиллагааны нөхцөлөө тохирохтой холбоотой, эрх зүйн орчны шаардлагуудыг дагаж мөрдөхтэй холбоотой зардал гэж ангилдаг. (Б.Б)

ХЭЛЦЭЛ (Transaction) Хоёр ба түүнээс дээш тооны талууд бараа, ажил, үйлчилгээ солилцох нөхцөлөө тохирч солилцох, холбогдох саналаа нэгтгэх, зөвшилцөх үйл ажиллагааг хэлцэл гэдэг. Монгол Улсын Иргэний хуульд зааснаар иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл / эс үйлдэхүй/-г хэлцэл гэнэ. Хэлцэл нь хууль зүйн нэр томьёонд хамаарах бөгөөд оролцогч талуудын тоогоор, төлбөрийн шинжээр, хэлцэл хэрэгжих онцлогоор, биелэгдэх хугацаагаар нь зааглан ангилдаг. Хэлцлийг хуульд заасан хэлбэрээр, хуульд заагаагүй бол талууд хэлэлцэн тохиролцож амаар буюу бичгээр хийнэ. Технологийн орчны өөрчлөлттэй холбоотойгоор цахим хэлбэрээр хэлцэл хийхийг мөн хуульчилсан бөгөөд цахим хэлбэрээр хийх хэлцэл нь талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж, цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар, эсхүл бусад байдлаар техникийн хэрэгсэл, программ хангамжийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлж, харилцан хүлээн зөвшөөрч, цахим гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. (Б.Б)

ХЭМ ЗОХИЦОЛГҮЙ МЭДЭЭЛЭЛ

(Asymmetric information) Эдийн засгийн харилцаанд оролцогчид тухайн арилжааны нөхцөлийн талаар харилцан адилгүй мэдээлэлтэй байдаг.

37 S.Schiavo And P.Sundaram, To Serve And To Preserve: Improving Public Administration In A Competitive World, 2000, x. 579, 590.

Өөрөөр хэлбэл, эдийн засагт хийгдэж байгаа ихэнх арилжаа нь тэгш бус, хэмжээ зохицолгүй мэдээллийн нөхцөлд хийгддэг. 2001 оны Нобелийн шагналыг Жорж Акерлоф (Goerge A. Akerlof), А.Майкл Спенс (A. Michael Spence), Жозеф Э.Стиглиц (Joseph E. Stiglitz) нар зах зээл дээрх мэдээллийн тэгш бус байдлыг судалсныхаа төлөө хүртсэн бөгөөд мэдээллийн тэгш бус байдлын талаарх тэдний судалгаа нь зах зээл хэрхэн ажиллах зарчмыг илүү нарийн тайлбарлаж компаниудын мэдээлэл ил тод байх нь чухал болохыг тодорхойлсон. Тэгш бус мэдээлэл нь хэрэглэгч-иргэдийг буруу сонголт хийж эрсдэлд орох нөхцөл болдог. Иймд эдийн засгийн харилцааг зохицуулах үүргийнхээ хүрээнд төр иргэдэд мэдээллийг нээлттэй, тэгш хүргэх нөхцөлийг бүрдүүлж шаардлага тавьж байдаг. Тухайлбал, арилжааны банкны эдийн засгийн чадавх, дампуурч болзошгүй эрсдэлийн талаар иргэдийн мэдээлэл дутмаг байлсаас хадгаламж эзэмшигчид эрсдэлд орох нөхцөл үүсэх тул санхүүгийн зах зээлийн зохицуулагч байгууллагаас банкны тайлангийн ил тод байдал, тогтвортой байдлын шалгуурыг хангаж байгаа эсэхэд хяналт тавина. (Б.Б)

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ (*Executive agencies*) Хэрэгжүүлэгч агентлагууд нь төрийн үйл ажиллагааны залгамж чанарыг таслахгүй хангаж ажилладаг. Хэрэгжүүлэгч агентлагийг сонгуулиар гарч ирсэн улс төрийн албан тушаалтан, аль эсвэл тухайн салбарын өндөр мэдлэг, чадвартай мэргэжилтэн, экспертүүд удирддаг. Уг байгууллагууд улсын нийслэлд төвлөрөн байрлах боловч зарим байгууллагууд нь улс орон даяар нэгж, салбартай, мөн орон нутгийн захиргааны нэг хэсэг болж үйл ажиллагаа явуулдаг. Хэрэгжүүлэгч агентлаг нь сонгуулийн үр дүнгээс үл

хамааран үйл ажиллагаа нь тасралтгүй явагдах бөгөөд бүтцийн томоохон өөрчлөлтүүд байнга хийгддэггүй. Улс орны хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын уялдаа холбоог хангаж түүнийг зохицуулахад гол үүрэг гүйцэтгэж ажилладаг. Хэрэгжүүлэгч агентлагууд нь босоо болон хэвтээ түвшинд ажилладаг бөгөөд босоо түвшинд шийдвэр нь төвлөрсөн, түвшин бүрд хяналттай байдаг бол хэвтээ түвшний байгууллагын шийдвэр төвлөрсөн бус, хамтын хяналттай байдаг онцлогтой. Босоо түвшинд пирамидын оройд улс төрийн албан тушаалтнууд байрлах бөгөөд тэд юу хийх ёстойг шийдвэрлэнэ. Шийдвэр шат шатанд доошоо явж хэрэгжсээр иргэнд төрийн бодлогын үр дүн болж хүрнэ. Судлаачид газар зүйн загварыг ашиглаж гүйцэтгэх засаглалыг өөрөөр тайлбарладаг. Өндөр, нам уул толгод, тэдгээрийн хөндийд иргэд амьдрах бөгөөд уул толгодын оройд гүйцэтгэх засаглалын байгууллагууд байрлана гэдэг байна. Монгол Улсын хувьд төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийн давхардал, хүнд суртлыг багасгах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг шуурхай, чанартай болгох зорилготой Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Цаг уур, орчны шинжилгээний газар, Гааль болон татварын ерөнхий газар, Архивын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар зэрэг нийт 25 хэрэгжүүлэгч агентлагтай³⁸. (Ж.Ж)

ХЭРЭГЛЭГЧИЙН ЗАН ҮЙЛ (*Customer behavior*) Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний сонголт хийх, хэрэглэх, зарцуулах талаарх хэрэглэгчийн шийдвэр гаргах үйл явц. Хэрэглэгчийн сэтгэл хөдлөл, хандлага, сонирхол

38 Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт. Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн жагсаалт.

нь хэрэглэгчийн зан үйлийг тодорхойлдог. Хэрэглэгчийн зан үйлийг маркетингийн асуудал гэж үздэг байсан бол 1990-ээд оноос хэрэглэгчийн зан үйл нь нийгмийн салбарын олон шинжлэх ухааны, тухайлбал, сэтгэл зүй, философи, эдийн засгийн ухааны уулзварт судлагдах болсон. Хэрэглэгчийн бие даасан байдал нь орчин үеийн эдийн засгийн харилцааны гол хөдөлгөх хүч болсон бөгөөд үйлчилгээ хэрэглэгчдэд ойр байх, хувь хүнд чиглэсэн маркетингийг хөгжүүлэх зэрэг нь хэрэглэгчийн зан үйлийн судалгаанд харгалзах гол асуудал болсон. (Б.Б)

ХЭРЭГЛЭГЧИЙН СОНГОЛТ (*Customer's choice*) Хэрэглэгч бараа, ажил, үйлчилгээнд зарцуулах төсөвтөө багтаан хэрэгцээгээ хангах, сэтгэл ханамжаа хамгийн өндөр түвшинд хүргэхүйц сайн сонголт хийхийг эрмэлзэж байдаг. Хэрэглэгчийн сонголт нь түүний бараа, ажил, үйлчилгээг худалдан авах шийдвэрээр илэрдэг. Худалдан авах шийдвэрт бараа, ажил үйлчилгээний үнийн өөрчлөлт, хэрэглэгчийн орлогын өөрчлөлт, хэрэглээний онцлог, орлуулах болон хавсрах бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн байдал зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг. Хэрэглэгчийн сонголтын өөрчлөлтийг нийлүүлэлт буюу үйлдвэр аж, ахуйн газрын шийдвэрт харгалзахаас гадна тухайн зах зээлд төрөөс хэрэгжүүлэх бодлогын сонголтод мөн харгалзах шаардлагатай. (Б.Б)

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (*Customer service*) Хэрэглэгч болон боломжит хэрэглэгчдийг тусламж үйлчилгээгээр хангах үйл явц. Энэ нь хэрэглэгч үйлчилгээ авах эсвэл худалдан авалт хийхээс өмнө, явцад, болон дараа нь үзүүлэх үйлчилгээ юм.

Хэрэглэгчийн үйлчилгээ нь бүтээгдэхүүнийг хэмнэлттэй, зөв ашиглахад туслах зорилготой олон төрөл байна. Үүнд, бүтээгдэхүүнийг төлөвлөх, суурилуулах, сургах, засварлах, шинэчлэх, устгалд оруулах үйлчилгээнүүд орно. Эдгээр үйлчилгээг хэрэглэгчийн байршилд үзүүлж буй тохиолдолд гэрээр хүргэх үйлчилгээ гэнэ. Хэрэглэгчийн үйлчилгээ амжилтад хүрэх нь "хэрэглэгчийн хувийн онцлогт тохируулж чаддаг" ажилтнуудаас хамаарна. Үйлчилгээ үзүүлж буй хүмүүс хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэх талаар сайн бэлтгэгдсэн байх ёстой. Байгууллага хэрэглэгчийн үнэнч байдал, итгэлийг бий болгохын тулд сайн дэмжлэг тусалцаагаар хангах нь чухал. Орчин цагт мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашиглан хэрэглэгчийг дэмжсэн үйлчилгээнүүд хөгжиж байна. Жишээ нь, веб сайтаар дамжуулан үйлчилгээ үзүүлэх ажилтантай шууд ярилцах (чатлах), хэрэглэгчийн дэлгэцийг нэг зэрэг ажилтны дэлгэцэд гаргаснаар сайтаар дамжуулан хэрэглэгчийг удирдан чиглүүлэх болсон. (Д.Ч)

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ (*Customer rights*)

Хэрэглэгч нь тухайн бараа, ажил, үйлчилгээний талаар мэдээлэл авах, сонгох, сонгосон бараа, ажил, үйлчилгээний чанар, аюулгүй байдал нь хангагдсан байх, үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн буруугаас хохирсон хохирлоо барагдуулж авах, бараа, ажил, үйлчилгээний гэмтэл, согогийг засварлуулах, хэрэглээний соёлд суралцах, хэрэглэгчийн эрхээ хамгаалуулах үндсэн эрхтэй. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн актуудыг төрөөс баталж хэрэгжүүлдэг ба эрхийг хамгаалах чиг үүргийг төрийн байгууллага, зарим

тохиолдолд төрийн чиг үүргийг хувийн хэвшил, олон нийтийн байгууллага гэрээгээр хэрэгжүүлдэг. (Б.Б)

ХЭРЭГЦЭЭ (Need) Хүн амьдрахын тулд хоол идэх, хувцас өмсөх, орон сууцанд амьдрах зэрэг өдөр тутам зайлшгүй шаардагдах зүйлийн хэрэгцээг хангах хэрэгтэй юм. Хүний амьдрал хөгжилд зайлшгүй шаардагдах зүйлийг хэрэгцээ гэнэ. Ийм учраас хэрэгцээ нь амьд бие махбодын дотоод орчны буюу түүний амьдралын гадаад нөхцөлийн тогтвортой шаардлага юм. Хэрэгцээ нь хүний сэтгэхүйн үйлийн үндсэн түлхэгч хүч нь болдог. Хүн өөрийн хэрэгцээг хангахын тулд түүнийг бүтээх ямар нэгэн арга хэрэгслийг эрж хайн олсны үндсэн дээр онол, парктикийн ямар нэгэн асуудлыг шийдвэрлэнэ. Ийнхүү хүн амьдрахын тулд хамтран нэгдэж, нийгмийн үйлдвэрлэлд татагдан орж, өөрийн амьдралын хэрэгцээт зүйлийг үйлдвэрлэн бүтээхийн зэрэгцээ өөрөө өсөж хөгжиж байдаг. (Ц.Д)

ХЭРЭГЦЭЭНИЙ ШАТЛАЛЫН ОНОЛ (Maslow's hierarchy need theory)

Энэ нь Маслоу (А.Н. Maslow)³⁹-гийн боловсруулсан сэдэлжүүлэлтийн Агуулгын онол (Content theory) юм. Хүний сэдэл нь таван түвшний хэрэгцээний дагуу дараалан үүсэж, эдгээр хэрэгцээг хангаж ажилласнаар ажиллах хүсэл эрмэлзэл буюу сэдэл үүсдэг болохыг тайлбарласан “Сэдлийн тухай онол” юм. Америкийн сэтгэл судлаач Маслоугийн хэлснээр хүний зан үйл нь хэрэгцээнээс үүдэлтэй бөгөөд эдгээр хүний хэрэгцээ нь уялдаа холбоо бүхий хэд хэдэн үе шатаас бүрддэг байна. Өөрөөр хэлбэл, хүний хэрэгцээ нь хамгийн доод түвшин болох физиологийн хэрэгцээнээс эхлээд аюулгүй байдлын

хэрэгцээ, нийгмийн хэрэгцээ, өөрийгөө хүндэтгэх, өөрийгөө бодитой ашиглах хэрэгцээ гэсэн таван үе шатаас бүрдэнэ. Нэмж дурдахад доод түвшний хэрэгцээ тодорхой хэмжээгээр хангагдсан тохиолдолд хүн дараагийн түвшний хэрэгцээг дагаж мөрддөг бөгөөд аль хэдийн хангагдсан хэрэгцээ нь хүний зан үйлийг өдөөх үүрэг гүйцэтгэдэггүй. Физиологийн хэрэгцээ (physiological needs) гэдэг нь идэх, өмсөх, суух гэсэн хүний амьдралыг хангахтай шууд холбоотой хэрэгцээ байдаг бол аюулгүй байдлын хэрэгцээ (safety needs) нь бие бялдрын болон эдийн засгийн хувьд аюулгүй байдлыг хангах хэрэгцээг хэлдэг бөгөөд нийгмийн хэрэгцээ (social needs) гэдэг нь нийгмийн аливаа нэг бүлэгт хамаарагдах эсвэл хүмүүсээс хөндийрөхөөс зайлсхийж, тэдэнтэй нөхөрлөхийг хүсдэг хэрэгцээ юм. Харин өөрийгөө хүндлүүлэх хэрэгцээ (self-esteem needs) нь бусдаас сайн үнэлгээ, хүндэтгэлийг авах хүсэл эрмэлзэл бүхий хэрэгцээ байдаг бол, өөрийгөө танин мэдэх (self-actualizing needs) гэх хамгийн сүүлийн хэрэгцээ бол боломжит чадвараа дээд зэргээр ашиглан, бүтээлч хүн болох, бусдад өөрийгөө илэрхийлэх гэсэн дээд түвшний хэрэгцээ юм. Маслоугийн хэрэгцээний үе шатны онол нь Херцберг (F. Herzberg), МакГрегор (D. McGregor), Лайкерг (Likert), Азирис (C. Argyris) нарын дэвшүүлсэн Өсөлтийн онол (Growth model)-ын үндэс суурь болсон юм. (Ц.Д)

39 Maslow, Abraham H., A Theory of Human Motivation. Cincinnati: South-Western Publishing Co., 1960.

Зураг 4. А.Маслоугийн “Хэрэгцээний шатлал”



Эх сурвалж: Байгууллагын менежмент, х. 431

ХЯМРАЛЫН УДИРДЛАГА (Crisis management) Хямрал нь олон нийтийн аюулгүй байдал, эрүүл мэнд, сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлж буй газар хөдлөлт, үер, галт тэрэг замаасаа гарах, хортой хий ялгарах зэрэг аюул занал байна. Байгууллагын нэр хүнд буурах зэрэг аливаа байгууллагын зорилго, үнэ цэнд сөргөөр нөлөөлөх аюул занал нь хямрал мөн. Хямралын үед ямар нэгэн хариу арга хэмжээ авахгүй байхад үүсэх зардлын хэмжээ болон цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан маш богино хугацаанд шийдвэр гаргана. Түүнчлэн хямрал нь тухайн нөхцөл байдалтай холбоотой олон таамаглашгүй үйл явдал, тодорхой бус байдалд бий болно. Өөрчлөгдөж буй нөхцөл байдлаас хамааран гаргаж буй шийдвэрийн үр дүнг нарийн тодорхойлон харах боломжгүй. Хямралын удирдлага үндсэн зургаан үе шаттай: (1) Эрсдэлийн үнэлгээ хийх, (2) урьдчилан сэргийлэх, (3) бэлэн байдлыг хангах, (4) хариу үйлдэл хийх, (5) нөхөн сэргээх, (6) суралцах үе шатуудтай⁴⁰. (Г.Б)

40 Tokakis, Polychroniou, Boustras: "Crisis management in public administration: The three phases model for safety incidents", Satefy Science (2019), pp. 37-43.

ХЯНАЛТ (Control) Хяналт нь нэг талаас захиргааны ажлын чанарын баталгааг хангах (объектив тал), нөгөө талаас албан хаагчдын үйлдэл, харилцаа нь хууль, дүрэм, журмын дагуу зохих ёсоор хийгдэж байгаа эсэх (субъектив тал)-ийг магадлан тодорхойлоход чиглэгдэнэ⁴¹. Хяналт гэдгийг “байвал зохих” болон “одоо байгаа” нөхцөл байдлын хоорондын харьцуулалт хэмээн тодорхойлно. Өөрөөр хэлбэл хууль, дүрэм, журамд заагдсаны дагуу үйл ажиллагаа явагдаж байна уу, эсвэл төлөвлөсөн үр дүндээ хүрч чадаж байна уу, эсвэл стандартын дагуу үйл ажиллагаа явагдаж байна уу гэх мэтээр “байвал зохих” болон “одоо байгаа” нөхцөл байдлын хооронд харьцуулалт хийгдэх бөгөөд хэрэв зөрүүтэй нөхцөл байдал үүсвэл залруулга, сайжруулалт хийхэд хяналт чиглэгдэнэ. Хяналт нь байгууллагын зорилгын хэрэгжилтийг хангах үйл явц. Хяналтыг тохирсон арга зүйгээр, тогтмол тодорхой хугацаанд хийж үр дүнг нь шийдвэртээ ашиглах нь төлөвлөсөн хугацаанд зорьсон зорилгодоо хүрэх боломжийг хангана. Захиргааны практикт олон төрлийн хяналт хэрэгжинэ. (М.А)

ХЯНАЛТ БА ТЭНЦВЭР (Checks and balances) Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглал нь харилцан бие биендээ хяналт тавьж, эрх мэдлийн харилцааг тэнцвэржүүлдэг. Хяналт, тэнцвэрийн энэхүү харилцааны нэгэн сонгодог загвар нь АНУ-д хэрэгждэг бөгөөд эрх мэдэл засаглалын гурван салаа бүрд хуваарилагдсан байдаг. Эртний Грекийн түүхч Полибиус эртний Ромын засаглалын эрх мэдлийг эзэн хаан, язгууртнууд, ард түмэн гэсэн гурван хэсэгт хуваан дүн шинжилгээ хийсэн байдаг. Түүний санаа хожим засаглал хуваах үзэл, онолд нөлөөлсөн юм. Францын философич Монтескье

41 Klaus Koenig, Heinrich Siedentopf, "Oeffentliche Verwaltung in Deutschland", 1997, s. 664.

дарангуйлал нь аль ч төрийн хамгийн гол аюул заналхийлэл гэж бичсэн байдаг. Тэрээр “Хуулийн амин сүнс” гэсэн алдарт бүтээлдээ дарангуйллаас сэргийлэх хамгийн сайн арга зам бол эрх мэдлийг хуваах явдал гэжээ. Полибиус, Монтескье, Блекстоун, Локк нараас үндэстэй энэхүү үзэл санаа нь АНУ-ын Үндсэн хуульд тусгалаа олж төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван салаанд хуваасан байна. Өнөөдөр дэлхийн олон улс Үндсэн хуульдаа төрийн эрх мэдлийг гурван салаанд хуваах замаар хяналт, тэнцвэрийг зохистой түвшинд барьж байна. (Ж.Ж)

ХЯНАЛТ ШАЛГАЛТ (*Inspection*) Иргэн, хуулийн этгээдийн явуулж байгаа үйл ажиллагаа (үйлдэл, эс үйлдэхүй), түүнчлэн үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах арга хэмжээний цогцолборыг хэлнэ⁴². ЭЗХАХБ-ын тодорхойлсноор хяналт шалгалтыг 1) техникийн хяналт шалгалт, 2) татварын болон гаалийн хяналт шалгалт, 3) лиценз, зөвшөөрөл, татаасын хэрэглээтэй холбогдсон хяналт шалгалт, 4) шууд биш хяналт шалгалт гэж ангилна⁴³. (М.А)

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ (*Monitoring*)

Удирдлагыг системтэй цуглуулж, задлан шинжилсэн мэдээллээр тасралтгүй хангах үйл явц бөгөөд тогтоосон цаг хугацаа, төсвийн хүрээнд дэвшүүлсэн зорилгодоо (үр дүнд) хүрэхэд дэмжлэг үзүүлэх дотоод удирдлагын тасралтгүй хэрэгжих нэг чиг үүрэг. “Хяналт-шинжилгээ” нь төлөвлөсний дагуу ажил хэрэгжиж

эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд тасралтгүй хийгддэгээрээ онцлог юм. Хяналт-шинжилгээ нь суурь түвшингээс (анх ажил эхлэхэд байсан нөхцөл байдлаас) ахисан өөрчлөлт гарч байгаа эсэхэд төвлөрнө. Өөрөөр хэлбэл ахиц, дэвшил гарч байгаа эсэх болон түүний шалтгааныг илрүүлэхэд “хяналт-шинжилгээ”-ний ажил чиглэгдэх бөгөөд энд хяналт-шинжилгээний “шалгуур үзүүлэлт” чухал байр суурьтай. “Хяналт-шинжилгээ, үнэлгээ” гэдэг хоршоо үгийг практикт өргөн хэрэглэдэг ч үүний цаана “Хяналт-шинжилгээ” ба “Үнэлгээ” гэсэн хоёр ялгаатай хяналтын төрөл бий. (М.А)

42 Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хууль, 2003.

43 Florentin Blanc, “Inspection reforms: Why, How and with What Results”, OECD, p. 9.

Ц

ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ (*Salary scale*)

Эрх бүхий байгууллагаас тогтоосон төрийн албан тушаалын ангилал, зэрэглэлд хамаарах олговол зохих цалингийн хэмжээг хэлнэ. Төрийн албанд анхлан ажиллаж буй албан хаагч тухайн албан тушаалын цалингийн хамгийн доод шатлалаас эхлэн үндсэн цалинг тогтооно. Төрийн үйлчилгээг иргэдэд чанартай хүргэх үүднээс албан хаагчдад тэдний сонирхлыг өдөөх хангалттай хэмжээний урамшууллыг санал болгоно¹. Тухайн төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг харгалзан шатлал ахиулан цалинжуулна. (Г.Б)

ЦАХИМ-АРДЧИЛАЛ (*e-Democracy*)

Улс төрийн болон засаглалын үйл явцын зөвлөлдөх болон оролцооны хэлбэрт мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглах арга хэлбэр. Цахим ардчиллыг тоон ардчилал (digital democracy), интернет ардчилал (internet democracy) ч гэж бас нэрлэдэг. Засаглалын энэ хэлбэр нь хуулийг боловсруулах, хэлэлцэх явцад бүх насанд хүрсэн иргэдийн тэгш оролцоог хангах технологийн шийдэл болно. Цахим ардчилал нь улс төрийн чөлөөтэй, тэгш оролцоог хангах

нийгэм, эдийн засаг болон соёлын нөхцөлийг бүрдүүлдэг. Газар зүйн байршлын хувьд тархан суурьшсан иргэдтэй улсын хувьд цахим ардчиллын хэлбэрийг уламжлалт хэлбэртэй хослуулан хэрэглэх нь иргэдийн тэгш оролцоог хангах үндэс болно. (Д.З; Ч.Л нар)

ЦАХИМ АРИЛЖАА (*e-Commerce*)

Интернэтийн сүлжээ ашиглан бараа, үйлчилгээг худалдах, худалдан авах зэргээр цахимаар арилжих боломжийг хувь хүн болон аж ахуйн нэгжид олгодог бизнесийн загвар. Цахим арилжаа нь компьютер, гар утас зэрэг ухаалаг техник хэрэгслийг ашиглаж цаг хугацаа, зардал хэмнэн түргэн шуурхай явуулж болдгоороо энгийн арилжааны загвараас давуу талтай. Цахим арилжаа нь бизнес хоорондын, бизнес болон хэрэглэгч хоорондын, хэрэглэгч хоорондын, бизнес болон төр хоорондын гэсэн үндсэн хэлбэрүүдтэй байдаг.

Үйлдвэрлэгч болон бөөний худалдаа эрхлэгч, эсхүл жижиглэнгийн худалдаа эрхлэгч болон аж ахуйн нэгжүүд хоорондоо цахимаар шууд худалдах, худалдан авах үйл явцыг бизнес хоорондын (Business to Business-B2B) арилжаа гэнэ. Ийм загварын арилжааг цахим худалдааны порталыг ашиглан

¹ Shamsul Arefin, "Civil Service in Developed & Developing Countries - A Comparative Study", 2013, p. 17.

хийх бөгөөд зорилго нь тухайн талууд болох бизнесийн байгууллагуудын арилжааны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэгдэх ба худалдааны төлөөлөгчийн оролцоог хангах, ердийн хэлбэрээр захиалга өгөх авах гэх мэт илүүдэл хүн хүч, шаг дамжлага, тэдгээрт зарцуулагдах хугацаа, зардлыг дээд зэргээр хэмнэх боломж олгодог.

Эцсийн хүртэгч болох хэрэглэгчдээ бараа, үйлчилгээг зуучийн оролцоогүйгээр шууд худалдах үйл явцыг бизнес болон хэрэглэгч хоорондын арилжаа (Business to Consumer-B2C) гэх бөгөөд үйл ажиллагаагаа ийм зарчмаар явуулдаг бизнесийн байгууллагуудыг “бизнес болон хэрэглэгч хоорондын арилжаа эрхэлдэг” гэж тодотгон нэрлэж хэвшсэн байна. 1990-ээд онд дотком (dotcom - үндсэн үйл ажиллагаагаа веб сайтаараа зохион байгуулдаг компани) компанийн тэсрэлтийн үед интернэтийг ашиглан үйлчилгээгээ хүргэх, бараагаа борлуулах нь түгээмэл болжээ. Арилжааны энэхүү хэлбэр нь талуудад цаг зав, зардал, чирэгдлийг дээд зэргээр хэмнэж үр ашгаа өгдөг. (Д.З; Ч.Л нар)

ЦАХИМ БАРИМТ БИЧИГ (*e-Doc-ument*) Компьютер, компьютерын программ болон ижил төрлийн бусад хэрэгслийг ашиглан үүсгэх, илгээх, хүлээн авах, хадгалах боломжтой цахим өгөгдөл. Төрийн үйл ажиллагаа болон төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хялбаршуулахад цахим баримт бичгийг ашиглах шаардлага улам нэмэгдэж байна. Энэ чиглэлээр манай улсад цахим засаглалын бодлого, хөтөлбөр хэрэгжиж, цахим баримт бичгийг баталгааг эх сурвалж болгож бүх нийтээр хэрэглэдэг болох чиглэлээр арга хэмжээ авч байна. (Д.З; Ч.Л нар)

ЦАХИМ БОЛОВСРОЛ/ЦАХИМ СУРГАЛТ (*e-Education/ (e-Learning)*)

Мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан мэдлэг, ур чадвар, олгоход чиглэсэн бүх хэлбэрийн сургалтын үйл ажиллагаа. Сурах, суралцах үйл ажиллагаа зөвхөн танхимд явагддаг арга хэлбэр өөрчлөгдөн цахим боловсролын бие даасан болон холимог хэлбэр нийтлэг болж байна. Цахим сургалтад суралцагч орон зай, цаг хугацааны хязгаарт баригдахгүйгээр өрийн идэвх оролцоонд тулгуурлан хамрагдаж болдог давуу талтай нь ялангуяа насан туршийн боловсролын нэгэн чухал арга хэлбэр болж байна. Төрийн албан хаагчдыг албан үүргээс нь хөндийрүүлэхгүйгээр сургаж хөгжүүлэхэд цахим боловсролын арга хэлбэрийг ашигладаг. (Д.З; Ч.Л нар)

ЦАХИМ БҮРТГЭЛ (*Online registration*)

Хэрэглэгч аливаа зорилгоор бүртгүүлэх ажиллагааг зөвхөн интернетийн орчинд тодорхой өгөгдлийг ашиглаж бие даан гүйцэтгэх боломж. Төрийн үйлчилгээг олон нийтэд аль болох хүртээмжтэй, чирэгдэлгүй гүйцэтгэхэд цахим бүртгэл чухал ач холбогдолтой. Цахим бүртгэл нэвтэрснээр хэрэглэгч цаг хугацаа хэмнэн байгаа газраасаа, хэн нэг этгээдээс хамааралтай бус өөрөө чөлөөтэй бүртгэлд хамрагдах боломжтой байдгаараа давуу талтай. Цахим бүртгэл бол цахим засаглалыг хөгжүүлэх бодлогын бүрэлдэхүүн хэсэг юм. (Д.З; Ч.Л нар)

ЦАХИМ ДЭЛГҮҮР (*e-Store*)

Цахим хэлбэрээр буюу цахим хуудас, программ ашиглан бараа бүтээгдэхүүнийг танилцуулах, төлбөр хүлээн авах боломжийг бий болгосон дэлгүүрийг хэлнэ. “Цахим дэлгүүр” гэж төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил

үйлчилгээ худалдан тухайн хуульд зааснаар ерөнхий гэрээний дагуу бараа, үйлчилгээг худалдан авахад зориулсан худалдан авах ажиллагааны цахим системийн бүрэлдэхүүн хэсгийг хэлдэг. “Ерөнхий гэрээ” гэж захиалагч нь байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээг нэг ба түүнээс дээш нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй 3 хүртэл жилийн хугацаанд үнэ болон бусад нөхцөлийг тохирч байгуулсан гэрээ юм. (Д.3; Ч.Л нар)

ЦАХИМ ЗАСАГЛАЛ (*e-Governance*)

“е” гэдэг нь “electronic” гэх үгний эхний үсэг юм. Энэ үг нь 1900 оноос “electron” буюу “цахилгаан цэнэгтэй бичил биет” гэсэн утгаар хэрэглээнд орж ирсэн. Үгийн ерөнхий утга нь цахилгаан эрчим хүчээр ажиллах тоног төхөөрөмж гэсэн санааг илтгэдэг. Улс орнууд 1990-ээд оны эхээр төрийн алба, засаглалыг өөрчилж шинэчлэхэд мэдээлэл, харилцааны технологийн хувь нэмрийг үнэлж сонирхож эхэлсэн. Тухайлбал, 1990 оны дундуур улс орны засгийн газрууд ард иргэдтэй мэдээлэл солилцоходоо электрон сувгуудыг ашиглаж эхэлсэн байдаг. Монгол хэлнээ “e-governance” гэдгийг цахим засаглал хэмээн орчуулдаг. Цахим засаглал (буюу Electronic governance) нь захиргааны үйл явцад шаардлагатай мэдээлэл нээлттэй, хүртээмжтэй болж үр дүнд нь төрийн үйлчилгээ түргэн шуурхай, зардал, чирэгдэл багатай болж, түүгээр зогсохгүй хүнд суртал, авлигаас сэргийлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ хүрээнд төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцааны технологийг ашиглах, нэвтрүүлэх үйл ажиллагааг цахим засаглал гэж ойлгож болно. Цахим засаглал нь төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, төрийн бодлого зохицуулалт, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, захиргааны үйл явцыг либералчлах, үр ашгийг

нэмэгдүүлэх арга хэрэгсэл, альтернатив хувилбар болж байна. Өөрөөр хэлбэл, энэ нь засгийн газрын үйл ажиллагаанд мэдээлэл технологийг нэвтрүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд таатай, өртөг зардал багатай, шинэлэг байдлаар хүргэх үйл явцтай холбоотой юм. Цахим засаглалын дараах хэлбэрүүд байна. Үүнд:

- G2C (Government to Citizens) - Төрөөс иргэдэд чиглэсэн
- C2G (Citizen to Government) - Иргэдээс төрд чиглэсэн
- G2G (Government to Government) - Төрийн байгууллагууд хоорондын
- G2E (Government to Employees) - Төр болон хөдөлмөр эрхлэгчид хоорондын
- G2B (Government to Business) - Төр болон бизнесийн байгууллага хоорондын

Беллами (Bellamy), Тэйлор (Taylor) нар төрийн салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийг дараах гурван үе шаттай байна гэж үзжээ (Owen E.Hughes Public Management & Administration: an introduction, 2018). Үүнд:

- Автоматжуулалт (automation) - Үйл ажиллагаа, үйлчилгээг цахимжуулах Мэдээлэлжүүлэлт (informatization) - Олон эх сурвалжийн өгөгдлийг нэгтгэх, мэдээллийг ашиглах, мэдлэг болгох чадварыг өргөжүүлэх, мэдээллийг нээх, мэдээллийн хоёр чиглэлтэй харилцан үйлчлэлд шилжих, мэдээллийн шинэ нөөцийг үүсгэх
- Шилжилт (transformation) - Бизнес процессын дахин инженерчлэлийг ашиглан хил хязгааруудыг давж бүрэн шинээр тодорхойлох, өгөгдлийг хуваалцах

Цахим төрөөс технологийн өөрчлөлтийн далайц менежментийн шинэ загвар болох дижитал засаглал руу шилжих асуудал яригддаг. Дижитал засаглалд цахим төр, цахим ардчилал аль аль багтана. Цахим төр нь байгаа бүтцийг өөрчлөхгүйгээр илүү сайн төрийн үйлчилгээг хүргэх боломжийг үүсгэдэг бол технологийн дэвшлийн хувьд дижитал засаг (засаглал) нь техникийн дэвшлээс гадна төрийн байгууллагуудын суурь шилжилтийг хэрхэн хийхийг авч үздэг (Owen E.Hughes Public Management & Administration: an introduction, 2018). (Д.З; Ч.Л; Т.Т нар)

ЦАХИМ МОНГОЛ ХӨТӨЛБӨР (*e-Mongolia program*) Төрөөс 2005-2012 оны хооронд хэрэгжүүлсэн мэдээлэл, харилцаа холбооны талаар баримтлах дунд хугацааны хөгжлийн бодлого, авч хэрэгжүүлэх ажлын хэмжээг тодорхойлсон хөгжлийн баримт бичиг. Цахим монгол үндэсний хөтөлбөрийн хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээг салгах, бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг үүсгэн байгуулах, цахилгаан холбооны салбарыг либералчлах, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлэх, мэдээлэл холбооны сүлжээг олон улсын интернетийн урсгалд холбох, бүх нийтийг компьютержуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. (Д.З; Ч.Л нар)

ЦАХИМ СУРГАЛТЫН ПЛАТФОРМ (*e-Learning platform*) Цахим боловсрол олгох үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх зориулалттай мэдээллийн систем юм. Цахим сургалтын платформ нь сургалтын удирдлагын систем (LMS), сургалтын агуулгын удирдлагын систем (LCMS), мөн виртуал танхимын хэрэгсэл, виртуал сургалтын орчин (VLE) зэргийг

бүгдийг болон хэсэгчлэн агуулдаг. Сургалтын удирдлагын систем (LMS) гэдэг нь цахим сургалтыг явуулахад ашигладаг туслах хэрэгсэл бөгөөд багш болон/эсвэл сурагчид материал хуваалцах, даалгавар өгөх/авах ба хураалгах, онлайнар харилцах боломж олгодог веб суурьтай систем юм (Lonn & Teasley, 2009). СУС-ийн гол шинж нь өгөгдлийн сантай, сургалтын үйл явцад туслах зорилго, үүрэг бүхий ялгаатай функц хэрэгжүүлдэг модуль бүтэцтэй байдаг. Цахим сургалтын платформ нь нээлттэй эх бүхий (Moodle, OpenedX г.м) болон төлбөртэй (Canvas, Blackboard г.м) хувилбарууд байдаг. Нээлттэй эх бүхий платформмыг өөрийн хэрэгцээнд тааруулан нэмж хөгжүүлж ашиглах нь хөгжүүлэлтийн зардал хэмнэж хэрэглээнд нэвтрүүлэх хугацааг багасгадаг давуу талтай. (Д.З; Ч.Л нар)

ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ (*e-Service*) Мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан аргыг ашиглан нийтэд цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээ. Үйлчилгээний энэ төрөл нь үйлчилгээг хүргэгч, хүлээн авагч, хүргэх технологи буюу сувгууд гэсэн гэсэн үндсэн гурван бүрдэлтэй байдаг. Цахим үйлчилгээний онцлог нь түүнийг хүргэх, хүлээн авахад хүний оролцоо хамгийн бага гүйцэтгэгддэг учраас цаг хэмнэх, тав тухыг хангах, хүртээмж болон нөлөөг нэмэгдүүлэх давуу тал, боломж олгодог давуу талтай. Төрийн үйлчилгээний хүртээмж, чанар, үр нөлөөг дээд зэргээр сайжруулах зорилгыг хангахад цахим үйлчилгээний нэр төрлийг аль болох олшруулах, түүнийг иргэдийн зүгээс хялбар бөгөөд өргөн ашиглах нөхцөл бололцоог бүрдүүлэх явдал хамгийн чухал юм. Үүний бас нэг давуу тал нь үйлчилгээг үзүүлэхэд хүнээс хамааралтай гарч болзошгүй хувийн

ашиг сонирхлын зөрчил, ялгаварлал болон бусад сөрөг хандлагаас зайлсхийх боломжийг бүрдүүлдэг. Монгол Улсын Засгийн газраас Иргэн, Аж ахуйн нэгж байгууллагад зориулж төрийн үйлчилгээг e-Mongolia платформыг ашиглаж цахим нэг цонхны үйлчилгээгээр үзүүлж байна. (Д.3; Ч.Л нар)

ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ (e-Service accessible) Цахим үйлчилгээг орон зай, цаг зав, хувийн боломжийн ялгаанаас үл хамааран, үйлчлүүлэхийг хүссэн хүн бүр авах тэгш боломж. Энэ төрлийн үйлчилгээний хүртээмжийг зохих түвшинд хүргэхийн тулд шийдлийг боловсруулах болон зохион байгуулах шатанд хүссэн хэрэглэгч түүнийг ашиглахад бэрхшээл учирч болзошгүй бүх талын эрсдэлийг урьдчилан нарийн тооцсоны үндсэн дээр тэдгээр нөхцөл байдал үүсэхгүй байхаар шийдвэрлэсэн байх ёстой. (Д.3; Ч.Л нар)

ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ (e-Service accessibility) Цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй болон энэ хэлбэрийн үйлчилгээнд хамрагдах боломж ямар нэгэн байдлаар хязгаарлагдмал хүмүүст жирийн хүмүүсийнхээс ялгаваргүйгээр хүртээх боломжийг бүрдүүлсэн технологийн болон зохион байгуулалтын цогц шийдэл. Цахим үйлчилгээний хүртээмжтэй байдал нь хүмүүс ямар байдлаар хязгаарлагдмал байгаагаасаа үл хамааран боловсрол, эрүүл мэнд, ажил хөдөлмөр, худалдаа арилжаа гэх мэт нийгмийн бүхий л харилцаанд цахимаар оролцох тэгш эрхтэй байх ардчилсан ёсны зарчимд үндэслэдэг. Цахим үйлчилгээнд энэ бүх шаардлагыг хангаагүй нь хүний эрхийг зөрчсөн, ялгаварласан явдал болохоос

гадна, нийгмийн зарим хэсэг бүлэг гишүүд нийгмийн оролцоо, халамж үйлчилгээнд өөрөөсөө үл хамаарх шалтгаанаар хамрагдахгүй хохирч үлдэх шалтгааныг бий болгодог. Үйлчилгээний хүртээмжтэй байдлыг дэмжсэн технологи (Accessibility-supported e-Service) нь хувийн онцлог ялгаатай байдлаас үл шалтгаалан шаардлагатай бүх мэдээллийг цахим хэлбэрээр олж авах боломжийг хэрэглэгчдэд олгох байдлаар зохион бүтээсэн технологийн шийдэл юм. Тухайлбал, төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчдэд цахим үйлчилгээг хүртээмжтэй байлгахын тулд зөвхөн тэдэнд хэрэглэх боломжийг дэмжсэн технологийн шийдлийг тусад нь боловсруулж хэрэгжүүлдэг. (Д.3; Ч.Л нар)

ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛЫГ ДЭМЖСЭН ТЕХНОЛОГИ (Accessibility-supported e-Service) Хувийн онцлог ялгаатай байдлаас үл шалтгаалан шаардлагатай бүх мэдээллийг цахим хэлбэрээр олж авах боломжийг хэрэглэгчид олгох байдлаар зохион бүтээсэн технологийн шийдэл. Тухайлбал, төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчдэд цахим үйлчилгээг хүртээмжтэй байлгахын тулд зөвхөн тэдэнд хэрэглэх боломжийг дэмжсэн технологийн шийдлийг тусад нь боловсруулж хэрэгжүүлдэг. (Д.3; Ч.Л нар)

ЦАХИМ ХАЛДЛАГА (Cyberattack) Компьютерын мэдээллийн систем, дэд бүтэц, компьютерын сүлжээний аюулгүй байдалд халдсан аливаа хэлбэрийн цахим довтолгоо. Цахим халдлагыг санаа зорилгоор нь улс төрийн, гэмт хэргийн, хувийн сэдэлтэй гэж ангилж үздэг. Энэ үйлдлээр ихэвчлэн компьютерын ажиллагааг тасалдуулах, доторх

мэдээллийг хулгайлах, будлиулах, эсхүл өөр довтолгоонд бэлэн болгох зэрэг хор аюул учруулна. Ийм хор аюул учирснаар тухайн байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагаа доголдож, урьдчилан тааварлаагүй төрөл бүрийн үр дагавар учрах бөгөөд үүнтэй холбоотой мөнгө санхүүгийн болон бусад байдлаар хохирол учрах эрсдэл үүснэ. Уг үйлдэл цахим сөргөлдөөн болон терроризмын шинжийг агуулж байгаа нөхцөлд хамгийн өндөр аюул заналхийлэл дагуулдаг. Энэхүү халдлагыг байгууллагын компьютерын сүлжээ, гар утас зэрэг цахим хэлбэрийн холбоо мэдээллийн бүхий л бүтцээр дамжуулан үйлддэг. Байгууллага цахим аюулгүй байдлын найдвартай системийн тусламжтайгаар, хамгийн үр нөлөөтэй технологийг ашиглан энэ төрлийн халдлагыг илрүүлэх, таслан зогсоох болон урьдчилан сэргийлэх боломжтой. Улс орондоо цахим аюулгүй байдлыг хангаж халдлагаас урьдчилан сэргийлэх явдал төрийн бодлогын чухал үүрэг юм. Энэ бодлогын хүрээнд халдлагаас сэргийлэх хүчирхэг чадамж бүхий технологийг ашиглаж, аюулгүй байдлын цогц бүтцийг бий болгох хэрэгтэй байдаг. (Д.3; Ч.Л нар)

ЦАХИМ ХУВААГДАЛ (*Digital divide*) Мэдээлэл харилцааны технологи ашиглан цахим ертөнцөд нэвтрэн орж, хэрэгцээг мэдээллээ олж ашиглаж чадаж буй эсэхээс шалтгаалсан ялгарал. Интернетэд холбогддог хүний тоо асар хурдтай өсөж байгаа боловч нийгэмд интернетэд холбогддоггүй, хэзээ ч холбогдож үзээгүй хүмүүс байсаар л байна. Мөн цахим төхөөрөмжтэй ажиллах мэдлэг, чадвар байхгүй эсвэл ийм мэдлэг чадвар шаардлагагүй гэж үзэх ч хүн байдаг. Хувийн хэвшлийн байгууллага цахим үйлчилгээг авах хүсэлгүй эсвэл

чадваргүй хэрэглэгчдийг орхигдуулж болдог бол төрийн байгууллага ингэх боломжгүй. Иргэдийн интернетэд орох боломж, цахим үйлчилгээг чадвараас үл хамааран иргэн бүрд ижил нөхцөлтэйгөөр төрийн үйлчилгээг хүргэх үүрэгтэй. Цахим хуваагдал нь эдийн засгийн тэгш бус байдлыг хөөрөгдөж, хүн амын тодорхой хэсгүүдэд нийгмийн хөгжлийн ялгааг өсгөх эрсдэл үүсгэдэг тул төрөөс энэхүү хүчин зүйлд онцгой анхаарч, энэ үзэгдлийг арилгахын төлөө тусгайлан бодлого боловсруулж ажиллах хэрэгтэй байдаг. Уг хуваагдлыг арилгах арга хэмжээ нь цахим шилжилтийн нөхцөлд нийгмийн үйлчилгээг хүн бүрд өгөөжтэй хүргэх, бизнесийн орлогыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өрсөлдөх чадварыг өсгөх, улмаар улс орны хөгжилд нөлөөлөх зорилгыг агуулна. (Д.3; Ч.Л нар)

ЦАХИМ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА (*e-Government Procurement (e-GP)*) Худалдан авалтын үйл ажиллагааг явуулахад төрийн байгууллагууд, тендерт оролцогч талууд, зохицуулагч, хяналтын байгууллагууд, бусад дэмжин үйлчилгээ үзүүлэгчид, иргэний нийгмийн байгууллагууд бүгдээрээ мэдээлэл, харилцаа холбооны цахим технологийг ашиглах зохион байгуулалтын арга хэлбэр. Төрийн худалдан авах ажиллагаанд энэхүү цахим арга хэлбэрийг нэвтрүүлэх нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, гэрээний менежментийг шуурхай явуулахаас гадна энэ харилцаанд ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх, улмаар авлигаас урьдчилан сэргийлэх нөхцөл боломжийг бүрдүүлдгээрээ давуу талтай. Цахим худалдан авах ажиллагаа нь сайн засаглалыг хөгжүүлэх бодлогын нэг чухал хэсэг юм. Төрийн болон орон нутгийн

өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар цахим худалдан авах ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулдаг. (Д.З; Ч.Л нар)

ЦАХИМ ХУРАЛ (*e-Conference*)

Хамтран хэлэлцэх арга хэмжээг өөр байршлуудаас интернет технологийг ашиглан зохион байгуулах арга хэлбэр. Цахим хурал нь Интернет технологи, ялангуяа TCP/IP холболтуудын ачаар боломжтой болсон. Цахим хурлыг газар зүйн байрлалаас үл хамаарч дуу, дүрсийг шууд дамжуулах хэлбэрээр хийх боломжтой. Цахим хурал нь цаг хугацаа хэмнэхээс гадна газар зүйн байршлаас хамааран оролцоог хангах боломжийг бүрдүүлдэг давуу талтай. (Д.З; Ч.Л нар)

ЦАХИМ ШИЛЖИЛТ (*Digital transformation*)

Цахим бус эсвэл гараар гүйцэтгэх үйл ажиллагааг цахим хэлбэрээр солих эсвэл хуучин цахим технологийг шинэ цахим технологиор шинэчлэх замаар үйлчилгээ эсвэл бизнесийг өөрчлөх, цахим технологийг нэвтрүүлэх явц юм. Цахим шийдлүүд нь уламжлалт аргуудыг сайжруулж, дэмжихээс илүүтэйгээр автоматжуулах замаар үр ашиг хүртэхээс гадна шинэ төрлийн инновац, бүтээлч чадварыг бий болгодог. Цахим шилжилт нь бизнес хийдэг арга ажиллагааг өөрчлөх, зарим тохиолдолд цоо шинэ төрлийн бизнесийг бий болгох нөхцөлийг бүрдүүлдэг. МХХТ-ийн хөгжлийг дагаад бизнесийн бүхий л салбарууд бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэж, эдийн засгийн цахим шилжилтийн шинэ нөхцөлд хэрхэн дасан зохицох талаарх өмнөх тогтсон ойлголтуудыг бүхэлд нь өөрчилж, хэлбэршүүлж байна. Улс орнууд цахим шилжилтийг хийх талаар төрийн бодлого боловсруулан хэрэгжүүлж

эхэлсэн бөгөөд Монгол Улсын хувьд урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүддээ энэ талаар тусган хэрэгжүүлж байна. (Д.З; Ч.Л нар)

ЦАХИМ ШУУДАН (*e-Mail*)

Цахим тоног төхөөрөмж ашиглан хүмүүс хоорондоо зурвас эсвэл захиа солилцох арга. Анх энэ нэр томьёо нь цахим баримт дамжуулах гэдэг утгаар хэрэглэгдэж байсан бол одоо интернэтийг ашиглан хувь хүний эсвэл албан байгууллагын цахим хаягаар дамжуулан захиа явуулах, хүлээн авах шуудангийн үйлчилгээний хэлбэр болжээ. Орчин үед цахим үйлчилгээний бүртгэлийг цахим шуудангийн хаягаар баталгаажуулах болсон. Өөрөөр хэлбэл хувийн болон албаны цахим шуудангийн хаяг нь хувь хүний нэгэн чухал мэдээлэл юм. Албан байгууллагын эсвэл баталгаажуулж олгодог цахим шуудангийн хаягаар гүйцэтгэх цахим харилцаа албан ёсны харилцаа гэж хүлээн зөвшөөрөгдөх болжээ. Албан цахим шуудангийн хаягаар илгээсэн захидлыг нотолгоонд тооцож, гэрээ хэлцлийг хүртэл цахим шуудангаар солилцон гүйцэтгэх болсон. Тийм ч учраас байгууллагын албан хаягийг ажилд ороход үүсгэж, ажлаас гарахад хүчингүй болгодог. (Д.З; Ч.Л нар)

ЦЭВЭР ӨРСӨЛДӨӨН (*Pure competition*)

Цэвэр өрсөлдөөн гэдэг нь ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулдаг өргөн хүрээний өрсөлдөгчидтэй зах зээлийг тодорхойлдог нэр томьёо юм. Үүнийг ихэвчлэн төгс өрсөлдөөн гэж нэрлэдэг. Төгс өрсөлдөөн нь өрсөлдөөнийг аль болох хамгийн дээд түвшинд байлгах зах зээлийн бүтцийг тодорхойлно. Төгс өрсөлдөөнт зах зээлд үйлдвэрлэгч, нийлүүлэгч бүр нийт зах зээлийн багахан хэсгийг бүрдүүлдэг тул зах

зээлийн үнэд шууд нөлөөлж чадахгүй.² Тухайн салбарт зах зээл дээр худалдан авагчдын тоо асар их, бүх худалдан авагчид худалдаалагчид үнийн талаар бүрэн мэдээлэлтэй тул худалдан авагч, үйлдвэрлэгчдийн аль нь ч зэх зээлийн үнэд нөлөөлөхүйц зах зээлийн хангалттай хувь эзэлдэггүй, аж ахуйн нэгжүүд зах зээлд чөлөөтэй нэвтрэх, гарах онцлогтой. Төгс өрсөлдөөний зах зээл нь “үл зэгдэх гар”-ын зохицуулалттай бөгөөд хамгийн үр ашигтай хуваарилалтыг бий болгодог гэж үздэг. Гэхдээ бодит амьдрал дээр цэвэр зах зээл гэж байдаггүй. Ихэнх тохиолдолд холимог шинжтэй зах зээл оршин байна³. (З.А)

ЦЭВЭЭН Ж. (Tseveen J.) XX зууны эхэн үеийн Монголын нийгэм, улс төр, шинжлэх ухааны зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч, эрдэмтэн судлаач. Хойт Агийн омгийн захиргааны зайсан Жамсрангийн гэр бүлд 1881 онд төржээ. Тэрбээр эхлээд Эрхүүгийн багшийн сургуульд сурч байгаад шилжин, 1907 онд Санкт Петербургийн их сургуулийг төгссөн байна. Ж.Цэвээн 1907, 1908 онд Санкт Петербургийн их сургуулийн дорно дахины хэлний салбарт, монгол хэлний багшаар ажиллажээ. Энэ үедээ Монголын олон угсаатнаас цуглуулан тэмдэглэж авсан зүйр цэцэн үг, оньсого, дуу, мэндчилгээ, ерөөл магтаалыг орос орчуулгатай монгол галигаар 1907 онд хэвлүүлжээ. Монголчууд тусгаар тогтнолоо сэргээсний дараа Богд Хаант Монгол Улсад ирж, Гадаад хэргийг эрхлэн шийтгэх яамны соёл эрхэлсэн түшмэл, мөн яамны дэргэдэх сургуульд багшаар ажилласан. 1913-1914 онд Ерөнхий сайд Сайн ноён

хан Намнансүрэнгийн Хаант Орос улс дахь айлчлал, 1912 оны Орос-Монголын гэрээ, 1915 оны Хиагтын гэрээг байгуулах зэрэгт орчуулагчаар ажилласан. Монголын анхны тогтмол хэвлэл “Шинэ толь” сэтгүүл, “Нийслэл хүрээний сонин бичиг” зэргийг эрхлэн гаргаж Монголын сэтгүүл зүйн салбарыг үндэслэжээ 1921 оны хувьсгалд оролцож, Ардын Засгийн газрын Дотоод яамны дэд сайдаар томилогдон төрийн зохион байгуулалт, засаглалын хэлбэр, гадаад бодлогыг томьёолох, улс орны эдийн засгийг сэргээхэд хүчин зүтгэсэн. 1921 онд Судар бичгийн хүрээлэнг үүсгэн байгуулалцаж, эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллаж байжээ. Судар бичгийн хүрээлэнгийн гадаад харилцааг өргөжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан хүн юм. 1932-1937 онд Оросын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнд ажиллаж, ЗХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүнээр сонгогджээ. 1937 оны 8 дугаар сарын 11-нд хилс хэргээр баригдан хоригдож байгаад 1942 он 5 дугаар сарын 4-нд нас барсан. Ж.Цэвээн Монгол Улсын түүх, соёл, угсаатны зүйн чиглэлээр “Монгол Улсын түүх”, “Орчлон ертөнцийн байдлыг товчлон үзүүлсэн нь” (гурван боть), “Монголын олон ястны гарал үүсэл, байдлын тухай”, “Монгол Улсын газар орны байдал” зэрэг үнэт чухал бүтээл туурвижээ. Сайн ноён хан Т. Намнансүрэнгийн захиалгаар тухайн үеийн үндсэн хуульт улсуудын төрийн байгууламжийн талаар өгүүлсэн “Улсын эрх” хэмээх бүтээлийг туурвисан байна. Түүнчлэн гарамгай орчуулагч байсан бөгөөд К. Маркс, В. И. Ленин, Марко Поло, ПIANO Карпини, Вильгельм Рубрук, Жек Лондон, Жюль Верн нарын болон дорно дахины их бичгийн хүмүүсийн нийт арван таван зохиолыг монгол хэлнээ орчуулсан байна. (А.Ц)

2 Varian, Hal R. 2014. *Intermediate Microeconomics, 9th edition*. New York: W. W. Norton & Company, pp. 414-423.

3 Даваадорж, Ц, and болон бусад. 2007. *Экономиксийн үндэс*. Улаанбаатар: Содпресс, х. 41.

ЦЭРЭНДОРЖ Б. /Хичээнгүй сайд/ (Tserendorj B.) XX зууны Монголын төр, нийгмийн зүтгэлтэн, дипломатч, Монгол Улсын ерөнхий сайд. 1868 онд Жэвзүндамба хутагтын Их шавийн Хэрлэн Барсдай отгийн харьяат ард Балингийн гэрт мэндэлжээ. Цэрэндорж төрөлхийн сэргэлэн, тэрбээр оюун билгээ дайчлан бие даан оролдсоор монгол, манж, хятад хэл бичигт нэлээн сайн сурч, бичгийн боловсролтой болжээ. Хүрэн дэх Манж сайдын яаманд ажиллах хугацаандаа Чин Улсын төр доройтож буйг ойлгож, Монгол улс тусгаар тогтнолоо сэргээн мандуулах үйлсэд зүтгэсэн. 1911 оноос Гадаад яамны [Гадаад хэргийг эрхлэн шийтгэх яам] дэс түшмэл, 1913 оноос Гадаад яамны дэд сайд, 1915 онд тэргүүн сайдын албанд дэвшин ажилласан. 1912-1913 онд Гадаад яамны сайд Чин ван Ханддорж, 1913-1914 онд Ерөнхий сайд Сайн ноён хан Намнансүрэн нар Хаант Орос Улсад айлчлахад хамт явсан. Хиагтын гурван улсын гэрээнд Монголын засгийн газрын төлөөлөгчөөр оролцсон. 1918 оны 5 дугаар сард Автономит Засгийн газрыг “самуун намын аюулаас хамгаалахын тулд хятад цэргийн нэг хороог Ар Монголд ирүүлэх” тухай Хятадын төлөөлөгч Чен И-д бичиг илгээж байсан. 1921 оны ардын хувьсгалын дараа Б.Цэрэндорж Гадаад яамны эрхэлсэн түшмэл, Ардын Засгийн газрын Ерөнхий сайдын жинхэнэ орлогч, Гадаад яамны тэргүүн сайдаар ажиллаж байгаад, 1923 онд Ерөнхий сайд жалханз хутагт С.Дамдинбазар нас барсны дараагаар Ардын Засгийн газрын Ерөнхий сайдаар томилогдон 1928 он хүртэл ажилласан. Цэрэндорж нь 1921 оны хувьсгалын дараа Монгол Улсад Бүгд найрамдах засаг тогтоох үйл явцад идэвхийлэн оролцож “Үндсэн хууль” зохиох комиссын даргаар ажилласнаас

гадна нийт 60 гаруй хууль, дүрэм боловсруулахад оролцжээ. Монгол төрийн гадаад бодлогыг дан ганц ЗХУ-тай харилцах бус, капиталист улс орнуудтай ч мөн харилцах, дотооддоо хуучин ноёд, язгууртнуудын эсрэг үйл ажиллагаа явуулах бус тэднийг улсын аж ахуйн ажилд татан оруулах, хувийн капиталыг дэмжин, иргэн бүр чинээлэг амьдрах нөхцөлийг бий болгох бодлого баримтлан ажилласан. Шинэ тулгар улс орноо төвхнүүлдэхийн тулд эдийн засгаа хөгжүүлэх, мөнгө санхүүг хэмнэх талаар өөрөө үлгэрлэн, бусдад зааж сургамжилдаг, төрийн ажилд нэгэн үзүүрт сэтгэлээр зүтгэдэг төрийн зүтгэлтэн байжээ. 1928 онд өвчнөөр нас баржээ. (А.Ц)

Ч

ЧАДАВХЫН МЕНЕЖМЕНТ (*Capability management*)

Байгууллага үүрэг амлалтаа хэрэгжүүлэх болон амжилтад хүрэхэд шаардлагатай хүмүүн капиталын менежментэд ашигладаг үйл явц¹. Чадавхын менежмент нь байгууллагын зорилго, зорилтдоо хүрэхэд нөөцийг үр дүнтэй удирдахад шаардлагатай механизмыг бүрдүүлэх зорилготой. Байгууллагын байгууллагын байршил, стратеги, хүний нөөцийн эрэлт хэрэгцээ, санхүүгийн нөхцөл байдал ба нийт ажиллах хүчин зэргийг хамруулна. Ингэснээр байгууллагын үйл ажиллагааны зардлыг бага байлгах гэсэн байгууллагын одоогийн болон ойрын ирээдүйн шаардлагад чадавхыг нийцүүлнэ. Чадавхыг тэргүүлэх, дасан зохицох, дагах стратегийн дагуу удирдана².

- **Тэргүүлэх (lead) стратеги:** Байгууллагад хэрэгцээтэй чадавхыг их хэмжээний хөрөнгө оруулалтаар бүрдүүлснээр гүйцэтгэл өндөртэй ажиллагсдын бүтээмжийн үр дүнд байгууллагын нийт гүйцэтгэл нэмэгдэнэ.
- **Дасан зохицох (match) стратеги:**

Хэрэгцээтэй чадавхыг бүрдүүлэхэд төвийг сахисан байр суурийг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн зах зээлийн дундаж цалингийн хэмжээг ажиллагсдад олгон тэднийг татах бусад (гэр бүлд ээлтэй орчин, нийгмийн хариуцлагатай байгууллага зэрэг) үзүүлэлтийг хослуулан хэрэглэнэ.

- **Дагах (lag) стратеги:** Байгууллагад шаардлагатай чадавхыг бүрдүүлэхэд төдийлөн анхаарал хандуулахгүй. Хөдөлмөрийн зах зээлийн дундаж цалингаас багаар ажиллагсдаа цалинжуулах нь ур чадвар муутай ажиллагсдыг татах ба шинээр ажилд орсон ажиллагсдыг сургах зардал өндөртэй. Энэ стратегийн дагуу бага цалинтай байх нь ажилгүй байснаас дээр гэсэн логик сэтгэлгээнд үндэслэсэн. (Г.Б)

ЧАДВАРЖУУЛАХ ЗАМААР ХҮЧИРХЭГ-ЖҮҮЛЭХ НЬ (*Empowerment*)

“Empowerment” гэдгийн үндэс нь “empower (+ment)” буюу “хэн нэгэнд эрх мэдэл, удирдлага, бүрэн эрхийг өгөх” гэсэн утгатай.³ Өөрөөр хэлбэл, энэ нь “хэн нэгэнд аливаа юмыг хийх чадвар суулгах боломж олгох, зөвшөөрөх” буюу тодорхой ажил үүргийг гүйцэтгэх эрхийг бусдад (ихэвчлэн доош нь)

1 Хүний нөөцийн менежментийн нэр томъёо MNS ISO 30400:2018.
2 Evan M.Berman, James S.Bowman, Jonathan P.West, Montgomery R.Van Wart “Human Resource Management in Public Service: Paradoxes, Processes, and Problems” 5th Edition, Sage 2016, p. 250.

3 Empower (v.). (n.d.). Retrieved November 08, 2020, from https://www.etymonline.com/word/empower?ref=etymonline_crossreference

шилжүүлэх утгыг илэрхийлдэг. Уг нэр томьёо нь анх төрийн засаглах үйл явцад иргэдийг оролцуулах үйл явцтай холбогдон гарч ирсэн. Чадваржуулах замаар эрх мэдлийг нэмэгдүүлэх гэдэг нь хүмүүсийн хооронд харилцаа, хамтын ажиллагааны орон зай бий болгосноор тэдэнд тулгарч буй бэрхшээлийг арилгах, нөхцөл байдлыг өөрчлөх чадвартай болгох, үүний тулд шинэ санаа бодол, ойлголт, мэдлэгтэй болгох гэсэн үг (НҮБХХ, 2007) юм.⁴ Засаглалын үзэл баримтлалын хүрээнд “empowerment” гэдэг нь иргэдийг чадавхжуулах замаар тэднийг хүчирхэг болгох, тэдэнд өөрсдийн эрх ашгийн төлөө нэгдсэн зохион байгуулалтад орж хамтран ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж өгдөг тухай ойлголт байдаг. (Т.Т)

ЧАНАРЫН ДУГУЙЛАН (Quality circle)

Байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, үр дүн, үйлчилгээ, үйл ажиллагааны чанарыг сайжруулах зорилго бүхий, ижил эсвэл ойролцоо чиг үүрэгтэй 10 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй ажилтан, албан хаагчдын сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бүлэг⁵. Чанарын дугуйлан нь тогтмол тодорхой хугацаанд (14 хоногт, сард, улиралд гэх мэт) цуглаж, байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагаанд тулгамдаж байгаа тодорхой асуудлыг шинжлэн, шийдэл боловсруулах зорилготойгоор ажиллах бөгөөд гаргасан шийдэл нь удирдлагын багийн дэмжлэгтэйгээр практикт хэрэгжих боломжтой болдог. Чанарын дугуйлангаас гарсан санал, шийдлийг нэвтрүүлснээр байгууллагад бий болсон эерэг өөрчлөлтөөс (хэмнэлт, сайжралт гэх мэт) хамааран тэднийг урамшуулах механизм нь дугуйлангийн

үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй байхад нөлөөлнө. Сүүлийн үед ИСО стандартыг төрийн байгууллагуудад нэвтрүүлэх хандлага нэмэгдэж байгаа бөгөөд энэ хүрээнд ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх, тасралтгүй сайжруулалт хийх боломжит нэг арга зам болгон чанарын дугуйланг ашиглах нь зохимжтой. (М.А)

ЧАНАРЫН НЭГДСЭН УДИРДЛАГА (Total quality management)

Тохирсон цагт нь зохистой үнээр хэрэглэгчийн сэтгэлд нийцсэн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах замаар байгууллага зорилгодоо үр дүнтэйгээр хүрэхийн тулд хэрэгжүүлж байгаа системтэй үйл ажиллагаа юм⁶. Чанарын нэгдсэн удирдлагыг хэрэглэгчийн сэтгэл ханамж, үнэнч байдлаар дамжуулан урт хугацаанд амжилттай ажиллах менежментийн арга, тасралтгүй сайжруулалт хийхэд бүх ажилтнууд нь оролцдог хэрэглэгчид чиглэсэн байгууллагын удирдлагын систем хэмээн үздэг. Чанарын нэгдсэн удирдлагын гол амжилт нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулахад байгууллагын бүх гишүүд оролцох явдал бөгөөд чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх, тасралтгүй сайжруулалт хийх явдал байгууллагын соёл болон төлөвшсөн байхад оршино. Чанарын удирдлага нь төлөвлөх (plan), хэрэгжүүлэх (do), шалгах (check), сайжруулах (act) гэсэн дөрвөн цикл үйл ажиллагаанаас бүрдэнэ. Энэ цикл үйл ажиллагааг товчоор PDCA цикл хэмээн нэрлэнэ. Чанарын нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлнэ гэдэг нь дараах найман зарчмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно гэсэн үг юм. Үүнд: 1) Үйл ажиллагаа нь хэрэглэгчид чиглэсэн байх, 2) Удирдлагын манлайлал

3) Ажилтан бүрийн оролцоог

4 Даваадулам (2010) Засаглал үзэл баримтлал, нэр томьёоны тайлбар толь бичиг. Улаанбаатар.

5 Цэнд Н., Батхүрэл Г., Шуурав Я., ... “Менежмент”, 2013, 299 дэх тал.

6 Демингийн шагналын хорооноос гаргасан тодорхойлолт.

хангах, 4) Үйл явцад төвлөрөх, 5) Байгууллага гэдэг нь нэг нэгдсэн систем гэдэг агуулгаар үйл ажиллагааг удирдах буюу системийн хандлага, 6) Тасралтгүй сайжруулалт хийх, 7) Ноголгоонд үндэслэсэн шийдвэр гаргах, 8) Байгууллагын бүх түвшинд үр дүнтэй харилцааг бий болгох зэрэг болно. (М.А)

ЧАНАРЫН УДИРДЛАГА (*Quality management*) Чанарын удирдлага нь хүссэн дээд түвшинд хүрэхийн тулд хийгдэх ёстой бүх ажил, үйл ажиллагааг хянах удирдлагын цогц үйл явц юм. Үүнд, чанарын бодлогыг тодорхойлох, чанарын төлөвлөлт болон чанарын баталгаа боловсруулах, хэрэгжүүлэх, чанарыг хянах, мөн чанарыг тасралтгүй сайжруулах зэрэг орно. Үүнийг чанарын нэгдсэн удирдлага (Total quality management - TQM) гэж нэрлэнэ⁷. Чанарын нэгдсэн удирдлага нь байгууллагын чанарыг тасралтгүй сайжруулахад чиглэсэн удирдлагын цогц систем юм. Судлаач Жозеф М.Журан (Joseph M. Juran) чанарын нэгдсэн удирдлагыг стратегийн төлөвлөлтийн нэг бүрэлдэхүүн хэмээн үзсэн. Тэрээр нийт чанарын удирдлагыг "Чанарын гурвал" гэж нэрлэх чанарын төлөвлөлт, чанарын хяналт, чанарыг сайжруулалт гэсэн удирдлагын гурван процессоос бүрдэнэ хэмээн анх тодорхойлсон байна⁸. Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001-ийг аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа, чанарын удирдлагадаа нэвтрүүлснээр үйлдвэрлэл, үйлчилгээнийхээ чанарыг тасралтгүй сайжруулах, байгууллагын соёлыг бий болгох, байгууллагын үр ашиг, үнэлэмжийг нэмэгдүүлэх боломжтой. (Д.Ч)

7 Retrieved from Investopedia: <https://www.investopedia.com/terms/q/quality-management.asp>

8 Juran, J.M., The quality trilogy: a universal approach to managing for quality, Quality Progress, 1986, x. 2, 3.

ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ХАНДЛАГА (*Quality management approach*)

Нийгмийн хөгжлийн явцад чанарын нэгдсэн байдлаар удирдах чанарын удирдлагын хандлагын үзэл баримтлал хөгжсөн. XVII зуун буюу аж үйлдвэржилтээс өмнөх үед гар урчууд бүтээгдэхүүнийхээ чанараа өөрсдөө хариуцдаг байв. Харин аж үйлдвэржилт нь чанарын үзлэг шалгалт (Quality control)-ыг мэргэжил, мэргэжлийн алба болон хөгжихөд нөлөөлсөн гэж үздэг. Чанарын үзлэг шалгалт нь үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүн шаардлага хангаж байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгдэж байв. Аж үйлдвэрлэлийн хувьсгал, масс үйлдвэрлэлийн эхлэлтэй холбоотойгоор АНУ, Европт бий болсон чанарын статистик хяналт үнэлгээ нь чанарын хяналт (Quality control)-ын үзэл баримтлалууд үүсэж хөгжихөд нөлөөлсөн. Чанарын удирдлагыг цөөн тооны улсын байгууллагуудад элементүүдээс хэрэгжүүлж эхэлсэн ба 1990-ээд оноос засгийн газраас хийх шинэчлэлийн үйл явцад идэвхэжсэн. Чанарын нэгдсэн удирдлага нь чанарын тасралтгүй сайжруулалт, чанарын баталгаажуулалтыг нэгтгэн зохион байгуулсан арга ба энэ нь өөрийн өвөрмөц зарчмуудтай, түүгээрээ удирдлагын уламжлалт захиргаадалтын аргаас давуу талтай. (Г.Б)

ЧАНАРЫН ХЯНАЛТ (*Quality control*)

Чанарын удирдлагын үйл ажиллагааг чанарын удирдлага, чанарын хяналт, чанарын баталгаажуулалт гэж ангилан үздэг. Чанарын хяналт нь чанарын шаардлагыг хангахад чиглэсэн чанарын менежментийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын шаардлага хангасан эсэхийг шалгах, турших, стандартад нийцүүлэхийн тулд

ашигладаг системчилсэн үйл явцыг хэлнэ. Чанарын хяналтын зорилго нь эцсийн үр дүнг хүлээгдэж буй үр дүнтэй нийцүүлэхийн тулд асуудлыг тодорхойлох, засаж сайжруулах, арилгах, урьдчилан сэргийлэх явдал юм.

Чанарын хяналт нь дараах үе шатуудаас бүрдэнэ⁹.

Бодит гүйцэтгэлийг үнэлэх,

- Бодит гүйцэтгэлийг гүйцэтгэлийн зорилготой харьцуулах,
- Төлөвлөсөн гүйцэтгэл ба бодит гүйцэтгэлийн хоорондох ялгааг арилгах яаралтай арга хэмжээ авах. (3.А)

ЧИГ ҮҮРГИЙН ТӨВЛӨРЛИЙГ СААР-УУЛАХ (*Function decentralization*)

Латин хэлний “function” буюу функц гэх үг нь “гүйцэтгэх, биелүүлэх (perform, execute)” гэсэн утгатай. Төрийн захиргааны шинжлэх ухаанд функц гэдэг нь байгууллагын дүрэм, хуулиар хүлээсэн үүрэг гэсэн утгаар хэрэглэгддэг. Монгол хэлнээ “function” ба “decentralization” гэдэг хоёр үгийн нийлэмжийг “чиг үүргийн төвлөрлийг сааруулах” хэмээн орчуулан хэрэглэдэг. Чиг үүргийн төвлөрлийг сааруулах гэдэг нь засгийн газрын салбар нэгжүүдийн хооронд эрх мэдэл, хариуцлагыг хуваарилах үйл явц юм. Үүнд засгийн газрын үйлчилгээний төрөл, тоо хэмжээ, үйлчилгээ хүргэх байгууллагуудыг тогтоох явдал багтана. Үүний үр дүнд орон нутгийн захиргаад нь төвийн яамдын орон нутаг дахь салбар, үйлчилгээний дүүрэг, бие даасан агентлаг, эсвэл засгийн газрын орон нутаг дахь нэгж хэлбэртэй байж болно. Практикт төвлөрлийг сааруулах газар зүйн болон чиг үүргийн хэлбэр

өөр хоорондоо нягт холбоотой байдаг. (Г.Т)

ЧИГ ҮҮРЭГ (*Function*) Хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнд тодорхой үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тогтвортой чиглэл¹⁰ юм. “Чиг үүрэг” төрийн институт, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн чиг үүрэг гэсэн түвшинд хэрэглэгдэж болно. Энэ нь нэгдсэн ойлголтоор “төрийн чиг үүрэг” гэх өргөн ойлголтоор тайлбарлагдах бөгөөд төрийн байгууллагаас нийгмийн эмх журмыг тогтоох, аливаа зөрчил маргааныг таслан шийдвэрлэх; төрийн үйлчилгээний байгууллагаас боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, дахин хуваарилалтын хүрээнд нийгмийн халамж, тусламжийг хүргэх; төрийн институцээс гадаад улс орон, олон улсын байгууллагуудтай найрсаг харилцах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах; шударга, ил тодоор өрсөлдөж, улс төрийн хүчин иргэдийн олонхын саналаар ялалт байгуулж, сонгуулийн үр дүнд парламентыг байгуулах, парламент нийгмийн асуудлыг шийдвэрлэх хууль тогтоох зэрэг өргөн үйл явцад “чиг үүрэг” ойлголтыг ашигладаг. (Г.Б)

ЧИМИД, БЯРААГИЙН (*Chimed B.*)

Хуульч, сурган хүмүүжүүлэгч, эрдэмтэн, төрийн зүтгэлтэн Чимид 1934 онд Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумд төржээ. МУИС-д 1962-1966 онд суралцаж, хуульч мэргэжил эзэмшжээ. “БНМАУ-ын захиргааны эрх зүйн асуудал” сэдвээр хууль зүйн ухааны докторын зэргийг 1975 онд хамгаалжээ. Бага залуу насандаа малчин, бичиг үсгийн бүлгэмийн

9 Goetsch, D. L., & Davis, S. B. (2016). *Quality Management for Organizational Excellence: Introduction to Total Quality*. New Jersey: Pearson Education, Inc, p. 122.

10 П.Зоригтбаатар: “Монгол Улсын Засгийн газрын төвлөрлийг сааруулах бодлого, түүний хэрэгжилт”, илтгэлийн эмхтгэл, Улаанбаатар 2018, х. 12.

багш зэрэг ажил хийж байгаад, цэрэгт татагджээ. 1953-1956 онд ардын цэрэгт байлдагч, салааны туслах, 1956 оноос сумандаа багийн дарга, Хөвсгөл аймгийн Намын хороонд зааварлагч, 1966 оноос МУИС-д багш, тэнхимийн эрхлэгч, 1978 оноос Шүүх яамны сайд, 1982 оноос Улсын дээд шүүхийн дарга, 1984 оноос Улсын дээд шүүхийн дарга бөгөөд улсын ерөнхий арбитрч, 1986 оноос Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн төрийн байгуулалтын хэлтсийн дарга, 1990 оноос Улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайдын зөвлөх, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын даргын зөвлөх, Монгол Улсын хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, МУИС-ийн хууль зүйн дээд сургуулийн тэнхимийн эрхлэгч, Удирдлагын академийн эрх зүйн тэнхимийн багш зэрэг алба ажлыг хашиж байжээ. “Монгол Улсын захиргааны эрх зүй”, “Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал”, “Багийн өнгөрсөн, одоо, ирээдүй”, “Шүүхийн тогтолцооны үүсэл хөгжил” зэрэг нэг сэдэвт зохиол, эрдэм шинжилгээний олон өгүүлэл бичиж хэвлүүлсэн нь залуу судлаач, эрдэмтэн багш нарын гарын авлага болсоор байна. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуульч боловсон хүчнийг сургаж бэлтгэхэд томоохон хувь нэмэр оруулжээ. Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг боловсруулах ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж парламентад хамгаалж хэлэлцүүлж батлуулсан шинэ үндсэн хуулийн эхийг баригч байлаа. Эрх зүйн шинэтгэл, хүний эрхийн талаарх гол гол тэмдүүдийг боловсруулалцсан байна. Ардын Их Хурлын депутатаар 3 удаа, Ардын Их Хурлын Тэргүүлэгч

гишүүнээр нэг удаа сонгогдож, МАХН-ын XVIII, XIX их хуралд төлөөлөгчөөр оролцож, Намын Төв Хорооны орлогч гишүүн, гишүүнээр сонгогдож байжээ. Монгол Улсын хөдөлмөрийн баатар, гавьяат хуульч цол бусад одон, медалиудаар шагнагджээ. Монгол улс ардчилал, зах зээлийн нийгэмд шилжин орох үеийн эрх зүйн шинэтгэл хийх, түүнд тулгуурлан төрийн тогтолцоог төвхнүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан хүний нэг юм. 2013 онд өвчнөөр таалал төгсжээ. (А.Ц)

ЧИНГИСИЙН БИЛЭГ (*Genghis Khan's teachings*) Чингис хааны билэг сургаал нэртэй, шүлэглэсэн хэлбэртэй сургаалын цоморлиг монголчуудын дунд ихэд тархсан юм. Олон янзын хувилбар, нэртэйгээр уламжлан иржээ. Түүнд айл гэрийн журмаас эхлэн төр барих арга зарчмын тухай олон сургаал багтсан байдаг. Тусдаа товхимол байхаас гадна Монголын нууц товчоо, Лувсанданзаны Алтан товч, Оюун түлхүүр зэрэг олон ном зохиолд Чингис хаан хөвүүд, дүү нараа айлдсан сургаалууд агуулагдаж байдаг. Академич Ч. Далай “Чингисийн нэртэй холбогдсон зарим дурдатгал, сургаал, хэлсэн үг, зарлиг, гэрээс зэрэг монгол хүний үе залгамжлан санаж, сахиж хэрэгжүүлж явах ёстой зүйлсийг Өгэдэй хаан удирдан эмхлүүлж “Засаг хууль”-д нэмж бичүүлсэн нь өнөө үед Чингисийн билэг сургаал хэмээн нэрлэгдэн, хэрэгжиж байна” гэжээ. Төрт ёсныхоо уламжлалыг хойч үедээ эзэмшүүлэхийн тулд Чингис хааны сургаалыг тусгайлан хадгалж, тодорхой хугацаанд хүүхэд, дүү нар, ноёдод дуудан сонсгодог байжээ. Энэ талаар Юань Улсын сударт тэмдэглэсэн байдаг. Шодбал хааныг сууринд суухад Байжу ноёнтон уг сургаалыг дуудан сонсгосон аж. “Олон хэргэмтэн ноёд Даймин Диан ордонд

хурахуйд Байжу бээр зарлигийг хүлээн алтан авдарт хадгалж агсан Тайзу Богдын эрдэнэт сургаалыг уншив. Түүний бие цогц сүр гэрэлтэй, дуу аялгуу нь ялгам тод, хурагсад олноор чих тавин, хичээнгүйлэн сонсохгүй байх нь үгүй” гэжээ. Чингисийн билэг сургаалд хожим шашны болон бусад зүйлс нэмэн орсон боловч үндсэн хэсэг, агуулга нь бүтэн байгаа нь ажиглагддаг. (А.Ц)

ЧӨЛӨӨЛӨЛТ (Exemptions) Бизнес эрхлэгчдэд эсвэл дэмжлэг шаардлагатай нийгмийн бүлэгт хуулиар олгосон тусгай нөхцөл буюу аливаа салбарын бодлогыг хэрэгжүүлэх хэрэгслийн төрөл. Ихэвчлэн орлогын тодорхой хэсэг эсвэл зарим төрлийн орлогын татвар ногдохоос чөлөөлөх дэмжлэгийг хэрэгжүүлэхээр хуульчилдаг. Эдийн засгийн уналт, хэлбэлзлийн нөхцөлд бизнес эрхлэгчдийг эрсдэлээс хамгаалах, жижиг дунд бизнесийг дэмжиж хөгжүүлэх эсвэл аль нэг салбарт дотоодын үйлдвэрлэгчийг дэмжих чиглэлд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хөтөлбөр хэрэгжүүлнэ. Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор экспортын татвараас чөлөөлөх, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд ашиглах өндөр технологийн эм, техник хангамжийн хэрэгслийг импортын татвараас чөлөөлөх, тодорхой салбарт гадаадын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор ашгийн болон бусад татвараас чөлөөлөх зэрэг хөнгөлөлт, чөлөөлөлтийн түгээмэл хэлбэрүүд байдаг. Түүнчлэн, төрөөс ард иргэдийнхээ амьдралын нөхцөлийг сайжруулах, жижиг дунд бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн зардлыг бууруулах зорилгоор банкны системээр дамжуулж хөнгөлөлттэй нөхцөлтэй буюу зээлийн хүүгээс тодорхой хугацаанд чөлөөлөх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. (Б.Б)

ЧУУЛГАН (Session) Чуулган хэмээх нь олноор хуран чуулж, хамтын хэрэг хэлэлцэх үйл ажиллагааны хэлбэр юм. ХҮП зууны үеэс Монголын халх 4, Дөрвөд 2 аймагт ноёд чуулж хэрэг хэлэлцдэг уламжлал тогтжээ. Зарим чуулганаар хууль цаазын баримт бичиг гаргадаг байв. Жишээ нь, Монгол Ойрадын ноёдын чуулганаар тогтоосон Их цааз, түүнд оруулсан нэмэлтүүдийг дурдаж болно. Түүнчлэн чуулганы үеэр зөрчил гарч, өөр зуураа тэмцэлдэх явдал гардаг байснаас үүдэн “ноёдын үхэл чуулганд, нохойн үхэл ганганд” хэмээх үг хүртэл гарчээ. Богд хаант Монгол Улсын үед аймаг бүр чуулгантай, түүнийг чуулганы дарга удирдан явуулдаг байжээ. БНМАУ-ын үед Ардын Их Хурлын, эдүгээ Улсын Их Хурлын хуралдааныг нийтэд нь чуулган хэмээн нэрлэдэг болжээ. Энэ нь Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр юм. (А.Ц)

Ш

ШАВЬ (*Shabi*) Богд болон хутагт хувилгаадын мэдлийн хамжлага ардууд. Анх Өндөр гэгээн Занабазарыг таван настай байхад нь Монголын шарын шашны тэргүүн болгон Жавзандамба хутагт хэмээн өргөмжлөхөд Түшээт хан түүнд 108 банди нарыг шавь болгон өргөжээ. Хожим Өндөр гэгээний гурван ах тус бүр арав, авга ах Дүүрэгч ноён хоёр өрхийг шавь болгон өргөснөөр Жавзандамба хутагтын шавь үүссэн байна. Улмаар наймдугаар богдын үед шавь нарын тоо улам бүр өссөөр байжээ. Ялангуяа наймдугаар богд Улсын эзэн хаан болсноос хойш бүр ч их өссөн байна. Шавь ард нь татвар төлдөггүй, цэрэгт явдаггүй зэрэг давуу талтай байсан учраас шавь болох эрмэлзэл их байжээ. XIX зууны хоёр дугаар хагасаас тайж нар татвар төлөх ёстой болсон учраас тэд ч шавь болохыг эрмэлздэг болжээ. Богдоос гадна тамгатай хутагт нар шавьтай байжээ. Ардын хувьсгалаас өмнө тамгатай 13 хутагт байв. Тэд халх дөрвөн аймгийн өрх, хүн амын 20-иод хувь, мал сүргийн 10 орчим хувийг эзэгнэн захирдаг байжээ. (А.Ц)

ШАТАЛСАН БҮТЭЦ (*Hierarchical structure*) Hierarchy гэдэг нь Латины “hierarchy” (XIV зуун) буюу “эрэмбэ” гэсэн үгнээс үндэстэй. Үгийн утга нь “байгууллага доторх хүн эсвэл ямар нэг

зүйлийн эрэмбэ, дараалал”-ыг илтгэдэг. Монгол хэлний тайлбар тольд “эрэмбэ” гэдгийг “юмны зүй тогтол эмх цэгц бүхий дэс дараа” хэмээн тайлбарласан байдаг. Энэ үгийн ерөнхий утга “үелсэн, дараалсан зүйлийг” илтгэж байгаагаас үзвэл “шатлах” гэсэн агуулгаар хэрэглэх нь зохимжтой юм. Харин “structure” гэдэг нь Латины “structura” (XV зуун) буюу “барилга барих, бүтээн байгуулах” гэсэн үгнээс гаралтай. Үгийн утга нь 1610 оноос “юмсын дотоод бүрэлдэхүүний байгуулалт, нийлэмжтэй байдал, зохион байгуулалт” гэсэн санааг илэрхийлэх болсон. Өөрөөр хэлбэл, үгийн ерөнхий агуулга нь аливаа зүйлийн “эмх журамтай байдал, дотоод бүтэц” гэсэн утгыг илтгэж байна. Энэ хоёр үгийн нийлэмж нь “эмх цэгц, эрэмбэ дараа бүхий бүтэц” гэсэн агуулгатай байгаагаас үзвэл “hierarchical structure” гэдгийг “шаталсан бүтэц” хэмээн орчуулан хэрэглэж болно. Тухайлбал, захиргааны байгууллагын шаталсан бүтэц нь доод шатны этгээд нь дээд шатныхаа этгээдэд захирагдах, байгууллагын дээд удирдлагаас буурах дараалаар хамгийн доод шатны ажилтан хүртэлх албан тушаалын шатлалтай байх, байгууллагын бүтцийн дээрээс доош чиглэсэн хариуцлагын түвшингээр дамжих захирах-захирагдах

харилцаагаар зохицуулагддаг. Захиргааны байгууллага нь “зохион байгуулалт, эрх мэдлийн шаталсан түвшингүүдтэй, төвлөрсөн нэгдмэл удирдлагатай, цац хэлбэртэй байдаг (А.Цанжид, 2009, хуудас 67)”. Өөрөөр хэлбэл, “тушаал дамжуулах тодорхой босоо бүтцийн хүрээнд доод нэгж бүр нь дээд нэгждээ захирагддаг, дээд нэгж нь доодох нэгжээ захирдаг тогтолцоо” бүхий шаталсан загвар юм (Ш.Батсүх, 1996)”. Захиргааны байгууллагын бүтэц нь пирамид маягийн шаталсан хэлбэртэй байдаг бөгөөд зохион байгуулалтын бүтцийн дагуу ажилтан бүр зөвхөн нэг шууд удирдах даргатай, нэгж бүрд эрх мэдлийн тодорхой хүрээ, үйл ажиллагааны чиглэлийг тогтоосон байдаг онцлогтой. Энэ нь байгууллагын ажилтнуудыг нэг зорилгын төлөө нэгтгэж, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах боломжийг олгодог юм. (Т.Т)

ШАТЛАЛ (*Hierarchy*) Шатлал нь эрх мэдлийн түвшинг эрэмбэлэхтэй холбоотой ойлголт бөгөөд удирдлагын хэлхээ холбоо болон хяналттай холбогдоно. Үгийн гарлын хувьд эртний Грекийн “hieros” (sacred) буюу ариун нандин, “archein” (rule, order) буюу захирах, эмх цэгц, эрэмбэ гэсэн үгнээс үүсэлтэй. Макс Веберийн бюрократ ёсны талаарх үзэл баримтлалд байгууллага доторх хууль ёсны рационал эрх мэдлийн шатлалын асуудал томьёологдон оржээ. Түүний үзлээр шаталсан эрх мэдэл нь төвлөрсөн эрх мэдэл болон нягт холбогдсон удирдлагын хэлхээнээс бүрддэг бөгөөд эрх мэдэл аажмаар доошоо шилждэг байна. Янз бүрийн түвшний нэгжийн хоорондын харилцаа нь дээд удирдлага болон түүний харьяа нэгж нь зөвхөн өөрийн дээр байгаа нэгжийн өмнө хариуцлага хүлээх байдлаар хэрэгжинэ. Шатлал нь ажил

хариуцсан нэгжүүд дээр суурилах бөгөөд, нэгж бүр ажил үүргийн хувьд ялгаатай, тус тусын хариуцсан үүрэг даалгавартай ажилладаг. (Ж.Ж)

ШИЙДВЭР ГАРГАЛТ (*Making decision*) 1950 оноос эхлэн шийдвэр гаргалт хэмээх нэр томьёо шинжлэх ухааны эргэлтэд орж, судлаачид шийдвэр гаргалтын онолгыг өргөн хүрээнд судалж эхэлсэн. Өнөөг хүртэл судлаачид өөр өөрсдийн өнцгөөс шийдвэр гаргалтын талаар янз янзын тайлбар, томьёолол дэвшүүлсээр байна. Нэг хэсэг судлаачид “шийдвэр гаргалт гэдэг нь шийдвэр гаргахын өмнө болон дараа авч хэрэгжүүлэх цогц бодлого, стратеги” гэж үздэг. Нөгөө хэсэг нь “шийдвэр гаргах гэдэг нь асуудлыг олж харахаас эхлээд түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар гаргасан шийдвэрийг хүртэлх үйл явцыг хэлнэ” гэжээ. Шийдвэрийн онолын гол судлаач Херберт Саймон “Зөвхөн шийдвэр гаргаад орхих нь хангалттай биш ба түүнийг хэрэгжүүлэх нь чухал юм” гэж үзэж эхний хэсгийн судлаачдын дүгнэлттэй санал нэгддэг. Харин “Шийдвэр гаргалт гэдэг нь хоёр буюу түүнээс дээш хэд хэдэн хувилбаруудаас сонголт хийх, оюун ухаан, танин мэдэхүйн үйл явцын үр дүн” гэж үздэг судлаачид дараагийн бүлэгт хамаарна. Оксфордын толь бичигт “Шийдвэр гаргалт нь байгууллага, тодорхой бүлэг хүмүүс ямар нэг чухал зүйлийн талаар гаргаж буй шийдлийн үйл явц” гэж бичжээ. Кэмбрэйжийн толь бичигт “сонголт хийж буй үйл явц бөгөөд ялангуяа хамгийн чухлыг сонгох үйл явц”, менежментийн бүтээлд “шийдвэр гаргах нь тулгамдаж буй асуудлыг шийдэхийн тулд хоёр эсвэл түүнээс дээш хувилбаруудаас сонголт хийх үйл явцад оролцох” гэж үзжээ. Шийдвэр гаргах үйл явц, түүний онол арга зүйн судалгаа нь улс төр, бизнесийн

удирдлагын хүрээнд илүү судлагдсан тул дээрх байгууллагуудын талаарх жишээ баримт дээр тулгуурласан бүтээлүүд түгээмэл байна. Гэхдээ шийдвэрийн үнэ цэнэ, рационал байдал, үр дүн, тодорхой бус байдал зэргийг судлахад шинжлэх ухааны салбар бүр өөр өөрийн тайлбар, хандлагаар авч үздэг. Тухайлбал,

- *Философийн хувьд*: Шийдвэрийн онол нь шийдвэр гаргах рационал чанарыг үнэлж цэгнэдэг (шударга ба шударга бус, үнэн бодиттой эсэх)
- *Улс төрийн хувьд*: Хамтын шийдвэр гаргалт болон санал хураалт, сонгуулийн арга хэлбэрийг судлахад төвлөрдөг.
- *Сэтгэл судлалын хувьд*: Шийдвэр гаргахад хувь хүмүүсийн үйл байдал буюу бихевиорт тулгуурлан шинжлэхэд анхаардаг
- *Эдийн засаг, бизнесийн хувьд*: Шийдвэр гаргалтын үр ашиг ба хор хохирлыг тооцоход чиглэдэг зэрэг тухайн салбарын онцлог талаас судлагдаж, улмаар энэ нь арга зүйн олон шинэ хандлагуудыг бий болгох боловч шийдвэрийн онолын үндсэн агуулгын хүрээнд судлагддаг байна. (Я.Т)

ШИЙДВЭРИЙН МОД (Decision tree)

Шийдвэрийн боломжит хувилбаруудыг тодорхойлон, тэдгээрийн үр дүн, хариу үйлдлийг нөхцөлт алгоритмаар тооцоолж, модны бүтэцтэй төстэй диаграммаар харуулдаг шийдвэр гаргалтын арга техник. 1960-аад онд анх боловсруулсан шийдвэрийн мод нь өгөгдөл олборлолтын нэг арга бөгөөд ангиллын (classification) ба регрессийн (regression) гэсэн хоёр төрөлтэй. Лео Брейман (Leo Breiman), Чарльз Стоун (Charles Stone) нар ангилал ба регрессийн мод (clas-

sification and regression tree-CART) алгоритмыг анх боловсруулж 1984 онд нийтэд танилцуулжээ. Ангиллын мод аргад таамаглаж буй үр дүн нь тухайн өгөгдөл хамаарах анги бүлэг байдаг бол регрессийн мод аргад таамаглаж буй үр дүнг бодит тоо гэж үзэх боломжтой. Шийдвэрийн мод аргыг тодорхой бус нөхцөл байдлын орчинд нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэх, эдийн засгийн прогноз, стратегийн төлөвлөлт, стратегийн шийдвэрийн шинжилгээнд ашиглах нь үр дүнтэй. Байгууллагын стратегийн шийдвэрүүд нь тодорхой бус байдлын нөхцөлүүдийг агуулдаг тул шийдвэрийн хувилбаруудын дүн шинжилгээнд энэ аргыг ашигласнаар тодорхойгүй байдлыг аль болох багасгаж, тодорхой болгох боломжтой. Шийдвэрийн мод аргыг олон салбарт өргөн ашигладаг. Энэ аргын давуу тал нь диаграмм дээр боломжит шийдвэрүүдийг дагаж мөрдөх болон ойлгоход хялбар. (Д.Ч)

ШИЙДВЭРИЙН ОНОЛ (Decision theory)

Шийдвэр гаргах онол нь оновчтой шийдвэр гаргах аргуудын тухай онол. Шийдвэрийн онолыг статистик үүднээс авч үзвэл оновчтой шийдвэрт хүргэх тоон аргуудын багц болно. Орчин үеийн шийдвэрийн онолын хөгжил XX зууны дунд үеэс эхлэлтэй. Шийдвэрийн онолыг үндэслэгч Леонард Саваже (Leonard Savage)-ийн 1954 онд хэвлэгдсэн “Статистикийн үндэс” бүтээл нь тодорхой бус нөхцөлд байдалд, ялангуяа эдийн засаг, шийдвэрийн шинжлэх ухаанд хамгийн сайн танигдсан онол юм. Шийдвэрийн онолоор оновчтой шийдвэр нь хүлээгдэж буй ашиг тусыг хамгийн их байлгах тэр шийдвэр юм. Онолын гол санаа нь шийдвэрийн сонголтыг ердийн тооцоонд оруулах замаар оновчтой болгох явдалд

оршино¹. Шийдвэрийн онол нь дотроо хоёр төрөлд хуваагдана. Шийдвэрийн үр дүнг шинжлэх эсвэл хязгаарлалт, таамаглалын дагуу оновчтой шийдвэрийг тодорхойлдог норматив шийдвэрийн онол ба шийдвэр гаргагч хэрхэн шийдвэр гаргаж байгаад дүн шинжилгээ хийдэг дескриптив шийдвэрийн онол. Шийдвэрийн онол нь тоглоомын онолын салбартай нягт холбоотой бөгөөд эдийн засаг, статистик, мэдээлэл, сэтгэл судлал, биологи, улс төр болон бусад нийгмийн шинжлэх ухааны салбар дундын сэдэв юм. (Д.Ч)

ШИЙТГЭВЭР (Punishment) Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг гаргасан ажилтан, албан тушаалтан, хуулийн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хэвлэмэл хуудсаар байцаагчаас хариуцлага ногдуулсан шийдвэрийг шийтгэвэр гэнэ. Байцаагч шийтгэвэр ногдуулахдаа зөрчил үүссэн шалтгаан, шинж байдал, агуулга, хэлбэр, хохирлын хэмжээ, сөрөг нөлөөлөл, зөрчил арилсан эсэх зэрэг хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан холбогдох хууль тогтоомжийн дагуу бие даан шийдвэрлэнэ. Шийтгэвэрийн хуудсаар торгууль ногдуулахад хуульд заасан хэмжээг мөрдөх бөгөөд тогтоосон хэмжээг багасгаж үл болно. (Ч.Э)

ШИЛЖИЛТИЙН ЭДИЙН ЗАСАГ (Transitional economy) Төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооноос зах зээл рүү шилжиж буй эдийн засгийг хэлнэ. 1980-аад оны сүүлээс хуучин ЗХУ болон Зүүн ба Төв Европ, Азийн зарим орнуудад эхэлсэн улс төр, нийгэм ба эдийн засгийн томоохон өөрчлөлтийг тодорхойлж энэ нэр томъёог ашиглах болсон. Энэхүү шилжилтийн явцад

тухайн эдийн засагт бүтцийн томоохон өөрчлөлт ордог. Юуны түрүүнд үнийг чөлөөлж, зах зээлийн эрэлт ба нийлүүлэлтийн зарчимд суурилсан үнэ бүрдэх механизмыг бий болгоно. Зах зээлийн эдийн засаг нь хувийн өмчид суурилдаг учир төрийн мэдэлд байсан өмчийг хувьчлах, шинээр хувийн өмч бий болгохыг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ. Макро эдийн засгийн түвшинд төвлөрсөн төлөвлөгөөнөөс татгалзаж, эдийн засгийг тогтворжуулах сангийн ба мөнгөний бодлого, тэдгээрийг хэрэгжүүлэх институцийг бий болгоно. Санхүүгийн цоо шинэ тогтолцоо, банкны системийг бүрдүүлэх, гадаад худалдааг чөлөөлөх, төрийн үүргийг шинээр тодорхойлж, хувийн өмчийн эрхийг баталгаажуулах, өрсөлдөөнийг дэмжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг системийн томоохон өөрчлөлтүүд шилжилтийн эдийн засагтай улс орнуудад өрнөсөн. Шилжилтийн үйл явц дээрх улс орнуудад харилцан адилгүй хурдтай, ялгаатай амжилттай хэрэгжиж ирсэн. Хуучин ЗХУ болон Зүүн Европын ихэнх орон, Монгол Улсад “огцом өөрчлөлт” (big bang) явагдсан бол Азийн орнууд болох БНХАУ, Вьетнам, Лаос зэрэг орнуудад энэ өөрчлөлт аажим (gradual transition) явагдсан гэж үздэг. Сүүлийн 30 гаруй жилийн турш явагдсан энэхүү шилжилт нь улс орнуудад харилцан адилгүй үр дүнтэй байна. 2004 болон 2007 онд Европын Холбооны гишүүн болсон 10 орчим орон болох Чех, Эстон, Унгар, Латви, Польш, Хорват, Словак, Литв, Словени, Болгар, Румын зэрэг орнуудын хувьд шилжилтийн үйл явц дуусаж, эдгээр нь зах зээлийн бүрэн тогтолцоотой улс орон болсон гэж Дэлхийн банк² дүгнэсэн. Бусад орнуудын хувьд шилжилтийн үйл явц үргэлжилж байна. Шилжилтийн эдийн

¹ Britannica тайлбар толь, <https://www.britannica.com/science/decision-theory-statistics>

² <http://siteresources.worldbank.org/ECAEXT/Resources/publications/UnleashingProsperity.pdf>

засаг хэмээх нэр томьёог сүүлийн үед илүү өргөжүүлэн ойлгож, диктатураас чөлөөлөгдөж буй, эдийн засгийн хэт их зохицуулалттай байсан Латин Америк, Африк, Азийн цөөн тооны орныг мөн ийнхүү нэрийдэх болсон. (Ч.Н)

ШИЛЖҮҮЛГИЙН ЗАРДАЛ (*Transfer payment*)

Тусламж, дэмжлэг шаардлагатай нийгмийн бүлэг, иргэдэд чиглэсэн нийгмийн хамгааллын бодлого, хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс иргэдэд олгож буй мөнгөн дэмжлэгийг шилжүүлгийн зардал гэнэ. Тухайлбал, нийгмийн хамгааллын зардал, сургалтын төлбөрийн дэмжлэг, өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмж зэргийг шилжүүлгийн зардал гэсэн ангилалд багтаадаг. Шинж чанарын хувьд ямар нэг эдийн засгийн үнэ цэнийг харилцан шилжүүлэхгүйгээр хийгддэг төлбөр ба төрөөс хэрэгжүүлэх орлогын дахин хуваарилалтын арга хэрэгсэл болдог онцлогтой. (Б.Б)

ШИЛЖҮҮЛЭГ (*Transfer*) Эдийн засгийн аливаа нөөц буюу мөнгө, хөрөнгө, өмчлөх эрхийг нэг данснаас нөгөөд шилжүүлэх үйлдлийг хэлнэ. Мөнгө, хөрөнгө, бусад нөөцийн байршил, харьяаллын шилжилтээс гадна өмчлөх эрхийн шилжилт хийгдэх үед шилжүүлэг гэсэн нэр томьёог хэрэглэдэг ба банк санхүү, бараа бүтээгдэхүүний зах зээлийн ажил гүйлгээнд ялгаатай онцлог бүхий утгыг агуулна. (Б.Б)

ШИЛЭН ДАНС (*Glass account*) Төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит хуулийн этгээд, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн

төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч нь батлагдсан төсөв болон түүний гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын зарцуулалтын дүнгийн талаарх мэдээллийг олон нийтийн цахим сүлжээнд ил тод нээлттэй байршуулахыг хэлнэ.³Монгол Улсын Их Хурал Шилэн дансны хуулийг 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдөр баталсан. Энэ хуулийн зорилго нь Төсөв, санхүүгийн холбогдолтой мэдээллүүд нээлттэй байлгах, шилэн дансны нэгдсэн тогтолцоотой болох, түүнтэй төрийн сангийн тогтолцоог уялдуулах, мөн түүнчлэн хууль, тогтоомжийн дагуу улсын аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагаас бусад төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсөв, санхүүг нээлттэй болгохтой холбогдсон эрх үүргийг тодорхой болгож, хариуцлагыг өндөржүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааны эрх зүйн үндсийг тогтоох, нөгөө талаар төсвийн талаарх мэдээлэл хайх, хүлээн авах, төсвийн үйл ажиллагаанд (төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах) оролцох иргэний эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тус тус тусгасан байна. Шилэн

3 Шилэн дансны тухай хууль

дансыг төрийн бүхий л байгууллагууд мөрдөх зайлшгүй шаардлага нь дараах байдлаар тодорхойлогдсон. Үүнд:

- Төсвийн хариуцлага, сахилга бат, тогтвортой байдал алдагдаж байна. Төсвийн хөрөнгийг зүй бусаар ашиглах, авлига хээл, хахууль болон бусад эдийн засгийн гэмт хэргүүд тухайлбал татвар, тусгай сангийн хөрөнгийн ашиглалт шамшигдуулалт, гадаад, дотоод өр зээлийн асуудлууд ихээр бий болсон;
- Төсөв, санхүүгийн холбогдолтой мэдээллүүд нээлттэй байх ёстой бөгөөд яг ямар мэдээлэл нээлттэй байх талаарх мэдээллийн агуулгыг хуульчлах;
- Төсөв, санхүүгийн холбогдолтой мэдээллүүд нээлттэй байлгах талаар хууль, тогтоомжийн дагуу улсын аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагаас бусад төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэгтөрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийноролцоотой хуулийн этгээдийн албан тушаалтны эрх үүргийг тодорхой болгож, хариуцлагыг өндөржүүлэх;
- Төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдал, шилэн данс зэргийг тодорхойлсон хуулийн нэр томьёог ойлгомжтой байдлаар тусгаж, нэг мөр болгох;
- Төсөв, санхүүгийн мэдээллийн буюу шилэн дансны нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, одоо байгаа тогтолцоонуудтай холбох,

тухайлбал төрийн сан, төсвийн мэдээллийн сан. (А.Э)

ШИНЖЛЭХ УХААН (Science)

Шинжлэх ухаан (лат. scientia буюу "мэдлэг") бол ертөнцийн талаарх оновчтой тайлбарлал, урьдчилан хэлэхүйн хэлбэрээр мэдлэгийг бий болгож, зохион байгуулдаг тогтолцоо бүхий үйл ажиллагаа юм. Ертөнцийн талаарх эмх цэгцтэй зөв мэдлэг олж авах танин мэдэхүйн өвөрмөц тусгай үйл ажиллагаа нь эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, сургалт-судалгааны байгууллага, мөн засгийн газрын агентлаг, компаниудын хүрээнд зохион байгуулагддаг. Орчин үеийн шинжлэх ухааныг байгалийн шинжлэх ухаан (биологи, хими, физик), хүн болоод нийгмийг судалдаг нийгмийн шинжлэх ухаан (эдийн засаг, улс төр судлал, сэтгэл зүй, социологи) хэмээн ангилахаас гадна хийсвэр ойлголтыг судалдаг формаль шинжлэх ухаан (логик, математик, онолын компьютерын шинжлэх ухаан) хэмээн ангилах нь түгээмэл. Гэвч формаль шинжлэх ухаан нь эмпирик нотолгоонд тулгуурладаггүй тул шинжлэх ухаан мөн эсэх дээр дээр санал зөрөлддөг. Харин инженер, анагаах ухаан гэх мэт өнөөгийн шинжлэх ухааны мэдлэгийг практик зорилгоор ашигладаг салбаруудыг хэрэглээний шинжлэх ухаан гэж тодорхойлдог. Харин хүмүүнлэгийн ухаан (философи, түүх, утга зохиол)-ны салбарыг оросоор шинжлэх ухаан хэмээн нэрлэдэг ч, шинжлэхүйн арга, судалгааны оногдохуун зэрэг онцлогоор нь шинжлэх ухаан хэмээн үзэлгүйгээр зөвхөн ухаан, урлаг буюу либерал арг хэмээн нэрлэдэг онцлогтой. Өөрөөр хэлбэл энэ бүхэн шинжлэх ухаан, философийг хэрхэн авч үздэгийг тайлбарладаг байсан өрнө дахины уламжлал, сэтгэлгээний

онцлог, соёлоос хамаардаг. Шинжлэх ухааны гол зорилго бол шинэ мэдлэг юм. Гагцхүү тэр мэдлэг нь обьектив, системлэг, эмх цэгцтэй, үнэн магад, шинжлэх ухааны хэл буюу ойлголт, ухагдахуунаар илэрхийлэгдсэн байх ёстой. Үнэний төлөөх эрэл хайгуул хэмээн үзэж болно. Үнэн гэдэг нь ямагт дээгүүр эрэмбэд орших шинжлэх ухааны гол үнэт зүйлс юм. Үүний төлөө эрдэмтэд өөрийнхөө амьдрал, оюун ухааныг шинжлэх ухаанд зориулдаг ажээ. Шинжлэх ухаан олон төрлөөр тодорхойлогддог ч үйл ажиллагаа, мэдлэг, институт гэсэн үндсэн гурван хэлбэрээр ойлгогддог. Эдгээрийн нэгдсэн хэлбэршилт бол шинжлэх ухааны парадигм нь тухайн үеийн ертөнцийн талаарх шинжлэх ухааны ерөнхий дүр зураглалыг бүрдүүлж байдаг. Харин социал утгаараа нийгэм-соёлын үзэгдэл, нийгмийн ухамсрын нэг хэлбэр бөгөөд нийгмийн ой санамжид хамаарах, цашилбал обьектив мэдлэгийн бие даасан ертөнц гэх мэтээр тайлбарлагдана. (Б.П)

ШИНЖЛЭХ УХААНЫ МЕНЕЖМЕНТ (*Scientific management*) Шинжлэх ухааны менежмент бол менежментийн философийн нэр томьёо бөгөөд ФредрихТэйлор (F.W.Taylor)-ын нэртэй шууд холбогдоно. 1800-аад оны сүүл үе нь аж үйлдвэржилтийн эрчимтэй хөгжлийн үе байсан боловч АНУ-д байгалийн нөөц баялгийг үр ашиггүй зарцуулах, улс төрийн хувьд ёс суртахууны доройтолд орж авлига нүүрлэсэн үе байв. Энэ үед шинэчлэгчид байгалийн баялгийг зохистойгоор, бүрэн дүүрэн, үр ашгийг нэмэгдүүлсэн төрийн захиргаа болон менежментийн шинэ, үр дүнтэй аргууд хэрэгтэй хэмээн онцлох болсон. Тейлор өөрөө үйлдвэрлэлийн инженер байсан бөгөөд тухайн үеийн асуудлыг шийдвэрлэхэд ажилчид

болон удирдлагын аль алиных нь оюун санаанд сэтгэлгээний (менталь) хувьсгал хэрэгтэй хэмээн итгэж байсан. Тейлор ажлыг оновчтой, илүү өндөр бүтээмжтэй, үр ашигтай хийхийн тулд шинжлэх ухааны арга зүйг ашигласан менежментийн философийг боловсруулсан. Түүний инженерийн туршлагаар муу менежмент болон үр дүнгүй хөдөлмөр эрхлэлт нь үйлдвэрлэлийн бүтээмжийн асуудлыг үүсгэж хэмээн үзэж байв. Эхний асуудлыг шийдвэрлэхэд сайн боловсорсон менежерүүд ажлын төлөвлөлт болон хяналтыг хариуцах ёстой. Түүнээс бус захиргаадах, ташуурдах эсвэл эрхий хурууны дүрмээр ажиллах ёсгүй. Үүний оронд ажилд авах, зааварлах, сургах, бүтээмжийг урамшуулахад хамтын хүчин чармайлт гаргах ёстой. Хөдөлмөрийн үр ашиггүй байдлыг шийдвэрлэхийн тулд гурван өөрчлөлт шаардлагатай. Нэгдүгээрт, ажлын загвар зураглалыг сайжруулах хэрэгтэй. Ажилтан бүрийн хийж буй ажлыг тухайлан судалснаар стандарт арга, арга зүй буюу ажил бүрийг гүйцэтгэх “хамгийн шилдэг арга зам” тодорхой болно гэж үзсэн. Ийм замаар үр дүнгүй зарцуулсан цаг, хүчин чармайлтыг бууруулна хэмээн үзжээ. Хоёрдугаарт, тухайн ажил бүрийг хамгийн үр бүтээмжтэй хийхэд зориулагдсан ажлын хэрэгслийг байгууллага хангаж өгөх ёстой. Эцэст нь урамшууллын системээр ажиллах урам зоригийг хөхүүлэн дэмжих ёстой. Эдгээр гурван шийдэл нь хөдөлмөрийн харилцааны ихээхэн том асуудал болох “цэрэгжилт”-ийг үгүй болгоно хэмээн үзэж байв. Тейлорынхоор бол ажилтнууд уг чанараараа залхуу бөгөөд хариуцсанаасаа илүү ихийг хийх нь ач холбогдолгүй гэж үздэгээс болоод ажлыг удаашруулах хандлагатай. Тейлорын менежментийн философи нь

“Шоп менежмент” (1903), “Шинжлэх ухааны менежмент” (1911) бүтээлүүдэд нь гол тусгалаа олсон байдаг бөгөөд түүний анхлан гаргасан “шинжлэх ухааны менежмент” гэх нэр томьёог Луис Брандейс 1911 онд хэрэглэсэн байна. Шинжлэх ухааны менежмент бизнес, төрийн захиргаанд маш их үр нөлөө үзүүлсэн байдаг. (Б.П)

ШТАЙН, ГЕНРИХ ФРИДРИХ (*Heinrich Friedrich Karl Reichsfreiherr vom und zum Stein, 1857-1831*)

Пруссын төрийн зүтгэлтэн. Пруссын захиргааны реформыг хэрэгжүүлсэн хүн. Штайн уул уурхайн департаментэд алба хааж эхэлсэн ба энэ албыг удаан хугацаагаар хашиж, дараа нь Вестфалиа муж улсын орон нутгийн захиргааны байгууллагад ажилласан байна. 1796 онд Рейн ба Вестфалиа мужийн захирагч болжээ. 1804 онд Аж үйлдвэрийн сайд болжээ. Гурав дугаар Фридрих Уильям хаантай санал зөрөлдсөний учир 1807 онд огцорч төрөлх цайздаа очжээ. Тэнд Пруссын төрийг бүхэлд нь шинэчлэх утга бүхий Нассаугийн меморандум (*Nassauer Denkschrift*) гэдгээ боловсруулсан байна. Эл баримт бичгийн үндсэн санаа бол итгэл даах чадвартай, үр нөлөө бүхий төрийг буй болгохын тулд төр болон хүн амын хооронд амьд харилцааг буй болгох, иргэдийг төрийн хэрэгт хариуцлагатайгаар оролцуулдаг болох ёстой гэдэг юм. Тэр энэ санаагаа Английн өөрийгөө удирдах систем дээр үндэслэн гаргасан бөгөөд илүү баяжуулсан байна. Тэрбээр өөрийгөө удирдах ёсыг нэвтрүүлснээр иргэдийн ухамсар (*Bürgersinn*), нийгэмлэгийн уур амьсгалыг (*Gemeingeist*) буй болгоно хэмээн үзэж байжээ. Удалгүй Уильям хаан Наполеоны зөвлөсний дагуу Штайныг ерөнхий сайдын албан тушаалд томилжээ. Энэ нь түүнд үзэл санаагаа хэрэгжүүлэх таатай

боломжийг олгосон байна. Тэрбээр газрын эздэд нөхөн олговор олгож, тариачдыг хамжлагаас чөлөөлөх, язгууртнуудаас татвар авах, газрын худалдааг чөлөөтэй болгох, хотуудад өөрийгөө удирдах ёсыг нэвтрүүлэх талаар хууль гаргаж хэрэгжүүлсэн нь Пруссын төрд бүрэн хэмжээний реформ хийсэн явдал байв. Пруссын нийт нутаг дэвсгэрийг өөр өөрийн чиглэлээр нэгтгэн удирдах эрх бүхий салбарын яамдыг байгуулжээ. Мужуудад төв засгийн газарт шууд захирагддаг тэргүүн Oberpräsident-ийн албан тушаалыг буй болгон захиргааны дунд төвшний бүтцийг бүрдүүлсэн байна. Гэвч 1808 онд Прусс Улс Францтай дайтах магадлалын талаар бичсэн түүний захидлыг Францын нууц албад олж авсан учир Наполеон түүнийг ардын дайсан хэмээн зарлаж Австраас зугтахад хүрчээ. Тэрбээр 1812 онд Оросын хаан Александр I –ийн зөвлөх болжээ. 1831 онд Вестфалиад нас эцэслэжээ. Штайн хэмжээгүй эрхт хаант төрд либерал маягийн үзэл санааг нэвтрүүлсэн сэтгэгч, төрийн зүтгэлтэн байжээ. (А.Ц)

ШУДАРГА БАЙДАЛ (*Integrity*)⁴ Ёс зүйн тодорхой зарчимд захирагдахыг хэлнэ. Энэ нь үйл ажиллагаатай холбоотой. Хүнийг ёс зүйн дүрэмд захирагдахыг шаарддаг. Хүн шударга байвал нэнэнч зан чанартай байдаг байна. Тиймээс “шударга байдал” буюу “integrity” төрийн албаны өдөр тутмын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой. Шударга байдалд дараах ойлголтуудыг багтаан үзэж болно. Үүнд:

- Төрийн албан хаагчийн зан үйл нь байгууллагынх нь зорилготой нийцсэн байх
- Төрийн өдөр тутмын үйлчилгээ найдвартай явагдах

⁴ Авлигатай тэмцэх газар (2019). Төрийн албан хаагчийн ёс зүй: гарын авлага. Улаанбаатар, 2019, х. 43.


- Хууль зүйн болон шударга ёсны үндсэн дээр иргэдэд алагчлалгүй, тэгш хандах
- Олон нийтийн хөрөнгийг зөв зохиистой, үр дүнтэй, ашигтайгаар зарцуулах
- Шийдвэр гаргах үйл явц иргэдэд ил тод, нээлттэй байх ёстой.
- Хуулийн хэрэгжилт
- Сонгуулийн удирдах байгууллага
- Омбудсмен (төрийн хяналт шалгалт)
- Аудитын байгууллага
- Авлигатай тэмцэх байгууллага
- Улс төрийн намууд
- Хэвлэл мэдээллийн байгууллагууд
- Иргэний нийгэм
- Бизнесийн салбар зэрэг юм.

Хувь хүний шударга байдал нь стандарт, дүрэм журам, процедурын дагуу байгууллагын зорилгыг биелүүлэх төрийн албан хаагчийн ёс зүйд хамаардаг⁵. Эдгээр зарчим нь шударга байдал, ёс зүйн удирдлагын тогтолцоог тулган шалгах заавар чиглэл, удирдлага, хяналтын чиг үүргийг тодорхойлсон бөгөөд шударга байдлыг тодорхойлон тогтоох, шударга байдалд чиглүүлэх, шударга байдлыг хянах, шударга ёсыг сахиулах гэсэн удирдлагын тогтолцооны үндсэн дөрвөн чиг үүргийг хамардаг. (ЦД)

ШУДАРГА БАЙДЛЫН ТОГТOLЦOО (*Integrity system*) Үндэсний Шударга байдлын тогтолцоо гэдэг нь тухайн улс оронд авлигын эсрэг тэмцэх үүрэг бүхий гол байгууллагуудын цогц юм. Нийт улс орныг хамарсан төдийгүй орон нутгийн засаглалын хүрээнд ч шударга байдлын тогтолцоо байх ёстой. AMNESTY INTERNATIONAL-ын тодорхойлсноор үндэсний шударга байдлын тогтолцоо нь дараах үндсэн тулгуур багануудаас бүрддэг⁶. Үүнд:

- Төрийн хууль тогтоох эрх мэдэл
- Төрийн гүйцэтгэх эрх мэдэл
- Шүүх засаглал
- Улсын салбар

Зураг 1. Үндэстний Шударга байдлын тогтолцооны үндсэн тулгуур баганууд



Эх сурвалж: Transparency International (2016). NIS Assessment Toolkit. [transparency.org/files/content/ins/NIS_AssessmentToolkit_EN.pdf](https://www.transparency.org/files/content/ins/NIS_AssessmentToolkit_EN.pdf)

Үндэсний шударга байдлын тогтолцоо нь тухайн нийгмийн улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын хүрээнүүдэд тулгуурласан байдаг. Тиймээс системийн үйл ажиллагаа нь эдгээр хүрээнүүдийн хөгжил, уламжлал, шинж чанар зэргээс ихээхэн хамааралтай байдаг. (ЦД)

ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ (*The independence of a judge*)

Шүүгч гэж хуульд заасан үндэслэл, журмын дагуу томилогдож, шүүгчийн тангараг өргөсөн, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа Монгол Улсын иргэнийг хэлнэ,

5 Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага OECD “Авлигатай тэмцэх гарин авлага” 2016, х. 61.

6 Transparency International (2016). NIS Assessment Toolkit. [transparency.org/files/content/ins/NIS_AssessmentToolkit_EN.pdf](https://www.transparency.org/files/content/ins/NIS_AssessmentToolkit_EN.pdf)

Шүүгчийн хараат бус байдал нь аливаа ардчилсан улсын шүүн таслах ажлын үндсэн хуулийн зарчим мөн. Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана гэж заасан. Түүнчлэн Монгол Улсын Шүүхийн тухай хуульд шүүгчийн хараат бус байдлын дараах зарчим тогтоосон байна. Үүнд:

- Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ аливаа этгээдээс хараат бус байж, гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд захирагдана.
- Шүүгчийн хараат бус байдал халдашгүй байх бөгөөд шүүгчийн хараат бус байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар баталгаажуулна (42.1, 42.2).

Мөн тус хуульд зааснаар, шүүгч дараах баталгаагаар хангагдана: 1) Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хязгаарлах, түдгэлзүүлэх, дуусгавар болгохыг хориглох; 2) шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр албан тушаалд болон өөр шүүхэд шилжүүлэх, эсхүл сэлгэн ажиллуулахыг хориглох; 3) хугацаагүй томилогдож, захиргааны болон гуравдагч этгээдийн санаачилгаар чөлөөлөгдөхгүй, огцрохгүй, аливаа дайчилгаа болон цэргийн жинхэнэ албанд татахгүй байх; 4) шүүгчийн эдийн засгийн болон нийгмийн хангамж, халамжийн тогтолцоог энэ хууль болон бусад хуулиар бүрдүүлэх, хангах; 5) шүүгч өөрийн хүсэлтээр ахисан түвшинд

мэргэшлээ дээшлүүлэх зорилгоор хоёр жил хүртэл хугацаагаар гадаад улсад суралцах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болсон тохиолдолд ажлын байр нь хэвээр хадгалагдах (42.3.1-42.3.5). Мөн шүүгчийн хараат бус байдалд халдсан, шүүхийн үйл ажиллагаанд саад учруулсан хэн боловч хуулийн хариуцлага хүлээнэ гэж заажээ (42.5). (Ч.Э)

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ (*The General Council of Courts*)

Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах Үндсэн хуулиар тогтоосон чиг үүрэг бүхий байгууллага мөн. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Шүүхийн ерөнхий зөвлөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин дөрөвдүгээр зүйлийн 4-т заасны дагуу шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно. (Ч.Э)

ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ (*Judicial power*)

Шүүх эрх мэдэл нь шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэх бүрэн эрхийн нийлбэр цогц юм. Бие даасан шүүх эрх

мэдэлтэй байх нь аливаа ардчилсан нийгмийн нэг үндсэн шинж мөн. Учир нь шүүх гагцхүү хараат бус байж хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны жинхэнэ баталгаа болж чадна. Монгол Улсад шүүх эрх мэдлийн хараат бус байдлын Үндсэн хуулийн эрх зүйн үндэс бүрэлдсэн байдаг. Тухайлбал, Монгол Улсын шинэ Үндсэн хууль нь шүүх эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэлтэй ижил түвшинд тогтоон тунхаглаж, Үндсэн хуульд шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх бөгөөд “шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно”, “шүүх үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хариуцна”, “шүүх бие даасан шүүгч хараат бус байна”, “хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” зэрэг шүүхийн байгууламжтай холбоотой олон зарчмыг тогтоосон байдаг. Шүүх эрх мэдэл нь нэгдүгээрт, эрүү, иргэний, захиргааны зэрэг эрх зүйн маргааныг эцэслэн хянан шийдвэрлэх, хоёрдугаарт, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд хуулиар тогтоосон хэмжээ хязгаарын дотор гаднын хяналт тавьж хэрэгжүүлэх чиг үүрэгтэй. Нөгөөтээгүүр, эрх зүйн маргааныг хуулийн дагуу шийдвэрлэх замаар хүний эрх, эрх чөлөөг хангахад үнэлж баршгүй үүрэг гүйцэтгэдэгт шүүх эрх мэдлийн агуулга оршино. Өөрөөр хэлбэл, шүүх эрх мэдэл бол аливаа этгээд дур зоргоороо авирлахгүй байх, бүх хэрэг маргаан шударга ёс, зүй ёс, хуулийн дагуу шийдвэрлэгдэж байх, түүнчлэн хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох баталгаа болдог юм. (Ч.Э)



ЭДИЙН ЗАСАГЧ (*Economist*) Эдийн засагч хүн бол байгаль, нийгмийн нөөц ба түүний үйлдвэрлэл, бүтээгдэхүүний хоорондын хамаарлыг судалдаг шинжээч юм. Энэ мэргэжлийн хүн орон нутгаас эхлээд бүхэл бүтэн улс үндэстэн, тэр ч байтугай дэлхий дахины эдийн засаг, нийгмийг судалдаг. Эдийн засагч нь нөөцийг түгээн хуваарилах болон бараа бүтээгдэхүүн судлах үйлчилгээ үзүүлнэ. Мөн боловсрол, эрүүл мэнд, хөгжил болон хүрээлэн буй орчин гээд олон салбарын эдийн засгийн асуудлуудад шинжилгээ хийж, дүгнэлт гаргана. Зарим эдийн засагчид бүтээгдэхүүний үнэ, эрүүл орчин, техникийн хүчин чадлыг шинжлэх зэрэг эдийн засгийн мэргэжилтэн олон өөр чиглэлээр ажилладаг. Эдийн засагчийн мэргэжлээр суралцсан эсвэл энэ мэргэжлийн дадлага, туршлагатай мэргэжилтэн нь эконометриксийн болон тохиолдлын судалгааны арга техник ашиглан эдийн засгийн ба статистик мэдээлэл цуглуулж боловсруулалт хийж, үр дүнг шинжлэн тайлагнана. Мөн санхүү, хөдөлмөр, хөдөө аж ахуй зэрэг дагнасан салбарын эдийн засгийн болон статистикийн мэдээллийг судалж, дүгнэлт гаргана. Хууль дүрэм, төрийн байгууллагын шийдвэрээс амьдралд гарах нөлөөллийн талаар ашиг алдагдлын шинжилгээн дээр тулгуурлан шүүх болон хууль тогтоох байгууллагад

дүгнэлт өгч, зөвлөмж гаргана. Эдийн засагч хүн эдийн засгийг ойлгох, шинэ боломжийг эрэлхийлэх үүрэгтэй. Эдийн засагчийн үндсэн үүрэг бол их хэмжээний өгөгдөлд дүн шинжилгээ хийх, зах зээлийн чиг хандлагыг зөв судлах, асуудлыг шийдвэрлэх компаниудын бодлогыг боловсруулах, эдийн засгийн бодлогыг боловсруулах явдал юм. Эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн байхаас гадна ажил үүргийн хүрээндээ эдийн засгийг макро микро түвшинд судлах эсвэл эдийн засгийн тодорхой хүрээнд гарсан өөрчлөлт, хөгжлийг судална. (А.Э.ц)

ЭДИЙН ЗАСГИЙН ЗАСАГЛАЛ (*Economic governance*) Улс орны эдийн засгийг удирдахын тулд засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого болон төрийн зохицуулалтын арга хэрэгслийн нийлбэр цогцыг хэлнэ. Энэ хүрээнд макро эдийн засгийн удирдлага болон микро эдийн засгийн зохицуулалтын арга хэрэгсэл багтдаг. Макро эдийн засгийн удирдлага нь нийт эдийн засгийн түвшинд тогтвортой байдлыг хангах, ялангуяа ажил эрхлэлт болон инфляцыг зохицуулах, эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэсэн бодлого ба институт юм. Микро эдийн засгийн удирдлага нь пүүс компанийн үйл ажиллагаа явуулах орчныг тодорхойлж буй дүрэм журмын нийлбэр. Энд үйл ажиллагааны

тусгай зөвшөөрлөөс эхлэн бизнес эрхлэхтэй холбоотой төрөөс тавьж буй аливаа шаардлага багтах бөгөөд бизнес эрхлэхэд дөхөмтэй байдлыг илэрхийлдэг. Мөн пүүсийн түвшин дэх корпорацийн засаглалын асуудал үүнд хамаарна. Эдийн засгийн засаглал нь “сайн засаглал”-ын нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд эдийн засгийн бүхий л үйл ажиллагааг удирдан чиглүүлэх ерөнхий хүрээ (general framework) юм. Энэ нь төрийн (нийтийн) болон хувийн хэвшлийн үйл ажиллагаанд аль алинд нь чухал нөлөөтэй. Төрийн эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлого болон тэдгээрийг хэрэгжүүлдэг төрийн байгууллагууд нь нээлттэй, ил тод, тогтвортой байснаар төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэж, эдийн засгийн өсөлт болон урт хугацааны хөгжлийг хангах боломжтой. Нөгөө талаас, пүүс компаниудын засаглал нь мөн нээлттэй, ёс зүйтэй, ил тод байснаар хэрэглэгч болон оролцогч талуудын итгэлийг олж, үр ашгийг хангах боломжтой юм. (Ч.Н)

ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛ (*Economic theory*) Эдийн засгийн ухааныг дотор нь судалж буй зүйлээс нь хамааруулан микро, макро эдийн засгийн ухаан гэж хоёр үндсэн хэсэгт хувааж үздэг боловч өрх гэр, аж ахуйн нэгж, төр хамтдаа нийлж эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэх учраас макро, микро эдийн засгийг тус тусдаа бие даасан салангид шинжлэх ухаан мэтээр ойлгож болохгүй. Микро эдийн засаг нь эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэгч өрх гэр, аж ахуйн нэгжийн түвшин дэх эдийн засгийн зүй тогтлуудыг судалдаг бол макро эдийн засаг нь эдийн засгийн тогтолцооны ерөнхий зүй тогтлуудыг судална. Өөрөөр хэлбэл макро эдийн засгийн онол нь эдийн засагт болж буй үзэгдэл, үйл явцууд тэдгээрийн хоорондын холбоо, шүтэлцээг судлан эдийн засгийн

ирээдүйн төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлж байдаг. Иймээс макро эдийн засгийг улс орны эдийн засгийг бүхэл бүтэн цогц байдлаар нь авч үзэн түүний хөгжлийн зүй тогтол, хэтийн төлөвийг судалдаг эдийн засгийн онолын хэсэг мөн гэж тодорхойлж болно. Эдийн засгийн үндсэн онол нь олон янзын ойлголтыг ашигладаг тоон эдийн засгийн загварт тулгуурладаг. Макро эдийн засгийн онолын үндсэн урсгал, үзэл баримтлалын хувьд аваад үзвэл 1) сонгодог онол, 2) Кейнсийн онол, 3) Шинэ сонгодог онол, 4) Шинэ Кейнсийн онол гэж хувааж авч үздэг.

1. Сонгодог онол. Энэ онол нь 1770-аад оны дунд үеэс үүссэн бөгөөд гол төлөөлөгчид нь английн эдийн засагч Адам Смит, Давид Рикардо нар юм. Сонгодог онолын үндсэн үзэл баримтлал нь:
 - Эдийн засаг нь үл үзэгдэгч гар буюу зах зээлийн механизм болох бараа бүтээгдэхүүний үнэ, зээлийн хүү, цалин зэргээр зохицуулагдана. Үнэ, зээлийн хүү, цалингийн өөрчлөлтүүд нь хэрэглэгч, пүүсүүдэд ямар шийдвэр гаргах талаар дохио өгч байдаг.
 - Үнэ, зээлийн хүү, цалингийн уян, хатан байдал нь төрийн оролцоогүйгээр эдийн засгийг зохицуулж тэнд үүссэн сөрөг үзэгдлүүдийг шийдвэрлэж чадна гэж үздэг.
2. Кейнсийн онол. 1930-аад оны дундуур Английн нэрт эдийн засагч Джон Майнорд Кейнс өөрийн алдарт бүтээл “Хөдөлмөр бүрэн эрхлэлт ба хүү мөнгөний ерөнхий онол” гэсэн номондоо анх төрийн зохицуулалт бүхий зах зээлийн тогтолцооны онолын үндэслэлийг боловсруулан тавьсан. Уг онол нь: Үнэ, зээлийн хүү, цалин зэрэг нь

удаан өөрчлөгддөг уян хатан бус шинжтэй тул зах зээлийг бүрэн зохицуулж чадахгүй. Иймээс Засгийн газар өөрийн зардал, татварын хэмжээг өөрчлөн нийт эрэлтэд нөлөөлөх замаар эдийн засагт зохицуулалт хийх нь ихээхэн үр ашигтай гэж үздэг. Кейнсийн онол 1930-аад оны дунд үеэс 1970-аад он хүртэл нилээд давамгайлах шинжтэй байсан.

3. Шинэ сонгодог онол. Энэ онол нь 70-аад онд үүссэн бөгөөд гол төлөөлөгчид нь Милтон Фридман, Роберт Барро, Роберт Лукас нар юм. Уг онол үнэ, зээлийн хүү, цалин зэрэг нь уян хатан шинжтэй хэдий ч эдийн засгийн өөрчлөгдөж буй нөхцөл байдалд тэр бүр хурдан дасан зохицож чаддаггүй нь мэдээллийн тархцын хурд, нийгмийн зан заншил зэрэгтэй холбоотой. Харин эдийн засгийн субъектууд нь боломжтой бүх мэдээллийг ашиглан ирээдүйн талаар хамгийн зөв таамаглал гарган өөрчлөгдөж буй нөхцөл байдалд хурдан зохицож чаддаг. Иймээс төр эдийн засагт оролцох нь эдийн засгийн байдлыг муутгана гэж үздэг.

4. Шинэ Кейнсийн онол. Энэ онол нь 1980-аад онд үүссэн бөгөөд гол төлөөлөгчид нь Георги Акерлот, Грегори Мэнькю, Дэвид Ровер юм. Уг онол үзэхдээ эдийн засгийн субъектууд өөрсдийн эрх ашиг, сонирхлыг дагаж байдаг ч үнийн өөрчлөлттэй зохицон байхын тулд гаргах зардлууд нь эргээд үнийн түвшинг уян, хатан бус байдалд хүргэдэг. Иймээс үнийн механизм нь эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, зохицуулж чаддаггүй. Харин ч эдийн засгийн мөчлөгийн шалтгаан болдог. Ийм нөхцөлд

төр эдийн засгийг үр ашигтай ажиллуулах боломжтой гэж үздэг.

Эдгээр онолын урсгалууд нь үүссэн цагаасаа эхлэн өнөөг хүртэл бие биенийгээ устгаж үгүй хийгээгүй харин ч нэг нэгнийхээ сул талыг нөхөн хамтран оршиж ирсэн билээ. (А.Э)

ЭДИЙН ЗАСГИЙН ОРОЛЦООТОЙ ӨСӨЛТ (*Inclusive growth rate*)

Хүртээмжтэй оролцоотой өсөлт гэдэг нь хамгийн ерөнхий байдлаараа эдийн засгийн өсөлтийг бий болгоход хүмүүсийг өргөнөөр оролцуулж, уг өсөлтийн үр дүнгээс иргэд өргөнөөр хүртэж байдаг тийм өсөлтийг хэлдэг байна (Elena Ianchovichina and Susanna Lundstrom, Leonard Garrido, 2009). Хүртээмжтэй өсөлтийн гол шинж тэмдэг нь өсөлт урт хугацаанд тогтвортой байхын зэрэгцээ ядуурлыг мэдэгдэхүйц бууруулсан (pro- poor growth), эдийн засгийн олон салбарыг хамарсан “өргөн суурьтай” (broad based), өсөлтийн үр дүнг “хуваалцсан” (Shared growth), өсөлт нь улс орны ажиллах хүчний ихэнх хэсгийн хамруулсан байхын зэрэгцээ “бүтээмжтэй ажил эрхлэх” боломжийг хүн амд олгосон байх ёстой гэж үздэг. Ийм нөхцөлд бий болсон өсөлтийг л хүртээмжтэй өсөлт гэж ойлгодог. Хүртээмжтэй өсөлтийн энэхүү тодорхойлолт нь эдийн засгийн макро болон микро түвшний өсөлтийг тодорхойлогч хүчин зүйлүүдтэй шууд холбоотой гэж үздэг. Микро түвшинд энэхүү ойлголт нь эдийн засгийн салбаруудын төрөлжилтөд хүргэх бүтцийн өөрчлөлт, өрсөлдөөн, шинэ ажлын байр болон бизнесийн нэгжүүд олноор бий болох асуудлыг багтаадаг. Хүртээмжтэй өсөлтийн ойлголт нь эдийн засгийн өсөлтийн зөвхөн хурдыг төдийгүй, өсөлтийн хэв шинж, бүтцийг хамтад нь авч үздэг. Дэлхийн банкны “Өсөлт ба Хөгжлийн Комисс”-оос 2008

онд гаргасан “Growth Report: Strategies for Sustained Growth and Inclusive Development” илтгэлд хүртээмжтэй өсөлтийн гол үзэл баримтлалыг тэгш хамруулах (encompasses equity), тэгш боломж (equality of opportunity), зах зээл болон ажил эрхлэлтийн шилжилт өөрчлөлтийг дэмжсэн байх нь үр ашигтай өсөлтийн стратегийн гол бүрэлдэхүүн хэсэг гэж тэмдэглэжээ. Хүртээмжтэй өсөлтийн ойлголтыг ашигт малтмалын нөөц баялагтай орнуудын хувьд судлаачид онцгойлон авч үзсэн байна. Олборлох аж үйлдвэр нь ажиллах хүчийг олноор нь ашигладаггүй бөгөөд энэ салбар хурдацтай өсөж байхад Голланд өвчин газар авч, эдийн засгийн бусад секторууд нь уналтад ордог тул хүртээмжтэй өсөлтийн эдийн засгийн олон салбарыг хамарсан “өргөн суурьтай” (broad based) байх шаардлагыг хэрхэн хангаж байгааг судлах зорилгоор эдгээр секторуудын өсөлтийг тусгайлан судлах шаардлагатай гэж үздэг. (А.Э)

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ (*Growth of economy*) Эдийн засгийн өсөлтийг эдийн засгийн тодорхой хугацаанд үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээний инфляцад тохируулсан зах зээлийн үнэлгээ өссөн гэж тодорхойлж болно. Эдийн засгийн өсөлтийг ДНБ-ний өсөлтийн хувь буюу бодит ДНБ-ээр хэмждэг. Өсөлтийн эдийн засаг нь тухайн эдийн засагт өсөлт, тухайн улсын нэг хүнд ногдох бүтээгдэхүүний орт хугацаан дахь өсөлтийг бий болгож буй хүчин зүйлсийн талаар судалдаг. Зарим хүчин зүйлсийн хувьд улс орнуудын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний ялгаатай түвшнүүд, зарим улс яагаад эдийн засгийн өсөлт нь илүү хурдан байдаг шалтгаан, ижил түвшний өсөлтөөр улс орнууд нэгийгээ гүйцэх боломж зэргийг судалдаг байна. Эдгээр дотроос хамгийн их судлагдсан хүчин зүйлс нь

хөрөнгө оруулалтын түвшин, хүн амын өсөлт болон технологийн өөрчлөлт юм. (А.Э)

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ (*Economic development*) Төрийн захиргааны салбарын эдийн засгийн судалгаанд эдийн засаг, нийгмийн хөгжил гэдэг нь тухайн улс, бүс нутаг, орон нутгийн иргэд эсвэл хувь хүний эдийн засгийн сайн сайхан байдал, амьдралын чанарыг дээшлүүлэх үйл явцыг зорилт, зорилгын дагуу тодорхойлдог. Энэ нэр томьёо нь XX, XXI зууны үед байнга хэрэглэгддэг байсан боловч барууны орнуудад энэ ойлголт хамаагүй удаан оршин тогтнож байжээ. “Модернизаци”, “Баруунчлал”, ялангуяа “үйлдвэржилт” гэдэг нь эдийн засгийн хөгжлийн талаар ярилцаж байх үед хэрэглэгддэг бусад нэр томьёо юм. Эдийн засгийн хөгжил гэдэг нь хүмүүсийн сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогын оролцоо байдаг бол эдийн засгийн өсөлт нь зах зээлийн бүтээмж, ДНБ-ий өсөлтийн үзэгдэл юм. (А.Э)

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ (*Economics rights*) Хөдөлмөрлөх, ажил хөдөлмөрөө чөлөөтэй сонгох, хөдөлмөрлөх эрхийнхээ төлөө ажил олгогчтой нөхцөлөө тохиролцох, хөдөлмөрийн ая таатай нөхцөлөөр хангуулах, амьжиргаандаа хүрэлцэхүйц цалин хөлстэй байх, зарцуулсан хөдөлмөртөө тохирох цалин хөлс авах зэрэг амьдралд зайлшгүй шаардагдах нөөцийг бүрдүүлэх, зарцуулахтай холбоотой хүний анхдагч эрхийг эдийн засгийн эрхэд тооцдог. Мөн эвлэлдэн нэгдэх эрхийг эдийн засгийн эрхэд хамруулдаг. НҮБ-аас баталсан эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактад эдийн засгийн эрхэд хамаарах цалин хөлсийг шударгаар тогтоох, аливаа ялгаваргүйгээр адил үнэлгээтэй хөдөлмөрт тэгш цалин хөлс

олгох, эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс доргүй хөдөлмөрлөх нөхцөлийг бий болгох, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон ажлын нөхцөлийг бүрдүүлэх, ээлжийн амралтыг цалин хөлстэйгөөр эдлүүлэх, баярын өдөрт цалин хөлс олгох зэрэг заалтуудыг тусгасан байдаг¹. (Б.Б)

ЭЭРЭГ МАНЛАЙЛАЛ (*Positive leadership*) Эерэг манлайлал бол манлайллын харьцангуй шинэ хандлага бөгөөд ажиллагчид эерэг орчинд ажиллаж байхдаа илүү аз жаргалтай, илүү үр бүтээлтэй ажилладаг гэсэн ойлголтод суурилдаг. Эерэг манлайлал нь нийтлэг ёс суртахуун, үнэт зүйлс, зан чанарыг төлөвшүүлж, алсын харааг өөрчилж, бусадтай эерэг харилцаа тогтоож, үр дүнг тасралтгүй бий болгохын тулд эерэг сэтгэл хөдлөлөөр дүүрэн байгууллагын уур амьсгалыг бүрдүүлдэг, ажиллагсдын сайн сайхан байдал, тогтвортой гүйцэтгэлийн түвшинг дээшлүүлдэг манлайлал. Эерэг манлайллын мөн чанар нь ажиллагсдын хувийн зан чанарыг өөрчлөхөд бус үзэл бодол, хүрээг өөрчлөхөд оршино. Эерэг манлайлал нь хүмүүсийг нийтлэг зорилгын хүрээнд нэгтгэж, бүх оролцогч талуудад үнэ цэнийг бий болгохын тулд тэднийг алхам алхмаар удирдан чиглүүлэх боломжийг олгодог. Эерэг манлайллын алсын хараанд багтдаг гол элементүүд ‘амлалт, зориг, нэр төр, эрүүл хяналт, сонголт, шийдвэр, хүсэл эрмэлзэл, хариуцлага, эрх чөлөө, сорилт, хувийн үнэлэмж, жинхэнэ хамт олон, харилцаа холбоо, идэвх, нийгмийн дэмжлэг, итгэл’ гэж үздэг.² Blanch болон бусад эрдэмтэд (2016) нар эерэг манлайллыг

гурван бүрэлдэхүүн хэсэгт ангилж үзсэн³. Үүнд

1. Ажиллагсдын чадавхыг илэрхийлж буй давуу тал, ур чадварт анхаарлаа төвлөрүүлэх;
2. Үр дүнг үнэлэн ажилтны болон байгууллагын гүйцэтгэлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

Ажиллагчдын нөхцөл байдалд чухал ач холбогдолтой бүрэлдэхүүн хэсгүүдэд төвлөрөн ажиллах; (3.А)

ЭЭРЭГ НӨЛӨӨЛӨЛ БҮХИЙ ЗАХИРГААНЫ АКТ (*Positive administrative act [regulation]*) Эрх зүйн үйлчлэл чиглэсэн этгээдэд эрх олгосон, эсхүл ашигтай нөхцөл байдлыг бий болгосон захиргааны актыг эерэг нөлөөлөл бүхий захиргааны акт гэнэ (ЗЕХ-ийн 37.5). Захиргааны актаар тухайн этгээдийн эрх зүйн байдал дээрдсэн тохиолдолд эерэг нөлөөлөл бүхий захиргааны акт болно. Тухайлбал захиргааны акт нь үйлчлэл чиглэсэн этгээдэд эрх зүйн томоохон давуу тал үүсэх үндэслэл болох, эрх олгох явдлыг үүнд хамааруулна. Уг заалт ёсоор эрх зүйн байдлыг тодорхойлох захиргааны акт ч эерэг нөлөөлөлтэй байж болно. Жишээ нь, хэрэв захиргааны байгууллага Монгол Улсын иргэн мөн эсэх дээр нэг хүнтэй санал зөрөлдсөн тохиолдолд эрх бүхий байгууллагаас тухайн хүнийг Монгол Улсын иргэн мөн болохыг гэрчилсэн тодорхойлолт олгох нь чиглэж буй иргэний хувьд эерэг нөлөөлөл бүхий захиргааны акт болно.⁴ (Ч.Э)

ЭЗЭН АГЕНТЫН АСУУДАЛ (*Principle agent problems*) Өмчийн эзэн ба гэрээний үндсэн дээр ажилладаг, өмчийг захиран зарцуулах эрхтэй

1 Монгол Улсын олон улсын гэрээ, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, <https://legalinfo.mn/mn/detail/1284>

2 Lloyd, P. J., & Atella, M. D. (2000). Positive leadership that inspires: Theoretical and empirical perspectives from positive psychology, existential theory, and hardiness research. *The Psychologist Manager Journal*, 4(2), pp. 155–165.

3 Blanch, J., Gil, F., Antino, M., & Rodriguez-Mucoz, A. (2016). Positive leadership models: Theoretical framework and research. *Psychologist Papers*, 37(3), pp. 170–176.

4 Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, Улаанбаатар, 2017, х. 180–181.

этгээд (агент)-ийн хооронд үүсдэг асуудлыг эзэн-агентын асуудал гэдэг. Нэг талаас өмчийн эзэн төлөөлөгч (агент)-ийг эзний ашиг сонирхлын төлөө ажиллана гэсэн хүлээлттэй байдаг боловч төлөөлөгч эзний эрх ашигт нийцсэн шийдвэр гаргах албагүй гэж үздэг. Энэхүү эрх мэдэл, мэдээллийн тэгш бус байдал нь эзэн ба төлөөллийн харилцаанд асуудлыг үүсгэдэг ба харилцаа нь гэрээ, хэлцлээр зохицуулагдана. Төрийн өмч, төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах үүрэгтэй захиргааны менежер болон иргэдийн эрхийг төлөөллөөр хэрэгжүүлж байгаа төлөөлөгчид нь иргэдийг төлөөлөхдөө гаргаж байгаа зан үйл, түүнтэй холбоотой зөрчлийг эзэн-агентын асуудлаар тайлбарладаг. Эзэн агентын харилцаанд үүсэх асуудлыг шийдвэрлэх гарц нь хяналтын оновчтой тогтолцоо бүрдүүлэх, үйл ажиллагааг нээлттэй болгох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга гэж үздэг. (Б.Б)

ЭЛЭГДЭЛ, ЭЛЭГДЛИЙН ЗАРДАЛ (*Depreciation, Depreciation cost*) Урт хугацаанд ашиглагдах боломжтой аливаа хөрөнгийн мөнгөөр илэрхийлсэн үнэ цэнэ нь ашиглалтын явц, хэрэглээний байдал, эдэлгээний боломжит хугацаа, технологийн нөхцөл зэргээс шалтгаалж буурч байдаг. Энэхүү үнэ цэнийн бууралтыг элэгдлээр хэмжинэ. Иймд элэгдэл гэдэг нь биет ба биет бус хөрөнгийн нийт өртгийг ашиглах жилийн туршид хуваарилах нягтлан бодох бүртгэлийн арга юм. Элэгдлийн зардал нь хөрөнгийг ашиглахтай холбоотой тухайн тайлангийн хугацаанд тооцогдсон элэгдлийн дүн юм. Элэгдлийг тооцох аргуудаас байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлог, санхүү, татварын эрх зүйн орчны зохицуулалтад нийцүүлэн сонгож хэрэглэх боломжтой. Үйл

ажиллагааны үр дүнгийн хэмжилтийг оновчтой байлгах үүднээс элэгдэл тооцох тохирох аргыг сонгож мөрдөх хэрэгцээ үүснэ. Элэгдэл тооцох шулуун шугамын, үйл ажиллагааны буюу бүтээгдэхүүний нэгжид ногдуулах, ашиглах жилүүдийн нийлбэрийн, үлдэгдлийг бууруулах ба элэгдэл тооцох тусгай гэсэн аргуудыг түгээмэл хэрэглэдэг. (Б.Б)

ЭНГИЙН ХУВЬЦАА (*Common share*)

Компанид хөрөнгө оруулж хувь эзэмшиж байгааг нотлох үнэт цаас бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг хүртэх эрхтэйг нотолдог. Хувьцаа эзэмшсэний дараа үүсэх эрх үүргийн ялгаанаас хамаарч энгийн ба давуу эрхтэй хувьцаа гэж ялгадаг. Энгийн хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож хэлэлцэж буй бүх асуудлаар саналаа өгөх саналын эрхтэй, компанийн ашгаас хамаарч ногдол ашиг хүртэх эрхтэй. Харин давуу эрхтэй хувьцаа эзэмшигч нь түрүүлж орлого хүртэх боломжтой буюу тогтмол эсвэл тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах эрхтэй. (Б.Б)

ЭППЛЕБИ, ПОЛ (*Appleby, Paul.H. 1891-1963*)

Захиргааны ухааны нэрт эрдэмтдийн нэг. 1912 онд Гриннел коллежийг төгссөний дараа олон жил сэтгүүлчээр ажиллажээ. 1933-1947 он хүртэл төрийн албанд ажилласан байна. 1947 онд Сиракусын Их сургуулийн иргэний болон төрийн асуудлын сургуулийн декан болсон байна. Энэ үеэс эхлэн урьд өмнө хийж байсан судалгааныхаа ажлыг үргэлжлүүлэн олон ном бичсэн байна. (Big Democracy, 1945, Policy and Administration, 1949, Public Administration in India: A Report of a Survey, 1953, Re-examination of India's Administrative System, 1956, Public Administration of a Welfare

State, 1961, Citizens as Sovereigns, 1962, Morality and Administration in Democratic Government, 1969). Захиргааны албан хаагчид бодлогод оролцох нь ардчилсан нийгэмд ч зохистой зүйл юм гэж үзэж байсан байна. Тэрбээр захиргааны албан хаагчид нь бодлогод нөлөөгүй бөгөөд зөвхөн хэрэгжүүлэгчид байдаг гэсэн үзлийг шүүмжилж, захиргааны албан хаагчид нь хуулийн төсөл боловсруулах, бодлого гаргагчдад зөвлөх зэргээр бодлогод нөлөө үзүүлдэг болохыг нотолж байжээ. Нийтийн захиргааны ажил бол бодлого гаргах явдал ч бас мөн гэж бичиж байжээ. (А.Ц)

ЭРГЭЛТИЙН САН (*Revolving fund*)

Нэгээс дээш төсвийн жилд үргэлжлэх үйл ажиллагааг тогтоосон зориулалт, зарчмын дагуу санхүүжүүлж тухайн үйл ажиллагаанаас олсон орлогыг эргэн сандаа төвлөрүүлэх, хөрөнгийн эргэн төлөлтөөр дахин санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлдэг тусгай дансыг эргэлтийн сан гэдэг. Төрийн ба бизнесийн аль ч салбарын байгууллага, улсын ба орон нутгийн төсөвт эргэлтийн санг ашиглаж болно. Эргэлтийн сан байгуулах нь урт хугацаанд хэрэгжих төсөл, хөтөлбөр, төрийн бодлогын хувилбарыг тогтвортой хэрэгжих гол нөхцөл болсон санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлдгээрээ ач холбогдолтой. (Б.Б)

ЭРГЭН ТӨЛӨГДӨХ ЗЭЭЛ (*Payable loan*)

Аливаа үйл ажиллагаа, хэрэгцээний санхүүжилтийг санхүүгийн байгууллага, иргэнээс тодорхой хугацаа, хүүтэй, эргэн төлөх нөхцөлтэйгөөр авахыг зээл гэнэ. Санхүүгийн тайлангийн хугацааны эцэст зээлийн тодорхой хэсэг төлөгдөөгүй байгаа бол энэхүү үлдэгдлийг эргэн төлөгдөх зээл гэж нэрлэнэ. Эргэн төлөгдөх зээл нь

тайлагнасан хугацаанаас хойш нэг жилийн хугацаанд төлөгдөх нөхцөлтэй бол богино хугацааг өр төлбөрийн ангилалд хамаарна. Зээлийн эргэн төлөгдөх хугацаа урт тохиолдолд зээлийн хүү өндөр, бусад нөхцөл хатуу байх хандлагатай. Зээлийн гэрээнд эргэн төлөгдөх хугацаа, эргэн төлөх хэлбэр, тооцох хүү зэрэг нөхцөлийг тусгах ба урт хугацаанд эргэн төлөх тохиолдолд инфляцын хүлээлт зэрэг ирээдүйн эрсдэлийг харгалзан зээлийн хүүг өндөр тогтоох ба эргэн төлөгдөх бусад нөхцөлийг ч хатуу тогтоодог. (Б.Б)

ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛГҮЙ ОЛГОСОН САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ (*Non-repayable financial support*)

Эргүүлэн төлөх нөхцөл, үүрэг хүлээлгэлгүйгээр олон улсын байгууллага, хандивлагчдаас олгож байгаа хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, техник тусалцааны хэлбэрээр олгосон хөрөнгийн эх үүсвэр. Түүнчлэн Засгийн газрын тусгай санд улсын төсвөөс урсгал зардал, хөрөнгийн зардлыг санхүүжүүлэх зориулалттай эргэн төлөгдөх нөхцөлгүй төвлөрүүлсэн хөрөнгийг мөн энэ төрлийн эх үүсвэрт оруулж тооцдог. Эргэн төлөгдөх нөхцөлгүй олгосон эх үүсвэрийг ихэвчлэн нийгмийн салбарын төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулна. (Б.Б)

ЭРДЭС БАЯЛГИЙН БУС ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН (*Non-mining GDP*)

Улсын хил хязгаар дотор, уул уурхайн салбараас бусад салбарт санхүүгийн жилийн хугацаанд үйлдвэрлэгдсэн нийт бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлийн үнээр илэрхийлсэн дүн буюу бүтээсэн нэмүү өртгийн хэмжээг хэлнэ. Уул уурхайн салбараас хамааралтай эдийн засгийн хувьд уул уурхайн

болон бусад салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засгийн өсөлтөд оруулах хувь нэмрийг ялгаж тооцох нь ач холбогдолтой бөгөөд баялгийн ашиглалтаас бий болох хуримтлал бусад салбарын өсөлтөд хэрхэн нөлөөлж байгааг дүгнэхэд ашиглагдана. Уул уурхайн үйлдвэрлэл голлосон эдийн засаг бүхий улс орны хөгжлийн түвшинг хэмжихэд эрдэс баялгийн бус Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт чухал ач холбогдолтойд тооцдог. (Б.Б)

ЭРСДЭЛ (Risk) Тодорхойгүй нөхцөл байдлаас үүдэлтэй үйл явдлын урьдчилан тооцоолоогүй сөрөг үр дагаврыг эрсдэл гэнэ. Эрсдэлийг аливаа үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны зүгээс нөлөөлөх тааламжгүй нөлөөлөл, аливаа нэг үзүүлэлтийн хүлээгдэж буй болон бодитой үр дүнгийн зөрүү, тааламжгүй, хүлээгээгүй үр дүнд хүрэх магадлал гэх зэргээр тодорхойлдог. Энэхүү үзэгдлийн сөрөг үр дагавар болон түүний тохиох магадлалаар эрсдэлийг хэмждэг. Үйл ажиллагаа явуулж буй салбарын онцлогоос үүдэлтэй эрсдэл, санхүүжилтийн чадварыг илтгэх зээлийн эрсдэл, хууль зүйн, байгаль орчны аюулгүй байдал, эрүүл ахуйн, нэр хүнд, ёс зүйн болон санхүүгийн хэрэгслийн, төлбөрийн чадварын зэрэг эрсдэлийн хэлбэрүүд байна. Эрсдэлийг бууруулах, хүлээн авах, шилжүүлэх, зайлсхийх зэрэг эрсдэлийн удирдлагын аргыг нөхцөл байдалдаа тохируулан хэрэглэдэг. (Б.Б)

ЭРСДЭЛИЙН ЗАСАГЛАЛ (Risk governance) Эрсдэлийн удирдлага нь засаглалын тогтолцооны чухал бүрдэл хэсэг. Эрсдэлийн засаглал нь үнэт зүйлс, төвлөрсөн бус эрх мэдлийн хүрээнд эрсдэлийг удирдах засаглалын зарчмуудыг хэрэгжүүлдэг.⁵

‘Эрсдэлийн засаглал’ нь эрсдэлийн асуудлыг зохицуулах, бууруулах, хянах бүлэг, нийгэм, олон улсын хамтын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, хязгаарладаг институцийн бүтэц, бодлогын үйл явцыг аль алиныг нь илэрхийлдэг ойлголт.⁶ Эрсдэлийн засаглал нь эрсдэлийн менежментэд оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг, удирдлагын шийдвэр гаргах найдвартай үндэслэлийг бүрдүүлэхийн тулд холбогдох эрсдэлийн мэдээллийг цуглуулах, эрсдэлийг тодорхойлох, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, мэдээлэх үйл явцыг тодорхойлдог. Эрсдэлийн засаглал нь нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчин, одоо байгаа болон шинээр гарч ирж буй технологи, аюулгүй байдал, санхүү зэрэг бусад олон асуудлуудыг хамардаг. Шийдвэр гаргагчид холбогдох үр өгөөжийг хуртэхийн тулд эрсдэл бүхий шийдвэр гаргах тохиолдол цөөнгүй. Учир нь технологийн инновац, нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал нөлөөтэй шийдвэр, төсөл хөтөлбөр тодорхой эрсдэл дагуулдаг. Гэвч олон эрсдэл, ялангуяа шинэ технологитой холбоотой эрсдэлүүдэд тодорхой өгөөж, боломж агуулдаг. Эрсдэлийн илүү сайн засаглалыг бий болгох нь тулгарч болох эрсдэлүүд, тэдгээрийн сөрөг үр дагаврыг багасгахын зэрэгцээ хүртэх үр өгөөж, боломжийг хангах явдал юм.⁷ (З.А)

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Risk management) Болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлж, дүн шинжилгээ хийж, эрсдэлийг бууруулах/ багасгах арга хэмжээ авах. II. Эрсдэлт үйл явдлын магадлал, нөлөөллийг багасгах, хянах зорилгоор нөөцийг зохицуулж, хэмнэлттэй зарцуулж, эрсдэлийг

6 Renn, O., & Klink, A. (2013). A Framework of Adaptive Risk Governance for Urban Planning. Sustainability, 5(5), 2036-2059.

7 IRGC. (2017). An introduction to the IRGC Risk Governance Framework. Lausanne, Switzerland: International Risk Governance Center, p. 5.

5 Hopkin, P. (2017). Fundamentals of Risk Management: Understanding, evaluating and implementing effective risk management, 4th edition. Croydon: Kogan, pp. 335-338.

тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх явдал. Эрсдэл нь тодорхой бус байдлын нөлөө юм⁸. Эрсдэлийн менежмент судлаач Pfnuer (2010)-н тодорхойлсноор эрсдэл тодорхойлох, үнэлэх, хуваарилах, түүнийг бууруулах стратеги боловсруулах ба хянах үе шагуудаас бүрдэнэ⁹. Эрсдэл хуваарилалтын үе шагууд цикл хэлбэрээр орших ба төсөл хэрэгжүүлэлтийн үе шат бүрд давтамжтай байдлаар ашиглагдана. Тухайлбал төслийг бэлтгэх, төлөвлөлтийн эхний үе шатанд үүсэх эрсдэлийг тодорхойлж, үнэлж, хуваарилж, түүнийг бууруулах стратеги боловсруулж, хянаж ажиллах ба төслийн дараагийн үе шатанд эрсдэлийн менежментийн эдгээр циклүүд давтагдаж байдаг онцлогтой. Талуудын хооронд эрсдэлийг оновчтой хуваарилснаар төсөл амжилттай, үр ашигтай хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Үйл ажиллагааны үе шат бүрд эрсдэл хуваарилалтын циклийг харгалзан эрсдэлийг удирдаж ажилласнаар тухайн төсөл үр ашигтай хэрэгжих боломжийг бүрдүүлнэ. (Г.Б)

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (*Risk assessment*) Хүн амьтан, хөрөнгө нөөц, байгаль орчинд учирч болзошгүй сөрөг үр дагавар, нөлөөллийн цар хэмжээ, түүний учир шалтгаан, уг сөрөг үр дагаврын илрэх магадлалыг тооцоолохыг эрсдэлийн үнэлгээ гэдэг. Үнэлгээг хийснээр эрсдэлийг удирдах, сэргийлэх арга замаа тодорхойлно. Эрсдэлийг үнэлэхдээ тухайн системд тулгарч буй асуудал, бэрхшээлийн шалтгааныг тогтоож үр дагаврыг урьдчилан тооцох, цаашид үүсэх эрсдэлийн хохирлын давтамж, хэмжээг гаргаж эрэмбэлэх ажлуудыг оролцогч талуудын оролцоотойгоор хийнэ. Аливаа эрсдэлийн тохиолдох магадлал болон түүний үр дагаврыг

тодорхойлсноор эрсдэлийн талаарх ойлголтыг тодорхой болгох ба үүнийг бүхэлд нь эрсдэлийн шинжилгээгээр хийдэг¹⁰. Эрсдэлийн үнэлгээний үе шатанд байгууллагын зорилго, үйл ажиллагааны зохицуулалт, улс төр, ёс зүй, санхүүгийн болон бусад хүчин зүйлсийг харгалзан ирээдүйд чиглэсэн, тэнцвэрт шийдвэр гаргахад эрсдэлийг эрэмбэлнэ. Эрсдэлийн үнэлгээгээр ямар төрлийн эрсдэл, хэр цар хүрээгээр илэрч болохыг тодруулсны дараа түүнийг хэрхэн удирдах арга замаа сонгодог. Эрсдэлийг хамгийн сайн хянаж, харьцангуй боломжит бага зардлаар даван туулж чадах оролцогчид хуваарилах нь эрсдэл хуваарилалтын алтан дүрэм юм¹¹. Талуудын эрсдэлийг оновчтой хуваарилснаар аливаа төслийн анх төлөвлөсөн эдийн засгийн үр ашигт хүрэх тул эрсдэл хуваарилалт нь төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд нөлөөлдөг чухал хүчин зүйл болдог. (Г.Б; Б.Б нар)

ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ (*Risk analysis*) Эрсдэлийн шинжилгээ нь аливаа бодлого, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг нарийвчлан судлах, хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй саад бэрхшээлийг олж тогтоох, дүн шинжилгээ хийх, удирдах үйл ажиллагаа¹². Байгууллагын эсвэл системийн түвшинд эрсдэл нь холбогдох зорилгод хэрхэн нөлөөлөхийг тодорхойлохын тулд боломжтой мэдээллийг системийг ашиглах хэрэгтэй. Эрсдэлийн шинжилгээгээр тодорхойлсон эрсдэлүүдийн магадлал

10 Tokakis, Polychroniou, Boustras: 2019, "Crisis management in public administration: The three phases model for safety incidents", *Safety Science* (2019), pp. 37-43.

11 Forrer, J., Kee, J.E. and et al (2010), "Public-Private Partnerships and Public Accountability Question", *Public Administration Review*, Vol 70(3), pp. 475-484.

12 Bhatta, G. (2015). *International Dictionary of Public Management and Governance*. New York: Routledge, p. 559.

8 Хүний нөөцийн менежмент Нэр томъёо Монгол Улсын Стандарт ISO 30400:2018

9 Pfnuer, Andreas and et al. (2010) "Risikomanagement bei Public Private Partnerships", *Springer*.

ба хүлээгдэж буй нөлөөллийн тоон хэмжээг тодорхойлдог¹³. Эрсдэлийг шинжлэхдээ чанарын, хагас тоон, эсхүл тоон аргуудыг ашиглана¹⁴.

- Чанарын үнэлгээ нь үр дагавар, магадлалын хослолоор илэрхийлэгдэх “их”, “дунд”, “бага” гэсэн тодорхой түвшингүүдээр эрсдэлийн түвшин, магадлал, үр дагаврыг тодорхойлж, чанарын шалгуураар эрсдэлийн түвшинг үнэлнэ.
- Хагас тоон аргад үр дагавар, магадлал ба тэдгээрийн хослолоор томьёо ашиглаж эрсдэлийн түвшинг тодорхойлдог тоогоор зэрэглэсэн хэмжигдэхүүнийг ашигладаг.
- Тоон шинжилгээний аргаар үр дагавар ба түүний магадлалын бодит хэмжээг тооцоолох ба нөхцөл байдлыг тодорхойлох үед тогтоосон тусгай нэгжээр эрсдэлийн түвшингийн хэмжээг гаргана.

Шаардлагатай нарийвчлалын түвшин нь шийдвэр гаргах хэрэгцээ, шаардагдах мэдээллийн бэлэн байдал, хэрэглэх нөхцөл байдлаас хамаарна. Зарим аргууд болон шинжилгээний нарийвчлалын түвшинг хууль, дүрмээр тодорхойлж өгч болно. (З.А)

ЭРТНИЙ МОНГОЛ УГСААНЫ УЛСУУДЫН ТӨР, ЗАХИРГАА (*Administration in early Mongolian states*)

Хүннү гүрний дараа Монгол нутагт байсан Сяньби, Жужан улсуудын төр захиргааны зохион байгуулалт, бүтэц ч Хүннүгийн уламжлалыг дагасан бололтой. Сяньбийн төр, захиргааны зохион байгуулалтын

талаар сурвалж бичигт тэмдэглэгдсэн мэдээ хомс боловч Сяньбийг нэгдсэн төр улс болгосон Тяньшихуай хааны үед нутгаа мөн зүүн, төв, баруун гэсэн гурван хэсэгт хувааж байжээ. Тэдгээр нь дотроо аравтын системээр зохион байгуулагдсан нэгжүүд байсан бололтой байдаг. Төв хэсгийг хаан өөрөө, баруун, зүүн гарыг толгойлогч, их толгойлогч нар захирдаг байжээ. Түүнчлэн Тяньшихуай хаан хууль зохион хэрэг, явдлыг шүүдэг байсан тухай дурджээ. Жужан Улсыг “хутугтай”, “зөв”, “тэнгэрийн” гэх мэт цолтой хаад захирдаг байжээ. Улсаа мөн аравтын системээр зохион байгуулдаг байжээ. Хаан чухал хэргийг заримдаа том түшмэдүүдийн элэлдээнээр, ихэнхдээ өөрөө гаргадаг байжээ. Хааны дараагаар ордог байсан том тушаалтан бол төрийн сайд буюу госян байжээ. Жужан Улс хэв хуультай байсан гэж судлаачид үздэг боловч Г.Сүхбаатар тэр үед бичиг үсэгтэй болж зурхай, тооны ухаан, гадаад хэл мэддэг эрдэмт сайдтай байсан болохоор хуулиа ч бас бичсэн байж болно хэмээн үзсэн байна. Жужаны хаад бурхны шашны шүтдэг, улсын багш тодруулж хувь иргэн оноон өгч байжээ. Мөн хаан бүр “Ашид амгалан” (464-485), “Машид түвшин” (485-491), “машид тайван” (492-506) гэх мэт оны цолтой байжээ. Г.Учидагийн үзэж байгаагаар монгол угсааны улсууд 240 оноос өмнө хаанаа хаан хэмээн нэрлэх болсон ажээ. (А.Ц)

ЭРТНИЙ ХЯТАДЫН ЗАХИРГАА (*Administration in ancient China*)

Хятад Улс бол захиргааны эртний бөгөөд баялаг уламжлалтай улс юм. Захиргааны эх үүсэл бүр Шан (Инь) улсын үед, н.т.ө. ХУ-ХI зууны үед тавигдсан гэдэг. Хятадын захиргааны онцлог бол түүхийнхээ бүх үед төвлөрлийг хүчтэй болгоход чиглэж иржээ. Газрын том эзэд нэг хэсэгтээ

13 Hopkin, P. (2017). *Fundamentals of Risk Management: Understanding, evaluating and implementing effective risk management, 4th edition*. Croydon: Kogan Page, pp. 143-144.

14 СХЗҮЗ. (2011). *Эрсдэлийн менежмент – Эрсдэлийн үнэлгээний арга*. Улаанбаатар: Стандартчилал, хэмжил зүйн үндэсний зөвлөл, х. 8.

хааны захиргаанд, дуулгавартай байгаад аажмаар тухайн орон нутагтаа бүрэн эрхтэй “жижиг хаад” маягтай болж төвөөс зугтах хүч үйлчилж эхэлдэг байна. Түүний нөгөө талаар үе үе ардын бослого гарч, улс орон хямардаг байжээ. Төвлөрлийг хүчтэй болгох гол арга нь газрыг хааны мэдэлд авах явдал байжээ. Улс орныг тойрог, эсхүл муж болгон хувааж, тэдгээрийг дотор нь жижиг нэгжүүд болгон хуваадаг байжээ. Газар, ус зэргийг орон нутагт хааны нэрийн өмнөөс зохицуулахын тулд шатлал бүхий захиргааны том аппаратыг байгуулж иржээ. Жишээ нь, Чжоу Улсад (н.т.ө. XI-III зуун) “тэнгэрийн хүү” хэмээн зарладаг хаан бүх эрх мэдлийг төвлөрүүлж байжээ. Түүний шадар, цай, шаньфу гэсэн том албан тушаалтнууд хааны хүсэл зоригийг хэрэгжүүлэх хаанд үйлчлэх үүргийг гүйцэтгэдэг байжээ. Төрийн аж ахуйн үйл ажиллагаа, ой, ус, бэлчээр зэрэг тусгай асуудал хариуцсан албан тушаалтнууд байдаг байжээ. Орон нутагт тойрог бүрээ захирсан чжухоу хэмээх албан тушаалтнууд байдаг байжээ. Хан Улсын үед захиргааны аппарат бүр томорч, тодорхой ажлыг нэг хүн бус, бүхэл бүтэн алба хариуцах болжээ. Эхлээд бүр н.т.ө. 4 –р зууны үед цэргийн болон сангийн асуудал хариуцсан албад гарч иржээ. Түүнчлэн цензурын алба үүссэн байна. Хятадын захиргааны уламжлалд хэд хэдэн онцлог бий. Түүний нэг нь төрийн албан хаагчдыг сургаж бэлтгэдэг, шалгаж ажилд авдаг явдал юм. Тухайлбал, н.т.ө. 124 онд дээд тушаалын түшмэдүүдийг бэлтгэх зориулалттай Хааны академи байгуулагдсан ба түүнийг Дээд бөө хариуцдаг байжээ. Түүнчлэн төрийн төвлөрөл, ёс зүй зэргийг Күнзийн болон Даосын үзэлтнүүд оюун санааны талаас нь үндэслэж зөвтгөж, эсвэл шүүмжилж ирсэн нь онцлог юм. Үүнд магадгүй хятадын төрт ёсны нэг нууц

буй хэмээн үзэж болох юм. Хятадын төрийн төвлөрөл, захиргааны хөгжил Умард Хятадад байсан Цин Улсын үед улам хүчтэй болсон ажээ. Хятадын захиргааны эрх мэдлийг төвлөрүүлдэг, захиргааны шатлал бүхий том аппарат ажилладаг зэрэг шинж Хятадад тогтсон хаант улсууд, тэр ч байтугай Манжийн үед үргэлжилсээр XX зууны арваад он хүрсэн хэмээн судлаачид үздэг байна. (А.Ц)

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН (*Health insurance fund*) Эрүүл мэндийн доройтлын улмаас ирээдүйд учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ хуваалцах зорилгоор даатгуулагчид хураамж төлж бүрдүүлсэн санг хэлнэ. Эрүүл мэндийн даатгалын сан нь эв санааны нэгдлийн зарчимд ихэвчлэн суурилдаг ба энэ нь даатгуулагчид ижил зарчмаар хураамж төлж санд төвлөрүүлсэн хувь оролцоо, шимтгэлийн хэмжээнээс үл хамааран эрүүл мэндийн шалтгаанаас үүдэлтэй санхүүгийн эрсдэлээ хуваалцдаг зарчим. Төрийн өмчийн эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, эрсдэл нөхөн төлөх нөхцөл, хэмжээг эрх зүйн актаар зохицуулдаг. Төлбөртэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нөхцөлд эрүүл мэндийн даатгал нь зардлыг санхүүжүүлэх нэмэлт эх үүсвэр болно. (Б.Б)

ЭРХ ЗҮЙТ УЛС (*The Rule of law State*) Эрх зүйт улсын үндсэн зарчим, түүний шалгуурын асуудлыг нэлээд эргнээс судалж ирсэн бөгөөд 1885 онд А.Дисей анх удаа цэгцтэйгээр томьёолсон гэж үздэг. Үүнд: Нэгд, хууль нь эцсийн бөгөөд дээд хүчинтэй байна. Ялангуяа гүйцэтгэх эрх мэдэл өөрийн үзэмжээр асуудал шийдвэрлэх эрхийг хязгаарлах ёстой бөгөөд хэрэв хуульд харшилсан шийдвэр гаргасан бол хүчингүй болгоно. Хоёрт, Хуулийн

өмнө хүн бүр эрх тэгш байх ёстой. Та тариачин байна уу засгийн төлөөлөгч байна уу гэдгээс л хамааран эрх зүйн адил нөхцөл үйлчлэх ёстой. Гуравт, Үндсэн хуулийн дэг журам нь эрх зүйн зайлшгүй байх эх сурвалж биш. Тодруулбал, английн эрх зүй нь хүний эрх чөлөөг бичмэл үндсэн хуультай улс орнуудаас илүү төвшинд хамгаалж ирсэн хэмээн тэмдэглэж байжээ.¹⁵ Эрх зүйт улс гэж хүний эрхийг хүндэтгэн хамгаалдаг, Үндсэн хууль, хуулийг дээдэлдэг, иргэний нийгмийн хяналтад байдаг төрийг хэлнэ. Эрх зүйт улсын шинж: 1) ард түмний бүрэн эрх хангагдсан байх; 2) төрийн зүгээс хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх зарчмыг тунхаглах; 3) хүний эрх, эрх чөлөөний баталгааны үндсэн хуулийн механизмыг тогтоох; 4) Үндсэн хууль болон бусад хуулийг дээдлэх; 5) төрийн эрх мэдэл хуваарилагдсан байх; 6) шүүхийн хараат бус байдлыг Үндсэн хуулиараа баталгаажуулах; 7) хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх; 8) хэвлэл мэдээллийн эрх чөлөө хангагдсан байх. (Ч.Э)

ЭРХ МЭДЛИЙГ БҮРЭН ШИЛЖҮҮЛЭХ (Devolution) “Devolution” гэх нэр үгийн үндэс нь “devolve” (Латины “deolvere”) юм. Үгийн утга нь “доош өнхрөх (to roll down)” гэсэн санааг илтгэдэг. Үгийн ерөнхий утга нь 1550 оноос “шилжүүлэх буюу transfer” гэсэн ойлголтыг илэрхийлэх болжээ. Монгол хэлнээ “devolution” гэдгийг эрх мэдлийг шилжүүлэх гэсэн утгаар орчуулан хэрэглэдэг. Энэ нь бие дааж шийдвэр гаргах эрх мэдлийн хамгийн дээд хэмжээг илэрхийлж, орон нутгийн захиргаатад тодорхой чиг үүргийг шилжүүлэн өгөх үйл явц юм. Эрх мэдлийн бүрэн шилжүүлэх гэдэг нь бие даасан статустай, боловсон хүчнээ өөрсдөө томилдог, эрх зүйн хувьд

хүлээн зөвшөөрөгдсөн газар нутагтай, хариуцсан чиг үүргээ санхүүжүүлэх орлого бүрдүүлэх чадавхтай, төрийн захиргааны тогтолцоон дахь бусад байгууллагуудтай харьцдаг, өөрөө засаглах эрхтэй байдгаараа онцлог юм. (Т.Т)

ЭРХ МЭДЛИЙГ ТӨЛӨӨЛҮҮЛЭХ (Delegation) Энэ үгийн үндэс нь Латины “delegatio” буюу “төлөөлөх, төлөөлөх хүнийг илгээх (to send as a representative)” гэсэн утгыг илэрхийлдэг. “Хүмүүсийг үүрэг даалгаврын хамт илгээх (persons sent by commission)” гэсэн утгаар 1818 оноос хэрэглэсэн байдаг. “Delegation” гэдгийг монгол хэлнээ эрх мэдлийг төлөөлүүлэх гэсэн утгаар орчуулдаг. Эрх мэдэл төлөөлүүлэх гэдэг нь нягтралыг сааруулахаас илүү өргөн хүрээтэй юм. Өөрөөр хэлбэл, энэ нь эрх мэдлийг тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх техникийн болон захиргааны чадавхтай, боловсон хүчний талаарх төвийн бодлогоос ангид байж болох, үйлчилгээний шууд төлбөр ногдуулах боломжтой, төвийн яамдын шууд хяналтгүйгээр шийдвэр гаргаж хэрэгжүүлэх өргөн эрх мэдэлтэй байгууллагуудад шилжүүлдэг. (Т.Т)

ЭРХ МЭДЭЛ (Power, authority) Англи хэлэнд эрх мэдлийг *authority*; *power* гэсэн агуулгын хувьд хоёр өөр ойлголтоор илэрхийлдэг бөгөөд монгол хэлэнд адилхан эрх мэдэл гэж орчуулагддаг. *Authority* нь төрийн захиргааны байгууллага, хуулиар олгогдсон бүрэн эрхт албан тушаалтнаар дамжин хэрэгжиж байгаа эрх мэдэл юм. Улс орны төрийн гэргүүн ерөнхийлөгч нь дээрх хоёр эрх мэдлийг зэрэг эзэмшиж болно. Нэг үгээр хэлбэл ерөнхийлөгчид бусдыг манлайлах, нөлөөлөх чадвар байхаас гадна Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрх мэдэл бий. Төрийн албан хаагч

15 Ч.Өнөрбаяр, М.Ариунаа, Д.Отгонтуяа. Төрийн онол. Улаанбаатар, 2007, х. 65.

нь иргэн, хуулийн этгээдийн явуулж буй үйл ажиллагаа, үзүүлж буй ажил үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах ажлыг хийдэг. Энэ нь хууль ёсны эрх мэдэл юм. Энэ эрх мэдэл нь хууль ёсоор хэн нэгэнд бусдыг тушаах, захирах эрх олгох тухай юм. Тухайлбал, замын цагдаа жолооч нарын хөдөлгөөнийг зохицуулж, баруун зүүн тийш эргүүлэх, хөдөлгөөнийг зогсоох, эхлүүлэх эрх мэдэлтэй.

Эрх мэдлийн power гэсэн ойлголтын хүрэн дэх утга нь хэн нэгэн хүн бусдын үйлдэлд хяналт тавих, нөлөөлөх чадварын тухай юм. Өөрийн хүсэл зорилгоо бусдын эсэргүүцэл, ашиг сонирхлыг үл харгалзан хэрэгжүүлэх, бусдын зан байдалд нөлөөлөн хянах, хийхгүй байсан үйлдлийг хийлгэх хувь хүний чадвар, зан чанар юм. Америкийн нэрт улс төр судлаач Р.Даль “Эрх мэдлийн тухай үзэл баримтлал” өгүүлэлдээ¹⁶ “А нь Б-гийн ямар нэгэн тохиолдолд хийхгүй байсан зүйлийг хийлгэж чадвал А нь Б-тэй харьцуулахад илүү эрх мэдэлтэй байна” гэж тодорхойлсон байдаг. Эрх мэдлийн уг сурвалж нь мэдлэг, туршлага, статус, харизм буюу бусдыг өөртөө татах чадвартай холбогдоно. Энэхүү эрх мэдэл нь зөвхөн доошоо чиглэхгүй, босоо хэвтээ түвшинд чиглэсэн байж болно. Эрх мэдэл нь хэн нэгэнд бусдыг хянах, хүссэн зүйлээ хийх боломжийг олгоод зогсохгүй тэдэнд нөлөө үзүүлэх боломжийг өгдөг. Хамгийн энгийнээр тайлбарлавал их сургуулийн оюутан профессор багшийн өгсөн даалгаврыг хүссэн хүсээгүй хийж байгаа нь профессор оюутан хоёрын дунд эрх мэдлийн харилцаа байгааг харуулна. (Ж.Ж)

ЭРХ МЭДЭЛ (*Power*) Эрх мэдэл гэдэг нь өөрийн хүсэл зорилгоо бусдын эсэргүүцэл, ашиг сонирхлыг үл харгалзан хэрэгжүүлэх, бусдын зан байдалд нөлөөлөн хянах, хийхгүй байсан үйлдлийг хийлгэх хувь хүний чадвар, зан чанар юм. Америкийн нэрт улс төр судлаач Р.Даль “Эрх мэдлийн тухай үзэл баримтлал” өгүүлэлдээ¹⁷ “А нь Б-гийн ямар нэгэн тохиолдолд хийхгүй байсан зүйлийг хийлгэж чадвал А нь Б-тэй харьцуулахад илүү эрх мэдэлтэй байна” гэж тодорхойлсон байдаг. Эрх мэдлийн уг сурвалж нь мэдлэг, туршлага, статус, харизм буюу бусдыг өөртөө татах чадвартай холбогдоно. Энэхүү эрх мэдэл нь зөвхөн доошоо чиглэхгүй, босоо хэвтээ түвшинд чиглэсэн байж болно. Эрх мэдэл нь хэн нэгэнд бусдыг хянах, хүссэн зүйлээ хийх боломжийг олгоод зогсохгүй тэдэнд нөлөө үзүүлэх боломжийг өгдөг. Хамгийн энгийнээр тайлбарлавал их сургуулийн оюутан профессор багшийн өгсөн даалгаврыг хүссэн хүсээгүй хийж байгаа нь профессор оюутан хоёрын дунд эрх мэдлийн харилцаа байгааг харуулна. Англи хэлэнд *power, authority* гэсэн хоёр ойлголт байдаг бөгөөд монгол хэлэнд хоёулаа эрх мэдэл гэж орчуулагддаг. Гэхдээ энэхүү хоёр ойлголт нь агуулгын хувьд ялгаатай. Эхнийх нь хэн нэгэн хүн бусдын үйлдэлд хяналт тавих, нөлөөлөх чадварын тухай асуудал байдаг бол хоёр дахь нь хууль ёсоор хэн нэгэнд бусдыг тушаах, захирах эрх олгох тухай юм. Тухайлбал, замын цагдаа жолооч нарын хөдөлгөөнийг зохицуулж, баруун зүүн тийш эргүүлэх, хөдөлгөөнийг зогсоох, эхлүүлэх эрх мэдэлтэй. (Ж.Ж)

16 Dahl, Robert A., The Concept of Power, Behavioral Science, 2:3 (1957) p. 201

17 Dahl, Robert A., The Concept of Power, Behavioral Science, 2:3 (1957) p. 201.

ЭРХ МЭДЭЛ ХУВААРИЛАХ (*Separation of powers*)

Төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг бие даасан байгууллагуудад хуваарилахыг эрх мэдэл хуваарилах гэнэ. Улс төрийн эрх мэдлийг хуваарилах, үүрэг, үйл ажиллагааг нь зааглах тухай үзэл санааг Английн философич, улс төрийн сэтгэгч Ж.Локк (XVII зуун) анх гаргасан бөгөөд тэрээр засаглалыг хууль тогтоох (парламент болон эзэн хааны дунд хуваах), гүйцэтгэх (шүүх засаглал багтана), холбооны (олон улсын харилцааны асуудлыг эрхэлнэ) гэж ангилсан байна. Харин Францын сэтгэгч Ш.Монтескье (XVIII зуун) эрх мэдэл хуваарилах онолын орчин үеийн загварыг бий болгосон бөгөөд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглал гэж хуваажээ. Түүний үзэл санаа АНУ-ын Үндсэн хуульд тусгалаа олсон байдаг. Эрх мэдлийг хуваарилах зарчмын нэг чухал үндэслэл нь хэн нэгэн албан тушаалтан, аль эсвэл төрийн байгууллага иргэний эрх, эрх чөлөөг зөрчих хэмжээний эрх мэдлийг өөртөө төвлөрүүлэхгүй байлгах явдал юм. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглал нь харилцан бие биедээ хяналт тавьснаар эрх мэдлийн харилцаа тэнцвэрждэг. Орчин үед эрх мэдэл хуваарилах онолын үзэл баримтлал анхны агуулгаасаа илүү тэлж, улс орон бүр өөрийн орны онцлогт тохируулан хууль тогтоох, гүйцэтгэх, шүүхэд эрх мэдлийг хуваарилж байна. Эдүгээ ардчилал хөгжсөн орнуудад тулгамдаж буй нэг асуудал нь гүйцэтгэх засаглалд илүү их эрх мэдэл төвлөрөх болсон явдал юм. Ардчиллын онолд хууль тогтоох байгууллага нь ардчилсан төрийн гол цөм нь болдог боловч бодит байдал дээр гүйцэтгэх засаглал бүхнийг удирдан чиглүүлж, хянадаг. Парламентын засаглалтай оронд ялсан нам засгийн газраа байгуулж, намын дарга нь ерөнхий сайд болдог. Энэ нь хууль тогтоох байгууллагыг

засгийн газар дахь нам, эвслийн хүсэл сонирхолд нийцсэн хуулийг баталдаг байгууллага болгох төлөв байдал ажиглагдаж байна¹⁸. Сонгуулийн ирц буурах, популист хөдөлгөөнүүд хүчээ авах болсноор хууль тогтоох байгууллагууд легитим байдлаа бага багаар гүйцэтгэх засаглалд алдаж байна. Цаашид эрх мэдлийн хуваарилалт нийгэм, улс төрийн амьдралын хөгжлийг дагаж хувьсан өөрчлөгдөх төлөвтэй байна. (Ж.Ж)

ЭРХЭЛСЭН ТҮШМЭЛ (*Principal officer*)

Төрийн захиргааны албан тушаалыг тэргүүн, эрхэлсэн, ахлах, дэс, туслах түшмэлийн албан тушаал хэмээн ангилна. “Эрхэлсэн түшмэл” хэмээх хоршоо үг нь “бие дааж удирдах”¹⁹ эрх мэдэл бүхий албан тушаал” гэсэн утгатай. Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлого боловсруулах хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагын бүтцийн нэгжийг удирдах, бодлогын тодорхой чиглэлийг хэрэгжүүлэх үүрэг хүлээж ажлын гүйцэтгэл, үр дүнг тэргүүн түшмэлийн өмнө хариуцах албан тушаал нь эрхэлсэн түшмэлийн албан тушаал юм²⁰. Эрхэлсэн түшмэлийн албан тушаалд яамны газрын дарга, хэлтсийн дарга, тэдгэртэй адилтгах бусад албан тушаал хамаарах бөгөөд төрийн захиргааны ТЗ-11, ТЗ-12, ТЗ-13 дугаар зэрэглэлийн албан тушаал юм. Эрхэлсэн түшмэлийн албан тушаалд төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн албан хаагч томилогдоно²¹. (М.А)

18 Jelena von Achenbach., Separation of powers and the role of political theory in contemporary democracies, International Journal of Constitutional Law, Volume 15, Issue 3, July 2017, pp. 861–865.

19 Монгол хэлний тайлбар толь, <https://mongol.toli.mn/dictionary/detail/137170>, үзсэн 2020.12.01.

20 Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоол.

21 Төрийн албаны тухай хуулийн 23.2.2 дахь заалт.

ЭРЭЛТ (*Demand*) Бараа, ажил, үйлчилгээний үнийн тухайн түвшинд хэрэглэгчийн худалдан авах боломжтой тоо хэмжээгээр тодорхойлогдох эдийн засгийн суурь ойлголт. Эрэлтэд бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ, орлуулах болон харилцан хамааралтай хэрэглэгдэх бүтээгдэхүүний үнэ ба нийлүүлэлт, хэрэглэгчийн орлогын өөрчлөлт, эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хүлээлт, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл, сургалчилгаа зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг. Хэрэглэгч тус бүрийн бараа, ажил, үйлчилгээнээс авах таашаал, орлого, хэрэглээний зан төлөв, ирээдүйн талаарх хүлээлт харилцан адилгүй боловч зах зээлийн нийт эрэлт нь хувийн эрэлтийн нийлбэрээр тодорхойлогдоно гэж үзэж эрэлтийн таамаглалыг хийдэг. Эрэлтийг таамаглаж ирээдүйн борлуулалтын хэмжээг урьдчилан үнэлснээр үйлдвэрлэгч, нийлүүлэгчид зах зээлд хэрхэн ажиллах стратегиа тодорхойлно. Төрийн үйлчилгээний талаарх иргэдийн эрэлт, хүлээлт, хандалтын давтамжийг урьдчилан тодорхойлсноор үйлчилгээний цэгийн тоо, хүчин чадлыг мөн оновчтойгоор төлөвлөх боломжтой. (Б.Б)

ЭРЭЛТИЙН УДИРДЛАГА (*Demand management*) Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний эрэлтийг тодорхойлох, таамаглах, нөлөөлөх хүчин зүйлийг үнэлэх, үр дүнд үндэслэн эрэлтэд нөлөөлөх бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхийг эрэлтийн удирдлага гэнэ. Эрэлтийн удирдлагыг макро түвшинд төр, салбарын удирдлага хэрэгжүүлдэг бол микро түвшинд байгууллагын удирдлага хэрэгжүүлдэг. Төрөөс стратегийн ач холбогдолтой, санхүүгийн зах зээлийн тэнцвэр, эдийн засгийн өсөлт, төсвийн орлого гүрдүүлэлт зэрэг нөлөөлөх голлох бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтэд

нөлөөлж зохицуулалт хийдэг. Эдийн засагт инфляцыг хөөрөгддөг нэг хүчин зүйл нь нийлмэл эрэлтийн өсөлт байдаг. Харин Засгийн газрын зардал, хөрөнгө оруулалт, цэвэр экспорт өсөх нь нийлмэл эрэлтийг өсгөж улмаар энэ нь эрэлтээс үүдсэн инфляцын шалтгаан болдог. Иймд эдийн засгийг тогтворжуулах зорилгоор төрөөс тодорхой бараа, үйлчилгээний эрэлтэд нөлөөлөх арга хэмжээг хэрэгжүүлнэ. (Б.Б)

ЭС ҮЙЛДЭХҮЙ (*Inaction*) Эс үйлдэхүй гэж тухайн этгээд түүнд хүлээлгэсэн эрх зүйн үүргийн дагуу хийх ёстой байсан үйлдлийг үйлдээгүй байдлаар илэрхийлэгдсэн, нийгэмд гэм хортой, хууль зөрчсөн зан үйлийг ойлгоно. Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогч нь захиргааны байгууллагыг хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхийг шаардах эрхтэй (ЗЕХ-ийн 15.1.7). Үүнд хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа эс үйлдэхүй хамаарна. Нөгөөтгээгүүр, Захиргааны ерөнхий хуульд зааснаар, захирамжилсан үйл ажиллагаа гэж хориглосон, зөвшөөрсөн, журамласан, тогтоосон, эсхүл татгалзсан үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно (ЗЕХ-ийн 37.2) гэж зааснаас үзвэл тодорхой тохиолдолд эс үйлдэхүйг захиргааны актад тооцох боломжтой нь харагдаж байна. Эс үйлдэхүйг захиргааны актад тооцохын тулд гурван нөхцөл хангагдсан байх шаардлагатай: а) Эрх зүйн тусгай зохицуулалтаар захиргааны байгууллагын эс үйлдлийг захиргааны акт гэж тогтоосон байх. б) Иргэн, хуулийн этгээд өргөдөл гаргаснаас хойш захиргааны байгууллага хариу үйлдэл хийлгүй хуульд заасан хугацааг хэтрүүлсэн байх. в) Захиргааны байгууллага эс үйлдэхүйгээрээ "гаргасан" захиргааны актын агуулгаар маргаан гарахгүй байх үүднээс иргэн, хуулийн этгээдийн гаргасан

өргөдөл тодорхой, ойлгомжтой байх ёстой. Эс үйлдэхүйгээр захиргааны акт гаргах зохицуулалт аль болох цөөн байх нь тохиромжтой. Учир нь ийм тохиолдлууд ихээхэн маргаан дагуулдаг.²² (Ч.Э)

ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ (*Patriotism*) Эл ойлголтын агуулга, үндэсний үзэл зэрэг бусад ойлголтоос ялгарах ялгааны талаар мэтгэлцээн их байсаар ирсэн ба одоо ч байгаа юм. Тийм болохоор түүний талаар бүгдээрээ хүлээн зөвшөөрдөг тодорхойлолтыг хэлэх боломжгүй юм. Ерөнхийд нь эх орон, ард түмэн, түүх, соёлоо хайрлах ухамсарт хандлага гэж ойлгож болно. Стефен Натансон (Stephen Nathanson) эх оронч үзэл нь дараах шинжтэй гэжээ:

- Эх орондоо онцгой сэтгэл татагдах
- Эх орондоо өөрийгөө биечлэн хамааруулах мэдрэмж
- Эх орныхоо сайн сайхны төлөө онцлон анхаарах
- Эх орны сайн сайхны төлөө өөрийгөө зориулах хүсэл эрмэлзэл.

Эх оронч үзлийг үндэсний үзлээс ялган үзэх хэрэгтэй. Энэ хоёр ойлголтыг ижил хэмээн үзэх нь байдаг боловч маш олон эрдэмтэн тэдгээрийн ялгааг тодорхойлох гэж оролдон янз бүрийн саналыг дэвшүүлсэн байдаг. (Ц.Д)

ЭЭЛЖИЙН АМРАЛТ (*Vacation*) Ажил олгогчоос ажиллагсад олгосон үүрэгт ажлаас түр чөлөөлөх хугацаа бөгөөд хүний нөөцийн удирдлагын үүрэг, функцийг нэг юм. Төрийн албан хаагч буюу хувь хүний түвшинд энэхүү ойлголт хэрэглэгдэх ба тухайн улс орны хууль эрх зүйн орчноос шалтгаалж, хөдөлмөрийн тухай хууль болон төрийн албаны тухай хуулиар зохицуулагдаж, албан хаагчийн жил бүр эдлэх ёстой

албан ёсны амралт юм. Төрийн албан хаагчийн ажилласан жилээс хамааран тухайн жилд эдлэх ёстой амралтын хоног тодорхойлогдоно. Түүнчлэн хөдөлмөрийн үйл ажиллагааг зохицуулсан хууль, дүрэм журмын дагуу ээлжийн амралтын хугацааг уян хатан байдлаар илэрхийлж болно. (Г.Б)

22 Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, Улаанбаатар, 2017, х. 180.

Я

ЯАМ (Ministry) Төрийн орон нутаг, эсхүл салбар хариуцсан байгууллагын уламжлалт нэр. Монгол Улсад Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яам, Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яам, Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яам, Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яам, Дотоод хэргийн бүгд эрхлэн шийтгэгч яам гэсэн таван яамыг байгуулснаас гадна Улсын хурлын газрыг яам гэж нэрлэж байжээ. 1921 оны ардын хувьсгалын дараа аймгийн захиргааг аймгийн яам гэж нэрлэж байжээ. Орчин үед яам нь төрийн захиргааны төв байгууллага юм. Монгол Улсад ерөнхий чиглэлийн болон салбарын яамд ажиллана. Түүнчлэн гадаад улсад суугаа элчин төлөөлөгчийн газрыг яам хэмээн нэрлэдэг. Хуучны ном зохиолд заримдаа яам гэдгийг орон тоо гэсэн утгатайгаар хэрэглэдэг байсныг Арван буянт номын цагаан түүхээс үзэж болно.

Орчин үед аливаа улс орны төрийн захиргааны төв байгууллагыг яам (ministry, министерство, ministerium, Ministère г.м.) хэмээн нэрлэдэг. Зарим оронд түүнийг департамент (АНУ, Швейцар, Филиппин), нарийн бичгийн дарга нарын газар (Мексик), товчоо (Гонк Конг) хэмээн нэрлэх нь бий. Зөвлөлт Орос Улсад Ардын комиссариат хэмээн нэрлэж байжээ. Яамыг ихэвчлэн сайд толгойлно.

1992 онд батлагдсан Үндсэн хуульд зааснаар Монгол Улсад төрийн захиргааны төв байгууллагууд буюу Яамд ажилладаг. Яамд нь ерөнхий чиг үүргийн болон салбарын хэмээн ангилагддаг. Сан, гадаад хэрэг, хууль зүй, дотоод хэрэг гэх мэтийн бүх салбаруудад хамааралтай нийтлэг асуудлыг эрхлэх чиг үүрэг бүхий яамдыг ерөнхий чиглэлийн гэх ба боловсрол, эрүүл мэнд, соёл, эрчим хүч гэх мэт нэг салбарыг дагнасан чиг үүрэг бүхий яамдыг салбарын яам хэмээн үздэг байна. (А.Ц)

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ (Discrimination) Хүмүүс болон бүлгүүдийг арьс өнгө, нас, хүйс, бэлгийн хандлага зэрэг шинж чанарыг нь харгалзан шударга бусаар хандахыг хэлнэ. Сэтгэл зүйн талаас нь авч үзвэл ялгаварлан гадуурхалт нь айдас ба үл ойлголцлоос үүдэлтэй байдаг. Ялгаварлан гадуурхалтад өртсөн хүмүүс бусад хүмүүсээс илүү стресстэй байдаг. Энэ нь арьс өнгөний болон угсаатны бүлгүүдэд бас хамааралтай. Байнгын стресстэй байх нь бие махбодын болон сэтгэл санаа, эрүүл мэндэд муугаар нөлөөлдөг. Хямрал, таргалалт, цусны даралт ихсэх гэх мэт өвчин үүсгэдэг байна¹. AMNESTY INTERNATIONAL-ын тодорхойлсноор бодлого, хууль

¹ Америкийн сэтгэл судлалын нийгэмлэг (2019). apa.org/topics/racism-bias-discrimination/types-stress.

юмуу хандлагад зүй бус ялгаварлал гаргасны улмаас хүний эрх болон хуульд заасан бусад эрхээ эдлэх боломжгүй үед ялгаварлан гадуурхалт буй болдог байна. Ялгаварлан гадуурхалт нь шууд ялгаварлал, шууд бус ялгаварлал, бүлэг хоорондын ялгаварлал зэрэг олон хэлбэртэй байдаг. Шууд ялгаварлан гадуурхалт нь бүлгүүдийн хооронд илт ялгаварлал гаргаснаас зарим бүлгүүдийн хүмүүс эрхээ эдлэх боломж байхгүй юмуу бага байх үед үүснэ. Шууд бус ялгаварлан гадуурхалт нь хууль тогтоомж юмуу бодлого ерөнхий байх үед үүснэ. Жишээ нь сонгуульд оролцоход боловсролын түвшин заасан байх нь зарим бүлгийн хүмүүсийг шууд бусаар ялгаварлахад хүргэдэг. Бүлэг хоорондын ялгаварлан гадуурхалт нь ялгаварлалын хэд хэдэн хэлбэрээс үүдэн хүн амын зарим бүлгүүд хохиролтой байдалд орох үед үүснэ. Тухайлбал, эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс бага цалин олгох зэрэг юм². Ардчилсан нийгэмд шууд хэлбэрийн ялгаварлан гадуурхалт хуулиар хоригтой байдаг боловч шууд бус болон бүлэг хоорондын ялгаварлан гадуурхалт үүсэх явдал бий. (Ц,Д)

ЯПОНЫ ЗАХИРГААНЫ УЛАМЖЛАЛ *(Administrative tradition of Japan)*

Японы нэгдмэл төр улс Ү зуунаас эхтэй аж. ҮI зуунд Сётоку-тайси гэгч овог аймгуудын тэмцэлд ялж Ямагогийн хаадын анхны зарлиг буюу Сётокугийн Үндсэн хуулийг гаргажээ. Түүнд төрийн удирдлагын зарчмуудыг тодорхойлсон аж. Түүнд яг хуулийн заалт байхгүй шахам бөгөөд харин хувийн эрх ашигт биш, нийт япончуудын эрх ашигт үйлчлэх, эв эетэй байх гэх мэт шашин-ёс суртахууны шинжтэй зүйлс орсон байжээ. Төрийн хамгийн дээд оройд бүрэн эрхт хаан, түүний дор ноёд-түшмэд, тэгээд харц олон түмэн гэсэн

хуваарийг тогтоосон байна. Гэвч энэ хуулийг бүрэн хэрэгжүүлж амжаагүй байхад дахин тэмцэл гарч 645 онд Тайхо гэгч ялж мөн өөрийн хуулийг гаргасан байна. Хаанаа эрхэм дээд бөө, цэргийн командлагч, хүн дүрсийг олсон нарны бурхан хэмээн үзэж түүнд үг дуугүй захирагдах ёстой болжээ. Японы төв, орон нутгийн болон шашны, иргэний байгууллагуудын бүтэц нь эл зарчимд үндэслэгдэн боловсруулагджээ. Хаан хаанчилна, харин улсыг удирдахгүй. Сётокугийн хуульд зөвлөхүүд бол төрийн чухал хэргийг зөв шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ хэмээн заадаг байна. Тиймээс Японд төрийн бүх эрх мэдлийг билиг тэмдэг байдлаар гартаа атгадаг хаан, улс орныг удирддаг түшмэдүүд гэсэн хос засаглал буй болжээ. Тайхогийн хуулиар төв, орон нутаг, шашин, иргэний талыг хамарсан төрийн бүх байгууллагуудын бүтцийг тодорхойлжээ. Түүнчлэн албан тушаалын зэрэг дэв, пүнлүү, түшмэдийг бэлтгэх зэрэг асуудлыг тусгасан байна. Төрийн дээд эрх мэдлийг Төрийн зөвлөл (Дадзе-кан) хэрэгжүүлж, бодлогын ерөнхий чиглэлийг гаргадаг байжээ. Түүнээс гадна шашны асуудлыг хариуцсан Төрийн зөвлөл (Дзинги-кан) байсан аж. Хааны дэргэд ахлах сайд байжээ, түүнд зөвлөгөө өгнө. Төрийн зөвлөлд зүүн ба баруун сайдууд байх ба зөвлөгчдийнхөө тусламжтайгаар зүүн сайд том асуудлыг, баруун сайд жижиг асуудлыг эрхлэн шийдвэрлэдэг байжээ. Цэрэг, сан, хууль зүйн болон дотоод хэргийн яамд буй болсон байна. Дотоодын хагарал тэмцлийн улмаас XII зууны үед цэргийн захиргаа буюу сёгуны засаглал тогтжээ. Хаан билиг тэмдгийн төдий үлдэж цэргийн том жанжин-сёгун улсыг захирах болсон байна. Орон нутагт хааны томилдог захирагчдаас гадна цэргийн захиргаа буй болсон байна. Мөн энэ үед мөрдөн байцаах алба буй болжээ. Таван

2 [Amnesty.org/en/what-we-do/discrimination/](https://www.amnesty.org/en/what-we-do/discrimination/)

ахлах мөрдөн байцаагчид ноёд, том түшмэдүүдийг хянадаг байжээ. Татвар хураах үүрэг бүхий албан тушаалтнууд буй болсон аж. (А.Ц)

ERG ОНОЛ (*ERG theory*) Клейтон Алдерфер (C.P.Alderfer)-ийн боловсруулсан хэрэгцээний онол юм. Тэрээр А.Маслоугийн хэрэгцээний шатлалын онолд өөрчлөлт оруулж шинэчлэн ERG онол хэмээн нэрлэсэн. ERG гэдэг нь оршин тогтнох (*existence*), харилцан уялдаа холбоотой байх (*relatedness*), өсөж хөгжих (*growth*) гэсэн гурван англи үгийн товчлол юм. Учир нь уг онолоор зөвхөн дараах гурван хэрэгцээ хүнд байдаг гэж үзжээ³.

Нэгд, оршин тогтнох хэрэгцээ буюу эрүүл саруул байж, сэтгэл зовохгүй амьдрахын тулд эд хөрөнгөтэй байх, хоёрт, харилцаатай байх хэрэгцээ буюу бусад хүмүүстэй сайн харилцаатай байх, гуравт, өсөж хөгжих хэрэгцээ буюу хувь хүн дотоод нөөц хүчээ дайчлан хөгжүүлж, албан тушаал ахиж дэвших, мэдлэг чадвараа өргөжүүлэн хөгжүүлэх хэрэгцээ юм. ERG онол нь А.Маслоугийн хэрэгцээний шатлалын тоог цөөрүүлж 3 болгосон ба хэрэгцээ нь шаталсан бүтэцтэйгээр нэг шатлалаас нөгөөд шилжих үйл явцтай. Гэхдээ А.Маслоугийн хэрэгцээний шатлал шиг өгсөх чиглэлтэй бус, хэрэгцээний өндөр түвшинг хангаж чадаагүй тохиолдолд урьд нь хангагдсан хэрэгцээний доод түвшин рүү буцаж болох юм. Алдерфер ажилтан өсөж хөгжиж чадаагүй бол нийгмийн илүү доогуур хэрэгцээ рүү ухарч, орлогоо бүх талаар нэмэгдүүлэх чармайлт гаргах болдог⁴ гэжээ. (Ц.Д)

3 Ганбаатар, Д., Я.Шуурав, Д.Сэржамц (2019). Менежмент. Улаанбаатар хот. х. 352.

4 송은석 (2012). 신뢰중심의 조직관리. 서울, 아림기획.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр ашигласан эх сурвалж

1. Авлигатай тэмцэх газар. Төрийн албан хаагчийн ёс зүй: гарын авлага. Улаанбаатар, 2019.
2. Адам Смит. Үндэстнүүдийн баялаг. Улаанбаатар, 2018.
3. Адъяа, Ю. “Менежментийн ухаан”. Улаанбаатар, 2002.
4. Александр Питринги болон бусад зохиогчид. Нийгмийн баримжаат төр ба нийгмийн ардчилал. Орч. Ч.Оюунгэрэл. Нийгмийн ардчиллын сурах бичиг 3-р дэвтэр. Фридрих-Эбертийн сан. 2009.
5. Аренд Лийпхарт. Ардчиллын хэв загвар. Орч. Д.Ганбат. Улаанбаатар, 2007
6. Амартя Сен. Хөгжил бол эрх чөлөө. Орч. А.Энхбаатар, Э.Мөнхжаргал, Улаанбаатар, 2014.
7. Аналитическая философия: становление и развитие. М., 1998.
8. Бадарч, Д., Мөнххүж, Б. Системийн сэтгэлгээ. Улаанбаатар, 2014.
9. Базарпүрэв, С. Улс төрийн системийн онол. Улаанбаатар, 2006.
10. Батболд, Ц. Бодлогын шинжилгээний онол, арга зүйн үндэс. Улаанбаатар, 2019.
11. Батсүх, Ш., Долгоржав, Я., Ганцоож, Ц. Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх нь, нэг цонхны үйлчилгээ, ТҮЦ машин, Иргэд хүлээн авах төв. ХБНГУ-ын Конрад Аднауэр-Сан, 2015.
12. Батсүх, Ш. Захиргааны шинжлэх ухааны ерөнхий онолын зарим асуудал. Шинэ толь №9, 1996.
13. Батсүх, Ш. Төрийн захиргаа, засаглал - төрийн албан хаагчдад зориулсан гарын авлага. Улаанбаатар, 2017.
14. Батсүх, Ш. Улсын салбарын шинэ удирдлага: Туршлага, сургаж. Улаанбаатар, 2009.
15. Болд, Н. Мөргөлдөөн судлал. Улаанбаатар, 2010.
16. Боловсрол судлалын нэр томьёоны тайлбар толь бичиг. Улаанбаатар, 1992.
17. Ванчигсүрэн, Д., Энхтүвшин, Б. Боловсрол судлалын ухагдахууны товч тайлбар толь. Улаанбаатар. 1994.
18. Ганбаатар, Д., Шуурав, Я., Сэржамц, Д. Менежмент. Улаанбаатар, 2019.
19. Ганболд, Ц нар. Улс төрийн шинжлэх ухаан. МУИС. Улаанбаатар, 2001.
20. Ганболд, Ц. Улс төрийн сэтгэл судлал ба хүчирхийллийн сэтгэл зүй. Улаанбаатар, 2005.
21. Гантулга, Т. Улс төрийн зөвшилцөл. Улаанбаатар, 2001.
22. Гүйцэтгэлийн удирдлага. Орчуулагч Н.Хашбат, Сүүн Сувд ХХК. Улаанбаатар, 2015.
23. Даваадулам, Ц. Засаглал үзэл баримтлал, нэр томьёоны тайлбар толь бичиг. 2010.
24. Даниел Белл. Грядущее постиндустриальное общество. 1999.
25. Даш-Ёндон, Б. Хөгжихүйн философи. Улаанбаатар, 2019.
26. Даш-Ёндон, Б. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. 3 боть эмхтгэл. 1-р боть. Ред: Г.Чулуунбаатар. Улаанбаатар, 2011.
27. Джон Ролз. Теория справедливости / Под ред. В.В. Целищева. - Издательство Новосибирского университета, 1995.
28. Досс, Эрик. “Тогтвортой хөгжлийн зорилго 16”. НҮБ ба Хууль дээдлэх ёс. 2020.
29. Достоевского, Ф.М. Институциональная структура производства государственных услуг: от вебериянской бюрократии – к современным реформам государственного управления: монография Капогузов Е.А. – Издательство Омского государственного университета им. 2012.

30. Долгор, Б нар. Улс төр судлал. ШУТИС. Улаанбаатар, 2014.
31. Дорж, Т. Менежмент, сурах бичиг. Улаанбаатар: МУИС, Пресс хэвлэлийн газар. 2018.
32. Дэлгэржаргал, Д. Төрийн албан хаагчдын сэдэл ба шинэчлэгч зан үйлийн харилцан нөлөөлөл. Төрийн захиргаа сэтгүүл. 2014/№04(33). Улаанбаатар, 2014.
33. Дэлхийн банк. Нийгмийн эгэх хариуцлагын үндсэн ойлголт. Улаанбаатар, 2017.
34. Дэлхийн банк. “Өрийн дарамтгүй, тогтвортой бөгөөд хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгох нь”. Улаанбаатар, 2018.
35. Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /OECD/. Авлигатай тэмцэх гарын авлага. Улаанбаатар, 2016.
36. Егоров, В.К., Чичканов, В.П., Энциклопедия государственного управления в России. В двух томах. М., 2008.
37. Еоин Янг, Лиза Квин. Үр нөлөө бүхий бодлогын баримт бичиг боловсруулах нь гарын авлага. Улаанбаатар, 2012.
38. Захиргааны ерөнхий хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл №48. 2015.
39. Знание // Новая философская энциклопедия. В четырех томах. М.: Мысль, 2010.
40. Знания как предмет эпистемологии. ИФРАН. М., 2011.
41. Инновацийн тухай хууль. 2012.
42. Инновац, традиция, реформа, // Новая философская энциклопедия. В четырех томах. М.: Мысль, 2010.
43. “Иргэдийн төсөв” эмхэтгэл. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн тайлан.
44. История и философия науки. Под ред. М.А.Эскиндарова, А.Н.Чумакова М., 2018.
45. Кауфманн Даниел ба Висенте Педро. “Хуулиар зөвшөөрсөн авлига”, 2005. Дахин нэмж засварлан хэвлэсэн, Дэлхийн банк. 2015.
46. Ким Гюж Жонг. Төрийн захиргааны ерөнхий онол. Сөүл, 1998.
47. Клаус Шваб. Четвертная промышленная революция. М., 2016.
48. Конрад Аденаурын сан. Орон нутгийн эрх зүйн шинэчлэл. Улаанбаатар. 2015.
49. Кун, Т. Структура научных революций. М., 2009.
50. Левикова, С.И., Молодежная культура. М., 2002.
51. Манукян.В.Р., Трошихина.Е.Г. Современные психологические концепции благополучия и зрелости личности: области сходства и различий // Вестник Пермского университета. Философия. Психология. Социология. 2016.
52. Массовая культура. М., 2004.
53. Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт. (1990-2019 оны). Улаанбаатар, 2019.
54. Монгол дахь улс төрийн соёл: Уламжлал, орчин үе. ШУА-ын Философийн хүрээлэн. Улаанбаатар, 2020.
55. “Монгол улсад нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь”. Монгол Улсын Засгийн газар/МНУХ. 2003.
56. Монгол Улсын Авлигын эсрэг хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл №35. 2006 он.
57. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл №07. 2021.
58. Монгол Улсын Иргэний хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл № 07. 2002.
59. Монгол Улсын Төрийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл №01. 2018.
60. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх субьектив хүчин зүйлсийн шинжилгээ. Ред: Даш-Ёндон, Б. Улаанбаатар, 2019.
61. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал ба тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилт. Ред: Чулуунбаатар, Г. Улаанбаатар, 2021.

62. Монгол Улсын Үндсэн хууль. Улаанбаатар, 1992.
63. Монголын нийгмийн өөрчлөлт. Улаанбаатар, 2013. Ред: Даш-Ёндон. Б.
64. Моррис Стивен Д. “Орчин үеийн Мексик дэх авлига ба улс төр”. Алабамагийн их сургуулийн хэвлэлийн газар, Тускалуза, 1991.
65. Мөнхжаргал, Б., Амаржаргал, Б. ”Менежмент”. Улаанбаатар, 2002.
66. Наука и религия: Междисциплинарный и кросс-культурный подход. М., 2006.
67. Науковедение. Новая философская энциклопедия. В 4-х томах. М.: Мысль, 2010.
68. Нийтийн удирдлагын үндэс. МУИС. Улаанбаатар, 2018.
69. Новая философская энциклопедия. В 4-х томах. М.: Мысль, 2010.
70. Өлзийсайхан, Ч. Элит судлал. Улаанбаатар, 2006.
71. Парадигм // Новая философская энциклопедия. В четырех томах. М.: Мысль, 2010.
72. Поппер, К. Ницета историцизма
73. Поппер, К. Нээлттэй нийгэм ба түүний дайснууд. 1945 он.
74. Поппер, К. Открытое общество и его враги. Т. 2. М.: Феникс, 1992.
75. Райли, Бенжамин. Монгол Улсын сонгуулийн тогтолцооны шинэчлэл, тогтолцооны хувилбарууд. НҮБХХ. Улаанбаатар, 2010.
76. Самуэль П.Хатингтон. “Иргэншил хоорондын мөргөлдөөн, шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам”. Улаанбаатар, 2005.
77. Симон Баут болон бусад зохиогчид. Эдийн Засаг ба Нийгмийн Ардчилал. Орч. Ч. Оюунгэрэл. Нийгмийн ардчиллын сурах бичиг 2-р дэвтэр. Фридрих-Эбертийн сан. 2009.
78. Синёор Ян. Авлига. “Дэлхийн нэвтэрхий толь”. Лондонгийн эдийн засгийн хүрээлэн, 2006.
79. Сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалт. АСТОУХ-ын гарын авлага. Улаабаатар, 2010.
80. Сорос, Ж. Супер хөөс. 2008.
81. Социальный капитал // С.Г.Коленько. Менеджмент в сфере культуры и искусства. М.,2016.
82. Степин, В.С.,. Научное познание в социальном контексте. Избранные труды. Минск: БГУ. 2012.
83. Сүнг Үн Сог. Итгэлд суурилсан байгууллагын удирдлага. Сөүл, Арим хэвлэлийн газар, 2012.
84. Сүхбаатар, Ж. Захиргааны шинэтгэлийн тойм, сургаж, цаашлын чиг хандлага, “Захиргааны шинэтгэл: Асуудал ба шийдэл” бага хурал дээр тавьсан илтгэл. 2011.
85. Теоретическая культурология: Энциклопедия культурологии. Глав. ред. К.Э. Разлогов М., Академический проект. РИК. 2005.
86. Тогтвортой хөгжил ба оюуны урсгал. Эмхтгэл. Улаанбаатар, 2019.
87. Тони Бовэйрд., Элке Лөйффлер. Улсын салбарын менежмент, засаглал. Улаанбаатар, 2014
88. Тоффлер, Э. Эрх мэдлийн огцом хувирал
89. Төрийн албаны тухай хууль. Улаанбаатар, 2017.
90. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль. Улаанбаатар, 2002.
91. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль. Улаанбаатар, 2010.
92. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл № 48. 2005 он.
93. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль. Улаанбаатар, 2010.
94. Увс, П., Хэрлэн, Б. Байгууллагын зан үйл. Улаанбаатар, 2017.

95. Удирдлагын академи. Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх. Гарын авлага. Улаанбаатар, 2019.
96. Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг. Улаанбаатар, 2020.
97. Управление // Энциклопедия государственного управления в России. В двух томах. Рук. В.К.Егоров, В.П.Чичканов М., 2008 г.
98. Фирсов.М.В., Студёнова.Е.Г. Технология социальной работы. М., 2012.
99. Фрэнсис Фукуяма.Төрийг төвхнүүлэхүй. Орч. Гомбосүрэн, Ц. Улаанбаатар, 2014.
100. Хаек.Ф.А. Боолчлогдох зам. Орч: Чойжил. Д., Цэнгүүн, П. Улаанбаатар: “Мон судар”. 2008.
101. Хау. Харилцааны онолууд: Өөр бусад харилцаа - Онол, гэр бүл, тодорхойлолт, хөгжил, харилцаа ба парадигма. 1998.
102. Цанжид, А. Төрийн захиргаа. Улаанбаатар, 2009.
103. Цанжид, А., Дэлгэржаргал, Ц. Хос суртахуунт төр. Улаанбаатар, 2019
104. Цанжид, А. Хамжих засаглал. Удирдлагын Академийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан Эрдэм Шинжилгээний Салбар Хуралдаанд тавьсан илтгэл. 2014.
105. Цацралт, Б. Төрийн албаны цахим шилжилт, түүний эргэн тойронд” СЭЗИС-ийн судалгааны илтгэл. 2021.
106. Цэвэл, Я. Монгол хэлний их тайлбар толь бичиг. Улаанбаатар, 1966.
107. Шаповалов, В, Ф. Философия науки и техники. М., 2004.
108. Шинжлэх ухаан, технологийн их сургууль: “Төрийн удирдлага”, Улаанбаатар, 2019.
109. Эскиндарова, М.А., Чумакова, А.Н., Под ред. История и философия науки. М., 2018.

Англи хэлээр ашигласан эх сурвалж

110. Aberbach, Joel D., and Bert A.Rockman. In The Web Of Politics: Three Decades of the U.S. Federal Executive. Washington, D.C: Brookings Institution, 2000.
111. Acemoglu, Daron, and James A., Robinson. Economic Origins of Dictatorship and Democracy. New York: Cambridge University Press, 2006.
112. Ackoff.R.L., et al. A Prologue to National Development. 1981.
113. Advances political psychology. 2020.
114. Aldred, R. Ethical and Political Issues in Contemporary Research Relationships. Sociology, 2008.
115. Allais, Maurice. “Le Comportement de L’Homme Rationnel devant le Risque: Critique des Postulats et Axiomes de l’Ecole Americaine.”. Econometrica, 1953.
116. Almond, Gabriel A., and Sidney Verba The Civic Culture: Political Attitudes and Democracy in Five Nations. Princeton, NJ: Princeton University Press, 1963.
117. Arendt, Hannah. The Origins of Totalitarianism. New York: Harcourt, Brace, 1951.
118. Armstrong, John A. The Politics of Totalitarianism. New York: Random House, 1961.
119. Bache, Ian, and Stephen George. Politics in the European Union. Oxford: Oxford University Press, 2006.
120. Baldez, Lisa. “Intersectionality.” Politics & Gender 3, no. 2. June 2007.
121. Barber, James. South Africa in the Twentieth Century: A Political History-In Search of a Nation State. Oxford, U.K.: Blackwell, 1999.
122. Bartle. Phi I (2002). Preparing a community development policy paper: Guidelines for ministry leaders. <http://www.scn.org/ip/cds/cmp/modules>

123. Baumgartner, F.R., Berry, J.M., Honjnacki, M., Kimball, D.C., & Leech, B.L. *Lobbying And Policy Change: Who Wins, Who Loses, And Why*. Chicago: University Of Chicago Press. 2009.
124. Bayes, Thomas. "An Essay towards Solving a Problem in the Doctrine of Chances." "Номлолын боломжууд дахь асуудлыг шийдвэрлэх ЭССЭ-нүүд" Communicated by Mr. Price. *Philosophical Transactions of the Royal Society of London* 53, 1763.
125. Beckwith, Karen. "A Common Language of Gender?" *Politics & Gender* 1, no. 1. March 2005.
126. Bernoulli, Daniel. "Exposition of a New Theory on the Measurement of Ellsberg, Daniel. "Risk, Ambiguity, and the Savage Axioms." *Quarterly Journal of Economics* 75, 1961.
127. Birnbaum, Jeddrey H. "The Road to Riches Is Called K Street". *Washington post*. June 22. 2005.
128. Bovaird, Tony and Loeffler, Elke. *Public Management and Governance*, second edition. London, 2009.
129. Bowen, John, and Roger Petersen, eds. *Critical Comparisons in Politics and Culture*. Cambridge : Cambridge University Press, 1999.
130. Burns, Nancy. 2005. "Finding Gender." *Politics & Gender* 1, no. 1. March 2005.
131. Caet i. Policy research paper: Points to ponder. 2002. <http://www.unt.edu/ cjs/po nd erp.htm>
132. Cartwright, S. *The Blackwell Encyclopedia of Management: Human resource management*. Blackwell Publishing Ltd, 2005.
133. Carter, April. *The Political Theory of Anarchism*. London: Routledge and Kegan Paul, 1971.
134. Cas Mudde and Cristybal Rovira Kaltwasser. *Populism: A Very Short Introduction*. Oxford University Press. 2017.
135. Charles N. Edell, *Nation Builder. John Quincy Adams and the Grand Strategy of the Republic*, 2014.
136. Coen, David. *lobbying the European Union: Institutions, Actor and Policy*: Oxford, UK: Oxford University Press, 2007.
137. Cohen, Joshua, and Matthew Howards, eds. *Is Multiculturalism Bad for Women?* Princeton, N.J.: Princeton University Press, 1999.
138. Comfort, Nicolas. *Brewer's Politics: A Phrase and Fable Dictionary*. London: Cassell, 1995.
139. Commission of European Union. "What is the transparency Initiative?". 2006.
140. Choudhury, T. *The Role of Muslim Identity Politics in Radicalisation (A Study in Progress)*. Durham, N.C. University of Durham, 2007.
141. Curry, M. R. "On the Possibility of Democracy in a Geocoded World: GIS and Redistricting." *Social Science Computer Review* 17, no. 1. 1999.
142. David Marsh., Gerry Stoker. *Theory and Methods in Political Science*. 3rd ed. New York, 2010.
143. David Sangokoya. 5 challenges for civil society in the Fourth Industrial Revolution. <https://www.weforum.org/agenda/2017/12/5>
144. David Schultz. *Encyclopedia of Public administration and Public policy*. 2004.
145. David Schultz. *Systems analysis // Encyclopedia of Public administration and Public policy*. 2004.
146. David Schultz. *Scientific management // Encyclopedia of Public administration and Public policy*. 2004.
147. Davis, Flora. *Moving the Mountain: The Womens Movement in America since 1960*. Urbana: University of Illinois Press, 1999.

148. Dexter, L. A. *Elite and Specialized Interviewing*. Evanston, :Northwestern University Press, 1970.
149. Diamond, Larry Jay, and Marc F. Plattner, eds. *Electoral Systems and Democracy*. Baltimore: Johns Hopkins University Press, 2006.
150. Diamond, L., Gunther, R. *Political Parties and Democracy*. London, 2001.
151. *Diminished Democracy : From Membership to Management in American Civic Life*. Norman: University Of Oklahoma Press, 2000.
152. Dimock, M.E. *A Philosophy of Administration*. 1958.
153. Dingwall, R. 'Confronting the Anti-Democrats: The Unethical Nature of Ethical Regulation in Social Science'. 2006.
154. Dishion, T. J., Patterson, G. R., & Kavanagh, K. A. An experimental test of the coercion model: Linking theory, measurement, and intervention. In J.McCord & R.E.Tremblay (Eds.), *Preventing antisocial behavior: Interventions from birth through adolescence*. Guilford Press. 1992.
155. Dmitri Denisov. *Lobbying and government relations*. 3rd ed. 2010.
156. Donald C.Menzel. *Ethics moments in Government: Cases and Controversies*. CRC Press. 2010.
157. Dubow, Saul. *Racial Segregation and the Origins of Apartheid in South Africa, 1919-36*. Basingstoke, U.K.: Macmillan, 1989.
158. "Dynamic" of Power Cycle Theory: Expectations, Competition, and Statecraft." *International Political Science Review* 24. 2003.
159. Easton, David. *The Political System: An Inquiry into the State of Political Science*. New York: Knopf, 1953.
160. Eisfeld, Rainer, ed. *Pluralism. Developments in the Theory and Practice of Democracy*. Opladen, Ger.: Budrich-Verlag, 2006.
161. Ephraim Nimni. *Marxism and Nationalism: Theoretical Origins of a Political Crisis*. 1991.
162. Evans, Sara M. *TidalWave: How Women Changed America Centurys End*. New York: Free press. 2003
163. Farnham, Barbara. "The Theory of Democratic Peace and Threat Perception." *International Studies Quarterly* 47, no. 3. September 2003.
164. Flora, Peter, ed. *State Formation, Nation-building, and Mass Politics in Europe: The Theory of Stein Rokkan*. With Stein Kuhnle and Derek Urwin. Oxford: Oxford University Press, 1999.
165. Frederick Herzberg. *One More Time: How Do You Motivate Employees?.* Harvard Business review. 2003.
166. Fred Luthans. *Organizational Behavior*. 7th ed. University of Nebraska
167. Fred W, Riggs. *Administration in Developing Countries: The theory of Prismatic Society*, 1964.
168. Friedrich, Carl J., Michael Curtis, and Benjamin Barber, eds. *Totalitarianism in Perspective: Three Views*. New York: Praeger, 1969.
169. Friedrich, Carl J., and Zbigniew Brzezinski. *Totalitarian Dictatorship and Autocracy*. Cambridge, Mass: Harvard University Press, 1956.
170. Gaddis, John. *The Cold War: A New History*. New York: Penguin Books, 2005.
171. Galderisi, Peter F. *Redistricting in the New Millennium*. Lanham, Md.: Rowman and Littlefield, 2005.
172. Gauthier, David. *Morals by Agreement*. Oxford: Oxford University Press, 1986.
173. George Thomas Kurian, editor in chief. *The encyclopedia of political science*. 2011.
174. Gilboa, Itzhak, and David Schmeidler. "Maxmin Expected Utility with a Non-Unique Prior." *Journal of Mathematical Economics* 18, 1989.

175. Godwin, William. 1793. *Enquiry Concerning Political Justice*. Oxford: Oxford University Press, 1971.
176. Gordon, Uri. *Anarchy Alive! Anti-authoritarian Politics from Practice to Theory*. London: Pluto, 2008.
177. Graeme Gill and Luis F. Angosto-Ferrandez. *Introduction: Symbolism and Politics, Politics, Religion & Ideology*. 2018.
178. Grofman, Bernard, and Arend Lijphart. *Political Gerrymandering and the Courts*. New York: Agathon Press, 1990.
179. Guelke, Adrian. *Rethinking the Rise and Fall of Apartheid*. Basingstoke, U.K.: Palgrave Macmillan, 2005.
180. Hacking, Ian. *The Emergence of Probability*. Cambridge: Cambridge University Press, 1975.
181. Halliday, Fred. *The Making of the Second Cold War*. London: Verso, 1986.
182. Hanhimaki, Jussi, and Westad, Odd. *The Cold War: A History in Documents and Eyewitness Accounts*. Oxford: Oxford University Press, 2004.
183. Hardy, Leroy, Alan Heslop, and Stuart Anderson, eds. *Reapportionment Politics: The History of Redistricting in the 50 States*. Beverly Hills, Ca.: Sage Publications, 1981.
184. Hawkesworth, Mary E. *Globalization, E. Feminist Activism*. Lanham, Md.: Rowman and Littlefield. 2006.
185. Hegel, G. W. F. *Phenomenology of Spirit*. Translated by A. V. Miller. Oxford, UK: Oxford University Press, 1977.
186. Henry Mintzberg. *The Strategy Concept I: Five Ps for Strategy*. *California Management Review*, 1987.
187. Henry Mintzberg. *Tracking Strategies: Towards a General Theory of Strategy Formation*. 2008.
188. Herbert A. Simon. *Administrative behavior: A Study of Decision-Making Processes in Administrative Organization*. 1947.
189. Heyes, C. "Identity Politics." In *The Stanford Encyclopedia of Philosophy*, edited by Edward N. Zalta. 2007.
190. Hirschman, Albert O. *Exit, Voice, and Loyalty: Responses to Decline in Firms, Organizations, and States*. Cambridge, Mass.: Harvard University Press, 1970.
191. Hojnacki and Baumgartner. *The Use of Symbolic Arguments in the Policy Process*. 2003.
192. Human Rights First. *2008 Hate Crime Survey: Racism and Xenophobia*. 2008.
193. Huntington, Samuel. *The Clash of Civilizations and the Remaking of the World Order*. New York: Simon and Schuster, 1996.
194. Iancu, Bogdan. *The Law/Politics Distinction in Public Law Adjudication*. Utrecht, The Netherlands: Eleven International, 2009.
195. Inglehart, Ronald, and Christian Welzel. *Modernization, Cultural Change, and Democracy: The Human Development Sequence*. New York: Cambridge University Press, 2005.
196. Johnston, David. *The Idea of a Liberal Theory*. Princeton, N.J.: Princeton University Press, 1994.
197. Johnson, Janet Buttolph, and H. T. Reynolds. *Political Science Research Methods*. Washington, D.C.: CQ Press, 2005.
198. Judith Squires. *The New Politics of Gender Equality* book.
199. Kagan, Robert A. *Adversarial Legalism: The American Way of Law*. Cambridge, Mass.: Harvard University Press, 2001.
200. Katie Smith Milway & Amy Saxton, *Stanford Social Innovation Review, the Challenge of Organizational Learning*, 2011, Marx, Karl. "After the Revolution: Marx Debates Bakunin." In *The MarxEngels Reader*, 2nd ed., edited by Robert C. Tucker, 542–548. New York: Norton, 1978.

201. Kelly, D. Revisiting the Rights of Man: Georg Jellinek on Rights and the State. *Law and History Review*, 2004.
202. Klingemann, Hans-Dieter. *The Comparative Study of Electoral Systems*. Oxford, UK: Oxford University Press, 2009.
203. Lasswell, Harold. *Psychopathology and Politics*. Chicago: University of Chicago Press, 1930.
204. Lasswell, Harold D., Daniel Lerner, and C. Easton Rothwell. *The Comparative Study of Elites: An Introduction and Bibliography*. Stanford, Calif.: Stanford University Press, 1952.
205. Lawler, Edward E., III, Reward systems, in *Improving Life at Work*. J Richard Hackman and J. Lloyd Suttle, eds., Goodyear, Santa Monica, CA, 1977.
206. Leonie Huddy, David O. Sears, and Jack S. Levy *The Oxford Handbook of Political Psychology* (2 ed.). 2013.
207. Locke, John. *Two Treatises of Government*. Edited by Peter Laslett. Cambridge: Cambridge University Press, 1988.
208. Lundquist, A. Absenteeism and job turnover as a consequence of unfavorable job adjustment, *Acta Social*. 3. 1958.
209. Marlene Fiol C., and Marjorie A. Lyles. Organizational learning, *The Academy of Management Review*. Vol. 10, No. 4. Oct., 1985.
210. Martin's, 2000. Tordoff, William. *Government and Politics in Africa*, 4th ed. Bloomington: Indiana University Press, 2002.
211. Maslow, Abraham H., *A Theory of Human Motivation*. Cincinnati: South-Westery Publishing Co., 1960.
212. Measuring Public Service Motivation: An Assessment of Construct Reliability and Validity. *Journal of Public Administration Research and Theory*. 61(1):5-22., 1996.
213. Merelman, Richard M. *Pluralism at Yale*. Madison: University of Wisconsin Press, 2003.
214. Michael E. Milakovich. *Balancing Customer Service, Empowerment And Performance With Citizenship. Responsiveness And Political Accountability*
215. Mill, John Stuart. *On Liberty*. Indianapolis: Hackett, 1978. Rawls, John. *A Theory of Justice*. Rev. ed. Cambridge, Mass.: Harvard University Press, 1999.
216. Mohanty, Chandra Talpade. *Feminism without Borders decolonizing Theory, Practicing Solidarity*. Durham, N.C.: Duke University Press, 2003.
217. Müller, T. *The Parliamentary System*. Oxford Handbooks. 2016.
218. Morton a. Kaplan . *Systems theory and political science*. Source: *Social Research*, Vol. 35, No. 1, Focus-Trends and Issues in American Political Science. 1968.
219. Mudde, C., & Kaltwasser, C. R. *Populism. Oxford Handbooks Online*. 2013.
220. Murray, Charles. *Losing Ground*. New York: Basic Books, 1984.
221. Narveson, Jan. *The Libertarian Ideal*. Philadelphia: Temple University Press, 1988.
222. Nassmacher, Karl-Heinz: "Comparative Political Finance in Established Democracies (introduction)", in Nassmacher, Karl-Heinz (Ed.): *Foundation for Democracy. Approaches to Comparative Political Finance*, Baden-Baden: Nomos, 2001.
223. Nassmacher, Karl-Heinz. "Intriduction: political Parties,w Funding and Democracy" Chapter 1 in *Funding of Political parties and Election Campaigns: Handbook Series*. 2003.
224. N'Diaye, Boubacar, Abdoulaye Saine, and Mathurin Houngnikpo. *Not Yet Democracy: West Africa's Slow Farewell to Authoritarianism*. Durham, N.C.: Carolina Academic Press, 2005.
225. Okin, Susan. *Justice, Gender, and the Family*. New York: Basic Books, 1989. *Women in Western Political Thought*. Princeton, N.J.: Princeton University Press, 1979.

226. Olin O.Oedekoven., Alzahgui, V., Alimaa. J. “Манлайллын үндэс” Улаанбаатар 2014.
227. Organization Culture and leadership. San Francisco, 2004.
228. Parsons, Talcott. Suggestions for a Sociological Approach th the Theory of Organizations, Administrative Science Quarterly.vol.1. 1956.
229. Pasquino, G. Populism and Democracy. Twenty-First Century Populism. 2008. doi:10.1057/9780230592100_2
230. Pediaa. Difference Between Hoesty ans Integrity. 2016.
231. Perry, J. L & L.R.Wise. The motivational basis of public service. Public Administration Review. 1990.
232. Peter M. Senge, “Taking Personal Change Seriously: The Impact of Organizational Learning on Management Practice,” Academy of Management Executive, 17, no. 2. 2003.
233. Poggi, Gianfranco. The Development of the Modern State. London: Hutchinson, 1978.
234. Proudhon, Pierre-Joseph. 1840. What Is Property?. Cambridge: Cambridge University Press, 1994.
235. Rachel Cooper. What is Civil Society, its role and value in 2018? University of Birmingham 15 October 2018. <https://assets.publishing.service.gov.uk>.
236. Richard Hefferna. A Theory of Consensus Politics. (2001) New Labour and Thatcherism Political Change in Britain.
237. Riggs, FW. “Presidentialism vs Parliamentarism: Implications for Representativeness and Legitimacy” 18.3 International Political Science Review 25. 1997.
238. Robert T. Golembiewski., Gerald J. Miller (auth.), Samuel L. Long The Handbook of Political Behavior. 1981.
239. Robert V Presthus. The organizational society; an analysis and a theory. New York : Vintage books. 1962.
240. Robinson, in International Encyclopedia of the Social & Behavioral Sciences, 2001.
241. Roemer, John E., Woojin Lee, and Karine Van Straeten. Racism, Xenophobia, and Distribution: Multi-issue Politics in Advanced Democracies. New York: Russell Sage. 2007.
242. Ronald D, Brunner. Introduction to the policy sciences Political science 5076, Fall 1976. Springer. Policy Sciences, Vol. 30, No. 4. 1997.
243. Ronald D., Rotunda. The Politics of Language: Liberalism as Word and Symbol. 1986.
244. Roniger, Luis. “Political Clientelism, Democracy and Market Economy.” Comparative Politics 36, no. 3. 2004.
245. Rush, Mark E. Does Redistricting Make a Difference?: Partisan Representation and Election
246. Saideman, Stephen M., and R. William Ayres. For Kin or Country: Xenophobia, Nationalism, and War. New York: Columbia University Press, 2008.
247. Sandbrook, R. The “Crisis” in political development theory. The Journal of Development Studies, 12(2). 1976.
248. Sapru, R.K.S. Public Policy. fomulation, implementation and evaluation. 2009
249. Satz, Debra, and Robert Reich. Toward a Humanist Justice: The Political Philosophy of Susan Moller Okin. New York: Oxford University Press, 2009.Sheehan, Sean M. Anarchism. London: Reaktion, 2003.
250. Schein., E.H.Organizational Psychology, Englewood Cliffs, N.J.: Prentice-Hall, 1966.
251. Schoepf, B. G. Ethical, methodological and political issues of aids research in Central Africa. Social Science & Medicine, 1991.
252. Smith. C. Money to Burn: Party Finance and Party Organization in Germany and Austria. Chicago, 2004.
253. Social capital // Encyclopedia of Public administration and Public policy. David Schultz. 2004.

254. Social entrepreneurship // Encyclopedia of Public administration and Public policy. David Schultz. 2004.
255. Sparks, Allister. The Mind of South Africa: The Story of the Rise and Fall of Apartheid. London: Mandarin, 1991.
256. Stears, Marc. Progressives, Pluralists and the Problems of the State. Oxford: Oxford University Press, 2002.
257. Stokes, Susan Carol. "Political Clientelism." In The Oxford Handbook of Comparative Politics, edited by Carles Boix and Susan Carol Stokes, 604–627. Oxford: Oxford University Press, 2007.
258. Svendsen, G.T. The Political Economy of the European Union. Cheltenham, UK. Edward Elgar. 2003.
259. Tami Davis Biddle. Coercion Theory: A Basic Introduction For Practitioners. Texas National Security Review: Volume 3, Issue 2. 2020. Online: ISSN 2576-1153.
260. Tardi, Gregory. The Law of Democratic Governing. Vols. 1-2. Toronto: Carswell, 2004.
261. Taras, Ray. Europe Old and New: Transnationalism, Belonging, Xenophobia. Lanham, Md.: Rowman and Littlefield, 2009.
262. The Modern World-System. Vol. 2, Mercantilism and the Consolidation of the European World-Economy, 1600-1750. New York: Academic Press, 1980.
263. The Modern World-System. Vol. 3, The Second Great Expansion of the Capitalist World-Economy, 1730-1840. San Diego: Academic Press, 1989.
264. Theobald, Robin. Corruption, Development and Underdevelopment. London: Macmillan, 1990.
265. "The Foreign Policies of Small States: Challenging Neorealism in Its Own Backyard." British Journal of Political Science 25 . April 1995.
266. Thomas, C.S. (Ed.). Research Guide To U.S. And International Interest Groups. London: Praeger. 2004.
267. Tilly, Charles, ed. The Formation of National States in Western Europe. Princeton, N.J.: Princeton University Press, 1975.
268. Transparency International. NIS Assessment Toolkit. 2016.
269. Ulla Ovaska, Hilkka Vihinen, Henk Oostindie, Joaquin Farinys, Mojca Hrabar, Emils Kilis, Jurij Kobal, Talis Tisenkopfs and Hans Vulto. Network Governance Arrangements and Rural-Urban Synergy.
270. UNDP, Fighting Corruption to Improve Governance. Corporate Policy Paper. 1998.
271. United Nations Development Programme Glossary of Key Terms in "Governance for Sustainable Development: A UNDP Policy Document, New York, 1997.
272. United Nations, "Public Administration and Democratic Governance: Governments Serving Citizens". New York, 2007.
273. UN. Public Administration And Democratic Governance: Governments Serving Citizens. 2007.
274. VanDyck, C., K. Concept and definition of civil society sustainability. Washington DC: Centre for Strategic and International Studies. 2017.
275. Waldmeir, Patti. Anatomy of a Miracle: The End of Apartheid and the Birth of the New South Africa. London: Viking, 1997.
276. Walford, G. 'Ethics and Power in a Study of Pressure Group Politics', in G. Walford, 1994. (ed.) Researching the Powerful in Education. London: UCL Press. Wall, L.L. and D. Brown. 2007.
277. Weber Max (T.Parsons, ed.: A.M.Henderson and Parsons, trans), The Theory of Social and Economic Organization. New York: Oxford University Press, 1947.
278. Weiner, Myron, ed. Modernization and Dynamics of Growth. New York: Basic Books, 1966.

279. Wesselius, Erik. High Time to Regime EU lobbying “Consumer Policy Review 1”. Jan/ Feb: 2005.
280. Zuckerman, Harriet. Scientific Elites: Nobel Laureates in the United States. New Brunswick, N.J.: Transaction, 1996.

Солонгос хэлээр ашигласан эх сурвалж

1. 김영중, 안희남 (1997). 행정학, 법문사.
2. 김규정(1998). 행정학기초이론, 서울.
3. 안희남 (1997). 행정학, 법문사
4. 오석홍 (1990). 조직관리.서울.
5. 백원기(1994). 행정학 연구. 서울,
6. 송운석 (2012). 신뢰중심의 조직관리. 서울, 아람기획.
7. 한호섭 (1999). 행정학 용어 사전.서울, 행정학용어표준화연구회. 새 정보 미디어.
8. 조석중, 허중경 (1995). 공공조직관리, 한국라디오 및 텔레비전대학.
9. 최창호, 정세욱 (1997). 행정학, 법문사
10. 김규정(1998). 행정학기초이론, 서울.
11. 송운석 (2012). 신뢰중심의 조직관리. 서울, 아람기획.

Цахим эх сурвалж

1. <http://www.academy.edu.mn>
2. <https://www.Amnesty.org>
3. <https://www.apa.org>
4. <https://www.collinsdictionary.com>
5. <https://www.communities.gov.uk>
6. <https://www.data.worldbank.org>
7. <https://www.dictionary.cambridge.org>
8. <https://www.digitalcommons.chapman.edu>
9. <https://www.doi.org>
10. <https://www.encyclopedia.com>
11. <https://www.en.unesco.org>
12. <https://www.en.wikipedia.org>
13. <https://www.humanrightsfirst.org>
14. <https://www.investopedia.com>
15. <http://www.jstor.org>
16. <https://www.mdpi.com>
17. <https://www.merriam-webster.com>
18. <https://www.mirror.unhabitat.org>
19. <https://www.onlinelibrary.wiley.com>
20. <https://www.Pediaa.com>
21. <http://www.philosophy.ru>
22. <https://www.plato.stanford.edu>
23. <http://www.scn.org>
24. <https://www.transparency.org>
25. <https://www.unpan1.un.org>
26. <https://www.wid.world/>